**“Эрх зүйн боловсрол” академи**

**Ханнс-Зайделийн сан**

# *“ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ”*

## *Судалгааны тайлан*

**УЛААНБААТАР ХОТ**

**2018 он**

AKADEMIE "RECHTSBILDUNG"

HANNS-SEIDEL-STIFTUNG

*Bericht zur Studie*

# “BEWERTUNG DER UMSETZUNGSFOLGEN DES ALLGEMEINEN VERWALTUNGSGESETZES”




Ulaanbaatar
2018

Remove Watermark Now

© ХАННС-ЗАЙДЕЛИЙН САН, “ЭРХ ЗҮЙН БОЛОВСРОЛ” АКАДЕМИ, 2018 он

## ГАРЧИГ

Өмнөтгөл 4

**Нэг. УДИРТГАЛ ХЭСЭГ**

Захиргааны ерөнхий хуулийн I, II, III, IV, V, VI, VIII, IX, X дугаар бүлгийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн судалгаа 6-8

Дүгнэлт, зөвлөмжийн товч агуулга 9-16

Хавсралт 17-61

**Хоёр. ЗЕХ-ИЙН 1, 2, 4, 10 ДУГААР БҮЛГИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ХЭСЭГТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

ЗЕХ-ийн 1-р бүлгийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан 63-69

ЗЕХ-ийн 2-р бүлгийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан 70-82

ЗЕХ-ийн 4-р бүлгийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан 83-119

ЗЕХ-ийн 10-р бүлгийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан 120-139

ЗЕХ-ийн 1,2,4,10-р бүлгийн дүгнэлт, зөвлөмж 140-146

**Гурав. ЗЕХ-ИЙН 3, 6, 11 ДҮГЭЭР БҮЛГИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ХЭСЭГТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

ЗЕХ-ийн 3-р бүлгийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан 148-189

ЗЕХ-ийн 6-р бүлгийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан 190-214

Remove Watermark Now

ЗЕХ-ийн 11-р бүлгийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан 215-222

ЗЕХ-ийн 3,6,11-р бүлгийн дүгнэлт, зөвлөмж 223-228

**Дөрөв. ЗЕХ-ИЙН 5, 8, 9 ДҮГЭЭР БҮЛГИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ХЭСЭГТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

1. Төлөвлөх үе шат 230-234
2. Хэрэгжүүлэх үе шат 234-235
3. Үнэлэх үе шат
   *3.1 Захиргааны гэрээ* 235-245
   *3.2 Захиргааны шийдвэр гүйцэтгэл* 245-251
   *3.3 Гомдол гаргах журам* 251-260

ЗЕХ-ийн 5,8,9-р бүлгийн дүгнэлт, зөвлөмж 260-264

**Тав. НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ** 265-280

**Хавсралтууд:**

ЗЕХ-ийн 1, 2, 4, 10 дугаар бүлгийн зарим зүйл, хэсэгт хийсэн үнэлгээний тайлангийн Хавсралт 1- 20

ЗЕХ-ийн 3, 6, 11 дүгээр бүлгийн зарим зүйл, хэсэгт хийсэн үнэлгээний тайлангийн Хавсралт 1- 5

ЗЕХ-ийн 5, 8, 9 дүгээр бүлгийн зарим зүйл, хэсэгт хийсэн үнэлгээний тайлангийн Хавсралт 1- 4

pdfelement

Remove Watermark Now

## Өмнөтгөл

Монгол Улсад захиргааны үйл ажиллагааны суурь харилцааг бүхэлд нь анх удаа нэгтгэн зохицуулж, улмаар иргэнд ээлтэй захиргаа бий болгож хөгжүүлэхэд голлох үүрэг гүйцэтгэх цоо шинэ Захиргааны ерөнхий хууль батлагдан гарч 2016 оны 7-р сарын 1-ний өдрөөс мөрдөгдөж эхэлснээс хойш 2 жил орчим болжээ. Энэ богино хугацаанд шинэ зохицуулалтыг нэг мөр ойлгож хэрэгжүүлэхэд саад бэрхшээл тулгарах нь мэдээж. Тэдгээрийн уг шалтгааныг эрт илрүүлэн засч залруулах нь ч хийгдвэл зохих ажлын нэг бөгөөд хуулийг цаашид зөв хэрэгжүүлэхэд эерэгээр нөлөөлөх нь дамжиггүй юм.

ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сан нь Монгол дахь албан ёсны түншлэгч байгууллагын нэг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хүсэлт ирүүлсний дагуу 2010 оноос Захиргааны ерөнхий хуулийн төслийг боловсруулахад оролцож, батлагдан гарсных нь дараа олон нийтэд таниулан сурталчлах, сургалт зохион байгуулах чиглэлээр яамтай хамтран ажиллаж ирлээ. Тухайлбал германы захиргааны эрх зүйн салбарын томоохон эрдэмтэн судлаачдыг урьж хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэгт удаа дараа зөвлөгөө, дүгнэлт өгүүлж, өөрийн үүсгэн байгуулсан “Эрх зүйн боловсрол” академид 2015- 2016 оны заагт дээр анхны сургагч багш нарыг нь бэлтгэсэн. Улмаар 2016 оноос эхлэн орон даяар сургалт зохион байгуулж захиргааны нийт албан хаагч, захиргааны хэргийн шүүгчдийг хамруулж байгаагийн зэрэгцээ хэрэглээ, судалгааны зориулалтаар шинжлэх ухааны анхны тайлбарыг нь 2017 онд эрхлэн гаргах зэрэг ажлыг хийгээд байна.

Захиргааны ерөнхий хуулиар орон даяар явуулсан сургалтын явцаас түүний онцлог зүйл, заалт хэрхэн хэрэгжиж байгааг судлах хэрэгцээ байгаа нь ажиглагдаж, улмаар энэ чиглэлд ХЗДХЯ-тай хамтран ажиллах тухай санал солилцсоны дүнд судалгааны багийг хоёр талаасаа бүрдүүлж тус хуулийн 10 бүлгийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн байдлыг 2018 оны гурваас зургадугаар сард судлах ажлыг гүйцэтгэлээ.

Бид энэхүү судалгаагаар Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр цаашид авах арга хэмжээний талаар санал, дүгнэлт гаргахыг эрмэлзсэн болно.

Энэхүү судалгааг үндсэн ажлынхаа хажуугаар бага хугацаанд амжуулан хийж гүйцэтгэсэн багийнхан, дэмжлэг үзүүлсэн нийт байгууллага, иргэдэд талархал илэрхийлж, цаашдын ажил үйлсэд нь өндөр амжилт хүсье.

ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар

Сангийн “Эрх зүйн боловсрол” академи

pdfelement

Remove Watermark Now

# Vorwort

Es sind nun beinahe 2 Jahre vergangen, seitdem das Allgemeine Verwaltungsgesetz (AllgVG) am 01. Juli 2016 in Kraft trat, welches zum ersten Mal bei der umfassenden Regelung der grundlegenden Verhältnisse der Verwaltungstätigkeiten in der Mongolei, darüber hinaus der Entwicklung des bürgerfreundlichen Verwaltungswesens eine sehr bedeutende Rolle spielen soll. In diesem kurzen Zeitraum sind Schwierigkeiten bei einheitlichem Verständnis und Anwendung der neuen Regelungen eine Selbstverständlichkeit. Den wirklichen Grund dafür frühzeitig zu erkennen und zu berichtigen, ist eine der wichtigsten Maßnahmen und dies wird die korrekte Anwendung des Gesetzes bestimmt positiv bewirken.

Die Hanns-Seidel-Stiftung beteiligte sich auf Wunsch des Ministeriums für Justiz und Inneres, eines der offiziellen Partner in der Mongolei, an der Ausarbeitung des Entwurfs des AllgVG und arbeitet seit dessen Inkraftreten mit dem genannten Ministerium bei der Verbreitung des Gesetzes in der Öffentlichkeit und der Durchführung von Bildungsveranstaltungen zusammen: Renommierte Wissenschaftler des deutschen Verwaltungsrechts wurden zu Beratung und Stellungnahmen mehrmals eingeladen und die von ihr gegründete Akademie „Rechtsbildung“ hat an der Schwelle von 2015 zu 2016 die ersten Multiplikatoren fortgebildet. Seither wurden landesweit Bildungsmaßnahmen für die Gesamtheit der Verwaltungsbeamten und -richter veranstaltet, und daneben im Jahr 2017 der erste wissenschaftliche Kommentar zum Forschungszweck herausgegeben.

pdfelement

Aus den landesweit durchgeführten Bildungsveranstaltungen wurde der Forschungsbedarf hinsichtlich der Anwendung einiger besonderer Paragraphen des Gesetzes herauskristallisiert. Während des Meinungsaustausches mit dem Ministerium für Justiz und Inneres über die Zusammenarbeit wurde dann ein Monitoring-Team beiderseits gebildet und im Zeitraum von März bis Juni 2018 die Anwendungslage einiger Paragraphen von insgesamt 10 Abschnitten des Gesetzes gemonitort.

Mit dieser Studie versuchten wir aufgrund der Evaluierung der aktuellen Umsetzungslage des AllgVG konkrete Vorschläge und Schlußfolgerungen zu weiteren Maßnahmen auszuarbeiten.

Unser Dank richtet sich an die Mitglieder des Teams, die neben ihrer eigentlichen Berufstätigkeit die Studie in kurzer Zeit durchgeführt haben, sowie an alle Organisationen und Bürger, die uns unterstützt haben. Bei Ihrer weiteren Arbeit wünschen wir viel Erfolg.

Vertretung der Hanns-Seidel-Stiftung in der Mongolei

Akademie „Rechtsbildung“

Remove Watermark Now

# НЭГ. УДИРТГАЛ ХЭСЭГ

## ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН I, II, III, IV, V, VI, VIII, IX, X ДУГААР БҮЛГИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН СУДАЛГАА

Улаанбаатар хот 2018.6.21

Монгол Улсын захиргааны байгууллагын үйл ажиллагааг өрөнхий нэг стандартад оруулсан Захиргааны ерөнхий хууль 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр батлагдаж, 2016 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөгдсөнөөс хойш 2 жил орчим болжээ.

Энэ хугацаанд захиргааны байгууллагууд болон захиргааны хэргийн шүүхээс тус хуулийг практикт нэг мөр, зөв ойлгон хэрэгжүүлэх, хэрэглэхэд зарим асуудал тулгамдаж байгаа нь ажиглагдлаа.

Иймд Захиргааны ерөнхий хуулийн зарим тодорхой зүйл, заалтын хэрэгжилтийн байдал, үр дагаврыг нь судлаж цаашид боловсронгуй болгох санал, дүгнэлт гаргахад энэхүү судалгаа чиглэгдсэн болно.

**Судалгааны зорилго:**

- Захиргааны ерөнхий хуулийн 10 бүлгийн (Төлөвлөлтийг зохицуулсан 7-р бүлгээс бусад) зарим тодорхой зүйл, заалтын зохицуулалт анх хуулиар тавьсан зорилгодоо хүрсэн эсэх, практикт хэрхэн хэрэгжиж байгаа, тэдгээрийн хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг тогтоох, урьдчилан тооцоолоогүй бусад үр дагавар гарсан эсэхийг тодорхойлох;

- Хуулийн цаашдын үр дагавар, нөлөөллийг илрүүлэн гаргаж хууль тогтоомжийг боловсронгуй болгоход холбогдох санал, дүгнэлт өгөхөд оршино.

**Судалгаа хийсэн байдал:**

Монгол Улсын Хууль тогтоомжийн тухай хуулийн (2015 онд батлагдаж, 2017 оны 7-р сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж буй) 51 дүгээр зүйлийн 51.3- т "... хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно" гэж заасан. Мөн Улсын Их Хурлаас 2017 оны эхээр баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"- д Захиргааны ерөнхий хуульд 2018 онд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгасан байна.

Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх ажлыг Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтран явуулж, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-ыг ерөнхийд нь баримтлан "Төлөвлөх", "Хэрэгжүүлэх", "Үнэлэх" гэсэн үе шаттайгаар гүйцэтгэлээ.

Remove Watermark Now

Судалгаа явуулах хүрээг тогтоох зорилгоор 2017 оны 12-р сард Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчид, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч нартай, 2018 оны 1-р сарын 25-нд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон 13 яамдын төлөөллийг оролцуулж, 2-р сарын 02-нд Засгийн газрын хэрэгжүүлэгч, тохируулагч 27 агентлаг, Эрчим хүчний зохицуулах хороо, Харилцаа холбооны зохицуулах хороо, Цөмийн энергийн комиссын ажлын алба, Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын үйлчилгээг зохицуулах зөвлөлийн төлөөллийг, 2-р сарын 09-нд Улсын Их Хурлаас байгуулдаг байгууллагын төлөөллийг тус тус оролцуулж таван удаа ярилцлага зохион байгуулсан (захиргааны албан хаагчидтай хийсэн ярилцлагын тэмдэглэлийг Удиртгал хэсгийн Хавсралтаас, захиргааны хэргийн шүүгчидтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлийг "ЗЕХ-ийн 1, 2, 4, 10 дугаар бүлгийн зарим зүйл хэсэгт хийсэн үнэлгээний тайлан" хэсгийн 9-р хавсралтаас үзнэ үү). Эдгээр ярилцлагад дүн шинжилгээ хийснээр Захиргааны ерөнхий хуулийн үнэлгээнд хамрагдах бүлэг, зүйл, заалтуудыг тодорхойлж, харгалзах шалгуур үзүүлэлтийг сонгон томьёолсон болно.

Судалгаа хийхдээ багийн гишүүд гурван хэсэгт хуваагдаж ЗЕХ-ийн төлөвлөлтийн үйл ажиллагааг зохицуулсан долоодугаар бүлгээс бусад арван бүлгийн нийт гучин найман зүйлийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийлээ.

Судалгааны хүрээнд эрх зүйн харьцуулалтын арга, шүүхийн практик судлах, холбогдох байгууллагын ажилтнуудтай ярилцах, тайлан, статистикийн тоо баримтад дүн шинжилгээ хийх, иргэдээс анкетын болон ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулах зэрэг аргыг ашигласан бөгөөд багийн гишүүд 2018 оны гурваас зургадугаар сард Нийслэл, Сүхбаатар, Орхон аймаг болон Булган аймгийн Тэшиг суманд ажиллаж судалгаа хийв.

pdfelement

Судалгааны багийг Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газрын тэргүүн, доктор(Sc),проф Ц.Сарантуяа удирдаж, сангийн "Эрх зүйн боловсрол" академийн гүйцэтгэх захирал А.Энхтуяа багийн нарийн бичгийн даргаар ажилласан болно.

Тус судалгааны ажлыг ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сан нийт тавин найман сая төгрөгөөр санхүүжүүлэв.

**Судалгааны багийн бүрэлдэхүүн:**

| | | |
|---|---|---|
| Багийн зөвлөх | Д.Ганзориг | Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн, захиргааны эрх зүйн судлаач |
| Үндсэн судлаач | А.Алтанзул | Удирдлагын академийн Эрх зүйн тэнхимийн багш, доктор (PhD) |
| Үндсэн судлаач | Ц.Цогт | Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, хууль зүйн доктор (LL.D.) |
| Үндсэн судлаач | Т.Мөнх-Эрдэнэ | МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш, хууль зүйн магистр (LL.M-University of Vienna) |
| Үндсэн судлаач | А.Сарангэрэл | Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч |
| Үндсэн судлаач | Д.Алтантуяа | ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газар, ЗХХАХШБ-ийн хэлтсийн ахлах мэргэжилтэн |
| Үндсэн судлаач | Ц.Нугармаа | ХЗДХЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, |

Remove Watermark Now

| | |
|---|---|
| Үндсэн судлаач Б.Алтантуяа | дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн ХЗДХЯ- ны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн |
| Туслах судлаач С.Амартүвшин | Хуульч, хууль зүйн магистр (LL.M.) |
| Туслах судлаач П.Баттулга | Хуульч |
| Социологч Л.Булган | Монголын Хараат бус судалгааны хүрээлэн |

**Үнэлгээний тайлангийн бүтэц:**

1. Удиртгал хэсэг
2. ЗЕХ-ийн 1, 2, 4, 10 дугаар бүлгийн зарим зүйл, хэсэгт хийсэн үнэлгээний тайлан
3. ЗЕХ-ийн 3, 6, 11 дүгээр бүлгийн зарим зүйл, хэсэгт хийсэн үнэлгээний тайлан
4. ЗЕХ-ийн 5, 8, 9 дүгээр бүлгийн зарим зүйл, хэсэгт хийсэн үнэлгээний тайлан
5. Нэгдсэн дүгнэлт, зөвлөмж

Хавсралтууд:

- ЗЕХ-ийн 1, 2, 4, 10 дугаар бүлгийн зарим зүйл, хэсэгт хийсэн үнэлгээний тайлангийн Хавсралт 1- 20
- ЗЕХ-ийн 3, 6, 11 дүгээр бүлгийн зарим зүйл, хэсэгт хийсэн үнэлгээний тайлангийн  Хавсралт 1- 5
- ЗЕХ-ийн 5, 8, 9 дүгээр бүлгийн зарим зүйл, хэсэгт хийсэн үнэлгээний тайлангийн Хавсралт 1- 4

pdfelement

Remove Watermark Now

# ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖИЙН ТОВЧ АГУУЛГА[1]

**ЗЕХ-ийн 1-р бүлэг:**

Энэхүү судалгааны ажлын хүрээнд 1-р бүлгийн 3-р зүйлийн 3.1.4, 3.1.7, 4-р зүйлийн 4.2.6, 4.2.8 дахь заалтыг сонгон авч, практикт хэрхэн хэрэгжиж байгааг үнэлж дүгнэхийг зорьсон болно. Иймээс энэхүү үнэлгээний ажилд сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах дүгнэлтийг хийж байна.

- *"Хүлээн зөвшөөрөгдсөн байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд:*

Захиргааны ерөнхий хууль (ЗЕХ)- д зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа нь захиргааны үйл ажиллагаа биш, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (ЗХШХШтХ)- д энэ маргааныг захиргааны хэргийн шүүх хянан хэлэлцэхгүй байхаар заасан атал Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрийг эс зөвшөөрвөл Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар гомдол гаргаж шийдвэрлүүлэхээр заасан нь хоорондоо ихээхэн зөрчилдөөнтэй болжээ.

- *"Практикт хэрэгжиж байгаа байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд*:

1. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд ЗЕХ үйлчлэхгүй байхаар хуульчилж, улмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас гарснаас бусад шийдвэрийг захиргааны акт байхаар нэмэлт оруулсныг Үндсэн хуулийн зөрчил мөн эсэхийг хянуулахаар Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс Улсын Дээд шүүхэд санал хүргүүлж УДШ энэ талаар Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргасан байна. Эдгээр тогтоолыг үндэслэн Нийслэл дэх захиргааны анхан шатны шүүхэд зөрчлийн хэрэг үүсгэн хянагдаж байгаа нийт зөрчлийн хэргийн ажиллагааг Үндсэн хуулийн цэцийн шийдвэр эцэслэн гарах хүртэл хугацаагаар түдгэлзүүлсэн байна. Өөрөөр хэлбэл, захиргааны хэргийн шүүхэд зөрчлийн хэргийг өнөөдрийн байдлаар шийдвэрлээгүй, түдгэлзүүлсэн байдалтай байна.

2. Манай улсын өнөөгийн шүүхийн практикаас харахад Захиргааны хэргийн шүүх нь захиргааны байгууллагын улс төрийн болон бодлогын шинжтэй үйл ажиллагааг түүний захиргааны үйл ажиллагаанаас тэр бүр тодорхой зааглаагүйгээс улс төрийн болон бодлогын шинжтэй шийдвэр мөн, биш хэмээн маргаж, түүнд дүгнэлт хийлгүйгээр шийдсэн 3 тохиолдол гарсан байна. Эндээс үзвэл шүүхийн практикт ЗЕХ-ийн холбогдох заалтыг нэг мөр ойлгох шаардлага байна.

3. ЗЕХ хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш хугацаанд бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн шийдвэр гаргах тохиолдолд урьдчилан мэдэгдэх, оролцоог нь хангах гэсэн ЗЕХ-ийн заалтад үндэслэн хэрэг шийдвэрлэсэн 34 тохиолдол гарсан байна.[2] Судалгаанаас харахад энэ зарчмыг захиргааны байгууллага баримталж ажиллаагүй гэсэн эрх зүйн дүгнэлтийг дийлэнх тохиолдолд хийжээ. Эндээс үзвэл ЗЕХ-д заасан дээрх зарчим нь захиргааны байгууллагын үйл ажиллагаанд бүрэн дүүрэн хэрэгжихгүй байна.

4. ЗЕХ хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш ЗЕХ-д заасан, хууль ёсны итгэлийг хамгаалах зарчимд үндэслэн хэрэг шийдвэрлэсэн зөвхөн 1 тохиолдол гарсан байх бөгөөд эндээс тус заалт амьдралд хэрхэн хэрэгжиж байгаа талаар дүгнэлт өгөх боломжгүй байна.

**ЗЕХ-ийн 2-р бүлэг:**

Хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх судалгааны ажлын хүрээнд "төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага", мөн "нутгийн өөрөө удирдах байгууллага болон шийдвэр, үйл ажиллагаанд нь захиргааны хэргийн шүүхэд

[1] Нэгдсэн дүгнэлт, зөвлөмжийг бүрэн эхээр нь Үнэлгээний тайлангийн Тав дахь хэсгээс үзнэ үү.
[2] Шүүхийн шийдвэрийг шүүхийн шийдвэрийн цахим сангаас шүүлт хийж хайсан болно, Т.М.

Remove Watermark Now

гомдол гаргахаар хуульд тусгайлан заасан байгууллага"-д холбогдох заалтыг сонгон авч, эдгээр заалтууд хуулийн зорилгодоо хүрсэн эсэх, практикт хэрхэн хэрэгжиж байгаа талаар үнэлэлт дүгнэлт өгөхийг зорьсон болно.

- *"Зорилгод хүрсэн байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд:*

ЗЕХ-д тус хуулийн зорилгыг тодорхойлохдоо "нийтийн эрх зүйн хүрээнд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг захиргааны байгууллага"-д ямар субъект багтахыг заажээ. Хуульд захиргааны байгууллагыг тодорхойлохдоо хуучин 2002 оны ЗХШХШтХ- ийн "нээлттэй тоочих" зарчмаас аль болох зайлсхийхийг оролдсон байх боловч бүхэлдээ ерөнхийлөн заах зарчмыг баримталсан гэж дүгнэх боломжгүй байна. Манай улсын ЗЕХ нь ерөнхий заалтын зарчмыг бүрэн баримтлаагүй боловч захиргааны байгууллагуудыг тодорхойлж өгөх  зорилгодоо хүрсэн гэж дүгнэж байна.

- *"Практикт хэрэгжиж байгаа байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд:*

Нэг. ЗЕХ-д "төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага" нь захиргааны байгууллага болно гэж заасан бөгөөд энд "төрийн захиргааны дээд эсхүл төв байгууллага" гэдэг нэр томъёог хэрэглээгүй, харин "төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв байгууллага" хэмээн өргөн агуулга бүхий томъёоллыг хэрэглэсэн байгааг анхаарах нь зүйтэй байна. "Төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв байгууллага" гэдэгт Монгол Улсын Засгийн газар, яам, агентлаг багтах нь хууль боловсруулагчдын болон хууль тогтоогчдын үзэл баримтлал, хуулийн зорилго, эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах онол, арга зүйн талаасаа тодорхой ойлгогдож байна. Практикт хуульчид болон захиргааны хэргийн шүүхийн шүүгчдийн аль аль нь энэ заалтыг ямар нэг хоёрдмол утгагүй ойлгон, маргаангүй хэрэглэж ирсэн байх бөгөөд 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш Монгол Улсын Засгийн газрыг Захиргааны хэргийн шүүхэд хариуцагчаар татаж хэрэг шийдвэрлэсэн тохиолдол 21[3] байна.

Засгийн газрын үйл ажиллагааг бодлогын, буюу захиргааны гэж хоёр ангилан авч үздэг бөгөөд Засгийн газрын захиргааны үйл ажиллагаагаар иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдсөн бол ердийн шүүх (захиргааны хэргийн дагнасан шүүхтэй улсад энэхүү шүүх) зөрчигдсөн эрхийг сэргээх учиртай. Монгол Улсын Засгийн газар нь иргэн, хуулийн этгээдэд шууд чиглэсэн, эрх зүйн үр дагавартай шийдвэр гаргах хууль зүйн өргөн боломжтой. Тухайлбал, 2017 онд Засгийн газраас гаргасан 106 шийдвэрийг түүвэрлэн үзэхэд 8.55% хувь буюу 9 нь захиргааны акт, 42.4% хувь буюу 45 нь захиргааны хэм хэмжээний акт байна.

Монгол Улсын Засгийн газрын шийдвэр, үйл ажиллагаагаар иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдсөн бол захиргааны болон иргэний хэргийн шүүх тус тусын хэргийн харьяаллын дагуу маргааныг шийдвэрлэх нь тодорхой байх бөгөөд хэрэв аль ч шүүх тухайн маргааныг авч хэлэлцэхгүй бол Монгол Улсын Үндсэн хуулийн цэц аль нэг шүүхэд хэргийн харьяалал тогтоож өгнө.

*Хоёр.* Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар эрх нь зөрчигдсөн гэж үзсэн иргэдийн мэдээллийн шаардлагын хүрээнд Үндсэн хуулийн цэц маргаан үүсгээгүй бөгөөд харин аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа маргааны харьяалал тогтоох гомдлын дагуу Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд харьяалал тогтоосон тохиолдол гарсан байна.

*Гурав.* ЗЕХ-д "нутгийн өөрөө удирдах байгууллага" буюу аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, баг, хорооны ИНХ нь захиргааны байгууллага болохыг тодорхой заажээ.

[3] Шүүхийн шийдвэрийн цахим санд нээлттэй байгаа шийдвэрийг түүж судалсан болно. Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн гаргасан "Засгийн газрын шийдвэр шүүхийн хяналтад байх нь: Үндсэн хуулийн цэц болон ердийн шүүхийн харьяаллын асуудал" сэдэвт судалгааны тайланд 35 кэйс байгаа тухай дурджээ https://drive.google.com/file/d/19bHUidJ0OQi4QiG_7gOhLOKErYzjICsn/view



pdfelement

Remove Watermark Now

2002 оны ЗХХШтХ-д ч энэ агуулгаар хуульчлагдсан байсан болно. Энэ заалтыг шүүхийн практикт ямар нэг хоёрдмол утгагүй ойлгож, маргаангүй хэрэглэж ирсэн бөгөөд одоо ч тийнхүү хэрэглэж байгаа болох нь шүүхийн шийдвэрийн судалгаагаар тогтоогдсон.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, баг, хорооны ИНХ-ыг захиргааны байгууллага байна гэдгийг ЗЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтад нэрлэн заасан байх бөгөөд нутгийн өөрөө удирдах байгууллагын захиргааны үйл ажиллагаа нь Захиргааны хэргийн шүүхийн хяналтад багтана.

Харин энэ бүлгийн "хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно" гэж заасан 8-р зүйлийн хувьд практикт хангалттай хэрэгжихгүй байгаа тул ямар тохиолдолд бүрэн эрхээ бусдад шилжүүлж болохыг материаллаг хуулиудад тодорхой хуульчилж өгөх нь чухал байна.

**<u>ЗЕХ-ийн 3-р бүлэг:</u>**

ЗЕХ-ийн 11.3-т заасан захиргааны үйл ажиллагааны хэлбэрээс захиргааны актын хэлбэр голчлон хэрэглэгдэж байгаа бол ЗЕХ-ийн 11.4 дэх заалтын агуулгыг захиргааны байгууллагууд ойлгохгүй байгаа тул уг заалт нь хэрэгждэггүй гэсэн дүгнэлтэнд хүрлээ.

ЗЕХ-ийн 13.1 дэх хэсгийн захиргааны акт, гэрээний эрх зүйн үйлчлэл шууд ба шууд бусаар чиглэсэн этгээдийн талаар хуульд тусгасан томъёоллын талаар судлаач, шүүгчдээс ярилцлага авахад олонхи нь оновчтой гэж үзсэн ба харин хэнийг багтаах вэ гэдэг асуултад ялгаатай байдлаар хариулсан бол иргэд уг томьёоллыг ойлгохгүй байна гэж хариулжээ. Иймд энэ заалтыг зорилгодоо хүрсэн байдлын шалгуураар авч үзвэл хангалтгүй байна гэж үзлээ. Хүлээн зөвшөөрөгдөх байдлын шалгуураар авч үзвэл иргэдээс авсан санал асуулгын үр дүнгээс харахад 46,7 хувь нь ямар нэг байдлаар захиргааны байгууллагын шийдвэр гаргах ажиллагаанд оролцож байжээ. Харин үлдсэн 52 хувь болох иргэдээс оролцож байгаагүй шалтгааныг нь тодруулан асуухад: "оролцох эрхтэй" гэдгээ мэдэхгүй байснаас оролцоогүй гэж 20 хувь, "хариулж мэдэхгүй байна" гэж 30 хувь нь үзсэн нь шийдвэр гаргах ажиллагаанд оролцох эрхтэй талаар мэдээлэл хангалтгүй байгааг харуулж байна.

pdfelement

ЗЕХ-ийн 24.1, 24.5 заалтыг практикт хэрэглэж байгаа байдлын шалгуур үзүүлэлтээр авч үзэхэд хангалтгүй байна. Шийдвэр гаргах ажиллагаанд хамаарах нотлох баримтын талаар ойлголт муу, ялангуяа судалгаа, тооцоолол, шинжилгээнд суурилсан аргаар нотлох баримтыг үнэлэх гэдгийг ойлгохгүй байна.

ЗЕХ-ийн 25-р зүйл - Захиргааны байгууллагууд ЗЕХ-д заасан нотлох баримтыг цуглуулах, үнэлэх ажиллагааг хангалттай хийхгүй байна.

Судалгаанд хамрагдсан 14 байгууллага ЗЕХ-ийн 26, 27, 28-р зүйлд заасны дагуу сонсох ажиллагааг хийж эхлүүлсэн байна. Гэхдээ хуульд заасан журам, шаардлагын дагуу явагдахгүй байгаа нь судалгааны явцад ажиглагдлаа. Зорилгодоо хүрсэн байдлын шалгуур үзүүлэлтийн хувьд хангалттай гэж үзсэн харин практикт хэрэгжиж байгаа байдлыг хангалтгүй гэж дүгнэж байна.

Судалгаагаар ЗЕХ-ийн 29-р зүйлд заасан журмын дагуу захиргааны шийдвэрийн хувийн хэрэг, хяналтын дагалдах хуудас хөтөлж байгаа нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, СХД-ийн Тамгын газар байна. Зорилгодоо хүрсэн байдлын шалгуураар авч үзвэл хувийн хэргийн бүрдүүлбэр байхыг захиргааны байгууллага, шүүгч нар дэмжсэн тул хангалттай гэж үзлээ. Харин практикт хэрэгжиж буй байдлын шалгуур үзүүлэлтийн хувьд хангалтгүй гэж дүгнэж байна.

Зөвлөмж:

- *Огт хэрэгжээгүй заалт*

Remove Watermark Now

- Захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүн оролцох тохиолдолд сонсох ажиллагаа хийх тухай заалт ойлгомжгүй, хэрэгжих боломжгүй байдлаас бус харин захиргааны байгууллагын санаачилгагүй, хэрэгжүүлэх хүсэл зориггүйгээс шууд шалтгаалсан гэж дүгнэх боломжтой.

- Хуулийн зохицуулалтын агуулга, томъёолол ойлгомжгүйгээс хэрэгждэггүй заалтад захиргааны байгууллага хуульд заасан үйл ажиллагааны хэлбэрээс сонгон хэрэглэх боломжгүй тохиолдолд өөрөө тогтоох тухай /11.4/ заалт хамаарч байна. Захиргааны байгууллагын зүгээс тавьж буй саналд ямар үйл ажиллагаа байхыг тодорхойлсон тайлбар хэрэгтэй гэжээ.

-Хуулийн 13.1-д заасан “шууд болон шууд бусаар” гэсэн томьёоллыг өөрчлөх шаардлагатай.

-Нөхцөл байдлыг тогтоох, нотлох баримт цуглуулах талаар ЗЕХ-ийн 24, 25-р зүйлээр албан тушаалтан, албан хаагчдад сургалт явуулах шаардлагатай байна.

Хэрэгжиж эхэлж буй заалтуудын хувьд иргэдэд ЗЕХ-ийн талаар системтэй мэдээлэл өгөх, нөгөө талаас жишээ нь, сонсох ажиллагааны нарийвчилсан үлгэрчилсэн журмыг Засгийн газраас гаргах шаардлагатай байна. ЗЕХ-ийн 103, 105-р зүйлд заасан зохицуулалтын хэрэгжилт сайжирвал энэ бүлэгт нөлөөлөх боломжтой гэж таамаглал дэвшүүлж байна.

**<u>ЗЕХ-ийн 4 дүгээр бүлэг:</u>**

ЗЕХ-д Зөрчлийн тухай хуулийн дагуу оруулсан нэмэлт зохицуулалт нь ЗЕХ-ийн зорилгод нөлөөлж уг хууль, Зөрчлийн тухай, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуулиуд хоорондоо уялдаагүй, шүүхийн практикт хэрэгжүүлэх боломжгүй болсон үр дагавар бий болжээ. Иймд уг хуулийн заалтад өөрчлөлт оруулах шаардлага гарч байна.

.Судалгааны явцад шүүхийн шийдвэрийн shuukh.mn мэдээллийн сангаас шүүлт хийхэд ЗЕХ-ийн 37.7-г хэрэглэж гаргасан шүүхийн шийдвэр, захиргааны акт байхгүй байна. ЗЕХ-ийн 37.7-д заасан заалтыг тодорхой болгон өөрчлөх шаардлагагүй, харин жишээтэйгээр тайлбарлан таниулах, ойлгуулах ажлыг хийх нь зүйтэй.

Захиргааны байгууллага бичгээр гаргаж байгаа актдаа “бодит нөхцөл байдлыг тодорхой заах” үүрэгтэй /ЗЕХ-ийн 40.4/ ба уг заалт захиргааны байгууллагын практикт нэг мөр хэрэгжиж байна.

ЗЕХ-д заасан мэдэгдэх шаардлагыг биелүүлээгүй үндэслэлээр захиргааны актыг хүчингүй болгоход /ЗЕХ-ийн 43/ дээд шатны шүүхээс хэлбэрийн төдий шаардлага учир энэ үндэслэлээр акт хүчингүй болгох үндэслэлгүй гэж дүгнэн тайлбарлажээ. Хэргийн оролцогч талуудаас захиргааны актыг мэдэгдэх шаардлагыг хангаагүй талаар маргадаг боловч шүүхээс энэ үндэслэлээр захиргааны актыг хүчингүй болгосон тохиолдол зөвхөн 1 удаа гарсан байна. ЗЕХ-ийн зорилго, үзэл баримтлалын дагуу цаашид захиргааны актыг мэдэгдэх ажиллагааг захиргааны байгууллага заавал хийдэг болох, хуулийг нэг мөр хэрэгжүүлэх шаардлагатай болох нь судалгаанаас харагдаж байна.

Хэдийгээр зарим байгууллагаас актыг мэдэгдэх ажиллагааны талаар анхаарч журам гаргаж, мэдэгдэх хуудасны загвар батлан мөрдүүлж байгаа боловч энэ нь хангалтгүй байна. Иймд шүүхээс уг хуулийн заалтыг хуулийн зорилгод нийцүүлэх болон ЗЕХ-ийн тусгай зарчмыг заасан зохицуулалттай хэрхэн уялдуулан хэрэглэх талаар нэг мөр ойлголт бий болгож, нэгдсэн практик тогтоох, захиргааны актыг мэдэгдэх шаардлагыг хангаагүй бол актыг хүчингүй болгох үндэслэлээр өөрчлөлт оруулах, мэдэгдэх нарийвчилсан журмыг тухайн захиргааны байгууллага гаргах боломжийн талаар тайлбарлан таниулах шаардлага гарч байна.

Шүүхийн шийдвэрүүдийн үндэслэл, шүүгчдийн дунд хийсэн хэлэлцүүлгийн тэмдэглэл, захиргааны шүүхийн шүүгчдийн дунд явуулсан сургалтын үр дүнгээс харахад ЗЕХ-ийн “иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд

Remove Watermark Now

заасан үндэслэл байгаагүй” гэсэн заалтыг хэт ерөнхий байдлаар томьёолсноос шалтгаалж үүнд хуульд үндэслэх зарчмыг зөрчсөн алдааг хамааруулан ойлгохоор заасан, хуулийн үндсэн үзэл баримтлал, зорилгод нийцэхгүй нөхцөл байдал бий болжээ. Иймээс ЗЕХ-ийн уг зүйлд /47.1.6/ хуулийн зорилгод нийцүүлсэн нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй байна.

ЗЕХ-ийн хууль бус захиргааны актыг хүчингүй болгохтой холбоотой зохицуулалтын зорилго, үзэл баримтлалыг захиргааны байгууллага, шүүгч нарт болон иргэдэд тайлбарлан ойлгуулах, шүүх нэг мөр ойлгож хэрэглэх, нэгдсэн практик тогтоох боломжтой тул уг заалтад өөрчлөлт оруулах шаардлагагүй байна.

ЗЕХ-д заасан, эрх зүйн зөрчилгүй захиргааны актыг цуцлах, захиргааны акт гаргах ажиллагааг дахин хийхтэй холбоотой заалтыг захиргааны байгууллагууд нэг мөр ойлгоогүй байгаа нь судалгаанаас харагдаж байна. Иймд энэ чиглэлээр мөн тайлбарлан таниулах ажил явуулах хэрэгцээтэй. Хуульд өөрчлөлт оруулах шаардлагагүй байна.

ЗЕХ нь Монгол Улсад батлагдан мөрдөгдөж байгаа шинэ хууль, түүнийг нийтээр дагаж мөрдөөд 2 жил орчим болж байгаа тул зарим зүйл заалт ялангуяа онолын ойлголт бүхий зохицуулалтыг нь сайн тайлбарлан таниулах шаардлагатай байгааг анхаарах нь зүйтэй.

**<u>ЗЕХ-ийн 5-р бүлэг:</u>**

Захиргааны гэрээ байгуулах эрхийг Монгол Улсын хуулиудад хуульчилсан байдалд дүн шинжилгээ хийж үзвэл ЗЕХ-ийн захиргааны байгууллага өөрийн зарим чиг үүрэг, эрх мэдлийг бусад этгээдэд шилжүүлэхтэй холбоотой зүйл, заалтын хүрээнд төрийн алба, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, газрын харилцаа, нийгмийн халамж, даатгал зэрэг харилцаанд захиргааны гэрээ байгуулсан байна.

Нэгтгэн дүгнэвэл, захиргааны гэрээг хуульчилсан нь ихээхэн ач холбогдолтой, практикт захиргааны гэрээ байгуулах замаар захиргааны байгууллагууд чиг үүргээ хэрэгжүүлж буй боловч ЗЕХ-ийн захиргааны гэрээний талаарх зохицуулалт тухайн гэрээнүүдэд “хэрэглэгдэж” буй нь цөөн байна. Мөн түүнчлэн ЗЕХ-ийн гэрээний талаарх зохицуулалт зорилгодоо хүрсэн түвшинг тодорхойлоход цаг хугацааны хувьд эрт байна. ЗЕХ-ийн гэрээний зохицуулалт зорилгод хүрсэн эсэх түвшинг тодорхойлохын тулд тухайн хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш байгуулагдсан гэрээний талаарх маргаан шүүхээр шийдвэрлэгдсэн байх шаардлагатай. Тэдгээр гэрээнд ЗЕХ-ийн зохицуулалтыг хэрэглэсэн, гэрээ нь хуулийн зохицуулалтад нийцсэн эсэхээс зорилго биелэсэн түвшин тогтоогдох боломжтой болно.

ЗЕХ-ийн захиргааны гэрээний зохицуулалтыг тухайлсан гэрээнд хэрэглэхийг (наад зах нь тавигдах шаардлага хангах) захиргааны байгууллагуудад ойлгуулах хэрэгцээ, шаардлага тулгамдаж байна. ЗЕХ-ийн захиргааны гэрээтэй холбогдох зохицуулалтад зайлшгүй нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох шаардлага байхгүй байна.

**<u>ЗЕХ-ийн 6-р бүлэг:</u>**

Монгол Улсын Үндсэн хуулиар (Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн хоёр дахь хэсэг) ИТХ- д олгогдсон эрх хэмжээг бие даан шийдвэр гаргах эрх ба шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн чиг үүрэг гэж ялгаатай авч үзсэн байна. Тиймээс ЗЕХ-ийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх хүрээнд Хурлын гаргаж буй захиргааны хэм хэмжээний актыг энэ хоёр шинжээр нь ялгах шаардлагатай (бие даасан хэм хэмжээний акт ба захиргааны хэм хэмжээний акт).

ЗЕХ-д заасан Засгийн газрын баталсан захиргааны хэм хэмжээний актыг бүртгэх, хянах байгууллагыг УИХ-ын харьяа нэгжид бий болгож, үүнтэй холбоотойгоор Засгийн

pdfelement

газрын тухай хуулийн захиргааны хэм хэмжээний акт хүчин төгөлдөр болох асуудлыг зохицуулсан заалтыг хүчингүй болгох шаардлага харагдаж байна.

УИХ-ын харьяа нэгжид УИХ-аас байгууллагддаг захиргааны байгууллагууд, мөн ИТХ-ын захиргааны хэм хэмжээний актыг бүртгэж, хянах чиг үүргийг олгох шаардлагатай. Захиргааны хэм хэмжээний актыг баталснаас хойш ажлын таван өдрийн дотор бүртгүүлэх хугацааг нийслэл, орон нутгийн түвшинд ялгаатай тогтоох хэрэгцээтэй.

Захиргааны хэм хэмжээний акт эрх зүйн зөрчилтэй байгаа тухай дүгнэлтийг хүлээн авсан байгууллага өөрийн гаргасан актыг хянаж, зөрчлийг арилгасан бол бүртгүүлэхээр дахин хүргүүлэхэд мөн ИТХ-ын онцлогийг харгалзах шаардлага бий.

Засгийн газар хянан бүртгэх үйл ажиллагааныхаа хүрээнд ирүүлсэн дүгнэлтийг хэлэлцэж түүнд үндэслэн захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох эсэхийг шийдвэрлэх заалтыг агуулгын зөрчилтэй мөн бусад хуультай зөрчилдөж байгаа эсэхийг нягтлах (Үүнд: ИТХ-ын шийдвэр, УИХ-аас байгууллагддаг хараат бус байгууллагын шийдэрийг хүчингүй болгох субьект Засгийн газар мөн эсэх).

Хүчин төгөлдөр болоогүй шийдвэрийг хүчингүй болгох зохицуулалт нь томъёоллын, эсхүл зарчмын алдаа эсэхийг нягтлах шаардлагатай байна. Бусад заалтын хувьд хэрэгжилт хангалтгүй байх шалтгаан нь захиргааны байгууллагууд хуульд заасан үүргээ биелүүлэхгүй, тэдний хариуцлагагүй үйлдэлтэй холбоотой гэж дүгнэж болохоор байна.

**<u>ЗЕХ-ийн 8-р бүлэг:</u>**

ЗЕХ-ийн захиргааны шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой бүлгийн зохицуулалтын агуулгаас үзвэл мөн хуульд заасан захиргааны шийдвэрийн төрлүүдээс “захиргааны акт” -ыг гүйцэтгэх журмыг илүүтэйгээр зохицуулснаас болоод мөн хуульд заасан захиргааны бусад шийдвэр, ялангуяа “захиргааны гэрээ” -ний гүйцэтгэлийг хэрхэх нь тодорхойгүй орхигдсон байна.

Судалгаанд хамрагдсан байгууллагууд ЗЕХ-ийн захиргааны шийдвэр гүйцэтгэлийн харилцааг зохицуулсан бүлгийг хэрэглэдэггүй нь уулзалт, ярилцлагын үеэр тодорхой харагдсан. Захиргааны байгууллагууд ЗЕХ-ийн захиргааны шийдвэр гүйцэтгэлийн зохицуулалтыг хэрэглэх гэхээс илүүтэй ийм боломж, зохицуулалт байгааг мэдэхгүй нь элбэг тохиолдож байна. Үүнээс үүдээд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг байгууллагын дотоод журам, эсхүл ажилтны үзэмжээр явуулснаас хожим нь захиргааны шийдвэр гүйцэтгэл нь эрх зүйн зөрчилтэйд тооцогдох магадлал өндөр байна.

Түүнчлэн, ЗЕХ-д заасназр захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй журмыг захиргааны шийдвэр гүйцэтгэлд хэрэглэдэг тохиолдол байна. Тэдгээрийг улсын нэгдсэн бүртгэлд шинэчлэн бүртгүүлэх шаардлагатай, ингэснээр газар чөлөөлөх шийдвэрийг гүйцэтгэх үйл ажиллагаа нь ЗЕХ-ийн шийдвэр гүйцэтгэлийн зохицуулалтад нийцэх боломжтой болох юм.

ЗЕХ-ийн захиргааны шийдвэр гүйцэтгэх байгууллага болох тусгайлан эрх олгосон цагдаагийн болон мэргэжлийн байгууллага, өөр захиргааны байгууллагаас тусламж авч болох талаарх зохицуулалтад мөн хуулийн “захиргааны байгууллагын харилцан туслах үүрэг” зохицуулсан заалтын агуулга зөрчилдөөгүй, харин ч бие биенээ нөхцөлдүүлсэн шинжтэй уялдаа бүхий байна.

ЗЕХ-д “мэдэгдэлд заасан хугацаанд үүргийг биелүүлээгүй бол ... албадлага хэрэглэхийг шийдвэрлэсэн захиргааны акт гарган, нэн даруй” биелүүлэхээр заасан боловч мөн зүйлд уг актад гомдол гаргаж болохоор байгаа нь зөрчилдөж байна. Өөрөөр хэлбэл, нэн даруй биелүүлэх зохицуулалт хэрэгжих боломжгүй болж байна. Тиймээс нэн даруй биелүүлэх зохицуулалтыг хангахын тулд шийдвэр гүйцэтгэл хийгдэхдээ хууль болон үүрэг хүлээгчийн эрх зөрчигдсөн гэж үзвэл нөхөж гомдол гаргаж тогтоолгох боломжтой байхаар өөрчлөлт оруулж болох юм.



Remove Watermark Now
pdfelement

Remove Watermark Now

ЗЕХ-ийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой бүлгийн зохицуулалт нь нийтлэг байдлаар захиргааны бүх төрлийн шийдвэрийг гүйцэтгэх журмыг тодорхойлсон шинжтэй байгааг илүү тодорхой болгож, энэ агуулгаар захиргааны актыг онцлон заасан хэсгүүдэд өөрчлөлт оруулж болохоор байна. Түүчнлэн захиргааны байгууллагуудад ЗЕХ-ийн захиргааны шийдвэр гүйцэтгэлийн зохицуулалтыг таниулах сургалт, мэдээлэл өгөх нь уг зохицуулалтыг хэрэгжүүлэх, улмаар ЗЕХ-д шийдвэр гүйцэтгэлийг зохицуулж өгсөн зорилгод хүрэхэд дөхөм болохоор байна.

**ЗЕХ-ийн 9-р бүлэг:**

ЗЕХ-ийн гомдол гаргах журам нь захиргааны гэрээтэй холбогдуулан гомдол гаргах харилцааг зохицуулаагүй гагцхүү захиргааны актад гомдол гаргах, уг гомдлыг хянан шийдвэрлэх журмыг тогтооход зорьсон болох нь тодорхой. Гэрээний талууд, ялангуяа захиргааны нөгөө тал буюу иргэн, хуулийн этгээд гэрээний тал болсон захиргааны дээд шатанд гомдол гаргах эрх байх уу гэсэн асуулт тодорхой зохицуулалтгүй орхигдсон байна.
Гэрээтэй холбоотой маргаан гарсан тохиолдолд шүүх нэхэмжлэлийн шаардлага нь захиргааны акт эсхүл гэрээ байхыг ялгахгүйгээр урьдчилан шийдвэрлүүлсэн байхыг шаардах[4] тул ЗЕХ-д гэрээтэй холбогдуулж урьдчилан шийдвэрлүүлэх журмаар гомдол гаргах шаардлага тавигдах эсэх талаар зохицуулалт хийх нь зайлшгүй юм.

ЗЕХ-ийн энэ бүлгийн зохицуулалт зорилгодоо бүрэн хүрэхгүй байгаагийн шалтгаан нь зэрэгцсэн олон хуулийн зохицуулалттай, гомдол хянан шийдвэрлэх хүн хүч, төсөв, цаг хугацаа хүрэлцдэггүй зэрэгтэй холбоотой. Мөн ИТБАТГӨГШтХ-ийн зохицуулалт давхцсаны улмаас гомдол хянан шийдвэрлэх ажиллагааг саармагжуулах, урьдчилан тооцоолоогүй үр дагавар бий болох зэрэг нь хуулийн хэрэгжилтэд нөлөөлж байна.

ЗЕХ-ийн энэ бүлгийн зохицуулалтыг саармагжуулж буй ИТБАТГӨГШтХ-г үүргээ гүйцэтгэсэн гэж үзэж хүчингүй болгох нь зүйтэй байна. ЗЕХ-ийн гомдол гаргах журмын тухай бүлэгт захиргааны гэрээтэй холбогдуулж урьдчилан шийдвэрлүүлэх журмаар гомдол гаргах шаардлага тавигдах эсэх талаар мөн гомдлын шаардлагын төрлийг тодорхой зохицуулаагүй тул тэдгээрийг ялган зааж өгөх талаар холбогдох өөрчлөлт оруулах саналтай байна. Түүнчлэн гомдол хянан шийдвэрлэх чиг үүргийг тусад нь байгууллага, бүтцэд хариуцуулсан салбарт захиргааны байгууллагын үндсэн тогтолцооны дээд шатны байгууллага, албан тушаалтанд доод шатны шийдвэрийг хянах эрх хэмжээ давхцуулан хуулиар олгохгүй байх, гагцхүү гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллага гомдлыг шийдвэрлэх эрхтэй гэсэн зохицуулалт ЗЕХ-д оруулах нь ач холбогдолтой байж болох юм.

**ЗЕХ-ийн 10-р бүлэг:**

Иргэний хууль, Захиргааны ерөнхий хууль холбогдох бусад хуульд заасны дагуу төрийн буруутай үйл ажиллагаанаас учирсан хохирлыг төр барагдуулж байгаа боловч буцаагаад төрийг хохиролгүй болгох тухай холбогдох хуулийн хэрэгжилт 0 хувьтай байна. Захиргааны ерөнхий хууль батлагдснаас хойш хугацаанд төдийгүй энэ талаарх эрх зүйн зохицуулалт бусад хуульд бий болсон үеэс хойш энэ нь огт хэрэгжээгүй байна.

Иймд уг асуудлыг нарийвчлан зохицуулах шаардлагатай бөгөөд ийнхүү зохицуулахдаа төрийн албан хаагчийг хувийн хариуцлагатай байлгах эсэх, албан хаагчийнхаа ямар алдаа дутагдлын улмаас үүссэн хохирлыг төр хариуцах, ямрыг албан тушаалтнаас буцаан гаргуулах талаарх зохицуулалт, хамтын удирдлагатай

[4] Шүүхийн практикт ЗХШХШтХ-ийн 54.1.3-ийг зөвхөн захиргааны акттай холбогдуулан нэхэмжлэл гаргаж буй тохиолдолд хэрэглэж байгаа, учир нь ЗЕХ-ийн 92-94 дүгээр зүйл үйлчлэхээр заасан, түүнд нь зөвхөн захиргааны актад гомдол гаргах тухай зохицуулалт байгаа гэдэг үндэслэлээр.

Remove Watermark Now

байгууллагын учруулсан хохирлыг буруутай этгээдэд хэрхэн ногдуулах, буруутай этгээдээс төрд учирсан хохирлыг гаргуулах асуудлыг төрийн аль нэг бүтцэд хариуцуулсан одоогийн тогтолцоо нь оновчтой эсэх, эсхүл уг асуудлыг төрийн бус байгуулллагаар гүйцэтгүүлэх зэрэг асуудлыг нэгтгэн зохицуулах шаардлагатай.

Төрийг буцааж хохиролгүй болгох асуудлыг шийдвэрлэхгүй байгаа нь төрийн албан хаагчдыг хариуцлагагүй шийдвэр гаргах замаар иргэн, хуулийн этгээдэд хохирол учруулах явдлыг улам бүр нэмэгдүүлж байх тул буруутай этгээдээр төрийг буцааж хохиролгүй болгох ажиллагааг хэрэгжүүлэх, хэвшүүлэх шаардлагатайг анхаарах.

Хохирол, нөхөн төлбөртэй холбоотой харилцааг зохицуулсан Захиргааны ерөнхий хуулийн зарим зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хуультай зөрчилдөж байгаа бөгөөд бодит практикт үүсэх зарим тохиолдлыг шийдвэрлэхэд хангалттай зохицуулалт агуулаагүй байх тул хууль хоорондын харилцан уялдааг хангах нь зүйтэй.

Захиргааны байгууллагын хууль ёсны ажиллагаанаас иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирлыг нөхөн төлөх талаарх хуулийн хэрэгжилтийг судлахад уг асуудал нэгдсэн зохион байгуулалтгүй байгаа бөгөөд захиргааны байгууллагын хууль ёсны ажиллагаанаас иргэн, хуулийн этгээдэд учрах хохирол гэх ойлголт нь өөрөө тодорхойгүй байна. Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлснээс хойш “захиргааны байгууллагын хууль ёсны үйл ажиллагаанаас иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирол”-ыг хэрхэн нөхөн төлсөн талаарх нэгдсэн тооцоо, судалгаа байхгүй байна. Иймээс эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулах зэрэг зөвлөмжийг хууль санаачлагчид хүргүүлж байна.

**<u>ЗЕХ-ийн 11-р бүлэг:</u>**

Судалгаанд хамрагдсан 14 захиргааны байгууллага хууль зөрчсөн албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагын тухай ЗЕХ-ийн заалтыг хэрэгжүүлж шийдвэр гаргаагүй байна. Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй 660 хуулиас 184 хуульд төрийн албан хаагчдад хүлээлгэх хариуцлагыг зохицуулсан. Төрийн албаны тухай хуулийг эшилсэн 145 хууль байна. Захиргааны алдаатай акт гаргасан тохиолдолд ЗЕХ-иар сахилгын шийтгэл болон уучлал хүсэх шийтгэл хүлээлгэхээр зохицуулсан.

Гэм буруутай албан тушаалтанд хүлээлгэж буй сахилгын шийтгэл нь Төрийн албаны тухай хуулиар зохицуулж буй шийтгэлээс хэрхэн ялгаатай болох, давхцал үүсвэл хэрхэн зохицуулах талаар асуултууд гарч ирж байна. Эдгээр асуултад онол арга зүйн тайлбар гаргах нь зүйтэй болов уу.

ЗЕХ-д заасан, захиргааны байгууллагын болон шүүхийн шийдвэрийг үл биелүүлсэн албан тушаалтанд холбогдох хуульд заасан хариуцлагыг шүүх оногдуулна гэсэн заалтыг тайлбарлах, хэрэв шүүхээс буруутай албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх шаардлагатай гэж үзвэл захиргааны хариуцлага хүлээлгэх буюу торгох шийтгэлийн хэлбэртэй байх боломжтой байна.

СУДАЛГААНЫ БАГ

pdfelement

Remove Watermark Now

**Хавсралт**

## “ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ” СЭДЭВТ

### Уулзалт-ярилцлагын тэмдэглэл

2018.01.25 Улаанбаатар хот

“Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилт” сэдэвт уулзалт, ярилцлагыг Хууль зүй дотоод хэргийн яам, ХБНГУ-ын Ханнс Зайделийн сантай хамтран 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 09 цаг 15 минутад Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хуульчдын танхимд зохион байгуулав.

Уг уулзалт, ярилцлагад Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон төрийн захиргааны төв байгууллага болох 13 яамдын төлөөлөл, Захиргааны ерөнхий хуулийн ажлын хэсэгт орж ажилласан гишүүд, зөвлөхүүд болон Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн үр дагавар үнэлгээ хийх ажлын хэсгийн гишүүд оролцов.

**Уулзалт, ярилцлагыг чиглүүлэгч:** “Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилт” сэдэвт уулзалт, ярилцлагыг нээж үг хэлнэ үү хэмээн Хууль зүй дотоод хэргийн яамны Дэд сайд Энхбаяр, Захиргааны ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсгийн гишүүдийг индэрт урив.

**Дэд сайд Б.Энхбаяр:** Та бүхний өглөөний амгаланг айлтган мэндчилье. Өнөөдрийн “Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилт” сэдэвт уулзалт, ярилцлага бол чөлөөт, ажил хэрэгч та бүхий өмнө тулгарч буй асуудлуудыг ярилцах, тодорхой асуудлуудыг онол арга зүй, практик талаас нь хөндсөн ийм хэлэлцүүлэг болоосой гэж хүсэж байна. Захиргааны ерөнхий хууль бол манай улсын хувьд бол захиргааны эрх зүйн шинэтгэл төдийгүй эрх зүйн салбарт оруулсан маш том алхам байсан. Хууль хэрэгжээд жил гаран хугацаа болж байна. Өөрөөр хэлбэл бид нар явц байдлыг хууль зүйн хэрэглээ талаасаа, шүүхийн процесс талаасаа мөн практик дээр гарч буй асуудлыг харах ийм хэрэгцээ, шаардлага байна гэж үзэж байна. Хууль хэрэгжилтийн явцад үүсч байгаа асуудал байвал уг асуудлуудыг шийдэх ёстой. Гарцаагүй тулгамдсан тийм зүйлүүд байвал даруй, хугацаа алдахгүй шийдэх ёстой. Хуультай биш хэрэгжүүлэх механизмтэй холбоотой асуудал байгаа бол түүнийг зөв олж харах, ярих ёстой. Мөн ойлголтын зөрүүтэй асуудлууд байвал түүнийгээ оновчтой зөв зааглаж ярих ёстой. Тэгэхгүй бол хүн өөрийн алдааг өөрөөсөө бус өөр зүйлээс хайж эхэлдэг түүнийгээ эрдэмтдээс хайна, эсвэл хуулиас хайна. Ийм асуудлууд бол шинэ тутам гарч буй хуулиуд дээр анзааргдаад байна. Энэ нь шилжилтийн онцлог байж магадгүй. Тухайн хуулийг гардаж хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн алба хаагчид, албан тушаалтнуудтай холбоотой ийм асуудлууд байна. Хуулийн хэрэгжилт харилцан адилгүй байгаа. Өөрөөр хэлбэл тухайн хүнээс хамаарч байна уу, эсхүл байгууллагын удирдлагаас хамаарч байна уу, эсхүл заримдаа үүнийг хэрэглэж байгаа шүүгчээс хамаарч байгаа зэргээр хэрэглээний явцад өөр өөр жишиг тогтоож байгаа асуудлууд байна.

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулах асуудал бол УИХ-аас баталсан хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох хөтөлбөрт туссан. Энэ талаар урьдчилсан ямар нэг дүгнэлт, чиглэл байхгүй. Өөрөөр хэлбэл заавал энэ зүйлийг өөрчилнө гэж Засгийн газар, Хууль зүй дотоод хэргийн яамнаас бодлого гаргаж ажлын хэсэг гаргасан гэж үзэж болохгүй. Үзэл баримтлал бол гараагүй ажлын хэсгийн тушаал өчигдөр албажиж гарсан байгаа. Энэ хүрээнд олон талаас нь асуудлуудаа ярилцаад асуудал юу байна шийдэл юу байна гэсэн зорилго, санаа агуулж байгаа гэдгийг хэлмээр байна.

Сургалт сурталчилгаа бол нилээд их шаардлагатай байна. Энэ сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах, тасралтгүйгээр ойрын 5 жилдээ сургалт сурталчилгаа хийх шаардлагатай байна.

Шийдвэр гаргах түвшинд яригддаг гол асуудал бол Засгийн газар захиргааны шүүхийн харьяалалд байх эсэх асуудал юм. Энэ асуудалтай холбоотой оны өмнө Засгийн газрын хуралдаан дээр тодорхой кэйс маргааны асуудлыг хэлэлцэх явцдаа энэ асуудлаар Үндсэн хуулийн Цэцэд хандаж нэг мөр болгох асуудал гаргасан. Үүний дагуу судалгаа хийгдэж байгаа. Миний хувьд бол Засгийн газар захиргааны хэргийн хяналтаас бүрэн гарах ёстой этгээд гэж

pdfelement

ойлгодоггүй тодорхой онол арга зүй, хэрэглээний хувьд тодорхой ойлгох боломжтой хувилбаруудыг гаргах тал дээр илүү ажиллах ёстой. Жишээ нь: Засгийн газрын хөдөлмөрийн маргаан бол заавал хянагдах ёстой. Гэтэл үүнтэй хамт УИХ, Засгийн газраас явуулж байгаа томоохон бүтээн байгуулалтын шинжтэй, мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой хугацаа алдах, зогсох ийм асуудлууд хүртэл яригдаж байна. Эрдэнэт үйлдвэрийн маргаан одоо ямар маргаан бэ? Хүний эрх ашиг уу? Албаны эрх ашиг уу? Улсын эрх ашиг уу? Энэ өөрөө ямар төрлийн маргаан юм. Хууль тогтоох байгууллага шийдвэр гаргасан байна. Үүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар яах ёстой юм? Хөшигтийн хөндийн асуудал байна. 2 улсын хоорондын зээлийн хэлэлцээртэй асуудал дээр Засаг дарга нь газар олгосноос болоод энэ асуудал хойшлоод байгаад байх уу? Үүний хохирол үр дагавар гэдэг бол хэдэн зуун тэр бум төгрөгөөр хэмжигдэх эргээд улс оронд хохиролтой үр дагаврууд гарч байна. Энэ мэт улс орны шинжтэй томоохон асуудлуудыг яах ёстой бэ? Үүнийг хууль зүйн талаас нь илүү нарийвчлаад ямар зохицуулалт хийж болохоор байна гэдэг хувилбаруудыг энэ ажлын хэсгийн хүмүүстэй олон талаас нь ярилцаасай гэж хүсэж байна. Ингэж ярилцах тусмаа илүү зөв шийдвэр гарна. Өнөөдрийн уулзалт, ярилцлагын үйл ажиллагаанд амжилт хүсье баярлалаа гэв.

**Уулзалт, ярилцлагыг чиглүүлэгч**: Энэхүү уулзалт ярилцлагыг хамтран зохион байгуулж байгаа Ханнс Зайделийн сангийн тэргүүн Сарантуяа захирал гадаад томилолттой. Энэхүү уулзалтад ирж амжсангүй. Иймээс Эрх зүйн боловсрол академийн гүйцэтгэх захирал Энхтуяа таныг үг хэлнэ үү хэмээн урьж байна.

**Эрх зүйн боловсрол академийн гүйцэтгэх захирал А.Энхтуяа:** Та бүхэнд энэ өглөөний мэндийг хүргэе! Энэ уулзалт ярилцлагыг хамтран зохион байгуулж байгаа Хууль зүй дотоод хэргийн яам, түүний холбогдох хэлтэс Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн хамт олонд талархал илэрхийлье! Мөн энэ ярилцлагад хүрэлцэн ирсэн та бүхэнд талархал илэрхийлье! Өнөөдрийн уулзалт ярилцлагын гол зорилгын талаар Энхбаяр сайд та бүхэнд танилцууллаа. Иймээс энэ удаагийн уулзалт ярилцлага үр өгөөжтэй байгаад Захиргааны ерөнхий хуулийг цаашид улам боловсронгуй болгох чиглэлд хувь нэмэр оруулна гэж найдаж байна.

Ханнс Зайделийн сан 1995 оноос хойш Монгол Улсын Засгийн газартай байгуулсан эрх зүйн салбарт дэмжлэг туслалцаа үзүүлэх хэлэлцээрийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. 2001 онд Эрх зүйн боловсрол академи гэж дэргэд нь байгуулагдсан төрийн бус байгууллага. “Эрх зүйн боловсрол” академи Захиргааны ерөнхий хуулиар өмнө явагдсан сургалтуудыг Хууль зүй дотоод хэргийн яамтай хамтран зохион байгуулсан. 2016, 2017 онуудад төрийн захиргааны нийт албан хаагчдад сургалт зохион байгуулсан. Үүнээс гадна сургалтын гарын авлага Захиргааны ерөнхий хуулийн судалгаа хэрэглээний тайлбар гаргах зэрэг ажлуудыг хийж байна. 2018 онд Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн талаар судалгаа хийхээр төлөвлөсөн.Яагаад судалгаа хийхээр төлөвлөсөн бэ? гэхээр Захиргааны ерөнхий хууль бол манай улсын хувьд онцлог хууль. Хэдийгээр зарим зохицуулалтууд салбарын хуулиудад байсан ч гэсэн Захиргааны ерөнхий хуулиар захиргааны байгууллагуудын үйл ажиллагааг нэгдсэн стандартад оруулахад чиглэсэн хууль гэдгээрээ онцлог. Энэ хуулийг хэрэгжүүлэхэд нэлээд асуудал гарах нь ойлгомжтой. Энэ бүх асуудлын учрыг олоход манай хийх гэж байгаа судалгаа хувь нэмэр болно гэж үзэж байгаа.

Хууль зүй дотоод хэргийн яам энэ хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар төлөвлөсөн байгаа, энэ ажлын хэсэгтэй мөн хамтран ажиллах гэж байна.

Та бүхэнд тулгамдаж байгаа асуудлууд, энэ хуулийг хэрэгжүүлэхэд ямар асуудал гарч байгаа, юу нь болохгүй байна? гэдэг талаар тодорхой ярилцана гэж бодож байна. Өнөөдрийн ярилцлагад Захиргааны ерөнхий хуулийн төсөл дээр ажилласан ажлын хэсгийн зарим гишүүд. тухайлбал Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Ганзориг, МУИС-ХЗС-ийн багш, доктор профессор П.Одгэрэл, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч доктор Ц.Цогт зэрэг хүмүүсээс асууж тодруулах зүйл байвал чөлөөтэй ярилцана гэж бодож байна. Та бүхэнд амжилт хүсье.

**Уулзалт, ярилцлагыг чиглүүлэгч**: Өнөөдрийн “Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилт” сэдэвт уулзалт ярилцлагаар хөтөлбөрт зааснаар хоёр мэдээллийг сонсох ёстой байгаа. Эхний мэдээлэл Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой болон одоо хийж

Remove Watermark Now

байгаа ажлын талаар мэдээлэл өгнө үү? хэмээн Хууль зүй дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн дарга Ариунтуяа таныг урьж байна.

**Хэлтсийн дарга Д.Ариунтуяа**: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Захиргааны ерөнхий хууль хэрэгжээд жил зургаан сарын хугацаа өнгөрөөд байна. Энэ хооронд Хууль зүй дотоод хэргийн яам нэлээдгүй ажил хийсэн. Өнөөдөр та бүхэнд танилцуулах гэж байгаа зүйл маань хоёр хэсэгтэй.

Нэг: Захиргааны ерөнхий хууль 2015 онд батлагдснаар хуулийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд Хууль зүй дотоод хэргийн яам ямар ажлууд хийсэн талаар товч танилцуулъя.

Хууль зүйн яам /хуучин нэрээр/-ны Төрийн нарийн бичгийн дарга энэ хуулийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөө баталж энэ чиглэлээр нэлээдгүй ажлыг хийсэн.

1.1.Хууль зүйн сургуулийн захиргааны эрх зүйн багш, судлаач, ажилтнуудад зориулсан сургалтыг 2015 оны 10 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд Ханнс-Зайделийн сантай хамтран амжилттай зохион байгуулж нийт 32 багш, судлаач, ажилтнуудыг хамруулсан.

1.2. Захиргааны ерөнхий хуулийг заах сургагч багш бэлтгэх сургалтыг 2015 оны 11 дүгээр сарын 23-28-ны өдрүүдэд /нийт 6 өдөр/ зохион байгуулж, 31 сургагч багш бэлтгэн, гэрчилгээ олгосон.

1.3.Захиргааны ерөнхий хуулийн талаар Ханнс-Зайделийн сантай хамтран шторк бэлтгэж хэвлэл, мэдээллийн хэрэгсэлээр сурталчилсан. Дээрх шторкийг /CD хэлбэрээр/ аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ, яамдуудад албан бичгээр хүргүүлж, холбогдох мэдээллийн хэрэгсэлээр түгээсэн.

1.4.Захиргааны ерөнхий хууль 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэхтэй холбогдуулан Хууль зүйн яам /хуучин нэрээр/, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн Эрх зүйн боловсрол академитай хамтран яам, агентлаг болон нийслэл, дүүргүүдийн ЗДТГ, Захирагчийн ажлын алба, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагуудын албан хаагчдад зориулсан танилцуулах сургалтыг 2016 оны 2 дугаар сарын 16-наас 4 дүгээр сарын 1-ний хооронд, мөн 21 аймагт 4 дүгээр сарын 17-30-ны хооронд тус тус зохион байгуулж, нийт 100 гаруй удаагийн сургалтаар **7500 гаруй** ажилтан, албан хаагчийг хамруулж, брошур, гарын авлага, сурталчилгааны материалуудыг түгээж, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчилсан байна.

pdfelement

1.5.Захиргааны ерөнхий хуулийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 3.2 дахь хэсэгт заасны дагуу Захиргааны ерөнхий хуулийн агуулгыг Хууль зүйн их, дээд сургуулиудын Захиргааны эрх зүйн хичээлийн сургалтын хөтөлбөрт шинэчлэн тусгуулах саналыг Хууль зүйн сайдын /хуучин нэрээр/ албан бичгээр Боловсрол, соёл, шинжлэх ухааны Сайдад /хуучин нэрээр/ хүргүүлж, хэрэгжсэн байна.

1.6.Захиргааны ерөнхий хуулийн 61 дүгээр зүйлийн 61.6, 72 дугаар зүйлийн 72.2, 54 дүгээр зүйлийн 54.4 дэх заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах журмуудыг эрх олгосон захиргааны байгууллагууд баталсан. Үүнд:

- Хууль зүйн сайд /хуучин нэрээр/-ын 2016 оны 7 сарын 1-ний өдрийн А/222 тоот тушаалаар "Нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал",
- Хууль зүйн сайд /хуучин нэрээр/-ын 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн А/226 тоот тушаалаар "Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санг эрхлэн хөтлөх тухай" журмыг хууль хэрэгжиж эхлэхээс өмнө батлуулж бэлтгэл ажлыг хангасан байна.

7.Хууль зүйн яам /хуучин нэрээр/, Ханнс-Зайделийн сантай хамтран Захиргааны ерөнхий хуулиар сургагч багш нарт болон иргэдэд зориулсан сургалтын гарын авлагыг гаргаж төрийн байгууллагууд болон иргэдэд хүргүүлсэн.

Хоёр:Захиргааны ерөнхий хууль 2016 оны 7 дугаар сарын 1-нээс эхлэн хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулаад Хууль зүй дотоод хэргийн яамны бүтцэд захиргааны хэм хэмжээний актын хяналт,

Remove Watermark Now

бүртгэлийн хэлтэс гэсэн шинэ нэгжийг байгуулсан. Энэ нэгж маань Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар бүлгийн хүрээнд дараахь ажлыг хийж хэрэгжүүлсэн.

Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлд “Засгийн газар нь төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын шийдвэр хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх талаар хяналт тавих үүрэгтэй.“ гэж заасны дагуу энэ хяналтыг Хууль зүй дотоод хэргийн яам хэрэгжүүлдэг. Энэ чиглэлийн хүрээнд Захиргааны ерөнхий хуульд захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийг Хууль зүй дотоод хэргийн яам хэрэгжүүлэхээр тусгасан. Хууль батлагдахаас өмнө энэ асуудлыг Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолын хүрээнд тус яам хийдэг байсан бол Захиргааны ерөнхий хууль батлагдан, хэрэгжиж эхэлснээр бид хуулийн дагуу захиргааны хэм хэмжээний актыг хянах, бүртгэх асуудал яригдаж, улмаар хууль зөрчсөн зөрчилд хариуцлага тооцох асуудал гарч ирсэн.

Ажил авахад нийтдээ улсын нэгдсэн санд 960 хэм хэмжээний акт бүртгэлтэй байсан. Засгийн газрын тогтоол хэрэгжиж байх үед сайд, агентлагийг дарга нар, зөвлөл, хороо, Засаг даргын шийдвэрийг л зөвхөн хянадаг байсан бол Захиргааны ерөнхий хууль хэрэгжсэнээр эдгээр дээр нэмээд захиргааны чиг үүргийг хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээд орж ирж байгаа. Тухайлах юм бол хуульчдын холбоо. Энэ байгууллага нь төрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэдэг ийм байгууллага. Мөн хууль тогтоомжийг биелүүлж захирамжлан шийдвэр гаргадаг Засгийн газрын бус агентлаг гэж орж ирж байгаа. Энэ нь Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо гэх мэт 8 байгууллага байдаг. Түүнчлэн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдээс гаргасан хэм хэмжээ тогтоосон шийдвэрүүдийг Хууль зүй, дотоод хэргийн яам хянаж бүртгэх ажил хуулиар орж ирж байгаа. Түүнчлэн Захиргааны ерөнхий хуульд Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, бүх шатны шүүх прокуророос хуульд заасан эрх мэдэл буюу хууль тогтоох эрх зүйн маргаан шийдвэрлэх онцгой бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрээс бусад захиргааны чиг үүрэг шийдвэртэй холбогдуулан эдгээр байгууллагыг захиргааны байгууллагад тооцохоор заасан байгаа.

Улсын нэгдсэн санд бүртгэлтэй байгаа 960 хэм хэмжээний актыг Захиргааны ерөнхий хуульд нийцсэн эсэхийг Хууль зүй, дотоод хэргийн яам нэг бүрчлэн Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагын дагуу хянаад энэ актуудын 487 нь Захиргааны ерөнхий хуульд нийцэхгүй байна гэж үзсэн. Учир нь ач холбогдлоо алдсан, зохицуулж байсан хууль нь хүчингүй болсон, эсхүл шинэчилсэн найруулга нь батлагдснаар эрх олгосон заалтгүй болсон, эсхүл заалтууд нь өөрчлөгдсөн г.м бусад шалтгаанаар нийцэхгүй байна гэсэн дүгнэлтийг холбогдох байгууллагуудад хүргүүлж хуульд нийцүүлэх ажлыг үе шаттайгаар хийж ажилласнаар 120 гаруй шийдвэрийг хүчингүй болгож өөрчилсөн байгаа.

Одоогоор улсын нэгдсэн санд нийт 832 шийдвэр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа. Захиргааны ерөнхий хуулиар шинээр орж ирсэн байгууллагуудын нийтдээ 1000 гаран захиргааны хэм хэмжээний актыг татан авч үзээд энэ нь мөн Захиргааны ерөнхий хууль болон бусад хуульд нийцэхгүй гэсэн шалтгаанаар хамтран ажиллаж хуульд нийцүүлэх ажлын Хууль зүй дотоод хэргийн яам үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Түүнчлэн захиргааны хэм хэмжээний актаа хуульд нийцүүлэхийн тухайд заавал хуулиар тусгайлан эрх олгосон байх ёстой гэсэн хуулийн шаардлага тавьж байгаа. Өнөөдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 482 хууль байгаа. Энэ хуулиудад хичнээн эрх олгосон заалт оруулсан бэ? гэдэг судалгааг гаргасан. Судалгаанаас харахад 206 хуулиар дамжуулан нийтдээ 1476 байгууллагад дүрэм, журам батлах эрхийг олгосон гэсэн судалгаа гарсан. Үүнээс нэгдсэн санд байгаа 832 хэм хэмжээ тогтоосон шийдвэрээ хасах юм бол 644 хууль тогтоогчоос олгосон эрхийг хэрэгжүүлээгүй гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Цаашдаа энэ ажлууд маань үргэлжлээд явахаар байгаа.

Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиудад судалгаа хийж дууссанаар бид дараахь ажлыг төлөвлөж байна.

Нэгдүгээрт нь эрх олгосон заалтын хүрээнд захиргааны хэм хэмжээний актыг холбогдох захиргааны байгууллагаас татаж улсын нэгдсэн санд бүртгүүлсэн эсэх. Хоёрдугаарт нь эрх олгосон актын хүрээнд захиргааны хэм хэмжээний акт батлан гаргаагүй зөрчлийг илрүүлж

Remove Watermark Now

холбогдох байгууллагад хууль хэрэгжүүлэх тухай албан бичиг явуулж хамтран ажиллана гэсэн төлөвлөгөөтэй байна. Мөн захиргааны хэм хэмжээний акт батлагдсан боловч улсын нэгдсэн санд бүртгүүлэхгүйгээр дагаж мөрдөж байгаа зөрчил дутагдлууд нэлээдгүй байгаа. Энэ нь хуульд зааснаар захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд заавал бүртгүүлснээр хүчин төгөлдөр болох ёстой. Үүнийг мөрдөж ажиллахгүй байгаа дутагдлууд нэлээн гарч байгаа.

Одоо тус хэлтэсээс Захиргааны ерөнхий хуулийн 69 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд улсын нэгдсэн санд бүртгэлтэй байгаа актууддаа хяналт шинжилгээ үнэлгээ хийх ажлыг холбогдох захиргааны байгууллагуудтайгаа хамтран хийж байна. Хяналт шинжилгээний дүнг үндэслэн цаашид авах арга хэмжээний талаарх саналаа Засгийн газарт танилцуулахаар ажиллаж байна.

Мөн 2017 онд Захиргааны ерөнхий хуулийн чадваржуулах сургалтыг Ханнс Зайделийн сантай хамтран 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт хийсэн байгаа. Түүнчлэн энэ хуулийг иргэдэд сурталчлах зорилгоор иргэдэд зориулсан гарын авлага гаргаж, Захиргааны ерөнхий хуультай хамт хэвлүүлэн 21 аймаг болон нийслэлийн 9 дүүргийн иргэдэд тараасан байгаа.

Захиргааны ерөнхий хуулийг хэрэгжүүлэхийн төлөө өнгөрсөн жил гарны хугацаанд хамтран ажилласанд баярлалаа.

Мөн Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой засч залруулах хэлэлцэн боловсруулах ажил юу байна энэ талаар өнөөдөр нээлттэй хэлэлцүүлэгийг Ханнс Зайделийн сантай хамтран зохион байгуулж байна. Та бүхнийг идэвхтэй оролцохыг хүсье. Баярлалаа.

**Уулзалт, ярилцлагыг чиглүүлэгчээс**: Захиргааны ерөнхий хуулийн бэлтгэл ажлыг хангах болон хэрэгжилтийн тал дээрх хийсэн ажлын талаар мэдээлэл өгсөн Ариунтуяа даргад баярлалаа.

За дараагийн мэдээллийг Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлснээр шүүх дээр энэ хуулийг хэрхэн хэрэглэж шийдвэрээ гаргаж байгаа талаар “Захиргааны ерөнхий хуулийн хэрэглээ” сэдвийн хүрээнд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Ц.Цогт мэдээлэл хийнэ. Таныг индэрт урьж байна.

pdfelement

**Шүүгч Цогт:** Ер нь бол Захиргааны ерөнхий хуулийг шүүх дээр хэрэглэж тодорхой маргаан шийдвэрлэж байгаа. Тэр статистикээс юуг дүгнэж болох бэ? гэвэл: Бид энэ хуулийг хэрэглэх төлөв байдал захиргааны байгууллага дээр ямар байгаа бэ? Хэрэглэх ёстой асуудал дээрээ хэрэглэж байна уу? Хэрэглээн дундаа алдаа гарч байна уу?, эсхүл Огт ойлгогдохгүй асуудлууд гарч байна уу? Захиргааны байгууллага, иргэн хоёрын хооронд ийм асуудал үүсч байна уу? гэдгийг харж болох юм.

Ханнс Зайдел сангийн хүсэлтээр 2017 оны 1 сараас 07 дугаар сарыг хүртэл хугацаанд нийт захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдээр шийдвэрлэгдсэн хэргүүдэд судалгаа хийх замаар өнөөдрийн танилцуулгыг хийж байна. Эндээс юуг харж болохоор байна гэхээр шүүхүүдэд Захиргааны ерөнхий хуулийг хэрэглэж ямар хэрэг маргаан шийдэж байна. Энэ дотроо аль зүйл заалтыг илүү хэрэглэгдэж байна. Мөн энэ нь яагаад ингэж хэрэглэгдэж байна гэдгийг. Тухайн зохицуулалттай холбоотой захиргааны байгууллагууд шийдвэр гаргахдаа тэр зохицуулалтыг буруу зөрүү хэрэглэснээс маргаан үүсч байна гэж харагдах гээд байна. Захиргааны ерөнхий хуулийн үндсэн хоёр чиглэл байгаа, зохицуулж байгаа хоёр этгээд болон захиргаа, иргэн тэдгээрийн хоорондын харилцааг зохицуулах тэр дотроо захиргааны үйл ажиллагааг стандартад оруулаад ойлгомжтой тодорхой болгоход оршиж энэ судалгаа ч мөн үүнд чиглэсэн байгаа.

Судалгаар shuuh.mn шүүхийн шийдвэрийн цахим санд оруулсан байгаа. Бүх шийдвэрийг татаж судалсан байгаа. Нийтдээ захиргааны хэргийн анхан шатны шүүх 2017 оны эхний хагас жилд 1070 хэрэг шийдвэрлэсэн албан ёсны мэдээ байна. Түүний 920 шийдвэр нь судалгаа хийх үед цахим санд орсон байсан. Энэ 920 шийдвэрийг шүүж үзээд нийслэл дэх захиргааны хэргийг анхан шатны шүүх /хотын захиргаа, хурал, дүүрэг, төрийн захиргааны төв, Засгийн газрын байгууллагууд, бие даасан агентлагууд/-ын шийдвэр үйл ажиллагаа бол харьяаллаараа Нийслэлийн захиргааны хэргийн шүүх шийдэж байгаа. Энэ шүүх 67, орон нутгийн шүүхүүд бол 77

Remove Watermark Now

хэргийг шийдсэн байна. Энэ дотроос 140 хэрэг дээр бол ямар нэг байдлаар шүүхийн шийдвэрт Захиргааны ерөнхий хуулийг хэрэглэсэн байна. 140 шийдвэрт хэрэглэсэн байна гэдэг нь 140 тохиолдолд захиргааны байгууллага ерөнхий хуулийг хэрэглэсэн гэсэн үг бас биш. Яагаад гэвэл шүүх шийдэхдээ "Та энэ тохиолдолд ерөнхий хуулийг хэрэглэх ёстой байсан байна хэрэглээгүй байна" гэж өөрөө шийдвэр гаргахдаа энэ хуулийг хэрэглэх замаар шийдвэр гаргасан тохиолдол байдаг. Энэ хэргүүдийн маргааны төрлөөс аваад үзвэл ер нь сүүлийн үед хүн ажлаас халсан маргаан шийддэг болсон энэ нь эмгэнэлтэй. Цаана нь олон төрлийн эрх зүйн маргаан байгаа. Хамгийн олон ерөнхий хууль хэрэглэж шийдсэн маргаан нь төрийн албаны маргаан байна 77-г шийдвэрлэсэн. Тэгээд газрын маргаан олон хэрэг дээр. Бусад нь сонгууль, ашигт малтмал зэрэг хэргүүд дээр хэрэглэгдсэн байдаг юм байна.

Шүүх Захиргааны ерөнхий хуулийн аль зүйл заалтыг хэрэглэх магадлалтай бэ? гэхээр тодорхойлолт буюу материаллаг зохицуулалт агуулсан Жишээ нь: Захиргааны акт гэж юу болох, ямар акт илт хууль бус болох бэ? гэх мэт зохицуулалтыг зайлшгүй хэрэглэж таарна. Хоёрдугаарт хамгийн гол хэрэглэгдэж байгаа зохицуулалт бол процесс байгаа. Захиргаа шийдвэр гаргахдаа ямар үе шатаар ямар арга замаар иргэнтэй харьцах тэрийг тодорхой хэрэг дээр хуультай харьцуулж үзээд нийцэж байна уу?, эсхүл нийцэхгүй байна уу? гэдэг тийм зохицуулалт. Шүүгээд үзэхээр хэрэглэсэн 140 хэргийн 74% нь шүүх нэхэмжлэлийн шаардлага хангаж шийдвэрлэхдээ ерөнхий хуулийг хэрэглэсэн байна. Тэгэхлээр ямар тохиолдолд шүүх нэхэмжлэлийн шаардлага хангахдаа тухайн хуулийг хэрэглэж байна гэдэг бол захиргааны байгууллага шийдвэр гаргахдаа хуульд заасан зохицуулалтыг дагаагүй, мөрдөөгүй, эсхүл бүрэн дүүрэн ойлгож хэрэглэж чадаагүй байна гэж ойлгохоор байна. Энэ 74% гэхдээ зарим нь нэхэмжлэлийг бүрэн хангасан зарим нь нэхэмжлэлийн зарим хэсгийг хангасан шийдвэрүүд байна. Нарийвчлан шүүх дээр яг ямар зохицуулалт хэрэглэгдээд байна гэвэл захиргаа шийдвэрээ гаргахдаа чи хэрэглээгүй байна гэж үзээд байгаа зохицуулалт байна уу? нэхэмжлэлийн шаардлага хангасан зохицуулалтыг үзвэл "зарчим" байгаа. Төрийн үйл ажиллагааны тусгай зарчим гээд шинэ хуульд нэлээн харийн юмнууд орж ирсэн. Хоёрдугаарт оролцогчийн эрхийн зохицуулалт байна. Захиргааны шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцогчийн эрхийг энэ хуулиар нэлээн тодорхой болгож өгсөн. Тэгэхээр оролцогчийн эрхийг барьж шүүх шийдэж байна гэсэн үг. Үүний цаана юу харагдаж байна гэхлээр захиргаа шийдвэр гаргахдаа тэр тусмаа сөрөг үйлчлэл бүхий шийдвэр гаргахдаа оролцогчийг татан оролцуулах эрхийг нь хангах тал дээр асуудалтай байна гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Нөгөө талаас нь нөхцөл байдлыг урьдчилан тогтоох, сонсох ажиллагаа явуулах гэсэн 2 бүлэг зохицуулалт байгаа. 24, 25, 26, 27 дугаар зүйлийн зохицуулалтууд энэ нэг талаас шинэлэг зохицуулалт.

Ашигт малтмалын тухай хууль бол шийдвэр гаргахаасаа өмнө урьдчилж нөгөө этгээддээ хэлдэг зохицуулалт байсан бусад хуульд байгаагүй.

Сонсох ажиллагаа явуулах зохицуулалт бол шинэ тиймээс манай захиргаа хэрэглэхдээ алдаа оноотой юм байгаа юм шиг байна.

Мөн аливаа шийдвэр гаргахдаа нөхцөл байдлыг урьдчилан тогтоо гэдэг зохицуулалт орж ирсэн. Энэ нь манай практикт хүн ажлаас халчхаад шүүгдэхээр араас нь ажлаас халсан үндэслэл юм аа бүрдүүлдэг. Энэ асуудлын хувьд урьдчилаад тэр үндэслэлүүдийг нь тогтоож байгаад шийдэх ёстой. Үүнтэй холбоотой алдаа гаргадаг алдааг гаргахгүйн тулд ерөнхий хуульд урьдчилаад тогтоо гэсэн заалт оруулж ирсэн. Үүнийг бас шүүх нэлээдгүй барьж хэрэг маргаан шийдвэрлэсэн байна.

Нөгөө нэг бүлэг зүйл бол захиргааны актад тавигдах шаардлага. Бичгээр гарч байгаа захиргааны акт бол дийлэнх хүний эрх рүү чиглэсэн шийдвэр байгаа. Энд тавигдаж байгаа. Агуулгын хувьд нэгдүгээрт та гаргасан шийдвэрээ нөгөө хүндээ мэдэгдсэн байх ёстой. Тэр мэдэгдэх үүрэг танд бий болсон. Мэдэгдсэн эсэх талаар маргаан гарвал захиргаа мэдэгдсэнээ нотолно гэсэн ийм зохицуулалт орсон. Нөгөөх нь бичгээр гаргаж байгаа захиргааны актад энэ шийдвэрийг зөвшөөрөхгүй байгаа тохиолдолд хаана ямар хугацаанд гомдол гаргах тухай акт өөрөө дотроо агуулах ёстой гэсэн агуулгыг шинэ хуульд оруулсан. Энэ нь иргэнд ч, захиргаанд ч амар, цаашлаад шүүхэд маргааныг шийдвэрлэхэд ч дөхөмтэй. Энэ тохиолдолд иргэн би мэдээгүй гэж мэлзэх боломжгүй зохицуулалт болсон. Эдгээрийг шүүх дээр хэрэглэгдсэн байна.

Remove Watermark Now

Нэг маргаантай зүйл бол илт хууль бус захиргааны акт гэж юуг хэлэх юм бэ? гэдэг юм байгаа. Энд агуулгын хувьд маргаан төдийлөн байхгүй. Энэ яагаад маргаан дагуулаад байна гэхээр ерөнхий хуулийг дагаж гарсан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт буюу илт хууль бус болохыг тогтоолгох нэхэмжлэлд хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй гэсэн зохицуулалт орсон. Үүнтэй холбоотой хуульчид, өмгөөлөгчид ашиглаж хугацаа алдсан юмнуудаар шүүхэд маргах ийм механизм нэлээд байгаа. Үүнтэй холбоотой илт хууль бус болохыг тогтоолгох нөхцөл нэлээн хөндөгдөж байгаа.

Мөн гомдол гаргах журамтай холбоотой зохицуулалтууд хэрэглэгдсэн байдаг юм байна. Хамгийн түгээмэл давтамжтай хэрэглэгдэж байгаа шүүх өөрийн шийдвэрийн үндэслэл болгож захиргааг буруутгаж буй тэр заалтууд энэ байна. Зарчмаа барихгүй байна, хууль төгс биш тодорхой бус зохицуулалтууд нэлээн байдаг. Яг тэр маргааныг шүүх шийдэхдээ зарчмаа хардаг захиргааны үйл ажиллагааны зарчимтай нийцээгүй байвал таны шийдвэр үйл ажиллагаа зарчимдаа нийцээгүй байна гэж явдаг.

Сонсох ажиллагааг хийх ёстой, хийх боломжгүй тохиолдлуудаа маш тодорхой захиргаа өөрөө заагаад хуульд заасан үндэслэлүүдийг маш тодорхой дурдаад тодорхойлоод явах ёстой. Ингээд шүүх дээр маргаан гарсан тохиолдолд ийм нөхцөл байдал байсан гэдгээ шүүх дээр нотлоход л болно.

Ерөнхий хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 бодит нөхцөл байдлаа бүрэн дүүрэн судалж байж энэ шийдвэрээ гаргаарай гэсэн үндэслэлээр захиргааны актыг хүчингүй болгож байгаа тохиолдол их байна. Миний саяны ярьдаг бол ерөнхий хуулийн ерөнхий зохицуулалтын талаар байсан. Одоо тодорхой хэдэн маргаан дагуулсан зүйл, заалтуудын талаар ярья.

Нэгдүгээрт сая Энхбаяр сайд ярьсан ерөнхий хуулийн 5.1.1-ийн захиргааны байгууллагыг тодорхойлсон тодорхойлолт дотор Засгийн газар буюу гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх дээд байгууллага орох юм уу? орохгүй юм уу? гэж. Энэ асуудалтай холбоотой маргаан, шүүхийн шийдвэр хүртэл гарсан байгаа. Би хувь хүний байр сууриа илэрхийлж болохгүй байгаа. Дараа нь шүүх дээр ийм асуудал үүсдэг учраас ер нь бол энэ тийм маргаантай асуудал биш. Өөрөөр хэлбэл ямар тохиолдолд Засгийн газрын шийдвэр, үйл ажиллагаа Захиргааны ерөнхий хуулийн хяналт буюу ер нь хуулийн хяналтад байх ёстой юм? ямар тохиолдолд байхгүй юм гэдгийг онолын тайлбар хийх журмаар хийх боломжтой. Тухайлах юм бол Засгийн газар өөрөө бол миний ойлгож байгаагаар 90% захиргааны байгууллагын, магадгүй 10% улс төрийн шийдвэр гаргадаг байгууллага мөн. Тэгэхээр ерөнхий хуулийн өөрийн нь агуулгыг бүрэн ашиглаж чадах юм бол энэ үүсээд байгаа тодорхой тохиолдлыг шийдээд явах боломжтой. Түүнээс биш Засгийн газар ерөөсөө шүүхийн хяналтад байна гэж ойлгож болохгүй. Харин хяналтыг хэрэгжүүлж байгаа этгээд нь шүүх юм. Цаад эрх нь зөрчигдөж байгаа этгээд эрхээ хамгаалуулах хянуулах боломжтой байна уу? гэдэг л асуудал.

Хоёр дахь асуудал ерөнхий хуулийн 47.1.6 бол захиргааны актыг ямар тохиолдолд илт хууль бус гэж тооцох бэ? Үүний нэг үндэслэл байгаа, иргэн хуулийн этгээдийн эрх хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байгаагүй гээд. 47.1.6-ийн зохицуулалт маргаан үүсгээд байгаа. Яагаад маргаан үүсээд байна гэхээр хөөн хэлэлцэх хугацаанаас тойрох хандлага нэлээн байгаа. Хөөн хэлэлцэх хугацаа алдсан дээрээ 47.1.6-г барьж маргадаг. Тэгэхлээр илт хууль бус тооцох энэ зохицуулалт бол уг нь их тодорхой. Илт хууль бус уу? үгүй юу гэдэг дээр маргах аргагүй байх ёстой. Хэрвээ энэ илт хууль бус биш ч юм шиг, мөн ч юм шиг болоод ирвэл энэ илт хууль бус биш байх ёстой. Энэ нь хүчингүй болгох захиргааны актаасаа үр дагавраараа илүү ялгаатай байдаг учраас энэ дээр нэлээн маргаан гардаг.

Мөн Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 1-ийг 47.1.6-тай цуг хэрэглэх ёстой. Захиргааны үйл ажиллагаа хуулиас эх авсан, тодорхой тохиолдол үүссэн үед шийдвэр гаргах ёстой.

Мөн 50.1, 50.2 гэсэн зохицуулалт шинээр орж ирсэн. Энэ нь захиргааны акт гараад үйлчлээд актад гомдол гаргах хугацаа дууссан тохиолдолд захиргааны шийдвэр гаргах ажиллагааг дахин хийх. Үүнтэй холбоотой маргаан бас гарсан байна.

Remove Watermark Now

Төгсгөлд нь хэлэх нэг зүйл бол энэ судалгаан дээрээс харвал ерөнхий хууль бусад хуулиудын өрсөлдөөнтэй байдал, аль хууль нь хэрэглэгдэх бэ? ямар тохиолдолд гэсэн асуудал үүсэж байна. Үүн дээр ерөнхий хуулийн 3.3 зэрэг заалтуудыг харах хэрэгтэй. Шийдвэр гаргах эрх бүхий байгууллага шийдвэр гаргаад гаргасан шийдвэрт гомдол гаргаад гомдол нь хангагдаагүй бол шийдвэр хэрэгждэг байх ёстой. Харин гаргасан шийдвэрээ хэрэгжүүлэх гэхээр яаж хэрэгжүүлэх бэ? гээд асуудал үүсдэг. Үүнийг шийдэхийн тулд захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаа гээд бүхэл бүтэн бүлэг орж ирсэн. Одоо ямар асуудал байна гэхээр захиргааны байгууллагын шийдвэрийг биелүүлэх байгууллага байхгүй байна гэсэн асуудал яригдаж байна. Энэ асуудлыг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар гаргасан захиргааны эсрэг гаргасан шийдвэрийг биелүүлэхтэй хольж болохгүй. Хэм хэмжээний актын талаар маргаан нэлээн байгаа. Хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө 119 дүгээр тогтоолын харьяалалд ордоггүй байсан бие даасан агентлаг, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын шийдвэрийг яах бэ? гэдэгтэй холбоотой маргаанууд нэлээн байна. За миний мэдээлэл энд хүрээд дуусч байна. Амжилт хүсье.

**Уулзалт, ярилцлагыг чиглүүлэгчээс**: Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой хууль хэрэглээний явцад манай захиргааны байгууллагуудаас гаргасан шийдвэртэй холбоотой гарсан маргаан шүүхийн хяналтад орж хянагдах явцад болон шүүх шийдвэрээ гаргахдаа энэ хуулийн хэрэглээний явцад хийгдсэн судалгааны дүнг товчхон байдлаар мэдээлэл өгсөн Ц.Цогт шүүгчдээ баярлалаа.

Өнөөдрийн уулзалт ярилцлагын гол хэсэг рүүгээ бид орж байна. Одоо бүгдээрээ захиргааны ерөнхий хуулийг хэрэглээд явж байхад ямар хүндрэл бэрхшээлтэй асуудлууд гарч байна гэдгийг ярилцах цаг эхэлж байна. Тэгэхээр Захиргааны ерөнхий хуулийн ажлын хэсэгт зөвлөхөөр ажилласан Д.Ганзориг багш, Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, доктор, профессор П.Одгэрэл, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Ц.Цогт, Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн дарга Д.Ариунтуяа нарыг урьд зассан суудлуудад суухыг урьж байна. Эдгээр хүмүүс та бүхний Захиргааны ерөнхий хууль хэрэгжүүлэх явцад гарч байгаа асуудлаа асууж тодруулаад ярилцаад явъя. Мөн захиргааны хэм хэмжээний актын тухайд манай хэлтсийнхэн байгаа тул хариуцсан байгууллагын асуултад хариулт авах боломжтой байгааг бас хэлье.

pdfelement

**Чөлөөт ярилцлагын цаг**.

**Асуулт Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын, Хууль зүйн хэлтсийн дарга Даваажаргал:** За та бүхний энэ өглөөний амгаланг айлтгая. Захиргааны ерөнхий хууль батлагдсантай холбогдуулаад манай дээр нэлээн олон асуудлууд гарч байгаа. Хууль зүй, дотоод хэргийн яам нэлээн сайн ойлгож хамтарч ажилладаг. Бас энэ захиргааны шүүхийн маргааны ихэнх хувийг манай нийслэл дангаараа бүрдүүлж байдаг байгууллага. Ерөнхий хууль гараад нэг хүндрэлтэй асуудал гараад ирсэн нь нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг захиргааны байгууллага гээд томьёолсон. Гэтэл Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-д заасны дагуу нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь өөрийнхөө нутаг дэвсгэрийн хэмжээний нийгэм, эдийн засаг, амьдралын асуудлыг бие даан шийдвэрлэнэ гэж заасан энэ утга агуулга маань алдагдсан. Жишээ нь: Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс Улаанбаатар хот руу орж ирж байгаа шилжилт хөдөлгөөнийг яаралтай зогсоо гэсэн чиглэлийг нийслэлийн Засаг даргад өгсөн. Энэ зөвлөмжийг биелүүлж 2017 оны 1 дүгээр сард А/10/42 гэсэн захирамж гаргасан. Захиргааны ерөнхий хуулийн 70 дугаар зүйлийн тусгай зохицуулалт гэдэг дээр гэнэтийн буюу яаралтай гаргаж байгаа захирамжийг бүртгүүлэхгүй байж болно гэж заасан байна. Үүний дагуу А/10/42 хэмээх захирамж гарган нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдүүлсэн. Үүн дээр ямар нэг маргаан гараагүй цаг үеийн шаардлагаар энэ захирамжийг буюу энэ шилжилт хөдөлгөөнийг хориглохоор шийдвэрлэсэн шийдвэрийг сунгахаар шийдвэрлэсэн. Энэ сунгасан шийдвэрийг өмнө гарсан учир яаралтай гэж үзэхгүй байгаа учир гаргасан шийдвэрээ бүртгүүлэх гээд Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яам татгалзсан хариу өгч байна. Үндэслэл нь хуулиар танайд энэ асуудлыг зохицуулах эрх олгогдоогүй байна гээд байна. Засгийн газраас нийслэлийн Засаг даргад энэ шилжилт хөдөлгөөнийг хоригло гээд даалгачихсан. Манайх Засгийн газрын шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй учраас энэ захирамжийг гаргаад Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж байгаа. Тэгэхлээр та нарт ийм эрх олгогдоогүй байна. Монгол Улсын Үндсэн хуульд монгол улсын иргэн өөрийн оршин суух газраа чөлөөтэй сонгох эрхтэй гэж заасан байдаг.

Remove Watermark Now

Мөн нөгөө талдаа Улаанбаатар хотод амьдарч буй иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийн талаар асуудал үүсч байгаа. Энэ үндсэн дээр нийслэлийн Засаг дарга арга хэмжээ аваад асуудлуудаа шийдээд явах гэхээр Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр очоод гацна. Ер нь бол 1992 оноос 2017 оныг хүртэл захиргааны хэм хэмжээний акт нийтдээ 96-г хурлаас баталсан. Энэ 96 шийдвэрээс 2 шийдвэрийг л хуулиар эрх олгогдсон гэдгээр бүртгэсэн байдаг. Энэ 2 бүртгэгдсэн шийдвэр нь Захиргааны ерөнхий хууль батлагдсаны дараа хууль дээр заасан үндэслэлээр гаргасан шийдвэр байгаа. Шийдвэрүүдийг бүртгүүл гэдэг шаардлага Засгийн газрын тогтоолоор бидэнд ирсэн. Гэтэл Захиргааны ерөнхий хуульд өөрт нь л тусгаагүй бол бид нар буцааж хэрэглэнэ гэж ойлгохгүй байгаа. Биднийг бол буцааж хэрэглэ гэсэн шаардлага тавьж байгаа. 2016 оны 7 дугаар сараас өмнө гарсан тогтоолуудыг бүгдийг нь бүртгүүл гэсэн шаардлага тавьсан. Энэ асуудалд эрх зүйн хувьд бэлэн биш байсан. Ямар ч хууль тогтоомжууд дээр иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг хуулиар тусгайлан эрх олгогдоогүй байсан. Амьдрал баян учраас иргэдтэй холбоотой маш яаралтай шийдвэрүүд гаргах шаардлагатай болдог. Жишээ нь: дугаарын хязгаарлалт, нэгдүгээр эгнээгээр зорчих энэ болгон дээр хурлаасаа шийдвэр гаргаад засаг даргын захирамжаар дамжуулаад хэрэгжүүлээд явдаг байсан. Одоо замын цагдаа зам дээр хүн зогсоогоод торгох боломжгүй болсон. Энэ асуудлуудыг эргэж харах шаардлага байна гэж харж байна.

**Хариулт Ганзориг**: 2015 онд энэ хуулийг батлаад 2016 оноос энэ хууль мөрдөгдөөд иржээ. Захиргааны эрх зүйн энэ харилцааг одоо эндээс эхэлсэн гэж харж болохгүй. Урьд нь энэ харилцаа явж л байсан. Үүнийг хуульчилж системтэй болгож гаргаж ирсэн ийм л зүйл.

Захиргааны байгууллага гэдэг нэр томьёо хэзээнээс ингэж тогтож ирэв ээ гэхээр 2002 оны Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд анх удаа захиргааны байгууллага гэсэн нэр томьёо орсон. Нэр томьёон дотор саяны асуугаад байгаа нутгийн өөрөө удирдах байгууллага орсон явж байсан. Тиймээс одооноос л нутгийн өөрөө удирдах байгууллага болгочихлоо. Урьд нь ийм байгаагүй гэдэг дүгнэлт өөрөө их асуудалтай байна. Ерөнхий зарчмуудыг урьдаас нь авсан шүү гэдгийг анхаарах хэрэгтэй.

pdfelement

Үндсэн хуулийн хэрэглээний асуудлын хувьд тэр дундаа Үндсэн хуулийн 62.2-т нутгийн өөрөө удирдах байгууллага төрийн эрх бүхий байгууллага тухайлж заагаагүй асуудлаар өөрөө Үндсэн хуульд нийцүүлэн бие даасан шийдвэр гаргаж болно гэсэн ийм зарчим байна. Хэм хэмжээний актыг бүртгүүлэх бүртгүүлээд хүчин төгөлдөр болгохтой холбоотой асуудал, хуулиар тусгайлан эрх олгосон гэдгийг юу гэж үзэж тайлбарлаж явж байгаа гэдэг асуудал байна. Хууль тогтоомжид нийцсэн эсэхийг хянадаг байгууллага нь Хууль зүй, дотоод хэргийн яам мөн. Энэ үүднээсээ хуульд нийцэж байгаа эсэх асуудлыг хянана. Буцаан хэрэглэх асуудлыг яг юутай холбож юу асуусныг нь ойлгосонгүй. Гэхдээ 2000 оноос хойш хийхээ байсан нэг арга хэмжээ байгаа. Энэ нь ямар ч хууль гарсан дагаад Их Хурлын тогтоол гардаг байсан. Тэр нь хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тогтоол гээд энэ тогтоолоороо Засгийн газарт үүрэг өгдөг. Засгийн газар дахиад доошоо үүрэг өгдөг ийм ажиллагаа байсан. Өөрөөр хэлбэл буцааж хэрэглэх гэхээс илүү өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа хэм хэмжээний актуудыг одоо байгаа хуульдаа нийцүүлэх арга хэмжээ авах. Үүнээс биш буцаагаад байгаа явдал биш, нийцүүлж байгаа ажил юм.

**Асуулт Зам тээврийн яамны хуулийн хэлтсийн дарга Бат-Эрдэнэ:** Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хэм хэмжээний актуудаа хуульд нийцүүлээд ирүүл гээд байгаа. Энэ нь өмнө нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан эрх зүйн актуудаа ахиж сонсох, санал авах зэрэг эрх зүйн актыг дахин шинэчлэн боловсруулах ажил болж байна. Үүнийг асууж байгаа юм. Энэ нь хуулийг буцааж хэрэглээд дахин баталж гаргаж байгаа явдал болоод асуудал үүсгээд байна. Яам үүн дээр буруу шаардлага тавиад байна. Тиймээс үүнийг болих хэрэгтэй. Хууль хэрэгжиж эхэлснээс хойших актуудыг энэ хуульд нийцүүлэн гаргах ёстой. Жишээ нь: Иргэний нисэхийн тухай хууль дээр иргэний нисэхийн бас дүрмийг төрийн захиргааны төв байгууллага батална гэж заагаад энэ дүрмээр дараах үйл ажиллагааг зохицуулна гээд 15 үйл ажиллагааг жагсаасан байна. Гэтэл дараах үйл ажиллагааг зохицуулна гэдгээ тус тусад нь дүрэм болгоод 60 гаран дүрэм болгоод улсын бүртгэлд өгсөн. Үүнийг өмнө нь Хууль зүй, дотоод хэргийн яам бүртгээд яваад байсан. Одоо Захиргааны ерөнхий хууль хэрэгжээд энэ шаардлагыг салбартаа тавихаар Хууль зүй, дотоод хэргийн яамтай яриад болчихно гээд байгаа энэ мэт асуудлуудыг хүлээж авахгүй байх хэрэгтэй.

Remove Watermark Now

Хоёр дахь асуудал шүүхтэй холбоотой иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хоорондын зааг ялгаа замбараагүй байна. Жишээ нь ажлаас халагдсан хүн иргэний хэрэг дээр гурван шатны шүүхээр яваад хэрэгсэхгүй болж байхад нэхэмжлэлийн шаардлага ижил захиргааны хэргийн шүүх дээр очиход захиргааны хэргийн шүүгч хэрэг үүсгэж байгааг анхаарах.

Мөн гурав дахь асуудал Захиргааны ерөнхий хуультай холбоотой хэд хэдэн асуудал байна. Захиргааны ерөнхий хуулийн 105.2-т томилсон болон дээд шатны албан тушаалтан энэ хуулийн 105.2-т заасан дараахь сахилгын шийтгэлийн аль нэгийг оногдуулна гэж байгаа. Энд хоёр субъект байна. Нэг нь томилсон, нөгөөх нь дээд шатны байгууллага, албан тушаалтан байж болохоор байна. Үүнтэй холбоотой асуудлыг зохицуулж нэг мөр болгох шаардлагатай байна.

Мөн шийтгэлийг хуульд өөр өөрөөр оруулж ирэх бус нэг стандарттай байлгамаар байна. Үүнийг анхаарах хэрэгтэй. Хуулийн 12 дугаар зүйлийн 1-д захиргааны шийдвэр гаргах ажиллагаа гэж гээд тодорхойлолтод захиргааны хэм хэмжээний акт байхгүй, захиргааны гэрээ, захиргааны акт 2 байгаа нь ойлгомжгүй байна. Захиргааны шийдвэр гаргах ажиллагаа гэдэгт энэ гурав гурвуулаа багтах юм биш үү? Мөн захиргааны хэм хэмжээний акт гэдгийг томьёолохдоо “шийдвэр”-ийг ойлгоно гэж заасан байгаа. 12.2-т зааснаар 11.1.3-т заасан шийдвэр гаргах ажиллагааг энэ хуулийн зургадугаар бүлэгт заасны дагуу зохицуулна гэж байгаа. Эдгээр нь хоорондоо логикгүй уялдаагүй байна гэж харагдаж байна.

Дараа нь мөн хуулийн 60.1.3-т тэмдэглэх хэсэгт үндэслэл болгож байгаа хуулийн заалтыг заасан байх. Тэмдэглэх хэсэг гэж юуг хэлээд байгаа юм бэ? уул нь энэ нь үндэслэл болгох хэсгийг хэлээд байгаа байхгүй юу. Үндэслэх хэсэгт хуулийн тусгайлан эрх олгосон хуулийн зүйл заалтыг оруулсан байх гээд найруулбал ойлгомжтой байна. Албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврыг шинэчлэх хэрэгтэй. Албан бичгэн дээр сайд гэсэн гарын үсэг зурдаг. Зарим нь сайд гээд гарын үсэг зурдаг. Зарим нь шууд нэрээ бичдэг. Уул нь Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу захиргааны акт тодорхой байх ёстой. Хэнээс гаргаж хэнд хандаж байгаа нь тодорхой байх шаардлагатай үүний анхаарах хэрэгтэй.

pdfelement

Дараахь нь 63 дугаар зүйлд санал авахгүй байх гээд байгаа. Энд санал авахыг шаардахгүй гэж заасан нь хэн шаардахгүй юм бэ? гэдэг нь мөн тодорхойгүй байна. Тиймээс үүнийг санал авах ажиллагааг хийхгүй байж болно гэж өөрчлөх хэрэгтэй.

Мөн захиргааны акт гэдэг томьёоллоо харах хэрэгтэй. Захиргааны акт гэж гадагшаа чиглэсэн гээд байх юм. Яагаад дотогшоо чиглэсэн холимог шинжтэй байж болохгүй гэж би бодож байна. Үндсэн хуульд зааснаар төр, иргэн, хуулийн этгээд эрх тэгш байхаар заасан манай хуулиудад төрийн байгууллагын давуу эрхүүдийг л хуульчлаад байдаг. Төрийн байгууллага үүргээ биелүүлээгүй бол ямар ч хариуцлага байхгүй. Иргэн, аж ахуй нэгжид бол баахан хариуцлага тооцно. Үүнтэй холбоотойгоор Засгийн газрын үйл ажиллагаа захиргааны шүүхийн хяналтаас гадуур байж болохгүй байх гэж бодож байна.

**Хариулт П.Одгэрэл**: Түрүүний ярьсан 96 хэм хэмжээний акт бүртгүүлэх гэсэн 2-ийг нь л бүртгэсэн тухай ярьсан. Энэ үнэхээр асуудалтай байна. Энэ асуудлыг л шийдэх ёстой. Үндсэн хуулийн 62 дугаар зүйл Захиргааны ерөнхий хуулийн энэ заалтад үйлчилдэггүй. Энэ яах аргагүй хийдэлтэй хэсэг одоо тэгэхээр Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийг яаж хэрэглэх үү? Үүний хүрээнд ямар дүрэм, журмууд гарах уу? Энд үнэхээр зохицуулалт хэрэгтэй үүний яах бэ? гэдэг гаргалгаа хэрэгтэй.

Хуульд нийцүүлэх гэдэг дээр Хууль зүй, дотоод хэргийн яам арай уян хатан хандах хэрэгтэй байхаа. Дахиад сонсгол хийгээд дахин шийдвэр гаргах үйл ажиллагаа явуулаад дахин цоо шинэ ажиллагаа хий гэдэг шаардлага тавьж байна гэдэг бол арай хатуу. Хүчингүй болсон бол яах вэ, амьдрал баян өөр асуудлууд ч байгаа юм билүү. Хууль зүйн яамтай яриад заавал хүчингүй болгоод шинээр ажиллагаа хийх шаардлага байна уу? нийцүүлээд шинэ өөрчлөлт оруулаад явах боломж байна уу? гээд хэрэгжилттэй холбоотой асуудлууд байгаа.

**Асуулт Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын мэргэжилтэн Нарангарав:** Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31.1-ийг юу гэж ойлгох бэ? “Хурал засаг даргаас хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд заасан

Remove Watermark Now

шийдвэр тухайн нутаг дэвсгэр дээр хүчин төгөлдөр дагаж мөрдөх бөгөөд түүнийг холбогдох байгууллага албан тушаалтан иргэн заавал биелүүлнэ." гэж заасан. Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийг бариад асуудлуудаа шийдэх гэхээр Хууль зүй, дотоод хэргийн яам танайд ийм шийдвэр гаргах эрх байхгүй байна гээд байгаа. Энэ асуудлыг шийдээд өгөөч ээ гэж хүсэж байна.

**Хариулт П.Одгэрэл:** Үндсэн хуульд зааснаар иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд ийм эрх олгосон байгаа. Ерөнхий хуулиар бол хуулиар тусгайлан эрх олгосон бол батлах энэ бүлэг чинь 800 гаруй дүрэм журмыг бүртгээд нэгтгээд нэгдсэн стандартад оруулаад бусад хууль хоорондын зөрчлийг арилгаад хэрэглэх эрх нь нээгдээд явдаг ийм зохицуулалт. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрүүд ийм нэгдсэн зохицуулалтад орох уу? гэдэг асуудал байна. Хэрвээ ерөнхий хуульдаа оруулахгүй гэвэл бас нэг цэгцтэй болгох хэрэгтэй. Бас хамаагүй замбараагүй ингээд яваад байж болохгүй тэгэхлээр шинэ зохицуулалт хийх юм уу? эсвэл энэ зохицуулалт дээрээ нэмэлт зохицуулалт хийх юм уу? гэдэгт асуудал байна.

**Хариулт Ц.Цогт:** Шинэ хуулиар орж ирсэн зарим заалтууд хууль тогтоох эрх хэмжээг захиргаанд шилжүүлэхтэй холбоотой нэлээн нарийвчилсан зохицуулалт хийж өгч байгаа. Өөрөөр хэлбэл хууль тогтоох эрх мэдэл Их хуралд бий тусгайлсан асуудлаар захиргааны байгууллагад хэм хэмжээ тогтоох эрхээ шилжүүлж байгаа тохиолдолд тодорхой ойлгомжтой байх ёстой гэсэн шаардлага тавьж байгаа. Иймээс ерөнхий зохицуулалтыг шинэчилж нарийвчлан зааж өгч ерөнхий зохицуулалтыг байхгүй болгох тал руу явах хэрэгтэй.

Үндсэн хуулийн 62 дугаар зүйл өөртөө 2 том нөхцөлтэй. Нэгдүгээрт энэ асуудлаар хуулиар төрийн өөр бусад аль нэг байгууллагад эрх олгогдоогүй байх. Хоёрдугаарт төрийн аль нэг дээд шатны байгууллагад эрх олгогдоогүй байх гэсэн маш тодорхой заалт байгаа. Өөр бусад хуульд тухайн асуудлыг зохицуулсан зохицуулалт байгаа эсэхийг маш сайн шалгах хэрэгтэй. Үнэхээр тийм ямар ч зохицуулалт байхгүй бол хотын асуудлыг зохицуулсан нэг ч зохицуулалт байхгүй биш шүү дээ. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Байгаль орчны хуулиудад заасан, мөн онцгой байдал үүссэн үед авах арга хэмжээ гэх мэт өөр зохицуулалтууд байгаа. Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн энэ зохицуулалт маш цөөхөн тохиолдолд гардаг.

**Хариулт Ганзориг:** МУ-д 500 гаруй хууль байна. Одоогийн байдлаар 500 гаруй хуульд хуралд, эсвэл аль нэг байгууллагад ямар нэг байдлаар тухайн асуудлыг шийдвэрлэх эрх хэмжээ байхгүй тохиолдол үүсвэл 62.2-руу орно. Эсхүл бусад байгууллагад эрх өгөөгүй бол 62.2-г хэрэглэнэ. Ерөнхий зарчим болж өгөхгүй байгаа, логик болж өгөхгүй байгаа ийм юм байвал асуудал байна.

**Хариулт Цогт**: Тэр дээд шатны байгууллага уу? томилдог этгээд үү? гэдэг дээр  Дээд шатны байгууллага гэдэг бол тухайн албан тушаалтны шийдвэрийг хүчингүй болгодог, мэргэжлийн удирдлагаар хангадаг, гаргасан шийдвэрийг хянах хүчингүй болгох эрх хуулиар олгогдсон этгээд дээд шатны байгууллага, зарим томилдог тохиолдолд сахилгын арга хэмжээг хэн авах бэ? гэдэг асуудал гарч ирдэг.

**Хариулт Ариунтуяа**: Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн талаар шүүгч болон багш нар тодорхой тайлбар хийлээ. Нэмж хэлэхэд 62.2-ийг барьж байна гэдэг хууль зөрчсөн үйлдэл болохгүй. Шилжилт хөдөлгөөний хувьд өмнө баталсан захирамжийг бүртгүүлээгүй зөвхөн нэмэлт, өөрчлөлтийг иргүүлсэн. Тэгэхээр бидний зүгээс тушаалын эхний хувь байхгүй нэмэлт, өөрчлөлтийг бүртгэхгүй гэсэн хариу өгсөн. Бат-Эрдэнэ даргын хувьд ярьсан багц дүрэм нь 2 хууль дээр байгаа. Энэ нь өмнө нь маш замбараагүй бүртгэгдээд явж байсан юм байна лээ. Үүнийг цэгцлэх ажлыг хийгээд явж байгаа.

**Асуулт Даваажав**: Хурлаас 96 тогтоол гарсан уг тогтоолуудыг үндэслээд Засаг даргын захирамж гаргаж байгаа. Энэ ажлын хэрэгжилт ер нь зогсонги байдалд орох гээд байна. Бид юу гэж ойлгож байна гэхээр 1992 оноос 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэл гаргасан тогтоолуудаа эрүүлэн хянаж үзээд энэ нь хууль зөрчсөн байх юм бол хуульд нийцүүлэх арга хэмжээ аваад бүртгүүлэх, хууль зөрчөөгүй байх юм бол тэдгээрийг бүртгүүлэхгүйгээр дагаж мөрдөөд явъя ингэж ойлгож болох уу?

**Хариулт Цогт:** Ер нь бол хүчин төгөлдөр мөрдүүлье гэвэл бүртгүүл.  Гэхдээ тэр дотроо уян хатан гээд байгаа.  Дахин ажиллагаа хийх нэг байна, мөн хийхгүй бас байж магадгүй гээд байна.

Ерөнхий хууль гараад ерөнхий хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа тохиолдолд хэм хэмжээний акт мөрдүүлэх гэж байгаа л бол бүртгүүлэх л ёстой. Гагцхүү ҮХ-ийн 62-с бусад тохиолдолд шүү. Өнөөдөр яригдаж байгаа асуудал бол урьдчилсан хяналт. Хууль зүй, дотоод хэргийн яам хэм хэмжээний актад урьдчилсан хяналт тавьж байгаа асуудал юм. Харин батлагдаад гараад тэр хэм хэмжээний актын улмаас эрх нь зөрчигдөж байгаа этгээд хянуулахаар шүүхэд хандах эрх нь нээлттэй. Энэ бол дараагийн хяналт, агуулгын хяналт.

**Хариулт Д.Алтантуяа:** Даваажаргал даргын ярьж байгаа шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлаар хориглосон хэм хэмжээ тогтоосон шийдвэр Батболд дарга гаргасан байна. Энэ шийдвэрийг гаргахдаа яаж гаргах бэ гэвэл Засгийн газрын тогтоолоор процессыг маш тодорхой зааж өгсөн байна. Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлсэн, Засгийн газрын тогтоол өөрөө юуг үндэслэж гарсан бэ? гэхээр Шилжилт хөдөлгөөний тухай хуульд “Засгийн газар шилжилт хөдөлгөөний журам гаргаж болно” гэж заасны дагуу гаргасан. Энэ Засгийн газрын тогтоол өөрөө хуульд нийцсэн байх ёстой. Гэтэл Засгийн газрын тогтоолоор хориглосон акт гаргах үүрэг өгсөн. Үүнийг яамнаас Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 18-ийг бариад үзэхээр шилжилт хөдөлгөөнийг зөвхөн хуулиар хориглож болохоор заасан тул Засгийн газрын тогтоол өөрөө хууль зөрчиж гарсан. Энэ асуудлаар ажлын хэсгийн хүмүүсийн саналыг сонсох хэрэгтэй. Үндсэн хуулийн заалт маш тодорхой оршин суух эрхийг тийм тийм тохиолдолд зөвхөн хуулиар хязгаарлаж болно гэж заасан. Иймээс нийслэлийнхэн Засгийн газартай хамтраад хуульд өөрчлөлт оруулах хэрэгтэй. Утаа зөвхөн энэ жил яригдаж буй асуудал биш.

**Хариулт Цогт**: Хэм хэмжээ тогтоосон актыг батлах эрхийг хуульд нэг этгээдэд өгсөн байвал тэр этгээд өөр этгээдэд шилжүүлэн өгч болохгүй хориотой. Өнөөдрийн энэ асуудлын хүрээнд нийслэлээс дээд шатны байгууллагадаа танай тогтоолыг хэрэгжүүлээд бүртгүүлэх гэсэн бүртгэхгүй байна. Иймээс хэрэгжүүлэх боломжгүй байна гэсэн асуудлыг дээд шатны захиргаандаа тавиад шийдвэрлүүлэх ёстой. Зарим тохиолдолд Засгийн газрын шийдвэр үнэхээр хуульд нийцэхгүй байна гэвэл Хууль зүй, дотоод хэргийн яам Засгийн газарт өөрт нь хандах зохицуулалт мөн байгаа.

**Асуулт НИТХ-ын Хуулийн хэлтсийн дарга Мөнх-Оргил:** Засгийн газрын тогтоол Хууль зүй, дотоод хэргийн яамаар хянагдаж байгаа. Энэ тогтоолын төслүүдийг хуульд нийцэж байгаа эсэхийг яагаад хянадаггүй юм бэ? 100 гаран журам байна. Нийслэлийн харилцааг зохицуулсан. Өнгөрсөн онд нэг журам л батлуулсан үүнтэй холбоотой нэлээдгүй асуудлууд үүсээд байна. Яаж зохицуулах бэ?

**Хариулт Алтантуяа:** Уг хэм хэмжээний актуудаа хуульд нийцүүлээд аваад ирвэл бид бүртгэхэд асуудал байхгүй.

**Уулзалт, ярилцлагыг чиглүүлэгч:** Цайны завсарлага 15 минут.

**Уулзалт, ярилцлагыг чиглүүлэгч:** Чөлөөт ярилцлага үргэжилж байна. Асуулт байна уу?

**Асуулт Уул уурхайн яам хуулийн хэлтсийн мэргэжилтэн Мөнхбаяр:** Сайн байцгаана уу? асууж тодруулах зүйл байна. Захиргааны гэрээ гэж ямар гэрээг ойлгох бэ? Жишээ нь: газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ захиргааны гэрээ мөн үү? Гараад байгаа хүндрэл нь энэ гэрээг байгуулсан 20 гаран компани байгаа. Энэ гэрээтэй холбоотой маргаан гарахаар бүгд өөр өөрсдийнхөөрөө тайлбарладаг. Иргэний гэрээ, захиргааны гэрээ гээд аль өөрсөндөө ашигтайгаар тайлбарлаж маргаан үүсгэдэг. Үүнийг яаж зохицуулах бэ? Тайлбарлаж өгнө үү.

**Хариулт П.Одгэрэл:** Захиргааны гэрээ гэж нийтийн эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагддаг гэрээ гэж хуулиараа хэлсэн байгаа. Гэрээний талууд болох Газрын тосны хэрэг эрхлэх газар Газрын тосны тухай хууль дээр заасан төрийн чиг үүрэг, эрх үүргүүдийн хүрээнд гэрээ хийсэн бол энэ захиргааны гэрээ. Хуучин бол иргэний эрх зүйн гэрээ гэж явж байсан. Жилийн өмнөөс л захиргааны гэрээ гэдэг ойлголт орж ирсэн. Иймээс хуучин гэрээнүүдээ өөрчлөлт оруулах хэрэгтэй. Жишээ нь: Газар эзэмших гэрээ гээд байна. Энэ гэрээний нэг талд газрын алба нөгөө талаас иргэн байдаг. Энэ гэрээгээр дамжуулан тухайн эзэмшил газрын асуудлыг шийдэж болохоор байх ёстой.



Remove Watermark Now

Remove Watermark Now

**Асуулт Мөнхбаяр:** Бүтээгдэхүүн хуваах гэрээний загварыг Засгийн газрын тогтоол гараад загварыг нь гаргасан байдаг. Ийм ийм юм байна. Гэрээ байгуулагч талуудын үндсэн нөхцөлийг л өөрчилнө гээд заасан байдаг. Тиймээс бид тэр гэрээнд өөрийн агентлагийнхаа эрх, үүргийг оруулах боломжгүй болж байна. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээг энэ захиргааны гэрээ, эсвэл иргэний гэрээ гээд нэг тийш нь болгож баталгаажуулсан тайлбар гаргаж болохгүй юу?

**Хариулт Цогт:** Ямар гэрээг захиргааны гэрээ гэж үзэх бэ? гэхээр энэ гэрээний үр дүнд тухайн гэрээний нэг тал болсон захиргааны байгууллагын хуулиар хүлээсэн нийтийн удирдлагын чиг үүрэг тодорхой байдлаар хэрэгждэг, хэрэгжүүлэхийн төлөө гэрээний нэг тал болж оролцож байгаа бол тэр гэрээ захиргааны гэрээ. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ гэдэг бол нэг талд нийтийн өмчийг харьялж байгаа салбарын гэрээ. Энэ гэрээг иргэний гэрээ болно гэдэгт эргэлзэж байна. Харин энэ гэрээ иргэний гэрээ боллоо гэхэд нэг талдаа ашигтай байна гэсэн ойлголт байхгүй. Тэр тусмаа захиргааны байгууллага давуу эрхтэй заавал оруулах эрх ашгийг нь хуульд заагаад өгсөн байдаг. Тэдгээрийг л гэрээндээ сайн оруулж өгөх хэрэгтэй.

**Хариулт Одгэрэл:** Захиргааны гэрээний нэг давуу тал нь захиргаа давуу эрхтэй оролцдог. Гэрээнд заасан үүргээ шүүхээр биш захиргаа өөрөө албадлага хэрэглээд гэрээний гүйцэтгэлээ хангадаг. Иргэний гэрээнд гэрээний гүйцэтгэлтэй маргаан гарсан тохиолдолд заавал шүүхээр ордог. Захиргааны гэрээ гэрээний гүйцэтгэл, хяналт шалгалт хийхтэй холбоотой асуудлаар өөрсдөө албадлага хэрэглээд явдаг. Мөн цуцлахад давуу тал байдаг. Хэрвээ нийтийн ашиг сонирхолд хохирол учрахаар бол захиргаа өөрийн санаачлагаараа гэрээг цуцлах боломжтой.

**Асуулт Даваажаргал**: Захиргааны гэрээ гэдгийг манайх ингэж ойлгож байгаа. Захиргааны байгууллагаас эрх зүйн харилцааг өөрчлөх, эхлүүлэх, дуусгавар болж байгаа ийм гэрээг байгуулж болно гэсэн байгаа. Үүнийг би боломж олгосон заалт гэж харьж байгаа. Тиймээс заавал захиргааны гэрээ гэхгүй хоёр тал харилцан тохироод яваад байгаа энэ нь зөв үү? заавал бүх гэрээгээ захиргааны гэрээ гэж хийх ёстой юу?

**Хариулт Ц.Цогт**: Зарчмын хувьд захиргаа төлөөлж гэрээ байгуулж гэрээгээр зохицуулагдаж байгаа зүйл чинь төрийн захиргааг төлөөлж хэрэгжүүлж байгаа л бол захиргааны гэрээ болно. Хэлбэрийг яаж хийсэн нь хамаагүй. Харин иргэний гэрээ бол өөр. Зохицуулалтаасаа хамаарч байгаа асуудал. Гэрээг сонгох гэдэг бол энэ гэрээг захиргааны гэрээ болгох уу? иргэний гэрээ болгох уу? гэсэн сонголт биш. Харин тухайн асуудлыг гэрээгээр шийдэх үү? үгүй юу гэдэг сонгох эрх юм.

pdfelement

**Хариулт П.Одгэрэл**: Газрын хууль дээр жишээ авъя. Газар эзэмших гэрээ нь энэ гээд хуульд тодорхой заасан байдаг. Тэгэхлээр гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулж чаддаггүй. Гэрээний нөхцөлийг хуульд заасан байдаг болохоор, үүнийг уян хатан болгох хэрэгтэй, хуульд өөрчлөлт оруулах хэрэгтэй.

**Хариулт Д.Ганзориг:** Гэрээнд тавигдах нийтлэг шаардлага байгаа. Гэрээ ямар шаардлага агуулах ёстой бэ? Түрүүний багш нарын хэлсэнтэй санал нийцэхгүй юм байна. Гэрээнд захиргаа давуу эрхтэй оролцоно гээд байна. Гэрээ өөрөө чөлөөтэй эрх тэгш, хоёр тал ижил үүрэг хүлээсэн, ийм байж гэрээний шаардлага хангагдах ёстой.

**Асуулт Бат-Эрдэнэ:** Гэрээг захиргааны гэрээ гэх үү? Иргэний гэрээ гэж үзэх үү гэдэг асуудал чухал байна. Жишээ нь: хөдөлмөрийн гэрээг юу гэж үзэх бэ? Миний хувьд захиргааны гэрээ гэж үзэхээр байна. Захиргааны гэрээ гэсэн тодорхойлолтод хөдөлмөрийн харилцаа гэж байхгүй байна. Тэгэхлээр ийм санал байна. Хөдөлмөрийн гэрээг нь иргэний хуулиараа, харин тушаалыг нь захиргаагаар хэлэлцэх. Мөн хөдөлмөрийн гэрээ байгуулах нь анхдагч юм уу? тушаал гаргах нь анхдагч юм уу? энэ ойлгомжгүй байна.

**Хариулт Цогт:** Захиргааны гэрээнд захиргаа давуу эрхтэй гэдэг нь байгуулахдаа давуу эрхтэй гэсэн санаа биш тухайн гэрээг байгуулахад захиргааны байгууллагыг хуульчилсан байдаг. Тиймээс тэр хуульчилсан эрх үүргийг заавал гэрээндээ оруулах ёстой гэдгээрээ давуу гэсэн санаа. Хөдөлмөрийн гэрээ бол захиргааны гэрээ биш. Ер нь бол манайхтай адил эрх зүйн тогтолцоотой улс орнууд хөдөлмөрийн эрх зүйн харилцааг захиргааны эрх зүйд оруулж судалдаг.

Remove Watermark Now

**Асуулт Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны хуулийн хэлтсийн мэргэжилтэн Жавжанжаргал:** Санал байна. Төр захиргааны байгууллагууд ерөнхий хуульд заасны дагуу Засгийн газрын худалдан авалтын үр дүнд захиалагч нарт олгосон гэрээг захиргааны гэрээний шинжийг шууд утгаараа агуулж байгаа гэж ойлгож байгаа. Өөрөөр хэлбэл нэг талаас захиргааны байгууллага өөрөө шууд захиалагч талаас орж захиалагч гүйцэтгэгч болж барилга барьж, худалдан авалт хийх гэж байгаа нь иргэний эрх зүйн харилцаа боловч захиргааны эрх бүхий албан тушаалтнаас гэрээ байгуулах эрх олгосон шийдвэр байгаа энэ шийдвэр өөрөө энэ гэрээний салшгүй хэсэг болж явдаг. Тэр утгаараа дагалдах бусад бичиг баримт нь захиргааны гэрээний шинжийг бас агуулаад байдаг гэж ойлгож байгаа.

Захиргааны ерөнхий хууль гарснаар захиргааны байгууллагууд замбараагүй шийдвэр гаргадаг байсныг бас хумьсан олон ололттой хууль гэж харж байгаа.

Манайд нийтээр дагаж мөрдөх 50 актын жагсаалт ирсэн мониторинг хийж хүргүүлсэн. Он гарсан дахиад жагсаалт ирсэн 50 акт маань 53 болж ирсэн. 1991-2010 он хүртэл одоогоор хүчинтэй байгаа гэсэн актуудын жагсаалт ирсэн байгаа ийм далайцтай ажлуудыг өмнө нь хийж ирсэн байна. Эндээс харвал захиргааны актыг захиргааны акт гэж маш тодорхой тодорхойлсон 37 дугаар зүйлийн 37.1-д. Мөн 59 дүгээр зүйлд хэм хэмжээний актыг тодорхойлсон захиргааны хэм хэмжээний акт гэж 59.1-ийн дагуу хуулиар тусгайлан эрх олгосон дүрэм, журам болгоныг бүртгүүлэх үү? гэдэг асуудал байна. Захиргааны акт болон захиргааны хэм хэмжээний актын тодорхойлолтыг хооронд хольсон шинжтэй оруулсан байна. Мөн “эрдэм шинжилгээний ажилтныг аттестатчилах журам”-ыг сайдын тушаалаар 2007 оноос эхлэн хэрэгжүүлсэн энэ журмыг бүртгүүлсэн бүртгэлтэй. Энэ журам ерөнхий хуульд зааснаар бол 37.7 дугаар зүйл гэж ойлгож байна. Нэг талаас тодорхойлсон тухайлсан хэд хэдэн этгээдүүдэд чиглэсэн нөгөө талаас тухайн байгууллагын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, хүний нөөцийг бэхжүүлэхтэй холбоотой асуудал болсон. Иймд хэм хэмжээний актын шинжийг бүрэн агуулж чадахгүй байна гэж үзэхээр байна. Энэ журмыг бүртгүүлэх үү? яах бэ? гэдэг асуудал байна.

**Хариулт П.Одгэрэл**: Хэм хэмжээний акттай холбоотойгоор 37.7 буюу захиргааны актын энэ зохицуулалтыг харах хэрэгтэй байгаа. Саяны тохиолдолд аттестатчилах журмыг батлах эрх хуулиар олгосон бол хэм хэмжээний акт мөн. Харин хуулиар эрх олгоогүй бол 37.7-д хамаарна. Ерөнхий хуулийн 37.7-г яагаад оруулсан бэ? гэхээр хуульд хэм хэмжээний акт, захиргааны акт хоёрын дунд хуулиар тусгайлан эрх олгогдоогүй зохицуулалтгүй хоцрох асуудлыг 37.7-р зохицуулахаар оруулсан.

**Асуулт Уул уурхайн яам Мөнхбаяр**: Хэм хэмжээний актыг бүртгэхтэй холбоотой тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт явуулах тусгай зөвшөөрөл хуулиар манайд олгогдоогүй. Харин Засгийн газрын хуралдааны тэмдэглэл болон тогтоолыг үндэслэж гаргаж байгаа. Энэ хууль зөрчсөн үү? Хууль зүй, дотоод хэргийн яам бүртгээд байгаа.

**Хариулт Цогт:** Хууль зөрчсөн байна. Хууль зүй, дотоод хэргийн яам үүнийг нь бүртгээд байгаа бол мөн л хууль зөрчсөн байна. Ер нь бол өмнө хууль гарахаас өмнөх шийдвэрүүдээ хуульд нийцүүлэх ёстой. Саяны тохиолдол бол маш тодорхой эрх олгогдоогүй байгаа тохиолдолд хүчин төгөлдөр үйлчлэхгүй акт байна.

**Хариулт Одгэрэл**: Хуулиар тусгайлан эрх авах шаардлагатай дүрэм, журам байна. Ийм дүрэм, журмуудыг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэрээр өөрчлөх хэрэгтэй. Ямар асуудалд заавал хуулиар эрх олгох бэ? гэдгийг яам анхаарах хэрэгтэй. Энэ зөвхөн захиргааны ерөнхий хуулийн асуудал биш.

**Асуулт Эрчим хүчний яамны Хуулийн хэлтсийн дарга Нямдорж:** Санал хэлье. Хэд хэдэн шийдэл байна. Манай байгууллага хэд хэдэн төрийн өмчийн үйлдвэрийн газруудтай. Энд сайд ямар нэг арга хэмжээ аваад хариуцлага тооцох гэхээр нөгөө этгээдүүд өөр газраас томилогдсон байдаг. Тэр томилсон газраас нь арга хэмжээ авах гэхээр би эрчим хүчний салбартаа байдаг гээд нэг журам барьчихдаг. Засгийн газрын 2017 оны 50 дугаар тушаал гэж байдаг. Энэ асуудлаар яам нь ч арга хэмжээ авч чаддаггүй нөгөө томилсон төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар нь ч арга хэмжээ авч чаддаггүй сүүлдээ Засгийн газар луу хандсан. Энэ мэт харилцааг нарийвчилж зохицуулах шаардлагатай байна.

Remove Watermark Now

**Асуулт Бат-Эрдэнэ**. Эерэг нөлөөлөл бүхий захиргааны акт, сөрөг нөлөөлөл бүхий захиргааны акт гээд хуульд оруулсан байна. Ингэж оруулах шаардлага байхгүй юм биш үү? Яагаад гэвэл сөрөг нөлөөлөл гээд байгаа нь эерэг асуудлаа л бий болгох гээд байгаа юм.

**Хариулт Цогт:** Үүнийг бид зохиосон асуудал биш. Гэхдээ энэ шийдвэр нийтийн өмнөөс гарч байгаа шийдвэр учраас нэг этгээдэд магадгүй сөрөг үйлчлэл үзүүлэх ёстой санаагаар нь сөрөг гээд байгаа.

**Асуулт Бат-Эрдэнэ**: Худалдан авах гэрээний загварыг Сангийн яам гаргадаг. Үүнээс болж асуудлууд гардаг. Үүнийг Хууль зүй, дотоод хэргийн яам анхаарах хэрэгтэй.

**Асуулт Байгаль орчин, аялал, жуулчлалын яам Раднаабазар:** Захиргааны ерөнхий хуулийг бид уншихад ойлгомжтой хэдий ч иргэд уншихад их төвөгтэй, хэл бичгийн хувьд төвөгтэй хууль байгаа.

Мөн Захиргааны ерөнхий хуулийг захиргааны хэргийн шүүгч нар хэрхэн ойлгож байдаг юм бол эргэлзээтэй байдаг. Жишээ нь 27, 28 дугаар зүйлд сонсох ажиллагаа гээд байгаа. Шүүгч нар янз янзын байдлаар шийдвэр гаргадаг. Анхан, давах, хяналт гээд өөр өөр шийдвэр гаргаад байдаг. Шүүх хурал дээр үүнийг тайлбарлах боломжгүй. Шүүгч нар хууль хэрэглээний талаар хоорондоо ярьдаг, тогтдог зүйл байна уу?

Хөдөлмөрийн хууль, Захиргааны ерөнхий хуулиудын уялдаа холбоо байхгүй байна. Үүнээс болж маргаан их гарч байна. Хуулиар эрх олгогдоогүйтэй холбоотой асуудал байна. Жишээ нь: Нийслэлийн утаа, тусгай хамгаалал, газар олгох зэрэг асуудал дээр маш хурдан шийдвэр гаргах болдог. Тэгэхлээр хуулиар эрх олгогдоогүй учраас тэр үүсээд байгаа асуудлыг яаж шийдэх бэ? Түрүүн хэлсэнчлэн бүх хуулиудыг шүүдэг. Юм олдохгүй болохоор Үндсэн хуулийн 62-ийг бариад шийдвэр гаргаж байгаа. Үүнийг нь Хууль зүй, дотоод хэргийн яам бүртгэхгүй, танайд ийм эрх олгогдоогүй байна гэдэг. Энэ мэт асуудлыг яах бэ? Мөн захиргааны хэргийн шүүх хуулиа сайн судлаач ээ. Ерөнхий хуулийн талаар давтан сургалт хийгээч ээ гэж хэлмээр байна. Баярлалаа.

**Хариулт Цогт:** Хэм хэмжээний актаар зайлшгүй зохицуулах шаардлага байна гэж үзсэн зүйл байвал тэр асуудлыг шийдвэрлэхээр хуульд эрх нь олгогдоогүй бол хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгтэй. Хэрвээ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаас өмнө зайлшгүй шаардлагатай гэж үзвэл энэ асуудлаар заавал хэм хэмжээний актаар биш нэг бүрчилсэн тохиолдлыг шийдвэрлэх замаар шийдэх ёстой байх. Шүүхтэй холбоотой асуудлыг мэддэг хүн байхгүй байна. Шүүгч нар болохгүй байвал шүүхийг мэддэг байгууллагад нь асуудлыг тавих хэрэгтэй. Шүүхийн практик гэдэг бол явж байж тогтдог зүйл. Тэр тусмаа шинэ хуулийн хэрэгжилтийн хувьд, дээд шатны шүүх мөн чанартаа алдааг залруулах гэж байгаа учраас өөрчлөлт гарч байвал анхан шатны шүүхийн алдааг засаж байна гэж ойлгох хэрэгтэй. Харин нэг алдааг олон давтахгүй байх нь доод шатны шүүхүүдийн асуудал. Хэрэглээний асуудал бол та бүхэн дээр ч гарч байна. Шүүхүүд дээр ч гарч байна. Тодорхой хугацааны дараа практик тогтох ёстой. Ер нь бол хууль хэрэглээний асуудал дээр өөр өөр байр суурьтай байхыг үгүйсгэхгүй.

**Хариулт Одгэрэл**: Сонсох ажиллагааны талаар мөн ярьсан энэ асуудал дээр сонсох ажиллагаа хийхгүй байх нөхцөл гээд хууль дээр байгаа. Яаралтай, шуурхай шийдэх асуудлыг бол сонсох ажиллагаа хийхгүй гээд байгаа. Сонсох ажиллагаа хийхгүй ийм ийм ажиллагаа байна гээд тодорхой тохиолдлуудыг заасан байгаа.

**Асуулт нийслэлийн Засаг даргын Тамгын газар С.Энхжаргал**: Өнөөдрийн энэ хэлэлцүүлэг Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтэд үнэлэлт дүгнэлт өгөөд юу нь болж байна? юу нь болохгүй байна гэдгээ ярьж дүгнэж байна гэж ойлгож байна.

Хууль зүй, дотоод хэргийн яам зохион байгуулаад нийслэл болон орон нутагт хуулийн сургалт зохион байгуулсан. Аймаг болон нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хүрээнд нийтлэг нэг хүндрэлтэй асуудал тулгардаг. Энэ асуудлыг нэмэлт, өөрчлөлт хийхдээ анхаарах ёстой бол уу гээд хоёр санал хэлье.

Нэгдүгээрт Захиргааны ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлд заасны дагуу хувийн хэрэг бүрдүүлэх асуудал байгаа. Үүнийг байгууллага болгон өөр өөрөөр бүрдүүлж байна. Үүнийг Хууль

Remove Watermark Now

зүй, дотоод хэргийн яам болон архивын ерөнхий газар нар хамтаар нэг зөвлөмж юм уу тодорхой нэг стандарт ч юм уу боловсруулж өгвөл зүгээр байна.

Хоёрдугаарт засаг дарга болон түүний ажлын албанаас гарч байгаа захиргааны акт хурлаас гарсан хэм хэмжээний актыг үндэслэн гарч байгаа тохиолдол их байгаа. Энэ тохиолдолд учирч байгаа бэрхшээл нь Захиргааны ерөнхий хуульд заасан захиргааны хэм хэмжээний актын бүртгэлтэй холбоотой асуудал байна. Хууль батлагдахаас өмнө гаргасан хэм хэмжээний актыг хүчин төгөлдөр гээд Засаг дарга мөрдөөд захиргааны акт гаргадаг. Тэр захиргааны акттай холбоотой маргаан гараад захиргааны шүүхэд очиход нөгөө үндэслэл болгосон хэм хэмжээний акт хүчин төгөлдөр байгаа эсэх асуудлаар маргаан гараад байгаа. Энэ хэм хэмжээний актын бүртгэлтэй холбоотой хууль батлагдахаас өмнө батлагдан мөрдөгдөж байсан захиргааны хэм хэмжээний актыг бүртгэж бүртгэлийн ажиллагаа хүчин төгөлдөр эсэх талаар журам, зөвлөмж гаргаж өгөхгүй бол болохгүй байна. Захиргааны ерөнхий хууль гарсан дагаж мөрдөх журмын тухай хууль гараагүй учраас ийм ойлгомжгүй асуудлууд гараад байгаа юм болов уу гэж бодож байна. Тиймээс дагаж мөрдөх журмын тухай хууль байж болох уу гэсэн санал байна.

Нутгийн захиргааны байгууллагуудын шийдвэр гүйцэтгэх ажиллагааг бол агентлагууд хийдэг. Иймээс нийслэлийн агентлагууд болон дүүргүүдэд энэхүү уулзалт ярилцлагыг хийж тэднийг сонсвол хууль хэрэглээн дээр тулгамдсан ямар хүндрэлтэй асуудал байгаа талаар олон саналууд гарах болов уу гэж бодож байна. Ийм хэлэлцүүлэг хийж байгаад талархалтай байна.

**Д.Ариунтуяа**: Баярлалаа. Ер нь бид цуврал ярилцлага хийж байгаа. Өнөөдөр нийслэл, яамдуудад дараагийн долоо хоногт агентлагууд тэрний дараагийн долоо хоногт Улсын Их Хурлын байгууллагуудад хийхээр төлөвлөсөн байгаа.

Хэлэлцүүлэгт оролцсон та бүхэнд баярлалаа. Уулзалт, ярилцлага 12 цаг 30 минутад дуусав.

ТАНИЛЦСАН: ЗХХАХБХ-ийн ахлах мэргэжилтэн Э.Сэлэнгэ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН: ЗХХАХБХ-ийн мэргэжилтэн С.Дархантөгс

pdfelement

## “ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ” СЭДЭВТ

### Уулзалт-ярилцлагын тэмдэглэл

2018.02.02 Улаанбаатар хот

“Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилт” сэдэвт уулзалт, ярилцлагыг Хууль зүй, дотоод хэргийн яам, ХБНГУ-ын Ханнс Зайделийн сантай хамтран 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 09 цаг 18 минутад Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хуульчдын танхимд зохион байгуулав.

**Уулзалт, ярилцлагыг чиглүүлэгч: ХЗДХЯамны ЗХХАХБХ-ийн ахлах мэргэжилтэн Э.Сэлэнгэ:** Улсын Их Хурлаас 2015 оны 06 сарын 19-ний өдөр Захиргааны ерөнхий хуулийг баталж, 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээр өдгөө нэг жил зургаан сарын хугацаа өнгөрөөд байна.

Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгасны дагуу ХЗДХС-ын тушаалаар Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсгийг өнгөрсөн 7 хоногт, мөн ХЗДХЯ, Ханнс Зайделийн сантай хамтран Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхийг ажлын хэсгийг тус тус байгуулсан. Бид “Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилт” сэдэвт энэхүү уулзалт ярилцлагыг цуврал байдлаар зохион байгуулахаар төлөвлөсний дагуу өнөөдрийн уулзалт, ярилцлагыг эхлэх гэж байна.

Remove Watermark Now

За өнөөдрийн уулзалт ярилцлагад Засгийн газрын хэрэгжүүлэгч, тохируулагч 27 агентлаг, Эрчим хүчний зохицуулах хороо, Харилцаа холбооны зохицуулах хороо, Цөмийн энергийн комиссын ажлын алба, Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын үйлчилгээг зохицуулах зөвлөл, Захиргааны ерөнхий хуулийн ажлын хэсэгт орж ажилласан гишүүд, зөвлөхүүд болон Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлын хэсгийн гишүүд, Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийнхэн оролцож байна.

За одоо ингээд “Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилт” сэдэвт уулзалт, ярилцлагыг нээж үг хэлнэ үү хэмээн Хууль зүй дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн дарга Д.Ариунтуяаг индэрт урья.

**Хууль зүй, дотоод хэргийн яамны ЗХХАХБХ-ийн дарга Д.Ариунтуяа**:

Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая.

Өнөөдрийн уулзалтыг нээж үг хэлэх ёстой байсан Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Энхбаяр нь тус яамны харьяа Хил хамгаалах ерөнхий газар дээр яаралтай уулзалт, зөвлөгөөнтэй болсон тул хүрэлцэн ирж амжсангүй, миний бие нь өнөөдрийн уулзалт ярилцлагыг нээж байна.

Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхлээд нэг жил зургаан сар өнгөрсөн байна. Уг хугацаанд тус яам нь Ханнс Зайделийн сантай хамтарч нэлээдгүй ажлыг хийж гүйцэтгэсэн байна. УИХ-ын тогтоолоор баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг боловсронгуй “2020 хүртэлх үндсэн чиглэлд” Захиргааны ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар тусгагдсан. Захиргааны ерөнхий хуулийг хэрэгжүүлж байгаа төрийн захиргааны байгууллагуудад уг хуулийг хэрэглэх явцад тулгамдаж байгаа ямар асуудал байна. Мөн Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой засч залруулах хэлэлцэн боловсруулах ажил юу байна энэ талаар өнөөдөр нээлттэй хэлэлцүүлгийг Ханнс Зайделийн сантай хамтран зохион байгуулж байна.

Тус хэлэлцүүлэг, уулзалтыг 3 хувааж явуулж байгаа бөгөөд 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон төрийн захиргааны төв байгууллага болох 13 яамдын төлөөлөл урьж оролцуулсан. Энэ удаагийн хэлэлцүүлэгт Засгийн газрын агентлагууд, Эрчим хүчний зохицуулах хороо, Харилцаа холбооны зохицуулах хороо, Цөмийн энергийн комиссын ажлын алба, Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөл, Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын үйлчилгээг зохицуулах зөвлөлийг албан хаагчдийг хамруулж байгаа бол 2018 оны 02 дугаар сарын 09-ний өдөр хэлэлцүүлэг уулзалтад УИХ-аас байгуулагддаг Засгийн газрын бус бие даасан байгууллагуудыг урьж оролцуулахаар төлөвлөн ажиллаж байгаа. За ингээд та бүхнийг уг хэлэлцүүлэгт идэвхтэй оролцохыг хүсээд тус арга хэмжээг нээж байна.

“Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилт” сэдэвт хэлэлцүүлэгт Ханнс Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газрын тэргүүн Сарантуяа оролцож байгаа бөгөөд мөн Захиргааны ерөнхий хуулийг боловсруулах ажлын хэсэгт ажиллаж байсан доктор П.Одгэрэл, Д.Сүнжид багш, доктор Ц.Цогт шүүгч болон судлаачид ирж оролцож байгаа тул эдгээр хүмүүстэй чөлөөтэй ярилцаарай. За ингээд энэхүү уулзалт, ярилцлагыг хамтран зохион байгуулж байгаа Ханнс Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газрын тэргүүн Сарантуяа таныг үг хэлнэ үү хэмээн урьж байна.

**Ханнс Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газрын тэргүүн Ц.Сарантуяа:**

Та бүхэнд энэ өглөөний мэндийг хүргэе. Хууль зүй, дотоод хэргийн яамны ЗХХАХБХ-ийн дарга Д.Ариунтуяа та бүхэнд үндсэн танилцуулгыг хийлээ. Та бүхэн мэдэж байгаа байхаа.

Remove Watermark Now

Монгол Улсад 1997 оноос хойш Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль дуншиж байгаад 2002 онд батлагдаж мөн Захиргааны хэргийн шүүх байгуулагдсан.

Захиргааны хэргийн шүүхэд хэрэглэгдэж байгаа гол хууль болох Захиргааны ерөнхий хууль 2015 онд батлагдаад 2016 онд хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль хэрхэн хэрэгжиж байгаа тухай бид тухай бүр хэлэлцүүлэг, судалгааг зохион байгуулж Улсын Дээд Шүүхтэй хамтран амжилттай хийж, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж, давж заалдах шатны шүүх байгуулагдаж байсан удаатай юмаа.

Захиргааны ерөнхий хууль батлагдаж, хүчин төгөлдөр болоод жил гаруй хугацаа өнгөрсөн байна. Энэ хууль манай улсын эрх зүйн амьдралд, манай улсын захиргааны үйл ажиллагаанд нэгэн шинэ хуудсыг нэмж байгаа учраас энэ хууль болж өгвөл төгс төгөлдөр байх учиртай. Нэгэнт ажил хийвэл дуустал хийнэ гэдэг үүднээс энэ хууль нь батлагдан гараад ажил дууслаа гэж үзэлгүйгээр, хэрхэн яаж сайжруулах шаардлагатай байгаа эсэхийг судлах ийм ажил эхэлж байгаа юм. Энэ хуулийг Захиргааны хэргийн шүүхэд хэрэглэдэг, хэрэгжүүлдэг та бүхэнтэй харилцан тохиролцсоны үндсэн дээр хэлэлцүүлэх, уулзалтыг зохион байгуулж байна.

Бид 2017 оны 12 дугаар сард Захиргааны хэргийн анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн шүүгч нарыг тусгайлан урьж ярилцлага хийж эдгээр шүүгчдийн санал бодлыг судалсан болно. Одоо он гарснаар Засгийн газрын яам, агентлаг болон холбогдох бусад байгууллагуудыг урьж уулзалтыг зохион байгуулж байна. Эдгээр тус бүр зохион байгуулж байгаа уулзалтаас хурлын тэмдэглэл гарна гэж бодож байна. Хамтран хэрэгжүүлж байгаа байгууллагуудаас энэ хурлын тэмдэглэлийн үндсэн дээр асуудалтай байгаа харилцааг тодорхойлж холбогдох судалгааг хамтарч шийдэх бөгөөд Та бүхэн энэ хуулийг гардаж хэрэгжүүлдэг учраас ямар зүйл, заалт нь асуудалтай байгаа, нэг мөр ойлгоход хүндрэлтэй байгаа болон нийт уялдаа холбоог авч үзэх, мөн энэ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэх, мөн Монголын захиргаа өөгүй ажиллахад Та бүгдийн хувь нэмэр маш чухал байгаа болно.

Тус хуулийн төслийг боловсруулах ажлын хэсгийн гишүүд болон эрдэмтэн, судлаачидтай хамтарч 2017 оны зун Захиргааны ерөнхий хуулийн тайлбар номыг гаргаж та бүгдийн хүртээл болгож, Засгийн газрын агентлаг, байгууллагуудад тарааж өгсөн бөгөөд уг арга хэмжээнээс хоцорч тухайн тайлбарыг авч амжаагүй байгууллагуудад өнөөдрийн арга хэмжээний төгсгөлд дахин авах боломжтой. Ингээд өнөөдрийн энэ хэлэлцүүлэгт хүрэлцэн ирсэн та бүхэнд амжилт хүсэж, цагийг үр дүнтэй ашиглаж хэлэх гэсэн зүйлээ хэлж тэмдэглүүлээрэй. Анхаарал тавьсан баярлалаа.

**Уулзалт, ярилцлагыг чиглүүлэгч**: **ХЗДХЯамны ЗХХАХБХ-ийн ахлах мэргэжилтэн Э.Сэлэнгэ:** Уулзалт, ярилцлагыг нээж үг хэлсэн Ариунтуяа дарга, Сарантуяа багшдаа баярлалаа. За одоо хөтөлбөрт зааснаар хоёр мэдээллийг сонсох ёстой байгаа. Эхний мэдээлэл Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой болон одоо хийж байгаа ажлын талаар мэдээлэл өгнө үү? хэмээн Хууль зүй дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн дарга Ариунтуяа таныг урьж байна.

**Хууль зүй, дотоод хэргийн яамны ЗХХАХБХ-ийн дарга Д.Ариунтуяа**: Захиргааны ерөнхий хууль хэрэгжээд жил зургаан сарын хугацаа өнгөрөөд байна. Энэ хооронд Хууль зүй дотоод хэргийн яам нэлээдгүй ажил хийсэн. Өнөөдөр та бүхэнд танилцуулах гэж байгаа зүйл маань хоёр хэсэгтэй.

Нэг: Захиргааны ерөнхий хууль 2015 онд батлагдсанаар хуулийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яам ямар ажлууд хийсэн талаар товч танилцуулъя.

Хууль зүйн яам /хуучин нэрээр/-ны Төрийн нарийн бичгийн дарга энэ хуулийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөө баталж энэ чиглэлээр нэлээдгүй ажлыг хийсэн.

Remove Watermark Now

1.1.Хууль зүйн сургуулийн захиргааны эрх зүйн багш, судлаач, ажилтнуудад зориулсан сургалтыг 2015 оны 10 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд Хансс-Зайделийн сантай хамтран амжилттай зохион байгуулж нийт 32 багш, судлаач, ажилтнуудыг хамруулсан.

1.2. Захиргааны ерөнхий хуулийг заах сургагч багш бэлтгэх сургалтыг 2015 оны 11 дүгээр сарын 23-28-ны өдрүүдэд /нийт 6 өдөр/ зохион байгуулж, 31 сургагч багш бэлтгэн, гэрчилгээ олгосон.

1.3.Захиргааны ерөнхий хуулийн талаар Ханнс-Зайделийн сантай хамтран шторк бэлтгэж хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилсан. Дээрх шторкийг /CD хэлбэрээр/ аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ, яамдуудад албан бичгээр хүргүүлж, холбогдох мэдээллийн хэрэгслээр түгээсэн.

1.4.Захиргааны ерөнхий хууль 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэхтэй холбогдуулан Хууль зүйн яам /хуучин нэрээр/, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн Эрх зүйн боловсрол академитай хамтран яам, агентлаг болон нийслэл, дүүргүүдийн ЗДТГ, Захирагчийн ажлын алба, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагуудын албан хаагчдад зориулсан танилцуулах сургалтыг 2016 оны 2 дугаар сарын 16-наас 4 дүгээр сарын 1-ний хооронд, мөн 21 аймагт 4 дүгээр сарын 17-30-ны хооронд тус тус зохион байгуулж, нийт 100 гаруй удаагийн сургалтаар 7500 гаруй ажилтан, албан хаагчийг хамруулж, брошур, гарын авлага, сурталчилгааны материалуудыг түгээж, хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчилсан байна.

1.5.Захиргааны ерөнхий хуулийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 3.2 дахь хэсэгт заасны дагуу Захиргааны ерөнхий хуулийн агуулгыг Хууль зүйн их, дээд сургуулиудын Захиргааны эрх зүйн хичээлийн сургалтын хөтөлбөрт шинэчлэн тусгуулах саналыг Хууль зүйн сайдын /хуучин нэрээр/ албан бичгээр Боловсрол, соёл, шинжлэх ухааны Сайдад /хуучин нэрээр/ хүргүүлж, хэрэгжсэн байна.

pdfelement

1.6.Захиргааны ерөнхий хуулийн 61 дүгээр зүйлийн 61.6, 72 дугаар зүйлийн 72.2, 54 дүгээр зүйлийн 54.4 дэх заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах журмуудыг эрх олгосон захиргааны байгууллагууд баталсан. Үүнд:

- Хууль зүйн сайд /хуучин нэрээр/-ын 2016 оны 7 сарын 1-ний өдрийн А/222 тоот тушаалаар “Нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал”,

- Хууль зүйн сайд /хуучин нэрээр/-ын 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн А/226 тоот тушаалаар “Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санг эрхлэн хөтлөх тухай” журмыг хууль хэрэгжиж эхлэхээс өмнө батлуулж бэлтгэл ажлыг хангасан байна.

1.7.Хууль зүйн яам /хуучин нэрээр/, Ханнс-Зайделийн сантай хамтран Захиргааны ерөнхий хуулиар сургагч багш нарт болон иргэдэд зориулсан сургалтын гарын авлагыг гаргаж төрийн байгууллагууд болон иргэдэд хүргүүлсэн.

Хоёр:Захиргааны ерөнхий хууль 2016 оны 7 дугаар сарын 1-нээс эхлэн хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулаад Хууль зүй, дотоод хэргийн яамны бүтцэд захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтэс гэсэн шинэ нэгжийг байгуулсан. Энэ нэгж маань Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар бүлгийн хүрээнд дараахь ажлыг хийж хэрэгжүүлсэн.

Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлд “Засгийн газар нь төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын шийдвэр хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх талаар хяналт тавих үүрэгтэй.“ гэж заасны дагуу энэ хяналтыг Хууль зүй дотоод хэргийн яам хэрэгжүүлдэг. Энэ чиглэлийн хүрээнд Захиргааны ерөнхий хуульд захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийг Хууль зүй дотоод хэргийн яам хэрэгжүүлэхээр тусгасан. Хууль

батлагдахаас өмнө энэ асуудлыг Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолын хүрээнд тус яам хийдэг байсан бол Захиргааны ерөнхий хууль батлагдан, хэрэгжиж эхэлснээр бид хуулийн дагуу захиргааны хэм хэмжээний актыг хянах, бүртгэх асуудал яригдаж, улмаар хууль зөрчсөн зөрчилд хариуцлага тооцох асуудал гарч ирсэн.

Ажил авахад нийтдээ улсын нэгдсэн санд 960 хэм хэмжээний акт бүртгэлтэй байсан. Засгийн газрын тогтоол хэрэгжиж байх үед сайд, агентлагийг дарга нар, зөвлөл, хороо, Засаг даргын шийдвэрийг л зөвхөн хянадаг байсан бол Захиргааны ерөнхий хууль хэрэгжсэнээр эдгээр дээр нэмээд захиргааны чиг үүргийг хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээд орж ирж байгаа. Тухайлах юм бол хуульчдын холбоо. Энэ байгууллага нь төрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэдэг ийм байгууллага. Мөн хууль тогтоомжийг биелүүлж, захирамжлсан шийдвэр гаргадаг Засгийн газрын бус бие даасан агентлаг гэж орж ирж байгаа. Энэ нь Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо гэх мэт 8 байгууллага байдаг. Түүнчлэн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдээс гаргасан хэм хэмжээ тогтоосон шийдвэрүүдийг Хууль зүй, дотоод хэргийн яам хянаж бүртгэх ажил хуулиар орж ирж байгаа. Түүнчлэн Захиргааны ерөнхий хуульд Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, бүх шатны шүүх прокуророос хуульд заасан эрх мэдэл буюу хууль тогтоох эрх зүйн маргаан шийдвэрлэх онцгой бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрээс бусад захиргааны чиг үүрэг шийдвэртэй холбогдуулан эдгээр байгууллагыг захиргааны байгууллагад тооцохоор заасан байгаа.

Улсын нэгдсэн санд бүртгэлтэй байгаа 960 хэм хэмжээний актыг Захиргааны ерөнхий хуульд нийцсэн эсэхийг Хууль зүй, дотоод хэргийн яам нэг бүрчлэн Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагын дагуу хянаад энэ актуудын 487 нь Захиргааны ерөнхий хуульд нийцэхгүй байна гэж үзсэн. Учир нь ач холбогдлоо алдсан, зохицуулж байсан хууль нь хүчингүй болсон, эсхүл шинэчилсэн найруулга нь батлагдсанаар эрх олгосон заалтгүй болсон, эсхүл заалтууд нь өөрчлөгдсөн г.м бусад шалтгаанаар нийцэхгүй байна гэсэн дүгнэлтийг холбогдох байгууллагуудад хүргүүлж хуульд нийцүүлэх ажлыг үе шаттайгаар хийж ажилласнаар 120 гаруй шийдвэрийг хүчингүй болгож өөрчилсөн байгаа.

Одоогоор улсын нэгдсэн санд нийт 832 шийдвэр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа. Захиргааны ерөнхий хуулиар шинээр орж ирсэн байгууллагуудын нийтдээ 1000 гаран захиргааны хэм хэмжээний актыг татан авч үзээд энэ нь мөн Захиргааны ерөнхий хууль болон бусад хуульд нийцэхгүй гэсэн шалтгаанаар хамтран ажиллаж хуульд нийцүүлэх ажлын Хууль зүй дотоод хэргийн яам үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Түүнчлэн захиргааны хэм хэмжээний актаа хуульд нийцүүлэхийн тухайд заавал хуулиар тусгайлан эрх олгосон байх ёстой гэсэн хуулийн шаардлага тавьж байгаа. Өнөөдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 482 хууль байгаа. Энэ хуулиудад хэчнээн эрх олгосон заалт оруулсан бэ? гэдэг судалгааг гаргасан. Судалгаанаас харахад 206 хуулиар дамжуулан нийтдээ 1476 байгууллагад дүрэм, журам батлах эрхийг олгосон гэсэн судалгаа гарсан. Үүнээс нэгдсэн санд байгаа 832 хэм хэмжээ тогтоосон шийдвэрээ хасах юм бол 644 хууль тогтоогчоос олгосон эрхийг хэрэгжүүлээгүй гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Цаашдаа энэ ажлууд маань үргэлжлээд явахаар байгаа.

Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиудад судалгаа хийж дууссанаар бид дараахь ажлыг төлөвлөж байна. Нэгдүгээрт нь эрх олгосон заалтын хүрээнд захиргааны хэм хэмжээний актыг холбогдох захиргааны байгууллагаас татаж улсын нэгдсэн санд бүртгүүлсэн эсэх. Хоёрдугаарт нь эрх олгосон актын хүрээнд захиргааны хэм хэмжээний акт батлан гаргаагүй зөрчлийг илрүүлж холбогдох байгууллагад хууль хэрэгжүүлэх тухай албан бичиг явуулж хамтран ажиллана гэсэн төлөвлөгөөтэй байна.

Мөн захиргааны хэм хэмжээний акт батлагдсан боловч улсын нэгдсэн санд бүртгүүлэхгүйгээр дагаж мөрдөж байгаа зөрчил, дутагдлууд нэлээдгүй байгаа. Энэ нь хуульд

Remove Watermark Now

зааснаар захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд заавал бүртгүүлснээр хүчин төгөлдөр болох ёстой. Үүнийг мөрдөж ажиллахгүй байгаа дутагдлууд нэлээн гарч байгаа.

Одоо тус хэлтсээс Захиргааны ерөнхий хуулийн 69 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд улсын нэгдсэн санд бүртгэлтэй байгаа актууддаа хяналт, шинжилгээ үнэлгээ хийх ажлыг холбогдох захиргааны байгууллагуудтайгаа хамтран хийж байна. Хяналт, шинжилгээний дүнг үндэслэн цаашид авах арга хэмжээний талаарх саналаа Засгийн газарт танилцуулахаар ажиллаж байна.

Мөн 2017 онд Захиргааны ерөнхий хуулийн чадваржуулах сургалтыг Ханнс Зайделийн сантай хамтран 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт хийсэн байгаа. Түүнчлэн энэ хуулийг иргэдэд сурталчлах зорилгоор иргэдэд зориулсан гарын авлага гаргаж, Захиргааны ерөнхий хуультай хамт хэвлүүлэн 21 аймаг болон нийслэлийн 9 дүүргийн иргэдэд тараасан байгаа.

Захиргааны ерөнхий хуулийг хэрэгжүүлэхийн төлөө өнгөрсөн жил гарны хугацаанд хамтран ажилласанд баярлалаа.

Мөн Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой засч залруулах хэлэлцэн боловсруулах ажил юу байна энэ талаар өнөөдөр нээлттэй хэлэлцүүлгийг Ханнс Зайделийн сантай хамтран зохион байгуулж байна. Та бүхнийг идэвхтэй оролцохыг хүсье. Баярлалаа.

**Уулзалт, ярилцлагыг чиглүүлэгч**: **ХЗДХЯамны ЗХХАХБХ-ийн ахлах мэргэжилтэн Э.Сэлэнгэ:** Захиргааны ерөнхий хуулийн бэлтгэл ажлыг хангах болон хэрэгжилтийн хүрээнд хийсэн ажлын талаар мэдээлэл өгсөн Ариунтуяа даргад баярлалаа.

За дараагийн мэдээллийг Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлснээр шүүх дээр энэ хуулийг хэрхэн хэрэглэж шийдвэрээ гаргаж байгаа талаар “Захиргааны ерөнхий хуулийн хэрэглээ” сэдвийн хүрээнд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, Захиргааны ерөнхий хуулийн ажлын хэсгийн гишүүнээр ажилласан судлаач Ц.Цогт мэдээлэл хийнэ. Таныг индэрт урьж байна.

pdfelement

**Шүүгч Ц.Цогт:** Ер нь бол Захиргааны ерөнхий хуулийг шүүх дээр хэрэглэж тодорхой маргаан шийдвэрлэж байгаа. Тэр статистикээс юуг дүгнэж болох бэ? гэвэл: Бид энэ хуулийг хэрэглэх төлөв байдал захиргааны байгууллага дээр ямар байгаа бэ? Хэрэглэх ёстой асуудал дээрээ хэрэглэж байна уу? Хэрэглээн дундаа алдаа гарч байна уу?, эсхүл Огт ойлгогдохгүй асуудлууд гарч байна уу? Захиргааны байгууллага, иргэн хоёрын хооронд ийм асуудал үүсч байна уу? гэдгийг харж болох юм.

Ханнс Зайделийн сангийн хүсэлтээр 2017 оны 1 сараас 07 дугаар сарыг хүртэл хугацаанд нийт захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдээр шийдвэрлэгдсэн хэргүүдэд судалгаа хийх замаар өнөөдрийн танилцуулгыг хийж байна. Эндээс юуг харж болохоор байна гэхээр шүүхүүдэд Захиргааны ерөнхий хуулийг хэрэглэж ямар хэрэг маргаан шийдэж байна. Энэ дотроо аль зүйл заалтыг илүү хэрэглэгдэж байна. Мөн энэ нь яагаад ингэж хэрэглэгдэж байна гэдгийг. Тухайн зохицуулалттай холбоотой захиргааны байгууллагууд шийдвэр гаргахдаа тэр зохицуулалтыг буруу зөрүү хэрэглэснээс маргаан үүсч байна гэж харагдах гээд байна. Захиргааны ерөнхий хуулийн үндсэн хоёр чиглэл байгаа, зохицуулж байгаа хоёр этгээд болон захиргаа, иргэн тэдгээрийн хоорондын харилцааг зохицуулах тэр дотроо захиргааны үйл ажиллагааг стандартад оруулаад ойлгомжтой тодорхой болгоход оршиж энэ судалгаа ч мөн үүнд чиглэсэн байгаа.

Судалгаар shuuh.mn шүүхийн шийдвэрийн цахим санд оруулсан байгаа. Бүх шийдвэрийг татаж судалсан байгаа. Нийтдээ захиргааны хэргийн анхан шатны шүүх 2017 оны эхний хагас жилд 1070 хэрэг шийдвэрлэсэн албан ёсны мэдээ байна. Түүний 920 шийдвэр нь судалгаа хийх үед цахим санд орсон байсан. Энэ 920 шийдвэрийг шүүж үзээд нийслэл дэх захиргааны хэргийг

анхан шатны шүүх /хотын захиргаа, хурал, дүүрэг, төрийн захиргааны төв, Засгийн газрын байгууллагууд, бие даасан агентлагууд/-ын шийдвэр үйл ажиллагаа бол харьяаллаараа Нийслэлийн захиргааны хэргийн шүүх шийдэж байгаа. Энэ шүүх 67, орон нутгийн шүүхүүд бол 77 хэргийг шийдсэн байна. Энэ дотроос 140 хэрэг дээр бол ямар нэг байдлаар шүүхийн шийдвэрт Захиргааны ерөнхий хуулийг хэрэглэсэн байна. 140 шийдвэрт хэрэглэсэн байна гэдэг нь 140 тохиолдолд захиргааны байгууллага ерөнхий хуулийг хэрэглэсэн гэсэн үг бас биш. Яагаад гэвэл шүүх шийдэхдээ “Та энэ тохиолдолд ерөнхий хуулийг хэрэглэх ёстой байсан байна, хэрэглээгүй байна” гэж өөрөө шийдвэр гаргахдаа энэ хуулийг хэрэглэх замаар шийдвэр гаргасан тохиолдол байдаг. Энэ хэргүүдийн маргааны төрлөөс аваад үзвэл ер нь сүүлийн үед хүн ажлаас халсан маргаан шийддэг болсон. Энэ нь эмгэнэлтэй. Цаана нь олон төрлийн эрх зүйн маргаан байгаа. Хамгийн олон ерөнхий хууль хэрэглэж шийдсэн маргаан нь төрийн албаны маргаан байна 77-г шийдвэрлэсэн. Тэгээд газрын маргаан олон хэрэг дээр. Бусад нь сонгууль, ашигт малтмал зэрэг хэргүүд дээр хэрэглэгдсэн байдаг юм байна.

Шүүх Захиргааны ерөнхий хуулийн аль зүйл, заалтыг хэрэглэх магадлалтай бэ? гэхээр тодорхойлолт буюу материаллаг зохицуулалт агуулсан. Жишээ нь: Захиргааны акт гэж юу болох, ямар акт илт хууль бус болох бэ? гэх мэт зохицуулалтыг зайлшгүй хэрэглэж таарна. Хоёрдугаарт хамгийн гол хэрэглэгдэж байгаа зохицуулалт бол процесс байгаа. Захиргаа шийдвэр гаргахдаа ямар үе шатаар ямар арга замаар иргэнтэй харьцах тэрийг тодорхой хэрэг дээр хуультай харьцуулж үзээд нийцэж байна уу?, эсхүл нийцэхгүй байна уу? гэдэг тийм зохицуулалт. Шүүгээд үзэхээр хэрэглэсэн 140 хэргийн 74% нь шүүх нэхэмжлэлийн шаардлага хангаж шийдвэрлэхдээ ерөнхий хуулийг хэрэглэсэн байна. Тэгэхлээр ямар тохиолдолд шүүх нэхэмжлэлийн шаардлага хангахдаа тухайн хуулийг хэрэглэж байна гэдэг бол захиргааны байгууллага шийдвэр гаргахдаа хуульд заасан зохицуулалтыг дагаагүй, мөрдөөгүй, эсхүл бүрэн дүүрэн ойлгож хэрэглэж чадаагүй байна гэж ойлгохоор байна. Энэ 74% гэхдээ зарим нь нэхэмжлэлийг бүрэн хангасан зарим нь нэхэмжлэлийн зарим хэсгийг хангасан шийдвэрүүд байна. Нарийвчлан шүүх дээр яг ямар зохицуулалт хэрэглэгдээд байна гэвэл захиргаа шийдвэрээ гаргахдаа чи хэрэглээгүй байна гэж үзээд байгаа зохицуулалт байна уу? нэхэмжлэлийн шаардлага хангасан зохицуулалтыг үзвэл “зарчим” байгаа. Төрийн үйл ажиллагааны тусгай зарчим гээд шинэ хуульд нэлээн харийн юмнууд орж ирсэн. Хоёрдугаарт оролцогчийн эрхийн зохицуулалт байна. Захиргааны шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцогчийн эрхийг энэ хуулиар нэлээн тодорхой болгож өгсөн. Тэгэхээр оролцогчийн эрхийг барьж шүүх шийдэж байна гэсэн үг. Үүний цаана юу харагдаж байна гэхлээр захиргаа шийдвэр гаргахдаа тэр тусмаа сөрөг үйлчлэл бүхий шийдвэр гаргахдаа оролцогчийг татан оролцуулах эрхийг нь хангах тал дээр асуудалтай байна гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Нөгөө талаас нь нөхцөл байдлыг урьдчилан тогтоох, сонсох ажиллагаа явуулах гэсэн 2 бүлэг зохицуулалт байгаа. 24, 25, 26, 27 дугаар зүйлийн зохицуулалтууд нь нэг талаас шинэлэг зохицуулалт.

Ашигт малтмалын тухай хууль бол шийдвэр гаргахаасаа өмнө урьдчилж нөгөө этгээддээ хэлдэг зохицуулалт байсан. Харин бусад хуульд байгаагүй.

Сонсох ажиллагаа явуулах зохицуулалт бол шинэ. Тиймээс манай захиргаа хэрэглэхдээ алдаа оноотой юм байгаа юм шиг байна.

Мөн аливаа шийдвэр гаргахдаа нөхцөл байдлыг урьдчилан тогтоо гэдэг зохицуулалт орж ирсэн. Энэ нь манай практикт хүн ажлаас халчихаад шүүгдэхээр араас нь ажлаас халсан үндэслэл юм аа бүрдүүлдэг. Энэ асуудлын хувьд урьдчилаад тэр үндэслэлүүдийг нь тогтоож байгаад шийдэх ёстой. Үүнтэй холбоотой алдаа гаргадаг. Алдааг гаргахгүйн тулд ерөнхий хуульд урьдчилаад тогтоо гэсэн заалт оруулж ирсэн. Үүнийг бас шүүх нэлээдгүй барьж хэрэг маргаан шийдвэрлэсэн байна.

Нөгөө нэг бүлэг зүйл бол захиргааны актад тавигдах шаардлага. Бичгээр гарч байгаа захиргааны акт бол дийлэнх хүний эрх рүү чиглэсэн шийдвэр байгаа. Энд тавигдаж байгаа. Агуулгын хувьд нэгдүгээрт та гаргасан шийдвэрээ нөгөө хүндээ мэдэгдсэн байх ёстой. Тэр мэдэгдэх үүрэг танд бий болсон. Мэдэгдсэн эсэх талаар маргаан гарвал захиргаа мэдэгдсэнээ

Remove Watermark Now

нотолно гэсэн ийм зохицуулалт орсон. Нөгөөх нь бичгээр гаргаж байгаа захиргааны актад энэ шийдвэрийг зөвшөөрөхгүй байгаа тохиолдолд хаана ямар хугацаанд гомдол гаргах тухай акт өөрөө дотроо агуулах ёстой гэсэн агуулгыг шинэ хуульд оруулсан. Энэ нь иргэнд ч, захиргаанд ч амар, цаашлаад шүүхэд маргааныг шийдвэрлэхэд ч дөхөмтэй. Энэ тохиолдолд иргэн би мэдээгүй гэж мэлзэх боломжгүй зохицуулалт болсон. Эдгээрийг шүүх дээр хэрэглэгдсэн байна.

Нэг маргаантай зүйл бол илт хууль бус захиргааны акт гэж юуг хэлэх юм бэ? гэдэг юм байгаа. Энэ нь агуулгын хувьд маргаан төдийлөн байхгүй. Энэ яагаад маргаан дагуулаад байна гэхээр ерөнхий хуулийг дагаж гарсан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт буюу илт хууль бус болохыг тогтоолгох нэхэмжлэлд хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй гэсэн зохицуулалт орсон. Үүнтэй холбоотой хуульчид, өмгөөлөгчид ашиглаж хугацаа алдсан юмнуудаар  шүүхэд маргах ийм механизм нэлээд байгаа. Үүнтэй холбоотой илт хууль бус болохыг тогтоолгох нөхцөл нэлээн хөндөгдөж байгаа.

Мөн гомдол гаргах журамтай холбоотой зохицуулалтууд хэрэглэгдсэн байдаг юм байна. Хамгийн түгээмэл давтамжтай хэрэглэгдэж байгаа. Шүүх өөрийн шийдвэрийн үндэслэл болгож захиргааг буруутгаж буй тэр заалтууд энэ байна. Зарчмаа барихгүй байна, хууль төгс биш тодорхой бус зохицуулалтууд нэлээн байдаг. Яг тэр маргааныг шүүх шийдэхдээ зарчмаа хардаг захиргааны үйл ажиллагааны зарчимтай нийцээгүй байвал таны шийдвэр үйл ажиллагаа зарчимдаа нийцээгүй байна гэж явдаг.

Сонсох ажиллагааг хийх ёстой. Хийх боломжгүй тохиолдлуудаа маш тодорхой захиргаа өөрөө заагаад хуульд заасан үндэслэлүүдийг маш тодорхой дурдаад тодорхойлоод явах ёстой. Ингээд шүүх дээр маргаан гарсан тохиолдолд ийм нөхцөл байдал байсан гэдгээ шүүх дээр нотлоход л болно.

Ерөнхий хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 бодит нөхцөл байдлаа бүрэн дүүрэн судалж байж энэ шийдвэрээ гаргаарай гэсэн үндэслэлээр захиргааны актыг хүчингүй болгож байгаа тохиолдол их байна. Миний саяны ярьдаг бол ерөнхий хуулийн ерөнхий зохицуулалтын талаар байсан. Одоо тодорхой хэдэн маргаан дагуулсан зүйл, заалтуудын талаар ярья.

Нэгдүгээрт Энхбаяр сайд ярьсан. Ерөнхий хуулийн 5.1.1-ийн захиргааны байгууллагыг тодорхойлсон тодорхойлолт дотор Засгийн газар буюу гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх дээд байгууллага орох юм уу? орохгүй юм уу? гэж. Энэ асуудалтай холбоотой маргаан, шүүхийн шийдвэр хүртэл гарсан байгаа. Би хувь хүний байр сууриа илэрхийлж болохгүй байгаа. Дараа нь шүүх дээр ийм асуудал үүсдэг учраас ер нь бол энэ тийм маргаантай асуудал биш. Өөрөөр хэлбэл ямар тохиолдолд Засгийн газрын шийдвэр, үйл ажиллагаа Захиргааны ерөнхий хуулийн хяналт буюу ер нь хуулийн хяналтад байх ёстой юм? Ямар тохиолдолд байхгүй юм гэдгийг онолын тайлбар хийх журмаар хийх боломжтой. Тухайлах юм бол Засгийн газар өөрөө бол миний ойлгож байгаагаар 90% захиргааны байгууллагын, магадгүй 10% улс төрийн шийдвэр гаргадаг байгууллага мөн. Тэгэхээр ерөнхий хуулийн өөрийн нь агуулгыг бүрэн ашиглаж чадах юм бол энэ үүсээд байгаа тодорхой тохиолдлыг шийдээд явах боломжтой. Түүнээс биш Засгийн газар ерөөсөө шүүхийн хяналтад байна гэж ойлгож болохгүй. Харин хяналтыг хэрэгжүүлж байгаа этгээд нь шүүх юм. Цаад эрх нь зөрчигдөж байгаа этгээд эрхээ хамгаалуулах хянуулах боломжтой байна уу? гэдэг л асуудал.

Хоёр дахь асуудал ерөнхий хуулийн 47.1.6 бол захиргааны актыг ямар тохиолдолд илт хууль бус гэж тооцох бэ? Үүний нэг үндэслэл байгаа. Иргэн, хуулийн этгээдийн эрх хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байгаагүй гээд. 47.1.6-ийн зохицуулалт маргаан үүсгээд байгаа. Яагаад маргаан үүсээд байна гэхээр хөөн хэлэлцэх хугацаанаас тойрох хандлага нэлээн байгаа. Хөөн хэлэлцэх хугацаа алдсан дээрээ 47.1.6-г барьж маргадаг. Тэгэхлээр илт хууль бус тооцох энэ зохицуулалт бол уг нь их тодорхой. Илт хууль бус уу? үгүй юу гэдэг дээр маргах аргагүй байх ёстой. Хэрвээ энэ илт хууль бус биш ч юм шиг, мөн ч юм шиг болоод ирвэл энэ илт хууль бус биш байх ёстой. Энэ нь хүчингүй болгох захиргааны актаасаа үр дагавраараа илүү ялгаатай байдаг учраас энэ дээр нэлээн маргаан гардаг.

Remove Watermark Now

Мөн Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 1-ийг 47.1.6-тай цуг хэрэглэх ёстой. Захиргааны үйл ажиллагаа хуулиас эх авсан, тодорхой тохиолдол үүссэн үед шийдвэр гаргах ёстой.

Мөн 50.1, 50.2 гэсэн зохицуулалт шинээр орж ирсэн. Энэ нь захиргааны акт гараад үйлчлээд актад гомдол гаргах хугацаа дууссан тохиолдолд захиргааны шийдвэр гаргах ажиллагааг дахин хийх. Үүнтэй холбоотой маргаан бас гарсан байна.

Төгсгөлд нь хэлэх нэг зүйл бол энэ судалгаан дээрээс харвал ерөнхий хууль бусад хуулиудын өрсөлдөөнтэй байдал, аль хууль нь хэрэглэгдэх бэ? Ямар тохиолдолд гэсэн асуудал үүсэж байна. Үүн дээр ерөнхий хуулийн 3.3 зэрэг заалтуудыг харах хэрэгтэй. Шийдвэр гаргах эрх бүхий байгууллага шийдвэр гаргаад гаргасан шийдвэрт гомдол гаргаад гомдол нь хангагдаагүй бол шийдвэр хэрэгждэг байх ёстой. Харин гаргасан шийдвэрээ хэрэгжүүлэх гэхээр яаж хэрэгжүүлэх бэ? гээд асуудал үүсдэг. Үүнийг шийдэхийн тулд захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаа гээд бүхэл бүтэн бүлэг орж ирсэн. Одоо ямар асуудал байна гэхээр захиргааны байгууллагын шийдвэрийг биелүүлэх байгууллага байхгүй байна гэсэн асуудал яригдаж байна. Энэ асуудлыг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар гаргасан захиргааны эсрэг гаргасан шийдвэрийг биелүүлэхтэй хольж болохгүй. Хэм хэмжээний актын талаар маргаан нэлээн байгаа. Хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө 119 дүгээр тогтоолын харьяалалд ордоггүй байсан бие даасан агентлаг, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын шийдвэрийг яах бэ? гэдэгтэй холбоотой маргаанууд нэлээн байна. За миний мэдээлэл энд хүрээд дуусч байна. Амжилт хүсье.

**Уулзалт, ярилцлагыг чиглүүлэгч**: **ХЗДХЯамны ЗХХАХБХ-ийн ахлах мэргэжилтэн Э.Сэлэнгэ:** Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой хууль хэрэглээний явцад манай захиргааны байгууллагуудаас гаргасан шийдвэртэй холбоотой гарсан маргаан шүүхийн хяналтад орж хянагдах явцад болон шүүх шийдвэрээ гаргахдаа энэ хуулийн хэрэглээний явцад хийгдсэн судалгааны дүнг товчхон байдлаар танилцуулж, мэдээлэл өгсөн Ц.Цогт шүүгчдээ баярлалаа.

Өнөөдрийн уулзалт ярилцлагын гол хэсэг рүүгээ бид орж байна. Одоо бүгдээрээ Захиргааны ерөнхий хуулийг хэрэглээд явж байхад ямар хүндрэл бэрхшээлтэй асуудлууд гарч байна гэдгийг ярилцах цаг эхэлж байна. Тэгэхээр Захиргааны ерөнхий хуулийн ажлын хэсэгт зөвлөхөөр ажилласан Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, доктор, профессор П.Одгэрэл, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Ц.Цогт, доктор Д.Сүнжид багш, Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн дарга Д.Ариунтуяа нарыг урьд зассан суудлуудад суухыг урьж байна. Эдгээр хүмүүсээс та бүхэн Захиргааны ерөнхий хуулийг хэрэгжүүлэх явцад гарч байгаа хүндрэлтэй асуудлаа асууж тодруулаад, ярилцаад явъя. Мөн захиргааны хэм хэмжээний актын тухайд манай хэлтсийнхэн байгаа тул хариуцсан байгууллагын асуултад хариулт авах боломжтой байгааг бас хэлье.

**Чөлөөт ярилцлагын цаг**.

**Асуулт: Харилцаа холбооны зохицуулах хорооны Захиргааны удирдлагын хэлтсийн дарга Эрдэнэбулга:** Та бүхний энэ өглөөний амгаланг айлтгая. Захиргааны ерөнхий хууль батлагдсантай холбогдуулаад манай салбар дээр 2001 оноос хойш технологийн салбар дээр бодлого, чиглэл болон баримт бичгийг гаргаж явж байна. Ерөнхий хуулийн төсөл боловсруулж байсан ажлын хэсгийн гишүүдээс асуух гэсэн юмаа? Энэ бол миний хувийн бодол шүү. Монголчууд бол Ром-Германы эрх зүйт системтэй улс байдаг. Гэтэл энэ Захиргааны ерөнхий хуулийг харахад Англи-Саксоны эрх зүйтэй хууль юм шиг харагдаад байна. Хэт нарийвчилсан заалттай. Учир нь бид одоо холбогдох хуулиудаа бүгдийг нь нарийвчлан ийм ийм журмыг тусгайлан эрх олгосон заалт тусгахаар явж байна. Одоо яг ямар гажуудал үүсээд байна вэ? гэвэл бид зөвхөн Монгол Улсын хувьд хараад байдаг. Гэтэл манай салбар бол өөрөө глобал дэлхийн хувьслыг бид тооцоолж чаддаггүй. Мөн техникийн шаардлагуудыг

Remove Watermark Now

стандартаар тохируулна гээд байдаг. Гэтэл техникийн шаардлагууд тухай болгондоо шинэчлээд яваад байгаа. Эдгээр техникийн шаардлагуудыг хуулинд томьёолох боломжгүй байгаад байдаг. Тэгэхээр яахын бэ? Бид Wi-Fi-тай холбоотой журам боловсруулаад хянуулж бүртгүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлэхэд ямар үндэслэлээр буцаасан бэ гэвэл Wi-Fi антеныг тохируулахыг хориглоно гэсэн заалтыг, мөн хориглосон заалт оруулсан байгаа нь танай салбар хууль давж хориглосон заалт тусгасан нь болохгүй гэж буцаасан байдаг. Гэтэл бид нийтийн эрх ашгийн төлөө нэг хүний тэр антеннын автомат горимыг яагаад хориглож болохгүй гэж?

Мөн Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйл дээр заасан байдаг. Хуулиар тусгайлан эрх олгосон байх гэж заасан байдаг. Гэтэл бид холбогдох хуулиндаа 70-аад журмыг бүгдийг нь ийм журам, ийм журам гэж нарийвчлан тусгах гэж байна. Мөн хүн болгоны мэддэг салбар болох Facebook болон интернет орчинтой холбоотой зохицуулалт хийх гэтэл хуулиар тусгайлан эрх олгосон заалт байхгүй болохоор хүнийг доромжлох, гүтгэгдэж л байдаг. Гэтэл зөрчлийн тухай хуулиар хүнийг гүтгэж болохгүй гээд заасан байдаг бөгөөд энийг хэн хэрэгжүүлдэг вэ? гэвэл цагдаагийн байгууллагууд болон хууль хяналтын байгууллагууд байдаг. Гэтэл танайх шалгаад өг гээд байдаг. Сүүлд нэг том хийсэн ажил гэвэл гар утасны хулгай сүүлийн үед дэндэж байна. Жилд 17000 өргөдөл, гомдол цагдаагийн байгууллагад ирж байна. Бид салбарынхаа хэмжээнд ярилцаж байгаад бүх техникийн зохицуулалтыг нь хийгээд 4 үүрэн оператортай ярилцаад хулгайд алдагдсан гар утсыг хэн нэгэн аваад сим картаа хийхэд таны гар утас энэ хэрэглэгчийн ийм дугаар дээр байна гэсэн системийг хийж байна. Гэтэл энэ системтэй холбоотой журмыг гаргах гэхээр боломжгүй болчхоод гацчихаад байгаад байна. Дахиад хэлэхэд манай салбар бол их онцлогтой олон улсын хэм хэмжээ тогтоосон цаанаасаа стандарттай юмыг бид Монгол Улсад авчирч Захиргааны ерөнхий хуульд нийцүүлж акт гаргаад санд бүртгүүлэх гэхээр хуульд эрх олгосон заалтгүй болчихоод байна.

**Хариулт: Доктор П.Одгэрэл**:Тодорхой санал гаргасанд баярлалаа. Захиргааны ерөнхий хууль бол их газрын буюу Германы хуулийн загвар бөгөөд тэр загварыг бид нутагшуулсан байгаа. Энэ бол Англи-Саксоных бишээ. Магадгүй шийдвэр гаргах ажиллагааг нэлээн нарийвчлан зохицуулсан тийм тал байгаа байх. Энэ нь харин Англи-Саксоны эрх зүйн бүлийн нөлөөлөл тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байж магадгүй бөгөөд ерөнхий хуульд хэм хэмжээний акттай холбоотой тэр бүлэгт орсон байхыг үгүйсгэхгүй ээ.

За харин 2 асуудлыг ярьж байна. Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлээр хуулиар хориглоогүй байхад та нар журмаараа хориглочихоод гээд. Тэгэхээр хуулийн заалтад тийм заалт орохын хувьд оруулсан. Уг нь бол энэ заалтын хувьд бид маргаж л байсан. Журам гэдэг бол тодорхой хэмжээний хязгаарлалт тогтоодог хүссэн, хүсээгүй тэгж байж л журам болно. Тийм болохоор бид энэ заалтаа эргэж харах зайлшгүй шаардлага байгаа байх.

Дараагийн асуудал нь хуулиар тусгайлсан эрх байхгүй гээд хэм хэмжээний актыг бүртгэж авахгүй байна гэсэн гээд. Түрүүн Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсээс хийсэн танилцуулга дээр нэлээн их ажил хийж байгаа гээд, магадгүй нийгэмд зайлшгүй шаардлагатай дүрэм журмыг гаргах хэрэгтэй болж байгаа бол Хууль зүй, дотоод хэргийн яамтайгаа ярилцаж байгаад салбарын хуулиуд дээр нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл хийх боломжтой.

**Хариулт: Шүүгч Ц.Цогт:** Тэгэхээр би ингэж бодож байна. Энэ асуудал өмнөх хэлэлцүүлэг дээр хөндөгдөж байсан. Тусгай зохицуулалт олгосон тохиолдолд хэм хэмжээний акт гаргана гэдэг чинь ямар учиртай юм бэ? гэж. Онол номын хувьд бид нар бол энэ хуулийг зохиосон ч юм байхгүй. Нийтлэг их газрын гэсэн тогтолцоотой улс орон харилцан нэг нэгнийхээ зохицуулалтыг аваад явдаг зохицуулалт юм. Хамгийн гол асуудал бол нь хэм хэмжээ тогтооно гэдэг бол өөрөө парламентын эрх хэмжээний асуудал байдаг. Хамгийн түрүүнд тавигддаг шаардлага гэвэл та хэрвээ хэм хэмжээ тогтоох гэж байгаа бол? хүний амьдралын хэв маягт өөрчлөлт зохицуулалт хийх гэж байгаа бол мөн эрхийг нь хязгаарлах гэж байгаа бол? та энэ эрхээ парламентаас заавал авсан байх ёстой. Харин парламентаас энэ эрхээ өгдөг юм нь юу вэ гэвэл хуулиар тодорхой

Remove Watermark Now

харилцаан дээр тодорхой шийдвэр нарийвчилсан зохицуулалт, хэм хэмжээ тогтоох эрхийг нь шилжүүлэх тухай ойлголт юм. Тийм учраас бид нар хүссэн ч, хүсээгүй ч парламентаас хэм хэмжээ тогтоох эрхийг шилжүүлж байгаа учраас энэ заалтыг барихаас өөр аргагүй юм. Энийг барьж байна гэдэг нь тухайлбал техникийн шинж чанартай, технологийн шинж чанартай нарийвчилсан тийм зохицуулалтыг хариуцсан яам, агентлаг нь зохицуулалт хийхийг үгүйсгэж байна гэсэн үг биш юм. Нэг зүйлийг анзаарсан уу? Ерөнхий хууль дээр стандартыг хэм хэмжээний акт дээр хамаарахгүйгээр зохицуулсан байгаа. Хэм хэмжээ тогтоох гэх юм уу, стандарт тогтоох гэдэг ч юм уу, техникийн шинж чанартай юмс дээр шууд хуулийн зохицуулалт гэхээсээ илүүтэй яам, агентлаг, байгууллагуудын өөрийн хуулиар олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд стандарт тогтоох эрх нь байх ёстой. Урьдчилсан бүртгэл хийж байгаа Хууль зүй, дотоод хэргийн яам шийдвэр гаргаж байгаа байгууллага 2 хоорондоо тэр томьёолол оо зөв хийх ёстой гэж бодож байна.

**Асуулт: Гадаадын иргэн харьяатын газрын Эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн ахлах мэргэжилтэн Бат:**_Манай байгууллага дээр Захиргааны ерөнхий хуультай холбоотой 2 асуудал үүсээд маргаантай байна. Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлийн сонсох ажиллагааны талаар. Төрийн албан хаагч амралтаа авчихаад алга болсон. Ажилдаа ирэхгүй хаана байгаа нь мэдэгдэхгүй 3 сарын дараа Солонгос улсад байгааг нь Facebook дээрээс мэдсэн бөгөөд холбогдож чадаагүй. Тэгээд ажилдаа ирээч ээ гэхээр хариу байхгүй. Ирэхгүй бол ажлаас чинь чөлөөллөө гэсэн ч хариу өгдөггүй. Энэ тохиолдолд энэ хуулиа харахаар сонсох ажиллагааг хийгээгүй бол халах боломжгүй болсон.

Дараагийн асуудал бол шүүхийн шийдвэрээр буцаж ажилдаа томилогдож байгаа албан хаагч мөн ажилдаа ирэхгүй алга болсон. Утсаа авахгүй холбогдож чадахгүй, илт зугтаж байгаа, шуудангаар гэрийнхэн нь хаягаар бас хүргүүлсэн боловч байхгүй. Энэ хаяг дээрээ ийм хүн байхгүй байна гээд шуудангаас буцаад ирдэг. Ингээд ерөнхий хуулийн 27 дугаар зүйл дээр байгаа сонсох ажиллагааг явуулах боломжгүй болчихоод байна. Түрүүн Ц.Цогт шүүгч хэллээ. Яг энэ асуудал шүүх дээр унаж байгаа гээд. Манай Захиргааны ерөнхий хууль маань захиргаандаа хэтэрхий халдсан заалттай, Хөдөлмөрийн тухай хуультай адилхан болсон байна. Бид чинь бас энэ хуулийг хэрэгжүүлнэ. Тийм болохоор хүндрэлтэй асуудлууд үүсэж байгаа болохоор ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт ороход анхааралдаа аваасай гэж хүсэж байна.

**Хариулт: Шүүгч Ц.Цогт:** Үнэхээр тийм асуудал үүсэхийг үгүйсгэхгүй. Би ч бас түрүүн энэ талаар ярьсан л даа. Зарим тохиолдолд өөрт нь ашиггүй шийдвэрийг авахгүй байх, бултах ч гэх мэт зүйл гарахыг үгүйсгэхгүй. Тэр тохиолдолд шүүхэд тухайн байгууллага өөрсдийнхөө нотлох баримтыг гаргахад л хангалттай.

**Хариулт: Доктор П.Одгэрэл**: За сонсох ажиллагаатай холбоотойгоор нэлээн ярьдаг л даа. Практик дээр нэг тогтмоор байгаамаа. Сонсох ажиллагааг хийхгүй байх тохиолдол гэээд. Өөрөөр хэлбэл яаралтай оруулах, хойшлуулшгүй бол нийтийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх бол гээд тийм тохиолдол байгаа бол шууд шийдвэрээ гаргаж болно ш дээ. Энэ бол цэвэр практик дээр зохицуулах асуудал гэж ойлгож байгаа. Жишээлбэл газрын харилцаан дээр ийм, ийм үед сонсох ажиллагааг хийхгүй, байгаль орчинд ийм үед сонсох ажиллагааг хийхгүй гээд яваандаа тогтох байхаа. Мэдээж энэ хууль зөвхөн иргэний эрхийг хамгаалах биш, захиргаа үйл ажиллагаагаа явуулах боломжоор хангасан аль болох баланс барихаар зохицуулсан байгаа.

Мөн мэдэгдэх гэж бас байна. Уг нь хуулиа сайн судлах хэрэгтэй байна. Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйл дээр байгаа захиргааны актыг шуудангаар явуулаад орон нутагт ажлын 10 өдөр нийслэлд 5 өдөрт явуулаад мэдэгдсэнд тооцно гээд, аль эсвэл хэвлэл мэдээлэл дээр нийтэлбэл мэдэгдсэнд тооцно гэсэн зохицуулалт байгаа шүү.

**Асуулт: ОБЕГ-ын хуулийн зөвлөх н.Мөнхбат:**_Яг энэ эрх зүйн зохицуулалт дээр сонсох ажиллагаан дээр нэг дутагдалтай зүйл байгаад байна. Сонсох ажиллагаа явуулаад эхлэхэд нөгөө хүн маань алга болчихдог. Улсын хэл давaад зугтаад алга болдог. Илт

Remove Watermark Now

зугтаадаг, хүлээж авахаас. Сонсох ажиллагаа гэдэг маань ерөнхий хуулийн 43 дугаар зүйл чинь шийдвэр гарсны дараа мэдэгдэх асуудал болохоос биш сонсох ажиллагаа биш байхгүй юу? Тэгэхээр сонсох ажиллагаа явуулах гэхээр тайлбар мэдэгдэл гаргах боломж нь байгаад байдаг. Гэтэл нөгөө хүн илт зугтаад байгаа болохоор нөгөө хүндээ мэдэгдэх боломжгүй байгаад байдаг. Энэ дээр ганц зохицуулалт нь байхгүй байгаа нь ямар хугацааны дараа бид нар сонсох ажиллагаа явуулснаас хойш ямар хугацааны дараа захиргааны шийдвэр гаргах ёстой юм бэ?

Дараагийн нэг асуудал юу вэ гэвэл Захиргааны ерөнхий хуулийн шийтгэл оногдуулах хэсэг байна. Энэ Төрийн албаны тухай хуультай илт зөрчилдсөн зохицуулалт байгаад байна. Төрийн албанаас 10 жил эргэж орж ирэхгүйгээр халах гэсэн сахилгын шийтгэл байгаад байна л даа. Гэтэл төрийн албан дээр 1 жил эргэж орж ирэхгүй гээд байж байгаа. Шинэ хуулиар бол 3 жил хүртэл гээд байж байна. Тэгэхээр хүлээлгэж байгаа хугацаа маань олон болчихлоор аль заалтаа барих гэх мэт хүндрэлтэй нөхцөл байдал үүсгээд байна.

Мөн дараагийн нэг асуудал нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйл дээр иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ гээд зохицуулалт байгаад байна. Гэтэл энэ заалтыг харахаар зөвхөн албан тушаалтанд хандаад гаргасан заалт байгаад байдаг. Түрүүн Ц.Цогт шүүгч хэлж байсан улс төрийн нөхцөл байдлаас болоод буугаад яваад өгсөн байдаг. Ийм үед бид хэнд хандах уу гэдэг асуудал гарч ирээд байна. Нөгөө албан тушаалтан чинь ажлаа өгчихлөөр зүгээр л иргэн болчихоод байна. Тэгээд энэ хуулиа барихаар албан тушаалтан биш болчихоод байна. Иймд энэ заалтын хүрээнд иргэн, хуулийн этгээд ч гэдэг юм уу,эсхүл албан тушаалтан дээр давхар оруулаад өгчих боломж байгаа болов уу?

**Хариулт: Шүүгч Ц.Цогт:** За шууд сүүлийн хэсгээс хариулъя. Хувь этгээдэд хариуцлага ногдуулах зохицуулалт байгаа ш дээ. Тийм болохоор ажлаа хаяад явсан байна уу? зугтаад явсан байна уу? тэр бол тийм сонин зүйл биш байх л даа. Тухайн үед бүрэн эрх хэрэгжүүлж байсан ямар этгээд байдгийн? гэдгээс хамаарна. Хэрвээ хамтын удирдлагатай байгууллагуудад ч гэсэн заавал хүн халах биш өөр шийдвэрээр иргэн, захиргааны байгууллагад сөрөг үйлчлэлтэй шийдвэр гаргаад хохирол учруулж болно ш дээ. Тэгвэл тэр шийдвэр гаргасан этгээд нь хариуцлагаа хүлээнэ ш дээ. Захиргаа гэхээсээ илүүтэй захиргааны албан тушаалыг хашиж байгаа хувь этгээдийг илүү хариуцлагажуулах шинжтэй зохицуулалтыг оруулсан юм. Яахав зарим хүмүүс энэ хэсгийг ор тас хүлээн зөвшөөрдөггүй л дээ. Яагаад тэгж хэлж байна вэ гэвэл энэ зохицуулалт хэрвээ ороод ирвэл захиргаа шийрэгнээд шийдвэр гаргаж чадахгүй болж байна гэж ярьдаг ш дээ тээ? Шийдвэр гаргаж чадахаа болиод зарим улсуудад хорьдог юм байна лээ. Манайд бол захиргааны байгууллага өөрөө тогтворгүй, хариуцлагагүй байдаг.

Шийтгэл оногдуулах хэсэг дээр бол тухайн хуулийнхаа зохицуулалтыг зөрчсөн зөрчилд тухайн хуулиараа ногдуулж байгаа хариуцлагаа хүлээлгээд явна. Жишээ татая. Төрийн албаны тухай хуулийг зөрчөөд үндэслэлгүйгээр халагдсантай холбоотойгоор ч юм уу? аль эсвэл төрийн албан хаагчдын үр дүнг бодитойгоор дүгнэх ёстой байтал нэг шинэ дарга ирээд 30 тавих ёстой байсан үнэлгээг 10 гэж тавиад л үр дүнгээрээ гээд ингээд бодитой үнэлээгүй гээдгээрээ тэр хуулиараа заасан хариуцлагаа хүлээнэ. Харин Захиргааны ерөнхий хуулийг зөрчсөн зөрчил гаргасан зөрчлийн хэр хэмжээнээс хамаараад ерөнхий хуулинд заасан тэр хариуцлагыг хүлээнэ. Хуулиудыг хоорондоо зөрчилдөж байнаа гэхээсээ илүүтэй тухай зөрчил гарсан харилцаа өөр өөр байгаа тухайн хуулийн хариуцлагыг хүлээх зохицуулалт байгаа.

**Хариулт: Доктор П.Одгэрэл**:Сонсох ажиллагаан дээр хугацаа нэмж оруулъя гэж ярьж байна. Тэгэхээр Захиргааны ерөнхий хуулинд нэг зовлонтой юм байдаг. Энэ хууль чинь өөрөө бүх хуульд үйлчилдэг болохоор хэтэрхий нарийвчилсан зохицуулалт тусгах боломжгүй байгаа. Өөрөөр хэлбэл төрийн албатай холбоотой сонсох ажиллагаа, тусгай зөвшөөрөлтэй холбоотой сонсох ажиллагаа ч юм уу зайлшгүй байх шаардлагатай болчихоод байгаан. Тийм ч учраас

Remove Watermark Now

захиргааны актыг мэдэгдэх зохицуулалтыг сонсох ажиллагаан дээр төсөөтэй хэрэглэх боломжтой гэж үзэж байгаа.

За мөн сахилагын шийтгэлтэй холбоотой хугацааны асуудал нь Төрийн албаны шинэ хуультай холбогдуулж яриад байгаа тийм болохоор энэ бас тодруулж, эргэж харах хэрэгтэй болоод байгаа.

**Уулзалт, ярилцлагыг чиглүүлэгч: ХЗДХЯамны ЗХХАХБХ-ийн ахлах мэргэжилтэн Э.Сэлэнгэ:** Цайны завсарлага 15 минут.

**Уулзалт, ярилцлагыг чиглүүлэгч: ХЗДХЯамны ЗХХАХБХ-ийн ахлах мэргэжилтэн Э.Сэлэнгэ:** Чөлөөт ярилцлага үргэлжилж байна. Асуулт байна уу?

**Асуулт: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын хуулийн хэлтсийн дарга Э.Эрдэнэхишиг:** Юуны өмнө энэхүү уулзалт ярилцлагыг зохион байгуулсанд баярлалаа. Хуулийн хэрэгжилтийн талаар санал солилцох боломж ховор байдаг. Миний бие 4 асуудал дээр санал хэлмээр байна.

1. Захиргааны ерөнхий хуульд төрийн захиргааны байгууллага захиргааны хэм хэмжээний акт гаргахдаа бусад төрийн захиргааны байгууллагын саналыг авахаар заасан байна. Гэтэл хэм хэмжээний акт гаргаагүй мөртлөө бусад хэм хэмжээ тогтоогоогүй гаргаж байгаа шийдвэрүүд нь бусад төрийн захиргааны байгууллагын гаргаж байгаа шийдвэртэй зөрчилдөх, нийцэхгүй байх тохиолдлууд гардаг. Иймээс энэ байдлыг тус хуулийн өөрчлөлтийг хийхдээ нэмж тусгах шаардлагатай. Тухайлбал: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын тогтоолоор төрийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийг баталдаг. Компанийн дүрэмд тухайн компанийн үйл ажиллагааны үндсэн хүрээг тодорхойлдог. Гэтэл сайдын тушаалаар энэ байгууллагын энэ үйл ажиллагааг шилжүүлэх гэх мэт шийдвэр гаргадаг. Энэ нь хамтын удирдлагатай байгууллагын гаргасан шийдвэр биелэгдэх боломжгүй болдог. Энэ асуудал буюу захиргааны байгууллагаас албан ёсоор санал авахгүй шийдвэр гаргаад байгаа нь практик дээр байсаар байна.

pdfelement

2.Захиргааны шийдвэрийн хяналтын хуудас болон дагалдах хуудасны асуудал. Энэ нь захиргааны байгууллагуудад ачаалал нэлээн нэмж байна. Яг ямар шийдвэрт хөтлөх гэдгийг нарийн тодорхойлж, заагламаар байна. Захиргааны бүх шийдвэрт гэхээр амжихгүй, боломжгүй байдал үүсч байна. Цаашид ач холбогдол багатай шаардлагагүй шийдвэрт хувийн хэрэг хөтлөх нь захиргааны байгууллагуудад нэмэлт ачаалал үүсгэж байгааг эргэн хармаар байна.

3.Хуулиар тусгайлан эрх олгох тухай Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйлийн талаар. Энэ асуудал манай байгууллагад тулгамдсан асуудал. Одоогийн байдлаар зарим асуудлаар ЗГХЭГ болон ХЗДХЯ-аас зөвлөгөө авсны үндсэн шийдвэрүүдээ батлаад ажиллаж байна. Хамгийн гол нь үйлчлэх этгээдүүдийн тоо тодорхой байгаа нөхцөлд тухайн байгууллага хэм хэмжээний актаа гаргаад мөрдүүлж болно гэсэн зохицуулалтыг оруулмаар байна. Бид энэ талаар зөвлөгөө авъя гэхээр хуулиа шинэчил гэдэг. Хуулин дээрээ ажиллаж байгаа ч төрийн захиргааны байгууллагын хувьд удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлж байгаа доод шатны байгууллагуудад зориулсан шийдвэрийг гаргаж болохоор байлгах талаар хуульд өөрчлөлт оруулах тал дээр анхаарч үзнэ үү.

4.Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн талаар. Захиргааны байгууллагын дур зоргоор авирлах асуудлыг хязгаарлая гэсэн хуульд нийцүүлэх гэсэн буруутай шийдвэр гарсан этгээд өөрөө хохирол барагдуулдаг байдал. Захиргааны байгууллагууд энэ асуудал үр дүнтэй ажиллах ёстой гэж бодож байна. Хууль батлагдсанаас хойш буруутай этгээд өөрөө хохирлыг барагдуулсан тохиолдлууд хэд гарсан бол гэдэгт анхаарч үзсэн үү.

**Асуулт: Цаг уур орчны шинжилгээний газрын мэргэжилтэн н.Чагнаадорж:** Ц.Цогт шүүгч та шүүгч гэдэг утгаараа бус ажлын хэсгийн гишүүн гэдэг утгаараа тайлбарламаар байна.

Remove Watermark Now

**Хариулт: Шүүгч Ц.Цогт**:Саналыг хүлээн авлаа. Хүмүүсийн саналыг хуулийн ажлын хэсгээс тэмдэглэл хөтөлж байгаа. Тэмдэглэлд бүх саналыг тэмдэглээд боломжийн хэрээр тусгаад явах байх

**Асуулт: ОБЕГ-ын хуулийн зөвлөх н.Мөнхбат:** Захиргааны ерөнхий хуулийн 104 дүгээр зүйлд хохирлыг барагдуулах гэсэн зохицуулалт байна. Харин Иргэний хуульд гэм хорыг арилгах талаарх зохицуулалт байдаг. Нөхөн олговор, нөхөн төлбөр гэсэн зохицуулалт бас байна. Иргэний хуулиар бол гэм хорыг арилгах гэдэг асуудал бас байгаа. Нэр томьёоны хувьд энэ байгаагаараа явах уу. Үүнтэй холбоотойгоор Даатгалын тухай хуульд даатгагч нь даатгуулагчийн өмнөөс учирсан гэм хорыг арилгахын төлөө хийж байгаа үйл ажиллагааг даатгал гэж ойлгодог. Энэ асуудлыг захиргааны ерөнхий хуулинд зохицуулалттай нь тусгаж өгөх боломжтой юу. Практик дээр энэ асуудлыг авч хэлэлцдэггүй. Танайхаас гараагүй даатгалаас гарсан санхүүжилт байна гэж үзээд байх тохиолдол байна. Иймээс нөхөн олговор болон хохирол төлүүлэх харилцааг даатгалтай яаж холбож зохицуулах боломжтой вэ. Хуулинд тусгаж болох уу?

**Хариулт: Шүүгч Ц.Цогт**:Хуулийн 104 дүгээр зүйлийн томьёолол дээр анхаарах, Иргэний хуульд нийцүүлэх гэж байх шиг байна. Хууль зүй, дотоод хэргийн яамныхан хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа анхаарна байх. Гэхдээ гэм хор гэдэг бол гэм буруутай үйлдлийн улмаас учирсан хохирлыг төлүүлэх асуудал болно. Харин Захиргааны ерөнхий хууль нь захиргааны байгууллагын хууль ёсны болон хууль бус үйл ажиллагааны улмаар учирсан хохирлын талаар болно. Тухайлбал: Иргэний өмчлөлийн газар нь дүүргийн газар зохион байгуулалт хийх, замын трасст орох тохиолдол байна. Энэ тохиолдолд тус дүүргийн иргэний өмчлөлийн газрыг нөхөн төлбөртэйгөөр эргүүлэн авах шийдвэр хууль ёсных байдаг. Энэ үед хохирлын хэмжээн дээр маргаан үүсдэг. Иймээс зөвхөн буруутай үйлдлийн улмаас учирсан гэм хор гэж томьёолох боломж байхгүй. Гэхдээ нэр томьёон дээр ХЗДХЯ ажиллах байх, мөн УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны дэргэд нэр томьёоны алба байгаа түүн дээр ажиллах байх. Мөн Хохирлын сангийн тухай хуулийн төсөл боловсруулагдаж байсан. Тэр хуулийн төсөл 104.2-тэй нэлээн уялдах байсан. Гадны улсад хохирлын сан гэж байдаг. Гэтэл манай улсад иргэний хохирол барагдуулах төсөв нь аль ч байгууллагын төсөвт тусгагддаггүй. Харин тэр Даатгалын асуудлыг хэлж мэдэхгүй байна.

pdfelement

**Хариулт: Доктор Одгэрэл:**Нөхөх олговор гэдэг бол Үндсэн хуулийн нэр томьёо болно.

**Асуулт: МХЕГ-ын хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн н.Мөнхбаяр**: Нэг асуудал байгаа нь илт хууль бус актын талаар юм. Гомдол гаргах, хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй гэж заасан. Үүнтэй холбоотойгоор асуудлууд гарсан. Шүүх дээр ч гарсан байх. Энэ хууль батлагдахаас өмнө гарсан шийдвэрт тухайн үед нь гомдол гаргаагүй мөртөө хууль үйлчилж эхэлсний дараа илт хууль бус гэж гомдол гаргаад, улмаар шүүхэд хандах тохиолдол гараад байна. Тухайн үед шийдвэр гаргасан албан тушаалтнууд нь ажлаасаа гарах, тэтгэвэрт гарах зэргээр байхгүй, цаашлаад холбоотой нотлох баримтууд нь байхгүй болсон байдаг. Түүнчлэн Захиргааны ерөнхий хууль үйлчилснээр л тухайн шийдвэрт хувийн хэрэг үүсгэх болсон. Түүнээс өмнө ийм асуудал байгаагүй тул нотлох баримт цуглуулах боломжгүй болоод байна. Энэ асуудал нь шүүх дээр нэг жилийн турш үргэлжлэх тохиолдол байна. Зарим нь илт хууль бус акт, зарим нь хууль бус маргаан болж шийдвэрлэгдэж байна. Энэ бүгдийн цаана хамгийн гол нь Монгол Улсын төсөвт орох ёстой их хэмжээний мөнгө орохгүй байх тохиолдол гарч байна. Иймээс илт хууль бус акт гэж үзэх, түүнд гомдол гаргах асуудлын ялгавартай байлгамаар байна. Эсхүл дагаж мөрдөх журмын тухай хуулиар зохицуулах ёстой байсан. Миний бодлоор хэм хэмжээний актуудад илт хууль бус актад хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй. Харин эрх бүхий албан тушаалтын гаргасан актад хөөн хэлэлцэх хугацааг хязгаарлах асуудал байж болохоор өөрчлөх санал гаргаж байна.

Дараагийн нэг асуудал бол хуулийн 48 дугаар зүйл. Хууль бус актын хөөн хэлэлцэх хугацаа 5 жилээр тусгасан. Шүүх гомдлыг хүлээн авах боломжгүй гэсэн. Нэгэнт хүлээн авах боломжгүй гэсэн байхад хөөн хэлэлцэх хугацаа захиргааны байгууллагад адилхан тавьж

Remove Watermark Now

болохгүй юу. Өргөдөл гомдлын тухай хуулиар бас хугацаа тогтоосон. Хэд хэдэн хуулиар хугацаа тогтоосон заалтуудыг оруулсан байгааг нэг мөр тодорхой болгох тал дээр анхаарч ажилламаар байна.

**Хариулт: Доктор Одгэрэл:** Захиргааны байгууллага өөрөө санаачлагаараа алдаагаа засах боломжийг олгож байгаа. Сонгуулийн хугацаа 4 жил байдаг тул шинээр гарч ирсэн албан тушаалтнууд өмнөх албан тушаалтны хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, засах боломж олгох гэсэн санаагаар хуульд тусгасан. Таны өгсөн саналыг тэмдэглэж аваад хугацааг жигдлэх боломжийг судлах байх.

**Хариулт: Шүүгч Ц.Цогт:** Илт хууль бус актад хөөн хэлэлцэх хугацаа тооцохгүй гэснээр шүүхэд хандах тоо ихэссэн нь үнэн. "Илт хууль бус" гэдгээр хандах юм бол хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй гэдгийг хуульчид маань гарц гэж хараад байх шиг байна. Бид үүнийг хуульчид болон өмгөөлөгчдийн сургалтад байнга хэлж байгаа. Илт хууль бус захиргааны актад тооцуулна гэдэг бол маш хүнд, нотлоход хүнд, маш цөөн тохиолддог. Харин хөөн хэлэлцэх хугацааг тогтоолгох, тооцуулах, хуулийн зөрчилтэй байна гэж тооцуулах бол илт хууль бусад тооцуулахаас хамаагүй хялбар, өргөн боломжтой, илүү сайн хамгаалалтын хэлбэр юм.

Захиргааны ерөнхий хуулийн 48.2-т заасан хугацаа практикаас үүдэлтэй. Хотын захирагч солигдоод 10 жилийн өмнө олгогдсон байсан маш олон газар олгосон шийдвэрийг хүчингүй болгосон. Энэ бол газар авсан иргэндээ эерэг үр дагавар бүхий акт. Хэрэв иргэнд эерэг үр дагавар бий болгосон байвал захиргаа өөрөө 5 жилийн дотор л хүчингүй болгоно гэсэн зохицуулалт юм. Энийг зөвхөн захиргаа санаачлагаараа хийнэ.

**Асуулт: ОӨУБЕГ-ын эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн н.Чимаа:** Хуульд заасанаар улсын бүртгэгчийн гаргаж байгаа шийдвэр захиргааны акт болж байна. Бүртгэгчийн хууль бус шийдвэр гаргаснаас захиргаанаас санаачлаад Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээх гэтэл тус хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн байсан. Харин Захиргааны ерөнхий хуулийн 105 дугаар зүйлийн дагуу хариуцлага ногдуулах нөхцөл байдал үүсэхэд энэ хуульд хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт байхгүй байна. Иймээс ямар хуулийг баримталж 105 дугаар зүйлийн дагуу хариуцлага тооцох вэ. Энэ талаар Захиргааны хэргийн шүүхээс тодруулга авахад энэ талаар шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг байхгүй, тодорхой хариу өгөөгүй. Иймд хөөн хэлэлцэх хугацааны талаар тодруулж өгнө үү.

**Хариулт: Шүүгч Ц.Цогт:** Энэ асуудал дээр хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалт хийгээгүй. Шүүхийн практикаар шийдвэрлэгдээд явах байх. Хариуцлага хүлээлгэх асуудлыг хэн санаачлах эрхтэй гэдэг талаар хууль бус актын улмаас өөрийн нь эрх ашиг хөндөгдсөн иргэн тухайн албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар хүсэлт, гомдол гаргасан тохиолдолд гарна. Энэ хууль бол төрийн албан тушаалтан доод шатны албан тушаалтанд хариуцлага ногдуулдаг хууль биш. Тухайн албан тушаалтан алдаа гаргасан бол Төрийн албаны тухай хуулиар шийдвэрлэгдэх тул тэр хуульд заасан хугацааг баримтална.

**Асуулт: Гадаадын иргэн харьяатын эрх зүй, гадаад харилцааны хэлтсийн ахлах мэргэжилтэн Бат:** Манай байгууллагын даргын тушаалаар гадаадын иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлдэг. БГД-ийн Иргэний шүүхийн шүүгчийн захирамжаар гадаадын иргэнийг хилээр гарахыг түдгэлзүүлсэн захирамж ирснийг манай байгууллага бүрэн эрхийнхээ дагуу гарахыг түдгэлзүүлсэн шийдвэр гаргасан. Гэтэл өмгөөлөгч нь Иргэний шүүхээс ирүүлсэн шийдвэрийн дагуу гаргасан шийдвэрийг биелүүлэхдээ сонсох ажиллагаа явуулаагүй гэх үндэслэлээр манай байгууллагыг Захиргааны шүүхэд өгсөн. Энэ бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны нэг хэсэг гэж тайлбарласан боловч хэрэг үүсгэсэн. Иргэний шүүхийн захирамжийг зөв буруу эсэхийг Захиргааны шүүх шүүхээр болсон. Иймэрхүү асуудал гарах тохиолдолд хэрхэх?

**Хариулт: Шүүгч Ц.Цогт**: Шүүхийн шийдвэрийн дагуу хийж байгаа үйл ажиллагаа бол захиргаа өөрөө санаачлагаараа хийж байгаа ажил биш болно. Тэр шийдвэрт гомдол гаргах эрх

Remove Watermark Now

нь байж болно. Харин хүлээж авч байгаа шүүх нь захиргаа өөрөө гаргасан шийдвэр үү, шүүхийн шийдвэрийн дагуу биелүүлсэн шийдвэр үү гэдгийг ялгаж салгах ёстой.

**Асуулт: ОБЕГ-ын хуулийн зөвлөх н.Мөнхбат:** Захиргааны ерөнхий хуулийн 29.2-т захиргааны шийдвэрийн хувийн хэрэгт шийдвэр гаргахад оролцсон байдал нь шийтгэл оногдуулах, шагнуулах үндэслэл болох талаар зохицуулалт. Тухайлбал: ажилтныг ажлаас халсан шийдвэр гаргаад тэр нь шүүх хандан эргүүлж томилох шийдвэр гаргуулж, тухайн байгууллага ажиллаагүй хугацааны төлбөр төлөх тохиолдлууд нийтлэг байна. Энэ үед шийдвэр гаргахдаа шийдвэрт оролцсон байдлыг тогтоох шаардлага гарна. Оролцсон байдлаас хамаарч сахилгын шийтгэл ногдуулах байдал бий болно. Захиргааны байгууллага халсан хүний оронд шинэ ажилтан авч ажиллуулсан байдаг. Төлбөрийн асуудал гарахаар тусгайлан төсөвт ийм зардал байхгүй. Тухайн байгууллага шийдвэр гаргасан хүнээс төлбөр олж авах асуудал. Холбогдох хүндээ сахилгын шийтгэл авсан, мөнгөн төлбөрийг бас гаргуулах асуудал байна энэ асуудлыг яаж шийдвэрлэх вэ.

Өөр нэг санал хэлмээр байна. Хуулийн 3 дугаар зүйлд заасан үйлчлэх хүрээний асуудал гамшиг, ослын үед гаргасан захиргааны шийдвэрийг хамаарахгүй байхаар тусгаж өгнө үү. Тухайлбал: галын машин айлын хашааг эвдэж нэвтлэн зайлшгүй гал унтраах гэх мэт тохиолдол.

**Хариулт: Доктор Одгэрэл:** Хууль үйлчлэхгүй гэхээр шүүхийн хяналтаас гадуур байна гэсэн үг. Бүгд хуулийн дор байх Үндсэн хуулийн зарчим байна. Энэ зарчим, шаардлагаар таны хэлсэн асуудлыг хуулийн үйлчлэлээс хасах боломж хязгаарлагдмал.

**Хариулт: Шүүгч Ц.Цогт:** Эхний асуултад хариулахад хариуцлага ногдуулах харилцаа нь иргэний хүсэлт дээр үндэслэсэн байвал зохилтой харилцаа юм.

Дараагийн асуудал онцгой тохиолдолд зарим ажиллагааг явуулахгүй шийдвэр гаргах эрх нь хуульд угаасаа туссан байгаа. Зарим процессын ажиллагааг хийхгүй байх боломж байгаа. Түүгээр явна.

pdfelement

**Асуулт: НОБГ-ын хуулийн зөвлөх Даваасүрэн:** Онцгой ажиллагааг үйлчлэхгүй харилцаанд оруулах асуудлыг дахин харах хэрэгтэй гэж бодож байна. Байгалийн гамшигийг хэззэ ч, ямар ч хууль зохицуулахгүй тул хуулийн үйлчлэлээс хасуулах саналтай байна. Өөр нэг асуудал бол хуулийн 5.1-д “Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг дараах нийтийн эрх зүйн этгээдийг захиргааны байгууллага гэж ойлгоно” гэж заасан. Нийслэлийн онцгой байдлын газар босоо удирдлагатай байгууллага. НЗДТГ-ын харьяа хэрэгжүүлэгч агентлаг. Нөгөө талаар Онцгой байдлын ерөнхий газартаа харьяална. Ингээд бид 2 байгууллагын алийг нь дагахаа мэдэхээ больдог. МХЕГ, ЦЕГ гэх мэт манайхтай адил. Аль байгууллагын удирдлагыг дагах зохистой вэ?

**Хариулт: Шүүгч Ц.Цогт:** Энэ асуудал бол салбарын хуулиар зохицуулах асуудал. Мэргэжлийн удирдлагаар хангаж байгаа байгууллага чинь дээд шатны байгууллага нь болно. Өөрөөр хэлбэл таны гаргаж байгаа шийдвэрийг хянах, хүчингүй болгох эрх бүхий байгууллага юм.

Харин хуулийн үйлчлэх хүрээ буюу 3.1.4 дэх заалтын талаар өмнө нь тайлбарласан болно.

**Асуулт: Зэвсэгт хүчний жанжин штабын хуулийн зөвлөх Эрдэнэ-мөнх:** Хуулийн үйлчлэх хүрээтэй холбоотой 2 санал байна. Хуулийн үйлчлэхгүй харилцаа буюу 3.1.5-д “онц болон дайны байдал зарласан үед зэвсэгт хүчин ашиглах, цэрэг хөдөлгөх;” гэдэгт 2 асуудал орхигдсон байна. 1.Онц байдал, дайны байдал 2-ын дундах асуудал буюу дайн бүхий байдал. 2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар бүх нийтийн дайчилгаа /УИХ-аар баталгаажуулдаг/. Эдгээр 2 асуудал орхигдсоныг тусгаж өгөх боломжтой юу. Түүнчлэн Олон улсын энхийг сахиулах ажиллагаанд тодорхой тооны бүрэлдэхүүнтэй цэргийн баг явдаг. Тэнд ч

Remove Watermark Now

Монгол Улсын хууль тогтоомжоо дагаж мөрддөг. Багийн захирагч гэдэг хүн захиргааны шийдвэрээ гаргана. Энэ тохиолдолд Захиргааны ерөнхий хууль үйлчлэх үү.

**Хариулт: Шүүгч Ц.Цогт:** Цэргийн байгууллагын өөрийн дотоод харилцаанд энэ хууль үйлчлэхгүй. Харин танай байгууллагад харьяалалгүй иргэн болон танай байгууллага 2-ын хоорондын захиргааны шинжтэй харилцаанд үйлчилнэ. Таны эхний гаргасан саналыг хуулийн төсөл боловсруулах явцдаа харгалзан үзэх байх.

**Асуулт: МХЕГ-ын дотоод хяналтын ахлах байцаагч Отгон**: Манайд хуулиар эрх олгосон байцаагч нар байдаг. Тэдгээр байцагч нарын нэг нь нэгэн компанид Төрийн хяналт, шалгалтын тухай хуульд заасан журмаа зөрчөөд албан шаардлагаар дүгнэлт гаргасан. Тэгээд тэр дүгнэлтийг нь үндэслээд тэр этгээдэд эрүүгийн хэрэг үүсгэсэн байдаг. Тэгээд нөгөө хүн нь хэзээ хойно тэр актыг мэдээд Захиргааны хэргийн шүүхэд илт хууль бус акт байна гэсэн гомдол гаргасан бөгөөд тухайн шүүхээс илт хууль бус акт биш байна гэж шийдвэр гарсан байдаг. Тэгээд манайд хандахад илт хууль бус актад хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй гэдэг. Тэгээд энэ дагуу манайд гомдол гаргахаар бид нар Өргөдөл гомдлын тухай хуулиа харахаар тухайн асуудлаар шүүхийн шийдвэр гарсан бол хүлээж авахгүй гэж хариу өгдөг. Нөгөө хүн маань энэ асуудлаар шүүхээс илт хууль бус акт гэж шийдвэр гарсан тул танайх энэ асуудлаа шийдэж өг гээд байдаг. Бид одоо яг аль хуулиа барьж шийдэх ёстой вэ? нөгөө Өргөдөл гомдлын тухай хуулиа бариад суух уу? Захиргааны ерөнхий хуулиа үзэх ёстой юу?

**Хариулт: Доктор Д.Сүнжид:** Хөөн хэлэлцэх хугацаа нь дууссан юм уу?

**Асуулт: МХЕГ-ын дотоод хяналтын ахлах байцаагч н.Отгон**: Дууссан байгаа. Гол нь нөгөө хүн л хохироод яваад байгаан.

**Хариулт: Доктор Д.Сүнжид:** Хөөн хэлэлцэх хугацаа дууссан болохоор танайх Иргэнээс төрийн байгууллагад хандаж гаргасан өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэх тухай хуулиа ч Захиргааны ерөнхий хуулиа ч харсан өөрсдийнхөө хариуг өгөх боломжтой.

**Хариулт: Шүүгч Ц.Цогт:** Миний бодлоор танай захиргааны байгууллагын л эрх хэмжээний асуудал гэж бодож байна. Та нар тэрийг юу гэж үзэж байгаан? Хуульд нийцээгүй акт гэж үзэж байгаа бол тэр хуулийнхаа хэмжээнд үзээд залруулаад явах боломжтой юм бол. Тэр актаар өөр нэг этгээдэд эерэг үйлчлэл үүсгээгүй бол, зөвхөн тэр хүнд сөрөг үйлчлэлтэй акт байгаад та нар тэр актыг хуульд нийцээгүй юм байна гэж үзэж байгаа бол шийдэх эрх та нарт өөрсдөд чинь л байгаан байна ш дээ.

**Асуулт: НОБГ-ын хуулийн зөвлөх Даваасүрэн:** Манай дээр үүрэг гүйцэтгэж байгаа галын машины жолооч үүргээ гүйцэтгээгүйгээс болоод хүний амь нас хохироод ч юм уу энэ тохиолдолд сахилгын арга хэмжээ авна. Тэгэхээр тэр хүн ирээд шүүхтэлээ, ингэхээр Төрийн албаны тухай хуулинд байхгүй санкцуудыг Цэргийн дүрмээр зохицуулсан байдаг. Одоо жишээлбэл цолны 1 шатлал бууруулах. Тэгэхээр бид нар бууруулаад явчихаар үндэслэл байхгүйгээр миний цолыг хуулинд заасан үндэслэлгүйгээр авч хаялаа гэж маргах тохиолдол гарахад шүүх хуулинд заасан арга хэмжээ, эсхүл цэргийн дүрмээрээ бариад шийдсэн нь зөв байдаг юм уу? Бид нар цэргийн дүрмээ бариад шийтгэх үү?

**Хариулт: Шүүгч Ц.Цогт:** Тодорхой хэрэг дээр урьдчилан ярих нь миний ёс зүйн дүрэмд хориотой. Наад жишээг чинь би орхиод илүү ойлгомжтой юм ярья. Төрийн тусгай алба хаагч нарт төрийн тусгай албан хаагчдын зохицуулалт хэрэгжинэ. Төрийн тусгай албан хаагчийг ажлаас нь шилжүүлж байгаа. Гэхдээ өөртэй нь зөвшилцөхгүй тэрийгээ юу гэж тайлбарлаж байна гэхээр Цэргийн албаны тухай хуулийн 22-т зааснаар цэргийн албан хаагч бол шилжүүлэх шийдвэрийг офицер дээр бол захиргаа өөрөө гаргаж болдог. Төрийн албаны тухай хууль бол заавал өөртэй нь зөвшилцөнө гэж байна. Энэ хүн бол цэргийн албан хаагч учраас өөртэй нь зөвшилцөөгүй шилжүүлсэн юмаа гэж байна. За энэ тохиолдолд бол хууль хэрэглээний хувьд яах вэ? гэхээр шүүх бол юу харах вэ? гэхээр 1-рт цэргийн албан хаагч дотроо

тусгай албан хаагч буюу төрийн тусгай албан хаагчдын зохицуулалтад хамрагдаж байгаа тохиолдолд албанаас нь чөлөөлөх, төрийн алба хаах эрхийг хязгаарлахтай зохицуулалт Төрийн албаны тухай хуулинд дагаж мөрдөнө гэж байна. Өөртэй нь зөвшилцсөн байна гэж байгаа. Энэ чинь бол шүүхийн өөрийнх нь шүүх зарчим маргаж байгаа 2 талын эрх ашгийн балансыг барьж шийддэг.

**Хариулт: Доктор П.Одгэрэл:** Энэ дээр нэг тодруулах юм байна. Байгууллагын дотоод асуудалд энэ хууль үйлчилдэггүй. Ялангуяа гадагш чиглэсэн харилцаанд үйлчилдэг шиг, харин ямар тохиолдолд гадагш үйлчлэх вэ? гэхээр цалинг нь бууруулах, төрийн албанд ажиллах эрхэнд нь халдах ч юм уу, хууль ёсны эрхэнд халдах үед л гадагш чиглэнэ л гэсэн үг. Тийм болохоор Захиргааны ерөнхий хууль захиргааны байгууллагын дотоод асуудалд оролцохгүй л гэсэн үг.

**Асуулт: ОБЕГ-ын Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга:** Тодруулах зүйл байна. Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаалаар хүн шилжүүллээ гэхэд заавал асуух ёстой юу? гэхдээ цалин бууруулахгүйгээр. Асуух ёстой гэж ойлгоод байна. Жишээлбэл: Дарханаас Улаанбаатар хот руу шилжүүлэхэд эхнэр нь Дарханд ажилтай хүүхэд нь сургуульд сурдаг тэгээд гэр оронтой бол яах уу? Гадагш чиглэсэн гэж бодож байна. Захирах захирагдах ёс нь биелэгдэхгүй болчихоод байна. Энэ тохиолдолд яах уу?

**Хариулт: Доктор П.Одгэрэл:** Хэрвээ хуулиар шилжүүлэх дээ зөвшөөрөл авахаар хуульчилсан бол тэр эрхийг нь хангах ёстой. Тэр эрхийг хангаагүй бол гадагш чиглээд явна. Жишээлбэл: Цэцгээ гэдэг багшийг хөдөө томилолтоор явуулъя. Цэцгээ багш нялх хүүхэдтэй. Насанд хүрээгүй хүүхэдтэй бол Хөдөлмөрийн тухай хуулиар зөвхөн өөрийнх нь зөвшөөрөлтэйгөөр. Энэ тохиолдолд ректорын тушаал Цэцгээ багшийн хувьд гадагш чиглэгдэж байна. Хөдөлмөрийн тухай хуульд заагдсан эрх нь зөрчигдөж байгаа учир. Эрэгтэй багшийн хувьд бол дотогш чиглэсэн учир дотогш чиглэсэн болно.

**Асуулт: Зэвсэгт хүчний жанжин штабын хуулийн зөвлөх Эрдэнэ-мөнх :** Хэм хэмжээний актын талаар юм асуух гэсийн? Зэвсэгт хүчний үндсэн болон тайван цагт гүйцэтгэх үүрэг нь бол Төрийн болон албаны нууцын тухай хуулиараа зарим нэг асуудал нууцад хамаараад явдаг. Тэгэхээр Батлан хамгаалахын сайд ч юм уу? Зэвсэгт хүчний жанжин штабын дарга өөрт олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд нууц тушаал гаргадаг. Тэгээд улсын нэгдсэн санд бүртгүүлэх гэхээр хэм хэмжээний эмхтгэлд гарахаар нийтэд ил болчих гээд байдаг. Нууц асуудлаар гарсан хэм хэмжээний акт улсын нэгдсэн санд бүртгүүлэх үү? Манайх бол бүртгүүлэхгүй гэж бодож байгаа.

**Хариулт: Хууль зүй, дотоод хэргийн яамны ЗХХАХБХ-ийн дарга Д.Ариунтуяа:** Хэм хэмжээ тогтоосон акт нэг их байхгүй байх тиймүү? Гадагш чиглэсэн?

**Асуулт: Зэвсэгт хүчний жанжин штабын хуулийн зөвлөх Эрдэнэ-мөнх :** Манайх бол төрийн цэргийн байгууллагынхаа хэмжээнд.

**Хариулт: Хууль зүй, дотоод хэргийн яамны ЗХХАХБХ-ийн дарга Д.Ариунтуяа:** Тэгвэл тэр чинь хэм хэмжээ тогтоосон акт биш шүү. Гадагш чиглэсэн биш.

**Уулзалт, ярилцлагыг чиглүүлэгч**: **ХЗДХЯамны ЗХХАХБХ-ийн ахлах мэргэжилтэн Э.Сэлэнгэ:** Ийм нууцтай холбоотой ганц нэг зүйл гарч ирэхийг үгүйсгэхгүй. Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйл дээр захиргааны акт байж болно гээд 3 нөхцөлтэй нэг заалт байж байгаа. Тэр хүрээнд үзээрэй. Саяын асуусан асуултын хүрээнд.

Өөр Захиргааны ерөнхий хуулийн хүрээнд асуулт болон санал байна уу? байхгүй бол санал гаргаж, асуулт тавьсан захиргааны байгууллагууддаа баярлалаа. Одоо ингээд санал асуулт, хариултын хэсгийг өндөрлөөд сүүлийн хэсэг болох уулзалтыг дүгнэж Захиргааны ерөнхий хуулийг боловсруулах ажлын хэсэгт үндэсний зөвлөхөөр ажилласан доктор П.Одгэрэл багшийг урьж байна.



Remove Watermark Now
pdfelement

Remove Watermark Now

**Дүгнэлт доктор П.Одгэрэл**: За өнөөдөр Захиргааны ерөнхий хуулийн талаар нэлээн идэвхтэй ярилцаж мөн оролцлоо. Захиргааны ерөнхий хуулийн талаар ялангуяа захиргааны хэм хэмжээний актын талаар нэлээдгүй асуудал гараад байгаа. Энэнтэй холбоотойгоор Хууль зүй, дотоод хэргийн яамнаас өнөөдөр хийсэн ажлуудынхаа талаар танилцуулга хийсэн байгаа. Мөн цаашид хийх ажлын талаар төлөвлөсөн ажил байгаан байна. Захиргааны ерөнхий хуулиас гадна бусад салбарын хуулиудад өөрчлөлт оруулах, аль эсвэл хуулинд эрх олгосон 1400 гаруй заалтаас 600 гаруй нь батлагдаагүй байна гэж байна. Магадгүй нэмэгдэх ч юм уу, хасагдах ч юм уу хэлж мэдэхгүй байна. Хуулинд хэм хэмжээг батлах эрх олгоогүй зайлшгүй шаардлагатай асуудлаа төрийн захиргааны байгууллагууд нь Хууль зүй, дотоод хэргийн яамтайгаа уулзаж холбогдох хуулийн талаар арга хэмжээгээ авах талаар цаашдаа идэвхтэй ажиллах байх. Ингэснээр асуудлууд нь яваандаа нэлээн цэгцрэх байх гэж найдаж байна.

Мөн Захиргааны ерөнхий хууль дээр захиргааны илт хууль бус акт дээр нэлээд асуудал үүсдэг. Энэ нь яваандаа цэгцрээд гайгүй болчих байхаа. Яагаад гэвэл илт хууль бус акт маань хүлээн зөвшөөрөхгүй алдаанууд байдаг. Өөрөөр хэлбэл гэмт хэрэг, зөрчил үйлдэхийг даалгасан ч юм уу, аль эсвэл хэн гаргасан нь тодорхойгүй, хийж чадахгүй зүйлийг үүрэг болгох гэх мэт байдаг. Тэгэхээр энэ дээр хөөн хэлэлцэх хугацаа тооцохын аргагүй тохиолдлууд байдаг. Тийм болохоор энэ асуудал маань яваандаа гайгүй болоод жигдрээд явчих байхаа. Хамгийн гол асуудал нь Ц.Цогт шүүгч маань тайлбарлаад байсан Захиргааны ерөнхий хуулийн 47.1.6 дээр хууль заагаагүй үндэслэл байгаагүй, 1-рт магадгүй хэрэглээгээрээ тухай захиргааны актыг уншсан чинь ямар ч хуулийн үндэслэлгүй байхын бол, 2-рт акт нь өөр үндэслэлээр ажлаас халсан, хуульд байхгүй бол гэх мэт тодорхой нөхцөлөөр практикаар цаашдаа явах байхаа.

Захиргааны ерөнхий хуулийн хувьд яг нарийвчлаад зохицуулахад их бэрхшээлтэй. Яагаад гэвэл энэ хууль нь бүх салбарт үйлчилдэг учраас нарийвчлан зохицуулах боломжгүй байдаг. Аль болох ерөнхий, зарчмын шинжтэй зохицуулалтыг бид нар тусгасан байгаа. Мөн хэрэглээний хувьд бид бас бодох ёстой. Яагаад гэвэл та нар бас салбар салбарын хүмүүс байгаа болохоор Захиргааны ерөнхий хууль тэгээд салбарын хуулиуд, тэгээд дүрэм журмууд байгаа. Тэгэхээр ерөнхий хуулиас салбарын хууль руу ороход нарийвчлагдана. Дахиад дүрэм журмууд руу ороход илүү нарийвчлагдана. Тэгэхээр хэрэглээний хувьд энэ дүрэм журмуудаар зохицуулагдаагүй бол салбарын хуулиар, салбарын хуулиар тухайн асуудлыг зохицуулаагүй бол ерөнхий хуулиа хэрэглэдэг. Тийм болохоор бүхий л юмыг ерөнхий хууль руу оруулахгүйгээр салбарын хуулиуд дээр тийм орон зай зөндөө байгаа, аль болох бид салбарын хуулиудаа цаашаа хөгжүүлээд илүү нарийвчлан зохицуулалтуудыг хийх шаардлагатай байгаа.

Мөн хугацааны хувьд эргэж харах зүйл бас байгаа байх. Мэдээж зарим байгууллагуудад хуульд заасан хугацаа болон оролцоог, зарим тохиолдолд нэмэгдэх ч юм уу, хасагдах ч юм уу тийм тохиргоо гарч магадгүй юм. За тэгээд дүгнээд үзэхэд Захиргааны ерөнхий хууль маань яг хэрэгжихгүй, гацсан тийм зохицуулалт байхгүй, харин цаашдаа ерөнхий хуулиа илүү нарийвчлаад тодорхой болгоод өгчихвөл болохоор санагдаж байна. Харин та бүхэнд Захиргааны ерөнхий хуультай холбоотой санал байхын бол Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр байгуулагдсан ажлын хэсэгт бичгээр өгөөрэй. Ирүүлсэн санал бүрийг чинь бид хуулийн төсөлд тусгах тал дээр анхаарах болно.

Хэлэлцүүлэгт оролцсон та бүхэнд баярлалаа.
Уулзалт, ярилцлага 12 цаг 30 минутад дуусав.

ТАНИЛЦСАН:ЗХХАХБХ-ийн ахлах мэргэжилтэн Э.Сэлэнгэ
ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН: ЗХХАХБХ-ийн мэргэжилтэн Д.Түвшинбаяр

Remove Watermark Now

# “ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ” СЭДЭВТ

## Уулзалт-ярилцлагын тэмдэглэл

2018.02.09 Улаанбаатар хот

“Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилт” сэдэвт уулзалт, ярилцлагыг Хууль зүй дотоод хэргийн яам, ХБНГУ-ын Ханнс Зайделийн сантай хамтран 2018 оны 02 дугаар сарын 09-ний өдөр 09 цаг 30 минутад Ханнс Зайделийн сангийн байрны сургалтын танхимд зохион байгуулав.

Уг уулзалт, ярилцлагад Улсын Их Хурлын харьяа байгууллагууд оролцсон.

**Уулзалт, ярилцлагыг чиглүүлэгч:** “Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилт” сэдэвт уулзалт, ярилцлагыг нээж үг хэлнэ үү хэмээн Хууль зүй дотоод хэргийн яамны Дэд сайд Энхбаяр, Захиргааны ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсгийн ахлагчийг индэрт урив.

**Дэд сайд Б.Энхбаяр:** Та бүхний өглөөний амгаланг айлтган мэндчилье. Өнөөдрийн “Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилт” сэдэвт уулзалт, ярилцлага бол чөлөөт, ажил хэрэгч та бүхний өмнө тулгарч буй асуудлуудыг ярилцах, тодорхой асуудлуудыг онол арга зүй, практик талаас нь хөндсөн ийм хэлэлцүүлэг болоосой гэж хүсэж байна.

Захиргааны ерөнхий хууль бол манай улсын хувьд захиргааны эрх зүйн шинэтгэл төдийгүй эрх зүйн салбарт оруулсан маш том алхам байсан. Хууль хэрэгжээд жил гаран хугацаа болж байна. Өөрөөр хэлбэл бид нар явц байдлыг хууль зүйн хэрэглээ талаасаа, шүүхийн процесс талаасаа, мөн практик дээр гарч буй асуудлыг харах ийм хэрэгцээ, шаардлага байна гэж үзэж байна. Хууль хэрэгжилтийн явцад үүсч байгаа асуудал байвал уг асуудлуудыг шийдэх ёстой. Гарцаагүй тулгамдсан тийм зүйлүүд байвал даруй, хугацаа алдахгүй шийдэх ёстой. Хуультай биш хэрэгжүүлэх механизмтай холбоотой асуудал байгаа бол тэрийг зөв олж харан ярих ёстой. Мөн ойлголтын зөрүүтэй асуудлууд байвал тэрийгээ оновчтой зөв зааглаж ярих ёстой. Тэгэхгүй бол хүн өөрийн алдааг өөрөөсөө бус өөр зүйлээс хайж эхэлдэг. Тэрийгээ эрдэмтдээс хайна, эсвэл хуулиас хайна. Ийм асуудлууд бол шинэ тутам гарч буй хуулиуд дээр анзаарагдаад байна. Энэ нь шилжилтийн онцлог байж магадгүй. Тухайн хуулийг гардаж хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн алба хаагчид, албан тушаалтнуудтай холбоотой ийм асуудлууд байна. Хуулийн хэрэгжилт харилцан адилгүй байгаа. Өөрөөр хэлбэл тухайн хүнээс хамаарч байна уу, эсхүл байгууллагын удирдлагаас хамаарч байна уу, эсхүл заримдаа үүнийг хэрэглэж байгаа шүүгчээс хамаарч байгаа зэргээр хэрэглээний явцад өөр өөр жишиг тогтоож байгаа асуудлууд байна.

Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал бол УИХ-аас баталсан хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд туссан. Энэ талаар урьдчилсан ямар нэг дүгнэлт, чиглэл байхгүй. Өөрөөр хэлбэл заавал энэ зүйлийг өөрчилнө гэж Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас бодлого гаргаж ажлын хэсэг гаргасан гэж үзэж болохгүй. Үзэл баримтлал бол гараагүй ажлын хэсгийн тушаал дөнгөж албажиж гарсан байгаа. Энэ хүрээнд олон талаас нь асуудлуудаа ярилцаад асуудал юу байна, шийдэл юу байна гэсэн зорилго, санаа агуулж байгаа гэдгийг хэлмээр байна.

Сургалт сурталчилгаа бол нийлээд их шаардлагатай байна. Энэ сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах, тасралтгүйгээр ойрын 5 жилдээ сургалт сурталчилгаа хийх шаардлагатай байна.

Шийдвэр гаргах түвшинд яригддаг гол асуудал бол Засгийн газар захиргааны шүүхийн харьяалалд байх эсэх асуудал юм. Энэ асуудалтай холбоотой оны өмнө Засгийн газрын хуралдаан дээр тодорхой кэйс маргааны асуудлыг хэлэлцэх явцдаа энэ асуудлаар Үндсэн хуулийн Цэцэд хандаж нэг мөр болгох асуудал гаргасан. Үүний дагуу судалгаа хийгдэж байгаа. Миний хувьд бол Засгийн газар захиргааны хэргийн хяналтаас бүрэн гарах ёстой этгээд гэж ойлгодоггүй. Тодорхой онол арга зүй, хэрэглээний хувьд тодорхой ойлгох боломжтой хувилбаруудыг гаргах тал дээр илүү ажиллах ёстой. Жишээ нь: Засгийн газрын хөдөлмөрийн маргаан бол заавал хянагдах ёстой. Гэтэл үүнтэй хамт УИХ, Засгийн газраас явуулж байгаа томоохон бүтээн байгуулалтын шинжтэй, мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой хугацаа

pdfelement

Remove Watermark Now

алдах, зогсох ийм асуудлууд хүртэл яригдаж байна. Эрдэнэт үйлдвэрийн маргаан одоо ямар маргаан бэ? Хүний эрх ашиг уу? Албаны эрх ашиг уу? Улсын эрх ашиг уу? Энэ өөрөө ямар төрлийн маргаан юм. Хууль тогтоох байгууллага шийдвэр гаргасан байна. Үүнийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар яах ёстой юм? Хөшигтийн хөндийн асуудал байна. 2 улсын хоорондын зээлийн хэлэлцээртэй асуудал дээр Засаг дарга нь газар олгосноос болоод энэ асуудал хойшлоод байгаад байх уу? Үүний хохирол үр дагавар гэдэг бол хэдэн зуун тэр бум төгрөгөөр хэмжигдэх эргээд улс оронд хохиролтой үр дагаврууд гарч байна. Энэ мэт улс орны шинжтэй томоохон асуудлуудыг яах ёстой бэ? Үүнийг хууль зүйн талаас нь илүү нарийвчлаад ямар зохицуулалт хийж болохоор байна гэдэг хувилбаруудыг энэ ажлын хэсгийн хүмүүстэй олон талаас нь ярилцаасай гэж хүсэж байна. Ингэж ярилцах тусмаа илүү зөв шийдвэр гарна. Өнөөдрийн уулзалт, ярилцлагын үйл ажиллагаанд амжилт хүсье баярлалаа гэв.

**Уулзалт, ярилцлагыг чиглүүлэгч**: Энэхүү уулзалт, ярилцлагыг хамтран зохион байгуулж байгаа Ханнс Зайделийн сангийн тэргүүн Сарантуяа таныг үг хэлнэ үү хэмээн урьж байна.

**Ханнс Зайделийн сангийн тэргүүн Сарантуяа:** Та бүхэн мэдэж байгаа байх. Монгол Улсад 2002 онд анх удаа Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль батлагдаж, 2004 онд захиргааны хэргийн шүүх үйл ажиллагаагаа явуулж эхэлсэнээр шүүхүүд өөрийн практикийг тогтоож ирсэн түүхтэй.

Удаагаар нь захиргааны үйл ажиллагааг нэг мөр болгох зорилгоор Захиргааны ерөнхий хуулийн төслийг боловсруулж батлуулсан нь Азийн улс орнуудын дотор Захиргааны хэргийн шүүхтэй улсын тоонд орох болсон. 1992 оны Үндсэн хуулиас өмнө эдгээр ойлголт огт байсангүй. ЗХХШТ хуулийг батлагдан гарсны дараа Улсын дээд шүүхтэй хамтран энэ хуулийн хэрэгжилтийн талаар социологийн судалгаа явуулаад Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх байгуулах цаг нь ирсэн гэдгийг нотолж давж заалдах шатны шүүх саяхан байгуулагдсан байгаа.

ХЗДХЯ-ны ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх зорилгоор ЗЕХ-ийн хэрэглээний талаар судалгаа хийхээр зорьж байна. Энэ үйл ажиллагааг явуулахад дэмжиж хамт байгаа Дэд сайд Энхбаяр болон яамны хамт олонд талархлаа илэрхийлж байна. ЗЕХ-ийн хэрэглэх, хэрэгжүүлэх ажиллагаа нь Захиргааны байгууллага болон захиргааны шүүх дээр явагддаг байгаа. Энэ утгаараа яаманд дэмжлэг үзүүлэх зорилгоор Захиргааны хэргийн анхан болон давж заалдах шатны шүүгчдийн уулзалт, ярилцлагыг зохион байгуулж тус бүр протокол бичиж, үүн дээр тулгуурлан социологийн судалгаанд оруулах асуултаа боловсруулах байх гэж бодож байна.

pdfelement

ХЗДХЯ-тай хамтран яам, засгийн газрын харьяа байгууллагууд, мөн УИХ-аас байгууллагддаг байгууллагуудын дунд тус тусад нь энэ хэлэлцүүлгийг зохион байгуулж байна.

Энэ утгаараа өнөөдөр УИХ-аас байгууллагддаг байгуулагууд ЗЕХ-ийн хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал юу байна вэ гэдгийг ярилцаж саналаа хэлээсэй гэж хүсч байна. Энэ хэлэлцүүлгээс гарсан үр дүнг ХЗДХЯ-ны холбогдох мэргэжилтэн протокол хөтлөн социологийн судалгаанд оруулах асуудлаа боловсруулахад хамтран ажиллах байх гэж бодож байна.

Өнөөдөр та бүхэнтэй ярилцахаар ЗЕХ-ийг боловсруулахад оролцсон ажлын хэсгийн гишүүд хүрэлцэн ирсэн байна. Уулзалт ярилцлагад амжилт хүсье.

**Уулзалт, ярилцлагыг чиглүүлэгч**: Өнөөдрийн “Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилт” сэдэвт уулзалт ярилцлагаар хөтөлбөрт зааснаар хоёр мэдээллийг сонсох ёстой байгаа. Эхний мэдээлэл Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангахтай холбоотой болон одоо хийж байгаа ажлын талаар мэдээлэл өгнө үү? хэмээн Хууль зүй дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн дарга Ариунтуяа таныг урьж байна.

**Хэлтсийн дарга Д.Ариунтуяа**: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Захиргааны ерөнхий хууль хэрэгжээд жил зургаан сарын хугацаа өнгөрөөд байна. Энэ хооронд Хууль зүй, дотоод хэргийн яам нэлээдгүй ажил хийсэн. Өнөөдөр та бүхэнд танилцуулах гэж байгаа зүйл маань хоёр хэсэгтэй.

Нэг: Захиргааны ерөнхий хууль 2015 онд батлагдснаар хуулийн бэлтгэл ажлыг хангах хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яам ямар ажлууд хийсэн талаар товч танилцуулъя.

Remove Watermark Now

Хууль зүйн яам /хуучин нэрээр/-ны Төрийн нарийн бичгийн дарга энэ хуулийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөө баталж энэ чиглэлээр нэлээдгүй ажлыг хийсэн.

1.1.Хууль зүйн сургуулийн захиргааны эрх зүйн багш, судлаач, ажилтнуудад зориулсан сургалтыг 2015 оны 10 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд Хансс-Зайделийн сантай хамтран амжилттай зохион байгуулж нийт 32 багш, судлаач, ажилтнуудыг хамруулсан.

1.2. Захиргааны ерөнхий хуулийг заах сургагч багш бэлтгэх сургалтыг 2015 оны 11 дүгээр сарын 23-28-ны өдрүүдэд /нийт 6 өдөр/ зохион байгуулж, 31 сургагч багш бэлтгэн, гэрчилгээ олгосон.

1.3.Захиргааны ерөнхий хуулийн талаар Ханнс-Зайделийн сантай хамтран шторк бэлтгэж хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилсан. Дээрх шторкийг /CD хэлбэрээр/ аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ, яамдуудад албан бичгээр хүргүүлж, холбогдох мэдээллийн хэрэгслээр түгээсэн.

1.4.Захиргааны ерөнхий хууль 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэхтэй холбогдуулан Хууль зүйн яам /хуучин нэрээр/, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн Эрх зүйн боловсрол академитай хамтран яам, агентлаг болон нийслэл, дүүргүүдийн ЗДТГ, Захирагчийн ажлын алба, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэрэгжүүлэгч агентлагуудын албан хаагчдад зориулсан танилцуулах сургалтыг 2016 оны 2 дугаар сарын 16-наас 4 дүгээр сарын 1-ний хооронд, мөн 21 аймагт 4 дүгээр сарын 17-30-ны хооронд тус тус зохион байгуулж, нийт 100 гаруй удаагийн сургалтаар **7500 гаруй** ажилтан, албан хаагчийг хамруулж, брошур, гарын авлага, сурталчилгааны материалуудыг түгээж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан байна.

1.5.Захиргааны ерөнхий хуулийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 3.2 дахь хэсэгт заасны дагуу Захиргааны ерөнхий хуулийн агуулгыг Хууль зүйн их, дээд сургуулиудын Захиргааны эрх зүйн хичээлийн сургалтын хөтөлбөрт шинэчлэн тусгуулах саналыг Хууль зүйн сайдын /хуучин нэрээр/ албан бичгээр Боловсрол, соёл, шинжлэх ухааны Сайдад /хуучин нэрээр/ хүргүүлж, хэрэгжсэн байна.

pdfelement

1.6.Захиргааны ерөнхий хуулийн 61 дүгээр зүйлийн 61.6, 72 дугаар зүйлийн 72.2, 54 дүгээр зүйлийн 54.4 дэх заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараахь журмуудыг эрх олгосон захиргааны байгууллагууд баталсан. Үүнд:

- Хууль зүйн сайд /хуучин нэрээр/-ын 2016 оны 7 сарын 1-ний өдрийн А/222 тоот тушаалаар "Нөлөөллийн шинжилгээ хийх аргачлал",
- Хууль зүйн сайд /хуучин нэрээр/-ын 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн А/226 тоот тушаалаар "Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санг эрхлэн хөтлөх тухай" журмыг хууль хэрэгжиж эхлэхээс өмнө батлуулж бэлтгэл ажлыг хангасан байна.

1.7.Хууль зүйн яам /хуучин нэрээр/, Ханнс-Зайделийн сантай хамтран Захиргааны ерөнхий хуулиар сургагч багш нарт болон иргэдэд зориулсан сургалтын гарын авлагыг гаргаж төрийн байгууллагууд болон иргэдэд хүргүүлсэн.

Хоёр:Захиргааны ерөнхий хууль 2016 оны 7 дугаар сарын 1-нээс эхлэн хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулаад Хууль зүй, дотоод хэргийн яамны бүтцэд Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтэс гэсэн шинэ нэгжийг байгуулсан. Энэ нэгж маань Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар бүлгийг хэрэгжүүлэхээр дараахь ажлыг хийж байна.

Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлд "Засгийн газар нь төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын шийдвэр хууль тогтоомжид нийцэж байгаа эсэх талаар хяналт тавих үүрэгтэй." гэж заасны дагуу энэ хяналтыг Хууль зүй, дотоод хэргийн яам хэрэгжүүлдэг. Энэ чиглэлийн хүрээнд Захиргааны ерөнхий хуульд захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийг Хууль зүй, дотоод хэргийн яам хэрэгжүүлэхээр тусгасан. Хууль батлагдахаас өмнө энэ асуудлыг Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолын хүрээнд тус яам хийдэг байсан бол Захиргааны ерөнхий хууль батлагдан, хэрэгжиж эхэлснээр бид хуулийн дагуу захиргааны хэм

хэмжээний актыг хянах, бүртгэх асуудал яригдаж, улмаар хууль зөрчсөн зөрчилд хариуцлага тооцох асуудал гарч ирсэн.

Ажил авахад нийтдээ улсын нэгдсэн санд 960 хэм хэмжээний акт бүртгэлтэй байсан. Засгийн газрын тогтоол хэрэгжиж байх үед сайд, агентлагийг дарга нар, зөвлөл, хороо, Засаг даргын шийдвэрийг л зөвхөн хянадаг байсан бол Захиргааны ерөнхий хууль хэрэгжсэнээр эдгээр дээр нэмээд захиргааны чиг үүргийг хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээд орж ирж байгаа. Тухайлах юм бол Хуульчдын холбоо. Энэ байгууллага нь төрийн чиг үүргийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэдэг иймь байгууллага. Мөн хууль тогтоомжийг биелүүлж, захирамжилсан шийдвэр гаргадаг Засгийн газрын бус агентлаг гэж орж ирж байгаа. Энэ нь Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо гэх мэт 8 байгууллага байдаг. Түүнчлэн аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдээс гаргасан хэм хэмжээ тогтоосон шийдвэрүүдийг Хууль зүй, дотоод хэргийн яам хянаж, бүртгэх ажил хуулиар орж ирж байгаа. Түүнчлэн Захиргааны ерөнхий хуульд Монгол Улсын Их Хурал, Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, бүх шатны шүүх прокуророос хуульд заасан эрх мэдэл буюу хууль тогтоох эрх зүйн маргаан шийдвэрлэх онцгой бүрэн эрхийнхээ дагуу гаргасан шийдвэрээс бусад захиргааны чиг үүрэг шийдвэртэй холбогдуулан эдгээр байгууллагыг захиргааны байгууллагад тооцохоор заасан байгаа.

Улсын нэгдсэн санд бүртгэлтэй байгаа 960 хэм хэмжээний актыг Захиргааны ерөнхий хуульд нийцсэн эсэхийг Хууль зүй, дотоод хэргийн яам нэг бүрчлэн Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагын дагуу хянаад энэ актуудын 487 нь Захиргааны ерөнхий хуульд нийцэхгүй байна гэж үзсэн. Учир нь ач холбогдлоо алдсан, зохицуулж байсан хууль нь хүчингүй болсон, эсхүл шинэчилсэн найруулга нь батлагдснаар эрх олгосон заалтгүй болсон, эсхүл эрх олгосон заалтууд нь өөрчлөгдсөн г.м бусад шалтгаанаар нийцэхгүй байна гэсэн дүгнэлтийг холбогдох байгууллагуудад хүргүүлж хуульд нийцүүлэх ажлыг үе шаттайгаар хийж ажилласнаар 120 гаруй шийдвэрийг хүчингүй болгож өөрчилсөн байгаа.

Одоогоор улсын нэгдсэн санд нийт 832 шийдвэр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа. Захиргааны ерөнхий хуулиар шинээр орж ирсэн байгууллагуудын нийтдээ 1000 гаран захиргааны хэм хэмжээний актыг татан авч үзээд энэ нь мөн Захиргааны ерөнхий хууль болон бусад хуульд нийцэхгүй гэсэн шалтгаанаар хамтран ажиллаж хуульд нийцүүлэх ажлын Хууль зүй, дотоод хэргийн яам үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Түүнчлэн захиргааны хэм хэмжээний актаа хуульд нийцүүлэхийн тухайд заавал хуулиар тусгайлан эрх олгосон байх ёстой гэсэн хуулийн шаардлага тавьж байгаа. Өнөөдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 482 хууль байгаа. Энэ хуулиудад хичнээн эрх олгосон заалт оруулсан бэ? гэдэг судалгааг гаргасан. Судалгаанаас харахад 206 хуулиар дамжуулан нийтдээ 1476 байгууллагад дүрэм, журам батлах эрхийг олгосон гэсэн судалгаа гарсан. Үүнээс нэгдсэн санд байгаа 832 хэм хэмжээ тогтоосон шийдвэрээ хасах юм бол 644 хууль тогтоогчоос олгосон эрхийг хэрэгжүүлээгүй гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Цаашдаа энэ ажлууд маань үргэлжлээд явахаар байгаа.

Хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиудад судалгаа хийж дууссанаар бид дараахь ажлыг төлөвлөж байна. Нэгдүгээрт эрх олгосон заалтын хүрээнд захиргааны хэм хэмжээний актыг холбогдох захиргааны байгууллагаас татаж улсын нэгдсэн санд бүртгүүлсэн эсэх. Хоёрдугаарт эрх олгосон актын хүрээнд захиргааны хэм хэмжээний акт батлан гаргаагүй зөрчлийг илрүүлж холбогдох байгууллагад хууль хэрэгжүүлэх тухай албан бичиг явуулж хамтран ажиллана гэсэн төлөвлөгөөтэй байна. Мөн захиргааны хэм хэмжээний акт батлагдсан боловч улсын нэгдсэн санд бүртгүүлэхгүйгээр дагаж мөрдөж байгаа зөрчил дутагдлууд нэлээдгүй байгаа. Энэ нь хуульд заасанаар захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд заавал бүртгүүлснээр хүчин төгөлдөр болох ёстой. Үүнийг мөрдөж ажиллахгүй байгаа дутагдлууд нэлээн гарч байгаа.

Одоо тус хэлтэсээс Захиргааны ерөнхий хуулийн 69 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд улсын нэгдсэн санд бүртгэлтэй байгаа актууддаа хяналт, шинжилгээ үнэлгээ хийх ажлыг холбогдох захиргааны байгууллагуудтайгаа хамтран хийж байна. Хяналт, шинжилгээний дүнг үндэслэн цаашид авах арга хэмжээний талаарх саналаа Засгийн газарт танилцуулахаар ажиллаж байна.



Remove Watermark Now
pdfelement

Remove Watermark Now

Мөн 2017 онд Захиргааны ерөнхий хуулийн чадваржуулах сургалтыг Ханнс Зайделийн сантай хамтран 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт хийсэн байгаа. Түүнчлэн энэ хуулийг иргэдэд сурталчлах зорилгоор иргэдэд зориулсан гарын авлага гаргаж, Захиргааны ерөнхий хуультай хамт хэвлүүлэн 21 аймаг болон нийслэлийн 9 дүүргийн иргэдэд тараасан байгаа.

Захиргааны ерөнхий хуулийг хэрэгжүүлэхийн төлөө өнгөрсөн жил гарны хугацаанд хамтран ажилласанд баярлалаа.

Мөн Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой засч залруулах хэлэлцэн боловсруулах ажил юу байна энэ талаар өнөөдөр нээлттэй хэлэлцүүлэгийг Ханнс Зайделийн сантай хамтран зохион байгуулж байна. Та бүхнийг идэвхтэй оролцохыг хүсье. Баярлалаа.

**Уулзалт, ярилцлагыг чиглүүлэгчээс**: Захиргааны ерөнхий хуулийн бэлтгэл ажлыг хангах болон хэрэгжилтийн тал дээрх хийсэн ажлын талаар мэдээлэл өгсөн Ариунтуяа даргад баярлалаа.

Нэмж нэг зүйлийг тодруулж хэлэхэд өнөөдрийн уулзалт ярилцлагад УИХ-аас байгууллагддаг Засгийн газрын бус бие даасан агентлагууд байгаатай холбогдуулан өмнө нь Засгийн газрын 119 дүгээр тогтоолын хүрээнд хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг танай байгууллагууд ХЗДХЯ-нд ирүүлдэг байсан. Ирүүлсэн хэм хэмжээ тогтоосон шийдвэрүүд нь хууль тогтоомжид нийцэж байвал  улсын нэгдсэн санд хүлээн авав гэсэн дардас дардаг байсан. Харин ирүүлсэн хэм хэмжээ тогтоосон шийдвэр нь хуульд нийцэхгүй бол зөвлөмж хүргүүлдэг байсан. Өнөөдрийн байдлаар Улсын нэгдсэн санд Санхүүгийн зохицуулах хорооны 1, Сонгуулийн ерөнхий хорооны 5, Үндэсний аудитын газрын 2 актууд тус тус бүртгэлтэй байна. Тиймээс бусад байгууллагууд нь хууль тогтоогч хуулиар дамжуулан эрх шилжүүлснээр хэм хэмжээ тогтоосон дүрэм, журам баталсан бол түүнийгээ ХЗДХЯ-нд ирүүлж бүртгүүлэн, захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд нийтлүүлснээр хүчин төгөлдөр болно гэдгийг анхаарах хэрэгтэй байгааг хэлье.

pdfelement

За дараагийн мэдээллийг Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлснээр шүүх дээр энэ хуулийг хэрхэн хэрэглэж шийдвэрээ гаргаж байгаа талаар “Захиргааны ерөнхий хуулийн хэрэглээ” сэдвийн хүрээнд Захиргааны ерөнхий хуулийн ажлын хэсгийн гишүүн, судлаач, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Ц.Цогт мэдээлэл хийнэ. Таныг индэрт урьж байна.

**Шүүгч Цогт:** Захиргааны ерөнхий хуулийн зохицуулалт бол иргэн, захиргаа 2-ын хоорондын харилцааг зохицуулахад чиглэсэн бөгөөд нарийвчилсан зохицуулалтыг бусад салбарын хуулиар зохицуулна. Ер нь бол Захиргааны ерөнхий хуулийг шүүх дээр хэрэглэж тодорхой маргаан шийдвэрлэж байгаа. Тэр статистикээс юуг дүгнэж болох бэ? гэвэл: Бид энэ хуулийг хэрэглэх төлөв байдал захиргааны байгууллага дээр ямар байгаа бэ? Хэрэглэх ёстой асуудал дээрээ хэрэглэж байна уу? Хэрэглээн дундаа алдаа гарч байна уу?, эсхүл Огт ойлгогдохгүй асуудлууд гарч байна уу? Захиргааны байгууллага, иргэн хоёрын хооронд ийм асуудал үүсч байна уу? гэдгийг харж болох юм.

Ханнс Зайдел сангийн хүсэлтээр 2017 оны 1-7 дугаар сарыг хүртэл хугацаанд нийт захиргааны хэргийн анхан шатны шүүхүүдээр шийдвэрлэгдсэн хэргүүдэд судалгаа хийх замаар өнөөдрийн танилцуулгыг хийж байна. Эндээс юуг харж болохоор байна гэхээр шүүхүүдэд Захиргааны ерөнхий хуулийг хэрэглэж ямар хэрэг маргаан шийдэж байна. Энэ дотроо аль зүйл заалтыг илүү хэрэглэгдэж байна. Мөн энэ нь яагаад ингэж хэрэглэгдэж байна гэдгийг. Тухайн зохицуулалттай холбоотой захиргааны байгууллагууд шийдвэр гаргахдаа тэр зохицуулалтыг буруу зөрүү хэрэглэснээс маргаан үүсч байна гэж харагдах гээд байна. Захиргааны ерөнхий хуулийн үндсэн хоёр чиглэл байгаа, зохицуулж байгаа хоёр этгээд болон захиргаа, иргэн тэдгээрийн хоорондын харилцааг зохицуулах тэр дотроо захиргааны үйл ажиллагааг стандартад оруулаад ойлгомжтой тодорхой болгоход оршиж энэ судалгаа ч мөн үүнд чиглэсэн байгаа.

Судалгаа shuuh.mn шүүхийн шийдвэрийн цахим санд оруулсан байгаа. Бүх шийдвэрийг татаж судалсан байгаа. Нийтдээ захиргааны хэргийн анхан шатны шүүх 2017 оны эхний хагас жилд 1070 хэрэг шийдвэрлэсэн албан ёсны мэдээ байна. Түүний 920 шийдвэр нь судалгаа хийх үед цахим санд орсон байсан. Энэ 920 шийдвэрийг шүүж үзээд нийслэл дэх захиргааны хэргийг

Remove Watermark Now

анхан шатны шүүх /хотын захиргаа, хурал, дүүрэг, төрийн захиргааны төв, Засгийн газрын байгууллагууд, бие даасан агентлагууд/-ын шийдвэр үйл ажиллагаа бол харьяаллаараа Нийслэлийн захиргааны хэргийн шүүх шийдэж байгаа. Энэ шүүх 67, орон нутгийн шүүхүүд бол 77 хэргийг шийдсэн байна. Энэ дотроос 140 хэрэг дээр бол ямар нэг байдлаар шүүхийн шийдвэрт Захиргааны ерөнхий хуулийг хэрэглэсэн байна. 140 шийдвэрт хэрэглэсэн байна гэдэг нь 140 тохиолдолд захиргааны байгууллага ерөнхий хуулийг хэрэглэсэн гэсэн үг бас биш. Яагаад гэвэл шүүх шийдэхдээ “Та энэ тохиолдолд ерөнхий хуулийг хэрэглэх ёстой байсан байна хэрэглээгүй байна” гэж өөрөө шийдвэр гаргахдаа энэ хуулийг хэрэглэх замаар шийдвэр гаргасан тохиолдол байдаг. Энэ хэргүүдийн маргааны төрлөөс аваад үзвэл ер нь сүүлийн үед хүн ажлаас халсан маргаан шийддэг болсон байна. Энэ нь эмгэнэлтэй. Цаана нь олон төрлийн эрх зүйн маргаан байгаа. Хамгийн олон ерөнхий хууль хэрэглэж шийдсэн маргаан нь төрийн албаны маргаан байна. 77-г шийдвэрлэсэн. Тэгээд газрын маргаан олон хэрэг дээр. Бусад нь сонгууль, ашигт малтмал зэрэг хэргүүд дээр хэрэглэгдсэн байдаг юм байна.

Шүүх Захиргааны ерөнхий хуулийн аль зүйл заалтыг хэрэглэх магадлалтай бэ? гэхээр тодорхойлолт буюу материаллаг зохицуулалт агуулсан. Жишээ нь: Захиргааны акт гэж юу болох, ямар акт илт хууль бус болох бэ? гэх мэт зохицуулалтыг зайлшгүй хэрэглэж таарна. Хоёрдугаарт хамгийн гол хэрэглэгдэж байгаа зохицуулалт бол процесс байгаа. Захиргаа шийдвэр гаргахдаа ямар үе шатаар ямар арга замаар иргэнтэй харьцах. Тэрийг тодорхой хэрэг дээр хуультай харьцуулж үзээд нийцэж байна уу?, эсхүл нийцэхгүй байна уу? гэдэг тийм зохицуулалт. Шүүгээд үзэхээр хэрэглэсэн 140 хэргийн 74% нь шүүх нэхэмжлэлийн шаардлага хангаж шийдвэрлэхдээ ерөнхий хуулийг хэрэглэсэн байна. Тэгэхлээр ямар тохиолдолд шүүх нэхэмжлэлийн шаардлага хангахдаа тухайн хуулийг хэрэглэж байна гэдэг бол захиргааны байгууллага шийдвэр гаргахдаа хуульд заасан зохицуулалтыг дагаагүй, мөрдөөгүй, эсхүл бүрэн дүүрэн ойлгож хэрэглэж чадаагүй байна гэж ойлгохоор байна. Энэ нь 74%. Гэхдээ зарим нь нэхэмжлэлийг бүрэн хангасан, зарим нь нэхэмжлэлийн зарим хэсгийг хангасан шийдвэрүүд байна. Нарийвчлан шүүх дээр яг ямар зохицуулалт хэрэглэгдээд байна гэвэл захиргаа шийдвэрээ гаргахдаа чи хэрэглээгүй байна гэж үзээд байгаа зохицуулалт байна уу? нэхэмжлэлийн шаардлага хангасан зохицуулалтыг үзвэл “зарчим” байгаа. Төрийн үйл ажиллагааны тусгай зарчим гээд шинэ хуульд нэлээн харийн юмнууд орж ирсэн. Хоёрдугаарт оролцогчийн эрхийн зохицуулалт байна. Захиргааны шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцогчийн эрхийг энэ хуулиар нэлээн тодорхой болгож өгсөн. Тэгэхээр оролцогчийн эрхийг барьж шүүх шийдэж байна гэсэн үг. Үүний цаана юу харагдаж байна гэхлээр захиргаа шийдвэр гаргахдаа тэр тусмаа сөрөг үйлчлэл бүхий шийдвэр гаргахдаа оролцогчийг татан оролцуулах эрхийг нь хангах тал дээр асуудалтай байна гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Нөгөө талаас нь нөхцөл байдлыг урьдчилан тогтоох, сонсох ажиллагаа явуулах гэсэн 2 бүлэг зохицуулалт байгаа. 24, 25, 26, 27 дугаар зүйлийн зохицуулалтууд. Энэ нэг талаас шинэлэг зохицуулалт.

Ашигт малтмалын тухай хууль бол шийдвэр гаргахаасаа өмнө урьдчилж нөгөө этгээддээ хэлдэг зохицуулалт байсан бусад хуульд байгаагүй.

Сонсох ажиллагаа явуулах зохицуулалт бол шинэ. Тиймээс манай захиргаа хэрэглэхдээ алдаа оноотой юм байгаа юм шиг байна.

Мөн аливаа шийдвэр гаргахдаа нөхцөл байдлыг урьдчилан тогтоо гэдэг зохицуулалт орж ирсэн. Энэ нь манай практикт хүн ажлаас халчихаад шүүгдэхээр араас нь ажлаас халсан үндэслэл юмаа бүрдүүлдэг. Энэ асуудлын хувьд урьдчилаад тэр үндэслэлүүдийг нь тогтоож байгаад шийдэх ёстой. Үүнтэй холбоотой алдаа гаргадаг. Алдааг гаргахгүйн тулд ерөнхий хуульд урьдчилаад тогтоо гэсэн заалт оруулж ирсэн. Үүнийг бас шүүх нэлээдгүй барьж хэрэг маргаан шийдвэрлэсэн байна.

Нөгөө нэг бүлэг зүйл бол захиргааны актад тавигдах шаардлага. Бичгээр гарч байгаа захиргааны акт бол дийлэнх хүний эрх рүү чиглэсэн шийдвэр байгаа. Энд тавигдаж байгаа. Агуулгын хувьд нэгдүгээрт та гаргасан шийдвэрээ нөгөө хүндээ мэдэгдсэн байх ёстой. Тэр мэдэгдэх үүрэг танд бий болсон. Мэдэгдсэн эсэх талаар маргаан гарвал захиргаа мэдэгдсэнээ нотолно гэсэн ийм зохицуулалт орсон. Нөгөөх нь бичгээр гаргаж байгаа захиргааны актад энэ шийдвэрийг зөвшөөрөхгүй байгаа тохиолдолд хаана ямар хугацаанд гомдол гаргах тухай акт

Remove Watermark Now

өөрөө дотроо агуулах ёстой гэсэн агуулгыг шинэ хуульд оруулсан. Энэ нь иргэнд ч, захиргаанд ч амар, цаашлаад шүүхэд маргааныг шийдвэрлэхэд ч дөхөмтэй. Энэ тохиолдолд иргэн би мэдээгүй гэж мэлзэх боломжгүй зохицуулалт болсон. Эдгээрийг шүүх дээр хэрэглэгдсэн байна.

Нэг маргаантай зүйл бол илт хууль бус захиргааны акт гэж юуг хэлэх юм бэ? гэдэг юм байгаа. Энэ нь агуулгын хувьд маргаан төдийлөн байхгүй. Энэ яагаад маргаан дагуулаад байна гэхээр ерөнхий хуулийг дагаж гарсан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалт буюу илт хууль бус болохыг тогтоолгох нэхэмжлэлд хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй гэсэн зохицуулалт орсон. Үүнтэй холбоотой хуульчид, өмгөөлөгчид ашиглаж хугацаа алдсан юмнуудаар  шүүхэд маргах ийм механизм нэлээд байгаа. Үүнтэй холбоотой илт хууль бус болохыг тогтоолгох нөхцөл нэлээн хөндөгдөж байгаа.

Мөн гомдол гаргах журамтай холбоотой зохицуулалтууд хэрэглэгдсэн байдаг юм байна. Хамгийн түгээмэл давтамжтай хэрэглэгдэж байгаа шүүх өөрийн шийдвэрийн үндэслэл болгож захиргааг буруутгаж буй тэр заалтууд энэ байна. Зарчмаа барихгүй байна, хууль төгс биш тодорхой бус зохицуулалтууд нэлээн байдаг. Яг тэр маргааныг шүүх шийдэхдээ зарчмаа хардаг захиргааны үйл ажиллагааны зарчимтай нийцээгүй байвал таны шийдвэр үйл ажиллагаа зарчимдаа нийцээгүй байна гэж явдаг.

Сонсох ажиллагааг хийх ёстой, хийх боломжгүй тохиолдлуудаа маш тодорхой захиргаа өөрөө заагаад хуульд заасан үндэслэлүүдийг маш тодорхой дурдаад тодорхойлоод явах ёстой. Ингээд шүүх дээр маргаан гарсан тохиолдолд ийм нөхцөл байдал байсан гэдгээ шүүх дээр нотлоход л болно.

Ерөнхий хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 бодит нөхцөл байдлаа бүрэн дүүрэн судалж байж энэ шийдвэрээ гаргаарай гэсэн үндэслэлээр захиргааны актыг хүчингүй болгож байгаа тохиолдол их байна. Саяны ярьдаг бол ерөнхий хуулийн ерөнхий зохицуулалтын талаар байсан. Одоо тодорхой хэдэн маргаан дагуулсан зүйл, заалтуудын талаар ярья.

Нэгдүгээрт сая Энхбаяр сайд ярьсан ерөнхий хуулийн 5.1.1-ийн захиргааны байгууллагыг тодорхойлсон тодорхойлолт дотор Засгийн газар буюу гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх дээд байгууллага орох юм уу? орохгүй юм уу? гэж. Энэ асуудалтай холбоотой маргаан, шүүхийн шийдвэр хүртэл гарсан байгаа. Би хувь хүний байр сууриа илэрхийлж болохгүй байгаа. Дараа нь шүүх дээр ийм асуудал үүсдэг учраас ер нь бол энэ тийм маргаантай асуудал биш. Өөрөөр хэлбэл ямар тохиолдолд Засгийн газрын шийдвэр, үйл ажиллагаа Захиргааны ерөнхий хуулийн хяналт буюу ер нь хуулийн хяналтад байх ёстой юм?, ямар тохиолдолд байхгүй юм гэдгийг онолын тайлбар хийх журмаар хийх боломжтой. Тухайлах юм бол Засгийн газар өөрөө бол миний ойлгож байгаагаар 90% захиргааны байгууллагын, магадгүй 10% улс төрийн шийдвэр гаргадаг байгууллага мөн. Тэгэхээр ерөнхий хуулийн өөрийн нь агуулгыг бүрэн ашиглаж чадах юм бол энэ үүсээд байгаа тодорхой тохиолдлыг шийдээд явах боломжтой. Түүнээс биш Засгийн газар ерөөсөө шүүхийн хяналтад байна гэж ойлгож болохгүй. Харин хяналтыг хэрэгжүүлж байгаа этгээд нь шүүх юм. Цаад эрх нь зөрчигдөж байгаа этгээд эрхээ хамгаалуулах хянуулах боломжтой байна уу? гэдэг л асуудал.

Хоёр дахь асуудал ерөнхий хуулийн 47.1.6 бол захиргааны актыг ямар тохиолдолд илт хууль бус гэж тооцох бэ? Үүний нэг үндэслэл байгаа, иргэн хуулийн этгээдийн эрх хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байгаагүй гээд. 47.1.6-ийн зохицуулалт маргаан үүсгээд байгаа. Яагаад маргаан үүсээд байна гэхээр хөөн хэлэлцэх хугацаанаас тойрох хандлага нэлээн байгаа. Хөөн хэлэлцэх хугацаа алдсан дээрээ 47.1.6-г барьж маргадаг. Тэгэхлээр илт хууль бус тооцох энэ зохицуулалт бол уг нь их тодорхой. Илт хууль бус уу? үгүй юу гэдэг дээр маргах аргагүй байх ёстой. Хэрвээ энэ илт хууль бус биш ч юм шиг, мөн ч юм шиг болоод ирвэл энэ илт хууль бус биш байх ёстой. Энэ нь хүчингүй болгох захиргааны актаасаа үр дагавраараа илүү ялгаатай байдаг учраас энэ дээр нэлээн маргаан гардаг.

Мөн Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 1-ийг 47.1.6-тай цуг хэрэглэх ёстой. Захиргааны үйл ажиллагаа хуулиас эх авсан, тодорхой тохиолдол үүссэн үед шийдвэр гаргах ёстой.

pdfelement

Remove Watermark Now

Мөн 50.1, 50.2 гэсэн зохицуулалт шинээр орж ирсэн. Энэ нь захиргааны акт гараад үйлчлээд актад гомдол гаргах хугацаа дууссан тохиолдолд захиргааны шийдвэр гаргах ажиллагааг дахин хийх. Үүнтэй холбоотой маргаан бас гарсан байна.

Төгсгөлд нь хэлэх нэг зүйл бол энэ судалгаан дээрээс харвал ерөнхий хууль бусад хуулиудын өрсөлдөөнтэй байдал, аль хууль нь хэрэглэгдэх бэ? ямар тохиолдолд гэсэн асуудал үүсэж байна. Үүн дээр ерөнхий хуулийн 3.3 зэрэг заалтуудыг харах хэрэгтэй. Шийдвэр гаргах эрх бүхий байгууллага шийдвэр гаргаад гаргасан шийдвэрт гомдол гаргаад гомдол нь хангагдаагүй бол шийдвэр хэрэгждэг байх ёстой. Харин гаргасан шийдвэрээ хэрэгжүүлэх гэхээр яаж хэрэгжүүлэх бэ? гээд асуудал үүсдэг. Үүнийг шийдэхийн тулд захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаа гээд бүхэл бүтэн бүлэг орж ирсэн. Одоо ямар асуудал байна гэхээр захиргааны байгууллагын шийдвэрийг биелүүлэх байгууллага байхгүй байна гэсэн асуудал яригдаж байна. Энэ асуудлыг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар гаргасан захиргааны эсрэг гаргасан шийдвэрийг биелүүлэхтэй хольж болохгүй. Хэм хэмжээний актын талаар маргаан нэлээн байгаа. Хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө 119 дүгээр тогтоолын харьяалалд ордоггүй байсан бие даасан агентлаг, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын шийдвэрийг яах бэ? гэдэгтэй холбоотой маргаанууд нэлээн байна. За ингээд танилцуулга зогсооё.

**Уулзалт, ярилцлагыг чиглүүлэгчээс**: Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой хууль хэрэглээний явцад манай захиргааны байгууллагуудаас гаргасан шийдвэртэй холбоотой гарсан маргаан шүүхийн хяналтад орж хянагдах явцад болон шүүх шийдвэрээ гаргахдаа энэ хуулийн хэрэглээний явцад хийгдсэн судалгааны дүнг товчхон байдлаар мэдээлэл өгсөн Ц.Цогт шүүгчдээ баярлалаа.

Өнөөдрийн уулзалт ярилцлагын гол хэсэг рүүгээ бид орж байна. Одоо бүгдээрээ захиргааны ерөнхий хуулийг хэрэглээд явж байхад ямар хүндрэл бэрхшээлтэй асуудлууд гарч байна гэдгийг ярилцах цаг эхэлж байна. Тэгэхээр Захиргааны ерөнхий хуулийн ажлын хэсэгт зөвлөхөөр ажилласан Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, доктор, профессор П.Одгэрэл, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Ц.Цогт, Хууль зүйн сургуулийн багш, доктор Д.Сүнжид, Хууль зүй, дотоод хэргийн яамны захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн дарга Д.Ариунтуяа нарыг урьд зассан суудлуудад суухыг урьж байна. Эдгээр хүмүүс та бүхний Захиргааны ерөнхий хууль хэрэгжүүлэх явцад гарч байгаа асуудлаа асууж тодруулаад ярилцаад явъя. Мөн захиргааны хэм хэмжээний актын тухайд манай хэлтсийнхэн байгаа тул хариуцсан байгууллагын асуултад хариулт авах боломжтой байгааг бас хэлье.

**Чөлөөт ярилцлагын цаг**.

**Авлигатай тамцэх газар**: Эрүүгийн хууль дээр үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэдэг ойлголт байдаг.  Энэ нь 6 ба түүнээш дээш сарын цалнгийн хэмжээний давсан орлого олоод түүнийгээ тайлбарлаж чадаагүй тохиолдолд үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэдэгт ойлголтод ордог. Эрүүгийн хэрэг гэж авч үзэх гэхээр хөөн хэлэлцэх хугацаа нь дууссан. Энэ тохиолдолд аль шүүхэд хандах вэ?

**Шүүгч Цогт:** ЗЕХ-ийн хэрэглээтэй яаж холбогдох билээ? Гэмт хэрэг үү? захиргааны хэрэг үү? Эрүүгийн хэргийн талаар мэдээлэл өгч чадахгүй. Зөрчлийн хуулиар шийдвэрлэх боломжтой байх.

**Одгэрэл багш:** Ер нь бол сөрөг захиргааны акт гаргаж байгаа бол захиргааны байгууллага өөрөө нотлох ёстой. Захиргааны байгууллага өөрөө нотлож чадхааргүй бол эрүүгийн хэрэг болохгүй. Нотлох үүргийг захиргаа нь гүйцэтгэх ёстой.

**Авлигатай тамцэх газар**: Сонсох ажиллагааны талаар тодруулга авмаар байна. Бид иргэний хүсэлтийн дагуу ажиллагаа явуулдаг. Энэ ажиллагаанд шалгадаж байгаа албан тушаалтай мөн өргөдөл гаргагч хамаардаг. Үүний дараа хэргийг шийдвэрлээд тухайн шалгагдаж байгаа этгээдийн хамаарах дээд албан тушаалтан болон байгууллагад нь албан тоот хүргүүлдэг. Албан тоотоо явуулахаасаа өмнө шалгагдаж байгаа албан тушаалтандаа сонсох ажиллагааг хийдэг. Энэ тохиолдолд манайх тухай шалгагдаж байгаа этгээдэд сонсох ажиллагааг хийх үү, эсвэл тухайн шалгагдаж байгаа этгээдийн  удирдлага нь сонсох ажиллагааг хийх ёстой юу?

Remove Watermark Now

Авлигатай тэмцэх газраас хүргүүлж байгаа бичгүүдийг шүүх өөр өөрөөр хүлээж аваад байна. Жишээ нь албан тушаалтан ажлаас халагдаад бүх шатны шүүхээр яваад дээд шүүхэд очиход тухайн албан хаагчийг халсан шийдвэр нь акт үндэслэж халаагүй АТГ-ын бичгийг үндэслэж халсан байна гэсэн шийдвэр гагаж буцаасан байдаг. Бас нэг шүүх нь АТГ-ын албан бичиг үндэслэж халах нь үндэслэлтэй гэх мэтчилэн өөр өөр шийдвэрүүд гараад байна. Иймд захиргааны акт ямар байх талаар тайлбарлаж өгөөч.

Мөн ЗЕХ-ын 28.1.3-ийг үндэсэлж шийдвэрлэж байвал сонсох ажиллагааг хийхгүй байж болно гэсэн байдаг. Үүнийг тайлбарлаж өгөөч.

**Шүүгч Цогт:** Миний бодлоор АТГ-ын бичиг, тухайн байгууллагын шийдвэрийг алийг нь акт гэж үзэх маргаантай асуудал. Процессийн хуулиар хариуцагчаар нэг байгууллага орж байгаа тохиолдолд наад 2 шүүх дээр хэлэлцэж байгаа хэргийг нэгтгэх боломжтой. Захиргааны актын гол шалгуур нь аль акт нь эрх зүйн үр дагвар үүсгэж байгаа гэдгээр л тодорхойлогдоно. Хэрвээ танай бичгийг акт гэж үзэж байвал тухай байгууллагын шийдвэрийг акт гэж үзэх шаардлага байхгүй. Одоо эндээс наад асуудлыг чинь шийдэх боломжгүй байна.

**Сүнжид багш:** Захиргааны ерөнхий хуулийн тайлбар дээр саналыг акт гэж үзэхгүй. Цаашид хууль хэрэглээний талаар тодорхой болгох шаардлагатай.

**Одгэрэл багш:** Танай албан бичгийг биелүүлэх үүрэгтэй бол захиргааны акт, өөрчлөх боломжтой бол захиргааны акт биш болно. Сонсох ажиллагааг хийхдээ иймийм хуулийг үндэслэж байна гэдгээ тайлбарласан бол дахиж хийх шаардлагагүй гарахгүй. Түрүүн хэлсэнчлэн 28.1.3-т сонсох ажиллагааг хийхгүй талаар асуусан. Сонсох ажиллагааг эрх ашиг нь хөндөгдөж байгаа этгээдэд сонсох боломжоор хангах, харин өргөдөл гомдол гаргасан этгээдэд сонсох албагүй.

**Шүүгч Цогт:** Сонсох ажиллагааг хийхдээ холбогдох бүх хуулийг тусгаж байвал сайн. Дараа нь маргаан гарсан тохиолдолд холбогдох хуулийн заалтуудаа дурьдаж сонсох ажмллагааг хийсэн гэдгээ нотолсон байхад болно. Нийтийн эрх ашгийг хөндөх онцгой үед буюу халдварт өвчин гарсан үед сонсох ажиллагааг хийх шаардлагагүй.

pdfelement

**ТАЗ Сосор:** Захиргааны ерөнхий хуулинд хохирол барагдуулах гэсэн бүлэг заалт орсон байгаа. Үндсэндээ энэ нь Захиргааны ерөнхий хуулийн гол заалтын нэг гэж үзэж байна. ТАЗ-өөс тус заалтанд их хүлээлт тавьж байсан. Захиргааны ерөнхий хууль батлагдахаас өмнө ТАЗ, Төрийн албаны тухай хуулийг баримтлан буруутай албан тушаалтнаас хохирол нөхөн төлүүлэх гэж шүүхээр хоёр ч удаа ороод амжилт олоогүй. Үүнээс харж байхад бусад улс оронд ямар зохицуулалттай байдгийг мэдэхгүй, буруутай албан тушаалтнаас уг хохирлыг барагдуулж байгаа явдал хэр байдгийг мэдэхгүй байна, манайд бол буруутай албан тушаалтнаас хохирол барагдуулах байтугай тухайн байгууллагын төсвөөс мөнгө гаргаж харин нөгөө буруутай албан тушаалтан хариуцлага хүлээхгүй байна нэгдүгээрт.

Хоёр дугаарт, хууль бус захиргааны акттай холбоотой хэрэг маргаан үүсгэн шүүхээр явж байна, хугацааны хувьд хамгийн наад тал нь 1 жил 3 сар болдог түүнээс дээш 3 жил ч болдог. Шинэчлэн батлагдсан төрийн албаны тухай хуулинд тухайн албан тушаалтаныг халсан, сольсонтой холбоотойгоор тухайн ажлыг хэн гүйцэтгэх зэрэг асуудал маргаантай болдог. Тухайлбал: тухайн ажилтныг халсан нь үнэн, бусад холбогдох баримт бичгээр тодорхой, шүүх шийдчих асуудал дээр нөгөө өмгөөлөгч нь янз бүрийн жижиг асуудлуудыг гарган ирж тухай шүүх хурлыг сунжруулаад хугацаа аваад байдаг.

Гуравдугаарт нь: Хууль бус томилгооны асуудал байна. Шалгалт өгсөн өгөөгүй хамаагүй томилоод тэр нь жилийн дараа ирдэг, хожим шүүх дээр очоод уначихна, яагаад унав? гэтэл тэр хүний буруу биш нөгөө томилсон албан тушаалтны буюу захиргааны буруу байдаг гэтэл түүнээс хойш олон хүн 2, 3 дахь хүн солигдоод өнгөрсөн байдаг. Гэтэл эцэст нь ямар нэг байдлаар томилогдсон хүн хожоод үлддэг зэрэг иймасуудлууд байна. Мөн түрүүн ярьж байсан Засгийн газар Захиргааны хэргийн шүүхэд хариуцагч биш гээд, яаж ч бодсон хариуцагч болоод явж байна, тухайлбал: засгийн газрын тийм тийм тогтоолоор томилсугай гээд, захиргааны шүүхийн харьяалал биш иргэний шүүхээр явна гэсэн ч адилхан шүүхээр л явна. Харин ч Захиргааны хэргийн дагнасан шүүх байхад яагаад энэнээс татгалзаад байдаг юм ерөөсөө ойлгохгүй юм.

**Цогт шүүгч**: Захиргааны ерөнхий хуулийн дагуу хохирлын асуудал дээр хоёр байгууллага үүрэг хүлээж байна. /Аудит, шүүх/ Дээд шатны захиргааны байгууллага доод шатны захиргааны

Remove Watermark Now

байгууллагынхаа шийдвэрийг хууль бусын тогтоогоод хүчингүй болгоод түүнээс үүдсэн хохирлыг шийдэж байгаа тохиолдолд дээд шатны захиргааны байгууллага тус шийдвэрээ Үндэсний аудитын газарлуу явуулна, төсвийн хөрөнгийн зарцуулалтанд гол хяналт тавьж байгаа байгууллага бол аудит юм. Шүүх зөвхөн төрийн албаны маргаан бус, хууль бус захиргааны актаас учирсан хохирлыг буруутай этгээдээс гаргуулахаар шийдсэн тохиолдолд шийдвэрээ мөн аудитруу явуулах зохицуулалттай байгаа. Үндэсний аудитад хуулиар хүлээсэн үүрэг байгаа. Үндсэндээ Дээд шатны захиргааны байгууллага, Шүүх, Аудит гэсэн эдгээр 3 байгууллага хууль бус захиргааны актаас үүдэлтэй хохирлыг нөхөн төлөх асуудалд гол үүрэг гүйцэтгэдэг байгууллага юм. Шүүхийн хугацааны хувьд тусгай журмаар явагдах зохицуулалттай хэд хэдэн зохицуулалтыг заасан: Тендер, сонгууль зэрэг асуудлыг богино хугацаанд шийдвэрлэнэ гэж заасан байгаа, магадгүй түрүүний сонгон шалгаруулалттай холбоотой асуудалд уялдуулаан харьцагуй богино хугацаанд шийдвэрлэх саналыг ТАЗ-с гаргаад ажлын хэсэгт саналаа оруулсан гэж ойлгож байгаа. Гэхдээ манай улс шиг шүүхэд хянан шийдвэрлэх хугацааг ийм богинохон хугацаанд тогтоосон улс орон хаана ч  байхгүй. Хойшилдог тохиолдол байгаа ч 60 хоногийн дотор хурлын товыг заавал зарлана. Хууль бусаар томилогдсон хэрэг маргаан гарч байна, уг хүнийг томилсон шийдвэр хэний гаргасан шийдвэр юм? гэхээр захиргаа л байдаг. Захиргаа шүүхэд орж ирээд юу гэдэг вэ гэхээр өмнөх дарга гэдэг, одоо бол өмнөх дарга гэсэн ойголт байхгүй, шүүхэд зөвхөн захиргаа гэдгээр л ойлгогдоно, гэхдээ бүх хэрэгт ингэж яваагүй, миний мэдэж байгаагаар үнэхээр шаардлага хангахгүй, мэргэжил байхгүй, тэр ажлыг хийх чадваргүй тийм хүнийг дарга нар сонгуулиар явж байгаад томилчихдог, тийм тохиолдод тухайн хүнийг ажлаа үргэлжлүүлэн хийх боломжтой байна уу, үгүй байна уу тогтоох хэрэгтэй.

**Одгэрэл багш:** Хохирлын талаар Захиргааны ерөнхий хууль дээр нэмэлт хийж болох уу үгүй юу гэдэгт Захиргааны ерөнхий хууль өөрөө төрийн алба, ашигт малтмал, татвар гээд бүх зүйлд үйлчлэх ёстой. Төрийн албаны буруутай этгээдээс хохирол учирч байгаа тохиолдолд уг нь тэр албан тушаалтан хариуцлага хүлээх ёстой гээд хуульчилбал маш сайн, энийг захиргааны ерөнхий хууль дээр биш харин төрийн албаны тухай хууль дээр оруулбал дээр, захиргааны ерөнхий хуульд  оруулчихвал ашигт малтмал ч юмуу арай өөр төрийн албан хаагчдад үйлчлэхэд арай хүндрэлтэй, тийм болохоор төрийн албаны хууль дээр байвал их зүгээр байна. Хууль бус томилгооны асуудал гэдэгт мөн адилхан ялангуяа Төрийн албаны тухай хууль дээр төрийн албан хаагчийг ажлаас халсан шийдвэр гээд тусдаа бүлэг оруулбал тун зүгээр.

**Д.Сүнжид:** Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 18.54-т зааснаар нийтийн өмчийг хамгаалахаар Төрийн бус байгууллагууд захиргааны шүүхэд хандах эрхтэй. Захиргааны ерөнхий хуулийн 103 заалтаар төрийн бус байгууллагууд  буруутай үйлдлийг нэхэмжлэх боломжтой болж байгаа юм. 2018 онд энэ хохиролын асуудал, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар заалттай холбоотой асуудлууд нэг тийшээ шийдвэрлэгдэх байх гэж бодож байна. Төрийн бус байгууллага нийтийн өмч, хүүхдийн эрх, эрүүл мэнд, хүрээлэн буй орчны асуудлаар захиргааны шүүхэд хандаж болно гэж судлаач, хуульч хүний хувьд харж байна.

**ХЭҮК Өнөржаргал:** Сүүлийн таван жил хууль, хүний эрхийг хангаж байгаа эсэх дээр судалгаа хийж ажиллаж байна. Захиргааны ерөнхий хуультай холбоотой эргэлзээтэй асуудлууд гарч байгаа, манайх хүний эрхтэй холбоотой аливаа асуудлаар санал гаргах, захиргааны шийдвэр хүний эрхийн зарчмын хэм хэмжээнд нийцсэн байхад санал гаргах, олон улсын гэрээ, конвенцид нэгдэн орох асуудалд санал гаргах гэх зэрэг. Захиргааны хэм хэмжээний актад манай коммиссын шаардлага зөвлөмж, санал гэж гардаг. Шаардлага зөвлөмж нь захиргааны акт мөн эсэхэд тодохойлоход хүндрэлтэй байдаг гэтэл цаана нь хүний эрхийг зөрчсөн асуудал гарчихсан байдаг үүний нэг жишээ АББД-ын асуудал юм. Үүнд хэн хамаарах вэ гэхэд эрх бүхий албан тушаалтан байдаг, манайд ирсэн гомдлын дагуу бид шалгаад буруутай этгээдэд шаардлага зөвлөмжийг хүргүүлдэг, гэтэл үүнийг захиргааны акт гэж үзэх үү, учир нь энэ захирамжилсан шинжтэй гэж үзэж тухайн эрх бүхий албан тушаалтны дээд албан тушаалтанд хариуцлага тооцуулах шаардлага зөвлөмжийг хүргүүлдэг, гэтэл манай комиссоос гаргасан шаардлага зөвлөмжийг тухайн албан тушаалтан мөн хууль бус гэж үзэн хүчингүйд тооцдог. Хэрэв захиргааны акт гэж үзэх бол хоёр хуулийг хэрэглэх боломжтой юм. Нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актын хувьд хүний эрхийн зарчимд нийцэж байна уу гэдэгт саналын товьёог өгч ажилладаг бөгөөд шинээр батлагдсан Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуульд манай комиссыг нийтээр дагах хэм хэмжээ тогтоох байгууллагаар шууд оруулсан байдаг гэтэл манайх нийтээр дагах хэм хэмжээ тогтоох байгууллага биш энэ нь хуулийн хийдлийг бий болгож байгаа юм, гэх мэтчилэн шинээр гарч байгаа хуулиудад зөрчил их байх юм. Энэ бүхэнд та бүхний саналыг сонсъё.

Remove Watermark Now

**Цогт шүүгч:** Хүний эрхийн шаардлага зөвлөмжтэй холбоотой маргаан манай шүүхээр орж байсан /гэхдээ нэг л хэрэг/. Шүүхийн практик нэг хэргээр тогтоно гэж байхгүй, ер нь онол ойлголтоо нэгтгээд явах шаарлагатай. Шат шатны шүүх өөр өөрөөр шийдвэрлэсэн зарим нь акт гэж үзсэн бол зарим нь биш гэж үзсэн. ХЭҮК-ийн гишүүний шаардлага зөвлөмжийн асуудал нь дээр дурдсан АТГ-ийн албан бичиг акт мөн үү биш үү гэдэгтэй яг адилхан. Яагаад гэвэл, ХЭҮК-ийн шаардлага зөвлөмж нь их тодорхой, тухайн халах, томилох албан тушаалтанд шаардлага хүргүүлнэ, арга хэмжээ аваад тэд хоногийн дотор хариу мэдэгдэнэ гэсэн заалт байдаг, харин мэдэгдэхгүй бол комисс өөрөө шүүхэд хандана гэдэг. Захиргааны акт гаргадаг эрх бүхий этгээд байхын тулд өөр этгээдээс санал авдаггүй, тухайн акт гарснаараа өөрөө асуудлыг эцэслээд, эрх зүйн үр дагавар шууд үүсдэг байх шаардлагатай. Түрүүний тохиолдолд комиссын шаардлага зөвлөмжийг энэ бол захиргааны акт мөн гэж шийдсэн байдаг. Ер нь ингээд шүүхэд хандаж байвал ажлаас нь халсан хөдөлмөрийн маргаан болж байгаа юм.

**Ариунтуяа дарга:** Манайх ЗХХА-ын бүртгэлийг хийдэг. ХЭҮК нь нийт төрийн байгууллагад хамааралтай журам огт байдаггүй зөвхөн хуулийн заалтаар үйл ажилагаагаа явуулдаг гэж ойлголоо. Түрүүн дурдсан нийслэл болон 21 аймгаас гарч байгаа актуудыг хүний эрх зөрчсөн эсэх талаар хянадаг гэж ярьсан үүнийг журамласан бол бид бүртгээд явна.

**Цогт шүүгч:** ХЗДХЯ-ны хувьд мэргэжлийн яам гэдэг үүднээс бүх яам, агетлаг, байгууллагуудын шийдвэрт урьдчилсан хяналт хийх эрх нь олгогдсон.

**Одгэрэл багш:** Хэм хэмжээний актууд бүгд ХЗДХЯ-аар хянагдахаар төсөлд тусагдсан боловч УИХ дээр хуулийг хэлэлцэх үед УИХ-ын хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг ЗГ-т хүргүүлэхээр өөрчлөлт орсон. Уул санаа нь ХЗДХЯ мэргэжлийн яам гэдгээрээ хянах шаардлагатай байсан.

**Ариунтуяа дарга:** Хяналт гэдэг нь хуулиар эрх олгогдсон эсэхийг хянаж байгаа гэдгийг ойлгох хэрэгтэй.

**ТАЗ Сосор:** Захиргааны байгууллагын шийдвэрийн талаар олон жил судалгаа хийсэн хүний хувьд ЗЕХ бол захиргааны үйл ажиллагааг хуульчилсан, актын талаар, захиргааны хэм хэмжээний актын шалгуурын талаар маш сайн ойлголтыг тусгаж өгсөн хууль юм. Сайжрах зүйлүүд байгаа хэдий ч яаран битгий өөрчлөлт оруулаарай гэж хэлмээр байна.

**Одгэрэл багш:** ЗЕХ-ийн 8-р зүйлд тусгайлан заасан бүрэн эрх гэдэг заалт бий. Энэ заалт нь онцгойлон харьяалах эрхийг оруулж өгөх гэсэн заалт юм.

**Цогт шүүгч:** 100 хувийн хамтын удирдлагатай байгууллагын хувьд орон тооны гишүүдээрээ шийдвэрлэж болох асуудлыг шийдвэрлэж өгөхөөр зорьсон заалт. Жишээ нь: ИТХ-ын эзгүйд тэргүүлэгчид нь тодорхой онцгой бүрэн эрхийг шийдвэрлэхээр хуульд заасан байдаг.

Бие даасан агентлагуудын ЗГ-ын агентлагаас ялгардаг онцлог зүйл нь салбартаа хэм хэмжээ тогтоосон акт гаргах замаар салбартаа зохицуулалт хийх эрхтэй байдаг. Энэ эрхээ ЗЕХ-д нийцүүлэн салбарын хуулиндаа сайн тусгаж өгөх хэрэгтэй. Салбарын хуульд ЗЕХ-ын суурь ойголтруу халдсан зохицуулалт тусгаж болохгүй гэдгийг анхаарах хэрэгтэй.

**СЕХ Бат-эрдэнэ :** ЗЕХ-ийн 60.1.8 дахь заалт нь зөвхөн батлах эрхийг заасан заалтаа оруулж өгөхөөр заасан байдаг. Уул нь иргэдэд ойлгомжтой байх үүднээс эшлэл авалгүйгээр бүтэн заалтаар буюу хамааралтай бүх заалтыг бичиж байх саналтай байна. Мөн ЗЕХ-ийн 5.2.3 дахь заалтын талаар тайлбар авмаар байна.

**Ариунтуяа дарга:** Ер нь бол журам дээр хууль их хуулж бичих хандлагатай байдаг. Түүнээс ХЗДХЯ эшлэл хийгээгүй байна гээд журам буцаасан тохиолдолд байхгүй. Нэгэнт хуулиар зохицуулан асуудлыг журмаар зохицуулах шаардлага байхгүй гэсэн санаагаар уг заалтыг хуульд тусгасан.

**Цогт шүүгч:** ЗЕХ-ийн 5.2.3 дахь заалтын хувьд танайх орон нутгийн сонгуулийн хороогоо татан буулгачихдаг. Харин татан буугдсаны дараа маргаан гарвал хариуцах эзэнгүй болдог. Хамгийн гол нь СЕХ байгуулсан байгууллагаа татан буулгахдаа хөөн хэлэлцэх хугацаагаа харах хэрэгтэй. Мөн шүүхэд маргах хугацаа дууссан эсэхийг давхар харгалзан үзэж байж татан буулгах хэрэгтэй. Үүнээс үүдэлтэйгээр маргаан гарвал тухайн татан буулгасан хороог байгуулсан СЕХ-г хариуцагчаар татахаас өөр арга байхгүй болдог.

Хэлэлцүүлэгт оролцсон та бүхэнд баярлалаа.
Уулзалт, ярилцлага 12 цаг 30 минутад дуусав.

ТАНИЛЦСАН: ЗХХАХБХ-ийн ахлах мэргэжилтэн Э.Сэлэнгэ
ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН: ЗХХАХБХ-ийн мэргэжилтэн М.Мөнх-Алдар

Remove Watermark Now

# ХОЁР. Захиргааны ерөнхий хуулийн I, II, IV, X дугаар бүлгийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан

Гүйцэтгэсэн:

- **Т.Мөнх-Эрдэнэ**
  /МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхмийн багш, хууль зүйн магистр (LL.M-University of Vienna)/
- **А.Сарангэрэл**
  /Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч/
- **Б.Алтантуяа**
  /Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын мэргэжилтэн/

pdfelement

Remove Watermark Now

# ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН 1 ДҮГЭЭР БҮЛГИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

## НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

1.1. Үнэлгээ хийх үндэслэл, шаардлага

"Хууль тогтоомжийн тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт "... хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно" гэж заасан. Мөн Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд "Захиргааны ерөнхий хууль"-д нэмэлт, өөрчлөлт хийхээр тусгажээ.[5]

Энэхүү үндэслэл, шаардлагын хүрээнд Захиргааны ерөнхий хуульд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-ыг ерөнхийд нь баримтлан үнэлгээг хийж, гүйцэтгэлээ.

Захиргааны ерөнхий хууль нь нийтийн эрх зүйн хүрээнд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэн захиргааны байгууллагаас захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт гаргах, захиргааны гэрээ байгуулах замаар иргэн, хуулийн этгээдтэй харилцах үйл ажиллагааны эрх зүйн суурь зохицуулалтыг бүрдүүлэх зорилго бүхий хууль бөгөөд энэхүү зорилгодоо хүрэхэд бодитой хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх, тус хуулийг практикт хэрэглэхэд тулгамдаж буй үндсэн болон бусад ямар асуудал байгаа эсэхийг тодруулахад энэхүү хэрэгжилтийн үнэлгээний судалгааны зорилго оршино.

pdfelement

1.2. Үнэлгээ хийх хүрээ

ЗЕХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажил нь тус хуулийг бүхэлд нь хамарч буй хэдий ч яг энэхүү үнэлгээний ажлын хүрээнд ЗЕХ-ийн 1 дүгээр бүлэг /Нийтлэг үндэслэл/-ийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.7, 4 дүгээр зүйлийн 4.2.6, 4.2.8 дахь заалтуудын хэрэгжилтийг судалж, түүний үр дагаврын үнэлгээг хийхээр судалгааны хүрээг тогтоосон болно.

1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт

1.3.1. "Хүлээн зөвшөөрөгдсөн байдал" шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг баталсантай холбоотойгоор ЗЕХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтад "... зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, ..." гэж нэмэлт оруулсан нь практик дээр хууль хэрэглэж буй шүүгч, хуулийг хэрэгжүүлж ажиллаж буй захиргааны байгууллагууд, захиргааны эрх зүйн салбарын эрдэмтэн судлаачид, хуульчдын дунд ихээхэн маргаан дагуулсан бөгөөд эндээс үндэслэж энэхүү нэмэлт өөрчлөлтийн хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг судлах шаардлагыг нөхцөлдүүлсэн. Сонгосон заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

| д/д | Сонгосон зүйл, заалт | Зүйл, заалтын агуулга |
|---|---|---|

[5] УИХ-ын 2017.01.12-ны өдрийн 11 дүгээр тогтоолын Хавсралтын 151-ийг үзэх.

Remove Watermark Now

| | | |
|---|---|---|
| 1 | ЗЕХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын тодруулсан хэсэг | 3.1.4. хууль сахиулах, гэмт хэрэг хянан шийдвэрлэх, **зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа**, түүнд тавих прокурорын хяналт, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа; |

1.3.2. “Практикт хэрэгжиж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд хэд хэдэн зүйл, заалтын практик хэрэгжилтийг судлах шаардлагатай байна. Тэдгээрийн багцлан үзвэл, ЗЕХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалт, 4 дүгээр зүйлийн 4.2.6, 4.2.8 дахь заалтууд юм. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

| д/д | Сонгосон зүйл, заалт | Зүйл, заалтын агуулга |
|---|---|---|
| 1 | ЗЕХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын тодруулсан хэсэг | 3.1.4. хууль сахиулах, гэмт хэрэг хянан шийдвэрлэх, **зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа**, түүнд тавих прокурорын хяналт, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа; |
| 2 | ЗЕХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалт | 3.1.7. улс төрийн шийдвэр гаргах ажиллагаа.<br><br>Тайлбар: Улс төрийн шийдвэр гаргах ажиллагаа гэж улс төрийн байгууллага, албан тушаалтны хуульд заасан бүрэн эрхэд шалгуургүйгээр заасан, эсхүл шүүхийн журмаар шалган тогтоох боломжгүй шийдвэр гаргах ажиллагааг ойлгоно. Улс төрийн албан тушаалтан, байгууллага дангаараа шийдвэр гаргасныг улс төрийн шийдвэр гаргах ажиллагаанд хамааруулах үндэслэл болохгүй. |
| 3 | ЗЕХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.2.6, | 4.2.6. бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах тохиолдолд тэдгээрт урьдчилан мэдэгдэх, оролцоог нь хангах; |
| 4 | ЗЕХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.2.8 дахь заалт | 4.2.8. .хууль ёсны итгэлийг хамгаалах.<br><br>Тайлбар: Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим гэж нийтийн эрх зүйн аливаа харилцаанд захиргааны үйл ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээдэд эдийн буюу мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх эрх зүйн үр дагавар үүссэн тохиолдлыг ойлгоно. Харин энэ хуулийн 48.2-т заасан тохиолдол үүсвэл захиргааны үйл ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээдийн итгэл хамгаалагдахгүй. Иргэн, хуулийн этгээдэд эерэг үр дагавар үүсэхээр байсан ч уг харилцаа дууссан бол итгэл хамгаалах зарчим хэрэглэгдэхгүй. |

1.4. Үнэлгээний арга зүй

Энэхүү үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг ерөнхийд нь



pdfelement

баримтлан хийж гүйцэтгэв. Түүнчлэн ЗЕХ-ийн дээр дурдсан зүйл, заалтуудын хэрэгжилтийг судлахдаа эрх зүйн харьцуулалт хийх, задлан шинжлэх (анализ), баримт бичигт дүн шинжилгээ хийх, ярилцлага хийх гэсэн хууль зүйн шинжлэх ухааны судалгааны аргуудыг ашигласан болно. Түүнчлэн Ханнс-Зайделийн сан, "Эрх зүйн боловсрол" академиас 2017 онд эрхлэн гаргасан ЗЕХ-ийн хэрэглээ, судалгааны зориулалт бүхий шинжлэх ухааны тайлбар, ХБНГУ-ын захиргааны эрх зүйн хүлээн зөвшөөрөгдсөн ном зохиол, Захиргааны үйл ажиллагааны тухай хуулийн шинжлэх ухааны тайлбар, гарын авлагаас гадна, төрийн албан хаагчид, шүүгчдээс авсан ярилцлагын судалгааны үр дүнг ашигласан болно.

## ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

### 2.1. "Хүлээн зөвшөөрөгдсөн байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Монгол Улсын Их Хурал 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг баталж, улмаар энэхүү хууль батлагдсантай холбогдуулан Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтад "зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа"-нд ЗЕХ үйлчлэхгүй байхаар нэмэлт оруулжээ. Тодруулбал, хууль тогтоогч зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа захиргааны байгууллагын үйл ажиллагааг захиргааны үйл ажиллагаа биш гэж үзэж дээрх нэмэлтийг оруулсан байна.

Гэвч дээрх нэмэлт нь практик дээр хууль хэрэглэж буй шүүгч, хуулийг хэрэгжүүлэн ажиллаж буй захиргааны байгууллага, захиргааны эрх зүйн салбарын эрдэмтэн судлаачид, хуульчдын дунд ихээхэн шүүмжлэл[6] дагуулж байгаагаас үзвэл энэхүү нэмэлтийн хүлээн зөвшөөрөгдөх байдал дутмаг байгааг илтгэж байна.

Түүнчлэн, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд ЗЕХ үйлчлэхгүй байхаар хуульчилж, улмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас гарснаас бусад шийдвэрийг захиргааны акт байхаар нэмэлт оруулсныг үндсэн хуулийн зөрчил бүхий байна гэж үзэж Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс Улсын Дээд шүүхэд санал хүргүүлж, улмаар Улсын Дээд шүүх энэхүү саналыг үндэслэлтэй гэж үзэж, Үндсэн хуулийн цэцэд хянуулахаар хүсэлт явуулсан байна.[7]

Эдгээр тогтоолуудыг үндэслэн одоогоор Нийслэл дэх захиргааны анхан шатны шүүхэд зөрчлийн хэрэг үүсгэн хянагдаж байгаа нийт зөрчлийн хэргүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг Үндсэн хуулийн цэцийн шийдвэр эцэслэн гарах хүртэл хугацаагаар түдгэлзүүлэн шийдвэрлэж байна. Өөрөөр хэлбэл, захиргааны хэргийн шүүхэд зөрчлийн хэргийг өнөөдрийн байдлаар шийдвэрлээгүй, түдгэлзүүлсэн байдалтай байна.

---

[6] Энэ асуудлаар Монголын Хуульчдын холбооны Захиргааны эрх зүйн хорооноос "Зөрчлийн тухай хууль ба Татварын хууль тогтоомжийн уялдаа, хэрэглээ" сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийг нийт хуульч, судлаачдын дунд зохион байгуулсан байх бөгөөд тэрхүү хэлэлцүүлэгт оролцож илтгэл тавьсан, санал бодлоо хэлсэн хуульч, судлаачид Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг захиргааны үйл ажиллагаа биш гэж үзсэн хэрнээ Захиргааны хэргийн шүүх зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаан дахь гомдлыг хянан үзэхээр хуульчилсан нь зөрчилдөөнтэй болсныг шүүмжилж байсан байна.

[7] Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 221/ШТ2018/0085 дугаартай тогтоол



Remove Watermark Now

ЗЕХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтад зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа нь захиргааны үйл ажиллагаа биш гэсэн атлаа, улмаар Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт энэ маргааныг захиргааны хэргийн шүүх хянан хэлэлцэхгүй байтал Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Оролцогч энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.7, 6.10, 6.11, 6.12, 6.14, 6.15, 6.16, 6.17, 6.18, 6.19, 6.20, 6.21, 6.22, 6.23, 6.24, 6.25, 6.27 дахь заалтад заасан эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрийг эс зөвшөөрвөл Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар гомдол гаргаж шийдвэрлүүлнэ" гэж заасан нь ихээхэн зөрчилдөөнтэй болжээ.

**2.2. "Практикт хэрэгжиж байгаа байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал**

**1/ ЗЕХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын "... зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, ..." гэсэн хэсгийн тухайд:**

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд ЗЕХ үйлчлэхгүй байхаар хуульчилж, улмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас гарснаас бусад шийдвэрийг захиргааны акт байхаар нэмэлт оруулсныг үндсэн хуулийн зөрчил бүхий байна гэж үзэж Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс Улсын Дээд шүүхэд санал хүргүүлж, улмаар Улсын Дээд шүүх энэхүү саналыг үндэслэлтэй гэж үзэж, Үндсэн хуулийн цэцэд хянуулахаар хүсэлт явуулсан байна.[8]

Эдгээр тогтоолуудыг үндэслэн одоогоор Нийслэл дэх захиргааны анхан шатны шүүхэд зөрчлийн хэрэг үүсгэн хянагдаж байгаа нийт зөрчлийн хэргүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг Үндсэн хуулийн цэцийн шийдвэр эцэслэн гарах хүртэл хугацаагаар түдгэлзүүлэн шийдвэрлэж байна. Өөрөөр хэлбэл, захиргааны хэргийн шүүхэд зөрчлийн хэргийг өнөөдрийн байдлаар шийдвэрлээгүй, түдгэлзүүлсэн байдалтай байна.

**2/ ЗЕХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь заалтын тухайд:**

Орчин үеийн захиргааны эрх зүйн онолд нийтийн захиргаа буюу захиргааны байгууллагыг тодорхойлохдоо формаль болон материаллаг аспектыг аль алиныг нь хослуулах чиг хандлагатай болсон.[9] Нийтийн захиргааг формаль болон материаллаг аспектыг хослуулан тодорхойлохдоо төрийн гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагааг дотор нь **губернатив[10]болон административ** гэж хоёр ангилан авч үзнэ. Тодруулан тайлбарлавал, гүйцэтгэх эрх мэдлийн улс төрийн болон бодлогын шинжтэй үйл ажиллагааг гүйцэтгэх эрх мэдлийн административ буюу захиргааны үйл ажиллагаанаас салган зааглах учиртай.[11] Улс төрийн болон бодлогын шинжтэй үйл ажиллагаа нь Засгийн газрын үйл ажиллагаа байна гэдэг нь тодорхой хэдий ч нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна.

Улс төрийн болон бодлогын шинжтэй үйл ажиллагаа гэдэгт төрийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлдог, тодорхойлсон чиглэлийнхээ хүрээнд төрийн үйл

---

[8] Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 221/ШТ2018/0085 дугаартай тогтоол
[9] Hartmut Maurer, Allgemeines Verwaltungsrecht, 16. Auflage, Verlag C.H.Beck, 3дахь тал
[10] Улс төрийн болон бодлогын шинжтэй шийдвэр гаргах үйл ажиллагаа /цаашид энэ томъёоллоор авч үзнэ/, Т.М.
[11] Alfred Katz, Staatsrecht Grundkurs im öffentlichen Recht, 12.überarbeitete Auflage, Verlag C.F.Müller, 192дахь тал

ажиллагааг уялдуулан зохицуулдаг, ингэхдээ төрийн үйл ажиллагааг улс төрийн удирдлагаар хангах замаар улс төрийн хувьд удирддаг Засгийн газрын улс төрийн шинжтэй үйл ажиллагааг ойлгоно.[12] Тухайлбал, Засгийн газраас үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, стратеги төлөвлөгөө, хөгжлийн хөтөлбөр, үндэсний болон бүс нутгийн бодлого, салбарын бусад бодлогын баримт бичгийг ямар нэг хууль зүйн шалгуургүйгээр боловсруулж батлах, түүнийгээ хэрэгжүүлэхдээ доод шатны байгууллагууддаа удирдамж, чиглэл өгөх, улс төрийн удирдлагаар хангах, Төрийн албаны тухай хуульд заасан улс төрийн албан тушаалтнуудыг эрх хэмжээнийхээ хүрээнд томилж, чөлөөлөх гэх мэт Засгийн газрын улс төрийн шинжтэй[13] болон бодлогын шинжтэй үйл ажиллагаа нь губернатив үйл ажиллагаа болно. Засгийн газрын эл үйл ажиллагаа нь нэгэнт захиргааны үйл ажиллагаа биш тул Захиргааны хэргийн шүүхийн хяналтаас гадуур байна.

Гэтэл манай улсын өнөөгийн шүүхийн практикаас авч үзэхэд Захиргааны хэргийн шүүх захиргааны байгууллагын улс төрийн болон бодлогын шинжтэй үйл ажиллагааг түүний захиргааны үйл ажиллагаанаас тодорхой зааглахгүйгээр захиргааны хэрэг үүсгэх, хэргийн оролцогчид улс төрийн болон бодлогын шинжтэй шийдвэр мөн, биш хэмээн маргаж байхад түүнд нь тодорхой эрх зүйн дүгнэлт хийхгүйгээр шийдсэн кэйс 3 гарсан байна[14] (**Хавсралт 1**-ээс үзэж болно). Өөрөөр хэлбэл, ЗЕХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.7[15] дахь заалтад заасан захиргааны байгууллагын улс төрийн шийдвэр гаргах ажиллагаа захиргааны үйл ажиллагаа биш гэсэн заалтыг анхаарахгүйгээр, эсхүл түүнийг буруу тайлбарлан хэрэглэж байгаа асуудал захиргааны хэргийн шүүхийн практикт байгааг анхаарах хэрэгтэй байна.

**3/ ЗЕХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.2.6 дахь заалтын тухайд:**

ЗЕХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.2.6 дахь заалтад “бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах тохиолдолд тэдгээрт урьдчилан мэдэгдэх, оролцоог нь хангах” тусгай зарчмыг хуульчилж өгсөн байна.

Энэхүү зарчмыг хуульчлах болсон зорилго нь захиргааны байгууллагаас гадагш чиглэсэн шийдвэр нь хэн нэг этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөхөөр байвал уг этгээдэд захиргааны байгууллага мэдэгдэх, тэдний саналыг авах, сонсох ажиллагааг явуулах үүргийг бэхжүүлэх явдал юм. Энэ зарчим нь ЗЕХ-ийн 26 дугаар зүйл, 27-28 дугаар зүйл, 43 дугаар зүйл, 62 дугаар зүйл, 63 дугаар зүйл, 74-77 дугаар зүйлтэй шууд уялдаа холбоотой байна.

ЗЕХ хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш захиргааны байгууллагууд энэхүү зарчмыг үйл ажиллагаандаа баримталж ажиллаж байгаа эсэх нь харилцан адилгүй байгаа гэдэг нь шүүхийн шийдвэрийн статистикаар нотлогдож байна. ЗЕХ хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойшхи хугацаанд ЗЕХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.2.6 дахь заалтыг үндэслэн хэрэглэж шийдвэрлэсэн 34 кэйс гарсан байх[16] бөгөөд дийлэнх нь энэ

[12]Мөн тэнд
[13]Политика буюу улс төр гэх ухагдахууны хүрээнд нийгмийн амьдралыг удирдан зохион байгуулах төрөл бүрийн бодлогыг ойлгодог. Жишээ нь: Хууль зүйн бодлого, эдийн засгийн бодлого, соёлын бодлого, бүс нутгийн бодлого гэх мэт. Энэ талаар Wolff/Bachof, Verwaltungsrecht I, §18 Ib дахь хэсэгт.
[14] Шүүхийн шийдвэрийг шүүхийн шийдвэрийн цахим сангаас шүүлт хийж хайсан болно, Т.М.
[15]Зарчмын хувьд уг заалтын гол зорилго бол аливаа захиргааны байгууллагын улс төрийн болон бодлогын шинжтэй үйл ажиллагааг захиргааны үйл ажиллагаа биш гэж тооцож, энэ хүрээнд Захиргааны хэргийн шүүх иргэн, хуулийн этгээдийн эрхийн зөрчил бий болсон эсэхийг хянах шаардлагагүй байхаар хуульчилсан ач холбогдлыг анхааран үзэх шаардлагатай юм, Т.М.
[16] Шүүхийн шийдвэрийг шүүхийн шийдвэрийн цахим сангаас шүүлт хийж хайсан болно, Т.М.



Remove Watermark Now

Remove Watermark Now

зарчмыг захиргааны байгууллага баримталж ажиллаагүй гэсэн эрх зүйн дүгнэлтийг хийжээ (**Хавсралт 2**-оос үзэх боломжтой).

Эндээс үзвэл, ЗЕХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.2.6 дахь заалтад заасан зарчим нь захиргааны байгууллагуудад бүрэн дүүрэн хэрэгжиж байгаа хэмээн дүгнэх боломжгүй байна.

**4/ ЗЕХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.2.8 дахь заалтын тухайд:**

ЗЕХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.2.8 дахь заалтад "хууль ёсны итгэлийг хамгаалах" тусгай зарчмыг хуульчилсан бөгөөд энэхүү тусгай зарчим нь манай улсын захиргааны байгууллагын үйл ажиллагаанд өмнө нь төдийлөн танил биш, эрх зүйн хэлбэрт ороогүй байсан зарчим учраас хууль тогтоогч "Хууль ёсны итгэлийг хамгаалах зарчим гэж нийтийн эрх зүйн аливаа харилцаанд захиргааны үйл ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээдэд эдийн буюу мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх эрх зүйн үр дагавар үүссэн тохиолдлыг ойлгоно. Харин энэ хуулийн 48.2-т заасан тохиолдол үүсвэл захиргааны үйл ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээдийн итгэл хамгаалагдахгүй. Иргэн, хуулийн этгээдэд эерэг үр дагавар үүсэхээр байсан ч уг харилцаа дууссан бол итгэл хамгаалах зарчим хэрэглэгдэхгүй" гэсэн аутентик тайлбарыг хийж өгсөн.

Энэхүү зарчмыг хуульчлах болсон зорилго нь эрх зүйт төрийн хууль тогтоомжийн хүрээнд иргэн, хуулийн этгээдэд үүсдэг хууль ёсны итгэлийг нь захиргааны байгууллага хүндэтгэж, хамгаалж ажиллах явдлыг бэхжүүлэх асуудал юм. Энэхүү зарчим нь ЗЕХ-ийн 37.4, 37.5, 48.2, 49 дүгээр зүйлүүдтэй уялдаа холбоотой хэрэглэгдэнэ.

ЗЕХ хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш захиргааны байгууллагууд энэхүү зарчмыг үйл ажиллагаандаа баримталж ажиллаж байгаа эсэх нь судалгааны явцад ажиглагдаагүй бөгөөд Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар, Сүхбаатар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, түүний ажлын алба, аймгийн нутгийн захиргааны байгууллагын удирдлагууд, холбогдох ажилтнуудтай хийсэн ярилцлагын үеэр энэхүү заалтыг хэрэглэж шийдвэр гаргаж байсан тохиолдлыг асуухад байхгүй байсан нь анхаарал татаж байсан болно.

pdfelement

ЗЕХ хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойшхи хугацаанд ЗЕХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.2.8 дахь заалтыг үндэслэн хэрэглэж шийдвэрлэсэн зөвхөн 1 кэйс гарсан байна[17] (**Хавсралт 2**). Эндээс үзвэл, ЗЕХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.2.8 дахь заалтад заасан зарчим нь захиргааны байгууллагуудад бүрэн дүүрэн хэрэгжиж байгаа хэмээн дүгнэх боломжгүй байна.

## ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Захиргааны ерөнхий хууль 2015 онд батлагдсанаас хойш 3 жил, хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш 2 орчим жил өнгөрчээ. Энэ хугацаанд тус хуулийн хэрэгжилтийн талаар судалгаа хийгдэж байгаагүй байна. Энэхүү хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх судалгааны ажлын хүрээнд 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.7, 4 дүгээр зүйлийн 4.2.6, 4.2.8 дахь заалтыг сонгон авч, практикт хэрхэн хэрэгжиж байгаа эсэхийг үнэлж дүгнэхийг зорьсон болно. Иймээс энэхүү үнэлгээний ажилд сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах дүгнэлтийг хийж байна.

*"Хүлээн зөвшөөрөгдсөн байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд:*

[17] Шүүхийн шийдвэрийг шүүхийн шийдвэрийн цахим сангаас шүүлт хийж хайсан болно, Т.М.

Remove Watermark Now

ЗЕХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтад “зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа”-нд ЗЕХ үйлчлэхгүй гэсэн нэмэлтэд хийсэн дүгнэлт.

ЗЕХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтад зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа нь захиргааны үйл ажиллагаа биш гэсэн атлаа, улмаар Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт энэ маргааныг захиргааны хэргийн шүүх хянан хэлэлцэхгүй байтал Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Оролцогч энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.7, 6.10, 6.11, 6.12, 6.14, 6.15, 6.16, 6.17, 6.18, 6.19, 6.20, 6.21, 6.22, 6.23, 6.24, 6.25, 6.27 дахь заалтад заасан эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрийг эс зөвшөөрвөл Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар гомдол гаргаж шийдвэрлүүлнэ” гэж заасан нь ихээхэн зөрчилдөөнтэй болсон төдийгүй практикт хүлээн зөвшөөрөгдөх байдал нь дутмаг байна.

“Практикт хэрэгжиж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

1. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд ЗЕХ үйлчлэхгүй байхаар хуульчилж, улмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас гарснаас бусад шийдвэрийг захиргааны акт байхаар нэмэлт оруулсныг үндсэн хуулийн зөрчил бүхий байна гэж үзэж Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс Улсын дээд шүүхэд санал хүргүүлж, улмаар Улсын дээд шүүх энэхүү саналыг үндэслэлтэй гэж үзэж, Үндсэн хуулийн цэцэд хянуулахаар хүсэлт явуулсан байна. Эдгээр тогтоолуудыг үндэслэн одоогоор Нийслэл дэх захиргааны анхан шатны шүүхэд зөрчлийн хэрэг үүсгэн хянагдаж байгаа нийт зөрчлийн хэргүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг Үндсэн хуулийн цэцийн шийдвэр эцэслэн гарах хүртэл хугацаагаар түдгэлзүүлэн шийдвэрлэж байна. Өөрөөр хэлбэл, захиргааны хэргийн шүүхэд зөрчлийн хэргийг өнөөдрийн байдлаар шийдвэрлээгүй, түдгэлзүүлсэн байдалтай байна.

pdfelement

2. Манай улсын өнөөгийн шүүхийн практикаас авч үзэхэд Захиргааны хэргийн шүүх захиргааны байгууллагын улс төрийн болон бодлогын шинжтэй үйл ажиллагааг түүний захиргааны үйл ажиллагаанаас тодорхой зааглахгүйгээр захиргааны хэрэг үүсгэх, хэргийн оролцогчид улс төрийн болон бодлогын шинжтэй шийдвэр мөн, биш хэмээн маргаж байхад түүнд нь тодорхой эрх зүйн дүгнэлт хийхгүйгээр шийдсэн кэйс 3 гарсан байх бөгөөд эндээс үзвэл шүүхийн практикт ЗЕХ-ийн 3.1.7 дахь заалтыг зөв хэрэглэхгүй байна гэж дүгнэлээ.

3. ЗЕХ хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойшхи хугацаанд ЗЕХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.2.6 дахь заалтыг үндэслэн хэрэглэж шийдвэрлэсэн 34 кэйс гарсан байх[18] бөгөөд дийлэнх нь энэ зарчмыг захиргааны байгууллага баримталж ажиллаагүй гэсэн эрх зүйн дүгнэлтийг хийжээ. Эндээс үзвэл, ЗЕХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.2.6 дахь заалтад заасан зарчим нь захиргааны байгууллагуудад бүрэн дүүрэн хэрэгжихгүй байна.

4. ЗЕХ хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойшхи хугацаанд ЗЕХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.2.8 дахь заалтыг үндэслэн хэрэглэж шийдвэрлэсэн зөвхөн 1 кэйс гарсан байх бөгөөд эндээс тус заалт амьдралд хэрхэн хэрэгжиж байгаа талаар дүгнэлт өгөх боломжгүй байна.

[18] Шүүхийн шийдвэрийг шүүхийн шийдвэрийн цахим сангаас шүүлт хийж хайсан болно, Т.М.

Remove Watermark Now

# ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН 2 ДУГААР БҮЛГИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

## НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

### 1.1. Үнэлгээ хийх үндэслэл, шаардлага

"Хууль тогтоомжийн тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт "... хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно" гэж заасан. Мөн Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд "Захиргааны ерөнхий хууль"-д нэмэлт, өөрчлөлт хийхээр тусгажээ.

Энэхүү үндэслэл, шаардлагын хүрээнд Захиргааны ерөнхий хуульд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан "Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-ыг ерөнхийд нь баримтлан үнэлгээг хийж, гүйцэтгэлээ.

Захиргааны ерөнхий хууль нь нийтийн эрх зүйн хүрээнд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэн захиргааны байгууллагаас захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт гаргах, захиргааны гэрээ байгуулах замаар иргэн, хуулийн этгээдтэй харилцах үйл ажиллагааны эрх зүйн суурь зохицуулалтыг бүрдүүлэх зорилго бүхий хууль бөгөөд энэхүү зорилгодоо хүрэхэд бодитой хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх, тус хуулийг практикт хэрэглэхэд тулгамдаж буй үндсэн болон бусад ямар асуудал байгаа эсэхийг тодруулахад энэхүү хэрэгжилтийн үнэлгээний судалгааны зорилго оршино.

### 1.2. Үнэлгээ хийх хүрээ

ЗЕХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажил нь тус хуулийг бүхэлд нь хамарч буй хэдий ч яг энэхүү үнэлгээний ажлын хүрээнд ЗЕХ-ийн 2 дугаар бүлэг /Захиргааны байгууллага/-ийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.5, 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалтуудын хэрэгжилтийг судалж, түүний үр дагаврын үнэлгээг хийхээр судалгааны хүрээг тогтоосон болно.

### 1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт

#### 1.3.1. "Зорилгод хүрсэн байдал" шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

ЗЕХ-ийн 1 дүгээр зүйлд тусгаснаар энэ хуулийн зорилтыг "... нийтийн эрх зүйн хүрээнд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэн захиргааны байгууллагаас захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт гаргах, захиргааны гэрээ байгуулах замаар иргэн, хуулийн этгээдтэй харилцах үйл ажиллагааны эрх зүйн суурь зохицуулалтыг бүрдүүлэхэд оршино" гэж тодорхойлжээ. Үүнээс үзэхэд ЗЕХ-аар зохицуулах шаардлагатай үндсэн зорилтын нэг бол ямар үйл ажиллагааг захиргааны байгууллагын үйл ажиллагаа гэж тооцох, түүнчлэн ямар байгууллагуудыг захиргааны байгууллага гэж ойлгохтой холбогдсон харилцааг зохицуулах явдал болох нь харагдаж байна. Иймд энэхүү үнэлгээний шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дээр дурдсан зорилтыг хангахтай холбогдуулан ЗЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.5 дахь заалтуудад захиргааны байгууллагад хамаарах этгээдүүдийг тодорхойлон зааж өгснийг тус тус сонгож[19], эдгээр

[19]Тухайлбал, сүүлийн үед энэ заалттай холбоотойгоор Засгийн газар нь захиргааны байгууллага мөн, эсхүл биш гэсэн маргаан өрнөж байгаа.



pdfelement

заалтуудын хэрэгжилтийг “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээг хийх нь зүйтэй гэж үзлээ. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

| дд | Сонгосон зүйл, заалт | Зүйл, заалтын агуулга |
|---|---|---|
| 1 | ЗЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.5 дахь заалт | 5 дугаар зүйл.<br>5.1.Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг дараах нийтийн эрх зүйн этгээдийг захиргааны байгууллага гэж ойлгоно:<br>5.1.1.төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага;<br>5.1.5.нутгийн өөрөө удирдах байгууллага болон шийдвэр, үйл ажиллагаанд нь захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргахаар хуульд тусгайлан заасан байгууллага. |
| 2 | ЗЕХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1 | 8.1.Хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно. |

1.3.2. “Практикт хэрэгжиж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

ЗЕХ-д гарч буй тулгамдсан асуудлуудыг багцлан авч үзвэл хэд хэдэн тулгамдсан асуудал байгаа гэж үзэж болох юм. Тэдгээрийн нэг нь ЗЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.5 дахь заалт юм.

ЗЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.5 дахь заалтад:

“- төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага;

- нутгийн өөрөө удирдах байгууллага болон шийдвэр, үйл ажиллагаанд нь захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргахаар хуульд тусгайлан заасан байгууллага” гэж тус тус захиргааны байгууллагад хамаарах этгээдүүдийг зааж өгөхдөө төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа буюу хууль хэрэгжүүлж байгаа нийтийн захиргааны байгууллагуудыг бүхэлд нь хамрахуйц байдлаар ойлгомжтой, тодорхой хуульчилж өгч чадсан эсэхэд анхаарах шаардлага байж болох юм. Иймээс энэхүү хэсэгт “Практикт хэрэгжиж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд дээр дурдсан эрх зүйн зохицуулалтуудыг сонгож, эерэг болон сөрөг үр дагаврыг тодруулан үнэлгээ хийхээр энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

1.4. Үнэлгээний арга зүй

Энэхүү үнэлгээг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ыг ерөнхийд нь баримтлан хийж гүйцэтгэв. Түүнчлэн ЗЕХ-ийн дээр дурдсан зүйл, заалтуудын хэрэгжилтийг судлахдаа эрх зүйн харьцуулалт хийх, задлан шинжлэх (анализ), баримт бичигт дүн шинжилгээ хийх, ярилцлага хийх гэсэн хууль зүйн шинжлэх ухааны судалгааны аргуудыг ашигласан болно. Түүнчлэн Ханнс-Зайделийн сан, “Эрх зүйн боловсрол” академиас 2017 онд эрхлэн гаргасан ЗЕХ-ийн хэрэглээ, судалгааны зориулалт бүхий шинжлэх ухааны тайлбар, ХБНГУ-ын захиргааны эрх зүйн хүлээн зөвшөөрөгдсөн ном зохиол, Захиргааны үйл ажиллагааны тухай хуулийн шинжлэх ухааны тайлбар, гарын авлагаас гадна, төрийн албан хаагчид, шүүгчдээс авсан ярилцлагын судалгааны үр дүнг ашигласан болно.



Remove Watermark Now

Remove Watermark Now

# ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

## 2.1. “Зорилгод хүрсэн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Юуны өмнө ЗЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтад төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв болон орон нутгийн байгууллагыг, 5.1.5 дахь заалтад нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг тус тус захиргааны байгууллага хэмээн хуульчлан тодорхойлохдоо ЗЕХ-ийн 1 дүгээр зүйлд заасан “нийтийн эрх зүйн хүрээнд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг захиргааны байгууллага”-ыг бүхэлд нь болоод оновчтой тодорхойлох хуулийн зорилгод хүрсэн эсэхийг тодруулахын тулд Үндсэн хуулийн эрх зүйн болон орчин үеийн захиргааны эрх зүйн онолын хүрээнд захиргааны байгууллагыг хэрхэн авч үздэгийг тайлбарлах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Тийм ч учраас нийтийн захиргааны байгууллагыг тодорхойлдог онолын үзэл баримтлалын хүрээнд судалгаа хийсэн болно (Хавсралт 3. Онолын судалгааг үзнэ үү).

ЗЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтад захиргааны байгууллагыг тодорхойлохдоо Монгол Улсын Засгийн газрыг түүнд хамааруулсан эсэх нь онолын хийгээд шүүхийн практик дээр маргаан өрнүүлж байгаа[20] тул энэ асуудал дээр судалгааны нарийвчилсан хүрээг тогтоож, тухайлсан хариу өгөхийг зорив.

УИХ-аас 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр баталсан ЗЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг дараах нийтийн эрх зүйн этгээдийг захиргааны байгууллага гэж ойлгоно:” гэж захиргааны байгууллагын ерөнхий шинжийг тодорхойлсон, мөн зүйлийн 5.1.1 дэх заалтад “төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага;” захиргааны байгууллага байна гэж заасан.

Дээр дурдсан заалтын “төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв байгууллага” гэдэгт Монгол Улсын Засгийн газар хамаарахаар ойлгож, хуульчилсан гэдгийг ЗЕХ-ийг боловсруулахад оролцсон ажлын гишүүдийн бэлтгэсэн “Захиргааны ерөнхий хууль /сургалтын гарын авлага/, 2016”-ын 29 дэх талд, “Захиргааны ерөнхий хуулийн тайлбар /судалгаа, хэрэглээний/, 2017”-ын 79 дэх талд болон профессор, доктор П.Одгэрэлийн “Захиргааны эрх зүйн ерөнхий анги, 2016” сурах бичгийн 106 дахь талд маш тодорхой дурдсан байна. Өөрөөр хэлбэл, ЗЕХ-ийн зорилго болон гол үзэл баримтлал нь бүхий л захиргааны байгууллагын үйл ажиллагааг журамласан суурь зохицуулалтыг бий болгох, түүний тулд захиргааны үйл ажиллагаа явуулж буй нийтийн захиргааны байгууллагуудын хамрах хүрээг хуульчлан тодорхойлох явдал байсан байна.

ЗЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтад буй “төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага” гэдгийг эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах системчлэх аргуудын хүрээнд тайлбарлавал:

- ЗЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтад заасан “төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага” гэдгийг төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг байгууллагуудын холбогдох хууль тогтоомжоор хүлээсэн **чиг үүргийн**(Засгийн газар, түүний харьяаны

[20]Тухайлбал Хурдан морины бүсийн уралдааны 2017 оны хуваарийг тогтоох тухай Засгийн газрын 2017 оны 63 дугаар тогтоолын хүрээнд практикт маргаан гарч, Захиргааны хэргийн шүүхээр уг маргаан нь шийдвэрлэгдсэн билээ. Тухайн үед Монгол Улсын Засгийн газар захиргааны байгууллага мөн/биш гэсэн байр суурь хуульчдын дундаас гарч, энэ талаар 2017 онд “Шүүхийн хяналт ба Засгийн газар” сэдэвт хуульчдын нээлттэй хэлэлцүүлгийг Монголын хуульчдын холбооны Захиргааны эрх зүйн хорооноос зохион байгуулж байсан байна, Т.М.

Remove Watermark Now

захиргааны байгууллагад харьяалуулсан чиг үүргийг гүйцэтгэж байна уу, эсхүл орон нутгийн байгууллагад харьяалуулсан чиг үүргийг гүйцэтгэж байна уу гэдэг гол шалгуур) болон **нутаг дэвсгэрийн харьяалалд** тулгуурлаж төв, орон нутаг гэж хуваасан байна. Өөрөөр хэлбэл, хууль тогтоогч “төрийн захиргааны төв байгууллага” гэсэн явцуу томъёоллыг хэрэглээгүй[21], харин ямар чиг үүргийг гүйцэтгэж, аль нутаг дэвсгэрийн хүрээнд үйлчлэх шийдвэр гаргах эрх бүхий байгууллага вэ гэдгийг шалгуур болгон төв, орон нутгийн гэж ангилсан байна. Тодруулбал, зөвхөн тухайн орон нутгийн хүрээнд үйлчлэх шийдвэр гаргадаг баг, хороо, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Засаг дарга нар төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг орон нутгийн байгууллага, харин улсын нутаг дэвсгэрт бүхэлд нь үйлчилдэг шийдвэр гаргадаг Засгийн газар, яам, агентлагийг төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв байгууллагад багтахаар хуульчилсан байна гэж ойлгож болохоор байна.

Иймд, ЗЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтад заасан “төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага” гэдгийн төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв байгууллага гэдэгт нь Монгол Улсын Засгийн газар багтана гэж ойлгох нь хууль зүйн үндэслэлтэй байна.

## 2.2. “Практикт хэрэгжиж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

ЗЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.5 дахь заалт практикт хэрэгжих явцад Монгол Улсын Засгийн газар захиргааны байгууллага биш, тиймээс түүний үйл ажиллагааг Захиргааны хэргийн шүүх хянах учиргүй, түүнчлэн, Монгол Улсын Ерөнхийлөгч захиргааны байгууллагад хамаарах уу зэрэг маргаантай асуудлууд үүсч, энэхүү маргаан бүхий үндэслэл, тайлбарууд шүүхийн шатанд кэйс болж хувирсан тохиолдол ч гарсан байна.[22] Тиймээс энэ хэсэгт ЗЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.5 дахь заалтын практикт хэрэгжиж байгаа байдлыг дүгнэхдээ Засгийн газар, Ерөнхийлөгч, нутгийн өөрөө удирдах байгууллагыг сонгон авч судалсан болно.

**Нэг.** Монгол Улсын Засгийн газар захиргааны байгууллага болох эсэх тухайд:

Орчин үеийн захиргааны эрх зүйн онолд нийтийн захиргаа буюу захиргааны байгууллагыг тодорхойлохдоо формаль болон материаллаг аспектыг аль алиныг нь хослуулах чиг хандлагатай болсон.[23] Нийтийн захиргааг формаль болон материаллаг аспектыг хослуулан тодорхойлохдоо төрийн гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагааг

---

[21]Энэ тухай дэд профессор, доктор О.Мөнхсайханы бичсэн “Захиргааны хэргийн шүүхээс Засгийн газрын захиргааны үйл ажиллагааг хянах нь Үндсэн хууль зөрчөөгүй” хэмээх өгүүллээс мөн уншиж болно.
https://www.academia.edu/36319877/Zahirgaanii_shuuh_Zasgiin_gazriig_hyanah_ni_2017_03.pdf

[22]Тухайлбал, “Монголиан коппер корпорейшн” ХХК-ийн нэхэмжлэлтэй Монгол Улсын Засгийн газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар хариуцагчаар оролцсон захиргааны хэрэгт хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нь Монгол Улсын Засгийн газар нь захиргааны байгууллага биш тул хариуцагчаар оролцох ёсгүй гэсэн агуулгаар маргасан байна. http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/1010/view
Түүнчлэн, 2013 онд хийгдсэн шүүхийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр Ерөнхийлөгчийн зарлигаар чөлөөлөгдсөн шүүгчдийг бүгдийг нь буцаан томилох ёстой атал заримыг нь үндэслэлгүйгээр буцаан томилоогүй тухай маргаанд Ерөнхийлөгч нь ЗЕХ-д заасан захиргааны байгууллага биш гэсэн дүгнэлтийг захиргааны хэргийн шүүхээс хийж байсан кэйс гарсан байна. Нийслэл дэх Захиргааны хэргийн шатны шүүхийн шүүгчийн захирамж, 2016.09.23, №1125, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн тогтоол, 2016.10.14, №0648.

[23] Hartmut Maurer, Allgemeines Verwaltungsrecht, 16. Auflage, Verlag C.H.Beck, 3дахь тал

дотор нь **губернатив**[24]**болон административ** гэж хоёр ангилан авч үзнэ. Тодруулан тайлбарлавал, гүйцэтгэх эрх мэдлийн улс төрийн болон бодлогын шинжтэй үйл ажиллагааг гүйцэтгэх эрх мэдлийн административ буюу захиргааны үйл ажиллагаанаас салган зааглах учиртай.[25] Улс төрийн болон бодлогын шинжтэй үйл ажиллагаа нь Засгийн газрын үйл ажиллагаа байна гэдэг нь тодорхой хэдий ч нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна.

Улс төрийн болон бодлогын шинжтэй үйл ажиллагаа гэдэгт төрийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлдог, тодорхойлсон чиглэлийнхээ хүрээнд төрийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулдаг, ингэхдээ төрийн үйл ажиллагааг улс төрийн удирдлагаар хангах замаар улс төрийн хувьд удирддаг Засгийн газрын улс төрийн шинжтэй үйл ажиллагааг ойлгоно.[26] Тухайлбал, Засгийн газраас үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, стратеги төлөвлөгөө, хөгжлийн хөтөлбөр, үндэсний болон бүс нутгийн бодлого, салбарын бусад бодлогын баримт бичгийг ямар нэг хууль зүйн шалгуургүйгээр боловсруулж батлах, түүнийгээ хэрэгжүүлэхдээ доод шатны байгууллагууддаа удирдамж, чиглэл өгөх, улс төрийн удирдлагаар хангах, Төрийн албаны тухай хуульд заасан улс төрийн албан тушаалтнуудыг эрх хэмжээнийхээ хүрээнд томилж, чөлөөлөх гэх мэт Засгийн газрын улс төрийн шинжтэй[27]болон бодлогын шинжтэй үйл ажиллагаа нь губернатив үйл ажиллагаа болно. Засгийн газрын эл үйл ажиллагаа нь нэгэнт захиргааны үйл ажиллагаа биш тул Захиргааны хэргийн шүүхийн хяналтаас гадуур байна. Гэтэл манай улсын өнөөгийн шүүхийн практикаас авч үзэхэд Захиргааны хэргийн шүүх Засгийн газрын улс төрийн болон бодлогын шинжтэй үйл ажиллагааг түүний захиргааны үйл ажиллагаанаас тодорхой зааглахгүйгээр захиргааны хэрэг үүсгэх, улмаар улс төрийн болон бодлогын шинжтэй Засгийн газрын шийдвэрийг хянах тохиолдол цөөнгүй гарсан байна. Өөрөөр хэлбэл, ЗЕХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.7[28] дахь заалтад заасан захиргааны байгууллагын улс төрийн шийдвэр гаргах ажиллагаа захиргааны үйл ажиллагаа биш гэсэн заалтыг анхаарахгүйгээр, эсхүл түүнийг буруу тайлбарлан хэрэглэж байгаа асуудал захиргааны хэргийн шүүхийн практикт байгааг анхаарах хэрэгтэй байна.

Харин административ буюу захиргааны үйл ажиллагаа гэдэг нь хууль тогтоогчийн баталсан хууль болон Засгийн газраас гаргасан шийдвэрийн хүрээнд тодорхойлогдсон буюу зохицуулагдсан, хууль тогтоомжийг амьдралд хэрэгжүүлэх хүрээнд хууль, эрх зүйтэй холбогдсон үйл ажиллагааг ойлгоно.[29] Тодруулбал, энд Засгийн газрын болон бусад захиргааны байгууллагын хууль биелүүлж байгаа захиргааны шинжтэй бүх үйл ажиллагаа хамаарна.

Нэгэнт энэ харилцаанд хууль тогтоогчийн батлан гаргасан хуулийг Засгийн газар болон бусад захиргааны байгууллагууд хэрэглэж, хэрэгжүүлдэг тул иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн, эсхүл зөрчсөн шийдвэр гаргадаг.

---

[24] Улс төрийн болон бодлогын шинжтэй шийдвэр гаргах үйл ажиллагаа /цаашид энэ томъёоллоор авч үзнэ/, Т.М.

[25] Alfred Katz, Staatsrecht Grundkurs im öffentlichen Recht, 12.überarbeitete Auflage, Verlag C.F.Müller, 192дахь тал

[26]Мөн тэнд

[27]Политика буюу улс төр гэх ухагдахууны хүрээнд нийгмийн амьдралыг удирдан зохион байгуулах төрөл бүрийн бодлогыг ойлгодог. Жишээ нь: Хууль зүйн бодлого, эдийн засгийн бодлого, соёлын бодлого, бүс нутгийн бодлого гэх мэт. Энэ талаар Wolff/Bachof, Verwaltungsrecht I, §18 Ib дахь хэсэгт.

[28]Зарчмын хувьд уг заалтын гол зорилго бол аливаа захиргааны байгууллагын улс төрийн болон бодлогын шинжтэй үйл ажиллагааг захиргааны үйл ажиллагаа биш гэж тооцож, энэ хүрээнд Захиргааны хэргийн шүүх иргэн, хуулийн этгээдийн эрхийн зөрчил бий болсон эсэхийг хянах шаардлагагүй байхаар хуульчилсан ач холбогдлыг анхааран үзэх шаардлагатай юм, Т.М.

[29] Wolff/Bachof, Verwaltungsrecht I, 76 дахь талаас эхлэн үзэх.



Remove Watermark Now

Remove Watermark Now

Тийм учраас Засгийн газар болон бусад захиргааны байгууллагууд нь иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн, эсхүл зөрчсөн бол шүүхээс тэдгээр иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээх ёстой[30] тул Засгийн газрын болон бусад захиргааны байгууллагын административ буюу захиргааны шинжтэй үйл ажиллагаа нь иргэний эрхийг зөрчсөн бол тэрхүү зөрчигдсөн эрхийг шүүх сэргээх нь зайлшгүй бөгөөд гарцаагүй байх учиртай болдог. Тийм ч учраас хууль тогтоогч Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт "Захиргааны хэргийн шүүх Үндсэн хуулийн цэц болон өөр шүүхэд харьяалуулснаас бусад нийтийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэнэ", Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтад "Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд зааснаас бусад байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа болон тэдгээрийн гаргасан захиргааны актын талаар гаргасан гомдол"-оор иргэний хэрэг үүсгэх тухай заaж өгчээ. **Дээрхээс дүгнэвэл, Монгол Улсын Засгийн газрын шийдвэр, үйл ажиллагаагаар иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдсөн бол захиргааны болон иргэний хэргийн шүүх тус тусын хэргийн харьяаллын дагуу маргааныг шийдвэрлэх нь тодорхой байх бөгөөд хэрэв аль ч шүүх тухайн маргааныг авч хэлэлцэхгүй бол Монгол Улсын Үндсэн хуулийн цэц аль нэг шүүхэд хэргийн харьялал тогтоож өгнө[31]. Энэ бол эрх зүйт төрийн суурь зарчим юм.**

Монгол Улсын Засгийн газар тодорхой иргэн, хуулийн этгээдэд шууд чиглэсэн шинжтэй шийдвэр гаргах хууль зүйн боломж бусад улсын Засгийн газартай харьцуулахад маш өндөр байдаг.[32] Жишээ нь: Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасны дагуу "Тамхи үйлдвэрлэх, тамхины ургамал тарих үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүнс, хөдөө аж ахуйн, тамхи импортлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг үйлдвэр, худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг тус тус үндэслэн Засгийн газар олгоно", Газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалтад заасны дагуу "улсын тусгай хэрэгцээнд авахтай холбогдуулан газрыг солих буюу эргүүлэн авах тохиолдолд нөхөх олговор олгох", 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсэгт заасны дагуу "Газар зохион байгуулалт хийх тухай Засгийн газрын ... шийдвэрийг холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллага биелүүлэх үүрэгтэй", 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэгт заасны дагуу "Засгийн газар аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга газар эзэмшигч, ашиглагчтай урьдчилан тохиролцож, гэрээ байгуулсны үндсэн дээр бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг тодорхой хугацаатайгаар нийтийн эдэлбэрт болон тусгай хэрэгцээнд төлбөртэй буюу төлбөргүйгээр ашиглаж болно", 46.2 дахь хэсэгт заасны дагуу "Засгийн газар нийгмийн зайлшгүй шаардлагыг үндэслэн бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг уг шаардлага арилтал захиргааны журмаар нийтийн эдэлбэрт болон тусгай хэрэгцээнд төлбөртэй буюу төлбөргүйгээр ашиглах тухай шийдвэр гаргаж болно", Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасны дагуу "Засгийн газар 500 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулагчтай түүний гаргасан хүсэлтийн дагуу үйл ажиллагаа явуулах орчныг нь тогтвортой байлгах зорилгоор хөрөнгө оруулалтын гэрээ байгуулна", Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу "Засгийн газар нь ... иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд хортой нөлөөлөл бүхий

[30]Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2, 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт иргэний зөрчигдсөн эрхээ шүүхээр сэргээлгэх үндсэн эрхийг баталгаажуулж өгсөн байдгийг анхаарах.

[31]Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйл.

[32]Тухайлбал, ХБНГУ, Австри зэрэг орнуудын Холбооны Засгийн газар нь шууд иргэн, хуулийн этгээдэд чиглэсэн шийдвэр гаргах тохиолдол түгээмэл бус буюу тийм хууль зүйн боломжийг хууль тогтоогч олгохгүй байхыг анхаардаг, Т.М.

үйлдвэрлэлийн болон бусад үйл ажиллагааг төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг харгалзан өмчийнх нь хэлбэрийг үл харгалзан зогсоох" гэх мэтчилэнгээр холбогдох салбарын хуулиудаар иргэн, хуулийн этгээдэд шууд чиглэсэн захирамжилсан шийдвэр гаргах хууль зүйн боломж Монгол Улсын Засгийн газарт маш их байна.

Тиймээс үүнийг тодруулахын тулд Монгол Улсын Засгийн газар Захиргааны хэргийн шүүхэд хариуцагчаар оролцсон тохиолдлыг судалж үзсэн бөгөөд ЗЕХ хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн хугацаанаас хойш нийт 21 кэйс гарсан байна (Хавсралт 4-ыг үзнэ үү). Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газраас 2017 онд гаргасан нийт шийдвэрүүдээс 106 шийдвэрийг түүвэрлэн авч, тэдгээрт ээлэх захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт болон улс төрийн болон бодлогын шинжтэй шийдвэрийн хувийг тодорхойллоо. Тус 106 шийдвэрийн **8.55%** хувь буюу **9** нь захиргааны акт, **42.4%** хувь буюу **45** нь захиргааны хэм хэмжээний акт, **49.05%** хувь нь буюу **52** нь улс төрийн болон бодлогын шинжтэй шийдвэр байгаа болно (Хавсралт 5. Монгол Улсын Засгийн газрын 2017 онд гаргасан шийдвэрт хийсэн дүн шинжилгээг үзнэ үү).

**Хоёр.** Монгол Улсын Ерөнхийлөгч ЗЕХ-ийн 5 дугаар зүйлд заасан захиргааны байгууллагад хамаарах эсэх тухайд:

*Эрх зүйн зохицуулалт*

Үндсэн хуулийн цэцэд маргаан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1-д "Цэц нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавьж түүнийг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэнэ", 2-т "Үндсэн хуулиас бусад хуулийг зөрчсөн эсэх тухай маргааныг Цэц харьяалан шийдвэрлэхгүй" гэж тус тус заасан.

2002 оны Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар захиргааны хэргийн шүүхийн харьяалан шийдвэрлэх маргааныг жагсаалтын зарчмаар хуульчилсан байсан ба үүнд Ерөнхийлөгч багтаагүй байсан.[33] Харин 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдөр батлагдсан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн §13.1-д "Захиргааны хэргийн шүүх Үндсэн хуулийн цэц болон өөр шүүхэд харьяалуулснаас бусад нийтийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэнэ" хэмээн ерөнхий заалтын зарчмыг хэрэглэх захиргааны хэргийн шүүхийн харьяалан шийдвэрлэх маргааныг нэлээд өргөн хүрээтэйгээр хуульчилсан. Эндээс үзэхэд Ерөнхийлөгчийн Үндсэн хууль зөрчөөгүй буюу бусад органик болон ердийн хуулийг зөрчсөн үйл ажиллагааны улмаас иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн бөгөөд уг маргаан нь нийтийн эрх зүйн маргаан байвал захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэж болохоор ойлгогдож байна.

Нөгөөтэйгүүр, Захиргааны ерөнхий хуулийн §5.4-т "Нийтийн эрх зүйн асуудлаар бие даан, өөрийн нэрийн өмнөөс дангаар захиргааны шийдвэр гаргах бүрэн эрх хуулиар тусгайлан олгогдсон албан тушаалтныг захиргааны байгууллага гэж үзнэ" гэж заасны дагуу Ерөнхийлөгч захиргааны байгууллагад тооцогдох боломжтой. Ерөнхийлөгчид Үндсэн хуулиас гадна бусад хуулиар тодорхой эрхүүд олгогдсон байх бөгөөд үүнд төрийн

---

[33]Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 02 дугаар дүгнэлтээр шийдвэрлэсэн маргаанд тухайн үеийн УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч Р.Эрдэнэбүрэн, С.Баярцогт нар тайлбар иргүүлэхдээ "2002 оны Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн анхны төсөлд Монгол Улсын Ерөнхийлөгчийг захиргааны байгууллагад тооцон Захиргааны хэргийн шүүхээр хянагдах боломжтой байдлаар тусгасан байсан ч хэлэлцүүлгийн явцад Ерөнхийлөгчөөс гадагш чиглэсэн, эрх зүйн шууд үр дагавартай шийдвэр төдийлөн гарахгүй учраас,мөн Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчсөн бол огцруулах асуудлыг нэгэнт Үндсэн хуулиар зохицуулсан учир хуулийн "Монгол Улсын Ерөнхийлөгч" гэсэн заалтыг хассан" тухай тайлбарласан байдаг.



Remove Watermark Now

Remove Watermark Now

жинхэнэ албан хаагчийн томилготой холбоотой эрхүүд багтаж байна. Тухайлбал, Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга, Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, гишүүнийг томилдог. Мөн үүнээс гадна Шүүхийн ёс зүйн хороо, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн орон тооны зөвлөл, хороодын дарга, гишүүнийг томилж байна. Ерөнхийлөгч нь өөрийн зарлигаар олгосон цэргийн цолыг хураан авах эрхийг эдэлнэ.[34] Ерөнхийлөгч 2018 оны 03 дугаар сарын 28-ны өдөр 33 дугаар зарлиг гаргаж Ж.Жекейд олгосон “бригадын генерал” цолыг, 2018 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр Чимэддоржийн Амарболд, Пүрэвийн Даш нарт хүртээсэн “Хошууч генерал” цол, Тожооны Дашдэлэгт хүртээсэн “Бригадын генерал” цолыг тус тус хураан авсан саяхны жишээг дурдаж болно. Хэрэв эдгээр албан тушаалтныг Ерөнхийлөгч үүрэгт ажлаас нь чөлөөлсөн, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн шийдвэр гаргасан тохиолдолд уг маргааныг Үндсэн хуулийн цэц харьяалан шийдвэрлэхгүй гэдэг нь тодорхой байна.

Түүнчлэн, Ерөнхийлөгчийн Монгол Улсаас гадаад улсад суух элчин сайдыг томилох, өөрийн зөвлөхийг томилох, Улсын Их Хурлаас баталсан хуульд бүрэн болон хэсэгчлэн хориг тавих, уучлал хүссэн ялтанд уучлал үзүүлэх гэх мэт шийдвэр нь ямар нэг хууль зүйн шалгуургүйгээр Үндсэн хуулиар олгогдсон өөрийн бүрэн эрх, хүсэл зоригийн үндсэн дээр гардаг тул захиргааны шинжтэй үйл ажиллагаа биш байдаг.

*Шүүхийн практикт гарсан тохиолдол*

2013 онд хийгдсэн шүүхийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхээс бусад шатны шүүхийн нийт 409 шүүгчийг чөлөөлж, тойргийн журмаар байгуулагдсан шинэ шүүхэд буцаан томилуулах тухай саналыг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсэн бөгөөд Ерөнхийлөгч 397 шүүгчийн зарлигийг гаргаж, 12 шүүгчийг зарлиг гаргалгүй орхигдуулсан байдаг. Мөн 2015 онд хийгдсэн шүүхийн бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтөөр 1 шүүгчийн зарлигийг гаргаагүй тохиолдол дахин давтагдсан. Үүнтэй холбоотой асуудлаар эрх нь зөрчигдсөн шүүгч нар болон бусад иргэдийн зүгээс Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргасан байдаг боловч Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэхээс татгалзсан[35], мөн иргэний хэргийн шүүхэд гаргасан нэхэмжлэлийг иргэний хэргийн шүүх “харьяаллын бус” гэсэн үндэслэлээр хүлээн авахаас татгалзсан[36] байдаг. Тиймээс нэхэмжлэгч нар нь Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу аль ч шүүх авч хэлэлцэхгүй байгаа эрх зүйн маргааны харьяаллыг тогтоолгохоор Цэцэд хандаж гомдол гаргажээ.

Улмаар буцаан томилогдоогүй шүүгч нар хэргийн харьяалал тогтоолгохоор Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргасны дагуу Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааны 2017 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 11 дүгээр магадлалаар “нэр бүхий 12 шүүгчийг Ерөнхийлөгчийн зарлигаар албан тушаалд нь буцаан томилоогүйтэй

---

[34]Цэргийн албаны тухай хуулийн 28.2,

[35]Үндсэн хуулийн цэцийн гишүүний тогтоол, 2015.03.26, №36, Үндсэн хуулийн цэцийн бага суудлын хуралдааны магадлал, 2015.06.25, №08, **Магадлалд:** “Ерөнхийлөгчийн 2013 оны 198 дугаар зарлигаар чөлөөлөгдсөн шүүгч эрх нь зөрчигдсөн гэж үзвэл шүүхэд хандах эрх нь нээлттэй байна” гэжээ:

[36] Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамж, 2015.08.06, №24857, захирамжийг хэвээр үлдээсэн мөн шүүхийн тогтоол 2015.10.01, №923

холбогдуулан эрх нь зөрчигдсөн тухай маргааныг Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд анхан шатны журмаар харьяалуулан шийдвэрлэхээр тогтоосон байна.[37]

Дээрх маргаанд Улсын Дээд шүүхээс Цэцэд "Захиргааны байгууллагын Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасснаар тодорхойлдог. Гэтэл үүнд Монгол Улсын Ерөнхийлөгч шууд утгаараа хамаарахгүй байна. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн§13.1-д "Захиргааны хэргийн шүүх Үндсэн хуулийн цэц болон өөр шүүхэд харьяалуулснаас бусад нийтийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэнэ" гэсэн нь Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн дурдсанчлан "... Ерөнхийлөгч захиргааны хэргийн шүүхэд хариуцагч болно гэсэн хатуу шаардлага биш" гэсэн тайлбарыг өгчээ.

Харин Үндсэн хуулийн цэц магадлалынхаа үндэслэлдээ "Үндсэн хуулиас бусад хууль зөрчигдсөн эсэх асуудал нь Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх маргаанд хамаарахгүй. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн §13.1-д "Үндсэн хуулийн цэц болон өөр шүүхэд харьяалуулснаас бусад нийтийн эрх зүйн маргааныг Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэхээр хуульчилжээ. Иймд Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т Улсын Дээд шүүх "хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокуророос шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэх" гэж заасны дагуу уг маргааныг Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд анхан шатны журмаар харьяалуулан шийдвэрлүүлэх үндэслэлтэй" гэж үзсэн байна.

**Гурав.** Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь ЗЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь хэсэгт заасснаар захиргааны байгууллага болох тухайд:

Монгол Улсын Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжинэ", мөн зүйлийн 2 дахь хэсэгт "Нутгийн өөрөө удирдах байгууллага бол аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал, тухайн Хурлын хуралдааны чөлөө цагт түүний Тэргүүлэгчид мөн" гэж тус тус заасан байдаг.

Мөн Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт "Нутгийн өөрөө удирдах байгууллага нь дараахь тогтолцоотой байна: 9.1.1.аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал; 9.1.2.сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал; 9.1.3.баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал" хэмээн заасснаас нутгийн өөрөө удирдах байгууллага гэдэгт аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон баг, хорооны Иргэдийн нийтийн хурал хамаардаг болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна" гэж заасснаас үзвэл нутгийн өөрөө удирдах байгууллага нь тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэдэг болохынхоо хувьд УИХ-аас баталсан хуулиар өөрт оногдсон чиг үүргийг хэрэгжүүлэх, өөрийн нутаг дэвсгэрт оршин сууж буй

[37] http://www.supremecourt.mn/news/348



Remove Watermark Now

Remove Watermark Now

иргэн, хуулийн этгээдэд шууд чиглэсэн, эрх зүйн үр дагавар үүсгэсэн, захирамжилсан шийдвэр, үйл ажиллагаа явуулах бөгөөд энэ хүрээндээ захиргааны байгууллагад тооцогддог.

2002 оны Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд ч нутгийн өөрөө удирдах байгууллага нь захиргааны байгууллагад тооцогддог байсан[38] төдийгүй түүнийг үргэлжлүүлэн ЗЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь хэсэгт нутгийн өөрөө удирдах байгууллага нь захиргааны байгууллага болно гэдгийг хоёрдмол утгагүй нэрлэн хуульчилжээ.

Орчин үеийн захиргааны эрх зүйн онолд нутгийн өөрөө удирдах байгууллагыг нутаг дэвсгэрийн гишүүнчлэл бүхий нийтийн эрх зүйн нэгдэл гэж үздэг[39] ба энэ нь тодорхой нутаг дэвсгэрт байнга амьдарч буй бүх хүн гишүүнчлэлтэй байдаг нэгдэл юм. ИТХ болон ИНХ нь тухайн орон нутагт оршин суугаа бүртгэл бүхий иргэдийн гишүүнчлэлтэй хэмээн үзнэ.

2002 оны Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу болон 2016 оноос хүчин төгөлдөр мөрдөгдсөн Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу бүх шатны ИТХ нь Захиргааны хэргийн шүүхэд хариуцагчаар татагдан оролцсон кэйс маш олон тоотой байна.[40]

**ЗЕХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн тухайд:**

ЗЕХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно” гэж заажээ.

Энэ хэсгийн гол зорилго нь эрх шилжүүлэх харилцааг нарийвчлан зохицуулж өгөх явдал бөгөөд Үндсэн хуулийн суурь зарчмын дагуу захиргаа нь хуулиар зөвшөөрч заасныг хийх үүрэгтэй бөгөөд тэрхүү чиг үүрэг, бүрэн эрхээ хэрэгжүүлснийхээ төлөө хариуцлагаа өөрөө хүлээх учиртай юм. Тодруулбал, дээрх чиг үүрэг, бүрэн эрхээ захиргаа нь зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд л бусад этгээдэд шилжүүлэх эрхтэй байна.

Гэвч өнөөдөр Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Барилгын тухай хуулийн[41] 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалтад барилгын ажлын зөвшөөрөл олгож, барилга байгууламжийг ашиглалтад оруулах бүрэн эрхийг зөвхөн аймаг, нийслэлийн Засаг даргад олгосон байтал Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр баталсан 5/14 дүгээр тогтоолын Нэгдүгээр хавсралт “Нийслэлийн нутаг дэвсгэрт барилга барих газрын эрх олгох, барилгын эх зураг батлах, барилга угсралтын ажил эхлүүлэх, ашиглалтад оруулах үйл ажиллагааны журам”[42]-ын 1.2.4-т “ арван долоо хүртэлх давхар барилгын барилга угсралтын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгох үйл ажиллагааг нийслэлийн барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн байгууллага” хариуцан хэрэгжүүлнэ гэж заасны дагуу Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар барилгын ажлын зөвшөөрөл олгож байна.

---

[38]2002 оны Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалт болон 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалтыг үзэх.
[39]Энэ талаар П.Одгэрэл, Захиргааны эрх зүйн ерөнхий анги, 3 дахь хэвлэлт, 107-108 дахь талаас үзэх.
[40] Шүүхийн шийдвэрийн цахим сангаас түүж судалсан болно. Энэ тайлангийн Хавсралт 4-т хавсаргав.
[41] http://www.legalinfo.mn/law/details/11705?lawid=11705
[42] http://legal.barilga.mn/law/333

Remove Watermark Now

Дээрхээс үзвэл хуульд Нийслэлийн Засаг дарга олгохоор заасан тусгай зөвшөөрлийг Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар олгож байгаа нь буруу байх бөгөөд хуульд тусгай зөвшөөрөл олгох бүрэн эрхийг хэн нэг этгээдэд шилжүүлэхийг зөвшөөрөөгүй байхад журмаар шилжүүлж буй нь ЗЕХ-ийг зөрчсөн үйлдэл болж байна.

**ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ**

Захиргааны ерөнхий хууль 2015 онд батлагдсанаас хойш 3 жил, хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш 2 орчим жил өнгөрчээ. Энэ хугацаанд тус хуулийн хэрэгжилтийн талаар судалгаа хийгдэж байгаагүй байна. Энэхүү хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх судалгааны ажлын хүрээнд 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.5 дахь заалтыг сонгон авч, эдгээр заалтууд хуулийн зорилгодоо хүрсэн эсэх, практикт хэрхэн хэрэгжиж байгаа эсэхийг үнэлж дүгнэхийг зорьсон болно. Иймээс энэхүү үнэлгээний ажилд сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах дүгнэлтийг хийж байна.

*"Зорилгод хүрсэн байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд:*

ЗЕХ-ийн 1 дүгээр зүйлд тус хуулийн зорилгыг тодорхойлохдоо "нийтийн эрх зүйн хүрээнд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг захиргааны байгууллага"-д ямар субъектууд багтахыг хуульчлахыг зорьсон байх бөгөөд тийнхүү захиргааны байгууллагыг тодорхойлохдоо хуучин 2002 оны Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар захиргааны байгууллагыг тодорхойлж байсан "нэлттэй тоочих" зарчмаас аль болох зайлсхийхийг оролдсон байх боловч бүхэлдээ ерөнхий заалтын зарчмыг баримталсан гэж дүгнэх боломжгүй байна.

Харьцуулах үүднээс ХБНГУ-ын Захиргааны үйл ажиллагааны тухай хуулийг авч үзвэл тус хуульд захиргааны байгууллагыг тоочдоггүй, харин үйл ажиллагааны шинжээр нь ерөнхий заалт хийсэн байдаг. Тодруулбал: ХБНГУ-ын Захиргааны үйл ажиллагааны тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: "Энэ хууль нь дараах байгууллагын нийтийн эрх зүйн шинжтэй захиргааны үйл ажиллагаанд үйлчилнэ: 1/ Холбооны байгууллагын, Холбооны шууд харьяанд байдаг байгууллага, албан газрын болон нийтийн эрх зүйн сангийн; 2/ Мужийн байгууллагын, орон нутгийн байгууллагын, орон нутгийн нийгэмлэгийн болон Холбооны хууль тогтоомжийн дагуу эрх авч Мужийн хяналтын доор үйл ажиллагаа явуулдаг нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн ..." гэж, мөн хуулийн 1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "Энэ хуульд хэрэглэсэн байгууллага гэдэг ойлголтод нийтийн захиргааны чиг үүргийг хэрэгжүүлж байгаа бүх нэгж хамаарна"[43] гэж тус тус заасан байдаг. Эндээс үзвэл, ХБНГУ-ын Захиргааны үйл ажиллагааны тухай хууль нь захиргааны байгууллагыг тоочин заагаагүй, харин түүний хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, чиг үүрэг нь нийтийн эрх зүйн хүрээн дэх нийтийн захиргааны шинжтэй байгаа бүх нэгжийг захиргааны байгууллага гэж үзнэ хэмээн ерөнхий заалтын зарчмыг баримталсан байна.

Хэдийгээр манай улсын ЗЕХ нь ерөнхий заалтын зарчмыг бүрэн баримтлаагүй боловч ЗЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.5 дахь заалт нь захиргааны байгууллагуудыг тодорхойлж өгөх талаар хуулийн зорилгодоо хүрсэн гэж дүгнэж байна.

*"Практикт хэрэгжиж байгаа байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд:*

[43]ХБНГУ-ын Захиргааны үйл ажиллагааны тухай хууль (VwVfG), https://www.gesetze-im-internet.de/vwvfg/__1.html



pdfelement

Remove Watermark Now

*Нэг.* ЗЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтад “төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага” нь захиргааны байгууллага болно гэж заасан байх бөгөөд энд “төрийн захиргааны төв байгууллага” гэдэг томъёоллыг хэрэглээгүй, харин “төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв байгууллага” хэмээн өргөн агуулга бүхий томъёоллыг хэрэглэсэн байгааг анхаарах нь зүйтэй байна. “Төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв байгууллага” гэдэгт Монгол Улсын Засгийн газар, яам, агентлаг багтах нь хууль боловсруулагчдын болон хууль тогтоогчдын үзэл баримтлал, хуулийн зорилго, эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах онол, арга зүйн талаасаа тодорхой ойлгогдож байна. Практикт хуульчид болон Захиргааны хэргийн шүүхийн шүүгчдийн аль аль нь энэ заалтыг ямар нэг хоёрдмол утгагүй ойлгон, маргаангүй хэрэглэж ирсэн байх бөгөөд 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш Монгол Улсын Засгийн газрыг Захиргааны хэргийн шүүхэд хариуцагчаар татаж, хэргийг шийдвэрлэсэн кэйс 21[44] байгааг судалгааны өмнөх бүлэгт дурдсан болно.

***Дүгнэлт:***

1. Засгийн газрын үйл ажиллагааг губернатив буюу улс төрийн-бодлогын, административ буюу захиргааны үйл ажиллагаа гэж хоёр ангилан авч үздэг бөгөөд Засгийн газрын захиргааны үйл ажиллагаагаар иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол нь зөрчигдсөн бол ердийн шүүх (тэр дундаа Захиргааны хэргийн шүүх) тэрхүү зөрчигдсөн эрхийг сэргээх учиртай гэдэг нь үндсэн хуульт ёс, эрх зүйт төрийн зарчмын зүй ёсны нэгэн шаардлага болно (Хавсралт 4. Онолын судалгааг үзнэ үү).

2. Засгийн газрын шийдвэр, үйл ажиллагаа нь иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хөндсөн, эсхүл зөрчсөн бол шүүхээс хянах нь үндсэн хуульт ёс, эрх зүйт төрийн зарчмын зүй ёсны нэгэн шаардлага болж юм. Монгол Улсын Засгийн газар нь бусад орны Засгийн газартай харьцуулахад иргэн, хуулийн этгээдэд шууд чиглэсэн, эрх зүйн үр дагавартай шийдвэр гаргах хууль зүйн өргөн боломжтой болох нь холбогдох салбарын хуулиудад иргэн, хуулийн этгээдэд шууд чиглэсэн, тухайлсан шинжтэй шийдвэр гаргах болон нийтээр дагаж мөрдөх олон тооны захиргааны хэм хэмжээний актыг батлан гаргах боломжийг олгосон байгаагаар нотлогдож байна. Тухайлбал, 2017 онд Засгийн газраас гаргасан 106 шийдвэрийг түүвэрлэн үзэхэд **8.55%** хувь буюу **9** нь захиргааны акт, **42.4%** хувь буюу **45** нь захиргааны хэм хэмжээний акт байгаа нь Засгийн газрын энэхүү захиргааны үйл ажиллагааг шүүхээс хянах үндэслэл болж байна (**Хавсралт 5**. Засгийн газрын 2017 оны зарим шийдвэрт хийсэн дүн шинжилгээг үзнэ үү).
3. Монгол Улсын Засгийн газрын шийдвэр, үйл ажиллагаагаар иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдсөн бол захиргааны болон иргэний хэргийн шүүх тус тусын хэргийн харьяаллын дагуу маргааныг шийдвэрлэх нь тодорхой байх бөгөөд хэрэв аль ч шүүх тухайн маргааныг авч хэлэлцэхгүй бол Монгол Улсын Үндсэн хуулийн цэц аль нэг шүүхэд хэргийн харьяалал тогтоож өгнө. Энэ бол эрх зүйт төрийн суурь зарчим юм.

*Хоёр.* Ерөнхийлөгчийн зарлигтай холбоотой тодорхой эрх зүйн маргаан дээр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд харьяалал тогтоосон тохиолдол гарсан байх бөгөөд эндээс дүгнэвэл Монгол Улсын

---

[44] Шүүхийн шийдвэрийн цахим санд нээлттэй байгаа шийдвэрийг түүж судалсан болно. Энэ тайлангийн Хавсралт 3-т хавсаргав. Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн гаргасан “Засгийн газрын шийдвэр шүүхийн хяналтад байх нь: Үндсэн хуулийн цэц болон ердийн шүүхийн харьяаллын асуудал” сэдэвт судалгааны тайланд 35 кэйс байгаа тухай дурджээ https://drive.google.com/file/d/19bHUidJ0OQi4QiG_7gOhLOKErYzjlCsn/view

Remove Watermark Now

Үндсэн хуулийн цэц Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн маргааныг захиргааны хэргийн шүүхэд харьяалуулснаар Монгол Улсын Ерөнхийлөгчийг захиргааны байгууллага байх боломжтой гэдгийг хууль зүйн хувьд хүлээн зөвшөөрсөн байна.

***Дүгнэлт:***

Орчин үеийн ардчилсан, эрх зүйт төртэй улсад иргэн хүнд шүүхэд мэдүүлэх, эрх зүйн хамгаалалт авах боломж бүх талаар олгогдсон байх ёстой. Дээрхээс үзэхэд Ерөнхийлөгчийн Үндсэн хуулийг зөрчөөгүй, харин бусад хуулийг зөрчсөн үйл ажиллагааг ердийн шүүх (тэр дундаа Захиргааны хэргийн шүүх) хянах боломжтой гэдгийг Үндсэн хуулийн цэц тогтоосон байна. Энэхүү маргаан нь одоо Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд хянан шийдвэрлэгдэж байна.

*Гурав.* ЗЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтад “нутгийн өөрөө удирдах байгууллага” буюу аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, баг, хорооны ИНХ нь захиргааны байгууллага болохыг тодорхой заажээ. 2002 оны Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалтуудад ч энэ агуулгаар хуульчлагдсан байсан болно. Энэ заалтыг шүүхийн практикт ямар нэг хоёрдмол утгагүй ойлгож, маргаангүй хэрэглэж ирсэн бөгөөд одоо ч тийнхүү хэрэглэж байгаа болох нь шүүхийн шийдвэрийн судалгаагаар тогтоогдлоо (**Хавсралт 6**-г үзнэ үү).

***Дүгнэлт:***

1. Нутгийн өөрөө удирдах байгууллагын гаргасан иргэн, хуулийн этгээдэд чиглэсэн, шууд эрх зүйн үр дагавар бүхий захиргааны акт, нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан захиргааны хэм хэмжээний акт нь шүүхийн хяналтын доор байна гэдэг нь үндсэн хуульт ёс, эрх зүйт төрийн зарчмын зүй ёсны нэгэн шаардлага байна.

2. Тийм учраас аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, баг, хорооны ИНХ-ыг захиргааны байгууллага байна гэдгийг ЗЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтад нэрлэн заасан байх бөгөөд нутгийн өөрөө удирдах байгууллагын захиргааны үйл ажиллагаа нь Захиргааны хэргийн шүүхийн хяналтад багтана.

***Дүгнэлт:***

- ЗЕХ-ийн энэ бүлгийн 8 дугаар зүйлийн хувьд хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно гэж заасан 8.1 дэх заалт практикт хангалттай хэрэгжихгүй байна.

  Судалгааны тайлангийн хэсэгт авч үзсэн Барилгын тухай хуулийн зохицуулалтын жишээн дээрээс дүгнэхэд “хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно” гэж заасан ЗЕХ-ийн 8.1 дэх заалтыг практикт хэрэгжүүлэхийн тулд хууль тогтоомжийн хоорондын уялдааг сайжруулж, ямар тохиолдолд, ямар үндэслэлээр эрх бүхий этгээд нь өөрт хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлж болохыг материаллаг хуулиудад тодорхой хуульчилж өгдөг байх нь чухал байна.

pdfelement

Remove Watermark Now

# ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН 4 ДҮГЭЭР БҮЛГИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

## НЭГ.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Засгийн газрын 59 дүгээр зүйлийн зургаадугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ аргачлал”-ыг баримтлан Захиргааны ерөнхий хуулийн 4-р бүлгийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.7, 40 дүгээр зүйлийн 40.4, 43 дугаар зүйл, 47 дугаар зүйлийн 47.1.6, 48 дугаар зүйл, 49 дүгээр зүйл, 50 дугаар зүйлийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээг хийж гүйцэтгэв.

Энэхүү үнэлгээний ажлын зорилт нь Захиргааны ерөнхий хуулийн холбогдох заалтын хэрэгжилтийн бодит нөхцөл байдлыг судлан, дүн шинжилгээ хийх, практикт гарч байгаа хүндрэл, бэрхшээлтэй асуудлыг судлах, практикт нийцэж байгаа байдал, цаашид уг хуулийн заалтуудыг үр дүнтэй хэрэгжүүлэх болон бусад шаардлагатай авч хэрэгжүүлэх арга хэмжээний боломжит хувилбарын санал, дүгнэлт гаргахад оршино.

Үнэлгээг төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх үе шаттайгаар хийв.

## ХОЁР.ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

2.1.Үнэлгээг хийх шалтгаан

Захиргааны ерөнхий хууль /цаашид “ЗЕХ” гэх/ нь 2015 оны 6 дугаар сарын 19-нд батлагдсан бөгөөд 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн нийтээр даган мөрдөгдөж практикт хэрэгжиж эхэлжээ.

Монгол Улсын Их Хурлын “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай 2017 оны 11 дүгээр тогтоолын хавсралтын Нэгийн 151-д Хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгахүндэслэлээр Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яам хариуцан боловсруулахаар тусгажээ. Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахын өмнө Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д Хууль санаачлагч хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажлын үе шатыг хэрэгжүүлэхдээ тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхээр заасан. Эдгээр үндэслэлийн дагуу Хууль зүй, дотоод хэргийн яам, Ханнс-Зайделийн сангийн “Эрх зүйн боловсрол” академиийн захиалгаар энэхүү үнэлгээний хийж гүйцэтгүүлэхээр ажлын хэсэг байгуулжээ.Үнэлгээ хийх шалтгаан нь ЗЕХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг шалган тогтооход чиглэгдэж байна.

Тодруулбал, үнэлгээний зорилттой холбоотойгоор нийтийн эрх зүйн хүрээнд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэн захиргааны байгууллагаас захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт гаргах, захиргааны гэрээ байгуулах замаар иргэн, хуулийн этгээдтэй харилцах үйл ажиллагааны эрх зүйн суурь зохицуулалтыг бүрдүүлэх зорилго бүхий ЗЕХ нь энэхүү зорилгодоо хүрэхэд ямар бодитой хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх, тус хуулийг практикт хэрэглэхэд тулгамдаж буй үндсэн болон бусад ямар асуудал байгаа эсэхийг тодруулах, үнэлгээний хамаарах хуулийн зүйл, заалт нь тухайн харилцааг зохицуулах оновчтой хувилбар мөн эсэх, хангалттай зохицуулж чадаж байгаа байдал, нөгөөтэйгүүр хуулийн хэрэгжилтийн байдал хангалтгүй байгаа эсэхийг шалган тогтоосны үр дүнд ЗЕХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэх талаар дүгнэлт гаргана.

Remove Watermark Now

2.2.Үнэлгээ хийх хүрээ

Үнэлгээ хийх ажлын хүрээнд Захиргааны ерөнхий хуулийн хэрэглээний талаар захиргааны байгууллага, Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчдээс захиргааны хэргийн шүүхийн шүүгчдээс гаргасан саналыг авсны үндсэн дээр ЗЕХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлын хэсгээс судлан үнэлгээний хүрээг тогтоож, уг үнэлгээний хүрээг ажлын хэсгийн гишүүд баг болон багийн гишүүд дотроо үнэлгээ хийх хүрээнд хамаарах хуулийн зүйл, заалтыг хуваан авч үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэв.

Энэхүү үнэлгээний тайланд ЗЕХ-ийн дөрөвдүгээр бүлгийн 37 дугаар зүйлийн 37.1, 37.7, 40 дүгээр зүйлийн 40.4, 43 дугаар зүйл, 47 дугаар зүйлийн 47.1.6, 48 дугаар зүйл, 49 дүгээр зүйл, 50 дугаар зүйл буюу нийт 7 зүйлийн хэрэгжилт, түүний үр дагаврыг судлан, үнэлгээг хийж гүйцэтгэв.

2.3.Шалгуур үзүүлэлтийг тогтоосон байдал

Үнэлгээний зорилт, шалтгаанд нийцүүлэн үнэлгээ хийх хүрээнд хамаарах ЗЕХ-ийн дөрөвдүгээр бүлгийн 37.1, 37.7, 40 дүгээр зүйлийн 40.4, 43 дугаар зүйл, 47 дугаар зүйлийн 47.1.6, 48 дугаар зүйл, 49 дүгээр зүйл, 50 дугаар зүйл тус бүрийг үнэлгээ хийх шалтгаан, шалгуур үзүүлэлт бүрээр шалган, хуулийн хэрэгжилтийн гол асуудлыг судлан тогтоох, үнэлэхэд тохиромжтой шалгуур үзүүлэлтийг хуулийн зүйл бүрт ялгаатай байдлаар 1-3 хүртэл шалгуур үзүүлэлтийг сонгов.

Шалгуур үзүүлэлт, харьцуулах хэлбэрийг дор дурдсан байдлаар сонгож томьёолов:

| № | Үнэлгээ хийх хүрээнд хамаарах ЗЕХ-ийн зүйл, заалт | Шалгуур үзүүлэлт, харьцуулах хэлбэр | Шалгуур үзүүлэлтийн томьёолол |
|---|---|---|---|
| 1. | **37 дугаар зүйл.Захиргааны акт**<br><br>37.1 дэх заалт: | 1.Зорилгод хүрсэн байдал<br><br>2.Практикт хэрэгжиж байгаа байдал | Зөрчлийн хуулийн дагуу оруулсан нэмэлт зохицуулалтаас шалтгаалж энэ хуулийн зорилгод нөлөөлсөн эсэхийг судлах, практикт ямар үр дагавар бий болж байгаа, хүндрэл гарч байгаа эсэхийг тогтоох |
| 2. | 37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсэг: | Зорилгод хүрсэн байдал | Хуулийн зохицуулалт ойлгомжгүй тул нарийвчлан оруулах шаардлагатай эсэх, Захиргааны актын тусгай тохиолдолыг захиргааны хэм хэмжээний актаас ялгах асуудлыг тодруулах |
| 3. | **40 дүгээр зүйл.Захиргааны актыг бичгээр гаргах** | Практикт хэрэгжиж байгаа байдал | ЗЕХ-ийн бусад заалттай уялдуулсан өөрчлөлт оруулах шаардлагатай эсэх, практикт хэрэглэгдэж байгаа эсэх |

pdfelement

| | | | |
|---|---|---|---|
| | 40 дүгээр зүйлийн 40.4 дахь заалт: | | |
| 4. | **43 дугаар зүйл.Захиргааны актыг мэдэгдэх:** | 1.Зорилгод хүрсэн байдал<br>2.Практикт хэрэгжиж байгаа байдал | Илүү нарийвчлан зохицуулах шаардлагатай эсэхийг судлах |
| 5. | **47 дугаар зүйл.Захиргааны акт илт хууль бус болох**<br>**47 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг 6 дахь заалт:** | Практикт хэрэгжиж байгаа байдал | Ямар тохиолдолд уг заалтыг хэрэглэх, илүү ойлгомжтой, тодорхой өөрчлөх шаардлагатай эсэх |
| 6. | **48 дугаар зүйл.Хууль бус захиргааны актыг хүчингүй болгох** | 1.Зорилгод хүрсэн байдал<br>2.Практикт хэрэгжиж байгаа байдал | Зөвхөн захиргааны байгууллагын хувьд хэрэглэх үү, ямар тохиолдолд хэрэглэх вэ, илүү нарийвчлан зохицуулалт оруулах эсэх |
| 7. | **49 дүгээр зүйл.Эрх зүйн зөрчилгүй захиргааны актыг цуцлах** | Практикт хэрэгжиж байгаа байдал | Ямар тохиолдолд уг заалтыг хэрэглэх, илүү ойлгомжтой, тодорхой өөрчлөх шаардлагатай эсэх |
| 8. | **50 дугаар зүйл.Захиргааны акт гаргах ажиллагааг дахин хийх** | Практикт хэрэгжиж байгаа байдал | Практикт хэрэгжиж байгаа эсэх, хэрэгжихгүй байгаа бол ямар шалтгаан нөхцөл байгааг олж тогтоох |

**2.4.Цуглуулах мэдээлэл, мэдээлэл цуглуулах арга**

Энэхүү үнэлгээг хийхэд тоон болон чанарын мэдээллийг аль алиныг нь ашигласан бөгөөд үнэлгээний хүрээнд хамаарах ЗЕХ-ийн зүйл бүрийн шалгуур үзүүлэлт, түүний томьёолол ялгаатай байгаатай холбоотойгоор өөр өөр мэдээлэл цуглуулах аргыг ашигласан болно.

Мэдээлэл цуглуулах ажлын хүрээнд хууль тогтоомжийг хэрэглэж гаргасан шүүхийн шийдвэрүүд буюу шүүхийн болон хуулийн хэрэгжилтийн практик, хуулийн үзэл баримтлал, онолын үндэслэлийг тухайн сэдвээр гарсан мэргэжлийн ном, товхимол, гарын авлага, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээний бүтээл /харьцуулсан судалгаа/, салбарын эрдэмтэдийн саналыг асуултад хариулах хэлбэрээр болон тэдний хэвлэл, мэдээллийн хэрэгслээр өгсөн нийтлэлийгсудалсан, захиргааны

Remove Watermark Now

байгууллагуудаас ярилцлагын болон анкетын судалгаа авсан, захиргааны актуудыг төрлөөр ангилан тухайлсан захиргааны актад дүн шинжилгээ хийсэн, захиргааны актын загваруудыг жишиг болгон авсан.

## ГУРАВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлгээний ажлыг хэрэгжүүлэх үе шатны явцад нийт 130 шүүхийн шийдвэрийг shuukh.mn вэб сайтаас түүвэрлэн, судалгааны хэлбэрт оруулж бэлтгэсэн, захиргааны байгууллага, албан тушаалтнаас анкетын судалгаа авах зорилгоор асуулт бэлтгэн, нийт захиргааны 20 гаруй байгууллага, албан тушаалтнаас анкетын судалгааг авсан, маргааны нийт төрлөөр захиргааны актыг түүвэрлэн сонгон авсан, нийт 50 гаруй хууль тогтоомжийг түүвэрлэн авч судалсан, мэргэжлийн ном, товхимол, гарын авлага, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээний бүтээлийг судалж, салбарын зарим эрдэмтдээс асуулт бэлтгэн хариулт авах хэлбэрээр судалгаа авч, ЗЕХ-ийн үзэл баримтлал, хуулийн төсөл хэлэлцэх үеийн ажлын хэсгийн гишүүдийн ярилцлагын тэмдэглэлүүдийг судалсан.

## ДӨРӨВ.ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

**4.1.Мэдээллийг үнэлсэн байдал:**

Дээр дурдсан үнэлгээний хэрэгжүүлэх үе шатанд цуглуулж, ашигласан тоон болон чанарын мэдээлэл нь үнэлгээний хүрээнд хамаарах ЗЕХ-ийн зүйл, заалтын хэрэгжилтийг үнэлэхэд хангалттай, бодитой бөгөөд хамааралтай байсан болно.

**4.2.Шалгуур үзүүлэлт, харьцуулах хэлбэрийг ашиглан үнэлсэн байдал:**

**1.ЗЕХ-ийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийн хэрэгжилтийн үнэлгээний талаар:**

pdfelement

| № | Үнэлгээ хийх хүрээнд хамаарах ЗЕХ-ийн зүйл, заалт | Шалгуур үзүүлэлтийн томьёолол | Цуглуулсан мэдээллийн төрөл |
|---|---|---|---|
| 1. | **37 дугаар зүйл.Захиргааны акт**<br><br>37.1 дэх заалт:<br><br>37.1.Захиргааны акт гэж захиргааны байгууллагаас **зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас бусад**тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн, эрх зүйн шууд үр дагавар бий болгосон амаар, бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагааг ойлгоно. | Зөрчлийн хуулийн дагуу оруулсан нэмэлт зохицуулалт нь ЗЕХ-ийн зорилгод нөлөөлсөн үү? Практикт ямар үр дагавар, хүндрэл гарч байна вэ? | 1.Тухайн сэдвээр гарсан мэргэжлийн ном, товхимол, гарын авлага, эмхэтгэл, хууль хэрэгжүүлэгч, хэрэглэгч байгууллагуудаас хийсэн хэлэлцүүлгийн дүгнэлт /харьцуулсан судалгаа/-ийг судалсан.<br><br>2. Салбарын эрдэмтдийн саналыг асууж, салбарын зарим эрдэмтдээс саналаа илэрхийлсэн нийтлэлийг судалсан.<br><br>3.Хууль тогтоомжийг хэрэглэж гаргасан шүүхийн шийдвэрүүд буюу шүүхийн болон хуулийн хэрэгжилтийн практикийг судалсан. |

Remove Watermark Now

**1.Зөрчлийн хуулийн дагуу оруулсан нэмэлт зохицуулалт нь ЗЕХ-ийн зорилгод нөлөөлсөн үү?**

ЗЕХ нь 2015 оны 06 дугаар сарын 19-ний өдөр батлагдаж, 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөгджээ.

Харин ЗЕХ дагаж мөрдөгдөж эхэлсэн өдрөөс нэг жилийн дараа **Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль** *УИХ-аас 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр батлагдсан* **батлагдсантай холбогдуулан ЗЕХ-ийн** *37 дугаар зүйлийн 37.1-д "***зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас бусад***" гэсэн өөрчлөлт оруулж улмаар уг өөрчлөлт нь* 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөгджээ.

Захиргааны актын ойлголтыг *"***зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас бусад***" гэсэн өөрчлөлтөд хамаарахгүйгээр ЗЕХ-ийн 37.1-д заалтыг үндэслэх, тогтоох хэсэгтээ хэрэглэж гаргасан шүүхийн шийдвэр нийт 42 байгаа бөгөөд энэ нь шүүхийн практикт захиргааны актын шинж, ойлголтыг хэрэглэж байгаа захиргааны актын хууль зүйн үндэслэлд дүгнэлт өгч байгаа гэдэг нь харагдаж байна. /шүүхийн шийдвэрийг түүвэрлэсэн /Хавсралт 7/.*

Зөрчлийн хуулийг үндэслэн ЗЕХ-ийн 37 дугаар зүйлийн 37.1-д оруулсан өөрчлөлт хэрэгжиж эхэлснээс шалтгаалж ЗЕХ-ийн зорилго, хуулийн хэрэгжилтэд сөрөг үр дагавар, хүндрэл гарч байгаа нь дор дурдсан судалгаанаас харагдаж байна:

Үүнд:

**ЗЕХ-ийн зорилго, үндсэн зорилгыг тодорхойлсон үзэл баримтлал, онолын үндэслэл, захиргааны эрх зүйн салбарын эрдэмтэн судлаачдын нийтлэл, Хуулийн хэрэгжилтийн талаар хуульч, захиргааны байгууллага, шүүгчдийн дунд явагдсан хэлэлцүүлгээс судлахад:** *(Хавсралт 8. ЗЕХ-ийн үзэл баримтлал, эрдэмтэн судлаачдын нийтлэл, дүгнэлт), (Хавсралт 9. Хэлэлцүүлгийн илтгэлүүд, дүгнэлтүүд)*

ЗЕХ-ийн*37 дугаар зүйлийн 37.1-дэх заалт нь захиргааны актын үндсэн ойлголт, шинжийг тодорхойлсон суурь зохицуулалт байна.*Захиргааны эрх зүйн онол, ЗЕХ-ийн зорилгын хувьд захиргааны акт нь захиргааны салбар эрх зүйн суурь ойлголт, захиргааны үйл ажиллагааны гол хэлбэр бөгөөд материаллаг төдийгүй процессын эрх зүйн хувьд ач холбогдолтой юм. Захиргааны актыг тодорхойлсон энэхүү заалт нь хууль зүйн бие даасан ойлголтын анхны ухагдахуунд хамаарах актын үндсэн шинж болох захиргааны байгууллагаас гаргасан байх, гадагш чиглэсэн байх, тодорхой тохиолдлыг зохицуулах, эрх зүйн үр дагавар үүсгэх, захирамжлах үйл ажиллагааг хуульчилсан. Захиргааны актын хуулийн энэ томьёолол нь захиргааны эрх зүйн онолын сонгодог утгаар нь тодорхойлсон байна.

Захиргааны актын үндсэн ойлголт, шинжийг тодорхойлсон суурь зохицуулалтад ЗЕХ-ийн *"***зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас бусад***" гэсэн өөрчлөлт орсноос шалтгаалж ЗЕХ-ийн захиргааны акт гэсэн суурь ойлголт өөрчлөгдөж улмаар ЗЕХ-иар үндсэн зорилгод нөлөөлж хуулиар тодорхойлсон захиргааны актын зорилгыг бүхэлд нь гажуудуулахад хүргэжээ.*

Захиргааны актын тодорхойлолтод Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас бусад гэж зохицуулсан нь захиргааны актын ойлголтын үндсэн агуулгыг өөрчлөх үр дагавар үзүүлснээс гадназахиргааны байгууллагаас гаргадаг захиргааны актыг аливаа онолын үндэслэл, судалгаагүйгээр захиргааны актын 2 төрөл бий болгожээ.

Remove Watermark Now

Эрх зүйн үр дагаврын хувьд захиргааны актын хууль ёсны байдлыг хянах, улмаар хүчингүй болгох харилцан адилгүй процедур бүхий хяналтын үе шат, шүүхийн харьяаллын зөрчлийг бий болгож байна. Үүний улмаас иргэд, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхээ захиргааны хэргийн шүүхээр хамгаалуулах, өөрөөр хэлбэл захиргааны актын улмаас бий болсон эрх, хууль ёсны ашиг сонирхлоо шийдвэрлүүлэх журам нь давхардалгүй, нэгдмэл журам /тэр нь хууль дээдлэх ёсыг чанд баримталсан, процедур ойлгомжтой нэгдмэл журамласан / байх нь чухал бөгөөд зөрчигдсөн тохиолдолд эрхийг хамгаалах, нөхөн сэргээхэд иргэнд ээлгүй, хоёрдмол зохицуулалтыг үүсгэсэн гэсэн дүгнэлт гарчээ.

**Шүүхийн практикийг судлахад:**

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 221/ШТ2018/0085 дугаартай тогтоолоор Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д оруулсан Зөрчил хянан шийдвэрлэх хууль батлагдсантай холбогдуулан оруулсан “зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас бусад” гэсэн өөрчлөлтийг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн агуулгатай гэж үзэн Улсын дээд шүүхэд санал хүргүүлжээ. Уг тогтоолыг үндэслэн Улсын дээд шүүхийн нийтийн шүүгчдийн хуралдааны 2018 оны 04 дүгээр сарын 19-ний 02 дугаар тогтоолоор Захиргааны ерөхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн холбогдох заалт Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх асуудлаар Үндсэн хуулийн цэцэд хүсэлт мэдүүлсэн байна.

Эдгээр тогтоолуудыг үндэслэн одоогоор Нийслэл дэх захиргааны анхан шатны шүүхэд зөрчлийн хэрэг үүсгэн хянагдаж байгаа нийт зөрчлийн хэргүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа Үндсэн хуулийн цэцийн шийдвэр эцэслэн гарах хүртэл хугацаагаар түдгэлзүүлэн шийдвэрлэж байна. Өөрөөр хэлбэл, захиргааны хэргийн шүүхэд зөрчлийн хэргийг өнөөдрийн байдлаар шийдвэрлээгүй, түдгэлзүүлсэн байдалтай байна.

**Захиргааны давж заалдах шүүхийн тогтоолын агуулгыг хүснэгтээр харуулбал:**

Захиргааны эрх зүйн суурь ухагдахуун, харилцааг зохицуулсан Захиргааны ерөнхий хуулийн бүтцийг Зөрчлийн хууль шинээр боловсруулсантай холбогдуулан хөндсөн байгаа нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-ийн хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим алдагдахад хүргэж болзошгүй болжээ.

Тухайлбал, Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийн захиргааны байгууллагаас гэсний дараа зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас бусад гэж нэмснээр зөрчил[5] гэсэн ойлголтыг хуулиар тогтоосон журам зөрчсөн зөрчил гаргасан этгээдэд шийтгэл ногдуулах зорилго бүхий харилцаанаас нь хэтрүүлэн зөрчлийн бус[6], захиргааны эрх зүйгээр зохицуулагдах харилцаа буюу захиргааны удирдан зохион байгуулах эрх хэмжээ, иргэний эрх, үүргийн хоорондын харилцаа, уг харилцаанаас үүссэн маргаанд хэрэглэхээр өргөжүүлж[7], жишээ нь газар эзэмшлийн маргаан, татварын[8] харилцаанаас үүссэн маргааныг зөрчилд хамруулж, зөрчил шалган шийдвэрлэх журмаар хэлэлцэх болсноор иргэд угтаа ижил захиргааны шийдвэрийн (захиргааны акт) маргааныг захиргааны хэргийн шүүхээр хоёр[9] өөр журам, зарчим бүхий хянан шийдвэрлэх ажиллагаа-гаар хянуулахад хүрч хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим алдагдахаар байна. Өөрөөр хэлбэл, захиргааны эрх зүйн хэм хэмжээ, зарчмаар шийдвэрлэгдвэл зохих

харилцаа, маргаан эрүүгийн эрх зүйн (зөрчлийн буюу шийтгэлийн эрх зүйн) хэм хэмжээгээр шийдвэрлэгдэхэд[10] хүрч байгаа нь шүүхээс эдгээр хуулийг хэрэглэхэд хүргэж байна.

**Захиргааны эрх зүй дэх шүүхийн үүрэг буюу захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго:**

Хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд заасан бол захиргааны байгууллагаас гаргасан нэхэмжлэлийг үндэслэн захиргааны хэргийг шийдвэрлэхэд оршдог. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлж, захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагаагаар хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх тогтолцоог бий болгож буй хэрэг юм. Гэхдээ энэхүү баталгаа, тогтолцоо нь гагцхүү оролцогчдын процессын эрх хангагдсан, мэтгэлцэх, шүүх нотлох[11] зарчмыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэгжүүлж байж, эдгээрт үндэслэж шүүх эцсийн шийдвэр гаргах[12]зохицуулалттай нөхцөлд л (2.3-д тайлбарласан) бодитой хэрэгжих боломжтой.

**Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, журам:**

Эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх эрх нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, журам нь (*анхнаасаа шийтгэл хүлээх зөрчил гаргасан гэж тогтоогдсон этгээдийн хувьд бус*) эрхээ хамгаалан шүүхэд мэдүүлэгчийн хувиар шаардлага гарган нэхэмжлэх, маргаж буй асуудлыг үндэслэх эсхүл няцаах баримтыг заах, гаргах, тайлбарлах, мэргэжлийн байгууллагаар шинжлүүлэх зэргээр мэтгэлцэх, нотлох ажиллагаа хийгдэх боломжтой, шүүх (*захиргааны байгууллагын тогтоосон зөрчил-ийг хэлбэрийн төдий батлагчийн хувьд бус*) иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхол захиргааны шийдвэр, үйл ажиллагаанаас зөрчигдсөн эсэхийг тогтоогчийн хувьд хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах хууль зүйн зохицуулалт бүрдсэн үед бодитоор хэрэгжих учиртай.

Гэтэл Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулиар Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 37 дугаар зүйлийн 37.1д нэмэлт, өөрчлөлт оруулснаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд Захиргааны ерөнхий хууль үйлчлэхгүй болох, улмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үр дүнд гарсан шийдвэр нь захиргааны актад хамаарахгүй болсон байна. Ингэснээр захиргааны хэргийн шүүх захиргааны байгууллагаас зөрчил шалган шийдвэрлэх журмаар гаргасан захиргааны актыг агуулгын хувьд Захиргааны ерөнхий хуульд заасан хуульд үндэслэх болон зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, үндэслэл бүхий байх шаардлага хангасан эсэхийг нь хянах, захиргааны акт гаргах процессын шаардлага хангасан эсэхийг нягтлах боломжгүй болсон байна.

Түүнчлэн, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулиар Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11, 7 дугаар зүйлийн 7.3, 112 дугаар зүйлийн 112.9 д нэмэлт, өөрчлөлт оруулснаар шүүх нотлох зарчим, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримт гаргаж өгөх, энэ талаар хүсэлт гаргах эрхийг хязгаарласан төдийгүй хэргийн үйл баримт, хэргийн оролцогчийн буруутай үйл ажиллагаа, хууль зүйн үндэслэл, хууль хэрэглээний талаар нотлох болон үгүйсгэх байдлаар мэтгэлцэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчмыг хэрэгжүүлэх боломжгүйд хүргэсэн байна.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, журам нь *шүүхийн өмнө эрх тэгш байх, эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулах, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх* Үндсэн хуулийн баталгааны хэрэгжилтийг харуулах гол шалгуур үзүүлэлт юм. Гэтэл захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны гол зарчмууд болох шүүх нотлох, мэтгэлцэх зарчмууд захиргааны хэргийн шүүхээс гомдол хянан шийдвэрлэх ажиллагаа ны дагуу хянах хэргийн, тухайлбал энэ хэргийн хувьд хэрэгжих боломжгүй байгаа нь хэргийн оролцогчдын Үндсэн хуулиар хамгаалагдсан эрх, баталгаа хангагдахгүй нөхцөлд хүргэж байна.

Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар дамжуулан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд шинээр бий болгосон гомдол хянан шийдвэрлэх ажиллагаа нь хянан шийдвэрлэх ажиллагаа нэршилтэй боловч шүүхээс бодит байдлаар хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах боломжгүй, хэлбэрийн хувьд шүүх хянан шийдвэрлэж байгаа мэт, шүүх хянасан гэх нэр төдий процесс болоход хүрч байна.

Учир нь захиргааны хэргийн шүүх гомдол хянан шийдвэрлэх ажиллагаа ны үед шүүх нотлох, мэтгэлцэх зарчим хэрэгжихгүй, зөвхөн зөрчил шалгах ажиллагааны үед цуглуулсан баримтад үндэслэн хэргийг шийдвэрлэх болно. Тиймээс нь энэ тохиолдолд шүүх үндсэн үүргээ биелүүлэх боломжгүй, бодит байдлаар хууль зүйн болон үйл баримтыг тогтоох боломжийг үгүйсгэснээр Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 2-д ... шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно гэж заасантай нийцэхгүйд хүргэж байна. Нэг үгээр хэлбэл, гомдол хянан шийдвэрлэх ажиллагаа нь шүүх хэрэг, маргаан хянан шийдвэрлэх үндсэн зарчим, ажиллагаа хийгдэхгүй учир үнэн чанартаа шүүх хянах шийдвэрлэх ажиллагаа явагдсан гэж үзэх боломжгүй (агуулгын хувьд) энэ утгаараа шүүхээс өмнө шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлсэнтэй ялгаагүй нөхцөлд хүргэж байна.

Ингэснээр иргэн, хуулийн этгээд эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх эрх нь хэлбэрийн хувьд хангагдсан мэт боловч агуулгын хувьд хязгаарлагдсан байна.

***(Хавсралт 10.** Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн "Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, УДШ-д санал гаргах тухай" тогтоол 2018.02.07, УДШ-ийн нийт шүүгчдийн хуралдааны "Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хүсэлт мэдүүлэх тухай" тогтоол 2018.04.19, 2018.05.04, Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн "Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа түдгэлзүүлэх тухай" захирамжууд).*

**2.Дүгнэлт, зөвлөмж**

Үнэлгээний судалгаанаас үзэхэд ЗЕХ-ийн 37 дугаар зүйлийн 37.1-д Зөрчлийн хуулийн дагуу оруулсан нэмэлт зохицуулалт нь ЗЕХ-ийн зорилгод шууд нөлөөлж, Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуулиуд хоорондоо уялдаагүй, зөрчилдөөнтэй байгаа, Зөрчлийн тхуай хуулийг үндэслэн оруулсан өөрчлөлтийг шүүхийн практикт хэрэгжүүлэх боломжгүй болсон үр дагавар, хүндрэл гарсан байна. Иймд уг хуулийн заалтад өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

**2.ЗЕХ-ийн 37 дугаар зүйлийн 37.7 дахь заалтын хэрэгжилтийн үнэлгээний талаар:**



Remove Watermark Now
pdfelement

Remove Watermark Now

| № | Үнэлгээ хийх хүрээнд хамаарах ЗЕХ-ийн зүйл, заалт | Шалгуур үзүүлэлтийн томьёолол | Цуглуулсан мэдээллийн төрөл |
|---|---|---|---|
| 2. | **37 дугаар зүйл.Захиргааны акт**<br>37 дугаар зүйлийн 37.7 дахь хэсэг:<br>37.7.Нийтлэг шинжээр тодорхойлогддог, эсхүл тодорхойлж болохуйц этгээдэд чиглэсэн, эсхүл эд юмсын нийтийн эрх зүйн байдлыг тодорхойлох, түүнийг ашиглахтай холбоотой захиргааны акт байж болно. | Хуулийн зохицуулалт ойлгомжгүй тул нарийвчлан оруулах шаардлагатай эсэх? | 1.Хуулийн үзэл баримтлалыг судалсан.<br>2.Хуулийн заалтыг хэрэглэж гаргасан шүүхийн шийдвэрүүдийг судалсан.<br>3.Онолын үндэслэлийг тухайн сэдвээр гарсан мэргэжлийн ном, товхимол, гарын авлага, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээний бүтээл /харьцуулсан судалгаа/-ийг судалсан. |

Энэхүү хуулийн заалтыг судлах үндэслэл нь зарим захиргааны байгууллагаас хуулийн заалтыг ойлгомжгүй учир хэрэглэх боломжгүй байгаа талаар уг заалтыг ойлгомжтой байдлаар тодруулж өгөх санал гарсны дагуу уг хуулийн заалтын хэрэгжилтийг үр нөлөөг судлав.

ЗЕХ-ийн 37.7 дахь заалт нь захиргааны актын онцлог харилцааг зохицуулах зорилгоор захиргааны актын ойлголтод оруулсан нэмэлт зохицуулалт нь юм. Захиргааны эрх зүйн онолын хувьд захиргааны актын тусгай тохиолдол гэж үзэж заавал тусад нь авч үздэг. Энэ хуулийн заалтад захиргааны актын үндсэн шинжийг агуулж байгаа захиргааны актын бие даасан төрөлд хамаарахгүй харин захиргааны актын нэг хэлбэрт хамаарах онолын хувьд нийтлэг зарим тохиолдолд ерөнхий захирамж гэж нэрлэгддэг актын агуулгыг тодорхойлсон юм. Уг актад автозамын тэмдэглэгээ, удаан зогсохыг, эсхүл зогсохыг хориглосон тэмдэглэгээ зэрэг хамаардаг.[45]Судалгааны явцад шүүхийн шийдвэрийн shuukh.mn мэдээллийн сангаас шүүл хийхэд ЗЕХ-ийн 37.7-г хэрэглэж гаргасан шүүхийн шийдвэр, захиргааны актын байхгүй байна.

ЗЕХ-ийн 37.7-дахь хуулийн заалтыг тодорхой болгон өөрчлөх шаардлагагүй харин жишээтэйгээр тайлбарлан таниулах, ойлгуулах ажлуудыг хийх нь зүйтэй.

**3.ЗЕХ-ийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх хэсгийн хэрэгжилтийн үнэлгээний талаар:**

| № | **Үнэлгээний хүрээнд хамаарах ЗЕХ-ийн зүйл, заалт** | Шалгуур үзүүлэлтийн томьёолол | Цуглуулсан мэдээллийн төрөл |
|---|---|---|---|
| 3. | **40 дүгээр зүйл.Захиргааны актыг бичгээр гаргах** | Энэ зохицуулалтын зорилго, ач холбогдол юу вэ? | 1. Захиргааны байгууллагуудаас ярилцлагын болон анкетын судалгаа авсан. |

[45]П.Одгэрэл, Захиргааны эрх зүйн ерөнхий анги 2016, х 175, 176, Захиргааны ерөнхий хуулийн 2017 онд гарсан судалгаа, хэрэглээний тайлбарын х181-183

Remove Watermark Now

| | | | |
|---|---|---|---|
| | 40 дүгээр зүйлийн 40.4 дахь заалт:<br><br>40.4.Захиргааны актад тухайн захиргааны акт гаргах шаардлага бүхий бодит нөхцөл байдлыг тодорхой заана. | Практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? | 2.Уг заалтыг хэрэглэж гарсан шүүхийн шийдвэр судалсан.<br><br>3.Уг заалттай хамааралтай бусад ЗЕХ-ийн хуулийн заалтыг уялдуулан судалсан.<br><br>4.Захиргааны актыг төрлөөр нь сонгон авч тухайлсан захиргааны актад хуулийн заалтын хэрэгжилт ямар байгаад дүн шинжилгээ хийсэн. |

**1.Энэ зохицуулалтын зорилго, ач холбогдол юу вэ?**

ЗЕХ-ийн 40 дүгээр зүйлд бичгээр гаргах захиргааны акт, түүнд тавигдах шаардлагуудыг зохицуулжээ. Бичгээр гаргах захиргааны акт заавал үндэслэл бүхий байх, үндэслэх хэсэгтэй байхыг үндсэн шаардлагыг хуулиар үүрэгжүүлжээ. Захиргааны акт үндэслэл бүхий байх шаардлагын агуулга нь шийдвэр гаргахад нэг талаас актыг гаргах үндсэн шалтгаан болсон бодит нөхцөл байдал, нөгөө талаас хууль зүйн үндэслэлийг актад заавал тусгах нөхцөл юм[46]. Үүнтэй холбоотойгоор ЗЕХ-ийн 40.4-д заасан бичгээр гаргаж байгаа захиргааны актад "бодит нөхцөл байдлыг тодорхой заах" гэсэн хуулийн заалтын зорилго нь бичгэн хэлбэрээр гаргаж байгаа актад тавигдах шаардлага бөгөөд захиргааны байгууллага нь бичгээр акт гаргах бүртээ тухайн актыг гаргах үндсэн шалтгааныг бий болгосон бодит нөхцөл байдлыг заавал заах шаардлагыг үүрэгжүүлсэн заалт юм. Энэ заалт нь ЗЕХ-ийн 40.2.3-д "Бичгээр гаргасан захиргааны акт дараах шаардлагыг хангасан байна: захиргааны актыг гаргах бодит нөхцөл байдал, хууль зүйн үндэслэлийг заах;" гэсэн заалттай шууд холбоотой. Харин 40.5 дахь заалт нь "бодит нөхцөл байдлыг тодорхой заах" шаардлага хамаарахгүй бичгээр гаргах зарим онцлог захиргааны актыг тусад нь зохицуулжээ. Харин ЗЕХ-ийн 4.2.5-д "захиргааны үйл ажиллагаа нь бодит нөхцөлд тохирсон байх" тусгай зарчмыг зохицуулсан заалт нь ЗЕХ-ийн 40.4-д заасан "бичгээр гаргах захиргааны актад бодит нөхцөл байдлыг тодорхой заах" гэсэн зохицуулалтын агуулга нь ялгаатай байна. Захиргааны байгууллага нь захиргааны акт гаргахдаа эдгээр ЗЕХ-ийн 4.2.5, 40.4-д заасныг зөрчсөн тохиолдолд уг акт нь хууль ёсны байх шаардлагыг хангахгүй бөгөөд ЗЕХ-ийн 48 дугаар зүйлд заасны дагуу хүчингүй болгоно.

2.1.Захиргааны байгууллагуудаас авсан анкетын судалгаанд /Хавсралт 11/ нийт 20 захиргааны байгууллага оролцсон. Анкетын судалгаанаас үзэхэд:

| № | Судалгаанд оролцсон төрийн байгууллагуудыг жагсаабал: |
|---|---|
| | **Яам** |
| 1 | Монгол Улсын Ерөнхий сайд |
| 2 | Гадаад харилцааны яам |

[46]ЗЕХ-ийн захиргааны акттай холбоотой хэсгийн боловсруулсан доктор П.Одгэрэл, Захиргааны эрх зүйн ерөнхий анги, 2016, х 190-191

Remove Watermark Now

| | |
|---|---|
| 3 | Сангийн яам |
| 4 | Байгаль орчин, аялал жуулчлалын яам |
| | **Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг** |
| 5 | Гаалийн ерөнхий газар |
| 6 | Ашигт малтмал, газрын тосны газар |
| 7 | Татварын ерөнхий газар Улсын төсөв орлого хяналтын газар |
| 8 | Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар |
| 9 | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар |
| 10 | Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэс |
| 11 | Нийгмийн даатгалын ерөнхий газар |
| | **Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч, тохируулагч агентлаг** |
| 12 | Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар |
| 13 | Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар |
| 14 | Нийслэлийн Газрын алба |
| 15 | Баянзүрх дүүргийн Газрын алба |
| 16 | Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газар |
| 17 | Баянзүрх дүүргийн Татварын хэлтэс |
| Бие даасан агентлаг | |
| 18 | Санхүүгийн зохицуулах хороо |
| 19 | Монгол Улсын Ерөнхий Аудитор |
| 20 | Ус сувгийн удирдах газар ОНӨААТНҮГ |

pdfelement

- Захиргааны байгууллагаас тухайн захиргааны актад уг актыг гаргах болсон бодит нөхцөл байдлыг зайлшгүй дурдах талаар төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан буюу судалгаанд оролцсон байгууллагууд бүгд мэддэг байна /100 хувь тийм гэсэн хариулт өгчээ/.
- Захиргааны актыг боловсруулах, гаргах үедээ акт гаргах болсон бодит нөхцөл байдал, шалтгааныг тодорхойлон зааж дурдах талаар судалгаанд хамрагдсан захиргааны байгууллагаас 95 хувь нь дурдаж, 5 хувь дурдаагүй байна.
- Ажлаас чөлөөлөх шийдвэрийн хувьд бүтэц, орон тоо өөрчлөгдсөн нөхцөл байдал, газар эзэмших эрх хүчингүй болгох шийдвэрийн хувьд бусдын газартай давхцал бий

Remove Watermark Now

болсон, ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүчингүй болгох шийдвэрийн хувьд тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлт гаргаагүй нь баримтаар тогтоогдож байгаа нь бүгд захиргааны акт гаргах шаардлага бүхий нөхцөл байдал гэж үзсэн 75 хувь буюу 15 захиргааны байгууллага байна.

2.2.Захиргааны байгууллагаас гаргасан тодорхой актуудад хийсэн дүн шинжилгээ /Хавсралт 12/:

| № | Акт гаргасан захиргааны байгууллагын нэр, актын дугаар, утга | Актын үндэслэх хэсэгт ЗЕХ-ийн 40.4-д заасан “захиргааны акт гаргах бодит нөхцөл байдлыг заасан байдал” |
|---|---|---|
| 1 | Ашигт малтмал, газрын тосны газрын кадастрын хэлтсийн даргын 2017.0.7.31-ний 460 дугаар шийдвэр, Хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах тухай | Үндэслэх хэсгийн нэгт “Дараахь аж ахуйн нэгжүүдээс Кадастрын хэлтэст гаргасан өргөдөлд Засаг даргын “дэмжихгүй” санал ирсэн тул хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсугай” гэжээ. |
| 2 | Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018.05.01-ний өдрийн А/113 дугаар тушаал,<br><br>Газар ашиглах эрхийг дуусгавар болгож, газрыг чөлөөлөх тухай | Үндэслэх хэсгийн нэгт “Усны нөөцийг бохирдож хомсдохоос сэргийлэх, голын бургас модыг сүйтгэх, уул нурааж тухайн орчны төлөв байдал, байгалийн унаган төрхийг алдагдуулан дархан цаазат газрын нийтлэг дэглэм горимыг зөрчиж буй үндэслэлээр газар ашиглах эрхийг дуусгавар болгосугай” гэжээ. |
| 3 | Монгол Улсын Сангийн сайдын 2018.05.11-ний өдрийн 6-1/2820 тоот шийдвэр, Гомдол хянасан тухай | Үндэслэх хэсгийн нэгт “Т” ХХК-иас ирүүлсэн тендерээс үзэхэд сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт ирүүлсэн боловч санхүүгийн тайлан, тодруулга ирүүлээгүй, Санхүүгийн зохицуулах хорооны төлбөрийн чадварыг хангасан тухай тодорхойлолтыг 2017 оны 4 улирал тус бүрээр ирүүлээгүй байх тул ТШӨХ-ийн 4.2 /е/, 12.1-д заасан шаардлагыг тус тус хангахгүй гэж үнэлсэн нь үндэслэлтэй байна” гэжээ. |
| 4 | Нийслэлийн Засаг даргын 2018.01.23-ны өдрийн А/54 дүгээр захирамж, Газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох тухай, | Үндэслэх хэсгийн нэгт “Баянзүрх дүүргийн 3 дугаар хороо, 33-р сургуулийн баруун хойд талд байрлах 140 мкв газрыг үйлчилгээний зориулалтаар эзэмшигч иргэн Х-д нь уг газрын талбайн хэмжээг зөвшөөрөлгүйгээр нэмэгдүүлсэн бөгөөд тухайн газраа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу 2 жил дараалан ашиглаагүй тул иргэний газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгосугай” гэжээ. |
| 5 | Монгол Улсын Засгийн газрын 2017.12.06-ны өдрийн 332 дугаар тогтоол, Ажлаас чөлөөлөх тухай | Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.8, 30 дугаар зүйлийн 30.1, Төрийн албаны тухай хуулийн $35^1$ дүгээр зүйл, Төрийн албаны зөвлөлийн 2017 оны 1102 дугаар албан бичгээр ирүүлсэн саналыг тус тус |

pdfelement

| | | |
|---|---|---|
| | | үндэслэн Засгийн газрын 2017.09.27-ны өдрийн 291 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай гэжээ. |
| 6 | Монгол Улсын Ерөнхий сайдын 2018.05.01-ний өдрийн 85 дугаар захирамж, Ажлаас чөлөөлөх тухай | Захирамжийн үндэслэх хэсгийн нэгт “Албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн гэрээ байгуулан улсад үлэмж хэмжээний хохирол учруулсан нь П-г Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн даргын үүрэгт ажлаас нь халсугай” гэжээ. |
| 7 | Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсийн байцаагчийн 2018.04.12-ны өдрийн 251201803 тоот шийтгэх хуудас, Зөрчилд шийтгэл оногдуулах тухай | Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Хаан банк” ХХК татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, Татварын ерөнхий хуулийн 71 дүгээр зүйлийн 71.2.1, Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйлийн 11.3 дэх заалтыг зөрчсөн тул шийтгэл оногдуулах үндэслэлтэй байна гэжээ. |
| 8 | Монгол Улсын Ерөнхий Аудитын 2017.07.16-ны өдрийн Б/237 дугаар тушаал, Ажлаас чөлөөлөх тухай | Тушаалын үндэслэх хэсгийн нэгт “МУЕА-н 2017 оны А/60 тушаалаар батлагдсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрыг өөрчлөн байгуулах тухай” тушаал, мөн оны А/88 дугаартай “Нийслэл дэх Төрийн аудитын газрын бүтцийн нэгжүүдийн ажлын байрны жагсаалт, ажлын байрны тодорхойлолтыг батлах тухай” тушаалаар Нийслэл дэх Төрийн Аудитын газрын бүтэц, зохион байгуулалт, өөрчлөгдөн, орон тоо цөөрч ажлын байрны тодорхойлолтод заасан шаардлагад нийцэхгүй байх тул Х-г Нийслэл дэх Төрийн аудитын газрын мэдлээс 2017.07.16-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй” гэжээ. |
| 9 | Нийслэлийн Засаг даргын 2017.08.21-ний өдрийн А/609 дүгээр захирамж, Тусгай зөвшөөрлийг цуцалж, газрын хэвлий ашиглах эрхийг дуусгавар болгох тухай | Үндэслэх хэсгийн 2 дахь хэсэгт “түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосноос хойш 3 жилийн хугацаанд газрын хэвлий ашиглаж эхлээгүй, энэ захирамжийн 2 дахь хавсралтад заасан аж ахуйн нэгж, байгууллагын газрын хэвлий ашиглах эрхийг дуусгавар болгосугай.” гэжээ. |
| 10 | Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018.04.02-ны өдрийн Б/245 дугаар тушаал, Л.-ийг шилжүүлэн томилох тухай, | Цэргийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.14-т заасныг үндэслэн Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын нягтлан бодогч, ахлах дэслэгч Л.-ийг 2018.04.03-ны өдрөөс үүрэгт ажлаас нь чөлөөлж, мөн өдрөөс Баруун бүсийн төв Ховд аймгийн ОБгазарт нягтлан бодогчоор томилсугай.” Гэжээ. |
| 11 | Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын | Тушаалын үндэслэх хэсгийн нэгт “улсын тусгай хамгаалалттай газарт газар ашиглах зөвшөөрөлтэй 8 |

Remove Watermark Now

| | | |
|---|---|---|
| | 2017.10.23-ны өдрийн А/288 дугаар тушаал, Газар ашиглах эрхийг дуусгавар болгох, эрх олгох тухай | иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын иргүүлсэн хүсэлт, хамгаалалтын захиргааны саналыг үндэслэн газар ашиглах эрхийг дуусгавар болгож, эдгээр иргэн, аж ахуйн нэгж, байгуулсан гэрээг цуцалсугай.” гэжээ. |

Захиргааны байгууллагын бичгээр гаргаж байгаа ЗЕХ-ийн 40.4 заасан захиргааны актад “бодит нөхцөл байдлыг тодорхой заах” шаардлагыг ханган гаргах заалт захиргааны байгууллагууд ойлгож, уг заалтыг захиргааны байгууллагуудаас практикт нэгэнт нэг мөр хэрэглэж байгаагаас үзэхэд уг хуулийн заалт практикт зорилгодоо нийцсэн байдлаар хэрэгжиж байна.

3.Шүүхийн практикийг судалсан талаар:

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийн сангаас хийсэн шүүлтээс нийт 4 шүүхийн шийдвэрийн үндэслэх, болох тогтоох хэсэгт ЗЕХ-ийн 40.4 дэх заалтыг хэрэглэсэн байх бөгөөд уг хуулийн заалтыг баримтлан захиргааны актыг хүчингүй болгосон 1 шүүхийн шийдвэр байна /Хавсралт 13/.

4.Хуулийн хэрэгжилтийг ЗЕХ-ийн бусад заалттай уялдуулсан өөрчлөлт оруулах шаардлагатай юу?

Уг хуулийн заалтад бодит нөхцөл байдлыг заагаагүй акт хүчингүй болгох үндэслэлийн хамаарлыг тодруулан  тайлбарлах шаардлагатай байна. ЗЕХ-ийн 40.2.3-тэй давхардсан заалт бөгөөд хууль хэрэглээнд хамтад нь хэрэглэх боломжтой. ЗЕХ-ийн хуулийн 47 дугаар зүйлд бичгээр гаргасан захиргааны актад ЗЕХ-ийн 40.2-т заасан тавигдах шаардлагыг хангаагүй захиргааны актыг илт хууль бус гэж үзэх хууль зүйн хөшүүрэг болох заалтыг нэмж оруулах шаардлагатай байна. Учир нь энэхүү хөшүүргийг хийж өгсөн нөхцөлд захиргааны актад бодит нөхцөл байдлыг заавал тусгах, акт нь бодит нөхцөл байдалд нийцэх хуулийн зорилго хэрэгжихээр байна.

pdfelement

**4. ЗЕХ-ийн 43 дугаар зүйлийн хэрэгжилтийн үнэлгээний талаар:**

| № | Үнэлгээ хийх хүрээнд хамаарах ЗЕХ-ийн зүйл, заалт | Шалгуур үзүүлэлтийн томьёолол | Цуглуулсан мэдээллийн төрөл |
|---|---|---|---|
| 4. | **43 дугаар зүйл.Захиргааны актыг мэдэгдэх:**<br><br>43.1.Захиргааны актыг хаяглагдсан этгээд болон эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдэд хуульд заасан журмын дагуу мэдэгдэнэ. Захиргааны актыг мэдэгдэх ажиллагааг түүнийг гаргасан захиргааны байгууллага хариуцна.<br><br>43.2.Захиргааны байгууллага захиргааны актыг хуульд өөрөөр заасан тохиолдолд өөрт нь гардуулах, шаардлагатай | -Энэ зохицуулалтын зорилго, ач холбогдол юу вэ?<br><br>-Захиргааны актыг мэдэгдэх механизм практикт хэрэгжиж байна уу?<br><br>-Хэрэгжүүлэх явцад саад, бэрхшээл байгаа юу? | 1. Захиргааны байгууллагуудаас ярилцлагын болон анкетын судалгаа авсан.<br><br>2.Захиргааны шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийсэн.<br><br>3.Уг заалттай хамааралтай бусадхуулийн заалтыг уялдуулан судалсан.<br><br>4.Захиргааны актыг төрлөөр нь сонгон авч тухайлсан захиргааны актад хуулийн заалтын хэрэгжилт ямар |

| | | | |
|---|---|---|---|
| | тохиолдолд утас, факс, шуудан, цахим болон бусад хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд ийнхүү мэдэгдсэнээ баримтжуулна.<br><br>43.3.Захиргааны актыг баталгаат шуудангаар явуулснаас хойш нийслэлд ажлын таван өдөр, орон нутагт ажлын 10 өдөр өнгөрсний дараа уг актыг мэдэгдсэнд тооцно.<br><br>43.4.Хуульд өөрөөр заасан тохиолдолд захиргааны актыг гардуулах бөгөөд гардан авсан этгээд гарын үсгээ зурж баталгаажуулна. Захиргааны актыг албан ёсоор гардуулснаар түүнийг мэдэгдсэнд тооцно.<br><br>43.5.Захиргааны актын хаяглагдсан этгээд өөрийн албан ёсны хаягтаа байхгүй, хаягийн өөрчлөлтийг захиргааны байгууллагад мэдэгдээгүй, эсхүл зориуд санаатайгаар хүлээн авахаас зайлсхийсэн тохиолдолд хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлснээс хойш ажлын 10 өдөр өнгөрсний дараах өдрийг уг актыг албан ёсоор мэдэгдсэнд тооцно.<br><br>43.6.Захиргааны актыг мэдэгдвэл зохих этгээд 20 буюу түүнээс дээш тооны байх тохиолдолд төлөөлөгчид, төлөөлөгч байхгүй бол хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдэгдэж болно.<br><br>43.7.Хуульд өөрөөр заасан тохиолдолд захиргааны актыг нийтэд мэдэгдэх бөгөөд захиргааны актыг үйлчлэх тодорхой нутаг дэвсгэрийн хэмжээнд хэвшсэн журмаар нийтэд танилцуулснаас хойш ажлын 10 өдөр өнгөрсний дараа уг актыг мэдэгдсэнд тооцно. | | байгаад дүн шинжилгээ хийсэн.<br><br>5.Захиргааны байгууллагуудад хэрэглэж байгаа шийдвэр мэдэгдэх журам, загвар мэдэгдэх хуудсыг судалсан. |

| | | | |
|---|---|---|---|
| | Тайлбар: Хэвшсэн журмаар нийтэд танилцуулах гэж захиргааны байгууллагын албан ёсны мэдээллийн самбар, цахим хуудас, орон нутгийн болон үндэсний шинжтэй хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг ойлгоно.<br><br>43.8.Захиргааны актыг мэдэгдсэн эсэх талаар маргаан гарсан тохиолдолд захиргааны актыг гаргасан байгууллага захиргааны актыг мэдэгдсэн хугацааг нотлох үүрэгтэй. | | |

**1.Энэ зохицуулалтын зорилго, ач холбогдол юу вэ?**

Онолын хувьд захиргааны акт батлан гарснаар эрх зүйн харилцаа үүссэн, үр дүндээ хүрсэн гэж үздэггүй буюу хүчин төгөлдөр захиргааны актад тооцдоггүй байна. Харин захиргааны актыг хаяглагдсан болон эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн этгээдэд хууль ёсны дагуу мэдэгдсэн үеэс гадагшаа чиглэсэн шинжийг агуулж, эрх зүйн харилцаа үүсч, хууль зүйн үр дагавар бий болгох хүчинтэй төгөлдөр захиргааны акт гэж үздэг. Хууль ёсны дагуу мэдэгдээгүй бол захиргааны акт болдоггүй, уг актыг дотоод баримт бичигт тооцох, уг акт үйлчлэх хүчин чадалгүй байх үр дагавартай байдаг. Захиргааны актыг мэдэгдэх эрхгүй этгээдээр илгээх нь хуульд заасан журмаар мэдэгдсэнд тооцогддоггүй. Тодруулбал, захиргааны актыг мэдэгдэх үйл ажиллагаа нь түүний хүчин төгөлдөр болохтой шууд холбоотой. Захиргааны актыг мэдэгдэх ажиллагаа нь хаяглагдсан болон эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн этгээд өөрийн хуульд заасан эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах ач холбогдолтой[47]. Энэ үзэл баримтлалын дагуу ЗЕХ-ийн 43 дугаар зүйлээр захиргааны актыг мэдэгдэх хэлбэр, мэдэгдсэнд тооцогдох хугацаа, үндэслэл, мэдэгдэх үүргийг хариуцах этгээд, мэдэгдсэнээ баримтжуулах үүрэг, мэдэгдэх хугацааг нотлох үүрэг зэргийг нарийвчилан зохицуулжээ.

**2.Захиргааны актыг мэдэгдэх механизм практикт хэрэгжиж байна уу?**

1.ЗЕХ-ийн 43 дугаар зүйлд заасанаас бусад хуульд актыг мэдэгдэх дараахь байдлаар заажээ:

| Бусад хууль тогтоомжоор захиргааны актыг мэдэгдэх талаар тусгайлан зохицуулсан заалтууд: |
|---|
| **1.Ашигт малтмалын тухай хуулиас:**<br><br>20.1.Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 10.1.2-д заасан журмын дагуу зохион байгуулж, доор дурдсан ажиллагааны аль нэгийг гүйцэтгэнэ: |

[47]ЗЕХ-ийн захиргааны акттай холбоотой хэсгийн боловсруулсан доктор П.Одгэрэл, Захиргааны эрх зүйн ерөнхий анги, 2016, х 202-204, Захиргааны ерөнхий хуулийн тайлбар, 2017, х 208-209



pdfelement Remove Watermark Now

20.1.1.хүсэлт гаргасан хуулийн этгээдийн техникийн болон үнийн саналд энэ хуулийн 10.1.2-д заасан журмын дагуу үнэлгээ өгч, хамгийн өндөр үнэлгээ авсан оролцогчид тусгай зөвшөөрөл олгох боломжтойг мэдэгдэх;

20.1.2.хэрэв 2 болон түүнээс дээш оролцогч адил үнэлгээ авсан бол хүсэлтээ хамгийн түрүүнд бүртгүүлсэн оролцогчид тусгай зөвшөөрөл олгох боломжтойг мэдэгдэх.

26.3.Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 26.1, 26.2-т заасан ажиллагааг гүйцэтгэсний үндсэн дээр өргөдлийг бүртгэснээс хойш ажлын 20 өдөрт багтаан дараахь шийдвэрийн аль нэгийг гаргаж, өргөдөл гаргагчид мэдэгдэнэ:

26.3.1.өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг нь энэ хуулийн 24.3, 24.4, 25.1-д заасан шаардлагыг хангаагүй бол хүсэлтийг хүлээн авахаас татгалзаж шалтгаан, үндэслэлийг нь дурдсан хариуг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэж, өргөдөл бүртгэх дэвтэрт энэ тухай тэмдэглэх;

26.3.2.хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн талбайд ашиглалтын тусгай зөвшөөрөл хүсч өргөдөл гаргасан бол онцгой эрхийнх нь дагуу уурхайн талбай олгож, ашиглалтын тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг энэ хуулийн 34.1-д заасан хугацаанд төлүүлэх;

26.3.3.хүсэлтэд дурдсан талбай нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, эсхүл тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайтай ямар нэг байдлаар давхцаагүй бол уурхайн талбай олгож, тусгай зөвшөөрлийн эхний жилийн төлбөрийг энэ хуулийн 34.1-д заасан хугацаанд төлүүлэх;

26.3.4.хүсэлтэд дурдсан талбай нь энэ хуулийн 26.3.3-т заасан талбайн аль нэг хэсэгтэй давхацсан бол ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзаж, шалтгаан үндэслэлийг нь дурдсан хариуг өргөдөл гаргасан этгээдэд бичгээр мэдэгдэж, энэ тухай өргөдөл бүртгэх дэвтэрт тэмдэглэх.

pdfelement

28.2.Төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 28.1-д заасан өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 15 өдөрт багтаан тусгай зөвшөөрөл эзэмшигч уг зөвшөөрөл эзэмших эрхийг хадгалах нөхцөлийг хангасан эсэхийг хянаж зөрчилгүй бол тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 27.1.7-д заасан хугацаагаар сунгаж энэ тухай тусгай зөвшөөрлийн бүртгэлд тэмдэглэж өргөдөл гаргасан этгээдэд мэдэгдэнэ.

49.6.Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 49.5-д заасан ажиллагааг өргөдлийг бүртгэснээс хойш ажлын 5 өдөрт багтаан гүйцэтгэж дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

49.6.3.тусгай зөвшөөрөл шилжүүлэн авч байгаа тал уг тусгай зөвшөөрлийг эзэмших эрхгүй, эсхүл шилжүүлэх тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр бус бол өргөдлийг хүлээн авахаас татгалзаж, холбогдох баримт бичгийг буцааж хариу мэдэгдэх.

51.7.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь барьцааны гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхээргүй, эсхүл энэ хуулийн 22, 28 дугаар зүйлд зааснаар тусгай зөвшөөрлийн хугацаа дуусгавар болох нөхцөл бүрдсэн тохиолдолд төрийн захиргааны байгууллага энэ тухай барьцаалагчид мэдэгдэх бөгөөд барьцаалагч нь мөн хуулийн 7.1-д заасан эрх бүхий этгээдэд тусгай зөвшөөрлийг шилжүүлэх саналыг тэргүүн ээлжинд гаргах эрхтэй.

51.8.Тусгай зөвшөөрлийн хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас 14-өөс доошгүй хоногийн өмнө төрийн захиргааны байгууллага энэ тухай тусгай зөвшөөрөл барьцаалагчид мэдэгдэх бөгөөд барьцаалагч энэ мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10

Remove Watermark Now

| |
|---|
| хоногийн дотор тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 51.7-д заасны дагуу шилжүүлэх саналыг уг албанд ирүүлнэ.<br><br>56.2.Төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэл тогтоогдсоноос хойш ажлын 10 өдөрт багтаан тусгай зөвшөөрөл эзэмшигчид энэ тухай мэдэгдэл өгөх бөгөөд түүнд тусгай зөвшөөрлийг цуцлах болсон үндэслэлийг тодорхой заана.<br><br>56.3.Энэ хуулийн 56.2-т заасан мэдэгдэлд заасан үндэслэлийг зөвшөөрөхгүй бол тусгай зөвшөөрөл эзэмшигч түүнийгээ нотлох баримт бичгийг төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.<br><br>56.4.Төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 56.3-т заасан баримт бичгийг хянаж үндэслэлтэй бол тусгай зөвшөөрлийг цуцлах тухай мэдэгдлийг хүчингүй болгох ба үндэслэлгүй бол тусгай зөвшөөрлийг цуцалж эдгээр шийдвэрийг эзэмшигчид нь мэдэгдэнэ.<br><br>62.6.Төрийн захиргааны байгууллага нь маргаантай хил, цэгийн солбицлуудыг шалгаж, холбогдох засвар, өөрчлөлтийг хийсэн шийдвэр гаргаж, энэ тухай маргаанд оролцогч талуудад мэдэгдэнэ. |
| **2.Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулиас:**<br><br>**9 дүгээр зүйл. Жагсаал, цуглаан хийх журам**<br><br>9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:<br><br>3. Засаг дарга жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор түүнийг бүртгэсэн эсэхээ бичгээр мэдэгдэнэ. |
| **3.Төрийн хяналт шалгалтын тухай хуулиас**<br><br>$5^{3}$.3.Гүйцэтгэлийн шалгалт хийхдээ шалгуулагч этгээдэд ажлын хоёроос доошгүй хоногийн өмнө урьдчилан мэдэгдэнэ. |
| **4.Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулиас:**<br><br>7.7.Энэ хуулийн 6.6-д заасан зүйлийг энэ хуулийн 7.6-д заасан хугацаанд ирүүлээгүй бол төрийн захиргааны байгууллага мэдүүлэг гаргагчийг тухайн мэдүүлгээсээ татгалзсанд тооцож, энэ тухай мэдүүлэг гаргагчид бичгээр мэдэгдэнэ. |
| **5.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулиас:**<br><br>21.2.Аймаг, нийслэлийн Засаг дарга нь энэ хуулийн 21.1-д заасан өргөдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдөрт багтаан тусгай зөвшөөрөл эзэмшигч уг зөвшөөрөл эзэмших эрхийг хадгалах нөхцөлийг хангасан эсэхийг хянаж, зөрчилгүй бол тусгай зөвшөөрлийг энэ хуулийн 20.1.5-д заасан хугацаагаар сунгаж, энэ тухай тусгай зөвшөөрлийн бүртгэлд тэмдэглэж, өргөдөл гаргасан этгээдэд мэдэгдэнэ.<br><br>21.3.Аймаг, нийслэлийн Засаг дарга ашиглалтын тусгай зөвшөөрлийн хугацааг сунгасан тухай шийдвэрийг түүнийг гарснаас хойш ажлын 10 өдөрт багтаан энэ хуулийн 19.7-д заасан байгууллагуудад мэдэгдэнэ. |
| **6.Банкны тухай хуулиас** |

pdfelement

Remove Watermark Now

| |
|---|
| 23.3.Монголбанк нь банк байгуулах тусгай зөвшөөрөл олгох эсэх шийдвэрийг энэ хуулийн 20.1-д заасан өргөдлийг хүлээн авснаас хойш 60 хоногийн дотор гаргаж, энэ тухай банк үүсгэн байгуулагчид гурав хоногийн дотор бичгээр мэдэгдэнэ. |
| **7.Татварын ерөнхий хуулиас**<br><br>54.1.Татвар төлөгчийн хугацаандаа төлөөгүй татвар болон энэ хуулийн 48 дугаар зүйлд заасан журмаар татварын албанаас тодорхойлон тогтоосон татварыг төлүүлэхээр мэдэгдэх хуудсыг татвар төлөгчид гардуулах бөгөөд түүнд дараах зүйлийг тусгана: |
| **8.Хөдөлмөрийн тухай хуулиас:**<br><br>40.5.Ажил олгогч энэ хуулийн 40.1.1, 40.1.2 -т заасан үндэслэлээр хөдөлмөрийн гэрээг цуцлах тухайгаа ажилтанд нэг сарын өмнө мэдэгдэх бөгөөд аж ахуйн нэгж, байгууллага, түүний салбар, нэгж татан буугдсаны улмаас ажилтнуудыг бөөнөөр халах тохиолдолд ажилтны төлөөлөгчдөд 45 хоногийн өмнө мэдэгдэж, энэ хуульд заасны дагуу хэлэлцээ хийнэ. |
| **10.Эрчим хүчний тухай хуулиас:**<br><br>27.5.Зохицуулах хороо нь эрчим хүчний тарифт орох өөрчлөлтийн талаар түүнийг мөрдөж эхлэхээс 15-аас доошгүй хоногийн өмнө хэрэглэгчид мэдэгдэх буюу хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.<br><br>28.5.Хэрэглэгч энэ хуулийн 27.5-д заасны дагуу мэдэгдсэнээс хойш 15 хоногийн дотор хангагчтай байгуулсан гэрээндээ зохих өөрчлөлт оруулах бөгөөд гэрээндээ өөрчлөлт оруулаагүй нь энэхүү өөрчлөлтийг мөрдөхөөс татгалзах үндэслэл болохгүй. |

pdfelement

3.Захиргааны байгууллагаас гаргасан тодорхой актуудад хийсэн дүн шинжилгээ:

| № | Захиргааны актыг мэдэгдсэн акт гаргасан захиргааны байгууллагын нэр, актын дугаар, утга | Захиргааны актыг мэдэгдсэн агуулга |
|---|---|---|
| 1 | АМГТГКХ-ийн 2017.07.31-ний өдрийн 460 дугаар тушаал, Хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах тухай<br><br>АМГТГКХ-ийн даргын 2017.07.31-ний өдрийн 7/5282 тоот албан бичиг, Шийдвэрийн дагуу мэдэгдэл хүргүүлэх тухай | Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5 дахь заалтыг үндэслэн 2017.07.31-ний өдрийн 460 дугаар шийдвэрээр танай компанид хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан болохыг мэдэгдье гэжээ.<br><br>/Захиргааны актыг мэдэгдэх хуулийн үндэслэлийг тодорхой зааж өгөөгүй байв/ |
| 2 | ОӨУБЕГ-н улсын бүртгэгчийн 2017.12.20-ны өдрийн 17/61 тоот мэдэгдэл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан мэдэгдэл, | УБЕГД-н 2015 оны тушаалын хавсралт<br><br>/Захиргааны актыг мэдэгдэх хуулийн үндэслэлийг тодорхой зааж өгөөгүй байв/ |

| | | |
|---|---|---|
| 3 | Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018.04.02-ны өдрийн Б/245 дугаар тушаал,<br><br>Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын 2018.03.05-ны өдрийн 19/102 тоот албан бичиг, 2018.03.01-ний өдрийн шийдвэрийн төсөл танилцуулах тухай хуудас, | Нэхэмжлэгчид мэдэгдэж, гарын үсэг зурсан байв.<br><br>/Захиргааны актыг мэдэгдэх хуулийн үндэслэлийг тодорхой зааж өгөөгүй байв/ |
| 4 | Цагдаагийн ерөнхий газрын Тендерийн үнэлгээний хорооны 2018.04.18-ны өдрийн 6/674 тоот мэдэгдэл, | Мэдээлэл ирүүлээгүй, түгээх станц байхгүй үндэслэлээр тендер гэж үзэж тендерээс татгалзах болсныг үүгээр мэдэгдье гэжээ |

**3.Захиргааны нийт 20 байгууллагаас авсан анкетын судалгааны талаар /Хавсралт 11/:**

**Танай байгууллагын хувьд захиргааны актыг иргэн, хуулийн этгээдэд мэдэгдэх ажиллагаа явуулахад ямар хүндрэл учирч байна вэ гэсэн асуултад:** иргэн, хуулийн этгээд шийдвэрээ гардаж авдаггүй талаар 40 хувь буюу 8 захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээд хаягтаа байдаггүй тул байгууллагад буцан ирдэг талаар 55 хувь буюу 11 захиргааны байгууллага, мэдэгдэх хугацааг тодорхойлоход хүндрэлтэй байдаг талаар 5 хувь буюу 1 захиргааны байгууллага хариулт өгчээ.

Захиргааны актыг мэдэгдэх Захиргааны ерөнхий хуулийн зохицуулалтыг илүү нарийвчлан зохицуулах шаардлагатай юу гэсэн асуултад: шаардлагатай гэж 80 хувь буюу 16 захиргааны байгууллага, шаардлагагүй гэж 20 хувь буюу 4 захиргааны байгууллага хариулжээ.

**4.ЗЕХ хэрэгжиж эхэлснээс хойш захиргааны актыг мэдэгдэх ажиллагааг журам гарган, мэдэгдэх хуудасны загвар баталсан захиргааны байгууллагын талаар:**

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2017 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/22 дугаар тушаалаар “оролцогчид мэдэгдэх хуудасны загвар”, “шийдвэрийн төсөл танилцуулах хуудас”, “захиргааны шийдвэрийн мэдэгдэх хуудасны загвар” тус тус батлан мөрдүүлж байна. Мөн Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2018 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/86 дугаар тушаалаар “мэдэгдэх хуудасны загвар”, “захиргааны шийдвэрийн төсөл танилцуулах хуудас”, “захиргааны шийдвэрийг мэдэгдэх хуудас”-ны загвар, “захиргааны шийдвэрийн хяналтын хуудас”-ны загвар баталжээ **/Хавсралт 14**/.

**5.Шүүхийн шийдвэрийн shuukh.mn сангаас ЗЕХ-ийн 43 дугаар зүйлийг хэрэглэж гаргасан шүүхийн шийдвэрийн шүүж, дүн шинжилгээ хийсэн талаар /Хавсралт 15/**:

Захиргааны хэргийн анхан шатны нийт 21 шүүхийн шийдвэрт нэхэмжлэгч, хариуцагчаас ЗЕХ-ийн 43 дугаар зүйлд заасан захиргааны актыг мэдэгдэх ажиллагааны талаар маргаж, шүүхээс үндэслэх хэсэгтээ дүгнэсэн 20 шийдвэр, тогтоох хэсэгтээ 43 дугаар зүйлийг баримтлан захиргааны актыг хүчингүй болгосон 1 шийдвэр байна.



Remove Watermark Now

Remove Watermark Now

Үндэслэх хэсэгтээ 43 дугаар зүйлийг баримталж тогтоох хэсэгтээ ЗЕХ-ийн 4.2.6-д заасан "4.2.Захиргааны үйл ажиллагаанд дараах тусгай зарчмыг баримтална:4.2.6.бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах тохиолдолд тэдгээрт урьдчилан мэдэгдэх, оролцоог нь хангах;" гэсэн заалтыг баримтлан захиргааны актыг хүчингүй болгосон 4 шийдвэр байна.

**6.Дүгнэлт, зөвлөмж:**

Шүүгчдийн дунд явуулсан хэлэлцүүлгээс шүүхийн практикт ЗЕХ-ийн 43 дугаар зүйлд заасан мэдэгдэх шаардлагыг биелүүлээгүй үндэслэлээр захиргааны актыг хүчингүй болгоход дээд шатны шүүхээс хэлбэрийн төдий шаардлага учир энэ үндэслэлээр акт хүчингүй болгох үндэслэлгүй гэж дүгнэсэн талаар тайлбарлажээ. Хэргийн оролцогч талуудаас 43 дугаар зүйлд заасан захиргааны актыг мэдэгдэх шаардлагыг хангаагүй талаар маргадаг боловч шүүхээс энэ үндэслэлээр захиргааны актыг хүчингүй болгосон тохиолдол зөвхөн 1 удаа гарсан байна. Захиргааны актыг хаяглагдсан болон эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн этгээдэд хууль ёсны дагуу мэдэгдсэн үеэс гадагшаа чиглэсэн шинжийг агуулж, эрх зүйн харилцаа үүсч, хууль зүйн үр дагавар бий болгох хүчинтэй төгөлдөр захиргааны акт гэж үздэг ЗЕХ-ийн зорилго, үзэл баримтлалын дагуу цаашид захиргааны актыг мэдэгдэх ажиллагаа захиргааны байгууллага заавал хийдэг болгох, хуулийн хэрэгжилтийг нэг мөр болгох шаардлагатай гэдэг нь судалгаанаас харагдаж байна. Хэдийгээр зарим байгууллагаас актыг мэдэгдэх ажиллагааны талаар анхаарч журам гаргаж, мэдэгдэх хуудасны загвар батлан мөрдүүлж байгаа боловч энэ нь хангалтгүй байна. Иймд шүүхээс уг хуулийн заалтыг хуулийн зорилгод нийцүүлэх болон ЗЕХ-ийн тусгай зарчмыг зохицуулсан4.2.6-д заасан зохицуулалттай хэрхэн уялдуулан хэрэглэх талаар нэг мөр ойлголтыг бий болгож, нэгдсэн практик тогтоох, ЗЕХ-ийн 48 дугаар зүйлд 43 дугаар зүйлд захиргааны актыг мэдэгдэх шаардлагыг хангаагүй захиргааны акт хүчингүй болгох үндэслэлээр өөрчлөлт оруулах, мэдэгдэх нарийвчилсан журмыг тухайн захиргааны байгууллага гаргах боломжийн талаар тайлбарлан таниулах шаардлагатай байна.

pdfelement

**5. 47 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтын хэрэгжилтэнд хийсэн үнэлгээний талаар:**

| № | Үнэлгээ хийх хүрээнд хамаарах ЗЕХ-ийн зүйл, заалт | Шалгуур үзүүлэлтийн томьёолол | Цуглуулсан мэдээллийн төрөл |
|---|---|---|---|
| 5. | **47 дугаар зүйл.Захиргааны акт илт хууль бус болох**<br><br>**47 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг 6 дахь заалт:**<br><br>47.1.Дараах тохиолдолд захиргааны акт илт хууль бус болно:<br><br>47.1.6.иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байгаагүй; | 1.Захиргааны акт илт хууль бус байх үндэслэлд оруулж өгсний гол ач холбогдол юу вэ? Хуульд үндэслэх зарчимтай холбогдох хамаарал бий юу? Практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? | 1. Захиргааны байгууллагуудаас ярилцлагын болон анкетын судалгаа авсан.<br><br>2.Захиргааны шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийсэн. |

Remove Watermark Now

**1.Захиргааны акт илт хууль бус байх үндэслэлд оруулж өгсний гол зорилго, ач холбогдол юу вэ? Хуульд үндэслэх зарчимтай холбогдох хамаарал бий юу?**

Захиргааны акт илт хууль бус байх гэдэг нь ноцтой алдааг илэрхийлдэг, илт хууль бус захиргааны акт анхнаасаа эрх зүйн үйлчлэл үзүүлэхгүй, захиргааны актаар бий болсон үүргийг иргэн биелүүлэх шаардлагагүй. Илт хууль бус үндэслэлийг тогтоохдоо тухайн актын алдаа нь ноцтой үр дагавар бүхий, уг алдаа нь нийтэд илэрхий мэдэгдэж байгаа тохиолдлыг шалгана. ЗЕХ-ийн 47.1.6-д заасан “иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байгаагүй;” гэдгийг хуульд үндэслэх зарчмыг зөрчсөн алдаануудыг хамааруулан ойлгоно. Хуульд үндэслэх зарчим нь захиргаанаас иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх ашгийг хөндсөн үйл ажиллагааг хуулиар эрх олгогдсон, хуулиар зөвшөөрсөн үед л хэрэгжүүлэх боломжтой холбоотой юм. Захиргааны байгууллагаас хуулиар эрх олгогдоогүй тохиолдолд хүний эрх, эрх чөлөө, эд хөрөнгөнд халдсан захиргааны шийдвэр гаргасан тохиодолд уг захиргааны акт нь ЗЕХ-ийн 47.1.6-д заасны дагуу илт хууль бус захиргааны акт болох үзэл баримтлалын дагуу энэ хуулийн заалтын агуулгыг ойлгоно.[48]

**2.Практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?**

Захиргааны 20 байгууллагаас авсан анкетын судалгааны талаар:

Захиргааны акт гаргахдаа ЗЕХ-ийн 47.1.6 дахь заалтыг хэрэглэж байсан гэсэн асуултад тийм гэсэн хариултын 10% буюу 2 байгууллага, Үгүй гэсэн хариултыг 20 хувь буюу 4 байгууллага, мэдэхгүй гэсэн хариултыг 70 хувь буюу 14 байгууллага өгчээ.




Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6 дах заалт ойлгомжгүй, дэлгэрэнгүй тайлбарласан өөрчлөлт оруулах шаардлгатай юу гэсэн асуултад ойлгомжгүй, хэрэглэхэд хүндрэлтэй учир дэлгэрэнгүй тайлбар оруулах шаардлагатай гэж 85 хувь буюу 17 байгууллага хариулт өгч, өдөр тутам хэрэглэдэг, өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж 15 хувь буюу 3 байгууллага хариулт өгчээ.

[48]П.Одгэрэл, Захиргааны эрх зүйн ерөнхий анги 2016, х 81-83, 213-215, хуулийн үзэл баримтлал, танилцуулгад хийсэн дүн шинжилгээ

Remove Watermark Now




**3.Шүүхийн шийдвэрийн shuukh.mn сангаас ЗЕХ-ийн 47.1.6 дахь заалтыг хэрэглэж гаргасан шүүхийн шийдвэрийн шүүж, дүн шинжилгээ хийсэн талаар /Хавсралт 16-аас дэлгэрэнгүйг харах боломжтой/:**

ЗЕХ хууль хэрэгжиж эхэлснээс хойш ЗЕХ-ийн 47.1.6 дахь заалтыг шүүхийн шийдвэрийн үндэслэх, тогтоох хэсэгтээй хэрэглэж гаргасан нийт 40 шүүхийн шийдвэр байгаагаас төрлөөр авч үзвэл Төрийн албаны маргаан 18, Ашигт малтмалын маргаан 7, Бусад 7, Газрын маргаан 4, Татварын маргаан 2, Нийгмийн даатгалын маргаан 1, Тусгай зөвшөөрөлтэй холбоотой маргаанд 1 байна.

pdfelement




ЗЕХ-ийн 47.1.6 дахь заалтыг шүүхийн шийдвэрийн үндэслэх, тогтоох хэсэгтээй хэрэглэж гаргасан нийт 40 шүүхийн шийдвэрээс 22 шийдвэрээр ЗЕХ-ийн 47.1.6 заалтыг үндэслэн захиргааны актыг илт хууль бусад тооцсон байна. Захиргааны актыг илт хууль бус гэж тооцсон шүүхийн 22 шийдвэр байгаа бөгөөд үүнээс 19 шүүхийн шийдвэр нь илт хууль бусад тооцох үндэслэлийг шийдвэрийн Үндэслэх хэсэгтэй дүгнэлт хийснийг дор дурдсан хүснэгтээр үзүүлэв:

Remove Watermark Now

| № | ЗЕХ-ийн 47.1.6 заалтыг баримтлан захиргааны актыг хүчингүй болгосон зарим шүүхийн шийдвэрийн үндэслэлийн талаар |
|---|---|
| **1.** | Дээрх байдлуудаас дүгнэлт хийхэд хариуцагч Дархан-Уул аймгийн Засаг дарга нь 2016 оны11 дүгээр сарын 29-ний өдрийн А/440 дүгээр захирамжаар нэхэмжлэгч "С-" ХХК-ийн газарэзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгож, дээрх захиргааны акт гарсантай холбогдууланөмнөх Засаг даргын гаргасан 2016 оны А/272 дугаар захирамжийг хүчингүйд тооцож,Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1 – 40.1.6-д заасан үндэслэл тогтоогдохгүйбайхад нэхэмжлэгчийн газар эзэмших эрхэд халдаж, эрхийн гэрчилгээг хүчингүй болгосонь Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6-д *"иргэн, хуулийн этгээдийн эрх,хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байгаагүй"* гэж зааснаар илтхууль бус захиргааны акт гэж үзэх хууль зүйн үндэслэлтэй байна гэж шүүх бүрэлдэхүүнүзлээ. |
| **2.** | Засгийн газрын 2013 оны 391 дүгээр тогтоолд үндэслэсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн заалтууд нь төрийн өмчийн талаарх Засгийн газрын бүрэн эрхийн заалтууд бөгөөд уг хуулийн заалтаар хувийн өмчийн асуудлыг шийдвэрлэснийг Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6-д "иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байгаагүй;" гэж зааснаар илт хууль бус болохыг тогтоох нь зүйтэй. |
| **4.** | Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2017 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/23 дугаар тушаалаар Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2015 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн А/84 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцохдоо Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2016 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 1076 дугаар захирамжийг үндэслэсэн нь уг актыг илт хууль бус гэж үзэх үндэслэл болж байна. |
| **5.** | Хууль зүй, дотоод хэргийн яаманд албан хаагчдыг нөөцөд авах, ийнхүү нөөцөд авсан тохиолдолд тэдний цалин хөлс, нийгмийн даатгалыг хэрхэн тооцох талаар тусгайлсан журам байхгүй, нэхэмжлэгч нар нь уг хуулийн 23.3, 23.4-т заасан үндэслэлүүдээр чөлөөлөгдөөгүй байхад тэднийг нөөцөд байгаад тооцож, ажлын байраар хангах арга хэмжээ авахыг Төрийн захиргааны удирдлагын газрын даргад үүрэг болгосон, нэхэмжлэгч нарт өөр ажлын байр санал болгосон нь бүхэлдээ хууль зүйн үндэслэлгүй, утга агуулгын илэрхий алдаатай захиргааны акт болсон байна. Энэ тохиолдолд нэхэмжлэгч нарыг "санал болгосон ажлын байранд очиж ажиллаагүй" гэж буруутгах боломжгүй, анхнаасаа өөр ажлын байрсанал болгох хуульд заасан нөхцөл бүрдээгүй байх бөгөөд энэ талаархи хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тайлбар хууль бус юм. |
| **6.** | Л.Г нь Нийгмийн халамж үйлчилгээний хэлстийн даргын 2016 оны 08 сарын 17-ны өдрийн Б/28 дугаартай тушаалаар үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт шилжин ажиллаж 2016 оны 08, 09, 10 дугаар саруудад цалингаа авч хөдөлмөрийн харилцаанд орсон байхад Л.Г-ийг ажлын байр хасагдсан эсвэл цөөрсөн аль үндэслэлээр ажлаас чөлөөлсөн нь тушаалд тодорхойгүй, энэ талаар дурдагдаагүй байна. Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 47.1.6-д заасан илт хууль бус шинжийг агуулж байх тул Увс аймгийн Хөдөлмөр,халамжийн үйлчилгээний газрын даргын 2016 оны 11 сарын 03-ны өдрийн Б/70 дугаартай тушаалыг илт хууль бус болохыг тогтоож шийдвэрлэх нь зүйтэй байна. |

pdfelement

Remove Watermark Now

| | |
|---|---|
| **7.** | Нэгэнт эрх бүхий албан тушаалтан хянаж баталгаажуулаагүй, гарын үсэг зураагүй, үүнийг хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч нар шүүх хуралдааны явцад хүлээн зөвшөөрч байгаагаас үзвэл эрх зүйн үйлчлэлгүй, хүчин төгөлдөр бус актыг биелүүлэхийг шаардсан хариуцагчийн үйлдэл нь нэхэмжлэгч “Ш ” ХХК-ийн хууль ёсны ашиг сонирхолд халдах үндэслэл болохгүй юм.Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1-д “дараахь тохиолдолд захиргааны акт илт хууль бус болно”...47.1.6-д “иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байгаагүй” гэж зааснаар Татварын байцаагч нарын гаргасанакт нь илт хууль бус актад хамаарч байна гэж шүүх дүгнэв. |
| **8.** | МҮ-015651 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг олгосон шийдвэр нь анхнаасаа хууль зөрчиж гарсан илт хууль бус акт тул түүнийг шилжүүлсэн шийдвэр нь мөн адил илт хууль бус шинжийг агуулж байгаа илт хууль бус акт гэж үзэв.<br><br>Нөгөө талаар гуравдагч этгээд “О м” ХХК-нд маргаан бүхий тусгай зөвшөөрлийг эзэмших хуулиар хамгаалагдах эрх хууль ёсны эрх ашиг үүсээгүй байна. Учир нь тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж байсан Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д зааснаар шүүх хууль ёсоор үүссэн эрхийг хамгаалах болохоос хууль бусаар үүссэн эрхийг хамгаалах үндэсгүй юм. |
| **9.** | Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлд заасан захиргааны актыг илт хууль бус-д тооцох үндэслэл нь илэрхий, ноцтой хор уршиг бүхий, засах боломжгүй алдааг ойлгох бөгөөд 47.1.6-д иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульдзаасан үндэслэл байгаагүй гэдэг нь захиргааны актыг гаргах эрх зүйн үндэслэл огт байхгүй, эсхүл акт ямар ч хуульд үндэслээгүй гарсныг ойлгоно. Энэ нь захиргааны шийдвэр хуульд үндэслэх зарчим буюу эрх зүйт төрийн хууль дээдлэх зарчмыг зөрчиж байгаагаараа илт ноцтой алдаанд тооцогддог учиртай.<br><br>Иймд нэхэмжлэгч Дурсамж ретро ХХК-ийн Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2016 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/166 тоот тушаалын “Т З” ХХК-д холбогдох хэсгийг илт хууль бус болохыг тогтоолгох тухай нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд хангаж шийдвэрлэх нь зүйтэй гэж шүүх дүгнэв. |
| **10.** | Ажлын байрны тодорхойлолтод заасан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд авч хэрэгжүүлсэн арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нэхэмжлэгчийн алдаа дутагдал, гэм буруу, учруулсан хохирлын хэр хэмжээг бодит хийсэн үйл ажиллагаанд үндэслэн бодитойгоор үнэлж тогтоогоогүй, мөн С үнэлгээ тавьсан атлаа D үнэлгээнд хэрэглэх хариуцлагын арга хэмжээг авч хэрэгжүүлэн нэхэмжлэгчийг албан тушаал бууруулсан хариуцагчийн үйлдэл нь илт хууль бус бөгөөд Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6-д заасны дагуу нэхэмжлэгч Т.Ганболдын албан тушаал, цалин буурахгүй байх эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байгаагүй гэж үзэхээр байна. |
| **11.** | Иймд уг маргаан бүхий захиргааны актын улмаас нэхэмжлэгчийн үндэслэлгүйгээр албан тушаал, цалин буурахгүй байх эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хариуцагч зөрчсөн тул нэхэмжлэгчийн иймхүү зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг шүүхээс сэргээн тогтоох нь үндэслэлтэй байх тул нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хանган шийдвэрлэв. |
| **12.** | “О” ХХК-ийн “Тусгай зөвшөөрлийг цуцлах тухай” 2009 оны 516 дугаар шийдвэр нь Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6-д “иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байгаагүй;” гэсэн |

Remove Watermark Now

| | |
|---|---|
| | заалтыг зөрчиж гаргасан захиргааны акт болох нь дээр дурьдсан хууль зүйн үндэслэл, хэрэгт авагдсан баримтуудаар тус тус тогтоогдож байна.<br><br>Учир нь Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6-д заасан “хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байгаагүй” гэдэгт “ захиргааны байгууллага, албан тушаалтан хуулиар тогтоосон хязгаарлалтыг зөрчих, түүнчлэн хуулиас гадуур нэмэлт хязгаарлалт тогтоох, бүрэн эрхээ хэтрүүлэх зэргээр захиргааны акт гаргасан”-ыг ойлгоно. |
| **13.** | Хариуцагчаас нэхэмжлэгч Ц.Х-д сахилгын шийтгэл ногдуулахдаа дээрх хуулийн зохицуулалтыг удирдлага болгосон байх ба хуулийн 1 дүгээр зүйлд заасан зөрчлүүдээс аль зөрчлийг гаргасан, тухайн зөрчлийг хэрхэн илрүүлсэн болон байгууллагын зүгээс хяналт шалгалт хийсэн эсэх нь тодорхойгүй байх ба ямар эх сурвалжаас мэдээлэл авч нэхэмжлэгчийг буруутгаж байгаагаа нотолж чадаагүйн дээр Захиргааны ерөнхий хуулийн 24 дүгээр зүйл /Нөхцөл байдлыг тогтоох/-д заасан үүргээ захиргааны байгууллага биелүүлээгүй, 25 дугаар зүйлд заасан шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах, оролцогчийг сонсох, тайлбар гаргуулах зэрэг ажиллагааг хийгээгүй байна. Хариуцагчаас нэхэмжлэгчид мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 /Захиргааны акт, захиргааны гэрээг батлан гаргахын өмнө эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдэд захиргааны шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар тайлбар, санал гаргах боломж олгоно/-д заасан боломжийг олгоогүй, түүнийг эзгүйд арга хэмжээ авч, ажлаас чөлөөлсөн нь үндэслэлгүй болжээ. |
| **14.** | Мөн Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 97 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, энэ талаар төрийн дээд шатны байгууллагад гомдол гаргах журам”-ын 4 /Сахилгын шийтгэл ногдуулах үндэслэлийг заавал шалгаж тогтоон, энэ тухай баримт, үндэслэлийг зөрчил гаргасан албан хаагчид урьдчилан танилцуулсан байна. Зөрчил гаргасан албан хаагч уг баримт материалтай танилцаад нэмэлт тайлбар хийх, дахин шалгалт явуулахыг шаардах эрхтэй/ -т заасныг зөрчиж сахилгын ямар зөрчил гаргасныг тогтоолгүйгээр Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийг баримталж арга хэмжээ авсан шийдвэр нь Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6 /иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байгаагүй/ -д заасны дагуу илт хууль бус акт гэж үзэх үндэслэлтэй. |
| **15.** | Хариуцагчаас нэхэмжлэгч нарын орон тоо хасагдсан тохиолдлын хугацааг бодит байдлаас өөрөөр тогтоож тэтгэмж олгосон акт гаргасан өдөр мөрдөгдөж байсан хуулийн заалтыг баримтлан нэхэмжлэгч нарт Төрийн албаны тухай хуулиар олгогдох байсан баталгааг дордуулсан хэлбэрээр эдлүүлэх шийдвэр гаргах үндэслэл байгаагүй учир маргаан бүхий акт нь Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6-д заасан илт хууль бус байдлыг агуулж байна. |
| **16.** | Нэхэмжлэгч нь Баянгол дүүргийн Засаг даргын 2015 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/756 дугаар захирамжийг Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6-д зааснаар иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байгаагүй гэж маргаж байх боловч уг захиргааны акт гарснаас хойш буюу 2015 оны 60 дугаар сарын 19-ний өдөр батлагдан, 2016 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн тул түүнээс өмнө үйлчилж байсан Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай /2002 оны/ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.7-д “захиргааны акт гаргах эрх зүйн үндэслэл байгаагүй” гэж зааснаар Баянгол дүүргийн |

pdfelement

| | |
|---|---|
| | Засаг даргын 2013 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/287 дугаартай захирамжийг илт хууль бус болохыг тогтоожшийдвэрлэх нь зүйтэй байна. |
| **17.** | Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 175 дугаар тогтоол нь нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байгаагүй байхад гарсан, хуульд нийцээгүй, хуульд заасан үндэслэл, журмын дагуу гараагүй илт хууль бус захиргааны акт байна. |
| **18.** | Нөгөө талаар татан буугдсан Тахарын ерөнхий газрын дарга тушаал гаргаж<br><br>нэхэмжлэгчийг ажлаас чөлөөлсөн нь Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6-д “иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байгаагүй;” гэснийг зөрчсөн гэх нэхэмжлэгч, түүний өмгөөлөгчийн тайлбарыг буруутгахааргүй байна гэж дүгнэв. |
| **19.** | Нэхэмжлэгч Н.Энхбаярт сахилгын шийтгэл ногдуулах тухай хариуцагч Хэнтий аймгийн Засаг даргын 2016 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн Б/83 дугаар захирамжийг Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6 дахь хэсэгт заасан үндэслэлээр илт хууль бус захиргааны акт гэж шүүх үзэв. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байгаагүй, Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсэгт заасан үндэслэл байгаагүй байна. |

**5.Дүгнэлт, зөвлөмж**

Дээр дурдсан шүүхийн шийдвэрүүдийн үндэслэлд дурдсан байдал, шүүгчдийн дунд хийсэн хэлэлцүүлгийн тэмдэглэл, захиргааны шүүхийн шүүгчдийн дунд явуулдаг сургалтын хэлэлцүүлэг зэргээс дүн шинжилгээ хийхэд ЗЕХ-ийн 47.1.6 дахь заалтыг ерөнхий байдлаар хуульд оруулсанаас шалтгаалж ЗЕХ-ийн 47.1.6 дахь заалтын “иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байгаагүй” гэдэгт хуульд үндэслэх зарчмыг зөрчсөн алдаануудыг хамааруулан ойлгохоор заасан ЗЕХ-ийн хууль тогтоогчийн үндсэн үзэл баримтлал, зорилгод нийцэхгүй байгаа нөхцөл байдал бий болжээ. Иймээс ЗЕХ-ийн 47.1.6 дахь заалтад хуулийн зорилгод нийцүүлсэн нэмэлт тодруулга байдлаар өөрчлөлт оруулах нь зүйтэй байна.

**6. ЗЕХ-ийн 48 дугаар зүйлийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний талаар:**

| № | Үнэлгээ хийх хүрээнд хамаарах ЗЕХ-ийн зүйл, заалт | Шалгуур үзүүлэлтийн томьёолол | Цуглуулсан мэдээллийн төрөл |
|---|---|---|---|
| 2. | 48.1.Сөрөг нөлөөлөл бүхий хууль бус захиргааны актад гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаа өнгөрснөөс үл хамааран захиргааны байгууллага тухайн захиргааны актыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хүчингүй болгоно. | Хуулийн зорилго, үзэл баримтлал юу вэ? Практикт хэрхэн хэрэгжиж байгаа вэ? | Энэ хуулийн заалтыг хэрэглэж гаргасан захиргааны шүүхийн шийдвэрүүдэд хайлт хийж дүн шинжилгээ хийсэн. |



pdfelement Remove Watermark Now

Remove Watermark Now

| | | | |
|---|---|---|---|
| | 48.2.Эерэг нөлөөлөл бүхий хууль бус захиргааны актыг дараах тохиолдолд хүчингүй болгоно:<br><br>48.2.1.хууль, захиргааны хэм хэмжээний актаар, эсхүл захиргааны актад түүнийг хүчингүй болгохоор заасан;<br><br>48.2.2.бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, эсхүл нийтийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлсөн;<br><br>48.2.3.захиргааны актаар олгосон эрхийг хэрэгжүүлээгүй;<br><br>48.2.4.захиргааны актыг гаргуулахдаа хууран мэхлэх, айлган сүрдүүлэх, авлига өгөх буюу бусад хууль бус аргыг хэрэглэсэн;<br><br>48.2.5.нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшилсан.<br><br>48.3.Захиргааны байгууллага энэ хуулийн 48.2.1, 48.2.2, 48.2.3, 48.2.5-д заасан тохиолдолд захиргааны актыг гаргасан өдрөөс хойш таван жилийн дотор хүчингүй болгож болно. | | |

pdfelement

**1.Хууль бус захиргааны актыг эрх зүйн үр дагавараар нь эерэг, сөрөг гэж ангилсны зорилго, ач холбогдол юу вэ?**

Захиргааны үйл ажиллагаа хууль ёсны байх зарчмын дагуу иргэдийн эрхийг хамгаалах зорилгоор хууль бус захиргааны актыг хүчингүйд тооцох зохицуулалтыг ЗЕХ-ийн 48 дугаар зүйлд оруулжээ. Захиргааны актыг хүчингүйд тооцох үндэслэлийг авч үзэхийн тулд нэг талаас захиргааны үйл ажиллагаа хууль ёсны байх зарчмын дагуу хууль захиргааны акт хүчингүй болох ёстой боловч нөгөө талаасаа нэгэнт хүчин төгөлдөр үйлчилж улмаар иргэдэд эерэг үр нөлөө үзүүлж, иргэд өөрийн үйл ажиллагаагаа захиргааны актад нийцүүлэн төлөвлөдөг учир иргэдэд эерэг нөлөөлөл үзүүлж байгаа захиргааны актыг сөрөг нөлөөлөл бүхий захиргааны актаас ялгамжтайгаар хүчингүй болгох шаардлага байдаг. Захиргааны актыг эерэг, сөрөг нөлөөлөлөөр нь ялгаж байгаа гол ач холбогдол нь иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, итгэлийг хамгаалахад оршидог байна. Сөрөг нөлөөлөл бүхий захиргааны актыг хүчингүй болгосноор уг актын үйлчилэл шууд чиглэгдэж байгаа аливаа иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх сөрөг үр дагавар, байдлыг арилгадаг. Сөрөг нөлөөлөл бүхий захиргааны актыг

Remove Watermark Now

хүчингүй болгоход эерэг нөлөөлөл бүхий захиргааны актыг хүчингүй болгоход хэрэглэдэг нарийвчилсан зохицуулалт шаардлагагүй байдаг, захиргааны байгууллага сөрөг нөлөөлөл бүхий захиргааны актыг хүчингүй болгохдоо сонгох боломжоо хэрэглэдэг.[49]

**2.Практикт хэрэглэгдэж байгаа байдал:**

**Шүүхийн шийдвэрийн shuukh.mn сангаас ЗЕХ-ийн 48 дугаар зүйлийг хэрэглэж гаргасан шүүхийн шийдвэрийн шүүж, дүн шинжилгээ хийсэн талаар /Хавсралт 17-оос дэлгэрэнгүйг харах боломжтой/:**

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрүүдээс шүүлт хийхэд ЗЕХ-ийн 48 дугаар зүйлийг баримтлан талуудаас маргаж, талуудын маргаж байгаа зүйлд үндэслэх хэсэгтээ дүгнэлт өгсөн нийт 21 шийдвэр байгаагаас зарим шүүхийн шийдвэрээр 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг хэрэглэсэн 7 шийдвэр байгаагаас2 шүүхийн шийдвэрийн Тогтоох хэсэгт баримтлан захиргааны актыг хүчингүй болгож, 5 шийдвэр нь үндэслэх хэсэгтээ захиргааны актыг дүгнэх зорилгоор хэрэглэсэн, 48.2 дахь заалтыг үндэслэх, тогтоох хэсэгтээ хэрэглэсэн 13 шийдвэр байна.

ЗЕХ-ийн 48 дугаар зүйлийг хэрэглэн захиргааны актыг хүчингүй болгосон шүүхийн шийдвэрийн үндэслэлийг дор дурдснаар хүснэгтээр харуулав:

| № | ЗЕХ-ийн 48 дугаар зүйлийг баримтлан захиргааны актыг хүчингүй болгосон зарим шүүхийн шийдвэрийн үндэслэлийн талаар |
|---|---|
| **1.** | Дугаар: 86<br><br>Огноо: 2018-02-07<br><br>/Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр./<br><br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/4330/view<br><br>Хэрэгт авагдсан бичгийн нотлох баримт, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч нарыншүүхэд гаргасан тайлбараар хариуцагч нь нэхэмжлэгчийг маргаан бүхий дүгнэлт гаргах үйлажиллагаанд оролцуулаагүйгээс гадна мэдэгдэх үүргээ хэрэгжүүлээгүй болох нь нотлогдсонтул Захиргааны ерөнхий хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-д “Сөрөг нөлөөлөл бүхий хууль бусзахиргааны актад гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаа өнгөрснөөс үл хамааран захиргаанызбайгууллага тухайн захиргааны актыг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн хүчингүй болгоно” гэжзаасны дагуу Байгаль, орчин, аялал жуулчлалын яамны ажлын хэсэг 2017 оны 06 дугаарсарын 28-ны өдрийн 17/01 дүгээр дүгнэлт нь хууль бус болно. |
| **2.** | Дугаар: 07<br><br>Огноо: 2017-03-20<br><br>/Өвөрхангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр/<br><br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/2841/view |

[49]П.Одгэрэл, Захиргааны эрх зүйн ерөнхий анги 2016, х 218, 219, ЗЕХ-ийн тайлбар, 2017, х 219-216

pdfelement

Remove Watermark Now

| | |
|---|---|
| | Нөгөө талаар 08/01 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан тусгай хэрэгцээнийгазруудын солбицлын цэгүүд нь алдаатай буюу зөрчилтэй байгаа нь уг тогтоолыг илт хуульбусад тооцох үндэслэл болохгүй юм. Учир нь: Захиргааны ерөнхий хуулийн 45 дугаар зүйлдзааснаар захиргааны актын бичилт болон тооцооны алдаа, түүнтэй адилтгаж болохоор өөрбусад илэрхий алдааг захиргааны актын үндсэн зохицуулалт, утга агуулгыг өөрчлөхгүйгээрзахиргааны байгууллага өөрөө буюу эсхүл оролцогчийн хүсэлтээр засах эрхтэй. Тиймээсхариуцагч нь маргаан бүхий акт болох 2007 оны 08/01 дүгээр тогтоолынхоо нэгдүгээрхавсралтаар баталсан газруудын булангийн цэгүүдийн солбицлын алдаа буюу зөрчлийгзөвтгөн шинээр батлан гаргах замаар залруулах боломжтой бөгөөд ингэж залруулахдаанэхэмжлэгчийн Ашигт малтмалын тухай хууль, Газрын тухай хууль болон бусад хуультогтоомжоор олгогдсон эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн талбайдашигт малтмал хайх эрх, хууль ёсны ашиг сонирхлыг нь сэргээсэн шийдвэр гаргах үүрэгтэй.Ингэхдээ Захиргааны ерөнхий хуулийн 48 дугаар зүйлийгн 48.1, Газрын тухай хуулийн 20дугаар зүйлийн 20.1.3, 20.1.4-т тус тус зааснаар хариуцагч нь маргаан бүхий 08/01 дүгээртогтоолдоо нэхэмжлэгч компанийн эзэмшлийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд тусгагдсан4843.62 га газраас Уянга сумын газар нутагт харъяалах хэсгийг хүчингүй болгож ороннутгийн тусгай хэрэгцээнээс хасах тухай өөрчлөлт оруулах, эсхүл Газрын тухай хуулийн 20дугаар зүйлийн 20.1.4 дэх хэсэгт зааснаар “Чинтөгс” ХХК-тай тохиролцсоны үндсэн дээр тускомпанийн эзэмшлийн газрыг нөхөх олговортойгоор эргүүлэн авах тухай шийдвэрүүдийн альнэгийг нь гаргах боломжийг хууль тогтоогч олгожээ. |

**3.Дүгнэлт, зөвлөмж**

pdfelement

ЗЕХ-ийн 48 дугаар зүйлийн зорилго, үзэл баримтлалыг захиргааны байгууллага, шүүгч нар, иргэдэд тайлбарлан ойлгуулах, шүүхээс хууль хэрэглэх явцдаа нэг мөр ойлгох, нэгдсэн практик тогтоох боломжтой, уг хуулийн заалтад өөрчлөлт оруулах шаардлагагүй байна.

**7.ЗЕХ-ийн 49 дүгээр зүйлийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний талаар:**

| № | Үнэлгээ хийх хүрээнд хамаарах ЗЕХ-ийн зүйл, заалт | Шалгуур үзүүлэлтийн томьёолол | Цуглуулсан мэдээллийн төрөл |
|---|---|---|---|
| 2. | **49 дүгээр зүйл.Эрх зүйн зөрчилгүй захиргааны актыг цуцлах**<br>49.1.Захиргааны актад гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаа өнгөрснөөс үл хамааран түүнийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн цуцалж болно.<br>49.2.Энэ хуулийн 49.1-д заасан захиргааны актыг ижил агуулгаар дахин батлах | Энэ зохицуулалтын зорилго, ач холбогдол юу вэ? Практикт хэрэгжиж байгаа эсэх? | 1.Энэ хуулийн заалтыг хэрэглэж гаргасан захиргааны шүүхийн шийдвэрүүдэд хайлт хийж дүн шинжилгээ хийсэн.<br>2.Захиргааны байгууллагуудаас анкетын судалгаа авсан. |

Remove Watermark Now

| | | | |
|---|---|---|---|
| | шаардлагатай, эсхүл хууль зүйн үндэслэлгүй бол цуцлахгүй.<br><br>49.3.Зэрэг нөлөөлөл бүхий захиргааны актыг түүнд гомдол гаргах боломжгүй болсон хэдий ч дараах тохиолдолд цуцалж болно:<br><br>49.3.1.цуцлах нөхцөлийг хууль, захиргааны хэм хэмжээний актад, эсхүл тухайн захиргааны актад заасан бол;<br><br>49.3.2.захиргааны актад нэмэлт зохицуулалт заасан бөгөөд түүнийг тухайн этгээд хуульд заасан хугацааны дотор биелүүлээгүй бол;<br><br>49.3.3.шинэ нөхцөл байдал бий болсноор нийтийн ашиг сонирхол зөрчигдөхөөр бол;<br><br>49.3.4.хууль, захиргааны хэм хэмжээний акт өөрчлөгдсөний үндсэн дээр захиргааны байгууллага тухайн захиргааны актыг гаргах эрхгүй болсон бөгөөд уг актаар эрх олгогдсон этгээд эрхээ хэрэгжүүлж эхлээгүй бол;<br><br>49.3.5.нийтийн ашиг сонирхолд ноцтой сөрөг нөлөө үзүүлэхээс урьдчилан сэргийлэх, эсхүл түүнийг зайлуулахын тулд.<br><br>49.4.Захиргааны актаар олгосон болон олгож байгаа мөнгөн тэтгэмж, эсхүл тодорхой зорилго бүхий үйлчилгээг хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн ч уг захиргааны актыг дараах тохиолдолд бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн цуцална:<br><br>49.4.1.захиргааны актаар олгосон тэтгэмж, үйлчилгээ уг актад заасан зориулалтаар ашиглагдаагүй бол;<br><br>49.4.2.захиргааны актаар нэмэлт зохицуулалт заасан бөгөөд тухайн этгээд уг үүргийг | | |

pdfelement

Remove Watermark Now

| | | | |
|---|---|---|---|
| | биелүүлээгүй, эсхүл захиргааны актад заасан хугацаанд биелүүлээгүй бол.<br><br>49.5.Захиргааны байгууллагаас өөрөөр заагаагүй бол захиргааны акт цуцлагдснаар хүчин төгөлдөр бус болно.<br><br>49.6.Энэ хуулийн 49.3.3, 49.3.4, 49.3.5-д заасан үндэслэлээр захиргааны актыг цуцалсан тохиолдолд учирсан эд хөрөнгийн хохирлыг тухайн этгээдийн шаардснаар нөхөн төлнө. | | |

**1.Энэ зохицуулалтын зорилго, ач холбогдол юу вэ?**

Илт хууль бус болон хууль бус захиргааны акт нь алдаатай, эсхүл эрх зүйн зөрчилтэй байдаг. Харин захиргааны акт эрх зүйн зөрчилгүй, алдаагүй батлагдсан боловч тухайн акттай холбоотой бодит нөхцөл байдал эсхүл, эрх зүйн нөхцөл байдал өөрчлөгдсөнөөс шалтгаалж захиргааны актаар хийхээр зорилго тавьсан үйл ажиллагаа хүссэн үр дүн, үр дагаварт хүрэх боломжгүй болсон тохиолдолд захиргааны байгууллагаас өөрийн гаргасан актыг цуцлах боломжыг ЗЕХ-ийн 49 дүгээр зүйлээр хуулчилсан. Захиргааны актыг цуцлах гэдэг нь түүнийг эрх зүйн үйлчлэлгүй болгож байгаа ойлголт юм. Алдаагүй, эрх зүйн зөрчилгүй захиргааны актыг захиргаанаас цуцлахдаа тухайн акт нь иргэд, бусад этгээдэд эерэг, сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа эсэхийг таньж мэдэх, сөрөг нөлөөлөл бүхий актын хувьд хэдийд ч цуцлах боломжтой байдаг. Харин иргэд, бусад этгээдэд актын улмаас эерэг нөлөөлөл, үр дагавар бий болсон захиргааны актыг цуцлахдаа зөвхөн ЗЕХ-ийн 49.3-д заасан үндэслэл байгаа тохиолдолд цуцлана.[50]

**2.Практикт хэрэгжиж байгаа эсэх?**

**Захиргааны 20 байгууллагаас авсан анкетын судалгааны талаар:**

**ЗЕХ-ийн 49 дүгээр зүйлийг хэрэглэж захиргааны актыг цуцалж байсан тохиолдол байна уу? гэсэн асуултад хэрэглэж захиргааны актыг цуцалсан гэж** 10 хувь буюу 2 захиргааны байгууллага хариулж, харин 90 хувь буюу 18 байгууллага уг хуулийн заалтыг хэрэглэж байгаагүй гэсэн хариултыг өгчээ. Түүнчлэн **ЗЕХ-ийн 49 дүгээр зүйлийг хэрэглэж захиргааны актыг цуцлах зохицуулалт нь ойлгомжгүй учир дахин дэлгэрэнгүй тайлбарлах шаардлагатай юу гэсэн асуултад уг заалтыг** хэрэглэж захиргааны актыг цуцлах зохицуулалт ойлгомжгүй хэрэглэхэд хүндрэлтэй гэж 85 хувь буюу 17 байгууллага, уг заалтыг хэрэглэдэг өөрчлөх шаардлагагүй гэж 15 хувь буюу 3 байгууллага хариулжээ.

[50]П.Одгэрэл, Захиргааны эрх зүйн ерөнхий анги 2016, х 22-224, ЗЕХ-ийн тайлбар, 2017, х 226-231

Remove Watermark Now

**Шүүхийн шийдвэрийн shuukh.mn сангаас ЗЕХ-ийн 49 дугаар зүйлийг хэрэглэж гаргасан шүүхийн шийдвэрийн шүүж, дүн шинжилгээ хийсэн талаар:**

Захиргааны шүүхийн шийдвэрийн сангаас шүүлт хийхэд ЗЕХ-ийн 49 дүгээр зүйлийг хэрэглэж гаргасан шүүхийн шийдвэр олдоогүй. Харин нэхэмжлэгч зөрөг нөлөөлөл бүхий захиргааны актын цуцалсныг шийдвэрийг ЗЕХ-ийн 49.3-д зааснаар үндэслэлгүй гэж марган хариуцагч захиргааны байгууллагаас нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрч шийдвэрлэсэн 1 шийдвэр байна.

Уг шийдвэрийн үндэслэлийг харуулбал:

| № | ЗЕХ-ийн 49 дугаар зүйлийг баримталсан үндэслэлийн талаар |
|---|---|
| **1** | 2017 оны 02 сарын 20 Дугаар 16 Дархан сум<br><br>Хариуцагчийн зөвшөөрлийг баталж,<br><br>хэргийг хэрэгсэхгүй болгох тухай<br><br>Хэргийн индекс: 114/2016/0096/З<br><br>**Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3 болон 48 дугаар зүйлд заасанүндэслэл үүсээгүй.**<br><br>Аймгийн засаг даргын 2016 оны 11 дүгээр сарын 29-ны “Газар эзэмших эрхийн гэрчилгээгхүчингүй болгох тухай” А/440 тоот захирамжийн 3 дах хэсгээр Компаниудад газар эзэмшихэрх олгосон Аймгийн засаг даргын 2016 оны 07 дугаар сарын 08-ны А272 тоот захирамжийгхүчингүй болгож цуцлажээ.<br><br>Засаг дарга захирамжийн үндэслэлээ өмнөх “газар эзэмших эрх Дархан-Уул аймгмйн Засагдаргын 2016 оны 07 дугаар сарын 08-ны А/272 тоот захирамж холбогдох хууль тогтоомжзөрчсөн гэж үзэж хүчингүй болгосон. “Эрх олгосон захирамж” холбогдох хууль тогтоомжзөрчиж гаргасан гэдэг үндэслэлийг хүлээн зөвшөөрөх боломжгүй юм. Хэдий тийм боловч эрхолгосон захирамж эрх зүйн зөрчилтэй байсан ч түүний дараах үндэслэлээр цуцлахаар заажээ.Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.4-д Зөрөг нөлөөлөл бүхий захиргааны актгэж эрх зүйн үйлчлэл чиглэсэн этгээдэд эрх олгосон, эсхүл ашигтай нөхцөл байдлыг бий<br><br>болгосон захиргааны актыг ойлгоно.<br><br>Захиргааны ерөнхий хуулийн 48 дугаар зүйлийн 48.2-д Зөрөг нөлөөлөл бүхий хууль бусзахиргааны актыг дараах тохиолдолд хүчингүй болгоно: 48.2.1-д Хууль, захиргааны хэмхэмжээний актаар, эсхүл захиргааны актад түүнийг хүчингүй болгохоор заасан; 48.2.2-дБусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, эсхүл нийтийн ашиг сонирхолд сөргөөрнөлөөсөн; 48.2.3. захиргааны актаар олгосон эрхийг хэрэгжүүлээгүй; 48.2.4. захиргааны<br><br>актыг гаргуулахдаа хууран мэхлэх, айлган сүрдүүлэх, авлага өгөх буюу бусад хууль бусаргыг хэрэглэсэн; 48.2.5 нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээндхаршилсан” гэж эрх олгосон захиргааны актыг цуцлах үндэслэлийг дурджээ. Дээрх нөхцөлүүссэн тус үндэслэлээр захиргааны актыг цуцлаж байгаа талаар Аймгийн засаг даргын 2016оны 11 дүгээр сарын 29-ны “Газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох тухай” А/440тоот захирамжад дурдаагүй, шалган тогтоогоогүй байна.Иймд “зөрөг нөлөөлөл бүхий захиргааны актыг цуцлах” нөхцөл үүсээгүй байхад манайкомпаниудад **газар эзэмших эрх олгосон** захиргааны |

pdfelement

| | |
|---|---|
| | шийдвэрийг цуцлах хүчингүй болгохэрх захиргааны байгууллагад байхгүй бөгөөд өөрт хуулиар олгоогүй үндэслэлээр зэрэгнөлөөлөл бүхий захиргааны актыг цуцласан нь нэхэмжлэгч компаниудын Газрын тухайхууль, Газар эзэмших гэрээгээр эдлэх эрх, хууль ёсны ашиг сонирхолыг зөрчиж байна. |

**3.Дүгнэлт, зөвлөмж**

ЗЕХ-ийн 49 дүгээр зүйлийг практикт захиргааны байгууллагууд төдийлөн таньж мэдэж, ойлгоогүй байгаа нь судалгаанаас харагдаж байгаа тул энэ чиглэлээр тайлбарлан таниулах шаардлагатай. Хуульд өөрчлөлт оруулах шаардлагагүй байна.

**8.ЗЕХ-ийн 50 дугаар зүйлийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний талаар:**

| № | Үнэлгээ хийх хүрээнд хамаарах ЗЕХ-ийн зүйл, заалт | Шалгуур үзүүлэлтийн томьёолол | Цуглуулсан мэдээллийн төрөл |
|---|---|---|---|
| 2. | **50 дугаар зүйл.Захиргааны акт гаргах ажиллагааг дахин хийх**<br><br>50.1.Захиргааны актад гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаа дууссан хэдий ч хаяглагдсан этгээдийн хүсэлтээр дараах тохиолдолд захиргааны акт гаргах ажиллагааг дахин хийж болно:<br><br>50.1.1.захиргааны актын үндэслэж байгаа бодит эсхүл эрх зүйн нөхцөл байдал нь хаяглагдсан этгээдийн талд хожим зэрэгээр өөрчлөгдсөн;<br><br>50.1.2.хаяглагдсан этгээдийн хувьд ашигтай нотлох баримт бий болсон.<br><br>50.2.Хаяглагдсан этгээд нь өргөдөл, гомдлыг шийдвэр гаргах ажиллагаар дахин явуулах үндэслэл бий болсныг мэдсэнээс хойш гурван сарын дотор гаргана. | Энэ зохицуулалтын зорилго, ач холбогдол юу вэ? Практик хэрэгжиж байгаа эсэх? | 1.Энэ хуулийн заалтыг хэрэглэж гаргасан захиргааны шүүхийн шийдвэрүүдэд хайлт хийж дүн шинжилгээ хийсэн.<br><br>2.Захиргааны байгууллагуудаас анкетын судалгаа авсан. |

**1.Энэ зохицуулалтын зорилго, ач холбогдол юу вэ?**

ЗЕХ-ийн 50 дугаар зүйл нь шинэ нөхцөл байдал бий болсны улмаас захиргааны актын үндэслэлийг эргэн харж захиргааны акт гаргах ажиллагаа дахин явуулах боломжийг зохицуулсан. Дахин захиргааны акт гаргах ажиллагаа нь захиргааны акт шууд чиглэгдэж байгаа этгээдийн гаргасан хүсэлтийн үндсэн явагддаг. Захиргааны акт шууд чиглэгдэж байгаа буюу оролцогч нь тухайн захиргааны актыг гомдол гаргаж шийдвэрлүүлэх боломжгүй бөгөөд захиргааны актын үндэслэл болж буй бодит нөхцөл байдал эсхүл, эрх зүйн байдал хожим өөрчлөгдсөнөөс шалтгаалж тухайн актын үйлчлэлд эрх зүйн зөрчил үүсэж эрх ашиг нь хөндөгдөж буй этгээд, захиргааны



Remove Watermark Now
pdfelement

Remove Watermark Now

байгууллагаас эрх зүйн зөрчлийг хүчингүй болгуулахаар хүсэлт гаргах боломж юм. Бодит нөхцөл байдал, эсхүл эрх зүйн байдал өөрчлөгдсөн нөхцөл байдал тогтоогдохгүй бол дахин захиргааны акт гаргах ажиллагаа явуулах хүсэлтийг хүлээн авах үндэслэлгүй юм.[51]

**2.Практикт хэрэгжиж байгаа эсэх?**

**Захиргааны 20 байгууллагаас авсан анкетын судалгааны талаар:**

ЗЕХ-ийн 50 дугаар зүйлийг хэрэглэж захиргааны актыг дахин гаргаж байсан тохиолдол байгаа юу гэсэн асуултад судалгаанд оролцсон захиргааны байгууллагаас 20 хувь буюу 4 байгууллага хэрэглэж байсан боловч актын нэр, огноог тодорхой мэдэхгүй байна гэж хариулсан, уг заалтыг 80 хувь буюу 16 байгууллага хэрэглэж байгаагүй гэсэн хариултыг өгсөн. Мөн ЗЕХ-ийн **50 дугаар зүйлийг хэрэглэж захиргааны актыг дахин гаргах зохицуулалт нь ойлгомжгүй учир дахин дэлгэрэнгүй тайлбарлах шаардлагатай юу гэсэн асуултад судалгаанд оролцогч захиргааны байгууллагаас** 70 хувь буюу 14 байгууллага шаардлагатай гэсэн хариултыг өгч, 30 хувь буюу 6 байгууллага нь шаардлагагүй гэж хариулжээ.

**2.Шүүхийн шийдвэрийн shuukh.mn сангаас ЗЕХ-ийн 50 дугаар зүйлийг хэрэглэж гаргасан шүүхийн шийдвэрийн шүүж, дүн шинжилгээ хийсэн талаар:**

Захиргааны шүүхийн шийдвэрийн сангаас шүүлт хийхэд ЗЕХ-ийн 50 дугаар зүйлийг хэрэглэж гаргасан 3 шийдвэр байгаа бөгөөд шүүхийн шийдвэрийн үндэслэлийг дор дурдсан хүснэгтээр харуулав:

| № | ЗЕХ-ийн 50 дугаар зүйлийг баримтлан захиргааны актыг хүчингүй болгосон зарим шүүхийн шийдвэрт нэхэмжлэгч талаас маргасан үндэслэлийн талаар |
|---|---|
| **1.** | 2018 оны 03 сарын 06 Дугаар 147<br><br>Үндэслэх хэсэгтэй дурдсан шийдвэр:<br><br>Захиргааны ерөнхий хуулийн 50 дугаар зүйлд захиргааны акт гаргах ажиллагааг дахин хийхэрх зүйн зохицуулалтыг хуульчилсан. Мөн хуулийн 50 дугаар зүйлийн 50.1.1. “Захиргааныактын үндэслэж байгаа бодит эсхүл эрх зүйн нөхцөл байдал нь хаяглагдсан этгээдийн талдхожим эерэгээр өөрчлөгдсөн”, 50.1.2. “хаяглагдсан этгээдийн хувьд ашигтай нотлох баримтбий болсон” тохиолдолд захиргааны акт гаргах ажиллагааг дахин хийж болно гэж заажээ.Дээрх байдлаас дүгнэхэд нэхэмжлэгчийн хувьд Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн ХурлынТэргүүлэгчдийн 2016 оны “Улаанбаатар хотын усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсийгшинэчлэн тогтоох тухай” 50 дугаар тогтоолоор батлагдсан усны сан бүхий газрын онцгой,энгийн хамгаалалтын, хориглолтын, хязгаарлалтын бүстэй давхцалгүй гэх нотлох баримтыгэрх бүхий байгууллагаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад ирүүлсэн, мөнхүчингүй болгохоор маргаж буй А/609 дугээр захирамжийн үндэслэл болсон 02-05-132/747дугаар “Зөрчил арилгуулах тухай” албан шаардлагад гомдол гаргах эрхийг төрийнзахиргааны байгууллагаас нэхэмжлэгчид олгоогүй байна.Иймд маргаан бүхий А/609 дугээр захирамжийн түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгайзөвшөөрлийг цуцлах үндэслэл болсон хууль зүйн заалтыг нэхэмжлэгчийн хувьд зөрчсөн ньТөрийн хяналт, шалгалтын тухай хуульд зааснаар бүрэн гүйцэд |

pdfelement

[5151]П.Одгэрэл, Захиргааны эрх зүйн ерөнхий анги 2016, х 225-228, ЗЕХ-ийн тайлбар, 2017, х 232-234

| | |
|---|---|
| | тогтоогдоогүйгээс гаднанэхэмжлэгчийн Захиргааны ерөнхий хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуузахиргааны актад гомдол гаргах эрхийг хязгаарлаж, маргаан бүхий актыг гаргасан ньнэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн байх тул Нийслэлийн Засаг даргын2017 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн А/609 дүгээр захирамжийн 1 дэх заалтын “М” ХХК-дхолбогдох хэсгийг хүчингүй болгож шийдвэрлэв. |
| **2.** | 2017 оны 10 сарын 17 Дугаар 749<br><br>Иймд нэхэмжлэгчийн зүгээс Говь-Алтай аймгийн Засаг дарга өөрийнх нь зөвшөөрөөгүйсаналтай нь холбогдуулан гаргасан нэхэмжлэгчийн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэндэмжсэн санал нь хуулийн шаардлага хангаагүй байх тул үүнийг Засаг даргаас алдаагаа зассан захиргааны акт гаргасан гэж дүгнэх боломжгүй байна. Хэрэв Засаг дарга урьдчиланшийдвэрлэх журмаар хуульд заасан хугацаанд нэхэмжлэгчийн гаргасан хүсэлтийг хүлээнавч дахин захиргааны акт гаргасан нь Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн19.4-т заасан шаардлагыг хангасан тохиолдолд үүнийг Захиргааны ерөнхий хуулийн 50дугаар зүйлд заасан захиргааны акт гаргах ажиллагааг дахин хийх нөхцөл бүрдсэн гэжойлгож болох юм. Гэтэл бодит байдалд нэхэмжлэгч “М” ХХК нь Засаг даргын татгалзсанхариуг мэдсэнээс болон хариуцагчийн тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан шийдвэр<br><br>гарснаас даруй 8 сарын дараа аймгийн Засаг даргад хүсэлтээ гаргасан, Засаг даргын дэмжсэн санал нь хуульд заасан шаардлага хангаагүй байх тул захиргааны акт гаргах ажиллагааг дахин хийх хууль зүйн үндэслэлгүй юм. Захиргааны ерөнхий хуулийн 50 дугаархуулийн 50.1.1-т “Захиргааны актын үндэслэж байгаа бодит эсхүл эрх зүйн нөхцөл байдал ньхаяглагдсан этгээдийн талд хожим зэрэгээр өөрчлөгдсөн” гэх эрх зүйн нөхцөл байдалтогтоогдохгүй байгаагаас гадна мөн хуулийн 50 дугаар зүйлийн 50.2-т “...үндэслэл бийболсныг мэдсэнээс хойш 3 сарын дотор гаргана” гэж журамласан. Энэ нь захиргааны актыгмэдсэнээс хойш эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдөж буй иргэн, хуулийн этгээд ньгагцхүү хуульд заасан хугацаанд гомдол гаргах эрхтэй бөгөөд эрх зүйн нөхцөл байдалэерэгээр өөрчлөгдсөн бол 3 сарын дотор захиргааны акт гаргах ажиллагааг дахин хийх зохицуулалт болохоос биш хуулийн шаардлага хангаж ирүүлээгүй Засаг даргын саналыгүндэслэж хэзээ ч хамаагүй гомдол/ хүсэлт гаргах хугацаагүй эрхийн ойлголт биш юм. |
| **3** | 2017 оны 01 сарын 11 Дугаар 02<br><br>Энэ хугацаанд Төв аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн2016 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн “Хэргийг хэрэгсэхгүй болгох тухай”151/ш32016/02980 дугаартай захирамжаар[1] “...Төв аймгийн Татварын хэлтэс нь шүүхэднэхэмжлэл гаргахдаа Татварын ерөнхий хуулийн 70 дугаар зүйлийн 70.1 дэх хэсгийн“Хугацаанд нь төлөөгүй татварын өрийг энэ хуулийн 63, 64 дүгээр зүйлд заасан журмындагуу барагдуулах боломжгүй бол татварын алба шүүхэд нэхэмжлэл гаргана” гэсэншаардлагыг хангаагүй байна гэж үзлээ. Иймд нэхэмжлэгч нь Татварын ерөнхий хуулийн 63дугаар зүйлд заасан ажиллагааг хийгээгүй тул хэргийг хэрэгсэхгүй болох хууль зүйнүндэслэлтэй байна” гэж дүгнээд Төв аймгийн татварын хэлтсийн нэхэмжлэлтэй Ануд номинХХК-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн, мөн Шүүхийн шинжилгээнийүндэсний хүрээлэнгийн 2016 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 2418 дугаартай “Шинжээчийн дүгнэлт” [2] -ээр “Хавтаст хэрэгт авагдсан “Нэмэгдсэн өртгийн албан татварын падаан” гэсэн 21 ширхэг баримтууд үйлдвэрийн анхны эхээр байна...” гэсэндүгнэлт гаргасан зэргээр нэхэмжлэгч аж ахуйн нэгж нь тухайн үед буюу 2013 онд худалданавалт хийж авсан гэх Нэмэгдсэн өртгийн албан |



Remove Watermark Now

Remove Watermark Now

| | |
|---|---|
| | татварын падаан нь хуурамч биш болох ньтогтоогдсон гэж үзэж, энэ баримтаараа Захиргааны ерөнхий хуулийн 50 дугаар зүйлд **Захиргааны акт гаргах ажиллагааг дахин хийх буюу уг зүйлийн 50.1-д “**Захиргааныактад гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаа дууссан хэдий ч хаяглагдсан этгээдийнхүсэлтээр дараах тохиолдолд захиргааны акт гаргах ажиллагаааг дахин хийж болно”,50.1.1-д “захиргааны актын үндэслэж байгаа бодит эсхүл эрх зүйн нөхцөл байдал ньхаяглагдсан этгээдийн талд хожим эерэгээр өөрчлөгдсөн”, 50.1.2-т “хаяглагдсан этгээдийнхувьд ашигтай нотлох баримт бий болсон” гэсэн үндэслэлээр өмнө нь тавьдсан хүчинтөгөлдөр актуудад холбогдох асуудлыг дахин хянуулах хүсэлт гаргасанд хариуцагчтатварын хэлтсээс 2016 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн “Албан бичгийн хариу” 05/1543дугаартай албан бичгээр[3] “...хяналт шалгалтын ажлыг дахин хийх боломжгүй ...” гэсэнхариу өгсөн нь хариуцагчийг дахин хяналт шалгалт хийх үүргээ биелүүлээгүй, хууль бус эс үйлдэхүй гаргасан гэж буруутгах үндэслэлгүй байна. |

**3.Дүгнэлт, зөвлөмж**

ЗЕХ-ийн 50 дугаар зүйлийг практикт захиргааны байгууллагууд төдийлөн таньж мэдэж, ойлгоогүй байгаа нь судалгаанаас харагдаж байгаа тул энэ чиглэлээр тайлбарлан таниулах шаардлагатай. Хуульд өөрчлөлт оруулах шаардлагагүй байна.

ЗЕХ нь Монгол Улсад батлагдан мөрдөгдөж байгаа шинэ хууль бөгөөд нийтээр дагаж мөрдөгсөн үеэс 2 жил орчим болж байгаа тул практикийн хэрэглээнд зарим зүйл заалт ялангуяа онолын ойлголтыг багтаасан зохицуулалтыг нилээд сайн тайлбарлан таниулж хэрэглээнд орсны дараа хэрэгжиж эхлэх онцлогтой гэдгийг анхаарах зүйтэй.

pdfelement

Remove Watermark Now

# ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН 10 ДУГААР БҮЛГИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2015 онд Монгол Улсын Их Хурлаас баталж 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн Захиргааны ерөнхий хуулийн 10 дугаар бүлгийн эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг илрүүлэх, харьцуулан үнэлэх ажиллагаар Засгийн газрын 2016 оны 59 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын дагуу үнэлнэ.

Үнэлгээний зорилго нь

- Захиргааны ерөнхий хуулийн 10 дугаар бүлэг Хохиролын талаарх зохицуулалт нь анх хуулиар тавьсан зорилгодоо хүрсэн түвшинг тогтоох;
- Цаашдын үр дагавар, нөлөөллийг илрүүлэн гаргаж хууль тогтоомжийг боловсронгуй болгох холбогдох санал, дүгнэлт өгөхөд оршино.

Үнэлгээг дараахь үе шаттайгаар хийж гүйцэтгэлээ. Үүнд:

1. Төлөвлөх үе шат
2. Хэрэгжүүлэх үе шат
3. Үнэлэх үе шат

## НЭГ.ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

### 1.1.Үнэлгээ хийх шалтгаан

Захиргааны ерөнхий хуулийн 10 дугаар бүлэгт үнэлгээ хийх шалтгаан нь хуулийн зохицуулалт нь тухайн харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх, хэрэгжилийн байдал хангалтгүй байгаа гэсэн таамаг байгааг тогтоох, одоо хуулиар бий болгосон хохирол арилгах талаарх эрх зүйн зохицуулалт нь оновчтой хувилбар мөн эсэхийг илрүүлэх.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахаар заасан бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад “ тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх”-ээр заасан нь үнэлгээ хийх шалтгаан юм.

### 1.2.Үнэлгээний хүрээг тогтоох

Захиргааны ерөнхий хуулийн 10 дугаар бүлгийн зохицуулалтыг бүхэлд нь үнэлэх бөгөөд үнэлэгдэх шаардлагатай зүйл, хэсгийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 1

| д/д | Үнэлэгдэх зүйл | Үнэлэгдэх хэсэг, заалт |
|---|---|---|
| 1 | 101 дүгээр зүйл | 101.1.Төрийн албаны тухай хуулийн 4.2.7, Иргэний хуулийн 498.2-т заасны дагуу захиргааны байгууллагын гаргасан алдааны улмаас учруулсан хохирлыг төр хариуцна. |

Remove Watermark Now

| | | |
|---|---|---|
| | | 101.2.Иргэн, хуулийн этгээд өөрт учирсан хохирлыг хохирол учруулсан захиргааны байгууллагаас нэхэмжилж, тухайн захиргааны байгууллагаас гаргуулна. |
| 2 | 103 дугаар зүйл | 103.1.Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ.<br><br>103.2.Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна.<br><br>103.3.Энэ хуулийн 103.2-т заасан дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж байхгүй бол гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг төрийн аудитын байгууллага хариуцна.<br><br>103.4.Гомдлыг хянан шийдвэрлэсэн дээд шатны захиргааны байгууллага болон шүүх хохирлыг буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр гаргасан актын хувийг холбогдох аудитын байгууллагад хүргүүлэх үүрэгтэй. |
| | 104 дүгээр зүйл | 104.1.Захиргааны байгууллагын хууль ёсны үйл ажиллагаанаас иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөний улмаас хохирол учирсан бол төрөөс нөхөх олговор олгож хохирлыг барагдуулна.<br><br>104.2.Нөхөх олговор олгох журмыг хуулиар тусгайлан зохицуулна.<br><br>104.3.Захиргааны байгууллага нөхөх олговрын хэмжээг иргэн, хуулийн этгээдтэй харилцан тохиролцож болно.<br><br>104.4.Нөхөх олговрын хэмжээний талаар маргаан гарвал захиргааны журмаар хамтатган нэхэмжлээгүй бол иргэний хэргийн шүүхээр шийдвэрлүүлнэ. |

pdfelement

**1.2.Шалгуур үзүүлэлтийг тогтоох**

Өмнөх үе шатанд үнэлгээ хийхээр сонгосон Захиргааны ерөнхий хуулийн 10 дугаар бүлгийн холбогдох зүйл, заалтын хэрэгжилтийн байдлыг тогтоохад туслах Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтын 3.4-т заасан шалгуур үзүүлэлтээс үнэлэх зүйл, заалтын хэрэгжилтийг бодитоор илэрхийлж гаргаж чадах шалгуур үзүүлэлтийг энэ үе шатанд харгалзуулан сонгов.

Хүснэгт 2

| д/д | Үнэлгэдэх зүйл | Үнэлгэдэх хэсэг, заалт | Шалгуур үзүүлэлт |
|---|---|---|---|

Remove Watermark Now

| | | | |
|---|---|---|---|
| | 101 дүгээр зүйл | 101.1.Төрийн албаны тухай хуулийн 4.2.7, Иргэний хуулийн 498.2-т заасны дагуу захиргааны байгууллагын гаргасан алдааны улмаас учруулсан хохирлыг төр хариуцна.<br><br>101.2.Иргэн, хуулийн этгээд өөрт учирсан хохирлыг хохирол учруулсан захиргааны байгууллагаас нэхэмжилж, тухайн захиргааны байгууллагаас гаргуулна. | Хүлээн зөвшөөрөгдсөн байдал, Практикт нийцэж байгаа байдал |
| | 103 дугаар зүйл | 103.1.Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ.<br><br>103.2.Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна.<br><br>103.3.Энэ хуулийн 103.2-т заасан дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж байхгүй бол гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг төрийн аудитын байгууллага хариуцна.<br><br>103.4.Гомдлыг хянан шийдвэрлэсэн дээд шатны захиргааны байгууллага болон шүүх хохирлыг буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр гаргасан актын хувийг холбогдох аудитын байгууллагад хүргүүлэх үүрэгтэй. | Хүлээн зөвшөөрөгдсөн байдал, Зорилгодоо хүрсэн түвшин, Практикт нийцэж байгаа байдал |
| | 104 дүгээр зүйл | 104.1.Захиргааны байгууллагын хууль ёсны үйл ажиллагаанаас иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөний улмаас хохирол учирсан бол төрөөс нөхөх олговор олгож хохирлыг барагдуулна.<br><br>104.2.Нөхөх олговор олгох журмыг хуулиар тусгайлан зохицуулна.<br><br>104.3.Захиргааны байгууллага нөхөх олговрын хэмжээг иргэн, хуулийн этгээдтэй харилцан тохиролцож болно.<br><br>104.4.Нөхөх олговрын хэмжээний талаар маргаан гарвал захиргааны журмаар | Хүлээн зөвшөөрөгдсөн байдал, Практикт нийцэж байгаа байдал |

pdfelement

| | | | |
|---|---|---|---|
| | | хамтатган нэхэмжлээгүй бол иргэний хэргийн шүүхээр шийдвэрлүүлнэ. | |

Шалгуур үзүүлэлтийг сонгохдоо тухайн зүйл, заалтын хэрэгжилтийг хамгийн сайнаар илэрхийлэн гаргаж ирэх гэсэн шаардлагаар сонгосон бөгөөд тухай хуулийн зохицуулалтад төдий л ач холбогдолтой бус шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

**1.4.Харьцуулах хэлбэрийг сонгох**

Үнэлгээ хийхэд хуулийн үр дагаврын үнэлгээний үндэс нь судалж буй зохицуулалтын талаарх ажиглагдаж буй болон хэмжиж болохуйц мэдээллийг цугуулж, түүний зарим үзүүлэлтийг хооронд нь харьцуулах явдал юм.

Эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг тогтоох ажиллагаа нь практик дээр тухайн хуулийн үйлчлэх хүрээ, тухайн салбарт гарсан хөгжил, өөрчлөлтийг болон бусад холбогдох мэдээллийг тогтоож, тэдгээрийг хооронд нь харьцуулах ажиллагаан дээр үндэслэнэ.

Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн зохицуулалтын үр дүн, үр нөлөөг зөвхөн нэг талаас нь үнэлэх нь учир дутагдалтай тул өмнөх үе шатанд тогтоосон шалгуур үзүүлэлт бүрд тохирсон харьцуулах хэлбэрийг сонгон үнэлгээг хийх болно.

Захиргааны ерөнхий хуулийн 10 дугаар бүлгийн холбогдох зүйл заалтыг үнэлэх шалгуур үзүүлэлтээр сонгож авсан зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийг хууль хэрэгжүүлэх явцад бий болсон бодит үр дагавар нь анх хуулиар тавьсан зорилгыг хангаж чадаж байгааг харьцуулах аргаах тогтооно. Үүнийг харьцуулах тоо бармит нь хуулийг хэрэгжүүлэгч байгууллагын тайлан, статистик, шүүхийн шийдвэр байна.

Захиргааны ерөнхий хуулийн 10 дугаар зүйлийн практипт хэрэгжиж буй байдлыг үнэлэхдээ хууль хэрэгжиж эхэлснээс өмнөх болон дараа, байх ёстой болон байгаа гэсэн харьцуулалтын аргын тусламжтайгаар тогтооно.

Хүлээн звөшөөрөгдсөн байдлыг хууль хэрэгжиж эхэлснээс хойшхи тоо баримтыг байх ёстой болон одоо байгаа гэсэн харьцуулалтын аргыг ашиглан тогтооно.

Хүснэгт 3

| д/д | Үнэлгээний хүрээ | Шалгуур үзүүлэлт | Харьцуулах хэлбэр |
|---|---|---|---|
| 1 | 101.1.Төрийн албаны тухай хуулийн 4.2.7, Иргэний хуулийн 498.2-т заасны дагуу захиргааны байгууллагын гаргасан алдааны улмаас учруулсан хохирлыг төр хариуцна. | Практик нийцэж буй байдал<br><br>Хүлээн зөвшөөрөгдсөн байдал | Байх ёстой ба одоо байгаа түвшин<br><br>Тодорхой тохиодолд судлах |
| 2 | 101.2.Иргэн, хуулийн этгээд өөрт учирсан хохирлыг хохирол учруулсан захиргааны байгууллагаас нэхэмжилж, | Практик нийцэж буй байдал | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш |



Remove Watermark Now

| | | | |
|---|---|---|---|
| | тухайн захиргааны байгууллагаас гаргуулна. | Хүлээн зөвшөөрөгдсөн байдал | Тодорхой тохиолдол судлах |
| 3 | 103.1.Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ. | Практикт нийцэж буй байдал | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш |
| 4 | 103.2.Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна. | Практикт нийцэж буй байдал<br><br>Зорилгодоо хүрсэн түвшин | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш |
| 5 | 103.3.Энэ хуулийн 103.2-т заасан дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж байхгүй бол гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг төрийн аудитын байгууллага хариуцна. | Практикт нийцэж буй байдал<br><br>Зорилгодоо хүрсэн түвшин | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш |
| 6 | 103.4.Гомдлыг хянан шийдвэрлэсэн дээд шатны захиргааны байгууллага болон шүүх хохирлыг буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр гаргасан актын хувийг холбогдох аудитын байгууллагад хүргүүлэх үүрэгтэй. | Практикт нийцэж буй байдал<br><br>Зорилгодоо хүрсэн түвшин | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш |
| 7 | 104.1.Захиргааны байгууллагын хууль ёсны үйл ажиллагаанаас иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөний улмаас хохирол учирсан бол төрөөс нөхөх олговор олгож хохирлыг барагдуулна. | Практикт нийцэж буй байдал | Өмнөх болон дараах |
| 8 | 104.2.Нөхөх олговор олгох журмыг хуулиар тусгайлан зохицуулна. | Практикт нийцэж буй байдал | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш |

pdfelement

| | | | |
|---|---|---|---|
| | | | |
| 9 | 104.3.Захиргааны байгууллага нөхөх олговрын хэмжээг иргэн, хуулийн этгээдтэй харилцан тохиролцож болно. | Хүлээн зөвшөөрөгдсөн байдал | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш |
| 10 | 104.4.Нөхөх олговрын хэмжээний талаар маргаан гарвал захиргааны журмаар хамтатган нэхэмжлээгүй бол иргэний хэргийн шүүхээр шийдвэрлүүлнэ. | Хүлээн зөвшөөрөгдсөн байдал | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш |

### 1.5.Шалгуур үзүүлэлтийг томьёолох

Энэ үе шатанд үнэлгээ хийх зүйл, хэсэг бүр дээр тогтоосон шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамгийг дэвшүүлж, асуулт тавих замаар шалгуур үзүүлэлтийг томьёолох юм. Ийнхүү шалгуур үзүүлэлтийг томьёолсноор үнэлгээний дараагийн алхмууд нь томьёолсон шалгуур үзүүлтэд хариулт өгөхөд чиглэгдэнэ.

Хүснэгт 4

| д/д | Үнэлгээний хүрээ | Шалгуур үзүүлэлт | Харьцуулах хэлбэр | Шалгуур үзүүлэлтийн томьёолол |
|---|---|---|---|---|
| 1 | 101.1.Төрийн албаны тухай хуулийн 4.2.7, Иргэний хуулийн 498.2-т заасны дагуу захиргааны байгууллагын гаргасан алдааны улмаас учруулсан хохирлыг төр хариуцна. | Практик нийцэж буй байдал<br><br>Хүлээн зөвшөөрөгдсөн байдал | Байх ёстой ба одоо байгаа түвшин<br><br>Тодорхой тохиодолд судлах | Төр захирганы байгууллагын гаргасан алдааны улмаас иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирлыг төр хариуцан арилгаж чадаж байна уу? |
| 2 | 101.2.Иргэн, хуулийн этгээд өөрт учирсан хохирлыг хохирол учруулсан захиргааны байгууллагаас нэхэмжилж, тухайн захиргааны байгууллагаас гаргуулна. | Практик нийцэж буй байдал<br><br>Хүлээн зөвшөөрөгдсөн байдал | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш<br><br>Тодорхой тохиолдол судлах | Иргэн, хуулийн этгээд хохирлоо буруутай тухайн захиргааны байгууллагаас гаргуулан авч чадаж байна уу?<br><br>Энэхүү зохицуулалт нь холбогдох |

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | этгээдүүдэд хүлээн зөвшөөрөгдсөн үү? |
| 3 | 103.1.Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ. | Практикт нийцэж буй байдал | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш | Төр өөрт учирсан хохирлыг буцаан буруутай албан тушаалтнаас хохирлыг гаргуулан авч чадаж байна уу? |
| 4 | 103.2.Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна. | Практикт нийцэж буй байдал<br><br>Зорилгодоо хүрсэн түвшин | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш | Дотоод аудитын нэгж төрийг хохиролгүй болгох арга хэмжээ авч байна уу?<br><br>Энэхүү зохицуулалт нь захиргааны байгууллага хуульд нийцсэн үйл ажиллагаа явуулдаг байх зорилгод хүрсэн үү? |
| 5 | 103.3.Энэ хуулийн 103.2-т заасан дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж байхгүй бол гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг төрийн аудитын байгууллага хариуцна. | Практикт нийцэж буй байдал<br><br>Зорилгодоо хүрсэн түвшин | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш | Төрийн аудитын байгууллага төрийг хохиролгүй болгох арга хэмжээ авч байна уу?<br><br>Энэ зохицуулалт нь ЗЕХ-ийн зорилгыг хангахад чиглэсэн оновчтой зохицуулалт мөн үү? |

pdfelement

| | | | | |
|---|---|---|---|---|
| 6 | 103.4.Гомдлыг хянан шийдвэрлэсэн дээд шатны захиргааны байгууллага болон шүүх хохирлыг буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр гаргасан актын хувийг холбогдох аудитын байгууллагад хүргүүлэх үүрэгтэй. | Практикт нийцэж буй байдал<br><br>Зорилгодоо хүрсэн түвшин | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш | Аудитын байгууллага болон шүүх хуульд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлж байна уу?<br><br>Энэхүү зохицуулалт нь хуулийн зорилгыг хангаж чадсан уу? |
| 7 | 104.1.Захиргааны байгууллагын хууль ёсны үйл ажиллагаанаас иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөний улмаас хохирол учирсан бол төрөөс нөхөх олговор олгож хохирлыг барагдуулна. | Практикт нийцэж буй байдал | Өмнөх болон дараах | Нөхөх олговор олгогдох ажиллагаа хэрхэн хэрэгжиж байна вэ? |
| 8 | 104.2.Нөхөх олговор олгох журмыг хуулиар тусгайлан зохицуулна. | Практикт нийцэж буй байдал | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш | Холбогдох хууль батлагдсан уу? |
| 9 | 104.3.Захиргааны байгууллага нөхөх олговрын хэмжээг иргэн, хуулийн этгээдтэй харилцан тохиролцож болно. | Хүлээн зөвшөөрөгдсөн байдал | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш | Энэхүү зохицуулалтыг төрийн байгууллага хэрхэн хэрэглэж байна вэ?<br><br>Иргэдийн эрх ашиг, сонирхолыг зөрчихгүй байж чадаж байна уу? |
| 10 | 104.4.Нөхөх олговрын хэмжээний талаар маргаан гарвал | Хүлээн зөвшөөрөгдсөн байдал | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш | Шүүхээр шийдвэрлүүлсэн тохиолдолд |



Remove Watermark Now
pdfelement

| | | | | |
|---|---|---|---|---|
| | захиргааны журмаар хамтатган нэхэмжлээгүй бол иргэний хэргийн шүүхээр шийдвэрлүүлнэ. | | | шүүхийн шийдвэр хэрхэн гарсан вэ?<br><br>Шүүх маргааныг шийдвэрлэхэд баримтлах эрх зүйн зохицуулалт хангалттай байна уу? |

**1.6.Мэдээлэл цуглуулах аргыг сонгох**

Төлөвлөлтийн үе шатанд хийгдсэн өмнөх алхам /үнэлгээний шалтгаан, хүрээг тогтоох, шалгуур үзүүлэлтийг сонгох, харьцуулах хэлбэрийг тогтоох, шалгуур үзүүлэлтийг томьёолох/-уудаа ямар тохиодолд тоон, ямар тохиолдолд чанарын мэдээллийг ямар аргаар цуглуулахаа энэ үе шатанд сонгоно.

Захиргааны ерөнхий хуулийн 10 дугаар бүлэгт үнэлгээг хийхдээ мэдээлэл цуглуулах дараахь аргыг ашиглана. Үүнд:

- Захиргааны байгууллагын үйл ажиллагааны улмаас иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирлыг барагдуулах чиг үүргийн хүрээнд оролцогч төрийн эрх бүхий байгууллагуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулах /Хууль зүй, дотоод хэргийн яам, Үндэсний аудитын газар, Төрийн албаны зөвлөл, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар,
- Дээрх байгууллагуудын тайлан, статистикийг ашиглах,
- Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлснээс хойшхи буюу 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойшхи Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрүүдийг судлах замаар үнэлгээг хийхэд ашиглах холбогдох чанарын болон тоон мэдээлийг цуглуулна.

pdfelement

## ХОЁР.ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон мэдээлэл цуглуулах аргыг ашиглан 2018 оны 04 дүгээр сарын 01-ээс 05 дугаар сарын 01-ний өдрийн хооронд хэрэгжүүлэх үе шатыг хийж гүйцэтгэв. Энэ үе шатанд холбогдох төрийн байгууллагуудтай уулзалт ярилцлага[52] хийж, төрийн байгууллага буруутай гэж шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр[53], Төлбөр барагдуулах талаар гаргасан төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтын шийдвэр[54]зэргийг судалж Захиргааны ерөнхий хуулийн 10 дугаар бүлгийг хэрэгжилтийг үнэлэхэд шаардлагатай мэдээллийг цуглуулав.

## ГУРАВ.ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

[52]Үнэлгээний тайлангийн хавсралтад ярилцлагын аргаар авсан судалгааны тайланг хавсаргав.
[53]Үнэлгээний тайлангийн хавсралтад 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойшхи гарсан төрийн холбогдох байгууллагаас төлбөр барагдуулах шүүхийн шийдвэрийг эмхтгэн хавсаргав.
[54]Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалыг хавсралт хэсэгт хавсаргав.

Remove Watermark Now

Төлөвлөх үе шатанд Захиргааны ерөнхий хуулийн 10 дугаар бүлгээс сонгож авсан үнэлэгдэх зүйл, хэсэг, заалт тус бүрийг хэрэгжүүлэх үе шатанд олж авсан мэдээлэл дээр тулгуурлан үнэлэх болно.

**3.1.Захиргааны ерөнхий хуулийн 101.1**

Хүснэгт 5

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 101.1.Төрийн албаны тухай хуулийн 4.2.7, Иргэний хуулийн 498.2-т заасны дагуу захиргааны байгууллагын гаргасан алдааны улмаас учруулсан хохирлыг төр хариуцна. |
| **Томьёологдсон шалгуур үзүүлэлт** | Төр захирганы байгууллагын гаргасан алдааны улмаас иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирлыг төр хариуцан арилгаж чадаж байна уу? |

**Үнэлгээ:** Төр нь түүний буруутай үйл ажиллагааны улмаас иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирлыг барагдуулах талаарх зохицуулалт Иргэний хуулийн 498.2 дахь хэсэгт “Хуульд өөрөөр заагаагүй бол төрийн албан хаагч албан үүргээ зөрчсөн гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-ийн улмаас бусдад гэм хор учруулсан бол уг гэм хорыг түүний ажиллаж байгаа хуулийн этгээд буюу төр хариуцан арилгана.” гэж, Төрийн албаны тухай хуулийн 4.2.7 дахь хэсэгт “хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад гаргасан алдааны улмаас төрийн албан хаагчийн учруулсан хохирлыг төр хариуцах.” гэж тус тус заасан бөгөөд Захиргааны ерөнхий хууль батлагдсанаар дээрх хуулиуд дахь эрх зүйн зохицуулалтыг давтан хуульчилсан байна.

pdfelement

2016 оны 07 дугаар сарын 01-ний өдөр буюу Захиргааны ерөнхий хууль хүчин төгөлдөр үйлчилсэн өдрөөс 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл ямар нэг аливаа хэлбэрээр төр, түүний албан хаагч буруутай үйл ажиллагаа явуулж иргэн, хуулийн этгээдэд хохирол учруулсан хэмээн шүүх эцэслэн шийдвэрлэсэн иргэний хэргийн болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр 997 байгаа бөгөөд эдгээрийг маргааны төрөл, учруулсан хохирлын хэмжээгээр эмхтгэн харуулбал[55]:

Хүснэгт 6

| **Үзүүлэлт** | **Маргааны төрөл** | | | | | **Нийт** |
|---|---|---|---|---|---|---|
| | Ажлаас үндэслэлгүйгээр халагдсан | Бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад хохирол учруулсан | Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас хохирол учруулсан | Гэрээний үүрэг болон ажил гүйцэтгэхтэй холбоотой маргаан | | |
| | | | | Зөвлөх үйлчилгээ | Тендерийн маргаан | |
| | **2016 он** | | | | | |
| Маргааны тоо | 154 | 30 | 5 | 9 | 195 | **405** |
| Хохирлын хэмжээ | 879.700.5 | 4.026.259.9 | 65.885.4 | 8.949.160.4 | 5.917.160.8 | **20.638.044.6** |
| **2017 он** | | | | | | |
| Маргааны тоо | 234 | 46 | 8 | 8 | 128 | **424** |
| Хохирлын хэмжээ | 958.381.8 | 1.035.818.9 | 89.591.0 | 766.091.6 | 7.499.692.9 | **10.339.576.2** |

[55]Шүүхийн шийдвэрийн дэлгэрэнгүйг хавсралт хэсгээс үзэх.

Remove Watermark Now

| 2018 он | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Маргааны тоо | 95 | 12 | 1 | 1 | 59 | **168** |
| Хохирлын хэмжээ | 488.908.0 | 11.253.1 | 20.000.0 | 400.0 | 527.620.1 | **1.048.182.0** |

**Дээрх шүүхийн шийдвэрийг төр хэрхэн барагдуулж байгаа талаар:** Шүүхийн шийдвэрт тухайн буруутай шийдвэрийг гаргасан байгууллагаас хохирлыг гаргуулахыг заадаг боловч тухайн байгууллагын ямар хөрөнгөнөөс гэдгийг тодорхой заадаггүй байна. Практик дээр иргэн, хуулийн этгээд хохирлоо барагдуулахаар холбогдох буюу шүүхийн шийдвэрт нэр заасан байгууллагад ханддаг боловч тухайн байгууллагад хохирол төлөхөд зориулж төсөвлөсөн мөнгөн хөрөнгө байдаггүй тул ихэнхи тохиолдолд шүүхийн шийдвэрт нэрлэн заасан байгууллага уг хохирлыг барагдуулдаггүй байна.[56]

Иймээс иргэд, хуулийн этгээд нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад албадлагын арга хэмжээ хэрэглүүлэхээр ханддаг байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.2-т “Улсын төсвөөс санхүүждэг төлбөр төлөгч-хуулийн этгээдийн дансанд байгаа төлбөр төлөх зориулалт бүхий мөнгөн хөрөнгө нь төлбөрт хүрэлцэхгүй тохиолдолд дараагийн жилийн төсөвт нэмж тусгаж, төлбөрийг барагдуулна” гэж заасныг баримтлан дараа жилийн улсын төсөвт тусгах замаар төр хохирлыг барагдуулдж байна.

Өөрөөр хэлбэл шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хувьд төлбөр төлөгч улсын төсөвт байгууллагад шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх бусад арга хэрэгсэл /төлбөрийн шаардлагын хэмжээгээр дансны зарлагын гүйлгээг битүүмжлэх, өмчлөлийн хөрөнгөнөөс төлбөрийг гаргуулах г.м/ ашиглах боломжгүй байдаг байна. Иймээс 2009 оноос хойш Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцад “Иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирлын нөхөн төлбөр”-т зориулж тодорхой мөнгөн хөрөнгийг жил бүрийн Төсвийн тухай хуулиар баталдаг болжээ.

pdfelement

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага тухайн төсөвт байгууллагын төсвөөс хохирлыг гаргуулах боломжгүй тохиолдолд Хууль зүй, дотоод хэргийн сайдад хандан, түүний төсвийн багцаас төлбөрийг гаргуулах замаар шийдвэрлэж байна. Өмнөх хүснэгт 6-д дурдсан шүүхийн шийдвэрийг барагдуулсан эх үүсвэрээр нь ангилан үзүүлбэл:

Хүснэгт 7

| **Он** | **Төлбөрийн хэмжээ** | **Хохирол барагдуулсан эх үүсвэр** | | **Үлдэгдэл** |
|---|---|---|---|---|
| | | Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцаас | Холбогдох төсөвт байгууллагын төсвөөс | |
| 2016 он | 20.638.044.6 | 12.622.920.7 | 2.699.162.3 | 5.315.961.6 |
| 2017 он | 10.339.576.2 | 923.442.0 | 3.826.789.8 | 5.589.344.4 |
| 2018 он | 1.048.182.0 | 37.428.7 | 234.960.2 | 775.793.1 |

Дээрхээс үзэхэд төр иргэн, хуулийн этгээдэд өөрийн буруутай үйл ажиллагаанаас учруулсан хохирлыг тодорхой хэмжээгээр барагдуулж байгаа боловч төсвийн төлөвлөлттэй холбоотойгоор хохирол барагдуулах ажиллагаа хүлээгддэг бол жил

[56]Тухайн байгууллага өөрөө бага дүнтэй хохирлыг барагдуулах тохиолдол байдаг бөгөөд ийм тохиолдол хэд гарсныг судалгааны явцад мэдэх боломжгүй бөгөөд улс жилдээ нийт хэдэн төгрөгийг хохирол төлөхөд зарцуулж байгааг нэгтгэн дүгнэдэг, хяналт тавьдаг байгууллага байхгүй байна.

Remove Watermark Now

бүрийн улсын төсөвт урьчилан таамаглах байдлаар хохирлыг арилгахад зориулсан эх үүсвэрийг баталдаг боловч уг эх үүсвэр хүрэлцдэггүйгээс хохирол барагдуулах мөнгөн дүн улам бүр хуримтлагдаж байна.

Энэ нь төрийн албан хаагчийн гаргаж байгаа алдаа дутагдал тогтмол нэмэгдэж байгааг харуулж байгаа ч уг асуудалд анализ хийж нэгдсэн удирдлагаар хангадаг, цаашдын төлөв, стратегийн тодорхойлдог байгууллага одоогоор байхгүй байна.

### 3.2.Захиргааны ерөнхий хуулийн 101.2

Хүснэгт 8

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 101.2.Иргэн, хуулийн этгээд өөрт учирсан хохирлыг хохирол учруулсан захиргааны байгууллагаас нэхэмжилж, тухайн захиргааны байгууллагаас гаргуулна. |
| **Томьёологдсон шалгуур үзүүлэлт** | Иргэн, хуулийн этгээд хохирлоо буруутай тухайн захиргааны байгууллагаас гаргуулан авч чадаж байна уу?<br><br>Энэхүү зохицуулалт нь холбогдох этгээдүүдэд хүлээн зөвшөөрөгдсөн үү? |

**Үнэлгээ:**Төрийн буруутай үйл ажиллагааны улмаас хохирол учирсан гэж шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт хариуцагч төрийн захиргааны байгууллагаас гаргуулах талаар зааж өгсөн байдаг боловч хуулийг хэрэглэгч байгууллагуудтай уулзалт хийх үед шүүхийн шийдвэрт тухайн байгууллагын төсвийн аль багцаас гаргах талаар зааж өгдөггүй тул төсвийн захирагч нь дур мэдэн шийдвэрлэхэд хүндрэлтэй байдаг талаар дурдаж байсан болно. Захиргааны ерөнхий хуулийн 101 дүгээр зүйлийн 101.2 дахь хэсэгт тухайн буруутай шийдвэрийг гаргасан захиргааны байгууллага хохирлыг барагдуулахаар заасан боловч жил бүрийн төсвийн тухай хуулиар төсөвт байгууллага бүрт “төрийн буруутай үйл ажиллагаанаас учирсан хохирол барагдуулах төлбөр”-т зориулсан хөрөнгө батлагддаггүй тул Захиргааны ерөнхий хуулийн 101.2 дахь хэсэг ихэнх тохиолдолд зөрчигдөж байна.

Өөрөөр хэлбэл 2009 оноос эхлэн жил бүрийн төсвийн тухай хуулиар Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцад “Төрийн буруутай үйл ажиллагааны улмаас иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирлыг барагдуулах” төлбөрт зориулсан хөрөнгийг баталдаг болсон бөгөөд энэхүү хөрөнгө нь өөрийн төсвөөс иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирлоо барагдуулах боломжгүй нийт төсөвт байгууллагын шүүхийн шийдвэрийг гүйцэтгэхэд зарцуулж байна.

Захиргааны ерөнхий хууль батлагдахдаа Төсвийн тухай хуульд болон бусад холбогдох хуульд өөрчлөлт оруулаагүй тул Захиргааны ерөнхий хуулийн 101 дүгээр зүйлийн 101.2 дахь хэсэг зөрчигдөж хохирлыг тухайн байгууллага бус Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцаас хохирол барагдуулах ажиллагаа одоо хүртэл хийгдэж байна.

Түүнчлэн төрийн байгууллага бүрийн төсөвт хохирол барагдуулахад зориулсан мөнгөн хөрөнгө байх талаарх зохицуулалт хэрэгжүүлэгч байгууллагуудад хүлээн зөвшөөрөгдөөгүй бөгөөд тийм ч учраас одоог хүртэл Захиргааны ерөнхий хуулийг баримтлахгүйгээр жил бүрийн төсвийн хуулийг баталж байна. Иргэн, хуулийн этгээдийн хувьд энэ нь хүндрэл үүсгэдэг бөгөөд тухай хариуцагч төрийн байгууллага хохирол барагдуулахад зориулсан мөнгөн хөрөнгө байхгүй тохиолдолд хэрхэн хохирлоо барагдуулах нь ойлгомжгүй байна. Иймээс энэ талаарх эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай.

Remove Watermark Now

### 3.3.Захиргааны ерөнхий хуулийн 103.1

Хүснэгт 8

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 103.1.Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ. |
| **Томьёологдсон шалгуур үзүүлэлт** | Төр буруутай албан тушаалтнаас хохирлыг гаргуулан авч чадаж байна уу? |

**Үнэлгээ:**Төрд учирсан хохирлыг буруутай этгээдээр гаргуулан авах талаар Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-д “Энэ хуулийн 498.1, 498.2, 498.4-т заасан этгээд өөрийн шууд санаатай буюу илтэд болгоомжгүй үйлдлээр гэм хор учруулсан бол гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй.”, Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2 дахь заалтад “төрийн албаны тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах, төрийн албанд шударга ёсны зарчмыг хэрэгжүүлэх мэргэшил, арга зүйн удирдлагаар хангах, төрийн байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан стандартын хэрэгжилтийг шалган зааварлах, зөрчлийг арилгуулах хугацаатай үүрэг өгөх, гүйцэтгэлд нь хяналт тавих, энэ хуулийн 39.1-д заасан маргааныг хянан шийдвэрлэх, албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас төрд учруулсан хохирлыг арилгуулахаар төрийн нэрийн өмнөөс шүүхэд нэхэмжлэл гаргах;”, Гаалийн тухай хуулийн 239 дүгээр зүйлийн 239.4 дэх хэсэгт “Гаалийн байгууллага энэ хуулийн 239.2-т зааснаар барагдуулсан хохирлыг буруутай гаалийн албан тушаалтнаар нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргана.” гэж тус тус заасан.

pdfelement

Хэдийгээр хууль тогтоомжид төрийг хохиролгүй болгох талаар зааж өгсөн боловч өнөөг хүртэл нэг ч удаа холбогдох хуулиар эрх, үүрэг хүлээсэн төрийн холбогдох бүтэц төрийг хохиролгүй болгох талаар арга хэмжээ аваагүй байна.

Энэ талаар төрийн холбогдох байгууллагатай уулзалт ярилцлага хийх замаар судалгааг хийсэн бөгөөд холбогдох шүүхийн шийдвэрийн практик мөн байхгүй байна.

Түүнчлэн Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 дэх хэсгийг хэрэглэн хэрэг маргаан үүсгэхэд хамтын удирдлагатай байгууллагын тухайд буруутай этгээдийг хэрхэн тогтоох, шийдвэр гаргасан албан тушаалтан өөрчлөгдсөн тохиолдолд хохирлыг хэнээс нэхэмжлэх, буруутай үйлдэл гэдгийг хэрхэн тодорхойлох зэрэг олон асуудал тодорхой бус байгааг анхаарах шаардлагатай. Түүнчлэн төрийн холбогдох байгууллагын буруутай гэж шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн тоо тогтмол нэмэгдэж байгаа бөгөөд сүүлийн хоёр жилийн дундажийг харахад зөвхөн Захиргааны хэргийн шүүх 2016 онд 1780 хэрэг, 2017 онд 1908[57] хэрэг шийдвэрлэхдээ 41,5 орчим хувийг хангаан шийдвэрлэсэн байна. Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага төрийн холбогдох байгууллага хохирол учруулсан гэж шийдвэрлэсэн 2016 онд 405, 2017 онд 424 шүүхийн шийдвэрийг гүйцэтгэсэн байна.

Дээрх бүх шүүхийн шийдвэрүүдэд дахин төрийн байгууллага буруутай албан тушаалтанд хандан нэхэмжлэл гарган хэрэг үүсгэж явахад шүүхийн ачаалал болон төрийн байгууллагын ачаалал нэмэгдэхээр харагдаж байна. Иймд төрийг буцааж хохиролгүй болгох эрх зүйн орчинг тодорхой судалгааны үндсэн дээр боловсронгуй болгох шаардлагатай байна.

[57]Шүүн таслах ажиллагааны тайлан 2016, 2017 он, Шүүхийн ерөнхий зөвлөл

Remove Watermark Now

Дүгнэвэл:Төр өөрт учирсан хохирлыг буруутай этгээдээр буцаан гаргуулах талаарх хуулийн хэрэгжилт маш хангалтгүй түвшинд буюу огт хэрэгжихгүй байна. Үүний шалтгаан нь хуулийн хэрэгжилтийг тодорхой хугацаанд үнэлгээ хийдэггүй, холбогдох процессийг нарийвчлан зохицуулаагүй, төрийн байгууллагын хүний нөөцийг шийдвэрлээгүй зэрэгтэй холбоотой хэмээн дүгнэж байна.

**3.4.Захиргааны ерөнхий хуулийн 103.2**

Хүснэгт 9

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 103.2.Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна. |
| **Томьёологдсон шалгуур үзүүлэлт** | Дотоод аудитын нэгж төрийг хохиролгүй болгох арга хэмжээ авч байна уу?<br><br>Энэхүү зохицуулалт нь захиргааны байгууллага хуульд нийцсэн үйл ажиллагаа явуулдаг байх зорилгод хүрсэн үү? |

**Үнэлгээ:**Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49-т “”дотоод аудит”гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг;”, 69 дүгээр зүйлийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна.” гэж заасан байна. Үүний дагуу төсвийн ерөнхийлөн захирагч бүрд дотоод аудитын нэгж ажиллаж байгаа бөгөөд үүнээс төлөөлүүлэн Хууль зүй, дотоод хэргийн яамны дотоод аудитын нэгжтэй ярилцлагын аргаар судалгаа хийж, буруутай албан тушаалтнаар төрд учирсан хохирлыг буцаан гаргуулсан талаарх шүүхийн шийдвэр байгаа эсэхийг судлан үзсэн болно.

Захиргааны ерөнхий хууль батлагдсанаас хойш аль ч дотоод аудитын нэгжээс буруутай албан тушаалтнаас төрийг хохиролгүй болгох талаар огт арга хэмжээ авагдаагүй байна. Мөн энэ нь Төрийн албаны тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2 дахь хэсэгт Төрийн албаны зөвлөл төрийн төлөөлөн буруутай этгээдээс трд учирсан хохирлыг барагдуулах нэхэмжлэл гаргах эрхтэй гэж заасантай давхардсан бөгөөд зөрчилдсөн байх тул ямар тохиолдолд Төрийн албаны зөвлөл хариуцах, ямар тохиолдолд дотоод аудитын нэгж хариуцах ялгаа заагыг Захиргааны ерөнхий хуульд тодорхой зааж өгөөгүй байна.

Мөн дээд шатны дотоод аудитын нэгж нь хаана ямар шүүхийн шийдвэр гарч байгаа талаар огт мэдээлэлгүй бөгөөд шүүхээс гаргасан шийдвэрийнхээ талаар холбогдох этгээдүүдэд мэдэгдэх, хүргүүлэх ажиллагааг хэрэгжүүлдэггүй болох нь судалгааны явцад тогтоогдсон болно.

Түүнчлэн дотоод аудитын нэгж хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд хэрхэх, төрийн буруутай үйл ажиллагаатай холбоотой шүүхийн шийдвэрт анализ хийж, нэгдсэн удирдлагаар хангах, цаашид хэрхэх стратегийг боловсруулах чиг үүргийг аль ч байгууллагад хүлээлгээгүй байгаа нь хуулийн хэрэгжилтийг хангалтгүй болгоход нөлөөлсөн байна.

Remove Watermark Now

### 3.5.Захиргааны ерөнхий хуулийн 103.3

Хүснэгт 10

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 103.3.Энэ хуулийн 103.2-т заасан дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж байхгүй бол гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг төрийн аудитын байгууллага хариуцна. |
| **Томьёологдсон шалгуур үзүүлэлт** | Төрийн аудитын байгууллага төрийг хохиролгүй болгох арга хэмжээ авч байна уу?<br><br>Энэ зохицуулалт нь Захиргааны ерөнхий хуулийн зорилгыг хангахад чиглэсэн оновчтой зохицуулалт мөн үү? |

**Үнэлгээ:**Төрийн аудитын тухай хуульд зааснаар Төрийн аудитын байгууллага нь аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, сахилгын хариуцлага ногдуулах асуудлыг эрх бүхий албан тушаалтан, байгууллагад тавих, төрийн албанаас халах санал хүргүүлэх, Ерөнхий аудитор улс орны эрх ашгийн төлөө гжэ үзсэн аливаа асуудлаар санал, зөвлөмж бэлтгэж Улсын Их Хурал, түүний Байнгын хороо, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах гэх мэт онцгой эрх хэмжээтйэ. Үүн дээр нэмэгдэн Захиргааны еөрнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2 дахь хэсэгт заасны дагуу буруутай албан тушаалтнаас төрд учирсан хохирлыг барагдуулж төрийг хохиролгүй болгох чиг үүрэгтэй болсон байна.

Судалгааны явцад Төрийн аудитын байгууллага дээр очиж эрх бүхий албан тушаалтантай ярилцлагын аргаар судалгаа хийсэн бөгөөд Захиргааны ерөнхий хууль батлагдсанаас хойш өнөөг хүртэл Төрийн аудит шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх зорилгоор улсын төсвөөс гарсан мөнгөн хөрөнгийг буруутай этгээдээс гаргуулж төрийг хохиролгүй болгох талаар огт арга хэмжээ аваагүй байна. Тайлбарлахдаа ямар шүүхийн шийдвэр гарч байгаа талаар аудитын байгууллага огт мэддэггүй бөгөөд жилийн дараа өмнөх жилийн үйл ажиллагаанд аудит хийдэг, төрийн өмнөөс шүүхэд хандаад нэхэмжлэл гаргаад явах хүний нөөц, орон тоог шийдвэрлэж өгөөгүй гэжээ.

Өөрөөр хэлбэл төрийн аудитын байгууллага төрийг хохиролгүй болгох талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байгаа нь төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа дутмаг, Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангах талаар сул ажиллаж байгаатай холбоотой байна.

### 3.6.Захиргааны ерөнхий хуулийн 103.4

Хүснэгт 11

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 103.4.Гомдлыг хянан шийдвэрлэсэн дээд шатны захиргааны байгууллага болон шүүх хохирлыг буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр гаргасан актын хувийг холбогдох аудитын байгууллагад хүргүүлэх үүрэгтэй. |
| **Томьёологдсон шалгуур үзүүлэлт** | Аудитын байгууллага болон шүүх хуульд заасан үйл ажиллагаа хэрэгжүүлж байна уу?<br><br>Энэхүү зохицуулалт нь хуулийн зорилгыг хангаж чадсан уу? |

**Үнэлгээ:**Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлсэн 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойш төрийн буруутай үйл ажиллагааны улмаас иргэн, хуулийн этгээдийг хохироосон гэж үзсэн 997[58] шүүхийн шийдвэрийг судлаач судалсан бөгөөд эдгээр шийдвэрийг шүүхээс төрийн холбогдох аль байгууллагад тухайлбал Үндэсний аудитын газар, Төрийн албан зөвлөл, Хууль зүй, дотоод хэргийн яам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт хүргүүлээгүй байна.

Түүнчлэн дээрх шүүхийн шийдвэрийн дагуу буруутай албан тушаалтнаас хохирлыг төлүүлэхээр шийдвэрлэсэн нэг ч шүүхийн шийдвэр, аудитын акт тавигдаагүй тул Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.4 дэх хэсэгт заасан шийдвэр, актыг хүргүүлэх тухай асуудлыгцааш үргэлжлүүлэн судлах боломжгүй юм.

Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.4 дэх хэсгээс үзэхэд буруутай албан тушаалтнаар хохирол нөхөн төлүүлэх гомдлыг шүүхээс гадна дээд шатны захиргааны байгууллага шийдвэрлэж болохоор заасан байна. Энэ нь Иргэний хууль, Төрийн албаны тухай хуульд заасан “шүүхэд нэхэмжлэл” гаргах замаар төрийг хохирол болгох зохицуулалттай зөрчилдөж байгаа бөгөөд агуулгын хувьд тун ойлгомжгүй зохицуулалт байна.

Иймд төрийг буцааж хохирол болгох асуудлыг нарийвчлан журамлаагүй байгаа нь хуулийн дагуу уг үүргийг хүлээсэн байгууллагуудын хувьд ойлгомжгүй байдал үүсгэж, хуулийн хэрэгжилтэнд сөргөөр нөлөөлж байна. Иймээс уг зохицуулалт нь хуулийн зорилгыг хангахад чиглэсэн боловч ойлгомжгүй, хэт ерөнхий байгаагаас зорилгодоо хүрч чадахгүй байна.

### 3.7.Захиргааны ерөнхий хуулийн 104.1

Хүснэгт 12

| | |
|---|---|
| **Үнэлгдэх хэсэг** | 104.1.Захиргааны байгууллагын хууль ёсны үйл ажиллагаанаас иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөний улмаас хохирол учирсан бол төрөөс нөхөх олговор олгож хохирлыг барагдуулна. |
| **Томьёологдсон шалгуур үзүүлэлт** | Нөхөх олговор олгогдох ажиллагаа хэрхэн хэрэгжиж байна вэ? |

**Үнэлгээ:**Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Төр газрын эзэнд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, уг газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авч болно.” Монгол Улсын Үндсэн хуулийн “хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө;” гэж төрийн хууль ёсны үйл ажиллагааны улмаас иргэн, хуулийн этгээдэд нөхөх олговор олгох талаарх эрх зүйн үндэсийг тогтоосон болно.

Газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалтад Засгийн газар нь “улсын тусгай хэрэгцээнд авахтай холбогдуулан газрыг солих буюу эргүүлэн авах

[58]Уг тоо нь нэмэгдэх магадлалтай. Энэ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хандан албадлагын журмаар гүйцэтгүүлсэн шүүхийн шийдвэрийн тоо юм. Иргэн, хуулийн этгээд буруутай байгууллагаас шууд хохирлоо барагдуулсан талаарх тоо баримтыг судалж тогтоох боломжгүй байна.



Remove Watermark Now

Remove Watermark Now

тохиолдолд нөхөх олговор олгох” бүрэн эрхтэй бөгөөд газрыг нөхөн олговортойгоор эргүүлэн авах талаарх харилцааг уг хуулиар зохицуулсан байна.

Түүнчлэн Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийг баталж хэрэгжүүлсэн бол 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр нийслэлийн Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт гарсан нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, үймээн самууны үеэр амь бие, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирсон иргэн, цагдаа, дотоодын цэрэг, онцгой байдлын байгууллагын албан хаагч, хуулийн этгээдэд нөхөх олговор олгохтой холбогдсон харилцааг зохицуулах Хохирогчид нөхөн олговор олгох тухай хуулийн мөн баталсан байна.

Дээр дурдсан хуулиар зохицуулсан хоёр тохиолдол нь Захиргааны ерөнхий хуулийн 104 дүгээр зүэлийн 104.1 дэх хэсэгт заасан “захиргааны байгууллагын хууль ёсны ажиллагаа” гэдэгт хамаарахгүй тул энэ асуудлыг судлаагүй болно.

Төрийн захиргааны хууль ёсны үйлдлийн улмаас иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирлыг нөхөн төлөх асуудлыг нэгтгэн зохион байгуулж, бүртгэж байгаа төрийн бүтэц байхгүй болох нь судалгааны явцад тодорхой болсон болно.

Газрыг нөхөн төлбөртэйгээр солих асуудлыг Засгийн газрын шийдвэрээр олгож байгаа бөгөөд ийм тохиолдол 2017-2018 онд гараагүй байна. Улаанбаатар хотын дахин төлөвлөлттэй холбоотойгоор газар чөлөөлөх асуудал гарч байгаа боловч уг тохиолдолд газрын нөхөн төлбөрийг төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж иргэн, хуулийн этгээдтэй тохиролцож олгож байна.

**3.8.Захиргааны ерөнхий хуулийн 104.2**

pdfelement

Хүснэгт 13

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 104.2.Нөхөх олговор олгох журмыг хуулиар тусгайлан зохицуулна. |
| **Томьёологдсон шалгуур үзүүлэлт** | Холбогдох хууль батлагдсан уу? |

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл” баталсан бөгөөд уг бодлогын баримт бичигт Захиргааны ерөнхий хуулийн 104 дүгээр зүйлийн 104.2 дахь хэсэгт заасан Нөхөн олговор олгох журмын тухай хуулийн төслийг боловсруулах талаар заалт байхгүй байна.

Өмнөх хэсэгт дурдсан нөхөн олговор олгох асуудал нь нэгдсэн зохион байгуулалт, бүртгэл байхгүй байгаа нь эрх зүйн зохицуулалт байхгүйтэй холбоотой юм. Иймд уг харилцааг зохицуулах хуулийн төслийг боловсруулан батлуулах хэрэгцээ, шаардлага байна хэмээн үзэж байна.

**3.9.Захиргааны ерөнхий хуулийн 104.2**

Хүснэгт 14

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 104.3.Захиргааны байгууллага нөхөх олговрын хэмжээг иргэн, хуулийн этгээдтэй харилцан тохиролцож болно. |
| **Томьёологдсон шалгуур үзүүлэлт** | Энэ зохицуулалтыг захиргааны байгууллага хэрхэн хэрэглэж байна вэ? |

Remove Watermark Now

Захиргааны байгууллагын хууль ёсны шийдвэрийн улмаас иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирлыг нөхөн олгох талаарх нэгдсэн эрх зүйн зохицуулалт байхгүй бөгөөд “газар ашиглах, эзэмших, өмчлөх”-өөс өөр ямар эрх захиргааны байгууллагын хууль ёсны үйл ажиллагаанаас зөрчигдөж, ямар хэмжээний нөхөн олговор олгож байгаа вэ гэдэг тоо баримт, судалгаа байхгүй байна.

Газар, түүнтэй холбоотой эрхийн хувьд нөхөн олговортойгоор төр эргүүлэн авах боломжтой талаар зохицуулсан боловч судалгааны хугацаанд энэ талаар гаргасан Засгийн газрын шийдвэр байхгүй байна.

Харин Хөдөлмөрийн тухай хуульд үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр өвчилсөн ажилтан болон эдгээр шалтгаанаар нас барсан ажилтны ар гэрт учирсан хохирлыг нөхөн төлөх хувь хэмжээгзохицуулсан боловч ажил олгогч нь захиргааны байгууллагаас гадна хувийн хэвшил байгаагаас гадна уг нөхөн төлбөрийн асуудал нь захиргааны хууль ёсны ажиллагаанаас учирсан нөхөн төлбөрт хамааруулах эсэх талаарх материаллаг зохицуулалт нь тодорхой бус байна.

Иймээс нөхөн олговор олгохдоо захиргааны байгууллага түүний хэмжээг иргэн, хуулийн этгээдтэй хэрхэн тохиролцож байгаа нь тодорхойгүй байна.

Түүнчлэн нөхөн олговор олгох журмыг зохицуулсан хуулийн төсөл боловсруулагдаагүй байгаа нь уг асуудлыг тодорхойгүй болгож байна.

**3.10.Захиргааны ерөнхий хуулийн 104.2**

Хүснэгт 15

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 104.4.Нөхөх олговрын хэмжээний талаар маргаан гарвал захиргааны журмаар хамтатган нэхэмжлээгүй бол иргэний хэргийн шүүхээр шийдвэрлүүлнэ. |
| **Томьёологдсон шалгуур үзүүлэлт** | Шүүхээр шийдвэрлүүлсэн тохиолдолд шүүхийн шийдвэр хэрхэн гарсан вэ?<br><br>Шүүх маргааныг шийдвэрлэхэд баримтлах эрх зүйн зохицуулалт хангалттай байна уу? |

Шүүхийн шийдвэрийн нэгдсэн цахим сангаас шүүлт хийхэд Захиргааны ерөнхий хууль батлагдснаас хойшхи хугацаанд шүүх Захиргааны ерөнхий хуулийн 104.4 дэх хэсгийг хэрэглэсэн тохиолдол байхгүй байна.

Хэрэв шүүхэд иргэн, хуулийн этгээдээс Захиргааны ерөнхий хуулийн 104.4 дэх хэсгийг баримтлан нэхэмжлэл гаргавал шүүх нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох талаар зохицуулалт нь байхгүй байна. Өөрөөр хэлбэл захиргааны ямар ямар хууль ёсны үйл ажиллагаанаас иргэн, хуулийн этгээдийн эрх ашиг сонирхол хөнгөгдөж болох асуудал нь зохицуулагдаагүй байна.

Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогод өртсөн, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөр өвчилсөн ажилтан болон эдгээр шалтгаанаар нас барсан ажилтны ар гэрт учирсан хохирлыг нөхөн төлөх хувь хэмжээг Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулсан байна.

**Дөрөв.Дүгнэлт, зөвлөмж**

Remove Watermark Now

Захиргааны ерөнхий хуулийн 10 дугаар бүлэг буюу "Хохирол"-ын талаарх эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн байдлыг үнэлж, дараахь дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

- Төрийн буруутай үйл ажиллагаанаас иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирлыг төр хариуцан барагдуулах хуулийн зохицуулалтын хэрэгжилт нь Төсвийн тухай хуулийн дагуу төсөв боловсруулах, батлуулах хугацаанаас хамааран өмнөх оны шүүхийн шийдвэрээр олгогдох хохирлын төлбөр дараа онд хуримтлагдаж байгаа боловч төр иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг хугацаа хожимдуулж байгаа хэдий ч барагдуулж байна. Төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас иргэн, хуулийн этгээд хохирох явдал жил ирэх тутам нэмэгдэж байгаа нь улсын төсөвт нилээд ачаалал үүсгэж байна. Холбогдох тооцоо, судалгааг хавсралт хэсгээс харна уу.

- Иргэний хууль, Захиргааны ерөнхий хууль бусад холбогдох хууль заасны дагуу төрийн буруутай үйл ажиллагаанаас учирсан хохирлыг төр барагдуулж байгаа боловч буцаагаад төрийг хохиролгүй болгох тухай холбогдох хуулийн хэрэгжилт 0 хувьтай байна. Захиргааны ерөнхий хууль батлагдснаас хойшхи хугацаагаанд төдийгүй энэ талаарх эрх зүйн зохицуулалт бусад хуульд бий болсон үеэс хойш энэ нь огт хэрэгжихгүй байна. Хэрэгжихгүй байгаа шалтгаан нь төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа байхгүй, хууль хэрэгжүүлэх талаар санаачлагагүй ажилладаг, холбогдох хүний нөөцийг шийдвэрлэж өгөөгүй, буруутай этгээдээс буцааж хэрхэн төрд учирсан хохирлыг гаргуулж авах талаарх процессийг нарийвчлан журамлаж өгөөгүйтэй зэрэгтэй холбоотой байна. Иймд уг асуудлыг нарийвчлан зохицуулах шаардлагатай бөгөөд ийнхүү зохицуулахдаа төрийн албан хаагчийг хувийн хариуцлагатай байлгах, эсэх, төрд албан хаагчийнхаа ямар алдаа дутагдлын улмаас үүссэн хохирлыг хариуцах, ямарыг албан тушаалтнаас буцаан гаргуулах талаарх зохицуулалт, хамтын удирдлагатай байгууллагын учируулсан хохирлыг буруутай этгээдэд хэрхэн ногдуулах, буруутай этгээдээс төрд учирсан хохирлыг гаргуулах асуудлыг төрийн аль нэг бүтцэд хариуцуулсан одоогийн тогтолцоо нь оновчтой эсэх, эсхүл уг асуудлыг төрийн бус байгуулллагаар гүйцэтгүүлэх зэрэг асуудлыг нэгтгэн зохицуулах шаардлагатай.
- Төрийг буцааж хохиролгүй болгох асуудлыг шийдвэрлэхгүй байгаа нь төрийн албан хаагчдыг хариуцлагагүй шийдвэр гаргах замаар иргэн, хуулийн этгээдэд хохирол учруулах явдлыг улам бүр нэмэгдүүлж байх тул буруутай этгээдээр төрийг буцааж хохиролгүй болгох ажиллагааг хэрэгжүүлэх, хэвшүүлэх шаардлагатайг анхаарах.

- Хохирол, нөхөн төлбөртэй холбоотой харилцааг зохицуулсан Захиргааны ерөнхий хуулийн зарим зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хуультай зөрчилдөж байгаа бөгөөд бодит практик үүсэх зарим тохиолдлыг шийдвэрлэхэд хангалттай зохицуулалт агуулаагүй байх тул хууль хоорондын харилцан уялдааг хангах нь зүйтэй.

- Захиргааны байгууллагын хууль ёсны ажиллагаанаас иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирлыг нөхөн төлөх талаарх хуулийн хэрэгжилтийг судалахад уг асуудал нэгдсэн зохион байгуулалтгүй байгаа бөгөөд, захиргааны байгууллагын хууль ёсны ажиллагаанаас иргэн, хуулийн этгээдэд учирах хохирол гэх ойлголт нь өөрөө тодорхойгүй байна. Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлснээс хойш "захиргааны байгууллагын хууль ёсны үйл ажиллагаанаас иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирол"-ыг хэрхэн нөхөн төлсөн нь талаарх нэгдсэн тооцоо,

pdfelement

судалгаа байхгүй байна. Иймээс захиргааны байгууллагын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулах зэрэг зөвлөмжийг хууль санаачлагчид хүргүүлж байна.

Remove Watermark Now

Remove Watermark Now

# ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН 1, 2, 4, 10 ДУГААР БҮЛГИЙН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

## Нэг. ЗЕХ-ийн 1 дүгээр бүлгийн дүгнэлт:

Захиргааны ерөнхий хууль 2015 онд батлагдсанаас хойш 3 жил, хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш 2 орчим жил өнгөрчээ. Энэ хугацаанд тус хуулийн хэрэгжилтийн талаар судалгаа хийгдэж байгаагүй байна. Энэхүү хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх судалгааны ажлын хүрээнд 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.7, 4 дүгээр зүйлийн 4.2.6, 4.2.8 дахь заалтыг сонгон авч, практикт хэрхэн хэрэгжиж байгаа эсэхийг үнэлж дүгнэхийг зорьсон болно. Иймээс энэхүү үнэлгээний ажилд сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах дүгнэлтийг хийж байна.

- *"Хүлээн зөвшөөрөгдсөн байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд:*

ЗЕХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтад "зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа"-нд ЗЕХ үйлчлэхгүй гэсэн нэмэлтэд хийсэн дүгнэлт.

ЗЕХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтад зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа нь захиргааны үйл ажиллагаа биш гэсэн атлаа, улмаар Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт энэ маргааныг захиргааны хэргийн шүүх хянан хэлэлцэхгүй байтал Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Оролцогч энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.7, 6.10, 6.11, 6.12, 6.14, 6.15, 6.16, 6.17, 6.18, 6.19, 6.20, 6.21, 6.22, 6.23, 6.24, 6.25, 6.27 дахь заалтад заасан эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрийг эс зөвшөөрвөл Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар гомдол гаргаж шийдвэрлүүлнэ" гэж заасан нь ихээхэн зөрчилдөөнтэй болсон төдийгүй практикт хүлээн зөвшөөрөгдөх байдал нь дутмаг байна.

pdfelement

- *"Практикт хэрэгжиж байгаа байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд:*

1. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд ЗЕХ үйлчлэхгүй байхаар хуульчилж, улмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас гарснаас бусад шийдвэрийг захиргааны акт байхаар нэмэлт оруулсныг үндсэн хуулийн зөрчил бүхий байна гэж үзэж Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс Улсын дээд шүүхэд санал хүргүүлж, улмаар Улсын дээд шүүх энэхүү саналыг үндэслэлтэй гэж үзэж, Үндсэн хуулийн цэцэд хянуулахаар хүсэлт явуулсан байна. Эдгээр тогтоолуудыг үндэслэн одоогоор Нийслэл дэх захиргааны анхан шатны шүүхэд зөрчлийн хэрэг үүсгэн хянагдаж байгаа нийт зөрчлийн хэргүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг Үндсэн хуулийн цэцийн шийдвэр эцэслэн гарах хүртэл хугацаагаар түдгэлзүүлэн шийдвэрлэж байна. Өөрөөр хэлбэл, захиргааны хэргийн шүүхэд зөрчлийн хэргийг өнөөдрийн байдлаар шийдвэрлээгүй, түдгэлзүүлсэн байдалтай байна.

2. Манай улсын өнөөгийн шүүхийн практикаас авч үзэхэд Захиргааны хэргийн шүүх захиргааны байгууллагын улс төрийн болон бодлогын шинжтэй үйл ажиллагааг түүний захиргааны үйл ажиллагаанаас тодорхой зааглахгүйгээр захиргааны хэрэг үүсгэх, хэргийн оролцогчид улс төрийн болон бодлогын шинжтэй шийдвэр мөн, биш хэмээн маргаж байхад түүнд нь тодорхой эрх зүйн дүгнэлт хийхгүйгээр шийдсэн кэйс 3 гарсан байх бөгөөд эндээс үзвэл шүүхийн практикт ЗЕХ-ийн 3.1.7 дахь заалтыг зөв хэрэглэхгүй байна гэж дүгнэлээ.

Remove Watermark Now

3. ЗЕХ хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойшхи хугацаанд ЗЕХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.2.6 дахь заалтыг үндэслэн хэрэглэж шийдвэрлэсэн 34 кэйс гарсан байх[59] бөгөөд дийлэнх нь энэ зарчмыг захиргааны байгууллага баримталж ажиллаагүй гэсэн эрх зүйн дүгнэлтийг хийжээ. Эндээс үзвэл, ЗЕХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.2.6 дахь заалтад заасан зарчим нь захиргааны байгууллагуудад бүрэн дүүрэн хэрэгжихгүй байна.

4. ЗЕХ хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойшхи хугацаанд ЗЕХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.2.8 дахь заалтыг үндэслэн хэрэглэж шийдвэрлэсэн зөвхөн 1 кэйс гарсан байх бөгөөд эндээс тус заалт амьдралд хэрхэн хэрэгжиж байгаа талаар дүгнэлт өгөх боломжгүй байна.

**<u>Хоёр. ЗЕХ-ийн 2 дугаар бүлгийн дүгнэлт:</u>**

Захиргааны ерөнхий хууль 2015 онд батлагдсанаас хойш 3 жил, хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш 2 орчим жил өнгөрчээ. Энэ хугацаанд тус хуулийн хэрэгжилтийн талаар судалгаа хийгдэж байгаагүй байна. Энэхүү хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх судалгааны ажлын хүрээнд 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.5, 8 дугаар зүйлийн 8.1 дэх дахь заалтыг сонгон авч, эдгээр заалтууд хуулийн зорилгодоо хүрсэн эсэх, практикт хэрэгжиж байгаа эсэхийг үнэлж дүгнэхийг зорьсон болно. Иймээс энэхүү үнэлгээний ажилд сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах дүгнэлтийг хийж байна.

- *“Зорилгод хүрсэн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:*

ЗЕХ-ийн 1 дүгээр зүйлд тус хуулийн зорилгыг тодорхойлохдоо “нийтийн эрх зүйн хүрээнд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг захиргааны байгууллага”-д ямар субъектууд багтахыг хуульчлахыг зорьсон байх бөгөөд тийнхүү захиргааны байгууллагыг тодорхойлохдоо хуучин 2002 оны Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар захиргааны байгууллагыг тодорхойлж байсан “нэалттэй тоочих” зарчмаас аль болох зайлсхийхийг оролдсон байх боловч бүхэлдээ ерөнхий заалтын зарчмыг баримталсан гэж дүгнэх боломжгүй байна. Хэдийгээр манай улсын ЗЕХ нь ерөнхий заалтын зарчмыг бүрэн баримтлаагүй боловч ЗЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.5 дахь заалт нь захиргааны байгууллагуудыг тодорхойлж өгөх талаар хуулийн зорилгодоо хүрсэн гэж дүгнэж байна.

- *“Практикт хэрэгжиж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:*

*Нэг.* ЗЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтад “төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага” нь захиргааны байгууллага болно гэж заасан байх бөгөөд энд “төрийн захиргааны төв байгууллага” гэдэг томъёоллыг хэрэглээгүй, харин “төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв байгууллага” хэмээн өргөн агуулга бүхий томъёоллыг хэрэглэсэн байгааг анхаарах нь зүйтэй байна. “Төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв байгууллага” гэдэгт Монгол Улсын Засгийн газар, яам, агентлаг багтах нь хууль боловсруулагчдын болон хууль тогтоогчдын үзэл баримтлал, хуулийн зорилго, эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах онол, арга зүйн талаасаа тодорхой ойлгогдож байна. Практикт хуульчид болон Захиргааны хэргийн шүүхийн шүүгчдийн аль аль нь энэ заалтыг ямар нэг хоёрдмол утгагүй ойлгон, маргаангүй хэрэглэж ирсэн байх бөгөөд 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш Монгол Улсын

[59] Шүүхийн шийдвэрийг шүүхийн шийдвэрийн цахим сангаас шүүлт хийж хайсан болно, Т.М.

Remove Watermark Now

Засгийн газрыг Захиргааны хэргийн шүүхэд хариуцагчаар татаж, хэргийг шийдвэрлэсэн кэйс 21[60] байгааг судалгааны өмнөх бүлэгт дурдсан болно.

*Дүгнэлт:*

Засгийн газрын үйл ажиллагааг губернатив буюу улс төрийн-бодлогын, административ буюу захиргааны үйл ажиллагаа гэж хоёр ангилан авч үздэг бөгөөд Засгийн газрын захиргааны үйл ажиллагаагаар иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол нь зөрчигдсөн бол ердийн шүүх (тэр дундаа Захиргааны хэргийн шүүх) тэрхүү зөрчигдсөн эрхийг сэргээх учиртай гэдэг нь үндсэн хуульт ёс, эрх зүйт төрийн зарчмын зүй ёсны нэгэн шаардлага болно (Хавсралт 1. Онолын судалгааг үзнэ үү).

Засгийн газрын шийдвэр, үйл ажиллагаа нь иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хөндсөн, эсхүл зөрчсөн бол шүүхээс хянах нь үндсэн хуульт ёс, эрх зүйт төрийн зарчмын зүй ёсны нэгэн шаардлага болж юм. Монгол Улсын Засгийн газар нь бусад орны Засгийн газартай харьцуулахад иргэн, хуулийн этгээдэд шууд чиглэсэн, эрх зүйн үр дагавартай шийдвэр гаргах хууль зүйн өргөн боломжтой болох нь холбогдох салбарын хуулиудад иргэн, хуулийн этгээдэд шууд чиглэсэн, тухайлсан шинжтэй шийдвэр гаргах болон нийтээр дагаж мөрдөх олон тооны захиргааны хэм хэмжээний актыг батлан гаргах боломжийг олгосон байгаагаар нотлогдож байна. Тухайлбал, 2017 онд Засгийн газраас гаргасан 106 шийдвэрийг түүвэрлэн үзэхэд 8.55% хувь буюу 9 нь захиргааны акт, 42.4% хувь буюу 45 нь захиргааны хэм хэмжээний акт байгаа нь Засгийн газрын энэхүү захиргааны үйл ажиллагааг шүүхээс хянах үндэслэл болж байна (Хавсралт 2. Засгийн газрын 2017 оны зарим шийдвэрт хийсэн дүн шинжилгээг үзнэ үү).

Монгол Улсын Засгийн газрын шийдвэр, үйл ажиллагаагаар иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдсөн бол захиргааны болон иргэний хэргийн шүүх тус тусын хэргийн харьяаллын дагуу маргааныг шийдвэрлэх нь тодорхой байх бөгөөд хэрэв аль ч шүүх тухайн маргааныг авч хэлэлцэхгүй бол Монгол Улсын Үндсэн хуулийн цэц аль нэг шүүхэд хэргийн харьяалал тогтоож өгнө. Энэ бол эрх зүйт төрийн суурь зарчим юм.

pdfelement

*Хоёр.* Ерөнхийлөгчийн зарлигтай холбоотой тодорхой эрх зүйн маргаан дээр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд харьяалал тогтоосон тохиолдол гарсан байх бөгөөд эндээс дүгнэвэл Монгол Улсын Үндсэн хуулийн цэц Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн маргааныг захиргааны хэргийн шүүхэд харьяалуулснаар Монгол Улсын Ерөнхийлөгчийг захиргааны байгууллага байх боломжтой гэдгийг хууль зүйн хувьд хүлээн зөвшөөрсөн байна.

*Дүгнэлт:*

Орчин үеийн ардчилсан, эрх зүйт төртэй улсад иргэн хүнд шүүхэд мэдүүлэх, эрх зүйн хамгаалалт авах боломж бүх талаар олгогдсон байх ёстой. Дээрхээс үзэхэд Ерөнхийлөгчийн Үндсэн хуулийг зөрчөөгүй, харин бусад хуулийг зөрчсөн үйл ажиллагааг ердийн шүүх (тэр дундаа Захиргааны хэргийн шүүх) хянах боломжтой гэдгийг Үндсэн

[60] Шүүхийн шийдвэрийн цахим санд нээлттэй байгаа шийдвэрийг түүж судалсан болно. Энэ тайлангийн Хавсралт 3-т хавсаргав. Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн гаргасан "Засгийн газрын шийдвэр шүүхийн хяналтад байх нь: Үндсэн хуулийн цэц болон ердийн шүүхийн харьяаллын асуудал" сэдэвт судалгааны тайланд 35 кэйс байгаа тухай дурджээ https://drive.google.com/file/d/19bHUidJ0OQi4QiG_7gOhLOKErYzjlCsn/view

хуулийн цэц тогтоосон байна. Энэхүү маргаан нь одоо Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд хянан шийдвэрлэгдэж байна.

*Гурав.* ЗЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтад “нутгийн өөрөө удирдах байгууллага” буюу аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, баг, хорооны ИНХ нь захиргааны байгууллага болохыг тодорхой заажээ. 2002 оны Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалтуудад ч энэ агуулгаар хуульчлагдсан байсан болно. Энэ заалтыг шүүхийн практикт ямар нэг хоёрдмол утгагүй ойлгож, маргаангүй хэрэглэж ирсэн бөгөөд одоо ч тийнхүү хэрэглэж байгаа болох нь шүүхийн шийдвэрийн судалгаагаар тогтоогдлоо (Хавсралт 4-ийг үзнэ үү).

*Дүгнэлт:*

Нутгийн өөрөө удирдах байгууллагын гаргасан иргэн, хуулийн этгээдэд чиглэсэн, шууд эрх зүйн үр дагавар бүхий захиргааны акт, нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан захиргааны хэм хэмжээний акт нь шүүхийн хяналтын доор байна гэдэг нь үндсэн хуульт ёс, эрх зүйт төрийн зарчмын зүй ёсны нэгэн шаардлага байна.

Тийм учраас аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, баг, хорооны ИНХ-ыг захиргааны байгууллага байна гэдгийг ЗЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтад нэрлэн заасан байх бөгөөд нутгийн өөрөө удирдах байгууллагын захиргааны үйл ажиллагаа нь Захиргааны хэргийн шүүхийн хяналтад багтана.

Хуульд заасаан бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно гэж заасан ЗЕХ-ийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт практикт хангалттай хэрэгжихгүй байна.

pdfelement

**<u>Гурав. ЗЕХ-ийн 4 дүгээр бүлгийн дүгнэлт:</u>**

1) Үнэлгээний судалгаанаас үзэхэд ЗЕХ-ийн 37 дугаар зүйлийн 37.1-д Зөрчлийн тухай хуулийн дагуу оруулсан нэмэлт зохицуулалт нь ЗЕХ-ийн зорилгод шууд нөлөөлж, Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуулиуд хоорондоо уялдаагүй, зөрчилдөөнтэй байгаа, зөрчлийн хуулийг үндэслэн оруулсан өөрчлөлтийг шүүхийн практикт хэрэгжүүлэх боломжгүй болсон үр дагавар, хүндрэл гарсан байна. Иймд уг хуулийн заалтад өөрчлөлт оруулах шаардлагатай байна.

2) Судалгааны явцад шүүхийн шийдвэрийн shuukh.mn мэдээллийн сангаас шүүл хийхэд ЗЕХ-ийн 37.7-г хэрэглэж гаргасан шүүхийн шийдвэр, захиргааны актын байхгүй байна. ЗЕХ-ийн 37.7-дахь хуулийн заалтыг тодорхой болгон өөрчлөх шаардлагагүй, харин жишээтэйгээр тайлбарлан таниулах, ойлгуулах ажлуудыг хийх зүйтэй.

3) Захиргааны байгууллагын бичгээр гаргаж байгаа ЗЕХ-ийн 40.4-т заасан захиргааны актад “бодит нөхцөл байдлыг тодорхой заах” шаардлагыг хангаж гаргах заалт захиргааны байгууллагууд ойлгож, уг заалтыг захиргааны байгууллагуудаас практикт нэгэнт нэг мөр хэрэглэж байгаагаас үзэхэд уг хуулийн заалт практикт зорилгодоо нийцсэн байдлаар хэрэгжиж байна.

4) Шүүгчдийн дунд явуулсан хэлэлцүүлгээс шүүхийн практикт ЗЕХ-ийн 43 дугаар зүйлд заасан мэдэгдэх шаардлагыг биелүүлээгүй үндэслэлээр захиргааны актыг хүчингүй болгоход дээд шатны шүүхээс хэлбэрийн төдий шаардлага учир энэ үндэслэлээр акт хүчингүй болгох үндэслэлгүй гэж дүгнэсэн талаар тайлбарлажээ. Хэргийн оролцогч

талуудаас 43 дугаар зүйлд заасан захиргааны актыг мэдэгдэх шаардлагыг хангаагүй талаар маргадаг боловч шүүхээс энэ үндэслэлээр захиргааны актыг хүчингүй болгосон тохиолдол зөвхөн 1 удаа гарсан байна. Захиргааны актыг хаяглагдсан болон эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн этгээдэд хууль ёсны дагуу мэдэгдсэн үеэс гадагшаа чиглэсэн шинжийг агуулж, эрх зүйн харилцаа үүсч, хууль зүйн үр дагавар бий болгох хүчинтэй төгөлдөр захиргааны акт гэж үздэг ЗЕХ-ийн зорилго, үзэл баримтлалын дагуу цаашид захиргааны актыг мэдэгдэх ажиллагааг захиргааны байгууллага заавал хийдэг болгох, хуулийн хэрэгжилтийг нэг мөр болгох шаардлагатай гэдэг нь судалгаанаас харагдаж байна. Хэдийгээр зарим байгууллагаас актыг мэдэгдэх ажиллагааны талаар анхаарч журам гаргаж, мэдэгдэх хуудасны загвар батлан мөрдүүлж байгаа боловч энэ нь хангалтгүй байна. Иймд шүүхээс уг хуулийн заалтыг хуулийн зорилгод нийцүүлэх болон ЗЕХ-ийн тусгай зарчмыг зохицуулсан 4.2.6-д заасан зохицуулалттай хэрхэн уялдуулан хэрэглэх талаар нэг мөр ойлголтыг бий болгож, нэгдсэн практик тогтоох, ЗЕХ-ийн 48 дугаар зүйлд, 43 дугаар зүйлд захиргааны актыг мэдэгдэх шаардлагыг хангаагүй захиргааны акт хүчингүй болох үндэслэлээр өөрчлөлт оруулах, мэдэгдэх нарийвчилсан журмыг тухайн захиргааны байгууллага гаргах боломжийн талаар тайлбарлан таниулах шаардлагатай байна.

5) Дээр дурдсан шүүхийн шийдвэрүүдийн үндэслэлд дурдсан байдал, шүүгчдийн дунд хийсэн хэлэлцүүлгийн тэмдэглэл, захиргааны шүүхийн шүүгчдийн дунд явуулдаг сургалтын хэлэлцүүлэг зэргээс дүн шинжилгээ хийхэд ЗЕХ-ийн 47.1.6 дахь заалтыг ерөнхий байдлаар хуульд оруулснаас шалтгаалж ЗЕХ-ийн 47.1.6 дахь заалтын “иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байгаагүй” гэдэгт хуульд үндэслэх зарчмыг зөрчсөн алдаануудыг хамааруулан ойлгохоор заасан ЗЕХ-ийн хууль тогтоогчийн үндсэн үзэл баримтлал, зорилгод нийцэхгүй байгаа нөхцөл байдал бий болжээ. Иймээс ЗЕХ-ийн 47.1.6 дахь заалтад хуулийн зорилгод нийцүүлсэн нэмэлт тодруулга байдлаар өөрчлөлт оруулах нь зүйтэй байна.

6) ЗЕХ-ийн 48 дугаар зүйлийн зорилго, үзэл баримтлалыг захиргааны байгууллага, шүүгч нар, иргэдэд тайлбарлан ойлгуулах, шүүхээс хууль хэрэглэх явцдаа нэг мөр ойлгох, нэгдсэн практик тогтоох боломжтой, уг хуулийн заалтад өөрчлөлт оруулах шаардлагагүй байна.

7) ЗЕХ-ийн 49 дүгээр зүйлийг практикт захиргааны байгууллагууд төдийлөн таньж мэдэж, ойлгоогүй байгаа нь судалгаанаас харагдаж байгаа тул энэ чиглэлээр тайлбарлан таниулах шаардлагатай. Хуульд өөрчлөлт оруулах шаардлагагүй байна.

8) ЗЕХ-ийн 50 дугаар зүйлийг практикт захиргааны байгууллагууд төдийлөн таньж мэдэж, ойлгоогүй байгаа нь судалгаанаас харагдаж байгаа тул энэ чиглэлээр тайлбарлан таниулах шаардлагатай. Хуульд өөрчлөлт оруулах шаардлагагүй байна.

9) ЗЕХ нь Монгол Улсад батлагдан мөрдөгдөж байгаа шинэ хууль бөгөөд нийтээр дагаж мөрдөгдсөн үеэс хойш 2 жил орчим болж байгаа тул практикийн хэрэглээнд зарим зүйл, заалт ялангуяа онолын ойлголтыг багтаасан зохицуулалтыг нэлээд сайн тайлбарлан таниулж хэрэглээнд орсны дараа хэрэгжиж эхлэх онцлогтой гэдгийг анхаарах нь зүйтэй.



Remove Watermark Now

Remove Watermark Now

**<u>Дөрөв. ЗЕХ-ийн 10 дугаар бүлгийн дүгнэлт:</u>**

Захиргааны ерөнхий хуулийн 10 дугаар бүлэг буюу "Хохирол"-ын талаарх эрх зүйн зохицуулалтын хэрэгжилтийн байдлыг үнэлж, дараахь дүгнэлт, зөвлөмжийг хийж байна. Үүнд:

1) Төрийн буруутай үйл ажиллагаанаас иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирлыг төр хариуцан барагдуулах хуулийн зохицуулалтын хэрэгжилт нь Төсвийн тухай хуулийн дагуу төсөв боловсруулах, батлуулах хугацаанаас хамааран өмнөх оны шүүхийн шийдвэрээр олгогдох хохирлын төлбөр дараа онд хуримтлагдаж байгаа болович төр иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг хугацаа хожимдуулж байгаа хэдий ч барагдуулж байна. Төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас иргэн, хуулийн этгээд хохирох явдал жил ирэх тутам нэмэгдэж байгаа нь улсын төсөвт нилээд ачаалал үүсгэж байна.

2) Иргэний хууль, Захиргааны ерөнхий хууль бусад холбогдох хууль заасны дагуу төрийн буруутай үйл ажиллагаанаас учирсан хохирлыг төр барагдуулж байгаа болович буцаагаад төрийг хохиролгүй болгох тухай холбогдох хуулийн хэрэгжилт 0 хувьтай байна. Захиргааны ерөнхий хууль батлагдсанаас хойшхи хугацаагаанд төдийгүй энэ талаарх эрх зүйн зохицуулалт бусад хуульд бий болсон үеэс хойш энэ нь огт хэрэгжихгүй байна. Хэрэгжихгүй байгаа шалтгаан нь төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа байхгүй, хууль хэрэгжүүлэх талаар санаачлагагүй ажилладаг, холбогдох хүний нөөцийг шийдвэрлэж өгөөгүй, төрд учирсан хохирлыг буруутай этгээдээс буцааж хэрхэн гаргуулж авах талаарх процессийг нарийвчлан журамлаж өгөөгүйтэй зэрэгтэй холбоотой байна. Иймд уг асуудлыг нарийвчлан зохицуулах шаардлагатай бөгөөд ийнхүү зохицуулахдаа төрийн албан хаагчийг хувийн хариуцлагатай байлгах эсэх, төр албан хаагчийнхаа ямар алдаа дутагдлын улмаас үүссэн хохирлыг хариуцах, ямрыг нь албан тушаалтнаас буцаан гаргуулах талаарх зохицуулалт, хамтын удирдлагатай байгууллагын учируулсан хохирлыг буруутай этгээдэд хэрхэн ногдуулах, буруутай этгээдээс төрд учирсан хохирлыг гаргуулах асуудлыг төрийн аль нэг бүтцэд хариуцуулсан одоогийн тогтолцоо нь оновчтой эсэх, эсхүл уг асуудлыг төрийн бус байгуулллагаар гүйцэтгүүлэх зэрэг асуудлыг нэгтгэн зохицуулах шаардлагатай.

3) Төрийг буцааж хохиролгүй болгох асуудлыг шийдвэрлэхгүй байгаа нь төрийн албан хаагчдыг хариуцлагагүй шийдвэр гаргах замаар иргэн, хуулийн этгээдэд хохирол учруулах явдлыг улам бүр нэмэгдүүлж байх тул буруутай этгээдээр төрийг буцааж хохиролгүй болгох ажиллагааг хэрэгжүүлэх, хэвшүүлэх шаардлагатайг анхаарах.

4) Хохирол, нөхөн төлбөртэй холбоотой харилцааг зохицуулсан Захиргааны ерөнхий хуулийн зарим зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хуультай зөрчилдөж байгаа бөгөөд бодит практикт үүсэх зарим тохиолдлыг шийдвэрлэхэд хангалттай зохицуулалт агуулаагүй байх тул хууль хоорондын харилцан уялдааг хангах нь зүйтэй.

5) Захиргааны байгууллагын хууль ёсны ажиллагаанаас иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирлыг нөхөн төлөх талаарх хуулийн хэрэгжилтийг судлахад уг асуудал нэгдсэн зохион байгуулалтгүй байгаа бөгөөд, захиргааны байгууллагын хууль ёсны ажиллагаанаас иргэн, хуулийн этгээдэд учирах хохирол гэх ойлголт нь өөрөө тодорхойгүй байна. Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлснээс хойш "захиргааны байгууллагын хууль ёсны үйл ажиллагаанаас иргэн, хуулийн этгээдэд

учирсан хохирол”-ыг хэрхэн нөхөн төлсөн талаарх нэгдсэн тооцоо, судалгаа байхгүй байна. Иймээс захиргааны байгууллагын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулах зэрэг зөвлөмжийг хууль санаачлагчид хүргүүлж байна.

Remove Watermark Now

pdfelement

Remove Watermark Now

# ГУРАВ. Захиргааны ерөнхий хуулийн III, VI, XI дүгээр бүлгийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан

Гүйцэтгэсэн:

- **А.Алтанзул**
  /Удирдлагын академийн Эрх зүйн тэнхимийн багш, хууль зүйн ухааны доктор (Ph.D)/
- **Д.Алтантуяа**
  /Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газар, Захиргааны хэм хэмжээний актын хяналт, бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн/

pdfelement

Remove Watermark Now

# I хэсэг. ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН 3 ДУГААР БҮЛГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2015 онд Монгол Улсын Их Хурлаас баталж 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар бүлгийн эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг илрүүлэх, харьцуулан үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын дагуу үнэлнэ.

Үнэлгээний зорилго нь

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахаар заасан бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад “ тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх”-ээр заасан нь үнэлгээ хийх шалтгаан юм.

Үнэлгээг дараахь үе шаттайгаар хийж гүйцэтгэлээ. Үүнд:

4. Төлөвлөх үе шат
5. Хэрэгжүүлэх үе шат
6. Үнэлэх үе шат

## НЭГ.ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

### 1.1.Үнэлгээ хийх шалтгаан

Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар бүлэгт үнэлгээ хийх шалтгаан нь захиргааны шийдвэр гаргах ажиллагааны оролцогчдыг оновчтой тодорхойлсон болон иргэдийн оролцооны эрхийг захиргааны байгууллага хэрхэн хангаж байгаа талаар, захиргааны байгууллага бодит нөхцөл байдлыг тогтоох замаар хуульд үндэслэсэн шийдвэр гаргах үүргээ хэрхэн хэрэгжүүлж буйг тандан судлах зорилготой.

pdfelement

### 1.2.Үнэлгээний хүрээг тогтоох

Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар бүлгийн 11,13, 24, 25, 26, 27, 28, 29,31, 33 дугаар зүйлийн зохицуулалтыг үнэлэх бөгөөд үнэлэгдэх шаардлагатай зүйл, хэсгийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 1

| № | Үнэлэгдэх хэсэг, заалт |
|---|---|
| 1 | 11.3.Хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд захиргааны байгууллага энэ хуулийн 11.1-д заасан үйл ажиллагааны хэлбэрээс сонгон хэрэглэнэ.<br>11.4.Хуульд өөрөөр заагаагүй, энэ хуулийн 11.1-д заасан хэлбэрээс сонгож хэрэглэх боломжгүй тохиолдолд захиргааны байгууллага захиргааны үйл ажиллагааны өөр бусад хэлбэрийг өөрөө тогтооно. |
| 2 | 13.1.Захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд оролцогч /цаашид “оролцогч” гэх/ гэж захиргааны байгууллагад өргөдөл, хүсэлт гаргасан этгээд, захиргааны акт, захиргааны гэрээний эрх зүйн үйлчлэл шууд болон шууд бусаар чиглэсэн этгээд болон захиргааны байгууллагаас шийдвэр гаргах ажиллагаанд татан оролцуулсан этгээдийг ойлгоно. |

| | |
|---|---|
| | 13.2.Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн этгээд захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд гуравдагч этгээдээр оролцоно.<br>13.3.Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдийг түүний хүсэлтээр, эсхүл захиргааны байгууллага өөрийн санаачилгаар, оролцогчийн зөвшөөрснөөр шийдвэр гаргах ажиллагаанд татан оролцуулна.<br>13.4.Захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүн оролцох тохиолдолд дохио, зангаа, тусгай тэмдэгт ашиглан хэлмэрчийн тусламжтайгаар оролцоно. |
| 3 | 24.1.Захиргааны байгууллага захиргааны шийдвэр гаргах<br>ажиллагаанд хамаарах бодит нөхцөл байдлыг тогтооно.<br>24.2.Энэ хуулийн 24.1-д заасан бодит нөхцөл байдлыг тогтооход ач холбогдол бүхий шаардлагатай ажиллагаа хийх, нотлох баримтыг цуглуулах, үнэлэх үүргийг захиргааны байгууллага хүлээнэ |
| 4 | 25-р зүйл. Нотлох баримт цуглуулах<br>25.1.Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны нөхцөл байдлыг тогтооход шаардлагатай нотлох баримтыг захиргааны байгууллага дараах байдлаар цуглуулна:<br>25.1.1.ач холбогдол бүхий мэдээллийг цуглуулах;<br>25.1.2.оролцогчийг сонсох, тайлбар гаргуулах;<br>25.1.3.шинжээч оролцуулан дүгнэлт гаргуулах;<br>25.1.4.гэрч, гуравдагч этгээдээс тайлбар гаргуулах;<br>25.1.5.баримт бичиг болон хууль, бусад шийдвэртэй танилцах, хуулбарлах;<br>25.1.6.шаардлагатай бол туршилт хийх;<br>25.1.7.оролцогчийн хүсэлтээр зайлшгүй шаардлагатай нотлох баримтыг гаргуулан авах. |
| 5 | 26-р зүйл. Оролцогчийг сонсох<br>26.1.Захиргааны акт, захиргааны гэрээг батлан гаргахын өмнө эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдэд захиргааны шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар тайлбар, санал гаргах боломж олгоно.<br>26.2.Энэ хуулийн 26.1-д заасан оролцогчоос тайлбар, санал авах ажиллагааг сонсох ажиллагаа гэнэ. |
| 6 | 27.3.Сонсох ажиллагааны талаарх мэдэгдэлд дараах мэдээллийг тусгана:<br>27.3.1.сонсох ажиллагааг явуулах журам, ажиллагаа явуулах он, сар, өдөр, цаг, байрлал, дараалын талаарх мэдээлэл; |



Remove Watermark Now
pdfelement

Remove Watermark Now

| | |
|---|---|
| | 27.3.2.захиргааны шийдвэр гаргах эрх олгогдсон хууль, захиргааны хэм хэмжээний актын зүйл, заалт;<br><br>27.3.3.захиргааны шийдвэр гаргах тухайн асуудлын талаарх мэдээлэл, үндэслэл<br><br>27.4.Сонсох ажиллагааг дараах арга хэлбэрээр явуулна:<br><br>27.4.1.сонсгол зохион байгуулах;<br><br>27.4.2.саналыг бичгээр авах;<br><br>27.4.3.биечлэн уулзах;<br><br>27.4.4.утсаар санал авах;<br><br>27.4.5.цахим хэлбэрээр санал авах;<br><br>27.4.6.төлөөлөгчөөр дамжуулан санал авах;<br><br>27.5.Сонсох ажиллагаа явуулах хугацаа оролцогчийн тайлбар, санал гаргах боломжийг хангасан байна<br><br>27.7.Сонсох ажиллагааны үед гарсан саналыг захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд заавал тусгах үүрэг хүлээхгүй боловч тусгаагүй шалтгааныг тайлбарлах үүрэгтэй.<br><br>27.6.Сонсох ажиллагааны явц, үр дүнгийн талаар тэмдэглэл хөтөлж, гарсан саналыг захиргааны шийдвэрт хэрхэн тусгасан талаар мэдээлэл бэлтгэж баримтжуулна. |
| 7 | 28.1.Дараах тохиолдолд сонсох ажиллагаа хийхгүй байж болно:<br><br>28.1.1.нийтийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөр бол;<br><br>28.1.2.гарцаагүй байдлын улмаас, эсхүл нийтийн ашиг сонирхлын үүднээс хойшлуулшгүй ажиллагаа явуулах шаардлагатай бол;<br><br>28.1.3.иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, гомдлыг хангаж шийдвэрлэж байгаа тохиолдолд;<br><br>28.1.4.захиргааны шийдвэрийг техник хэрэгслийн тусламжтайгаар гаргаж байгаа бол;<br><br>28.1.5.захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж байгаа бол;<br><br>28.1.6.төр, байгууллага, хувь хүний нууцын тухай хууль тогтоомжоор хамгаалагдсан бусдад дамжуулах боломжгүй мэдээлэлд хамаарах бол.<br><br>28.2.Энэ хуулийн 28.1-д заасан сонсох ажиллагааг хийгээгүй шалтгаанаа захиргааны байгууллага нотлох үүрэгтэй |
| 8 | 29.1.Захиргааны байгууллагаас захиргааны шийдвэрийн хувийн хэргийг хөтлөх бөгөөд уг хувийн хэрэгт шийдвэр гаргах үйл ажиллагааны үндэслэл, үе шат, оролцогчийн санал, холбогдох баримт, сонсох ажиллагаа, уулзалт, хуралдааны тэмдэглэл, шийдэл, хүргүүлсэн, мэдэгдсэн баримт зэргийг бүрдүүлэн, архивт хадгална. |

pdfelement

| | |
|---|---|
| | 29.2.Захиргааны шийдвэр бүрд хяналтын дагалдах хуудас хавсаргах бөгөөд дагалдах хуудсанд захиргааны шийдвэр боловсруулахад оролцсон албан хаагч бүрийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, оролцоо, гүйцэтгэлийн тухай дэлгэрэнгүй тэмдэглэсэн байна. Дагалдах хуудсанд албан хаагчийн захиргааны шийдвэр боловсруулахад оролцсон оролцоо, гүйцэтгэлийг тэмдэглэсэн байна.<br><br>29.3.Энэ хуулийн 29.2-т заасан дагалдах хуудсыг албан хаагчид шагнал олгох, үр дүнгийн урамшуулал тооцох, сахилгын шийтгэл хүлээлгэх, эсхүл хөдөлмөрийн харилцааг дуусгавар болгоход харгалзана |
| 9 | Зөвлөгөө, мэдээлэл өгөх<br><br>31.1.Захиргааны байгууллага захиргааны шийдвэр гаргахтай холбоотой мэдээлэл өгөх үүрэгтэй.<br><br>31.2.Оролцогчоос гаргасан хүсэлт, тайлбар, мэдээлэл зэрэг нь захиргааны шийдвэр гаргах ажиллагааны явцад бүрэн бус, эсхүл буруу бичигдсэн байвал захиргааны байгууллага оролцогчид холбогдох зөвлөгөө өгөх үүрэгтэй. |
| 10 | 33-р зүйл |

### 1.3.Шалгуур үзүүлэлтийг тогтоох, томьёолох, харьцуулах хэлбэр

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтын 3.4-т заасан шалгуур үзүүлэлтээс үнэлэх зүйл, заалтын хэрэгжилтийг бодитоор илэрхийлж гаргаж чадах шалгуур үзүүлэлтийг энэ үе шатанд харгалзуулан сонгов.

Мөн үнэлгээ хийх зүйл, хэсэг бүр дээр тогтоосон шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамгийг дэвшүүлж, асуулт тавих замаар шалгуур үзүүлэлтийг томьёолох юм. Ийнхүү шалгуур үзүүлэлтийг томьёолсноор үнэлгээний дараагийн алхамууд нь томьёолсон шалгуур үзүүлтэд хариулт өгөхөд чиглэгдэнэ.

Үнэлгээ хийхэд хуулийн үр дагаврын үнэлгээний үндэс нь судалж буй зохицуулалтын талаарх ажиглагдаж буй болон хэмжиж болохуйц мэдээллийг цугуулж, түүний зарим үзүүлэлтийг хооронд нь харьцуулах явдал юм.

Эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг тогтоох ажиллагаа нь практик дээр тухайн хуулийн үйлчлэх хүрээ, тухайн салбарт гарсан хөгжил, өөрчлөлтийг болон бусад холбогдох мэдээллийг тогтоож, тэдгээрийг хооронд нь харьцуулах ажиллагаан дээр үндэслэнэ.

Хүснэгт 2

| д/д | Үнэлгээний хүрээ | Шалгуур үзүүлэлт | Шалгуур үзүүлэлтийн томьёолол | Харьцуулах хэлбэр |
|---|---|---|---|---|
| | 11.3.Хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд захиргааны байгууллага энэ хуулийн 11.1-д заасан үйл ажиллагааны хэлбэрээс сонгон хэрэглэнэ. | Зорилгодоо хүрсэн байдал | Онолын ойлголтыг ЗЕХ-д бүрэн, оновчтой тодорхойлж чадсан эсэх | Байх ёстой ба одоо байгаа түвшин |

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 11.4.Хуульд өөрөөр заагаагүй, энэ хуулийн 11.1-д заасан хэлбэрээс сонгож хэрэглэх боломжгүй тохиолдолд захиргааны байгууллага захиргааны үйл ажиллагааны өөр бусад хэлбэрийг өөрөө тогтооно. | Практикт хэрэгжиж байгаа байдал | Практикт хэрхэн хэрэгжиж байгаа вэ?<br><br>2.Хэрэгжүүлэх явцад саад учруулж байгаа шалтгаан байна уу? | Тодорхой тохиодолд судлах |
| 2 | 13.1.Захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд оролцогч /цаашид “оролцогч” гэх/ гэж захиргааны байгууллагад өргөдөл, хүсэлт гаргасан этгээд, захиргааны акт, захиргааны гэрээний эрх зүйн үйлчлэл шууд болон шууд бусаар чиглэсэн этгээд болон захиргааны байгууллагаас шийдвэр гаргах ажиллагаанд татан оролцуулсан этгээдийг ойлгоно.<br>13.2.Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн этгээд захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд гуравдагч этгээдээр оролцоно.<br>13.3.Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдийг түүний хүсэлтээр, эсхүл захиргааны байгууллага өөрийн санаачилгаар, оролцогчийн зөвшөөрснөөр шийдвэр гаргах ажиллагаанд татан оролцуулна.<br>13.4.Захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүн оролцох тохиолдолд дохио, зангаа, тусгай тэмдэгт ашиглан хэлмэрчийн тусламжтайгаар оролцоно. | Зорилгодоо хүрсэн байдал | 1.Оролцогчийн талаархи онолын ойлголтыг ЗЕХ-д бүрэн, оновчтой тодорхойлж чадсан эсэх<br><br>2. Шууд болон шууд бусаар чиглэсэн этгээд ба татан оролцуулсан этгээд гэж томьёолсон нь зөв эсэх. | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш |
| | | Хүлээн зөвшөөрөгдсөн байдал | 1.Иргэн, хуулийн этгээд ЗЕХ-д заасан захиргааны байгууллагын шийдвэр гаргах ажиллагаанд оролцож санал, хүсэлт, тайлбараа гаргах эрхтэй гэдгээ мэдэж байгаа эсэх;<br><br>2.Гуравдагч этгээдээр оролцож байгаа эсэх;<br><br>3.Ирээдүйд эрх ашиг нь хөндөгдөх асуудлаар шийдвэр гаргагч урьдчилан санал, тайлбар авч байгаа эсэх | |

pdfelement

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | Практикт хэрэглэгдэж байгаа байдал | 1.Захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд оролцогчдыг тодорхойлж өгснөөр ямар эерэг үр дүн гарч байгаа эсэх;<br><br>2.Шийдвэр гаргах ажиллагаанд иргэдийг оролцуулахад хүндрэл бэрхшээл байгаа эсэх;<br><br>3.Иргэд шийдвэр гаргах ажиллагаанд оролцоход бэрхшээл | |
| 3 | 24.1.Захиргааны байгууллага захиргааны шийдвэр гаргах<br><br>ажиллагаанд хамаарах бодит нөхцөл байдлыг тогтооно.<br><br>24.2.Энэ хуулийн 24.1-д заасан бодит нөхцөл байдлыг тогтооход ач холбогдол бүхий шаардлагатай ажиллагаа хийх, нотлох баримтыг цуглуулах, үнэлэх үүргийг захиргааны байгууллага хүлээнэ | Практикт хэрэглэгдэж байгаа байдал | 1.Захиргааны байгууллага, албан тушаалтан нотлох баримт цуглуулах, үнэлэх үүргийг хэрхэн биелүүлж буй өнөөгийн байдлыг судлах<br><br>2.Цугларсан нотлох баримтыг үнэлэхэд тусгай мэдлэг, ур чадвар шаардагдаж байгаа эсэх | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш<br><br>Тодорхой тохиолдол судлах |
| 4 | 25-р зүйл. Нотлох баримт цуглуулах<br><br>25.1.Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны нөхцөл байдлыг тогтооход шаардлагатай нотлох баримтыг захиргааны байгууллага дараах байдлаар цуглуулна: | Зорилгодоо хүрсэн байдал | 1. Бодит нөхцөл байдлыг тогтоох ач холбогдол бүхий нотлох баримтуудыг ЗЕХ -д бүрэн тусгаж өгсөн эсэх<br><br>2. Захиргааны байгууллагын цуглуулсан нотлох баримтыг шүүх маргаан | Тодорхой тохиолдол судлах |



pdfelement
Remove Watermark Now

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 25.1.1.ач холбогдол бүхий мэдээллийг цуглуулах;<br><br>25.1.2.оролцогчийг сонсох, тайлбар гаргуулах;<br><br>25.1.3.шинжээч оролцуулан дүгнэлт гаргуулах;<br><br>25.1.4.гэрч, гуравдагч этгээдээс тайлбар гаргуулах;<br><br>25.1.5.баримт бичиг болон хууль, бусад шийдвэртэй танилцах, хуулбарлах;<br><br>25.1.6.шаардлагатай бол туршилт хийх;<br><br>25.1.7.оролцогчийн хүсэлтээр зайлшгүй шаардлагатай нотлох баримтыг гаргуулан авах | | шийдвэрлэхдээ өөрийн цуглуулсан нотлох баримттай харьцуулж болох эсэх | |
| | | Хүлээн зөвшөөрөгдсөн байдал | Нөхцөл байдлыг тогтоох ажиллагаанд иргэдийн оролцоо хэрхэн хангагдаж байгаа эсэх | |
| | | Практикт хэрэглэгдэж байгаа байдал | 1.Ач холбогдол бүхий мэдээллийг бусад мэдээллээс хэрхэн зөв ялгаж, нотлох баримтын хэмжээнд үнэлж байгаа эсэх<br><br>2. Туршилт хийж буй хэлбэрийг зөв сонгож байгаа эсэх | |
| 5 | 26-р зүйл. Оролцогчийг сонсох<br><br>26.1.Захиргааны акт, захиргааны гэрээг батлан гаргахын өмнө эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдэд захиргааны шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар тайлбар, санал гаргах боломж олгоно.<br><br>26.2.Энэ хуулийн 26.1-д заасан оролцогчоос тайлбар, санал авах ажиллагааг сонсох ажиллагаа гэнэ. | Хүлээн зөвшөөрөгдсөн байдал | ЗЕХ-ийн уг заалт оролцогчийн эрхийг хамгаалсан заалт болсон эсэх | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш |
| | | Практикт хэрэглэгдэж байгаа байдал | Сонсох ажиллагааг зохион байгуулахад гарч буй бэрхшээл, хүндрэл | Тодорхой тохиолдол судлах |
| 6 | 27.3.Сонсох ажиллагааны талаарх мэдэгдэлд дараах мэдээллийг тусгана:<br><br>27.3.1.сонсох ажиллагааг явуулах журам, ажиллагаа явуулах он, сар, өдөр, цаг, байрлал, дараалын талаарх мэдээлэл; | | | Хууль хүчин төгөлдөр |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 27.3.2.захиргааны шийдвэр гаргах эрх олгогдсон хууль, захиргааны хэм хэмжээний актын зүйл, заалт;<br><br>27.3.3.захиргааны шийдвэр гаргах<br><br>тухайн асуудлын талаарх мэдээлэл, үндэслэл<br><br>27.4.Сонсох ажиллагааг дараах арга хэлбэрээр явуулна:<br><br>27.4.1.сонсгол зохион байгуулах;<br><br>27.4.2.саналыг бичгээр авах;<br><br>27.4.3.биечлэн уулзах;<br><br>27.4.4.утсаар санал авах;<br><br>27.4.5.цахим хэлбэрээр санал авах;<br><br>27.4.6.төлөөлөгчөөр дамжуулан санал авах;<br><br>27.5.Сонсох ажиллагаа явуулах хугацаа оролцогчийн тайлбар, санал гаргах боломжийг хангасан байна<br><br>27.7.Сонсох ажиллагааны үед гарсан саналыг захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд заавал тусгах үүрэг хүлээхгүй боловч тусгаагүй шалтгааныг тайлбарлах үүрэгтэй.<br><br>27.6.Сонсох ажиллагааны явц, үр дүнгийн талаар тэмдэглэл хөтөлж, гарсан саналыг захиргааны шийдвэрт хэрхэн тусгасан талаар мэдээлэл бэлтгэж баримтжуулна. | Практикт хэрэглэгдэж байгаа байдал | Сонсох ажиллагааны хэлбэрүүдийг хэрэглэж байгаа эсэх | үйлчилж эхэлснээс хойш<br><br>Тодорхой тохиолдол судлах |
| 7 | 28.1.Дараах тохиолдолд сонсох ажиллагаа хийхгүй байж болно: | Зорилгодоо хүрсэн байдал | 1.Сонсох ажиллагааг хийхгүй байх бүх тохиолдлыг ЗЕХ-д зааж өгсөн үү? | |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| | 28.1.1.нийтийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөр бол;<br><br>28.1.2.гарцаагүй байдлын улмаас, эсхүл нийтийн ашиг сонирхлын үүднээс хойшлуулшгүй ажиллагаа явуулах шаардлагатай бол;<br><br>28.1.3.иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, гомдлыг хангаж шийдвэрлэж байгаа тохиолдолд;<br><br>28.1.4.захиргааны шийдвэрийг техник хэрэгслийн тусламжтайгаар гаргаж байгаа бол;<br><br>28.1.5.захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж байгаа бол; | | 2. Уг хуульд байгаа тохиолдлыг тодорхойлж байгаа ойлголтууд сонсох ажиллагааг хийхгүй бодит нөхцөл болж байна уу?<br>3. нийтийн ашиг сонирхол, сөргөөр нөлөөлөх, нийтийн ашиг сонирхлын үүднээс, хойшуулшгүй ажиллагаа зэргийн агуулгыг ЗЕХ-д ойлгомжтой байдлаар зааж өгсөн үү? | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш<br><br>Тодорхой тохиолдол судлах |
| | 28.1.6.төр, байгууллага, хувь хүний нууцын тухай хууль тогтоомжоор хамгаалагдсан бусдад дамжуулах боломжгүй мэдээлэлд хамаарах бол.<br><br>28.2.Энэ хуулийн 28.1-д заасан сонсох ажиллагааг хийгээгүй шалтгаанаа захиргааны байгууллага нотлох үүрэгтэй | Практикт хэрэглэгдэж байгаа байдал | Сонсох ажиллагаа хийгээгүй шалтгаанаа ямар тохиолдол үүссэн, үүнийг ямар нотлох баримтаар тогтоодог талаар тайлбарладаг эсэхийг судлах | |
| 8 | 29.1.Захиргааны байгууллагаас захиргааны шийдвэрийн хувийн хэргийг хөтлөх бөгөөд уг хувийн хэрэгт шийдвэр гаргах үйл ажиллагааны үндэслэл, үе шат, оролцогчийн санал, холбогдох баримт, сонсох ажиллагаа, уулзалт, хуралдааны тэмдэглэл, шийдэл, хүргүүлсэн, мэдэгдсэн баримт зэргийг бүрдүүлэн, архивт хадгална.<br><br>29.2.Захиргааны шийдвэр бүрд хяналтын дагалдах хуудас хавсаргах бөгөөд дагалдах хуудсанд захиргааны шийдвэр боловсруулахад оролцсон | Зорилгодоо хүрсэн байдал | 1.Захиргааны байгууллагаас шийдвэрийн хувийн хэрэг бүрдүүлэх хэрэгцээ шаардлага заавал байх эсэх<br><br>2. Захиргааны шийдвэрийн хувийн хэрэг, дагалдах хуудас нь захиргааны байгууллагад хандсан өргөдөл, гомдол, мэдээлэлд нотлох баримт бүхий | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш<br><br>Тодорхой тохиолдол судлах |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| | албан хаагч бүрийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, оролцоо, гүйцэтгэлийн тухай дэлгэрэнгүй тэмдэглэсэн байна. Дагалдах хуудсанд албан хаагчийн захиргааны шийдвэр боловсруулахад оролцсон оролцоо, гүйцэтгэлийг тэмдэглэсэн байна.<br><br>29.3.Энэ хуулийн 29.2-т заасан дагалдах хуудсыг албан хаагчид шагнал олгох, үр дүнгийн урамшуулал тооцох, сахилгын шийтгэл хүлээлгэх, эсхүл хөдөлмөрийн харилцааг дуусгавар болгоход харгалзана | | мэдээлэл өгөх, шүүхэд тайлбар гаргах, өөрт нь ЗЕХ-ын 105-р зүйлд хүлээлгэсэн хариуцлага, 103-р зүйлд заасан хохирол барагдуулах, мөн урамшуулал авахад зориулагдсан зохицуулалт мөн эсэх<br><br>3.Захиргааны хувийн хэрэг бүрдүүлэхэд захирааны зардал өсөх эсэх | |
| | | Практикт хэрэглэгдэж байгаа байдал | Захиргааны хувийн хэргийн бүрдүүлэхэд тулгарч буй бэрхшээл, хүндрэл | |
| 9 | Зөвлөгөө, мэдээлэл өгөх<br><br>31.1.Захиргааны байгууллага захиргааны шийдвэр гаргахтай холбоотой мэдээлэл өгөх үүрэгтэй.<br><br>31.2.Оролцогчоос гаргасан хүсэлт, тайлбар, мэдээлэл зэрэг нь захиргааны шийдвэр гаргах ажиллагааны явцад бүрэн бус, эсхүл буруу бичигдсэн байвал захиргааны байгууллага оролцогчид холбогдох зөвлөгөө өгөх үүрэгтэй. | Хүлээн зөвшөөрөгдсөн байдал | Оролцогчийн эрх, ашиг сонирхлыг хангасан заалт болсон эсэх, практикт бодитой хэрэгжиж байгаа болон энэ боломжоо ашиглахад бэрхшээл, хүндрэл байгаа эсэх | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш |
| | | Практикт хэрэглэгдэж байгаа байдал | Захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд оролцож буй иргэнд ямар хэлбэр, хугацаанд зөвлөгөө өгөх, энэ нь хуульд заасан чиг үүрэгт нь хамааралтай эсэх, хүндрэл, | Тодорхой тохиолдол судлах |

pdfelement

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | бэрхшээл байгаа эсэх | |
| 10 | **33 дугаар зүйл.Хугацааг тодорхойлох** | Практикт хэрэглэгдэж байгаа байдал | Хугацааны зохицуулалт нь практикт бодитой хэрэгжих боломжтой эсэх | Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш |

**1.4 .Мэдээлэл цуглуулах аргыг сонгох**

- Санал асуулга

1.ЗЕХ-ийн 3 дугаар бүлгийн тухайд иргэдээс санал асуулга авахаар болсон. Эх олонлогийн хэмжээг харгалзан 95 хувийн итгэмжлэх интервалд, түүврийн алдаа 4 хувь байхаар тооцож, зохистой хэмжээг 500 байна гэж тогтоосон (www.surveymonkey.com) /Захиргааны ерөнхий хуулийн талаархи олон нийтийн санал асуулгын тайлангаас харна уу/.
2. Шүүгчид

pdfelement

- Чанарын буюу экспертийн болон бүлгийн ярилцлага

1.УИХ-аас байгууллагддаг захиргааны байгууллага, яам, нийслэлийн Засаг дарга, ИТХ, дүүргийн Засаг даргын Тамгын газар, нэг аймаг, нэг сумын захиргааны байгууллагын албан тушаалтан, төрийн албан хаагчдыг хамруулах,
2. Нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нар,
3. Захиргааны эрх зүйгээр мэргэшсэн судлаач багш, өмгөөлөгч нар,
4. Санамсаргүй түүврийн аргаар сонгосон иргэд

- Баримт бичгийн судалгаа

1.Сурах бичиг, судлаачдын бүтээл
2.Шүүхийн шийдвэрт шинжилгээ хийх
3.Захиргааны байгууллагын шийдвэрт шинжилгээ хийх

## ХОЁР.ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон мэдээлэл цуглуулах аргыг ашиглан 2018 оны 04 дүгээр сарын 01-ээс 05 дугаар сарын 01-ний өдрийн хооронд хэрэгжүүлэх үе шатыг хийж гүйцэтгэв.

- Санал асуулга

Remove Watermark Now

**Иргэд:**

*Түүвэрлэлт*

“Захиргааны ерөнхий хууль”-ийн хэрэгжилт, хуулийн талаарх иргэдийн мэдлэгийг тандах зорилготой "Олон нийтийн санал асуулга"-ын хувьд зөвхөн нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд авсан. Учир нь, хууль хэрэгжээд зөвхөн нэг жилийн гаруй болж байгаа, мөн засаг захиргааны төв байгууллагууд нийслэлд төвлөрсөн байдлыг харгалзан, түүврийг зөвхөн Улаанбаатар хотоос сонгохоор болсон. Судалгаанд түүврийн нэгжийг сонгохдоо нийслэлийн 9 дүүргээс тодорхой тооны нэгжийг сонгов.

**Зорилтот бүлэг:**

Нийслэлийн давж заалдах шатны шүүгчдээс анкетын судалгаа авахаар хандсан боловч нэг шүүгч нь санал асуулгыг бөглөсөн болно.

➢ Чанарын судалгаа буюу ярилцага

- Захиргааны байгууллага дээр очиж, холбогдох 50 албан тушаалтан, албан хаагчаас ярилцлага авсан.

Хүснэгт 6

| № | Байгууллага | Биелэлт |
|---|---|---|
| 1 | Нийслэлийн ИТХ | 4/16 |
| 2 | Нийслэлийн ЗДТГ | 4/16 |
| 3 | ЗГХЭГ | 4/19 |
| 4 | Монголбанк | 4/23 |
| 5 | УИХ-ын Тамгын газар | 4/23 |
| 6 | Санхүүгийн зохицуулах Хороо | 5/1 |
| 7 | Төрийн албаны Зөвлөл | 4/30 |
| 8 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | 4/27 |
| 9 | Эрүүл мэндийн яам | 5/4 |
| 10 | Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ | 5/11 |
| 11 | Орхон аймаг | 6/ |
| 12 | Булган аймгийн Тэшиг сум | 6/ |
| 13 | Дорнод аймаг | 4/10 |
| 14 | Дорноговь аймаг | 5/16 |

- Шүүгчдээс авсан бүлгийн ярилцлагыг нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 3 шүүгчээс авсан.
- 9 судлаачдаас ярилцлага авсан.
- ЗЕХ-ийн сургагч багш нараас бүлгийн ярилцлага авсан.

pdfelement

Remove Watermark Now

- 20 иргэнээс ярилцлага авсан.

  - Баримт бичгийн судалгаа

- Шүүхийн 61 шийдвэрт шинжилгээ хийсэн.
- Захиргааны байгууллагын 30 шийдвэрт шинжилгээ хийсэн.
- Сурах бичиг 1, 1 онолын тайлбар, 2 гарын авлага, эрдэм шинижлгээний 10 өгүүлэлд шинжилгээ хийсэн.

## ГУРАВ.ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Төлөвлөх үе шатанд Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар бүлгээс сонгож авсан үнэлэгдэх зүйл, хэсэг, заалт тус бүрийг хэрэгжүүлэх үе шатанд олж авсан мэдээлэл дээр тулгуурлан үнэлэх болно.

### 3.1. ЗЕХ-ийн 11-р зүйл

*Хүснэгт 7. Шалгуур үзүүлэлт 1*

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 11.3.Хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд захиргааны байгууллага энэ хуулийн 11.1-д заасан үйл ажиллагааны хэлбэрээс сонгон хэрэглэнэ.<br>11.4.Хуульд өөрөөр заагаагүй, энэ хуулийн 11.1-д заасан хэлбэрээс сонгож хэрэглэх боломжгүй тохиолдолд захиргааны байгууллага захиргааны үйл ажиллагааны өөр бусад хэлбэрийг өөрөө тогтооно. |
| **Зорилгодоо хүрсэн байдал** | онолын ойлголтыг ЗЕХ-д бүрэн, оновчтой тодорхойлж чадсан эсэх |

pdfelement

**Үнэлгээ :**

- Бүлгийн ярилцлага:

Судалгаанд хамрагдсан 14 захиргааны байгууллагын 50 албан хаагчдаас бүлгийн ярилцлага авахад 11.3-д зааснаар захиргааны акт, захиргааны хэмжээний актын талаар зохих мэдлэгтэй байв. Харин захиргааны гэрээний талаар ойлголтгүй, иргэний гэрээнээс ямар ялгаатай талаар сайн мэдэхгүй байна гэж хэлж байв. Жишээлбэл:

Төрийн албан хаагч 1:

Захиргааны актаар голдуу шийдвэрээ гаргадаг. Захиргааны гэрээг байгуулаад явж байна. Захиргааны гэрээг иргэдтэй байгуулж байгаа гэрээ гэж ойлгож байна. Үүнд ажил гүйцэтгэх, үр дүнгийн гэрээ зэрэг болно. Гэхдээ иргэний хуулиа барьж байгаа, ЗЕХ-ийн заалтыг гэрээний үндэслэх хэсэгт заахгүй байгаа.

Төрийн албан хаагч 2:

Захиргааны ерөнхий хуульд заасан захиргааны үйл ажиллагааны хэлбэрүүдийг хэрэглэж байна. Үүнээс өөр хэлбэр хэрэглээгүй. Гэхдээ захиргааны гэрээтэй холбоотой зохицуулалтыг тодорхой болгох шаардлагатай. Иргэний эрх зүйн гэрээнээс ялгагдах онцлог нь юу болох, Захиргааны ерөнхий хуульд заснаас гадна ямар төрлийн гэрээ захиргааны гэрээнд хамаарч байгаа, захиргааны гэрээ байгуулах үе шат, процессын онцлог юм болох гэх мэт зүйлийг тодорхой болгохгүй бол захиргааны байгууллагаас байгуулж буй гэрээг ялгаж тодорхойлоход хүндрэлтэй байна.

Remove Watermark Now

Мөн 11.4 –д заасан бусад хэлбэрийг өөрөө тогтооно гэдгийн талаар сайн ойлгохгүй байна. Тухайлбал, 11.1-д заасан хэлбэрүүдээс өөр захиргааны үйл ажиллагааны ямар хэлбэр байхыг мэдэхгүй байгаа тул энэ талаар бүх албан хаагчид тайлбарлаж өгөхийг судалгаа авч буй багийнханд хандаж байв.

Төрийн албан хаагч:

***ЗЕХ-д заасан 3 хэлбэрийг хэрэглэх боломжгүй нөхцөл байдал бий болж байсан уу? Хэрэв тийм бол захиргааны үйл ажиллагааны ямар хэлбэрийг тогтоож байсан бэ?***

Тодорхой асуудлыг шийдвэрлэх бүрэн эрх хуулиар олгогдоогүй гэсэн үндэслэлээр л хуульд заасан хэлбэрийг хэрэглэх боломжгүй нөхцөл байдал үүсэж байсан.

Төрийн албан хаагч:

ЗЕХ-ийн 11.4-ийг огт хэрэглэж байгаагүй юм байна. Ийм заалт байсныг саяхан л мэдлээ. Хуульд зааснаас өөр хувилбарыг хэрэглэнэ гэвэл эргээд хууль зөрчсөн гэж буруудах юм биш үү. Энэ заалтын томъёолол, агуулга нь хуульдаа хэр зэрэг нийцэж байгаа юм бэ ?

- Онолын судалгаа:

Энэ судалгааг хийхэд 1 сурах бичиг, 1 онолын тайлбар, 2 гарын авлага, эрдэм шинижлгээний 10 өгүүлэлд шинжилгээ хийснээс дараах хоёр тайлбар байна.

Захиргааны үйл ажиллагааны ийм хэлбэрийг хэлбэржээгүй захиргааны үйл ажиллагаа гэсэн ангилалд хамааруулдаг (Ханнс-Зайделийн сан, “Эрх зүйн боловсрол” академиас эрхлэн гаргасан Монгол Улсын Захиргааны Ерөнхий хуулийн судалгаа, хэрэглээний тайлбар, 2017).

Сүүлийн үед захиргааны үйл ажиллагааны хэлбэржсэн ба хэлбэржээгүй гэсэн ангилал шинээр гарч ирж байгаа ба хэлбэржээгүй гэдэгт эрх зүйн хэм хэмжээнд тусгалаа олоогүй шинэ тутам үйл ажиллагааны хэлбэрүүд орно. Эдгээр үйл ажиллагааны хэлбэрүүд нь ихэвчлэн захиргаа бусад субъекттэй хамтран ажиллах явцад илэрч гардаг (П.Одгэрэл. Захиргааны эрх зүйн ерөнхий анги.2016).

*Хүснэгт 8. Шалгуур үзүүлэлт 2*

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 11.3.Хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд захиргааны байгууллага энэ хуулийн 11.1-д заасан үйл ажиллагааны хэлбэрээс сонгон хэрэглэнэ.<br>11.4.Хуульд өөрөөр заагаагүй, энэ хуулийн 11.1-д заасан хэлбэрээс сонгож хэрэглэх боломжгүй тохиолдолд захиргааны байгууллага захиргааны үйл ажиллагааны өөр бусад хэлбэрийг өөрөө тогтооно. |
| **Практикт хэрэгжиж байгаа байдал** | Хэрэгжүүлэх явцад саад учруулж байгаа шалтгаан байна уу? |

**Үнэлгээ:**

Судалгаанд хамрагдсан нийт 14 байгууллагаас УИХ-аас байгууллагддаг 3 байгууллага, нийслэлийн ИТХ-ын хувьд захиргааны хэм хэмжээний актыг, бусад байгууллагууд бол захиргааны актыг голчлон гаргадаг байна. Харин захиргааны гэрээний хэлбэрээр захиргааны шийдвэр гаргах нь цөөн байна. (шалтгааныг нь өмнө нь дурдсан).

➢ Тоон баримтад хийсэн шинжилгээ :

Судалгаанд хамрагдсан захиргааны байгууллагуудаас захиргааны үйл ажиллагааны хэлбэрийн талаар нэгтгэсэн тоон мэдээлэл өгөх хүсэлт тавихад Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас хариу өгсөн.

Хүснэгт 9. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас гаргасан шийдвэр

| № | Үзүүлэлт | Тоо | Товч агуулга |
|---|---|---|---|
| 1 | Захиргааны акт, захиргааны гэрээний эрх зүйн үйлчлэл шууд чиглэсэн этгээдүүдэд хандсан шийдвэрийн тоо | Захиргааны акт 719, Захиргааны гэрээ 5 | **Захиргааны акт 719**<br>Захиргааны ерөнхий хууль хүчин төгөлдөр үйлчилсэн 2016.07.01-ний өдрөөс 2018.04.01-ний өдрийн байдлаар захиргааны актын үйлчлэл шууд чиглэсэн этгээдүүдэд хандсан нийт 719 шийдвэр батлагдсанаас үйл ажиллагаатай холбоотой А захирамж 276, хүний нөөцтэй холбоотой Б захирамж 443 батлагдсан байна.<br>**Захиргааны гэрээ 5**<br>Нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газраас 2017.01.01-ээс хойш нийт 329 гэрээ, санамж бичиг байгуулснаас Жагсаал цуглаан зохион байгуулахыг бүртгэх 5 гэрээг захиргааны гэрээнд хамааруулж үзэж болох юм. |

Харин 11.4 заалтыг огт хэрэглэж байгаагүй гэсэн хариултыг ярилцлагад оролцсон захиргааны байгууллагууд өгсөн.

**Дүгнэлт :**

1. Захиргааны байгууллага нь ЗЕХ-ийн 11.3 заасан захиргааны үйл ажиллагааны хэлбэрүүдээс захиргааны актыг голчлон хэрэглэж байна. Захиргааны гэрээний талаархи мэдлэг тааруу байгаагаас шалтгаалан хэрэглээ хангалтгүй байна.
Зорилгодоо хүрсэн байдлын шалгуур үзүүлэлтийг практикт хэрэгжиж буй байдлын шалгуур үзүүлэлттэй харьцуулахад захиргааны актын хэрэглээг голчлон хэрэглэж байгаа ч сонгоно гэж заасан тул энэ заалтын хэрэгжилт хангалтай гэж дүгнэлээ.

2. ЗЕХ-ийн 11.4 дэх заалтыг судалгаанд хамрагдсан захиргааны байгууллагууд хэрэглээгүй байна. Захиргааны байгууллагууд шалтгаанаа хуулийн заалтын агуулгыг

ойлгохгүй, үйл ажиллагааны өөр ямар хэлбэр байх талаар тодорхой жишээг хэлж мэдэхгүй гэжээ.

Зорилгодоо хүрсэн байдлын шалгуур үзүүлэлтийг практикт хэрэгжиж буй байдлын шалгуур үзүүлэлттэй харьцуулахад ЗЕХ-ийн 11.4 дэх заалт хэрэгждэггүй гэсэн дүгнэлтэнд хүрлээ.

### 3.2. ЗЕХ-ийн 13.1 зүйл

*Хүснэгт 10. Шалгуур үзүүлэлт 1*

| **Үнэлэгдэх хэсэг** | 13.1.Захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд оролцогч /цаашид “оролцогч” гэх/ гэж захиргааны байгууллагад өргөдөл, хүсэлт гаргасан этгээд, захиргааны акт, захиргааны гэрээний эрх зүйн үйлчлэл шууд болон шууд бусаар чиглэсэн этгээд болон захиргааны байгууллагаас шийдвэр гаргах ажиллагаанд татан оролцуулсан этгээдийг ойлгоно. |
|---|---|
| Зорилгод хүрсэн байдал | 1.Оролцогчийн талаархи онолын ойлголтыг ЗЕХ-д бүрэн, оновчтой тодорхойлж чадсан эсэх<br><br>2. Шууд болон шууд бусаар чиглэсэн этгээд ба татан оролцуулсан этгээд гэж томьёолсон |

**Үнэлгээ:**

- Онолын судалгаа

Энэ заалтын талаар холбогдох сурах бичиг, бүтээлүүдэд хэрхэн тодорхойлсон талаар түүвэр хийхэд Ханнс-Зайделийн сангаас гаргасан “Монгол улсын Захиргааны Ерөнхий хуулийн тайлбар”-т дараах байдлаар авч үзсэн байна:

“Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны хүрээнд эрх эдэлж, үүрэг хүлээн оролцож байгаа этгээдийг оролцогч гэнэ. Хүн, хуулийн этгээдийг захиргааны акт гаргах, захиргааны гэрээ байгуулахад оролцох байдлаар Захиргааны ерөнхий хуульд /цаашид ЗЕХ гэх/ 4 ангилж оруулсан. Үүнд:

-Захиргааны байгууллагад өргөдөл, хүсэлт гаргасан этгээд буюу хүн, хуулийн этгээдийг хэлнэ.

-Захиргааны акт, захиргааны гэрээний эрх зүйн чиглэл шууд чиглэсэн этгээд- захиргаанаас ямар нэгэн үйлдэл хийхийг зөвшөөрсөн, хориглосон, даалгасан, үүрэг хүлээсэн болон уг шийдвэрийн улмаас эрх ,хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн этгээдийг шийдвэрийн эрх зүйн үйлчлэл шууд чиглэсэн этгээд гэж ойлгоно.

- шууд бусаар чиглэсэн этгээд гэдэгт захиргааны аливаа зөвшөөрсөн, хориглосон, даалгасан зэрэг шийдвэр үйлчилж эхэлсний дараа , эсхүл хэрэгжих явцад, хэрэгжилт дуусгавар болсны дараа хуулиар хамгаалагдсан эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй хүн, хуулийн этгээдийг ойлгоно.

-татан оролцуулсан этгээд- өргөдөл гаргаагүй, шийдвэрийн үйлчлэлд шууд ба шууд бусаар чиглэгдээгүй ч гэсэн эрх, ашиг сонирхол нь хөндөгдөх хүн, хуулийн этгээдийг өөрийн хүсэлтээр болон захиргааны байгууллага санаачилгаараа шийдвэр гаргах ажиллагаанд татан оролцуулж болно (Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар /судалгаа, хэрэглээний/ 2017)”.

Remove Watermark Now

- Ярилцлага :

Чанарын судалгааг захиргааны эрх зүйгээр мэргэшсэн экспертүүдийг оролцуулж ярилцлага авсан. Экспертэд: захиргааны эрх зүйн судлаач -багш 3, захиргааны эрх зүйн судлаач- өмгөөлөгч 2, захиргааны чиглэлээр дагнан өмгөөлөл хийдэг -3, бусад өмгөөлөгч- 2, нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн 3 шүүгч байна.

Асуулт: Шууд болон шууд бусаар чиглэсэн  этгээд ба татан оролцуулсан этгээдэд хэнийг багтаах вэ? ингэж томьёолсон нь ойлгомжтой байна уу?

Судлаач 1:

Шууд – өргөдөл, хүсэлт гаргагч, хаяглагдсан этгээд, захиргааны гэрээ байгуулах болон байгуулахаар төлөвлөж буй этгээд, шийдвэр гаргах үндэслэл болсон өргөдөл, хүсэлтийн шийдвэрлэснээр сөрөг үр дагавар өртөх этгээд (эрх, үүрэг шууд үүсч, өөрчлөгдөж, дуусгавар болж буй этгээд)

Шууд бус – гуравдагч этгээд, шийдвэр гаргах ажиллагааны үр дүнд гарах захиргааны акт, байгуулах гэрээ эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь нөлөөлөх этгээдүүд

Харьцангуй ойлгомжтой гэж үзэж байна. Гэвч хууль зүйн нарийвчилсан томьёолол, тодорхой журам байхгүй тул зарим төрийн байгууллагууд болон иргэд, хуулийн этгээдүүдийн хувьд захиргааны шийдвэр ажиллагааны оролцогч, түүний эрхийн талаар ойлголт дутмаг байх магадлалтай байна. Иймд зарим орнуудын (Латви, Армен гэх мэт) захиргааны процессын хуулиудад тодорхойлсонтой адил уг ойлголтод ямар субьектууд хамаарахыг тайлбарлан тусгах (аутентик тайлбарыг ашиглаж болох) шаардлагатай байж болох юм.

Судлаач 2:

шууд - захиргааны актын үйлчлэл шууд чиглэсэн этгээд гэдэгт хаяглагдсан этгээд буюу хэн /аль байгууллага/-д холбогдож гарч байна, тэр этгээдийг хэлнэ. Гэрээний хувьд оролцогч этгээд.

шууд бус -Үйлчлэлийн үр дагавар дам байдлаар тусахыг хэлнэ. Жишээ нь: иргэн Б-д орон сууцны зориулалтаар газар эзэмшүүлсэн захирамж байна. Учир нь орон сууц бариад эхлэхээр бусдын эрхийг хөндөөд эхэлнэ.

Томъёоллын хувьд шууд ойлгогдоно.

pdfelement

Судлаач 3:

Хуульд заасан томъёолол шууд ойлгогдохоор биш байгаа ч судлаачийн зүгээс үзэхэд шууд чиглэсэн гэдэг нь тухайн захиргааны шийдвэрийн хаяглагдсан этгээд, харин шууд бусаар чиглэсэн этгээд гэж шийдвэр хаяглагдсан этгээдээс бусад уг шийдвэрийн үйлчлэлд өртөж болзошгүй этгээд гэж ойлгогдож байна.

Судлаач 4:

шууд – Захиргааны акт, захиргааны гэрээний эрх зүйн үйлчлэлд эрх ашиг нь шууд хөндөгдөж, түүнийгээ хамгаалах гэж өргөдөл, хүсэлт гаргаж байгаа иргэн, хуулийн этгээд.

шууд бус – Захиргааны акт, захиргааны гэрээний эрх зүйн үйлчлэлд эрх ашиг нь шууд бусаар, өөрөөр хэлбэл дам дамаар хөндөгдөж, түүнийгээ хамгаалах гэж өргөдөл, хүсэлт гаргаж байгаа иргэн, хуулийн тэгээд.

Оновчтой ойлгогдож байгаа. Хэтэрхий явцууруулах аваас эрх ашиг нь хөндөгдсөн этгээдүүдийн эрх зөрчигдөх нигуууртай ажгуу.

Судлаач 5:

шууд – Захиргааны акт, гэрээний үйлчлэл шууд чиглэж байгаа буюу тухайн захиргааны актын улмаас тухайн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол шууд хөндөгдөж буй

Remove Watermark Now

этгээд, тухайн этгээдэд өөрт нь хамааралтай. Газар эзэмших эрх хүчингүй болгож буй захирамжийн тухайд тухайн газрыг эзэмшиж буй этгээд
шууд бус - Захиргааны акт, гэрээний үйлчлэл шууд бусаар чиглэж байгаа буюу тухайн захиргааны актын улмаас тухайн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол шууд бусаар хөндөгдөж буй этгээд хамааралтай. Тухайлбал, барилгын зөвшөөрөл олгоход тухайн барилга барих газрын зэргэлдээ газар эзэмшигч этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөж болзошгүй.
Томъёоллын хувьд ойлгомжтой байна.

Судлаач 6:

шууд -Акт, Гэрээний үйлчлэл нь шууд чиглэсэн буюу Акт, Гэрээнд нэрлэн заасанаар шууд эрх үүрэгтэй болж байгаа бий болгож байгаа этгээд
шууд бус -Акт, Гэрээний үйлчлэл нь шууд бусаар чиглэсэн буюу Акт, Гэрээнд нэрлэн заагаагүй боловч эрх, үүрэг, ашиг сонирхолд нь нөлөөлөж байгаа бүх этгээд. Үүнд тухайлбал Шийдвэрийн улмаас эрх, ашиг сонирхол нь зөрчигдөж байгаа Гуравдагч этгээд, эсхүл эрх, ашиг сонирхол нь зөрчигдөөгүй боловч эрх, үүрэг үүсэж болох бусад этгээд орно.
Энэ нь Оролцогч гэдэг нэр томъёоны үйлчлэлийг аль болох өргөн болгож, шууд бус байдлаар акт, гэрээний харилцаанд шууд бусаар оролцох, эрх, үүрэг үүсэж байгаа этгээд ч Оролцогчийн эрхтэй байх боломжийг олгох зорилготой зохицуулалт гэж ойлгож байна.
Жишээ нь: Захиргааны гэрээний улмаас Төртэй биш, харин Төрийн бус байгууллагатай харилцаж эрх үүргээ хэрэгжүүлэхээр болж байгаа хувь хүн, Төрийн бус байгууллагад тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргаж хянуулах болсон хувь хүнийг Шууд бусаар чиглэсэн оролцогч гэдэгт хамруулж болох байх.
Ойлгомжтой гэж үзэж байгаа боловч Хангалттай тодорхой биш байна. Учир нь оролцогч нь ихэнх тохиолдолд ямар эрхтэйгээ мэдэхгүй жирийн иргэд байдаг.
Жишээ тусгах, тоочих аргаар илүү тодорхой болгож өгөхгүй бол Төрийн албан хаагчийн үзэмжээс хамаарч оролцогчийн эрхээ хэрэгжүүлэхэд хүндрэл учирна.

Судлаач 7

шууд – иргэн, хуулийн этгээд буюу захиргааны үйл ажиллагаа чиглэж буй хэн ч байж болно.
шууд бус – 2догч нөхцөлтэй буюу шууд чиглэж буй этгээдэд аливаа захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрийн улмаас шууд бусаар чиглэж буй хэн ч байж болох этгээд.
Томъёоллын хувьд оновчтой

Судлаач 8

шууд – иргэн, компани, нөхөрлөл, ТББ гэх мэт?
шууд бус - мэдэхгүй байна.
“Этгээд” гэдэг үг тохиромж муутай л юм. Ихэнх тохиолдолд хувь хүнийг төлөөлүүлж хэрэглэгддэг үг. Хуулийн этгээд гэдэгч байна. Гэвч төрийн бус байгууллагыг оролцогч байж болох ч этгээд гэдэг үгээр илэрхийлэх нь оновчгүй санагдаж байна.

❖ Бусад 1 судлаачийн хувьд огт ойлгомжгүй байна гэж санал өгчээ.

Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн 3 шүүгчээс ярилцлага авсан.

Шүүгч :

Оролцогч гэж захиргааны акт, гэрээ шууд болон шууд бусаар нөлөөлөх этгээдийг хэлнэ гэж заасан. Захиргааны процессын хуульд захиргааны хууль бус акт болон хэм хэмжээний актын улмаас эрх нь зөрчигдсөн болон зөрчигдөж болзошгүй этгээд заасан байгаа. Харин ЗЕХ-д нийтийн эрх ашгийг хамгаалж төлөөлөх ТББ гэж орсон. Үүнтэй холбоотой шууд бус гэсэн ойлголт гарна. Өөрөөр хэлбэл, өөрт нь шууд хамааралтай

Remove Watermark Now

биш, гэхдээ энэ чиглэлээр чиг үүрэг хэрэгжүүлдэг ТББ оролцогч болоод байна. Тэгэхээр оролцогчдын хувьд ойлгомжгүй зүйл байхгүй гэж үзэж байна.

Асуулт: Шийдвэр гаргах ажиллагаандаа татан оролцуулсан этгээдэд хэн орох вэ?

Судлаач 1:

Агуулгын хувьд акт чиглээгүй боловч эрх, хууль ёсны ашиг сонирхол нь акт гэрээний улмаас хөндөгдөж болзошгүй байгаа этгээдүүдийг ойлгож болохоор байна. Гэхдээ урьдчилсан нөхцөл нь захиргааны байгууллагаас татан оролцуулснаар оролцогчийн эрхийг эдлэхээр байна. Нөгөө талаар татан оролцуулсан этгээд нь захиргааны актын үйлчлэл шууд бусаар чиглэсэн этгээдтэй төстэй бөгөөд хэрэв шууд бусаар чиглэсэн болох нь тодорхой байвал шийдвэр гаргах ажиллагаанд өөрийн хүсэлтээр оролцож байгаа эсэхээс үл хамааран захиргааны байгууллага уг этгээдийг заавал татан оролцуулах үүрэгтэй байна.

Мөн энэ хэсэгт тодорхой этгээдийн ашиг сонирхлыг хамгаалах үүрэг бүхий байгууллага, албан тушаалтнуудыг оруулж болох юм. Тухайлбал, асран халамжлагч, харгалзан дэмжигчгүй хүүхдийн талаар шийдвэр гаргах үед харьяа засаг захиргааны нэгжийн Засаг дарга, нийгмийн ажилтан гэх мэт үүрэг хүлээсэн этгээдүүдийг оролцуулах. Түүнчлэн гэрч, шинжээч, орчуулагч гэх мэт субьектууд орох эсэх тодорхойгүй.

Хуульд заасан томъёолол оновчтой, ойлгогдохоор байна уу?

Уг томьёололд дараах эргэлзээ төлүүлж болохоор байна.

1. Татан оролцуулах этгээдүүдийн хувьд заавал эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх, хөндөгдөж болзошгүй байх нөхцөлийг шаардах нь оновчтой юу? Тухайлбал, чиг үүргээ хэрэгжүүлэн оролцох нийтийн албан хаагч, олон нийтийн болон ТББ оролцуулах шаардлагатай тохиолдол байж болох.
2. Оролцуулах процедур 1) өөрийн хүсэлт байгаа бол оролцуулна 2) харин захиргааны байгууллага өөрийн санаачлагаар оролцуулахаар бол оролцогч (тухайн этгээд үү эсхүл бусад оролцогч мөн орох уу)-ийн зөвшөөрөл заавал байх уу?

Энэхүү тохиолдолд эрх хууль ёсны ашиг сонирхол хөндөж болзошгүй этгээдээс гадна хуулиар тухайн акт чиглэсэн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиг үүрэгтэй этгээдүүдийг мөн оролцуулах агуулга нэмж тусгах боломжтой эсэх, тэр тохиолдолд оролцогчийн зөвшөөрлийн үл харгалзан оролцуулахаар зохицуулж болох юм.

Судлаач 2:

Хуульд заасан томъёолол оновчтой, ойлгогдохоор байна. Захиргааны байгууллагын шийдвэр гаргах ажилагаанд шийдвэр шууд болон шууд бусаар чиглэсэн этгээдээс гадна, захиргааны байгууллагад өөрт нь уг ажиллагаанд татан оролцуулах этгээдийг өөрөө тодорхойлж, сонгох боломжийг олгож байгаагаараа оновчтой зохицуулалт болсон гэж үзэж байна.

Судлаач 3:

Захиргааны шийдвэр дангаараа шууд гаргадаггүй, харин гаргасан шийдвэрийг баталгаажуулдаг, бүртгэдэг байгууллагууд байж болох байх. Яг энэ хэсэг дээр бүрхэг байна.

Судлаач 4:

Ойлгомжтой, түүнчлэн Шалгуур нь тодорхой байна.

Гэхдээ өмнө дурьдсан акт, гэрээий үйлчлэл шууд болон шууд бусаар чиглэсэн этгээд гэдэгтэйгээ агуулгын хувьд давхцаж болно гэдгийг энэ тодорхойлолт нь харуулаагүй байна. Өөрөөр хэлбэл ...болон/**буюу**...гэдэг холбоосоор холбох нь зүйтэй байх.

Судлаач 5:

Иргэн, компани, нөхөрлөл, ТББ орно.

Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн этгээдийн заавал оролцуулах үүргийг захиргаанд өгөх. Заавал оролцуулах ёстой гэж ойлгогдохгүй байна. Оролцох хүсэлт гаргасан бол заавал оролцуулах. Оролцоо ямар хэлбэртэй байхыг нэмж зохицуулах.

❖ Бусад 4 судлаачийн хувьд 1 судлаач огт ойлгомжгүй байна гэж санал өгсөн бол 3 нь ойлгомжтой тодорхой байна гээд нэмэлт тайлбар хийгээгүй болно.

Шүүгч:

Татан оролцуулсан этгээд гэдгийг захиргааны байгууллага өөрөө ойлгож хэрэгжүүлэх ёстой. Захиргааны байгууллага тодорхойлох ёстой. Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий ТББ-д хуулийн шаардлага байгаа. Гэтэл энэ шаардлага хангаагүй ТББ-ыг татан оролцуулахаар оролцогч мөн үү? гэдэг асуудал гарна. Жишээ нь, Туул голын эрэг хавийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох тухай шийдвэр гаргалаа гэж үзье. Үүнд Туул голыг хамгаалах холбоог татан оролцууллаа гэж бодье. Ингээд нөгөө ТББ-ыг Нийслэлийн засаг дарга дээр сонсох ажиллагаанд оролцуулсан байдаг. Тэгээд татан оролцуулсан этгээд бид нар нэхэмжлэл гаргана гэдэг асуудал гарна.

➢ Санал асуулга

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчдээс судалгаа авахаар анкет тараасан боловч нэг шүүгч саналаа өгсөн байна.

Шүүгч:

Хуульд заасан томъёолол оновчтой байна.

*Хүснэгт 11. Шалгуур үзүүлэлт 2*

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 13.2.Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн этгээд захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд гуравдагч этгээдээр оролцоно.<br>13.3.Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдийг түүний хүсэлтээр, эсхүл захиргааны байгууллага өөрийн санаачилгаар, оролцогчийн зөвшөөрснөөр шийдвэр гаргах ажиллагаанд татан оролцуулна. |
| **Хүлээн зөвшөөрөгдсөн байдал** | 1.Иргэн, хуулийн этгээд ЗЕХ-д заасан захиргааны байгууллагын шийдвэр гаргах ажиллагаанд оролцож санал, хүсэлт, тайлбараа гаргах эрхтэй гэдгээ мэдэж байгаа эсэх;<br><br>2.Гуравдагч этгээдээр оролцож байгаа эсэх;<br><br>3.Ирээдүйд эрх ашиг нь хөндөгдөх асуудлаар шийдвэр гаргагч урьдчилан санал, тайлбар авч байгаа эсэх |



Remove Watermark Now

Remove Watermark Now

**Үнэлгээ:**

- Иргэдээс захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд хэр оролцож байгаа талаар санал асуулгын аргаар судалгаа авсан /Захиргааны ерөнхий хуулийн талаархи олон нийтийн санал асуулгын тайлангаас харна уу/.

- Тоон баримтад хийсэн шинжилгээ :

Хүснэгт 12. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар

| | | | |
|---|---|---|---|
| 1 | Захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд захиргааны акт, гэрээний эрх зүйн үйлчлэл шууд бусаар чиглэсэн этгээдүүдэд хандсан шийдвэрийн тоо | | Нийслэлийн Засаг даргын гаргаж буй захиргааны акт нь ихэвчлэн нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд гаргадаг тул тодорхойлоход хүндрэлтэй. |
| 2 | Шийдвэр гаргах ажиллагаандаа татан оролцуулсан этгээдийн тоо | | Нийслэлийн Засаг даргын гаргаж буй захиргааны акт нь ихэвчлэн нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд гаргадаг тул тодорхойлоход хүндрэлтэй. |
| 3 | Гуравдагч этгээдийн тоо | | Нийслэлийн Засаг даргын гаргаж буй захиргааны акт нь ихэвчлэн нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд гаргадаг тул тодорхойлоход хүндрэлтэй. Захиргааны акттай холбоотой эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй этгээдийг тодорхойлох боломжгүй байна. |

pdfelement

*Хүснэгт 13. Шалгуур үзүүлэлт 3*

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 13.1.Захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд оролцогч /цаашид “оролцогч” гэх/ гэж захиргааны байгууллагад өргөдөл, хүсэлт гаргасан этгээд, захиргааны акт, захиргааны гэрээний эрх зүйн үйлчлэл шууд болон шууд бусаар чиглэсэн этгээд болон захиргааны байгууллагаас шийдвэр гаргах ажиллагаанд татан оролцуулсан этгээдийг ойлгоно. |
| **Практикт хэрэглэгдэж байгаа байдал** | 1.Захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд оролцогчдыг тодорхойлж өгснөөр ямар эерэг үр дүн гарч байгаа эсэх;<br><br>2.Шийдвэр гаргах ажиллагаанд иргэдийг оролцуулахад хүндрэл бэрхшээл байгаа эсэх;<br><br>3.Иргэд шийдвэр гаргах ажиллагаанд оролцоход бэрхшээл |

**Үнэлгээ:**

Remove Watermark Now

- Ярилцлага

Судалгаанд хамрагдсан  500 иргэдээс санамсаргүй түүврийн аргаар 20 хүнийг сонгож, шийдвэр гаргах ажиллагаанд оролцоход ямар бэрхшээл байгаа талаар ярилцлага авсан. Тэдний саналыг багцалж, нэгдсэн үнэлгээ хийлээ.

Захиргааны байгууллагын аливаа шийдвэр гаргах ажиллагаанд оролцох ёстой гэдгээ сайн мэддэггүй. Харин бидний эрхийг хангаж өгсөн хууль гарсан сайшаалтай байна. Хуульд заасан байгаа шууд ба шууд бус, мөн татан оролцуулсан этгээд гэж заасныг ойлгохгүй байна. Иргэдэд хамаатай хууль юм бол яагаад иргэдэд ойлгомжтой энгийн байдлаар хуульдаа зааж өгч болдоггүй юм бэ? Ер нь шийдвэр гаргах ажиллагаанд оролцох эрхийг хангах талаар санаачилга гаргахдаа төрийн ихэнхи байгууллагууд хангалтгүй ажилладаг. Гэхдээ сүүлийн үед цахим хаяг болон хэрэглэгчийн санал бодлыг сонсох аяныг зохион байгуулж эхэлж байна. Харин  энэ ажиллагаагаа тогтмол болгох, мэдээллээ байнга нийтэд сонсгож байх нь чухал юм. Ялангуа төсөв хөрөнгөтэй асуудлаар иргэдийн саналыг авч байх, тэдний шийдвэрт үндэслэдэг байх тал дээр учир дутагдалтай байна. Мөн иргэд төрийн байгууллагын үйл ажиллагааны болон бусад асуудлаар мэдээлэл өгөхийг хүсэхэд байгууллагын нууц гэдгээр өгөхөөс татгалзах, хүсэлт, өргөдөл гаргахад цаг хугацаанд нь хариу өгдөггүй явдал их байдаг. Эрх ашиг хөндөгдсөн эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдээс санал ер авдаггүй. Хотын төлөвлөлт гэж байхгүйгээс орц, гарцыг хаасан барилга байгууламжууд ихсэж, жирийн иргэдийн эрх ашиг хохирож байна. Тиймээс энэ хууль гарсан нь сайшаалтай боловч хуулийг хэрэгжүүлэх үүрэгтэй захиргааны байгууллагууд хангалтгүй ажиллаж байна.

Судалгаанд хамрагдсан захиргааны байгуулагын албан хаагчдаас ярилцлага хийхдээ энэ талаар асуухад:

Захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд иргэдийг оролцуулахыг дэмжиж байгаа ч төрийн байгууллагуудын байрны багтаамжаас шалтгаалан хүндрэл үүсдэг. Ялангуяа хэлэлцүүлэг хийж санал авах үед олон тооны иргэдийг хаана хүлээж авах вэ, гадуур байр түрээслэх болбол зардлыг яах вэ гээд асуудлууд үүсдэг. Иргэний бүртгэл, хаягжилтийн байдлаас шалтгаан шийдвэр гаргах ажиллагаанд оролцох ёстой иргэнийг олж тогтооход бэрхшээл гардаг.

- Ажиглалтын арга

Судалгаа хийж байх явцад гарсан ажиглалтын судалгаагаар: захиргааны байгууллагын шийдвэр гаргах ажиллагаанд оролцсон иргэдийн талаар мэдээлэл нэгдмэл байдлаар гардаггүй. Захиргааны байгууллагад хүсэлт тавихад хариу ирүүлээгүй. Шийдвэрийн хувийн хэрэгт иргэдийг оролцуулсан мэдээлэл Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газраас бусад байгууллагад байхгүй байна. Цахим хаягтаа иргэдийг оролцуулсан тухай мэдээлэл хэлбэрээр байрлуулсан ч ЗЕХ-д заасан журмын дагуу иргэдийг оролцуулсан байдал хангалтгүй байв.

Судалгаа хийх явцад 13.4 дэх заалтын хэрэгжилт ямар байгааг нэг шалгуур үзүүлэлтээр авч судалсан.

*Хүснэгт 14. Шалгуур үзүүлэлт*

| **Үнэлэгдэх хэсэг** | 13.4.Захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд хөгжлийн бэрхшээлтэй хүн оролцох тохиолдолд дохио, зангаа, тусгай тэмдэгт ашиглан хэлмэрчийн тусламжтайгаар оролцоно. |
|---|---|



pdfelement

Remove Watermark Now

| | |
|---|---|
| **Практикт хэрэглэгдэж буй байдал** | 1.Практикт хэрхэн хэрэгжиж байгаа вэ?<br><br>2.Хэрэгжүүлэх явцад саад учруулж байгаа шалтгаан байна уу |

**Үнэлгээ**

- Ярилцлага

Энэ заалтын хэрэгжилт ямар байгааг Дорноговьд аймагт зохион байгуулагдсан Хараагүйчүүдийн Холбооны Бүсийн чуулганд оролцогч 43 хүнээс бүлгийн ярилцлага авсан.

Ярилцлагын явцад гарсан саналуудыг нэгтгэвэл:

Хөгжлийн бэрхшээлтэй хүн ялангуяа хараааны бэрхшээлтэй хүний хувьд төрийн үйлчилгээг авахад хүндрэлтэй байдаг. Захиргааны шийдвэрүүд ихэвчлэн цаасан дээр гаргадаг тул бид тусгай тэмдэгт ашиглаж унших шаардлага гардаг. Харин төрийн ихэнхи байгууллагуудад энэ талын техник хэрэгсэл байхгүй. Мөн үүдэн суудаг угтах үйлчилгээний ажилтан дохионы хэл мэддэггүй. Бусад хөгжсөн улс орнуудад угтах үйлчилгээний ажилтан гадаад хэлээс гадна дохионы хэл сурсан байхыг шаарддаг. Захиргааны байгууллагууд хаалга шилэн болсон нь өнгө үзэмж талаасаа сайхан боловч хараааны бэрхшээлтэй хүнд зориулж тусгай тодруулагчтай наалт байдаггүйгээс бид осол аваарт өртөх боломж ихэсдэг. Албан байгууллагын дарга, мэрэгжилтнүүдийн өрөөний хаягийг томруулсан форматаар бичиж байршуулах нь чухал байна. Мөн үйлчилгээний байгууллагын стандартад шалны босгыг газартай эн тэнцүү байхаар хийдэг. Гэтэл хөдөө орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын шалны босго өндөр байдаг. Харин бидний эрх ашгийг хамгаалсан заалт ЗЕХ-д орсон нь маш сайшаалтай байна. Өмнө нь энэ талаар мэдээгүй байсан. Сая энэ судалгаа авахад мэдэж байна. Тиймээс гарсан хуулиа сурталчлах ажилдаа анхаарах хэрэгтэй. Мөн энэ талаар захиргааны байгууллагууд мэдэхгүй байгаагаас энэ хуулийн заалт хэрэгжихгүй болов уу. Энэ талаар сайн судлаарай.

pdfelement

- Ажиглалтын арга

Ярилцлага авсны дараа судалгаанд хамрагдсан байгууллагуудад ЗЕХ-ийн 13.4 хэрэгжилт ямар байгааг биечлэн очиж судлахад хуулийн хэрэгжилт хангалтгүй байв.

**Дүгнэлт**

1. -ЗЕХ-ийн 13-р зүйлийн 1 дэх хэсгийн шийдвэр гаргах ажиллагааны оролцогч болох захиргааны акт, гэрээний эрх зүйн үйлчлэл шууд ба шууд бусаар чиглэсэн этгээдийн талаар хуульд тусгасан томъёоллын талаар судлаач, шүүгчдээс ярилцлага авахад 9 судлаач, шүүгч нараас олонхи нь оновчтой гэж үзсэн ба харин хэнийг багтаах вэ гэдэг асуултад ялгаатай байдлаар хариулсан. Ялангуяа шууд бусаар чиглэсэн этгээд гэдгийг харилцан адилгүй агуулгаар тайлбарлаж байв.
- Татан оролцуулсан этгээдийн талаарх ойлголт ч судлаач, шүүгчдийн хувьд харилцан адилгүй байлаа.
- Иргэдийн хувьд хуульд заасан томъёоллын талаар асуухад мэдэхгүй, ойлгохгүй байна гэсэн хариуг өгч байсан.

Remove Watermark Now

Иймд уг ойлголтод ямар субьектууд хамаарахыг тайлбарлан тусгах (аутентик тайлбарыг ашиглаж болох) шаардлагатай гэсэн судлаач 1-ийн саналыг дэмжиж байна. Иймд 13.1-ийн заалт зорилгодоо хүрсэн байдлын шалгуураар авч үзвэл хангалтгүй байна гэж үзлээ.

2. 13-р зүйлийн заалтын хүлээн зөвшөөрөгдөх байдлын шалгуураар авч үзвэл иргэдээс авсан санал асуулгын үр дүнгээс харахад **46,7 хувь** нь ямар нэг байдлаар захиргааны байгууллагын шийдвэр гаргах ажиллагаанд оролцож байжээ. Харин үлдсэн **52 хувь** болох иргэдээс оролцож байгаагүй шалтгааныг нь тодруулан асуухад: Оролцох эрхтэй гэдгээ мэдэхгүй байснаас оролцоогүй гэж **20 хувь**, хариулж мэдэхгүй байна гэж **30 хувь** нь үзсэн нь захиргааны байгууллагын шийдвэр гаргах ажиллагаанд оролцоогүй гол шалтгаан нь иргэд оролцох эрхтэй гэдгээ мэдэхгүй учраас гэж хариулсан байдал өндөр байна. Энэ нь иргэдэд шийдвэр гаргах ажиллагаанд оролцох эрхтэй талаар мэдээлэл хангалтгүй байгааг харуулж байна. Харин эдгээр иргэдэд ЗЕХ-ийн талаар мэдээлэл өгөхөд ийм хууль гарсан нь сайшаалтай байна гээд цаашид шийдвэр гаргах ажиллагаанд идэвхитэй оролцох болно гэж байлаа. Тиймээс хуулийн хүрээнд иргэдийн эрх, үүргийг тодорхой ойлгуулах, мэдээллээр хангах шаардлага гарч байна. Хүлээн зөвшөөрөгдөх шалгуур үзүүлэлтийн хувьд уг заалт хангалттай гэж дүгнэж болно.

3. 13-р зүйлийн практикт хэрэглэгдэж буйг шалгуур үзүүлэлтээр авч үзвэл хангалтгүй байна. Энэ нь эрх бүхий байгууллагын санаачилга муу, хуулийг хэрэгжүүлэх хүсэл зориг сул байгаатай холбоотой. Мөн нөгөө талаас шийдвэр гаргах ажиллагаанд оролцогчийн эрхийг хангахын тулд тухайн байгууллагын зардал өсдөг тухай холбогдох албан тушаалтнууд саналаа хэлж байсан. Тиймээс байгууллагын үйл ажиллагааны тайланд шинжилгээ хийж, уг заалтын хэрэгжилтэд хүндрэл гарч буй шалтгааныг тогтоох шаардлагатай.

pdfelement

### 3.3. ЗЕХ-ийн 24-р зүйл

*Хүснэгт 15. Шалгуур үзүүлэлт 1*

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 24.1.Захиргааны байгууллага захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд хамаарах бодит нөхцөл байдлыг тогтооно.<br><br>24.2.Энэ хуулийн 24.1-д заасан бодит нөхцөл байдлыг тогтооход ач холбогдол бүхий шаардлагатай ажиллагаа хийх, нотлох баримтыг цуглуулах, үнэлэх үүргийг захиргааны байгууллага хүлээнэ.<br><br>24.4.Тухайн захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд хамааралтай тохиолдол бүрийн үндэслэлийг захиргааны байгууллага нарийвчлан шинжлэн судлах үүрэгтэй бөгөөд оролцогчийн хувьд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тогтооно. |
| **Практикт хэрэглэгдэж буй байдал** | 1.Захиргааны байгууллага, албан тушаалтан нотлох баримт цуглуулах, үнэлэх үүргийг хэрхэн биелүүлж буй өнөөгийн байдлыг судлах<br><br>2.Цугларсан нотлох баримтыг үнэлэхэд тусгай мэдлэг, ур чадвар шаардагдаж байгаа эсэх |

**Үнэлгээ**

Remove Watermark Now

- Баримт бичгийн шинжилгээ

Судалгаанд хамрагдсан 14 байгууллагуудын санасаргүй түүврээр авсан 30 шийдвэрт  баримт бичгийн шинжилгээг хийсэн.(нийслэл, дүүргийн хэмжээнд гарч буй газрын маргаан, ажилд томилох, халах зэрэг) Ингэхэд ЗЕХ-д заасан бодит нөхцөл байдлыг тогтоох талаар дурдаагүй, нотлох баримтыг цуглуулсан, үнэлсэн талаар мэдээлэл байхгүй байлаа. Энэ талаар холбогдох албан хаагчдаас асууж тодруулахад:

*Асуулт Та нотлох баримтыг цуглуулах, үнэлэх үүргээ гүйцэтгэхэд ямар бэрхшээл, хүндрэл гарч байна вэ?*

Төрийн албан хаагч 1:

Захиргааны шийдвэр гаргахаас өмнө бодит нөхцөл байдлыг тогтоох зайлшгүй шаардлагатай. Үүний үндсэн дээр зөв шийдвэр гаргах боломж бүрддэг. Гэхдээ шүүх, хуулийн байгууллага шиг нотлох баримтыг гаргуулах эрхгүй тул зарим тохиолдолд нотлох баримтыг бүрэн цуглуулж чадаагүйгээс нөхцөл байдлыг бодитоор тогтоож чадахгүй, буруу шийдвэр гаргах магадлалтай байдаг.

Төрийн албан хаагч 2:

Нэг газарт очиж шалгалт хийлээ гэж үзье. Тэгээд зөвлөгөө өгөх хэлбэрээр ажилладаг. Гэтэл нотлох баримт нь сонин зүйл гарна. Тухайн байгууллагын нотлох баримтыг бидэнд өгсөн тайлангаар тогтоодог. Тэрнээс өөр бусад хэлбэрээр тогтоох боломж нь бага. Тухайн санхүүгийн байгууллагын санхүүгийн тайлан, гаргаж өгсөн мэдээ, мэдээлэл гэдгээр хязгаарлаж үзэж байгаа. ББСБ-ын хувьд Зайны хяналтын болон газар дээр нь шалгалт хийх журам гэж бий. Тэр журмаар шалгалт хийгээд үнэлгээ өгөхөд тухайн байгууллагын санхүүгийн баримт бичиг, тайланд үндэслэнэ. Үүний дараа газар дээр нь хийсэн шалгалтын тайлан гэж гарна. Тайлангын ард тухай тухайн үеийн мэдээллийг хавсаргадаг. Тэрнээс нотлох баримт гэж үүнийг хэлнэ, ийм ийм нотлох баримт заавал бүрдүүлнэ гэдэг зүйл байхгүй.

Төрийн албан хаагч 3:

ЗЕХ-д заасан нотлох баримтыг цуглуулах, үнэлэх талаар сайн ойлголтгүй байна. Нотлох баримт гэдгийг мөрдөн байцаагч, шүүгч нар хэрэглэдэг гэж боддог байсан. Харин хуулиар бид аливаа шийдвэр гаргахдаа бодит нөхцөл байдлыг тогтоохын тулд нотлох баримт цуглуулах болсон байна. Энэ талаар тусгай мэдлэг чадвар шаардах эсэх талаар нэг мөр ойлголт алга. Өнөөдрийн явж ирсэн практик бол судалгаагүй, тооцоололгүй явж ирсэн үнэн. Дээрээс үүрэг өгөх юм уу нэг асуудал гарахаар нь шийдвэр гаргадаг явдал их бий.

Төрийн албан хаагч:

ЗЕХ-д байгаа шинжээч, гэрчийн мэдүүлгийг нотлох баримтад оруулж өгсөн. Эдгээр оролцогчид хууль сануулах уу. Захиргааны байгууллагад хуулиар ийм эрх олгоогүй гэж ойлгодог. Хэрэв шийдвэр гаргахад ач холбогдол бүхий мэдээлэл өгөх учиртай тул эдгээр оролцогч худлаа мэдүүлэг өгсөн бол яах вэ? Захиргааны байгууллага нотлох баримтыг үнэлэх үүрэгтэй гэж заасан биз дээ.

## Дүгнэлт

Энэ заалтын хэрэгжилтийг практикт хэрэглэж байгаа байдлын шалгуур үзүүлэлтээр авч үзэхэд хангалтгүй байна. Шийдвэр гаргах ажиллагаанд хамаарах нотлох баримтын талаар ойлголт муу, ялангуяа судалгаа, тооцоолол, шинжилгээнд суурилсан аргаар нотлох баримтуудаа үнэлэх гэдгийг ойлгохгүй байна. Иймд Захиргааны ерөнхий хуулийн 24.1-24.5 д заасан нөхцөл байдлыг тогтоох ажиллагаа түүний хүрээнд хийж

pdfelement

болох ажиллагаа ялангуяа газрын маргааны хувьд захиргааны байгууллага бараг хийхгүй байна.

*Хүснэгт 16. Шалгуур үзүүлэлт 1*

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 24.5.Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны явцад өөрийн чиг үүрэгт хамаарах асуудлаар гаргасан тайлбар болон өргөдөл, гомдлыг хүлээж авахаас захиргааны байгууллага татгалзаж болохгүй. |
| **Хүлээн зөвшөөрөгдсөн байдал** | Захиргааны байгуулага, албан тушаалтанд өргөдөл, гомдол, тайлбар гаргахаар хандахад хүлээж авахгүй байсан эсэх |

**Үнэлгээ**

- Санал асуулга

Иргэдийн гомдлыг шийдвэрлэхдээ дараах үйл ажиллагаанууд хийгдсэн эсэхийг тодруулсан /Захиргааны ерөнхий хуулийн талаархи олон нийтийн санал асуулгын тайлангаас харна уу/.

### 3.4. ЗЕХ-ийн 25-р зүйл

*Хүснэгт 17 Шалгуур үзүүлэлт 1*

| | |
|---|---|
| | 25-р зүйл. Нотлох баримт цуглуулах<br><br>25.1.Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны нөхцөл байдлыг тогтоохоод шаардлагатай нотлох баримтыг захиргааны байгууллага дараах байдлаар цуглуулна:<br><br>25.1.1.ач холбогдол бүхий мэдээллийг цуглуулах;<br><br>25.1.2.оролцогчийг сонсох, тайлбар гаргуулах;<br><br>25.1.3.шинжээч оролцуулан дүгнэлт гаргуулах;<br><br>25.1.4.гэрч, гуравдагч этгээдээс тайлбар гаргуулах;<br><br>25.1.5.баримт бичиг болон хууль, бусад шийдвэртэй танилцах, хуулбарлах;<br><br>25.1.6.шаардлагатай бол туршилт хийх;<br><br>25.1.7.оролцогчийн хүсэлтээр зайлшгүй шаардлагатай нотлох баримтыг гаргуулан авах. |
| **Зорилгод хүрсэн байдал** | 1. Бодит нөхцөл байдлыг тогтоох ач холбогдол бүхий нотлох баримтуудыг ЗЕХ -д бүрэн тусгаж өгсөн эсэх<br><br>2. Захиргааны байгууллагын цуглуулсан нотлох баримтыг шүүх маргаан шийдвэрлэхдээ өөрийн цуглуулсан нотлох баримттай харьцуулж болох эсэх |



Remove Watermark Now
pdfelement

**Үнэлгээ**

- Ярилцлага

Судалгаанд хамрагдсан байгууллагын албан хаагчдаас "Бодит нөхцөл байдлыг тогтоохоод ач холбогдол бүхий нотлох баримтуудыг хуульд бүрэн тусгаж өгсөн үү гэсэн асуултад: тийм гэж хариулсан боловч захиргааны шийдвэр гаргах ажиллагаа, шийдвэртэй нь танилцахад ЗЕХ-ийн 25-д заасан журмын дагуу хэрэглэсэн тохиолдол байхгүй байлаа.

Нийслэлийн захиргааны хэргийн анхан шатны шүүгч нартай ярилцлага хийхэд дараах саналыг гаргасан.

ЗЕХ-ийн 24-26 дугаар зүйлийг дурдаад эдгээр нь процесс ажиллагаа байна, нэг нь нөгөөтэйгээ хамаарал бүхий үргэлжилсэн шинжтэй ажиллагаа байтал дутуу хийсэн байна ч гэдэг юм уу, эрхийг нь зөрчсөн байна гэх мэтээр ЗЕХ-аас авч оруулдаг. Тэгэхээр хуульд эдгээр зохицуулалт байх хэрэгтэй. Захиргаа шийдвэр гаргаснаа заавал нотлох үүрэгтэй гэдгийг шийдвэрт дурдаад явж байгаа. Өөрөөр хэлбэл шүүх захиргааны байгууллагын цуглуулсан нотлох баримтыг гол эх сурвалжаа гэж авч үзэж болно.

Судлаач:
Нотлох баримтын талаар хуульд оруулсан зохицуулалт хангалттай. Харин нотлох баримтыг баримтжуулах, хэрхэн үнэлэх талаар албан хаагч нарт мэдлэг, ур чадвартай байхыг шаардах болов уу,

pdfelement

*Хүснэгт 17. Шалгуур үзүүлэлт 2*

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 25-р зүйл. Нотлох баримт цуглуулах<br><br>25.1.Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны нөхцөл байдлыг тогтоохоод шаардлагатай нотлох баримтыг захиргааны байгууллага дараах байдлаар цуглуулна:<br><br>25.1.1.ач холбогдол бүхий мэдээллийг цуглуулах;<br><br>25.1.2.оролцогчийг сонсох, тайлбар гаргуулах;<br><br>25.1.3.шинжээч оролцуулан дүгнэлт гаргуулах;<br><br>25.1.4.гэрч, гуравдагч этгээдээс тайлбар гаргуулах;<br><br>25.1.5.баримт бичиг болон хууль, бусад шийдвэртэй танилцах, хуулбарлах;<br><br>25.1.6.шаардлагатай бол туршилт хийх;<br><br>25.1.7.оролцогчийн хүсэлтээр зайлшгүй шаардлагатай нотлох баримтыг гаргуулан авах. |
| **Хүлээн зөвшөөрөгдсөн байдал** | Нөхцөл байдлыг тогтоох ажиллагаанд иргэдийн оролцоо хэрхэн хангагдаж байгаа эсэх |

Remove Watermark Now

**Үнэлгээ**

- Иргэдээс захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд оролцогчынх нь хувьд санал асуулгын аргаар судалгаа авсан /Захиргааны ерөнхий хуулийн талаархи олон нийтийн санал асуулгын тайлангаас харна уу/.

*Хүснэгт 18. Шалгуур үзүүлэлт 3*

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 25-р зүйл. Нотлох баримт цуглуулах<br><br>25.1.Захиргааны шийдвэр гаргах ажиллагааны нөхцөл байдлыг тогтооход шаардлагатай нотлох баримтыг захиргааны байгууллага дараах байдлаар цуглуулна:<br><br>25.1.1.ач холбогдол бүхий мэдээллийг цуглуулах;<br><br>25.1.2.оролцогчийг сонсох, тайлбар гаргуулах;<br><br>25.1.3.шинжээч оролцуулан дүгнэлт гаргуулах;<br><br>25.1.4.гэрч, гуравдагч этгээдээс тайлбар гаргуулах;<br><br>25.1.5.баримт бичиг болон хууль, бусад шийдвэртэй танилцах, хуулбарлах;<br><br>25.1.6.шаардлагатай бол туршилт хийх;<br><br>25.1.7.оролцогчийн хүсэлтээр зайлшгүй шаардлагатай нотлох баримтыг гаргуулан авах. |
| **Практикт хэрэглэгдэж байгаа байдал** | 1.Ач холбогдол бүхий мэдээллийг бусад мэдээллээс хэрхэн зөв ялгаж, нотлох баримтын хэмжээнд үнэлж байгаа эсэх<br><br>2. Туршилт хийж буй хэлбэрийг зөв сонгож байгаа эсэх |

pdfelement

**Үнэлгээ**

Судалгаанд хамрагдсан байгууллагын албан хаагчдаас ярилцлага авахад: ЗЕХ-д заасан журмын дагуу нотлох баримтыг цуглуулж бодит нөхцөл байдлыг тогтоох талаар хангалттай мэдээлэл, ойлголт байхгүй байгаа тул шийдвэр гаргахдаа ЗЕХ-ийг хэрэглэгдэггүй гэж хариулсан.

**Дүгнэлт**

Захиргааны байгууллагууд ЗЕХ-д заасан нотлох баримтыг цуглуулах, үнэлэх ажиллагаар хангалттай хийхгүй байна. Захиргааны шийдвэрийн талаар хангалттай нотлох баримтыг бүрдүүлэхгүй, иргэнээс санал авсан төдийхнөөр нотлох баримт цуглуулсан гэж үздэг. Бодит нөхцөл байдлыг тогтоосон судалгаа, шинжилгээ, аргачлал байхгүй, туршилт хийхгүй, зөвхөн ажлын байранд хурал хийх замаар захиргааны шийдвэрүүд гарч байгааг ажиглалт болон шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийхэд илэрч байна.

### 3.5. ЗЕХ-ийн 26-р зүйл

Remove Watermark Now

*Хүснэгт 19. Шалгуур үзүүлэлт 1*

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 26-р зүйл. Оролцогчийг сонсох<br><br>26.1.Захиргааны акт, захиргааны гэрээг батлан гаргахын өмнө эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдэд захиргааны шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар тайлбар, санал гаргах боломж олгоно.<br><br>26.2.Энэ хуулийн 26.1-д заасан оролцогчоос тайлбар, санал авах ажиллагааг сонсох ажиллагаа гэнэ. |
| **Хүлээн зөвшөөрөгдсөн байдал** | ЗЕХ-ийн уг заалт оролцогчийн эрхийг хамгаалсан заалт болсон эсэх |

**Үнэлгээ**

- Иргэдээс захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд оролцогчынх нь хувьд санал асуулгын аргаар судалгаа авсан /Захиргааны ерөнхий хуулийн талаархи олон нийтийн санал асуулгын тайлангаас харна уу/.

*Хүснэгт 19. Шалгуур үзүүлэлт 3*

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 26-р зүйл. Оролцогчийг сонсох<br><br>26.1.Захиргааны акт, захиргааны гэрээг батлан гаргахын өмнө эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдэд захиргааны шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар тайлбар, санал гаргах боломж олгоно.<br><br>26.2.Энэ хуулийн 26.1-д заасан оролцогчоос тайлбар, санал авах ажиллагааг сонсох ажиллагаа гэнэ. |
| **Практикт хэрэглэгдэж байгаа байдал** | Сонсох ажиллагааг зохион байгуулахад гарч буй бэрхшээл, хүндрэл |

pdfelement

**Үнэлгээ:**

Судалгаанд хамрагдсан 14 байгууллагын албан тушаалтан, албан хаагчдаас ярилцлага авсан болно.

Төрийн албан хаагч 1:

Олон оролцогчтой, цаасан ажиллагаа ихтэй тул шийдвэрийн төсөл боловсруулж буй байгууллага нь сонсох ажиллагааг өөрсдөө явуул гэдгийг шаарддаг. Тодорхой хэмжээгээр сонсох ажиллагаа хийгдэж байгаа. Газар, тусгай зөвшөөрөлтэй холбоотой шийдвэр гаргах ажиллагааг хуульд заасан журмаар явж байна. Жишээ нь газартай холбоотой зэрэг нөлөөтэй асуудалд сонсох ажиллагаа хийдэггүй, албан тушаалтан хүчингүй болгох, гомдлын дагуу шалгах ажиллагааны хувьд сонсох ажиллагаа хийгээд төлөвшсөн байгаа. Сонсох ажиллагааг журамлах хэрэгтэй байна.

Төрийн албан хаагч 2:

ЗГ-ыг захиргааны байгууллага гэж үзээд маргаан үүсгээд байгаа нь хүндрэл учруулдаг. Жишээ нь, захиргааны акт гаргахдаа эрх нь хөндөгдөж буй этгээдүүдэд сонсох ажиллагаа явуулна гэж хуульд заасан. Жишээ нь, томилох, чөлөөлөхтэй холбоотой маргаанд шүүх ЗГ-аас сонсох ажиллагаа явуулсан уу гэж асуудаг. Энэ нь захиргааны байгууллагын статуст ЗГ-ыг оруулах нь түүний эрх хэмжээ, эрх зүйн байдлыг дордуулсан гэж үзэхээр байна.  Сонсох ажиллагаа явуулсан уу, шийдвэр гаргахдаа бусад ажиллагаа явуулсан уу гэдэг асуудал үүсдэг. Гэтэл ЗГ УИХ-ын сонгуулийн үр дүнгээр байгуулагддаг.

Төрийн албан хаагч 3:

Заавал сонсох ажиллагаа хийж байгаа. Тэр тусмаа сахилгын шийтгэл дээр сонсох ажиллагааг заавал хийж байна. Сахилгын шийтгэл хүлээж байгаа албан хаагч сонсох ажиллагааг шууд хүлээн зөвшөөрөхгүй. Сонсох ажиллагаа явуулаад зөвшөөрсөн эсэхээ гарын үсэг зурж баталгаажуулах байгаа. Ганц нэг зөвшөөрөхгүй тохиолдол байсан. Ийм тохиолдолд хэн нэг албан тушаалтныг байлцуулж хийж байгаа учраас зөвшөөрөхгүй гэдэг тайлбар бичүүлж гарын үсэг зуруулдаг.

Төрийн албан хаагч 4:

Гомдол гаргах ажиллагааны хувьд, сонсох ажиллагааны хувьд, гуравдагч этгээдийн ашиг сонирхлын хувьд хөндөх зүйл бий. Жишээ нь, байгууллагад шалгалт хийгээд очдог. Гэтэл шалгалт өгөөгүй хүнийг томилсон байдаг. Тэгэхээр нь, манай зүгээс хууль бус гэдэг үндэслэлээр тушаалыг нь хүчингүй болгодог. Гэтэл тушаал хүчингүй болгохын тулд томилогдсон этгээдтэй уулзах хэрэгтэй болдог. Томилогдсон арав, хорин хүн байдаг. Тэр бүхэнтэй уулзана гэхээр ажил хүндэрнэ. Үнэндээ бол уулзах ямар ч шаардлага байхгүй, учир нь сонгон шалгаруулалтгүйгээр томилогдсон байгаа. Томилсон нь байгууллагын дарга, тэгэхээр байгууллагын дарга буруутай. Хуучин бол манайхаас шууд хүчингүй болгодог байсан. Одоо бол сонсох ажиллагаа явуулах, тэднийг дуудах, уулзах шаардлага гарна. Нэг л хариутай. Тэр нь намайг байгууллагын дарга л томилсон гэдэг. Тэгэхээр бидний хувьд томилсон даргад шийдвэрээ хүчингүй болго гэдэг даалгавар өгөх л болдог. Гэтэл байгууллагын дарга ТАЗ-ийн шийдвэрийн дагуу томилгоог хүчингүй болго гээд шийдвэрээ гаргахаар угтаа өөрөө буруу шийдвэр гаргасан атал хариуцлагаас мултарч, ТАЗ-ийн шийдвэрийн дагуу томилгоог хүчингүй болгосон гэдэг. Эндээс нөгөө албан хаагчид нь ТАЗ буруутай гээд маргадаг. Нэг байгууллагад шалгалт хийгээд шийдвэр гаргахаар ТАЗ-тэй арван хүн маргаан үүсгэнэ. Үүнээс сэргийлэхийн тулд байгууллагын даргад нь үүрэг болгодог. Энэ нь цаанаа заргалдахгүйн тулд гэсэн үг. Үүнийг ЗЕХ-д анхаарах хэрэгтэй байх.

Төрийн албан хаагч 5:

Сонсох ажиллагаа хуулийн дагуу хийгддэг. Гэхдээ манай байгууллагын хувьд тулгардаг асуудал бол эрх ашиг нь хөндөгдөж болзошгүй сөрөг үйлчлэлтэй захиргааны акт гаргах бол хорооны хурлаар хэлэлцэж тогтоол гаргадаг. Гэхдээ тухайн асуудал хорооны хурлаар яаж шийдэгдэх нь тодорхойгүй байдаг. Тухайн актыг гаргахаас өмнө сонсох ажиллагаа хийх ёстой. Тэгэхээр сонсох ажиллагаа хийх үү болих уу гэдэг эргэлзээ үүсдэг. Хорооны хурлаар сөрөг үйлчлэлтэй захиргааны актыг гаргахаар шийдвэл сонсох ажиллагааг хорооны хурлын материалыг хүлээн авах явцад хийх боломжгүй юм. Жишээ нь, нэг байгууллагын тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудал яригдлаа гэхэд хорооны хурлаар хэлэлцэхээс өмнө сонсох ажиллагаа хийхэд хүндрэлтэй байдаг.

Төрийн албан хаагч 6:

Хийгддэг гэж бодож байна. Хэм хэмжээний актын хувьд сонсох ажиллагаа гэхээс илүү хэлэлцүүлэг хийх, яамны цахим хуудсаар дамжуулж санал авах, холбогдох байгууллагуудаас нь санал авах хэлбэрээр хийдэг. Нэг удаагийн акт дээр ч сонсох ажиллагаа хийсэн. Албан хаагчийг томилох, чөлөөлөхдөө дуудаж сонсох ажиллагаа хийдэг. Эмч нар, эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой иргэдийн өргөдөл,



Remove Watermark Now

Remove Watermark Now

гомдолтой холбоотой асуудал үүсвэл утсаар бичгээр асууж тодруулах хэлбэрээр ч хийдэг.

Төрийн албан хаагч 6:

Нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой, олон иргэн, хуулийн этгээд хүсэлт гаргасан, эсхүл олон иргэн, хуулийн этгээдийн ашиг сонирхлыг хөндсөн шийдвэр гаргахад олон оролцогчийг сонсох, мэдэгдэх ажиллагаа явуулахад хүндрэлтэй байдаг. Иймд сонсох болон мэдэгдэх ажиллагааг хялбаршуулсан журам шаардлагатай.

Төрийн албан хаагч 7:

Сонсох ажиллагаа хийж байна. Харин сонсох ажиллагааг ямар хугацаанд, ямар шийдвэрүүдэд хийх вэ гэдгийг ЗЕХ-д тусгах ёстой. Эсвэл тусгай журмаар зохицуулах зүйтэй болов уу. Бид өнөөдөр эрх ашиг хөндөгдөж байгаа шийдвэр болгонд заавал сонсох ажиллагаа хийж байна. Харин энэ бүхэнд хэрэглэх цаас зардлыг тооцох нь зүйтэй болов уу.

Төрийн албан хаагч 8:

Сонсох ажиллагааг хэн явуулах вэ,? Жишээлбэл: газрын эрхийн гэрчилгээг хүчингүй болгох асуудлаар сонсох ажиллагаа хийлээ гэхэд газрын албаныхан хийдэг. Гэтэл захиргааны шийдвэрийг Засаг дарга гаргадаг. Гэтэл Засаг дарга сонсох ажиллагаа хийхгүй байна. Уг нь Засаг дарга л тэр хүний тайлбарыг сонсох ёстой биздээ

Шүүгч:

Сонсох ажиллагааны хувьд ажиглагдсан зүйл бол урьд өдөр нь утсаар мэдэгддэг. Тэгээд маргааш 10 цаг гэхэд хариугаа, тайлбараа өгөөрэй гэдэг. Тэгэхээр сонсох ажиллагааны боломжит хугацааг хуульчлах хэрэг гараад байгаа. Харин зарим нь бичгээр мэдэгдлээ өгөөд эргээд хэзээ хариу, тайлбар өгөх хугацааг заадаг. Үүнээс сонсох ажиллагааг бүрэн явуулах хугацаа ямар байхыг тодорхой болгох хэрэгтэй. Сонсох ажиллагааны маягт гэдэг зүйл зарим байгууллагад бий, заримд нь байхгүй. Тэрнийг нэг мөр болгох хэрэгтэй байх.

pdfelement

Сайн жишээ: Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газраас сонсох ажиллагааны журмыг батлан гаргасан байна (Хавсралт 2)

### 3.6. ЗЕХ-ийн 27-р зүйл

*Хүснэгт 20. Шалгуур үзүүлэлт 1*

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 27.3.Сонсох ажиллагааны талаарх мэдэгдэлд дараах мэдээллийг тусгана:<br><br>27.3.1.сонсох ажиллагааг явуулах журам, ажиллагаа явуулах он, сар, өдөр, цаг, байрлал, дарааллын талаарх мэдээлэл;<br><br>27.3.2.захиргааны шийдвэр гаргах эрх олгогдсон хууль, захиргааны хэм хэмжээний актын зүйл, заалт;<br><br>27.3.3.захиргааны шийдвэр гаргах<br><br>тухайн асуудлын талаарх мэдээлэл, үндэслэл<br><br>27.4.Сонсох ажиллагааг дараах арга хэлбэрээр явуулна:<br><br>27.4.1.сонсгол зохион байгуулах;<br><br>27.4.2.саналыг бичгээр авах; |

| | |
|---|---|
| | 27.4.3.биечлэн уулзах;<br><br>27.4.4.утсаар санал авах;<br><br>27.4.5.цахим хэлбэрээр санал авах;<br><br>27.4.6.төлөөлөгчөөр дамжуулан санал авах;<br><br>27.5.Сонсох ажиллагаа явуулах хугацаа оролцогчийн тайлбар, санал гаргах боломжийг хангасан байна<br><br>27.7.Сонсох ажиллагааны үед гарсан саналыг захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд заавал тусгах үүрэг хүлээхгүй боловч тусгаагүй шалтгааныг тайлбарлах үүрэгтэй.<br><br>27.6.Сонсох ажиллагааны явц, үр дүнгийн талаар тэмдэглэл хөтөлж, гарсан саналыг захиргааны шийдвэрт хэрхэн тусгасан талаар мэдээлэл бэлтгэж баримтжуулна. |
| **Практикт хэрэглэгдэж байгаа байдал** | Сонсох ажиллагааны хэлбэрүүдийг хэрэглэж байгаа эсэх |

**Үнэлгээ:**

Судалгаанд хамрагдсан 14 байгууллагын албан тушаалтан, албан хаагчдаас ярилцлага авсан болно.

ЗЕХ-ийн дагуу хийсэн сонсох ажиллагааны мэдэгдлийг хийсэн байгууллага Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газар байв.

Мэдэгдлийн хувьд жишээ нь, иргэн Б-ын газар эзэмших эрхийг хүчингүй болгуулья гээд гомдол ирсэн гэж үзье. Иргэн А-ийн гомдлын дагуу хяналт шалгалт хийхэд гомдол үндэслэлтэй бол Б-ийн газрын эзэмших эрхийг хүчингүй болгох мэдэгдэл хүргүүлнэ. Иргэн А-ийн гомдлоор хяналт шалгалт хийхэд танд ийм шийдвэрээр олгосон газар нь давхцсан тул Газрын тухай хуулийн дагуу газар эзэмших эрхийг хүчингүй болгохыг мэдэгдье, үүнтэй холбоотой гомдол, тайлбар байгаа бол ийм хугацаанд ийм хаягаар хандах, эсхүл ийм албан тушаалтантай ирж уулзахыг мэдэгддэг. Хугацаанд ирвэл баримтжуулаад явна, харин ирээгүй бол шийдвэр шууд хүчингүй болдог. Дараа нь гарсан шийдвэрийг шуудангаар явуулж байна. ЗЕХ-ийг хэрэгжүүлэх нарийвчилсан журам байхгүй байгаа тул харилцан адилгүй ойлгож, янз бүрээр мэдэгдэл гаргах тохиолдол байгаа.

Сонсох ажиллагааны хэлбэрийн хувьд захиргааны байгууллагууд хэлэлцүүлэг хийх, утсаар мэдэгдэх, саналын бичгээр авах хэлбэр зонхилж байв.

Харин сонсох ажиллагааны явцад гарсан саналыг захиргааны шийдвэрт тусгаагүй талаар хариу тайлбар өгсөн тухай тэмдэглэл СХД-ийн Засаг даргын тамгын газраас бусад байгууллагад байхгүй байна.

### 3.7. ЗЕХ-ийн 28-р зүйл



pdfelement
Remove Watermark Now

Remove Watermark Now



| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 28.1.Дараах тохиолдолд сонсох ажиллагаа хийхгүй байж болно:<br><br>28.1.1.нийтийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөр бол;<br><br>28.1.2.гарцаагүй байдлын улмаас, эсхүл нийтийн ашиг сонирхлын үүднээс хойшлуулшгүй ажиллагаа явуулах шаардлагатай бол;<br><br>28.1.3.иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, гомдлыг ханган шийдвэрлэж байгаа тохиолдолд;<br><br>28.1.4.захиргааны шийдвэрийг техник хэрэгслийн тусламжтайгаар гаргаж байгаа бол;<br><br>28.1.5.захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж байгаа бол;<br><br>28.1.6.төр, байгууллага, хувь хүний нууцын тухай хууль тогтоомжоор хамгаалагдсан бусдад дамжуулах боломжгүй мэдээлэлд хамаарах бол.<br><br>28.2.Энэ хуулийн 28.1-д заасан сонсох ажиллагааг хийгээгүй шалтгаанаа захиргааны байгууллага нотлох үүрэгтэй |
| **Зорилгодоо хүрсэн байдал** | 1.Сонсох ажиллагааг хийхгүй байх бүх тохиолдлыг ЗЕХ-д зааж өгсөн үү?<br>2. Уг хуульд байгаа тохиолдлыг тодорхойлж байгаа ойлголтууд сонсох ажиллагааг хийхгүй бодит нөхцөл болж байна уу?<br>3. нийтийн ашиг сонирхол, сөргөөр нөлөөлөх, нийтийн ашиг сонирхлын үүднээс, хойшуулшгүй ажиллагаа зэргийн агуулгыг ЗЕХ-д ойлгомжтой байдлаар зааж өгсөн үү? |

**Үнэлгээ:**

- Ярилцлага :

Судлаач 1:

Нийтийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөр бол гэсэн үндэслэлээр сонсох ажиллагаа хийхгүй гэж хуульд заасан.

Нийтийн ашиг сонирхол гэж юу ?

Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан тодорхойлсон. Гэхдээ энэ хуульд тодорхойлсон томьёоллын хувьд ижил эрх, хууль ёсны ашиг сонирхол бүхий бүлэг этгээдүүдийн (улс, аймаг, тариаланчид гэх мэт) ашиг сонирхол гэж ойлговол арай илүү оновчтой байж болох юм. Тухайлбал, нэг аймаг, сумын нутагт халдварт өвчинтэй холбоотой шийдвэр гаргахад шийдвэрийн үйлчлэл чиглэгдэх этгээдүүдийг оролцуулах санал авах нь нийтийн ашиг сонирхол (эрүүл мэнд, хэв журам) –д сөрөг нөлөөлөл үзүүлж болох юм.

Хуульд заасан томъёолол оновчтой, ойлгогдохоор байна уу?

Remove Watermark Now

Хэт ерөнхий байж магадгүй. “Нийтийн ашиг сонирхлын үүднээс хойшлуулшгүй тохиолдолд (цаг хугацааны хувьд) сонсгох ажиллагааг явуулахгүй” гэдэгтэй адил нөхцөл шалтгааны хувьд гарцаагүй, бодит гэх мэт тодотгол хийх шаардлагатай байж болохоор байна.

Судлаач 2:

Нийтийн ашиг сонирхол” хэмээх ойлголт цаг үеэ даган хувьсан өөрчлөгддөг ойлголт учраас нь хуулиар шууд шууд болон тодорхой тайлбар хийх нь зохимжгүй. Иймд “Нийтийн ашиг сонирхол” гэдгийг тодорхой нэг тохиолдолд хууль тогтоогчоос тогтоосон хуулийн агуулга, зорилгыг цогцоор нь тайлбарлах замаар тогтооно. Нийтийн ашиг сонирхлыг тухайн тохиолдолд тодорхойлоход шүүх чухал үүрэгтэй. Нийтийн ашиг сонирхол гэдгийг юуны өмнө, нийтийн ашиг сонирхлыг хувийн ашиг сонирхлын эсрэг тодорхойлох буюу нийтийн ашиг сонирхол нь хувийн ашиг сонирхлоос дээгүүр тавигдах тухай ойлголт болохын зэрэгцээ нийтийн байх шинж чанар нь агуулгын болоод тооны бүрдүүлбэртэй, гэхдээ тооны бүрдүүлбэрийг ердийн арифметик тоогоор тооцох боломж байдаггүйг анхаарах шаардлагатай.

Судлаач 3:

Хувь хүмүүсийн хувийн ашиг сонирхол бус, нийт иргэдийн нийтлэг сонирхол болно.
Хуульд заасан томъёолол оновчтой, ойлгогдохоор байна уу?- Ойлгомжгүй байна.

Судлаач 4:

Нийтийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөр бол гэсэн үндэслэлээр сонсох ажиллагаа хийхгүй гэж хуульд заасан.

3.1.Нийтийн ашиг сонирхол гэж юу ? Хувь хүмүүсийн тус тусын сонирхлын нийлбэр буюу нийт иргэдийн нийтлэг сонирхол юм. Энд мэдээж нэг хэсэг бүлэг этгээдийн сонирхол орохгүй

3.2.Хуульд заасан томъёолол оновчтой, ойлгогдохоор байна уу? Ойлгомжгүй гэхээс илүүтэйгээр хэт ерөнхий зохицуулсан нь хууль хэрэглэхэд төвөгтэй байдал гарч болзошгүй.

Судлаач 5:

Сонсох ажиллагааг хийгээгүй шалтгаанаа тайлбарлах, нотлох үүргээ хэрэгжүүлэхгүй байна.

Шүүгч:

Сонсох ажиллагаа хийхгүй байх үндэслэлд хамаардаг сөргөөр нөлөөлөхгүй байх гэдэгт юу оруулах вэ? гэдэг нь байхгүй, тэгэхээр бид өөрсдөө л тогтоох болно. Сөргөөр нөлөөлөх гэдэгт ямар нөлөөллийг хэлээд байна вэ? Үүнийг тодорхой болгох хэрэгтэй. Мөн сонсох ажиллагаа хийх байх үндэслэлд нэмж оруулах зүйл бол Эрүүгийн хуулиар зөрчил нь тогтоогдсон үүнийг хиймээргүй байна. Жишээ нь, сонгуулиар мөнгө тараасан гэдэг нь тогтоогдчихсон, гэтэл сонсох ажиллагаа хийгээгүй гээд байгаа. Гэтэл энд энэ ажиллагааг хийх огт шаардлагагүй. Өөр нэг зүйл бол жишээ нь, төрийн албаны маргаан дээр албан тушаалаа урвуулан ашигласан гээд эрүүгийн хэрэгт холбогдсон байхад сонсох ажиллагаа хийх гэдэг. Гэтэл автоматаар дараагийн захиргааны акт нь гарах ёстой. Өөрөөр хэлбэл, эрүүгийн журмаар үйл баримт нь тогтоосон асуудалд сонсох ажиллагаа хиймээргүй байгаа юм. Хуульд сонсох ажиллагаа хийхгүй байх гэдэгт эрүүгийн журмаар шийдэгдсэн гэдгийг оруулаагүй учраас одоо бол хийх л болоод байгаа юм. Сонсох ажиллагааны агуулга нь таны эрхийг зөрчсөн шийдвэр гарах гээд байна, танд сөргөөр нөлөөлөх захиргааны акт гарах гээд байна, эдгээртэй холбоотой нэмэлт зүйл байна уу гэдгийг лавлаж байгаа хэлбэр.

*Хүснэгт 22. Шалгуур үзүүлэлт 2*

Remove Watermark Now

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 28.1.Дараах тохиолдолд сонсох ажиллагаа хийхгүй байж болно:<br><br>28.1.1.нийтийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөр бол;<br><br>28.1.2.гарцаагүй байдлын улмаас, эсхүл нийтийн ашиг сонирхлын үүднээс хойшлуулшгүй ажиллагаа явуулах шаардлагатай бол;<br><br>28.1.3.иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, гомдлыг хангаж шийдвэрлэж байгаа тохиолдолд;<br><br>28.1.4.захиргааны шийдвэрийг техник хэрэгслийн тусламжтайгаар гаргаж байгаа бол;<br><br>28.1.5.захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулж байгаа бол;<br><br>28.1.6.төр, байгууллага, хувь хүний нууцын тухай хууль тогтоомжоор хамгаалагдсан бусдад дамжуулах боломжгүй мэдээлэлд хамаарах бол.<br><br>28.2.Энэ хуулийн 28.1-д заасан сонсох ажиллагааг хийгээгүй шалтгаанаа захиргааны байгууллага нотлох үүрэгтэй |
| **Практикт хэрэглэгдэж байгаа байдал** | Сонсох ажиллагаа хийгээгүй шалтгаанаа ямар тохиолдол үүссэн, үүнийг ямар нотлох баримтаар тогтоодог талаар тайлбарладаг эсэхийг судлах |

pdfelement

**Үнэлгээ:** Энэ талаар төрийн албан хаагчтай ярилцлага хийсэн:

Сонсох ажиллагаа хийхгүй байх талаар ЗЕХ-ийн 28 дугаар зүйлд заасан. Үүнийг тайлбарлаж, тодруулах зүйл бий. Жишээ нь, түгээмэл тархацтай ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон. Гэтэл нэг асуудлаар 90 орчим аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоход бүгдэд сонсох ажиллагаа хийхэд хүндрэлтэй. Тэгэхээр нь олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдэгдэхэд үүнийг иргэн, аж ахуйн нэгж сонсох ажиллагаа гэж үздэггүй. Иймээс хуулийн 28 дугаар зүйлийг тодорхой болгох шаардлага бий.

*ЗЕХ-ийн 28 дугаар зүйлд заасан сонсох ажиллагаа хийхгүй байх зохицуулалтыг тодорхой болгох гэдгээ тодруулна уу? Сонсох ажиллагаа хийхгүй байх үндэслэлээ нэмэх хэрэгтэй гэж ойлгох уу?*

Жишээ нь нийтийн ашиг сонирхлыг хангах гэж нэмж болно. Жишээ нь УИХ-аас Туул голын сав дагуу ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоход шууд утгаараа тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрхийг хөндөж байгаа ч цаана нь олон нийтийн эрх ашгийг хангаж байдаг. Ийм тохиолдолд хялбаршуулах байдлаар хөнгөвчилсөн хийх шаардлагатай. ЗЕХ-ийн 13 дугаар зүйлийг барихаар шийдвэр гаргах боломжгүй. ЗЕХ-ийн 28 дугаар зүйлийн өргөдөл гомдлыг хангаж шийдвэрлэх гэдгийг ч ялгаатай ойлгож байгаа. Жишээ нь, УИХ-ын өргөдөл гомдлын байнгын хороонд түгээмэл тархацтай ашигт малтмалтай холбоотой тусгай зөвшөөрөл хүчингүй болгох гомдлууд их ирдэг. Тэрийг манайхаас хүчингүй болгож шийдвэрлэхээр бидний хувьд УИХ-ын өргөдөл гомдлын байнгын хороонд ирсэн гомдлыг хангаж шийдвэрлэж байна гэсэн үг үү гэдэг асуудал

Remove Watermark Now

гарна. Мөн хэдэн мянган хүний эрх ашиг, 40 орчим тусгай зөвшөөрөл эзэмшигчийг эрх ашгийг харьцуулж үзэх хэрэгтэй. Тэгэхээр сонсох ажиллагааг хялбар байдлаар явуулах хэлбэрийг заамаар байна.

➢ Шүүхийн шийдвэрт хийсэн шинжилгээ

Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлснээс хойш нийслэл, 15 аймгийн нийт 61 захиргааны хэргийн шүүх хуралдааны шийдвэр, магадлал тогтоолд захиргааны шийдвар гаргах ажиллагаа, сонсох ажиллагаатай холбоотой маргаан гарсан эсэхэд судалгаа хийв. Үүнийг тус бүрд нь задалж үзвэл:

- Захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдааны шийдвэр 58, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хуралдааны магадлал 2, Улсын дээд шүүхийн захиргааны хэргийн хяналтын шатны шүүх хуралдааны тогтоол 1 байсан болно.
- Нийслэлийн дэх захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдааны шийдвэр -27, Булган аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдааны шийдвэр -5, Дундговь, Өмнөговь аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдааны шийдвэр тус бүр 3, Архангай, Хэнтий, Сэлэнгэ, Завхан, Баянхонгор, Сүхбаатар, Дархан-Уул аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдааны шийдвэр тус бүр 2, Дорнод, Дорноговь, Говь-алтай, Төв, Ховд, Хөвсгөл аймаг дах  захиргааны хэргийн анхан шатны шүүх хуралдааны шийдвэр тус бүр 1 байсан.

Эдгээр 61 шийдвэрийн 17 шийдвэрт ЗЕХ-ийн 24-28 зүйлийн хэрэгжилттэй холбоотой асуудлыг хөндсөн. Ингэхдээ хууль хэрэгжснээс хойших хугацааны байдлаар авч үзвэл 2017 оны  3 дугаар улирлаас эхлэн нэхэмжлэлийн шаардлага болон шүүхийн шийдвэрт  ЗЕХ-ийн 24-28-р зүйл заалттын хэрэглээ өссөн байна /Хавсралт 3/ .

pdfelement

**Дүгнэлт**

ЗЕХ-ийн 26, 27, 28-р зүйлүүд сонсох ажиллагааны талаар зохицуулсан. Судалгаанд хамрагдсан 14 байгууллага сонсох ажиллагааг хийж эхлүүлсэн байна. Гэхдээ хуульд заасан журам, шаардлагын дагуу сонсох ажиллагаа хангалттай явагдахгүй байгаа нь судалгааны явцад ажиглагдлаа. Ялангуяа сонсох ажиллагааны мэдэгдлийг хуульд заасан шаардлагын дагуу бэлтгэж, оролцогчдод өгөхгүй байна. Мөн сонсох ажиллагааны мэдэгдэл өгсний дараа хэзээ уг ажиллагааг явуулах, оролцогчдод тайлбар, санал гаргах хугацааг хэрхэн тооцох талаар зохицуулалт байхгүйгээс хэлбэрийн төдий ажиллагаа болоод байна. Захиргааны байгуулагын зүгээс гарч буй саналын хувьд зардал, хэн сонсох ажиллагааг хийх вэ гэдэг нь тодорхойгүйгээс бэрхшээл учирч байна гэжээ.

Зорилгодоо хүрсэн байдлын шалгуур үзүүлэлтийн хувьд хангалттай гэж үзсэн харин практикт хэрэгжиж байгаа байдлыг хангалтгүй гэж дүгнэж байна.

### 3.8. ЗЕХ-ийн 29-р зүйл

*Хүснэгт 24. Шалгуур үзүүлэлт 1*

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 29.1.Захиргааны байгууллагаас захиргааны шийдвэрийн хувийн хэргийг хөтлөх бөгөөд уг хувийн хэрэгт шийдвэр гаргах үйл ажиллагааны үндэслэл, үе шат, оролцогчийн санал, холбогдох баримт, сонсох ажиллагаа, уулзалт, хуралдааны |

| | |
|---|---|
| | тэмдэглэл, шийдэл, хүргүүлсэн, мэдэгдсэн баримт зэргийг бүрдүүлэн, архивт хадгална.<br><br>29.2.Захиргааны шийдвэр бүрд хяналтын дагалдах хуудас хавсаргах бөгөөд дагалдах хуудсанд захиргааны шийдвэр боловсруулахад оролцсон албан хаагч бүрийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, оролцоо, гүйцэтгэлийн тухай дэлгэрэнгүй тэмдэглэсэн байна. Дагалдах хуудсанд албан хаагчийн захиргааны шийдвэр боловсруулахад оролцсон оролцоо, гүйцэтгэлийг тэмдэглэсэн байна.<br><br>29.3.Энэ хуулийн 29.2-т заасан дагалдах хуудсыг албан хаагчид шагнал олгох, үр дүнгийн урамшуулал тооцох, сахилгын шийтгэл хүлээлгэх, эсхүл хөдөлмөрийн харилцааг дуусгавар болгоход харгалзана |
| **Зорилгодоо хүрсэн байдал** | 1.Захиргааны байгууллагаас шийдвэрийн хувийн хэрэг бүрдүүлэх хэрэгцээ шаардлага заавал байх эсэх<br><br>2. Захиргааны шийдвэрийн хувийн хэрэг, дагалдах хуудас нь захиргааны байгууллагад хандсан өргөдөл, гомдол, мэдээлэлд нотлох баримт бүхий мэдээлэл өгөх, шүүхэд тайлбар гаргах, өөрт нь ЗЕХ-ын 105-р зүйлд хүлээлгэсэн хариуцлага, 103-р зүйлд заасан хохирол барагдуулах, мөн урамшуулал авахад зориулагдсан зохицуулалт мөн эсэх<br><br>3.Захиргааны хувийн хэрэг бүрдүүлэхэд захираaны зардал өсөх эсэх |

pdfelement

**Үнэлгээ:**

Судалгаанд хамрагдсан захиргааны байгууллагын албан тушаалтан, албан хаагчдаас ярилцлага авсан.

Төрийн албан хаагч:

Захиргааны ерөнхий хууль дахь Засаг даргын гаргах шийдвэр ямар байх талаар заасны дагуу хэрэгжүүлж байна. Энэ талаар журам гаргасан. Гэхдээ хэвлэгдээгүй байгаа. Ер нь бол хуулийн дагуу хувийн хэргээ бүрдүүлж ажиллаж байна. Эргээд хувийн хэрэг шүүх дээр нотолгоо болох, лавлагаа болдог. Хуучин бол хувийн хэрэг гэдгээс өөр болсон, захирамжийн саналтай холбоотой материалуудыг нэг жил болгоод устгадаг байсан бол одоо хувийн хэрэг ямар нэг маргаан гарахад нотолгоо болох учраас архивлаад байна.
*Судалгааны явцад хувийн хэргийн бүрдүүлэлт хийхэд ямар нэг бэрхшээл байна уу?. Жишээ нь зардал, өөр бусад хүчин зүйлтэй холбоотой хүндрэл юу байна вэ?*
Ер нь бол гайгүй, гэхдээ засаг захиргааны хувьд ч юм уу, яам, тамгын газрын хувьд дарга нар нь шууд шийдвэр гаргасан тохиолдол байдаг. Тэгээд хойноос нь хөөж хувийн хэрэг бүрдүүлэх асуудал гарах нь бий. Захирамж гаргуулах гээд орж ирж байгаа байгууллагууд дээр дугаар тэмдэг өгөхгүй гэдэг байдлаар албадаж хувийн хэргийг бүрдүүлэх үе ч бий. Гэхдээ бүрдүүлсэн хувийн хэрэг маань шаардлагад хүрч байгаа гэдгийг мэдэхгүй. Боломжийн хирээр л оролцогчдын гарын үсэг, холбогдох материалуудыг нэгтгээд хуучнаасаа хэд дахин илүү цаас болдог. Оны эцэст арван хэдээс хорь орчим нэгж өгдөг байсан бол одоо 30-40 орчим нэгж болж нэмэгдсэн.

Remove Watermark Now

*Хувийн хэргийн гол зорилго нь эхлээд шийдвэр гаргахаас өмнө нотлох баримтууд бүрдүүлэх ёстой. Дараагийн зорилго нь иргэн хувийн хэрэгтэй танилцах боломжтой байх. Жишээ нь энэ асуудлаар буюу хувийн хэрэгтэй танилцах хүсэлт гаргасан иргэн байгаа юу?*

Иргэн бол гараагүй, харин шүүхээс бол хэд хэдэн удаа хувийн хэрэг үзсэн. Хуулийн хэлтсийнхэн шүүх дээр маргаантай асуудлаар байнга хувийн хэргийг үздэг. Хуулийн хэлтсийнхний хувьд хувийн хэргээс сугалж аваад үздэг. Тийм лавлагааг өдөр тутам хийж байна. Газрын маргаантай холбоотой нэг иргэн л хувийн хэрэг үзсэн. Өдөр тутам иргэд үзэх тохиолдол байхгүй, харин байгууллага дотор л хувийн хэргийг үзэх нь их болсон.

Хувийн хэргийн бүрдүүлэлт дээр өөр өөрийнхөөрөө ойлгоод бүрдүүлж байна. Агентлаг, дүүргийн 2017 оны үйл ажиллагааг шалгахад агентлаг бүрт өөр өөрөөр бүрдүүлсэн, учир нь нэгдсэн загвар байхгүй. Хуулиа уншаад ингэж ойлгосон, мэдэгдэх хуудас нэг иймэрхүү байх шиг байна гэх мэтээр харилцан адилгүй ойлголттой байна. Мөн архивт хадгална гэж байгаа. Гэтэл архивт хадгалахтай холбоотой асуудал нь журамлагдаагүй, үүнээс үүдээд хувийн хэргийн бүрдүүлэлт харилцан адилгүй, нэг загварт ороогүй байна. Тиймээс ХЗЯ ч юм уу Үндэсний архивын газар нь ч юм уу нэг загвар гаргаад өгөх нь зүйтэй байх. Хувийн хэргийн бүрдүүлэлт өөр өөр байгаагаас бус огт хувийн хэргийн бүрдүүлэлт хийхгүй байгаа зүйл байхгүй.

Төрийн албан хаагч:

Бүрдүүлбэрийг хуульд заасны дагуу хийж байгаа. Сөрөг болон эерэг гээд бүх захиргааны актад хувийн хэрэг бүрдүүлж байгаа. Манай онцлог шат ихтэй учраас шат бүр дээр албан тушаалтны саналыг тусгуулаад ЕНБД дээр тухайн акт очдог. Тэр бүрт хувийн хэргийн бүрдүүлбэрийг хангаж байгаа.

*Зардал гарч байна уу?*

Ер нь бол гайгүй, баримтжуулаад явсан дээр. Зардал их гарахгүй, учир нь баримт бичгийн төслийн арын хуудсанд хяналтын хуудсаа оруулсан. Мэдэгдэх хуудас бол манайд нэг их өгөөгүй.

pdfelement

Төрийн албан хаагч:

Актын хувьд хяналт шалгалтын газар хянан шалгагч нар ажиллахдаа банк бүр дээр хянан шалгагч бий. Тухайн банк бүрт үйл ажиллагаатай нь холбоотой бүх асуудлаар хувийн хэрэг үүсгээд тухайн хянан шалгагч нь хариуцаад явдаг. Хэм хэмжээний актын хувьд чиг үүрэг хариуцсан газар, хууль эрх зүйн хэлтэс хамтарч шийдвэрийн төслийг боловсруулаад чиг үүрэг хариуцсан газарт нь шийдвэрийн төсөлтэйгээ бүх материал нь нэгтгэгдэж байгаа. ЗЕХ гарахаас өмнө ч ингэж явдаг байсан.

Төрийн албан хаагч:

Захиргааны шийдвэрийн хувийн хэргийг бүрдүүлэхэд дараах хүндрэл бэрхшээл гарч байна:

- Захиргааны шийдвэрийн хувийн хэрэг бүрдүүлэх аргачлал, загвар байхгүйгээс захиргааны байгууллагууд янз бүрээр бүрдүүлж байгаа тул нэгдсэн аргачлал, загвартай болгох;
- Зарим тохиолдолд энэ нь бусад баримт бичгийн бүрдүүлэлттэй давхцаж захиргааны байгууллагад хүндрэл учруулж байна. Тухайлбал, төрийн жинхэнэ албан хаагчтай холбоотой шийдвэр гаргах ажиллагааны явцад бүрдүүлж байгаа баримт нь тухайн албан хаагчийн хувийн хэрэгт хадгалагдах шаардлагатай болдог. Мөн газар, тусгай зөвшөөрөлтэй холбоотой шийдвэрүүдийн хувийн хэрэг нь тухайн асуудлын хувийн хэрэгт мөн хадгалагдах шаардлагатай болдог тул энэ тохиолдлуудад тухайн хувийн хэргийг нь захиргааны шийдвэрийн хувийн хэрэгт адилтгах зохицуулалтыг хийх;
- Архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, журамд холбогдох өөрчлөлтийг хийх.

Шүүгч:

Remove Watermark Now

Хувийн хэргийн хувьд засаг даргад шууд чиглэсэн актын хувийн хэргийг газрын алба нь бүрдүүлээд байгаа. Гэхдээ үүнийг шууд буруу гэх боломжгүй, тэгэхээр бид харьяа чиг үүргийн гэдэг үндэслэлээр аваад явдаг. Тэгэхээр үүнийг харьяа чиг үүргийн байгууллага гэдгээр зохицуулвал дээр байх. Тэгэхгүй шийдвэр гаргах этгээд гэхээр арай өөр агуулга харагдах гээд байна.

Судалгаанд хамрагдсан 14 байгууллагаас ЗЕХ-д заасан журмын дагуу хувийн хэргийг хөтөлж байгаа байгууллага 4, салбарын хуулиараа өмнө нь хийж байсан 2 байгууллага байна.

Сайн жишээ: СХД-ийн Тамгын газар хувийн хэргийн бүрдүүлбэрийг хуульд заасан журмын дагуу тусгай хавтас нээж, тухайн шийдвэрт хамаарах нотлох баримтуудыг дугаарлаж, холбогдох гэрэл зураг, гэрчийн мэдүүлэг зэргийг багтаасан байв /Хавсралт 4/. Энэ талаар холбогдох төрийн албан хаагчтай ярилцлага хийхэд:

Хувийн хэргийн бүрдүүлбэр хийх нь чухал ач холбогдолтой. Жишээ нь их хэмжээний төсвийн мөнгө зарцуулах шийдвэр гаргая . Тэгвэл төсөл хариуцсан хэлтэс холбогдох саналаа гаргаахд хувийн хэрэгт өгнө, хуулийн хэлтсийнх хуульд нийцэж байгаа эсэхийг хянана, ингээд холбогдох нотлох баримтуудыг бүрдүүлээд шийдвэр гаргана. Магадгүй маргаан үүсвэл тухайн үед хэн ямар саналтай байсан, хэрхэн материал өгч байсныг хувийн хэргээс харах боломжтой. Шүүх дээр очиход ч бэлэн нотлох баримттай сууж байна. Харин манай зарим шүүгч нар захиргааны шийдвэр гаргаж байсан үеийн нотлох баримтад ач холбогдол өгөхгүй байгаад гайхдаг. Эндээс ашиг сонирхлын зөрчил байж болохоор юм. Уг нь шийдвэр анх гарч байх үеийн нотолгоо ч чухал шүү дээ. Ер нь ЗЕХ-гарсан захиргааны байгууллагын дур зоргоор шийдвэр гаргадаг явдлыг таслан зогсоох, шүүхийн хувьд шийдвэрээ гаргахад хэрэгтэй материаллаг хууль гарсан нь ач холбогдолтой юм. Даан ч хуулиа хэрэгжүүлэхдээ аль аль нь сул байна гэж дүгнэж байна. хувийн хэргийн хувьд бага зэрэг зардал өсч байгаа нь үнэн. Бид энэ асуудлыг шийдэх гэж олон хувилбар гаргасан. Цахим хэлбэр гэх мэт. Гэхдээ бас үүнийг хүндрэл гэж үзэж болохгүй. Төсөвт энэ зардлыг нэмж өгч болно шүү дээ.

pdfelement

**Дүгнэлт**

Захиргааны шийдвэрийн хувийн хэрэг, хяналтын дагалдах хуудасны талаар судалгаанд хамрагдсан захиргааны байгууллагуудаас хуульд заасан журмын дагуу хөтөлж байгаа нь Нийслэлийн засаг даргын Тамгын газар, СХД-ийн Тамгын газар байна. Ихэнхи байгууллагаас гарч буй санал бол зардал ихтэй, архив, хадгалалттай холбоотой бэрхшээлүүд гарч байна гэжээ.

Зорилгодоо хүрсэн байдлын шалгуураар авч үзвэл хувийн хэргийн бүрдүүлбэр байхыг захиргааны байгууллага, шүүгч нар дэмжсэн тул хангалттай гэж үзлээ. Харин практикт хэрэгжиж буй байдлын шалгуур үзүүлэлтийн хувьд хангалтгүй гэж дүгнэж байна.

**3.9. 31 р зүйл**

*Хүснэгт 25. Шалгуур үзүүлэлт 1*

| **Үнэлэгдэх хэсэг** | Зөвлөгөө, мэдээлэл өгөх |
|---|---|

Remove Watermark Now

| | |
|---|---|
| | 31.1.Захиргааны байгууллага захиргааны шийдвэр гаргахтай холбоотой мэдээлэл өгөх үүрэгтэй.<br><br>31.2.Оролцогчоос гаргасан хүсэлт, тайлбар, мэдээлэл зэрэг нь захиргааны шийдвэр гаргах ажиллагааны явцад бүрэн бус, эсхүл буруу бичигдсэн байвал захиргааны байгууллага оролцогчид холбогдох зөвлөгөө өгөх үүрэгтэй. |
| **Хүлээн зөвшөөрөгдсөн байдал** | Оролцогчийн эрх, ашиг сонирхлыг хангасан заалт болсон эсэх, практикт бодитой хэрэгжиж байгаа болон энэ боломжоо ашиглахад бэрхшээл, хүндрэл байгаа эсэх |

**Үнэлгээ:**

Судалгааны санал асуулгад оролцсон иргэдээс санамсаргүй түүврийн аргаар 20 иргэнийг сонгож, ярилцлага хийсэн. Захиргааны байгууллагуудын шийдвэрийн талаар хэвлэл мэдээлэл, цахим хаяг, интернэтээс олж авдаг. Гэхдээ захиргааны шийдвэр гаргахаас өмнө иргэнд мэдээлэл өгч байгаа нь тодорхойгүй байдаг гэж гэр хороололд амьдардаг болон хөдөө орон нутгаас ирсэн иргэд хариулсан бол хотын төвийн оршин суугчдын хувьд мэдээллийг хангалттай олж авдаг гэж хариулсан байна. Харин төрийн үйлчилгээ авахад зөвлөгөө, туслалцаа үзүүлэх тал дээр муу гэж судалгаанд оролцсон бүх иргэд хариулж байв.

*Хүснэгт 26. Шалгуур үзүүлэлт 2*

pdfelement

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 31.2.Оролцогчоос гаргасан хүсэлт, тайлбар, мэдээлэл зэрэг нь захиргааны шийдвэр гаргах ажиллагааны явцад бүрэн бус, эсхүл буруу бичигдсэн байвал захиргааны байгууллага оролцогчид холбогдох зөвлөгөө өгөх үүрэгтэй. |
| **Практикт хэрэглэгдэж байгаа байдал** | Захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд оролцож буй иргэнд ямар хэлбэр, хугацаанд зөвлөгөө өгөх, энэ нь хуульд заасан чиг үүрэгт нь хамааралтай эсэх, хүндрэл, бэрхшээл байгаа эсэх |

**Үнэлгээ:**

Захиргааны байгууллагуудаас иргэдэд зөвлөгөө өгдөг эсэх талаар тодруулахад тоон мэдээлэл байхгүй, тодорхой хариулж мэдэхгүй байв. Зарим албан хаагчийн хувьд ийм үүрэгтэй гэдгээ мэдэхгүй байсан ба ажлын ачаалал ихэсгэх зохицуулалт болсон байна гэж шүүмжилж байв. Төрийн албан хаагчид үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхээс гадна олон тооны төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэмэлт ажлуудыг хийдэг, дээрээс нь иргэдэд зөвлөгөө өгөх үүрэг нэмэгдэх нь ажлын үр дүнд муугаар нөлөөлнө гээд хэрэв зөвлөх үүргийг хуульчилсан бол төсөвт нэмж орон тоо нэмэх, цалин хөлсийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж саналаа хэлсэн.

**3.10. 33- р зүйл**

*Хүснэгт 26. Шалгуур үзүүлэлт 1*

Remove Watermark Now

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 33-р зүйл |
| **Практикт хэрэглэгдэж байгаа байдал** | Хугацааны зохицуулалт нь практикт бодитой хэрэгжих боломжтой эсэх |

**Үнэлгээ:**

Судалгаанд хамрагдсан захиргааны байгууллагын албан хаагчдаас энэ заалтын талаар асуухад ямар нэгэн санал алга гэж хариулсан тул шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэх боломжгүй болсон.

## ЗӨВЛӨМЖ

**1. Үнэлгээ хийхэд гарч байсан бэрхшээл**

Манай улсад хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээний нэгдсэн мэдээллийн сан байхгүй тул аливаа хууль зорилтод заасан үр дүндээ хүрсэн эсэхийг тоон шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд бэрхшээлтэй байдаг. Хэдийгээр чанарын буюу ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулж байгаа ч төрийн албан хаагчийн өгч буй мэдээллийн бодитой байдал эргэлзээтэй. Учир нь үр дүнгийн гэрээ, дээд албан тушаалтны дарамт зэрэг хүчин зүйлсээс хамаардаг билээ. Мөн захиргааны байгууллагуудын гаргасан шийдвэрийн нэгдсэн сан хангалтгүй, мэдээллийн ил тод байдал муу байгаа тохиолдолд бичиг баримтын шинжилгээ хийхэд хүндрэл гардаг. Энэ судалгааны явцад эдгээр бэрхшээлүүд харьцангуй бага гарсан нь ХЗДХЯ-ны зохион байгуулалт сайтай үйл ажиллагаанаас хамаарч байсныг дурьдахгүй өнгөрч болохгүй.

**2. Огт хэрэгжээгүй заалт**

-ЗЕХ-ийн үнэлгээ хийсэн зүйл, заалтуудын зорилгодоо хүрсэн байдлын шалгуур үзүүлэлтээр нь авч үзвэл практикт үр дагаврууд гарсаар байхад тухайн хуулийн зохицуулалт огт үйлчлэхгүй байна. Үүнд: ЗЕХ-ийн 13.4, 27.3, 27.7, 28.2 –р зүйл тус тус багтана.

Энэ нь хуулийн заалтын агуулга ойлгомжгүй, хэрэгжих боломжгүй байдлаас бус харин захиргааны байгууллагын санаачилгагүй, хэрэгжүүлэх хүсэл зориггүйгээс шууд шалтгаалж байна.

-Хуулийн зохицуулалтын агуулга, томъёолол ойлгомжгүйгээс хэрэгждэггүй заалтад 11.4-ийг оруулж байна. Захиргааны байгууллагын зүгээс тавьж буй саналд ямар үйл ажиллагаа байхыг тодорхойлсон тайлбар хэрэгтэй гэжээ.

-24, 25- р заалт буюу нөхцөл байдлыг тогтоох, нотлох баримтыг цуглуулах талаар захиргааны байгууллагууд ЗЕХ-д заасан журмын дагуу хийж байгаа талаар нотолгоо бүхий шийдвэрүүд гаргахгүй байна. Энэ нь захиргааны байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан, албан хаагчдын мэдлэг, ур чадвараас хамаарч байна гэж үзлээ. Иймд сургалт явуулах шаардлагатай.

-Мэдээллийн сан хангалттай биш тохиолдолд үнэлгээ хийхэд бэрхшээл гардаг тул Хууль тогтоомжийн тухай хуулиар хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийхээр заасан нь чухал зохицуулалт болсон.

-Судалгаа хийж байх явцад зарим заалт практикт огт хэрэгжээгүй байгаа нэг хүчин зүйл бол үнэлгээ хийх хугацаанаас бас хамаарч байсан.

pdfelement

### 3. Хэрэгжиж эхэлж байгаа заалт

Судалгаанд үнэлэгдсэн бусад зүйл, заалтууд энэ хэсэгт багтаж байна. Гэхдээ ихэнхи заалтын хувьд хэлбэрийн төдий хэрэгжиж эхэлж байна гэж үзлээ. Нийтлэг алдаа нь ЗЕХ-д заасан журмыгягштал баримтлаагүй, буруу хэрэглэсэн байна. Ж: сонсох ажиллагааны мэдэгдлийг захиргааны акт баталсны дараа хэрэглэдэг мэдэгдэх хуудас гэж ойлгох, сонсох ажиллагаа явуулаад тайлбар, санал өгөх хугацааг гаргадаггүй, иргэдээс саналыг аваагүй шалтгааны талаар тайлбар хийдэггүй зэргийг дурьдаж болно. Иймд сонсох ажиллагааны нарийвчилсан үлгэрчилсэн журмыг Засгийн газраас гаргах шаардлагатай байна.

ЗЕХ-ийн 103,105-р зүйлд заасан зохицуулалтын хэрэгжилт сайжирвал энэ бүлэгт нөлөөлөх боломжтой гэж таамаглал дэвшүүлж байна.

Remove Watermark Now
pdfelement

Remove Watermark Now

# II хэсэг. ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН 6 ДУГААР БҮЛГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

## НЭГ.ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

### 1.1.Үнэлгээ хийх шалтгаан

Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар бүлэгт үнэлгээ хийх шалтгаан нь захиргааны хэм хэмжээний актыг батлах, бүртгэх үйл ажиллагаагаа хэрхэн хуульд заасан журмын дагуу хэрэгжиж байгааг тандан судлах зорилготой.

### 1.2.Үнэлгээний хүрээг тогтоох

Захиргааны ерөнхий хуулийн 10 дугаар бүлгийн 59, 60.1.6, 64.1, 64.2, 64.3, 64.4, 64.5, 66.6, 66.7, 66.8, 67.1, 67.2, 67.3, 67.4, 67.5, 67.6 дугаар зүйлийн зохицуулалтыг үнэлэх бөгөөд үнэлгэдэх шаардлагатай зүйл, хэсгийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 1

| № | Үнэлгэдэх хэсэг, заалт |
|---|---|
| 1 | 59.1.Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно. 64.1.Захиргааны хэм хэмжээний актыг хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага батална |
| 2 | 60.1.6.хуулиар хориглоогүй асуудлаар хориглосон зохицуулалт тогтоохгүй байх |
| 3 | 64.2.Засгийн газраас баталсан захиргааны хэм хэмжээний акт /Засгийн газрын тогтоол/-ыг Улсын Их Хуралд хүргүүлнэ. |
| 4 | 64.3.Захиргааны хэм хэмжээний актыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянаж, бүртгэнэ. |
| 5 | 64.4.Захиргааны хэм хэмжээний актыг баталснаас хойш ажлын таван өдрийн дотор эрх бүхий байгууллагад хянуулж, бүртгүүлэхээр хүргүүлнэ. |
| 6 | 64.5.Сум, дүүргийн Засаг дарга гаргасан захиргааны хэм хэмжээний актаа ажлын 10 өдөрт багтаан дээд шатны Засаг даргаар дамжуулан хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. |
| 7 | 66.6.Хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага энэ хуулийн 66.3.2-т заасан дүгнэлтийг хүлээн авах үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ажлын 10 өдрийн дотор албан бичгээр хариу мэдэгдэнэ. |
| 8 | 66.7.Энэ хуулийн 66.6-д заасны дагуу ирүүлсэн мэдэгдлийг хүлээж авах үндэслэлгүй гэж үзвэл хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дүгнэлт гарган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ажлын 10 өдөрт багтаан хүргүүлнэ |

pdfelement

Remove Watermark Now

| | |
|---|---|
| 9 | 66.8Засгийн газар энэ хуулийн 66.7-д заасны дагуу ирүүлсэн дүгнэлтийг хуралдаанаараа хэлэлцэж уг дүгнэлтийг үндэслэн захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох эсэхийг шийдвэрлэнэ. |
| 10 | 67.1.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн захиргааны хэм хэмжээний актыг бүртгэсэн өдрөөс хойш 10 өдрийн дотор “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д бүрэн эхээр нь нийтлүүлнэ. |
| 11 | 67.3.Энэ хуулийн 67.2-т заасан шаардлагыг зөрчсөн тохиолдолд тухайн захиргааны хэм хэмжээний акт эрх зүйн үйлчлэл үзүүлэхгүй бөгөөд биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдэд үүрэг, хариуцлага хүлээлгэхгүй |
| 12 | 67.4.Хүчин төгөлдөр бус захиргааны хэм хэмжээний актыг дагаж мөрдүүлснээс үүсэх үр дагаврыг захиргааны хэм хэмжээний акт гаргасан хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага хариуцна. |
| 13 | 67.5.Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн, хүчин төгөлдөр болсон захиргааны хэм хэмжээний актыг бүрэн эхээр нь эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан болон баталсан байгууллагын цахим хуудсанд байршуулна.<br><br>67.6.Захиргааны хэм хэмжээний актыг үндэслэл болгох, хэсэгчлэн нийтлэх болон байгууллагын албан ёсны цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулахдаа улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн он, сар, өдөр, дугаарыг заана |

**1.3.Шалгуур үзүүлэлтийг тогтоох, томьёолох**

pdfelement

Энэ үе шатанд үнэлгээ хийх зүйл, хэсэг бүр дээр тогтоосон шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамгийг дэвшүүлж, асуулт тавих замаар шалгуур үзүүлэлтийг томьёолох юм. Ийнхүү шалгуур үзүүлэлтийг томьёолсноор үнэлгээний дараагийн алхамууд нь томьёолсон шалгуур үзүүлтэд хариулт өгөхөд чиглэгдэнэ.

Хүснэгт 2

| д/д | Үнэлгээний хүрээ | Шалгуур үзүүлэлт | Шалгуур үзүүлэлтийн томьёолол |
|---|---|---|---|
| 1 | 59.1.Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно.<br>64.1.Захиргааны хэм хэмжээний актыг хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага батална. | Зорилгодоо хүрсэн байдал | Онолын ойлголтыг ЗЕХ-д бүрэн, оновчтой тодорхойлж чадсан эсэх |
| | | Практикт хэрэглэгдэж байгаа байдал | Хууль хэрэгжүүлэхэд гарч буй бэрхшээл байгаа эсэх |

Remove Watermark Now

| | | | |
|---|---|---|---|
| 2 | 60.1.6.хуулиар хориглоогүй асуудлаар хориглосон зохицуулалт тогтоохгүй байх | Зорилгодоо хүрсэн байдал | Онолын ойлголтыг ЗЕХ-д бүрэн, оновчтой тодорхойлж чадсан эсэх |
| | | Практикт хэрэглэгдэж байгаа байдал | Хуулиар хориглоогүй асуудлаар хориглосон зохицуулалт хийхгүй байх нь төрийн захиргааны, УИХ-ын харьяа байгууллага болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын бүрэн эрхтэй хэрхэн нийцэж байгаа, бэрхшээл, хүндрэл |
| 3 | 64.2.Засгийн газраас баталсан захиргааны хэм хэмжээний акт /Засгийн газрын тогтоол/-ыг Улсын Их Хуралд хүргүүлнэ. | Практикт хэрэглэгдэж байгаа байдал | Засгийн газрын тогтоолыг УИХ-ын хүргүүлэх процесс хэрхэн явагдаж байгаа эсэх; |
| 4 | 64.3.Захиргааны хэм хэмжээний актыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянаж, бүртгэнэ. | Практикт хэрэглэгдэж байгаа байдал | Захиргааны байгууллагаас ХЗДХЯ-нд хүргүүлэх процеес хэрхэн явагдаж байгаа;<br><br>Хугацааны хувьд хэрэгжих боломжтой эсэх; |
| 5 | 64.4.Захиргааны хэм хэмжээний актыг баталснаас хойш ажлын таван өдрийн дотор эрх бүхий байгууллагад хянуулж, бүртгүүлэхээр хүргүүлнэ. | Практикт хэрэглэгдэж байгаа байдал | Хугацааны хувьд хэрэгжих боломжтой эсэх; |

pdfelement

Remove Watermark Now

| | | | |
|---|---|---|---|
| 6 | 64.5.Сум, дүүргийн Засаг дарга гаргасан захиргааны хэм хэмжээний актаа ажлын 10 өдөрт багтаан дээд шатны Засаг даргаар дамжуулан хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. | Практикт хэрэглэгдэж байгаа байдал | Сумын Засаг дарга аймгийн Засаг даргаар хүргүүлэх процесс хэрхэн явагдаж байгаа, ялангуяа хугацаа их эсхүл бага эсэх |
| 7 | 66.6.Хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага энэ хуулийн 66.3.2-т заасан дүгнэлтийг хүлээн авах үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ажлын 10 өдрийн дотор албан бичгээр хариу мэдэгдэнэ. | Практикт хэрэглэгдэж байгаа байдал | Захиргааны байгууллагаас ХЗДХЯ-ны дүгнэлтийг ямар үндэслэлээр хүлээн авахгүй байна вэ? |
| 8 | 66.7.Энэ хуулийн 66.6-д заасны дагуу ирүүлсэн мэдэгдлийг хүлээж авах үндэслэлгүй гэж үзвэл хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дүгнэлт гарган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ажлын 10 өдөрт багтаан хүргүүлнэ | Практикт хэрэглэгдэж байгаа байдал | Засгийн газарт Үндсэн хууль болон Засгийн газрын тухай хуулиар олгогдсон бүрэн эрх мөн эсэх; |
| 9 | 66.8Засгийн газар энэ хуулийн 66.7-д заасны дагуу ирүүлсэн дүгнэлтийг хуралдаанаараа хэлэлцэж уг дүгнэлтийг үндэслэн захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох эсэхийг шийдвэрлэнэ. | Зорилгодоо хүрсэн байдал | Онол, арга зүйн алдаатай эсэх |
| | | Практикт хэрэглэгдэж байгаа байдал | Засгийн газарт Үндсэн хууль болон Засгийн газрын тухай хуулиар олгогдсон бүрэн эрх мөн эсэх; |
| 10 | 67.1.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн захиргааны хэм хэмжээний актыг бүртгэсэн өдрөөс хойш 10 өдрийн дотор “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д бүрэн эхээр нь нийтлүүлнэ. | Практикт хэрэглэгдэж байгаа байдал | Хэм хэмжээний актыг бүртгэх, эмхэтгэлд нийтлүүлэхэд ямар хугацаа зарцуулж байгаа болон үүнтэй |

pdfelement

| | | | |
|---|---|---|---|
| | | | холбоотой ямар үр дагавар гарах эсэх; |
| 11 | 67.3.Энэ хуулийн 67.2-т заасан шаардлагыг зөрчсөн тохиолдолд тухайн захиргааны хэм хэмжээний акт эрх зүйн үйлчлэл үзүүлэхгүй бөгөөд биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдэд үүрэг, хариуцлага хүлээлгэхгүй | Практикт хэрэглэгдэж байгаа байдал | Хууль хэрэгжүүлэхэд гарч буй бэрхшээл байгаа эсэх |
| 12 | 67.4.Хүчин төгөлдөр бус захиргааны хэм хэмжээний актыг дагаж мөрдүүлснээс үүсэх үр дагаврыг захиргааны хэм хэмжээний акт гаргасан хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага хариуцна. | Практикт хэрэглэгдэж байгаа байдал | Хууль хэрэгжүүлэхэд гарч буй бэрхшээл байгаа эсэх |
| 13 | 67.5.Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн, хүчин төгөлдөр болсон захиргааны хэм хэмжээний актыг бүрэн эхээр нь эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан болон баталсан байгууллагын цахим хуудсанд байршуулна.<br><br>67.6.Захиргааны хэм хэмжээний актыг үндэслэл болгох, хэсэгчлэн нийтлэх болон байгууллагын албан ёсны цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулахдаа улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн он, сар, өдөр, дугаарыг заана | Практикт хэрэглэгдэж байгаа байдал | Хууль хэрэгжүүлэхэд гарч буй бэрхшээл байгаа эсэх |

### 1.4 .Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

- Чанарын буюу экспертийн болон бүлгийн ярилцлага

1.УИХ-аас байгууллагддаг захиргааны байгууллага, яам, нийслэлийн Засаг дарга, ИТХ, дүүргийн Засаг даргын Тамгын газар, нэг аймаг, нэг сумын захиргааны байгууллагын албан тушаалтан, төрийн албан хаагчдыг хамруулах,
2. Нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нар,
3. Захиргааны эрх зүйгээр мэргэшсэн судлаач багш, өмгөөлөгч нар
4. Санамсаргүй түүврийн аргаар иргэд

- Баримт бичгийн судалгаа
    - Сурах бичиг, судлаачдын бүтээл
    - Шүүхийн шийдвэрт шинжилгээ хийх
    - Захиргааны байгууллагын шийдвэрт шинжилгээ хийх



Remove Watermark Now
pdfelement

Remove Watermark Now

## ХОЁР.ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон мэдээлэл цуглуулах аргыг ашиглан 2018 оны 04 дүгээр сарын 01-ээс 05 дугаар сарын 01-ний өдрийн хооронд хэрэгжүүлэх үе шатыг хийж гүйцэтгэв.

➢ Чанарын судалгаа буюу ярилцага

- Захиргааны байгууллага дээр очиж, холбогдох 50 албан тушаалтан, албан хаагчаас ярилцлага авсан.

Хүснэгт 3

| № | Байгууллага | Биелэлт |
|---|---|---|
| 1 | Нийслэлийн ИТХ | 4/16 |
| 2 | Нийслэлийн ЗДТГ | 4/16 |
| 3 | ЗГХЭГ | 4/19 |
| 4 | Монголбанк | 4/23 |
| 5 | УИХ-ын Тамгын газар | 4/23 |
| 6 | Санхүүгийн зохицуулах Хороо | 5/1 |
| 7 | Төрийн албаны Зөвлөл | 4/30 |
| 8 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | 4/27 |
| 9 | Эрүүл мэндийн яам | 5/4 |
| 10 | Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ | 5/11 |
| 11 | Орхон аймаг | 6/ |
| 12 | Булган аймгийн Тэшиг сум | 6/ |
| 13 | Дорнод аймаг | 4/10 |
| 14 | Дорноговь аймаг | 5/16 |
| 15 | Хууль зүйн Үндэсний Хүрээлэн | |
| 16 | Хууль зүйн яам | |

- Шүүгчдээс авсан бүлгийн ярилцлагыг нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 3 шүүгчээс авсан.
- 9 судлаачаас ярилцлага авсан.

.

➢ Баримт бичгийн судалгаа

- Шүүхийн 61 шийдвэрт шинжилгээ хийсэн.
- Захиргааны байгууллагын 70 хэм хэмжээний актад шинжилгээ хийсэн.

pdfelement

Remove Watermark Now

## ГУРАВ.ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Төлөвлөх үе шатанд Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар бүлгээс сонгож авсан үнэлэгдэх зүйл, хэсэг, заалт тус бүрийг хэрэгжүүлэх үе шатанд олж авсан мэдээлэл дээр тулгуурлан үнэлэх болно.

### 3.1. ЗЕХ-ийн 59, 64-р зүйл

*Хүснэгт 4. Шалгуур үзүүлэлт 1*

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 59.1.Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно.<br>64.1.Захиргааны хэм хэмжээний актыг хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага батална. |
| **Зорилгодоо хүрсэн байдал** | онолын ойлголтыг ЗЕХ-д бүрэн, оновчтой тодорхойлж чадсан эсэх |

**Үнэлгээ:**

- Ярилцлага

*Хуулиар тусгайлан эрх олгогдсон байх шинжийн талаар*

Судалгаанд хамрагдсан 14 захиргааны байгууллага буюу албан хаагчдаас ярилцлага авахад Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын зүгээс дараах тайлбарыг өгсөн.

pdfelement

Хурлын ажлын алба:

Хурлыг захиргааны байгууллага гэж үзэх үү, Үндсэн хуулийн байгууллага гэж үзэх үү гэдэг асуудал гардаг. Нэрнээсээ эхлээд маргаан гардаг. Шүүх бол Үндсэн хуулийн байгууллага гэдэг бол, Хууль зүй, дотоод хэргийн яам захиргааны байгууллага хэм хэмжээний актаа бүртгүүл гэдэг. Хуульд захиргааны байгууллага гэдэгт ИТХ-ыг багтаасан. Хууль хэрэгжих явцад гарч буй асуудал нь Үндсэн хуулийн 62 дугаар зүйлийн 62.2 дахь хэсэгт бие даасан шийдвэр гаргана гэж заасан байгаа. Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагаас гаргах актыг бүртгэх, ялангуяа хэм хэмжээний актыг бүртгэх асуудал нь яаманд харьяалагдах уу үгүй юу гэдэг нь онолын болоод эрх зүйн зохицуулалтын хувьд маргаантай байгаа. Жишээ нь, дүүргүүдийн хурал дээр газрын бүтцийг тогтоох маргаанд шүүх бүртгүүлэх шаардлагагүй гэж үздэг.

Хурлын төлөөлөгч 1:

Өмнөх журмуудын хувьд хуульд нь бүртгүүлнэ гэсэн зохицуулалт байхгүй, дагаж мөрдөх журмын хууль байхгүй учраас нэгжийн хуулиар шийдвэр гарснаар хүчин төгөлдөр болсон байгаа. Тэгэхээр үүнийг хууль бус, хүчингүй гэж үзэх үндэслэлгүй юм. Хууль батлагдсанаас хойшхи асуудлын хувьд ЗЕХ-ийн 62.1-д заасныаар хуулиар тусгайлан олгосон эрх биш гэвэл нэгжийн хуулиар ИТХ бие даан шийдэж шийдвэр гаргасан бол үүнийг ХЗЯ-нд бүртгүүлэх шаардлагагүй болж байгаа юм. Тэгэхээр үүнийг ялгаж салгаж дүгнэлт өгмөөр байна.

Хурлын төлөөлөгч 2:

ИТХ-аас 1990 оноос хойш 76 орчим нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний акт гаргаад байгаа. Эдгээрийг ЗЕХ-тайгаа нийцэж байгаа эсэх нь өөр асуудал болоод байгаа. Тодорхой хэм хэмжээний актыг ИТХ-ын тэргүүлэгчдээс батлаад ХЗЯ-нд хүргүүлээд уг

Remove Watermark Now

яам ЗЕХ-тай нийцэхгүй байна гэсэн албан бичгүүд ирүүлсэн бий. Мөн хууль дүрмийн хүрээнд нийтээр мөрдөх акт гаргах атал гаргаагүй тохиолдол ч бий. Ойрын хугацаанд буюу 2-р улирлаас ИТХ-аас ямар арга хэмжээ авч, яаж зохион байгуулж байна вэ гэхээр 76 хэм хэмжээний актаа ямарч гэсэн хуульдаа нийцүүлээд мөн цаг үеийн шаардлага хангахгүй болсон хэм хэмжээний актаа хүчингүй болгох талаар саналаа ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар оруулахаар явж байна. Хуульд нийцүүлээд хэрэглэж болох актуудаа дахин хянан үзээд хуралд өргөн бариад хуульд заасны дагуу нөлөөллийн шинжилгээ хэлэлцүүлэг хийгээд авч явахаар болж байгаа. Өөр нэг зүйл бол Тэргүүлэгчид хэм хэмжээний акт гаргана гэдэг зохицуулалт хуульд байхгүй.

Төрийн албан хаагч:

Хэрэв хуульд нийцүүлнэ гэвэл 70 хуулийг өөрчилж байж хуулиар тусгайлан эрхээ олсны дараа журмуудаа ХЗЯ-д бүртгүүлэх боломж үүснэ. Харин Хурлын хувьд Үндсэн хуулийн 62 дугаар зүйлд зааснаар хуулиар зохицуулаагүй харилцааг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохицуулж болохоор зааснаар олон журам гарсан.

Мөн энэ талаар судлаачдаас үнэлгээ авсан.

Судлаач 1:

Захиргааны хэм хэмжээний актын үндсэн шинж болохын хувьд Захиргааны ерөнхий хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэхээс өмнө ч хэм хэмжээний актыг батлан гаргах болон шүүхээр хэрэг маргаан шийдвэрлэхэд гол үндэслэл, шаардлага болсоор ирсэн. Харин онцлог шинжтэй зарим бие даасан агентлаг, НӨУБ зэрэг гүйцэтгэх эрх мэдэлд шууд хамаарахгүй субьектуудаас баталж буй хэм хэмжээний актын хувьд нэмэлт зохицуулалт, тайлбар шаардлагатай байна.

Тухайлбал, НӨУБ-ын хувьд өөрийн бүрэн эрхийн хүрээнд хэм хэмжээний актыг батлах эрхийг Үндсэн хуулийн 62 дугаар зүйлээр олгосон гэж дүгнэж болохоор байна. Гэтэл практикт ихэнхдээ органик болон ердийн хуулиар эрх олгогдсон байхыг ойлгодог тул Үндсэн хуулиар олгогдсон эрхийн дагуу гаргах хэм хэмжээний актын онцлог зохицуулалтыг дараах агуулгаар тодруулан тусгаж болох юм.

1. НӨУБ-аас Үндсэн хуулийн 62.2-т заасны дагуу гарч буй НӨУЁ-ны зарчмын хүрээнд орон нутгийн шинжтэй асуудлыг шийдвэрлэхээр бие даан гаргаж буй хэм хэмжээний актын хувьд органик болон ердийн хуулиар тусгайлан эрх олгогдсон байхыг шаардах боломжгүй юм. Мөн нэгэн өөрийн бүрэн эрхийн хүрээнд гаргасан тул урьдчилсан хяналтыг хэрэгжүүлэх гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас хүчингүй болгох нь одоогийн хууль тогтоомжийн хүрээнд үндэслэлгүй юм.[61]
2. Харин НӨУБ-аас органик болон ердийн хуулиар тусгайлан олгогдсон эрхийн (шилжүүлсэн) эрхийн хүрээнд хэм хэмжээний акт баталсан бол хэм хэмжээний актын шинж, шаардлагыг бүрэн хангасан байхыг шаардах нь тохиромжтой байна.

Судлаач 2:

**Онолын талаас:** Төрийн эрх мэдэл хуваарилах онолын үүднээс гүйцэтгэх эрх мэдэл нь хууль тогтоох байгууллагаас баталсан хуулийг хэрэгжүүлэх учиртай. Өөрөөр хэлбэл нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоох эрх мэдэл гагцхүү хууль тогтоох байгууллага буюу парламентад байна. Иймд нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоох ажил нь гүйцэтгэх эрх мэдлийн буюу захиргааны байгууллагын үндсэн хийх ёстой ажил биш юм.

---

[61] ЗЗНДНТУтХ-ийн 25.4-т хурал өөрөө буюу НӨУБ нь өөрөө шийдвэрээ өөрчлөх хүчингүй болгох эрхтэй байхаар тусгасан байдаг. Гэтэл Захиргааны ерөнхий хуулийн 66.8-д “Засгийн газар энэ хуулийн 66.7-д заасны дагуу ирүүлсэн дүгнэлтийг хуралдаанаараа хэлэлцэж уг дүгнэлтийг үндэслэн захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох эсэхийг шийдвэрлэнэ” хэмээн зөрчилдөөнтэй зохицуулалтыг тусгасан.

Remove Watermark Now

Гэвч парламент тодорхой салбарын өдөр тутмын харилцааг цаг тухайд нь бүрэн гүйцэт зохицуулсан хэм хэмжээ гаргах бололцоогүй байдаг тул гүйцэтгэх эрх мэдэлд уг эрх мэдлээ шилжүүлэх шаардлага гардаг.

Энэ ч үүднээс захиргааны хэм хэмжээн тогтоосон акт хүчин төгөлдөр байх хамгийн эхний шаардлага бол “хуулиар тусгайлан эрх олгогдсон”-ы дагуу захиргааны байгууллагаас батлагдсан байх явдал юм. Түүнчлэн захиргааны хэм хэмжээний актад “хуульд нийцсэн байх, хуулиар хориглоогүй асуудлаар хориглосон зохицуулалт тогтоохгүй байх буюу хуульд заасанаас өөрөөр шинээр эрх, үүрэг үүсгэсэн агуулгатай байх боломжгүй байх нь зүйн хэрэг билээ.

Харин Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2-т “Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие дааж шийдвэрлэж болно” гэж заасны дагуу нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагас гаргасан захиргааны хэм хэмжээ тогтоосон актыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захирганы төв байгууллага хэрхэн бүртгэхийг хуулиар нарийвчлан зохицуулах нь зүйтэй болов уу.

Шүүгч:

Хэм хэмжээний акт дээр маргаж байгаа зүйл бий. Жишээ нь ТҮЦ-ний асуудлаар хэд хэдэн маргаан хэм хэмжээний акттай холбоотой. НИТХ-аас ТҮЦ-ний журмыг батлаад ХЗЯ руу явуулахад уг яам та нарын гаргасан шийдвэр хуулиас давсан зохицуулалттай байгаа тул хүчингүй болго гэдэг дүгнэлт гаргасан. Гэтэл одоо уг журам хүчинтэй ТҮЦ эрхлэгч нарт шаардлагаа тавьж байгаа. Эхлээд уг актыг хүчингүй болгуулахаар хандахад нь 2 удаа татгалздаг. Татгалзсан шалтгаан нь хэм хэмжээний акт биш байна, учир нь ХЗЯ-д бүртгүүлээгүй байна гэж үзсэн. Одоо болохоор НИТХ өөрөө хүчингүй болгохгүй байгаа тул уг актыг хүчингүй болгуулж өгөөч гэдэг шаардлага тавиад байгаа. НИТХ-аас хийсэн тайлбар нь ИТХ бол нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага учраас ЗГ-т оруулах асуудал байхгүй. Ер нь бол ХЗЯ-д бүртгүүлэхгүй гэдэг зүйл яриад байгаа.

pdfelement

Төрийн албан хаагч:

Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид зааснаар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь нутгийн өөрөө удирдах байгууллага бөгөөд түүний бие даасан байдлыг уг хууль тогтоомжоор баталгаажуулж өгсөн. Тодруулбал, Монгол Улсын Үндсэн Хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.1.7, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын дагуу нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол бие даан шийдвэрлэх бүрэн эрхтэй.

Онолын судалгаа:

Захиргааны хэм хэмжээний актыг батлан гаргаж буй субъектээр нь 1. Хуулиар тусгайлан эрх шилжүүлсний үндсэн дээр гаргасан хэм хэмжээний акт, 2. Бие даан гаргасан хэм хэмжээний акт 3. Захиргааны дотоод журам

Бие даасан хэм хэмжээний актыг гаргахад салбар мэргэжлийн хуулиар тусгайлан эрх олгосон байх шаардлагыг тавьдаггүй. (П.Одгэрэл. Захиргааны эрх зүйн ерөнхий анги.2016).

Төрийн албан хаагч:

Remove Watermark Now

Хуулиар эрх олгогдсон байхыг шаардах зөв. Гэхдээ амьдрал өөрөө баялаг, тухайн салбарт үүссэн тохиолдлыг түргэн шуурхай зохицуулах гэтэл хуулиар эрх олгоогүй байнаа гээд ямар нэгэн шийдвэр гаргахгүй байснаас бий болсон сөрөг үр дагаврыг яах вэ? Мэдээж хууль тогтоогчид энэ талаар мэдэгдэж холбогдох хуулинд заалт оруулж болно. Гэтэл манай хууль тогтоох процесс хэр зэрэг түргэн шуурхай явдаг билээ. Тиймээс бид хууль хэрэгжүүлэхдээ энэ бүх хүчин зүйлийг сайн тооцож байх хэрэгтэй болов уу?

Судалгаанд хамрагдсан бусад байгууллагын хувьд тухайлбал УИХ-аас томилогддог байгууллагын хувьд хуулиар тусгайлан эрх олгогдсны дагуу шийдвэр гаргах ёстой гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд харин бүртгэх үйл ажиллагаатай холбоотой зарчмын өөр саналтай байсан(энэ тухай холбогдох зүйл, заалт дээр яригдана).

Төрийн захиргааны байгууллага бол ЗЕХ-д заасан журмын дагуу эрх олгогдсны дагуу хэм хэмжээний актыг батлан гаргах талаар мэдээлэлтэй байсан.

*Гадагш чиглэсэн байх шинжийн талаар*

Судалгаанд хамрагдсан байгууллагуудын хувьд захиргааны хэм хэмжээний актын энэ шинжийн талаарх ойлголт харьцангүй сайн байсан. Гэхдээ чиг үүргийн дагуу хянадаг байгууллагуудтай холбоотой гаргасан журмыг захиргааны хэм хэмжээний акт мөн эсэх талаар эргэлздэг тухайгаа саналаа хэлж байв.

Төв банкнаас арилжааны банк руу чиглэсэн актууд нь нийтэд чиглэсэн захиргааны хэм хэмжээний акт биш буюу гадагш чиглэсэн шинжгүй байна гэсэн дүгнэлтийг өгч байсан.

Монголбанкны албан хаагч

pdfelement

*Хүснэгт 5. Шалгуур үзүүлэлт 2*

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 59.1.Захиргааны хэм хэмжээний акт гэж хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагаас нийтээр заавал дагаж мөрдүүлэхээр гаргасан, гадагш чиглэсэн, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй шийдвэрийг ойлгоно.<br>64.1.Захиргааны хэм хэмжээний актыг хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага батална. |
| Практикт хэрэглэгдэж байгаа байдал | Захиргааны байгууллагад гарч буй бэрхшээл, хүндрэл байгаа эсэх |

**Үнэлгээ:**

Төрийн захиргааны байгууллагын хувьд ЗЕХ гарахаас өмнө Засгийн газрын 119-р тогтоолын дагуу захиргааны хэм хэмжээний актыг баталж, мөрдүүлж байсан тул хуулиар тусгайлан эрх олгох заалтын дагуу хэм хэмжээний актаа гаргаж байгаа гэж ярилцлагад оролцсон төрийн албан хаагч нар хариулж байв.

Харин ИТХ-ын хувьд зорилгодоо хүрсэн байдлын шалгуураар гарч ирсэн онол, практикийн маргаантай асуудлаас болж хэрэгжилт хангалтгүй байна. Жишээ нь: Нийслэлийн ИТХ-ын хувьд 76 журам үйлчилж байна. Эдгээрээс хэд нь эрх олгогдоогүй

Remove Watermark Now

заалтын хүрээнд байна вэ гэсэн асуулт тавьж, бичгээр хариу өгөхийг хүссэн боловч хариу ирүүлээгүй болно.

УИХ-ын харьяа байгууллагын хувьд энэ заалтын дагуу хэм хэмжээний актаа гаргаж ажиллаж байгаа гэж холбогдох албан хаагч нар хариулсан. Монголбанкны хувьд 90 журам байгаа ч зөвхөн 2 нь бүртгэлтэй байна. Санхүүгийн зохицуулах Хороо 170 журам баталсан ч бүртгэл хангалтгүй. Төрийн албаны Зөвлөлийн 2019 оноос Төрийн албаны шинэ хууль хэрэгжиж эхлэхээс өмнө өөрт хамаарах журмуудаа шинэчлэх ажлын хэсэг гарч ажиллаж байна.

Харин судалгаанд хамрагдсан бүх захиргааны байгууллагууд хуулиар тусгайлан эрх олгогдсон хуулийн хэдэн заалт байдаг талаар тодорхой судалгаа байхгүй, тоон мэдээлэл өгч чадахгүй байна.

**Дүгнэлт**

1. ИТХ-ын Үндсэн хуулиар олгогдсон бие даасан шийдвэр гаргах эрх ба хуулиар түүнд шилжүүлсэн чиг үүрэг гэж байдаг. Тиймээс Хурлын гаргаж буй захиргааны хэм хэмжээний актыг энэ хоёр шинжээр нь ялгаж ЗЕХ-ийн энэ заалтыг хэрэглэх нь зүйтэй болов уу.
2. Захиргааны байгууллагууд өөрт тусгайлан эрх олгогдсон эсэх талаар салбарын хуулиудад судалгаа хийж тоон мэдээллийн сан бүрдүүлэх шаардлагатай байна. Ингэснээр салбарын хүрээнд хяналт шинжилгээг тогтмолжуулах, хуулиар зохицуулаагүй асуудлаар тохиолдол үүсэх эсэхийг урьдчилж судалж, хэрэв тийм нөхцөл байдал гарсан бол дээд шатны байгууллага, хууль тогтоогч нарт саналаа хүргүүлэх зэрэг процессын харилцааг зохицуулж өгөх
3. Хаанаас байгуулагдсан (ИТХ-ын бие даасан шийдвэр гаргах эрхээс бусад) эсэхээс үл хамааран гадагшаа чиглэсэн байнгын үйлчлэлтэй хэм хэмжээний акт гаргах гэж байгаа бол заавал эрх олгогдсон байхыг шаардах

pdfelement

### 3.2. ЗЕХ-ийн 60.1.6-р зүйл

*Хүснэгт 6. Шалгуур үзүүлэлт 1*

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 60.1.6.хуулиар хориглоогүй асуудлаар хориглосон зохицуулалт тогтоохгүй байх |
| **Зорилгодоо хүрсэн байдал** | Онолын ойлголтыг ЗЕХ-д бүрэн, оновчтой тодорхойлж чадсан эсэх |

**Үнэлгээ:**

Энэ заалтын хувьд мөн ИТХ-ын бүрэн эрхийн хүрээнд яригдсан. Хурлын ажлын алба, төлөөлөгч нартай ярилцлага хийхэд энэ заалтыг хэрэгжүүлэхэд бэрхшээл байна гэж саналаа хэлж байв.

Судлаач 1:
Захиргааны хэм хэмжээний акт шилжүүлсэн хууль тогтоомж болохынхоо хувьд эрх зүйн тодорхой зохицуулалт бий болгож хамаарах этгээдүүдэд хуульд шууд заагаагүй эсхүл тодорхой заагаагүй эрх, үүргийг үүсгэж, өөрчилж дуусгавар болгодог. Нөгөө талаар хэдий хуулиар хориглоогүй боловч тухайн орон нутгийн онцлогоос хамаарч НӨУБ-аас

Remove Watermark Now

баталсан хэм хэмжээний актдаа хориглосон зохицуулалт тусгах боломжгүй байх нь өөрөө удирдлагын байгууллагын “бие даан шийдвэрлэх” орон нутагтаа өөрийн удирдлагыг хараат бусаар хэрэгжүүлэх нөхцөлийг хязгаарлах үр дагавартай байж болох юм. Тиймээс уг шаардлагыг “хуулиар зөвшөөрсөн асуудлаар хориглосон зохицуулалт тогтоохгүй байх” гэсэн агуулгаар өөрчлөх нь зүйтэй байж болох юм.

Төрийн албан хаагч:

Захиргааны хэм хэмжээний актыг боловсруулахад энэ нь хүндрэл учруулдаг. Хуулиар хориглоогүй боловч, бодит нөхцөл байдалд хориглох зайлшгүй шаардлага гарч болно. Гэхдээ үүнээс илүү захиргааны байгууллага эрх шилжүүлэхийг хориглосон нь бодит нөхцөл байдалд хүндрэл учруулдаг. Хууль тогтоомжид Засаг даргын бүрэн эрхийг тодорхойлж, орон нутгийн агентлагууд ихэнх тохиолдолд хуулийн статусгүй байдаг. Иймээс бүх шийдвэрийг Засаг даргаар гаргуулах нь иргэн хуулийн этгээдэд хүндрэл үүсгэдэг.

*Хүснэгт 7. Шалгуур үзүүлэлт 2*

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 60.1.6.хуулиар хориглоогүй асуудлаар хориглосон зохицуулалт тогтоохгүй байх |
| Практикт хэрэглэгдэж байгаа байдал | Хуулиар хориглоогүй асуудлаар хориглосон зохицуулалт хийхгүй байх нь төрийн захиргааны, УИХ-ын харьяа байгууллага болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын бүрэн эрхтэй хэрхэн нийцэж байгаа, бэрхшээл, хүндрэл |

**Үнэлгээ:**

Судалгаанд хамрагдсан захиргааны байгууллагын шийдвэрт шинжилгээ хийсэн.

1. ИТХ-аас 1990 оноос хойш 76 орчим нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний акт гаргасан. Тэргүүлэгчид хэм хэмжээний акт гаргана гэдэг зохицуулалт хуульд байхгүй боловч 2016 оноос хойш 3 журмыг цахим хаягтаа байршуулсан байна. Хуулиар эрх олгогдоогүй журмаар зохицуулсан асуудал цөөнгүй байв.

ИТХ-аас гаргаж байгаа тогтоолд дугаарын хязгаарлалтын асуудал, нэгдүгээр эгнээний асуудал бий. Саяхан Нийслэлийн нийтийн тээврийн газар 4 хоног нэгдүгээр эгнээгээр явсан тээврийн хэрэгслийн зургийг аваад торгууль ногдуулах асуудал яригдсан. Гэтэл энэ асуудал нь Зөрчлийн тухай хуульд байхгүй.

ИТХ-ын төлөөлөгч

2. Үндэсний аудитын газар аудит хийх байгууллагууддаа хураангүй жагсаалт гэж гаргадаг. Энэ жагсаалтад байгаа байгууллагаас сонгож аудит хийлгэ гэдэг. Тухайн жагсаалтдаа журам гаргачихсан. Гэтэл Компанийн тухай хуульд ТӨК-ийн хувьд ТУЗ нь өөрөө сонгож аудит хийлгэнэ гэж заасан. Гэтэл ҮАГ нь журмаа батлаад энд заасан аудитын газруудаас сонго гэдэг. Тэгэхээр нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ХЗДХЯ руу энэ бүртгэсэн журам нь зөрчилтэй байгаа тул зөрчлийг арилгаач гэдэг бичиг явуулсан.

ЗГХЭГ-ын албан хаагч

Харин хэвлэл мэдээлэлд шинжилгээ хийж үзэхэд дараах тохиолдол гарсан байна.

Иргэн Цэвэгмид:

Замын хөдөлгөөний дүрэмд нэгдүгээр эгнээгээр явахыг хориглоно гэсэн заалт байхгүйгээр барахгүй нэгдүгээр, хоёрдугаар эгнээ гэсэн ойлголт ерөөсөө байдаггүй. Би нэгдүгээр эгнээгээр зорчихгүй гэсэн журам гарч эхэлсэн цагаас л нэг, хоёр, гуравдугаар эгнээ гэж хуулинд байхгүй. -2012 он Замын цагдаагаас Нийслэлийн засаг дарга Э.Бат-Үүлд Замын хөдөлгөөний ачаалал бууруулах найман зүйл бүхий санал танилцуулсан. Үүнийг нь НИТХ-ээр хэлэлцээд тэндээс батлагдсан журам.эвч энэ Засаг даргын захирамжийг Замын хөдөлгөөний дүрмийн заалт болгож хувиргадаг ажлаа Замын цагдаагийнхан хийж чадаагүй. Хөдөлгөөнд оролцож байгаа ямар ч жолооч замын тэмдэг тэмдэглэгээг нь хараад, замын хөдөлгөөний дүрмээ уншаад энэ эгнээ рүү орж болохгүй юм байна гэж мэддэг байх ёстой. Дүрэм журамдаа тусгаад өгчихсөн бол хотын даргын захирамж гэж харахаа болино. Тодруулж хэлбэл захирамжийг замын хөдөлгөөний дүрмийн заалт болгож оруулаагүйгээс өнөөдөр энэ журам нь хууль бус болчхоод, би тэмцээд байгаа юм.. Нийслэлийн засаг даргын захирамжид “Зорчих хэсгийн нэгдүгээр эгнээг нийтийн тээвэрт зориулна” гэж бичсэн байдаг. Зорчих хэсгийн нэгдүгээр эгнээ гэж байдаггүй байтал эд нар тийм захирамж гаргасан. Замын хөдөлгөөний зохион байгуулалтын зүгээс, мэргэжлийн түвшинд авч үзэхэд нийтийн тээвэрт зориулсан тусгай эгнээ гэж ярьдаг. Гэтэл өнөөдөр нэгдүгээр эгнээ гээд бүр хэвшчихсэн. Албаны хүмүүс нь, замын цагдаа нар нь хүртэл нэгдүгээр эгнээ гээд яриад сурчихсан. Ядаж нэр томьёоны хувьд зөв байх ёстой шүү дээ. 2012-2016 он хүртэл нэгдүгээр эгнээгээр явлаа гэж 648 мянган жолоочийг торгож хохироосон байна.

**Дүгнэлт**

1. Хуулиар хориглоогүй асуудал гэдгийг онол арга зүйн хувьд оновчтой тодорхойлох
2. Нөлөөллийн шинжилгээ болон хяналт шинжилгээ хийх явцад зайлшгүй хориглох нөхцөл байдал бий болсон үед дээд шатны байгууллага, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хандах процессыг нарийвчлан зохицуулах

pdfelement

**3.3. ЗЕХ-ийн 64.2 –р зүйл**

*Хүснэгт 8. Шалгуур үзүүлэлт 1*

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 64.2.Засгийн газраас баталсан захиргааны хэм хэмжээний акт /Засгийн газрын тогтоол/-ыг Улсын Их Хуралд хүргүүлнэ. |
| **Практикт хэрэглэгдэж байгаа байдал** | Засгийн газрын тогтоолыг УИХ-ын хүргүүлэх процесс хэрхэн явагдаж байгаа эсэх; |

**Үнэлгээ:**

Уг заалтын хэрэгжилтийг ЗГХЭГ, УИХ-ын Тамгын газрын холбогдох албан хаагчидтай ярилцлага хийсэн.

ЗГХЭГ:
Төрийн албан хаагч: 1
Өмнө нь бол Төрийн мэдээлэл сэтгүүлд нийтлүүлснээр хүчин төгөлдөр болдог байсан. Хууль тогтоомжийн тухай хуульд хууль тогтоомжийн эмхтгэл гэж оруулсан. Гэхдээ одоо бол УИХ-д хүргүүлээд төрийн мэдээлэлд нийтлүүлээд явж байгаа. Яагаад гэвэл Хууль

Remove Watermark Now

тогтоомжийн тухай хуульд заасан тэр хууль тогтоомжийн эмхтгэлд УИХ-ын хууль тогтоол орохоор заагаад Засгийн газрын шийдвэр, Ерөнхийлөгчийн зарлиг орохгүй болоод байгаа.

Төрийн албан хаагч 2:

Шүүхийн тухай хуульд шүүгч албан ёсоор хэвлэгдсэн хууль хэрэглэнэ гээд ч заасан. Шүүгч нар ЗГ-ын тогтоолыг нотлох баримтын шаардлага хангуулж ирүүлнэ үү гэдэг. Тэгэхээр хэрэв Төрийн мэдээлэлд хэвлэгдснийг явуулдаг.

Төрийн албан хаагч 3:

Одоо бол УИХ-д хүргүүлнэ гэж байгаа. Тэгэхээр яаж бүртгэж улсын нэгдсэн тогтолцоонд оруулна гэсэн үг вэ? гэдэг гаргалгаа алга. Гэтэл ЗГ-ын тухай хуулийн 30.9 дэх хэсэгт бүртгэнэ гээд орсон.

Жич: Засгийн газрын тухай хуулийн 30. 9.Засгийн газрын баталсан захиргааны хэм хэмжээний акт Захиргааны ерөнхий хуулийн 67.1, 67.2-т заасан журмын дагуу хүчин төгөлдөр болно.

УИХ-ын Тамгын газар:

Төрийн албан хаагч:

*Танай байгууллагад ЗГ-аас тогтоол ирүүлдэг. ЗЕХ хэрэгжсэнээс хойш хэдэн тогтоол ирүүлсэн бэ?*

--Ойролцоогоор 247 орчим тогтоол ирсэн. Гэхдээ бүх тогтоолоо ирүүлдэггүй. Хөрөнгө зарцуулах, нууцтай холбоотой тогтоолууд ирдэггүй.

*Хүргүүлсэн тогтоолыг хүлээж аваад хянах процесс байгаа юу?*

-----Байхгүй. Манайх хөдөлгөөнийг л хийдэг.

*Хэм хэмжээний акт хяналт шинжилгээ хийгээд, хянаж бүртгээд, нөлөөллийн шинжилгээ хийсэн эсэх гэдгийг шалгах ёстой?*

---Тийм зүйл бол байхгүй. Манай байгууллагад тийм чиг үүрэг байхгүй. Шийдвэр гарлаа хэвлэлтэд өгнө, нэмэлт өөрчлөлтөд кодификац хийж баяжуулалт хийдэг. Бусад орны парламентад үнэлгээ хийх асуудал байдаг байх. Манайд бол тийм зүйл алга.

pdfelement

## Дүгнэлт

Энэ заалтыг хэрэгжүүлэхэд Засгийн газраас гаргасан хэм хэмжээний актыг ЗЕХ-д заасан журмын дагуу бүртгэх, хянах эрх бүхий байгууллага нь ЗЕХ-даа тодорхойгүй байна. Харин Засгийн газрын тухай хуулийн 30. 9-д ХЗДХЯ-д байхаар хуульчилсан. Засгийн газар нь дээд шатны байгууллага тул салбарын яам нь хянах боломжгүй, мөн эрх мэдэл хуваарилах онолоор хууль тогтоох нь УИХ-д, шүүх эрх мэдлийг нь шүүхэд, гүйцэтгэх эрх мэдэл нь ЗГ-т байгаа. Гэтэл ЗГ-ыг нь захиргааны байгууллага гээд ЗЕХ-д хамаатуулж байгаа. Тэгвэл, захиргааны шүүх УИХ-ын шийдвэрийг ягаад хянаж болдоггүй вэ? Гэтэл энэ чинь адилхан эрх мэдлийн дээд байгууллага. Өөрөөр хэлбэл, гурван эрх мэдлээс ЗГ-ыг сугалж аваад ЗЕХ-нд хамаатуулаад захиргааны байгууллага гэж үзээд байгаа вэ? гэж ЗГХЭГ-ын албан хаагч нар үзсэн бол УИХ-ын Тамгын газрын албан хаагчид “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу УИХ хүчингүй болгоно” гэж Үндсэн хуульд заасны дагуу УИХ бүрэн хянах боломжтой гэж үзэж байна. ХЗДХЯ бүртгэж байгаа нь харьяа байгууллага гэдгээр хандаж байгаа асуудал биш. Хууль зүйн чиглэлийн бодлогыг хэрэгжүүлж байгаа яам гэдгээр бүртгэж байгаа. Энэ бол захирах захирагдах ёс биш. Энэ бол ХЗДХЯ чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой л асуудал гэж судалгаанд оролцсон шүүгч саналаа хэлж байв.

Remove Watermark Now

### 3.4. ЗЕХ-ийн 64.3 –р зүйл

*Хүснэгт 9. Шалгуур үзүүлэлт 1*

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 64.3.Захиргааны хэм хэмжээний актыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянаж, бүртгэнэ. |
| **Зорилгодоо хүрсэн байдал** | Онол, арга зүйн алдаа байгаа эсэх |

**Үнэлгээ:**

1. Судалгаанд хамрагдсан нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, УИХ-аас байгууллагддаг 8 байгууллага, судлаач, шүүгчтэй ярилцлага хийхэд захиргааны хэм хэмжээний актыг бүртгэх бүртгэх асуудал нь Хууль зүй, дотоод хэргийн яаманд харьяалагдах уу үгүй юу гэдэгт онолын болоод эрх зүйн зохицуулалтын хувьд маргаантай байгаа талаар саналаа хэлж байлаа.

Төрийн албан хаагч:

ЗЕХ батлагдснаас хойш ня-бо бүртгэл, нөгөөх нь цахим мөнгөний актыг бүртгүүлсэн байгаа. Монгол банкнаас 2000 оны дундуур бүртгүүлж байсан актууд www.legalinfo дээр байгаа. Бүртгүүлэхээ больсон учир нь, бүртгүүлэх талаар хуульд заагаагүй, МБ ЗГ-аас хараат бус байгууллага учраас үйл ажиллагаанд нь нөлөөлөхгүй гэдэг утгаар бүртгүүлээгүй гэж бойлгосон. ЗЕХ батлагдсанаас хойш бүртгүүлэх эсэх дээр асуудал яригдсан. Хуульд Сангийн яамтай хамтарч батална гэсэн актууд бий, үүнийг бүртгүүлж байгаа. Сүүлд Төв Банкны тухай хуульд өөрчлөлт ороход ОУВС-аас ТБ өөрийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэрээ бусдаар хянуулах нь ОУ-ын зарчимтай нийцэхгүй байна, учир нь санхүүгийн зах зээл хурдтай явж байгаа, ТБ үйл ажиллагаагаа явуулахад хэн нэг этгээд (шүүхээс бусад) дундаас нь хянах нь зохимжгүй байна гэсэн зөвлөмж өгсөн. Үүний дагуу ТБ-ны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахдаа банкны системын хэмжээнд гарч байгаа захиргааны хэм хэмжээний актыг бүртгүүлэхгүй гэж оруулсан боловч Хууль зүйн байнгын хороогоор дэмжигдээгүй. Тэгэхээр өмнө нь тогтсон бүртгүүлэх ёстой гэдэг ойлголттой болсон. Гэхдээ саналын хувьд УИХ-ын дэргэдэх байгууллага гэдгээрээ УИХ-д бүртгүүлж, хянуулах тогтолцоо нь илүү оновчтой болов уу.

Төрийн албан хаагч:

УИХ-аас байгууллагддаг байгууллага бүрэн эрхтэй, тэгэхээр бүрэн эрхээ хэрэгжүүлэх хүрээнд гаргасан журмаа Засгийн газрын байгууллагад бүртгүүлэх нь УИХ-аас байгууллагддаг байгууллагын бүрэн эрхэд халдах мэт асуудал гарна. Зарим нь үүнийг Үндсэн хуулиас давсан ч гэж үздэг. Бидний санал бол СЗХ УИХ-ын Тамгын газарт харьяалагдах учраас тэнд бүртгэлийн нэгж байсан нь дээр байх.

Энэ талаар судлаачийн санал:

Бухий л төрлийн хэм хэмжээний актыг нэгдсэн бүртгэл хяналтад оруулах, хууль тогтоомжид нь нийцүүлэх нь нэн чухал бөгөөд зайлшгүй үйл ажиллагаа. Энэ агуулгаараа Засгийн газрын 119 дүгээр тогтоолоор улсын нэгдсэн бүртгэлд заавал бүртгүүлэх шаардлага тавигддаггүй байсан НӨУБ-ийн хэм хэмжээний актыг бүртгэлийг Захиргааны ерөнхий хуулийн хүрээнд заавал хийдэг болсноороо ихээхэн ач холбогдолтой болсон. Тэр утгаараа Захиргааны ерөнхий хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш баталсан НӨУБ-ын хэм хэмжээний акттай холбоотой шүүхийн маргаан гараагүй байгаа нь хяналт бүртгэл, сайжирсантай холбоотой байж болох юм. Тухайлбал: 2011-2016 онд

Remove Watermark Now

НӨУБ-ын хэм хэмжээний акттай холбоотой 12 хэрэг маргаан шийдвэрлэснээс 9 буюу 75 % нь хэм хэмжээний актыг хүчингүй болгож шийдвэрлэсэн байдаг.
Хэм хэмжээний актын бүртгэлийн асуудлыг хариуцдаг Хууль зүй, дотоод хэргийн яам Захиргааны ерөнхий хуулийн хүрээнд хэм хэмжээний актын гаргах эрх бүхий байгууллагуудын 960 гаруй шийдвэрийг хяналт дүгнэхэд 50-иас илүү хувь нь ЗЕХ-ийн шаардлагыг хангаагүй тул буцаан хүргүүлсэн мэдээллээс үзэхэд бүртгэлийн ач холбогдол ихээхэн байгаа нь харагдаж байна. Харин практикт тулгараад буй маргаантай нэг асуудал нь Захиргааны ерөнхий хууль хүчин төгөлдөр болохоос өмнө батлагдсан НӨУБ-ын хэм хэмжээний актад Захиргааны ерөнхий хуулийн шаардлага тавигдах эсэх асуудал юм. Хууль зүйн яамнаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээнээс үзвэл нэгэнт хүчин төгөлдөр үйлчилж буй тул одоогийн хууль тогтоомжийн шаардлагаа хангах ёстой гэж үзэж байна. Энэ нь илүү хууль зүйн үндэслэлтэй. Гэтэл зарим төрийн байгууллагууд шүүхийн маргаанд оролцохдоо хуулийн үйлчлэлээс өмнө батлагдсан тул ЗЕХ-ийн шаардлага тавигдахгүй гэх үндэслэлийг гаргадгаас гадна шүүх зарим тохиолдолд уг үндэслэлээр ЗЕХ-ийг хэрэглэхгүй зөрүүтэй шийдвэр гаргаж байгаа нь ихээхэн төвөгтэй нөхцөлийг үүсгэж байна. Тухайлбал: “ННННН” ХХК нарын нэр бүхий 10 компанийн нэхэмжлэлтэй Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид холбогдох 2016 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн хэм хэмжээний актыг хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгох шаардлага бүхий хэргийг шийдвэрлэхдээ шүүх “Захиргааны Ерөнхий хууль хүчин төгөлдөр болохоос өмнө батлагдан гарсан захиргааны хэм хэмжээний актад энэ хуулийн үйлчлэл хамаарахгүй тул маргаан бүхий хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх шаардлагагүй байна” гэх дүгнэлт хийжээ.[62]
Тиймээс баталсан субьектээс үл хамааран одоо хүчин төгөлдөр хэвээр мөрдөгдөж буй бүхий л хэм хэмжээний актыг ЗЕХ-ийн шаардлагад нийцүүлэх, НӨУБ-ын зэрэг бүртгүүлээгүй хэм хэмжээний актуудыг ЗЕХ-ийн шаардлагын дагуу нөхөн бүртгүүлэх арга хэмжээг авах, мөн уг асуудлаар хууль хэрэглээгүй нэгдсэн ойлголтод хүрэх шаардлагатай болоод байна.

pdfelement

2. ЗЕХ батлагдахаас өмнө гарсан захиргааны хэм хэмжээний актыг бүртгэх эсэх талаар захиргааны байгууллагууд нэгдсэн ойлголтонд хүрээгүй байна.

Төрийн албан хаагч:
Өмнөх журмуудын хувьд хуульд нь бүртгүүлнэ гэсэн зохицуулалт байхгүй, дагаж мөрдөх журмын хуульд байхгүй учраас нэгжийн хуулиар шийдвэр гарснаар хүчин төгөлдөр болсон байгаа. Тэгэхээр үүнийг хууль бус, хүчингүй гэж үзэх үндэслэлгүй юм. Хууль батлагдсанаас хойшхи асуудлын хувьд ЗЕХ-ийн 62.1-д зааснаар хуулиар тусгайлан олгосон эрх биш гэвэл нэгжийн хуулиар ИТХ бие даан шийдэж шийдвэр гаргасан бол үүнийг ХЗЯ-нд бүртгүүлэх шаардлагагүй болж байгаа юм.
Төрийн албан хаагч:
Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас нийтээр дагаж мөрдүүлэхээр хэм хэмжээ тогтоосон шийдвэрүүдийн хувьд Захиргааны ерөнхий хуулийг дагаж мөрдөж эхэлснээс хойш захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхтэй холбоотойгоор хүндрэл гарч байна. Нөгөө талаар энэ нь Захиргааны ерөнхий хуулийн хэрэглээтэй холбоотой юм.
Нийслэл Улаанбаатар хотын хүн амын тоо эрс нэмэгдэж, эдийн засаг өсөж, нийгмийн харилцаа өргөжихийн хирээр хуримтлагдаж буй олон асуудлыг үр дүнтэй шийдвэрлэх, иргэдийн оролцоонд тулгуурласан, тэдний эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор эрх зүйн зохицуулалтыг бий болгох зайлшгүй шаардлага байдаг.

[62] Харин Улсын дээд шүүх 2 хэрэгт уг үндэслэлийг няцааж ЗЕХ-ийн шаардлагын дагуу бүртгүүлэх үүрэгтэй гэж үзсэн байна.

Remove Watermark Now

Энэ шаардлага, үндэслэлийн дагуу Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 1993 оноос хойш гаргасан 100 гаруй нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актыг дараах үндэслэлээр улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх хүсэлтэй байна. Үүнд:
Захиргааны ерөнхий хууль батлагдахаас өмнө хүчин төгөлдөр үйлчилж байсан Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолын 5 дахь заалтаар Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахдаа "Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам"-ыг дагаж мөрдөхийг зөвлөсөн байсан. Өөрөөр хэлбэл, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь Захиргааны ерөнхий хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад өөрийн баталсан захиргааны хэм хэмжээний актыг хүргүүлж хянуулж, бүртгүүлэх үүрэг хүлээгээгүй байсан. Захиргааны ерөнхий хуульд уг хуулийг буцаан хэрэглэх асуудлыг тусгайлан зохицуулаагүй тул хууль хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө батлагдсан захиргааны хэм хэмжээний актыг бүртгүүлэх харилцаанд Захиргааны ерөнхий хуулийн Зургаадугаар бүлгээр зохицуулсан журмыг баримтлах хууль зүйн үндэслэлгүй гэж үзэж байна. Иймд Нийслэл Улаанбаатар хотод тулгамдаж буй, холбогдох хууль тогтоомжоор зохицуулаагүй олон асуудлыг хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэн зохицуулж буй нийслэлийн нутаг дэвсгэрт нийтээр дагаж мөрдөхөөр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 1993 оноос хойш баталсан 100 гаруй журмыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх асуудлыг яаралтай шийдвэрлэх шаардлагатай байна.
Төрийн албан хаагч:
ЗЕХ батлагдахаас өмнө Үндсэн хуулийн 62.2, нэгжийн хуулийн 20.1.7-д зааснаар батлагдсан одоо харилцаа зохицуулаад үр дагавартай байгаа хэм хэмжээний актуудыг бүртгэж болдоггүй юм уу? Мөн үүнийг хялбаршуулсан журмаар бүртгэх саналыг танай судалгааны баг цааш нь хүргүүлж болох уу?
Төрийн албан хаагч:
ЗЕХ хэрэгжиж эхлэснээс хойш бүртгэлээ хийж байгаа. Нэг асуудал нь ЗЕХ-ийг дагаж мөрдөх журмын тухай хууль, хуулийг буцаан хэрэглэх тухай журам байхгүй байна. СЗХ нь 2006 оноос хойш санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилгоор энэ зах зээл дээр үйл ажиллагаа явуулж байгаа 2000 орчим аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зохицуулж байгаа. Тэгэхээр ХЗЯ-аас хуучин журмуудаа ЗЕХ-д нийцүүлэх шаардлага тавьдаг. ХЗЯ-аас ирүүлсэн дүгнэлт болон тодорхой албан тушаалтнуудтай уулзсан хүрээнд ажлын хэсэг ажиллаж байгаа. Мэдээж нэг дор 170 орчим журмаа өөрчлөх боломжгүй, энэ нь уг зах зээлд оролцогчдын тогтвортой байдлыг алдагдуулна. Тэгэхээр шат дараалсан арга хэмжээ авч байгаа. Процесстой холбоотой нэг зүйл бий. 170 журамтай холбоотой гэхэд зарим нь 10 жилийн өмнө гараад мөрдөөд явж байгаа. ХЗЯ-аас дүгнэлтээ аваад бүрдлээ хангах болно. Бүрдэл хангах гэхээр сонсох ажиллагаа хэлэлцүүлэг хийх болдог. Гэтэл эдгээр ажиллагаа нь журам гарахаас өмнө хийгдэх ёстой. Гэтэл журам хэрэгжиж эхлээд 10 жил болсон байдаг. Тэгээд нөхөж хийнэ гэхээр ойлгомжгүй болоод байна. Бүрдэл хангуул гэхээр шинэчлэн батлахтай адил болоод байна.

Энэ заалттай холбоотой гарч буй нэг асуудал бол өмнө нь Засгийн газрын 119-р тогтоолын дагуу бүртгүүлсэн болон уг тогтоолоор бүртгүүлэх үүрэг байгаагүй захиргааны байгууллагуудын хэм хэмжээний актын талаар маргаан үүсч байна.

Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр хийсэн шинжилгээгээр хууль батлагдсанаас хойш захиргааны хэм хэмжээний акттай холбоотой маргааны талаар нэгдсэн тоон мэдээлэл гараагүй байна. www.shuuh.mn-ээс хайлт хийхэд 2015 онд гарсан Засгийн газрын тогтоолоор баталсан "Дотоод аудиторт тавигдах журам"-д заасан



pdfelement

Remove Watermark Now

шаардлагатай холбоотой маргааныг Улсын Дээд шүүхийн захиргааны хэргийн танхим шийдвэрлэсэн байна. Ингэхдээ уг журмыг хууль зөрчөөгүй байна гэж үзжээ.

Харин давах шатны шүүхэд 21 шийдвэр байна. Эдгээрт шинжилгээ хийхэд: өмнө батлагдсан хэм хэмжээний актууд ЗЕХ-д хамаарахгүй гэж Шүүхээс үзсэн байна. Жишээлбэл:Нэхэмжлэгч нар уг актыг захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй,эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдүүдэд мэдэгдээгүй, сонсохажиллагаа явуулаагүй гэж маргаж байх боловч Захиргааны ерөнхий хууль 2016 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн бөгөөд уг хуулийг хүчин төгөлдөр болохоос өмнө буюу 2016 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр батлагдан гарсан захиргааны хэм хэмжээний актад энэ хуулийн үйлчлэл хамаарахгүй тул маргаан бүхий хэм хэмжээний актыг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх шаардлагагүй байна гэж шүүх дүгнэв.

*Хүснэгт 10. Шалгуур үзүүлэлт 2*

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 64.3.Захиргааны хэм хэмжээний актыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянаж, бүртгэнэ. |
| **Практикт хэрэглэгдэж байгаа байдал** | Хууль хэрэгжүүлэхэд гарч буй бэрхшээл байгаа эсэх |

**Үнэлгээ**

pdfelement

Энэ заалтын хэрэгжилтийн талаар ХЗДХЯ-ны захиргааны хэм хэмжээний актын бүртгэл, хяналт хариуцсан мэрэгжилтнүүдтэй экспертийн ярилцлага хийж, тоон мэдээлэлийг цуглуулсан.

Сүүлийн 2 жилийн байдлаар буюу 2017 оны 1 дүгээр сарын 01-ээс 2018 оны эхний хагас жил хүртэлх хугцаанд Хууль зүй, дотоод хэргийн яам Захиргааны хэм хэмжээний нийт **747** актыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу хянан үзэж, **254** актыг Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, **168** актад дүгнэлт хүргүүлж, 60 актыг хуульд заасан бүрдлийн шаардлага болон захиргааны хэм хэмжээний актад хамаарахгүй үндэслэлээр бүртгэх шаардлагагүй тул буцаан хүргүүлж, нэмэлт өөрчлөлт оруулсан **45** акт, хүчингүй болгосон **153** актыг улсын нэгдсэн санд хүлээн авч холбогдох өөрчлөлт хөдөлгөөнийг хийсэн. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангаас **170** лавлагаа өгч ажилласан байна.

### 3.5.ЗЕХ-ийн 64.4 –р зүйл

*Хүснэгт 11. Шалгуур үзүүлэлт 1*

| | |
|---|---|
| Үнэлэгдэх хэсэг | 64.4.Захиргааны хэм хэмжээний актыг баталснаас хойш ажлын таван өдрийн дотор эрх бүхий байгууллагад хянуулж, бүртгүүлэхээр хүргүүлнэ. |
| Практикт хэрэглэгдэж байгаа байдал | Хууль хэрэгжүүлэхэд гарч буй бэрхшээл байгаа эсэх |

**Үнэлгээ:**

Remove Watermark Now

- Экспертийн ярилцлага

Асуулт: Энэ заалтад байгаа хугацаанд байгууллагууд актаа ирүүлдэг үү ?
Ерөнхийдөө харилцан адилгүй бөгөөд ихэнх тохиолдолд хугацаа хоцорч ирдэг. Нийслэл дэх төрийн захиргааны байгууллагууд ирүүлэх боломжтой боловч хугацаандаа ирүүлдэггүй. Аймгуудын хувьд ялангуяа алсагдмал аймгуудын хувьд бэрхшээлтэй асуудал үүсч болно. Онгоц нисдэг аймгуудын хувьд бас ч гайгүй байдаг.

**3.6. ЗЕХ-ийн 64.4 –р зүйл**

*Хүснэгт 12. Шалгуур үзүүлэлт 1*

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 64.5.Сум, дүүргийн Засаг дарга гаргасан захиргааны хэм хэмжээний актаа ажлын 10 өдөрт багтаан дээд шатны Засаг даргаар дамжуулан хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. |
| **Практикт хэрэглэгдэж байгаа байдал** | Хууль хэрэгжүүлэхэд гарч буй бэрхшээл байгаа эсэх |

**Үнэлгээ:**

- Экспертийн ярилцлага

pdfelement

Асуулт: Энэ заалтанд байгаа хугацаанд байгууллагууд актаа ирүүлдэг үү ?
Хугацаандаа ирдэггүй. Алсагдмал сумын хувьд шуудангаар илгээх боломжгүй. Автомашинаар тээвэрлэх асуудал гардаг. Ихэнхи сумдын хувьд 7 хоногт нэг удаа явах машинаар аймгийн төв рүү явуулаад, аймгийн төвөөс шуудангаар ХЗДХЯ-д очдог гэж тооцолдог боловч өнөөдрийн байдлаар хуульд заасан хугацаанд ирэхгүй байна. Хугацааг сунгалаа гэхэд удаашрах сөрөг тал гарна гэж үзэж байна.

**3.7. ЗЕХ-ийн 66.4, 66.6 –р зүйл**

*Хүснэгт 13. Шалгуур үзүүлэлт 1*

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 66.4.Захиргааны хэм хэмжээний акт эрх зүйн зөрчилтэй байгаа тухай хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний энэ хуулийн 66.3.2-т заасан дүгнэлтийг хүлээн авсан захиргааны байгууллага өөрийн гаргасан захиргааны хэм хэмжээний актын хууль зүйн үндэслэлийг хянан үзэж, түүний эрх зүйн зөрчлийг арилгасан, эсхүл зохих нэмэлт, өөрчлөлт оруулсан бол энэ тухай ажлын 10 өдрийн дотор бүртгүүлэхээр дахин хүргүүлнэ. |
| **Практикт хэрэглэгдэж байгаа байдал** | Хууль хэрэгжүүлэхэд гарч буй бэрхшээл байгаа эсэх |

**Үнэлгээ:**

Remove Watermark Now

➢ Экспертийн ярилцлага

ХЗДХЯ 168 актад дүгнэлт хүргүүлсэн. Энэ заалтыг хэрэгжүүлэхэд нэг бэрхшээл үүссэн. Тухайлбал: ИТХ-ын захиргааны хэм хэмжээний актын хувьд ХЗДХЯ-наас ирсэн дүгнэлтийг хүлээн аваад холбогдох нэмэлт өөрчлөлтийг актад оруулах процесс үүсгэе гэхээр Хурлын хуралдаан тогтмол биш байдаг. Дараагийн хуралдаан хүлээх гэвэл хуульд заасан 10 хоног хэтэрнэ. Тэргүүлэгчид шийдэх бүрэн эрх олгогдоогүй. Тиймээс энэ заалт ИТХ-ын актад хугацааг өөрчлөх шаардлага гарч ирж байна.

*Хүснэгт 14. Шалгуур үзүүлэлт 1*

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 66.6.Хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага энэ хуулийн 66.3.2-т заасан дүгнэлтийг хүлээн авах үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ажлын 10 өдрийн дотор албан бичгээр хариу мэдэгдэнэ. |
| **Практикт хэрэглэгдэж байгаа байдал** | Хууль хэрэгжүүлэхэд гарч буй бэрхшээл байгаа эсэх |

**Үнэлгээ:**

➢ Экспертийн ярилцлага

pdfelement

Асуулт: Ийм тохиолдол гарсан уу

Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлснээс хойш Хууль зүй, дотоод хэргийн яамнаас хүргүүлсэн дүгнэлтийг хүлээн авах үндэслэлгүй гэж үзэж, хариу ирүүлсэн тохиолдол гараагүй байна.

Энэ шалгуур үзүүлэлтээр хууль хэрэгжснээс хойш нэг ч тохиолдол гараагүй, үнэлэх боломжгүй байна.

### 3.8. ЗЕХ-ийн 66.7 –р зүйл

*Хүснэгт 14. Шалгуур үзүүлэлт 1*

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 66.7.Энэ хуулийн 66.6-д заасны дагуу ирүүлсэн мэдэгдлийг хүлээж авах үндэслэлгүй гэж үзвэл хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дүгнэлт гарган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ажлын 10 өдөрт багтаан хүргүүлнэ |
| **Практикт хэрэглэгдэж байгаа байдал** | Хууль хэрэгжүүлэхэд гарч буй бэрхшээл байгаа эсэх |

**Үнэлгээ:**

➢ Экспертийн ярилцлага

Remove Watermark Now

Асуулт: ийм тохиолдол гарсан уу ?
Гараагүй байна.

Энэ шалгуур үзүүлэлтээр хууль хэрэгжснээс хойш нэг ч тохиолдол гараагүй, үнэлэх боломжгүй байна.

### 3.9. ЗЕХ-ийн 66.8 –р зүйл

*Хүснэгт 15. Шалгуур үзүүлэлт 1*

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 66.8 Засгийн газар энэ хуулийн 66.7-д заасны дагуу ирүүлсэн дүгнэлтийг хуралдаанаараа хэлэлцэж уг дүгнэлтийг үндэслэн захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох эсэхийг шийдвэрлэнэ |
| Зорилгодоо хүрсэн байдал | Онол, арга зүйн алдаатай эсэх |

**Үнэлгээ:**

1. ЗЕХ-д заасан шаардлагыг хангаагүй гэж ХЗДХЯ-ны дүгнэлтийг эс зөвшөөрсөн захиргааны байгууллагын мэдэгдлийг ХЗДХЯ мөн хүлээн аваагүй бол Засгийн газрын хуралдаанаар оруулна. Гэхдээ уг маргаан бүхий захиргааны хэм хэмжээний акт нь улсын бүртгэлд ороогүй тул ЗЕХ-ийн 67.2-д заасны дагуу хүчин төгөлдөр бус юм. Хүчин төгөлдөр болж амжаагүй байгаа актыг хүчингүй болгох эсэхийг шийдвэрлэх нь онол, арга зүйн хувьд алдаатай гэж үзэж байна.

2. Засгийн газраас хараат бус, бие даасан байгууллага болох ИТХ, УИХ-ын харьяа байгууллагын шийдвэрийн хувьд Засгийн газар хүчингүй болгох эрхгүй.

МУЗЗНДНТУТХ-ийн 25.4.Хурлаас гаргасан тогтоол, бусад шийдвэр нь хууль тогтоомж, Засгийн газар, тухайн асуудлыг харьяалах дээд шатны байгууллагаас гаргасан шийдвэрт нийцээгүй бол түүнийг тухайн Хурал өөрчлөх буюу хүчингүй болгоно. УИХ-ын тухай хуулийн 19.2.11. Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын гаргасан эрх зүйн актыг хянаж, хууль зөрчсөн шийдвэрийг хүчингүй болгуулах арга хэмжээ авах зэрэг хуулийн заалттай зөрчилдөж байна.

Төрийн албан хаагч :

Захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох эсэхийг Засгийн газар шийдвэрлэнэ гэдэг нь шүүхээс хууль зөрчсөн эсэхийг тогтоодог зарчимтай зөрчилдөж байна. Хэм хэмжээний акт хууль зөрчсөн эсэх талаар хоёр байгууллагын хооронд маргаан үүслээ гэхэд түүнийг эцсийн шийдвэр гаргах этгээд нь шүүх байх ёстой. Гэтэл ийм асуудал гарахад ЗГ шийдвэрлэнэ гэсэн нь эрх мэдлийн зарчим алдагдсан гэж үзэхээр байгаа.

*Хүснэгт 1.. Шалгуур үзүүлэлт 2*

Remove Watermark Now

| Үнэлэгдэх хэсэг | 66.8Засгийн газар энэ хуулийн 66.7-д заасны дагуу ирүүлсэн дүгнэлтийг хуралдаанаараа хэлэлцэж уг дүгнэлтийг үндэслэн захиргааны хэм хэмжээний актыг хүчингүй болгох эсэхийг шийдвэрлэнэ |
|---|---|
| **Практикт хэрэглэгдэж байгаа байдал** | Хууль хэрэгжүүлэхэд гарч буй бэрхшээл |

**Үнэлгээ:**

Энэ шалгуур үзүүлэлтээр хууль хэрэгжснээс хойш нэг ч тохиолдол гараагүй, үнэлэх боломжгүй байна.

### 3.10. ЗЕХ-ийн 67.1 –р зүйл

*Хүснэгт 16. Шалгуур үзүүлэлт 1*

| Үнэлэгдэх хэсэг | 67.1.Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн захиргааны хэм хэмжээний актыг бүртгэсэн өдрөөс хойш 10 өдрийн дотор “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д бүрэн эхээр нь нийтлүүлнэ. |
|---|---|
| **Практикт хэрэглэгдэж байгаа байдал** | Хэм хэмжээний актыг бүртгэх, эмхэтгэлд нийтлүүлэхэд ямар хугацаа зарцуулж байгаа болон үүнтэй холбоотой ямар үр дагавар гарах эсэх; |

pdfelement

**Үнэлгээ:**

ХЗДХЯ болон Хууль зүйн Үндэсний Хүрээлэнгийн ажил хариуцсан албан хаагчидтай ярилцлага хийсэн.

Төрийн албан хаагч:

Бодит байдалд хугацаандаа байж чадахгүй байгаа. Энэ хэсгийг 14 хоног болгох. Хэрвээ улсын бүртгэлд бүртгүүлсэн л бол эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд тэр даруй байршуулж байгаа. Захиргааны ерөнхий хуульд хэм хэмжээний актыг ийнхүү бүртгүүлж, Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлд нийтлүүлснээр хүчин төгөлдөр болно гэж заасан. Гэтэл Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэлийг хэм хэмжээний акт батлах эрх бүхий захиргааны байгууллага огт захиалдаггүй. Энэ нь хуулийн хэрэгжилтэд нөлөөлөх бас нэг хүчин зүйл болохыг анхаарч бүх захиргааны байгууллага тогтмол захиалдаг байх нь зүйтэй.

### 3.11. ЗЕХ-ийн 67.3 –р зүйл

*Хүснэгт 17. Шалгуур үзүүлэлт 1*

| Үнэлэгдэх хэсэг | 67.3.Энэ хуулийн 67.2-т заасан шаардлагыг зөрчсөн тохиолдолд тухайн захиргааны хэм хэмжээний акт эрх зүйн |
|---|---|

| | |
|---|---|
| | үйлчлэл үзүүлэхгүй бөгөөд биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдэд үүрэг, хариуцлага хүлээлгэхгүй |
| **Практикт хэрэглэгдэж байгаа байдал** | Хууль хэрэгжүүлэхэд гарч буй бэрхшээл байгаа эсэх |

**Үнэлгээ:**

Энэ заалтыг хэрэгжилтийн талаарх судалгааг шүүхийн түүврийн аргаар цуглуулсан 61 шийдвэр, судалгаанд хамрагдсан иргэдээс ярилцлагын аргаар авсан. Иргэд энэ заалтын талаар мэдээлэл, ойлголтгүй байв.

**3.12. ЗЕХ-ийн 67.4–р зүйл**

*Хүснэгт 18. Шалгуур үзүүлэлт 1*

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 67.4.Хүчин төгөлдөр бус захиргааны хэм хэмжээний актыг дагаж мөрдүүлснээс үүсэх үр дагаврыг захиргааны хэм хэмжээний акт гаргасан хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага хариуцна |
| **Практикт хэрэглэгдэж байгаа байдал** | Хууль хэрэгжүүлэхэд гарч буй бэрхшээл байгаа эсэх |

pdfelement

**Үнэлгээ:**

Судалгаанд хамрагдсан захиргааны байгууллагууд энэ заалтын талаар мэдээлэлтэй байгаа боловч өмнөх хэсэгт дурдсанчлан захиргааны хэм хэмжээний актуудаа бүртгүүлээгүй зөрчил нийтлэг байсан. Бүртгүүлээгүй актын улмаас гарсан хохирлын асуудлыг шийдвэрлэсэн тохиолдол судалгаанд хамрагдсан байгууллагад гараагүй байна. Шалтгааныг нь иргэд энэ хуулийн заалтын талаар мэдээлэл, ойлголтгүй байгаа учраас гомдол, маргаан үүсгээгүй байна гэж дүгнэсэн.

- Ярилцлага

Энэ талаар судалгаанд хамрагдсан 20 иргэнээс ярилцлагын аргаар судалгаа авахад 18 иргэн энэ хуулийн заалтыг мэдэхгүй, 2 нь буруу шийдвэр гаргасан албан тушаалтнаас хохирлоо авах болсон гэдгийг сонссон гэж хариулсан.

- Ажиглалтын арга

Судалгааны явцад захиргааны байгууллагын хэм хэмжээний актыг батлах, бүртгэхтэй холбоотой дараах зөрчлүүд гарч байна. Жишээ нь:

Тохиолдол шинжлэв:
Халамжийн тухай хуульд 2016 онд орсон нэмэлт, өөрчлөлтөөр байнгын асаргаатай иргэний асарч буй иргэнд тэтгэмж олгохдоо асаргаа шаардлагатай иргэнийг тогтоож байж асрагчид тэтгэмж олгодог. Хуульд ямар нэг шалгуур үзүүлэлт заалгүй, бие даах

чадваргүй, хүнд өвчтэй хүн байна гэж заасан. Тэгээд 2016 онд хуульд өөрчлөлт орж байнгын асаргаа шаардлагатай иргэнийг тодорхойлох өвчин гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлтийнг Эрүүл мэндийн болон халамжийн асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүн хамтран батална гэж заасан. Үүний дагуу ЭМЯ-тай хамтарч ажлын хэсэг байгуулагдаад эмч мэргэжилтнүүдийг оролцуулан жилийн турш ажиллаад 2018.02.23-нд тушаал батлагдсан. Урьд нь нэг тушаал Сангийн яаманд батлуулах гэхэд уг яам тэр дор нь нөлөөллийн шинжилгээ хий, хэлэлцүүлгийн материал, цахим хуудсан дахь мэдээллээ өг гэсний дагуу бүх материалаа өгөхөд манай тушаал батлагдаад ирсэн. Харин 2018.02.23-нд батлагдсан тушаалын хувьд ЭМЯ-нд танай байгууллага урдаа орсон учраас ЗЕХ-ийн 66.3 дахь хэсэгт заасны дагуу танайх бүртгүүлнэ гэж амаар бид мэдэгдсэн. Гэтэл тэндээс одоо болтол ХЗДХЯ руу явуулаагүй байдаг. Гэтэл бид 02.23-нд тушаал гараад 04.01 хүртэл хугацаа байгаа учраас энэ хугацаанд холбогдох хүмүүст сургалтаа хийнэ гээд төлөвлөсөн. Тэгэхээр бид хүчин төгөлдөр болоогүй тушаалаар сургалт хийчихсэн. Гэтэл тухайн тушаалыг 04.01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлээд эхэлсэн байгаа. Хэрэв энэ тушаал эргээд хүчингүй болвол хор уршиг нь их. Өөрөөр хэлбэл, хэрэглэж эхэлснээс хойш хүмүүст асаргааны мөнгө олгогдоод явж байгаа. 04.01-ний өдрөөс хэрэгжиж эхлэнгүүт эмч нар асаргаа шаардлагатай хүнээ тодорхойлоод үүнийг нь үндэслээд халамжийн мөнгө олгочихсон. Гэтэл энэ шийдвэрийг хүчингүй болговол үр дагавар нь яах вэ, олгогдсон мөнгийг яах вэ гэдэг асуудал гарна.

- Экспертийн ярилцлага

Зарим тохиолдолд хэм хэмжээ тогтоосон актын дагаж мөрдөх хугацааг баталсан байгууллага өөрсдөө тогтоож, холбогдох шийдвэрт тусгасан байдаг. Түүнчлэн зохих журмын дагуу бүртгүүлээгүй хэм хэмжээ тогтоосон актыг мөрдсөн /зарим тохиолдолд/ зөрчил гардаг.
Дээрх тохиолдлуудад Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.3-т “Энэ хуулийн 67.2-т заасан шаардлагыг зөрчсөн тохиолдолд тухайн захиргааны хэм хэмжээний акт эрх зүйн үйлчлэл үүсгэхгүй бөгөөд биелүүлээгүй иргэн, хуулийн этгээдэд үүрэг, хариуцлага хүлээлгэхгүй”, мөн зүйлийн 67.4-т “Хүчин төгөлдөр бус захиргааны хэм хэмжээний актыг дагаж мөрдүүлснээс үүсэх үр дагаврыг захиргааны хэм хэмжээний акт гаргасан хуулиар тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллага хариуцна” гэж заасантай зөрчилддөг тул уг шийдвэрийг бүртгүүлээгүй хугацаанд дагаж мөрдүүлснээс үүсэх үр дагаврыг тухайн байгууллага хариуцах зохицуулалттай байна гэсэн дүгнэлтийг хүргүүлдэг.

### 3.13. ЗЕХ-ийн 67.5, 67.6–р зүйл

*Хүснэгт 19. Шалгуур үзүүлэлт 1*

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 67.5.Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн, хүчин төгөлдөр болсон захиргааны хэм хэмжээний актыг бүрэн эхээр нь эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан болон баталсан байгууллагын цахим хуудсанд байршуулна.<br><br>67.6.Захиргааны хэм хэмжээний актыг үндэслэл болгох, хэсэгчлэн нийтлэх болон байгууллагын албан ёсны цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулахдаа улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн он, сар, өдөр, дугаарыг заана |



Remove Watermark Now

Remove Watermark Now

| **Практикт хэрэглэгдэж байгаа байдал** | Хууль хэрэгжүүлэхэд гарч буй бэрхшээл байгаа эсэх |
|---|---|

**Үнэлгээ:**

Судалгаанд хамрагдсан 14 захиргааны байгууллагын цахим хаяг болон мэдээллийн самбарт шинжилгээ хийсэн /Хавсралт 5/. Мэдээллийн самбарт захиргааны хэм хэмжээний актын талаар мэдээлэл байхгүй байлаа.

## ЗӨВЛӨМЖ

1. ИТХ-ын Үндсэн хуулиар (62.2)олгогдсон бие даасан шийдвэр гаргах эрх ба хуулиар түүнд шилжүүлсэн чиг үүрэг гэж байдаг. Тиймээс Хурлын гаргаж буй хэм хэмжээний актыг бие даасан хэм хэмжээний ба захиргааны хэм хэмжээний актын шинжээр нь ялгаж ЗЕХ-ийн энэ заалтыг хэрэглэх нь зүйтэй.

2. ЗЕХ-ийн 64.2-д заасан Засгийн газрын баталсан захиргааны хэм хэмжээний актыг бүртгэх, хянах байгууллага нь УИХ-ын харьяа нэгж байгуулах, энэ процесстэй холбоотойгоор Засгийн газрын тухай хуулийн 30.9 –р заалтыг хүчингүй болгох.

3. Энэхүү УИХ-ын харьяа нэгжид УИХ-аас байгууллагддаг захиргааны байгууллагуудын захиргааны хэм хэмжээний актыг бүртгэж, хянах.

4. Захиргааны хэм хэмжээний актыг батласнаас хойш ажлын таван өдрийн дотор бүртгүүлэх хугацааг нийслэл, орон нутгийн түвшинд ялгаатай тогтоох.

5. ЗЕХ-ийн 66.4 дэх заалтын хувьд ИТХ-ын онцлогийг харгалзах.

6. ЗЕХ-ийн 66.8 дахь заалтыг агуулгын болон бусад хуулиудтай зөрчилдөж байгаа эсхийг нягтлах, Үүнд: ИТХ-ын шийдвэр, УИХ-аас байгуулагддаг хараат бус байгууллагын шийдвэрийг хүчингүй болгох субьект Засгийн газар мөн эсэх.

7. Хүчин төгөлдөр болоогүй шийдвэрийг хүчингүй болгох зохицуулалт нь томъёоллын алдаа юу, эсвэл зарчмын алдаа юу гэдэгт тайлбар өгөх

8. ЗЕХ батлагдахаас өмнө гарсан захиргааны хэм хэмжээний актыг бүртгэх, мөн хуульд байгаа шаардлагыг хангахдаа дахиж процесс үүсгэх эсэх талаар гарч маргааныг нэг мөр болгох

9. Санал: одоо хүчин төгөлдөр үйлчилж буй захиргааны хэм хэмжээний актуудыг ЗЕХ-д нийцүүлж нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай.

10. Бусад заалтын хувьд хэрэгжилт хангалтгүй байх шалтгаан нь хуульд заасан үүргийг захиргааны байгууллагууд биелүүлэхгүй, тэдний хариуцлагагүй үйлдэлтэй холбоотой гэж дүгнэж байна.

pdfelement

Remove Watermark Now

# III хэсэг. ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН 11 ДҮГЭЭР БҮЛГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

## НЭГ.ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

### 1.1.Үнэлгээ хийх шалтгаан

Захиргааны ерөнхий хуулийн 11 дугаар бүлэгт үнэлгээ хийх шалтгаан нь захиргааны байгууллагын албан тушаалтан эрх зүй зөрчилтэй акт гаргасан зөрчилд хүлээлгэх хариуцлагыг хэрхэн оногдуулж байгаа практикийг тандан судлах зорилготой.

### 1.2.Үнэлгээний хүрээг тогтоох

Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 105, зохицуулалтыг үнэлэх бөгөөд үнэлэгдэх шаардлагатай зүйл, хэсгийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 1

| № | Үнэлэгдэх хэсэг, заалт |
|---|---|
| 1 | 105.1.Захиргааны байгууллагын захиргааны шийдвэр гаргах ажиллагаа болон захиргааны акт энэ хуулийн дагуу эрх зүйн зөрчилтэйд тооцогдож эрх зүйн үр дагаваргүй болсон бол тухайн гэм буруутай албан тушаалтны санаатай болон санамсаргүй үйлдсэн зөрчилд нь тохирох шийтгэлийг оногдуулна.<br>105.2.Тухайн албан тушаалтныг томилсон болон дээд шатны байгууллагын албан тушаалтан энэ хуулийн 105.1-д заасан зөрчил гаргасан, эсхүл захиргааны шийдвэрийг сайн дураараа эс биелүүлсэн албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дараах шийтгэлийн аль нэгийг оногдуулна:<br>105.2.1.хууль биелүүлж ажиллахыг хаалттай болон нээлттэй сануулах;<br>105.2.2.албан тушаалын цалингийн хэмжээг зургаан сар хүртэл хугацаагаар 2О хүртэл хувиар бууруулах;<br>105.2.3.ажлаас халах;<br>105.2.4.нийтийн албанд нэгээс арав хүртэл жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах.<br>105.4.Энэ хуулийн 105.1, 105.2 дахь хэсгээс бусад зүйл, заалтыг зөрчсөн албан хаагчид Төрийн албаны тухай хууль, тус харилцааг нарийвчлан зохицуулсан холбогдох бусад хуулиар хариуцлага хүлээлгэнэ. |
| 2 | 105.3.Албан тушаалтан хууль зөрчиж гаргасан захиргааны актаа хүчингүй болгосон тохиолдолд тухайн акт хувь хүнд чиглэсэн бол ганцаарчилсан уучлалт, харин хэд хэдэн хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн захиргааны актыг хүчингүй болгосон тохиолдолд энэ хуулийн 105.2-т заасан шийтгэлээс аль нэгийг оногдуулахаас гадна энэ талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан тэднээс уучлалт хүснэ. |

pdfelement

| | |
|---|---|
| 3 | 107.2.Захиргааны байгууллагын болон шүүхийн шийдвэрийг үл биелүүлсэн албан тушаалтанд холбогдох хуульд заасан хариуцлагыг шүүх оногдуулна. |

**1.3.Шалгуур үзүүлэлтийг тогтоох, томьёолох**

Энэ үе шатанд үнэлгээ хийх зүйл, хэсэг бүр дээр тогтоосон шалгуур үзүүлэлт бүрээр тодорхой таамгийг дэвшүүлж, асуулт тавих замаар шалгуур үзүүлэлтийг томьёолох юм. Ийнхүү шалгуур үзүүлэлтийг томьёолсноор үнэлгээний дараагийн алхамууд нь томьёолсон шалгуур үзүүлтэд хариулт өгөхөд чиглэгдэнэ.

Хүснэгт 2

| д/д | Үнэлгээний хүрээ | Шалгуур үзүүлэлт | Шалгуур үзүүлэлтийн томьёолол |
|---|---|---|---|
| 1 | 105.1.Захиргааны байгууллагын захиргааны шийдвэр гаргах ажиллагаа болон захиргааны акт энэ хуулийн дагуу эрх зүйн зөрчилтэйд тооцогдож эрх зүйн үр дагаваргүй болсон бол тухайн гэм буруутай албан тушаалтны санаатай болон санамсаргүй үйлдсэн зөрчилд нь тохирох шийтгэлийг оногдуулна.<br>105.2.Тухайн албан тушаалтныг томилсон болон дээд шатны байгууллагын албан тушаалтан энэ хуулийн 105.1-д заасан зөрчил гаргасан, эсхүл захиргааны шийдвэрийг сайн дураараа эс биелүүлсэн албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дараах шийтгэлийн аль нэгийг оногдуулна:<br>105.2.1.хууль биелүүлж ажиллахыг хаалттай болон нээлттэй сануулах;<br>105.2.2.албан тушаалын цалингийн хэмжээг зургаан сар хүртэл хугацаагаар 2О хүртэл хувиар бууруулах;<br>105.2.3.ажлаас халах;<br>105.2.4.нийтийн албанд нэгээс арав хүртэл жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах. | Зорилгодоо хүрсэн байдал | Онол арга зүйн хувьд алдаа байгаа эсэх |
| | | Практикт хэрэглэгдэж байгаа байдал | -<br>Хууль хэрэгжүүлэх явцдад гарч буй бэрхшээл, хүндрэл |

pdfelement
Remove Watermark Now

| | | | |
|---|---|---|---|
| | 105.4.Энэ хуулийн 105.1, 105.2 дахь хэсгээс бусад зүйл, заалтыг зөрчсөн албан хаагчид Төрийн албаны тухай хууль, тус харилцааг нарийвчлан зохицуулсан холбогдох бусад хуулиар хариуцлага хүлээлгэнэ. | | |
| 2 | 105.3.Албан тушаалтан хууль зөрчиж гаргасан захиргааны актаа хүчингүй болгосон тохиолдолд тухайн акт хувь хүнд чиглэсэн бол ганцаарчилсан уучлалт, харин хэд хэдэн хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн захиргааны актыг хүчингүй болгосон тохиолдолд энэ хуулийн 105.2-т заасан шийтгэлээс аль нэгийг оногдуулахаас гадна энэ талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан тэднээс уучлалт хүснэ. | Практикт хэрэглэгдэж байгаа байдал | - Хууль хэрэгжүүлэх явцдад гарч буй бэрхшээл, хүндрэл; |
| 3 | 107.2.Захиргааны байгууллагын болон шүүхийн шийдвэрийг үл биелүүлсэн албан тушаалтанд холбогдох хуульд заасан хариуцлагыг шүүх оногдуулна | Зорилгодоо хүрсэн байдал | Онол арга зүйн хувьд алдаа байгаа эсэх |

pdfelement

**1.4 .Мэдээлэл цуглуулах аргыг сонгох**

➢ Чанарын буюу экспертийн болон бүлгийн ярилцлага

1.УИХ-аас байгууллагддаг захиргааны байгууллага, яам, нийслэлийн Засаг дарга, ИТХ, дүүргийн Засаг даргын Тамгын газар, нэг аймаг, нэг сумын захиргааны байгууллагын албан тушаалтан, төрийн албан хаагчдыг хамруулах,

2. Нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нар,

➢ Баримт бичгийн судалгаа

- Сурах бичиг, судлаачдын бүтээл
- Шүүхийн шийдвэрт шинжилгээ хийх

## ХОЁР.ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон мэдээлэл цуглуулах аргыг ашиглан 2018 оны 04 дүгээр сарын 01-ээс 05 дугаар сарын 01-ний өдрийн хооронд хэрэгжүүлэх үе шатыг хийж гүйцэтгэв.

➢ Чанарын судалгаа буюу ярилцага

- Захиргааны байгууллага дээр очиж, холбогдох 50 албан тушаалтан, албан хаагчаас ярилцлага авсан.

Remove Watermark Now

Хүснэгт 3

| № | Байгууллага | Биелэлт |
|---|---|---|
| 1 | Нийслэлийн ИТХ | 4/16 |
| 2 | Нийслэлийн ЗДТГ | 4/16 |
| 3 | ЗГХЭГ | 4/19 |
| 4 | Монголбанк | 4/23 |
| 5 | УИХ-ын Тамгын газар | 4/23 |
| 6 | Санхүүгийн зохицуулах Хороо | 5/1 |
| 7 | Төрийн албаны Зөвлөл | 4/30 |
| 8 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам | 4/27 |
| 9 | Эрүүл мэндийн яам | 5/4 |
| 10 | Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ | 5/11 |
| 11 | Орхон аймаг | 6/ |
| 12 | Булган аймгийн Тэшиг сум | 6/ |
| 13 | Дорнод аймаг | 4/10 |
| 14 | Дорноговь аймаг | 5/16 |
| 15 | Хууль зүйн Үндэсний Хүрээлэн | |
| 16 | Хууль зүйн яам | |

pdfelement

- Шүүгчдээс авсан бүлгийн ярилцлагыг нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 3 шүүгчээс авсан.

## ГУРАВ.ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Төлөвлөх үе шатанд Захиргааны ерөнхий хуулийн 11 дугаар бүлгээс сонгож авсан үнэлэгдэх зүйл, хэсэг, заалт тус бүрийг хэрэгжүүлэх үе шатанд олж авсан мэдээлэл дээр тулгуурлан үнэлэх болно.

### 3.1. ЗЕХ-ийн 105 зүйл

*Хүснэгт 4. Шалгуур үзүүлэлт 1*

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 105.1.Захиргааны байгууллагын захиргааны шийдвэр гаргах ажиллагаа болон захиргааны акт энэ хуулийн дагуу эрх зүйн зөрчилтэйд тооцогдож эрх зүйн үр дагаваргүй болсон бол тухайн гэм буруутай албан тушаалтны санаатай болон |

Remove Watermark Now

| | |
|---|---|
| | санамсаргүй үйлдсэн зөрчилд нь тохирох шийтгэлийг оногдуулна.<br>105.2.Тухайн албан тушаалтныг томилсон болон дээд шатны байгууллагын албан тушаалтан энэ хуулийн 105.1-д заасан зөрчил гаргасан, эсхүл захиргааны шийдвэрийг сайн дураараа эс биелүүлсэн албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дараах шийтгэлийн аль нэгийг оногдуулна:<br>105.2.1.хууль биелүүлж ажиллахыг хаалттай болон нээлттэй сануулах;<br>105.2.2.албан тушаалын цалингийн хэмжээг зургаан сар хүртэл хугацаагаар 2О хүртэл хувиар бууруулах;<br>105.2.3.ажлаас халах;<br>105.2.4.нийтийн албанд нэгээс арав хүртэл жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах.<br>105.4.Энэ хуулийн 105.1, 105.2 дахь хэсгээс бусад зүйл, заалтыг зөрчсөн албан хаагчид Төрийн албаны тухай хууль, тус харилцааг нарийвчлан зохицуулсан холбогдох бусад хуулиар хариуцлага хүлээлгэнэ. |
| **Зорилгодоо хүрсэн байдал** | Онол арга зүйн хувьд алдаа байгаа эсэх |

pdfelement

**Үнэлгээ**

Энэ заалтын талаар судлаачдаас санал авсан болно.

Судлаач:

Захиргааны үйл ажиллагааны үндсэн дүрэм болох ЗЕХ-д захиргааны байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэр, үйл ажиллагаатай холбогдуулан хариуцлага хүлээлгэх асуудлыг тусгасан нь дэвшилттэй зохицуулалт болсон. Өөрөөр хэлбэл гаргаж буй шийдвэртээ илүү хариуцлагатай хандах шаардлагыг үүсгэсэн. Харамсалтай нь практикт уг зохицуулалтын дагуу хариуцлага хүлээлгэж байгаа эсэх нь тодорхойгүй байна. Энэ нь нэг талаас журмын дагуу захиргааны үйл ажиллагааг хууль бус болохыг тогтоолгосон этгээдүүд холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцохыг эргэж шаардахгүй, хариуцлага нэхэхгүй байгаатай холбоотой байж болох юм. Мөн уг зохицуулалтыг шинэчилсэн Төрийн албан хууль тогтоомжийн хүрээ, хариуцлагын механизмтай оновчтой уялдуулах нь чухал болов уу.

Энэ талаар онолын болон практик судалгаа, хангалттай туршлага байхгүй тул тодорхой санал дүгнэлт гаргаагүй болно.

Судлаач:

Онолын талаас хууль зөрчсөн нь шүүхээр тогтоогдсон албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх нь зүй ёсны асуудал боловч үүнийг хэт туйлшруулан авч үзэх нь эргээд захиргааны байгууллага үйл ажиллагаа явуулах боломжийг хязгаарлагдмал байна. Өөрөөр хэлбэл, төрийн албан хаагч би шийтгэл хүлээж магадгүй гэсэн айдастай байвал чиг үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлж чадахгүйд хүрнэ. Иймд энэ асуудлыг шийдвэрлэхдээ дээрх нөхцөл байдлын зохистой тэнцвэрийг олох нь зүйтэй болов уу. Тодруулбал, илт хууль бус шийдвэр гаргасан, эсхүл удаа дараа буюу нэг асуудлаар

дахин давтан шинжтэй хууль бус шийдвэр гаргасан албан тушаалтанд шийтгэл ногдуулдаг байхаар зохицуулж болох юм.

Хамтын удирдлагатай захиргааны байгууллагын шийдвэр хууль бус тохиолдолд албан тушаалтанд хэрхэн сахилгын шийтгэл ногдуулах вэ гэдгийг нарийвчлан зохицуулах шаардлагатай гэж үзэж байна. Тухайн шийдвэрийг гаргахад оролцсон бүхий л гишүүнд сахилгын шийтгэл ногдуулах уу эсхүл зөвхөн дэмжсэн санал өгсөн гишүүнд сахилгын шийтгэл ногдуулах уу гэх мэт.

Мөн уг зохицуулалтыг Төрийн албаны тухай хуульд заасан сахилгын шийтгэлийн төрөлтэй уялдуулах эсэх, алийг нь давуу гэж үзэхийг тодорхой болгох шаардлагатай. Учир нь Төрийн албаны тухай хуульд байхгүй сахилгын шийтгэлийн төрөл ЗЕХ-ийн 105-р зүйлд туссан байгаа.

Судлаач:

Маш чухал зохицуулалт. Энэ зохицуулалтыг хэрэгжилт тал дээр анхаарах зүйл их бий. Хэрэгжүүлэх байгууллагуудынх нь түвшинд УИХ-аас төсөв мөнгийг нь шийдвэрлэж өгөх, менежментын оновчтой хувирбарыг Засгийн газар журмаар баталгаажуулж өгөх зэрэг ажлууд л хиймээр байгаа юм.

Судлаач:

Хариуцлагын зохицуулалтыг тусгаж өгсөн нь сайн тал. Гэвч хэрэгжилт нь ямар байдаг талаар судалгаа байхгүй тул хэлэхэд хэцүү. Захиргааны хэргийн шүүхэд шийдвэрлэгдэж буй маргааны шийдвэрийг нэхэмжлэгч иргэн хуулийн этгээдийн талд 50 хувьтай шийдвэрлэдэг гэж үзвэл захиргааны байгууллага албан тушаалтны шийдвэр 50 хувьтай хангалтгүй дүн авна гэсэн үг. Хэрэв энэ тохиолдолд шүүхээд шийдвэрлэгдэж, хүчин төгөлдөр болсон шийдвэрийг үндэслэн тухайн захиргааны үйл ажиллагаанд алдаа гаргасан албан тушаалтныг шийдвэрлэх асуудал яригдах хууль зүйн үр дагавар байх ёстой. Манай байгууллагын судалгаагаар ЗЕХ-ийн 103-д заасан захиргаа өөрт учирсан хохирлоо буруутай албан тушаалтнаар барагдуулсан тохиолдол байхгүй гэж гарсан тул 105-аар зүйл мөн адил хэрэгждэг эсэх нь эргэлзээтэй.

pdfelement

*Хүснэгт 5. Шалгуур үзүүлэлт 1*

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 105.1.Захиргааны байгууллагын захиргааны шийдвэр гаргах ажиллагаа болон захиргааны акт энэ хуулийн дагуу эрх зүйн зөрчилтэйд тооцогдож эрх зүйн үр дагаваргүй болсон бол тухайн гэм буруутай албан тушаалтны санаатай болон санамсаргүй үйлдсэн зөрчилд нь тохирох шийтгэлийг оногдуулна.<br>105.2.Тухайн албан тушаалтныг томилсон болон дээд шатны байгууллагын албан тушаалтан энэ хуулийн 105.1-д заасан зөрчил гаргасан, эсхүл захиргааны шийдвэрийг сайн дураараа эс биелүүлсэн албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дараах шийтгэлийн аль нэгийг оногдуулна:<br>105.2.1.хууль биелүүлж ажиллахыг хаалттай болон нээлттэй сануулах;<br>105.2.2.албан тушаалын цалингийн хэмжээг зургаан сар хүртэл хугацаагаар 2О хүртэл хувиар бууруулах; |

Remove Watermark Now

| | |
|---|---|
| | 105.2.3.ажлаас халах;<br><br>105.2.4.нийтийн албанд нэгээс арав хүртэл жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах. |
| **Практикт хэрэглэгдэж байгаа байдал** | Хэрэгжүүлэхэд гарч буй бэрхшээл байгаа эсэх |

**Үнэлгээ:**

Судалгаанд хамрагдсан 14 байгууллагаас энэ заалтын хэрэгжилтийн талаар асуухад нэг ч шийдвэр гараагүй гэж хариулсан. . Иймд энэ шалгуур үзүүлэлтээр дүгнэлт гаргах боломжгүй болсон.

**3.2. ЗЕХ-ийн 105.3 зүйл**

*Хүснэгт 6. Шалгуур үзүүлэлт 1*

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 105.3.Албан тушаалтан хууль зөрчиж гаргасан захиргааны актаа хүчингүй болгосон тохиолдолд тухайн акт хувь хүнд чиглэсэн бол ганцаарчилсан уучлалт, харин хэд хэдэн хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн захиргааны актыг хүчингүй болгосон тохиолдолд энэ хуулийн 105.2-т заасан шийтгэлээс аль нэгийг оногдуулахаас гадна энэ талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан тэднээс уучлалт хүснэ. |
| **Практикт хэрэглэгдэж байгаа байдал** | Хэрэгжүүлэхэд гарч буй бэрхшээл байгаа эсэх |

pdfelement

**Үнэлгээ**

Судалгаанд хамрагдсан 14 байгууллагаас энэ заалтын хэрэгжилтийн талаар асуухад нэг ч шийдвэр гараагүй гэж хариулсан. Иймд энэ шалгуур үзүүлэлтээр дүгнэлт гаргах боломжгүй болсон.

**3.3. ЗЕХ-ийн 107.2**

*Хүснэгт 7. Шалгуур үзүүлэлт 1*

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 107.2.Захиргааны байгууллагын болон шүүхийн шийдвэрийг үл биелүүлсэн албан тушаалтанд холбогдох хуульд заасан хариуцлагыг шүүх оногдуулна |
| **Зорилгодоо хүрсэн байдал** | Онол, арга зүйн алдаатай эсэх |

**Үнэлгээ:**

Энэ заалтын талаар шүүгчдээс ярилцлага авсан болно.

Шүүгч:

Remove Watermark Now

Яг одоогоор ЗЕХ-ийн 107 дугаар зүйлээр шүүхэд хандахгүй байгаа ч албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх асуудлаар хандах нь бий. Шүүх бол халагдсан иргэний эрх ашгийг хамгаалдагаас халах шийтгэл ногдуулдаг байгууллага биш. Харин шүүх ажлаас халах шийтгэл ногдуулахыг харьяа дээд албан тушаалтанд даалгах шийдвэр гаргаж болох юм. Үндсэн хууль болон бусад хуульд шударга шүүхээр хамгаалуулах эрхтэй гэж л заасан. Иймд энэ заалт Үндсэн хууль, Шүүхийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, зарчим хэр нийцэж байна вэ?

Шүүгч:

Энэ зохицуулалтыг хууль тогтоогч яагаад оруулж ирсэн үндэс суурийг судлах хэрэгтэй. Шүүх ажлаас халах шийдвэр гаргана гэхээр утгагүй. Жишээ нь, төрийн тусгай албан хаагч болох ерөнхий прокурорыг ЗЕХ-ийн 107.1-д зааснаар ажлаас халж өгөөч гэж нэхэмжлэл гаргалаа гэхэд уг албан тушаалтныг хэн халж, чөлөөлөх вэ гэдэг нь салбарын хуульд бий. Үүний дундуур шүүх орох нь утгагүй. Тэгэхээр энэ зохицуулалт зөрчилтэй болж харагдаад байна. Харин энэ тохиолдолд иргэн дээд шатны байгууллагад хандаж гомдол гаргах хэлбэрээр зохицуулж болно. Гэтэл дээд шатны албан тушаалтан арга хэмжээ авахгүй байгаа бол шүүхэд дээд шатны албан тушаалтны буруутай үйл ажиллагааг тогтоолгоё гэж хандах хэлбэрээр зохицуулна гэсэн үг. Тэгэхээр шүүх даалгах хэлбэрээр дам байдлаар оролцож болно.

**Дүгнэлт, зөвлөмж:**

1.Судалгаанд хамрагдсан 14 захиргааны байгууллага ЗЕХ-ийн 11-р бүлгийн 105-р зүйлийг хэрэгжүүлж шийдвэр гаргаагүй байна. Иймд үнэлгээ хийх боломжгүй байв.

2. Монгол улсад хүчин төгөлдөр үйлчилж буй 660 хуулиас 184 хуулинд төрийн албан хаагчдад хүлээлгэх хариуцлагыг зохицуулсан. Төрийн албаны тухай хуулийг эшилсэн 145 хууль байна. Захиргааны алдаатай акт гаргасан тохиолдолд ЗЕХ-иар сахилгын шийтгэл болон уучлал хүсэх шийтгэл хүлээлгэхээр зохицуулсан.

Гэм буруутай албан тушаалтанд хүлээлгэж буй сахилгын шийтгэл нь Төрийн албаны тухай хуулиар зохицуулж буй шийтгэлээс хэрхэн ялгаатай болох, давхцал үүсвэл процессыг нь хэрхэн зохицуулах вэ гэдэг асуултууд гарч ирж байна. Эдгээр асуултанд онол арга зүйн үүднээс тайлбар гаргах нь зүйтэй болов уу?

3. ЗЕХ-ийн 107.2-ын заалтыг тайлбарлах, хэрэв шүүхээс буруутай албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх шаардлагатай гэж үзвэл захиргааны хариуцлага хүлээлгэх буюу торгох шийтгэлийн хэлбэртэй байх.

pdfelement

Remove Watermark Now

# ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН 3, 6, 11 ДҮГЭЭР БҮЛГИЙН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

## Нэг. ЗЕХ-ийн 3-р бүлэг

- ЗЕХ-ийн 11.3, 11.4

Дүгнэлт :

1. Захиргааны байгууллага нь ЗЕХ-ийн 11.3-т заасан захиргааны үйл ажиллагааны хэлбэрүүдээс захиргааны актыг голчлон хэрэглэж байна. Захиргааны гэрээний талаархи мэдлэг тааруу байгаагаас шалтгаалан хэрэглээ хангалтгүй байна.

Зорилгодоо хүрсэн байдлын шалгуур үзүүлэлтийг практикт хэрэгжиж буй байдлын шалгуур үзүүлэлттэй харьцуулахад захиргааны актын хэрэглээг голчлон хэрэглэж байгаа ч сонгоно гэж заасан тул энэ заалтын хэрэгжилт хангалтай гэж дүгнэлээ.

2. ЗЕХ-ийн 11.4 дэх заалтыг судалгаанд хамрагдсан захиргааны байгууллагууд хэрэглээгүй байна. Захиргааны байгууллагууд шалтгаанаа хуулийн заалтын агуулгыг ойлгохгүй, үйл ажиллагааны өөр ямар хэлбэр байх талаар тодорхой жишээг хэлж мэдэхгүй гэжээ.

Зорилгодоо хүрсэн байдлын шалгуур үзүүлэлтийг практикт хэрэгжиж буй байдлын шалгуур үзүүлэлттэй харьцуулахад ЗЕХ-ийн 11.4 дэх заалт хэрэгждэггүй гэсэн дүгнэлтэнд хүрлээ.

- ЗЕХ-ийн 13.1, 13.4

Дүгнэлт:

1. -ЗЕХ-ийн 13-р зүйлийн 1 дэх хэсгийн шийдвэр гаргах ажиллагааны оролцогч болох захиргааны акт, гэрээний эрх зүйн үйлчлэл шууд ба шууд бусаар чиглэсэн этгээдийн талаар хуульд тусгасан томъёоллын талаар судлаач, шүүгчдээс ярилцлага авахад 9 судлаач, шүүгч нараас олонхи нь оновчтой гэж үзсэн ба харин хэнийг багтаах вэ гэдэг асуултад ялгаатай байдлаар хариулсан. Ялангуяа шууд бусаар чиглэсэн этгээд гэдгийг харилцан адилгүй агуулгаар тайлбарлаж байв.

- Татан оролцуулсан этгээдийн талаарх ойлголт ч судлаач, шүүгчдийн хувьд харилцан адилгүй байлаа.

- Иргэдийн хувьд хуульд заасан томъёоллын талаар асуухад мэдэхгүй, ойлгохгүй байна гэсэн хариуг өгч байсан.

Иймд уг ойлголтод ямар субьектууд хамаарахыг тайлбарлан тусгах (аутентик тайлбарыг ашиглаж болох) шаардлагатай гэсэн судлаач 1-ийн саналыг дэмжиж байна. Иймд 13.1-ийн заалт зорилгодоо хүрсэн байдлын шалгуураар авч үзвэл хангалтгүй байна гэж үзлээ.

2. 13-р зүйлийн 1 дэх заалтын хүлээн зөвшөөрөгдөх байдлын шалгуураар авч үзвэл иргэдээс авсан санал асуулгын үр дүнгээс харахад 46,7 хувь нь ямар нэг байдлаар захиргааны байгууллагын шийдвэр гаргах ажиллагаанд оролцож байжээ. Харин үлдсэн 52 хувь болох иргэдээс оролцож байгаагүй шалтгааныг нь тодруулан асуухад: Оролцох эрхтэй гэдгээ мэдэхгүй байснаас оролцоогүй гэж 20 хувь, хариулж мэдэхгүй байна гэж 30 хувь нь үзсэн нь захиргааны байгууллагын шийдвэр гаргах ажиллагаанд оролцоогүй



pdfelement

Remove Watermark Now

гол шалтгаан нь иргэд оролцох эрхтэй гэдгээ мэдэхгүй учраас гэж хариулсан байдал өндөр байна. Энэ нь иргэдэд шийдвэр гаргах ажиллагаанд оролцох эрхтэй талаар мэдээлэл хангалтгүй байгааг харуулж байна. Харин эдгээр иргэдэд ЗЕХ-ийн талаар мэдээлэл өгөхөд ийм хууль гарсан нь сайшаалтай байна гээд цаашид шийдвэр гаргах ажиллагаанд идэвхитэй оролцох болно хэлж байлаа. Тиймээс хуулийн хүрээнд иргэдийн эрх, үүргийг тодорхой ойлгуулах, мэдээллээр хангах шаардлага гарч байна.

Хүлээн зөвшөөрөгдөх шалгуур үзүүлэлтийн хувьд уг заалт хангалттай гэж дүгнэж болно.

3. 13-р зүйлийн 1-ийн практикт хэрэглэгдэж буй шалгуур үзүүлэлтээр авч үзвэл хангалтгүй байна. Энэ нь эрх бүхий байгууллагын санаачилга муу, хуулийг хэрэгжүүлэх хүсэл зориг сул байгаатай холбоотой. Мөн нөгөө талаас шийдвэр гаргах ажиллагаанд оролцогчийн эрхийг хангахын тулд тухайн байгууллагын зардал өсдөг тухай холбогдох албан тушаалтнууд саналаа хэлж байсан. Тиймээс байгууллагын үйл ажиллагааны тайланд шинжилгээ хийж, уг заалтын хэрэгжилтэд хүндрэл гарч буй шалтгааныг тогтоох шаардлагатай.

- ЗЕХ-ийн 24.1, 24.5

Дүгнэлт:

Энэ заалтын хэрэгжилтийг практикт хэрэглэж байгаа байдлын шалгуур үзүүлэлтээр авч үзэхэд хангалтгүй байна. Шийдвэр гаргах ажиллагаанд хамаарах нотлох баримтын талаар ойлголт муу, ялангуяа судалгаа, тооцоолол, шинжилгээнд суурилсан аргаар нотлох баримтуудаа үнэлэх гэдгийг ойлгохгүй байна. Иймд Захиргааны ерөнхий хуулийн 24.1-24.5-д заасан нөхцөл байдлыг тогтоох ажиллагаа, түүний хүрээнд хийж болох ажиллагаа ялангуяа газрын маргааны хувьд захиргааны байгууллага бараг хийхгүй байна.

pdfelement

- ЗЕХ-ийн 25-р зүйл.

Дүгнэлт:

Захиргааны байгууллагууд ЗЕХ-д заасан нотлох баримтыг цуглуулах, үнэлэх ажиллагааг хангалттай хийхгүй байна. Захиргааны шийдвэрийн талаар хангалттай нотлох баримтыг бүрдүүлэхгүй, иргэнээс санал авсан төдийхнөөр нотлох баримт цуглуулсан гэж үздэг. Бодит нөхцөл байдлыг тогтоосон судалгаа, шинжилгээ, аргачлал байхгүй, туршилт хийхгүй, зөвхөн ажлын байранд хурал хийх замаар захиргааны шийдвэрүүд гарч байгааг ажиглалт болон шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийхэд илэрч байна.

- ЗЕХ-ийн 26, 27, 28

Дүгнэлт:

ЗЕХ-ийн 26, 27, 28-р зүйлүүд сонсох ажиллагааны талаар зохицуулсан. Судалгаанд хамрагдсан 14 байгууллага сонсох ажиллагааг хийж эхлүүлсэн байна. Гэхдээ хуульд заасан журам, шаардлагын дагуу сонсох ажиллагаа хангалттай явагдахгүй байгаа нь судалгааны явцад ажиглагдлаа. Ялангуяа сонсох ажиллагааны мэдэгдлийг хуульд заасан шаардлагын дагуу бэлтгэж, оролцогчдод өгөхгүй байна. Мөн сонсох ажиллагааны мэдэгдэл өгсний дараа хэзээ уг ажиллагааг явуулах, оролцогчдод тайлбар, санал гаргах хугацааг хэрхэн тооцох талаар зохицуулалт байхгүйгээс

Remove Watermark Now

хэлбэрийн төдий ажиллагаа болоод байна. Захиргааны байгуулагын зүгээс гарч буй саналын хувьд зардал, хэн сонсох ажиллагааг хийх вэ гэдэг нь тодорхойгүйгээс бэрхшээл учирч байна гэжээ.

Зорилгодоо хүрсэн байдлын шалгуур үзүүлэлтийн хувьд хангалттай гэж үзсэн харин практикт хэрэгжиж байгаа байдлыг хангалтгүй гэж дүгнэж байна.

- ЗЕХ-ийн 29-р зүйл

Дүгнэлт:

Захиргааны шийдвэрийн хувийн хэрэг, хяналтын дагалдах хуудасны талаар судалгаанд хамрагдсан захиргааны байгууллагуудаас хуульд заасан журмын дагуу хөтөлж байгаа нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, СХД-ийн Тамгын газар байна. Ихэнхи байгууллагаас гарч буй санал бол зардал ихтэй, архив, хадгалалттай холбоотой бэрхшээлүүд гарч байна гэжээ.

Зорилгодоо хүрсэн байдлын шалгуураар авч үзвэл хувийн хэргийн бүрдүүлбэр байхыг захиргааны байгууллага, шүүгч нар дэмжсэн тул хангалттай гэж үзлээ. Харин практикт хэрэгжиж буй байдлын шалгуур үзүүлэлтийн хувьд хангалтгүй гэж дүгнэж байна.

Зөвлөмж:

1. Үнэлгээ хийхэд гарч байсан бэрхшээл:

Манай улсад хуулийн хэрэгжилтийн хяналт шинжилгээний нэгдсэн мэдээллийн сан байхгүй тул аливаа хууль зорилтод заасан үр дүндээ хүрсэн эсэхийг тоон шалгуур үзүүлэлтээр үнэлэхэд бэрхшээлтэй байдаг. Хэдийгээр чанарын буюу ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулж байгаа ч төрийн албан хаагчийн өгч буй мэдээллийн бодитой байдал эргэлзээтэй. Учир нь үр дүнгийн гэрээ, дээд албан тушаалтны дарамт зэрэг хүчин зүйлсээс хамаардаг билээ. Мөн захиргааны байгууллагуудын гаргасан шийдвэрийн нэгдсэн сан хангалтгүй, мэдээллийн ил тод байдал муу байгаа тохиолдолд бичиг баримтын шинжилгээ хийхэд хүндрэл гардаг. Энэ судалгааны явцад эдгээр бэрхшээлүүд харьцангуй бага гарсан нь ХЗДХЯ-ны зохион байгуулалт сайтай үйл ажиллагаанаас хамаарч байсныг дурьдахгүй өнгөрч болохгүй.

2. Огт хэрэгжээгүй заалт:

-ЗЕХ-ийн үнэлгээ хийсэн зүйл, заалтуудын зорилгодоо хүрсэн байдлын шалгуур үзүүлэлтээр нь авч үзвэл практикт үр дагаврууд гарсаар байхад тухайн хуулийн зохицуулалт огт үйлчлэхгүй байна. Үүнд: ЗЕХ-ийн 13.4, 27.3, 27.7, 28.2 –р зүйл тус тус багтана.

Энэ нь хуулийн заалтын агуулга ойлгомжгүй, хэрэгжих боломжгүй байдлаас бус харин захиргааны байгууллагын санаачилгагүй, хэрэгжүүлэх хүсэл зориггүйгээс шууд шалтгаалж байна.

-Хуулийн зохицуулалтын агуулга, томъёолол ойлгомжгүйгээс хэрэгждэггүй заалтад 11.4-ийг оруулж байна. Захиргааны байгууллагын зүгээс тавьж буй саналд ямар үйл ажиллагаа байхыг тодорхойлсон тайлбар хэрэгтэй гэжээ.

-24, 25- р заалт буюу нөхцөл байдлыг тогтоох, нотлох баримтыг цуглуулах талаар захиргааны байгууллагууд ЗЕХ-д заасан журмын дагуу хийж байгаа талаар нотолгоо бүхий шийдвэрүүд гаргахгүй байна. Энэ нь захиргааны байгууллагын шийдвэр гаргах эрх

бүхий албан тушаалтан, албан хаагчдын мэдлэг, ур чадвараас хамаарч байна гэж үзлээ. Иймд сургалт явуулах шаардлагатай.

-Мэдээллийн сан хангалттай биш тохиолдолд үнэлгээ хийхэд бэрхшээл гардаг тул Хууль тогтоомжийн тухай хуулиар хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийхээр заасан нь чухал зохицуулалт болсон.

-Судалгаа хийж байх явцад зарим заалт практикт огт хэрэгжээгүй байгаа нэг хүчин зүйл бол үнэлгээ хийх хугацаанаас бас хамаарч байсан.

3. Хэрэгжиж эхэлж байгаа заалт :

Судалгаанд үнэлэгдсэн бусад зүйл, заалтууд энэ хэсэгт багтаж байна. Гэхдээ ихэнхи заалтын хувьд хэлбэрийн төдий хэрэгжиж эхэлж байна гэж үзлээ. Нийтлэг алдаа нь ЗЕХ-д заасан журмыгягштал баримтлаагүй, буруу хэрэглэсэн байна. Ж: сонсох ажиллагааны мэдэгдлийг захиргааны акт баталсны дараа хэрэглэдэг мэдэгдэх хуудас гэж ойлгох, сонсох ажиллагаа явуулаад тайлбар, санал өгөх хугацааг гаргадаггүй, иргэдээс саналыг аваагүй шалтгааны талаар тайлбар хийдэггүй зэргийг дурьдаж болно. Иймд сонсох ажиллагааны нарийвчилсан үлгэрчилсэн журмыг Засгийн газраас гаргах шаардлагатай байна.

ЗЕХ-ийн 103,105-р зүйлд заасан зохицуулалтын хэрэгжилт сайжирвал энэ бүлэгт нөлөөлөх боломжтой гэж таамаглал дэвшүүлж байна.

**<u>Хоёр. ЗЕХ- ийн 6-р бүлэг</u>**

- ЗЕХ-ийн 59, 60-р зүйл

Дүгнэлт:

1. ИТХ-ын Үндсэн хуулиар олгогдсон бие даасан шийдвэр гаргах эрх ба хуулиар түүнд шилжүүлсэн чиг үүрэг гэж байдаг. Тиймээс Хурлын гаргаж буй захиргааны хэм хэмжээний актыг энэ хоёр шинжээр нь ялгаж ЗЕХ-ийн энэ заалтыг хэрэглэх нь зүйтэй болов уу.

2.Захиргааны байгууллагууд өөрт тусгайлан эрх олгогдсон эсэх талаар салбарын хуулиудад судалгаа хийж тоон мэдээллийн сан бүрдүүлэх шаардлагатай байна. Ингэснээр салбарын хүрээнд хяналт шинжилгээг тогтмолжуулах, хуулиар зохицуулаагүй асуудлаар тохиолдол үүсэх эсэхийг урьдчилж судалж, хэрэв тийм нөхцөл байдал гарсан бол дээд шатны байгууллага, хууль тогтоогч нарт саналаа хүргүүлэх зэрэг процессын харилцааг зохицуулж өгөх.

3.Хаанаас байгуулагдсан (ИТХ-ын бие даасан шийдвэр гаргах эрхээс бусад) эсэхээс үл хамааран гадагшаа чиглэсэн байнгын үйлчлэлтэй хэм хэмжээний акт гаргах гэж байгаа бол заавал эрх олгогдсон байхыг шаардах.

4.Хуулиар хориглоогүй асуудал гэдгийг онол арга зүйн хувьд оновчтой тодорхойлох.



pdfelement
Remove Watermark Now

Remove Watermark Now

5.Нөлөөллийн шинжилгээ болон хяналт шинжилгээ хийх явцад зайлшгүй хориглох нөхцөл байдал бий болсон үед дээд шатны байгуулага, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хандах процессыг нарийвчлан зохицуулах.

- ЗЕХ-ийн 64.2

Дүгнэлт:

1.Энэ заалтыг хэрэгжүүлэхэд Засгийн газраас гаргасан хэм хэмжээний актыг ЗЕХ-д заасан журмын дагуу бүртгэх, хянах эрх бүхий байгууллага нь ЗЕХ-даа тодорхойгүй байна. Харин Засгийн газрын тухай хуулийн 30. 9-д ХЗДХЯ-д байхаар хуульчилсан. Засгийн газар нь дээд шатны байгууллага тул салбарын яам нь хянах боломжгүй, мөн эрх мэдэл хуваарилах онолоор хууль тогтоох нь УИХ-д, шүүх эрх мэдлийг нь шүүхэд, гүйцэтгэх эрх мэдэл нь ЗГ-т байгаа. Гэтэл ЗГ-ыг нь захиргааны байгууллага гээд ЗЕХ-д хамаатуулж байгаа. Тэгвэл, захиргааны шүүх УИХ-ын шийдвэрийг яагаад хянаж болдоггүй вэ? Гэтэл энэ чинь адилхан эрх мэдлийн дээд байгууллага. Өөрөөр хэлбэл, гурван эрх мэдлээс ЗГ-ыг сугалж аваад ЗЕХ-нд хамаатуулаад захиргааны байгууллага гэж үзээд байгаа вэ? гэж ЗГХЭГ-ын албан хаагч нар үзсэн бол УИХ-ын Тамгын газрын албан хаагчид “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу УИХ хүчингүй болгоно” гэж Үндсэн хуульд заасны дагуу УИХ бүрэн хянах боломжтой гэж үзэж байна. ХЗДХЯ бүртгэж байгаа нь харьяа байгууллага гэдгээр хандаж байгаа асуудал биш. Хууль зүйн чиглэлийн бодлогыг хэрэгжүүлж байгаа яам гэдгээр бүртгэж байгаа. Энэ бол захирах захирагдах ёс биш. Энэ бол ХЗДХЯ чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой л асуудал гэж судалгаанд оролцсон шүүгч саналаа хэлж байв.

pdfelement

Зөвлөмж:

1.Үндсэн хуулиар (62.2) ИТХ-д олгогдсон бие даасан шийдвэр гаргах эрх ба хуулиар түүнд шилжүүлсэн чиг үүрэг гэж байдаг. Тиймээс Хурлын гаргаж буй хэм хэмжээний актыг бие даасан хэм хэмжээний ба захиргааны хэм хэмжээний актын шинжээр нь ялгаж ЗЕХ-ийн энэ заалтыг хэрэглэх нь зүйтэй.

2.ЗЕХ-ийн 64.2-т заасан Засгийн газрын баталсан захиргааны хэм хэмжээний актыг бүртгэх, хянах байгууллага нь УИХ-ын харьяа нэгж байгуулах, энэ процесстэй холбоотойгоор Засгийн газрын тухай хуулийн 30.9 –р заалтыг хүчингүй болгох

3.Энэхүү УИХ-ын харьяа нэгжид УИХ-аас байгууллагддаг захиргааны байгууллагуудын захиргааны хэм хэмжээний актыг бүртгэж, хянах

4.Захиргааны хэм хэмжээний актыг батласнаас хойш ажлын таван өдрийн дотор бүртгүүлэх хугацааг нийслэл, орон нутгийн түвшинд ялгаатай тогтоох

5.ЗЕХ-ийн 66.4 дэх заалтын хувьд ИТХ-ын онцлогийг харгалзах

6.ЗЕХ-ийн 66.8 дахь заалтыг агуулгын болон бусад хуулиудтай зөрчилдөж байгаа эсхийг нягтлах. Үүнд: ИТХ-ын шийдвэр, УИХ-аас байгуулагддаг хараат бус байгууллагын шийдэрийг хүчингүй болгох субьект Засгийн газар мөн эсэх.

Хүчин төгөлдөр болоогүй шийдвэрийг хүчингүй болгох зохицуулалт нь томъёоллын алдаа юу эсвэл зарчмын алдаа юу гэдэгт тайлбар өгөх

7.ЗЕХ батлагдахаас өмнө гарсан захиргааны хэм хэмжээний актыг бүртгэх, мөн хуульд байгаа шаардлагыг хангахдаа дахиж процесс үүсгэх эсэх талаар гарч маргааныг нэг мөр болгох

Санал: одоо хүчин төгөлдөр үйлчилж буй захиргааны хэм хэмжээний актуудыг ЗЕХ-д нийцүүлж нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай.

Remove Watermark Now

8.Бусад заалтын хувьд хэрэгжилт хангалтгүй байх шалтгаан нь хуульд заасан үүргийг захиргааны байгууллагууд биелүүлэхгүй, тэдний хариуцлагагүй үйлдэлтэй холбоотой гэж дүгнэж байна.

## Гурав. ЗЕХ-ийн 11 дүгээр бүлэг

Дүгнэлт, зөвлөмж:

1.Судалгаанд хамрагдсан 14 захиргааны байгууллага ЗЕХ-ийн 11-р бүлгийн 105-р зүйлийг хэрэгжүүлж шийдвэр гаргаагүй байна. Иймд үнэлгээ хийх боломжгүй болсон.

2.Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй 660 хуулиас 184 хуулинд төрийн албан хаагчдад хүлээлгэх хариуцлагыг зохицуулсан. Төрийн албаны тухай хуулийг эшилсэн 145 хууль байна. Захиргааны алдаатай акт гаргасан тохиолдолд ЗЕХ-иар сахилгын шийтгэл болон уучлал хүсэх шийтгэл хүлээлгэхээр зохицуулсан.

Гэм буруутай албан тушаалтанд хүлээлгэж буй сахилгын шийтгэл нь Төрийн албаны тухай хуулиар зохицуулж буй шийтгэлээс хэрхэн ялгаатай болох, давхцал үүсвэл процессыг нь хэрхэн зохицуулах вэ гэдэг асуултууд гарч ирж байна. Эдгээр асуултанд онол арга зүйн үүднээс тайлбар гаргах нь зүйтэй болов уу?

3.ЗЕХ-ийн 107.2–ыг тайлбарлах, хэрэв шүүхээс буруутай албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх шаардлагатай гэж үзвэл захиргааны хариуцлага хүлээлгэх буюу торгох шийтгэлийн хэлбэртэй байх.

pdfelement

Remove Watermark Now

# ДӨРӨВ. Захиргааны ерөнхий хуулийн V, VIII, IX дүгээр бүлгийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан

Гүйцэтгэсэн:

- **Ц.Цогт**
  /Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч, хууль зүйн доктор (LL.D.)/
- **С.Амартүвшин**
  /Хуульч, хууль зүйн магистр (LL.M.)/
- **Ц.Нугармаа**
  /Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн/

pdfelement

Remove Watermark Now

# ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН 5, 8, 9 ДҮГЭЭР БҮЛГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн Захиргааны ерөнхий хуулийн 5, 8, 9 дүгээр бүлгийн эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт, түүний үр нөлөөг илрүүлэх, харьцуулан үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын дагуу үнэллээ.

Үнэлгээний зорилго нь:

- 1. Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар бүлэг буюу /**Захиргааны гэрээ/-ний** талаарх зохицуулалт нь анх хуулиар тавьсан зорилгодоо хүрсэн түвшин, практикт хэрэглэгдэж байгаа байгаа байдлыг тогтоох;
  2. Захиргааны ерөнхий хуулийн 8 дугаар **бүлэг буюу /Захиргааны шийдвэр гүйцэтгэл/-ийн талаарх зохицуулалт нь анх хуулиар тавьсан зорилгодоо хүрсэн эсэх,** хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг тогтоох;
  **3.** Захиргааны ерөнхий хуулийн 9 дүгээр **бүлэг буюу /**Захиргааны актад гомдол гаргах/ **талаарх зохицуулалт нь анх хуулиар тавьсан зорилгодоо хүрсэн эсэх,** бусад урьдчилан тооцоолоогүй үр дагавар гарсан эсэхийг тодорхойлох.

- Цаашдын үр дагавар, нөлөөллийг илрүүлэн гаргаж хууль тогтоомжийг боловсронгуй болгоход холбогдох санал, дүгнэлт өгөхөд оршино.

Үнэлгээг дараах үе шаттайгаар хийж гүйцэтгэлээ. Үүнд:

7. Төлөвлөх үе шат
8. Хэрэгжүүлэх үе шат
9. Үнэлэх үе шат

pdfelement

## НЭГ.ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

### 1.1.Үнэлгээ хийх шалтгаан

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-д Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахаар заасан бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтад “тухайн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх”-ээр заасан.

Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар бүлэгт үнэлгээ хийх шалтгаан нь:

- Захиргааны гэрээг захиргааны гадагш чиглэсэн үйл ажиллагаанд хэрэглэгдэх (иргэн, хуулийн этгээдтэй харилцах) хууль зүйн нэгэн шинэ “хэлбэр” болгон нэвтрүүлэх, ингэснээр захиргаанаас зөвхөн акт гаргах замаар зохицуулалт хийх “ганцаардсан” байдлыг шинэчлэх зорилгод хүрч байгаа эсэх илрүүлэх;

Захиргааны ерөнхий хуулийн 8 дугаар **бүлэгт** үнэлгээ хийх шалтгаан нь:

- Захиргааны ерөнхий хууль нь захиргааны шийдвэр гүйцэтгэлийн харилцааг бүрэн зохицуулж чадаж байгаа эсэхийг тодруулах, практик хэрэглэгдэж байгаа эсэхийг тогтоох;

Захиргааны ерөнхий хуулийн 9 дүгээр **бүлэгт** үнэлгээ хийх шалтгаан нь:

- Гомдол хянан шийдвэрлэх ажиллагааг захиргааны байгууллага “хэрэглэх” хүсэл зорилго байгаа эсэх, энэ ажиллагаа хий цаг алдсан, шат дамжлага үүсгэсэн ажил

Remove Watermark Now

биш гэдгийг нотлох боломжтой эсэх. Дээд шатны байгууллага, албан тушаалтан бодитоор гомдлыг шүүхээс өмнө урьдчилан шийдвэрлэх бодит боломжтой байдаг эсэхийг тогтоох.

**1.2.Үнэлгээний хүрээг тогтоох**

Захиргааны ерөнхий хуулийн 5, 8, 9 дүгээр бүлгийн зохицуулалтын үнэлэгдэх шаардлагатай зүйл, хэсгийг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 1

| д/д | Үнэлэгдэх зүйл | Үнэлэгдэх хэсэг, заалт |
|---|---|---|
| **ТАВДУГААР БҮЛЭГ/ЗАХИРГААНЫ ГЭРЭЭ/** | | |
| 1 | 52.1 дүгээр зүйл | 52.1.Захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн харилцааг үүсгэж, өөрчилж, эсхүл дуусгавар болгохоор захиргааны гэрээг эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн байгуулж болно. |
| 2 | 52.2.1-52.2.5 дугаар зүйл | 52.2.Дараах харилцаанд захиргааны гэрээг хэрэглэж болно:<br>52.2.1.төрийн алба, боловсрол, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах болон бусад захиргааны эрх зүйн харилцаанд;<br>52.2.2.захиргааны байгууллага өөрийн зарим чиг үүрэг, эрх мэдлийг бусад этгээдэд шилжүүлэх харилцаанд;<br>52.2.3.дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээг бий болгох, тогтвортой ашиглахтай холбогдсон харилцаанд;<br>52.2.4.концессын харилцаанд;<br>52.2.5.хуульд өөрөөр заасан бусад харилцаанд. |
| **НАЙМДУГААР БҮЛЭГ/ЗАХИРГААНЫ ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ/** | | |
| 3 | 83 дугаар зүйл | 83 дугаар зүйл. Захиргааны шийдвэр гүйцэтгэлд тавих шаардлага<br>83.1.Захиргааны шийдвэр гүйцэтгэхэд дараах шаардлагыг хангасан байна:<br>83.1.1.шийдвэр гүйцэтгэх эрхийг нотолсон шийдвэр байх;<br>83.1.2.үүрэг хүлээгчээс уг шаардлагыг биелүүлээгүй байх;<br>83.1.3.хуульд өөрөөр заагаагүй бол шаардах эрх бүхий шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 14 хоногийн хугацаа өнгөрсөн байх;<br>83.1.4.үүрэг хүлээгчид 14 буюу түүнээс доошгүй хоногийн хугацаанд захиргааны шийдвэрийг биелүүлэх тухай мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн байх. |
| 4 | 84 дүгээр зүйл | 84 дугаар зүйл. Захиргааны шийдвэр гүйцэтгэх байгууллага<br>84.1.Захиргааны шийдвэрийг дараах байгууллага гүйцэтгэнэ:<br>84.1.1.захиргааны актыг батлан гаргасан захиргааны байгууллага;<br>84.1.2.дээд шатны захиргааны байгууллагаас гаргасан захиргааны шийдвэрийг анхан шатны захиргааны байгууллага;<br>84.1.3.хуулиар тусгайлан эрх олгосон цагдаагийн болон мэргэжлийн байгууллага.<br>84.2.Захиргааны байгууллага шийдвэр гүйцэтгэлийн талаар өөр захиргааны байгууллагаас тусламж авч болно. |
| 5 | 90 дүгээр зүйл | 90 дүгээр зүйл. Албадлага хэрэглэх шийдвэр гаргах<br>90.1.Мэдэгдэлд заасан хугацаанд үүргийг биелүүлээгүй бол захиргааны шийдвэр гүйцэтгэлийг хариуцсан захиргааны байгууллага албадлага хэрэглэхийг шийдвэрлэсэн захиргааны акт гарган, түүнийг нэн даруй биелүүлнэ.<br>90.2.Энэ хуулийн 90.1-д заасан захиргааны актад зөвхөн захиргааны шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаатай холбоотой гомдол гаргах бөгөөд харин захиргааны акт гаргах журам үйлчлэхгүй. |
| **ЕСДҮГЭЭР БҮЛЭГ /ГОМДОЛ ГАРГАХ ЖУРАМ/** | | |
| 6 | 92 дугаар зүйл | 92 дугаар зүйл. Захиргааны “актад” гомдол гаргах |

| | | |
|---|---|---|
| | | 92.1.Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн, хуулийн этгээдээс түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл холбогдох захиргааны актыг хууль болон зорилгодоо нийцэж байгаа эсэх талаар хянуулахаар гомдол гаргах эрхтэй.<br>92.2.Энэ хуулийн 92.1-д заасан гомдол нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна. |
| | 95 дугаар зүйл | 95 дугаар зүйл. Гомдлыг хянан шийдвэрлэх журам<br>95.1.Захиргааны байгууллага гомдлыг хянан шийдвэрлэх талаар дараах ажиллагаа явуулна:<br>95.1.1.захиргааны акт хууль тогтоомж болон зорилгодоо нийцсэн эсэхийг шалгах;<br>95.1.2.захиргааны байгууллага сонгох боломжоо хэрэглэсэн байдлыг шалгах;<br>95.1.3.гомдол гаргагч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч, шаардлагатай бол эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн гуравдагч этгээдэд гомдлыг шийдвэрлэх он, сар, өдөр, газрыг урьдчилан мэдэгдэж, уг ажиллагаанд хүсэлтээр нь байлцуулах.<br>95.2.Энэ хуулийн 95.1.3-т заасан этгээд хүрэлцэн ирээгүй бол түүний оролцоогүйгээр гомдлыг хянан шийдвэрлэж болно.<br>95.3.Иргэн хүсэлт гаргасан, эсхүл захиргааны байгууллага шаардлагатай гэж үзвэл шинжээч томилон дүгнэлт гаргуулна.<br>**95.4**.Гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны явцын талаар тэмдэглэл хөтлөх бөгөөд уг тэмдэглэлд дараах зүйлийг тусгана:<br>95.4.1.захиргааны акт гаргаж байгаа байгууллагын нэр, хаяг, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр болон өөрийн нэр;<br>95.4.2.захиргааны акт гаргасан, гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан он, сар, өдөр, газар;<br>95.4.3.гомдол гаргагч, хариуцагч, бусад оролцогчийн эцэг, /эх/-ийн нэр болон өөрийн нэр;<br>95.4.4.гомдлын агуулга, шаардлага;<br>95.4.5.мэргэжлийн байгууллага болон шинжээчийн дүгнэлт, гэрчийн мэдүүлэг, бусад нотлох баримт;<br>95.4.6.тэмдэглэл хөтөлсөн болон гомдлыг шийдвэрлэсэн албан тушаалтан, захиргааны байгууллагын эрх баригчийн гарын үсэг.<br>**95.5**.Гомдол гаргагчийн хүсэлтийг хангаж шийдвэрлэхээр бол энэ хуулийн 95.4 дэх хэсэг үйлчлэхгүй бөгөөд гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллага захиргааны актыг шууд гаргаж болно.<br>95.6.Шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 95.1, 95.2, 95.3, 95.4-т заасан ажиллагаанд холбогдуулан гаргасан гомдлын талаар гомдол хянан шийдвэрлэх ажиллагаа явуулна.<br>95.7.Гомдол гаргагчийн хүсэлтийг захиргааны байгууллага хүлээн зөвшөөрч өөрөө шийдвэрлэж болно.<br>95.8.Хамтын удирдлага бүхий захиргааны байгууллага гомдлыг хэлэлцсэн бол асуудал шийдвэрлэх ердийн журмыг баримтлан захиргааны акт гаргана.<br>95.9.Гомдлыг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий захиргааны байгууллага гомдлыг шийдвэрлүүлэхээр бусдад шилжүүлэхийг хориглоно. |
| | 98 дугаар зүйл | 98 дугаар зүйл. Гомдлыг хянан үзээд гаргах захиргааны акт<br>98.1.Энэ хуулийн 93 дугаар зүйлд заасан захиргааны байгууллага гомдлыг хянан үзээд дараах захиргааны актын аль нэгийг гаргана:<br>98.1.1.захиргааны акт илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрөх;<br>98.1.2.гомдол гаргагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол уг захиргааны актыг бүхэлд нь, эсхүл холбогдох хэсгийг хүчингүй болгох; |



Remove Watermark Now
pdfelement

Remove Watermark Now

| | | |
|---|---|---|
| | | 98.1.3.захиргааны байгууллагын эс үйлдэхүй нь иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол захиргааны зохих акт гаргахыг тухайн захиргааны байгууллагад даалгах;<br>98.1.4.захиргааны актыг өөрчлөх;<br>98.1.5.захиргааны актыг хэвээр үлдээх. |

**1.3.Шалгуур үзүүлэлтийг тогтоох**

Үнэлгээ хийхээр сонгосон Захиргааны ерөнхий хуулийн 5, 8, 9 дүгээр бүлгийн холбогдох зүйл, заалтын хэрэгжилтийн байдлыг тогтооход туслах Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтын 3.4-т заасан шалгуур үзүүлэлтээс үнэлэх зүйл, заалтын хэрэгжилтийг бодитоор илэрхийлж гаргаж чадах шалгуур үзүүлэлтийг сонгосон.

Хүснэгт 2

| д/д | Үнэлэгдэх зүйл | Үнэлэгдэх хэсэг, заалт | Шалгуур үзүүлэлт |
|---|---|---|---|
| 1. | **ТАВДУГААР БҮЛЭГ** | **5-р бүлэг. Захиргааны гэрээ**<br>52.1<br>52.2.1 – 52.2.5 | **-Анх хуулиар тавьсан зорилгодоо хүрсэн эсэх,**<br>-Хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг тогтоох |
| 2. | **НАЙМДУГААР БҮЛЭГ** | **8-р бүлэг. Захиргааны шийдвэр гүйцэтгэл**<br>83.1.1 – 83.1.4<br>84.1.1 – 84.1.3<br>84.2<br>90.1 - 90.2 | **-Анх хуулиар тавьсан зорилгодоо хүрсэн эсэх,**<br>-Хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг тогтоох |
| 3. | **ЕСДҮГЭЭР БҮЛЭГ** | **9-р бүлэг Гомдол гаргах журам**<br>92.1-92.2<br>95.1.1-95.1.3<br>95.2-95.3<br>95.4.1-95.4.6<br>95.5-95.9<br>98.1.1-98.1.5 | **-Хуулиар тавьсан зорилгодоо хүрсэн эсэх,**<br>-Бусад урьдчилан тооцоолоогүй үр дагавар гарсан эсэх. |

pdfelement

Шалгуур үзүүлэлтийг сонгохдоо тухайн бүлэг, зүйл, заалтын хэрэгжилтийг илэрхийлэн гаргаж ирэх шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

**1.4.Харьцуулах хэлбэрийг сонгох**

Хууль хэрэгжиж эхэлснээр бий болсон үр дагаврын талаарх мэдээллийг хууль хүчин төгөлдөр хэрэгжиж эхлэхээс өмнө байсан нөхцөл байдал, хүчин зүйлсийн талаарх мэдээллүүдтэй харьцуулах аргаар дүн шинжилгээ хийснээр хуулийг батлах үед тавьсан зорилготой хэр уялдаж байгаа, түүнд хүрсэн түвшин, бусад эерэг, сөрөг өөрчлөлтүүдийг тогтоох, мөн холбогдох мэдээллийг цуглуулж, түүний зарим үзүүлэлтийг хооронд нь харьцуулах явдал юм.

Захиргааны ерөнхий хуулийн 5, 8, 9 дүгээр бүлгийг үнэлэх шалгуур үзүүлэлтээр сонгож авсан зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийг хууль хэрэгжүүлэх явцад бий болсон бодит үр дагавар нь **анх хуулиар тавьсан зорилгодоо хүрсэн эсэх,** хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг тогтоох, бусад урьдчилан тооцоолоогүй үр дагавар гарсан эсэх хуулиар тавьсан зорилгыг хангаж чадаж байгааг харьцуулах аргаар тогтооно. Үүнийг харьцуулах хэлбэр нь хууль тогтоомж хүчин төгөлдөр хэрэгжсэнээс хойш гарсан үр дагаврыг /одоо байгаа нөхцөл байдал/ бодитой хэмжиж тогтоосон үзүүлэлтүүдийн утгыг тухайн хуулийн хэм хэмжээгээр тогтоосон шаардлага, норм, хугацаа, давтамж, хэмжиж

Remove Watermark Now

болохуйц тодорхой тоогоор илэрхийлэгдсэн тоон үзүүлэлттэй харьцуулах хэлбэрээр хуулийн зорилгын хэрэгжилт ямар түвшинд байгааг тогтооно.

Захиргааны ерөнхий хуулийн 5, 8, 9 дүгээр бүлэгт тавигдсан шалгуур үзүүлэлтийн дагуу харьцуулан судлахдаа:

Зорилгод хүрсэн түвшинг - тухайн хууль, эсхүл зохицуулалт нь тавьсан зорилго, зорилтдоо хүрсэн эсэхийг тогтоохад, тухайн хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд анх тавьсан зорилгодоо хүрсэн үү, үгүй юу, хэр зэрэг хүрсэн гэдгийг олж тогтоох;

Хүлээн зөвшөөрөгдсөн байдлыг тогтоох - Иргэд, хуулийн этгээдээс хуулийг хэрэгжүүлснээр гарсан үр дагаврыг хэрхэн хүлээн авч байгааг тодорхойлох. Товчхондоо хуулийг нийгэм хүлээн зөвшөөрч, сайн дураар сахин биелүүлж байгаа эсэхийг энэ шалгуур үзүүлэлтээр томъёолох;

Бусад урьдчилан тооцоологүй үр дагавар гарсан эсэх - урьдчилан тооцоогүй болон шинээр гарч болзошгүй ямар үр дагаврууд байж болохыг тооцоолох харьцуулалтын аргын тусламжтайгаар тогтооно.

**1.5.Мэдээлэл цуглуулах аргыг сонгох**

Хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийхэд тоон болон чанарын мэдээлэл шаардлагатай. Төлөвлөлтийн үе шатанд хийгдсэн өмнөх алхам /үнэлгээний шалтгаан, хүрээг тогтоох, шалгуур үзүүлэлтийг сонгох, харьцуулах хэлбэрийг тогтоох/-уудаа ямар тохиолдолд тоон, ямар тохиолдолд чанарын мэдээллийг ямар аргаар цуглуулахаа энэ үе шатанд сонгоно.

Захиргааны ерөнхий хуулийн 5, 8, 9 дүгээр бүлэгт үнэлгээг хийхдээ мэдээлэл цуглуулах дараах аргыг ашиглана. Үүнд:

- Захиргааны байгууллага өөрийн чиг үүргийн хүрээнд үйл ажиллагаандаа захиргааны гэрээг хэрэглэж байгаа эсэх, мөн гаргасан шийдвэрийн гүйцэтгэл, түүнд албадлага хэрэглэж буй эсэх болон холбогдох гомдлын шийдвэрлэлтийн талаар захиргааны байгууллагуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулах /Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Үндэсний хөгжлийн газар, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Нийслэлийн Засаг даргын тамгын газар, түүний хэрэгжүүлэгч болон тохируулагч агентлагууд[63], Захирагчийн ажлын алба, Төрийн албаны зөвлөл[64], Санхүүгийн зохицуулах хороо[65], Татварын маргаан таслах зөвлөл, Сүхбаатар аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Сүхбаатар аймгийн Засаг даргын тамгын газар, түүний харьяа агентлагууд[66]/;
- Дээрх байгууллагуудын тайлан, статистикийг ашиглах, байгуулсан гэрээ, гаргасан шийдвэрийн гүйцэтгэл, гомдол шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийх;
- Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлснээс хойшхи буюу 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойших Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрүүдийг судлах, захиргааны байгууллагуудын гомдол шийдвэрлэлтийн чанарын болон тоон мэдээллийг цуглуулна.

## ХОЁР.ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон мэдээлэл цуглуулах аргыг ашиглан 2018 оны 04 дүгээр сарын 01-ээс 06 дугаар сарын 14-ний өдрийн хооронд хэрэгжүүлэх үе шатыг хийж гүйцэтгэв. Энэ үе шатанд сонгосон төрийн байгууллагуудтай уулзалт, ярилцлага

[63] Авто замын хөгжлийн газар, Байгаль орчны газар, Боловсролын газар, Нийслэлийн газрын алба, Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар, Эрүүл мэндийн газар.
[64] Гомдол шийдвэрлэх журамтай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн холбогдох мэргэжилтнүүдэд хандсан боловч судалгааны баг уулзалт хийж чадаагүй.
[65] Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт хийж, зарим асуултад хариулт авсан боловч судалгаанд шаардагдах баримт бичгийг судалгааны багт өгөөгүй болно.
[66] Боловсрол, соёл урлагийн газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэс.

хийж, Захиргааны ерөнхий хуулийн 5, 8, 9 дүгээр бүлгийг хэрэгжилтийг үнэлэхэд шаардлагатай мэдээллийг цуглуулав.

## ГУРАВ.ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

### 3.1. Захиргааны гэрээ

Хүснэгт 3

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 52.1.Захиргааны байгууллагаас нийтийн эрх зүйн харилцааг үүсгэж, өөрчилж, эсхүл дуусгавар болгохоор захиргааны гэрээг эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэн байгуулж болно. |
| **Томьёологдсон шалгуур үзүүлэлт** | 1. Гэрээгээр зохицуулах гэж зорьсон харилцаагаа бүрэн зохицуулж чадаж байгаа эсэх?<br>2. Тухайн гэрээгээр ямар асуудлуудыг зохицуулж байна вэ? Гэрээний зохицуулалт агуулга нь захиргаа тодорхой чиг үүргээ хэрэгжүүлэх чиглэгдэж байгаа эсэх? Гэрээгээр зохицуулах гэж зорьсон харилцаагаа бүрэн зохицуулж чадаж байгаа эсэх?<br>3. Нийтийн болон хувийн эрх зүйн хэм хэмжээгээр хавсран зохицуулагддаг харилцаанд захиргааны байгууллага "захиргааны гэрээ" ашиглахаар зохицуулсан нь "заавал" уг үйл ажиллагааны хэлбэрийг хэрэглэх үүрэг үүсгэж буй эсэх? ЗХШХШтХуулийн зохицуулалттай ЗЕХ-ийн 52.2 уялдаж хэрэглэгдэх тул захиргааны гэрээнээс үүсэх /эсхүл гэрээтэй холбоотой/ маргааныг хянан шийдвэрлэх шүүхийн харьяалалд хүндрэл гарч болох эсэхийг тодруулах |

**Үнэлгээ:**

1. Сонгодог утгаараа "захиргааны гэрээ" гэж нэрлэгдэх нь нийтийн захиргааны байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд явуулж буй үйл ажиллагааны хэлбэр болсон тэр гэрээ юм.[67] Захиргааны гэрээний холбогдох ойлголтыг салбарын хуулиудад зохицуулагдсан байдаг.[68] Захиргааны эрх зүйн эх сурвалж болох салбарын төрөлжсөн хуулиуд нь тухайн салбарынхаа мэргэжлийн онцлог бүхий нарийвчилсан зохицуулалтыг агуулдаг.[69] Өөрөөр хэлбэл, тухайн салбар эрх зүйн үйл ажиллагаанд захиргааны байгууллага оролцохдоо харилцан адилгүй чиг үүрэг гүйцэтгэдэг байна. Мөн захиргааны байгууллагын чиг үүргийг маш ерөнхий хуульчилсан болон бусадтай хамтрах үйл ажиллагааны хэлбэр (гэрээний зохицуулалт)-ийг тухайн салбарын хуульд тусгасан байдаг онцлогтой. Захиргааны гэрээтэй холбогдох зохицуулалтуудыг хуулиудад тусгахдаа "бүрэн эрх" гэх нэр томъёог хэрэглэх бөгөөд бүрэн эрхийг хэрэгжүүлнэ, биелэлтийг зохион байгуулах, иргэдийг татан оролцуулах, харилцан тохиролцох хэмээн тус тус заасан байдаг.

А. Гэрээний зохицуулалтыг тодорхойлон заасан
Тухайн гэрээг байгуулах журам, гэрээний талууд эрх, үүрэг, гэрээнд тавигдах шаардлага, гэрээний хугацаа, гэрээг хүчингүйд тооцох үндэслэл, түүнээс үүдэн гарах үр дагавар, гэрээтэй холбоотой маргааныг хянан шийдвэрлэх арга зам зэргийг хуульчилсан. Үүнд: Газрын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Концессын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль зэргийг дурдаж болно.

Б. Гэрээ байгуулах эрх олгосон
Гэрээ байгуулах шаардлагыг тусгасан боловч нарийвчилсан байдлаар зохицуулалт хийгээгүй. Өөрөөр хэлбэл цогц зохицуулалтыг хийгээгүй буюу ерөнхий суурь

[67] Ц.Цогт. Нийтийн эрх зүй дэх захиргааны гэрээ хувийн эрх зүйн гэрээнээс ялгагдах онцлог, шүүхийн хяналт. Хууль дээдлэх ёс. 2007 он №4
[68] Г.Банзрагч. "Эдийн засгийн захиргааны эрх зүй". Улаанбаатар хот., 2013 он. 122 дахь тал
[69] П.Одгэрэл. "Захиргааны эрх зүйн ерөнхий анги". Улаанбаатар хот. 2016 он. 245 дахь тал


Remove Watermark Now

зохицуулалтуудыг оруулсан байхыг ойлгоно. Үүнд: Ойн тухай хууль, Хот суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, Хог хаягдлын тухай хууль гэх мэт хамаарна.

В. Чиг үүрэг хэрэгжүүлэх хүрээнд гэрээ байгуулж шийдвэрлэж байгаа

Гэрээ байгуулах эрх олгосон цөөхөн хэдэн заалтыг тусгасан байх бөгөөд тэрхүү зохицуулалт нь судалгаа шаардагдах тодорхой бус байхыг ойлгоно. Өөрөөр хэлбэл салбар хуулиудыг нарийвчлан судлах шаардлагатай буюу практикт байгуулагдаж буй гэрээнүүдтэй тус бүр танилцах хэрэгтэй.

Тухайлбал, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд заасны дагуу иргэн, хуулийн этгээд Сүхбаатарын талбайд жагсаал, цуглаан хийхээр төлөвлөсөн бол мэдэгдлийг нийслэлийн Засаг даргад өгч, Засаг дарга мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор түүнийг бүртгэсэн эсэхээ бичгээр мэдэгдэхээр заасан. Тус хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу жагсаал, цуглаан зохион байгуулагч зохих үүрэг хүлээдэг бөгөөд энэхүү үүргийн биелэлтийг хангуулах зорилгоор нийслэлийн Засаг даргын тамгын газар жагсаал цуглаан зохион байгуулагчтай гэрээ байгуулж байна.[70] Нийслэлийн засаг даргад гэрээ байгуулж ажиллах шууд хуульд заасан тодорхой зохицуулалт байхгүй боловч Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, мөн Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ төрийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий засаг төрийн төлөөлөгч болохын хувьд захиргааны гэрээг тус харилцаанд хэрэглэж байна.

Мөн хуулийн хэрэгжилттэй холбогдуулан Захиргааны хэргийн шүүхээс шийдвэрлэсэн хэргийн судалгаа хийж үзэхэд захиргааны гэрээтэй холбоотой орон нутагт 4 хэрэг шийдвэрлэгдсэн[71] байсан бол нийслэлд 6 хэрэгт хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байна.

Өөр нэг анхаарал татаж буй зүйл захиргааны гэрээ байгуулагдсан эсэх асуудал юм. ЗЕХ-ийн 55 дугаар[72] зүйлд захиргааны гэрээ илт хууль бус болох үндэслэлүүдийг заасан байна. Өөрөөр хэлбэл уг зүйлд захиргааны гэрээний алдааны тухай тусгайлан зохицуулсан. Захиргааны гэрээний эрх зүйн алдаа гэдэгт гэрээг байгуулахад заавал биелүүлэх ёстой эрх зүйн хэм хэмжээнд урьдчилан тусгагдсан эрх зүйн шаардлагыг хангаагүй өөрөөр хэлбэл захиргааны гэрээний эрх зүйн зөрчилтэй байдлыг ойлгоно.[73]

Тодруулбал захиргааны гэрээний алдаа илт хууль бус байх үндэслэлийг агуулаагүй бол цаашид алдаатай байсан хэдий ч хүчин төгөлдөр үйлчилсээр байх болно. Энэхүү зохицуулалтыг захиргааны актын эрх зүйн алдааны зохицуулалттай харьцуулбал практик судалгаа ихээхэн шаардлагатай боловч ЗЕХ нь 2016 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж байгаа тул одоогоор уг зүйл заалтыг практикт хэрэглэсэн тохиолдол байхгүй байна. Гэвч судалгааны хүрээнд судлагдсан захиргааны гэрээнүүдийн хувьд ЗЕХ-ийн 55.1.14-ийн дагуу илт хууль бусад тооцогдож болохуйц (гэж үзэхээр) гэрээнүүдийн багагүй байна. Үүнд:

- Эрх бүхий этгээд тухайн гэрээг байгуулах итгэмжлэл олгоогүй буюу холбогдох шийдвэрийг гаргаагүй;[74]
- Хууль тогтоомжийн дагуу төлөөлөх эрхгүй этгээд байгуулсан;[75]

[70] НЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, “Монгол төрийн уламжлалыг сэргээх үндэсний хөдөлгөөн”-ий тэргүүнтэй 2018.04.11-ний өдөр байгуулсан “Жагсаал цуглаан бүртгэх тухай” гэрээ.

[71] Хавсралт ...

[72] Төлөөлөх эрхгүй этгээд захиргааны гэрээг байгуулсан тохиолдолд уг гэрээ илт хууль бус болохоор заасан байна. ИХ-н 63 дугаар зүйл, ЗЕХ-н 17, 19, 20 дугаар зүйл тус тус тайлбарлагдан хэрэглэгдэнэ.

[73] П.Одгэрэл. “Захиргааны эрх зүйн ерөнхий анги”. Улаанбаатар хот. 2016 он. 266 дахь тал

[74] Хуулийн дагуу тухайн захиргааны байгууллагыг төлөөлөх эрх бүхий этгээд төлөөлөх эрх олгосон, эсхүл холбогдох шийдвэр гаргаж гарын үсэг зурах эрх олгосон шийдвэргүй байгаагүй.

[75] Тухайлбал, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиар захиргааны байгууллагыг төлөөлөх эрх, түүний эрх хэмжээний тухайлан тусгасан байдаг ба салбарын хуульд тус этгээдүүдийн эрх хэмжээг хуульчилсан байдаг. Гэтэл хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх этгээд гэрээ байгуулсан тохиолдлууд байна. Жишээлбэл, НЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, “Монгол төрийн уламжлалыг сэргээх үндэсний хөдөлгөөн”-ий тэргүүнтэй 2018.04.11-ний өдөр байгуулсан “Жагсаал цуглаан бүртгэх тухай” гэрээ.

- Тухайн гэрээнд хуулийн дагуу төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурсан боловч гэрээний зүйлээс үзвэл тухайн гэрээг байгуулаагүй, харин “батлав” гэсэн утгаар оролцсон байдаг.[76]

3. Концессын гэрээнд тусгасан байвал зохих агуулгын хүрээнд маргаан шийдвэрлэх журам хамаарах талаар Концессын тухай хуульд[77] тусгайлан зохицуулсан ба тус хуулийн 34 дүгээр зүйлд “маргаан шийдвэрлэх” эрх зүйн зохицуулалтыг хуульчилсан байна. Уг зохицуулалтад концессын гэрээнд заасан үйл ажиллагаатай нь холбогдуулж концесс эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг арбитрын хэлэлцээртэй бол арбитрын журмаар, бусад тохиолдолд шүүхээр шийдвэрлэхээр заажээ. Уг зохицуулалтад талуудын хооронд үүссэн маргааныг шийдвэрлэхэд гэрээгээр харилцан тохиролцсон аргыг урьдач нөхцөл болгосон байна.

Гэвч захиргааны эрх зүйн гэрээ эсвэл хувийн эрх зүйн гэрээний аль нь болохыг тодорхойлохын тулд суурь ерөнхий онолуудыг тайлбарлан хэрэглэхээс гадна тухайн гэрээний зүйл, талуудын хооронд үүсэх маргааны харъяалал зэргээс хамааран ялгаж болдог боловч Захиргааны ерөнхий хуулиар зохицуулагдсан харилцааг захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэдэг бол Концессын тухай хуулиар арбитр болон шүүхээр хянан шийдвэрлэгдэх зохицуулалттай.

Захиргааны ерөнхий хуулиар Концессын гэрээг анх удаа захиргааны гэрээний төрөл болгон зохицуулсан.[78] Захиргааны ерөнхий хуулийн 52.2.4-т концессын харилцаанд захиргааны гэрээг хэрэглэж болно хэмээн шууд үүрэг болгоогүй сонгох боломжит хувилбараар тусгажээ. Сонгох боломжийг Захиргааны ерөнхий хуулийн 42.1-т тодорхойлсноор[79] хэрэглэгдэнэ. Иймээс энэхүү заалт нь концессын гэрээний тухайд бол захиргааны гэрээ байж болно, бас үгүй ч байж болно гэсэн утгыг агуулна.[80] Харин Захиргааны ерөнхий хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, 52.2.4 болон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.1-т зааснаар концессын гэрээ нь захиргааны гэрээ байх бөгөөд Захиргааны хэргийн шүүх, Үндсэн хуулийн цэц болон өөр шүүхэд харьяалуулснаас бусад нийтийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэнэ гэх утгаараа талууд маргаанаа уг шүүхээр шийдвэрлүүлэх боломжтой байна.

Харин гэрээгээр харилцан тохиролцсон аргын талаар тодруулбал, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.2-т Монгол улсын олон улсын гэрээнд заасан буюу зохигч хэлэлцэн тохиролцсон бол иргэн, хуулийн этгээдийн хооронд үүссэн маргааныг арбитр шийдвэрлэнэ.[81] Иймээс концессын гэрээний талууд маргаанаа арбитр тэр дундаа олон улсын арбитраар ч шийдвэрлүүлэхээр харилцан тохиролцож болохоор байна.

Иймд салбар хууль тогтоомжийн дагуу гэрээний талууд маргаанаа арбитраар шийдвэрлүүлэхээр харилцан тохиролцсон тохиолдолд арбитраар шийдвэрлүүлэх бөгөөд хэрэв тохиролцоогүй тохиолдолд Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлүүлэхээр байна.

Засгийн газраас 2016 онд байгуулсан 20 гэрээний зохицуулалтыг үзвэл шүүхээр 18, арбитраар 1 гэрээ маргаан хянан шийдвэрлүүлэх тухай зохицуулалтыг тус тус тусгасан байна. Дээрхээс үзвэл практикт талуудын хооронд үүссэн маргаанаа “Шүүх”-ээр

[76] Гэрээг “батлах” асуудал нь анхаарал татаж байгаа бөгөөд цаашид судлах шаардлагатай. Мөн “захиргааны гэрээ”-тэй холбоотойгоор гэрээний хэлбэрийн асуудлыг нарийвчлах шаардлагатай байна.
[77] Концессын тухай хууль. УБ. 2010 он. 21 дүгээр зүйл. 21.1.23 дахь заалт
[78] 52.2.Дараах харилцаанд захиргааны гэрээг хэрэглэж болно: 52.2.4.концессын харилцаанд
[79] Захиргааны байгууллагаас тодорхой асуудлыг шийдвэрлэхдээ хууль, захиргааны хэм хэмжээний актаар зөвшөөрөгдсөн боломжит хувилбаруудаас аль нэгийг хэрэглэх, эсхүл хэрэглэхгүй байхыг сонгох боломж гэнэ.
[80] Д.Сүнжид, Н.Баярмаа. “Концессын гэрээ буюу түүнээс үүсэх маргааныг хянан шийдвэрлэх харъяаллын асуудалд”. УБ. 2016 он. 7 дахь тал
[81] Д.Сүнжид, Н.Баярмаа. “Концессын гэрээ буюу түүнээс үүсэх маргааныг хянан шийдвэрлэх харъяаллын асуудалд”. УБ. 2016 он. 5 дахь тал



Remove Watermark Now

шийдвэрлүүлэх зохицуулалт бүхий концессын гэрээ ихэвчлэн байгуулагдсан байгааг ажиглаж болно.

Концессын тухай хуулийн 34.2-т заасанчлан талууд гэрээгээр харилцан тохиролцсон тохиолдолд арбитраар шийдвэрлүүлж болно. Гэтэл гэрээндээ шүүх эсвэл арбитраар шийдвэрлүүлнэ хэмээн хуулинд заасанчлан сонгох зохицуулалтыг оруулсан тохиолдолд шүүхэд хандаж шийдвэрлүүлэх нь илүү зохистой байна. Гэхдээ концессын нэг гэрээтэй холбогдох маргааны харъяаллын хувьд шүүх, арбитр хоёул нэгэн зэрэг ч байж болох бөгөөд тухайлбал захиргааны байгууллагын шийдвэрийн хууль ёсны байдалтай холбоотой маргаан нь Захиргааны хэргийн шүүхэд хянагдах ба харин гэрээний үүргээ зөрчсөн гэх маргааныг хэрэв тухайн талууд арбитраар шийдвэрлүүлэхээр сонгосон бол энэ хэсгийн маргаан нь арбитрын маргаан болно.[82]

Маргааны харъяаллаа шүүхээр шийдвэрлүүлэх зохицуулалттай гэрээ ихэвчлэн байна. Өнөөдрийн практикт Иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэгдсээр ирсэн боловч Захиргааны ерөнхий хуулинд захиргааны гэрээний зохицуулалт орсон байгаа. Иймээс цаашид маргааны харъяаллын шүүх гэдэгт Иргэний хэргийн шүүхийг ойлгох уу Захиргааны хэргийн шүүхийг ойлгох уу гэдэг нь эргэлзээтэй байна.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан зохицуулалтаас харвал Захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдэх харилцааг тухайлан тодорхойлж заасан. 13.1-т “Захиргааны хэргийн шүүх Үндсэн хуулийн цэц болон өөр шүүхэд харьяалуулснаас бусад нийтийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэнэ” гэж зохицуулсан. Концессын гэрээ нь захиргааны гэрээний нэгэн төрөл болох тухай ЗЕХ-ийн 52.2.4 дэх зохицуулалтаас харж болно. Харин “Захиргааны гэрээ” нь захиргааны үйл ажиллагааны нэг хэлбэр буюу нийтийн эрх зүйн харилцааны ойлголт юм.

Иймээс Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д заасны дагуу Захиргааны гэрээ /Концессын гэрээ/-тэй холбогдох маргааны харъяаллын шүүх гэдэгт Захиргааны хэргийн шүүхийг ойлговол зохилтой байна.

pdfelement

Хүснэгт 4

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 52 дугаар зүйл.Захиргааны гэрээ<br>52.2.1.төрийн алба, боловсрол, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах болон бусад захиргааны эрх зүйн харилцаанд;<br>52.2.5.хуульд өөрөөр заасан бусад харилцаанд. |
| **Томьёологдсон шалгуур үзүүлэлт** | 1.Ямар төрлийн гэрээнүүд хэрэглэгдэж байна вэ, ЗЕХ-ийн 52.2-т заасан харилцаанд хэрэглэгдэж байгаа эсэх?<br>2. Захиргааны гэрээг захиргаа үйл ажиллагаандаа хэрэглэх, ашиглах тэр боломж нөхцөл /хуулиар зөвшөөрсөн байдал, гэрээ байгуулах замаар аливаа захиргааны чиг үүргийг хэрэгжүүлж болох талаар хууль тогтоомжид хэр түгээмэл зохицуулалттай байгаа/ хангагдсан эсэх, |

**Үнэлгээ:**

1. Захиргааны байгууллага үйл ажиллагаандаа гэрээний хэлбэрийг хэрэглэн иргэд болон хуулийн этгээдтэй хамтран ажиллах болсон байна. Үүний тод илрэл нь сүүлийн жилүүдэд батлагдсан захиргааны эрх зүйн салбарын хуулиудад төрийн байгууллага бусадтай хамтран ажиллах хэлбэр (гэрээ байгуулах)-ийг хуульчлах болсон. Тухайлбал, Барилгын тухай хуулийн[83] 36.1-д “Төрөөс үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх зорилгоор барилга, хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн

[82] Д.Сүнжид, Н.Баярмаа. “Концессын гэрээ буюу түүнээс үүсэх маргааныг хянан шийдвэрлэх харъяаллын асуудалд”. УБ. 2016 он. 8 дахь тал
[83] Улсын Их Хурлаас 2016 онд батлагдсан.

Remove Watermark Now

захиргааны төв байгууллагаас энэ хуулийн 18.4, 34.2, 44.7-д заасны дагуу шилжүүлсэн чиг үүргийг төрийн бус, мэргэжлийн байгууллагаар **гэрээний** үндсэн дээр шилжүүлэн гүйцэтгүүлж болно.", Залуучуудын хөгжлийг дэмжих тухай[84] хуулийн 20.1.8.-д "энэ хуулийн 8.1.2, 8.1.5 дахь заалт, 9.4 дэх хэсэг, 10.1.4 дэх заалтад заасан чиг үүрэг, арга хэмжээг **гэрээний** үндсэн дээр төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлэх;", Хог хаягдлын тухай[85] хуулийн 14.2-т "Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг сум, дүүргийн Засаг даргатай **гэрээ** байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага гүйцэтгэнэ." гэж тус тус заасан байна.

Захиргааны байгууллагууд нь хууль тогтоомжид хуульчилсан "бүрэн эрх", "чиг үүрэг" гэсэн нэр томьёогоор түгээмэл илэрхийлсэн захиргааны байгууллага, албан тушаалтны чиг үүргийг биелүүлж байна. Чиг үүргээ хэрэгжүүлэхдээ "гэрээ" түгээмэл хэрэглэгдэх бөгөөд хамтран ажиллах, тендерийн үйл ажиллагаа эрхлэн явуулах(зөвшөөрөх), ... зэрэг төрлийн гэрээг Иргэний хууль болон холбогдох бусад хуулийг үндэслэн байгуулж, хэрэгжилтийг хангах нь түгээмэл болсон байна.

Монгол Улсын Их Хурлаас 2015 онд баталсан Захиргааны ерөнхий хуулийн 52 дугаар зүйлийн 52.1-д "захиргааны гэрээ"-г тодорхойлсон. Захиргааны гэрээг захиргааны үйл ажиллагааны нэг хэлбэр болох нь хууль зүйн утгаараа хүлээн зөвшөөрөгдөж, тусгай бүлэг болгон хуульчлагдсан.

Монгол Улсын Захиргааны ерөнхий хууль ("ЗЕХ")-ийн 52.2-т Захиргааны гэрээг хэрэглэж болох харилцааны төрлүүдийг нээлттэй жагсаалтын зарчмаар дурдсан бол ХБНГУ-ын ЗҮАтХ-д гэрээг эрх зүйн харилцааны төрлүүдээр ялган ангилсан зохицуулалт байхгүй бөгөөд 55 болон 56 дугаар зүйлд захиргааны гэрээний ерөнхий хоёр төрлийг зохицуулсан байна.[86] Харин Японы захиргааны эрх зүйд гэрээний нэг тал эсвэл хоёр тал нь захиргааны байгууллага байгаа тохиолдолд үүнийг захиргааны гэрээ гэж нэрлэдэг[87] бөгөөд захиргааны гэрээг нэгт, захиргааны бэлтгэл ажлын хүрээнд байгуулагдах гэрээ, хоёрт халамжийн захиргааны хүрээнд байгуулагдах гэрээ, гуравт зохицуулах захиргааны хүрээнд байгуулагдах гэрээ, дөрөвт захиргааны эрх зүйн субьект болон хувийн компаниудын хооронд байгуулагдах гэрээ, тавт захиргааны байгууллага хооронд байгуулагдах гэрээ гэсэн 5 төрөлд хуваан тайлбарласан байдаг.

pdfelement

---

[84] Улсын Их Хурлаас 2017 онд батлагдсан.
[85] Улсын Их Хурлаас 2017 онд батлагдсан.
[86] "Хуулийн 55 дугаар зүйлээр "Харьцуулах гэрээ" буюу Гэрээ байгуулж буй хоёр талд гэрээний харилцааны явцад ямар нэгэн үл ойлгогдох нөхцөл байдал үүссэн нөхцөлд харилцан үгүйсгэж, үл ойлголцолд хүрэхгүйн тулд аль аль нь тухайн нөхцөл байдалд таарсан (тухайн нөхцөл байдалтай уялдуулан харьцуулж үйлдэл хийх) буулт хийх үүрэг хүлээсэн гэрээг зохицуулсан бол 56 дугаар зүйлд "Солилцох гэрээ" буюу захиргаа болон иргэд харилцан бие биенийхээ өмнө үүрэг хүлээсэн хоёр талын үүргийн гэрээг хуульчилсан байна. Онолын хувьд Захиргааны гэрээг Тэгш эрх бүхий этгээдийн хооронд байгуулсан болон тэгш бус эрхтэй этгээдүүдийн хооронд байгуулсан гэрээ гэж хоёр ангилдаг. ЗҮАтХ-ийн 54 дүгээр зүйлийн 1 дэх өгүүлбэрт "Нийтийн эрх зүйд гэрээгээр (Нийтийн эрх зүйн гэрээ) эрх зүйн харилцаа үүсч, өөрчлөгдөж, дуусгавар болох боломжтой ба энэ нь бусад эрх зүйн хэм хэмжээнд харшлаагүй байна" гэж зааснаас харахад энэ нь тэгш эрхтэй болон тэгш бус эрхтэй этгээдүүийн хооронд байгуулагдах аль аль гэрээний үндэслэл болж байгаа бол 2 дахь өгүүлбэрт заасан "Ялангуяа Захиргааны байгууллагаас тодорхой этгээдэд чиглэсэн Захиргааны акт гаргахын оронд уг этгээдтэй Нийтийн эрх зүйн гэрээ байгуулж болно" гэсэн заалт нь зөвхөн тэгш бус эрхтэй этгээдүүдийн хооронд буюу Захиргаа иргэний хооронд байгуулагддаг гэрээний үндэслэл болж байна. ЗҮАтХ-ийн 55 болон 56 дугаар зүйлд заасан дээрх хоёр гэрээ нь Тэгш бус эрхтэй этгээдүүдийн хооронд байгуулагдах буюу Захиргаа иргэний хооронд байгуулагддаг гэрээний төрлүүд юм. Тэгш эрх бүхий этгээдүүдийн хооронд байгуулагддаг гэрээнд хоёр Захиргааны байгууллагын хооронд байгуулагдсан гэрээнүүд хамаарах бөгөөд тухайн харилцааг Захиргааны актаар зохицуулах ямар ч боломжгүй байна." Судалгааны явцад ХБНГУ-ын Бавари мужын Аугсбургийн их сургуульд "Монгол, Германы хуулиуд дахь Захиргааны гэрээний зохицуулалтыг харьцуулсан" сэдвээр магистрын зэрэг хамгаалсан, докторын судалгаа хийж буй А.Ононтой хийсэн ярилцлагаас.
[87] "Япон улсад захиргааны байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд захиргааны гэрээ нь өргөн хэрэглэгддэг. Онол болон шүүхийн жишигт хувийн болон нийтийн эрх зүйг ялган материаллаг хуулиудад тайлбар хийх арга нь хэрэглэгдэхээ больсон бөгөөд материаллаг хуулиудад нийтийн эрх зүйн гэрээ гэсэн ойлголтыг хэрэглэх шаардлагагүй болсон гэж үздэг." Судалгааны явцад Япон улсын Нагояа Их Сургуульд "Монгол, Японы хуулиуд дахь Захиргааны гэрээний зохицуулалтыг харьцуулсан" сэдвээр магистрын зэрэг хамгаалсан, докторын судалгаа хийж буй Г.Уянгатай хийсэн ярилцлагаас.

Remove Watermark Now

Аймаг, Нийслэлийн Засаг даргын бүрэн эрхийг 139 хуульд тусгасан байгаагаас 6 төрлийн харилцаанд “гэрээ байгуулах” эрхийг тодорхой заасан байна. Тодруулбал:

| Д/д | Хууль | Хуулийн заалт |
|---|---|---|
| 1 | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай | 29.1.Захиалагч энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан шаардлага хангасан, 28 дугаар зүйлд зааснаар “хамгийн сайн” үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэж, энэ тухай түүнд болон бусад тендерт оролцогч бүрт шалгараагүй үндэслэлийн хамт нэгэн зэрэг бичгээр мэдэгдэнэ. 29.2.Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдсэнээс хойш ажлын 5-аас доошгүй хоногийн дараа, тендер хүчинтэй байх хугацаанд багтааж гэрээ байгуулна. |
| 2 | Концессын тухай | 6.2.12.концессын гэрээ болон түүнтэй холбоотой бусад гэрээ, тухайлбал, концесс эзэмшигч санхүүжилт олохтой холбогдсон гэрээг концесс эзэмшигч болон бусад этгээдтэй байгуулах; 20.1.Дараах этгээд концессын гэрээний тал байна: 20.1.1.төрийн өмчийн зүйлийн концессын гэрээний хувьд концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутгийн өмчийн зүйлийн концессын гэрээний хувьд аймаг, нийслэлийн Засаг дарга; |
| 3 | Төсвийн тухай | 65.1.3.холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчтай Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээг байгуулж ажиллах; 65.1.4.орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх бараа, ажил, үйлчилгээг худалдан авах гэрээг холбогдох хуульд нийцүүлэн байгуулах; |
| 4 | Хог хаягдлын тухай | 9.3.8.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, олон улсын зээл, тусламжаар байгуулсан хог хаягдал сэргээн ашиглах, дахин боловсруулах, булшлах, устгах байгууламжийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулах; |
| 5 | Автотээврийн тухай | 7.1.5.хүн амын нутагшил, байршлын онцлог, зорчигч ба шуудан тээвэрлэлтийн хэрэгцээнээс шалтгаалан өрсөлдөх боломжгүй чиглэлд орон нутагт зорчигч, шуудан тээвэрлэлтийг зохих нөхөн төлбөр олгох нөхцөлтэйгээр тээвэрлэгчтэй гэрээ хийж гүйцэтгүүлэх; |
| 6 | Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай | 11.1.4.төсөл хэрэгжүүлэх гурван талт гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийг хангуулах; |

Захиргааны байгууллагуудтай хийсэн ярилцлагын хүрээнд[88] Захиргааны ерөнхий хуулийн 52.2-т заасан харилцаанд захиргааны гэрээ хэрэглэж байгаа эсэхийг тодруулахад “эрхэлж буй үйл ажиллагааны хувьд Захиргааны ерөнхий хуулийн гэрээний заалтыг тухай бүр хэрэглэж байгаа”, “чиг үүргийнхээ хүрээнд захиргааны гэрээ байгуулдаггүй, худалдан авах/тендер/-тай холбоотой гэрээг байгуулж ажилладаг”, “төрийн байгууллага болохын хувьд байгуулж байгаа гэрээ болгон ЗЕХ-ийн 52-т хамаарна гэж ойлгож байгаа”, “хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд гэрээ байгуулж буй тул захиргааны гэрээ юм” зэрэг ЗЕХ-ийг хэрэгжүүлж байгаа гэж ойлгогдохоор байв. Гэвч ЗЕХ хэрэгжиж эхэлснээс хойш байгуулсан гэрээнд ЗЕХ-ийн холбогдох заалтыг үндэслээгүй, захиргааны байгууллага тэгш эрхийн харилцаа /иргэний эрх зүйн/, эсхүл нийтийн эрх зүйн харилцаанд захиргааны гэрээ байгуулж байгаа эсэх тухай төрөлжүүлээгүй, мөн ЗЕХ-тай холбогдуулан байгуулсан гэрээний загварт өөрчлөлт ороогүй харвал захиргааны гэрээний тухай ойлголт хэвшээгүй, тухайн салбарын хууль болон өмнө нь хэрэгжүүлж ирсэн туршлагаар дээрх харилцаа үргэлжилж байна.

[88] Судалгааны тайланд ярилцлагын тэмдэглэлүүдийг хавсаргасан.

Мөн төрийн байгууллагууд үйл ажиллагаандаа захиргааны гэрээг ашиглах боломжийг хумьж байгаа нэг гол хүчин зүйл бол төсвийн талаарх ойлголт аж. Уулзалт хийсэн байгууллагууд батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг тул захиргааны гэрээ байгуулах боломжгүй тухайгаа илэрхийлдэг. Гэтэл захиргааны байгууллага нь салбар хуульд заасан чиг үүргээ төсвөөс үл хамаарч захиргааны акт гаргах байдлаар хэрэгжүүлдэг. Харин захиргааны гэрээ нь захиргааны байгууллагад нэг талын захирамжилсан шийдвэр гаргахын оронд илүү уян хатан, иргэдийн оролцоо, хамтын ажиллагааг дэмжсэн арга замыг санал болгож байгаа юм.[89]

Харин судалгаа хийсэн дээрх байгууллагуудын байгуулсан гэрээнд дүн шинжилгээ хийж үзвэл ЗЕХ-ийн 52.2-т заасан харилцаанд дараах гэрээ байгуулагдсан байна. Үүнд:

Төрийн алба:

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчтай Асгат сумын Засаг даргын байгуулсан үр дүнгийн гэрээ - Төсвийн тухай хуулийн 39.1, 39.2, 39.3, 39.4, 40.1 дэх заалтуудыг хэрэгжүүлэх хүрээнд;

Удирдлагын академид Засгийн газрын тэтгэлэгтэй суралцах төрийн жинхэнэ албан хаагчтай байгуулах гурван талт гэрээ – Төрийн албаны тухай хуулийн 27.1.9 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд.

Эрүүл мэнд:

Даатгуулагчдад эмийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээ - Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 10.1, 10.2, 13.1.2, 16.1.3 дэх заалтуудыг хэрэгжүүлэх хүрээнд;

Байгаль орчныг хамгаалах:

Орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах гэрээ (Сүхбаатар аймгийн Засаг дарга болон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч нарын хооронд байгуулсан) – Ашигт малтмалын тухай хуулийн 12.1 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд;

Бусад харилцаанд:

Хамтран ажиллах гэрээ (Аймгийн мэргэжлийн хяналтын газар болон сумын Засаг дарга нарын хооронд байгуулсан) – суманд мал эмнэлгийн, хүнсний аюулгүй байдлын хяналтыг хамтран хэрэгжүүлэх;

Иргэн, хуулийн этгээдэд хадлангийн зориулалтаар газар ашиглуулах гэрээ – Газрын тухай хуулийн 20.1.1, 20.2.1 дэх заалт, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 51 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд;

Хамтран ажиллах гэрээ (Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс болон Хас банк нарын хооронд байгуулсан) – Иргэдэд тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээг хүргэх, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс баталсан "Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээ үзүүлэх арилжааны банктай хамтран ажиллах" журмыг хэрэгжүүлэх;

Хүснэгт 5

| | |
|---|---|
| **Үнэлгэдэх хэсэг** | 52.2.2.захиргааны байгууллага өөрийн зарим чиг үүрэг, эрх мэдлийг бусад этгээдэд шилжүүлэх харилцаанд; |

[89] Судлаачид зарчмын хувьд гэрээний хэлбэрийг хуулиар хязгаарлаагүй тохиолдолд захиргааны актын оронд хэрэглэх боломжтой хэмээн үздэг. Захиргааны гэрээний агуулга материаллаг эрх зүйн хэм хэмжээнд нийцсэн байна. Захиргааны байгууллага зөвхөн хуулиар олгосон чиг үүрэг, эрх хэмжээнийхээ хүрээнд үйл ажиллагаа явуулдаг тул ЗЕХ-ийн 52.1 "эрх зүйн хэм хэмжээнд нийцэж" байх гэсний дагуу эрх зүйн зохицуулалтаар зөвшөөрөгдсөн хүрээнд байгуулна.



Remove Watermark Now
pdfelement

Remove Watermark Now

| | |
|---|---|
| **Томьёологдсон шалгуур үзүүлэлт** | 1. ЗЕХ-ийн 8, 11.2-11.3 дугаар зүйлийг хэрхэн хэрэглэж байна вэ?<br>2. Гэрээний үүргээ зөрчсөн тохиолдолд ямар арга замаар шийдвэрлэж байгаа вэ? |

**Үнэлгээ:**

Захиргааны байгууллагын зүгээс өөрийнхөө чиг үүргийг өөр этгээдэд шилжүүлэхтэй холбогдсон тодорхой харилцаа нь энэхүү ангилалд хамаарна. Гэхдээ тус тохиолдолд ЗЕХ-ийн 8.1-ийн "Хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно" гэсэн хориглосон хэм хэмжээг харгалзан үзэх ёстой. Учир нь иргэн хуулиар хориглосноос бусдыг хэрэгжүүлэх боломжтой байдаг бол захиргааны байгууллага хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлж, хариуцлага хүлээдэг болно. Тухайлбал, Төсвийн тухай хуулийн 14.4-т "Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй." гэж заасан байдаг.

Энэ асуудлын хүрээнд чиг үүргээ шилжүүлэх, бусдаар гүйцэтгүүлэх ойлголт харилцан адилгүй, өөр өөр хэлбэрээр ойлгож байгаа нь ажиглагдсан. Дээрхтэй холбоотойгоор Нийслэлийн Засаг даргын хуулиар олгосон бүрэн эрхийг судалж үзэхэд гэрээний үндсэн дээр чиг үүргээ шилжүүлэх эрх олгосон хэм хэмжээ байхгүй байсан. Төсвийн тухай хуулийн 6.4.3-т "иргэн, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх боломжтой хөтөлбөр, арга хэмжээг тэдгээрээр гүйцэтгүүлэх чиглэл баримтлах;" гэж заасныг үндэслэн Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба хог хаягдлын үйлчилгээнд захиалагчийн хяналт тавих чиг үүргээ гэрээний үндсэн дээр шилжүүлэн хэрэгжүүлж байна.[90]

pdfelement

1. Захиргааны байгууллагын үйл ажиллагааны нэг хэлбэр "Захиргааны гэрээ байгуулах" тухай Захиргааны ерөнхий хуулийн зохицуулалт нь Захиргааны байгууллагад захиргааны гэрээ байгуулж болох боломж, нөхцлөөр хангасан. Тухайлбал, тус хуулийн 11.2-т зааснаар Захиргааны үйл ажиллагааны хэлбэрийг хуульд өөрөөр заасан тохиолдолд захиргааны байгууллага тухайн хуульд заасны дагуу хэрэглэнэ, 11.3-т хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд захиргааны байгууллага энэ хуулийн 11.1-д заасан үйл ажиллагааны хэлбэрээс сонгон хэрэглэнэ гэж заасан нь захиргааны гэрээг үйл ажиллагаандаа хэрэглэх, ашиглах нөхцөл боломжоор хангасан заалтууд гэж ойлгож байна. Гэхдээ тус хуулийн 8.1-д хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно гэж заасан нь 11.3 дахь хэсэгт заасны дагуу сонгож хэрэглэх зохицуулалтыг хязгаарладаг.

Судалгаанд хамрагдсан байгууллагуудын хүрээнд дээрх хуулийн заалтуудтай холбоотой ярилцлага явуулахад тус асуудал хөндөгдөөгүй буюу үйл ажиллагааны хүрээнд хэрэглэж буй эсэх нь тогтоогдоогүй. Энэ нь нэг талаас ЗЕХ-ийн тус зохицуулалтын хэрэглээ болон ойлголт хангалтгүй байгааг илэрхийлж байна.

Харин ЗЕХ-ийн 8 дугаар зүйлийн хувьд чиг үүргээ шилжүүлэх ойлголт асуудалтай байна.[91]

2. Захиргааны гэрээний талууд гэрээгээр тохиролцсон үүргээ зохих журмын дагуу биелүүлэх ёстой. Захиргааны гэрээний үүрэг биелүүлэхтэй холбоотой тодорхой нарийвчилсан зохицуулалт байхгүй учраас иргэний хуулийн гэрээний гүйцэтгэлийн зохицуулалтыг тохируулан хэрэглэнэ.[92]

[90] УБ хотын Ерөнхий менежер бөгөөд захирагчийн ажлын албаны дарга, "Эмэгтэйчүүдийн эрх, хамгаалал хөгжлийн хүрээлэн" ТББ-тай байгуулсан 2018.03.01-ний өдрийн 18/06/73 дугаартай "Хог хаягдлын үйлчилгээнд хяналт тавих хамтран ажиллах" тухай гэрээ.
[91] ЗЕХ-ийн "8.1.Хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно." заасан.
[92] П.Одгэрэл. "Захиргааны эрх зүйн ерөнхий анги". Улаанбаатар хот. 2016 он. 278 дахь тал

Remove Watermark Now

Тус байгууллагуудтай хийсэн уулзалт, ярилцлагын үеэр гэрээний үүргээ зөрчсөн тохиолдолд холбогдох хууль болон гэрээнд заасны дагуу шийдвэрлэнэ, эсхүл одоогоор байгуулсан гэрээтэй холбоотой маргаан гардаггүй, эсхүл талууд харилцан ярилцаад шийддэг гэсэн хариулт элбэг байсан. Түүнчлэн дүн шинжилгээ хийсэн гэрээний хувьд талуудын эрх, үүргийг зохицуулсан байх боловч үүргийн зөрчил, түүнийг шийдвэрлэх арга замыг нарийвчилсан зохицуулалт агуулаагүй байв.

Захиргааны байгууллага захиргааны гэрээний биелэлтийг хангах үүрэгтэй. ЗЕХ-н 57 дугаар зүйл нь тэгш бус эрхийн гэрээнд тавигддаг шаардах эрх юм.[93] Мөн үүнд ЗЕХ-н наймдугаар бүлэгт[94] заасан зохицуулалтыг хэрэглэх тухай хуульд тусгасан. Гэвч уг бүлгийг үзвэл “Захиргааны шийдвэр гүйцэтгэл”-ийн тухай зохицуулсан буюу 82 дугаар зүйлийн 82.2-т захиргааны актад шийдвэр гүйцэтгэх тохиолдлыг заасан байна. Харин захиргааны гэрээний хувьд гэрээний гүйцэтгэлийг хангуулахад тухайн бүлгийн зохицуулалтыг хэрэглэх нь тохиромжгүй байгаа байдал ажиглагдаж байна. Тодруулбал захиргааны акт, захиргааны гэрээ нь захиргааны үйл ажиллагааны хэлбэрт хамаарах хэдий ч харьцангуй өөр өөр шинжтэй тул үүргийн биелэлтийг хангуулах адил арга хэрэглэх нь тохиромжгүй. Одоогоор энэ тохиолдолд Иргэний хуулийн үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргыг хэрэглэж байна.

Хүснэгт 6

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 52.2.3.дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээг бий болгох, тогтвортой ашиглалтай холбогдсон харилцаанд;<br>52.2.4.концессын харилцаанд; |
| **Томьёологдсон шалгуур үзүүлэлт** | 1. Концессын харилцаанд захиргааны гэрээг ашиглаж буй тохиолдол байна уу? Энэ харилцаанд концессын гэрээг хэрэглэх нь хэр зохимжтой байна вэ?<br>2. Концессын гэрээ хийгдэхэд ЗЕХ-ийн зохицуулалт талаасаа хүндрэл байна уу? Концессын харилцаанд захиргааны бус арбитрын гэрээгээр зохицуулж байгаа тохиолдол байна уу? |

**Үнэлгээ:**

Тус харилцаанд захиргааны гэрээг салбар бүрт өргөн хүрээнд байгуулж байна. Үүний гол шалтгаан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж захиргааны байгууллага өөрийн чиг үүргээ хэрэгжүүлж байгаа юм. Тодруулбал, дэд бүтэц бий болгох[95] хүрээнд захиргааны байгууллага шаардлагатай төлөвлөлт, түүний бүтээн байгуулалтыг тендер зохион байгуулах замаар шийдвэрлэдэг. Гэхдээ Нийслэлийн Засаг дарга өөрийн эрх хэмжээний хүрээнд нийгмийн үйлчилгээний шинжтэй ажлуудыг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулдаг байна. Жишээлбэл, хорих ангиас суллагдсан иргэдийг нийгэмшүүлэх.[96]

1. Захиргааны гэрээ нь практикт багагүй байгуулагддаг бөгөөд хамгийн түгээмэл болон эрх зүйн зохицуулалтын хувьд салбар хуулиудаар цогц байдлаар хуульчлагдсан гэрээ багагүй байна. Үүнд: Бүтээгдэхүүн хуваах гэрээ /Газрын тосны тухай хууль/, Газар эзэмшүүлэх гэрээ /Газрын тухай хууль/, Тендерийн гэрээ /Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль/ зэргийг нэрлэж болно.

[93] П.Одгэрэл. “Захиргааны эрх зүйн ерөнхий анги”. Улаанбаатар хот. 2016он. 280 дахь тал
[94] Захиргааны ерөнхий хууль. Улаанбаатар хот. 2015 он. Наймдугаар бүлэг: Захиргааны шийдвэр гүйцэтгэл
[95] Нийслэлийн Хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар болон Авто замын хөгжлийн газартай хийсэн уулзалтад дэд бүтцийн хүрээнд холбогдох зураг төсөл, төлөвлөлт болон түүний бүтээн байгуулалтыг тендер зохион байгуулах замаар шийдвэрлэдэг гэсэн ба захиргааны байгууллага нь батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг тул өөр хэлбэрийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байдаг байна.
[96] НЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтнүүдтэй хийсэн уулзалтаар тус төрлийн гэрээг дурдсан.

Remove Watermark Now

Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогод тусгагдсан хувийн хэвшил тэргүүлсэн эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах, бүх талын түншлэлийг хөхүүлэн дэмжих замаар Монгол Улсын эдийн засгийг тогтвортой хөгжүүлэхэд түлхэц болох зорилгоор Монгол Улсын Их Хурлаас 2009 онд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн талаар төрөөс баримтлах бодлого, 2010 онд Концессын тухай хуулийг тус тус баталжээ.

Хуульд зааснаар "Концесс" гэж төрийн, эсхүл орон нутгийн өөрийн өмчийн эд хөрөнгийг дэд бүтцийн болон нийгмийн суурь үйлчилгээг нийтэд үзүүлэх зорилгоор хуульд заасан нөхцөл, журмын дагуу гэрээний үндсэн дээр эзэмших, ашиглах, шинээр бий болгох, шинэчлэн сайжруулах онцгой эрхийг хэлнэ. Өөрөөр хэлбэл гэрээний үндсэн дээр шилжүүлж буй онцгой эрх юм.

Практикт түгээмэл байгуулагддаг гэрээнд концессын гэрээ зүй ёсоор орно. Концессыг хэрэгжүүлэх эрх бүхий этгээд болон концесс эзэмшигч нарын хооронд бичгээр байгуулагдсан гэрээг концессын гэрээ гэх бөгөөд тухайн гэрээнд тусгавал зохих агуулгыг Концессын тухай хуулийн 21 дүгээр зүйлд тусгайлан зохицуулсан байна. Мөн энэхүү гэрээг байгуулахдаа уг агуулгыг тусгасан жишиг концессын гэрээг удирдлага болгодог ба нийт 52[97] гэрээ байгуулагджээ.

Дээрх байгуулагдсан гэрээнүүдийг судалж үзвэл дэд бүтэц, барилга, эрчим хүч, эрүүл мэнд зэрэг салбарын[98] хүрээнд захиргааны байгууллага холбогдох хууль тогтоомж дахь чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд байгуулсан байх боловч тус бүрт нь авч үзвэл концессын гэрээнд иргэний болон захиргааны эрх зүйн шинжийн аль алийг нь агуулж байх буюу тухайн гэрээгээр хувийн болон нийтийн эрх зүйн харилцааг хоёуланг нь зохицуулж байна. Мөн уг гэрээ нь үндсэн шинжээрээ нийтийн, эсхүл хувийн эрх зүйн аль гэрээнд хамаарах эсэх, маргаан гарсан тохиолдолд хэрхэн шийдвэрлэх эсэх багагүй асуудлыг дагуулж байна.

Концессын гэрээг хувийн эрх зүйн талуудын тэгш эрх, гэрээний чөлөөт байдлын зарчимд суурилсан гэрээ, эсхүл захиргааны байгууллагаас баталсан захиргааны акт буюу шийдвэр гэж шууд тодорхойлох нь учир дутагдалтай бөгөөд нийтийн эрх ашиг хөндөгдөж нийгэм эдийн засгийн томоохон үр нөлөө бүхий харилцааг зохицуулдагын хувьд захиргааны гэрээ хэмээх институтэд хамаарах зохицуулалтын хэрэгсэл гэж үзэн мөн чанарыг тодорхойлох нь зүйд нийцэх юм. Иймд өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль болон онолын талаас үзвэл концессын гэрээг захиргааны гэрээнд хамааруулж үзэх нь илүү зохистой байна.

2. Концессын тухай хуулийн 34.2-т Концессын гэрээний талуудын хооронд үүссэн аливаа маргааныг гэрээгээр харилцан тохиролцсон аргаар шийдвэрлэнэ хэмээн заасан байна. Гэрээгээр харилцан тохиролцсон аргын талаар тодруулбал, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13.2-т зааснаар Монгол Улсын олон улсын гэрээнд заасан буюу зохигч хэлэлцэн тохиролцсон бол иргэн, хуулийн этгээдийн хооронд үүссэн маргааныг арбитр шийдвэрлэнэ. Тиймээс концессын

---

97 http://nda.gov.mn /Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газрын цахим хуудас/

98 Концессын гэрээтэй холбогдуулан Үндэсний хөгжлийн газрын холбогдох нэгжтэй уулзалт хийсэн. Тухайн нэгж нь Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор баталсан концессын зүйлийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлдэг. Тус байгууллагын http://nda.gov.mn байрлуулсан мэдээллээр бол нийт 52 гэрээ байгуулагдсан байна. Тухайлбал, дэд бүтэц байгуулах хүрээнд "Аглаг бүтээлийн хийд хүртэлх 6.2 км хатуу хучилттай авто зам төсөл"-ийн барих-шилжүүлэх гэрээ, эрчим хүчний салбарт "Тэлмэний дулааны цахилгаан станц барих, ашиглах, төрийн өмчид шилжүүлэх" гэрээ, барилга-боловсролын салбарт "Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 6-р цэцэрлэгийн 100 хүүхдийн өргөтгөлийн барилга барих төсөл"-ийн гэрээ.
ҮХГ-ын концесс хариуцсан нэгжтэй хийсэн уулзалтаар тухайн харилцаанд "захиргааны гэрээ" гэх агуулгаас илүү Концессын тухай хууль болон төсөлд хамаарах хууль тогтоомж болон хувийн хэвшлийн санаачилагад тулгуурлан байгуулдаг гэх бөгөөд одоогоор байгуулагдсан гэрээ барилга-боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц, эрчим хүч гэсэн салбарт ашиглагдаж байна.

гэрээний талууд[99] арбитраар маргаанаа шийдвэрлүүлэхээр харилцан тохиролцох боломжтой байна.

Мөн Арбитрын тухай хуульд зааснаар арбитрын хэлэлцээр гэдэгт гэрээний үндсэн дээр үүссэн эсэхээс үл хамааран бий болсон эрх зүйн харилцаатай холбоотойгоор талуудын хооронд үүссэн, эсхүл үүсч болох аливаа маргаан, эсхүл түүний тодорхой хэсгийг *арбитрын журмаар шийдвэрлүүлэх тухай талуудын тохиролцоо*[100]г ойлгодог. Мөн арбитрын хэлэлцээр нь бие даасан гэрээ, эсхүл тухайн гэрээний нэг хэсэг байж болдог. Үүний дагуу байгуулагдсан концессын гэрээнүүдэд дүн шинжилгээ хийж үзэхэд зарим гэрээнд "маргаан шийдвэрлэх" гэдэг хүрээнд арбитр гэсэн сонголт хийсэн байх боловч энэ талаар нарийвчилсан тохиролцоо байхгүй байх ба Арбитрын тухай хуулийн хүрээнд шийдэгдэж байна. Өөрөөр хэлбэл талууд хооронд үүссэн маргаанаа арбитраар шийдвэрлүүлэхэд гэрээндээ харилцан тохиролцсон тохиолдолд арбитраар шийдвэрлүүлэх нь хууль ёсны болно. 2015 оны 3 дугаар сараас 2016 оны 6 дугаар сарын хугацаанд байгуулагдсан концессын гэрээний хувьд олон улсын арбитраар шийдвэрлүүлэх зохицуулалт илүү давамгай байна.

Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны Иргэний хэргийн шүүх хуралдааны тогтоолд "Засгийн газрын тогтоолыг хүчингүй болох шаардлагын нэг үндэслэл болох тогтоол гаргах хуулиар тогтоосон журам зөрчсөн гэх үндэслэлээс үүдсэн маргааныг шүүхийн харьяаллынх гэж үзэж, харин гэрээний үүргээ зөрчсөн гэх маргаан нь талуудын хэлэлцэн тохирсон талуудын маргаан гэж дүгнэсэн нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2-т[101] нийцсэн байна" гэсэн байна. Тодруулбал Засгийн газрын тогтоол хуульд заасан журам нийцэж гарсан эсэх нь арбитрын харьяаллын маргаан биш бөгөөд Арбитр гэрээний маргааныг харьяаллын дагуу шийдвэрлэсэн тохиолдолд гэрээг цуцалсан Засгийн газрын тогтоол хэвээр байх нь зөрчилтэй юм.[102]

Иймээс талууд гэрээндээ маргаанаа арбитраар шийдвэрлүүлэхээр харилцан тохиролцсон тохиолдолд арбитрын харьяалалд хамаарах гэрээний маргааны талаар шүүх дүгнэлт өгөх үндэслэлгүй болно.

### <u>3.2. Захиргааны шийдвэр гүйцэтгэл</u>

Хүснэгт 7

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 82.1.Нийтийн эрх зүйн хүрээнд захиргааны байгууллагаас гаргасан захиргааны шийдвэрийг гүйцэтгэхэд энэ журам үйлчилнэ.<br>82.2.Дараах тохиолдолд захиргааны актад шийдвэр гүйцэтгэнэ:<br>82.2.1.гомдол гаргах хугацаа өнгөрсөн;<br>82.2.2.захиргааны актыг түдгэлзүүлэх шийдвэр хүчингүй болсон. |
| **Томьёологдсон шалгуур үзүүлэлт** | Захиргааны шийдвэрийг албадан гүйцэтгэхийн өмнө бүрдсэн байвал зохих нөхцөлийг бүрэн тодорхойлж чадсан эсэх, тухайлбал захиргааны шийдвэрээр үүрэг хүлээгч нь уг шийдвэрт холбогдуулан гомдол, |

[99] Засгийн газраас байгуулсан концессын гэрээнүүдийг сонгон шалгаруулалт болон шууд гэрээ байгуулах замаар байгуулсан байсан. Гэвч гэрээнд оролцогчдоос гадна гуравдагч этгээдийн гомдлыг хэрхэн шийдвэрлэх талаар зохицуулалт шаардлагатай байна. Учир нь сонгон шалгаруулалт болон шууд гэрээ байгуулсан шийдвэр, түүний байгуулсан гэрээтэй холбоотойгоор бусад концесс сонирхогч этгээд нь маргаан үүсгэх эрхтэй эсэх, хэрхэн шийдвэрлэх, мөн талууд тус тохиолдолд ямар үүрэг, эрх үүсэх талаар ойлгомжгүй байна.

[100] Арбитрын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх заалт.

[101] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль. УБ. 2002 он

13.1.Энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан үндэслэлээр гаргасан нэхэмжлэл, хүсэлт, гомдол /цаашид "нэхэмжлэл" гэх/-ыг шүүх харьялан шийдвэрлэнэ.

13.2.Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан буюу зохигч хэлэлцэн тохиролцсон бол иргэн, хуулийн этгээдийн хооронд үүссэн маргааныг арбитр шийдвэрлэнэ.

[102] 2016 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 00561 дугаар бүхий Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны иргэний хэргийн шүүх хуралдааны тогтоол болон бусад холбогдох шүүхийн шийдвэрүүдээс харж болно.

| | |
|---|---|
| | нэхэмжлэл гаргах эрхээ эдэлсэн, эсхүл уг эрхээсээ татгалзсан, эрхээ алдсан (хөөн хэлэлцэх хугацаа) эсэхийг шалгасан байдал |

**Үнэлгээ:**

ЗЕХ-ийн 8 дугаар бүлэг нь хэдийгээр захиргааны шийдвэр гүйцэтгэл гэж нэрлэгдсэн, 82 дугаар зүйлийн 82.1-д “нийтийн эрх зүйн хүрээнд захиргааны байгууллагаас гаргасан захиргааны шийдвэрийг гүйцэтгэхэд энэ журам үйлчилнэ” гэж заасан боловч уг бүлгийн зохицуулалтын агуулгаас үзвэл мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасан захиргааны шийдвэрийн төрлүүдээс “захиргааны акт”[103]-ыг гүйцэтгэх журмыг илүүтэйгээр зохицуулсан мэт ойлгогдож байна. Ингэснээр мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасан бусад захиргааны шийдвэрүүд ялангуяа “захиргааны гэрээ”[104]-ний гүйцэтгэлийг хэрхэх нь тодорхойгүй орхигдсон байна. Тиймээс энэ бүлгийн зохицуулалт нь нийтлэг байдлаар захиргааны бүх төрлийн шийдвэрийг гүйцэтгэх журмыг тодорхойлоход зорьсон болохыг илүү тодорхой болгож, энэ агуулгаар захиргааны актыг онцлон заасан хэсгүүдэд өөрчлөлт оруулах шаардлагатай байж болох юм.

ЗЕХ-ийн 82 дугаар зүйлд үндсэн хоёр нөхцөл бүрдсэн үед захиргааны актыг гүйцэтгэхээр заасан байна. Үүнд, гүйцэтгэх гэж буй захиргааны актыг эрх бүхий байгууллагаас түдгэлзүүлээгүй байх, уг актад гомдол гаргаж хянуулах хугацаа өнгөрсөн байх. Энэхүү заалтын “хугацаа өнгөрсөн” гэдэгт хугацаандаа гомдлоо гаргаад хянуулж дууссан байхыг хамтатган ойлговол захиргааны шийдвэрээр үүрэг хүлээгч нь уг шийдвэрт холбогдуулан гомдол, нэхэмжлэл гаргах эрхээ эдэлсэн, эсхүл уг эрхээ хэрэгжүүлээгүй, эрхээ алдсан (хөөн хэлэлцэх хугацаа) тохиолдолд л захиргааны шийдвэр гүйцэтгэл хийгдэх боломжтой гэж үзэхээр байна.

Хүснэгт 8

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 83.1.3.хуульд өөрөөр заагаагүй бол шаардах эрх бүхий шийдвэрийг мэдэгдсэнээс хойш 14 хоногийн хугацаа өнгөрсөн байх;<br>83.1.4.үүрэг хүлээгчид 14 буюу түүнээс доошгүй хоногийн хугацаанд захиргааны шийдвэрийг биелүүлэх тухай мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн байх. |
| **Томьёологдсон шалгуур үзүүлэлт** | 1.ЗЕХ-ийн 83.1.3, 83.1.4-т заасан хугацааны хувьд боломжит хугацаа мөн эсэх? |

**Үнэлгээ:**

ЗЕХ-ийн хуулийн 83 дугаар зүйлд албадлага хэрэглэн захиргааны шийдвэрийг гүйцэтгэхийн өмнө бүрдсэн байх нөхцлүүдийг тодорхойлсон бөгөөд Нийслэлийн газрын албатай хийсэн ярилцлагын хүрээнд эдгээр хугацааны талаар асуудал хөндөгдөөгүй. Энэ нь нэг талаас энэхүү хугацааг газар албадан чөлөөлөх харилцаанд хэрэглэхгүй байгааг харуулах үзүүлэлт болох юм. Нөгөө талаар, 2009 оны Нийслэлийн хэмжээнд

[103] ЗЕХ-ийн 82.2.Дараах тохиолдолд захиргааны актад шийдвэр гүйцэтгэнэ, 84.1.Захиргааны шийдвэрийг дараах байгууллага гүйцэтгэнэ: 84.1.1.захиргааны актыг батлан гаргасан захиргааны байгууллага; гэх мэт

[104] “Германы Захиргааны үйл ажиллагааны тухай хууль (ЗҮАтХ)-ийн 61 дүгээр зүйлд Захиргааны гэрээг шууд албадан гүйцэтгэх тухай мэдэгдэл (өргөдөл) гаргахыг зохицуулсан бөгөөд Захиргааны гэрээтэй холбоотой үүргийн биелэлтийг хангуулахаар гэрээний аль ч талаас Захиргааны гэрээг үндэслэн шууд гүйцэтгэх хуудас олгуулахаар шүүхэд мэдэгдэл гаргах боломжтой байна. Ийнхүү мэдэгдэл гаргасан тохиолдолд Захиргааны хүчин төгөлдөр гэрээ нь Захиргааны шийдвэр гүйцэтгэх үндэслэл болно гэсэн үг. Захиргаа энэ тохиолдолд шууд Захиргааны акт гарган Гэрээний биелэлтийг албадан хангуулах эрхгүй. Учир нь тухайн тохиолдолд Захиргаа Захиргааны акт гаргах эрхээсээ татгалзан буюу Захиргааны гэрээг байгуулахаар сонгосон тул өөрийн Захирах шинжтэй харилцаанаас татгалзан иргэн, хуулийн этгээдийн нэгэн адил статустай болсон гэж үздэг тул гэрээний биелэлтийг хангуулахаар шууд захиргааны акт гаргах эрхгүй, зөвхөн шүүхэд гомдол гаргах эрхтэй байна.” Судалгааны явцад ХБНГУ-ын Бавари мужийн Аугсбургийн их сургуульд “Монгол, Германы хуулиуд дахь Захиргааны гэрээний зохицуулалтыг харьцуулсан” сэдвээр магистрын зэрэг хамгаалсан, докторын сургалтанд хамрагдаж судалгаа хийж буй А.Ононтой хийсэн ярилцлагаас.



Remove Watermark Now

газар ашиглалттай холбогдон үүссэн зөрчлийг арилгахад баримтлах журамд тодорхой хугацаа заагаагүй нь ЗЕХ-ийн 83-тай нийцэхгүй байна.

Хүснэгт 9

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 84.1.Захиргааны шийдвэрийг дараах байгууллага гүйцэтгэнэ:<br>84.1.1.захиргааны актыг батлан гаргасан захиргааны байгууллага; |
| **Томьёологдсон шалгуур үзүүлэлт** | 1.Зохион байгуулалтын бүтцэд нь хариуцсан нэгж, салбар, ажилтан байгаа эсэх, энэ чиг үүрэг холбогдох ажилтны ажлын байрны тодорхойлолтод туссан эсэх?<br>2.Хэрэгжүүлэхэд байгууллагын бүтэц, зохион байгуулалт талаас саад болох шалтгаан бий эсэх, тухайлбал мэргэжлийн байгууллага, гүйцэтгэх ажилтны орон тоо байгаа эсэх, төсөв хөрөнгө төлөвлөгддөг эсэх?<br>3.Бодит үйлдэл, үйл ажиллагаа шаардсан /ж.нь: зөвшөөрөлгүй барилга, хашаа буулгах/ шийдвэрийг хэрэгжүүлж байгаа байдал |

**Үнэлгээ:**

1. Нийслэлийн газрын албаны хувьд газар чөлөөлөх[105] харилцааг дагнан эрхлэх чиг үүрэг бүхий хэлтэстэй байна. Хэдийгээр энэ хэлтэс Нийслэлийн газрын албаны[106] бүх шийдвэрийн гүйцэтгэлийг хариуцах чиг үүрэгтэй нэгж биш боловч газрын харилцааны хувьд бодит үйлдэл, үйл ажиллагаа шаардсан шийдвэр нь энэ хэлтэст хамаарах юм. Газар чөлөөлөх хэлтэс нь нийслэлийн хэмжээнд баригдах барилга, автозам, инженерийн шугам сүлжээний газрыг чөлөөлж, холбогдох газруудад хүлээлгэж өгөх болон нөлөөлөлд өртсөн газар эзэмшигч, ашиглагч, өмчлөгчидтэй гэрээ байгуулах, газрыг чөлөөлөх, нөхөх олговор олгох, тайлагнах үйл ажиллагааг зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй нэгж байна.

Уг хэлтсийн газар зохион байгуулагч нар дүүргийн газрын албаны хороо хариуцсан газар зохион байгуулагч нартай хамтран[107] газар чөлөөлөх шийдвэрийг гардан хэрэгжүүлдэг ажээ. Газар чөлөөлөх хэлтсийн “газар зохион байгуулагч”-ийн ажлын байрны тодорхойлолтод дүн шинжилгээ хийж үзвэл, “газар чөлөөлөх” ажлыг хариуцаж эрхлэх талаар тодорхой зааж тусгаагүй байна. Харин хэлтсийн даргын ажлын байрны тодорхойлолтод “газар чөлөөлөх үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлэх”, мөрдөж ажиллах хууль тогтоомжийн хэсэгт ЗЕХ-ийг нэрлэн заасан байна. Гэвч уулзалт, ярилцлагын үед ЗЕХ-ийн захиргааны шийдвэр гүйцэтгэлийн харилцааг зохицуулсан бүлгийг тус хэлтсийн газар чөлөөлөх чиг үүргийг хэрэгжүүлэхэд хэрэглэж байгаагүй нь тодорхой болсон билээ.

2. Захиргааны шийдвэр өөрөө хэрэгждэг байхын тулд хөрөнгөтэй, төсөвтэй, гүйцэтгэх эзэн тодорхой, албан байгууллагын чиг үүрэг, хариуцлагын үр дагавар тодорхой байх ёстой. Тиймээс тухайн байгууллагад захиргааны шийдвэр гүйцэтгэлийн хэрэгжилтийг хариуцсан ажлын байр байгаа эсэх, орон тоо, төсөв хөрөнгө нь хүрэлцээтэй эсэх нь чухал. Үүнийг Нийслэлийн газрын албаны Газар чөлөөлөх хэлтсийн жишээн дээр судлаж үзэв. Тус хэлтэс нь дарга, ахлах мэргэжилтэн, газар зохион байгуулагч 9, нийт 11 хүний орон тоотой ажиллаж[108] байна.

---

[105] Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын дарга, Нийслэлийн Засаг даргын хамтарсан 2016 оны А/223, А/677 дугаар тушаал, захирамжаар батлагдсан Нийслэлийн газрын албаны дүрмийн 3.1.22

[106] Нийслэлийн газрын албаны бүтэц http://www.gazar.ub.gov.mn/index.php/about/structure

[107] Нийслэлийн газрын албанаас гаргасан судалгаа болон иргэдийн зүгээс сошиалаар ирүүлсэн нийт 207 зөрчлийн 115 байршилд дүүргийн Газрын албатай хамтран газар чөлөөлөх ажил зохион байгуулсан. Нийслэлийн газрын албаны Газар чөлөөлөх хэлтсийн 2017 оны ажлын тайлангаас.

[108] Нийслэлийн газрын албаны Газар чөлөөлөх хэлтсийн 2017 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайлангаас: Газар чөлөөлөх хэлтэс нь “шинээр баригдах барилга байгууламж, авто замын трасст орж буй нэгж талбарын бүртгэл хийх, судалгаа гаргах, чөлөөлөгдөх газрын газар зохион байгуулалт хийж танилцуулах, газар чөлөөлөх ажлыг зохион байгуулах, чөлөөлөгдөх газрын үл хөдлөх хөрөнгийн фото зураг болон газрын байршлын зургийг бэлтгэх, чөлөөлөгдсөн хөдлөх болон үл хөдлөх хөрөнгийн тухай мэдээллийг газрын мэдээллийн санд бүртгэх санал боловсруулж, мэдээлэл технологийн хэлтэст хүргүүлэх, чөлөөлсөн газрыг



Remove Watermark Now

Remove Watermark Now

Ингэхдээ газар чөлөөлөх, албадан буулгах техник хэрэгсэл, зөөж тээвэрлэх автомашин, тоног төхөөрөмж газрын албаны өөрийн өмчлөл, мэдэлд байдаггүй ажээ. Энэ ажлыг хийж гүйцэтгэхдээ тээврийн хэрэгсэл тоног төхөөрөмжийг түрээслэн ажилладаг, харин албадан буулгасан хашаа болон ТҮЦ зэргийг дүүрэг тус бүрт байрлах журмын хашаанд байрлуулдаг байна.

Нийслэлийн газрын албанд улсын байцаагчийн эрхтэй албан хаагч байхгүй учир мэргэжлийн хяналтын газарт хүсэлт тавьж хамтран ажилладаг байна. Харин мэргэжлийн хяналтын байгууллага нь зөрчлийг шалгаад акт, дүгнэлт гаргахаас зөрчил арилгах гүйцэтгэлийг хийдэггүй, гүйцэтгэлийг газрын алба хийдэг гэсэн тайлбар өгч байлаа. Үүнээс үзвэл, газар чөлөөлөх ажлыг гардан гүйцэтгэх эдгээр ажилтнууд нь улсын байцаагчийн эрхгүй байгаагаас уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд саад учирдаг байна.

Нөгөөтэйгүүр, Газрын тухай хуулиар газрыг улсын хэрэгцээнд нөхөх олговортойгоор буцаан авахаар заасан байдаг. Засгийн газар уг нөхөх олговрыг улсын төсөвт тэр бүр хугацаанд нь суулгадаггүйгээс газрыг буцаан авсны дараа нөхөн олговор төлөх асуудал хоцордог. Газар чөлөөлөлтийн ажилд зориулсан төсөв байдаггүй, албан хаагчийн тоо хангалтгүй, Нийслэлийн хэмжээнд газар чөлөөлөлтийн хэлтэс нь 11 албан хаагчтай, шаардлагатай тохиолдолд дүүргээс мэргэжилтэн татан оролцуулдаг байна.

3. Газрын тухай хуулийн 57, 59 нь газар албадан чөлөөлөх эрх олгосон үндсэн зохицуулалт нь болох бөгөөд Нийслэл хотод 2009 оноос “Нийслэлийн хэмжээнд газар ашиглалттай холбогдон үүссэн зөрчлийг арилгахад баримтлах журам”[109] хэрэглэгдэж байгаа ажээ.

“Нийслэлийн хэмжээнд газар ашиглалттай холбогдон үүссэн зөрчлийг арилгахад баримтлах журам” нь ЗЕХ –д нийцүүлэн захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй байна. Энэхүү журмыг цаашид дагаж мөрдүүлэх бол ЗЕХ-ийн 65 дугаар зүйлд заасанаар улсын нэгдсэн бүртгэлд шинэчлэн бүртгүүлэх шаардлагатай ингэснээр газар чөлөөлөх шийдвэрийг гүйцэтгэх үйл ажиллагаа нь ЗЕХ-ийн шийдвэр гүйцэтгэлийн зохицуулалтад нийцэх боломжтой болох юм.

pdfelement

Зохих зөвшөөрөлгүйгээр газар дээр барилга, байгууламж барьсан, эсхүл бусад хэлбэрээр түүнийг дур мэдэн эзэмшсэн тохиолдолд газрын албанаас (Засаг дарга) уг газрыг чөлөөлөх тухай хугацаатай мэдэгдэл өгч, улмаар уг мэдэгдэлд заасан хугацаанд газрыг сайн дураар чөлөөлөөгүй бол уг газрыг албадан чөлөөлөх учиртай. Дээрх журмын 5.11-д заасанаар эхлээд газар эзэмшил, ашиглалтын зөрчлийг арилгах хугацааг тодорхой заасан “шаардах хуудас” хүргүүлж, биелэгдээгүй тохиолдолд эрчим хүч, дулаан, усны хэрэглээг хязгаарлах зэргээр тухайн газар дээр явуулж буй үйл ажиллагааг зогсоох арга хэмжээ авч, хугацаатай “албан шаардлага” хүргүүлэх, эцэст нь барилга байшинг буулгах зэргээр газрыг албадан чөлөөлөх дараалалтай байна.

Нийслэлийн газрын албаны 2017 оны газар чөлөөлөлтийн ажлын мэдээнээс үзвэл: Нийслэлийн Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/863 дугаар захирамжаар “Газрын зөрчил арилгах арга хэмжээ”-г зохион байгуулахаар шийдвэрлэсний дагуу 2017 оны 03 сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд батлагдсан удирдамжийн дагуу үйл ажиллагааг 3 чиглэлээр[110] зохион байгуулсан байна. Энэ ажлын

---

жижүүрийн зурагт тэмдэглэж, мэдээллийн сан үүсгэх, газар чөлөөлөх төсөв зохиох, батлуулах, газрын нөхөх олговор олгох, тайлагнах, улсын төсвөөр болон дараа төлөгдөх нөхцөлтэйгөөр шинээр баригдах өргөтгөл, шинэчлэл хийгдэх авто зам болон инженерийн шугам сүлжээний трассын газрын тоо бүртгэл хөтлөх, тоолох, тайлагнах, гэрээний хугацаа дуусахаас өмнө бусдын эзэмшил газрыг солих буюу эргүүлэн авах, нөхөн олговор олгох” ажлыг эрхлэн хариуцдаг байна.

[109] НИТХТ-ийн 2009 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан, Захиргааны хэм хэмжээний актын улсын гэдсэн бүртгэлд бүртгэгдээгүй.

[110] -Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд зохих зөвшөөрөлгүй байрлуулсан түц, контейнер, гараж, павильон зэрэг зөөврийн байгууламжуудын зөрчлийг арилгах, газар чөлөөлөх, -Нийтээр ашиглах авто болон явган хүний зам хааж байрлуулсан обьектуудыг чөлөөлж, чөлөөтэй зорчих нөхцлийг бүрдүүлэх, -Эзэмшил, ашиглалтад байгаа газраа дур мэдэн нийтийн эдэлбэр газарт сунгасан болон шинээр барьсан хашааг

хүрээнд зөвшөөрөлгүй байрлуулсан 542 ТҮЦ-ийг тогтоож, 373 ТҮЦ-ийг албадан чөлөөлөх арга хэмжээ авсан байна. ТҮЦ-ээс бусад төрлийн буюу гараж, контейнер, павильон зэрэг 192 байгууламжийг илрүүлснээс 118-ыг чөлөөлсөн гэжээ. Мөн 129 байршилд явган хүний зам, авто зам хаасан, орц гарц, авто машины зам хаасан хаалт, хашаа, бусад төрлийн обьектуудыг /ТҮЦ, контейнер, павильон/ чөлөөлөх ажил хийгдэж 78 байршилд газар чөлөөлөлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн ажээ.

Захиргааны байгууллагын тодорхой шийдвэрийг гүйцэтгэхэд бодит үйлдэл, үйл ажиллагаа явуулахыг шаардсан тохиолдлыг Баянгол дүүргийн 4-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “1000 машины зогсоол” гэж нэрлэгдэх болсон газрын жишээн дээр, газрын албанд байгаа газар чөлөөлөлтийн материалд тулгуурлан судалж үзлээ. Энэ тохиолдолд “Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” ХНН-д олгогдсон газарт хууль бусаар авто машины худалдаа, үйлчилгээ эрхэлж байгаа аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагааг таслан зогсоож, газар чөлөөлөх”–өөр тухайлан Нийслэлийн засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/1046 дугаар захирамж гарч, үүний дагуу газар чөлөөлөлт хийгдсэн[111] гэж ойлгохоор байна.

Харин газар чөлөөлөх ажлын баримт бичгүүд[112] тухайлбал, Төмөр зам дахь цагдаагийн газрын иргэдэд хандсан болон “Даяар хас” ХХК-д хаягласан “мэдэгдэх хуудас”, Баянгол дүүрэг дэх Цагдаагийн 2-р хэлтсийн “мэдэгдэл” нь огнооны хувьд А/1046 дугаар захирамжаас өмнө байх төдийгүй захирамж гарсан огнооноос өмнө “газар чөлөөлөх” шийдвэр гүйцэтгэх ажил эхэлсэн байжээ. Өөрөөр хэлбэл, дээрх мэдэгдэх хуудас, мэдэгдлүүдээр 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор газрыг сайн дураар чөлөөлсөн байх хугацаа тогтоож, 12 дугаар сарын 26-27-ны өдрүүдэд албадан чөлөөлөхөөр товлосон байдаг. Энэ тохиолдлын хувьд газар чөлөөлөх шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаатай холбоотой гомдол, шүүхэд нэхэмжлэл гаргаагүй, харин уг газрыг “Улаанбаатар төмөр зам” ХНН-д эзэмшүүлсэн 2017 оны А/813 дугаар захирамжтай холбоотой захиргааны маргаан шүүхэд хянагдаж байгаа ажээ.

<u>Дүгнэлт:</u> Газар албадан чөлөөлөх мэдэгдэл, шаардлага өгснөөс хойш албадлага хэрэглэх тогтсон хугацаагүй, шийдвэр гүйцэтгэхдээ ЗЕХ-ийг хэрэглэдэггүй, Нийслэлийн хэмжээнд хэрэглэж буй журам нь Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгэлгүй, хүчин төгөлдөр биш.

Хүснэгт 10

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 84.1.3.хуулиар тусгайлан эрх олгосон цагдаагийн болон мэргэжлийн байгууллага.<br>84.2.Захиргааны байгууллага шийдвэр гүйцэтгэлийн талаар өөр захиргааны байгууллагаас тусламж авч болно |
| **Томьёологдсон шалгуур үзүүлэлт** | 1. Захиргааны харилцан туслалцах зохицуулалттай уялдсан эсэх, уг зохицуулалтыг шийдвэр гүйцэтгэлд ашиглаж байгаа эсэх?<br>2. Албадлага хэрэглэх захиргааны акт гаргаж байгаа эсэх, түүнийг хэн, ямар байдлаар, ямар хугацаанд биелүүлж байгаа. Ийм үе шат байх хэрэгтэй юу? |

**Үнэлгээ:**

буулгах, зөвшөөрөгдсөн хэмжээнд хүртэл татуулах, газар чөлөөлөх. Нийслэлийн газрын албаны Газар чөлөөлөх хэлтсийн 2017 оны ажлын тайлангаас.

[111] Судалсан тохиолдлын хувьд, энэ 2017 оны А/1046 дугаар захирамжийг үндэслэн гэх боловч мөн Засаг даргын 2013 оны А/980, 2017 оны А/739 дугаар захирамжуудыг үндэслэсэн мэдэгдэл, мэдэгдэх хуудас байдаг.

[112] Нийслэлийн Засаг даргын 2017 оны А/1046 дугаар захирамж, Төмөр зам дахь цагдаагийн газраас тус байршилд автомашин байршуулан худалдаа, үйлчилгээ эрхэлдэг иргэдэд хандсан 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “мэдэгдэх хуудас”, мөн газрын 2017 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн “Даяар хас” ХХК-д мэдэгдэл хүргүүлэх тухай албан бичиг, Баянгол дүүрэг дэх Цагдаагийн 2-р хэлтсийн 2017 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 179 дугаар “мэдэгдэл” зэрэг баримтууд.



Remove Watermark Now

Remove Watermark Now

1. ЗЕХ-ийн 84 дүгээр зүйлийн 84.1.3, 84.2-ийн зохицуулалтад мөн хуулийн 10 дугаар зүйлийн “захиргааны байгууллагын харилцан туслах үүрэг”–тэй зөрчилдөөгүй, харин ч бие биенээ нөхцөлдүүлсэн шинжтэй уялдаа бүхий байна. Захиргааны шийдвэрийг гүйцэтгэхэд өөр байгууллагаас тусламж авах, цагдаагийн болон бусад мэргэжлийн байгууллага оролцохыг заасан 84 дүгээр зүйлийн зохицуулалтыг 10 дугаар зүйлээр илүү тодорхой болгож, туслалцаа хүссэн байгууллагатай хамтран ажиллах үүргийг хуульчилж өгсөн байна.

Нийслэлийн газрын албаны хувьд нөхөх олговортойгоор газар эргүүлэн авах асуудлыг нарийвчлан зохицуулсан зохицуулалт Газрын хуульд байхгүй, хэт ерөнхий, товчхон байдаг нь газар чөлөөлөх ажлыг гүйцэтгэхэд хүндрэл үүсгэдэг гэж буй боловч уг харилцаанд Захиргааны ерөнхий хуулийн шийдвэр гүйцэтгэлийн зохицуулалт хэрэглэгдэх байтал хэрэглэдэггүй, хэрэглэж байгаагүй ажээ.

Захиргааны ерөнхий хуульд заасан захиргааны байгууллагатай хамтран ажиллах тухай зохицуулалтын дагуу газар чөлөөлөх ажлыг гүйцэтгэхдээ төрийн бусад байгууллагатай хамтран ажилладаг эсэхийг тодруулахад ЗЕХ-ийн 10, 84.1.3, 84.2 –ийн зохицуулалтыг үндэслэн хамтран ажиллаж байгаагүй ажээ. Ийм зохицуулалт байгааг мэдээгүй байдалтай байсан. Хэдийгээр энэ зохицуулалтыг хэрэглээгүй боловч томоохон хэмжээний газар чөлөөлөлтийн арга хэмжээний үеэр бусад төрийн байгууллагуудтай хамтран ажилладаг тохиолдол[113] байна. Тухайлбал, газар эзэмшил, ашиглалтын зөрчлийг арилгах тухай нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж ажиллахдаа мэргэжлийн хяналт, онцгой байдлын болон цагдаагийн байгууллагатай хамтран ажилладаг аж. Гэвч өдөр тутмын шийдвэр гүйцэтгэх (газар чөлөөлөх)–д эдгээр байгууллагатай хамтран ажиллаж чаддаггүй талаар Нийслэлийн газрын албатай хийсэн уулзалтын үед тайлбарлаж байлаа.

Газрын тухай хуулийн 59 дүгээр зүйл, Нийслэлийн хэмжээнд газар ашиглалттай холбогдон үүссэн зөрчлийг арилгахад баримтлах журмын 5.1-ээс үзвэл дээрх байгууллагуудтай газар чөлөөлөлтийн үйл ажиллагаанд хамтран ажиллахад “гэрээ” байгуулах зохицуулалттай байна.

pdfelement

<u>Дүгнэлт:</u> Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулах хуулийн зохицуулалт дутмаг, бусад байгууллагатай хамтран ажиллахад хүндрэл үүсдэг гэх мэтээр захиргааны шийдвэр гүйцэтгэлийн талаарх ЗЕХ-ийн зохицуулалт байгааг мэдэхгүй, энэ зохицуулалтыг хэрэглэхгүй байгаа нь харагдаж байна.

2. Судалгааны зорилтот байгууллага болох Нийслэлийн газрын албатай хийсэн ярилцлагын явцад газар чөлөөлөх тохиолдолд тухай бүрт шийдвэр гардаггүй харин Нийслэлийн Засаг дарга ерөнхий “газар эзэмшлийн зөрчил арилгуулах” утгаар нэг захирамж[114] гаргаж, түүнийг үндэслэн ажлын хэсэг дүүрэг тус бүрд зөрчилтэй газрын судалгааг гаргаж, түүнд үндэслэн зөрчил арилгуулах шаардах хуудас өгснөөр газар чөлөөлөх ажил эхэлдэг[115] байна. Гэхдээ энэ газар чөлөөлөх ажил нь ихэвчлэн зохих зөвшөөрөлгүйгээр газар эзэмшиж, ашиглаж буй этгээдийн хувьд хэрэгжүүлдэг хэлбэр байна.

Хүснэгт 11

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 90.1.Мэдэгдэлд заасан хугацаанд үүргийг биелүүлээгүй бол захиргааны шийдвэр гүйцэтгэлийг хариуцсан захиргааны байгууллага |

[113] Цагдаагийн байгууллагаас газар эзэмшлийн зөрчил арилгах ажилд нэг албан хаагч гаргаж өгдөг байсныг Нийслэлийн засаг даргаар захирамж гаргуулж хамтран ажиллах чиглэл өгснөөр Нийслэлийн цагдаагийн газраас хүн хүч гарган хамтран ажиллаж байгаа. Нийслэлийн газрын албатай хийсэн уулзалтын тэмдэглэлээс.
[114] Тухайлбал, “ТҮЦ” Газрын зөрчил арилгах нэгдсэн арга хэмжээ /НЗД-ын 2016 оны 12 дугаар сарын 08-ний А/863 тоот ажлын хэсэг байгуулагдсан/
[115] Нийслэлийн газрын албаны орлогч дарга, газар чөлөөлөх хэлтэс, хуулийн мэргэжилтнүүдтэй хийсэн уулзалтын тэмдэглэл.

| | |
|---|---|
| | албадлага хэрэглэхийг шийдвэрлэсэн захиргааны акт гарган, түүнийг нэн даруй биелүүлнэ.<br>90.2.Энэ хуулийн 90.1-д заасан захиргааны актад зөвхөн захиргааны шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаатай холбоотой гомдол гаргах бөгөөд харин захиргааны акт гаргах журам үйлчлэхгүй. |
| **Томьёологдсон шалгуур үзүүлэлт** | 1. Нэн даруй биелүүлэх заалт нь ЗЕХ-ийн 82.2, 90.2-той хэрхэн уялдах, нэн даруй биелүүлсэн хэдэн тохиолдол байна вэ?<br>2. ЗЕХ-ийн 90.2-н хувьд тусдаа гомдол гаргахаар заасан нь оновчтой эсэх, энэ заалтаар гомдол гаргасан хэдэн тохиолдол байна вэ?<br>3. Гомдлыг хаана гаргах, улмаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байх эсэх, Энэ нь үндсэн захиргааны шийдвэрт гомдол гаргах, нэхэмжлэл гаргах эрхтэй хэрхэн уялдах, давтагдаж буй эсэх. |

**Үнэлгээ:**

1. ЗЕХ-ийн 90 дүгээр зүйлийн 90.1-д “мэдэгдэлд заасан хугацаанд үүргийг биелүүлээгүй бол ... албадлага хэрэглэхийг шийдвэрлэсэн захиргааны акт гарган, нэн даруй” биелүүлэхээр заасан боловч мөн зүйлийн 90.2-т уг актад гомдол гаргаж болохоор байгаа нь зөрчилдөж байна. Өөрөөр хэлбэл, нэн даруй биелүүлэх зохицуулалт хэрэгжих боломжгүй. Тиймээс нэн даруй биелүүлэх зохицуулалтыг хангахын тулд шийдвэр гүйцэтгэл хийгдэхдээ хууль болон үүрэг хүлээгчийн эрх зөрчигдсөн гэж үзвэл нөхөж гомдол гаргаж тогтоолгох боломжтой байхаар өөрчлөлт оруулж болох юм.

2. Нэн даруй биелүүлсэн хэдэн тохиолдол байгааг болон албадлага хэрэглэх шийдвэрт гомдол гаргасан хэдэн тохиолдол байгааг судалгаа хийсэн байгууллагын хүрээнд тодруулахад: Нийслэлийн газрын албаны Газар чөлөөлөх хэлтсийн хувьд “шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаатай холбоотой маргаан гардаггүй. Ихэнх тохиолдол иргэн өөрөө зөрчил гаргасан байдаг учир маргаан гаргадаггүй” гэсэн агуулгаар тайлбарлаж байсан.

3. ЗЕХ-ийн 90 дүгээр зүйлийн 90.2-т заасан гомдлыг хаана гаргах талаар тухайлсан зохицуулалтгүй байгаа ч мөн хуулийн 9 дүгээр бүлэгт заасан журам хэрэглэгдэх боломжтой. Харин мөн хуулийн 82.2-т зааснаар үндсэн захиргааны актыг гүйцэтгэх гол нөхцөл нь уг актад гомдол гаргах эрх хэрэгжсэн, эсхүл гомдол гаргах хугацаа өнгөрсөн байх явдал бөгөөд энэ гомдлын агуулга нь үндсэн захиргааны акттай холбоогүй зөвхөн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаагаар хязгаарлагдах нь тодорхой байна. Тиймээс давтагдсан зохицуулалтгүй харин гомдол гаргах эрхтэй адил нэхэмжлэл гаргах эрх нь албадлагын журмаар шийдвэр гүйцэтгэх ажиллагаа түдгэлзүүлэх үндэслэл болохгүй байдлаар тодруулсан нэмэлт оруулах нь ач холбогдолтой байж болох юм.

### <u>3.3. Гомдол гаргах журам</u>

Хүснэгт 12

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 92.1.Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн, хуулийн этгээдээс түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн гэж үзвэл холбогдох захиргааны актыг хууль болон зорилгодоо нийцэж байгаа эсэх талаар хянуулахаар гомдол гаргах эрхтэй.<br>92.2.Энэ хуулийн 92.1-д заасан гомдол нь Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна |
| **Томьёологдсон шалгуур үзүүлэлт** | 1. Зөвхөн актад гомдол гаргах харилцааг зохицуулах гэж зорьсон уу эсхүл ЗЕХ-ийн 11.1-д заасан 3 хэлбэрт үү гэдгийг тодруулах<br>2. Захиргааны гэрээтэй холбогдуулж гомдол гаргах харилцааг зохицуулж чадсан эсэх, гэрээтэй холбоотой гомдлыг хэрхэн урьдчилан шийдвэрлэж байгаа |



Remove Watermark Now
pdfelement

Remove Watermark Now

| | |
|---|---|
| | 3.Гомдлыг шийдвэрлэхдээ Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийг хэрэглэдэг эсэх, ЗЕХ болон ИТБАТГӨГШт хуулийн харилцан уялдаа, давхцлыг тодруулах |

**Үнэлгээ:**

1. ЗЕХ-ийн есдүгээр бүлгийн зохицуулалт нь бүхэлдээ мөн хуулийн 11 дүгээр зүйлд тодорхойлсон захиргааны үйл ажиллагааны хэлбэрүүдээс тухайлан захиргааны актад гомдол гаргах, уг гомдлыг хянан шийдвэрлэх журмыг тогтооход зорьсон болох нь тодорхой байна.

Захиргааны үйл ажиллагааны үндсэн гурван хэлбэрээс захиргааны хэм хэмжээний актыг батлах, түүнийг нь хянан бүртгэх (урьдчилсан хяналт), хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмыг мөн хуулийн зургадугаар бүлэгт зохицуулсан бөгөөд энэхүү бүлэгт хуулиар эрх олгогдсон захиргааны байгууллагаас хэм хэмжээний акт баталсан тохиолдолд түүнийг бүртгэх, дүгнэлт гаргах, шинжилгээ үнэлгээ хийх замаар хянах тогтолцоог тусд нь бүрдүүлсэн байдаг. Нөгөө талаар, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5-д захиргааны хэм хэмжээний акттай холбоотой нэхэмжлэлд хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй байхаар заасан бөгөөд хэм хэмжээний акт нь тодорхой нэг этгээдэд чиглэсэн үйлчлэлтэй бус харин ирээдүйд үүсэх нэг төрлийн олон тохиолдлыг зохицуулах зорилготой тул тухайн тохиолдол үүсэх бүрт гомдол гаргасан байхыг шаарддаггүй учир ЗЕХ-ийн есдүгээр бүлэг нь энэ төрлийн шийдвэрт үйлчлэхгүй.

Захиргааны хэм хэмжээний акт нь хууль тогтоогч эрхээ шилжүүлсний үндсэн дээр тодорхой захиргааны байгууллагад уг актыг гаргах эрх олгогддог. Ийнхүү шилжүүлж авсан эрх гэдэг утгаараа уг хэм хэмжээний актыг гаргах эрх тухайн захиргааны байгууллагын өөрийнх нь үндсэн бүрэн эрхэд хамаардаггүй бөгөөд өөрийн үндсэн эрхийн дагуу хэрэгжүүлж буй чиг үүрэг биш учир түүний дээд шатны байгууллага нь бусдын гомдлыг үндэслэн хянах эрх хэмжээгүй, харин урьдчилсан хяналтыг хууль зүйн яам ЗЕХ-д заасан нийтлэг шаардлагыг тавьж хэрэгжүүлдэг.

pdfelement

2. ЗЕХ-ийн энэ зохицуулалтыг шууд утгаар нь ойлговол гэрээтэй холбоотой харилцааг зохицуулах зорилгогүй зөвхөн захиргааны актад гомдол гаргах харилцааг зохицуулсан ажээ.

Харин захиргааны гэрээтэй холбоотой гэрээний талууд, ялангуяа захиргааны нөгөө тал буюу иргэн, хуулийн этгээд гэрээний тал болсон захиргааны дээд шатанд гомдол гаргах[116] эрх байх уу гэсэн асуултад онолын үндэслэл нэхэж байна. Захиргааны гэрээг байгуулах шатанд талууд уг гэрээний нөхцөлийг харилцан зөвшөөрсний үндсэн дээр уг гэрээ байгуулагддаг. Энэ нь захиргааны акттай харьцуулбал гэрээний агуулга, нөхцөлийг 2 тал бүгд зөвшөөрч байсан гэдэг утгаараа өөрсдөө хүлээн зөвшөөрсөн нөхцөлийн талаар нөгөө талдаа холбогдуулан маргах, гомдол гаргах боломж, шаардлага үүсэхгүй байх ёстой. Тиймээс захиргааны гэрээний талууд уг гэрээний агуулга, нөхцөлийн талаар гэрээ байгуулагдсанаас хойш ЗЕХ-ийн 55 дугаар зүйлд заасанаас бусад агуулгаар гомдол болон нэхэмжлэл гаргах эрхгүй[117] байх эсэх нь цаашид онолын хувьд тайлбар шаардсан хэрэг юм.

---

[116] Тухайлбал, "Германы Захиргааны үйл ажиллагааны тухай хууль (ЗҮАтХ)-д Захиргааны гэрээтэй холбогдож, маргаан гарсан тохиолдолд Захиргааны актын адил дээд шатны байгууллагад урьдчилан шийдвэрлүүлэхээр гомдол гаргах зохицуулалт байхгүй. Хуулийн 61 дүгээр зүйлд Захиргааны гэрээг шууд албадан гүйцэтгэх тухай мэдэгдэл (өргөдөл) гаргахыг зохицуулсан." Судалгааны явцад ХБНГУ-ын Бавари мужын Аугсбургийн их сургуульд "Монгол, Германы хуулиуд дахь Захиргааны гэрээний зохицуулалтыг харьцуулсан" сэдвээр магистрын зэрэг хамгаалсан, докторын сургалтанд хамрагдаж судалгаа хийж буй А.Ононтой хийсэн ярилцлагаас.

[117] Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2018 оны 57 дугаар захирамжтай Г.Эрдэнэбаярын нэхэмжлэлтэй хэрэгт захиргааны гэрээтэй холбогдуулан хариуцагч талаас сөрөг нэхэмжлэл гаргасныг шүүх хүлээн авахаас татгалзсан байна.

Харин гэрээний үүргийн биелэлттэй холбогдуулж захиргааны нөгөө тал[118] (иргэн, хуулийн этгээд) маргах эрхтэй байх нь ойлгомжтой, харин захиргааны байгууллагын хүлээсэн гэрээний үүргийн биелэлтийн талаар иргэн, хуулийн этгээд гомдол гаргах бол ЗЕХ-ийн 93 дугаар зүйлд заасан дээд шатны захиргааны байгууллага эсхүл гомдол хянан шийдвэрлэх байгууллагад хандаж шийдвэрлүүлэхээр зохицуулж болох юм. Нэгэнт одоо үйлчилж буй ЗЕХ-ийн есдүгээр бүлгийн зохицуулалт захиргааны гэрээнд холбогдох гомдолд үйлчлэхгүй нь тодорхой байгаа, гэрээтэй холбоотой маргаан гарсан тохиолдолд шүүх нэхэмжлэлийн шаардлага нь захиргааны акт эсхүл гэрээ байхыг ялгахгүйгээр урьдчилан шийдвэрлүүлсэн байхыг шаардах нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.3 –д шүүх нэхэмжлэл хүлээн авч, захиргааны хэрэг үүсгэхийн тулд захиргааны журмаар гомдлоо гаргаж, маргаанаа урьдчилан шийдвэрлүүлсэн байх[119] шаардлага тавьж буйгаас харагдаж буй тул ЗЕХ-д гэрээтэй холбогдуулж урьдчилан шийдвэрлүүлэх журмаар гомдол гаргах шаардлага тавигдах эсэх талаар зохицуулалт хийх нь зайлшгүй юм.

Харин ингэхдээ маргаан таслах зөвлөл гэх мэт гомдол хянан шийдвэрлэх тусдаа чиг үүрэг бүхий байгууллагатайгаас бусад салбар харилцаанд дээд шатны байгууллага гомдлыг үр дүнтэй хянан шийдвэрлэх боломжтой эсэх энэ нь хий шат дамжлага болохгүй, маргааныг шийдвэрлэх үр дүнтэй үе шат болох эсэхийг сайтар бодолцож энэ зохицуулалтыг хийх нь зөв байх.

Түүнчлэн, гэрээний тал биш гуравдагч этгээд захиргааны гэрээний зохицуулалттай холбогдуулж маргах тохиолдлын талаар ЗЕХ-д зохицуулалт[120] хэрэгтэй байна. Ингэхдээ ЗЕХ-ийн 9 дүгээр бүлгийн зохицуулалтыг хэрэглэхээр нэмэлт оруулах шаардлагатай юу эсхүл тусд нь гэрээний онцлогт тохирсон зохицуулалт хийх үү гэдгийг шийдвэрлэх нь зохилтой юм.

3. ЗЕХ-ийн 92 дугаар зүйлийн 92.2-т захиргааны актад гаргах гомдолд тавигдах шаардлагыг тодорхойлохдоо ИТБАТГӨГШт хуулийн 10 дугаар зүйлийг ишлэсэн байгаа учир ЗЕХ-ийн дагуу гомдлыг хянан шийдвэрлэх харилцаанд уг хууль хэрэглэгдэж байна.

Засгийн газрын Иргэд, олон нийттэй харилцах төвд иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг харуулсан мэдээнээс[121] үзвэл улсын хэмжээнд 2014 оны 6 сараас 2015 оны 6 сарын хугацаанд 20468, 2015 оны 6 сараас 2016 оны 6 сарын хугацаанд 22773 өргөдөл, гомдол ирсэн. Үүнээс эдгээр хугацаануудад харгалзах 5295 ба 7430 нь “гомдол” байсан гэж ангилагджээ. Мөн ИТБАТГӨГШт хуулийн дагуу 2014-2016 онд иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтээс[122] үзвэл гэр, орон сууц хүссэн, орон сууцны зээл, мөнгөн тусламж, тэтгэвэр, тэтгэмж, барьцаагүй зээл, хөдөлмөр

[118] Захиргааны байгууллага ЗЕХ-ийн 57-д заасанаар захиргааны гэрээний биелэлтийг хангах үүрэгтэй бөгөөд гэрээний нөгөө тал болох иргэн, хуулийн этгээдээс үүргийн гүйцэтгэл шаардах бол мөн хуулийн Наймдугаар бүлэгт заасан шийдвэр гүйцэтгэх зохицуулалтыг хэрэглэнэ.
[119] Шүүхийн практикт ЗХШХШтХ-ийн 54.1.3-ийг зөвхөн захиргааны акттай холбогдуулан нэхэмжлэл гаргаж буй тохиолдолд хэрэглэж байгаа, учир нь ЗЕХ-ийн 92-94 дүгээр зүйл үйлчлэхээр заасан, түүнд нь зөвхөн захиргааны актад гомдол гаргах тухай зохицуулалт байгаа гэдэг үндэслэлээр.
[120] Жишээлбэл, “Япон Улсад төр, эсвэл нутгийн өөрөө удирдах байгууллагууд нь гэрээний тал байдаг гэж үздэг бөгөөд гэрээ байгуулж буй захиргааны байгууллагууд нь зөвхөн төлөөлөн захиргааны гэрээ байгуулах бөгөөд тухайн гэрээ байгуулсан захиргааны байгууллага нь гэрээгээр эрх, үүрэг хүлээхгүй бөгөөд уг эрх, үүрэг нь шууд төр эсвэл нутгийн өөрөө удирдах байгууллагад үүсдэг. Зөвхөн нутгийн өөрөө удирдах байгууллагын байгуулсан гэрээтэй холбогдуулж гуравдагч этгээд гомдол гаргаж болохоор Нутгийн өөрөө удирдах байгууллагын тухай хуульд тусгайлан заасан байдаг. Төрийн байгуулсан гэрээний хувьд гуравдагч этгээд шүүхэд гомдол гаргах боломж байхгүй. Гэвч гэрээнд захиргааны актын шинж байгаа тохиолдолд хүчингүй болгох нэхэмжлэл гаргаж болохыг үгүйсэхгүй.” Судалгааны явцад Япон Улсын Нагоягийн их сургуулийн Хуулийн сургуульд захиргааны гэрээний сэдвээр докторын сургалтанд хамрагдаж судалгаа хийж буй Г.Уянгатай хийсэн ярилцлагаас.
[121] ИТБАТГӨГШт хуулийн 19 дүгээр зүйлийн 2.Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад өргөдөл, гомдол шийдвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулж удирдах үүргийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хүлээнэ. Засгийн газрын 11-11 төвийн мэдээ.
[122] 11-11 төвд хандсан иргэдийн санал хүсэлтийн шийдвэрлэлтийн байдлыг тусад нь нэгтгэн Засгийн газрын хуралд танилцуулж байгаа гэх тул уг тайланд Засгийн газрын 11-11 төвийн мэдээг хасч тусгадаг байна.

эрхлэлт, газар эзэмших ашиглахтай холбоотой асуудлаар тавьсан хүсэлт[123] дийлэнх хувийг эзэлсэн харагдана.

ИТБАТГӨГШтХуулиар өргөдөл ба гомдол гэсэн хоёр ойлголтыг нэгтгэн зохицуулснаас, захиргааны актад гаргасан гомдол нь уг хуулийн өргөдлийг (санал, мэдэгдлийн шинжтэй) шийдвэрлэх зохицуулалтаар хамтатган шийдвэрлэгдэх нь нийтлэг байна гэсэн дүгнэлт хийж болохоор юм. Учир нь энэ хуульд гомдол[124]-ыг тодорхойлсон агуулга нь ЗЕХ-ийн захиргааны актад гомдол гаргах, түүнийг шийдвэрлэх журамтай "зэрэгцсэн" (давхацсан) зохицуулалттай байна. Гэхдээ гомдлыг шийдвэрлэх журам нь хэт ерөнхий бөгөөд санал, мэдэгдлийн шинжтэй өргөдлийг шийдвэрлэхтэй ижил зохицуулалттай байгаа юм. ЗЕХ-ийн захиргааны актад гомдол гаргах, түүнийг шийдвэрлэх зохицуулалт төдийлөн хэрэглэгдэхгүй байгаа нь ИТБАТГӨГШтХуулийг хэрэглэдэг гэх дээрх байдлаас шалтгаалж байж болох юм.

Зарим тохиолдолд ЗЕХ биш харин салбарын хууль тогтоомжоор эрх олгогдсоны дагуу батлагдсан хэм хэмжээний актаар гомдлыг шийдвэрлэх процесс журамласан, захиргаанаас уг журмыг илүүтэй хэрэглэх нь түгээмэл байна. Тухайлбал, Татварын маргаан таслах зөвлөл[125] нь Татварын ерөнхий хуульд зааснаар татварын байгууллага, улсын байцаагчийн шийдвэр (захиргааны акт) –тэй холбогдуулан гаргасан гомдлыг хянан шийдвэрлэх ганцхан гэж хэлж болох чиг үүрэгтэй, ЗЕХ-ийн 93 дугаар зүйлд заасан гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллага юм.

Маргаан таслах зөвлөл гэх байгууллагын үндсэн чиг үүрэг бол татвар төлөгчөөс татварын албаны акт, дүгнэлт гэсэн хоёр төрлийн шийдвэрт гаргасан гомдлыг шийдвэрлэх явдал юм. Энэ байгууллага гомдлыг хянан шийдвэрлэх замаар маргаан таслах буюу шүүх төст байгууллага (quasi-judicial organ). Энэ байгууллагын гомдол хүлээн авах, хянан шийдвэрлэх процесс, шийдвэрийн үндэслэлт байдал, маргаж байгаа талуудын байр суурийг хэрхэн үнэлж дүгнэсэн зэргээр үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж чадаж байна уу гэдэг нь хэмжигдэнэ.

МТЗ нь гомдол хянан шийдвэрлэх ажиллагааг хийхдээ аль хуулийн зохицуулалтыг нийтлэг хэрэглэж байгааг судалж үзэхэд "Татварын ерөнхий хууль, МТЗ-ийн ажиллах журам, Иргэдээс төрийн байгууллага албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх журмын тухай хууль, шаардлагатай тохиолдолд ЗЕХ-ийг хэрэглэж байгаа" гэсэн тайлбар хийгдэж байна. Үүнээс ИТБАТГӨГШтХуулийг гомдлыг хүлээж авах, буцаах гэх мэтэд харилцаанд хэрэглэгддэг гэх бөгөөд энэ нь Татварын ерөнхий хуульд уг хуулийг хэрэглэнэ гэж зохицуулсанаас[126] улбаатай аж.

Татварын ерөнхий хуульд Татварын алба болон Маргаан таслах зөвлөл нь уг хуулийн 72.1-д заасны дагуу гаргасан <u>гомдлыг хянан шийдвэрлэхдээ</u> Захиргааны ерөнхий хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Маргаан таслах зөвлөлийн ажиллах журмыг[127] хамтад нь дагаж мөрдөхөөр заасанаас үүдэн гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагаанд зэрэгцсэн олон хуулийн зохицуулалт хэрэглэгдэх мэт, улмаар Захиргааны ерөнхий хуульд заасан гомдлыг хянан шийдвэрлэх процессын зохицуулалт хэрэглэгдэхгүй байх нөхцлийг үүсгэж

---

[123] 2014-2016 онд иргэдээс төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тухай Танилцуулга, ЗГХЭГ.
[124] 4-р зүйлийн 4/"гомдол" гэж төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаагаар иргэдийн хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэж сэргээлгэхээр гаргасан хүсэлтийг;
[125] 2018 оны 05 сарын 04-ны өдөр ТЕГ, НТГ-ын дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн нарийн бичгийн дарга, магадлагч нартай хийсэн ярилцлага.
[126] Татварын ерөнхий хуулийн 72.3-д Татварын алба болон Маргаан таслах зөвлөл нь энэ хуулийн 72.1-д заасны дагуу гаргасан гомдлыг хянан шийдвэрлэхдээ энэ хууль, Захиргааны ерөнхий хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Маргааны таслах зөвлөлийн ажиллах журмыг дагаж мөрдөнө.
[127] Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 22 дугаар тогтоолоор батлагдсан Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журам нь зөвхөн "татварын акт, дүгнэлттэй холбоотой гомдлыг" хянан шийдвэрлэхэд үйлчилнэ.

Remove Watermark Now

байна. Түүнчлэн, Татварын ерөнхий хуульд гомдлыг хянан шийдвэрлэх процесс тусгагдаагүй, харин Маргаан таслах зөвлөлийн ажиллах журам Захиргааны ерөнхий хуулийн гомдлыг хянан шийдвэрлэх зохицуулалтын харилцан хамаарлыг судалж үзвэл уг журам нь гомдлыг хүлээж авах, талуудыг оролцуулах, гомдлыг шийдвэрлэх процессоос илүү маргаан таслах зөвлөлийн дотоод процесс түлхүү зохицуулагдсан байна.

Өмнө МТЗ-д хүчингүй болгуулах шаардлага бүхий гомдол ерөнхийдөө голчлон ирдэг байсан бол ЗЕХ хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш шийдвэр гаргах процесстэй холбоотой гомдол ирэх болсон байна.

МТЗ-ийн зэрэгцээ дээд шатны татварын алба, байцаагч нарт гомдол гаргах тохиолдол байдаг нь ажиглагдсан бөгөөд хэрэв хуулиар МТЗ-тэй зэрэгцүүлэн дээд шатанд МТЗ-ийн харьяаллын асуудлаар гомдол гаргах, түүнийг хүлээн авч шийдвэрлэх эрх хэмжээ олгосон эсхүл олгогдоогүй ч практикт хүлээж авч ямар нэг байдлаар шийдвэрлэдэг энэ байдлыг засахгүй бол гомдлыг шийдвэрлэх зэрэгцсэн процедур зөвшөөрөгдсөн мэт тодорхойгүй байдлыг нөхцөлдүүлжээ. Тухайлбал, Татварын ерөнхий хуулийн 72 дугаар зүйлийн 72.1.1 ба 72.1.3 –д татварын улсын байцаагчийн шийдвэртэй холбоотой гомдлыг тухайн байцаагчийг шууд харьяалах татварын албаны даргад болон албаны дэргэдэх Маргаан таслах зөвлөлд аль алинд зэрэгцүүлэн гаргаж болохоор хуульчилсан байна.

МТЗ шиг гомдол хянан шийдвэрлэх чиг үүргийг тусад нь байгууллага, бүтцэд хариуцуулсан салбарт захиргааны байгууллагын үндсэн тогтолцооны дээд шатны байгууллага, албан тушаалтанд доод шатны шийдвэрийг хянах эрх хэмжээ давхцуулан хуулиар олгохгүй байх, гагцхүү гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллага гомдлыг шийдвэрлэх эрхтэй гэсэн зохицуулалт ЗЕХ-д оруулах нь ач холбогдолтой байж болох юм.

pdfelement

Хүснэгт 13

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 95.1.Захиргааны байгууллага гомдлыг хянан шийдвэрлэх талаар дараах ажиллагаа явуулна:<br>95.1.1.захиргааны акт хууль тогтоомж болон зорилгодоо нийцсэн эсэхийг шалгах;<br>95.1.2.захиргааны байгууллага сонгох боломжоо хэрэглэсэн байдлыг шалгах;<br>95.1.3.гомдол гаргагч, түүний төлөөлөгч, өмгөөлөгч, шаардлагатай бол эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдсөн гуравдагч этгээдэд гомдлыг шийдвэрлэх он, сар, өдөр, газрыг урьдчилан мэдэгдэж, уг ажиллагаанд хүсэлтээр нь байлцуулах.<br>95.2.Энэ хуулийн 95.1.3-т заасан этгээд хүрэлцэн ирээгүй бол түүний оролцоогүйгээр гомдлыг хянан шийдвэрлэж болно.<br>95.3.Иргэн хүсэлт гаргасан, эсхүл захиргааны байгууллага шаардлагатай гэж үзвэл шинжээч томилон дүгнэлт гаргуулна. |
| **Томьёологдсон шалгуур үзүүлэлт** | 1.Гомдол хянан шийдвэрлэх ажиллагааг захиргааны байгууллага “хэрэглэх” хүсэл зорилго байгаа эсэх<br>2. Хэдэн гомдол гарсан, хэдийг нь шийдсэн, хэдэд нь ЗЕХ болон бусад хуульд заасан процессын дагуу ажиллагаа хийж шийдвэрлэсэн, Энэ ажиллагаа хий цаг алдсан, шат дамжлага үүсгэсэн ажил уу эсхүл хэрэгцээтэй юу?<br>3. Гэрч, шинжээчтэй холбогдолтой зохицуулалт хэрэгжиж байгаа эсэх, хэр давтамжтай хийгддэг талаар тоон үзүүлэлт гаргах. |

**Үнэлгээ:**

1. Нийслэлийн газрын албатай хийсэн ярилцлагын хүрээнд гомдол хянан шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлэх талаар ямар чармайлт гарч байгааг тодруулахад

Remove Watermark Now

дотоод хяналт хариуцсан ажилтнууд гомдлыг (газар зохион байгуулагч, мэргэжилтнүүдийн газрын мэдээллийн санд зураг оруулах, өөрчлөх гэх мэт шийдвэрт) хүлээн авч ёс зүйн хороогоор шийдвэрлэдэг гэж тайлбарласан. Эдгээр ажлын байрны тодорхойлолтоос үзвэл, төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой (сахилгын хариуцлага ногдуулах) гомдлыг Захиргааны ерөнхий хуулийн 92 дугаар зүйлд заасны дагуу захиргааны актад нь гарсан гомдлыг хянан шийдвэрлэх этгээд, нэг ижил арга журмаар шийдвэрлэдэг тохиолдол байгаад байна. Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо зэрэг байгууллагатай хийсэн ярилцлагын дүнд тухайн байгууллагад гаргасан гомдлыг шийдвэрлэхэд ЗЕХ-ийн 95-99 дүгээр зүйлд заасан журмыг хэрэглэх талаар ойлголт тогтоогүй, гомдол шийдвэрлэх ажлыг эрхлэх чиг үүрэг бүхий албан тушаалтнууд тодорхойгүй байна.

2. Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ЗДТГ-ын 2017 оны мэдээгээр[128] өргөдөл, гомдол хэмээн хамтад нь гаргасан байх боловч хэд нь сумын захиргааны байгууллагын шийдвэр (захиргааны акт)-т гаргасан гомдол гэдэг нь тодорхойгүй, дийлэнх хувийг нь нийгмийн халамж, иргэний бичиг баримтын зөрчил арилгуулах, шагнуулах хүсэлттэй өргөдөл байна.

Аймгийн хувьд, 2009 онд Сүхбаатар аймгийн Засаг дарга Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай (ИТБАТГӨГШтХ) хууль болон Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоолыг[129] үндэслэн "Аймгийн Засаг дарга, Тамгын газарт иргэд, албан байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдлыг хүлээн авч хянан шийдвэрлэх журам"[130] шинэчлэн баталсан байна. Уг журмын агуулга, зохицуулалт нь өргөдөл ба гомдлыг ялгасан зүйл үгүй, хуулийн зохицуулалтыг давтсан шинжтэй. ЗЕХ-д нийцүүлэн шинэчилсэн зүйл үгүй байна.

Сүхбаатар аймагт халамжийн үйлчилгээ авах хүсэлтийн шинжтэй өргөдөл нийтлэг байдаг, гомдол цөөн байдаг гэсэн нь тус аймгийн ЗДТГ-ын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээгээр илэрхийлэгдэж[131] байна. Ингэхдээ эдгээр тайланд аль байгууллагын ямар шийдвэрт гомдол гарсан, шийдвэрлэлт зэргийн талаар тодорхой мэдээлэл тусгагдаагүй байна. Сүхбаатар аймагт хийсэн уулзалт, ярилцлагын үеэр захиргааны актад гомдол гардаггүй гэсэн хариултыг өгөх нь элбэг байсан, гомдол гарахгүй байна уу эсхүл гомдол гаргах эрх, хэрхэн гомдол гаргахаа мэдэхгүй байна уу гэдэг нь цаашид гүнзгийрүүлэн судлах асуудал байна.

Сүхбаатар аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх Гомдлын шаардлагын зөвлөлийн мэдээнээс үзвэл 2017 онд Нийгмийн даатгалын хэлтсийн чиг үүрэг, шийдвэртэй холбоотой 7 гомдол (ихэвчлэн тэтгэмж шийдвэрлүүлэх) хүлээж авсныг 2017 оны 6, 12 сард тус бүр 1 удаа нийт 2 удаа хуралдаанаар[132] хэлэлцэж, гомдлыг хэлэлцэх хуралдаанд зарим гомдол гаргагчийг оролцуулан хэлэлцсэн ажээ. Үүнээс дүгнэвэл гомдлыг тухай бүр хэлэлцэхгүй байгаа нь гомдлыг шийдвэрлэх хугацааны зохицуулалтыг дагахгүй байгааг илтгэнэ.

<u>Дүгнэлт:</u> Маргаан таслах, гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллагаас бусад тохиолдолд буюу энэ судалгаанд хамрагдсан дээд шатны захиргааны байгууллага гомдлыг ЗЕХ болон бусад хуульд заасан процессын дагуу

[128] Баруун-Урт сумын ЗДТГ-т 2017 онд иргэдээс бичгээр ирсэн өргөдөл, гомдлын агуулга, биелэгдсэн байдал гэсэн 2017 оны 12 –р сарын 25-ны өдрөөр огноолсон, мэргэжилтэн Д.Сумьяа гаргасан судалгаа

[129] http://legalinfo.mn/law/details/3022?lawid=3022 Өмнө нь "Хуулийн хэрэгжилтийг зохион байгуулахтай холбогдсон зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1995 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн 222 дугаар тогтоол үйлчилж байсан.

[130] 2009 оны 9 дүгээр сарын 01-ны өдрийн 352 дугаар захирамжаар

[131] Тус аймагт 2017 онд иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл гомдлын судалгаа тайлангаас[131] үзвэл 1 дүгээр улирлын нийт 1367 байгаагаас 2 буюу 0,07% нь гомдол, 2 дугаар улиралд нийт 864 байгаагаас 3 нь гомдол, 3 дугаар улиралд нийт 2093 байгаагаас 3 нь гомдол, 2018 оны 1 дүгээр улиралд нийт 724 байгаагаас 0 гомдол байсан ажээ.

[132] Сүхбаатар аймгийн НДХ-ийн дэргэдэх ГШЗ-ийн 2017 онд хийсэн ажлын нэгтгэлийн баримт

Remove Watermark Now

ажиллагаа хийж шийдвэрлэх талаар төдийлөн хүч чармайлт гаргахгүй байна гэж дүгнэж[133] болохоор ажээ.

3. Татварын МТЗ-ийн хувьд гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрч асуусан тохиолдол байхгүй гэх бөгөөд шинжээчийн хувьд маргаан таслах зөвлөлийн магадлагч нар нь санхүү, эдийн засаг, хуулийн мэргэжлийн хүмүүс байх шалгууртай тул шинжээчийн үүргийг эдгээр магадлагч нар гүйцэтгэдэг гэж үзэж болох юм.[134]

Хүснэгт 14

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 95.4.1.захиргааны акт гаргаж байгаа байгууллагын нэр, хаяг, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр болон өөрийн нэр;<br>95.4.2.захиргааны акт гаргасан, гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулсан он, сар, өдөр, газар;<br>95.4.3.гомдол гаргагч, хариуцагч, бусад оролцогчийн эцэг, /эх/-ийн нэр болон өөрийн нэр;<br>95.4.4.гомдлын агуулга, шаардлага;<br>95.4.5.мэргэжлийн байгууллага болон шинжээчийн дүгнэлт, гэрчийн мэдүүлэг, бусад нотлох баримт;<br>95.4.6.тэмдэглэл хөтөлсөн болон гомдлыг шийдвэрлэсэн албан тушаалтан, захиргааны байгууллагын эрх баригчийн гарын үсэг.<br>98-р зүйл 98.1.1-1.5,<br>98.1.1.захиргааны акт илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрөх;<br>98.1.2.гомдол гаргагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол уг захиргааны актыг бүхэлд нь, эсхүл холбогдох хэсгийг хүчингүй болгох;<br>98.1.3.захиргааны байгууллагын эс үйлдэхүй нь иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол захиргааны зохих акт гаргахыг тухайн захиргааны байгууллагад даалгах;<br>98.1.4.захиргааны актыг өөрчлөх;<br>98.1.5.захиргааны актыг хэвээр үлдээх. |
| **Томьёологдсон шалгуур үзүүлэлт** | Захиргааны акттай холбоотой гомдол /нэхэмжлэл/-ын шаардлагаас хамаарсан зохицуулалт шаардлагатай эсэх, тухайлбал даалгах шаардлага /95.4.4/ |

pdfelement

**Үнэлгээ:**

ЗЕХ-д дээд шатны байгууллагын эсхүл гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллагаас гомдлыг шийдвэрлээд гаргах шийдвэрийн төрлийг 98 дугаар зүйлд зааж өгсөн боловч гомдлын шаардлагын төрлийг[135] тодорхой зохицуулаагүй билээ.

Захиргааны байгууллагын шийдвэртэй холбогдуулан гомдол гаргах харилцаанд "даалгах шаардлага" бүхий гомдол гаргасан тохиолдол судалгаанд хамрагдсан байгууллагын хүрээнд илэрсэн. Харин гомдлыг хянан үзээд "зохих акт гаргахыг даалгах" шийдвэрийн төрлийг гаргаж болохоор ЗЕХ-ийн 98 дугаар зүйлийн 98.1.3-т зохицуулахдаа энэ төрлийн шийдвэр гаргахад хангагдсан байх урьдчилсан нөхцлийг "эс үйлдэхүй" байхаар заасан нь зөрчилтэй болжээ. Үүнээс үүдэн "зохих акт гаргахыг даалгах" шаардлага бүхий гомдолд "эс үйлдэхүй" байхгүй гэдэг үндэслэлээр шийдсэн тохиолдол[136] байна.

[133] Иргэдээс авсан судалгааны "Таны гомдлыг шийдвэрлэхдээ өөрийг тань оролцуулж, гомдлыг шийдвэрлэхэд байлцуулсан уу?" гэсэн асуултад 181 иргэн хамрагдсанаас 78 тийм, 103 үгүй гэж хариулсан байсан.
[134] Иргэдээс авсан судалгааны "Таны гомдлыг шийдвэрлэхдээ бусдыг гэрчээр дуудах, шинжээчээр томилох ажиллагаа хийж байсан уу?" гэсэн асуултад 179 иргэн хамрагдсанаас 38 тийм, 141 үгүй гэж хариулсан байсан.
[135] ЗЕХ-ийн 95 дугаар зүйлийн 95.4.4-д ...............
[136] ДТҮ ХК 2018 оны 2 дугаар сарын 01-ны 1-1Ю/0261, түүнд ТЕГ-аас өгсөн хариу

Remove Watermark Now

Мөн гомдлын шаардлагын төрлүүдийн хоорондын ялгааг сайтар гаргахгүйгээр[137] гомдол гаргах нь тохиолдоно. Тухайлбал “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК-аас ТЕГ-ын Улсын төсвийн орлого хяналтын газрын албан бичигтэй холбогдуулан ТЕГ-т ирүүлсэн гомдолд энэ талаар дурдагдсан байна. Үүний сацуу МТЗ-тэй хийсэн ярилцлагын дүнд дээд шатны захиргааны байгууллагад хандаж гаргах гомдлын шаардлагын төрөл олширсон, энэ нь ЗЕХ-д гомдлыг хянан үзээд гаргах шийдвэрийн төрлүүдийг 98 дугаар зүйлд зааснаас тодорхой хэмжээнд улбаалсан гэж дүгнэхээр байна. Учир нь өмнө нь хүчингүй болгож өгнө үү гэсэн нэг л гомдлын шаардлага зонхилдог байсан бол өдгөө хэдийгээр ховор боловч даалгах, илт хууль бус болохыг тогтоолгох гэх мэт гомдлын шаардлага цөөнгүй гаргах болсон нь тогтоогдсон. Жишээ нь “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ХК-аас ТЕГ-ын дэргэдэх МТЗ-д хандаж гаргасан өөр нэг гомдолд[138] татварын улсын байцаагчийн актыг ЗЕХ-ийн 92 дугаар зүйлийн 92.1-ийг ишлэн мөн хуулийн 98 дугаар зүйлийн 98.1.1-д заасан шийдвэрийн төрөл буюу илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрүүлэх (илт хүчин төгөлдөр бусад тооцуулах) шаардлага бүхий гомдол гаргасан байна. “Просетрийл эстейт” ХХК нь татварын дээд шатны байгууллагад хандаж “НӨАТ-ийн илүү төлөлтөө буцааж олгуулах” шаардлага бүхий гомдол гаргасан байна.

Хүснэгт 15

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 95.5.Гомдол гаргагчийн хүсэлтийг хангаж шийдвэрлэхээр бол энэ хуулийн 95.4 дэх хэсэг үйлчлэхгүй бөгөөд гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллага захиргааны актыг шууд гаргаж болно.<br>95.6.Шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 95.1, 95.2, 95.3, 95.4-т заасан ажиллагаанд холбогдуулан гаргасан гомдлын талаар гомдол хянан шийдвэрлэх ажиллагаа явуулна.<br>95.7.Гомдол гаргагчийн хүсэлтийг захиргааны байгууллага хүлээн зөвшөөрч өөрөө шийдвэрлэж болно.<br>95.8.Хамтын удирдлага бүхий захиргааны байгууллага гомдлыг хэлэлцсэн бол асуудал шийдвэрлэх ердийн журмыг баримтлан захиргааны акт гаргана.<br>95.9.Гомдлыг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий захиргааны байгууллага гомдлыг шийдвэрлүүлэхээр бусдад шилжүүлэхийг хориглоно. |
| **Томьёологдсон шалгуур үзүүлэлт** | 1. Маргаан таслах байгууллагаас бусад дээд шатны байгууллага, албан тушаалтан бодитоор гомдлыг шүүхээс өмнө урьдчилан шийдвэрлэх /шалган тогтоох цаг хугацаа, хүн хүч, төсөв, эрмэлзэл/ боломжтой эсэх<br>2. Гомдлыг хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий захиргааны байгууллага гомдлыг шийдвэрлүүлэхээр бусдад шилжүүлэхийг хориглосон зохицуулалт ЗЕХ-аас өмнөх үетэй харьцуулбал тохиолдож буй давтамжийг судлах. |

pdfelement

**Үнэлгээ:**

1. Судалгааны ажлын явцад дээрх асуулт дээд шатны байгууллага, албан тушаалтнаар тогтохгүй гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллагад[139] хүртэл хамааралтай болох нь харагдав. Татварын маргаан таслах зөвлөл, Төрийн албаны зөвлөл, Нийгмийн даатгалын гомдлын шаардлагын зөвлөл зэрэг ЗЕХ-ийн 93 дугаар

[137] Мөн өөр нэг тохиолдолд Трансинконсулт ХХК-ийн гомдолд татварын актыг “илт хууль бус болохыг тогтоолгож хүчингүй болгуулах” хэмээн гомдлыг шаардлагаа тодорхойлсон байгаагаас үзвэл гомдлын шаардлагын төрлийг ялгахгүй, эсхүл нэгтгэж гаргах зэрэг байдал нь уг гомдлыг шийдвэрлэх этгээдэд аль төрлийн гомдлын шаардлага гэж үзэж ЗЕХ№ийн 98.1-д заасан аль шийдвэрийг гарах нь тодорхойгүй болох, эргэлзээтэй нөхцөл үүсгэж болохоор байна.

[138] МТЗ хийсэн ярилцлагын хүрээнд цуглуулсан баримтад судлагдсан ................

[139] Төрийн албаны салбар зөвлөлийг гомдол гаргаж буй маргаан бүхий шийдвэрийг гаргасан албан тушаалтан тэргүүлж байгаа нь энэ ажиллагаа ЗЕХ-ийн зорьсончлон бодитой, үр дүнтэй байж чадах эсэхэд эргэлзээ төрүүлж байна.

Remove Watermark Now

зүйлийн 93.1-д заасан гомдол хянан шийдвэрлэх тухайлсан чиг үүрэг бүхий байгууллагын судалгааг хавсралтаас[140] үзнэ үү.

Тухайлбал, татварын маргаан таслах зөвлөлийн магадлагч нар татвар төлөгчийн гомдлыг зохих журмын дагуу ажиллагаа хийж амждаггүй, хугацаа хэтрэлт ихтэй, 60 (30+30) хоногийн хугацаа богино, энэ хугацаанд шалгаж шийдвэрлэх боломжгүй байдаг нь хүний нөөц дутмагтай холбоотой ажээ.

Түүнчлэн, Нийслэлийн газрын албанд дотоод хяналтын чиг үүрэг бүхий хоёр албан тушаалын байр шинээр бий болгосон гэх бөгөөд тэдгээрийн чиг үүрэг нь газар зохион байгуулалттай холбоотой гарсан гомдлыг хянан шийдвэрлэх явдал хэмээн тайлбарлаж байна. Гэвч эдгээр албан тушаалын чиг үүрэгт ажилтны ёс зүйн талаарх гомдлыг тэдний шийдвэртэй холбогдуулж гаргасан гомдолтой ижилтгэн шийдвэрлэх хандлага байна.

2. ЗЕХ-ийн 95 дугаар зүйлийн 95.9-ийн зохицуулалттай ойролцоо агуулга бүхий “тухайн байгууллага, албан тушаалтан өөрийн эрх хэмжээнд хамаарах өргөдөл, гомдлыг үндэслэлгүйгээр өөр байгууллага, албан тушаалтанд шилжүүлж болохгүй” гэсэн зохицуулалт ИТБАТГӨГШт хуулийн 7 дугаар зүйлийн 2 –д тусгагдан үйлчилж ирсэн. Хэдий тийм ч гомдлыг хянан шийдвэрлэх практикт тодорхой захиргааны шийдвэрт гаргасан гомдлыг хүлээн авсан дээд шатны захиргааны байгууллага өөрөө уг гомдлыг хянан шийдвэрлэх чиг үүргээ хэрэгжүүлэлгүй, харин тэрхүү доод шатны захиргаанд өөрөөр нь шийдвэрлүүлэхээр шилжүүлэх нь нийтлэг байсан.

Судалгааны явцад хамрагдсан байгууллагуудын жишээнээс тухайлбал, “Дархан төмөрлөгийн үйлдвэр” ХК-аас ТЕГ-ын Улсын төсвийн орлого хяналтын газрын албан бичигтэй холбогдуулан ТЕГ-т ирүүлсэн гомдол буюу МТЗ-д гаргадгаас өөр төрлийн гомдлын жишээн дээр авч үзье.

pdfelement

Энэхүү акт нь татварын акт, дүгнэлт гэх мэт МТЗ-д харьяалагдан гомдол гаргавал зохих акт биш боловч татвар төлөгчийн тодорхой хүсэлтэд татгалзсан хариу өгсөн акт гэж үзвэл УТОХГ-ын татгалзалд ТЕГ-т гомдол гаргах боломжтой, өөрөөр хэлбэл энэ төрлийн захиргааны актад МТЗ биш ТЕГ гэх мэт дээд шатны захиргаанд хандаж гомдол гаргаж болно. Харин уг гомдолд хариу өгсөн буюу шийдвэрлэсэн агуулгатай албан бичиг нь ТЕГ-ыг төлөөлж доод шатны байгууллагын шийдвэрт гаргасан гомдлыг шийдвэрлэх эрх бүхий этгээд нь Хуулийн хэрэгжилтийг хангах газрын дарга биш энэ нь ЗЕХ-ийн 95 дугаар зүйлийн 95.9-д заасан хориглолтыг зөрчсөн шинжтэй байна.

Нөгөө талаар, энэ төрлийн харилцаанд гомдол гаргаж буй этгээд нь ч “гомдол” гэж томьёолохгүй, гомдлыг шийдвэрлэж буй тал ч “гомдлыг шийдвэрлэж буй шийдвэр” гэсэн агуулгаар бус “албан бичигт хариу” өгч байна гэдэг агуулгаар хандаж байгаа нь энэ ажиллагааг гомдлыг шийдвэрлэсэн гэж үзэх, тооцох эсэхэд эргэлзээтэй, тодорхойгүй байдал үүсгэж байна.

Түүнчлэн, гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллагаас бусад дээд шатны байгууллагаас явуулж буй гомдол шийдвэрлэх ажиллагаанд ЗЕХ-ийн 95 дугаар зүйлд заасан журам хэрэглэгдэхгүй, зөвхөн “гомдолд үндэслэн хариу өгөх” байдлаар процесс нь явагдаж байна гэж дүгнэхээр байна.[141]

Хүснэгт 16

| | |
|---|---|
| **Үнэлэгдэх хэсэг** | 98.1.Энэ хуулийн 93 дугаар зүйлд заасан захиргааны байгууллага гомдлыг хянан үзээд дараах захиргааны актын аль нэгийг гаргана:<br>98.1.1.захиргааны акт илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрөх; |

[140] Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт газрын зөрчил арилгахаар албадан буулгалт хийсэн ажлын протоколтой дэлгэрүүлж танилцана уу.
[141] Иргэдээс авсан судалгааны “Таны гомдлыг өөрөө шийдвэрлэлгүй бусдад шилжүүлсэн тохиолдол бий юу?” гэсэн асуултад 185 иргэн хамрагдсанаас 54 тийм, 131 үгүй гэж хариулсан байсан.

Remove Watermark Now

| | |
|---|---|
| | 98.1.2.гомдол гаргагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол уг захиргааны актыг бүхэлд нь, эсхүл холбогдох хэсгийг хүчингүй болгох;<br>98.1.3.захиргааны байгууллагын эс үйлдэхүй нь иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол захиргааны зохих акт гаргахыг тухайн захиргааны байгууллагад даалгах;<br>98.1.4.захиргааны актыг өөрчлөх;<br>98.1.5.захиргааны актыг хэвээр үлдээх. |
| **Томьёологдсон шалгуур үзүүлэлт** | 98.1–ийн тохиолдолд "захиргааны акт" гэж томьёолсон нь зөв эсэх. Гомдлыг хангаагүй тохиолдолд үндсэн /original/ захиргааны актаас тусдаа үр дагавар гаргаж чадах эсэх |

**Үнэлгээ:**

Гомдлыг хянан шийдвэрлээд гаргасан шийдвэр нь бие даасан акт болох эсэх талаар ЗЕХ-аас өмнө шүүхийн практикт маргаантай байсан, бие даасан акт гэж үзэхгүй байх нь элбэг байсан. Харин ЗЕХ-ийн 98 дугаар зүйлийн зохицуулалтаар энэ нь захиргааны акт байхаар томьёологдсон. Гэвч гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллага эсхүл дээд шатны захиргааны байгууллага гомдлыг хангаагүй тохиолдолд гарч буй шийдвэр нь үндсэн захиргааны актаас тусдаа үр дагавар гаргах эсэх нь одоо ч тодорхойгүй байна. Захиргааны хэргийн шүүхийн одоогийн практикт ч гэсэн урьдчилан шийдвэрлүүлэх шаардлагыг биелүүлэх замаар гомдлоо дээд шатаар шийдвэрлүүлсэн шийдвэрийг нэхэмжлэлийн тусдаа шаардлага болгон гаргах нь ховор байна, шүүх ч тусдаа акт гэж үзэж уг нэхэмжлэлийн шаардлагад холбогдуулан хэрэг үүсгэхгүй байна.

## ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ:

**5-р бүлгийн дүгнэлт**

-Захиргааны гэрээ байгуулах эрхийг хуульчилсан байдлыг МУ-ын хуулиудад шинжилгээ хийж үзвэл 1/зөвхөн захиргааны гэрээ байгуулах эрхийг заасан, 2/гэрээний зохицуулалтыг тодорхойлон заасан, 3/тодорхой зохицуулалтгүй ч чиг үүрэг хэрэгжүүлэх хүрээнд гэрээ байгуулах эрх олгогдсон гэж үзэж болох гэсэн 3 ангилалд хувааж болохоор байна.

pdfelement

-Судалгаа хийсэн дээрх байгууллагуудын байгуулсан гэрээнд дүн шинжилгээ хийж үзвэл ЗЕХ-ийн 52.2-т заасан харилцаанд буюу төрийн алба, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, газрын харилцаа, нийгмийн халамж, даатгал зэрэг харилцаанд захиргааны гэрээ байгуулагдсан байна.

-ЗЕХ хэрэгжиж эхэлснээс хойших байгуулсан гэрээнд ЗЕХ-ийн холбогдох заалтыг үндэслээгүй, захиргааны байгууллага тэгш эрхийн харилцаа /иргэний эрх зүйн/, эсхүл нийтийн эрх зүйн харилцаанд захиргааны гэрээ байгуулж байгаа эсэх тухай төрөлжүүлээгүй, мөн ЗЕХ-тай холбогдуулан байгуулсан гэрээний загварт өөрчлөлт ороогүй харвал захиргааны гэрээний тухай ойлголт хэвшээгүй, тухайн салбарын хууль болон өмнө нь хэрэгжүүлж ирсэн туршлагаар дээрх харилцаа үргэлжилж байна.

-Захиргааны байгууллагын зүгээс өөрийнхөө чиг үүргийг өөр этгээдэд шилжүүлэхтэй холбогдсон харилцаанд ЗЕХ-ийн 8.1-ийн "Хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно" гэсэн хориглосон хэм хэмжээг харгалзан үзэх ёстой.

-Захиргааны ерөнхий хуулийн 52.2.4-т концессын харилцаанд захиргааны гэрээг хэрэглэж болно хэмээн шууд үүрэг болгоогүй сонгох боломжит хувилбараар тусгажээ. Практикт талуудын хооронд үүссэн маргаанаа "шүүх"-ээр шийдвэрлүүлэх зохицуулалт бүхий концессын гэрээ ихэвчлэн байгуулагдсан байна.

Remove Watermark Now

-Дүн шинжилгээ хийсэн гэрээний хувьд талуудын эрх, үүргийг зохицуулсан байх боловч үүргийн зөрчил, түүнийг шийдвэрлэх арга замыг нарийвчилсан зохицуулалт агуулаагүй байв.

-Судалгааны хүрээнд судлагдсан захиргааны гэрээнүүдийн хувьд ЗЕХ-ийн 55.1.14-ийн дагуу илт хууль бусад тооцогдож болохуйц гэрээнүүд багагүй байна.

-Захиргааны гэрээтэй холбоотой маргаан шүүхийн практикт цөөн боловч гарч байна. Одоогоор дийлэнх маргаан шүүхийн шатанд, эцэслэн шийдвэрлэгдээгүй буй тул дүгнэлт хийх боломжгүй байна.

Нэгтгэн дүгнэвэл, захиргааны гэрээний ухагдахууныг хуульчилсан зорилго нь ач холбогдолтой, практикт захиргааны гэрээ байгуулах замаар захиргааны байгууллагууд чиг үүргээ хэрэгжүүлж буй боловч ЗЕХ-ийн захиргааны гэрээний талаарх зохицуулалт тухайн гэрээнүүдэд “хэрэглэгдэж” буй нь цөөн байна.  Мөн түүнчлэн, ЗЕХ-ийн гэрээний талаарх зохицуулалт зорилгодоо хүрсэн түвшинг тодорхойлоход цаг хугацааны хувьд эрт байна. Учир нь ЗЕХ-ийн гэрээний зохицуулалтын зорилгод хүрсэн түвшин нь тухайн хууль хүчин төгөлдөр мөрдөгдсөнөөс хойш байгуулагдсан гэрээний талаарх маргаан шүүхээр шийдвэрлэгдэж, уг маргаанд тэдгээр гэрээнүүдэд ЗЕХ-ийн зохицуулалт хэрэглэгдсэн, уг зохицуулалтад нийцсэн эсэхээс хамаарч гарсан шийдвэрээр захиргааны үйл ажиллагааны гэн хэлбэр болох захиргааны гэрээг зохицуулах гэж зорьсон зорилго биелж буй түвшин тогтоогдох юм.

Зөвлөмж: ЗЕХ-ийн захиргааны гэрээний зохицуулалтыг практикт хийгдэж буй гэрээнд хэрэглэхийг (наад зах нь тавигдах шаардлага хангах) захиргааны байгууллагуудад таниулах хэрэгцээ, шаардлага тулгамдаж байна. ЗЕХ-ийн захиргааны гэрээтэй холбогдох зохицуулалтад зайлшгүй нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох шаардлагагүй байна.

**8-р бүлгийн дүгнэлт:**

pdfelement

-ЗЕХ-ийн 8 дугаар бүлгийн зохицуулалтын агуулгаас үзвэл мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасан захиргааны шийдвэрийн төрлүүдээс “захиргааны акт” -ыг гүйцэтгэх журмыг илүүтэйгээр зохицуулсанаас болоод мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасан бусад захиргааны шийдвэрүүд ялангуяа “захиргааны гэрээ” -ний гүйцэтгэлийг хэрхэх нь тодорхойгүй орхигдсон байна.

-Уулзалт, ярилцлагын үед судалгаанд хамрагдсан байгууллага ЗЕХ-ийн захиргааны шийдвэр гүйцэтгэлийн харилцааг зохицуулсан бүлгийг хэрэглэдэггүй нь тодорхой харагдсан. Захиргааны байгууллагууд ЗЕХ-ийн захиргааны шийдвэр гүйцэтгэлийн зохицуулалтыг хэрэглэх гэхээс илүүтэй ийм боломж, зохицуулалт байгааг мэдэхгүй нь элбэг тохиолдож байна. Үүнээс үүдээд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг байгууллагын дотоод журам, эсхүл ажилтны үзэмжээр явуулснаас хожим нь захиргааны шийдвэр гүйцэтгэл нь эрх зүйн зөрчилтэйд тооцогдох магадлал өндөр байна.

-ЗЕХ-д заасан албадлага хэрэглэх шийдвэр гаргадаггүй, хугацааг баримталдаггүй тухайлбал газар албадан чөлөөлөх мэдэгдэл, шаардлага өгснөөс хойш албадлага хэрэглэх тогтсон хугацаагүй, ЗЕХ-ийг хэрэглэдэггүй байдал тогтоогдсон.

-Захиргааны шийдвэр гүйцэтгэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмж, тухайлбал газар чөлөөлөх, албадан буулгах техник хэрэгсэл, зөөж тээвэрлэх автомашин, тоног төхөөрөмж тухайн шийдвэр гүйцэтгэх үүрэг бүхий байгууллагын өөрийн өмчлөл, мэдэлд байхгүй байгаа нь энэ чиг үүргийг хэрэгжүүлэхэд саад болж байна.

-Захиргааны шийдвэр гүйцэтгэлийн хэрэгжилтийг хариуцсан ажлын байр тодорхойгүй, орон тоо, төсөв хөрөнгө нь хүрэлцээ муутай, байгууллагын бүтэц, ажилтны ажлын байрны тодорхойлолтод “шийдвэр гүйцэтгэх” чиг үүргийн талаар тодорхой зааж өгдөггүй байдлыг засах шаардлагатай байна.

Remove Watermark Now

-Түүнчлэн, ЗЕХ-ийн 65 дугаар зүйлд зааснаар захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй журмыг захиргааны шийдвэр гүйцэтгэлд хэрэглэдэг тохиолдол байна. Тэдгээрийг улсын нэгдсэн бүртгэлд шинэчлэн бүртгүүлэх шаардлагатай, ингэснээр газар чөлөөлөх шийдвэрийг гүйцэтгэх үйл ажиллагаа нь ЗЕХ-ийн шийдвэр гүйцэтгэлийн зохицуулалтад нийцэх боломжтой болох юм.

-ЗЕХ-ийн 84 дүгээр зүйлийн 84.1.3, 84.2-ийн зохицуулалтад мөн хуулийн 10 дугаар зүйлийн “захиргааны байгууллагын харилцан туслах үүрэг”–тэй зөрчилдөөгүй, харин ч бие биенээ нөхцөлдүүлсэн шинжтэй уялдаа бүхий байна.

-Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулах хуулийн зохицуулалт дутмаг, бусад байгууллагатай хамтран ажиллахад хүндрэл үүсдэг гэх зэрэг тайлбар гаргах хэдий ч тэдгээрт хэрэглэж болох захиргааны шийдвэр гүйцэтгэлийн талаарх ЗЕХ-ийн зохицуулалт байгааг мэдэхгүй, энэ зохицуулалтыг хэрэглэхгүй байгаа нь харагдаж байна.

-Захиргааны шийдвэр гүйцэтгэлд бусад төрийн байгууллагуудтай хамтран ажилладаг тохиолдол практикт байх боловч ЗЕХ-ийн 10, 84.1.3, 84.2 –ийн зохицуулалтыг үндэслэдэггүй. Ийм зохицуулалт байгааг мэдээгүй байдалтай байна.

-ЗЕХ-ийн 90 дүгээр зүйлийн 90.1-д “мэдэгдэлд заасан хугацаанд үүргийг биелүүлээгүй бол ... албадлага хэрэглэхийг шийдвэрлэсэн захиргааны акт гарган, нэн даруй” биелүүлэхээр заасан боловч мөн зүйлийн 90.2-т уг актад гомдол гаргаж болохоор байгаа нь зөрчилдөж байна. Өөрөөр хэлбэл, нэн даруй биелүүлэх зохицуулалт хэрэгжих боломжгүй. Тиймээс нэн даруй биелүүлэх зохицуулалтыг хангахын тулд шийдвэр гүйцэтгэл хийгдэхдээ хууль болон үүрэг хүлээгчийн эрх зөрчигдсөн гэж үзвэл нөхөж гомдол гаргаж тогтоолгох боломжтой байхаар өөрчлөлт оруулж болох юм.

Нэгтгэн дүгнэвэл, захиргааны шийдвэр гүйцэтгэлийг хуульчилсан зорилго нь ач холбогдолтой, судалгаанд хамрагдсан байгууллагын нөхцөл байдалд жишээлэн дүгнэвэл практикт ЗЕХ-ийн шийдвэр гүйцэтгэлийн зохицуулалт хэрэглэгдэхгүй байна. Мөн түүнчлэн, ЗЕХ-ийн шийдвэр гүйцэтгэлийн талаарх зохицуулалт зорилгодоо хүрэхгүй байгаагийн шалтгаан нь захиргааны байгууллага энэ боломж, зохицуулалтын талаар мэдэхгүй, ЗЕХ хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны талаар маргаан гарч, шүүх шийдвэрлэсэн нь ховор байгаад оршиж байна.

Зөвлөмж: ЗЕХ-ийн 8-р бүлгийн бүлгийн зохицуулалт нь нийтлэг байдлаар захиргааны бүх төрлийн шийдвэрийг гүйцэтгэх журмыг тодорхойлоход зорьсон болохыг илүү тодорхой болгож, энэ агуулгаар захиргааны актыг онцлон заасан хэсгүүдэд өөрчлөлт оруулах саналтай байна. Түүнчлэн, Захиргааны байгууллагуудад ЗЕХ-ийн захиргааны шийдвэр гүйцэтгэлийн зохицуулалтыг таниулах сургалт, мэдээлэл өгөх нь уг зохицуулалт хэрэглэгдэх, улмаар ЗЕХ-д шийдвэр гүйцэтгэлийг зохицуулж өгсний зорилгод хүрэхээр байна.

**9-р бүлгийн дүгнэлт**

-ЗЕХ-ийн 92-99 –р зүйлийн зохицуулалт захиргааны гэрээтэй холбогдуулан гомдол гаргах харилцааг зохицуулаагүй гагцхүү захиргааны актад гомдол гаргах, уг гомдлыг хянан шийдвэрлэх журмыг тогтооход зорьсон болох нь тодорхой. Гэрээний талууд, ялангуяа захиргааны нөгөө тал буюу иргэн, хуулийн этгээд гэрээний тал болсон захиргааны дээд шатанд гомдол гаргах эрх байх уу гэсэн асуулт тодорхой зохицуулалтгүй байна.

-Гэрээтэй холбоотой маргаан гарсан тохиолдолд шүүх нэхэмжлэлийн шаардлага нь захиргааны акт эсхүл гэрээ байхыг ялгахгүйгээр урьдчилан шийдвэрлүүлсэн байхыг

Remove Watermark Now

шаардах[142] тул ЗЕХ-д гэрээтэй холбогдуулж урьдчилан шийдвэрлүүлэх журмаар гомдол гаргах шаардлага тавигдах эсэх талаар зохицуулалт хийх нь зайлшгүй юм.

-Түүнчлэн, гэрээний тал биш гуравдагч этгээд захиргааны гэрээний зохицуулалттай холбогдуулж маргах тохиолдлын талаар ЗЕХ-д зохицуулалт хэрэгтэй байна. Ингэхдээ ЗЕХ-ийн 9 дүгээр бүлгийн зохицуулалтыг хэрэглэхээр нэмэлт оруулах шаардлагатай юу эсхүл тусад нь гэрээний онцлогт тохирсон зохицуулалт хийх үү гэдгийг шийдвэрлэх нь зохилтой юм.

-ЗЕХ-ийн 92 дугаар зүйлийн 92.2-т захиргааны актад гаргах гомдолд тавигдах шаардлагыг тодорхойлохдоо ИТБАТГӨГШт хуулийн 10 дугаар зүйлийг ишлэсэн байгаа учир ЗЕХ-ийн дагуу гомдлыг хянан шийдвэрлэх харилцаанд уг хууль хэрэглэгдэж байна.

-ИТБАТГӨГШтХуулиар өргөдөл ба гомдол гэсэн хоёр ойлголтыг нэгтгэн зохицуулснаас, захиргааны актад гаргасан гомдол нь уг хуулийн өргөдлийг (санал, мэдэгдлийн шинжтэй) шийдвэрлэх зохицуулалтаар хамтатган шийдвэрлэгдэх нь нийтлэг байна. Учир нь энэ хуульд “гомдол” -ыг тодорхойлсон агуулга нь ЗЕХ-ийн захиргааны актад гомдол гаргах, түүнийг шийдвэрлэх журамтай “зэрэгцсэн” (давхацсан) зохицуулалт болжээ.

-ЗЕХ-ийн захиргааны актад гомдол гаргах, түүнийг шийдвэрлэх зохицуулалт төдийлөн хэрэглэгдэхгүй байгаа нь ИТБАТГӨГШтХуулийг хэрэглэдэг гэх дээрх байдлаас шалтгаалж байж болох бөгөөд уг хуульд гомдлыг шийдвэрлэх журам нь хэт ерөнхий бөгөөд санал, мэдэгдлийн шинжтэй “өргөдлийг” шийдвэрлэхтэй ижил зохицуулалттай байна.

-Гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагаанд зэрэгцсэн олон хуулийн зохицуулалт хэрэглэгдэх нөхцөл үүссэн. Үүнээс улбаалан Захиргааны ерөнхий хуульд заасан гомдлыг хянан шийдвэрлэх процессын зохицуулалт хэрэглэгдэхгүй байх нөхцлийг үүсгэж байна.

-Түүнчлэн, салбарын хуульд гомдлыг хянан шийдвэрлэх процесс тусгагдаагүй, журам (хэм хэмжээ тогтоосон акт) нь гомдлыг хүлээж авах, талуудыг оролцуулах, гомдлыг шийдвэрлэх процессоос илүү гомдол хянан шийдвэрлэх байгууллагын дотоод процесс түлхүү зохицуулагдсан байдгаас үзвэл, салбарын хуулиар гомдол хянан шийдвэрлэх ажиллагаа нарийвчлан зохицуулагдсан гэх тайлбар, тогтсон ойлголт таамаг нь үндэслэлгүй ажээ.

-Судалгаанд хамрагдсан байгууллагуудад гомдлыг шийдвэрлэхэд ЗЕХ-ийн 95-99 дүгээр зүйлд заасан журмыг хэрэглэх талаар ойлголт тогтоогүй, гомдол шийдвэрлэх ажлыг эрхлэх чиг үүрэг бүхий албан тушаалтнууд тодорхойгүй байна.

-Маргаан таслах, гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллагаас бусад тохиолдолд буюу энэ судалгаанд хамрагдсан дээд шатны захиргааны байгууллага гомдлыг ЗЕХ болон бусад хуульд заасан процессын дагуу ажиллагаа хийж шийдвэрлэх талаар төдийлөн хүч чармайлт гаргахгүй байна гэж дүгнэж байна.

-ЗЕХ-д дээд шатны байгууллагын эсхүл гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллагаас гомдлыг шийдвэрлээд гаргах шийдвэрийн төрлийг 98 дугаар зүйлд зааж өгсөн боловч гомдлын шаардлагын төрлийг тодорхой зохицуулаагүй нь гомдлын шаардлагын төрлүүдийн хоорондын ялгааг сайтар гаргахгүйгээр гомдол гаргахад хүргэж байж болзошгүй.

-Дээд шатны байгууллага, албан тушаалтан төдийгүй гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллагууд хүртэл гомдлыг шүүхээс өмнө бодитоор урьдчилан

[142] Шүүхийн практикт ЗХШХШтХ-ийн 54.1.3-ийг зөвхөн захиргааны акттай холбогдуулан нэхэмжлэл гаргаж буй тохиолдолд хэрэглэж байгаа, учир нь ЗЕХ-ийн 92-94 дүгээр зүйл үйлчлэхээр заасан, түүнд нь зөвхөн захиргааны актад гомдол гаргах тухай зохицуулалт байгаа гэдэг үндэслэлээр.

Remove Watermark Now

шийдвэрлэх /шалган тогтоох цаг хугацаа, хүн хүч, төсөв, эрмэлзэл/ боломж муутай байна. Тухайлбал, татварын маргаан таслах зөвлөлийн магадлагч нар татвар төлөгчийн гомдлыг зохих журмын дагуу ажиллагаа хийж цаг хугацаанд нь магадалж амждаггүй, хугацаа хэтрэлт ихтэй байдаг нь хүний нөөц дутмагтай холбоотой.

-Гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллага эсхүл дээд шатны захиргааны байгууллага гомдлыг хангаагүй тохиолдолд гарч буй шийдвэр нь үндсэн захиргааны актаас тусдаа үр дагавар гаргах эсэх нь одоо ч тодорхойгүй байна.

Нэгтгэн дүгнэвэл, судалгаанд хамрагдсан байгууллагын нөхцөл байдалд жишээлэн дүгнэвэл, практикт ЗЕХ-ийн гомдол хянан шийдвэрлэх тухайлсан зорилготой байгууллагуудаас бусад дээд шатны байгууллагад ЗЕХ-ийн 9 дүгээр бүлгийн зохицуулалт төдийлөн үр дүнтэй хэрэглэгдэхгүй байна. ЗЕХ-ийн энэ бүлгийн зохицуулалт зорилгодоо бүрэн хүрэхгүй байгаагийн шалтгаан нь зэрэгцсэн олон хуулийн зохицуулалттай, гомдол хянан шийдвэрлэх хүн хүч, төсөв, цаг хугацаа хүрэлцдэггүй зэрэг байна. Мөн ИТБАТГӨГШтХ-н зохицуулалт давхацсаны улмаас гомдол хянан шийдвэрлэх ажиллагааг саармагжуулсан урьдчилан тооцоолоогүй үр дагавар хуулийн хэрэгжилтэд нөлөөлж байна.

<u>Зөвлөмж:</u> ЗЕХ-ийн энэ бүлгийн зохицуулалтыг саармагжуулж буй ИТБАТГӨГШтХ-г үүргээ гүйцэтгэсэн гэж үзэж халах нь зүйтэй байна. ЗЕХ-ийн 9-р бүлэгт захиргааны гэрээтэй холбогдуулж урьдчилан шийдвэрлүүлэх журмаар гомдол гаргах шаардлага тавигдах эсэх, гомдлын шаардлагын төрлийг тодорхой зохицуулаагүй нь гомдлын шаардлагын төрлүүдийг ялган зааж өгөх талаар холбогдох өөрчлөлт оруулах саналтай байна. Түүнчлэн, гомдол хянан шийдвэрлэх чиг үүргийг тусад нь байгууллага, бүтцэд хариуцуулсан салбарт захиргааны байгууллагын үндсэн тогтолцооны дээд шатны байгууллага, албан тушаалтанд доод шатны шийдвэрийг хянах эрх хэмжээ давхцуулан хуулиар олгохгүй байх, гагцхүү гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллага гомдлыг шийдвэрлэх эрхтэй гэсэн зохицуулалт ЗЕХ-д оруулах нь ач холбогдолтой байж болох юм.

pdfelement

Remove Watermark Now

# ТАВ. НЭГДСЭН ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

**ЗЕХ-ийн 1 дүгээр бүлгийн дүгнэлт:**

Захиргааны ерөнхий хууль 2015 онд батлагдсанаас хойш 3 жил, хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш 2 орчим жил өнгөрчээ. Энэ хугацаанд тус хуулийн хэрэгжилтийн талаар судалгаа хийгдэж байгаагүй байна. Энэхүү хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх судалгааны ажлын хүрээнд 3 дугаар зүйлийн 3.1.4, 3.1.7, 4 дүгээр зүйлийн 4.2.6, 4.2.8 дахь заалтыг сонгон авч, практикт хэрхэн хэрэгжиж байгаа эсэхийг үнэлж дүгнэхийг зорьсон болно. Иймээс энэхүү үнэлгээний ажилд сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах дүгнэлтийг хийж байна.

- “Хүлээн зөвшөөрөгдсөн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

*ЗЕХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтад “зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа”-нд ЗЕХ үйлчлэхгүй гэсэн нэмэлтэд хийсэн дүгнэлт*

ЗЕХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтад зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа нь захиргааны үйл ажиллагаа биш гэсэн атлаа, улмаар Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт энэ маргааныг захиргааны хэргийн шүүх хянан хэлэлцэхгүй байтал Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Оролцогч энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.7, 6.10, 6.11, 6.12, 6.14, 6.15, 6.16, 6.17, 6.18, 6.19, 6.20, 6.21, 6.22, 6.23, 6.24, 6.25, 6.27 дахь заалтад заасан эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрийг эс зөвшөөрвөл Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар гомдол гаргаж шийдвэрлүүлнэ” гэж заасан нь ихээхэн зөрчилдөөнтэй болсон төдийгүй практикт хүлээн зөвшөөрөгдөх байдал нь дутмаг байна.

- “Практикт хэрэгжиж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

1. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд ЗЕХ үйлчлэхгүй байхаар хуульчилж, улмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хүрээнд гарснаас бусад шийдвэрийг захиргааны акт байхаар нэмэлт оруулсныг үндсэн хуулийн зөрчил бүхий байна гэж үзэж Үндсэн хуулийн цэцэд хянуулахаар хүсэлт явуулсан байна. Үүнтэй холбоотойгоор одоогоор Монгол Улсын хэмжээнд захиргааны хэргийн анхан шатны шүүхэд зөрчлийн хэрэг үүсгэн хянагдаж байгаа нийт зөрчлийн хэргүүдийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг Үндсэн хуулийн цэцийн шийдвэр эцэслэн гарах хүртэл хугацаагаар түдгэлзүүлэн шийдвэрлэж байна. Өөрөөр хэлбэл, захиргааны хэргийн шүүхэд зөрчлийн хэргийг өнөөдрийн байдлаар шийдвэрлээгүй, түдгэлзүүлсэн байдалтай байна.

2. Манай улсын өнөөгийн шүүхийн практикаас авч үзэхэд Захиргааны хэргийн шүүх захиргааны байгууллагын улс төрийн болон бодлогын шинжтэй үйл ажиллагааг түүний захиргааны үйл ажиллагаанаас тодорхой зааглахгүйгээр захиргааны хэрэг үүсгэх, хэргийн оролцогчид улс төрийн болон бодлогын шинжтэй шийдвэр мөн, биш хэмээн маргаж байхад түүнд нь тодорхой эрх зүйн дүгнэлт хийхгүйгээр шийдсэн кэйс 3 гарсан байх бөгөөд эндээс үзвэл нэг талаас шүүхийн практикт ЗЕХ-ийн 3.1.7 дахь заалтыг зөв хэрэглэхгүй байгаа явдал байх төдийгүй нөгөө талаас практикт зөв хэрэгжүүлэхийн тулд ЗЕХ-ийн эл заалтад хийсэн хууль тогтоогчийн аутентик тайлбарыг, эсхүл тухайн заалтын текст дэх томъёоллыг дахин нарийвчлан тодруулж томъёолох (яг ямар шийдвэр, үйл ажиллагааг улс төрийн эсхүл бодлогын гэх вэ гэдэг байдлаар) шаардлага байна гэж дүгнэлээ.

Remove Watermark Now

3. ЗЕХ хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш хугацаанд ЗЕХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.2.6 дахь заалтыг үндэслэн хэрэглэж шийдвэрлэсэн 34 кэйс гарсан байх бөгөөд дийлэнх нь энэ зарчмыг захиргааны байгууллага баримталж ажиллаагүй гэсэн эрх зүйн дүгнэлтийг хийжээ. Эндээс үзвэл, ЗЕХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.2.6 дахь заалтад заасан зарчмыг захиргааны байгууллагууд хэрхэн ойлгож байгаа талаар тухайлан судлах шаардлагатай байх бөгөөд энэхүү зарчмын агуулгыг сайтар ойлгохгүй байгаагаас улбаалан хуулийн дээрх зарчим нь хуулийн холбоотой бусад заалтын хамт амьдралд хэрэгжихгүй байх нөхцөл бүрдсэн байж болохоор байна.

4. ЗЕХ хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш хугацаанд ЗЕХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.2.8 дахь заалтыг үндэслэн хэрэглэж шийдвэрлэсэн зөвхөн 1 кэйс гарсан байх бөгөөд эндээс тус заалт амьдралд хэрхэн хэрэгжиж байгаа талаар дүгнэлт өгөх боломжгүй байна.

**ЗЕХ-ийн 2 дугаар бүлгийн дүгнэлт:**

Хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх энэхүү судалгааны ажлын хүрээнд 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.5, 8 дугаар зүйлийн 8.1. дэх заалтыг сонгон авч, эдгээр заалтууд хуулийн зорилгодоо хүрсэн эсэх, практикт хэрхэн хэрэгжиж байгаа эсэхийг үнэлж дүгнэхийг зорьсон болно. Иймээс энэхүү үнэлгээний ажилд сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах дүгнэлтийг хийж байна.

- “Зорилгод хүрсэн байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

ЗЕХ-ийн 1 дүгээр зүйлд тус хуулийн зорилгыг тодорхойлохдоо “нийтийн эрх зүйн хүрээнд гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг захиргааны байгууллага”-д ямар субъект багтахыг хуульчлахыг зорьсон байх бөгөөд тийнхүү захиргааны байгууллагыг тодорхойлохдоо хуучин 2002 оны Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар захиргааны байгууллагыг тодорхойлж байсан “нээлттэй тоочих” зарчмаас аль болох зайлсхийхийг оролдсон байх боловч бүхэлдээ ерөнхий заалтын зарчмыг баримталсан гэж үзэхээргүй байна. Хэдийгээр манай улсын ЗЕХ нь ерөнхий заалтын зарчмыг бүрэн баримтлаагүй боловч ЗЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 5.1.5 дахь заалт нь захиргааны байгууллагуудыг тодорхойлж өгөх талаар хуулийн зорилгодоо хүрсэн гэж дүгнэж байна.

- “Практикт хэрэгжиж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Нэг. ЗЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалтад “төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага” нь захиргааны байгууллага болно гэж заасан байх бөгөөд энд “төрийн захиргааны төв байгууллага” гэдэг томьёоллыг хэрэглээгүй, харин “төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв байгууллага” хэмээн өргөн агуулга бүхий томьёоллыг хэрэглэсэн байгааг анхаарах нь зүйтэй байна. “Төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв байгууллага” гэдэгт Монгол Улсын Засгийн газар, яам, агентлаг багтах нь хууль боловсруулагчдын болон хууль тогтоогчдын үзэл баримтлал, хуулийн зорилго, эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах онол, арга зүйн талаасаа тодорхой ойлгогдож байгаа болохыг судалгааны тайлангийн хэсэгт дурдсан болно. Практикт хуульчид болон захиргааны хэргийн шүүхийн шүүгчдийн аль аль нь энэ заалтыг ямар нэг хоёрдмол утгагүй ойлгон, маргаангүй хэрэглэж ирсэн бөгөөд 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш Монгол Улсын Засгийн газрыг захиргааны хэргийн шүүхэд хариуцагчаар татаж, хэргийг шийдвэрлэсэн кэйс 21 байгааг судалгааны бүлэгт дурдсан болно.

Дүгнэлт:

1.Засгийн газрын үйл ажиллагааг губернатив буюу улс төрийн-бодлогын, административ буюу захиргааны үйл ажиллагаа гэж хоёр ангилан авч үздэг бөгөөд бусад улсуудад түгээмэл хэрэглэгддэг уг онолын дагуу захиргааны байгууллагын тэр дундаа (Засгийн газрын) үйл ажиллагааг улс төрийн бодлогын, захиргааны гэж ангилах эхний оролдлогыг ЗЕХ-аар хийсэн нь зөв болсон гэж үзэж байна. Засгийн газрын захиргааны үйл ажиллагаагаар иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол нь зөрчигдсөн бол ердийн шүүх (тэр дундаа Захиргааны хэргийн шүүх) тэрхүү зөрчигдсөн эрхийг сэргээх учиртай гэдэг нь үндсэн хуульт ёс, эрх зүйт төрийн зарчмын зүй ёсны нэгэн шаардлага болно (Хавсралт 1. Онолын судалгааг үзнэ үү).

2.Засгийн газрын шийдвэр, үйл ажиллагаа нь иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хөндсөн, эсхүл зөрчсөн бол шүүхээс хянах нь үндсэн хуульт ёс, эрх зүйт төрийн зарчмын зүй ёсны нэгэн шаардлага юм. Монгол Улсын Засгийн газар нь бусад орны засгийн газартай харьцуулахад иргэн, хуулийн этгээдэд шууд чиглэсэн, эрх зүйн үр дагавартай шийдвэр гаргах хууль зүйн өргөн боломжтой болох нь холбогдох салбарын хуулиудад иргэн, хуулийн этгээдэд шууд чиглэсэн, тухайлсан шинжтэй шийдвэр гаргах болон нийтээр дагаж мөрдөх олон тооны захиргааны хэм хэмжээний актыг батлан гаргах боломжийг олгосон байгаагаар нотлогдож байна. Тухайлбал, 2017 онд Засгийн газраас гаргасан 106 шийдвэрийг түүвэрлэн үзэхэд 8.55% хувь буюу 9 нь захиргааны акт, 42.4% хувь буюу 45 нь захиргааны хэм хэмжээний акт байгаа нь Засгийн газрын энэхүү захиргааны үйл ажиллагааг шүүхээс хянах үндэслэл болж байна (Хавсралт 2. Засгийн газрын 2017 оны зарим шийдвэрт хийсэн дүн шинжилгээг үзнэ үү).

3.Монгол Улсын Засгийн газрын шийдвэр, үйл ажиллагаагаар иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдсөн бол захиргааны болон иргэний хэргийн шүүх тус тусын хэргийн харьяаллын дагуу маргааныг шийдвэрлэх нь тодорхой байх бөгөөд хэрэв аль ч шүүх тухайн маргааныг авч хэлэлцэхгүй бол Монгол Улсын Үндсэн хуулийн цэц аль нэг шүүхэд хэргийн харьяалал тогтоож өгнө. Энэ бол эрх зүйт төрийн суурь зарчим юм.

Хоёр. Ерөнхийлөгчийн зарлигтай холбоотой тодорхой эрх зүйн маргаан дээр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд харьяалал тогтоосон тохиолдол гарсан байх бөгөөд эндээс дүгнэвэл Монгол Улсын Үндсэн хуулийн цэц Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн маргааныг захиргааны хэргийн шүүхэд харьяалуулснаар Монгол Улсын Ерөнхийлөгчийг захиргааны байгууллага байх боломжтой гэдгийг хууль зүйн хувьд хүлээн зөвшөөрсөн байна.

Дүгнэлт:

Орчин үеийн ардчилсан, эрх зүйт төртэй улсад иргэн хүнд шүүхэд мэдүүлэх, эрх зүйн хамгаалалт авах боломж бүх талаар олгогдсон байх ёстой. Дээрхээс үзэхэд Ерөнхийлөгчийн Үндсэн хуулиас бусад хуулийг зөрчсөн үйл ажиллагааг ердийн шүүх (тэр дундаа Захиргааны хэргийн шүүх) хянах боломжтой гэдгийг Үндсэн хуулийн цэц тогтоосон байна. Энэхүү маргаан нь одоо Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд хянан шийдвэрлэгдэж байна.

Гурав. ЗЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтад “нутгийн өөрөө удирдах байгууллага” буюу аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, баг, хорооны ИНХ нь захиргааны байгууллага болохыг тодорхой заажээ. 2002 оны Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх

Remove Watermark Now

тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалтуудад ч энэ агуулгаар хуульчлагдсан байсан болно. Энэ заалтыг шүүхийн практикт ямар нэг хоёрдмол утгагүй ойлгож, маргаангүй хэрэглэж ирсэн бөгөөд одоо ч тийнхүү хэрэглэж байгаа болох нь шүүхийн шийдвэрийн судалгаагаар тогтоогдлоо (Хавсралт 4-ийг үзнэ үү).

Дүгнэлт:

1.Нутгийн өөрөө удирдах байгууллагын гаргасан иргэн, хуулийн этгээдэд чиглэсэн, шууд эрх зүйн үр дагавар бүхий захиргааны акт, нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан захиргааны хэм хэмжээний акт нь шүүхийн хяналтын дор байна гэдэг нь Үндсэн хууль ёс, эрх зүйт төрийн зарчмын зүй ёсны нэгэн шаардлага байна.

2.Тийм учраас аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, баг, хорооны ИНХ-ыг захиргааны байгууллага байна гэдгийг ЗЕХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.5 дахь заалтад нэрлэн заасан байх бөгөөд нутгийн өөрөө удирдах байгууллагын захиргааны үйл ажиллагаа нь Захиргааны хэргийн шүүхийн хяналтад багтана.

ЗЕХ-ийн энэ бүлгийн 8 дугаар зүйлийн хувьд судалгааны тайлангийн хэсэгт авч үзсэн Барилгын тухай хуулийн зохицуулалтын жишээн дээрээс дүгнэхэд “хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно” гэж заасан ЗЕХ-ийн 8.1 дэх заалтыг практикт хэрэгжүүлэхийн тулд хууль тогтоомжийн хоорондын уялдааг сайжруулж, ямар тохиолдолд, ямар үндэслэлээр эрх бүхий этгээд нь өөрт хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлж болохыг материаллаг хуулиудад тодорхой хуульчилж өгдөг байх нь чухал байна.

pdfelement

**ЗЕХ-ийн 3 дугаар бүлгийн дүгнэлт:**

1. Захиргааны байгууллага нь ЗЕХ-ийн 11.3-т заасан захиргааны үйл ажиллагааны хэлбэрүүдээс захиргааны актыг голчлон хэрэглэж байна. Захиргааны гэрээний талаархи мэдлэг тааруу байгаагаас шалтгаалан хэрэглээ хангалтгүй байна. Зорилгодоо хүрсэн байдлын шалгуур үзүүлэлтийг практикт хэрэгжиж буй байдлын шалгуур үзүүлэлттэй харьцуулахад захиргааны актын хэрэглээг голчлон хэрэглэж байгаа ч сонгоно гэж заасан тул энэ заалтын хэрэгжилт хангалтай гэж дүгнэлээ.

2. ЗЕХ-ийн 11.4 дэх заалтыг судалгаанд хамрагдсан захиргааны байгууллагууд хэрэглээгүй байна. Захиргааны байгууллагууд шалтгаанаа хуулийн заалтын агуулгыг ойлгохгүй, үйл ажиллагааны өөр ямар хэлбэр байх талаар тодорхой жишээг хэлж мэдэхгүй гэжээ. Зорилгодоо хүрсэн байдлын шалгуур үзүүлэлтийг практикт хэрэгжиж буй байдлын шалгуур үзүүлэлттэй харьцуулахад ЗЕХ-ийн 11.4 дэх заалт хэрэгждэггүй гэсэн дүгнэлтэнд хүрлээ.

3. -ЗЕХ-ийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн шийдвэр гаргах ажиллагааны оролцогч болох захиргааны акт, гэрээний эрх зүйн үйлчлэл шууд ба шууд бусаар чиглэсэн этгээдийн талаар хуульд тусгасан томъёоллын талаар судлаач, шүүгчдээс ярилцлага авахад 9 судлаач, шүүгч нараас олонхи нь оновчтой гэж үзсэн ба харин хэнийг багтаах вэ гэдэг асуултад ялгаатай байдлаар хариулсан. Ялангуяа шууд бусаар чиглэсэн этгээд гэдгийг харилцан адилгүй агуулгаар тайлбарлаж байв.

-Татан оролцуулсан этгээдийн талаарх ойлголт ч судлаач, шүүгчдийн хувьд харилцан адилгүй байлаа.

Remove Watermark Now

-Иргэдийн хувьд хуульд заасан томъёоллын талаар асуухад мэдэхгүй, ойлгохгүй байна гэсэн хариуг өгч байсан.

Иймд уг ойлголтод ямар субьект хамаарахыг тайлбарлан тусгах (аутентик тайлбарыг ашиглаж болох) шаардлагатай гэсэн судлаач 1-ийн саналыг дэмжиж байна. Иймд 13.1-ийн заалт зорилгодоо хүрсэн байдлын шалгуураар авч үзвэл хангалтгүй байна гэж үзлээ.

4.Хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалтын хүлээн зөвшөөрөгдөх байдлын шалгуураар авч үзвэл иргэдээс авсан санал асуулгын үр дүнгээс харахад 46,7 хувь нь ямар нэг байдлаар захиргааны байгууллагын шийдвэр гаргах ажиллагаанд оролцож байжээ. Харин үлдсэн 52 хувь болох иргэдээс оролцож байгаагүй шалтгааныг нь тодруулан асуухад: “оролцох эрхтэй” гэдгээ мэдэхгүй байснаас оролцоогүй гэж 20 хувь, “хариулж мэдэхгүй байна” гэж 30 хувь нь үзсэн нь захиргааны байгууллагын шийдвэр гаргах ажиллагаанд оролцоогүй гол шалтгаан нь иргэд оролцох эрхтэйгээ мэдэхгүй учраас гэж хариулсан байдал өндөр байна. Энэ нь иргэдэд шийдвэр гаргах ажиллагаанд оролцох эрхтэй талаар мэдээлэл хангалтгүй байгааг харуулж байна. Харин эдгээр иргэдэд ЗЕХ-ийн талаар мэдээлэл өгөхөд ийм хууль гарсан нь сайшаалтай байна гээд цаашид шийдвэр гаргах ажиллагаанд идэвхитэй оролцох болно хэлж байлаа. Тиймээс хуулийн хүрээнд иргэдийн эрх, үүргийг тодорхой ойлгуулах, мэдээллээр хангах шаардлага гарч байна. Хүлээн зөвшөөрөгдөх шалгуур үзүүлэлтийн хувьд уг заалт хангалттай гэж дүгнэж болно.

5. Хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-ийн практикт хэрэглэгдэж буй шалгуур үзүүлэлтээр авч үзвэл хангалтгүй байна. Энэ нь эрх бүхий байгууллагын санаачилга муу, хуулийг хэрэгжүүлэх хүсэл зориг сул байгаатай холбоотой. Мөн нөгөө талаас шийдвэр гаргах ажиллагаанд оролцогчийн эрхийг хангахын тулд тухайн байгууллагын зардал өсдөг тухай холбогдох албан тушаалтнууд саналаа хэлж байсан. Тиймээс байгууллагын үйл ажиллагааны тайланд шинжилгээ хийж, уг заалтын хэрэгжилтэд хүндрэл гарч буй шалтгааныг тогтоох шаардлагатай.

pdfelement

6. Хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-ийн заалтын хэрэгжилт хангалгүй байгааг ярилцлагад оролцсон зорилтот бүлгээс авсан ярилцлага болон судалгаанд хамрагдсан 14 байгууллагын үйл ажиллагаанд хийсэн шинжилгээгээр тогтоосон.

7.ЗЕХ-ийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.5-ын заалтын хэрэгжилтийг практикт хэрэглэж байгаа байдлын шалгуур үзүүлэлтээр авч үзэхэд хангалтгүй байна. Шийдвэр гаргах ажиллагаанд хамаарах нотлох баримтын талаар ойлголт муу, ялангуяа судалгаа, тооцоолол, шинжилгээнд суурилсан аргаар нотлох баримтуудаа үнэлэх гэдгийг ойлгохгүй байна. Иймд хуулийн 24.1-24.5- д заасан нөхцөл байдлыг тогтоох ажиллагаа, түүний хүрээнд хийж болох ажиллагаа ялангуяа газрын маргааны хувьд захиргааны байгууллага бараг хийхгүй байна.

8.ЗЕХ-ийн 25-р зүйл. Захиргааны байгууллагууд ЗЕХ-д заасан нотлох баримтыг цуглуулах, үнэлэх ажиллагааг хангалттай хийхгүй байна. Захиргааны шийдвэрийн талаар хангалттай нотлох баримтыг бүрдүүлэхгүй, иргэнээс санал авсан төдийхнөөр нотлох баримт цуглуулсан гэж үздэг. Бодит нөхцөл байдлыг тогтоосон судалгаа, шинжилгээ, аргачлал байхгүй, туршилт хийхгүй, зөвхөн ажлын байранд хурал хийх замаар захиргааны шийдвэрүүд гарч байгааг ажиглалт болон шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийхэд илэрч байна. Гэрчээс мэдүүлэг авахдаа хууль сануулах уу, хэрэв

санууулна гэвэл тухайн албан тушаалтанд хуулиар ийм эрх олгох нь зөв эсэх нь маргаантай юм.

9.ЗЕХ-ийн 26, 27, 28-р зүйлүүд сонсох ажиллагааны талаар зохицуулсан. Судалгаанд хамрагдсан 14 байгууллага сонсох ажиллагааг хийж эхлүүлсэн байна. Гэхдээ хуульд заасан журам, шаардлагын дагуу сонсох ажиллагаа хангалттай явагдахгүй байгаа нь судалгааны явцад ажиглагдлаа. Ялангуяа сонсох ажиллагааны мэдэгдлийг хуульд заасан шаардлагын дагуу бэлтгэж оролцогчдод өгөхгүй байна. Энэ нь судалгаанд хамрагдсан 14 байгууллагын захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд хийсэн шинжилгээгээр тогтоосон. Мөн сонсох ажиллагааны мэдэгдэл өгсний дараа хэзээ уг ажиллагааг явуулах, оролцогчдод тайлбар, санал гаргах хугацааг хэрхэн тооцох талаар зохицуулалт байхгүйгээс хэлбэрийн төдий ажиллагаа болоод байна. Захиргааны байгуулагын зүгээс гарч буй саналын хувьд зардал, сонсох ажиллагааг хэн хийх вэ гэдэг нь тодорхойгүйгээс бэрхшээл учирч байна гэжээ. Зорилгодоо хүрсэн байдлын шалгуур үзүүлэлтийн хувьд хангалттай гэж үзсэн, харин практикт хэрэгжиж байгаа байдлыг хангалтгүй гэж дүгнэж байна.

10.ЗЕХ-ийн 29 дүгээр зүйлд заасан захиргааны шийдвэрийн хувийн хэрэг, хяналтын дагалдах хуудасны талаар судалгаанд хамрагдсан захиргааны байгууллагуудаас хуульд заасан журмын дагуу хөтөлж байгаа нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, СХД-ийн Тамгын газар байна. Ихэнхи байгууллагаас гарч буй санал бол зардал ихтэй, архив, хадгалалттай холбоотой бэрхшээлүүд гарч байна гэжээ. Зорилгодоо хүрсэн байдлын шалгуураар авч үзвэл хувийн хэргийн бүрдүүлбэр байхыг захиргааны байгууллага, шүүгч нар дэмжсэн тул хангалттай гэж үзлээ. Харин практикт хэрэгжиж буй байдлын шалгуур үзүүлэлтийн хувьд хангалтгүй гэж дүгнэж байна.

Зөвлөмж:

- Огт хэрэгжээгүй заалт

-Үнэлгээнд хамрагдсан зүйл, заалтуудын зорилгодоо хүрсэн байдлын шалгуур үзүүлэлтээр нь авч үзвэл практикт үр дагавар гарсаар байхад тухайн хуулийн зохицуулалт огт үйлчлэхгүй байна. Үүнд ЗЕХ-ийн 11.4, 13.4, 24, 25, 27.3, 27.7, 28.2, 32, 33- р зүйл тус тус багтана. Энэ нь хуулийн заалтын агуулга ойлгомжгүй, хэрэгжих боломжгүй байдлаас бус харин захиргааны байгууллагын санаачилгагүй, хэрэгжүүлэх хүсэл зориггүйгээс шууд шалтгаалж байна.

-Хуулийн зохицуулалтын агуулга, томъёолол ойлгомжгүйгээс хэрэгждэггүй заалтад 11.4-ийг оруулж байна. Захиргааны байгууллагын зүгээс тавьж буй саналд ямар үйл ажиллагаа байхыг тодорхойлсон тайлбар хэрэгтэй гэжээ.

-Хуулийн 13.1-д заасан шууд ба шууд бус гэсэн томьёоллыг өөрчлөх шаардлагатай.

-Хуулийн 24, 25- р зүйлийн заалт буюу нөхцөл байдлыг тогтоох, нотлох баримтыг цуглуулах талаар захиргааны байгууллагууд ЗЕХ-д заасан журмын дагуу хийж байгаа талаар нотолгоо бүхий шийдвэрүүд гаргахгүй байна. Энэ нь захиргааны байгууллагын шийдвэр гаргах эрх бүхий албан тушаалтан, албан хаагчдын мэдлэг, ур чадвараас хамаарч байна гэж үзлээ. Иймд сургалт явуулах шаардлагатай.

-Судалгаа хийх явцад зарим заалт практикт огт хэрэгжээгүй шалтгааны нэгд, үнэлгээ хийх хугацаатай холбоотой байна гэж дүгнэв. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийхээр заасан байдаг.

- Хэрэгжиж эхэлж байгаа заалт

Судалгаанд үнэлэгдсэн 3-р бүлгийн заалтаас 11.3, 13.1, 26, 29-р зүйлүүд, бусад зүйл, заалт энэ хэсэгт багтаж байна. Гэхдээ ихэнхи заалтын хувьд хэлбэрийн төдий хэрэгжиж эхэлж байна гэж үзлээ. Нийтлэг алдаа нь ЗЕХ-д заасан журмыг ягштал баримтлаагүй, буруу хэрэглэсэн байна. Жишээ нь, сонсох ажиллагааны мэдэгдлийг захиргааны акт баталсны дараа хэрэглэдэг мэдэгдэх хуудас гэж ойлгох, сонсох ажиллагаа явуулаад тайлбар, санал өгөх хугацааг гаргадаггүй, иргэдээс саналыг нь аваагүй шалтгааны талаар тайлбар хийдэггүй зэргийг дурьдаж болно. Иймд сонсох ажиллагааны нарийвчилсан үлгэрчилсэн журмыг Засгийн газраас гаргах шаардлагатай байна. ЗЕХ-ийн 103, 105-р зүйлд заасан зохицуулалтын хэрэгжилт сайжирвал энэ бүлэгт нөлөөлөх боломжтой гэсэн таамаглал дэвшүүлж байна.

**ЗЕХ-ийн 4 дүгээр бүлгийн дүгнэлт:**

1.Үнэлгээний судалгаанаас үзэхэд ЗЕХ-ийн 37 дугаар зүйлийн 37.1-д Зөрчлийн тухай хуулийн дагуу оруулсан нэмэлт зохицуулалт нь ЗЕХ-ийн зорилгод шууд нөлөөлж, Захиргааны ерөнхий хууль, Зөрчлийн тухай, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуулиуд хоорондоо уялдаагүй, зөрчилдөөнтэй байгаа, Зөрчлийн тухай хуулийг үндэслэн оруулсан өөрчлөлтийг шүүхийн практикт хэрэгжүүлэх боломжгүй болсон үр дагавар, хүндрэл гарсан байна.

2.Судалгааны явцад шүүхийн шийдвэрийн shuukh.mn мэдээллийн сангаас шүүлт хийхэд ЗЕХ-ийн 37.7-г хэрэглэж гаргасан шүүхийн шийдвэр, захиргааны акт байхгүй байна. ЗЕХ-ийн 37.7-д заасан заалтыг тодорхой болгон өөрчлөх шаардлагагүй, харин жишээтэйгээр тайлбарлан таниулах, ойлгуулах ажлыг хийх нь зүйтэй.

3.Захиргааны байгууллагын бичгээр гаргаж байгаа захиргааны актад “бодит нөхцөл байдлыг тодорхой заах” ЗЕХ-ийн 40.4-т заасан шаардлагыг захиргааны байгууллагууд ойлгож, уг заалтыг захиргааны байгууллагуудаас практикт нэгэнт нэг мөр хэрэглэж байгаагаас үзэхэд уг хуулийн заалт практикт зорилгодоо нийцсэн байдлаар хэрэгжиж байна.

4. Шүүгчдийн дунд явуулсан хэлэлцүүлгээс шүүхийн практикт ЗЕХ-ийн 43 дугаар зүйлд заасан мэдэгдэх шаардлагыг биелүүлээгүй үндэслэлээр захиргааны актыг хүчингүй болгоход дээд шатны шүүхээс хэлбэрийн төдий шаардлага учир энэ үндэслэлээр акт хүчингүй болгох үндэслэлгүй гэж дүгнэсэн талаар тайлбарлажээ. Хэргийн оролцогч талуудаас 43 дугаар зүйлд заасан захиргааны актыг мэдэгдэх шаардлагыг хангаагүй талаар маргадаг боловч шүүхээс энэ үндэслэлээр захиргааны актыг хүчингүй болгосон тохиолдол зөвхөн 1 удаа гарсан байна.

Захиргааны актыг хаяглагдсан болон эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн этгээдэд хууль ёсны дагуу мэдэгдсэн үеэс гадагшаа чиглэсэн шинжийг агуулж, эрх зүйн харилцаа үүсч, хууль зүйн үр дагавар бий болгох хүчинтэй төгөлдөр захиргааны акт гэж үздэг ЗЕХ-ийн зорилго, үзэл баримтлалын дагуу цаашид захиргааны актыг мэдэгдэх ажиллагааг захиргааны байгууллага заавал хийдэг болгох, хуулийн хэрэгжилтийг нэг мөр болгох шаардлагатай гэдэг нь судалгаанаас харагдаж байна. Хэдийгээр зарим байгууллагаас актыг мэдэгдэх ажиллагааны талаар анхаарч журам гаргаж, мэдэгдэх хуудасны загвар батлан мөрдүүлж байгаа боловч энэ нь хангалтгүй байна.

Иймд шүүхээс уг хуулийн заалтыг хуулийн зорилгод нийцүүлэх болон ЗЕХ-ийн тусгай зарчмыг зохицуулсан 4.2.6-д заасан зохицуулалттай хэрхэн уялдуулан хэрэглэх



Remove Watermark Now

талаар нэг мөр ойлголтыг бий болгож, нэгдсэн практик тогтоох, ЗЕХ-ийн 48 дугаар зүйлд 43 дугаар зүйлийн захиргааны актыг мэдэгдэх шаардлагыг хангаагүй захиргааны акт хүчингүй болгох үндэслэлээр өөрчлөлт оруулах, мэдэгдэх нарийвчилсан журмыг тухайн захиргааны байгууллага гаргах боломжийн талаар тайлбарлан таниулах шаардлагатай байна.

5.Дээр дурдсан шүүхийн шийдвэрүүдийн үндэслэлд дурдсан байдал, шүүгчдийн дунд хийсэн хэлэлцүүлгийн тэмдэглэл, захиргааны хэргийн шүүхийн шүүгчдийн дунд явуулдаг сургалтын хэлэлцүүлэг зэргээс дүн шинжилгээ хийхэд ЗЕХ-ийн 47.1.6 дахь заалтыг ерөнхий байдлаар хуульд оруулснаас шалтгаалж ЗЕХ-ийн 47.1.6 дахь заалтын "иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байгаагүй" гэдэгт хуульд үндэслэх зарчмыг зөрчсөн алдааг хамааруулан ойлгохоор заасан хууль тогтоогчийн үндсэн үзэл баримтлал, зорилгод нийцэхгүй байгаа нөхцөл байдал бий болжээ. Иймээс ЗЕХ-ийн 47.1.6 дахь заалтад хуулийн зорилгод нийцүүлсэн нэмэлт тодруулга байдлаар өөрчлөлт оруулах нь зүйтэй байна.

6.ЗЕХ-ийн 48 дугаар зүйлийн зорилго, үзэл баримтлалыг захиргааны байгууллага, шүүгч нар, иргэдэд тайлбарлан ойлгуулах, шүүхээс хууль хэрэглэх явцдаа нэг мөр ойлгох, нэгдсэн практик тогтоох боломжтой, уг хуулийн заалтад өөрчлөлт оруулах шаардлагагүй байна.

7.ЗЕХ-ийн 49, 50 дугаар зүйлийг практикт захиргааны байгууллагууд төдийлөн таньж мэдэж, ойлгоогүй байгаа нь судалгаанаас харагдаж байгаа /судалгааны тайлангийн хэсэгт дурдсан/ тул энэ чиглэлээр хуулийн эл зохицуулалтыг тайлбарлан таниулах шаардлагатай. Хуульд өөрчлөлт оруулах шаардлагагүй байна.

8.ЗЕХ нь Монгол Улсад батлагдан мөрдөгдөж байгаа шинэ хууль бөгөөд нийтээр дагаж мөрдөгдсөн үеэс 2 жил орчим болж байгаа тул практикийн хэрэглээнд зарим зүйл, заалт ялангуяа онолын ойлголтыг багтаасан зохицуулалтыг нилээд сайн тайлбарлан таниулж хэрэглээнд орсны дараа хэрэгжиж эхлэх онцлогтой гэдгийг анхаарах зүйтэй.

**ЗЕХ-ийн 5 дугаар бүлгийн дүгнэлт:**

-Захиргааны гэрээ байгуулах эрхийг хуульчилсан байдлыг Монгол Улсын хуулиудад шинжилгээ хийж үзвэл 1/зөвхөн захиргааны гэрээ байгуулах эрхийг заасан, 2/гэрээний зохицуулалтыг тодорхойлон заасан, 3/тодорхой зохицуулалтгүй ч чиг үүрэг хэрэгжүүлэх хүрээнд гэрээ байгуулах эрх олгогдсон гэж 3 ангилж үзэж болохоор байна.

-Судалгаа хийсэн дээрх байгууллагуудын байгуулсан гэрээнд дүн шинжилгээ хийж үзвэл ЗЕХ-ийн 52.2-т заасан харилцаанд буюу төрийн алба, эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, газрын харилцаа, нийгмийн халамж, даатгал зэрэг харилцаанд захиргааны гэрээ байгуулагдсан байна.

-ЗЕХ хэрэгжиж эхэлснээс хойш байгуулсан гэрээнд ЗЕХ-ийн холбогдох заалтыг үндэслээгүй, захиргааны байгууллага тэгш эрхийн харилцаа /иргэний эрх зүйн/, эсхүл нийтийн эрх зүйн харилцаанд захиргааны гэрээ байгуулж байгаа эсэх тухай төрөлжүүлээгүй, мөн ЗЕХ-тай холбогдуулан байгуулсан гэрээний загварт өөрчлөлт ороогүйг харвал захиргааны гэрээний тухай ойлголт хэвшээгүй, тухайн салбарын хууль болон өмнө нь хэрэгжүүлж ирсэн туршлагаар дээрх харилцаа үргэлжилж байна.

Remove Watermark Now

-Захиргааны байгууллагын зүгээс өөрийнхөө чиг үүргийг өөр этгээдэд шилжүүлэхтэй холбогдсон харилцаанд ЗЕХ-ийн 8.1-ийн “Хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно” гэсэн хориглосон хэм хэмжээг харгалзан үзэх ёстой.

- Захиргааны ерөнхий хуулийн 52.2.4-т концессын харилцаанд захиргааны гэрээг хэрэглэж болно хэмээн шууд үүрэг болгоогүй сонгох боломжит хувилбараар тусгажээ. Практикт талуудын хооронд үүссэн маргаанаа “шүүх”-ээр шийдвэрлүүлэх зохицуулалт бүхий концессын гэрээ ихэвчлэн байгуулагдсан байна.

-Дүн шинжилгээ хийсэн гэрээний хувьд талуудын эрх, үүргийг зохицуулсан байх боловч үүргийн зөрчил, түүнийг шийдвэрлэх арга замыг нарийвчилсан зохицуулалт агуулаагүй байв.

-Судалгааны хүрээнд авч үзсэн захиргааны гэрээнүүдийн хувьд ЗЕХ-ийн 55.1.14-ийн дагуу илт хууль бусад тооцогдож болохуйц гэрээнүүд багагүй байна.

-Захиргааны гэрээтэй холбоотой маргаан шүүхийн практикт цөөн боловч гарч байна. Одоогоор дийлэнх маргаан шүүхийн шатанд, эцэслэн шийдвэрлэгдээгүй буй тул дүгнэлт хийх боломжгүй байна.

Нэгтгэн дүгнэвэл, захиргааны гэрээний ухагдахууныг хуульчилсан зорилго нь ач холбогдолтой, практикт захиргааны гэрээ байгуулах замаар захиргааны байгууллагууд чиг үүргээ хэрэгжүүлж буй боловч ЗЕХ-ийн захиргааны гэрээний талаарх зохицуулалт тухайн гэрээнүүдэд “хэрэглэгдэж” буй нь цөөн байна. Мөн түүнчлэн, ЗЕХ-ийн гэрээний талаарх зохицуулалт зорилгодоо хүрсэн түвшинг тодорхойлоход цаг хугацааны хувьд эрт байна. Учир нь ЗЕХ-ийн гэрээний зохицуулалтын зорилгод хүрсэн түвшин нь тухайн хууль хүчин төгөлдөр мөрдөгдсөнөөс хойш байгуулагдсан гэрээний талаарх маргаан шүүхээр шийдвэрлэгдэж, уг маргаанд тэдгээр гэрээнүүдэд ЗЕХ-ийн зохицуулалт хэрэглэгдсэн, уг зохицуулалтад нийцсэн эсэхээс хамаарч гарсан шийдвэрээр захиргааны үйл ажиллаганы нэг хэлбэр болох захиргааны гэрээг зохицуулах гэж зорьсон зорилго биелж буй түвшин тогтоогдох юм.

Зөвлөмж: ЗЕХ-ийн захиргааны гэрээний зохицуулалтыг практикт хийгдэж буй гэрээнд хэрэглэхийг (наад зах нь тавигдах шаардлага хангах) захиргааны байгууллагуудад таниулах хэрэгцээ, шаардлага тулгамдаж байна. ЗЕХ-ийн захиргааны гэрээтэй холбогдох зохицуулалтад зайлшгүй нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох шаардлагагүй байна.

**ЗЕХ-ийн 6 дугаар бүлгийн дүгнэлт:**

1. ЗЕХ-ийн 59-р зүйл: ИТХ-ын Үндсэн хуулиар /62.2/ олгогдсон бие даасан шийдвэр гаргах эрх ба хуулиар түүнд шилжүүлсэн чиг үүрэг гэж байдаг. Тиймээс Хурлын гаргаж буй захиргааны хэм хэмжээний актыг энэ хоёр шинжээр нь ялгаж ЗЕХ-ийн энэ заалтыг хэрэглэх шаардлагатай. Судалгаанд хамрагдсан ИТХ-д ЗЕХ-ийн 59, 60- р зүйлийн эрх олгогдсон байх заалт нь Үндсэн хуулийн Жаран хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт буюу ИТХ-ын бүрэн эрхийн заалттай зөрчилдөж байна гэж үзэж байв.

2.Захиргааны байгууллагууд өөрт тусгайлан эрх олгогдсон эсэх талаар салбарын хуулиудад судалгаа хийж тоон мэдээллийн сан бүрдүүлэх шаардлагатай байна.

pdfelement

Ингэснээр салбарын хүрээнд хяналт шинжилгээг тогтмолжуулах, хуулиар зохицуулаагүй асуудлаар тохиолдол үүсэх эсэхийг урьдчилж судалж, хэрэв тийм нөхцөл байдал гарсан бол дээд шатны байгууллага, хууль тогтоогч нарт саналаа хүргүүлэх зэрэг процессын харилцааг зохицуулж өгөх.

3. Хаанаас байгуулагдсан (ИТХ-ын бие даасан шийдвэр гаргах эрхээс бусад) эсэхээс үл хамааран гадагшаа чиглэсэн байнгын үйлчлэлтэй хэм хэмжээний акт гаргах гэж байгаа бол заавал эрх олгогдсон байхыг шаардах.

4.Хуулиар хориглоогүй асуудал гэдгийг онол арга зүйн хувьд оновчтой тодорхойлох, Нөлөөллийн шинжилгээ болон хяналт шинжилгээ хийх явцад зайлшгүй хориглох нөхцөл байдал бий болсон үед дээд шатны байгуулага, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хандах процессыг нарийвчлан зохицуулах.

5. ЗЕХ-ийн 64 дүгээр зүйлийн 64.2-ын заалт: Засгийн газраас гаргасан хэм хэмжээний актыг ЗЕХ-д заасан журмын дагуу бүртгэх, хянах эрх бүхий байгууллага нь ЗЕХ-даа тодорхойгүй байна. Харин Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30. 9-д ХЗДХЯ-д байхаар хуульчилсан. Засгийн газар нь дээд шатны байгууллага тул салбарын яам нь хянах боломжгүй юм. “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу УИХ хүчингүй болгоно” гэж Үндсэн хуульд заасны дагуу УИХ бүрэн хянах боломжтой гэж үзэж байна. Судалгаанд хамрагдсан ЗГХЭГ болон УИХ-ын Тамгын газрын албан хаагчид энэ саналыг гаргасан.

Зөвлөмж:

1.ИТХ-ын Үндсэн хуулиар (62.2) олгогдсон бие даасан шийдвэр гаргах эрх ба хуулиар түүнд шилжүүлсэн чиг үүрэг гэж байдаг. Тиймээс Хурлын гаргаж буй хэм хэмжээний актыг бие даасан хэм хэмжээний ба захиргааны хэм хэмжээний актын шинжээр нь ялгаж байх нь зүйтэй.

2.ЗЕХ-ийн 64.2-т заасан Засгийн газрын баталсан захиргааны хэм хэмжээний актыг бүртгэх, хянах байгууллага нь УИХ-ын харьяа нэгж байх, энэ процесстэй холбоотойгоор Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.9- р заалтыг хүчингүй болгох.

3.Энэхүү УИХ-ын харьяа нэгжид УИХ-аас байгууллагддаг захиргааны байгууллагуудын захиргааны хэм хэмжээний актыг бүртгэж, хянах (Судалгаанд хамрагдсан Төрийн албаны Зөвлөл, Санхүүгийн зохицуулах Хороо, Монголбанкны санал).

4.Захиргааны  хэм хэмжээний актыг батласнаас хойш ажлын таван өдрийн дотор бүртгүүлэх хугацааг нийслэл, орон нутгийн хувьд ялгаатай тогтоох.

5.ЗЕХ-ийн 66.4 дэх заалтын хувьд ИТХ-ын онцлогийг харгалзах. Үүнд, ИТХ-ын хуралдаан тогтмол явагддаггүй тул 10 хоногийн хугацаанд захиргааны хэм хэмжээний актын талаарх дүгнэлтээ ИТХ-аас ХЗДХЯ-д буцааж ирүүлэх боломжгүй байдаг.

6.ЗЕХ-ийн 66.8 дахь заалт агуулгын болон бусад хуулиудтай зөрчилдөж байгаа эсэхийг нягтлах. Үүнд, ИТХ-ын шийдвэр, УИХ-аас байгуулагддаг байгууллагын шийдэрийг хүчингүй болгох субъект нь Засгийн газар мөн эсэх, мөн “хүчин төгөлдөр



Remove Watermark Now

Remove Watermark Now

болоогүй шийдвэрийг хүчингүй болгох” зохицуулалт нь томъёоллын, эсхүл зарчмын алдаа юу гэдэгт тайлбар өгөх.

7.ЗЕХ батлагдахаас өмнө гарсан захиргааны хэм хэмжээний актыг бүртгэх, мөн хуульд байгаа шаардлагыг хангахдаа дахиж процесс үүсгэх /сонсох ажиллагаа, нөлөөллийн шинжилгээ хийх/ эсэх талаар гарч буй маргааныг нэг мөр болгох. Санал: одоо хүчин төгөлдөр үйлчилж буй захиргааны хэм хэмжээний актуудыг ЗЕХ-д нийцүүлж нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай.

**ЗЕХ-ийн 8 дугаар бүлгийн дүгнэлт:**

-ЗЕХ-ийн 8 дугаар бүлгийн зохицуулалтын агуулгаас үзвэл мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасан захиргааны шийдвэрийн төрлүүдээс “захиргааны акт” -ыг гүйцэтгэх журмыг илүүтэйгээр зохицуулснаас болоод мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д заасан бусад захиргааны шийдвэрүүд ялангуяа “захиргааны гэрээ” -ний гүйцэтгэлийг хэрхэх нь тодорхойгүй орхигдсон байна.

-Уулзалт, ярилцлагын үед судалгаанд хамрагдсан байгууллага ЗЕХ-ийн захиргааны шийдвэр гүйцэтгэлийн харилцааг зохицуулсан бүлгийг хэрэглэдэггүй нь тодорхой харагдсан. Захиргааны байгууллагууд ЗЕХ-ийн захиргааны шийдвэр гүйцэтгэлийн зохицуулалтыг хэрэглэх гэхээс илүүтэй ийм боломж, зохицуулалт байгааг мэдэхгүй нь элбэг тохиолдож байна. Үүнээс үүдээс шийдвэр гүйцэтгэх ажиллагааг байгууллагын дотоод журам, эсхүл ажилтны үзэмжээр явуулснаас хожим нь захиргааны шийдвэр гүйцэтгэл нь эрх зүйн зөрчилтэйд тооцогдох магадлал өндөр байна.

-ЗЕХ-д заасан албадлага хэрэглэх шийдвэр гаргадаггүй, хугацааг баримтладаггүй, тухайлбал газар албадан чөлөөлөх мэдэгдэл, шаардлага өгснөөс хойш албадлага хэрэглэх тогтсон хугацаагүй, ЗЕХ-ийг хэрэглэдэггүй байдал тогтоогдсон.

-Захиргааны шийдвэр гүйцэтгэлийг хэрэгжүүлэхэд шаардагдах тоног төхөөрөмж, тухайлбал газар чөлөөлөх, албадан буулгах техник хэрэгсэл, зөөж тээвэрлэх автомашин, тоног төхөөрөмж тухайн шийдвэр гүйцэтгэх үүрэг бүхий байгууллагын өөрийн өмчлөл, мэдэлд байхгүй байгаа нь энэ чигүүргийг хэрэгжүүлэхэд саад болж байна.

-Захиргааны шийдвэр гүйцэтгэлийн хэрэгжилтийг хариуцсан ажлын байр тодорхойгүй, орон тоо, төсөв хөрөнгө нь хүрэлцээ муутай, байгууллагын бүтэц, ажилтны ажлын байрны тодорхойлолтод “шийдвэр гүйцэтгэх” чиг үүргийн талаар тодрхой зааж өгдөггүй байдлыг засах шаардлагатай байна.

-Түүнчлэн, ЗЕХ-ийн 65 дугаар зүйлд зааснаар захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй журмыг захиргааны шийдвэр гүйцэтгэлд хэрэглэдэг тохиолдол байна. Тэдгээрийг улсын нэгдсэн бүртгэлд шинэчлэн бүртгүүлэх шаардлагатай, ингэснээр газар чөлөөлөх шийдвэрийг гүйцэтгэх үйл ажиллагаа нь ЗЕХ-ийн шийдвэр гүйцэтгэлийн зохицуулалтад нийцэх боломжтой болох юм.

-ЗЕХ-ийн 84 дүгээр зүйлийн 84.1.3, 84.2-ийн зохицуулалтад мөн хуулийн 10 дугаар зүйлд заасан “захиргааны байгууллагын харилцан туслах үүрэг” зөрчилдөөгүй, харин ч бие биенээ нөхцөлдүүлсэн шинжтэй, уялдаа бүхий байна.

Remove Watermark Now

-Шийдвэр гүйцэтгэх ажиллагааг явуулах хуулийн зохицуулалт дутмаг, бусад байгууллагатай хамтран ажиллахад хүндрэл үүсдэг гэх зэрэг тайлбар гаргах хэдий ч тэдгээрт хэрглэж болох захиргааны шийдвэр гүйцэтгэлийн талаарх ЗЕХ-ийн зохицуулалт байгааг мэдэхгүй, энэ зохицуулалтыг хэрэглэхгүй байгаа нь харагдаж байна.

-Захиргааны шийдвэр гүйцэтгэлд бусад төрийн байгууллагуудтай хамтран ажилладаг тохиолдол практикт байх боловч ЗЕХ-ийн 10, 84.1.3, 84.2- ын зохицуулалтыг үндэслэдэггүй. Ийм зохицуулалт байгааг мэдээгүй байдалтай байна.

-ЗЕХ-ийн 90 дүгээр зүйлийн 90.1-д "мэдэгдэлд заасан хугацаанд үүргийг биелүүлээгүй бол ... албадлага хэрэглэхийг шийдвэрлэсэн захиргааны акт гарган, нэн даруй" биелүүлэхээр заасан боловч мөн зүйлийн 90.2-т уг актад гомдол гаргаж болохоор байгаа нь зөрчилдөж байна. Өөрөөр хэлбэл, нэн даруй биелүүлэх зохицуулалт хэрэгжих боломжгүй. Тиймээс нэн даруй биелүүлэх зохицуулалтыг хангахын тулд шийдвэр гүйцэтгэл хийгдэхдээ хууль болон үүрэг хүлээгчийн эрх зөрчигдсөн гэж үзвэл нөхөж гомдол гаргаж тогтоолгох боломжтой байхаар өөрчлөлт оруулж болох юм.

Нэгтгэн дүгнэвэл, захиргааны шийдвэр гүйцэтгэлийг хуульчилсан зорилго нь ач холбогдолтой, судалгаанд хамрагдсан байгууллагын нөхцөл байдалд жишээлэн дүгнэвэл практикт ЗЕХ-ийн шийдвэр гүйцэтгэлийн зохицуулалт хэрэглэгдэхгүй байна. Мөн түүнчлэн, ЗЕХ-ийн шийдвэр гүйцэтгэлийн талаарх зохицуулалт зорилгодоо хүрэхгүй байгаагийн шалтгаан нь захиргааны байгууллага энэ боломж, зохицуулалтын талаар мэдэхгүй, ЗЕХ хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны талаар маргаан гарч, шүүх шийдвэрлэсэн нь ховор байгаад оршиж байна.

pdfelement

Зөвлөмж: ЗЕХ-ийн 8-р бүлгийн зохицуулалт нь нийтлэг байдлаар захиргааны бүх төрлийн шийдвэрийг гүйцэтгэх журмыг тодорхойлоход зорьсон болохыг илүү тодорхой болгож, энэ агуулгаар захиргааны актыг онцлон заасан хэсгүүдэд өөрчлөлт оруулах саналтай байна. Түүнчлэн, ЗЕХ-ийн захиргааны шийдвэр гүйцэтгэлийн зохицуулалтыг захиргааны байгууллагуудад таниулах сургалт, мэдээлэл өгөх нь уг зохицуулалт хэрэглэгдэх, улмаар ЗЕХ-д шийдвэр гүйцэтгэлийг зохицуулж өгсний зорилгод хүрэхээр байна.

**ЗЕХ-ийн 9 дүгээр бүлгийн дүгнэлт:**

-ЗЕХ-ийн 92- 99-р зүйлийн зохицуулалт захиргааны гэрээтэй холбогдуулан гомдол гаргах харилцааг зохицуулаагүй гагцхүү захиргааны актад гомдол гаргах, уг гомдлыг хянан шийдвэрлэх журмыг тогтооход зорьсон болох нь тодорхой. Гэрээний талууд, ялангуяа захиргааны нөгөө тал буюу иргэн, хуулийн этгээд гэрээний тал болсон захиргааны дээд шатанд гомдол гаргах эрх байх уу гэсэн асуулт тодорхой зохицуулалтгүй байна.

-Гэрээтэй холбоотой маргаан гарсан тохиолдолд шүүх нэхэмжлэлийн шаардлага нь захиргааны акт эсхүл гэрээ байхыг ялгахгүйгээр урьдчилан шийдвэрлүүлсэн байхыг шаардах тул ЗЕХ-д гэрээтэй холбогдуулж урьдчилан шийдвэрлүүлэх журмаар гомдол гаргах шаардлага тавигдах эсэх талаар зохицуулалт хийх нь зайлшгүй юм.

-Түүнчлэн, гэрээний тал биш гуравдагч этгээд захиргааны гэрээний зохицуулалттай холбогдуулж маргах тохиолдлын талаар ЗЕХ-д зохицуулалт хэрэгтэй байна. Ингэхдээ ЗЕХ-ийн 9 дүгээр бүлгийн зохицуулалтыг хэрэглэхээр нэмэлт оруулах

шаардлагатай юу, эсхүл тусад нь гэрээний онцлогт тохирсон зохицуулалт хийх үү гэдгийг шийдвэрлэх нь зохилтой юм.

-ЗЕХ-ийн 92 дугаар зүйлийн 92.2-т захиргааны актад гаргах гомдолд тавигдах шаардлагыг тодорхойлохдоо ИТБАТГӨГШт хуулийн 10 дугаар зүйлийг ишлэсэн байгаа учир ЗЕХ-ийн дагуу гомдлыг хянан шийдвэрлэх харилцаанд уг хууль хэрэглэгдэж байна.

-ИТБАТГӨГШтХуулиар "өргөдөл" ба "гомдол" гэсэн хоёр ойлголтыг нэгтгэн зохицуулснаас захиргааны актад гаргасан гомдол нь уг хуулийн өргөдлийг (санал, мэдэгдлийн шинжтэй) шийдвэрлэх зохицуулалтаар хамтатган шийдвэрлэгдэх нь нийтлэг байна. Учир нь энэ хуульд "гомдол"- ыг тодорхойлсон агуулга нь ЗЕХ-ийн захиргааны актад гомдол гаргах, түүнийг шийдвэрлэх журамтай "зэрэгцсэн" (давхцсан) зохицуулалт болно.

-ЗЕХ-ийн захиргааны актад гомдол гаргах, түүнийг шийдвэрлэх зохицуулалт төдийлөн хэрэглэгдэхгүй байгаа нь ИТБАТГӨГШтХуулийг хэрэглэдэг гэх дээрх байдлаас шалтгаалж байж болох бөгөөд уг хуульд гомдлыг шийдвэрлэх журам нь хэт ерөнхий бөгөөд санал, мэдэгдлийн шинжтэй "өргөдлийг" шийдвэрлэхтэй ижил зохицуулалттай байна.

-Гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагаанд зэрэгцсэн олон хуулийн зохицуулалт хэрэглэгдэх нөхцөл үүссэн. Үүнээс улбаалан Захиргааны ерөнхий хуульд заасан гомдлыг хянан шийдвэрлэх процессын зохицуулалт хэрэглэгдэхгүй байх нөхцлийг үүсгэж байна.

-Түүнчлэн, салбарын хуульд гомдлыг хянан шийдвэрлэх процесс тусгагдаагүй, журам (хэм хэмжээ тогтоосон акт) нь гомдлыг хүлээж авах, талуудыг оролцуулах, гомдлыг шийдвэрлэх процессоос илүү гомдол хянан шийдвэрлэх байгууллагын дотоод процессыг түлхүү зохицуулсан байдгаас үзвэл, салбарын хуулиар гомдол хянан шийдвэрлэх ажиллагаа нарийвчлан зохицуулагдсан гэх тайлбар, тогтсон ойлголт таамаг нь үндэслэлгүй ажээ.

- Судалгаанд хамрагдсан байгууллагуудад гомдлыг шийдвэрлэхэд ЗЕХ-ийн 95-99 дүгээр зүйлд заасан журмыг хэрэглэх талаар ойлголт тогтоогүй, гомдол шийдвэрлэх ажлыг эрхлэх чиг үүрэг бүхий албан тушаалтнууд тодорхойгүй байна.

- Маргаан таслах, гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллагаас бусад тохиолдолд буюу энэ судалгаанд хамрагдсан дээд шатны захиргааны байгууллага гомдлыг ЗЕХ болон бусад хуульд заасан процессын дагуу ажиллагаа хийж шийдвэрлэх талаар төдийлөн хүч чармайлт гаргахгүй байна гэж дүгнэж байна.

-ЗЕХ-д дээд шатны байгууллагын эсхүл гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллагаас гомдлыг шийдвэрлээд гаргах шийдвэрийн төрлийг 98 дугаар зүйлд зааж өгсөн боловч гомдлын шаардлагын төрлийг тодорхой зохицуулаагүй нь гомдлын шаардлагын төрлүүдийн хоорондын ялгааг сайтар гаргахгүйгээр гомдол гаргахад хүргэж байж болзошгүй.

-Дээд шатны байгууллага, албан тушаалтан төдийгүй гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллагууд хүртэл гомдлыг шүүхээс өмнө бодитоор урьдчилан шийдвэрлэх /шалган тогтоох цаг хугацаа, хүн хүч, төсөв, эрмэлзлэл/ боломж муутай байна. Тухайлбал, татварын маргаан таслах зөвлөлийн магадлагч нар татвар төлөгчийн



Remove Watermark Now
pdfelement

Remove Watermark Now

гомдлыг зохих журмын дагуу ажиллагаа хийж цаг хугацаанд нь магадлаж амждаггүй, хугацаа хэтрэлт ихтэй байдаг нь хүний нөөц дутмагтай холбоотой.

-Гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллага эсхүл дээд шатны захиргааны байгууллага гомдлыг хангаагүй тохиолдолд гарч буй шийдвэр нь үндсэн захиргааны актаас тусдаа үр дагавар гаргах эсэх нь одоо ч тодорхойгүй байна.

Нэгтгэн дүгнэвэл, судалгаад хамрагдсан байгууллагын нөхцөл байдалд жишээлэн дүгнэвэл, практикт ЗЕХ-ийн гомдол хянан шийдвэрлэх тухайлсан зорилготой байгууллагуудаас бусад дээд шатны байгууллагад ЗЕХ-ийн 9 дүгээр бүлгийн зохицуулалт төдийлөн үр дүнтэй хэрэглэгдэхгүй байна. ЗЕХ-ийн энэ бүлгийн зохицуулалт зорилгодоо бүрэн хүрэхгүй байгаагийн шалтгаан нь зэрэгцсэн олон хуулийн зохицуулалттай, гомдол хянан шийдвэрлэх хүн хүч, төсөв, цаг хугацаа хүрэлцдэггүй зэрэг байна. Мөн ИТБАТГӨГШтХ-н зохицуулалт давхцсаны улмаас гомдол хянан шийдвэрлэх ажиллагааг саармагжуулсан урьдчилан тооцоолоогүй үр дагавар хуулийн хэрэгжилтэд нөлөөлж байна.

Зөвлөмж: ЗЕХ-ийн энэ бүлгийн зохицуулалтыг саармагжуулж буй ИТБАТГӨГШтХ-г үүргээ гүйцэтгэсэн гэж үзэж халах нь зүйтэй байна. ЗЕХ-ийн 9-р бүлэгт захиргааны гэрээтэй холбогдуулж урьдчилан шийдвэрлүүлэх журмаар гомдол гаргах шаардлага тавигдах эсэх, гомдлын шаардлагын төрлийг тодорхой зохицуулаагүй тул гомдлын шаардлагын төрлүүдийг ялган зааж өгөх талаар холбогдох өөрчлөлт оруулах саналтай. Түүнчлэн, гомдол хянан шийдвэрлэх чиг үүргийг тусад нь байгууллага, бүтцэд хариуцуулсан салбарт захиргааны байгууллагын үндсэн тогтолцооны дээд шатны байгууллага, албан тушаалтанд доод шатны шийдвэрийг хянах эрх хэмжээ давхцуулан хуулиар олгохгүй байх, гагцхүү гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий байгууллага гомдлыг шийдвэрлэх эрхтэй гэсэн зохицуулалт ЗЕХ-д оруулах нь ач холбогдолтой байж болох юм.

pdfelement

**ЗЕХ-ийн 10 дугаар бүлгийн дүгнэлт:**

1.Төрийн буруутай үйл ажиллагаанаас иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирлыг төр хариуцан барагдуулах хуулийн зохицуулалтын хэрэгжилт нь Төсвийн тухай хуулийн дагуу төсөв боловсруулах, батлуулах хугацаанаас хамааран өмнөх оны шүүхийн шийдвэрээр олгогдох хохирлын төлбөр дараа онд хуримтлагдаж байгаа боловч төр иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлыг хугацаа хожимдуулж байгаа хэдий ч барагдуулж байна. Төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас иргэн, хуулийн этгээд хохирох явдал жил ирэх тутам нэмэгдэж байгаа нь улсын төсөвт нилээд ачаалал үүсгэж байна.

2.Иргэний хууль, Захиргааны ерөнхий хууль бусад холбогдох хууль заасны дагуу төрийн буруутай үйл ажиллагаанаас учирсан хохирлыг төр барагдуулж байгаа боловч буцаагаад төрийг хохиролгүй болгох тухай холбогдох хуулийн хэрэгжилт 0 хувьтай байна. Захиргааны ерөнхий хууль батлагдсанаас хойш хугацаанд төдийгүй энэ талаарх эрх зүйн зохицуулалт бусад хуульд бий болсон үеэс хойш энэ нь огт хэрэгжихгүй байна. Судалгааны ажлын явцад хийгдэж, хавсралтад хавсаргасан ярилцлага, асуулга зэргээс үзвэл энэ заалт хэрэгжихгүй байгаа шалтгаан нь төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа байхгүй, хууль хэрэгжүүлэх талаар санаачлагагүй ажилладаг, холбогдох хүний нөөцийг шийдвэрлэж өгөөгүй, буруутай этгээдээс төрд учруулсан хохирлыг буцааж хэрхэн гаргуулж авах талаарх процессыг нарийвчлан журамлаж өгөөгүй зэргэтэй

Remove Watermark Now

холбоотой байна. Иймд уг асуудлыг нарийвчлан зохицуулах шаардлагатай бөгөөд ийнхүү зохицуулахдаа төрийн албан хаагчийг хариуцлагатай байлгах, төр албан хаагчийнхаа ямар алдаа дутагдлын улмаас үүссэн хохирлыг хариуцах, ямрыг албан тушаалтнаас буцаан гаргуулах талаарх зохицуулалт, хамтын удирдлагатай байгууллагын учруулсан хохирлыг буруутай этгээдэд хэрхэн ногдуулах, буруутай этгээдээс төрд учирсан хохирлыг гаргуулах асуудлыг дан ганц төрийн байгууллагын дотоод аудит, эсхүл төрийн аудитад хариуцуулсан байгаа одоогийн тогтолцоо нь оновчтой эсэх, эсхүл уг асуудлыг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх зэрэг асуудлыг нэгтгэн зохицуулах шаардлагатай.

3.Төрийг буцааж хохиролгүй болгох асуудлыг шийдвэрлэхгүй байгаа нь төрийн албан хаагчдыг хариуцлагагүй шийдвэр гаргах замаар иргэн, хуулийн этгээдэд хохирол учруулах явдлыг улам бүр нэмэгдүүлж байх тул буруутай этгээдээр төрийг буцааж хохиролгүй болгох ажиллагааг хэрэгжүүлэх, хэвшүүлэх шаардлагатайг анхаарах.

4.Хохирол, нөхөн төлбөртэй холбоотой харилцааг зохицуулсан Захиргааны ерөнхий хуулийн зарим зүйл, заалтыг илүү тодорхой байдлаар засч хуульчлах (тухайлбал Төрийн албаны тухай хуулийн 39.1, Гаалийн тухай хуулийн 239.4 дэх хэсгүүдийг ЗЕХ-ийн 103.1 дэх хэсэгтэй уялдуулах), бодит практикт үүсэх зарим тохиолдлыг шийдвэрлэхэд хангалттай зохицуулалт агуулаагүй байх (тухайлбал ЗЕХ-ийн 104.2-104.4) тул хууль хоорондын харилцан уялдааг хангах нь зүйтэй.

5. Захиргааны байгууллагын хууль ёсны ажиллагаанаас иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирлыг нөхөн төлөх талаарх хуулийн хэрэгжилтийг судлахад уг асуудал нэгдсэн зохион байгуулалтгүй байгаа бөгөөд, захиргааны байгууллагын хууль ёсны ажиллагаанаас иргэн, хуулийн этгээдэд хохирол учрах гэх ойлголт нь өөрөө тодорхойгүй байна. Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлснээс хойш “захиргааны байгууллагын хууль ёсны үйл ажиллагаанаас иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирол”-ыг хэрхэн нөхөн төлсөн талаарх нэгдсэн тооцоо, судалгаа байхгүй байна. Иймээс захиргааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулах зэрэг зөвлөмжийг хууль санаачлагчид хүргүүлж байна.

pdfelement

**ЗЕХ-ийн 11 дүгээр бүлгийн дүгнэлт:**

1.Судалгаанд хамрагдсан 14 захиргааны байгууллага ЗЕХ-ийн 11-р бүлгийн 105-р зүйлийг хэрэгжүүлж шийдвэр гаргаагүй байна. Иймд үнэлгээ хийх боломжгүй болсон.

2. Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй 660 хуулиас 184 хуульд төрийн албан хаагчдад хүлээлгэх хариуцлагыг зохицуулсан. Төрийн албаны тухай хуулийг эшилсэн 145 хууль байна. Захиргааны алдаатай акт гаргасан тохиолдолд ЗЕХ-иар сахилгын шийтгэл болон уучлал хүсэх шийтгэл хүлээлгэхээр зохицуулсан. Гэм буруутай албан тушаалтанд хүлээлгэж буй сахилгын шийтгэл нь Төрийн албаны тухай хуулиар зохицуулж буй шийтгэлээс хэрхэн ялгаатай болох, давхцал үүсвэл процессыг нь хэрхэн зохицуулах вэ гэдэг асуултууд гарч ирж байна. Эдгээр асуултад онол арга зүйн үүднээс тайлбар гаргах нь зүйтэй болов уу?

3. ЗЕХ-ийн 107-р зүйлийн дагуу нэг ч шүүхийн шийдвэр гараагүй байна.

Зөвлөмж:

1. ЗЕХ-ийн 107. 2 –ийг хэрэглэх талаар нэгдсэн ойлголтонд хүрэх,

2. Хуулийн энэ заалтад “Захиргааны байгууллагын болон шүүхийн шийдвэрийг үл биелүүлсэн албан тушаалтанд холбогдох хуульд заасан хариуцлагыг шүүх оногдуулна.” гэсэн. Судалгаанд оролцогч: “Шүүх зөрчигдсөн эрхийг сэргээх, хамгаалах чиг үүрэгтэй. Хуулиар эрх олгогдсон албан тушаалтны бүрэн эрхийг шүүх хэрэгжүүлэх эрхтэй эсэх, тиймээс энэ заалт ойлгомжгүй байна” гэжээ. Санал: хэрэв шүүхээс буруутай албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх шаардлагатай гэж үзвэл захиргааны хариуцлага хүлээлгэх буюу торгох шийтгэлийн хэлбэртэй байх.

Remove Watermark Now
pdfelement

Remove Watermark Now

pdfelement

**Ханнс-Зайделийн сан**
**Монгол дахь төлөөлөгчийн газар**

**“Эрх зүйн боловсрол”**
**академи**

Сүхбаатарын гудамж 11 /1
ШХ 46/835, 14201 Улаанбаатар
Утас: +976-321294 / 327350
Цахим шуудан: hss@mongol.net
Цахим хуудас: www.mongolia.hss.de

Remove Watermark Now

# Захиргааны ерөнхий хуулийн I, II, IV, X дугаар бүлгийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлангийн Хавсралт 1- 20

pdfelement

Remove Watermark Now

**Хавсралт 1**

**Шүүхийн шийдвэрийн цахим сан дахь Захиргааны хэргийн шүүхэд ЗЕХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.4, мөн зүйлийн 3.1.7-г хэрэглэн хэрэг маргааныг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн үзүүлэлт**

- 2016 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс хойшхи шийдвэр, тодруулбал Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлсэн цаг хугацаанаас хойшхи шийдвэрүүдээс (www.new.shuukh.mn) шүүлт хийхэд ЗЕХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх хэсгийг хэрэглэн шийдвэрлэсэн шийдвэр байхгүй байна.

Харин ЗЕХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь хэсгийг хэлбэр болон агуулгын хувьд дурдсан ***3 кэйс*** (давхардаагүй тоогоор) байна. Тэдгээрийг задалбал: Гурван шатны шүүхийн бүх шатыг дамжин эцэслэн шийдвэрлэгдсэн хэрэг маргааны тоо 1; Анхан болон Давж заалдах шатны шүүхийн шатыг дамжин шийдвэрлэгдсэн хэрэг маргаан 2; дан анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг маргаан 1 байна.

3 кэйсийг маргааны төрлөөр нь тоон үзүүлэлтийг /давхардаагүй тоогоор/ гаргавал:

- Төрийн алба – 2
- Бусад – 1 байна.

pdfelement

## ЗЕХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.7-г дурдсан шүүхийн шийдвэрүүд

Remove Watermark Now

| Д/д | Шүүхийн шийдвэрийн дугаар, огноо /Анхан, давах, хяналт/ | Нэхэмжлэгч | Хариуцагч | Маргааны төрөл ба шийдвэрлэсэн байдлын товч агуулга |
|---|---|---|---|---|
| 1 | АШШ Дугаар: 32<br>Огноо: 2016-11-04<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/2069/view<br><br>ДЗШШ Дугаар: 0259<br>Огноо: 2016-12-20<br>http://new.shuukh.mn/zahirgaadavah/1087/view | А.Дэлгэржаргал, С.Сүхбаатар нар | Говь-Алтай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Т.Ганзориг, Төлөөлөгч Д.Ойнбилэг нар | • **Бусад**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>“Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн анхдугаар хуралдааныг бүхэлд буюу анхдугаар хуралдаанаас гарсан 01,02,03,04 дүгээр тогтоолуудыг хүчингүй болгуулж, анхдугаар хуралдааныг дахин хуралдуулахыг даалгах”<br><br>**ЗЕХ-ийн §3.1.7-г хэрэглэсэн байдал**:<br><br>Нэхэмжлэгч, хариуцагч нар маргаан бүхий шийдвэрүүд нь “улс төрийн шийдвэр гаргах ажиллагаа” мөн, биш эсэх дээр мэтгэлцэн тайлбартаа дурдсан байна. Гэвч анхан болон давж заалдах шатны шүүхийн зүгээс энэ талаар ямар ч дүгнэлт хийгээгүй, дурдаагүй байна. |
| 2 | АШШ Дугаар: 65<br>Огноо: 2017-01-23<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/2656/view<br><br>ДЗШШ Дугаар: 0247<br>Огноо: 2017-03-30<br>http://new.shuukh.mn/zahirgaadavah/1133/view<br><br>ХШШ Дугаар: 212<br>Огноо: 2017-05-31<br>http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/862/view | Б.Бямбадорж | Багануур дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал | • **Төрийн алба**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>““Багануур дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 8 дугаар тогтоолыг хүчингүй болгуулах, 2016 оны 08 дугаар сарын 05-ны өдрөөс 2016 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийг хүртэл ажилгүй байсан хугацааны цалин гаргуулах”<br><br>**ЗЕХ-ийн §3.1.7-г хэрэглэсэн байдал:**<br>Хариуцагчийн зүгээс маргаан бүхий актыг ЗЕХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д заасан “улс төрийн шийдвэр гаргах ажиллагаа” тул ЗХШ-д хамааралгүй гэж мэтгэлцсэн бөгөөд анхан шатны шүүхийн зүгээс тус шийдвэрийг улс төрийн шийдвэр гаргах ажиллагаа биш гэж дүгнэсэн. (Шүүхийн шийдвэрийн 10 дахь талд) Түүнчлэн ДЗШШ шийдвэрийг хэвээр үлдээн өөрчлөлт оруулсан бөгөөд энэ тал дээр дүгнэлт хийгээгүй. ХШШ-ээс хэргийг анхан шатны шүүхэд буцаасан боловч энэ талаар маргаантай асуудал байхгүй. |
| 3 | *АШШ* Дугаар: 7<br>Огноо: 2018-01-08<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/4306/view | Б.Ундрах | Ховд аймгийн Засаг дарга, Ховд аймгийн Зэрэг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал | • **Төрийн алба**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>“Ховд аймгийн Засаг даргын 2017 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн Б/54 дүгээр захирамжийг хүчингүй болгуулах, урьд эрхэлж байсан албан тушаалд эгүүлэн томилохыг даалгах, ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг гаргуулах, мөн хугацааны нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалыг нөхөн төлүүлж бичилт |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| | *ДЗШШ* Дугаар: 0216<br>Огноо: 2018-04-05<br>http://new.shuukh.mn/zahirgaadavah/2140/view | | | хийлгэх”<br><br>**ЗЕХ-ийн §3.1.7-г хэрэглэсэн байдал:**<br>Хариуцагчийн зүгээс маргаан бүхий актыг ЗЕХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д заасан “улс төрийн шийдвэр гаргах ажиллагаа” гэж мэтгэлцсэн боловч анхан болон давж заалдах шатны шүүхээс үүнд холбогдуулан тайлбар, дүгнэлт хийгээгүй байна. |

pdfelement

Remove Watermark Now

**Хавсралт 2**

| ЗЕХ-ийн 4.2.6 /34/ | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Он, сар, өдөр** | **Шүүхийн нэр** | **Дугаар** | **Нэхэмжлэгч** | **Хариуцагч** | **Нэхэмжлэлийн шаардлага** | **Эх сурвалж** |
| 2018.04.20 | Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 11 | А.Б | Засаг дарга | А аймгийн Ө сумын Засаг даргын 2017 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн “Газар эзэмших эрхийг хүчингүй болгох тухай” А/40 дугээр захирамжийн /1 дэх заалтын А.Б-д үр тарианы зориулалтаар 300 га газар хүчингүй болсонд тооцсугай гэх/ А.Б-д холбогдох хэсгүүдийг тус тус хүчингүй болгуулах тухай | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/4506/view |
| 2018.03.15 | Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 7 | Э ХХК | Д Засаг дарга | Д  Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн Газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох тухай А/612 дугаар захирамжийн Э ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгох | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/4485/view |
| 2018.03.02 | Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 137 | Д.М | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд | Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн Б/11 дүгээр тушаалыг бүхэлд нь хүчингүй болгож, нэхэмжлэгч Д.М-ыг урьд эрхэлж байсан Монгол Улсын Боловсролын их сургуулийн захирлын ажил, албан тушаалд эгүүлэн тогтоолгох тухай | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/4410/view |
| 2018.02.09 | Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 03 | Ц ХХК | Засаг дарга | А аймгийн Засаг даргын 2017 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн “Газар эзэмших эрхийг хүчингүй болгох тухай” А/463 дугаар захирамжийн хавсралтын /4, 5/ “Ц” ХХК-д холбогдох хэсгүүдийг тус тус хүчингүй болгох | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/4298/view |
| 2018.01.16 | Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 26 | Ш.Ж | Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга | “Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Б/08 дугаар тушаалын Ш.Ж т холбогдох хэсгийг илт хууль бус болохыг тогтоолгох, Сангийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд эгүүлэн тогтоож, ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг гаргуулах | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/4297/view |
| 2018.01.19 | Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 37 | С.Б | Зам, тээврийн хөгжлийн сайд | “Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн 02 дугаар тушаалыг хүчингүй болгуулах, Төмөр замуудын хамтын ажиллагааны байгууллага дахь Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн яамны төлөөлөгчийн албан тушаалд эгүүлэн тогтоолгох” | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/4296/view |
| 2017.11. | Нийслэл дэх | 846 | Б ХХК | Ашигт | Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн | http://new.shuukh.mn/zahi |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 15 | Захиргааны хэргийн анхан шатны шүүх | | | малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэс | даргын 2017 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 200 дугаар шийдвэрийн “Б” ХХК-нд холбогдох хэсгийг хүчингүй болгож, Ашигт малтмалын ашиглалтын MV-***** дугаартай тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах асуудлыг хуульд заасан журмын дагуу шийдвэрлэхийг Ашиг малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэст даалгуулах тухай | rgaaanhan/4203/view |
| 2017.12.01 | Сүхбаатар аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 45 | Б.А | АИТХД | Сүхбаатар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2017 оны 09 дүгээр сарын 04-ний өдрийн “Сахилгын шийтгэл оногдуулах тухай” Б/25 дугаар захирамжийг хүчингүй болгох | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/4037/view |
| 2017.10.17 | Говьсүмбэр аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 0015 | Ч.Б | Говьсүмбэр аймгийн ИТХТ | Говьсүмбэр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн “Тогтоолын заалт хүчингүй болгох тухай” 10 дугаар тогтоолыг хүчингүй болгуулах тухай | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3881/view |
| 2017.07.14 | Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 544 | Т.Лхагвадорж | Байгаль орчин, аялал жуулчлалын сайд | Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн Б/14 болон Б/16 дугаар тушаалыг хүчингүй болгож, Т.Лхагвадоржийг урьд эрхэлж байсан Мөнххайрхан Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны даргын албан тушаалд эгүүлэн тогтоолгох тухай | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3848/view |
| 2017.05.31 | Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 421 | З.Амгалан | Татварын ерөнхий газрын дарга | Татварын ерөнхий газрын даргын 2016 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн Б/207 дугаар тушаалыг хүчингүй болгож, З.Амгаланг Төв аймгийн Татварын хэлтсийн даргын албан тушаалд эгүүлэн тогтоолгох | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3648/view |
| 2017.08.18 | Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 636 | М.Нямгэрэл | Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар | Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2017 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн Б/12 дугаар тушаалыг хүчингүй болгож, урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд эгүүлэн тогтоолгох | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3581/view |
| 2017.08.28 | Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 0018 | Д.Д | Дорноговь аймгийн З сумын Засаг дарга | Дорноговь аймгийн Засаг даргын “Ажлаас халах тухай” 2016 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн Б/43 дугаар захирамжийг хүчингүй болгож, нэхэмжлэгч Д.Д-ыг түүний өмнө эрхэлж байсан ажил, тушаал болох Дорноговь аймгийн З сумын Засаг даргын Тамгын газрын даргын ажил, албан тушаалд эгүүлэн тогтоолгох | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3576/view |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2017.08.30 | Сүхбаатар аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 29 | Я.Эрдэнэхүү | Сүхбаатар аймгийн ИТХ-ын дарга | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн “Аймгийн ИТХ-ын бүтэц зохион байгуулалтанд өөрчлөлт оруулах тухай” 57 дугаар тогтоол, түүнийг үндэслэн гарсан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын “Ажлаас чөлөөлөх тухай” 2017 оны 04 дүгээр сарын 17-ны Б/16 дугаар захирамжийг тус тус хүчингүй болгож, нэхэмжлэгч Я.Эрдэнэхүүг Сүхбаатар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Дотоод ажил, намын бүлэг хариуцсан мэргэжилтний албан тушаалд эгүүлэн тогтоолгох | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3487/view |
| 2017.08.28 | Сүхбаатар аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 28 | Н.Очирпүрэв | Сүхбаатар аймгийн засаг дарга | Сүхбаатар аймгийн Онгон сумын Засаг даргын 2017 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн “Наваан овогтой Очирпүрэвийг Тамгын газрын даргын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай” Б/14, 2017 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн “Түр орлон гүйцэтгэгч томилох тухай” Б/15 дугаар захирамжийг тус тус хүчингүй болгож, нэхэмжлэгч Н.Очирпүрэвийг Сүхбаатар аймгийн Онгон сумын Засаг даргын Тамгын газрын даргын үүрэгт ажилд эгүүлэн тогтоолгох | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3484/view |
| 2017.07.17 | Хэнтий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 14 | Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Засаг дарга Б.Цогт-Орших | Хэнтий аймгийн Засаг дарга | Хэнтий аймгийн Засаг даргын 2017 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн Б/80 дугаар захирамжийн Б.Цогт-Оршиход холбогдох хэсгийг хүчингүй болгох | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3416/view |
| 2017.07.04 | Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 540 | Б.Эрдэнэцэцэг | Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайд | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн Б/282 дугаар тушаалыг хүчингүй болгож, Б.Эрдэнэцэцэгийг Өмнөговь аймгийн Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газрын даргын албан тушаалд эгүүлэн тогтоох | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3597/view |
| 2017.06.08 | Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 453 | Монголиан коппер корпорейшн ХХК | Монгол Улсын Засгийн газар, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газар | Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн өөрчлөлт, дүрмийн нэмэлт өөрчлөлтийг бүртгэсэн бүртгэл болон дахин олгосон гэрчилгээг тус тус хүчингүй болгож, “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ийн нийт энгийн хувьцааны 49 хувийн эзэмшигчээр “Монголиан коппер корпорейшн” ХХК-ийг бүртгэж, гэрчилгээ олгохыг Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт даалгах | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3303/view |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2017.05.17 | Баянхонгор аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 12 | Ё.Лхагвасүрэн | Баянхонгор аймгийн Засаг дарга | Баянхонгор аймгийн Засаг даргын 2016 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн А/356 дугаар захирамжийг хүчингүй болгож, нэхэмжлэгч Ё.Лхагвасүрэнгийн урьд эрхэлж байсан албан тушаал болох Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн мэргэжилтний албан тушаалд эгүүлэн тогтоолгох тухай | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3245/view |
| 2017.05.25 | Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 405 | Тогоогийн Чулуунгэрэл | Налайх дүүргийн Засаг дарга | Налайх дүүргийн Засаг даргын 2016 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн Б/17 дугаар захирамжийг хүчингүй болгож, "ажил, албан тушаалд эгүүлэн томилуулах, ажилгүй байсан хугацааны цалин олговор гаргуулж, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын дэвтэрт бичилт хийлгэх" | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3298/view |
| 2017.03.20 | Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 0005 | Ойн бирж ХХК | Сайншанд сумын Засаг дарга, Сайншанд сумын ИТХ Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар | Дорноговь аймгийн Сайншанд сумын Засаг даргын 2016 оны А/378 дугаар захирамжийн "Ойн бирж" ХХК-д холбогдох хэсэг, мөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 02/08 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 2 дахь заалт буюу "Ойн бирж" ХХК-д холбогдох хэсгийг тус тус хүчингүй болгож, нэхэмжлэгч "Ойн бирж" ХХК-ийн хүсэлтийг шийдвэрлэж, барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт даалгах | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/2817/view |
| 2017.03.09 | Хэнтий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 5 | Л.Наранбаяр | Дорнод аймгийн Хэрлэн сумын Засаг дарга | Дорнод аймгийн Хэрлэн сумын Засаг даргын 2016 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/04 дүгээр захирамжийг хүчингүй болгох | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3406/view |
| 2017.02.09 | Дархан-Уул аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 11 | "Мөнх зол улам дэлгэр" ХХК | Дархан-Уул аймгийн Засаг дарга | Дархан-Уул аймгийн Засаг даргын 2016 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/441 дүгээр "Газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох тухай" захирамжийн "Мөнх зол улам дэлгэр" ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгох | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/2690/view |
| 2016.10.20 | Сүхбаатар аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 19 | Ц.Алтансүх | Сүхбаатар аймгийн засаг дарга | Сүхбаатар аймгийн Засаг даргын 2016 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн "Ц.Алтансүхийг ажлаас чөлөөлөх тухай" Б/40 дүгээр захирамжийг хүчингүй болгох | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/1922/view |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2017.01.17 | Ховд аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 1 | З.Лхамхүү | Ховд аймгийн Засаг дарга | Ховд аймгийн Засаг даргын 2016 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн Б/58 дугаар "З.Лхамхүүг албан тушаалаас чөлөөлөх тухай" захирамжийг хүчингүй болгож, З.Лхамхүүг урьд эрхэлж байсан Ховд аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газрын даргын албан тушаалд эгүүлэн тогтоох | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3144/view |
| 2017.03.24 | Говь-Алтай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 10 | Т.Сүхбаатар | Цогт сумын Сонгуулийн хороо | Говь-Алтай аймгийн Цогт сумын Сонгуулийн хорооны 2016 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 06 дугаар тогтоолын Т.Сүхбаатарт холбогдох хэсгийг хүчингүй болгож, Т.Сүхбаатарыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрүүлэхээр өргөн мэдүүлэхийг хариуцагч Цогт сумын Сонгуулийн хороонд даалгах | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/2826/view |
| 2017.03.20 | Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 0005 | Ойн бирж ХХК | Сайншанд сумын Засаг дарга Сайншанд сумын ИТХ, Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар | сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 02/08 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 2 дахь заалт буюу "Ойн бирж" ХХК-д холбогдох хэсгийг тус тус хүчингүй болгож, нэхэмжлэгч "Ойн бирж" ХХК-ийн хүсэлтийг шийдвэрлэж, барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт даалгах | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/2817/view |
| 2017.03.10 | Хэнтий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 05 | Л.Наранбаяр | Дорнод аймгийн Хэрлэн сумын Засаг дарга | Дорнод аймгийн Хэрлэн сумын Засаг даргын 2016 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/04 дүгээр захирамжийг хүчингүй болгох | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/2780/view |
| 2017.02.16 | Дархан-Уул аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 15 | Н.Пүрэвдаш | Дархан-Уул аймгийн Засаг дарга | хариуцагч Дархан-Уул аймгийн Засаг даргын 2016 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/443 дугаар газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох тухай захирамжийн Н.Пүрэвдашид холбогдох хэсгийг хүчингүй болгох | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/2745/view |
| 2017.02.15 | Дархан-Уул аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 13 | Ж.Энхтүвшин, Б.Доржсүрэн, Н.Наранбат | Дархан-Уул аймгийн Засаг дарга | хариуцагч Дархан-Уул аймгийн Засаг даргын 2016 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/441 дүгээр "Газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох тухай" захирамжийн Ж.Энхтүвшин, Б.Доржсүрэн, Н.Наранбат нарт холбогдох хэсгийг хүчингүй болгох | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/2743/view |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2017.01.20 | Хөвсгөл аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 00001 | Ж.Даваасүрэн | Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Засаг дарга | Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Засаг даргын 2016 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/09 дүгээр захирамжийг хүчингүй болгож, Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын Засаг даргын 2016 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн А/47 дугаар захирамжийг захиргааны байгууллагаас дахин шинэ акт гаргах хүртэл гурван сарын хугацаагаар түдгэлзүүлэх | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/2676/view |
| 2017.01.16 | Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 38 | Д.Уламбаяр | Баянзүрх дүүргийн Сонгуулийн хороо | Баянзүрх дүүргийн Сонгуулийн хорооны 2016 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 64 дүгээр тогтоолыг хүчингүй болгох | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/2521/view |
| 2017.01.06 | Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 20 | Саяндевелопер ХХК | Байгаль орчин, аялал жуулчлалын сайд | Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн “Газар ашиглах эрхийг дуусгавар болгох тухай” А/11 дүгээр тушаалыг хууль бус болохыг тогтоон “Саяндевелопер”ХХК-нд холбогдох хэсгийг хүчингүй болгох | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/2512/view |
| 2017.03.07 | Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 158 | Сонголонхайрхан ХХК | Ашигт малтмал, Газрын тосны газрын Кадастрын хэлтэс | “Ашигт малтмал, Газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 2016 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 147 дугаар шийдвэрийн “Сонголонхайрхан” ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгох | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/2909/view |

pdfelement

**ЗЕХ-ийн 4.2.8 /1/**

| Он, сар, өдөр | Шүүхийн нэр | Дугаар | Нэхэмжлэгч | Хариуцагч | Нэхэмжлэлийн шаардлага | Эх сурвалж |
|---|---|---|---|---|---|---|
| 2017.03.20 | Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх | 0005 | Ойн бирж ХХК | Сайншанд сумын Засаг дарга, Сайншанд сумын ИТХ, Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар | Дорноговь аймгийн Сайншанд сумын Засаг даргын 2016 оны А/378 дугаар захирамжийн “Ойн бирж” ХХК-д холбогдох хэсэг, мөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 02/08 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 2 дахь заалт буюу “Ойн бирж” ХХК-д холбогдох хэсгийг тус тус хүчингүй болгож, нэхэмжлэгч “Ойн бирж” ХХК-ийн хүсэлтийг шийдвэрлэж, барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт даалгах | http://new.shuukh.mn/zahirgaaanhan/2817/view |

Remove Watermark Now



# ОНОЛЫН СУДАЛГАА

/Нийтийн захиргааны байгууллагыг тодорхойлох асуудал/

Үндсэн хуулийн эрх зүйн үүднээс авч үзвэл төрийн эрх мэдлийг хуваарилах тухай Монтескье-ийн боловсруулсан онолын дагуу төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх хэмээх гурван эрх мэдэлд хуваарилж, тэдгээр нь өөр хоорондоо харилцан тэнцвэртэй хяналтыг хэрэгжүүлэх учиртай гэж үздэг[1] бөгөөд энэ ч агуулгаар 1992 оны Монгол Улсын Үндсэн хуульд тусгалаа олж, хэлбэржин баталгаажсан.

Орчин үеийн захиргааны эрх зүйн онолын хүрээнд ч Үндсэн хуулийн дээрх үзэл баримтлал, эрх мэдлийн хуваарилалтын дотор захиргааны байгууллагыг авч үздэг бөгөөд ингэж үзэхдээ дараах зураглалаар[2] нийтийн захиргаа буюу захиргааны байгууллагыг нарийвчлан ойлгодог болно. Үүнд:




pdfelement

Дээрх зураглалыг тайлбарлахын тулд юуны өмнө орчин үеийн захиргааны эрх зүйн онолд нийтийн захиргаа[3] гэдэг ойлголтыг тайлбарладаг аспектуудыг авч үзэх шаардлагатай байна. Нийтийн захиргааг тодорхойлдог үндсэн 3 аспект бий.[4]

1) Захиргааг зохион байгуулалтын бүтэц талаас нь тодорхойлох;

2) Захиргааг материаллаг утгаар тодорхойлох;

3) Захиргааг формаль утгаар тодорхойлох.

[1] Энэ талаар гадаад, дотоодын олон эрдэмтдийн ном зохиол дээр тэмдэглэсэн байдаг. Тухайлбал, Creifelds Rechtswörterbuch, 19. Auflage, Verlag C.H.Beck, 509 дэх талаас үзэх.
[2] Alfred Katz, Staatsrecht Grundkurs im öffentlichen Recht, 12.überarbeitete Auflage, Verlag C.F.Müller, 190 дэх талаас эхлэн үзэх.
[3] Монголд "төрийн захиргаа" гэх ухагдахуунаар түгээмэл хэрэглэдэг, Т.М.
[4] Hartmut Maurer, Allgemeines Verwaltungsrecht, 16. Auflage, Verlag C.H.Beck, 1-2 дахь тал

Remove Watermark Now

Захиргааг зохион байгуулалтын бүтэц талаас нь тайлбарлавал: нийтийн захиргаа гэдэгт захиргааны үйл ажиллагаа явуулж байгаа захиргааны байгууллага, захиргааны байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлж байгаа бусад этгээдийг хамтад нь ойлгох буюу захиргааны байгууллагуудыг ойлгодог.

Захиргааг материаллаг утгаар нь тайлбарлавал: нийтийн захиргаа гэдэгт захиргааны үйл ажиллагааг, өөрөөр хэлбэл, захиргаанд оногдуулсан чиг үүргийг (=хуулийг) амьдрал дээр хэрэгжүүлж буй төрийн үйл ажиллагааг ойлгодог. Тодруулбал, зөвхөн гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагаа гэж үздэг.

Захиргааг формаль утгаар нь тайлбарлавал: нийтийн захиргаа гэдэгт материаллаг утгаар хуулийг хэрэгжүүлж байгаа эсэхээс үл хамаарч захиргааны байгууллагаас явуулж буй бүхий л үйл ажиллагааг ойлгодог.

Захиргааг материаллаг болон формаль утгаар тодорхойлсон дээрх хоёр аспектын хоорондын ялгааг авч үзэхдээ төрийн эрх мэдэл хуваарилалтын хүрээг шалгуур хийдэг. Формаль утгаараа захиргаа нь хуулийг хэрэгжүүлж байгаа эсэхээс үл хамаардаг захиргааны шинжтэй үйл ажиллагаа байдаг тул зөвхөн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд төдий бус, хууль тогтоох болон шүүх эрх мэдлийн дотор ч захиргааны шинжтэй үйл ажиллагаа явагддаг гэж үздэг. Тухайлбал, парламентын ажлын алба буюу УИХ-ын Тамгын газрын захиргааны шинжтэй үйл ажиллагаа, шүүхийн ажлын алба буюу Шүүхийн Тамгын газрын захиргааны шинжтэй үйл ажиллагаа гэх мэт нь хэдийгээр хууль тогтоох хийгээд шүүх эрх мэдлийн дотор оршин байгаа боловч нийтийн захиргаа болно гэж үздэг.

Харин материаллаг утгаараа захиргаа нь хуулийг амьдрал дээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу цэвэр гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагаа гэж үздэг тул энэ аспект нь өөрөө онол-практикийн маргаан ихээхэн дагуулдаг.[5] Гэвч энэхүү аспектын хүрээнд Германын захиргааны эрх зүйн эрдэмтэд нийтийн захиргааг тодорхойлох дараах 2 аргыг хөгжүүлсэн.[6]

pdfelement

1) Эерэг арга

2) Сөрөг арга

Эерэг аргаар нийтийн захиргааг тодорхойлоход нийтийн захиргаанд байх нийтлэг шинжүүдийг нэг бүрчлэн тоочих замаар илэрхийлдэг. Тухайлбал:

- Төрийн зорилт, хууль тогтоогчийн хүсэл зоригийг тухайн тохиолдолд хэрэгжүүлдэг
- Засгийн газраас гаргасан улс төрийн шийдвэрийн хүрээнд үйл ажиллагаа нь тодорхойлогддог ба хязгаарлагддаг
- Тухайн тохиолдолтой холбогдол бүхий шийдвэр гаргаж, удирдан чиглүүлдэг
- Үйл ажиллагаандаа ихэвчлэн захирамжилсан арга хэрэглэдэг

---

[5] Hartmut Maurer, Allgemeines Verwaltungsrecht, 16. Auflage, Verlag C.H.Beck, 2 дахь тал

[6] Hartmut Maurer, Allgemeines Verwaltungsrecht, 16. Auflage, Verlag C.H.Beck, 2-4 дэх талаас үзэх. Мөн энэ талаар профессор, доктор П.Одгэрэл, Захиргааны эрх зүйн ерөнхий анги, 3 дахь хэвлэлт, 2016, 28 дугаар талаас үзэж болно. Гэхдээ Германын захиргааны эрх зүйн эрдэмтэд одоог хүртэл дээрх хоёр аргыг төгс гэж үздэггүй бөгөөд аль аль нь асуудалтай хэмээн тэмдэглэдэг. Энэ нь захиргааны байгууллагын үйл ажиллагаа олон талтай бөгөөд тэдгээрийн чиг үүрэг ирээдүйд хувьсан өөрчлөгдөх боломжтой байдагтай холбоотой гэж тайлбарладаг.

Remove Watermark Now

- Тодорхой чиг үүргийг эрх хэмжээнийхээ хүрээнд хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлдэг

- Төрийн үйлчилгээ үзүүлдэг гэх мэт.

Дээрх шинжүүд нь хийсвэр бөгөөд ойлгоход хүндрэлтэй гэдгээс гадна хувьсан өөрчлөгдөх боломжтой буюу тогтворгүй гэж шүүмжлэгддэг болно. Иймд захиргааны эрх зүйн нэрт эрдэмтэн Волфф болон Бахоф нар дээрх шинжүүдийг нэгтгэн “Захиргаа нь материаллаг утгаараа нийгмийн гишүүдийн олон талт, нөхцөл болзол бүхий, эсхүл тодорхой зорилгод чиглэсэн нийтийн үйл хэргийг хэрэгжүүлэхэд тусгайлан зориулагдсан, үйл ажиллагаагаа бие даан явуулж, шийдвэр гаргадаг, түүнийгээ биелүүлж хариуцдаг нийгмийн үйл хэргийг гардан хэрэгжүүлэгч юм”[7] хэмээн тодорхойлолт өгөх оролдлого хийсэн байдаг.

Сөрөг аргаар нийтийн захиргааг тодорхойлоход нийтийн захиргаанд үл хамаарах хэсгийг нь тоочих байдлаар буюу хүрээг нь хязгаарлах замаар нийтийн захиргааг тодорхойлдог. Захиргааг сөрөг аргаар тодорхойлбол “Захиргаа гэдэг нь хууль тогтоох болон шүүх эрх мэдлээс бусад төрийн үйл ажиллагаа юм”.[8]

Дээрх тодорхойлолтыг төрийн эрх мэдэл хуваарилах онолтой холбон тайлбарлавал захиргаа нь зөвхөн гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагаа хэмээн ойлгож болно. Гэвч дээр дурдсанчлан хууль тогтоох болон шүүх эрх мэдлийн байгууллагаас тодорхой тохиолдолд захиргааны хяналтын үйл ажиллагаа явуулдаг гэдгийг мартаж болохгүй юм. Тийм учраас энэхүү аргыг мөн л асуудалтай гэж үздэг.

Ийм учраас орчин үеийн захиргааны эрх зүйн онолд нийтийн захиргаа буюу захиргааны байгууллагыг тодорхойлохдоо формаль болон материаллаг аспектыг аль алиныг нь хослуулах чиг хандлагатай болсон.[9]

pdfelement

Дээр дурдсанаар нийтийн захиргааг формаль болон материаллаг аспектыг хослуулан тодорхойлохдоо төрийн гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагааг дотор нь **губернатив[10] болон административ** гэж хоёр ангилан авч үзнэ.

Тодруулан тайлбарлавал, гүйцэтгэх эрх мэдлийн губернатив үйл ажиллагааг гүйцэтгэх эрх мэдлийн административ буюу захиргааны үйл ажиллагаанаас салган зааглах учиртай.[11] Губернатив үйл ажиллагаа нь Засгийн газрын үйл ажиллагаа байна гэдэг нь тодорхой хэдий ч нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна.

Губернатив үйл ажиллагаа гэдэгт төрийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлдог, тодорхойлсон чиглэлийнхээ хүрээнд төрийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулдаг, ингэхдээ төрийн үйл ажиллагааг улс төрийн удирдлагаар хангах замаар улс төрийн хувьд удирддаг Засгийн газрын улс төрийн шинжтэй үйл ажиллагааг ойлгоно.[12] Тухайлбал, Засгийн газраас үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, стратеги төлөвлөгөө, хөгжлийн хөтөлбөр, үндэсний болон бүс нутгийн бодлого, салбарын бусад бодлогын баримт бичиг боловсруулж батлах, түүнийгээ хэрэгжүүлэхдээ доод шатны байгууллагуудаа удирдамж, чиглэл өгөх, улс төрийн удирдлагаар хангах, Төрийн албаны тухай хуульд заасан улс

[7] Wolff/Bachof, Verwaltungsrecht I, §2 III дахь хэсэгт
[8] Hartmut Maurer, Allgemeines Verwaltungsrecht, 16. Auflage, Verlag C.H.Beck, 3 дахь тал
[9] Мөн тэнд
[10] Улс төрийн болон бодлогын шинжтэй үйл ажиллагаа, Т.М.
[11] Alfred Katz, Staatsrecht Grundkurs im öffentlichen Recht, 12.überarbeitete Auflage, Verlag C.F.Müller, 192 дахь тал
[12] Мөн тэнд

Remove Watermark Now

төрийн албан тушаалтнуудыг эрх хэмжээнийхээ хүрээнд томилж, чөлөөлөх гэх мэт Засгийн газрын улс төрийн шинжтэй[13] үйл ажиллагаа нь губернатив үйл ажиллагаа болно.

Засгийн газрын губернатив үйл ажиллагаа нь нэгэнт захиргааны үйл ажиллагаа биш тул Захиргааны хэргийн шүүхийн хяналтаас гадуур байна.

Харин административ буюу захиргааны үйл ажиллагаа гэдэг нь хууль тогтоогчийн баталсан хууль болон Засгийн газраас гаргасан шийдвэрийн хүрээнд тодорхойлогдсон буюу зохицуулагдсан, хууль тогтоомжийг амьдралд хэрэгжүүлэх хүрээнд хууль, эрх зүйтэй холбогдсон үйл ажиллагааг ойлгоно.[14] Тодруулбал, энд Засгийн газрын болон бусад захиргааны байгууллагын хууль биелүүлж байгаа захиргааны шинжтэй бүх үйл ажиллагаа хамаарна.

Нэгэнт энэ харилцаанд хууль тогтоогчийн батлан гаргасан хуулийг Засгийн газар болон бусад захиргааны байгууллагууд хэрэглэж, хэрэгжүүлдэг тул иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн, эсхүл зөрчсөн шийдвэр гаргадаг. Тийм учраас Засгийн газар болон бусад захиргааны байгууллагууд нь иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн, эсхүл зөрчсөн бол шүүхээс тэдгээр иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээх ёстой[15] тул Засгийн газрын болон бусад захиргааны байгууллагын административ буюу захиргааны шинжтэй үйл ажиллагаанд шүүхийн хяналт гарцаагүй байх учиртай болдог. Тодруулбал, энд Захиргааны шүүхийн хяналт зайлшгүй яригдана. Тэгж гэмээнэ Монгол Улсын Үндсэн хуулиар бэхжүүлсэн эрх зүйт төрийн зарчим хэлбэрэлтгүй хэрэгжинэ.

Дээрх бүгдээс дүгнэж хэлбэл, Засгийн газар нь эртний Грекийн Янус бурхан[16] мэт хоёр нүүртэй субъект гэж хэлж болох бөгөөд губернатив болон административ үйл ажиллагааг аль алиныг нь явуулдаг. Гагцхүү Засгийн газрын губернатив үйл ажиллагаа нь улс төрийн бодлогын шинжтэй удирдлагын үйл ажиллагаа байдаг тул Захиргааны хэргийн шүүхийн хяналтаас гадуур байна. Харин Засгийн газрын хуулийг биелүүлж буй захиргааны шинжтэй үйл ажиллагаа нь Захиргааны хэргийн шүүхийн хяналтад байх учиртай байна.

pdfelement

Гэвч Засгийн газар захиргааны байгууллага биш тухай маргаан практикт байдгийг үгүйсгэхгүй бөгөөд энэхүү маргаан нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 02 дугаар дүгнэлтээс улбаатай юм.[17]

Тухайн маргааны хүрээнд Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргасан нэр бүхий иргэд "... Монгол Улсын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д Монгол Улсын Засгийн газраас гаргасан шийдвэрийг Захиргааны хэргийн шүүх хянан үзэхээр зааж, уг хуулийн 8.1.2-т заасны дагуу хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч болохоор заасан нь Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 1, 45 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн. Учир нь, Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 1-д: "Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн", мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1-д: Засгийн газар нь "Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах" бүрэн эрхтэй гэж заасан. Иймч учраас Монгол Улсын Үндсэн

---

[13] Политика буюу улс төр гэх ухагдахууны хүрээнд нийгмийн амьдралыг удирдан зохион байгуулах төрөл бүрийн бодлогыг ойлгодог. Жишээ нь: Хууль зүйн бодлого, эдийн засгийн бодлого, соёлын бодлого, бүс нутгийн бодлого гэх мэт. Энэ талаар Wolff/Bachof, Verwaltungsrecht I, §18 I b дахь хэсэгт.

[14] Wolff/Bachof, Verwaltungsrecht I, 76 дахь талаас эхлэн үзэх.

[15] Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2, 16 дугаар зүйлийн 14 дэх хэсгийг харах.

[16] Янус бурхан – Эртний Грекийн домогт гардаг хоёр нүүртэй бурхан, Т.М.

[17] С.Магнайсүрэн, Б.Энхбаяр нарын мэдээллийн дагуу "2002 оны Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 болон 4.1.6 дахь заалт нь Үндсэн хууль зөрчсөн" гэж дүгнэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 02 дугаар дүгнэлт. http://www.legalinfo.mn/law/details/997?lawid=997

Remove Watermark Now

хуулийн 41 дүгээр зүйлд “1.Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг УИХ-ын өмнө хариуцна. 2.Засгийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана”, 45 дугаар зүйлийн 2-т: “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно” гэж хуульчилсан” гэж өөрсдийн мэдээллийн шаардлагыг үндэслэсэн байна.

Харин тухайн үед УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон оролцсон УИХ-ын гишүүн Р.Эрдэнэбүрэн, С.Баярцогт нар мэдээлэл гаргасан иргэдийн үндэслэлийг няцааж “... Захиргааны байгууллага, албан тушаалтан нь нийтийн ашиг сонирхлыг илэрхийлсэн хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр бусдыг захирамжилсан, иргэн, хуулийн этгээдийн Үндсэн хууль, бусад хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн олон тооны шийдвэр гаргаж байгаа боловч практикт захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, тэдний гаргасан захиргааны актын хууль зүйн үндэслэлийг хянах механизмыг оновчтой тогтоох зорилгоор Засгийн газраас 2001 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсэн бөгөөд энэ хуулийн төсөлд захиргааны хэргийн шүүх нь Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Засгийн газар, Засгийн газрын гишүүн /Ерөнхий сайд, сайд/, Монгол Улсын яам, Сонгуулийн ерөнхий хороо гэх мэт нийтийн эрх зүйн 17 субъекттэй холбогдсон маргааныг хянан шийдвэрлэхээр тусгасан байв. Улсын Их Хурлын чуулганаар Ерөнхийлөгчөөс эрх зүйн үр дагавар шууд бий болгодог захирамжилсан шийдвэр гаргах явдал бараг тохиолдохгүй мөн Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчсөн бол огцруулах асуудлыг нэгэнт Үндсэн хуулиар зохицуулсан учир хуулийн “Монгол Улсын Ерөнхийлөгч” гэсэн заалтыг хасч, харин гүйцэтгэх эрх мэдлийн дээд байгууллага болсон Засгийн газрын шийдвэр нь шүүхийн журмаар хянагдаж байх нь зүйтэй гэж үзэж хуулийн төсөлд хэвээр үлдээжээ. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2-ийн “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно” гэсэн заалт нь нэгдүгээрт, төрийн гүйцэтгэх эрх мэдлийн дээд байгууллага болох Засгийн газарт гаргасан алдаагаа өөрөө засах боломж олгож байгаа; хоёрдугаарт, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлаас Засгийн газрын гаргасан алдааг залруулах явдлыг зохицуулсан зүйл гэж үзэж байна. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12-т Монгол Улсын иргэн “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй”, мөн зүйлийн 14-т “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх... шударга шүүхээр шүүлгэх... эрхтэй” гэсэн заалтыг иш үндэс болгож, улмаар Монгол Улсын нэгдэн орсон олон улсын конвенцийн, тухайлбал, Хүний эрхийн түгээмэл тунхаглалын “Үндсэн хууль бусад хуулиар олгосон эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй” гэсэн Наймдугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын “Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч ялгаварлан гадуурхалтгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй...” гэсэн Хорин зургадугаар зүйлийн заалтуудыг баримтлан захиргааны хэргийн шүүхээс Монгол Улсын Засгийн газрын гаргасан захиргааны хууль бус акттай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэх тухай асуудлыг хуульчилсан ...” хэмээн үндэслэл бүхий тайлбар өгч байжээ.[18]

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц дээрх маргааныг хянан шийдвэрлэж, 2005 оны 02 дугаар дүгнэлтийг гаргасан бөгөөд тухайн үеийн Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх

[18] Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 02 дугаар дүгнэлтээс үзэх.

тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт нь Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1, Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн байна гэж шийдвэрлэсэн байдаг. Ийнхүү шийдвэрлэхдээ дэвшүүлсэн үндэслэл нь "Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно" гэсэн нь Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсын Засгийн газар төрийн гүйцэтгэх дээд байгууллага болохынх нь хувьд түүний шийдвэр хуульд нийцээгүй тохиолдолд хүчингүй болгох эрх бүхий субъектыг Үндсэн хуулиар тусгайлан тогтоосон байна. Улсын Их Хурал, Засгийн газар Үндсэн хуульд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд Үндсэн хуулийн цэцэд хандаж шийдвэрлүүлж болох нь нээлттэй байна. Хууль тогтоогчоос Засгийн газрын шийдвэрийг Захиргааны хэргийн шүүх хянаж байхаар хуульчилсан нь Үндсэн хуулиар тусгайлан тогтоосон Засгийн газар, Улсын Их Хурлын эрх хэмжээнд халдсан гэх үндэслэл тогтоогдож байна" гэсэн байдаг.[19]

Гэвч Үндсэн хуулийн цэц дээрх дүгнэлтээ гаргахдаа УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч нарын гаргасан тайлбарт байсан "... Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно" гэсэн заалт нь нэгдүгээрт, төрийн гүйцэтгэх эрх мэдлийн дээд байгууллага болох Засгийн газарт гаргасан алдаагаа өөрөө засах боломж олгож байгаа; хоёрдугаарт, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлаас Засгийн газрын гаргасан алдааг залруулах явдлыг зохицуулсан зүйл гэж үзэж байна ..." гэсэн үндэслэлтэй тайлбарт огт дүгнэлт хийгээгүй, түүнчлэн Засгийн газар Үндсэн хуулиас бусад хуулийг зөрчсөн, тэрхүү шийдвэр нь иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол ямар шүүх хянах вэ гэдгийг бодолцохгүйгээр рациональ бус шийдвэр гаргасан байдаг.

pdfelement

1992 оны Үндсэн хуулийн эх баригч, нэрт хуульч эрдэмтэн Б.Чимид багш дээрх маргааныг шийдвэрлэсэн Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 02 дугаар дүгнэлтийг хурцаар шүүмжилж 2005 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр сонинд ярилцлага өгсөн байдаг бөгөөд түүнд "... Захиргааны хэргийн шүүх "дараах байгууллага, албан тушаалтнаас гаргасан захиргааны хууль бус актад холбогдох маргааныг хянан шийдвэрлэнэ" гэсэн уг хуулийн IY зүйлийн нэг дэх хэсгийн заалт буюу хариуцагч байгууллагын нэрийн жагсаалтаас "Монгол Улсын Засгийн газар", "Сонгуулийн ерөнхий хороо" гэсэн (4.1.1, 4.1.6) заалтыг Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн юм. Ойлгомжгүй, мэргэжлийн бус энэ дүгнэлтийг нь парламент нухацтай хэлэлцэлгүй уухайн тас гэсэн мэт шууд л хүлээн зөвшөөрсөн. Ингэснээр Монголд үүсгэн төлөвшүүлж буй ардчиллын чухал механизм, хүний эрх, шүүх эрх мэдлийн хүрээнд болон хууль дээдлэх ёсонд харш ноцтой хохирол учруулах үр дагавар бий болгосон юм. Уг асуудал нарийн мэргэжлийн нэлээд ээдрээтэй зангилаа учраас олон түмэн төдийлөн анхаарч, учрыг нь ойлгоогүй байж болох юм. Хураангуйлж дүгнэвэл Үндсэн хуулийн цэц, УИХ-ын эл шийдвэр нь нэгдүгээрт, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага болох Засгийн газар, түүний гишүүд, яам болон Засгийн газрын гишүүний тэргүүлсэн агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын хийгээд сонгуулийн хууль биелүүлэх үүрэгтэй гүйцэтгэх байгууллагын засаг захиргааны үйл ажиллагааг шүүхийн хяналтаас гаргаж дархаллаа. Хоёрдугаарт, аливаа хэрэг, эрх зүйн маргааныг эцсийн дүнд гагцхүү шүүх хянан төгс шийдвэрлэнэ гэсэн агуулга бүхий Үндсэн хуулийн үзэл баримтлалыг хөсөрдүүлж, шүүхийн хараат бус байдалд халдан нэг шүүх (Цэц) нь нөгөө шүүхийнхээ Үндсэн хуульчлагдсан бүрэн эрхийг хасч хязгаарлалаа. Гуравдугаарт, Цэц, УИХ хоёрын шийдвэрийн хамгийн ноцтой бөгөөд нэлээд далд мэт гажуудал нь "төрийн

[19] Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 02 дугаар дүгнэлтээс үзэх.

| **Анхан шат** | 73 | 57 | 41 | 69 | **240** |
| **Давж заалдах** | 24 | 28 | 14 | 17 | **83** |
| **Хяналтын шат** | 13 | 14 | 10 | 8 | **45** |

| **Д/д** | **Шүүхийн шийдвэрийн огноо, дугаар, шүүх** | | | **Нэхэмжлэгч** | **Хариуцагч** | **Маргааны төрөл** | **Товч агуулга** |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2016.06.23 | 466 | Нийслэл дэх Захиргааны хэргийн шүүх | Т.Жигмэддагва, С.Хуягсүрэн | Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал | Бусад | Нэхэмжлэгч Т.Жигмэддагва нь 2015 оны 01 сарын 23-ны өдөр 80-89 УБА улсын дугаар бүхий машинаа Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэр болох Голомт банкны үүдэнд тавьсан байхад “Биг Айрон” ХХК-аас “Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2014 оны 98 дугаар тогтоолыг үндэслэн дугуйг түгжиж, улмаар 20,0 төгрөгөөр торгосон байна.<br>Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.6 дахь заалт болон Хууль зүйн сайдын 2014 оны А/218 дугаар тушаалаар батлагдсан Зориулалтын чирэгч автомашин ашиглан тээврийн хэрэгслийг зөөж шилжүүлэх журам"-ын дагуу "замын хөдөлгөөний дүрмээр түр буюу удаан зогсохыг хориглосон замын зорчих хэсэгт зайлшгүй зогсолтоос бусад хэлбэрээр зогсоож, хөдөлгөөнд саад учруулсан тээврийн<br>хэрэгслийг зөөж шилжүүлэхээр зохицуулсан байна. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид нь "Зориулалтын дугуй түгжигч ашиглах журам" батлан гаргаж, "түр буюу удаан зогсохыг хориглосон замын хэсэгт зогссон тээврийн хэрэгслийн дугуйг түгжихээр зохицуулалт хийсэн нь хуулиар зохицуулсан харилцааг өөрөөр зохицуулж, иргэдийн хуулиар хамгаалагдсан эрхийг хязгаарласан, аж ахуйн нэгжүүдэд давуу байдал олгож, төлбөр хураамж хууль бусаар хураалгасан гэж үзэх үндэслэл болсон.<br>Иймд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 70-р зүйлийн 70.2.3-т зааснаар Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2014 оны 06 дугаар сарын 26-ны өдрийн 98 дугаар |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | тогтоол нь илт хүчин төгөлдөр бус болохыг хүлээн зөвшөөрүүлж шийдвэрлүүлэхээр нэхэмжлэл гаргасан. **Шүүхийн шийдвэр:** Замын хөдөлгөөний дүрмээр зохицуулдаг хөдөлгөөний хориглосон заалтыг зөрчсөн этгээдэд хуулиар эрх олгосон улсын байцаагч захиргааны хариуцлага хүлээлгэх хуульчилсан заалтыг журмын хүрээнд гэрээгээр, түүнчлэн хуулиар эрх олгогдоогүй этгээд хэрэгжүүлж байгаа нь хууль бус бөгөөд ингэснээрээ маргаан бүхий журмыг илт хууль бус гэж тооцох үндэслэлтэй гэж үзэн нэхэмжлэлийн шаардлагыг хангасан. |
| 2 | 2011.11 .09 | №0439 | Нийслэлийн Захиргааны хэргийн шүүх | Ц.Болд | Сонгинхайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал | Төрийн алба | Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 12-р тогтоолоор 2010 оны 3 дугаар сарын 08-ны өдрийн Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 4 дүгээр хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн олонхийн буюу 77.8 хувийн санал авсан Цэгмидийн Болдыг Сонгинохайрхан дүүргийн Засаг даргад нэр дэвшүүлэн, томилж өгөхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид санал болгосон байна. Үүний дагуу Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3, 26.5, 29 дүгээр зүйлийн 29.2-т заасныг үндэслэн Ц.Болдыг Сонгинохайрхан дүүргийн Засаг даргаар томилсон Нийслэлийн Засаг даргын 2010 оны 3-р сарын 09-ний өдрийн 179 дүгээр захирамж хүчинтэй хэвээр байгаа нь тогтоогдож байна. Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 4 дүгээр хуралдаан 2010 оны 12 дугаар сарын 17-18, 20, 23-ны өдөр үргэлжлэн хуралдаж, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль /Цаашид Хуулийн гэх/-ийн 25 дугаар зүйлийн 25.1, 25.4-т заасныг тус тус үндэслэн, 2010 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 14-р “Хуралдааны тогтоол хүчингүй болгох тухай” тогтоолоор 2010 оны дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 4 дүгээр Хуралдааны 08, 09, 10, 11, 12 дугаар тогтоолуудыг хүчингүй болсонд тооцсон байна. Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан бөгөөд Хуулийн 23 дугаар зүйлийн 23.7-д дүүргийн Хурлын хуралдаанд тухайн Хурлын нийт төлөөлөгчдийн олонхи нь хүрэлцэн ирсэн бол хүчинтэйд тооцох бөгөөд мөн Хуулийн 23 дугаар зүйлийн 23.8-д хүндэтгэн үзэхээс бусад шалтгаанаар Хурлын төлөөлөгч зориудаар хуралдаанд оролцохгүй байх буюу түүнийг орхиж гарахыг хориглосон байна. Үүнээс үзвэл дээрх 2010 оны 3 дугаар сарын 08-ны өдрийн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 4 дүгээр хуралдаанд нийт 18 төлөөлөгч буюу олонх оролцсоноос, 4 төлөөлөгч орхиж гарсан нь хууль бус байх бөгөөд Хуулийн 23 дугаар зүйлийн 23.9-д “Хуралдаанд зориудаар оролцоогүй буюу орхиж гарсан тохиолдолд хуралдаанд оролцож эсрэг санал өгсөнд тооцож санал хураалт явуулна.” гэж заасны дагуу дээрх 12 дугаар тогтоолыг батлахдаа хуралдаанд оролцсон 14 |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | төлөөлөгч дэмжсэн, хуралдааныг орхиж гарсан буюу 4 төлөөлөгч эсрэг санал өгсөнд тооцон Хурлын 12 дугаар тогтоол баталсныг “олонх оролцоогүй хуралдаанаас гарсан хууль бус тогтоол” гэж үзэх үндэслэлгүй юм. Иймд Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2010 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 14 дүгээр тогтоолын Нэг дэх хэсгийн 12 дугаар тогтоолд холбогдох хэсгийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн. |
| 3 | 2013.03 .27 | 0123 | Нийслэлийн Захиргааны хэргийн шүүх | Монгол ардын хувьсгалт нам | Нийслэлийн Налайх дүүргийн Сонгуулийн хороо, Налайх дүүргийн ИТХ<br>Гуравдагч этгээд иргэн Ё.Бямбатогтох, Ц.Минжинхүү | Сонгууль | Сонгуулийн хорооноос намын жагсаалтаар болон хороонд нэр дэвшигчдийг нэгдсэн нэг жагсаалтаар ирүүлэхийг мэдэгдсэний дагуу Налайх дүүргийн Мянгатын зөвлөлөөс 2012 оны 11 сарын 07-ны өдрийн 37 дугаар албан бичгээр хүргүүлсэн Хавсралтад нийт нэр дэвшигчдээ нэгдсэн жагсаалтад оруулж, хороонд нэр дэвшигчийн ард нэр дэвшсэн тухайлсан хороог, намын жагсаалтаар нэр дэвшигчийн ард жагсаалтад эрэмбэлэгдсэн дугаарыг тухайлан тэмдэглэсэн байна. Сонгуулийн санал хураалтын дараа МАХН нь саналаа өгсөн нийт сонгогчдын 24,2 хувийг авч дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд 2 суудал авсан ба намын нэрийн жагсаалтын"нэг"-д эрэмбэлэгдсэн Дашзэвэгийн Цогоо, "хоёр"-т эрэмбэлэгдсэн Цогбадрахын Хатанбаатар нар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр сонгогдсон нь хуулийн дагуу тодорхой болсон юм. Гэтэл Налайх дүүргийн сонгуулийн хороо 2012 оны 11 сарын 24-ний өдрийн "Санал хураалтын дүнгийн тухай" 28 дугаар тогтоолын 6 дахь заалтад МАХН-аас дүүргийн 1, 2 дугаар хороонд буюу МАХН-ын нэрийн жагсаалтад ороогүй Ёндонсамбуугийн Бямбатогтох, Цэдэнбалжирын Минжинхүү нарыг намын жагсаалтын эхэнд бичигдсэн гэж Налайх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдөөр сонгогдсонд үндэслэлгүйгээр тооцож , түр үнэмлэх олгосон байна. Сонгуулийн хууль тогтоомжоор нэр дэвшигч нь зөвхөн нэг хороонд нэр дэвших ба хороонд нэр дэвшсэн иргэн намын нэрийн жагсаалтад давхар орох үндэслэлгүй болно. Дээрх нөхцөл байдлыг дүгнэж, шүүх нь нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангасан. |
| 4 | 2017.05 .03 | 337 | Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх | Д.Гэрэлт-Од | Баянгол дүүргийн ИТХ, Засаг дарга | Газар | Анх Баянгол дүүргийн Засаг даргын 2006 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 362 дугаар захирамжаар “дүүргийн 20 дугаар хорооны нутагт хүний үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж, ашиглалтгүй орхигдсон, барилгын болон ахуйн хур хогтой газрыг өөрийн хөрөнгөөр цэвэрлэж, нөхөн сэргээн, аж ахуйн зориулалтаар ашиглахаар хүсэлтээ ирүүлсэн” гэх үндэслэлээр нэхэмжлэгч Д.Гэрэлт-Одод Баянгол дүүргийн 20 дугаар хороо, ТЭЦ-4 станцын урд байрлалтай, 10000 м.кв газрыг 4 жилийн хугацаатай, аж ахуйн зориулалтаар эзэмшүүлж, газар эзэмших эрхийн 0286422 дугаартай гэрчилгээ олгож, газар эзэмшүүлэх гэрээ байгуулсан байна. Улмаар Баянгол дүүргийн Засаг даргын 2011 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 564 дүгээр захирамжаар нэхэмжлэгч Д.Гэрэлт-Одын газар эзэмших эрхийг 5 жилийн хугацаагаар сунгаж, газар эзэмших эрхийн |

Remove Watermark Now

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Гуравдагч этгээд Б.Туул | | 0364045 дугаартай гэрчилгээ олгож, газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулсан байна. Нэхэмжлэгч нь дээрх захирамжуудаар газраа эзэмших явцдаа хууль, журамд заасны дагуу төсөл сонгон шалгаруулалтын анхны үнэ болон тухайн жилийн газрын төлбөрүүдээ бүрэн төлж ирсэн болох нь хэрэгт авагдсан 2009 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн №49, 2011 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн №49 тоот “Газар ашиглаж, эзэмших гэрээ дүгнэж, газрын төлбөрийн тооцоо нийлсэн акт протокол”-ууд, газрын албаны нэхэмжлэх, төлбөр төлсөн зэрэг нь баримтуудаар тогтоогддог байна. Гэтэл маргаан бүхий Баянгол дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 8/02 дугаар тогтоолоор “Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5.3, 31 дүгээр зүйлийн 31.2, 33 дугаар зүйлийн 33.1.2, 33.4 дэх заалтыг зөрчиж газар эзэмших эрх олгосон, 40 дүгээр зүйлийн 40.1.6 дахь заалтыг зөрчиж газрыг хуульд заасан хугацаанд гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглаагүй” гэх үндэслэлээр нэхэмжлэгч Д.Гэрэлт-Одын газар эзэмших эрхийг хүчингүй болгохыг дүүргийн Засаг даргад даалгасан байна.<br>**Шүүхийн шийдвэр:** Нэхэмжлэгч нь Баянгол дүүргийн Засаг даргын 2015 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн А/756 дугаар захирамжийг Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6-д заасснаар иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байгаагүй гэж маргаж байх болович уг захиргааны акт гарснаас хойш буюу 2015 оны 60 дугаар сарын 19-ний өдөр батлагдан, 2016 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн тул түүнээс өмнө үйлчилж байсан Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай /2002 оны/ хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.7-д “захиргааны акт гаргах эрх зүйн үндэслэл байгаагүй” гэж заасснаар Баянгол дүүргийн Засаг даргын 2013 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/287 дугаартай захирамжийг илт хууль бус болохыг тогтоож шийдвэрлэсэн байна. |
| 5 | 2017.04<br>.05 | 235 | Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх | “Ланд энд хаус” ХХК | Баянзүрх дүүргийн ИТХ | Бусад | “Баянзүрх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2015 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн “Газрын төлбөр итгэлцүүрийг хэрэглэх газрын зааг, хязгаар, итгэлцүүрийн тоон утгыг тогтоох тухай” А/34 дүгээр тогтоол гаргасан. Энэхүү тогтоолоор газрын бүсчлэлийг өөрчилсөн бөгөөд түүнийг дагаад газрын төлбөр нэмэгдсэн байна. “Ланд энд хаус” ХХК нь Баянзүрх дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хамаарах Богдхан уулын тусгай хамгаалалттай газар нутгийн “Хүрэл тогоот”-ын 15 га газрыг аялал жуулчлалын зориулалтаар ашиглах 2014/45 дугаар гэрчилгээг 2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр авсан бөгөөд газар ашиглах гэрээг 2015 оны 05 дугаар сарын 21-ний өдрөөс 2019 оны 08 дугаар сарын 28-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатай байгуулсан болно.<br>**Шүүхийн шийдвэр**: “Нью тур” ХХК-иас тус шүүхэд нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд холбогдуулан “Нийслэлийн иргэдийн |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Төлөөлөгчдийн Хурлын 2010 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн 5/39 дүгээр тогтоолыг илт хүчин төгөлдөр бус болохыг хүлээн зөвшөөрүүлэх, ...” шаардлага бүхий нэхэмжлэлийг гаргаж, Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн 2012 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 272 дугаар шийдвэрээр “Нью тур” ХХК-ийн нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн байна. Улмаар нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь дүүргүүдийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд нутаг дэвсгэрийн газрын үнэлгээний бүсчлэлийн хил хязгаар, итгэлцүүрийн тоон утга, төлбөрийн хэмжээг хуульд нийцүүлэн батлах чиглэл өгсөн байна. Мөн нэхэмжлэгч тал нь төлбөрийн талаар гэрээндээ тусгаж, баталгаажуулсан тул төлбөр нэмэгдсэн гэж үзэхгүй. Иймд нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон. |
| 6 | 2012.12 .26 | №01 | Өмнөговь аймгийн Захиргааны хэргийн шүүх | “Пибоди Винсвэй Ресорсез” ХХК, “Саусгоби сэндс” ХХК | Өмнөговь аймгийн ИТХ | Газар | Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2012 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 1/5 дугаар тогтоолоор орон нутгийн тусгай хамгаалалтад авсан Гурвантэс сумын Баясах багийн орчим, Ноён сумын Толь хад, Ноён богд, Саран хөндий орчмын нийт 319158 га газарт нэхэмжлэгч “Пибоди Винсвэй Ресорсез” ХХК-ний XV-012483, “Саусгоби сэндс” ХХК-ний MV-016869, XV-009443, MV-012726, XV-009449 дугаартай тусгай зөвшөөрлөөр эзэмшиж байсан талбай хамрагдаж давхцсан болох нь хавтаст хэрэгт авагдсан нотлох баримтуудаар тогтоогджээ.<br>Нэхэмжлэгч “Пибоди Винсвэй Ресорсез” ХХК нь Ашигт малтмалын хайгуулын ажлыг хийх тусгай зөвшөөрлийн төлбөрийг тухай бүр нь төлж байсан, Ашигт малтмалын газартай байгуулсан 2011 оны 9 дүгээр сарын 22-ны өдрөөс 2014 оны 9 дүгээр зүйлийн 22-ны өдрийг хүртэл 3 жилийн хугацаатай “Ашиглалтын өмнөх үйл ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байсан байна. Мөн нэхэмжлэгч “ Саусгоби сэндс” ХХК ний MV-016869 дугаар Өмнөговь аймгийн Гурвантэс, Ноён сумын нутгийн 10992.92 гектар талбай бүхий уурхайн талбайд 2041 оны 7 дугаар сарын 04-ны өдрийг дуустал хугацаагаар ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрөлтэй байсан байна.<br>Гэтэл Өмнөговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас дээрх газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтанд авахдаа Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын нийтлэг бүрэн эрхийг зөрчжээ. Учир нь дээрх тогтоолыг гаргахдаа тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй харилцан тохиролцоогүй, мэдэгдээгүй байна. Иймд уг тогтоол нь хууль зөрчиж гарсан тул нэхэмжлэгч “Саусгоби сэндс” ХХК-ний нэхэмжлэлийн шаардлагын нэг хэсэг болох мөн аймгийн Гурвантэс сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2012 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 25 дугаар тогтоолыг хүчингүй болгуулахыг хүссэн шаардлагыг шүүх шийдвэрлэх шаардлагагүй гэж дүгнэсэн байна. Иймд Өмнөговь |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | аймгийн 2012 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 1/5 дугаар тогтоолын 1 дэх заалтыг хүчингүй болгох нь зүйтэй гэж шүүх шийдсэн. |
| 7 | 2017.06 .02 | 14 | Төв аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх | Д.Батбаяр | Төв аймгийн ИТХ | Төрийн алба | Нэхэмжлэгч “Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны 44 дүгээр тогтоол, 2017 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 24 дүгээр тогтоолыг хүчингүй болгуулж, ажилд эгүүлэн тогтоолгож, ажилгүй байсан хугацааны цалин гаргуулах” тухай нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлээ “би ажлаас чөлөөлөгдөх хүсэлт гаргаагүй, ажил албан үүргээ хангалттай биелүүлж байсан, ямар нэгэн сахилгын шийтгэл авч байгаагүй, Тэргүүлэгчид хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд тусгагдаагүй асуудлыг хэлэлцэж намайг ажлаас үндэслэлгүйгээр халсан” гэж тайлбарласан, харин хариуцагчаас “Тэргүүлэгчид бүрэн эрхээ хэрэгжүүлж хуралдсан, ажлаа хийж чадахгүй байсан учраас ажлаас нь чөлөөлсөн” гэсэн тайлбар гаргасан байна.<br>2017 оны 03 дугаар сарын 03-ны өдөр Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид ээлжит бус хуралдааны товыг тухайн өдөр хийхээр тогтоож, уг ээлжит бус хуралдаанаар “аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 44-р тогтоолд өөрчлөлт оруулах” асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсөн байна. Тус ээлжит бус хуралдаанаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан Д.Батбаярыг ажил үүргээ гүйцэтгэхгүй, ажилдаа хариуцлагагүй хандаж байсан мөн түүнийг ажлаас нь чөлөөлсөн 44 дүгээр тогтоолын үндэслэх хэсэгт хуулийн заалтыг буруу хэрэглэсэн тул түүнийг өөрчлөх талаар хэлэлцэн, хуралд оролцсон Тэргүүлэгчдийн 100 хувийн саналаар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 44 дүгээр тогтоолын үндэслэх хэсгийг өөрчлөн ...Төрийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-д заасныг үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга Д.Батбаяр нь албан үүргээ удаа дараа хангалтгүй биелүүлсэн гэсэн үндэслэлээр 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн үүрэгт ажлаас нь халж шийдвэрлэсэн болох нь хавтаст хэрэгт авагдсан авагдсан байна. Д.Батбаяр нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын ажлын байрны тодорхойлолтын 3 дахь бүлгийн “Ажлын байрны гол үйл ажиллагаа”-ны заалтуудыг зөрчсөн болохыг шүүх тогтоож, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. |
| | 2017.08 .17 | 0590 | Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх | | | | Захиргааны ерөнхий хуулийн 45 дугаар зүйлийн 45.1-д “Захиргааны актын бичилт болон тооцооны алдаа, түүнтэй адилтгаж болохоор өөр бусад илэрхий алдааг захиргааны актын үндсэн зохицуулалт, утга, агуулгыг өөрчлөхгүйгээр захиргааны байгууллага өөрөө, эсхүл оролцогчийн хүсэлтээр засах эрхтэй бөгөөд уг засварыг оролцогчид |



Remove Watermark Now
pdfelement

Remove Watermark Now

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | мэдэгдэх үүрэгтэй” гэж заасан бөгөөд уг зохицуулалтаар тавигдаж буй гол шаардлага нь захиргааны актын бичилт болон түүнтэй адилтгаж болох өөр бусад илэрхий алдааг засахдаа актын үндсэн зохицуулалт, утга, агуулгыг өөрчлөхгүйгээр засах эрхтэй байна. Гэтэл Төв аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 24 дүгээр тогтоолоор 44 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулахдаа Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 25.4, Төрийн албаны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.1-д заасныг үндэслэн “Д.Б нь албан үүргээ удаа дараа хангалтгүй биелүүлсэн тул 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн үүрэгт ажлаас нь халсугай” гэж өөрчилснийг анхан шатны шүүх үндэслэлтэй гэж үзсэн нь буруу болжээ. Анхан шатны шүүх нотлох баримтыг буруу үнэлж, холбогдох хууль буруу хэрэглэсэн байх тул шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн. |
| | 2017.11 .20 | 473 | Улсын Дээд шүүх | | | | Захиргааны байгууллагын шийдвэрийн үндэслэл ойлгомжтой тодорхой байх ёстой бөгөөд захиргааны байгууллага шүүхэд маргаан үүссэний дараа өөрийн гаргасан шийдвэрээ тодруулж, тайлбарлах биш, харин шийдвэр гаргах үедээ шийдвэрт тодорхой тусгах, түүний үндэслэлийг урьдчилан шалгаж холбогдох баримтыг цуглуулсан байх үүрэгтэй. Давж заалдах шатны шүүхээс хуулийг зөв тайлбарлан хэрэглэж, нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн байх тул магадлалыг хэвээр үлдээж, хариуцагчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэсэн. |
| 8 | 2017.05 .15 | 07 | Сүхбаатар аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх | П.Мөнхжаргал | Аймгийн ИТХ | Бусад | Нэхэмжлэгч П.Мөнхжаргал нь Сүхбаатар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд холбогдуулан “аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр сонгогдсонд тооцож, бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрүүлэх”-ийг даалгасан шийдвэр гаргуулахыг хүссэн. Тэрээр Сүхбаатар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны сонгуулийн 3 дугаар тойрогт Дарьганга суманд 2016 оны 10 дугаар сарын 19 нд болсон дахин сонгуульд Ардчилсан Намаас нэр дэвшин Монгол Ардын Намын нэр дэвшигч З.Энхтөртэй өрсөлдөн олонхийн санал авч сонгогдсонд тооцогдож, Сүхбаатар аймгийн Сонгуулийн хорооноос аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчийн түр үнэмлэх олгосон байна.<br>Хариуцагч талаас нэр дэвшигч П.Мөнхжаргалын Сонгуулийн тухай хууль зөрчсөн асуудал нь шүүхээр шийдэгдэх хүртэл Хурлын төлөөлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх боломжгүй хэмээн маргасан байна. Тодруулвал, Сүхбаатар аймгийн Монгол Ардын Намын хорооноос нэр дэвшигч П.Мөнхжаргалд холбогдуулан гаргасан Сонгуулийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3, 67.5, 70 дугаар зүйлийн 70.1.6, 70.5.4, 70.5.13, 70.5.15, 70.5.18, 76 зүйлийн 76.4-т заасныг зөрчсөн эсэх тухай гомдлыг Сүхбаатар аймаг дахь Сум дундын эрүүгийн хэргийн анхан |

pdfelement

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шатны шүүхийн шүүгчийн 2017 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 14 тоот захирамжаар хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Дээрх Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 44 дүгээр, 2017 оны 02 дугаар сарын 24-ны өдрийн 36 дугаар магадлалууд нь эцсийн шийдвэр, хуулийн хүчин төгөлдөр болсон тул нэр дэвшигч П.Мөнхжаргалыг Сонгуулийн хууль тогтоомжийг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй бөгөөд шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийдвэрээр нэгэнт тогтоогдсон үйл баримтыг захиргааны хэргийн шүүх дахин үнэлэхгүй, нотлох үүргийг хүлээхгүй гэж үзсэн ба нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, П.Мөнхжаргалыг Сүхбаатар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр сонгогдсонд тооцож, бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрөхийг Сүхбаатар аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд даалгаж шийдвэрлэх нь зүйтэй гэж шийдвэрлэсэн. |
| 9 | 2017.03.27 | 00011 | Хөвсгөл аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх | Улаан-Уул сумын Монгол ардын намын хороо | Улаан-Уул сумын ИТХ<br>Гуравдагч этгээд Б.Хандармаа, Н.Батбаяр | Төрийн алба | 2016 оны орон нутгийн сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан Улаан-Уул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдаан 2016 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 11 цагт эхэлсэн.Хэлэлцэх асуудлын дараалал ёсоор сумын Засаг даргад нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцэж Монгол ардын намаас Б.Хандармаа, Ардчилсан намаас Н.Батбаяр нарын нэр дэвшиж, төлөөлөгчдийн олонхын саналаар санал хураалтыг нууцаар явуулахаар шийдвэрлэсэн. Хоёр нэр дэвшигчийн нэрийн өмнөх дугуй дүрсэнд багтаан зөвлөх тэмдэглэгээгээр санал тэмдэглэхээр болсон. Ингээд санал хураалт явуулан дүнг нэгтгэхэд Монгол ардын намаас нэр дэвшсэн Б.Хандармаа 11 санал, Ардчилсан намаас нэр дэвшсэн Н.Батбаяр 10 санал авсан байсан. Гэтэл Ардчилсан намын зүгээс Б.Хандармаад өгсөн 2 санал тэмдэглэсэн хуудсыг хүчингүй тэмдэглэл хийсэн гэж маргасан. Тэр хоёр тэмдэглэгээ хоёулаа дугуй дотроо зөвлөсөн тэмдэглэгээ байсан. Удаан маргасны эцэст нэг тэмдэглэгээг тооцож, нөгөө тэмдэглэгээг хүчингүй гэж Ардчилсан намын бүлэг зүтгэж, тооллогын комиссын тогтоолд гарын үсэг зураагүй. Тооллогын комисс Б.Хандармаа 11 санал, Н.Батбаяр 10 санал авсан байна. Гэтэл сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга тооллогын комиссын тогтоолыг хүчингүй болгох санал хураалгаагүй ба Ардчилсан намын зүгээс дахин санал хураана гэж санал оруулсныг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга хүлээн авч, 11 төлөөлөгчид хүчээр гар өргөж, дахин санал хураалт явуулсан. Дахин санал хураалтыг явуулахдаа илээр санал хураасан. Нэгэнт Засаг даргад нэр дэвшигчийн төлөө санал хураалтыг нууцаар явуулахаар шийдвэрлэчихээд үүнийгээ зөрчиж, Монгол ардын намын төлөөлөгчдийг оролцуулалгүйгээр илээр санал хурааж, Н.Батбаярт 11 төлөөлөгч санал өгснөөр тооцож, Н.Батбаярыг Улаан-Уул сумын Засаг даргад нэр дэвшүүлэх тогтоолыг гаргасан. |



Remove Watermark Now

Remove Watermark Now

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | **Шүүхийн шийдвэр**: Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-ийн г/-д зааснаар Засаг даргыг томилуулах санал гаргаж аймгийн Засаг даргад уламжлах нь сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын онцгой бүрэн эрх байх ба мөн хуулийн 26 дугаар зүйлийн 26.2-т зааснаар сумын Засаг даргад тухайн Хурал дахь нам, эвслийн бүлэг, эсхүл Хурлын төлөөлөгч нэр дэвшүүлэх эрхтэй бөгөөд Хурлын хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн олонхийн буюу 50-аас дээш хувийн санал авсан нэр дэвшигчийг томилуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал болгох ёстой. Сумын Засаг даргад нэр дэвшигч Б.Хандармаа Улаан-Уул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 21 төлөөлөгчөөс 11 төлөөлөгчийн санал авсан тухай тооллогын комиссын хүчин төгөлдөр тогтоол гараагүй байхад шүүхээс түүнийг баталгаажуулах, улмаар Б.Хандармааг Засаг даргад нэр дэвшүүлээгүй эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоож, шаардагдах захиргааны акт гаргахыг хариуцагчид даалгах хууль зүйн үндэслэл үгүй юм. Өөрөөр хэлбэл хуулиар нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад олгосон онцгой бүрэн эрхийг шүүх хэрэгжүүлэх боломжгүй тул хэргийн нөхцөл байдлыг цааш тодруулах шаардлагатай, нэмж тодруулах зүйлийн цар хүрээ шүүхийн шинжлэн судлах боломжоос хэтэрсэн байна гэж үзсэн тул захиргааны байгууллагаас дахин шинэ акт гаргах хүртэл Улаан-Уул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн анхдугаар хуралдааны "Сумын Засаг даргад нэр дэвшүүлэх тухай" 06 дугаар тогтоол болон Улаан-Уул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тооллогын комиссын 2016 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 03, 04 дүгээр тогтоолуудыг нэг сарын хугацаагаар түдгэлзүүлсэн байна. |
| 10 | 2016.10.24 | 34 | Ховд аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх | Ховд аймгийн Соёл урлан бүтээлийн зөвлөл | Ховд аймгийн ИТХ<br>П.Самбалхүн-дэв /Ховд телевиз/ | Бусад | Ховд аймаг дахь олон нийтийн Ховд телевизийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн шийдвэрээр 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 90 дугаар тогтоол гаргаж хувийн өмчид шилжүүлжээ. Ингэхдээ тус телевизийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Н.Баасанжав нарын Ховд ТВ-ийг хувийн өмчлөлд шилжүүлж авахыг хүссэн удаа дараагийн хүсэлтийн дагуу хийгдсэн байна. Соёл урлан бүтээлийн зөвлөл болон тус зөвлөлд багтдаг орон нутгийн сэтгүүлчдийн байгууллага, зохиолчид, зураачид, хөгжмийн зохиолчдын холбоод Ховд аймгийн бусад ижил төрлийн байгууллагуудаас Ховд телевизийн "олон нийтийн" гэсэн статусыг хэвээр хадгалах нь нэн чухал гэсэн байр суурьтай байсан.<br>Хариуцагч талаас Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 3 дахь заалтанд "Орон нутгийн өмчид хамаарах үндсэн хөрөнгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, барьцаалах, шинээр олж авах асуудлыг гагцхүү Иргэдийн төлөөлөгчдийн хурал, түүний хуралдааны чөлөөт цагт Хурлын тэргүүлэгчид шийдвэрлэнэ" гэж заасан.Тухайн Ховд |

pdfelement

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ТВ-ийн ашиглаж байсан 7 төрлийн 10.4 сая төгрөгийн орон нутгийн өмчийн хөрөнгийг 2014 оны 2 дугаар сарын 28-ны өдөр аймгийн Засаг даргын Тамгын газарт хүлээн авч бүртгэсэн ба харин аналог системийн үед ашиглаж байсан, тоон системд шилжсэнээр ашиглах боломжгүй болсон хөрөнгийг тухайн телевизэд үлдээсэн болно. Иймд хаана ч ашиглах боломжгүй хөрөнгийн асуудлыг ашиглалтаас хасаж байгаа тул хууль зөрчигдөх үндэслэлгүй гэж тайлбарласан. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 90 дүгээр тогтоолоор холбогдох тогтоолуудыг хүчингүй болгож, Ховд телевизэд ашиглагдаж байсан техник, тоног төхөөрөмжүүдийг цаашид ашиглах боломжгүй болон сэлбэж өөрчлөх шаардлагатай болсон тул орон нутгийн өмчлөлийн хөрөнгүүдийг тус телевизэд шилжүүлсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.1 ....шилжүүлэх эд хөрөнгийн талаар өмч хамгаалах Байнгын зөвлөл дүгнэлт гаргасан байх зүйлийг зөрчсөн, мөн тухайн харилцааг зохицуулсан хуулийн тодорхой заалтыг хэрэглэлгүйгээр маргаан бүхий актыг гаргасан нь буруу гэж шүүх дүгнэсэн. Иймд нэхэмжлэгч нарын шүүхэд гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, Ховд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 90 дүгээр “Тогтоол хүчингүй болгох тухай” тогтоолыг хүчингүй болгосон. |

Remove Watermark Now

**Шүүхийн шийдвэрийн цахим сан дахь Захиргааны хэргийн шүүхэд ЗЕХ-ийн 8 дугаар зүйлийг хэрэглэн хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрийн үзүүлэлт**

Шүүлт хийж үзэхэд, ЗЕХ-ийн 8 дугаар зүйлийг хэрэглэн шийдвэрлэсэн гагцхүү 1 шийдвэр байна (Маргааны төрөл: Тусгай зөвшөөрөл).

| Д/д | Шүүхийн шийдвэрийн дугаар, огноо /Анхан, давах, хяналт/ | Нэхэмжлэгч | Хариуцагч | Маргааны төрөл ба шийдвэрлэсэн байдлын товч агуулга |
|---|---|---|---|---|
| 1 | АШШ Дугаар: 18<br>Огноо: 2016-10-06<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/1904/view | “Эрдэнэттранс порт” ХХК | Орхон аймгийн Автотээврийн төв | • **Тусгай зөвшөөрөл**<br><br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>“Орхон аймгийн Автотээврийн төвийн даргын 2016 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дугаар тушаалыг илт хууль бус болохыг тогтоолгох, 16902000 /арван зургаан сая, есөн зуун хоёр мянган/ төгрөгийн хохирлыг Орхон аймгийн Автотээврийн төсвөөс гаргуулах”<br><br>**ЗЕХ-ийн 8 дугаар зүйлийг хэрэглэсэн байдал:**<br>Нэхэмжлэгчийн зүгээс ЗЕХ-ийн 8 дугаар зүйлийг дурдсан бөгөөд шүүхээс энэ тал дээр тайлбар хийгээгүй боловч хариуцагч Орхон аймгийн Автотээврийн төвийг ЗЕХ-ийн §5.1.3-т заасан этгээд хэмээн дүгнэжээ. Агуулгын хувьд Автотээврийн үндэсний төв нь чиг үүрэг, эрх мэдлийг шилжүүлэн авсан этгээд мөн боловч хэлбэрийн хувьд энэ нь нийтийн эрх зүйн хуулийн этгээд буюу Төрийн өмчит үйлдвэрийн газар юм. Тодруулбал ЗЕХ-ийн §5.1.3-т гагцхүү хувийн эрх зүйн хуулийн этгээдүүд хамаарах бөгөөд чиг үүрэг, эрх мэдлийг шилжүүлэн авсан нийтийн эрх зүйн хуулийн этгээдүүдийг ЗЕХ-ийн §5.1.2-т заасан этгээдэд хамруулдаг. Энэ утгаараа шүүх буруу дүгнэсэн байна. Бусдаар ЗЕХ-ийн 8 дугаар зүйлийн хувьд шүүхийн зүгээс хэрэглээгүй байна. |

pdfelement

Remove Watermark Now

**Хавсралт 7**

ЗЕХ-ийн 37 дугаар зүйлийн 37.1-ийг хэрэглэж гаргасан шүүхийн шийдвэрийн түүвэр

| № | Шүүхийн шийдвэр дугаар, огоо /Анхан, давах, хяналт/ | Нэхэмжлэгч | Хариуцагч | Маргааны төрөл шийдвэрлэсэн байдлын товч агуулга |
|---|---|---|---|---|
| 1 | Дугаар: 132<br>Огноо: 2018-03-01<br>/Захиргааны хэргийн анхан шатны шүүх шийдвэрлэсэн шийдвэр./<br><br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/4405/view | Д -ийн Д | Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Байгаль орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн дугаар А-235 тоот тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг | • **Бусад**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>“Монгол улсын Газрын тухай хуулийн дугээр зүйлийн 44.8 , Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 35 дүгээо зүйлийн 35.1 , Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааны тэмдэглэл, Байгаль орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн дугаар А-235 тоот тушаалуудыг үндэслэн нэхэмжлэгч Д.Дг”....Богдхан уулын дархан цаазат газрын хязгаарлалтын бүсэд зохих журмын дагуу зөвшөөрөл авалгүйгээр удаан хугацаагаар оршин сууж буй иргэдийн ашиглаж буй газрын бүртгүүлж гэрчилгээжүүлэх үүрэг,бүхий ажлын хэсэг...”-гийн судалгаанд хамруулалгүй орхигдуулан хариуцагчийн эс үйлдэхүй нь хууль бус болохыг тогтоолгож газар ашиглуулах эрх бүхий иргэдийн судалгаанд хамруулахыг хариуцагчид даалгах”<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.2-т заасныг баримтлан “...Богдхан уулын дархан цаазат газрын хязгаарлалтын бүсэд зохих журмын дагуу зөвшөөрөл авалгүйгээр удаан хугацаагаар оршин сууж буй иргэдийн ашиглаж буй газрын бүртгүүлж гэрчилгээжүүлэх үүрэг бүхий ажлын хэсэг...”-ийн судалгаанд хамруулалгүй орхигдуулан хариуцагчийн эс үйлдэхүй нь хууль бус болохыг тогтоолгож, газар ашиглуулах эрх бүхий иргэдийн судалгаанд Д.Дг хамруулахыг хариуцагчид даалгах”-ыг хүссэн шаардлага бүхий **нэхэмжлэгч Д.Дгийн нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож** шийдвэрлэжээ. |
| 2 | Дугаар: 121<br>Огноо: 2018-02-28<br>/Захиргааны хэргийн анхан шатны шүүх шийдвэрлэсэн шийдвэр./<br><br>**http://new.shuukh.mn/zahirgaaanhan/4377/view** | “М” ХХК | Нийслэлийн Засаг дарга, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар, Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар | • **Тендер**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>“Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар олон нийтийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар (ОНӨААТҮГ)-ын 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 2/776, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 06/630 дугаар албан бичгийг тус тус хүчингүй болгуулах, гэрээ байгуулаагүй эс үйлдэхүй нь хууль бус |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Дугаар: 226<br>Огноо: 2018.04.11<br>/Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх/ | | ОНӨААТҮГ | болохыг тогтоож гэрээ байгуулахыг хариуцагчид даалгах, Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас зарласан НХААГ/201704132 дугаартай “Баянгол дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт А хэсэгчилсэн талбайн гадна цахилгаан хангамжийн эхний ээлжийн барилга угсралтын ажил”<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Шүүхийн шийдвэрийн ТОГТООХ хэсгийн 1 дэх заалтаар: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1, 28 дугаар зүйлийн 28.4, 29 дүгээр зүйлийн 29.2, 54 дүгээр зүйлийн 54.7, 55 дугаар зүйлийн 55.1-д тус тус заасныг баримтлан “Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 06/630 дугаар албан бичгийг хүчингүй болгуулах, гэрээ байгуулаагүй эс үйлдэхүй нь хууль бус болохыг тогтоож гэрээ байгуулахыг хариуцагчид даалгах, Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас зарласан НХААГ/201704132 дугаартай “Баянгол дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт А хэсэгчилсэн талбайн гадна цахилгаан хангамжийн эхний ээлжийн барилга угсралтын ажил”-ын тендер шалгаруулалтыг хүчингүй болгуулах” **“М” ХХК-ийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож,**<br><br>2 дахь заалтаар: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1-д заасныг баримтлан Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-ын 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 2/776 дугаар албан бичгийг хүчингүй болгох нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн авахаас татгалзаж, холбогдох ***хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.***<br><br>Давж заалдах шатны шүүх шийдвэрлэсэн байдал:<br>Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 121 дүгээр шийдвэрийн Тогтоох хэсгийн 1 дэх заалтыг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 29 дүгээр зүйлийн 29.1, 29.3, 46 дугаар зүйлийн 46.2, 47 дугаар зүйлийн 47.2.2, Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6, 4.2.8, 43 дугаар зүйлийн 43.1-д заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч “М” ХХК-ийн нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-ын 2017 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 2/776 дугаар албан бичиг, Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас зарласан НХААГ/201704132 дугаартай “Баянгол дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт А хэсэгчилсэн талбайн гадна цахилгаан хангамжийн эхний ээлжийн барилга угсралтын ажил”-ын тендер шалгаруулалтыг тус тус хүчингүй болгож, гэрээ байгуулаагүй эс үйлдэхүй нь |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | хууль бус болохыг тогтоож, гэрээ байгуулахыг хариуцагч Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-т даалгасугай гэж, 2 дахь заалтыг “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1, 109 дүгээр зүйлийн 109.2 дахь хэсгүүдэд заасныг баримтлан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн 2017 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 06/630 дугаар албан бичгийг хүчингүй болгох нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн авахаас татгалзаж, холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосугай” гэж, Тогтоох хэсгийн 3 дахь заалтыг “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэгт заасныг баримтлан “М” ХХК-иас нэхэмжлэл гаргахдаа улсын тэмдэгтийн хураамжид урьдчилан төлсөн 70.200 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээж, хариуцагч тус бүрээс 17550 төгрөг гаргуулж, нэхэмжлэгчид буцаан олгосугай” гэж өөрчлөн, шийдвэрийн бусад заалтыг хэвээр үлдээж шийдвэрлэжээ. |
| 3 | Дугаар: 60<br>Огноо: 2018-01-29<br>/Захиргааны хэргийн анхан шатны шүүх шийдвэрлэсэн шийдвэр./<br><br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/4259/view | ОАИТХТ | Сонгуулийн Ерөнхий хороо | • **Сонгууль**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>“...“Сонгуулийн Ерөнхий хорооны 2017 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 348 дугаартай албан бичгийг хүчингүй болгуулах, ОАИТХТ аймгийн Сонгуулийн хороог байгуулах эрхтэй болохыг тогтоолгох”<br><br>Гуравдагч этгээдийн бие даасан шаардлага:<br>“...Сонгуулийн Ерөнхий хорооны 2017 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 341 дүгээр албан бичгийг хүчингүй болгуулах, дахин сонгуулийг зохион байгуулах зардлыг 2018 оны улсын төсөвт тусгуулж, батлуулан, тус сонгуулийн хороонд олгохыг даалгуулах”<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Шүүхийн шийдвэрийн ТОГТООХ хэсгийн 1 дэх заалтаар: Сонгуулийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5, 31 дүгээр зүйлийн 31.1, 31.4, 31.5-т заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч ОАИТХТ-ийн “Сонгуулийн Ерөнхий хорооны 2017 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 348 дугаартай албан бичгийг хүчингүй болгуулах, ОАИТХТ аймгийн Сонгуулийн хороог байгуулах эрхтэй болохыг тогтоолгох” тухай ***нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож,***<br><br>2 дахь заалтаар: Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5-т заасныг баримтлан гуравдагч этгээдийн “...дахин сонгуулийг зохион байгуулах зардлыг 2018 оны төсөвт тусгуулж, батлуулан, тус сонгуулийн хороонд олгохыг даалгах” тухай ***бие даасан шаардлагыг хэрэгсэхгүй болгож,***<br><br>3 дахь заалтаар: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1, 54.2-т заасныг тус тус баримтлан гуравдагч этгээдийн |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | “...Сонгуулийн Ерөнхий хорооны 2017 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн 341 дугаартай албан бичгийг хүчингүй болгуулах” тухай ***бие даасан шаардлагыг хүлээн авахаас татгалзаж, холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож*** шийдвэрлэжээ. |
| 4 | Дугаар: 02<br>Огноо: 2018-01-15<br>/Захиргааны хэргийн анхан шатны шүүх шийдвэрлэсэн шийдвэр./<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/4255/view | “Э А Э” ХХК | Ө аймгийн Засаг дарга | • **Газар**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>“... өргөдөл гаргасан талбайд Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2-т зааснаар анхан шатны шүүлтийг хийж, дээрх талбай нь ямар нэг байдлаар ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон, тусгай хэрэгцээ, нөөцөд авсан, түүнчлэн хайгуулын тусгай зөвшөөрлөөр нэгэнт олгогдсон талбайтай бүхэлдээ буюу хэсэгчлэн давхцаагүй, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой гэж үзэн аймгийн Засаг даргаас саналыг авахаар явуулсан.<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Шүүхийн шийдвэрийн ТОГТООХ хэсгийн 1 дэх заалтаар: Ашигт малтмалын тухай хуулийн (2006) 19 дүгээр зүйлийн 19.4, 19.5, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.1.12, 30 дугаар зүйлийн 30.1, 30.1.13 дахь хэсэгт заасныг баримтлан нэхэмжлэгчийн гаргасан нэхэмжлэлийн зарим шаардлагыг хангаж, Өмнөговь аймгийн Засаг даргын 2015 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 3 тоот "Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүсч гаргасан өргөдөлд өгөх санал”-ыг хүчингүй болгож, Өмнөговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 73 тоот саналын “Э А Э” ХХК-д холбогдох хэсгийг тус тус хүчингүй болгуулж, “Х н” нэртэй газарт хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг хуульд заасны дагуу дэмжсэн санал гаргахыг хариуцагч нарт даалгах” ***нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож***,<br><br>2 дахь заалтаар: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т зааснаар нэхэмжлэгчээс улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 70200 /далан мянга хоёр зуун/ төгрөгийг орон нутгийн төсвийн орлогод хэвээр үлдээж, ***хариуцагч Өмнөговь аймгийн Засаг даргаас 35100 /гучин таван мянга нэг зуун/ төгрөгийг гаргуулж нэхэмжлэгчид олгож*** шийдвэрлэжээ. |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| 5 | Дугаар: 31<br>Огноо: 2017-12-08<br>/Захиргааны хэргийн анхан шатны шүүх шийдвэрлэсэн шийдвэр./<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/4243/view | Ц. Тунсагмаа | Сэлэнгэ аймгийн Цагдаагын газар | • **Бусад**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>Миний бие Алтанбулаг сумын Засаг дарга болох П.Батсайханыг албан үүргээ гүйцэтгэж явахад нь боловсролгүй гэж гүтгэж доромжлоогүй, Алтанбулаг сумын хүмүүсийн ярьсан дам ярианаас болж энэ хүний сонорт хүрсэн. Иймд энэ Ш.Энхбаатар нь П.Батсайханы талд үйлчилж иргэн надад 2 сая төгрөгийн шийтгэлийн хуудас бичсэнд гомдолтой байна. Шийтгэлийн хуудсыг хүчингүй болгож өгнө үү. Иймд энэ асуудлыг хуулийн дагуу шийдвэрлэж өгнө үү.<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэгт заасныг баримтлан Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газрын шуурхай удирдлагын албаны ахлах, ахлах дэслэгч Ш.Энхбаатарт холбогдох “2017 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 0004011 дугаартай 2.000.000 төгрөгийг ногдуулсан шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулахыг хүссэн тухай гомдлын шаардлаагаасаа гомдол гаргагч бүрэн хэмжээгээр татгалзсаныг баталж, ***хэргийг хэрэгсэхгүй болгож*** шийдвэрлэжээ. |
| 6 | Дугаар: 39<br>Огноо: 2018-01-22<br>/Захиргааны хэргийн анхан шатны шүүх шийдвэрлэсэн шийдвэр./<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/4224/view | “Эй” ХХК | Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн дарга | • **Ашигт малтмал**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 2017 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 466 дугаар шийдвэрийн “Эй” ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгож, NE-025273 дугаарт бүртгэсэн өргөдлийг зохих журмын дагуу шийдвэрлэхийг даалгах<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.1.16, 19 дүгээр зүйлийн 19.4, 19.5 хэсэгт заасныг баримтлан нэхэмжлэгч “Эй” ХХК-ийн “Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 2017 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 466 дугаар шийдвэрийн “Эй” ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгож, NE-025273 дугаарт бүртгэсэн өргөдлийг зохих журмын дагуу шийдвэрлэхийг даалгах” шаардлага бүхий ***нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож*** шийдвэрлэжээ. |
| 7 | Дугаар: 958<br>Огноо: 2017-12-20<br>/Захиргааны хэргийн анхан шатны шүүх шийдвэрлэсэн шийдвэр./<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/4142/view | “П” ХХК | “Д” ТӨХК, Тендерийн үнэлгээний хороо | • **Тендер**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>“Д” ТӨХК-д холбогдуулан “2017 оны 08 дугаар сарын 24-ний өдөр зарласан ХО-1/2017 Үнсэн сан 7-г барих, /Үнсэн сан 4-ийн далан өндөрлөх/ ажил гүйцэтгэх” Д/2017-529 дугаар гэрээг хүчингүй болгуулах, “Д” ТӨХК-ийн 2010 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 02/4480 дугаар албан бичгийг хүчингүй болгуулах 2017 оны 08 дугаар сарын 24-ний өдөр зарласан ХО-1/2017 Үнсэн сан 7-г барих, /Үнсэн сан 4-ийн далан өндөрлөх/ тендер сонгон шалгаруулалтын үнэлгээг дахин |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | хийхийг даалгуулах, “Д” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2017 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/128 дугаар тушаалаар байгуулагдсан “Үнсэн сан 7-г барих, /Үнсэн сан 4-ийн далан өндөрлөх ажил ХО-1/2017 дугаартай тендерийн үнэлэх Үнэлгээний хороонд холбогдуулан “Үнэлгээний хорооны 2017 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн №02 хурлын тэмдэглэлийг хүчингүй болгуулах<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Шүүхийн шийдвэрийн ТОГТООХ хэсгийн 1 дэх заалтаар: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1 дэх хэсэгт заасныг баримтлан нэхэмжлэгч “П” ХХК-иас “Д” ТӨХК-д холбогдуулан гаргасан “Д” ТӨХК-ийн 2010 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 02/4480 дугаар албан бичгийг хүчингүй болгуулах”-ыг хүссэн шаардлага ***нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж***,<br><br>2 дахь заалтаар: “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 28 дугаар зүйлийн 28.7.3, 28.7.4, 29 дүгээр зүйлийн 29.1, 29.2-т заасныг баримлан “П” ХХК-иас “Д” ТӨХК-д холбогдуулан “2017 оны 08 дугаар сарын 24-ний өдөр зарласан ХО-1/2017 Үнсэн сан 7-г барих, /Үнсэн сан 4-ийн далан өндөрлөх/ ажил гүйцэтгэх “Д/2017-529 дугаар гэрээг хүчингүй болгуулах, 2017 оны 08 дугаар сарын 24-ний өдөр зарласан ХО-1/2017 Үнсэн сан 7-г барих, /Үнсэн сан 4-ийн далан өндөрлөх/ тендер сонгон шалгаруулалтын үнэлгээг дахин хийхийг даалгуулах, “Д” ТӨХК-ийн гүйцэтгэх захирлын 2017 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/128 дугаар тушаалаар байгуулагдсан “Үнсэн сан 7-г барих, /Үнсэн сан 4-ийн далан өндөрлөх ажил ХО-1/2017 дугаартай тендерийн үнэлэх үнэлгээний хороонд холбогдуулан тус үнэлгээний хорооны 2017 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн №02 хурлын тэмдэглэлийг хүчингүй болгуулах” гэж ***нэхэмжлэлийн шаардлагыг тус тус хэрэгсэхгүй болгож*** шийдвэрлэжээ. |
| 8 | Дугаар: 881<br>Огноо: 2017-11-28<br>/Захиргааны хэргийн анхан шатны шүүх шийдвэрлэсэн шийдвэр./<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/4113/view | “Э” ХХК | Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн дарга | • **Ашигт малтмал**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 319 дүгээр шийдвэрийн “Э” ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгох, “Э” ХХК-ийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн NE-****** /XA-****** / дугаартай өргөдлийн дагуу Говь-Алтай аймгийн Цогт сумын Баруун нэртэй газарт 2443.81 гектар талбайд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэст даалгах<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.16, 19 дүгээр зүйлийн |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Дугаар: 83<br>Огноо: 2018-01-31<br>/ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх /<br>http://new.shuukh.mn/zahirgaadavah/1808/view<br><br>Дугаар: 157<br>Огноо: 2018-04-09<br>/ Улсын дээд шүүх /<br>http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/1319/view | | | 19.2, 19.6-д заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч “Э” ХХК-ийн “Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 2017 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 319 дүгээр шийдвэрийн “Э” ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгох, “Э” ХХК-ийн ашигт малтмалын хайгуулын хуулбар хувь 2018-06-02 -нд www.shuukh.mn сайтаас татаж авав. Хуудас: 10/10 тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн NE-****** /XA-****** / дугаартай өргөдлийн дагуу Говь-Алтай аймгийн Цогт сумын Баруун нэртэй газарт 2443.81 гектар талбайд ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэст даалгах” тухай шаардлага бүхий ***нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож*** шийдвэрлэжээ.<br><br>Давж заалдах шатны шүүх шийдвэрлэсэн байдал:<br>Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 881 дүгээр шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн давж заалдах гомдлыг хангахгүй орхисугай.<br><br>Улсын дээд шүүх шийдвэрлэсэн байдал:<br>Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 128/ШШ2017/0881 дүгээр шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн 221/МА2018/0083 дугаар магадлалыг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхисугай. |
| 9 | Дугаар: 934<br>Огноо: 2017-12-14<br>/Захиргааны хэргийн анхан шатны шүүх шийдвэрлэсэн шийдвэр./<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/4112/view<br><br>Дугаар: 85 | “А” ХХК | Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэс | • **Ашигт малтмал**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 2017 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 460 дугаар шийдвэрийн “А” ХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгож, “А” ХК-ийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг зохих журмын дагуу шийдвэрлэхийг Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэст даалгах<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.16, 19 дүгээр зүйлийн 19.2, 19.6-д заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч “А” ХК-ийн “Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 2017 оны 7 дугаар сарын 31-ний өдрийн 460 дугаар шийдвэрийн “А” ХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгож, “А” ХК-ийн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг зохих журмын дагуу шийдвэрлэхийг Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэст даалгах” тухай шаардлага бүхий ***нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож*** шийдвэрлэжээ. |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Огноо: 2018-01-31<br>/ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх /<br>http://new.shuukh.mn/zahirgaadavah/1907/view | | | Давж заалдах шатны шүүх шийдвэрлэсэн байдал:<br>Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 128/ШШ2017/0934 дүгээр шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэгч "А ч" ХК-ийн өмгөөлөгч Х.Б-ийн давж заалдах гомдлыг хангахгүй орхисугай. |
| 10 | Дугаар: 00034<br>Огноо: 2017-12-18<br>/Захиргааны хэргийн анхан шатны шүүх шийдвэрлэсэн шийдвэр./<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/4056/view | Н...ХХК | ..... сумын Засаг дарга | • **Бусад**<br>Шийдвэрлэсэн байдал:<br>Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 40 дүгээр зүйлийн 40.1.5, 40.1.6 заасныг баримтлан Хөвсгөл аймгийн Б.... сумын Засаг даргын 2016 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/31 дүгээр захирамжийн Н... ХХК-д ***холбогдох хэсгийг хүчингүй болгож*** шийдвэрлэжээ. |
| 11 | Дугаар: 765<br>Огноо: 2017-10-23<br>/Захиргааны хэргийн анхан шатны шүүх шийдвэрлэсэн шийдвэр./<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/4045/view<br><br>Дугаар: 851<br>Огноо: 2017-12-05 | "Т" ХХК | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Тендерийн үнэлгээний хороонд холбогдох | • **Бусад**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>-Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Тендерийн үнэлгээний хорооны 2017 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн 03 дугаар шийдвэрийг , - Үнэлгээний хорооны 2017 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн 02 дугаар Тендерээс татгалзах тухай дүгнэлт , - Үнэлгээний хорооны 2017 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн 02 дугаар Гэрээ байгуулах эрх олгох тухай дүгнэлтийг тус тус хууль бус байсан болохыг тогтоолгох нэхэмжлэлийн шаардлага<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Шүүхийн шийдвэрийн ТОГТООХ хэсгийн 1 дэх заалтаар: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсгийн 27.1.3, 27.4, 28 дугаар зүйлийн 28.1, 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсгийн 47.2.1, 47.2.2 дахь хэсэгт заасныг тус тус баримтлан Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын Тендерийн үнэлгээний хорооны 2017 оны 8 дугаар сарын 3-ны өдрийн 03 дугаар ***шийдвэр хууль бус байсан болохыг тогтоож,***<br><br>2 дахь заалтаар: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсгийн 54.1.1 дэх заалтад зааснаар Үнэлгээний хорооны 2017 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн 02 дугаар Тендерээс татгалзах тухай болон Гэрээ байгуулах эрх олгох тухай дүгнэлтүүдийг хууль бус байсан болохыг тогтоолгох ***нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн авахаас татгалзаж, холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож*** шийдвэрлэжээ.<br><br>Давж заалдах шатны шүүх шийдвэрлэсэн байдал:<br>Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 10 дугаар |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| | / Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх / http://new.shuukh.mn/zahirgaadavah/1519/view | | | сарын 23-ны өдрийн 128/ШШ2017/0765 дугаар шийдвэрийн ТОГТООХ хэсгийн 1 дэх заалтыг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.3, 27.4, 28 дугаар зүйлийн 28.7.4, 29 дүгээр зүйлийн 29.1, 47 дугаар зүйлийн 47.2.2-т заасныг тус тус баримтлан "Т м" ХХК-ийн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт холбогдуулан гаргасан "Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Тендерийн үнэлгээний хорооны 2017 оны 8 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар шийдвэр, 2017 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн 02 дугаар тендерээс татгалзах болон гэрээ байгуулах эрх олгох тухай дүгнэлтүүдийг хууль бус байсан болохыг тогтоолгох" тухай нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай" гэж өөрчилж, 2 дахь заалтыг хасч, бусад заалтыг хэвээр үлдээн, хариуцагчийн давж заалдах гомдлыг хангасугай. |
| 12 | Дугаар: 845<br>Огноо: 2017-11-15<br>/Захиргааны хэргийн анхан шатны шүүх шийдвэрлэсэн шийдвэр./ | Б.Б | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд бөгөөд Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дарга | • **Төрийн алба**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даргын 2017 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 02 дугаар тогтоолыг хүчингүй болгуулах, ажилгүй байсан хугацааны цалин гаргуулах, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэхийг даалгах<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Шүүхийн шийдвэрийн ТОГТООХ хэсгийн 1 дэх заалтаар: Төрийн албан тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.5, 7 дугаар зүйлийн 7.1.13, 11 дүгээр зүйлийн 11.1, 22 дугаар зүйлийн 22.1, 24 дүгээр зүйлийн 24.1. 24.1.3 дахь хэсэгт заасныг баримтлан Б.Б гийн нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж, ***Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн даргын 2017 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 02 дугаар тогтоолыг хүчингүй болгож,***<br><br>2 дахь заалтаар: Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6, Хөдөлмөрийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д заасныг баримтлан Б.Б гийн нэг сарын үндсэн цалинг 978,427 төгрөгөөр тооцож 2017 оны 01 дүгээр сарын 09-ний өдрөөс 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр өдөр хүртэл тооцоолон олгож, ***нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн нөхөн төлж, зохих бичилт хийхийг хариуцагчид даалгаж шийдвэрлэжээ***. |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| 13 | Дугаар: 47<br>Огноо: 2017-11-11<br>/Захиргааны хэргийн анхан шатны шүүх шийдвэрлэсэн шийдвэр./<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/4029/view<br><br>Дугаар: 279<br>Огноо: 2017-04-12<br>/ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх /<br>http://new.shuukh.mn/zahirgaadavah/2008/view<br><br>Дугаар: 264<br>Огноо: 2017-06-28<br>/ Улсын дээд шүүх /<br>http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/899/view | Д.М | Архангай аймгийн Засаг даргад холбогдох | • **Төрийн алба**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>2016 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн Засаг дарга Ц.М-гийн Спортын төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.М-д өгсөн үндэслэлгүй мэдэгдэл болон Аймгийн засаг даргын Спортын төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан тушаалд сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалгыг хүчингүй болгуулах тухай<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Шүүхийн шийдвэрийн ТОГТООХ хэсгийн 1 дэх заалтаар: Төрийн албаны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.15 дахь хэсэгт заасныг баримтлан нэхэмжлэгч Д.М-ын нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдөр 01/2270 дугаартай албан бичгийн холбогдох хэсэг болох Спортын төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан тушаалд сонгон шалгаруулалт зарлуулах тухай ***захиалгыг хүчингүй болгож***,<br><br>2 дахь заалтаар: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дэх хэсэгт заасныг баримтлан нэхэмжлэгч Д.М-ын 2016 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн Засаг дарга Ц.М-гийн Спортын төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.М-д өгсөн үндэслэлгүй мэдэгдэл болох захиргааны актыг хүчингүй болгуулах" тухай шаардлага бүхий нэхэмжлэлийн шаардлагаасаа татгалзсаныг батлаж, ***хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.***<br><br>Давж заалдах шатны шүүх шийдвэрлэсэн байдал:<br>Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 09 дүгээр шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр тус шүүхэд буцаасугай.<br><br>Улсын дээд шүүх шийдвэрлэсэн байдал:<br>Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 221/МА2017/0279 дугээр магадлалыг хэвээр үлдээж, хариуцагч Архангай аймгийн Засаг хуулбар хувь 2018-06-07 -нд www.shuukh.mn сайтаас татаж авав. Хуудас: 5/5 даргын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхисугай. |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| 14 | Дугаар: 30<br>Огноо: 2017-10-24<br>/Захиргааны хэргийн анхан шатны шүүх шийдвэрлэсэн шийдвэр./<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3955/view | М.Мэндсүрэн | Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад холбогдох, | • **Төрийн алба**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад холбогдуулан гаргасан “Тамгын газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн Б/54 тоот тушаалын заалтыг зөвтгөн Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д заасны дагуу чөлөөлөх, 30 дугаар зүйлийн 30.2 дахь заалтын дагуу нэг удаагийн буцалтгүй тусламж олгох”-ыг тус тус даалгуулахыг хүссэн шаардлага бүхий нэхэмжлэлтэй захиргааны хэргийг хянан хэлэлцэв.<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр 24.1.1, 27 дугаар зүйл 27.1.1, 30 дугаар зүйлийн 30.2-т заасныг тус тус баримтлан Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2017 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн Б/54 тоот тушаалын Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйл 24.1.3 гэсэн заалтыг 24 дүгээр зүйлийн 24.1.1-д заасны дагуу гэж зөвтгөх, мөн хуулийн 30 дугаар зүйлийн 30.2-д заасны дагуу М.Мэндсүрэнд нэг удаагийн буцалтгүй тусламж олгох”-ыг ***Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын даргад тус тус даалгаж шийдвэрлэжээ.*** |
| 15 | Дугаар: 20<br>Огноо: 2017-07-16<br>/Захиргааны хэргийн анхан шатны шүүх шийдвэрлэсэн шийдвэр./<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3946/view | Ө.Намхайдаг ва | Төв аймгийн Засаг дарга, Жаргалант сумын Засаг дарга | • **Газар**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>Төв аймгийн Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 01/1634 дугаар албан тоотыг хууль бус болохыг тогтоолгох, Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2016 оны 12 сарын 08-ны өдрийн А/877 дугаар захирамжийн Ө.Намхайдагвад холбогдох хэсгийг хүчингүй болгуулах тухай<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Шүүхийн шийдвэрийн ТОГТООХ хэсгийн 1 дэх заалтаар: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.3 дахь хэсэгт заасныг баримтлан нэхэмжлэгч Ө.Намхайдагваас гаргасан “Төв аймгийн Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 01/1634 дугаар албан тоотыг хууль бус болохыг тогтоолгох тухай” нэхэмжлэлийг нэхэмжлэгч, нэхэмжлэлээсээ татгалзсаныг баталж, ***Төв аймгийн Засаг даргад холбогдох захиргааны хэргийг хэрэгсэхгүй болгож,***<br><br>2 дахь заалтаар: Газрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 25 дугаар зүйлийн 25.4, 27 дугаар зүйлийн 27.1, 27.4, 34 дүгээр зүйлийн 34.1 дэх хэсэгт заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч Ө.Намхайдагваас гаргасан “Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2016 оны 12 сарын 08-ны өдрийн А/877 дугаар захирамжийн Ө.Намхайдагвад холбогдох хэсгийг хүчингүй болгуулах тухай” нэхэмжлэлийг захиргааны байгууллагаас дахин ***шинэ акт гаргах хүртэл*** |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | ***<u>захиргааны актыг зургаан сарын хугацаагаар түдгэлзүүлж шийдвэрлэжээ</u>***. |
| 16 | Дугаар: 19<br>Огноо: 2017-07-17<br>/Захиргааны хэргийн анхан шатны шүүх шийдвэрлэсэн шийдвэр./<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3945/view | Т.Даваажав | Төв аймгийн Жаргалант сумын Засаг дарга | • **Газар**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/877 дугаар захирамжийн Т.Даваажавт холбогдох хэсгийг хүчингүй болгуулах тухай<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Газрын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4, 29 дүгээр зүйлийн 29.3, 33 дугаар зүйлийн 33.1.2, 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэгт заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч Т.Даваажавын гаргасан “Төв аймгийн Жаргалант сумын Засаг даргын 2016 оны 12 сарын 08-ны өдрийн А/877 дугаар захирамжийн ӨТ.Даваажавт холбогдох хэсгийг хүчингүй болгуулах тухай” ***<u>нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.</u>*** |
| 17 | Дугаар: 30<br>Огноо: 2017-09-25<br>/Захиргааны хэргийн анхан шатны шүүх шийдвэрлэсэн шийдвэр./<br><br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3934/view | Б.Б | Баянхонгор дахь Цагдаагын газар | • **Төрийн алба**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн 2006 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн тушаалын Б.Бд холбогдох хэсгийг хүчингүй болгуулах, 2006 онд өвчний учир ажлаас чөлөөлөгдсөн болохыг нотолсон хууль ёсны тушаал гаргахыг Баянхонгор аймгийн Цагдаагийн газарт даалгах<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Шүүхийн шийдвэрийн ТОГТООХ хэсгийн 1 дэх заалтаар: Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 24 дүгээр зүйлийн 24.1, Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсгийг тус тус баримтлан нэхэмжлэлийн зарим хэсгийг хангаж, Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх ***<u>Цагдаагийн хэлтсийн 2006 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн тушаалын Б.Бд холбогдох хэсгийг хүчингүй болгож</u>***,<br><br>2 дахь заалтаар: Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийг баримтлан нэхэмжлэгчийн “2006 онд өвчний учир ажлаас чөлөөлөгдсөн болохыг нотолсон хууль ёсны тушаал гаргахыг Баянхонгор аймгийн Цагдаагийн газарт даалгах” ***<u>нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ</u>***. |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| 18 | Дугаар: 57<br>Огноо: 2017-10-04<br>/Захиргааны хэргийн анхан шатны шүүх шийдвэрлэсэн шийдвэр./<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3927/view | "Х" ХХК | Дархан-Уул аймгийн Засаг дарга | • **Ашигт малтмал**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>Дархан-Уул аймгийн Засаг даргын 2015 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 07 тоот "Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүсч гаргасан өргөдөлд өгөх саналыг хүчингүй болгуулах тухай<br><br>Шийдвэрлэсэн байдал<br>Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 дахь хэсгийн "е", 30 дугаар зүйлийн 30.1.13, Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4, 19.5 дахь хэсэгт заасныг тус тус баримтлан "Х-" ХХК-ийн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2015 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн Дархан-Уул аймгийн Хонгор сумын Тариат нэртэй газарт 2395.03 гектар талбайд ашигт малтмалын хайгуул хийх зөвшөөрөл авах өргөдлийн дагуу хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг "дэмжихгүй" гэсэн ***07 дугаар саналыг хүчингүй болгож шийдвэрлэжээ.*** |
| 19 | Дугаар: 0015<br>Огноо: 2017-10-17<br>/Говьсүмбэр аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх/<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3881/view | Ч.Б | Говьсүмбэр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид | • **Төрийн алба**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>Говьсүмбэр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн "Тогтоолын заалт хүчингүй болгох тухай" 10 дугаар тогтоолыг хууль бус болохыг тогтоож, хүчингүй болгуулах<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1, 4.2.6, 26 дугаар зүйлийн 26.1-д заасныг баримтлан Ч.Б-ын гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, Говьсүмбэр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн "Тогтоолын заалт хүчингүй болгох тухай" ***10 дугаар тогтоолыг хүчингүй болгож шийдвэрлэжээ.*** |
| 20 | Дугаар: 626<br>Огноо: 2017-08-23<br>/Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх/<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3869/view | Ж.Өнөрбаяр | Татварын ерөнхий газар | • **Татвар**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>Татварын ерөнхий газрын 2013 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 2а/217 дугаар албан бичгийг илт хууль бус болохыг тогтоолгох, сургалтын хөнгөлөлтөд хамрагдахаар гаргасан өргөдлийг шийдвэрлэхээс татгалзсан үйлдэл хууль бус болохыг тогтоож, шийдвэрлэхийг Татварын ерөнхий газарт даалгах<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Шүүхийн шийдвэрийн ТОГТООХ хэсгийн 1 дэх заалтаар: Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.2, 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсгийн |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Дугаар: 736<br>Огноо: 2017-10-19<br>/ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх /<br>http://new.shuukh.mn/zahirgaadavah/1511/view<br><br>Дугаар: 502<br>Огноо: 2017-12-04<br>/ Улсын дээд шүүх /<br>http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/1133/view | | | 54.1.1 дэх заалтыг баримтлан Татварын ерөнхий газрын 2013 оны 01 дүгээр сарын 24-ний хуулбар хувь 2018-06-02 -нд www.shuukh.mn сайтаас татаж авав. Хуудас: 8/8 өдрийн 2а/217 дугаар албан бичгийг илт хууль бус болохыг тогтоолгох ***нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн авахаас татгалзаж, холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосугай.***<br><br>2 дахь заалтаар: Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6, 24.7, Татварын ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалтын 17.1.2, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн 28.1.4 дэх заалтад заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч Ж.Өнөрбаярын сургалтын хөнгөлөлтөд хамрагдахаар гаргасан өргөдлийг шийдвэрлэхээс татгалзсан үйлдэл хууль бус болохыг тогтоож, шийдвэрлэхийг ***Татварын ерөнхий газарт даалгаж шийдвэрлэжээ.***<br><br>Давж заалдах шатны шүүх шийдвэрлэсэн байдал:<br>Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 128/ШШ2017/0626 дугаар шийдвэрийг хэвээр үлдээж, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн давж заалдах гомдлыг хангахгүй орхисугай.<br><br>Улсын дээд шүүх шийдвэрлэсэн байдал:<br>Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 128/ШШ2017/0626 дугаар шийдвэрийн “тогтоох” хэсгийн 2 дахь заалт, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 221/МА2017/0736 дугаар магадлалын “тогтоох” хэсгийн 1 дэх заалтыг “Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.7 дахь хэсгийг баримтлан нэхэмжлэгч Ж.Ө-н Татварын ерөнхий газарт холбогдуулан гаргасан сургалтын хөнгөлөлтөд хамрагдах өргөдлийг шийдвэрлэхээс татгалзсан үйлдэл хууль бус болохыг тогтоолгох, шийдвэрлэхийг даалгах нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосугай” гэж өөрчилж, шийдвэр, магадлалын бусад заалтыг хэвээр үлдээсүгэй. |
| 21 | Дугаар: 564<br>Огноо: 2017-07-19<br>/ Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх/<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3865/view | “Терра виста” ХХК | Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэст холбогдох | • **Ашигт малтмал**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн Төв аймгийн Баян сумын нутагт орших 914.67 га газарт хайгуулын тусгай зөвшөөрлийг “Терра виста” ХХК-д олгохгүй байгаа эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоож, тусгай зөвшөөрөл олгохыг даалгах<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.1.6, 19 дүгээр |

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Дугаар: 619<br>Огноо: 2017-08-30<br>/ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх /<br>http://new.shuukh.mn/zahirgaadavah/1488/view<br><br>Дугаар: 476<br>Огноо: 2017-11-20<br>/ Улсын дээд шүүх /<br>http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/1137/view | | | зүйлийн 19.4, 19.5 хэсэгт заасныг баримтлан нэхэмжлэгч “Терра виста” ХХК-ийн “Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтсийн Төв аймгийн Баян сумын нутагт орших 914.67 га газарт хайгуулын тусгай зөвшөөрлийг “Терра виста” ХХК-д олгохгүй байгаа эс үйлдэхүйг хууль бус болохыг тогтоож, тусгай зөвшөөрөл олгохыг даалгах” ***шаардлага бүхий нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ***.<br><br>Давж заалдах шатны шүүх шийдвэрлэсэн байдал:<br>Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 128/ШШ2017/0564 дүгээр шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн давж заалдах гомдлыг хангахгүй орхисугай.<br><br>Улсын дээд шүүх шийдвэрлэсэн байдал:<br>Улсын дээд шүүх шийдвэрлэсэн байдал:<br>Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 128/ШШ2017/0564 дүгээр шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 221/МА2017/0619 дүгээр магадлалын “ТОГТООХ” хэсгийн 1-д “...11.1.6 гэснийг 11.1.16...” гэж өөрчилж, шийдвэр, магадлалын бусад заалтыг хэвээр үлдээсүгэй. |
| 22 | Дугаар: 696<br>Огноо: 2017-09-25<br>/Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх/<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3788/view<br><br>Дугаар: 840<br>Огноо: 2017-11-30<br>/ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх /<br>http://new.shuukh.mn/zahirgaadavah/1 | Л.А ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Баттөр | Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга | • **Төрийн алба**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар Х.Хашбаатарын 2017 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 05/890 дугаартай “Хариуцлага тооцож, хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхолыг зохицуулах, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11, 11 дүгээр зүйлийн 11.1, 29 дүгээр зүйлийн 29.2.4-т заасныг тус тус баримтлан Л.А ийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, Авлигатай тэмцэх газрын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн даргын ***2017 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 05/890 дугаартай захиргааны актыг илт хууль бус болохыг тогтоож шийдвэрлэжээ***.<br><br>Давж заалдах шатны шүүх шийдвэрлэсэн байдал:<br>Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 128/ШШ2017/0696 дугаар шийдвэрийг хүчингүй болгож, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| | [536/view](#)<br><br>Дугаар: 87<br>Огноо: 2018-02-26<br>/ Улсын дээд шүүх /<br>http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/1267/view | | | сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.4, 28 дугаар зүйлийн 28.1.2-т заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч Б.А-ийн “АТГ-ын ХШДШАХ-ийн даргын 2017 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн “Хариуцлага тооцож, хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай” 05/890 дугээр захиргааны актыг илт хууль бус болохыг тогтоолгох“ тухай нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай<br><br>Улсын дээд шүүх шийдвэрлэсэн байдал:<br>Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 221/МА2017/0840 дугээр магадлалыг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхисугай |
| 23 | Дугаар: 51<br>Огноо: 2017-09-28<br>/Дархан-Уул аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх/<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3722/view | “Д” ХХК | Дархан-Уул аймгийн Засаг дарга | • **Ашигт малтмал**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>Дархан-Уул аймгийн Засаг даргын 2015 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 1-1852 тоот саналыг хүчингүй болгуулах, Ашигт малтмалын Кадастрын хэлтсийн №026393 дугаарт бүртгэгдсэн Шаргалт-1 нэртэй газарт хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг хуульд заасны дагуу дэмжсэн санал гаргахыг даалгах<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 дахь хэсгийн “е”, Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5 дахь хэсэгт заасныг тус тус баримтлан “Трожан холдинг” ХХК-ийн нэхэмжлэлийн зарим хэсгийг хангаж, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2015 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 1-1852 тоот саналыг хүчингүй болгож, Ашигт малтмалын Кадастрын хэлтсийн №026393 дугаарт бүргэгдсэн Шаргалт-1 нэртэй газарт хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг хуульд заасны дагуу дэмжсэн санал гаргахыг даалгах ***нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.*** |
| 24 | Дугаар: 56<br>Огноо: 2017-10-16<br>/Дархан-Уул аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх/<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3721/view | Ве ка” ХХК | Дархан-Уул аймгийн Засаг дарга | • **Ашигт малтмал**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>Дархан-Уул аймгийн Засаг даргын 2015 оны 10 дугаар сарын 30-ний өдрийн 1-1884 тоот ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүсч гаргасан өргөдөлд өгсөн саналыг хүчингүй болгуулах тухай<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 дахь хэсгийн “е”, Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5 дахь хэсэгт заасныг тус тус баримтлан “Вентур капитал” ХХК-ийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, Дархан-Уул |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | аймгийн Засаг даргын 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 1-1884 дугаарын ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүсч гаргасан өргөдөлд өгсөн саналыг ***хүчингүй болгож шийдвэрлэжээ***. |
| 25 | Дугаар: 52<br>Огноо: 2017-09-28<br>/Дархан-Уул аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх/<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3719/view | “П И” ХХК | Дархан-Уул аймгийн Засаг дарга | • **Ашигт малтмал**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>Дархан-Уул аймгийн Засаг даргын 2015 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 09 тоот ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүсч гаргасан өргөдөлд өгсөн саналыг хүчингүй болгуулж, 026205 дугаарт бүртгэгдсэн Баян-Уул нэртэй газарт хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг хуульд заасны дагуу дэмжсэн санал гаргахыг даалгах<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 дахь хэсгийн “е”, Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5 дахь хэсэгт заасныг тус тус баримтлан “Поларис Инвестмент” ХХК-ийн нэхэмжлэлийн зарим хэсгийг ханган, Дархан-Уул аймгийн Засаг даргын 2015 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 09 тоот саналыг хүчингүй болгож, нэхэмжлэгчийн Ашигт малтмалын Кадастрын хэлтсийн №026205 дугаарт бүртгэгдсэн Баян-Уул нэртэй газарт хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг хуульд заасны дагуу дэмжсэн санал гаргахыг даалгах шаардлагыг ***хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.*** |
| 26 | Дугаар: 537<br>Огноо: 2017-07-03<br>/Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх/<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3655/view | “Би Эн Би Ди” ХХК, “Хо Хо” ХХК | Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга | • **Бусад**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 02/3918 тоот албан бичгийг илт хууль бус болохыг тогтоолгох<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Шүүхийн шийдвэрийн ТОГТООХ хэсгийн 1 дэх заалтаар: Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.15, 14 дүгээр зүйлийн 14.1, 14.1.1, 40 дүгээр зүйлийн 40.2, Эрчим хүчний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.7, 3.1.9, 6 дугаар зүйлийн 6.1, 6.1.5, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 1, Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.3 дахь заалтад заасныг тус тус баримтлан “Улиастай чулуу” ХХК, “Би Эн Би Ди” ХХК-иудын нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын ***2016 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 02/3918 тоот албан бичгийг илт хууль бус болохыг тогтоож***,<br><br>2 дахь заалтаар: Эрчим хүчний тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийг баримтлан “Хо Хо” хуулбар хувь 2018-06-02 -нд www.shuukh.mn сайтаас |

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | татаж авав. Хуудас: 9/9 ХХК-ийн “Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 02/3918 тоот албан бичгийг илт хууль бус болохыг тогтоолгох” ***<u>нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.</u>*** |
| 27 | Дугаар: 688<br>Огноо: 2017-09-21<br>/Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх/<br>[http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3589/view](http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3589/view) | “ХХ”, “ХХХ ”, “ХХХХ ”, “Б ”, “Ү ”, “М ” ТББ | Монгол Улсын Засгийн газар | • **Бусад**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>...Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 63 дугаар тогтоолыг хууль бус байсан болохыг тогтоолгох, уг тогтоолын дагуу 2017 оны 03 дугаар сарын 05-ны өдөр Төв аймгийн Аргалант суманд зохион байгуулагдсан “Дүнжингарав” уралдаан хууль бус байсан болохыг тогтоох, Засгийн газарт жил бүрийн 10 дугаар сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдөр хүртэл улс, аймаг, сумын хэмжээний хурдан морины уралдаан бэлтгэл шат болон уралдааны явцад хүүхдээр морь унуулах, аливаа хэлбэрийн морин уралдаан зохион байгуулахыг хориглосон улс даяар дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний акт гаргахыг даалгах<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Шүүхийн шийдвэрийн ТОГТООХ хэсгийн 1 дэх заалтаар: Хүүхдийн эрхийн тухай 1989 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн конвенцийн 3 дугаар зүйлийн 1, 32 дугаар зүйлийн 1, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийн тухай Олон улсын хөдөлмөрийн байгууллагын 1999 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн 182 дугаар конвенцийн 7 дугаар зүйлийн 2.а, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.6-д заасныг тус тус баримтлан “ХХ”, “ХХХ ”, “ХХХХ ”, “Б ”, “Ү ”, “М ” ТББ-уудаас, Монгол Улсын Засгийн газарт холбогдуулан гаргасан нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж “Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 63 дугаар тогтоолын 1 дэх заалтыг хууль бус байсан болох”-ыг тогтоож, үлдэх хэсэг болох “Засгийн газрын 2017 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн 63 дугаар тогтоолын 2, 3 дугаар заалтыг хууль бус байсан болохыг тогтоолгох” ***<u>тухай нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож,</u>***<br><br>2 дахь заалтаар: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1-д заасны дагуу нэхэмжлэгч нараас гаргасан “...Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 63 дугаар тогтоолын дагуу 2017 оны 03 дугаар сарын 05-ны өдөр Төв аймгийн Аргалант суманд зохион байгуулагдсан “Дүнжингарав” уралдаан хууль бус байсан болохыг тогтоох” ***<u>нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн авахаас татгалзаж, холбогдох хэргийг хэрэгсэхгүй</u>*** |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | ***болгож***,<br><br>3 дахь заалтаар: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.2-д заасны дагуу нэхэмжлэгч нараас гаргасан “Монгол Улсын Засгийн газарт жил бүрийн 10 дугаар сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 01-ний өдөр хүртэл улс, аймаг, сумын хэмжээний хурдан морины уралдаан бэлтгэл шат болон уралдааны явцад хүүхдээр морь унуулах, аливаа хэлбэрийн морин уралдаан зохион байгуулахыг хориглосон улс даяар дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний акт гаргахыг даалгах” ***нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн авахаас татгалзаж, холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.*** |
| 28 | Дугаар: 518<br>Огноо: 2017-09-18<br>/Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх/<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3548/view | “Т”, “А” ХХК | Гаалийн ерөнхий газар | • **Бусад**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>Гаалийн улсын байцаагчийн 2013 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 21/13, 22/13 дугаартай “Татвар нөхөн төлүүлэх тухай” актуудыг хүчингүй болгуулах” тухай нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, “Тансаг Алтай” “Алтай сүлжээ” ХХК-д шалгалт хийх болсон 2013 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 10/13, 11/13 тоот удирдамжуудыг илт хууль бусад тооцуулах<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Шүүхийн шийдвэрийн ТОГТООХ хэсгийн 1 дэх заалтаар: Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 15 дугаар зүйлийн 15.1-д заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч “Т” ХХК, “А” ХХК-ийн нэхэмжлэлийн зарим хэсгийг хангаж, Гаалийн улсын байцаагчийн 2013 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 21/13, 22/13 дугаартай “Татвар нөхөн төлүүлэх тухай” ***актуудыг хүчингүй болгож,***<br><br>2 дахь заалтаар: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1-д заасныг баримтлан нэхэмжлэгч “Т” ХХК, “А” ХХК-ийн нэхэмжлэлийн үлдэх хэсэг “Т” “А” ХХК-д шалгалт хийх болсон 2013 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 10/13, 11/13 тоот удирдамжуудыг илт хууль бусад тооцуулах” ***тухай нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.*** |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| 29 | Дугаар: 452<br>Огноо: 2017-09-15<br>/Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх/<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3492/view | “Батсервис” ХХК | Баянгол дүүргийн Татварын хэлтэс | • **Бусад**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>Баянгол дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагчийн 2013 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 264026 дугаар актаар ногдуулсан 43620,7 мянган төгрөгийн торгууль, 28468,5 мянган төгрөгийн алданги, 126,0 мянган төгрөгийн хүүг Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай хуульд заасны дагуу өршөөн хэлтрүүлэхийг даалгуулах, тус хэлтсийн 2016 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 1/3044 дүгээр албан бичгийг илт хууль бус болохыг тогтоолгох<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Шүүхийн шийдвэрийн ТОГТООХ хэсгийн 1 дэх заалтаар: Татварын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.2, 74 дүгээр зүйлийн 74.1, 74.2, 74.3, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай /2006 оны/ хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.1.1, Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1, 4 дүгээр зүйлийн 4.3, 10 дугаар зүйлийн 10.2-д заасныг тус тус баримтлан “Баянгол дүүргийнг Татварын хэлтсийн татварын улсын байцаагчийн 2013 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 264026 дугаар актаар ногдуулсан 43620,7 мянган төгрөгийн торгууль, 28468,5 мянган төгрөгийн алданги, 126,0 мянган төгрөгийн хүүг Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай хуульд заасны дагуу өршөөн хэлтрүүлэхийг ***хариуцагч Баянгол дүүргийн Татварын албанд даалгаж,***<br><br>2 дахь заалтаар: Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6, Татварын ерөнхий хуулийн 221 дугаар зүйлийн 221.1.1, 221.1.2-т заасныг баримтлан Баянгол дүүргийн татварын хэлтсийн 2016 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн, 1/3044 дүгээр албан бичгийг илт хууль бус болохыг тогтоолгох тухай ***“Батсервис” ХХК-ийн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.*** |
| 30 | Дугаар: 00026<br>Огноо: 2017-09-07<br>/Орхон аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх/<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3467/view | М.Лхагва | Орхон аймгийн Баян-Өндөр сумын Яргуйт багийн иргэдийн Нийтийн Хурал, Яргуйт багийн иргэдийн Нийтийн Хурлын хуралдааны | • **Сонгууль**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>Яргуйт багийн иргэдийн Нийтийн Хурлын 2017 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 04 дугаартай тогтоол, Тооллогын комиссын 2017 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 04 дугаартай тогтоол, “Баян-Өндөр сумын Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн Б/09 дугаартай захирамжийн 1 дүгээр заалтын 2 дахь хэсэг буюу Яргуйт багийн Засаг даргаар М.Эрдэнэбулганыг түр томилсон захирамжийн хэсгийг хүчингүй болгуулах, Яргуйт багийн иргэдийн Нийтийн |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | Тооллогын комисс, Баян-Өндөр сумын Засаг дарга | Хурлыг зарлан хуралдуулж, багийн Засаг даргыг сонгох ажиллагааг дахин зохион байгуулахыг даалгах<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Шүүхийн шийдвэрийн ТОГТООХ хэсгийн 1 дэх заалтаар: Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 23 дугаар зүйлийн 23.10, 26 дугаар зүйлийн 26.2, 26.3 дахь заалтуудыг баримтлан нэхэмжлэгч М.Лхагвын Орхон аймгийн Баян-Өндөр сумын Яргуйт багийн иргэдийн Нийтийн Хуралд холбогдуулан гаргасан “Яргуйт багийн иргэдийн Нийтийн Хурлын 2017 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 04 дугаартай “Багийн Засаг даргыг томилуулахаар уламжлах тухай” тогтоолыг хүчингүй болгуулах, Яргуйт багийн иргэдийн Нийтийн Хурлыг зарлан хуралдуулж, багийн Засаг даргыг сонгох ажиллагааг дахин зохион байгуулахыг даалгах”, Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргад холбогдуулан гаргасан “Баян-Өндөр сумын Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн Б/09 дугаартай захирамжийн 1 дүгээр заалтын 2 дахь хэсэг буюу Яргуйт багийн Засаг даргаар М.Эрдэнэбулганыг түр томилсон захирамжийн хэсгийг хүчингүй болгуулах”-ыг хүссэн ***нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосугай.***<br><br>2 дахь заалтаар: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1 дэх заалтыг баримтлан М.Лхагвын Орхон аймгийн Баян-Өндөр сумын Яргуйт багийн иргэдийн Нийтийн Хурлын хуралдааны Тооллогын комисст холбогдуулан гаргасан “Тооллогын комиссын 2017 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 04 дугаартай тогтоолыг хүчингүй болгуулах”-ыг хүссэн ***нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, энэхүү шаардлагад холбогдох захиргааны хэргийг хэрэгсэхгүй болгосугай.*** |
| 31 | Дугаар: 11<br>Огноо: 2017-06-20<br>/Өмнөговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүү/<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3462/view | “Монголын төмөр зам” ТӨХК | Өмнөговь аймгийн Ханбогд сумын Засаг дарга | • **Газар**<br><br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>Ханбогд сумын Засаг даргын 2011 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 44 дүгээр захирамжийн Ш.Баттулга, О.Буджав нарт холбогдох хэсгийг, 2011 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 125 дугаар захирамж, 2011 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 200 дугаар захирамж, газрын 0300583, 0300584, 0332243, 0373359 дугаартай гэрчилгээнүүдийг тус тус хүчингүй болгуулах<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Шүүхийн шийдвэрийн ТОГТООХ хэсгийн 1 дэх заалтаар: Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 31 дүгээр зүйлийн 31.3, 61 дүгээр зүйл зүйлийн 61.1 дэх хэсэгт заасныг тус тус баримтлан “Монголын төмөр зам” ТӨХК-ийн |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсэг болох Өмнөговь аймгийн Ханбогд сумын Засаг даргын 2011 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 44 дүгээр захирамжийн Ш.Баттулга, О.Буджав нарт холбогдох хэсгийг, 2011 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 125 дугаар захирамжийг тус тус хүчингүй болгож, 2011 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 200 дугаар захирамжийг хүчингүй болгуулах ***нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож,***<br><br>2 дахь заалтаар: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.3 дахь хэсэгт зааснаар нэхэмжлэгч “газрын 0300583, 0300584, 0332243, 0373359 дугаартай гэрчилгээнүүдийг тус тус хүчингүй болгуулах” ***нэхэмжлэлийн шаардлагаасаа татгалзсаныг баталж,***<br><br>3 дахь заалтаар: Шүүхийн шийдвэрийн хоёр дахь заалтад хэргийн оролцогчид, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нар ***давж заалдах*** ***гомдол гаргах эрхгүй болохыг дурьдаж шийдвэрлэжээ.*** |
| 32 | Дугаар: 16<br>Огноо: 2017-06-15<br>/Баянхонгор аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх/<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3399/view | З.Нүрзэд | Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын Засаг дарга, Тамгын газрын дарга Б.Батбаатар | • **Төрийн алба**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын Засаг даргын 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/64 дүгээр захирамж, Хөх морьт сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2016 оны 1 сарын 04-ний өдрийн Б/01 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болгуулах, ажилд эгүүлэн тогтоолгох, 2015 оны 12 дугаар сарын 08-ны өдрөөс 2016 оны 1 дүгээр сарын 04-ний өдөр хүртэл ажилласан цалин, ажилгүй байсан хугацааны цалин гаргуулах, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлүүлэх<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Шүүхийн шийдвэрийн ТОГТООХ хэсгийн 1 дэх заалтаар: Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1, 68.2, 68.4 дэх хэсгийг баримтлан З.Нүрзэдийн нэхэмжлэлтэй, Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын Засаг даргын Тамгын газрын дарга Б.Батбаатарт холбогдох “Хөх морьт сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2016 оны 1 сарын 04-ний өдрийн Б/01 дүгээр тушаалыг хүчингүй болгуулах, ажилгүй байсан хугацааны цалин гаргуулах, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлүүлэх” ***захиргааны хэргийн нэхэмжлэгч, хариуцагчийн эвлэрлийг баталж, холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож,***<br><br>2 дахь заалтаар: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.2, 66.3 дахь хэсгийг баримтлан З.Нүрзэдийн нэхэмжлэлтэй, Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын Засаг даргын Тамгын газрын дарга Б.Батбаатарт холбогдох “Ажилд эгүүлэн тогтоолгох, 2015 оны 12 дугаар сарын |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | 08-ны өдрөөс 2016 оны 1 дүгээр сарын 04-ний өдөр хүртэл ажилласан цалинг гаргуулах" ***захиргааны хэргийн нэхэмжлэгч нэхэмжлэлийн зарим хэсгээсээ татгалзсаныг баталж, холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож,***<br><br>3 дахь заалтаар: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1, 54.2 дахь хэсгийг баримтлан Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын Засаг даргад холбогдуулан гаргасан "Говь-Алтай аймгийн Хөхморьт сумын Засаг даргын 2015 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/64 дүгээр захирамжийг хүчингүй болгуулах" шаардлага бүхий ***З.Нүрзэдийн холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэжээ.*** |
| 33 | Дугаар: 358<br>Огноо: 2017-05-11<br>/Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх/<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3187/view<br><br>Дугаар: 509<br>Огноо: 2017-07-18<br>/ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх /<br>http://new.shuukh.mn/zahirgaadavah/1632/view<br><br>Дугаар: 384<br>Огноо: 2017-10-18<br>/ Улсын дээд шүүх /<br>http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/1039/view | Нурамт холдинг ХХК | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга | • **Бусад**<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Захиргааны ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 47 дугаар зүйлийн 47.1.3-д заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч "Нурамт холдинг" ХХК-ийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргад холбогдуулан гаргасан "Аж үйлдвэрийн хуулбар хувь 2018-06-02 -нд www.shuukh.mn сайтаас татаж авав. Хуудас: 15/15 яам /хуучин нэрээр/-ны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 03/1181 тоот мэдэгдлээр "Спейшл интернэйшнл" ХХК /компанийн, нэр өөрчлөгдөж "Нурамт холдинг" ХХК болсон/-д олгогдсон хөнгөлөлттэй зээлийг хүчингүйд тооцсон шийдвэрийг илт хууль бус тооцуулах тухай" гэсэн шаардлага бүхий нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж, Аж үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын ***2016 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 03/1181 тоот мэдэгдлийг илт хууль бус болохыг тогтоож шийдвэрлэжээ.***<br><br>Давж заалдах шатны шүүх шийдвэрлэсэн байдал:<br>Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 358 дугаар шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр мөн шүүхэд буцаасугай.<br><br>Улсын дээд шүүх шийдвэрлэсэн байдал:<br>Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 7 дугаар сарын 18-ний өдрийн 221/МА2017/0509 дүгээр магадлалыг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхисугай. |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| 34 | Дугаар: 346<br>Огноо: 2017-05-05<br>/Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх/<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3137/view | “Богдын хар алт” ХХК | Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэс | • **Ашигт малтмал**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>Ашигт малтмалын газрын Кадастрын хэлтсийн 2015 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн ТХ-00062-DG өргөдөлд өгсөн Кадастрын хэлтсийн дүгнэлтийг хүчингүй болгуулж, уг дүгнэлтийг үндэслэн өргөдлийн бүртгэлээс хасагдсан ТХ-00062-DG өргөдлийн бүртгэлийг сэргээлгэх, Ашигт малтмалын газрын 2016 оны 04 дүгээр 13-ны өдрийн албан бичгийн зарим хэсгийг хүчингүй болгуулж, Ашигт малтмалын газрын Кадастрын хэлтсээс Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших “Амазон ресурс” ХХК-д олгосон хайгуулын XV-020296 дугаартай тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Ашигт малтмалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3, 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.3, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 12 дугаар зүйлийн 12.1-д тус тус заасныг баримтлан “Богдын хар алт” ХХК-ийн нэхэмжлэлээр Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэст холбогдуулан гаргаснаар Ашигт малтмалын газрын Кадастрын хэлтсийн 2015 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн ТХ-00063-DG өргөдөлд өгсөн дүгнэлтийг хүчингүй болгуулж, уг дүгнэлтийг үндэслэн өргөдлийн бүртгэлээс хасагдсан ТХ-00063-DG өргөдлийн бүртгэлийг сэргээлгэж, Ашигт хуулбар хувь 2018-06-02 -нд www.shuukh.mn сайтаас татаж авав. Хуудас: 11/11 малтмалын газрын 2016 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн албан бичгийн зарим хэсгийг хүчингүй болгуулж, Ашигт малтмал, газрын тосны Кадастрын хэлтсээс “Амазон ресурс” ХХК-д олгосон Дорноговь аймгийн Айраг сумын нутагт орших хайгуулын XV-020296 дугаартай тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулахыг хүссэн ***нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.*** |
| 35 | Дугаар: 20<br>Огноо: 2017-03-27<br>/Увс аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх/<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3030/view | Ходхүүгийн Золбат | Увс аймгийн Зүүнговь сумын Засаг дарга, Зүүнговь сумын иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчид, иргэдийн Нийтийн Хурал | • **Бусад**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>Увс аймгийн Зүүнговь сумын Тохой багийн Засаг даргаар томилохыг Зүүнговь сумын Засаг даргад даалгуулах тухай үндсэн нэхэмжлэл, Зүүнговь сумын Тохой багийн иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчдийн иргэдийн Нийтийн Хурлын хуралдааны товыг тогтоосон 2017 оны 01 сарын 25-ны өдрийн шийдвэр, 2017 оны 01 сарын 27-ны өдөр хуралдсан Тохой багийн иргэдийн Нийтийн Хурлын хуралдаан болон түүнээс гарсан 2017 оны 01 сарын 27-ны өдрийн 07 дугаартай тогтоолыг тус тус хүчингүй болгуулах<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Шүүхийн шийдвэрийн ТОГТООХ хэсгийн 1 дэх заалтаар: Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 8 дугаар |

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Дугаар: 410<br>Огноо: 2017-06-08<br>/ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх /<br>http://new.shuukh.mn/zahirgaadavah/1163/view | | | зүйлийн 8.1, 23 дугаар зүйлийн 23.4, 23.10, 26 дугаар зүйлийн 26.4 дэх хэсгүүдэд заасныг баримтлан нэхэмжлэгч Х.Золбатын " Зүүнговь сумын Тохой багийн иргэдийн Нийтийн Хурлын Хуралдааны 2016 оны 11 сарын 25-ны өдрийн 02 тоот тогтоолыг үндэслэн Тохой багийн Засаг даргаар томилохыг даалгуулах " тухай нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож, нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж 2017 оны 01 сарын 27-ны өдөр болсон Зүүнговь сумын Тохой багийн иргэдийн Нийтийн Хурлын Хуралдааныг болон хуралдаанаас гарсан ***2017 оны 01 сарын 27-ны өдрийн 07 дугаартай тогтоолыг тус тус хүчингүй болгож,***<br><br>2 дахь заалтаар: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1 дэх хэсэгт заасныг баримтлан нэхэмжлэгч Х.Золбатын " 2017 оны 01 сарын 27-ны өдөр багийн иргэдийн Нийтийн Хурлын Хуралдааныг товлон зарласан Тохой багийн иргэдийн Нийтийн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрийг хүчингүй болгуулах тухай " ***нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.***<br><br>Давж заалдах шатны шүүх шийдвэрлэсэн байдал:<br>Увс аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 20 дугаар шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн давж заалдах гомдлыг хангахгүй орхисугай |
| 36 | Дугаар: 0003<br>Огноо: 2017-04-04<br>/Говьсүмбэр аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх/<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/2930/view | Загдцэсэмийн Баярсайхан | Говьсүмбэр аймгийн Засаг дарга | • **Төрийн алба**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн 08 дугаар тогтоол, Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2016 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн Б/42 дугаар захирамжийг тус тус хүчингүй болгуулах, ажилгүй байсан хугацааны цалин, ээлжит сонгуулийн дүнгээр өөрчлөгдсөн тохиолдолд авах ёстой 6 сарын тэтгэмж, төрийн одон медаль авсан тохиолдолд байгууллагын дотоод журамд заасны дагуу олгогдох урамшуулал зэргийг гаргуулж, эрүүл мэнд болон нийгмийн даатгалын дэвтэрт зохих бичилт хийлгэхийг Говьсүмбэр аймгийг Засаг даргад даалгах;<br>П.Амарсайхан, Л.Жамбаасүрэн, Ш.Билэгтүмбэрэл нарын 2012-2016 оны хооронд Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч байхдаа намайг огцруулсан шийдвэрт оролцсон үйлдлүүдийг илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрүүлэх<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Шүүхийн шийдвэрийн ТОГТООХ хэсгийн 1 дэх заалтаар: Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8, 23 дугаар зүйлийн 23.4, 23.7, 24 дүгээр зүйлийн 24.3, 25 дугаар |

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | зүйлийн 25.1, 38 дугаар зүйлийн 38.1, Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6, Хөдөлмөрийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1, 130 дугаар зүйлийн 130.1, Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, Захиргааны ерөнхий хуулийн 101 дүгээр зүйлийн 101.2-т заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч З.Баярсайханы гаргасан нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 8 дугаар сарын 04-ний өдрийн 08 дугаар тогтоол, Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2016 оны 8 дугаар сарын 05-ны өдрийн Б/42 дугаар захирамжийг тус тус хүчингүй болгож; ажилгүй байсан хугацааны цалин олговорт 6971055 (зургаан сая есөн зуун далан нэгэн мянга тавин таван) төгрөг, ээлжит сонгуулийн дүнд чөлөөлөгдсөн тохиолдолд олгох 6 сарын тэтгэмж, төрийн одон медаль авсан тохиолдолд олгох нэг сарын үндсэн цалингийн 70 хувьтай тэнцэх урамшуулал зэргийг Говьсүмбэр аймгийн Засаг даргаас гаргуулж нэхэмжлэгч З.Баярсайханд олгох; ***түүний эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын дэвтэрт зохих журмын дагуу бичилт хийлгэхийг аймгийн Засаг даргад даалгаж,***<br><br>2 дахь заалтаар: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1, 109 дүгээр зүйлийн 109.2-т заасныг баримтлан З.Баярсайханаас Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд холбогдуулан гаргасан зарим нэхэмжлэлийн шаардлагаар үүсгэсэн захиргааны хэргийг хэрэгсэхгүй болгож, “П.Амарсайхан, Л.Жамбаасүрэн, Ш.Билэггүмбэрэл нарын 2012-2016 оны хооронд Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч байхдаа намайг огцруулсан шийдвэрт оролцсон үйлдлүүдийг илт хууль бус болохыг хүлээн зөвшөөрүүлэх” тухай ***нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн авахаас татгалзаж,***<br><br>3 дахь заалтаар: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 107 дугаар зүйлийн 107.5-д заасны дагуу шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 30 хоногийн дотор нэхэмжлэгч З.Баярсайханд холбогдох цалин хөлс, тэтгэмж, ***урамшууллыг олгох замаар шүүхийн шийдвэрийг биелүүлэхийг Говьсүмбэр аймгийн Засаг даргад мэдэгдэж шийдвэрлэжээ.*** |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| 37 | Дугаар: 0007<br>Огноо: 2017-03-09<br>/Булган аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх/<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/2801/view<br><br>Дугаар: 342<br>Огноо: 2017-05-16<br>/ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх /<br>http://new.shuukh.mn/zahirgaadavah/1341/view | Орхон сумын иргэн, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч С.Бат-Эрдэнэ | Булган аймгийн Засаг дарга З.Батзориг, Орхон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Н.Амартүвшин, хамтран хариуцагч Ц.Даваадорж | • **Төрийн алба**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>Орхон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааны тогтоолуудыг илт хууль бус болохыг тогтоож, хүчингүй болгуулах, аймгийн Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн Б/133 тоот захирамжийг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлийн шаардлага бүхий 158/2017/0001/3 дугаарын индекстэй<br>Шийдвэрлэсэн байдал:<br>Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1, 22.1.2, 23 дугаар зүйлийн 23.4, 23.13, 25 дугаар зүйлийн 25.2, 26 дугаар зүйлийн 26.4, 26.5-д заасныг баримтлан нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг бүрэн хангаж, Булган аймгийн Орхон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуралдааныг бүхэлд нь хууль бусад тооцож, түүний тогтоолууд болон Булган аймгийн Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн Ж.Ундрахыг Орхон сумын Засаг даргаар томилох тухай Б/133 дугаарын захирамж хууль бус болох нь тогтоогдсон тул ***тус тус хүчингүй болгож шийдвэрлэжээ.***<br><br>Давж заалдах шатны шүүх шийдвэрлэсэн байдал:<br>Булган аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 07 дугаар шийдвэрийн Тогтоох хэсгийн 1 дэх заалтыг “1. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, 23.7, 26 дугаар зүйлийн 26.3, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1, 109 дүгээр зүйлийн 109.2-т заасныг баримтлан нэхэмжлэгч С.Бат-Эрдэнийн нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, Булган аймгийн Орхон сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Анхдугаар хуралдааны 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай” 02, Хурлын даргыг чөлөөлөх тухай” 04, “Хурлын даргыг сонгох тухай” 05, “Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийг сонгох тухай” 06, “Сумын Засаг даргад уламжлах тухай” 07 дугаар тогтоолууд, Булган аймгийн Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн “Ж.Ундрахыг Орхон сумын Засаг даргаар томилох тухай” Б/133 дугаар захирамжийг тус тус хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагаас үлдэх “Булган аймгийн Орхон сумын Анхдугаар хуралдааны “Мандатын комисс байгуулах тухай” 01, “Тооллогын комисс батлах тухай” 03 дугаар тогтоолуудыг хүчингүй болгуулах тухай” хэсгийг хүлээн авахаас татгалзаж, холбогдох хэргийг хэргийг хэрэгсэхгүй болгосугай” гэж өөрчилж, хариуцагч болон гуравдагч этгээдийн өмгөөлөгчийн давж заалдах гомдлыг хангахгүй орхисугай. |



pdfelement

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| 38 | Дугаар: 40<br>Огноо: 2016-12-16<br>/Төв аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх/<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/2569/view | "Өгөөж сүмбэр" ХХК | Төв аймгийн Сүмбэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга | • **Ашигт малтмал**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>Сүмбэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 03 дугаар сарын 11-ний 09 дүгээр тогтоол илт хууль бус болохыг тогтоолгох тухай<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 22 дугаар зүйлийн 22.1.1, 22.1.12, 25 дугаар зүйлийн 25.1-д заасныг баримтлан Төв аймгийн Сүмбэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ***2016 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 09 дугаартай "Санал хүргүүлэх тухай" тогтоол илт хууль бус болохыг тогтоож шийдвэрлэжээ.*** |
| 39 | Дугаар: 1075<br>Огноо: 2016-12-20<br>/Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх/<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/2484/view | Н.Галцог | Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга | • **Төрийн алба**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2016 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн "Ажлаас чөлөөлөх, ажилд томилох, чиг үүрэг, орон тоо, төсөв, шилжүүлэх, цалин хөлс тогтоох тухай" А/81 дүгээр тушаалын Н.Галцогт холбогдох хэсгийг хүчингүй болгуулах, өмнө эрхэлж байсан ажил албан тушаалд томилохыг даалгах<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2.3-д заасныг баримтлан Цаг уур, орчны шинжилгээний газрын Удирдлага төлөвлөлт, санхүү, хамтын ажиллагааны хэлтсийн даргын албан тушаалд Захиргаа, хамтын ажиллагааны хэлтсийн даргын албан тушаалыг хашиж байсан албан хаагч болон Санхүү, аж ахуйн хэлтсийн даргын албан тушаалыг хашиж байсан албан хаагчийн хэнийг нь томилохыг хуульд заасан шалгуур үзүүлэлтүүдийн дагуу шалгаруулсан захиргааны шинэ акт гаргах хүртэл Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2016 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн "Ажлаас чөлөөлөх, ажилд томилох, чиг үүрэг, орон тоо, төсөв шилжүүлэх, цалин хөлс тогтоох тухай" дугаар А/81 тоот тушаалын 2 дугаар хавсралтын 17 буюу ***Н.Галцогт холбогдох хэсгийг шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн хоёр сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж,***<br><br>2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1, 3 дугаар зүйлийн 3.1.3, Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1-д заасныг тус тус баримтлан Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2016 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн "Ажлаас чөлөөлөх, ажилд томилох, чиг үүрэг, орон тоо, төсөв шилжүүлэх, цалин хөлс тогтоох тухай" дугаар А/81 тоот тушаалын 1 дүгээр хавсралтын 1-ийг буюу Н.Галцогт холбогдох хэсгийг |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Дугаар: 208<br>Огноо: 2017-03-15<br>/ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх /<br>http://new.shuukh.mn/zahirgaadavah/1102/view<br><br>Дугаар: 219<br>Огноо: 2017-06-05<br>/ Улсын дээд шүүх /<br>http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/847/view | | | хүчингүй болгуулах”-ыг хүссэн ***нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож,***<br><br>3. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.5-д заасныг баримтлан “Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2016 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн “Ажлаас чөлөөлөх, ажилд томилох, чиг үүрэг, орон тоо, төсөв шилжүүлэх, цалин хөлс тогтоох тухай” дугаар А/81 тоот тушаалыг бүхэлд нь хүчингүй болгуулах”-ыг хүссэн нэхэмжлэлийн шаардлагын нэхэмжлэгч Н.Галцогт холбогдох хэсгээс бусад хэсгийг хүлээн авахаас татгалзаж, тус ***хүлээн авахаас татгалзсан шаардлагад холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож,***<br><br>4. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 107 дугаар зүйлийн 107.5-д хуулбар хувь 2018-06-02 -нд www.shuukh.mn сайтаас татаж авав. Хуудас: 10/10 заасныг баримтлан хариуцагч “Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга нь энэ шийдвэрийн үндэслэх хэсэгт дурдсан хуульд заасан шалгуур үзүүлэлтүүдээр сонгон шалгаруулалт явуулах замаар энэ шүүхийн шийдвэрийг биелүүлж,<br><br>5. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 107 дугаар зүйлийн 107.6-д заасныг баримтлан Цаг уур, орчны шинжилгээний газрын Удирдлага төлөвлөлт, санхүү, хамтын ажиллагааны хэлтсийн даргын албан тушаалд Захиргаа, хамтын ажиллагааны хэлтсийн даргын албан тушаалыг хашиж байсан албан хаагч болон Санхүү, аж ахуйн хэлтсийн даргын албан тушаалыг хашиж байсан албан хаагчийн хэнийг нь томилохыг хуульд заасан шалгуур үзүүлэлтүүдийн дагуу шалгаруулсан захиргааны шинэ актыг шүүхээс тогтоосон хоёр сарын хугацаанд гаргаагүй тохиолдолд Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2016 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн “Ажлаас чөлөөлөх, ажилд томилох, чиг үүрэг, орон тоо, төсөв шилжүүлэх, цалин хөлс тогтоох тухай” ***дугаар А/81 тоот тушаалын 2 дугаар хавсралтын 17 бүгүү Н.Галцогт холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцож шийдвэрлэжээ.***<br><br>Давж заалдах шатны шүүх шийдвэрлэсэн байдал:<br>Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2016 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 1075 дугаар шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасугай.<br>Улсын дээд шүүх шийдвэрлэсэн байдал:<br>Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 221/МА2017/0208 дугаар магадлалыг хэвээр үлдээж, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гомдлыг хангахгүй орхисугай. |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| 40 | Дугаар: 1032<br>Огноо: 2016-12-12<br>/Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүх/<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/2475/view | “Бакунатур” ХХК | Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын хэлтэс | • **Ашигт малтмал**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>Ашигт малтмалын газрын Кадастрын хэлтсийн дарга Н.Чинбаатарын 2016 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 6/757 дугаар “Бакунатур” ХХК-д ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан шийдвэрийг хүчингүй болгох, Говь-Алтай аймгийн Дэлгэр, Тайшир сумдын нутагт байрлах Тайшир нэртэй газарт 25729.22 гектор талбайд хайгуулын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хамгийн түрүүнд гаргаж бүртгүүлсэн этгээд нь “Бакунатур” ХХК болохыг тогтоолгож хүлээн зөвшөөрүүлэх, Ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын Кадастрын хэлтэст Бакунатур ХХК-ийн NE-025139 дугаар бүртгэлтэй өргөдлийн дагуу Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дах хэсэгт заасан ажиллагааг дахин хийж, зохих журмын дагуу шийдвэрлэхийг даалгах, Ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын Кадастрын хэлтсийн дарга Н.Чинбаатарын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 1187 дугаар Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай Шийдвэрийн “Универсалнобле машинери” ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгуулах, Ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын Кадастрын хэлтсийн дарга Н.Чинбаатарын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 33 дугаар “Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай” шийдвэрийн Ихмонголын орд ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгуулах<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1, Ашигт малтмалын тухай хуулийн 19 хуулбар хувь 2018-06-02 -нд www.shuukh.mn сайтаас татаж авав. Хуудас: 13/13 дүгээр зүйлийн 19.1.2, 19.1.3, 19.1.4, 19.5, мөн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2, 49.3-т заасныг тус тус баримтлан нэхэмжлэгч “Бакунатур” ХХК-ийн “Ашигт малтмалын газрын Кадастрын хэлтсийн дарга Н.Чинбаатрын 2016 оны 01 дүгээр сарын 29-ны өдрийн 6/757 дугаар “Бакунатур” ХХК-д ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан шийдвэрийг хүчингүй болгох, Говь-Алтай аймгийн Дэлгэр, Тайшир сумдын нутагт байрлах Тайшир нэртэй газарт 25729.22 гектор талбайд хайгуулын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хамгийн түрүүнд гаргаж бүртгүүлсэн этгээд нь “Бакунатур” ХХК болохыг тогтоолгож хүлээн зөвшөөрүүлэх, Ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын Кадастрын хэлтэст Бакунатур ХХК-ийн NE-025139 дугаар бүртгэлтэй өргөдлийн дагуу Ашигт малтмалын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3 дах хэсэгт заасан ажиллагааг дахин хийж, зохих журмын дагуу шийдвэрлэхийг даалгах, Ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын Кадастрын хэлтсийн дарга Н.Чинбаатарын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 1187 дугаар Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай Шийдвэрийн “Универсалнобле машинери” ХХК-д |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | холбогдох хэсгийг хүчингүй болгуулах, Ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын Кадастрын хэлтсийн дарга Н.Чинбаатарын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 33 дугаар “Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тухай” шийдвэрийн Ихмонголын орд ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгуулах” тухай ***<u>нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.</u>*** |
| 41 | Дугаар: 0003<br>Огноо: 2017-01-23<br>/Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх/<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/2462/view | “Монголт” ХХК | Дорноговь аймгийн Засаг дарга | • **Газар**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>Дорноговь аймгийн Засаг даргын 2016 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн А/354 дугаар захирамжийн холбогдох хэсгийг хүчингүй болгуулах<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.5, 4.2.6-д заасныг тус тус баримтлан “Монголт” ХХК-ийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, Дорноговь аймгийн Засаг даргын 2016 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн А/354 дүгээр захирамжийн холбогдох хэсэг /А/562, А/129 дугаар захирамжуудыг хүчингүй болгосон хэсэг/-ийг ***<u>хүчингүй болгож шийдвэрлэжээ.</u>*** |
| 42 | Дугаар: 18<br>Огноо: 2016-09-26<br>/Хэнтий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүх/<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/1811/view | Хэнтий аймгийн Ардчилсан нам | Хэнтий аймгийн Биндэр сумын Сонгуулийн хороо | • **Сонгууль**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>Сумын сонгуулийн хорооны 2016 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн №03 дугаар “Нэр дэвшигчийн нэрсийн жагсаалтаас хасах тухай” тогтоолыг хүчингүй болгож, Э.Мөнх-Очирыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд нэр дэвшигчээр бүртгэхийг даалгах<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Сонгуулийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.8, 115 дугаар зүйлийн 115.1, 154 дүгээр зүйлийн 154.4, 157 дугаар зүйлийн 157.2.7, 159 дүгээр зүйлийн 159.1-д заасныг тус тус баримтлан нэхэмжлэгчийн нэхэмжлэлийн шаардлагыг зарим хэсгийг хангаж, Биндэр сумын Сонгуулийн хорооны 2016 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн №03 дугаар “Нэр дэвшигчийн нэрсийн жагсаалтаас хасах тухай” тогтоолыг хүчингүй болгож, Э.Мөнх-Очирыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд нэр дэвшигчээр бүртгэхийг даалгахыг хүссэн ***<u>нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.</u>*** |

pdfelement

Remove Watermark Now

**Хавсралт 8**

1.ЗЕХ-ИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ
2.ТАНИЛЦУУЛГА
3. Салбарын эрдэмтдийн санал, нийтлэл

## 1.ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### НЭГ. ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

Захиргааны ерөнхий хуулийн төслийг боловсруулах дараах хууль зүйн болон практик шаардлага байна.Үүнд:

*I.Хууль зүйн үндэслэл, шаардлага:*

Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2-т “ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, 16 дугаар зүйлийн 16.12-т “Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй.”, 16.14-т “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шударга шүүхээр шүүлгэх эрхтэй.”, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж тус тус зохицуулсан байна.

Мөн Улсын Их Хурлын 2012 оны 37 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны Засгийн газрын үйл ажиллагаа”-ны хөтөлбөрийн “ЭРХ ЧӨЛӨӨТЭЙ МОНГОЛ ХҮН” 5 дугаар бүлэгт “Захиргааны үйл ажиллагааг нарийвчлан зохицуулсан хуулийг батлуулж, нийтийн захиргааг мэргэшүүлэх, хариуцлагажуулах механизмыг бий болгох”-оор тусгасан.

pdfelement

*II.Практик үндэслэл, шаардлага:*

Шинэ Үндсэн хууль батлагдсанаас хойших 20 гаруй жилийн хугацаанд захиргааны байгууллагын үйл ажиллагааг зохицуулсан, хууль биелүүлэн төрийн гүйцэтгэх эрх мэдлийн чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллагуудын үйл ажиллагааны журмыг нэгтгэсэн, тэдгээрийн хоорондын ажлын уялдааг зохицуулсан суурь хууль байхгүйгээс захиргааны үйл ажиллагаа өнөөг хүртэл цэгцрээгүй, хоорондоо нийцэхгүй, уялдаа холбоо муутай, дур зоргын шинжтэй явж иржээ.

Өнөөдөр манай улсад 420 гаруй хууль үйлчилж байгаагийн 250 орчим хуульд нь захиргааны байгууллага, албан тушаалтан өөрийн бүрэн эрхийн хүрээнд аливаа шийдвэр гаргах боломжийг зохицуулсан байна. Гэвч эдгээр хуулиудад бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэр гаргаж хэрэгжүүлэх үндсэн зарчим, нийтлэг журам, түүнийг биелүүлэх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон зохицуулалт байхгүйгээс гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд Үндсэн хуульд заасан төрөөс хүний эрх, эрх чөлөөний баталгааг хангах шаардлага тэр бүр биелэгдэхгүй, хууль хэрэгжүүлэх үйл ажиллагааны явцад хүний эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хөндсөн шийдвэрийг дур зоргоор гаргаж хохироох явдал цөөнгүй гарч байна.

Захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд төрийн эрх мэдэл хуваарилах зарчим, эрх зүйт төрийн зарчим, эрх зүйт хуулийн зарчим (rule of law), хууль дээдлэх зарчим, тэгш эрхийн зарчим, зөрчигдсөн эрхээ шударга шүүхээр хамгаалуулах зарчим яаж тусгалаа олох, ямар байдлаар хэрэгжих нэгдсэн ойлголт, зохицуулалт байхгүй байна. Энэ нь төрийн захиргааны байгууллага иргэдийн эрхийг хөндсөн аливаа шийдвэр гаргахын өмнө тэдний оролцоог хангадаг зохицуулалтыг зарчим байдлаар хуулиар зохицуулаагүйтэй холбоотой.

Захиргааны хэргийн шүүх үйл ажиллагаагаа эхлээд 9 жилийн хугацаанд төрийн захиргааны байгууллага, албан тушаалтны хууль, хүний эрхийг зөрчсөн цөөнгүй шийдвэрийг хүчингүй болгож, зөрчигдсөн эрхийг сэргээх, гэм буруутанд хариуцлага хүлээлгэх арга хэмжээг авч ирсэн нь төрийн байгууллага хууль дээдлэн ажиллах, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчвөл

Remove Watermark Now

тэдгээрийн шийдвэр хүчингүй болдог гэсэн итгэлийг иргэдэд төрүүлж чадсан байна. Энэ байдал нь Захиргааны ерөнхий хуулийг батлан гаргах эрх зүй, нийгмийн бодит үндэслэл, шаардлагыг нөхцөлдүүлж байна.

**ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ БҮТЭЦ, ЗОХИЦУУЛАХ ХАРИЛЦАА, ХАМРАХ ХҮРЭЭ**

1.Энэ хуулиар хууль биелүүлэн ажиллах захиргааны байгууллагын үйл ажиллагааны нийтлэг журмыг зохицуулна.

2.Хууль тогтоох болон шүүх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтны зүгээс хууль биелүүлэн захиргааны шийдвэр гаргаж байгаа тохиолдолд энэхүү хуулийн шаардлагыг нэгэн адил мөрдөх юм. Өөрөөр хэлбэл, энэхүү хуулийн зохицуулалт нь субьектээр хязгаарлагдахгүйгээр хууль биелүүлэн шийдвэр гаргахтай холбогдсон харилцааг зохицуулна.

3.Захиргааны байгууллагаас гаргадаг шийдвэрийг 3 үндсэн хэсэгт хуваасан зохицуулалтыг тусгана. Өдөр тутам гаргадаг нэг удаагийн тохиолдлыг зохицуулдаг захиргааны акт, олон удаа хэрэглэх, нийтэд чиглэгдсэн захиргааны хэм хэмжээний акт, захиргааны гэрээ гэсэн захиргааны үйл ажиллагааны хэлбэрүүдэд хуваана.

4.Улсын Их Хурал зөвхөн хуулиа тогтоох, Засгийн газар зөвхөн хууль биелүүлэх үүргийг хэрэгжүүлэх боломжийг бодит утгаар нь бүрдүүлнэ.

5.Захиргааны ерөнхий хуулийн үндсэн болон тусгай зарчмын дагуу үйл ажиллагаагаа явуулсан эсэхийг дээд шатных нь захиргааны байгууллага цаашлаад Захиргааны хэргийн шүүх хянадаг байх зохицуулалтыг тусгана.

6.Иргэн, хуулийн этгээд болон захиргааны байгууллагын хоорондын харилцааны нийтлэг асуудлыг зохицуулна.

7.Хүний эрх, эрх  чөлөө, эрх, хууль ёсны ашиг сонирхол ямар тохиолдолд зөрчигдсөн, дордсон, хязгаарлуулсан гэж үзэх, улмаар захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд Үндсэн хууль, олон улсын гэрээ, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг яаж хамгаалуулах талаар энэ хуулиар зохицуулагдана.

8.Захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд иргэдийн оролцоог хангах зохицуулалтыг тусгана. Захиргааны шийдвэр гаргахаас өмнө, гарсны дараах үе шатанд иргэд хэрхэн яаж оролцож болох нөхцөлийг заан, хүний эрх, эрх чөлөөг зөрчигдсөний дараа нь авч үзэх бус харин зөрчигдөхөөс өмнө урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

9.Захиргааны байгууллагын шийдвэрийг гүйцэтгэх, биелэлтийг хангах эрх зүйн үндэслэл, журмыг тодорхойлно.

10.Захиргааны байгууллагын хоорондын харилцааг зохицуулах, тэдгээрийн хооронд гарсан маргааныг шийдвэрлэх ерөнхий зохицуулалтыг тусгана.

**ГУРАВ. ХУУЛЬ БАТЛАГДСАНААР БИЙ БОЛОХ ҮР ДАГАВАР, ТҮҮНИЙ АЧ ХОЛБОГДОЛ**

Энэ хууль батлагдсанаар манай улсын эрх зүйн шинэтгэлийн томоохон алхам болно.

Хууль гарснаар Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2-т заасан “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим” гэсэн заалт бодит утгаараа хэрэгжихэд чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, захиргааны үйл ажиллагааг зохицуулсан суурь хуультай болсноор захиргааны үйл ажиллагаа нийтлэг  нэг зохицуулалтад орж, захиргааны хэргийн шүүх эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхэд баримтлах эрх зүйн үндэслэл буй болж, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд ерөнхий үйл ажиллагааг стандартчлан зохицуулах, хүний эрх, эрх чөлөө, эрх, хууль, ёсны ашиг сонирхол зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх боломжийг энэ хуулиар дамжуулан хэрэгжүүлнэ. Үүнд:

Системчлэх: Өнөөдөр Монгол улсад 420 гаруй хууль үйлчилж байгаагийн 250 гаруй хууль нь захиргааны эрх зүйнд хамаарч байна. Эдгээр хуулийн хоорондын зөрчилгүй, нэгдмэл байдлыг

Remove Watermark Now

хангах үүднээс энэ хууль суурь хууль нь болно. Цаашдаа энэ суурь хуулийн зохицуулалт дээр үндэслэн салбарын хуулийг боловсронгуй болгож хөгжүүлэх боломж бүрдэнэ.

Дутууг гүйцээх: 2002 онд батлагдсан Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд Захиргааны ерөнхий ангиас “Захиргааны акт”-тай холбоотой 11 зүйл байдаг. Энэ хууль батлагдсанаар 11 бүлэг, 106 зүйлтэй болж Захиргааны ерөнхий анги бүрэн хуульчлагдана.

Хоосон орон зайг нөхөх: Одоогоор захиргааны байгууллагаас иргэн, хуулийн этгээдтэй хэрхэн, яаж харьцахыг зохицуулсан захиргааны ерөнхий хууль байхгүйгээс зарим нэг хуулиар зохицуулсан зохицуулалтын хүрээнд л асуудлыг шийдвэрлэхийг оролдож байна. Гэтэл дээр дурдсан 250 орчим хуулийн ихэнх хуульд нь захиргааны байгууллагын эрх, үүргийг хуульчилсан байдаг ч тэрхүү эрх, үүргээ хэрхэн, яаж хэрэгжүүлэхийг зохицуулаагүй байдаг. Иймээс энэ хуулиар дээрхи хоосон орон зайг нөхөх болно.

Захиргааны үйл ажиллагаа хуулийн зохицуулалтад орж захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээд хуулийг хэрэглэхэд хялбар, дөхөм, ойлгомжтой болно.

Иргэн, хуулийн этгээдийн хувьд захиргааны байгууллагын эрх мэдлийн хүрээнд эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах бололцоо бүрдэнэ.

Захиргааны байгууллага шийдвэр гаргах явцад иргэдийн оролцох боломжийг бүрдүүлснээр хүнд суртал, авлигалыг багасгахад ач холбогдолтой.

Энэ хууль нь захиргааны байгууллагуудаас хууль хэрэгжүүлэх үйл ажиллагаанд чухал түлхэц болж, үр нөлөөг нь дээшлүүлэх юм.

**ДӨРӨВ. ХУУЛИЙН ТӨСӨЛ НЬ МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ БОЛОН БУСАД ХУУЛЬТАЙ ХЭРХЭН УЯЛДАХ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛГООР ЦААШИД ШИНЭЭР БОЛОВСРУУЛАХ БУЮУ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ХУУЛИЙН ТАЛААРХ САНАЛ**

Энэ хууль нь Үндсэн хуулийн төрөөс хүний эрх, эрх чөлөөний баталгааг бүрдүүлж хангахтай холбогдсон зүйл, заалтууд, агуулга, үзэл санаанд бүрэн нийцэх бөгөөд энэ хуультай уялдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль, Монгол улсын Засгийн газрын тухай хууль, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Мэдээллийн ил тод ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулна.

pdfelement

## 2.ТАНИЛЦУУЛГА

Захиргааны ерөнхий хуулийн төсөл

Монгол Улс эрх зүйн шинэтгэлийн хүрээнд өнгөрсөн 20 гаруй жилийн хугацаанд шинэ Үндсэн хуультай холбоотой хуулиудаа батлан гаргасан. Захиргааны чиглэлийн үйл ажиллагааг зохицуулсан 250 гаруй хууль өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байна. Өнөөдрийг хүртэл төрийн захиргааны үйл ажиллагааг зохицуулсан салбар хуулиудын хүрээнд нийтлэг асуудлуудыг нэгтгэн зохицуулсан суурь хуулийг батлан гаргаагүй байна. Иймээс дээрхи асуудлыг зохицуулах үүднээс захиргааны байгууллагын үйл ажиллагааны талаарх ерөнхий болон процессын нийтлэг харилцааг зохицуулсан хуулийн төслийг боловсруулан батлуулах нь тулгамдсан асуудал болоод байна.

Юуны түрүүнд, төр, эрх зүйн түүхэн хөгжлийн үүднээс харахад Монгол Улсад “захиргаа” нь эрт дээр үеэсээ өөр өөрийн нийгмийн байгууллаас шалтгаалаад харилцан адилгүйгээр оршин тогтнож ирсэн. Тухайлбал, феодалын нийгмийн үед уламжлалт төр байсан бөгөөд 1655 онд Халх

Remove Watermark Now

монголд 8 хошуу байсан бол 1725 онд 74, 1911 онд 123 хошуу болсон байдаг. Эдгээр засаг захиргааны нэгжид захиргааны үүргийг XIY-XIX зууны сүүл үеийг хүртэл монголын улс төрийн байгуулалд ноёдын чуулган гүйцэтгэж байсан бөгөөд нийгмийн амьдралын олон талт асуудлыг хэлэлцэн эцэст нь цааз баталж нийтээр дагаж мөрддөг байсан бол социалист нийгмийн үед үзэл суртлын гэх нэг намын систем төрийн захиргаанд хяналт тавин ажиллаж байжээ. Энэ үед социалист үзэл сурталжсан захиргааны эрх зүй үйлчилж байсан бөгөөд захиргааны үйл ажиллагааг нэг намын тогтолцоогоор удирдаж, хянадаг байснаас гадна төрийн эрх мэдлийг хуваарилах болон харилцан хяналт тавих тухай ойлголт байсангүй нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байв. Товчоор хэлбэл, захиргаа төрд үйлчилдэг байсан. Харин орчин үед захиргаа үзэл суртлаас ангижран хуулийн хяналт руу орж байна. Өөрөөр хэлбэл, төрийн захиргаанаас нийтийн захиргаа руу шилжиж байна. Феодалын болон социализмын үед ч төртэй, захиргаатай байсан бол орчин үед ч захиргаатай байна, харин агуулгын болон хэлбэрийн хувьд ялгаатай.

Монгол Улс орчин цагийн “захиргаа”-ны суурийг 1992 онд шинэ Үндсэн хуулиараа тавьсан бөгөөд хүний эрх, эрх чөлөө, тэгш байдлыг хүлээн зөвшөөрч, хууль дээдлэх зарчмыг тунхаглан өгснөөр олон намын тогтолцоонд шилжиж эрх зүйд үндэслэсэн нийтийн захиргааг бий болгох үе эхэлсэн бөгөөд төрийн эрх мэдлийг бодит утгаар хуваарилж, харилцан хяналт тавих тогтолцоог бүрдүүлж, эрх зүйт төрийн хуулийн хяналтыг бий болгох түүхэн үеийг эхлүүлсэн.

Манай улсад захиргааны үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулсан Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль хэрэгжиж эхлээд 11 жил, Захиргааны хэргийн шүүх үйл ажиллагаагаа явуулж эхлээд 9 жилийн хугацаа өнгөрөөд байна. Энэ хугацаанд төрийн байгууллага хууль дээдлэн ажиллах, иргэд, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчвөл тэдгээрийн гаргасан шийдвэр хүчингүй болдог гэсэн уур амьсгалыг энэ хуулийн хэрэгжилт, захиргааны хэргийн шүүхийн тусламжтайгаар бүрдүүлж чадсан. Өөрөөр хэлбэл шинээр боловсруулагдаж байгаа Захиргааны ерөнхий хуулийг хүлээн авах эрх зүйн орчин болон энэ хуулийг захиргааны байгууллага, иргэдийн зүгээс хүлээн авах нийгэм-сэтгэл зүйн үндэс суурь бүрдсэн гэж үзэж энэхүү хуулийн төслийг боловсрууллаа.

pdfelement

Хуулийн төсөл боловсруулахдаа ХБНГУ-ын “Захиргааны үйл ажиллагааны тухай хууль”, Испанийн “Төрийн захиргааны эрх зүйн байдал, Захиргааны нийтлэг үйл ажиллагааны тухай хууль”, Японы “Захиргааны үйл ажиллагааны тухай хууль”, Латвийн “Захиргааны үйл ажиллагааны тухай хууль”, Нидерландын “Захиргааны ерөнхий хууль” -ыг судалж харьцуулсан судалгааг хийсэн. Хууль зүй, дотоод хэргийн яам, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Дэлхийн банкны Захиргааны шийдвэрийг стандарчилах төслөөс 2009 онд гаргасан “Нийтээр дагаж мөрдөх шийдвэрийн зохицуулалт, түүнийг сайжруулах арга зам сэдэвт судалгааны тайлан”, 2009 онд “Хэм хэмжээ тогтоосон акт” Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам”, Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2011 онд гаргасан “Захиргааны үйл ажиллагааны тухай хуулийн төслийг боловсруулах судалгааны ажлын тайлан”, Эрх зүйн судалгааны төвөөс 2012 онд “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журмын хэрэгжилт, судалгааны тайлан”, Дэрхийн банкнаас 2012 онд “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрт дүн шинжилгээ хийсэн судалгааны ажил”, Удирдлагын академаас 2013 онд хийсэн “Төрийн ба орон нутгийн захиргааны байгууллагын захиргааны шийдвэр гаргаж буй үйл явцад хийсэн дүн шинжилгээ хийсэн судалгааны тайлан” зэрэг гарын авлага, зөвлөмж зэргийг тус тус судлан ашиглалаа.

Хуулийн төслийн эхний хувилбарыг бэлэн болгосноор Нийслэлийн захиргааны хэргийн шүүх, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх, Улсын Дээд Шүүхийн Захиргааны хэргийн танхимын нийт 20 шүүгч, 6 шүүгчийн туслах, яам, агентлагийн хуулийн хэлтсийн 26 ажилтан, мөн Хууль зүйн яам, Монголын Хуульч Эмэгтэйчүүдийн холбоотой хамтран 21 аймаг, нийслэл Улаанбаатар хот, түүний алслагдсан 3 дүүрэгт ажиллах нийт 80 гаруй чиглүүлэгчдэд Улаанбаатар хотоос онлайн сургалтыг зохион байгуулснаар, чиглүүлэгч нар нь орон нутагт хуулийн төслийн хэлэлцүүлгийг иргэд, иргэний нийгмийн байгууллагууд, нутгийн захиргааны болон өөрөө удирдах ёсны байгууллагын ажилтнуудын дунд зохион байгуулснаар нийтдээ 1750 гаруй хүн оролцон, 660

Remove Watermark Now

гаруй санал гаргасныг ажлын хэсэг хүлээн авч хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулсан болно.

Хууль зүйн яамнаас эрх зүйн шинэчлэлийн хүрээнд батлагдсан хуулиуд болон боловсруулж буй хуулийн төслийн талаар төв, зүүн, баруун бүсийн 14 аймгийн хууль сахиулах байгууллагуудын нийт 600 гаруй ажилтнуудад зориулсан сургалт, хэлэлцүүлгийг Орхон, Хэнтий, Ховд аймагт зохион байгуулахад Захиргааны ерөнхий хуулийн төслийг танилцуулж тэдний саналыг авах, түүнчлэн Аймаг, нийслэлийн хууль зүйн хэлтсийн дарга нар болон хуулийн хэлтсийн мэргэжилтнүүдэд 2 удаа сургалт семинар, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог хангах зорилгоор 10 төрийн бус байгууллага, бие даасан судлаачдын төлөөлөл оролцсон 18 хүнд 2 өдрийн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулах замаар тэдний санал, зөвлөмжийг авах, мөн түүнчлэн Иргэний танхимд хуулийн төслийн талаарх мэдээлэл хийх зэргээр ажилласан байна.

Мөн Монгол Улсын болон АНУ, ХБНГУ, Япон улсын захиргааны эрх зүйн чиглэлээр мэргэшсэн эрдэмтэн судлаач, гадны зөвлөхүүдийн санал, зөвлөмжийг авч хуулийн төсөлд тусгалаа.

Түүнчлэн хуулийн төсөлд санал авахаар яам, агентлаг, төрийн болон төрийн бус байгууллага зэрэг нийт 87 байгууллага, захирганы эрх зүйн чиглэлээр мэргэшсэн 10 эрдэмтэн судлаачид хүргүүлснээр, нийтдээ 53 байгууллагын давхардсан тоогоор 715 санал ирснийг судлан үзэж хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулсан болно.

Хуулийн төсөл 11 бүлэг, 106 зүйлтэй бөгөөд дараах зарчмын шинжтэй зохицуулалтыг тусгасан. Үүнд:

1.Энэ хуулийн төслөөр захиргааны байгууллагаас иргэдтэй харилцах суурь харилцааг нэгдсэн стандартад оруулахаар тусгалаа. Ингэснээр төр, иргэний хоорондын харилцаанд суурь зохицуулалт бий болж иргэдийн эрх, хууль ёсны эрх ашиг сонирхол хамгаалагдах боломж бүрдэнэ.

2.Үндсэн хуульд заасан хүний эрхийг дээдлэх, хуульд үндэслэх зэрэг ардчилалын зарчмууд нь ихэнхдээ төр, иргэний хоорондын харилцаанд зөрчигддөг. Энэ хууль гарснаар Үндсэн хуулийн зарчмууд бодит амьдрал дээр хэрэгжих боломжийг нээж өгөх юм.

3.Энэ хуулиар захиргаа, иргэдтэй харилцах харилцааг бүхэлд нь зохицуулахаар тусгалаа. Захиргааны байгууллагаас иргэдтэй харилцаж байгаа бүхий л харилцаа захиргааны акт, гэрээ хоёроор дамжин хэрэгжихээр хуульчилсан.

4.Захиргааны байгууллага гэсэн ойлголтыг хүчин төгөлдөр үйлчилж байгаа ЗХХШтХ-ийн 4.1-д заасан жагсаалтын системээс татгалзаж, энэ хуулийн үзэл баримтлалд заасны дагуу гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа бүхий л этгээдийг оруулахаар зохицуулсан.

5.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар хориглогдсон этгээд нь захиргааны байгууллагыг төлөөлж захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд оролцохгүй байхаар хуульчилж өгсөн.

6.Захиргааны байгууллагуудын хоорондын харилцааг хуульчилж өгсөн. Энэ зохицуулалт орсноор захиргаа иргэдэд ил тод, хөнгөн шуурхай үйлчлэх зохицуулалтыг бий болголоо.

7.Оролцогчийн эрхийг хуульчилж өгсөн. Өөрөөр хэлбэл захиргаа шийдвэрээ гаргахдаа тухайн шийдвэрт эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болох оролцогчийг сонсох, тэдний итгэлийг хамгаалах зарчмын хүрээнд тодорхой зохицуулалтыг хуульчилсан.

Remove Watermark Now

8.Оролцогч нь захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд оролцоход хууль зүйн болон бусад мэргэжлийн туслалцаа авах эрхийг хуульчилсан.

9.Захиргааны акт гэсэн бүлэгт захиргааны актын нэмэлт зохицуулалт гэсэн зохицуулалтыг оруулсан. Энэ нь захиргааны актын гол зохицуулалтаас гадна тухайн захиргааны байгууллага нэмэлт зохицуулалтыг тусгаж өгөх боломжийг энэ хуулиар хуульчилсан.

10.Сонгох боломжийг төслийн 41 дүгээр зүйлд хуульчилсан. Захиргааны байгууллага, албан тушаалтнаас тодорхой шийдвэр гаргахдаа хуулиар зөвшөөрөгдсөн хувилбаруудаас аль нэгийг ашиглах боломжууд байдаг. Тэгвэл тухайн албан тушаалтан энэхүү боломжоо ашиглахдаа хувийн ашиг сонирхлоор ашигласан бол түүнийг хэрхэн шийдэх зохицуулалтыг оруулж өглөө.

11.Захиргааны актыг оролцогчид мэдэгдэх, мэдэгдснээр эрх зүйн үр дагавар үүсэх зохицуулалтыг тусгалаа.

12.Захиргааны гэрээний талаарх эрх зүйн зохицуулалтыг анх удаа хуульчилан тусгав.

13.Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах ажиллагааг Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор зохицуулж байсныг энэ хуулиар нэгдмэл байдлаар зохицуулахаар төсөлд тусгав. Ингэснээр захиргааны байгууллагаас гаргаж байгаа захиргааны хэм хэмжээний актын боловсруулалт шинжилгээ судалгааны үндэстэй, системтэй болж, захиргааны байгууллагуудын хүнд суртлыг багасгаж, тэдгээрийн шийдвэр гаргах чадварыг дээшлүүлнэ. Захиргааны байгууллагаас иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, захиргааны байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод болгосноор төрийн зохицуулалтын үр нөлөөг дээшлүүлэх, иргэдээс захиргааны байгууллагын үйл ажиллагаанд итгэх, дэмжих хандлагыг нэмэгдүүлэхээр хуульчиллаа.

14.Захиргааны байгууллага төлөвлөлт хийхдээ тухайн орон нутагт оршин суугаа иргэдийн оролцоог хангасны үндсэн дээр шийдвэрээ гаргаж байх зохицуулалтыг тусгайлан бүлэг болгон төсөлд тусгав.

pdfelement

15.Нийтийн эрх зүйн харилцаанд захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрийг захиргааны актыг батлан гаргасан захиргааны байгууллага өөрөө хариуцан гүйцэтгэхээр, харин шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд 3 арга хэрэгслийн хүрээнд захиргааны шийдвэрийн гүйцэтгэлийг хангуулахаар тусгалаа.

16.Төслийн 9 дүгээр бүлэгт иргэн, хуулийн этгээд захиргааны байгууллагаас гаргасан шийдвэрт гомдол гаргах эрхийг зохицуулсан. Өөрөөр хэлбэл ЗХХШтХ-д байсан урьдчилан шийдвэрлэх ажиллагааг энэ хуульд оруулж ирсэн.

17.Захиргааны байгууллагаас иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн захиргааны акт гаргасан тохиолдолд тэдгээрт учруулсан хохирлыг барагдуулах, нөхөх олговрын зохицуулалтыг тусгасан.

18.Энэ хуулиар захиргааны байгууллага захиргааны шийдвэр гаргах ажиллагаа болон захиргааны шийдвэрт баримтлах нөхцөл журам, шалгуур үзүүлэлт, процедурыг зөрчсөн тохиолдолд тухайн албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг 11 дүгээр бүлэгт тодорхойлон тусгав.

Remove Watermark Now

## 3. Салбарын эрдэмтдийн санал, нийтлэл

**3.1.Доктор Д.Сүнжид:**

**37 дугаар зүйл.Захиргааны акт**

37.1.Захиргааны акт гэж захиргааны байгууллагаас зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас бусад тодорхой нэг тохиолдлыг зохицуулахаар нийтийн эрх зүйн хүрээнд гадагш чиглэсэн, эрх зүйн шууд үр дагавар бий болгосон амаар, бичгээр гаргасан захирамжилсан шийдвэр болон үйл ажиллагааг ойлгоно. */Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/*

Асуулт:

Захиргааны актын тодорхойлолтод Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас бусад гэж зохицуулсан нь захиргааны актын ойлголтын үндсэн агуулгад нөлөөлөхүү?

Шууд нөлөөлнө. "Захиргааны акт" хэмээх хууль зүйн бие даасан ойлголтын анхны ухагдахуун нь захиргааны байгууллагаас гаргасан байх, гадагш чиглэсэн байх, тодорхой тохиолдлыг зохицуулах, эрх зүйн үр дагавар үүсгэх, захирамжлахыг ойлгодог бөгөөд энэ хэвээр тогтвортой энэхүү институцыг хөгжүүлж ирсэн. Тиймээс одоо "зөрчлөөс шалган шийдвэрлэх ажиллагаанаас бусад" гэж нэмсэнээр захиргааны байгууллагаас гаргадаг дурьдсан шинж агуулсан захиргааны актыг хоёр хувааж байна. Эрх зүйн үр дагаврын хувьд захиргааны актын хууль ёсны байдлыг хянах, улмаар хүчингүй болгох харилцан адилгүй процедур бүхий хяналтын үе шат, шүүхийн харьяаллын зөрчлийг бий болгож байна. Энэ бүхний эцсийн үр дагаврыг иргэд, хуулийн этгээд үүрнэ, өөрөөр хэлбэл захиргааны байгууллагаар асуудлыг шийдвэрлүүлэх иргэн, хуулийн этгээдэд аль болох нэг журмаар /тэр нь хууль дээдлэх ёсыг чанд баримталсан, процедур ойлгомжтой нэгдмэл журамласан / байх нь чухал бөгөөд зөрчигдсөн тохиолдолд эрхийг хамгаалах, нөхөн сэргээхэд хүртэл иргэнд ээлгүй, хоёрдмол зохицуулалтыг үүсгэсэн.

**3.2.Доктор П.Одгэрэл ярилцлага, нийтлэл:**

pdfelement

***МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхмийн багш, доктор, профессор П.Одгэрэлтэй Зөрчлийн тухай хуулийн талаар цөөн хором хөөрөлдөв.***

**-УИХ-аар Зөрчлийн тухай хууль болон Зөрчлийг шалган шийдвэрлэх тухай хуулийн төслийг хэлэлцэж байна. Эдгээр хуулийн төслийн талаар таны бодлыг сонсох гэсэн юм?**

-Захиргааны эрх зүй судлаач хүний хувьд Зөрчлийн тухай хууль болон Зөрчлийг хянан шалгах тухай хуулийн төслийг үндсэн гол концепцынх хувьд хүлээн зөвшөөрөх боломжгүй байна. Учир нь салбарын хууль болон дүрэм журам зөрчсөн зөрчил нь 2016 онд батлагдсан зөрчлийн тухай хуулиар захиргааны эрх зүйгээс эрүүгийн эрх зүйд хамаарахаар хуульчилсан.

Захиргааны эрх зүйн үндсэн зарчим нь иргэдийг торгох шийтгэх биш иргэдэд зөвлөх үйлчлэх чиг үүргээр илэрхийлэгддэг. Тийм ч учраас мэргэжлийн хяналтын байцаагч нь хуульч биш эмч, эдийн засагч, газарзүйч гэх мэт тухайн салбарын мэргэжилтнүүд байдаг бөгөөд иргэд тухайн салбарын хууль, дүрэм журмыг зөрчсөн тохиолдолд эхлээд зөрчлийг арилгуулахаар хугацаатай үүрэг даалгавар бүхий албан шаардлага өгөөд түүнийг биелүүлэхгүй бол торгох шийтгэх асуудал яригддаг.

Харин эрүүгийн эрх зүйн үндсэн зарчим нь гэмт үйлдэл болгонд тохирсон ял шийтгэл ногдуулахад оршдог. Зөрчлийн тухай хуульд иргэдийн гаргасан зөрчил болгонд шийтгэл ногдуулахаар шууд хуульчлан зөрчлийг жижиг гэмт хэрэг хэмээн үзсэн. Энэхүү зарчмын шинжтэй өөрчлөлт нь маш олон үр дагаврыг араасаа дагуулна. Тухайлбал зөрчлийг эрүүгийн хэргийн шүүхээр шийдвэрлэхээр болж, хянан шийдвэрлэх ажиллагаа нь өөрчлөгдөж, иргэд нэхэмжлэгч

Remove Watermark Now

байснаа хариуцагч болох зэргээр эрс өөрчлөлтүүд гарч байна. Иймучраас л зөрчлийн хуулийг хүлээн зөвшөөрөх боломжгүй байгаа юм. Судлаачийн хувьд зөрчил болгонд шийтгэл ногдуулдаг ийм хуультай улс орныг мэдэхгүй юм байна.

**-Иргэд болон нийгэмд хэрэгтэй зайлшгүй шаардлагатай болоод л энэхүү өөрчлөлтийг хийсэн байж таарна аа даа?**

-Уг нь одоо байгаа хуулийн зохицуулалтыг л сайжруулах гэж л өөрчилж шинэчилдэг гэж би ойлгодог. Гэтэл эсрэгээрээ одоо байгаагаа дордуулсан хууль, хуулийн төсөл яваад байна. Бодит байдал дээрээ иргэдийн эрх зүйн байдлыг дордуулсан хууль болсон.

Одоо хүчин хүчин төгөлдөр үйлчилж буй хуулиар мэргэжлийн хяналтын байцаагч албан шаардлага тавьсан эсвэл торгосон тохиолдолд иргэд захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж хэрэв тэрээр хууль зөрчсөн тогтоогдвол уг актуудыг хүчингүй болгуулж эрх хамгаалдаг бол зөрчлийн хууль хүчин төгөлдөр болсноор эрүүгийн шүүхээр иргэдийн зөрчил бүхий үйлдлийн бодит байдлыг тогтоох ажиллагаа явуулах учир иргэд гэмт этгээд буюу хариуцагч болох бөгөөд мэргэжлийн хяналтын байцаагч, прокурор, шүүгч бүгд иргэдийг яллах талд эсрэг ажиллана.

Дээр нь нэмж хэлэхэд мэргэжлийн хяналтын байцаагчийн ажиллагаанд эрүүгийн шүүх хяналт тавихгүй учир шүүхийн хяналтын гадна хоцорно. Хуулийн төслөөр прокурор иргэдийн гомдол мэдээллээр зөрчлийн хэрэг үүсгэх, хянан шалгах, шүүх хуралд яллагчаар оролцох зэргээр хуульчилсан байна. Мэргэжлийн хяналтын байцаагч дээр прокурор нэмэгдэхээр бизнессийн орчинд дарамт ихэснэ гэсэн үг. **Төрийн хяналт нэмэгдэнэ гэдэг чинь шууд утгаараа авлигын орчин шинээр нэмэгдэнэ гэсэн үг. Яагаад ийм өөрчлөлт хэрэгтэй болсныг үнэндээ сайн ойлгохгүй байна.**

-Иргэдийг 230 гаруй хуулиар торгож шийтгэдэг байсан бол одоо ганцхан хуулиар торгож шийтгэдэг болсон гээд дэвшилттэй зүйлүүд хийгдсэн гээд ярьж байна?

-Захиргааны эрх зүй судлаачийн хувьд үүнийг одоогийн хүрсэн хуулийн хөгжлийн төвшнөөс ухралт хийсэн болхиоролдлого хэмээн үзэж байна. Зөрчлийн хуулийг анх санаачлагч нь иргэдийг олон хуулиар биш нэг хуулиар шийтгэх өөрөөр хэлбэл "ял, шийтгэлийг нэг цонх"-оор харах үндсэн концепцээр зөрчлийн хуулийн төслийг боловсруулсан хэмээн мэдэгдэж байгаа юм.

Энэ нь шууд утгаараа шинээр эрүүгийн хууль дахиад бий болгосон гэсэн үг. Иргэд, бизнесс эрхлэгчдийг гэмт этгээд гэж үзээд яллах, шийтгэх байр суурьнаас хууль боловсруулсан байна шүү дээ. Нөгөө талаас салбарын 230 гаруй хуулийн төгсгөлд байдаг хариуцлагын хэсгийг механикаар таслан нэгтгэж нэг хууль болгосон. Зөвхөн зөрчлийн хуульд л шийтгэл байх бөгөөд бусад хууль, хэм хэмжээний актад торгосон шийтгэсэн заалт байх ёсгүй хэмээн хаа ч байхгүй шинэ онол гаргаж нэвтрүүлэлт хийсэн байгаа юм. Санкцгүй шийтгэлгүй хууль бол шүдгүй арслан гэсэн үг.

Хууль салбарынхаа онцлогийг агуулж, цогц байдлаар системчлэгдэж байж зохицуулах чадавхи нь нэмэгддэг. Сүүлийн 20 гаруй жилд бүтээсэн хуулийн тогтолцоогоо ингэж эвдэж самарч болохгүй л дээ.

**-Гудамжинд шүлсээ хаядаг, хүнийг гүтгэдэг, танхайрдаг этгээдүүдийг чангахан шийтгэж хашраахаар хуульчилж байгаа нь зөв санагддаг?**

-Хуулийн төсөл дээр ажиллаж байгаа нөхдүүд наад жишээг чинь байнга ярьдаг. Гудамжинд шүлсээ хаяж, танхайрч зөрчил гаргаж байгаа этгээд болон бизнесс эрхлэж хууль, дүрэм журам стандарт зөрчиж байгаа хоёр хоорондоо маш ялгаатай. Барилга барих, үйлчилгээ эрхлэх зэргээр

Remove Watermark Now

бизнесс хийхэд гарч буй зөрчлүүд нь зөвхөн тухайн бизнесс эрхлэгчээс биш маш олон хүчин зүйлээс хамаардаг.

Энэхүү зөрчлийг арилгахын тулд төр иргэдийг торгох, шийтгэх биш харин эсрэгээрээ ажлын байрыг нь хамгаалж дэмжиж хамтарч ажиллах ёстой. Энэ бол хаа ч хүлээн зөвшөөрөгдсөн төр болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааны суурь зарчим юм.Мөн зөрчил гаргаж байгаа этгээдүүдийг шийтгэж хашраахгүй бол энэ нь даамжраад гэмт хэрэг гарах шалтгаан болдог, ял завшдаг гэсэн үндэслэлүүд яригддаг.

Нийгмийн хэв журмын зөрчил гаргагчийг бизнесс эрхлэгчидтэй холиод, зөрчлийн хууль бүхлээрээ, өөрөөр хэлбэл таслаж нэгтгэсэн 230 гаруй хууль чинь бүгд аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой салбарын хууль шүү дээ. Бизнесс эрхлэгчид, татвар төлөгчдийг гэмт хэрэгтэн гэсэн нэг цонхоор харж хууль хийж болохгүй.

**-Ер нь энэ хуульд иргэд, нийгэмд хэрэгтэй өөрчлөлт шинэчлэлт байгаа юм уу, эрх биш байгаа байлгүй дээ?**

-Зөрчлийн хууль болон холбогдох хуулийн төслүүдийг гол хэрэглэгч болох мэргэжлийн хяналтын байцаагч нар дэмжээгүй, шүүхээс бас дэмжээгүй, хуульчдын холбоо дэмжээгүй, иргэд, бизнесс эрхлэгчид дэмжихгүй эсрэг шүүмжлээд байхад л зүтгүүлээд баталчихсан, одоо сайжруулна гээд яваад байгааг ойлгохгүй байна.

Суурь зарчим нь буруу бол засаж сайжруулна гэсэн ойлголт байхгүй улам л хүндрэх болно. Иргэдэд хэрэггүй бол энэ хууль хэнд хэрэгтэй юм бэ? Үнэхээр сонин асуулт байна.

**-Зөрчлийн хууль нэгэнт батлагдчихсан одоо хэрэгжүүлэх л ажил үлдсэн шүү дээ?**

-Харамсалтай нь Зөрчлийн хууль батлагдчихсан. Судлаачийн хувьд анх зөрчлийн хуулийн төслийн ажлын хэсэгт ажиллах санал тавьхад зарчмын хувьд болохгүй гээд татгалзсан, яг батлагдахын өмнө тухайн үеийн хууль зүйн сайд, хууль зүйн байнгын хорооны дарга болон ажлын хэсгийнхэнтэй уулзаж тайлбарлаад бараагүй.

Эрх зүйн шинэчлэл гэсэн лоозонгийн доор шуураад өнгөрсөн. Энэ хуулийг хэрэгжүүлэхэд маш их бэрхшээл хүндрэл гарах байх. Зөрчил болгонд шийтгэл ногдуулах, бүх торгууль шийтгэлийг таслаад нэгтгэчихсэн гээд хаа ч туршигдаж байгаагүй цоо шинэ зохицуулалтууд нь хууль хэрэглээний шинэ арга барил, онол, сургалт зайлшгүй шаардах бөгөөд олон асуудлыг араасаа дагуулна.

**-Судлаачийн хувьд зөрчлийн хуулийг бүхэлд нь үгүйсгэчихлээ. Одоо цаашид юу хийх хэрэгтэй бэ?**

-Болдогсон бол Зөрчлийн хуулийг хүчингүй болгочихмоор байна. Судлаачийн хувьд одоо байгаа захиргааны хариуцлагын тухай хуульдаа зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааны зохицуулалтыг л нарийвчлаад нэмээд хийгээд өгөхөд хангалттай санагддаг. Миний хувьд хамгийн гол харамсаад байгаа зүйл бол захиргааны эрх зүйн 230 гаруй хуулийг эвдээд хаячихлаа. Байгаль орчны салбар гэхэд л 40 гаруй хуультай, татвар гэхэд л 20 гаруй хууль олон арван хэм хэмжээний актаас бүрддэг.

Уг нь салбарын хуулиуд маань гайгүй системчлэгдээд зөв гольдорлоор хөгжиж байсан. Торгууль шийтгэл хариуцлага нь тухайн салбарын хуулиудад тусгагдаж зүйл заалттай нь нарийн уялдаа холбоотой байж амьд хуулийн тогтолцоо бий болох учиртай.

Зөрчлийн хуулийг хэрэгжүүлэх гээд цаг хугацаа алдана, болохгүй бол буцаагаад одоогийн нөхцөл байдлыг сэргээхэд амаргүй байх болно. Эцэст нь хэлэхэд энэ бүгд бол зөвхөн Одгэрэл

Remove Watermark Now

гэдэг судлаачийн үзэл бодол юм даа.Баахан гутранги санаа зовсон зүйл ярьчлаа. Цаг хугацаа бүгдийг харуулах байх бүх зүйл эерэг сайнаар бүтэх болтугай гээд залбарья даа.

**Эх сурвалж: "ХУУЛЬЧ NEWS" сэтгүүл**

УИХ-ын нэгдсэн чуулганаар Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэж байгаа.

Уг хуулийн төслийн талаар **МУИС-ын хууль зүйн сургуулийн нийтийн эрх зүйн тэнхмийн багш, хууль зүйн ухааны доктор П.Одгэрэлтэй ярилцлаа.**

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ХЭРЭГТЭЙ**

**-Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг чуулганаар хэлэлцэж байна. Захиргааны эрх зүй судлаач хүний хувьд ямар бодолтой байна вэ?**

-Зөрчлийн тухай хууль болон Зөрчлийг хянан шалгах тухай хуулийн төслийг үндсэн гол концепцийнх нь хувьд хүлээн зөвшөөрөх боломжгүй байгаа юм.

Яагаад гэхээр зөрчлийг эрүүгийн хэргийн шүүхээр шийдвэрлэхээр болж, хянан шийдвэрлэх ажиллагаа нь өөрчлөгдөж, иргэд нэхэмжлэгч байснаа хариуцагч болох зэргээр эрс өөрчлөлтүүд гарч байна.

Захиргааны эрх зүйн үндсэн зарчим нь иргэдийг торгох шийтгэх биш иргэдэд зөвлөх үйлчлэх чиг үүргээр илэрхийлэгддэг.

Иргэд тухайн салбарын хууль, дүрэм журмыг зөрсөн тохиолдолд эхлээд зөрчлийг арилгуулахаар хугацаатай үүрэг даалгавар бүхий албан шаардлага өгөөд түүнийг биелүүлэхгүй бол торгох шийтгэх асуудал яригддаг.

Харин эрүүгийн эрх зүйн үндсэн зарчим нь гэмт үйлдэл болгонд тохирсон ял шийтгэл ногдуулахад оршдог.

pdfelement

Энэхүү зарчмын шинжтэй өөрчлөлт нь маш олон үр дагаврыг араасаа дагуулна.

Ийм учраас л зөрчлийн хуулийг хүлээн зөвшөөрөх боломжгүй байгаа юм. Миний хувьд зөрчил болгонд шийтгэл ногдуулдаг ийм хуультай улс орныг мэдэхгүй юм байна.

**- Иргэд болон нийгэмд хэрэгтэй зайлшгүй шаардлагатай өөрчлөлтууд энэ хуулийн төсөлд бий юу?**

-Уг нь одоо байгаа хуулийн зохицуулалтыг сайжруулах гэж л өөрчилж шинэчилдэг гэж би ойлгодог. Гэтэл эсрэгээрээ одоо байгаагаа дордуулсан хууль, хуулийн төсөл яваад байна.

Бодит байдал дээрээ иргэдийн эрх зүйн байдлыг дордуулсан хууль болсон.

Зөрчлийн хууль хүчин төгөлдөр болсноор хууль эрх зүйн хүрээнд дараах дутагдлууд бий болно

1. Зөрчлийг захиргааны эрх зүйгээс эрүүгийн эрх зүйд хамаарахаар хуульчилсан,
2. Эрүүгийн шүүхээр иргэдийн зөрчил бүхий үйлдлийн бодит байдлыг тогтоох ажиллагаа явуулах учир иргэд гэмт этгээд буюу хариуцагч болох,
3. Мэргэжлийн хяналтын байцаагч, прокурор, шүүгч бүгд иргэдийг яллах талд эсрэг ажиллах,
4. Мөн мэргэжлийн хяналтын байцаагчийн ажиллагаанд эрүүгийн шүүх хяналт тавихгүй учир шүүхийн хяналтын гадна хоцрох,
5. Хуулийн төслөөр прокурор иргэдийн гомдол мэдээллээр зөрчлийн хэрэг үүсгэх,

Remove Watermark Now

6. Хянан шалгах, шүүх хуралд яллагчаар оролцох зэргээр хуульчилсан нь зөрчлийн хууль өөрөө зөрчилтэй хууль болсныг харуулж байна.

Өөрөөр хэлбэл зөрчлийн тухай хуульд иргэдийн гаргасан зөрчил болгонд шийтгэл ногдуулахаар шууд хуульчлан зөрчлийг жижиг гэмт хэрэг хэмээн үзсэн.

Мэргэжлийн хяналтын байцаагч дээр прокурор нэмэгдэхээр бизнесийн орчинд дарамт ихэснэ гэсэн үг.

Төрийн хяналт нэмэгдэнэ гэдэг чинь шууд утгаараа авлигалын орчин шинээр нэмэгдэнэ гэсэн үг. Яагаад ийм өөрчлөлт хэрэгтэй болсныг үнэндээ сайн ойлгохгүй юм.

**САНКЦГҮЙ ШИЙТГЭЛГҮЙ ХУУЛЬ БОЛ ШҮДГҮЙ АРСЛАН ГЭСЭН ҮГ**

**-Иргэдийг 230 гаруй хуулиар торгож шийтгэдэг байсан бол одоо ганцхан хуулиар торгож шийтгэдэг болсон гээд дэвшилттэй зүйлүүд хийгдсэн гэж яригдах юм?**

-Захиргааны эрх зүй судлаачийн хувьд үүнийг одоогийн хүрсэн хуулийн хөгжлийн төвшнөөс ухралт хийсэн болхи оролдлого хэмээн үзэж байна.

Зөрчлийн хуулийг анх санаачлагч нь иргэдийг олон хуулиар биш нэг хуулиар шийтгэх өөрөөр хэлбэл “ял, шийтгэлийг нэг цонх”-оор харах үндсэн концепцээр зөрчлийн хуулийн төслийг боловсруулсан хэмээн мэдэгдэж байгаа юм.

Энэ нь шууд утгаараа шинээр эрүүгийн хууль дахиад бий болгосон гэсэн үг. Иргэд, бизнес эрхлэгчдийг гэмт этгээд гэж үзээд яллах, шийтгэх байр суурьнаас хууль боловсруулсан байна шүү дээ.

Нөгөө талаас салбарын 230 гаруй хуулийн төгсгөлд байдаг хариуцлагын хэсгийг механикаар таслан нэгтгэж нэг хууль болгосон.

Зөвхөн зөрчлийн хуульд л шийтгэл байх бөгөөд бусад хууль, хэм хэмжээний актад торгосон шийтгэсэн заалт байх ёсгүй хэмээн хаа ч байхгүй шинэ онол гаргаж нээлт хийсэн байгаа юм.

pdfelement

Санкцгүй шийтгэлгүй хууль бол шүдгүй арслан гэсэн үг.

Хууль салбарынхаа онцлогийг агуулж, цогц байдлаар системчлэгдэж байж зохицуулах чадавхи нь нэмэгддэг. Сүүлийн 20 гаруй жилд бүтээсэн хуулийн тогтолцоогоо ингэж эвдэж самарч болохгүй л дээ.

**- Гудамжинд шүлсээ хаядаг, хүнийг гүтгэдэг, танхайрдаг этгээдүүдийг чангахан шийтгэж хашраахаар хуульчилж байгаа нь зөв санагддаг?**

- Хуулийн төсөл дээр ажиллаж байгаа нөхдүүд наад жишээг чинь байнга ярьдаг.

Гудамжинд шүлсээ хаяж, танхайрч зөрчил гаргаж байгаа этгээд болон бизнес эрхлэж хууль, дүрэм журам стандарт зөрчиж байгаа хоёр хоорондоо маш ялгаатай.

Барилга барих, үйлчилгээ эрхлэх зэргээр бизнес хийхэд гарч буй зөрчлүүд нь зөвхөн тухайн бизнес эрхлэгчээс биш олон хүчин зүйлээс хамаардаг.

Энэхүү зөрчлийг арилгахын тулд төр иргэдийг торгох, шийтгэх биш харин эсрэгээрээ ажлын байрыг нь хамгаалж дэмжиж хамтарч ажиллах ёстой.

Энэ бол хаа ч хүлээн зөвшөөрөгдсөн төр болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааны суурь зарчим юм.

Мөн зөрчил гаргаж байгаа этгээдүүдийг шийтгэж хашраахгүй бол энэ нь даамжраад гэмт хэрэг гарах шалтгаан болдог, ял завшдаг гэсэн үндэслэлүүд яригддаг.

Remove Watermark Now

Нийгмийн хэв журмын зөрчил гаргагчийг бизнес эрхлэгчидтэй холиод, зөрчлийн хууль бүхлээрээ, өөрөөр хэлбэл таслаж нэгтгэсэн 230 гаруй хууль чинь бүгд аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой салбарын хууль шүү дээ.

**БИЗНЕС ЭРХЛЭГЧИД, ТАТВАР ТӨЛӨГЧДИЙГ ГЭМТ ХЭРЭГТЭН ГЭСЭН НЭГ ЦОНХООР ХАРЖ ХУУЛЬ ХИЙЖ БОЛОХГҮЙ**

**- Ер нь энэ хуулинд иргэд, нийгэмд хэрэгтэй өөрчлөлт шинэчлэлт байгаа юм уу, эрх биш байгаа байлгүй дээ?**

-Зөрчлийн хууль болон холбогдох хуулийн төслүүдийг гол хэрэглэгч болох мэргэжлийн хяналтын байцаагч нар дэмжээгүй, шүүхээс бас дэмжээгүй, хуульчдын холбоо дэмжээгүй, иргэд, бизнес эрхлэгчид дэмжихгүй эсрэг шүүмжлээд байхад л зүтгүүлээд баталчихсан.

Одоо сайжруулна гээд яваад байгааг ойлгохгүй байна.

***Бизнес эрхлэгчид, татвар төлөгчдийг гэмт хэрэгтэн гэсэн нэг цонхоор харж хууль хийж болохгүй***

Суурь зарчим нь буруу бол засаж сайжруулна гэсэн ойлголт байхгүй улам л хүндрэх болно.

Иргэдэд хэрэггүй бол энэ хууль хэнд хэрэгтэй юм бэ? Үнэхээр сонин асуулт байна.

**-Судлаачийн хувьд зөрчлийн хуулийг бүхэлд нь үгүйсгэчихлээ. Одоо цаашид юу хийх хэрэгтэй юм бэ?**

- Болдогсон бол зөрчлийн хуулийг хүчингүй болгочихмоор байна.

Одоо байгаа захиргааны хариуцлагын тухай хуульдаа зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааны зохицуулалтыг л нарийвчлаад нэмээд хийгээд өгөхөд хангалттай санагддаг.

Миний хувьд хамгийн гол харамсаад байгаа зүйл бол захиргааны эрх зүйн 230 гаруй хуулийг эвдээд хаячихлаа.

Байгаль орчны салбар гэхэд л 40 гаруй хуультай, татвар гэхэд л 20 гаруй хууль олон арван хэм хэмжээний актаас бүрддэг. Уг нь салбарын хуулиуд маань гайгүй системчлэгдээд зөв гольдорлоор хөгжиж байсан. Торгууль шийтгэл хариуцлага нь тухайн салбарын хуулиудад тусгагдаж зүйл заалттай нь нарийн уялдаа холбоотой байж амьд хуулийн тогтолцоо бий болох учиртай.

Зөрчлийн хуулийг хэрэгжүүлэх гээд цаг хугацаа алдана, болохгүй бол буцаагаад одоогийн нөхцөл байдлыг сэргээхэд амаргүй байх болно.

Эцэст нь хэлэхэд энэ бүгд бол зөвхөн Одгэрэл гэдэг судлаачийн үзэл бодол юм даа. Баахан гутранги санаа зовсон зүйл ярьчлаа.

Цаг хугацаа бүгдийг харуулах байх бүх зүйл эерэг сайнаар бүтэх болтугай гээд залбаръя даа.

**Ярилцсанд баярлалаа.**

**Зөрчлийн тухай хуулиар мэдээлэл хийлээ**

"Хүний эрхийн тухай ярилцъя" өглөөний уулзалтын энэ сарын зочноор Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш, Хууль зүйн ухааны доктор, дэд профессор П.Одгэрэл оролцож, "Зөрчлийн тухай хуулийг хүлээн зөвшөөрөхгүй байх үндэслэл" сэдвээр мэдээлэл хийлээ.

Уулзалтад иргэний нийгмийн болон хэвлэл мэдээллийн байгууллага, иргэдийн төлөөлөл 35 хүн оролцлоо.

pdfelement

Remove Watermark Now

Судлаачийн зүгээс Зөрчлийн тухай хууль нь концепцийн хувьд захиргааны зөрчлийг эрүүгийн эрх зүйн салбарт харьяалагдахаар өөрчилсөн, Үндсэн хуультай зөрчилдсөн, салбарын хуулиудын бүтцийг эвдсэн, хэрэгжүүлэхэд туйлын хүндрэлтэй нөхцөл байдлыг бий болгож байгаа талаар өөрийн үзэл бодол, дүгнэлтээ танилцуулсан юм. Тухайлбал Зөрчлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 1.3.2 дахь хэсэгт "энэ хуульд заасан зөрчил тус бүрд шийтгэл оногдуулна" хэмээн заасан нь иргэд, бизнес эрхлэгчдийг яллах бодлого давамгайлсан, үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх явцад санамсаргүй гаргасан алдаа, зөрчил бүрд ял шийтгэл оногдуулахаар хуульчилсан байгаатай санал нийлэхгүй байгаагаа өөрийн хийсэн судалгаа, дүн шинжилгээнд тулгуурлан тайлбарлав.

Мөн бизнесийн салбарынхан, баялаг бүтээгчдэд алдаагаа засах боломж олгохгүйгээр шууд яллaverages, шийтгэдэг жишиг дэлхийн аль ч улсад байдаггүй талаар дурдаж, Зөрчлийн хуулийн шинэчилсэн найруулга Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн зөрчилдөж байгаа талаар онол болон жишээ баримтат тулгуурласан сонирхолтой мэдээлэл хийлээ.

Түүнчлэн Зөрчлийн тухай хуулийг батлагдахаас өмнө уг хуулийг хэрэгжүүлэх субъектүүд болох салбар бүрийн улсын байцаагч, хууль хяналтын байгууллагын ажилтнууд, иргэд олон нийт, судлаач эрдэмтэд, мэргэжлийн холбоодоор хэлэлцүүлэхэд дэмжлэг аваагүй бөгөөд сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд олсон туршлага, бэхэжсэн хуулийн тогтолцоог эвдэх сөрөг үр дагавартай гэсэн дүгнэлт гарч байсныг дурдахын зэрэгцээ уулзалтад оролцогчдын сонирхсон асуултад хариуллаа.

УИС-ийн Хууль зүйн сургууль нь “МУИС ХУУЛЬ ЗҮЙН БОДЛОГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ” хэмээх мэргэжлийн форум үүсгэж буй билээ. Энэхүү форум нь хууль зүйн салбарт талгамдаж буй асуудлаар цуврал хэлбэрээр хэлэлцүүлгүүдийг хийх бөгөөд асуудлыг олон ургалч үзлийн үүднээс хөндөн ярилцах, судлаачдын байр суурийг нийгэмд хүргэх зорилгтой. Энэ хэлэлцүүлгийн анхны цурал нь энэ хаврын чуулганаар хэлэлцэгдэх гэж буй “Зөрчлийн хуулийн төслийн” хүрээнд хийгдэх гэж байна. Хэлэлцүүлэгт тус хуулийн төслийг санаачлагч, төсөл боловсруулсан багийн гишүүд болон хуулийн төсөлтэй эсрэг байр суурьтай буй эрдэмтдийн оролцуулан Монголын хуульчдын холбооны Захиргааны эрх зүй хороотой хамтран зохион байгуулна.

СЭДЭВ: ЗӨРЧЛИЙН ХУУЛИЙН ТӨСӨЛ: ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ТОГТООМЖ УУ? ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ХУУЛЬ ТОГТООМЖ УУ?

pdfelement

Remove Watermark Now

**Хавсралт 9**

**ХУУЛЬЧ, ШҮҮГЧДИЙН ДУНД ХИЙСЭН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН ИЛТГЭЛ, ТЭМДЭГЛЭЛ:**

## ТАТВАРЫН АЛБАНААС ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БАЙДАЛ, ТУЛГАРЧ БУЙ БЭРХШЭЭЛ

**Ноорог**

### Оршил

Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш багагүй хугацаа өнгөрч байна. Энэ хугацаанд татварын албанаас зөрчлийн хуулийн сургалтыг албаны хэмжээнд зохион байгуулж, хуулийн хэрэгжилтэнд хяналт тавих, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлж ирлээ.

Зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Татварын ерөнхий газраас Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн зарим зүйл заалтыг хэрхэн ойлгож хэрэгжүүлэх талаар Улсын дээд шүүхэд хандан 4 асуудлаар тайлбар, зөвлөмж, тодруулга хүссэн. Улсын дээд шүүхээс хуулийн зүйл, заалтыг тайлбарлаж, зөвлөмж гаргах үндэсгүй, харин тодруулга өгөх нь зүйтэй гэдгээр албан бичгээр хариу өгсөн.

Уг тодруулгад: Татварын ерөнхий хуулийн 72 дугаар зүйлийн 72.1-д татварын алба болон татварын улсын байцаагчийн зөрчил шалган шийдвэрлэхээс бусад асуудлаар татвар төлөгч захиргааны журмаар гомдол гаргах эрхтэй болохыг зааж зохицуулсан байна” гэжээ.

Татварын ерөнхий хуулийн 72 дугаар зүйлийн 72.1-д заасан болон Улсын дээд шүүхийн тодруулгад дурдсанаар татвар төлөгч татварын улсын байцаагчийн шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо захиргааны журмаар гаргах эрхгүй болсон гэж ойлгохоор байна. Татварын маргаан таслах зөвлөл татварын улсын байцаагчийн акт, дүгнэлтийг зөвхөн татвар төлөгчийн гомдлоор хянан хэлэлцэх зохицуулалт Татварын ерөнхий хуульд хэвээр байгаа боловч хуулийн 72 дугаар зүйлтэй зөрчилдөж байна. Практикт зөрчил шалган шийдвэрлэхээс бусад асуудлаар захиргааны журмаар хандах нь харьцангуй цөөн байдаг. Харин зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа буюу татварын хяналт шалгалтын үр дүнд татварын улсын байцаагчийн үйлдсэн баримт бичгийг эс зөвшөөрч урьдчилан шийдвэрлэх журмаар хандах нь олонтаа гардаг. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.2 дугаар зүйлийн 1-д “Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах шийдвэр нь шийтгэлийн хуудас хэлбэртэй байна” гэж заасан. Гэтэл Татварын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлд татварын улсын байцаагчийн үйлдэх баримт бичигт илтгэх хуудас, акт, дүгнэлт бичихээр байгаа нь хоорондоо зөрчилдөж татвар төлөгчийн зүгээс шийтгэлийн хуудсыг эс зөвшөөрч маргаан таслах зөвлөлд хандахад түүнийг Татварын ерөнхий хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 72 дугаар зүйлийн 72.1-д заасан үндэслэлээр хүлээж авахаас татгалзах үндэслэл бүрдэж байна. Хуулийн дээрх зохицуулалтыг Татварын ерөнхий газрын дэргэдэх болон Нийслэлийн татварын газрын дэргэдэх маргаан таслах зөвлөл харилцан адилгүй байдлаар хэрэгжүүлж байна. Тухайлбал, татвар төлөгч эрх бүхий албан тушаалтны шийтгэлийн хуудсыг эс зөвшөөрч Нийслэлийн татварын газрын дэргэдэх маргаан таслах зөвлөлд гомдол гаргасан боловч уг зөвлөл гомдлыг хүлээн авахаас татгалзсан, ТЕГ-ын дэргэдэх МТЗ гомдлыг хүлээн авч хянаж байна. Харин Захиргааны хэргийн шүүх Нийслэлийн татварын газрын дэргэдэх маргаан таслах зөвлөл хүлээн авахаас татгалзсан гомдолд захиргааны хэрэг үүсгэжээ.

Хуулийн зөрчилдөөн ойлгомжгүй байдлаас үүдэн маргаан таслах зөвлөл шийтгэлийн хуудсыг хянан хэлэлцэх нь тодорхой бус байгаа нь татварын алба, татвар төлөгчийн хооронд ойлгомжгүй байдал үүсгэж байна.

### Прокурорын хяналт

Зөрчил шалган шийдвэрлэх тухай 2.2 дугаар зүйлийн 1-т “Прокурор зөрчлийн хэрэг бүртгэлтэд хяналт тавих ... бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, Прокурорын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “зөрчлийн хэрэг бүртгэлтэд хяналт тавих проркурорын бүрэн эрхийн тухай” заажээ. Мөн Улсын Ерөнхий прокурорын 2018 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтын аргачилсан заавар”, Эрх бүхий албан тушаалтнуудаас үйлдэх эрх зүйн хэлбэрийн загвар”-ын хүрээнд прокурорын хяналтан дор эрх бүхий албан тушаалтан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлж байна.

Прокурорын байгуулага хууль хэрэгжиж эхэлснээс хойш татварын албаны зарим хэлтэст Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн байдалд шалгалт

хийж хуулийн заалтыг нэг мөр хэрэгжүүлж ажиллаагүй татварын улсын байцаагч нарт хариуцлага тооцуулахаар прокурорын шаардлага ирүүлсэн.

Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал гэдэгт гомдол мэдээллийн шийдвэрлэлтийг бүртгүүлээгүй, хугацаа хоцроосон, түүнчлэн гомдол, мэдээллийг бүртгэлд авсан дардас байхгүй, хүлээн авсан огноо бичихгүй, нотлох баримтыг хуульд заасан журмаар цуглуулж бэхжүүлээгүй зэргийг дурдсан байна.

Татварын алба хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих чиг үүргийн хүрээнд шийтгэхийг урьтал болгохгүй, хууль тогтоомжийг сурталчлан таниулах, тэдэнд итгэл үзүүлэн ажиллах үүрэгтэй.

Гэтэл Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл бүрийг прокурот бүртгүүлэх, зөрчил тус бүрт шийтгэл оногдуулахаар тусгагдсан нь нэн даруй арилгах боломжтой, зөрчлийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан, ноцтой үр дагавар гараагүй, татварын улсын байцаагчийн шаардлагын хүрээнд арилгах боломжтой зөрчил гаргасан хүн, хуулийн этгээдэд заавал шийтгэл оногдуулах хуулийн орчин бүрдсэн байна[1].

Бүх шатны захиргаа, эрх бүхий албан тушаалтан буюу улсын байцаагч нарт зөрчлийг арилгуулах үүрэг байх ёстой. Учир нь, прокуророос илүү салбар эрх зүйн хууль тогтоомжийг амьдралд хэрэгжүүлэх чиг үүрэгтэй салбарын улсын байцаагч буюу захиргааны байгууллага, албан тушаалтан зөрчлийг арилгах тал дээр үр нөлөөтэй ажиллана гэж үздэг. Энэ нь захиргааны гол чиг үүрэг, зорилт байдаг[2].

Зарим прокурорын зүгээс татварын албаны дотоод ажлын зохион байгуулалтад хөндлөнгөөс хяналт тавих болов. Тухайлбал, шийтгэлийн хуудаст зөвхөн нэг улсын байцаагч гарын үсэг зурах ёстой бусад  татварын улсын байцаагч нар гарын үсэг зурах шаардлагагүй, хяналт шалгалтыг бүрэлдэхүүнтэй бус дангаар хийх нь зүйтэй гэх мэт шаардлага тавьж байгаа нь татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавихад хүндрэл учруулж байна.

Зөрчлийн тухай хуулийн 1.3 дугаар зүйлийн 2-т “Энэ хуульд заасан зөрчил тус бүрд шийтгэл оногдуулна” гэж заасан нь эрүүгийн эрх зүйн зарчим /legalitaet/ бөгөөд үүнээс хамаарч хянаж шалгах процесст прокурор хяналт тавихаар болж байна[3]. Татварын алба нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд төлбөрийн баримт олгоогүй хүн, хуулийн этгээдийг шууд торгох бус эхний ээлжинд албан шаардлага хүргүүлж зөрчлөө арилгах боломжийг олгож, зөрчлөө арилгаагүй тохиолдолд шаардлага биелүүлээгүй гэдгээр торгох, шийтгэлийн хамгийн хөнгөн хэлбэрийг сонгож хуулийг хэрэгжүүлж байна. Прокурор нэгэнт зөрчил үйлдэгдсэн бол шийтгэх ёстой гэсэн байр сууринаас хандаж байгаа нь татвар төлөгчийн хууль ёсны эрх ашиг сонирхлыг хохироогоод зогсохгүй эрх зүйн байдлыг дордуулж байна.

Татварын улсын байцаагч зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад үйлдэх баримт бичгийн тоо, хэрэгжүүлэх ажиллагаа нэмэгдсэнтэй холбоотой бичиг хэрэг, шатахуун, техникийн болон бусад дагалдах зардлууд нэмэгдэж байна.

Хяналт шалгалтын тоо нэмэгдэж, зөрчлийн хэрэг бүртгэлт хийх бүрт прокурорт биечлэн очиж бүртгүүлэх, мэдэгдэх, зөвшөөрөл авах, холбогдох хүмүүсээс мэдүүлэг, тайлбар авах зэрэгт улсын байцаагчдын ачаалал нэмэгдэж байна.

**Хуулийн зөрчилдөөн**

Татварын улсын байцаагч зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлээд татвар төлөгчид ямар баримт бичгээр хариуцлага хүлээлгэх нь эргэлзээтэй байна. Татварын албаны зүгээс татварын улсын байцаагч нарт шийтгэлийн хуудсаар нөхөн татвар, хариуцлагыг оногдуулах ёстой гэдэг чиглэл өгсөн боловч татвар төлөгч Татварын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлд заасан баримт бичгийг үйлдэж хариуцлага хүлээлгэх ёстой гэж маргаж байна. Ингэж маргаж байгааг буруутгах аргагүй юм. Учир нь Татварын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлд татварын улсын байцаагчийн үйлдэх баримт бичигт акт, дүгнэлт, илтгэх хуудас зэрэг байгаа бөгөөд шийтгэлийн хуудас байхгүй.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 2-т Эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд хүлээн авсанаас хойш 15 хоногийн дотор сайн дураар биелүүлнэ гэж заасан нь Татварын ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.6-т

---

[1] Мэргэжлийн хяналтын байгууллагаас Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлсэн санал.

[2] Зөрчлийн тухай хууль (шинэчилсэн найруулга) болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөлд өгөх санал, зөвлөмж Монголын хуульчдын холбооны Захиргааны эрх зүйн хороо legaldata.mn

[3] Зөрчлийн хуулийг хүлээн зөвшөөрөхгүй байх үндэслэл МУИС-ийн ХЗС-ийн Нийтийн эрх зүйн тэнхимийн дэд профессор, хууль зүйн ухааны доктор П.Одгэрэл видео



Remove Watermark Now

Remove Watermark Now

заасан татварын албанаас гаргасан акт, дүгнэлт, бусад баримт бичигтэй танилцах, үндэслэлгүй буюу хуульд нийцээгүй гэж үзвэл танилцсанаас хойш 30 хоногийн дотор гомдлоо захиргааны болон шүүхийн журмаар гаргах гэсэнтэй зөрчилдөж байх бөгөөд Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1-д заасан 30 хоногийн дотор гомдол гаргах эрхийг хязгаарлаж байна.

Зөрчлийн тухай хуулийн 6.9 дүгээр зүйлд зөрчлийн хэргийг дуусгахаас өмнө оролцогч, тэдгээрийн өмгөөлөгчийг зөрчлийн хэрэгтэй танилцуулах боломжоор хангах тухай заажээ. Татварын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3-т гарын үсэг зурж эцэслэн ёсчлоогүй татварын улсын байцаагчийн акт, дүгнэлт, бусад баримт бичиг, илтгэх хуудсыг татвар төлөгчид урьдчилан танилцуулах, зөвшөөрүүлэхээр албадахыг хориглосон зохицуулалт хэвээр үйлчилж байгаа бөгөөд хяналт шалгалтын ажил дууссаны дараа акт, дүгнэлтийг танилцуулах нь зохистой байдаг. Гэвч татварын улсын байцаагч хуулийн аль заалтыг баримтлах нь эргэлзээтэй байна.

## Татвар төлөгч татвар төлөхөөс зайлсхийх зорилгоор татварын хууль тогтоомж зөрчих үйлдэл (Зөрчлийн тухай хуулийн 11.19.1)

*МУИС-ийн Хууль Зүйн Сургуулийн*
*Нийтийн эрх зүйн тэнхимийн багш*
*О.Чулуунцэцэг*

Бид хуулийн нэр томъёоны ойлголтыг ялгамжтайгаар авч үзэн салбар эрх зүйн зохицуулалтын хүрээнд зөв тайлбарлан авч үзэх хэрэгтэй. Тухайлбал, Зөрчлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.19.1 дэх татвар төлөгч татвар төлөхөөс зайлсхийх зорилгоор татварын хууль тогтоомж зөрчих гэсэн заалтыг Эрүүгийн хуулийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь татвар төлөхөөс зайлсхийх гэсэн заалтаас ялган таньж, хууль хэрэглээнд оновчтойгоор зүйлчлэх нь зүйтэй юм.

Татвар төлөхөөс зайлсхийх (обход налогов буюу tax avoidance) гэдгийг эдийн засгийн тухайлсан зорилго, ашиг сонирхолд нийцүүлэхийн тулд татварын бүртгэлийн тодорхой үйлдэл, тооцоололдоо зохих ёсоор хуулийн дагуу тооцох үйлдлийг хийх боловч шууд буюу шууд бус аргаар дамжуулан татварын хэмжээг багасгах үйлдэл гэж томъёолж болно. Өөрөөр хэлбэл, энэ үйлдэл нь санхүүгийн төлөвлөлтийн арга барилд үндэслэн үе шаттайгаар татвар төлөх үүргээ хуулийн дагуу багасган мэдэгдэх ба хувийн санхүүгийн нөхцөл байдалдаа төлөх ёстой орлогын татварын хэмжээг багасгаж бууруулан өөрчлөх замаар хуулийн дагуух аргачлалыг ашиглахыг хэлнэ.

Татварын нотолгоо нь санхүүгийн тайланд тусгагдсан баримтууд болон нягтлан бодох бүртгэлийн тайлан, татварын тайлан зэрэг эх үүсвэр болон бусад эх үүсвэрээс авсан баримтаар нотлогдсон мэдээллээс бүрдэнэ. Татварын тайланд тусгагдсан санхүүгийн тайлангийн мэдээллийг буруу тайлбарлах нь тухайн татвар төлөгчийн бодол болохоос хууль зүйн факт биш байдаг. Учир нь буруу тайлбарласан тэрхүү зүйл нь фактын талаарх бодол юм. Фактын талаар буруу тайлбар өгөөгүй л бол энэ нь эрх зүйн хариуцлага хүлээх үндэслэл болдоггүй байна.

Татвар төлөх үүрэг нь өөрөө ёс зүйтэй холбоотой ойлголт бөгөөд ёс зүй нь зан суртахууны зарчимд үндэслэдэг тул ёс зүйг төлөвшүүлснээр татвар төлөх үүрэг бүрэн хэрэгжих боломжтой төдийгүй зөв үйлдлийн илэрхийлэл болдог байна.

Татвар төлөхөөс зайлсхийх зорилгоор үйлдэгддэг зөрчлүүд нь татвар ногдох зүйлийг нуун дарагдуулсан төдийгүй бусдад үндэслэлгүйгээр шилжүүлэх, санхүүгийн болон татварын тайланд тусгахгүй орхигдуулах, татварын хөнгөлөлт буюу хасалтыг ашиглан зардлаа өсгөх, орлогоо бууруулах буюу бага хэмжээгээр тайлагнах, борлуулалтын тодорхой хэсгийг нуух, үнэ шилжилтийн аргыг ашиглах, татварын хасалт хийх гэх мэт. Жишээлбэл;

- Татвар ногдох орлого, эд хөрөнгө, бусад зүйлсийг нуун дарагдуулах гэдгийг тухайн зүйлийг биет байдлаар нь татварын албанаас өнгөлөн далдлах буюу данс бүртгэл, тайлан балансад тусгахгүй байх, үндэслэлгүйгээр бусдад шилжүүлэх, хууль бус хэлцлээр халхавчлах, хуурамчаар өглөг үүсгэх, холбогдох баримт бичгийг нууцлахыг хэлдэг.
- Татвараа багасгахын тулд зардал болон бусад хасагдах зүйлийг үндэслэлгүйгээр өсгөх зорилгоор Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5-т “албан татвар суутган төлөгч нь бэлтгэн нийлүүлэгчид албан татвар төлсөн нь нэхэмжлэл, нэмэгдсэн өртгийн албан татварын падаан, нягтлан бодох бүртгэлийн бусад баримтад тусгагдаагүй бол уг албан татварыг хасаж тооцохгүй” ба Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2-т “албан татвар төлөгчийн баримтаар нотлогдоогүй зардлыг албан татвар ногдох орлогоос хасч тооцохгүй” гэж заасан байхад татварын хасалт хийдэг.
- Мөн татвар ногдох орлого, эд хөрөнгө, бусад зүйлсийг хувь хүн, хуулийн этгээдэд үндэслэлгүйгээр шилжүүлэх тохиолдлын хувьд Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.3-т “харилцан хамаарал бүхий этгээдүүд үнэгүй, эсхүл зах зээлийн үнээс хямд буюу өндөр үнэ, тарифаар хоорондоо бараа, ажил, үйлчилгээ борлуулсан” бол албан татвар тооцох үнэлгээг харъяалах татварын алба тухайн үеийн зах зээлийн үнэ, тарифыг үндэслэн тодорхойлох ёстой бөгөөд тус хуулийн 13 дугаар зүйлийн 13.9-т “Бараа, ажил, үйлчилгээг үйлдвэрлэлийн дотоод эргэлтэд ашигласнаас бусад хэлбэрээр бусдад үнэ төлбөргүй шилжүүлсэн буюу хувийнхаа

Remove Watermark Now

хэрэгцээнд ашигласан бол нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөхгүй" гэж заасныг татвар ногдох орлогоос чөлөөлөх эсвэл орлогод бүртгэхгүйгээр зардал болгон өсгөж тайлагнадаг.

➢ Хуулийн этгээдийн тамга, тэмдэг, дансыг бусдад шилжүүлэх буюу ашиглуулах үед аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага болон ерөнхий нягтлан бодогч санхүүгийн тайланд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулах бөгөөд гүйцэтгэх удирдлага тухайн компанийн нягтлан бодох бүртгэл санхүүгийн тайлангийн үнэн зөвийг хариуцна.

Татварын бүртгэлд татвар төлөгч бүрийн төлбөл зохих татварын ногдол, хөнгөлөлт, чөлөөлөлт, алданги, торгууль, тэдгээрийн төлөлт, хураалт, өрийг анхан шатны баримтад үндэслэн бүрэн тусгана. Гэхдээ тухайн анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглодог. Татвар төлөгч анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг хөтлөн татварын тайлан гаргахаас гадна татвар төлөгч холбогдох баримт, бүртгэлд үндэслэн хуулийн дагуу төлбөл зохих татварын ногдлоо өөрөө тодорхойлон татварын тайланд тусгадаг.

Татвар ногдох зүйлийг бусдад шилжүүлсэн аливаа этгээд нь энэ тухай баримтыг шилжүүлэн авсан этгээдэд тухай бүр, татварын албанд шаардсан үед гаргаж өгөх үүрэг хүлээх төдийгүй хувьцаа эзэмшигчдийн хурлаар компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар гүйцэтгэх удирдлагаас гаргасан дүгнэлтийг үндэслэдэг.

Татварын хяналт шалгалтын зорилго нь татварын хууль тогтоомж зөрчсөн үйлдлийг илрүүлэх, татварын хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахад чиглэдэг ба нягтлан бодох бүртгэл болон татварын тайлангийн үзүүлэлтүүд хоорондоо тохирч буй эсэхийг нягтлан хянадаг.

Татварын алба, татварын байцаагч татварын хууль тогтоомжийг зөрчихөд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулах зорилгоор шаардлага бичих бөгөөд зөрчлийн тухай тэмдэглэл, зөрчил гарахад нөлөөлсөн нөхцөл, шалтгааныг арилгах талаар шаардлагад тусгана. Тухайлбал, Тооллого явуулах ажлын хэсэг нь тооллого явуулсан тухай тэмдэглэл, бүртгэл үйлдэх бөгөөд тооллогоор илэрсэн зөрчил, тооллогоор илэрсэн зөрчлийг шийдвэрлэсэн байдлын талаар тусгах[4] ба бүх төрлийн согтууруулах ундаа, тамхи хураасан тухай тэмдэглэл[5] ч хамаарна. Түүнчлэн татварын алба, татварын улсын байцаагч төлбөл зохих татварын ногдлоо бүрэн гүйцэт тодорхойлж, хугацаанд нь төлсөн эсэх; тодорхой үйл ажиллагаа эрхлэхдээ бодит бус үнэ хэрэглэсэн, тайлан, бүртгэл хөтлөөгүй буюу дутуу хөтөлсөн, эсхүл бүртгэл, татварын тайланг гаргаж өгөөгүй нь нотлогдсон тохиолдолд; эд хөрөнгө битүүмжлэх, төлөөгүй татварт ногдуулах алданги тооцоход акт үйлдэхээр хуульчилсан.

Олон улсын туршлагаас судлахад татварын хууль тогтоомж зөрчих үйлдлийг бүртгүүлээгүй татвар төлөгчдөд, тайлан гаргаагүй этгээдэд, татвараа буруу тодорхойлсон, хугацаа хожимдуулж төлбөр хийсэн тохиолдолд хамруулан, тухайн хугацаанд бүрэн болон хэсэгчлэн ногдох татварыг нөхөн авах, торгуулийг автомат байдлаар оногдуулах, татвар ба хүүгийн хамт торгуулийн хэлбэрээр сонгох, эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ татвар төлөгчдийн үйл ажиллагааг зогсоох, данс хаах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байна.

pdfelement

Зөрчил шалган шийдвэрлэх нь зөрчлийн хэрэг бүртгэлт, түүнд тавих прокурорын хяналт, зөрчил шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаа[6] бөгөөд энэхүү үйл ажиллагаанд татварын албанаас бичсэн дүгнэлт хамаарна. Өөрөөр хэлбэл, татварын хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн, эсхүл их хэмжээний татвар ногдох орлогыг нуусан буюу бусад хэлбэрээр татвар төлөхөөс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн хэрэг бүртгэлт хийлгэхээр бол дүгнэлт бичихээр хуульчилсан[7]. Ийм үйлдэл нь гэмт хэргийн шинжийг бүрэн агуулах бөгөөд татвар төлөхөөс зугтах (уклонение от уплаты налогов буюу tax evasion)[8] эсвэл татварын залилан (tax fraud) гэсэн ойлголттой холбоотой юм. Тухайлбал, гэмт хэргийн шинжтэй бөгөөд хууль тогтоомжийн заалтыг урьдаас мэдэж байдаг[9] ба мэдсээр байж хууль зөрчин үйлдэгддэг бөгөөд хэн нэгэн этгээд татвар ногдуулах үйл ажиллагаанд болон төлбөл зохих төлбөрөөс ямар нэгэн байдлаар зориуд санаатайгаар зайлсхийх оролдлого хийх үйлдлийг хамаардаг. Жишээ нь: Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйлийн 1.3 дах заалт болох нягтлан бодох, анхан шатны бүртгэл, татварын тайлан, холбогдох баримт бичгийг устгасан, эсхүл нуусан, эсхүл нягтлан бодох бүртгэл хөтлөөгүй, холбогдох баримт бичгийг бүрдүүлэлгүй татварын тайлан гаргах боломжгүй болгосон үйлдлийг хамааруулж болох бөгөөд татварыг нөхөн төлүүлж, нөхөн төлүүлэх татварын 30 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. Харин Эрүүгийн хуулийн 18 дугаар зүйлийн 3 дах заалтад татвар төлөхөөс зайлсхийх зорилгоор их хэмжээний татвар ногдох орлого, эд хөрөнгө, бараа үйлчилгээг зориуд худал тодорхойлсон, нуусан бол 450000-5400000

---

[4] Тооллого явуулахад баримтлах журам. ҮТЕГ-ын даргын 2008 оны 220 дугаар тушаалын 6 дугаар хавсралт, тус журмын хавсралт 1.

[5] Бүх төрлийн согтууруулах ундаа, тамхи хураасан тухай тэмдэглэл. ҮТЕГ-ын даргын 2008 оны 281 дүгээр тушаалын 2 дугаар хавсралт.

[6] Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.1 дэх заалт. УБ.,2017

[7] Татварын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 2.6 дах заалт. УБ.,2008

[8] Victor Thuronyi. Comparative tax law. Kluwer law international. Great Britain. 2003. p.223

[9] Пепеляев С.Г. Налоговое право. Юристь. М.:2003. с.575

Remove Watermark Now

төгрөгөөр торгох ялаар шийтгэнэ. Мөн их хэмжээний татвар ногдох орлогыг их хэмжээний хохирол (50000 нэгж) учруулсан гэж үзэх үндэслэлтэй эсэхийг анхаарах, түүнчлэн эрх зүйн хэм хэмжээний заалтын ялгааг эдийн засгийн үр өгөөжийн талаас нь харьцуулан дүгнэн үзэх хэрэгтэй юм.

Шинээр батлагдсан хуулийн хэм хэмжээ нь санхүүгийн эрх зүйн хэм хэмжээтэй холбоотой тохиолдол бүрийг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тухайн гарсан зөрчилд захиргааны хариуцлага хүлээлгэх, санхүүгийн бүртгэлийн үнэн зөв хөтлөлтийг хэвшүүлэн хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх боловч хуулиар тодорхойлогдсон нэр томъёог зөв ялган зүйлчлэх, оногдуулж буй торгуулийн хэмжээг оновчтой байдлаар эдийн засгийн агуулгын хувьд тогтоож өгөх, татвар төлөгчдөд дарамт учруулахгүй байдлаар татварыг бүрдүүлэх зэргийг анхаарах нь зүйн хэрэг юм.

## “ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ХЭРЭГЛЭЭ” УУЛЗАЛТ, ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

“Ханнс- Зайделийн сан”-ийн байранд 2017 оны 12 дугаар сарын 19-ны өдөр Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч Д.Батбаатар, шүүгч Д.Баатархүү, Г.Билгүүн, Э.Зоригтбаатар, Э.Лхагвасүрэн, С.Мөнхжаргал, О.Номуулин, Ц.Сайхантуяа, Б.Тунгалагсайхан, Э.Халиунбаяр, Н.Хонинхүү, Ц.Цогт, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Ганзориг, Монголын хуульчдын холбооны Захиргааны эрх зүйн хорооны Удирдах зөвлөлийн гишүүн Н.Мягмар, Д.Сүнжид, З.Ганзориг, профессор Д.Одгэрэл, “Ханнс Зайделын сан”-ын “Эрх зүйн боловсрол” академийн захирал А.Энхтуяа, давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Б.Адилмаа нарыг оролцуулан, “Захиргааны ерөнхий хуулийн хэрэглээ” уулзалт, ярилцлагыг хийв. “Ханнс- Зайделийн сан”-ийн тэргүүн др.,Ц.Сарантуяа нээж үг хэлснээр уулзалт эхлэв.

Ц.Сарантуяа: Захиргааны ерөнхий хууль жил гаруй хугацааны өмнө батлагдсан. Захиргааны байгууллагын ажилтнуудын хувьд энэ хуулийг хэрэгжүүлэх асуудал харьцангуй жигдэрч байгаа гэж бодож байна. Энэ үед ерөнхий хуулиа илүү сайн болгохын тулд, ийм хэрэгцээ шаардлага байхгүй ч гэсэн нэг мөр ойлгохын тулд мониторинг хийх шаардлагатай байсан учраас Хууль зүй, дотоод хэргийн яамтай харилцан ажиллах хүрээнд он гарахаас өмнө шүүгч нартай уулзалт, ярилцлага хийе гэж бодсон юм. Хууль тогтоомжийн хяналт, үнэлгээг Улсын Их Хурал, Засгийн газар эсвэл хөндлөнгийн байгууллага хийх боломжтой байдаг. Тиймээс “Ханнс -Зайделийн сан”, “Эрх зүйн боловсрол” академи дангаараа хийе гэж бодсонгүй Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтраад явуулах юм. Энэ үйл ажиллагаа нь Хууль зүй, дотоод хэргийн яамны үндсэн төлөвлөгөөнд орж байгаа. Он гарахаас өмнө захиргааны хэргийн шүүхийн анхан шат болон давж заалдах шатны шүүхийн шүүгч нартай уулзаад саналыг нь авч байя гэж бодож байна. Мөн Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимаас бичгээр санал авах болсон. Ингээд 3 шатны шүүхээс саналыг нь авснаар бидний үйл ажиллагааны эхлэл тавигдаж байна.

Мониторинг хийх ажлын эхний уулзалт, ярилцлагыг Монголын хуульчдын холбооны Захиргааны эрх зүйн хороотой хамтарч хийж байна. Энэ үйл ажиллагааг хөтөлж байгаа Захиргааны эрх зүйн хорооны тэргүүнээр сонгогдсон шүүгч Ц.Цогтод баярлалаа. Өнөөдөр хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа, мөн хүсэлт тавьсны дагуу шат, шатны шүүхээс шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нар оролцож байна. Та бүхний хэлсэн санаанууд уулзалтын тэмдэглэлд тусгагдах болно. Захиргааны ерөнхий хуулийн хэрэглээ болон Зөрчлийн тухай хуультай холбоотой хэлэх санал байвал хэлээрэй гэв.

Д.Сүнжид: Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхлээд нэг жил дөрвөн сарын хугацаа өнгөрлөө. Энэ хооронд хуулийн нэгдмэл ойлголт бий болоогүй асуудал байна. Зөвхөн судлаачдын дунд биш хуулийг хэрэглэж байгаа захиргааны байгууллагын удирдах албан тушаалтан болон захиргааны хэргийн шүүгч нарын дунд нэгдсэн нэг ойлголт бий болох хэрэгтэй байна гэж үзэж байна гэв.

Шүүгч Ц.Цогт: Захиргааны хэргийн шүүхүүд Захиргааны ерөнхий хуулийг хэрхэн хэрэглэж байгаа тал дээр хийсэн дүгнэлтээ танилцуулав.

Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Ганзориг: Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Захиргааны хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш захиргааны хэргийн шүүгч нартай уулзаж, ярилцаж байгаад таатай байна. Захиргааны ерөнхий хууль гаргах гэж нэлээн эсэргүүцэлтэй тулгарч байсан. Гол эсэргүүцэгч нь захиргааны байгууллага өөрөө байсан, одоо ч энэ эсэргүүцэл байсаар байгаа. Жишээ нь Төв банкны тухай хуулийг хэлэлцүүлэх үед Захиргааны ерөнхий хуультай холбоотой маргаан гарч байсан. Захиргааны ерөнхий хуулийн үйлчлэлээс Төв банкийг хасах хуулийн төсөл орж байсан. Үүнд Төв банк гэдэг утгаар нь биш захиргааны байгууллага гэдэг үүднээс хандах ёстой. Хэрвээ ингээд хуулийн үйлчлэлээс захиргааны байгууллагыг хасаад байх юм бол захиргааны хэргийн шүүхийн харьяаллын хэрэг маргаан үлдэхгүй боллоо гэдэг саналаа хэлж байсан. Жил хагасын өмнө П.Одгэрэл багш Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн ажлын хэсэгтэй мэтгэлцээн өрнүүлсэн. Энэ хэрэг Үндсэн хуулийн цэц дээр шийдвэрлэгдэх гэж байгаа. Зөрчил нь ямраас үл хамаараад зарим тохиолдолд 3 шатаар, зарим тохиолдолд 2 шатаар хянан шийдвэрлэгдэж байгаа. Захиргааны ерөнхий хуульд санаатай болон санамсаргүйгээр халдах үйлдэл байна. Үүнд хамгаалалт хийх этгээд нь шүүх байгаа. Хамгаалалт хийхийн тулд хууль хэрэглээ байх ёстой, гэхдээ зөв хэрэглэх хэрэгтэй. Үүний тулд өнөөдрийнх шиг уулзалт ярилцлагыг олон дахин хийх хэрэгтэй юм.

Remove Watermark Now

Тодорхой хуулийн заалтыг хэрэглэх, хэрэглэхгүй тал дээр шүүгч болон багш нарын дунд мэтгэлцээн байна байх. Шүүхийн шийдвэрүүдийг судлаад үзэхээр асуудлын гүн рүү их орж байна. Үндсэн хуулийн цэц Монгол Улсын Үндсэн хуулийг эхнээс нь эхлээд дуустал нь тайлбарладаг шиг захиргааны хэргийн шүүх Захиргааны ерөнхий хуулийн эхнээс нь эхлээд дуустал нь тайлбарладаг байгаасай гэж бодож байна. Хуулийн мөн чанарыг сайн ойлговол хуулийг хэрэглэхэд тустай болов уу гэж бодож байна. Ингээд дараа дараагийн хэлэлцүүлэгт идэвхтэй оролцоосой гэж хүсэж байна гэв.

Ерөнхий шүүгч Д.Батбаатар: Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд Захиргааны ерөнхий хуулийн хэрэглээний асуудлын талаар танилцуулга хийв.

Шүүгч Ц.Цогт: Шүүгч нарын саналыг сонссоноор мониторинг хийх, мөн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгтэй болно гэвэл ямар зүйл заалтыг хэрхэн тайлбарлах болон ямар зохицуулалтыг засах шаардлагатай байгаа талаар тэмдэглэж авахад хэрэгтэй байгаа юм. Үүн дээр суурилаад мониторингийн судалгаа хийх болно тийм учраас шүүгч нар санал, бодлоо хэлээрэй, одоо П.Одгэрэл багш саналаа хэлэх байх гэв.

Профессор П.Одгэрэл: Захиргааны ерөнхий хуулийн талаар саналаа хэлье. Захиргааны ерөнхий хууль батлагдаад жил гаруй хугацаа өнгөрч байхад бусад салбар хуулиудын үйлчлэлээр нэмэлт өөрчлөлт их орлоо. Салбар хуульд өөрчлөлт орлоо гээд ерөнхий суурь хуульд өөрчлөлт оруулж болохгүй. Ийм өөрчлөлт орох байдал их байна. Салбар хуулийг шүүхийн шийдвэрийн үндэслэх хэсэгт дурддаг. Жишээ нь Зөрчлийн тухай хууль батлагдсанаар Татварын ерөнхий хууль захиргааны салбараас салах хандлагатай болж байна. Татварын байцаагчийн актыг шийтгэвэр гэж үзнэ гэхээр Захиргааны ерөнхий хуульд шийтгэвэр буюу зөрчилтэй холбоотой бүх зүйл захиргааны акт биш гэж заасан байгаа. Хэрвээ захиргааны акт биш гэж үзвэл илт хуульд бусад тооцох зэрэг зохицуулалтыг хэрэглэх боломжгүй болоод байгаа юм. Гэтэл татварын байцаагчийн акт болгон зөрчилтэй холбоотой асуудлыг зохицуулдаггүй.

Захиргааны шүүх захиргааны акт гаргах болсон эрх зүйн үндэслэлийг хянадаг болохоос иргэн, хуулийн этгээдийн гэм буруутай үйлдэлд дүгнэлт өгдөггүй. Зөрчлийн тухай хуулийг дагаад салбарын 200 гаруй хуульд өөрчлөлт оруулсан. Энэ нь захиргааны хэргийн шүүхээс аливаа хэрэг маргааныг салгаад ганцхан төрийн албаны хэрэг маргааныг шийдвэрлэдэг болж үлдэх байдал бий болоод байна. Эргээд салбарын тухай хуулийг боловсруулахад шүүхээс идэвхтэй оролцож, санал бодлоо хэлж, хуулийн төслүүд дээр ажиллаж байхгүй бол хэсэг бүлэг этгээдүүд хууль баталж, энэ нь эргээд Захиргааны хэргийн шүүхэд нөлөөлж байна. Үүнд хэрхэн оролцох вэ гэвэл захиргааны шүүхээс Үндсэн хуулийн Цэцэд Зөрчлийн тухай хууль Үндсэн хууль зөрчиж байгаа талаар хандах хэрэгтэй. Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6 дахь хэсэг нь тэр чигээрээ Үндсэн хуульд байдаг. Үндсэн хуулийн цэцээс Зөрчлийн тухай хуулийн иргэнийг торгодог, шийтгэдэг хэсэг нь Үндсэн хуулийн хуульд үндэслэх зарчмыг зөрчиж байна гэж тогтоовол Зөрчлийн тухай хуулийн бүх санкцын хэсэг нь салбар хуульдаа хамаарах боломжтой.

Захиргааны шүүх иргэн, хуулийн этгээдийн буруутай үйл ажиллагааг биш түүнд тогтоосон татварын байцаагчийн акт хуульд үндэслэж гарсан эсэхийг тогтоодог. Зөрчил нь гэмт хэрэг биш харин зөрчил гаргасан этгээд, захиргааны байгууллага, шүүх 3 нийлээд зөрчлийг арилгадаг. Захиргааны хариуцлага нь заавал торгоно гэсэн үг биш сонголттой. Зөрчлөө арилгавал торгохгүй байж болдог салбар юм. Ийм суурь онолыг Үндсэн хуультай нийцүүлээд, судалгаа баримттайгаар шүүхээс Үндсэн хуулийн цэцэд хандаж болох юм шиг байгаа юм. Судлаачид хандахаар авч хэлэлцдэггүй. Шүүхэд ийм боломж байгаа учраас судалгаа хийх хэрэгтэй. Салбарын хуульд өөрчлөлт оруулахад харьяа шүүхээс нь санал авдаг байдлыг бий болгох хэрэгтэй. Энэ асуудалд идэвхтэй хандахгүй бол Захиргааны хэргийн шүүхэд шийдвэрлэх хэрэг маргаан үлдэхгүй болох магадлалтай байна гэв.

Шүүгч Ц.Цогт: Шүүгч нарт Захиргааны ерөнхий хуулийн хэрэглээтэй холбоотой хэлэх санал байна уу гэхэд

Шүүгч С.Мөнхжаргал: Хамгийн гол нь Захиргааны ерөнхий хуулийг дагаж, мөрдөх журам байхгүйгээс болж хэрэглэхэд төвөгтэй байна. Одоохондоо хуулийн бүх заалт хэрэглэгдээгүй байна. 07 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө илт хууль бус актад 30 хоногийн хугацаа өгөөд хүлээж авахаас татгалздаг байсан. 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойш өмнө гарсан захиргааны актыг илт хууль бусад тооцуулахаар нэхэмжлэл гаргавал яах юм бэ? Өмнө хүлээж авахаас татгалзсан шүүхийн шийдвэртэй бол хүлээж авахгүй харин шинээр нэхэмжлэл гаргавал хүлээж авч болох ч юм шиг ийм асуудлууд их байна. Тийм болохоор дагаж мөрдөх журам гаргах хэрэгтэй байсан байх. Үнэхээр илт хууль бус захиргааны акт бол хүлээж аваад шийдвэрлэмээр байдаг. Гэтэл илт хууль бус биш байхад хүлээж аваад шийдвэрлэсэн тохиолдол ч байна гэхэд

Ерөнхий шүүгч Д.Батбаатар: Хууль батлагдахаас өмнө шүүхэд хандахад хугацаа өгөөд хүлээж авахаас татгалзсан захиргааны актыг дахин илт хууль бусад тооцуулахаар нэхэмжлэл гаргасан. Эсвэл маргаан бүхий захиргааны акт нь хууль батлагдахаас өмнө гарсан ч гэсэн шүүхэд хандаагүй байж байгаад хууль шинэчлэгдсэний дараа илт хууль бусад тооцуулахаар нэхэмжлэл гаргасан гэсэн 2 төрлийн маргаан байгаа гэв.

Шүүгч Ц.Цогт: Хууль боловсруулах ажлын хэсгээс хууль хэрэглэгдэж байхад нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн жагсаалт гэж гаргаад энэ энэ хуульд өөрчлөлт оруулах юм байна гэж жагсаалт гаргаж байсан. Гэтэл ерөнхий хуулийг дагаад салбарын хуульд өөрчлөлт оруулах гэхээр зарим нэг том салбар хуулиас болоод асуудал үүссэн. Захиргааны чиглэлийн бүх хуульд өөрчлөлт орох болоод



pdfelement

Remove Watermark Now

ерөнхий хуулийг батлахад саад болоод байсан учраас эхлээд ерөнхий хуулиа батлаад дараа нь салбар хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замыг сонгосон. С.Мөнхжаргал шүүгчийн асуусан шинэ хуульд шилжихтэй холбоотой журмын хувьд Засгийн газраас хэм хэмжээний бүх актыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлж гаргахыг Хууль зүй, дотоод хэргийн сайдад үүрэг болгосон тогтоол гарсан. Үүний дагуу яамнаас ажиллаж байгаа юм билээ .

Захиргааны ерөнхий хуулийг дагаж мөрдөх журам хэрэгтэй байсан байх. Гэхдээ шинэ хууль гарч байгаатай холбоотой хэрэглээний асуудлыг шүүхийн замаар шийдвэрлэх буюу шүүхийн практик тогтоодог Улсын дээд шүүхээс тодорхой хугацаа өнгөрсний дараа хуулийн заалтыг зөрүүтэй хэрэглэж байгаа олон тохиолдол цугларсны дараа тэдгээрт дүгнэлт өгөх ёстой юм байна. Түүнээс биш тохиолдол болгонд тайлбар гаргах нь боломжгүй байх гэв.

Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Ганзориг: Хууль батлагдахаас өмнө илт хууль бусад тооцуулахаар шүүхэд өгсөн, өгөөгүй 2 фактын хувьд ямар зарчмын ялгаа байгаа юм бэ? Нэг нь өмнө нь шүүхэд хандаад шийдвэрлүүлсэн, нэг нь хандаагүй байж байгаад шинэ хуулийг баримтлаад шүүхэд хандахад болохгүй зүйл байхгүй. Урьд нь хүчингүй болгуулахаар шүүхэд хандаад хөөн хэлэлцэх хугацаагаар буцаасан. Одоо харин хугацаа хожихийн тулд илт хууль бусад тооцуулахаар шүүхэд хандлаа гэж бодъё, тэгвэл үүнд хэрэг үүсгээд илт хууль бус нь тогтоогдохгүй бол буцаагаад явуулах боломж байгаа юу? гэхэд

Шүүгч Н.Хонинхүү: Өмнө нь нэхэмжлэл гаргахад хөөн хэлэлцэх хугацаа тооцдог байсан. Харин одоо тооцохгүй болсон болохоор өмнө нь хөөн хэлэлцэх хугацаа дууссан гээд хэргийг нь хүлээж аваагүй хүмүүст ялгавартай байдал бий болоод байна гэв.

Профессор П.Одгэрэл: Энэ тохиолдолд илт хууль бус актын хувьд хэн гаргасан нь тогтоогдохгүй эсвэл гэмт хэрэг үйлдэхийг шаардсан акт байвал үүнийг хүлээж авах ёстой гэж бодож байна. Яагаад гэвэл шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хүлээж авдаг хуулийн зохицуулалт байгаа гэв.

Ерөнхий шүүгч Д.Батбаатар: Бодит байдал дээр нэхэмжлэл гаргах болсон үндэслэл байна. Хууль зөрчиж гарсан учраас илт хууль бусад тооцуулах гэсэн байдаг. Ийм нэхэмжлэл гаргангуутаа явцын дунд хүчингүй болгуулъя гээд нэхэмжлэлийн шаардлагаа өөрчилчихдөг гэв.

Шүүгч Ц.Цогт: Шүүхэд өнөөдөр ийм шийдвэр гаргая гэдэг эрх байхгүй. Захиргааны акт хуульд үндэслэсэн байх ёстой. Аливаа захиргааны байгууллага өөрийнх нь эрх мэдлийн хүрээнээс хэтэрсэн акт гаргасан эсвэл дотоод чиг үүрэгт нь заагаагүй хяналт шалгалт хийсэн ч юм уу энэ тохиолдолд илт хууль бусад хамаарна гэв.

Шүүгч С.Мөнхжаргал: Иргэн А өмнө нь шүүхэд хандаад хүлээж авахаас татгалзсан захирамж гарсан байхад дахиад шүүхэд хандвал яах ёстой вэ? гэхэд

Шүүгч Э.Халиунбаяр: Ер нь илт хууль бусад тооцуулах нэхэмжлэл гаргасан хэргийг хүлээн авч байх саналтай байна. 3, 4 жил ийм нэхэмжлэл гаргаж байгаад хугацаа хожих гэх зэргийн асуудлаар дахиж хандахаа болих байх гэв.

Шүүгч Д.Баатархүү: Гэхдээ зөвхөн илт хууль бусад тооцуулах үндэслэлийг нь л шийдвэрлэх хэрэгтэй. Хүчингүй болгуулах нэхэмжлэлийг нь үлдээх хэрэгтэй гэв.

Шүүгч Ц.Цогт: Гол нь хүний эрхийн зөрчил гаргасан акт хүчинтэй байж болохгүй гэв.

Шүүгч Э.Халиунбаяр: Үүнд нотлох баримтын хүрээ ч гэсэн хамаарна гэв.

Шүүгч Ц.Цогт: Шинэ хуулийн үзэл баримтлалд нэг тогтсон зүйл нь илт хууль бус, эрх зүйн зөрчилтэй гэсэн 2 маргааныг ангилж өгсөн. Илт хууль бусад нь хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй, харин хүчингүй болгох нэхэмжлэл гаргахад олон шаардлага тавьж өгсөн. Өмгөөлөгчид илт хууль бусад тооцуулах нэхэмжлэл гаргахдаа хөөн хэлэлцэх хугацааг тойрохын тулд гаргадгийг бүгдээрээ мэдэж байгаа. Шинэ хуулийн дагуу хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргасан бол илт хууль бус гэж шийдвэрлэж болохгүй. Илт хууль бусад тооцуулах нэхэмжлэлийн шаардлагыг шийдвэрлэхэд хууль нээлттэй гэхдээ эцсийн хариу илт хууль бус эсэх тал дээр л шийдвэр гаргана. Ийм үзэл баримтлалаар шинэ Захиргааны хууль гарсан гэв.

Профессор П.Одгэрэл: Үүнийг гайхаж байна. Хүчингүй болгуулахаар шүүхэд хандсан нэхэмжлэлд шинээр нөхцөл байдал илрээд дахиад шүүхэд хандахад яагаад хүлээж авахгүй гэж? Хүлээж авч болно шүү дээ гэхэд

Шүүгч Ц.Цогт: Үгүй. Шүүх нэхэмжлэлийн шаардлагыг шүүх өөрчилж болохгүй гэв.

Ерөнхий шүүгч Д.Батбаатар: Хүчингүй болгох нэхэмжлэлийн шаардлага гаргасан байтал хэрэг хянан шийдвэрлэх явцад захиргааны акт нь илт хууль бус байдаг. Үүнийг хэрхэн шийдвэрлэх юм бэ?, Хүчингүй болгоход ард нь олон үр дагавар бий болдог, илт хууль бусад тооцоход нэхэмжлэлийн шаардлагыг тооцоод цаад үр дагаврыг нь тооцдоггүй. Хэрвээ 30 хоногтоо хүчингүй болгуулах нэхэмжлэл гаргахад илт хууль бус байгаа учраас хүчингүй болголоо гэж шийдвэрлэж болох уу? гэхэд

Шүүгч Ц.Цогт: Процессын хуульд эрхийн зөрчлийг хамгаалах 2 л зохицуулалт байгаа. Илт хууль бусад тооцох хамгаалалт нь өөрөө сул учраас ард нь гарах үр дагаврын тооцдоггүй. Тийм болохоор хэрхэн шийдвэрлэхийг нь нээлттэй орхиод зөвхөн шийдвэр нь илт хууль бус эсэх тал дээр гарна. Хэрвээ илт хууль бусад тооцуулах нэхэмжлэлийн шаардлагыг сольж болно гэвэл хөөн хэлэлцэх хугацаа тооцохоо больсон нь хамааралгүй болчихно гэв.

Шүүгч Н.Хонинхүү: 47.1.6 дахь хэсэгт хуульд заасан үндэслэл байгаагүй гэсэн байдаг. Гэтэл эрх олгосон акт гэж байдаг. Жишээ нь зохиогчийн эрх олгосон акт байна. Шинэ хуульд нэг бүрчлэн

Remove Watermark Now

зааж өгсөн байдаг харин өмнөх хуульд бусад гэсэн заалт байсан. Дээрх шийдвэр нь шинэ хуулийн зохицуулалтад хамаардаггүй. Бусдын эрхэд халдсан зүйл байхгүй, илэрхий алдаатай биш болохоор шийдвэрлэх боломжгүй байна. Илт хууль бусад тооцох үндэслэлийг нэг бүрчлэн зааж өгсөн учраас эдгээрээс өөр акт гарч ирвэл илт хууль бусад тооцох аргагүй болоод байна гэв.

Шүүгч Э.Зоригтбаатар: Бүртгэл хийгдээгүй хэм хэмжээний актын талаар нэхэмжлэл гаргахад шүүхээс бүртгэл хийгдээгүй учраас үр дагавар үүсгээгүй байна гээд хүлээн авахаас татгалздаг. Нэгэнт бүртгэлгүй учраас эрх зүйн үйлчлэлгүй, актыг гаргасан этгээдтэй маргаан үүсгээ гэж шийдвэрлээд байна. Жишээ нь машин ачдаг журам одоо болтол бүртгэгдээгүй байгаа. Тэгэхээр машин ачих шийдвэр гаргасан цагдаа болгонтой, машиныг ачсан компани болгонтой заргалдах байдал үүсээд байна гэхэд

Шүүгч Ц.Цогт: Бүртгэл хийгдээгүй хэм хэмжээний актыг хэрхэн шийдвэрлэх вэ гэсэн санал хэлж байна уу? гэхэд

Шүүгч Э.Зоригтбаатар: Бүртгэлгүй захиргааны акттай холбоотой хэргийг хүлээж авахгүй бол захиргааны байгууллага эрх зүйн хэм хэмжээ тогтоосон акт гаргачихаад бүртгүүлэхийг хүсэхгүй болно. Бүртгүүлэхгүй байх нөхцөлийг шүүх өөгшүүлээд байгаа юм гэв.

Ерөнхий шүүгч Д.Батбаатар: Бүртгэлгүй хэм хэмжээний актын улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдөөд шүүхэд хандахад хүлээн авахаас татгалзаж байгаа ч гэсэн бүртгэлгүй актыг хэрэгжүүлсэн этгээдийг хууль бус үйлдэл гаргасантай нь маргах хэрэгтэй гэсэн байдлаар шийдвэрлэж байгаа гэв.

Профессор П.Одгэрэл: Буртгэлгүй актын улмаас иргэн хохирсон бол актыг баталсан этгээд хариуцлага хүлээх зохицуулалт байгаа гэв.

Шүүгч Э.Зоригтбаатар: ТҮЦ хураасан болгонтой, машин ачсан болгонтой маргаан үүсгэх болоод байгаа. Нөгөө талаар гаргасан хэм хэмжээний актаа бүртгүүлэхгүй байх үр дагаврыг үүсгээд байна гэхэд

Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Ганзориг: Хэрэг хүлээн авахаас татгалзах шиг амархан зүйл байхгүй. Жишээ нь Монгол бичгээр бичсэн нэхэмжлэл ирсэн, шүүх кириллээр бич гээд хүлээж аваагүй. Хамгийн гол нь ямар хэлбэрээр бичсэнд биш хүлээж авах үгүйг шалгасан байсан. Шүүх тэр хэргийг хүлээж аваад орчуулж болох байсан. Э.Зоригтбаатар шүүгчийн асуусан асуулт нь нэхэмжлэлийн шаардлагын хувьд асуудалтай байна. Ерөөсөө захиргааны акт болоогүй зүйл дээр хэрэг үүсгэх болоод байгаа юм л даа гэв.

Шүүгч Б.Тунгалагсайхан: Одоогийн нөхцөл байдалд шүүхээс гарсан шийдвэр биелэгдэхгүй байна. Шүүхийн нэр хүнд буруу шийдвэр гаргасан захиргааны байгууллага шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд оршдог. Төрийн албанаас чөлөөлөгдсөн этгээд шүүхийн шийдвэрээр эгүүлэн томилогдох асуудал муу байна. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас гадна мэргэжлийн байгууллага гэдгийг юу гэж ойлгох вэ? Шүүхийн шийдвэр гүйцэтгэлтэй холбоотой заалтыг нэлээн анхаарч, судалгаа хийж ярихгүй бол хэчнээн зөв шийдвэр гаргасан ч гэсэн биелэгдэхгүй байна. Энэ нь эргээд ерөнхий хуультайгаа уялдсан юм уу гэдэг асуудал байна гэхэд

Шүүгч Ц.Цогт: Захиргааны ерөнхий хуульд орсон шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа нь иргэний эсрэг чиглэсэн захиргааны акттай холбоотой маргаанд шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа хийгддэг. Нэхэмжлэлийг хангасан захиргааны байгууллагын эсрэг гарсан шүүхийн шийдвэр Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулиар зохицуулагддаг гэв.

Шүүгч Э.Халиунбаяр: Дээд шатны байгууллага нь доод шатны байгууллагын гаргасан захиргааны актын хүчингүй болгосон шийдвэрийг яаж биелүүлэх юм бэ? гэхэд

Шүүгч Ц.Цогт: Төрийн албаны зөвлөлийн гаргасан шийдвэрийг анхан шатны шүүх хүлээж аваагүй тохиолдолд давж заалдах шатны шүүхэд нэхэмжлэл гаргаж болох уу? гэхэд

Шүүгч Э.Халиунбаяр: Даалгах нэхэмжлэл бол хүлээж авах байх гэв.

Шүүгч Ц.Сайхантуяа: Хүлээж авахгүй байна гэхээр Төрийн албаны зөвлөлийн гаргасан шийдвэр хуулийн адил үйлчлэх юм уу? гэхэд

Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Ганзориг: Мэргэжлийн байгууллага гэдэгт байшин буулгадаг компани мөн үү? 120 мянгатын барилгыг буулгахад ийм байгууллага олдоогүй. Онцгой байдал, мэргэжлийн хяналт, цагдаагийн байгууллагаас хүмүүс ирсэн гэхдээ энэ манай эрх хэмжээний асуудал биш гэдэг хариу өгсөн. Мэргэжлийн байгууллага гэж нарийн мэргэжил шаардсан байгууллагыг хэлэх болов уу гэж бодож байна гэв.

Шүүгч О.Номуулин: Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсгийг нэгдсэн нэг байдлаар хэрхэн ойлгох вэ? гэхэд

Шүүгч Ц.Цогт: Ерөнхий хуульд зохицуулалт нь байгаа аливаа хэрэг маргааны хувьд салбарын хуульд эрх зүйн харилцааг дээрдүүлсэн зохицуулалт байвал салбарын хуулиа хэрэглэнэ. Аль ч хуулинд ижил зохицуулалт байвал дуртайгаа хэрэглэж болно. Салбарын хуульд зохицуулалт байхгүй ерөнхий хуулиа баримтлана гэв.

Профессор П.Одгэрэл: Энэ зохицуулалтын агуулга нь салбарын хуулиар зохицуулагдаагүй хэсэгт ерөнхий хуулийг хэрэглэх гэсэн утгатай байгаа гэв.

“Эрх зүйн боловсрол” академийн захирал А.Энхтуяа: Энэ удаагийн ярилцлага эхний удаагийнх байлаа. Цаашид энэ үйл ажиллагаа үргэлжилнэ. Дараа дахиад уулзаж ярилцах боломж олдоно гэж бодож байна. Та бүхэн ярилцлагад идэвхтэй оролцож, санал бодлоо нээлттэй хуваалцсанд

баярлалаа. Захиргааны эрх зүйн хорооны гишүүд болон хүрэлцэн ирсэн та бүхэнд баярлалаа, ажилд нь амжилт хүсье гэв.

Ерөнхий шүүгч Д.Батбаатар: Дараагийн уулзалт, ярилцлагыг нарийвчилсан сэдвийн хүрээнд хийх хэрэгтэй юм байна гэснээр уулзалт, ярилцлага дуусав.

| | |
|---|---|
| Тэмдэглэл хөтөлсөн | Б.Адилмаа |
| Хянасан | Ц.Цогт |

## "ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ХЭРЭГЛЭЭ" СЭДЭВТ УУЛЗАЛТ-ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

2017.12.19 Улаанбаатар хот

Ханнс-Зайделийн сангийн сургалтын танхим

**А.Энхтуяа**: Ханнс-Зайделийн сангийн "Эрх зүйн боловсрол" академи, Монголын Хуульчдын холбооны Захиргааны эрх зүйн хороотой хамтран "Захиргааны ерөнхий хуулийн хэрэглээ" сэдэвт уулзалт-ярилцлагыг өнөөдөр зохион байгуулж байна.

Энэхүү уулзалт-ярилцлагад Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газрын тэргүүн, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Ц.Сарантуяа, Монголын Хуульчдын холбооны Захиргааны эрх зүйн хорооны удирдах зөвлөлийн гишүүд болох Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Ганзориг, доктор Д.Сүнжид, доктор П.Одгэрэл, доктор Ц.Цогт, Н.Мягмар, Т.Мөнх-Эрдэнэ нар болон Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчид хүрэлцэн ирж, оролцож байгаад баяртай байна.

Уулзалт-ярилцлагын гол зорилго нь Ханнс-Зайделийн сангийн "Эрх зүйн боловсрол" академи ирэх жилээс Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийхээр төлөвлөж байгаа. Энэ ажлын хүрээнд бэлтгэл ажил болгон эхний энэхүү уулзалт ярилцлагыг зохион байгуулж байгаа юм.

Ер нь Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлснээс хойш шүүхүүдэд хэрхэн яаж хэрэгжиж байгаа, хэрэглэхэд хүндрэл бэрхшээлтэй асуудал юу байна вэ гэдгийг ярилцах болно.

Хөтөлбөр ёсоор Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газрын тэргүүн, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Ц.Сарантуяа, Монголын Хуульчдын холбооны Захиргааны эрх зүйн хорооны удирдах зөвлөлийн гишүүд болох Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Ганзориг нар нээж үг хэлнэ. Дараа нь Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Ц.Цогт "Захиргааны хэргийн шүүхүүд дэх Захиргааны ерөнхий хуулийн хэрэглээ" сэдвээр, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч А.Сарангэрэл "Нийслэл дэх Захиргааны хэргийн шүүхэд Захиргааны ерөнхий хуулийг хэрэглэхэд гарч буй хүндрэл бэрхшээл, ямар асуудал тулгарч байгаа талаар мэдээлэл хийж, чөлөөтэй ярилцах байдлаар явна.

Ингээд Захиргааны ерөнхий хуулийг хэрэглэхэд тулгамдаж байгаа асуудлаар чөлөөтэй ярилцах байх гэж бодож байна.Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газрын тэргүүн, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Ц.Сарантуяа багшийг уулзалт ярилцлагыг нээхийг хүсье.

**Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газрын тэргүүн, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Ц.Сарантуяа**: Захиргааны ерөнхий хууль батлагдсанаас хойш 1 жил гарны дараа та бүхэнтэй уулзаж байгаадаа баяртай байна.

Ханнс-Зайделийн сан Захиргааны хэргийн шүүхтэй олон жил ойр ойрхон уулзаж, хамтарч ажиллаж байсан. Харин сүүлийн үед арай бага цугларч байна. Яагаад гэвэл захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагаа жигдэрч, төлөвшүүлэхээр бүгдээрээ завгүй явж байна.

Захиргааны ерөнхий хууль хэрэгжээд 1 жил гаруй хугацаа өнгөрсөн байна. Үүнээс өмнө захиргааны үйл ажиллагааг нэг мөр зохицуулсан эрх зүйн зохицуулалт байгаагүй учраас шинэ хуулийг баталсан.

Шинээр батлагдсан хуулийг захиргааны байгууллага хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд үнэлгээ өгөх, шүүгч нарт хуулийг хэрэглэхэд тулгарч буй хийдэл, давхцалтай асуудал юу байгаа талаар хоорондоо ярилцаад нэг мөр шийдвэрлэхэд үр дүнтэй уулзалт болно гэж бодож байна.

2015 онд Хууль тогтоомжийн тухай хууль шинэчлэн батлагдсан. Энэ хуулийн дагуу Монгол Улсын Их Хурал, Засгийн газар хуулийн хэрэгжилтийн талаарх хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх боломжтой болсон бөгөөд дээрх ажлыг хөндлөнгийн байгууллагуудаар хийлгэх боломжтой. Энэ ажлын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн яамтай хамтарч, яамны ажлын төлөвлөгөөнд оруулсны дагуу эхлэл болгон энэхүү уулзалтыг хийж байна.

Бидний зүгээс Хууль зүй, дотоод хэргийн яам ямар ажил хийхийг хараад суух нь учир дутагдалтай байгаа учраас Хууль зүй, дотоод хэргийн яам болон шүүхийн ажилд дэмжлэг үзүүлэх үүднээс эхлүүлж байя гэж бодож эхний ээлжинд уулзалт-ярилцлагыг Монголын Хуульчдын холбооны Захиргааны эрх зүйн хороотой хамтарч зохион байгуулахаар болсон. Хамтарч ажиллаж

Remove Watermark Now

байгаа Захиргааны эрх зүйн хороо болон уулзалт, ярилцлагад хүрэлцэн ирсэн захиргааны хэргийн шүүхийн шүүгч нарт баярлаж байна.

Мөн Захиргааны ерөнхий хуулийг боловсруулахад их хүчин зүтгэж, сэтгэл гарган ажилласан доктор П.Одгэрэл, доктор Ц.Цогт, Д.Ганзориг багш болон бусад судлаачид хүрэлцэн ирсэн явдалд баярлаж байна.

**Монголын Хуульчдын холбооны Захиргааны эрх зүйн хороо, Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Ганзориг**: Захиргааны хэргийн шүүхийн шүүгч, судлаач нар энэхүү уулзалт-ярилцлагад хүрэлцэн ирж уулзаж байгаадаа баяртай байна.

Юуны өмнө “Захиргааны ерөнхий хуулийн хэрэглээ”-ний асуудлаар хэлэлцүүлгийг зохион байгуулж байгаа Ханнс-Зайделийн сангийн “Эрх зүйн боловсрол” академ, Монголын Хуульчдын холбооны Захиргааны эрх зүйн хорооны бүрэлдэхүүнд талархлаа илэрхийлье.

Захиргааны ерөнхий хуулийн хэрэглээний асуудлаар ярих зүйл их байгаа, судлаач, шүүгч, шавь нартай ярилцаж байхад мэдэх, мэдэхгүй олон асуудал гарч байсан. Тийм ч учраас энэ бол эхлэл гэдгийг Ц.Сарантуяа багш бас хэллээ.

Өнөөдөр Захиргааны ерөнхий хуулийн ерөнхий хэрэглээний талаар ерөнхийлсөн байдлаар ярилцах байх гэж ойлгож байна. Цаашдаа тусгайлсан, тодорхой асуудлуудаар хэлэлцүүлэг зохион байгуулагдах байх, мэдээж зохион байгуулахад санхүү мөнгөний асуудал гарна. Гагцхүү хамгийн гол зүйл бол хуулийн хэрэгжилтийн талаарх бидний оролцоо чухал байгаа юм.

Захиргааны ерөнхий хууль бол Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлдэг хамгийн том хуулийн нэг, Захиргааны ерөнхий хууль мөрдөгдөж эхэлснээс хойш 1 жил 4 сарын хугацаа өнгөрсөн,хүүхдээр бол дөнгөж хөлд ороод алхдаг болж байна. Та бүхэн мэдэж байгаа байх анх хууль батлагдах үед багагүй хүндрэл, бэрхшээл байсан. Одоо тэр үед гарч байсан бэрхшээл заримдаа Захиргааны ерөнхий хуулийг эвдчих гээд байгаа юм сонсогдоод байгаа.

Жишээлбэл, Төв банкны тухай хуулийг хэлэлцэхэд Монголбанкийг Захиргааны ерөнхий хуулиас хасна гэдэг асуудал яригдаж, тогтоосон зарчим эвдэгдэх асуудал гарч байгаа юм. Мөн Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль батлагдсантай холбоотойгоор Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтад өөрчлөлт орж байх жишээтэй. Энэ мэтээр дөнгөж хөлд орж буй 1 ой 4 сартай хүүхдээ /Захиргааны ерөнхий хууль/ бид хамгаалж байхгүй бол болохгүй байгаад байна. Өнөөдөр яаж хамгаалах ёстой вэ гэдэг дээр ярилцах ёстой болов уу гэж бодож байна.

Хөдөө орон нутгуудаар явж байхад зарим захиргааны байгууллагууд Захиргааны ерөнхий хуулийг хэрэглэж байгаа, зарим нь хэрэглэхгүй байна. Засгийн газрын үндсэн үүрэг бол хуулийг биелүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих ёстой. Захиргааны ерөнхий хууль нэгэнт батлагдсан учраас захиргаа өөрийн хүсэл зоригоос үл хамаарч зайлшгүй биелүүлж таарна. Гагцхүү биелүүлэхдээ ямар байдлаар биелүүлж байгааг бас тусад нь ярих ёстой гэж бодож байгаа,

Захиргааны байгууллага дээр Захиргааны ерөнхий хуулийг хэрхэн хэрэгжүүлж байна вэ гэдэг дээр мониторингийн асуудлыг бас тавих нь зөв. Нөгөөтэйгүүр Захиргааны ерөнхий хуулийн хэрэглээ, төлөвшүүлэх асуудалд захиргааны байгууллага гэхээсээ илүүтэйгээр бид шүүгч нарт илүү их итгэж байгаа,

Тухайлбал, хуулийн ажлын хэсгийн гишүүд, УИХ, зарим эрдэмтэн судлаачдын дунд ойлгомжгүй, маргаантай байсан асуудлыг шүүх практикаараа зөв тайлбарлан хэрэглэх нь зөв гэсэн итгэл өндөр байсан. Эхний 1 жил 4 сард шүүхийн тайлбар, хэрэглээ зөв явсан байх гэж бодож байна.

Захиргааны хэргийн шүүхийн шүүгч нарт заах хичээлийн хөтөлбөрийг боловсруулж, Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлсэн. Үүнд захиргааны хэргийн шүүхийн гүйцэтгэх чиг үүргийн талаар тодорхой тусгагдсан.

Анх 2004 онд захиргааны хэргийн шүүх байгуулагдах үед бичиж байсан ном, сурах бичиг, Б.Чимид багшийн сургаалиудыг бид дахин дахин бодох ёстой юм байна гэж бодож байгаа, Захиргааны хэргийн шүүх захиргаатай харилцаж байх үндсэн зарчим нь юу вэ гэдгийг байнга бодож /санаж/байх ёстой. Захиргааны хэргийн шүүх тодорхой хэрэг маргааныг мэдээж хуулийг тайлбарлан шийдвэрлэнэ гэхдээ ерөнхий зарчмын зүйлүүдээ авч явах тухай асуудлууд байгаа, энэ асуудал дээр ирэх жилүүдэд бид гүнзгийрүүлсэн зүйлүүдийг ярилцах ёстой гэдэг санааг дэвшүүлж байна.

Ингээд олон зүйл ярьж болж байна. Гэхдээ цаг бага байгаа учраас энд хүрээд өндөрлөе. Та бүхэн Захиргааны ерөнхий хууль амьдралд зөв хэрэгжиж, хэрэгжүүлээд авч явах ганц хүмүүс та бүхэн учраас Захиргааны хэргийн шүүхийн шүүгч нар бол хамгийн том ачааг үүрч, та бүгдийн нуруун дээр том хариуцлага байгаа гэдгийг бодолцож өнөөдрийн хэлэлцүүлэгт анхаарлаа хандуулаасай гэж хүсэж байна.

**Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газрын тэргүүн, Хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Ц.Сарантуяа**: Ингээд Захиргааны хэргийн шүүхүүд дэх Захиргааны ерөнхий хуулийн хэрэглээний талаар Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Ц.Цогтын,

Захиргааны хэргийн шүүхэд Захиргааны ерөнхий хуулийг хэрэглэхэд гарч буй асуудлыг талаар Нийслэл дэх Захиргааны хэргийн шүүхийн шүүгч А.Сарангэрэлийн мэдээллийг тус тус сонсоё.

**Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Ц.Цогт мэдээллийг танилцуулав.**

**Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч А.Сарангэрэл мэдээллийг танилцуулав.**

**Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Ц.Цогт:** Мэдээллүүд танилцуулагдаж дууслаа. Цаг бага байгаа учраас дээрх мэдээлэлд дурдагдсан асуудал болон яригдаагүй зүйлийг тодруулаад ярилцаад явъя.

Өнөөдрийн хэлэлцүүлгийн хамгийн гол зорилго нь

1-рт Та бүгдээс гарч байгаа саналыг Захиргааны ерөнхий хуулийг батлах ажлын хэсгийн гишүүд болох доктор Д.Сүнжид, доктор П.Одгэрэл, Д.Ганзориг багш нар нэг бүрчлэн сонсож, цаашдаа Захиргааны ерөнхий хуулийн хэрэглээн дээр гарч байгаа асуудлуудыг судалж, цаашид хуулийг боловсронгуй болгох тал дээр ажиллах,

2-рт Эдгээр хүмүүсийн байгаа дээр өнөөдөр яригдаад байгаа эргэлзээтэй асуудлууд дээр санал бодлоо хуваалцах боломж байна.

Цаг бага байгаа учраас танилцуулсан мэдээлэлтэй холбоотойгоор лавшруулж, тодруулах байдлаар саналаа хэлэх байдлаар явъя.

**Доктор П.Одгэрэл**: Хуулийн хэрэглээтэй холбоотой санал хэлэх гэсэн юм. Санаа зовоож байгаа асуудлууд байна. Захиргааны ерөнхий хууль хэрэгжиж эхэлснээс хойш нилээд олон өөрчлөлт ороод яваад байна. Миний бодлоор Захиргааны ерөнхий хууль бол захиргааны хэргийн шүүхийн ажиллах орчин нь, захиргааны шийдвэр болгон дээр Захиргааны ерөнхий хууль хэрэглэдэг рам байгаа, энэ рам дээр салбар хуулиудын хуулиуд хэрэглэгддэг. Шүүхийн шийдвэр дээр заавал Захиргааны ерөнхий хуулийг хэрэглэхгүй ч гэсэн энэ хууль дээр захиргааны хэргийн шүүхийн үйл ажиллагаа явагдаж байгаа,

Захиргааны ерөнхий хуульд хамаагүй өөрчлөлт оруулах юм бол Захиргааны шүүхийн ажиллах механизм эвдэрнэ. Жишээлбэл, Захиргааны акт гэдэг ойлголтыг л эвдэхэд Захиргааны шүүх ажиллах боломжгүй болоод захиргааны байгууллага захиргаан хяналтаас гарч янз, янзын юм орж ирнэ. Цаад механизм зохицуулалтууд нь эргээд эхэлнэ. Үүний нэг жишээ гэвэл Зөрчлийн тухай хууль байна. Энэ хууль дээр акт гэдэг ойлголт нь 3-4 ороод ирсэн. Компанийн тухай хуулийг өөрчлөх гэж байна гээд Иргэний хуулийн “хэлцэл” гэдэг үгийг өөрчилчих юм бол хэлцэлтэй холбоотой Иргэний хуулийн суурь зохицуулалтууд чинь байхгүй болно. Тэгэхлээр энэ дээр манай шүүгч нарын оролцоо чухал бөгөөд хуулийн үзэл санаагаа шүүгч нар хамгаалж оролцох ёстой.

Зөрчлийн тухай хууль дээр акт гэдэг өөр ойлголт ороод орж байна гэдэг чинь нөгөө бидний өчнөөн олон жилийн сургалт, судалгаа, олон хүний хүч хөдөлмөрийн үр дүнд бий болсон Захиргааны ерөнхий хуулиар тогтчихсон, сонгодог ойлголтуудыг эвдээд, замбараагүй орж ирээд бүх юм өөрчлөгдөөд эхэллээ.

Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлд заасан акт гэдэг ойлголтыг хасчихвал захиргааны хэргийн шүүх ажиллах боломжгүй болно. Акт гэдгээр нь л бид захиргааны байгууллагын шийдвэр үндэслэлтэй эсэхийг хянана. Гэтэл акт гэдэг ойлголтыг хасаж байгаа үндэслэл нь Зөрчлийн тухай хууль, энэ хууль бол эрүүгийн чиглэлээр ороод ирсэн. Эрүү бол гэмт үйлдэлд л хяналт тавина. Зөрчлийн тухай хуулиар захиргааны хариуцлага бол ял шийтгэл гэдэг ойлголт /концевц/-оор ороод ирсэн. Харин захиргаа бол захиргааны үйл ажиллагаа хууль зүйн үндэслэлтэй эсэхэд хяналт тавина. Одоо ингээд эргээд харахаар салбарын хуулиудаас хамаараад Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт орох боломжтой болчхож байна. Тэгэхээр бид нар салбарын хуулиудын өөрчлөлт анхаарлаа хандуулахгүй бол болохгүй юм шиг байна. Салбарын хуулиуд дээр мэргэжилтнүүд ажиллаад явчихдаг, бараг хуульч нарын оролцоо байхгүй байгаад байна. Үүний нэг жишээ бол Зөрчлийн хууль, энэ хуулиар байцаагчийн акт бол шийтгэл, энэ нь бидний нөгөө Захиргааны ерөнхий хуульд заасан акт гэдэг ойлголтыг хасаад хаячихсан. Акт биш юм бол шүүх тэрийг илт хууль бусад тооцож, хүчингүй болгох уу?

Гэтэл татвар төлөгч ямар ч зөрчил хийгээгүй байхад зөрчил гээд акт гаргаад явчихдаг. Энэ нь юу гэж байна вэ гэхээр акт гэдэг ойлголтыг хассанаас болж захиргааны хэргийн шүүхийн хяналтаас гараад, алдагдаад явж байна. Тэгэхээр бид нар яг ийм салбарын хууль дээр анхаарлаа хандуулахгүй бол 1-рт Захиргааны ерөнхий хуулийг эвдэж байна, 2-рт Захиргааны хэргийн шүүхийг хийх ажилгүй болгож байна. Зөрчлийн тухай хууль гарсантай холбоотойгоор одоо бараг захиргааны хэргийн шүүх дээр төрийн албанаас өөр маргаан бараг байхгүй болж байна.

Би саяхан Татварын ерөнхий газар дээр хичээл зааж байхад зөрчил гэдэг бол ял гэж ойлгоод явж байна. Захиргааны хариуцлага гэдэг бол ял биш ш дээ. Энэ бол захиргаа сонгож хэрэглэдэг зүйл. Өөрөөр хэлбэл стандарт зөрчиж барилга барьчихлаа, энэ тохиолдолд байцаагч орж ирээд сануулаад, хугацаатай үүрэг өгөөд засуулаад торгох эсэхээ шийдээд явж байгаа нь ямар нэгэн байдлаар эрүүтэй холбоогүй асуудал. Энэ үр дагавар нь захиргааны хэргийн шүүхийн оршин тогтнох эсэхтэй холбоотой асуудал болчхоод байна. Захиргааны акт гэдэг ойлголтыг ямар ч онолын ойлголтгүйгээр өөрчилчихсөн. Иргэний хуулийн “хэлцэл” гэдэг ойлголтыг л өөрчилвөл иргэний эрх зүйн харилцаа хэрэгжихгүй, нөгөө 2000 жил явсан онол, номлол байхгүй болно. Яг үүнтэй адилхан захиргааны акт гэдэг ойлголтыг өөрчилчихвөл бидний сурсан мэдсэн, гаргасан зүйлүүд өөрчлөгдөнө.



Remove Watermark Now

Remove Watermark Now

Тэгэхээр энэ салбарын хуулийг яах вэ? үүний үндэс нь Зөрчлийн тухай хууль, энэ хуулиар салбарын 200 гаран хуулийг бариад авчихсан. Шүүхийн шийдвэр бүгдээрээ салбарын хуулийг үндэслэж гардаг. Энэ хуулиуд чинь явчих юм бол захиргааны хэргийн шүүх байхгүй болно шүү. Тэгэхээр бид нар энэ дээр анхаарлаа хандуулах ёстой. Судлаач бид нар ч гэсэн энэ талаар хэлж байгаа боловч хүлээж авахгүй байна. Харин шүүгч нар та бүхэн Зөрчлийн тухай хуулийг Үндсэн хуулийн цэцэд өгчихвөл зүгээр байгаа юм.

Сая танилцуулагдсан Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6 бол Үндсэн хуулийн заалт, өөрөөр хэлбэл Үндсэн хуулиар хүний өмчид зөвхөн хуульд заасан үндэслэлээр халдана, хүний эрх, эрх чөлөөг зөвхөн хуульд заасан үндэслэлээр хязгаарлана гээд заасан. Хуульд заагаагүй л бол хүний өмчид, хүний эрх, эрх чөлөөнд халдаж болохгүй гэсэн үзэл санаа юм. Тэрнээс биш энэ заалт чинь эрх хэмжээтэй холбоотой заалт биш, гэтэл Зөрчлийн хуулийн санкцууд журам, стандарт /дотроо 300-400 зохицуулалттай/ зөрчих л юм бол заавал торгоно, зөрчил болгон шийтгэлтэй гээд ороод ирчихсэн. Энэ байдал нь Үндсэн хуультай зөрчилдөж байгаа. Энэ асуудлаар бид Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргая гэхээр айгаад байна. 1-рт Бидний эрхийн асуудал, 2-рт Том улс төрийн асуудал. Зөрчлийн тухай хууль бол шууд УИХ-аар ороод батлагдчихсан. Аль ч намын эрх барьж байх үед Зөрчлийн тухай хуулийг Тэмүүжин, Эрдэнэбат нараас илүү мундаг болсон хуульч нар яриад УИХ орж байхад Лүндээжанцан, Баасанхүү, Ц.Нямдорж нар эсэргүүцээд дийлээгүй, бодлогоор ингэж оруулж ирсэн. Тэгэхээр манай шүүгч нар салбарын хуулиуд дээр болгоомжтой хандаж, анхаарал хандуулах хэрэгтэй байна. Тэгэхгүй бол татварын маргаан бол захиргааны хэргийн шүүхийн хяналтаас гараад, шийтгэврээр торгоод эхэлсэн. Одоо бол татварын байцаагчийн акт захиргааны акт гэдэг ойлголтоос гараад явчихсан. Ийм замаар татвартай холбоотой маргаан захиргааны хэргийн шүүх дээр орж ирэхгүй болчихсон.

Ийм замбараагүй нөхцөл байдлыг үүсгээд байна. Зөрчлийн тухай хууль ихээхэн үр дагавартай болчхоод байна. Иймд дээд шүүх хууль хэрэглээний талаар Үндсэн хуулийн цэцэд хандах боломжтой. Энэ байдлыг ашиглаад шүүгч нар ярьж байгаад нэгдмэл байдлаар саналаа Дээд шүүхэд гаргаж, Зөрчлийн тухай хуулиар Үндсэн хуулийн цэцэд хандвал их зүгээр байна. Тэрнээс биш бидэн шиг нэг судлаач хэлэхээр хүлээж авахгүй байна. Харин Дээд шүүх хандах юм бол бас нэг юм бодно, арай өөр байна байх

**Шүүгч Ц.Цогт:** П.Одгэрэл багш нилээн том, өргөн хүрээний асуудлыг хөндөж ярилаа. Тэгэхээр бид нарын санаа зовж байгаа захиргааны ерөнхий хуулийг эвдэх асуудал дээр санаа зовж байгаа зүйлүүд дээр нэг л байгаа, өөрөөр хэлбэл захиргааны ерөнхий хуулийг эвдэх асуудал нь эргээд ямар үр дагавар үүсгэж байгааг ярьж байна. Шүүх шийдэх юмаа авч үлдэх гээд байгаа юм биш, бид олон хэрэгтэй байхыг хүсээд байгаадаа биш, гол нь шүүхийн зорилго бол хүний эрхийг сэргээн тогтоох боломжтой байх ёстой. Тэгж байж гүйцэтгэх засаглал байх ёстой гэдэг агуулгаар яриад байгаа.

Тийм ч учраас анхан шатны шүүх, давж заалдах шатны шүүх шиг хэрэглэж байгаа хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах талаар нэмэлт санал гаргах эрхгүй гээд Монгол Улсын Шүүхийн тухай хуульд орсон. Давж заалдах болон хяналтын шатны шүүх хийх ажил боловч, анхан шатны шүүхийн хийх нэг ажил бол салбарын хуулиудад санал авахаар орж ирэх үед нь тухайн салбарын /газар, төрийн алба г.м/ хуулийн дотор зүйл рүү нь гэхээсээ илүүтэйгээр саяны ярьдаг ерөнхий хуулийн зарчим, үзэл баримтлал руу орж өөрчлөлт хийх гээд байгаа юмыг үндсэнд хааж, өөрчлүүлэхгүй байх талаар саналуудаа сайн өгч байвал сайн байна.

П.Одгэрэл багшийн саяын хэлсэн хуульд санал өгөх боломж нь давж заалдах болон хяналтын шатны шүүхэд илүү эрх байгаа. Шүүхийн ерөнхий зөвлөл хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргах эрхтэй болсон учраас хэрэглэж байгаа хуульд асуудал байвал Шүүхийн ерөнхий зөвлөлөөр дамжуулаад санал өгөх боломж байгаа, нөгөө нэг зүйл нь шууд дээд шатны шүүхэд хүсэлтээ гаргаад, дээд шатны шүүх нь зөвшөөрөх юм бол нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлц, дүгнэлтээ Үндсэн хуулийн цэц рүү хандах боломжтой.

Доктор П.Одгэрэл багшид баярлалаа. Манай шүүгч нарт түрүүний ярьсан зүйл дээр нэмээд саналаа хэлэх үү, Захиргааны ерөнхий хуулийг хэрэглэхэд ямар асуудал байна вэ? Цаг бага байгаа учраас точны хэлээд тэмдэглэлд тусгуулаад явья.

**Шүүгч Д.Халиуна**: Захиргааны ерөнхий хуулийн Захиргааны байгууллагын шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаатай холбоотой санал байна.

Захиргааны байгууллагын гаргасан шийдвэрийг биелүүлэхийг даалгах шаардлага бүхий нэхэмжлэлийг захиргааны хэргийн шүүхийн харьяаллын бус гэжд шууд хүлээн авахаас татгалзах үндэслэл болж өгөхгүй, хэрэг үүсгээд явахаар зөвхөн даалгах нэхэмжлэлийн шаардлагыг хэлэлцэх бөгөөд захиргааны байгууллагын гаргасан шийдвэрийн үндэслэл рүү орох шаардлага байхгүй.

Шийдвэрийн үндэслэл рүү орох гэж байгаа бол Захиргааны байгууллага өөрөө Захиргааны ерөнхий хуульд заасан шийдвэр гүйцэтгэлийн журмаар өөрөө хариуцаад биелүүлээд явах асуудал. Гэтэл захиргааны байгууллагын энэ шийдвэрийг биелүүлэхийг даалгах нэхэмжлэлийн шаардлагын хувьд шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг хянан уу? хянахгүй юу? зөвхөн даалгах шаардлагын хүрээнд шийдэх эсэх нь асуудал үүсгээд байна. Тэгэхээр захиргааны шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа, захиргааны хэргийн шүүх дээрх энэ асуудлыг шийдвэрлэх ажиллагаа 2-ын зааг ялгааг гаргаж ирж чадахгүй асуудал үүсгээд байна.

Remove Watermark Now

Тухайлбал, Төрийн албаны зөвлөлийн шийдвэрээр ажилд нь томилж шийдчихээд байхад захиргааны байгууллага Төрийн албаны зөвлөлийн шийдвэрийг биелүүлэхгүй байна гээд Төрийн албаны зөвлөлийн шийдвэрийг биелүүлэхийг даалгаж өгнө үү гэдэг нэхэмжлэлийн шаардлага гаргаад байна. Тэгээд шүүх хэрэг үүсгээд шалгах гэхээр бүхэл үндэслэл рүү нь орж шалгах болчхоод байдаг, гэтэл нэхэмжлэгчийн хүсэл зориг бол Төрийн албаны зөвлөлийн шийдвэр үндэслэлтэй эсэхийг шалгах шаардлагагүй, гагцхүү даалгах шаардлагын хүрээнд шууд даалгаад өгөөч гэдэг. Тэгвэл Төрийн албаны зөвлөл өөрийнхөө гаргасан /ажилд нь томилсон/ шийдвэрийг хангуулах ёстой гээд Захиргааны ерөнхий хуульд заасан. Гэтэл шүүх төрийн албаны зөвлөл өөрийнхөө гаргасан шийдвэрийг Захиргааны ерөнхий хуульд заасан захиргааны шийдвэр гүйцэтгэлийн журмаар хангуулах ёстой. Захиргааны хэргийн шүүхийн харьяаллын биш, нөгөөх нь Төрийн албаны зөвлөлийн шийдвэрийг биелүүлэхгүй байгаа эс үйлдэхүйтэй холбогдуулаад нэхэмжлэл гаргаад шүүх дээр зэрэгцээд яваад байна. Энэ хүрээ хязгаарын ялгаа заагийг яаж тогтоох вэ?

**Шүүгч Ц.Цогт**: Тийм асуудал байгаа, ярих цаг бага байгаа учраас саналуудаа сонсоод явчихья,

**Шүүгч Д.Оюумаа**: Захиргааны ерөнхий хуулийг үндэслэх хэсэгтээ тусгаад тогтоох хэсэгт заавал баримтлах хэрэгтэй юу?

**Шүүгч Ц.Цогт**: Би өнөөдрийн уулзалт-ярилцлагад давж заалдах шатны шүүхийн шүүгч гэдгээр биш, Захиргааны эрх зүйн хорооны гишүүний хувьд оролцож байгаа, ер нь зарчмын хувьд шүүгч шийдвэрийнхээ үндэслэх хэсэгт хэрэглэж шийдвэрлэж байгаа л бол тогтоох хэсэгт оруулах л ёстой.

**Шүүгч Г.Мөнхтулга**: Захиргааны ерөнхий хуулийн 100 дугаар зүйлд Захиргааны байгууллагын үйл ажиллагаанаас учирсан хохирол барагдуулах зохицуулалт байгаа. Энэ талаар нэг төрийн албаны маргаан гарсан. Нэхэмжлэгч сангийн сайд н.Чойжилсүрэн гэдэг хүн намайг ажлаас халсан учраас тэр хүнээс нь ажилгүй байсан хугацааны цалинг гаргуулах шаардлага гаргадаг, зүй нь бол зөв юм шиг байгаа юм. Хамгийн гол нь энэ асуудлыг аудитын байгууллага хөөцөлдөх ёстой байдаг. Гэтэл Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.3-д хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар төлүүлэх үүргийг аудитын байгууллага хариуцна, 103.4-д шүүх хохирлыг буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр гаргасан шийдвэрийг холбогдох аудитын байгууллагад хүргүүлнэ гэж байна.

тэгэхээр төрийн албатай холбоотой маргаан дээр ажлаас үндэслэлгүйгээр халсан хохирлыг байгууллага л нөхөж гаргаад байгаа, гэтэл буруутай албан тушаалтан ард нь үлдчихээд байгаа, үүний хойноос аудитын байгууллага явж байгаа тохиолдол одоо болтол байхгүй байна. Тэгэхээр Захиргааны ерөнхий хуулийн энэ заалтын хүрээнд шүүх гаргасан шийдвэрийнхээ биелэлтийг хариуцна гэдгээрээ төрийн албатай холбоотой маргааныг шийдвэрлэсэн шийдвэрүүдээ аудитын байгууллага руу хүргүүлээд байвал яах вэ? Тэгвэл аудит бас бид нар хуулиараа хийх ёстой юм байна гээд хэрэглэж эхлэх байх, тэгэхгүй бол Захиргааны ерөнхий хуулийн 103.4 бол ямар нэгэн байдлаар хэрэгжихгүй байна. бид санаачлагаараа хуулиа хэрэгжүүлэх үүднээс санаачлагаараа ямар нэгэн юм хийхгүй бол 1 жилийн хугацаа өнгөрсөн боловч аудитын байгууллага ямар нэгэн юм хийхгүй байна.

**Шүүгч Д.Халиуна:** Ер нь хүчин төгөлдөр болсон шийдвэрүүдээ Захиргааны ерөнхий хуулийн дээрх заалтыг нь дурдаад Төрийн албаны зөвлөл, Аудитын газарт хүргүүлээд хэвшчихвэл зүгээр юм уу.

**Шүүгч Ц.Цогт**: Энэ асуудал нь байгууллага хоорондын асуудал юм биш үү. Аудитын байгууллага хэрэгжүүлэхгүй байна гээд шүүх санаа зовох нь хэр зохистой юм. Ер нь зарчмын хувьд шүүгч гаргасан шийдвэрийнхээ биелэлтийг хангуулна гэж байгаа ч шууд ингээд явах нь хэр зохистой юм. Гагцхүү захиргааны аргаар явна уу гэхээс биш өөрөөр бол ач холбогдол өгөх нь шүүхийн үүрэг зорилготой чухам хэр нийцэж байгаа вэ, мэдээж бид хуулийг хэрэгжүүлэхийг бодож, зорьж байгаа. Өөр ямар санал байна вэ?

**Шүүгч Н.Долгорсүрэн**: Талууд захиргааны акт, үйл ажиллагаатай маргаж, хэдэн үндэслэл хэлээд маргаад байхад шүүх захиргааны актыг бүхэлд нь хянаад Захиргааны ерөнхий хуулийн зарчмуудыг хэрэгжүүлсэн эсэх, процессын болон материаллаг хуулийн захиргааны актын формаль шаардлага хангаж байгаа эсэхийг бүхэлд нь хянах гэхээр диспозитив зарчим алдагдаад байна бидний тавьж буй үндэслэлийн хүрээнд явна та маргаагүй зүйл рүү орох шаардлагагүй гээд байдаг. Тэгэхээр давах болон дээд шүүх хэргийг бүхэлд нь хянадаг шүүх захиргааны актын маргахгүй байгаа үндэслэлийг ч гэсэн бүхэлд нь хянаад явбал буруудах биз дээ.

2-рт Нэхэмжлэлийн шаардлагуудыг хараад байхад хүчингүй болгуулах, даалгах, тогтоох шаардлага л гаргаад байгаа харагдаад байгаа, аль ч шаардлага хангагдаж байгаа тохиолдолд нэхэмжлэгч хүн, хуулийн этгээдийн ямар эрх ашиг сонирхол зөрчигдсөн, энэ нь яаж нотлогдож байна, нэхэмжлэлийн шаардлага хангагдсанаар эрх нь яаж сэргээгдэх гээд байгаа гэдгийг бодох ёстой юм шиг байгаа юм. Гэтэл тогтоох нэхэмжлэлийн шаардлага дээр заримдаа

сүүлийн үед даалгах нэхэмжлэлийн шаардлагатай холбоотойгоор ашигт малтмалтай хэрэг дээр түрүүлж өргөдөл гаргасан болохыг тогтоож өгөөч гэдэг, тэгээд үйл баримтыг шалгахаар яах аргагүй түрүүлээд өргөдөл гаргасан нь тогтоогдоод, хариуцагч ч зөвшөөрөөд байдаг. Гэтэл энэ үйл

баримтыг тогтоочихлоо, гэтэл дараагийн олон үр дагаврууд болох татгалзсан шийдвэртэй маргахгүй байхаар шүүхээс түрүүлж өргөдөл гаргасан болохыг тогтоогдсоны үр дагаар байхгүй болчхоод байгаа юм

**Шүүгч Ц.Цогт**: Наадах чинь процесс тал руу нилээд ороод байна. Захиргааны ерөнхий хууль дээрх юмаа л нилээд яримаар байна. Нэхэмжлэлийн шаардлагын төрлийн асуудлаар Захиргааны эрх зүйн хороон дээр Т.Мөнх-Эрдэнэ бид нар ярьж байгаад нэхэмжлэлийн шаардлагын төрлийн талаар судалсан хүмүүсийг нь оролцуулаад тусад нь шүүгч нарт сургалт явуулбал илүү хэрэгтэй байх,

Эхний асуудал буюу шүүх захиргааны актын үндэслэлийг хянах цар хүрээг ямар байх вэ? Нэхэмжлэгчийн шүүхэд маргаагүй үндэслэл шүүх шалгах явцад илэрвэл шүүхийн эрх хэмжээ ямар хүрээнд хязгаарлагдах тал дээр доктор П.Одгэрэл багшид санал байна уу?

**Доктор П.Одгэрэл**: Миний бодлоор шүүх захиргааны актыг бүхэлд нь хянах ёстой. Ямар ч эрх зүйн зөрчил гаргасан бай хянах л ёстой. Түүнээс биш нэхэмжлэгчийн дурдаагүй үндэслэл гээд татгалзах, хязгаарлагдах боломжгүй гэж үзэж байна. Тэр байтугай шүүх хүчин төгөлдөр бус нэхэмжлэлийн шаардлагыг хянах явцад илт хууль бус байх үндэслэл гарвал захиргааны актыг илт хууль бус болохыг тогтоож шийдвэр гаргах ёстой гэж ойлгож байна.

**Шүүгч Ц.Цогт**: Захиргааны ерөнхий хуультай холбоотой саналаа хэлье. Хэтэрхий процессын асуудал яригдаад байгаа учраас энэ асуудлаа тусад нь ярья.

**Шүүгч Л.Өлзийжаргал**: Илт хууль бус дотор хүчингүй нь байх уу, хүчингүй дотор илт хууль бус нь байхуу гэдэг л хамгийн түрүүний асуудал болоод байна.

**Шүүгч Ц.Цогт**: Энэ удаад процессын юмаа болье.

**Шүүгч Л.Өлзийжаргал:** Сонсох ажиллагааны талаар санал байна. Ямар тохиолдолд сонсох ажиллагааг хэрэглэсэн гэж үзэх вэ?

Жишээлбэл. Сонгуулийн маргаан дээр шийдвэрээ гардуулсан боловч сонсох ажиллагаа хийгдээгүй гээд маргаж байгаа, тэгэхээр сонсох ажиллагааны хүрээ хязгаар ойлгомжгүй байгаа, мөн сонсох ажиллагааны талаар шат шатны шүүхийн шүүгч нар өөр өөр ойлголттой байгаа учраа асуудал үүсээд байна.

2-рт Төрийн байгууллага хооронд гарсан асуудалд шүүх дундуур нь орж, тэг, ингэ гэж болохгүй байна. Жишээлбэл, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан хэм хэмжээний актыг бүртгэх боломжгүй, хүчингүй болго гээд Хууль зүйн сайд дүгнэлт гаргачихаад байхад зөвшөөрөхгүй бол хуулиараа 10 хоногийн дотор Засгийн газарт очих ёстой. Гэтэл энэ дээр нэг асуудал үүсээд байна. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан шийдвэрийг Засгийн газар хүчингүй болгох зохицуулалт /эрх/ байхгүй. Энэ ямар зохицуулалтаар явах вэ?

**Шүүгч М.Батзориг**: Бодьтой кэйс дээр ярьвал илүү үр дүнтэй юм шиг байна. Жишээлбэл, Төрийн албаны тухай хуульд төрийн жинхэнэ албан хаагчийг сэлгэн ажиллуулах, шилжүүлэх ажиллуулах гэсэн 2 ялгаатай зохицуулалт байгаа,

Нийгмийн даатгалын ерөнхий газарт ажиллаж байсан төрийн жинхэнэ албан хаагчийг Дундговь аймаг дахь Нийгмийн даатгалын хэлтэст шилжүүлсэн байгаа юм. Төрийн албаны тухай хуульд бол тухайн байгууллагын удирдлага төрийн албан хаагчтай зөвшилцсөний үндсэн дээр гэж байгаа боловч энэ ажиллагаа огт хийгдээгүй. Энэ тохиолдолд захиргааны гаргасан акт /тушаал/-ыг Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6-д зааснаар илт хууль бусад тооцож болох уу?

Нөгөө жишээ нь газрыг албадан чөлөөлсөн. Ингэхдээ Газрын тухай хуульд зааснаар мэдэгдэх ёстой. Гэтэл мэдэгдэх ажиллагааг огт хийхгүйгээр газрыг албадан чөлөөлсөн ажиллагааг Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6-д зааснаар илт хууль бусад тооцож болох уу?

Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6 ойлгомжгүй байна.

Мөн улс төрийн шийдвэр гаргах ажиллагаа нь Захиргааны ерөнхий хуульд хамаарахгүй гэж байгаа. Жишээ: дүүргийн намаас Засаг даргад нэр дэвшүүлснийг дүүргийн хурал хэлэлцээд дээд шатны засаг дарга буюу Нийслэлийн Засаг дарга томилохоос татгалзсан. Энэ нь манай шүүхийн харьяалал маргаан, улс төрийн шийдвэр гаргах ажиллагаа мөн үү?

**Шүүгч Ц.Цогт**: Хэн маргаж байгаагаас шалтгаална. Тодорхой хэрэг дээр тодорхой хариулт өгөх нь өөрөө асуудалтай. Ер нь бол илт хууль бус гэдэг бол онолын хувьд манай хуульд заагдсан хэмжээгээр хязгаарлагдах ёстой. Миний бодлоор сонсох ажиллагаа хийгдээгүй гэдэг ч юм уу процессын зөрчил нь илүү хүчингүй болгуулах шаардлагын нөхцөл рүүгээ орох байх,

**Доктор П.Одгэрэл**: Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6 бол Үндсэн хуулийн заалт, Үндсэн хуульд өмчлөх эрхэд зөвхөн хуульд заасан үндэслэлээр л халдана, ерөнхий санаа нь хүний эрх, чөлөөг хуульд заасан үндэслэлээр хязгаарлана.

Үндсэн хуулийн хуульд заасан үндэслэл гэж яг юуг хэлээд байна вэ гэхээр жишээ нь: газар эзэмших эрхийг хүчингүй болгох үндэслэлүүдийг хуульд заасан. Тэдгээр үндэслэлээр л газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох яг л хуульд заасан үндэслэл, төрийн албанаас халах хуульд заасан үндэслэл л байх ёстой. М.Батзориг шүүгчийн хэлсэн төрийн жинхэнэ албан хаагчийг шилжүүлж байгаа тохиолдолд Төрийн албаны тухай хуульд яг ямар тохиолдолд шилжүүлэх, ямар тохиолдлыг сэлгэх талаар тодорхой заасан байгаа нь л хуульд заасан үндэслэл. Хуульд заагаагүй л

Remove Watermark Now

бол хүний эрхэд халдахгүй. Захиргааны акт дээр тухайн үндэслэлийг дурдаагүй, хуулийг баримтлаагүй бол маш илэрхий, Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6-д заасан хуульд заасан үндэслэл байгаагүй гэдэгт хамаарна.

**Шүүгч Н.Дуламсүрэн**: Захиргааны акт дээр заасан бол яах юм бэ?

**Шүүгч Д.Халиуна**: Барьсан байгаад хэрэглэх үү үгүй гэдэг бол өөр асуудал, баримтлаагүй нь л илт хууль бус

**Доктор П.Одгэрэл**: Хууль хэрэглээний асуудал бол өөр, процессын заалт бол илт хууль бус руу орохгүй.

**Шүүгч Ц.Цогт**: Өөр санал байна уу?

**Шүүгч Л.Батбаатар**: Захиргааны ерөнхий хууль дахь захиргааны хэргийн шүүхийн үүрэг бол энэ хуулийг нэг мөр хэрэгжүүлэх байгаа, практик дээр нэхэмжлэгч нар Захиргааны ерөнхий хуулийн сонсох ажиллагааг хэрэгжүүлээгүй байна хүчингүй болгож өгөөч гээд маргаад байна. Үүнийг нэг хэсэг бид шийдвэр дээрээ сайн тусгаад хүчингүй болгох үндэслэлтэй гээд шийдсэн. Гэтэл давах болон дээд шүүх акт агуулгын хувьд зөрчилгүй байна гэдэг үйл баримтад дүгнэлт хийгээд нөгөө сонсох ажиллагаа хийгдээгүй процесс ажиллагааг үгүйсгээд байгаа байдал байна. Үүнийг хариуцагч байгууллагууд ашиглаад сүүлдээ яаж байна гэхээр сонсох ажиллагааг хаяад, акт зорилгодоо нийцсэн гээд тайлбар тавиад байдаг болсон. Шүүх Захиргааны ерөнхий хуулийг төлөвшүүлэх юм бол өөрсдөө эхлээд хуулийн талаар нэг мөр нэгдсэн ойлголттой болоод, шийдвэртээ байнга тусгаж, хэрэглэж байж, захиргааны байгууллагуудаа төлөвшүүлэх ёстой юм уу? Эсхүл цаг хугацаагаар нь 5, 6 жилийн дараа аяндаа тогтоно гээд явах юм уу энэ тал дээр Захиргааны эрх зүйн хороо цаашид анхаарчээ гэж хэлмээр байна.

**Шүүгч Ц.Цогт**: Ойлголоо. Зарчмын хувьд бид эхний ээлжинд Захиргааны ерөнхий хуулийг хэрэглээнд оруулахын төлөө байгаа гэдгийг ойлгох хэрэгтэй. Тийм ч учраас анхан шатны шүүх хэрэглээнд ороод ирсэн юмыг хэрэглэх ёсгүй юм байна гэдэг тал руу аль болох явахгүй байх хэрэгтэй. Гэхдээ дан ганц процессын зөрчлүүдийг үндэслэж захиргааны актыг хүчингүй болгох үндэслэл болохгоход зовлонтой асуудлууд байгаа. Энэ бол тухайн хэргийн нөхцөл байдлаас ихээхэн хамаарна. Хэрвээ процессын зөрчлүүдийг хангаагүйгээс болоод захиргааны акт агуулгын хувьд авах юм байхгүй эрхийн зөрчилтэй, эсхүл дан ганц процессын зөрчилтэй боловч шийдвэр өөрөө агуулгын хувьдточны гарах ёстой. Энэ байдалд тухайн хэргийнхээ ньюансыг л харах хэрэгтэй.

Хуульд өөрчлөлт оруулах ч бай, практик тогтоох ч бай тодорхой хэмжээнд хэргийн шийдлүүд гарч ирж байх ёстой. Тэгэхгүй өнөөдөр 2 өөрөөр шийдчихлээ гээд дээд шүүх шууд кэйс, жишиг тогтоогоод 2 тийш нь хагалаад өгөөч гэдэггүй юм байна.

Ялангуяа шинэ хууль гараад удаагүй 1 жил гарны хугацаа өнгөрсөн байхад шууд кэйс, жишиг тогтоож болохгүй, тодорхой хэмжээнд хугацаа шаардлагатай.

**Доктор П.Одгэрэл**: Саяын хэлж байгаа процедурын алдаа бол мэдээж хүчингүй болгох үндэслэл дээр яригдах ёстой. Процессын алдаа нь бусад этгээдийн хууль ёсны эрх ашгийг зөрчсөн, хуулийн шаардлагыг зөрчсөн бол хүчингүй болно, хүчингүй болгох 48.2.5 дахь заалттай сайн холбож авч үзэх ёстой.

**Шүүгч Ц.Цогт**: Өөр санал байна уу?

**Шүүгч С.Төмөрбат**: Улс төрийн шийдвэр гаргах гэдэг дээр санал байна. Улсын Их Хурлаас гарч байгаа тогтоолыг улс төрийн шийдвэр гэдгээс яаж зааглах вэ? УИХ-ын тогтоолоор томилогдож, чөлөөлөгддөг төрийн жинхэнэ албан хаагч нар нь Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйл дээр заасан тусгайлан заасан эсхүл улс төрийн шийдвэр үү.

**Шүүгч Ц.Цогт:** Хууль тогтоох, гүйцэтгэх, зарим гүйцэтгэх эрх мэдлийн гэсэн байгууллага зарим тохиолдолд, маш ховор улс төрийн шийдвэр гаргаж байгаа,

Улс төрийн шийдвэр гэдгийг Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйл дээр тодорхой заасан. Энэ тохиолдолд хэн нэхэмжлэл гаргаж байгаагаас шалтгаалж захиргааны үйл ажиллагаа болох уу? Улс төрийн шийдвэр гаргах ажиллагаа болох уу гэдэг хамаарна.

Томилогдож байгаа этгээд нь процесс ажиллагаа зөрчигдсөн /хүчинтэй ирцээр шийдсэн эсэх, хүчинтэй хугацааны хувьд хэлэлцэх асуудалд оруулсан эсэх/ гэдэг үндэслэлээр л маргах боломжтой. Тэрнээс бид УИХ-ын гишүүдийн хүнийг томилно, томилохгүй гэдэг саналыг шүүхгүй.

Зөвхөн улс төрийн байгууллага тухайн шийдвэрийг гаргасан нь өөрөө улс төрийн шийдвэр гэж тооцох үндэслэл болохгүй гэж тайлбарласан байгаа. УИХ өөрөө улс төрийн байгууллага мөн, гагцхүү УИХ-аас гаргасан шийдвэр болгон улс төрийн шийдвэр гэсэн үг биш, гэхдээ болгоомжтой хандаж, шүүх аль хүртэл хэмжээнд дүгнэлт хийх ёстой гэдгээ бодохгүй бол Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийг Үндсэн хуулийн цэцэд өгсөн байгаа.

**Шүүгч Д.Халиуна**: УИХ-аас гарч байгаа ихэнх шийдвэр нь улс төрийн шийдвэр гаргах ажиллагаа болоод байгаа, Жишээ нь Төрийн нарийн бичгийн даргыг томилох нь нийтийн эрх зүйн асуудал, гэтэл тэрийг өөрсдөө улс төрийн шийдвэр гаргах ажиллагаа гэж ойлгоод би хэнийг тавих нь миний эрх гээд тусдаа хуулиар зохицуулсан юм яриад өөрсдөө ялгахгүй байгаа юм чинь шүүх тэрийг нь ялгаж, зохицуулж өгөх хэрэгтэй байх,

**Доктор П.Одгэрэл**: Улс төрийн шийдвэр нь эрх зүйн шийдвэрээс юугаараа ялгаатай вэ гэхээр улс төрийн хариуцлага тооцдогт л байгаа, өөрөөр хэлбэл мөрийн хөтөлбөр биелүүлээгүй

Remove Watermark Now

гээд эрх зүйн хариуцлага тооцдоггүй, гагцхүү улс төрийн хариуцлага тооцдог байх, тэр томилгоонууд процедураас гадна ажилласан жил, туршлага, Монгол улсын иргэн байх гэх мэт хуулийн шаардлага тавьж байгаа учраас улс төрийн шийдвэр гаргах ажиллагаа биш, захиргааны хэргийн шүүх хяналтад орох ёстой.

**Шүүгч М.Батзориг**: Дэд сайд улс төрийн албан тушаалтан. Энэ асуудал манай харьяаллын асуудал биш байж болох уу?

**Доктор П.Одгэрэл:** Дэд сайдаар тэгвэл гадаад улсын иргэнийг томилчвол Төрийн албаны тухай хуулийн зөрчил мөн биз дээ, тийм учраас улс төрийн шийдвэр гаргах ажиллагаанд хамаарахгүй, захиргааны хэргийн шүүхийн хяналтад байх ёстой.

**Шүүгч Ц.Цогт:** Улс төрийн шийдвэр гаргах ажиллагаатай холбоотой тухайн үед шүүхийн практикт маргаан дагуулсан асуудлыг үзэж харж байгаад оруулсан.

Засгийн газрын 2 гишүүнийг Ерөнхий сайд нь эвсэл байгуулж орчихоод эвслээ тараачихаар нь хөндлөнгөөс орж ирсэн Эрдэнэбат, Эрдэнэбаатар 2-ыг Элбэгдорж Ерөнхий сайд байхдаа УИХ руу бичиг оруулсан нь тэр үед захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргахад бид тухайн үед юугаа ч мэдэхгүй, хүлээж аваад явсан нь бөөн асуудал үүсгэсэн. Энэ л яг улс төрийн шийдвэр гаргах ажиллагаа юм.

Ерөнхий сайд танхимынхаа гишүүнийг томилох, томилохгүй, огцруулах, огцруулахгүй асуудал нь ямар ч хуулийн хязгаарлалт байхгүй тул өөрөөр хэлбэл тэр хүнд хамгаалагдах хуулийн эрх байхгүй. Цэвэр улс төрийн үзэмжээр шийдвэрлэгдэж байгаа асуудал.

Улс төрийн шийдвэр нь хуулиар тогтоосон процедур, хязгаарлалт, шаардлага тавиагүй юман дээр л улсын төрийн шийдвэр, бусад тохиолдолд процессын эрхтэй холбоотой Засаг дарга нарын асуудлыг аваад л явж байгаа, ингэхдээ зөвхөн процессын эрхийг зөрчсөн дээр л маргаж байгаа,

**Шүүгч Ц.Мөнхзул**: Бид процессын зөрчлийн улмаас нэхэмжлэгчийн эрх зөрчигдөөгүй байна, акт зорилгодоо нийцсэн байна гээд шийдээд байгаа, энэ шийдэж байгаа байр суурь дээрээ шүүх нэгдсэн байр суурьтай болох хэрэгтэй. Яагаад гэхээр өнөөдрийн хэлэлцүүлгийн зорилго бол Захиргааны ерөнхий хуулийг хэрэглэх, хамгаалах, нэг мөр ойлгож хэрэгжүүлэх гэж байгаа хирнээ бид өөрсдөө хуулиа хийдүүлээд байгаа, захиргааны байгууллага процессын зөрчил гаргасан байна гээд дүгнэсэн хирнээ энэ зөрчил нь актыг хүчингүй болгох үндэслэл биш, нэхэмжлэгчийн эрхийг зөрчөөгүй гээд шийдээд байгаа, тэгэхээр энэ дээр нэгдсэн байр суурьтай байх хэрэгтэй. Хуулиа хамгаалахын тулд процессын зөрчил дээр нь акцент /ач холбогдол/ өгвөл яасан юм бэ?

**Шүүгч Ц.Цогт**: Ойлгож байна. Гэхдээ өнөөдрийн энд цугласан бүрэлдэхүүн өөрөө дан шүүхийн бүрэлдэхүүн биш учраас хамаагүй ярих боломжгүй. Харин энэ асуудлаа анхан болон давах, хяналтын шатны шүүх нь ярилцаад боломжтой зүйл дээрээ тогтоод явах боломжтой.

Түрүүнээс хойш яригдаад байгаа учраас нэг зүйлийг анхаарах хэрэгтэй.

Жишээ нь: Ашигт малтмалын маргаан дээр хуулиараа тусгай зөвшөөрлийг цуцлах үндэслэл бүрдсэн гэдгийг мэдэгдэх үүрэгтэй ч надад мэдэгдээгүй учраас захиргааны актыг хүчингүй болгуулахаар маргалаа. Шалгах явцад шийдвэрийг үнэхээр мэдэгдээгүй болох нь тогтоогдсон, тэгвэл танд мэдэгдсэн байсан бол та төлбөрөө хугацаанд нь төлсөн гэдгээ нотлох ямар боломж, баримтууд байсан бэ? Тэрийг гаргаад ир гэхээр ямар ч баримт байхгүй байлаа гэж бодье.

Сонсох ажиллагааны гол зорилго бол тэр хугацаанд гарах гэж байгаа шийдвэрийг няцаах үндэслэлээ нотлох баримтыг гаргаж өгөх боломжийг л олгож байгаа л ажиллагаа,

За бид дээрх тохиолдолд мэдэгдээгүй процесс зөрчсөн үндэслэлээр л захиргааны актыг хүчингүй болгоё. Энэ мэдэгдээгүй процесс нь эргээд нөгөө хүний эрхийг яаж зөрчсөн юм, зөрчөөгүй байвал яахав.

Дараа нь ямар үр үүсэж байгаа вэ гэхээр тухайн асуудлаар захиргаа дахиж шийдвэр гаргахгүй гэдэг юм яваад байгаа юм.

Захиргаа агуулгын хувьд алдаагүй, үндэслэлтэй гэхдээ зөвхөн процессын зөрчилтэй шийдвэр гаргасан гээд шүүх хүчингүй болголоо гэж бодоход цаад үр дагавар нь 16 тэрбум, магадгүй 21 тэрбум төгрөгийн татварын зөрчил байхад захиргаа дахиад тэр асуудлаар хяналт шалгалт хийх эрхтэй гэж үзэх үү эрхгүй гэж үзэх үү гэдэг дээр захиргааны эрх зүйн шинжлэх ухаан, хуулийн хувь, шүүхийн хувьд том асуудал байгаад байгаа юм. Тийм учраас энэ процессын зөрчлийг зөрчигдөж буй эрх гэдэгтэй сайн уялдуулж авч үзэх хэрэгтэй.

Энэ асуудлаар анхан давж заалдах шатны шүүх уулзаж, ярилцах боломж байгаа гэж ойлгож байна.

**Шүүгч Ц.Батсүрэн**: 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс өмнөх захиргааны үйл ажиллагаанд Захиргааны ерөнхий хууль хэрэглэгдэх үү? Хэрэв хэрэглэвэл ямар хүрээнд хэрэглэх вэ?

Манай шүүх дээр бөхчүүд допинг хэрэглэсэн, хэрэглээгүй гээд маргаан гарсан. Засгийн газрын тогтоолоор батлагдсан "Допингийн шинжилгээ хийх журам" хууль батлагдахаас өмнө гараад хэрэгжиж байгаа, захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй актууд нилээд их байгаа. Захиргааны ерөнхий хуулиар хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй актыг эрх зүйн үйлчлэлгүй, биелүүлээгүй этгээдийн үйл ажиллагаанд хариуцлага хүлээлгэхгүй гэсэн заалт бий.

pdfelement

Remove Watermark Now

**Шүүгч Ц.Цогт**: Анхан болон давж заалдах шатны шүүх дээр яг энэ асуудал гараад 2 хэрэг хянагдаж байгаа. Ерөнхий хууль батлагдахаас өмнө гарсан хэм хэмжээний акт, Гаргасан байгууллага нь Засгийн газрын бус бие даасан агентлаг гаргасан хэм хэмжээний акт нь хүчтэй байгаад байдаг. одоо Захиргааны ерөнхий хууль хэрэгжээд эхэлсэн гэтэл энэ журмыг үндэслээд надад үүрэг хүлээлгээд байна гээд журамтай нь маргаж байгаа.

Мэдээж Захиргааны ерөнхий хууль хүчин төгөлдөр болсноос хойш журмыг хэрэгжүүлж хүн, хуулийн этгээдээс үүрэг шаардах гэж байгаа бол хуулиа хэрэгжүүлж, тухайн журам нь шинэ хуультай нийцсэн байхыг шаардана. Гэхдээ тухайн журмын маргаж байгаа акт нь хуулиас давсан, журмандаа хуулийн заалтыг биччихсэн байдаг. Маргаж байгаа журмын заалт нь хуулийн заалт байдаг.

Хуулийн заалтаас илүү давж гарсан зохицуулалт байхгүй байгаа тохиолдолд
яах вэ? шүүх журмыг хүчингүй болголоо гэхэд хууль нь хүчин төгөлдөр байгаа, уг журмаар шаардаж байгаа үүрэг нь хуулиас л гарсан үүрэг л байгаа юм. Ийм байвал яах вэ? зовлонтой л асуудал.

**Доктор П.Одгэрэл**: Шилжилтийн зохицуулалт байх ёстой байсан байна, нэгэнт хууль мөрдөгдөж байгаа учраас захиргаа өөрөө хуульд нийцүүлж нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх арга хэмжээг авах ёстой. Нэгдсэн бүртгэлд бүртгэгдээгүй бол эрх зүйн эх сурвалж болохгүй. Цаад утгаараа шүүх хэрэглэхгүй. Нэгдсэн бүртгэлд бүртгэж байгаагийн гол санаа бол эрх зүйн эх сурвалж, бүртгэлтэй учраас шүүх хэрэглэнэ гэдгийг л нотолж байгаа санаа юм.

**Шүүгч Д.Халиуна**: Хууль зүйн яам зөвхөн бүртгэл хийх үүрэгтэй этгээд үү эсхүл бүртгэхээс өмнө цэгнэх үүрэг нь байгаа юм уу?

**Шүүгч Ц.Цогт**: Хэм хэмжээний акт дээр 2 янзын хяналт байгаа, нэг нь урьдчилсан хяналт буюу захиргааны хяналт, өөрөөр хэлбэл захиргаа батлагдахаас өмнө урьдчилаад Хууль зүйн яаманд өгч хянуулах,

Нөгөө нь хүчин төгөлдөр болсны дараах буюу тодорхой эрх зөрчсөнтэй холбоотой шүүхийн хяналт

**Шүүгч Д.Халиуна**: Хууль зүйн яам нутгийн өөрөө удирдах байгууллагын шийдвэрийг ямар хэмжээнд хянах юм бэ?

**Шүүгч Ц.Цогт**: Шинэ хуулиар ялгаагүй л аваад явж байгаа, гэхдээ нутгийн өөрөө удирдах ёсны хэм хэмжээний акт дээр 2 өөр юм байгаа

1. Нэг нь шууд Үндсэн хуулийн заалтаас үүдэлтэй хэм хэмжээний акт гаргах эрх байж болно гэж судлаачид үзэж байгаа, тэр тохиолдолд Захиргааны ерөнхий хуулийн дараалын дагуу хянах уу үгүй юу гэдэг асуудал,

2. Хуулиар эх сурвалж өгөөд нутгийн захиргааны байгууллагад эрх олгосны дагуу гарч байгаа хэм хэмжээний акт бол Захиргааны ерөнхий хуулийн шалгуурын дагуу шалгах эрх Хууль зүйн яаманд байгаа,

Ингээд цаг дуусаж байгаа тул уулзалт ярилцлагыг энд хүрээд өндөрлөе гэв.

.

Тэмдэглэл хөтөлсөн:

Шүүгчийн туслах Х.Эрдэнэцогт

pdfelement

Remove Watermark Now



- Захиргааны хэргийн давж заалдах шүүхийн “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, УДШ-д санал гаргах тухай” тогтоол 2018.02.07,
- УДШ-ийн нийт шүүгчдийн хуралдааны “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хүсэлт мэдүүлэх тухай” тогтоол 2018.04.19, 2018.05.04,
- Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа түдгэлзүүлэх тухай” захирамжууд

2018 оны 02 сарын 07 өдөр Дугаар 221/ШТ2018/0085 Улаанбаатар хот

ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААГ
ТҮДГЭЛЗҮҮЛЖ, УЛСЫН ДЭЭД
ШҮҮХЭД САНАЛ ГАРГАХ ТУХАЙ

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүх хуралдааныг Ерөнхий шүүгч Д.Батбаатар даргалж, шүүгч С.Мөнхжаргал, шүүгч Ц.Цогт нарын бүрэлдэхүүнтэй, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Б.Адилмаа, гомдол гаргагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн өмгөөлөгч Э.Нарангарав, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Э.Балжинням нарыг оролцуулан Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 960 дугаар шийдвэрийг эс зөвшөөрч гаргасан гомдол гаргагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гомдлоор Юу Эм Ди ХХК-ийн гомдолтой, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч Б.Отгонцэнгэлд холбогдох захиргааны хэргийг Ц.Цогтын илтгэснээр хянан хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ нь:

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 960 дугаар шийдвэрээр: Зөрчлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дүгээр зүйлийн 10.1 дэх хэсгийг баримтлан Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч Б.Отгонцэнгэлийн 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 1702000095 дугаар шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах тухай Юу Эм Ди ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Э.Нарангаравын гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэжээ.

Юу Эм Ди ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Э.Нарангарав давж заалдах гомдолдоо: Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 960 дугаар шийдвэрийг эс зөвшөөрч гомдол гаргагч Юу Эм Ди ХХК-ийн зүгээс доорх үндэслэлээр давж заалдах гомдол гаргаж байна.

Шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагчийн гаргасан шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах хуралд иргэн Б.Отгонцэнгэлээс иргэн Э.Балжиннямд өгсөн итгэмжлэлийн дагуу шүүх хуралдаан явуулсан нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-ыг зөрчсөн. Энэ байдлыг шүүх хуралдааны эхэлд хууль ёсны итгэмжлэл гэж үзэхгүй гэж гомдол гаргагчийн зүгээс үзсэн боловч шүүх хуралдааныг үргэлжлүүлэн хийсэн юм. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.4-т заасны дагуу түдгэлзүүлэх үндэслэлтэй байсан гэж үзэж байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д Засаг дарга нь ... газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, гарсан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавих, энэ талаарх Засаг даргын тайланг хэлэлцэж дүгнэх ... тухай заах газартай холбоотой асуудал болон Газрын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3-т заасан асуудлаар буюу зөрчилд дурдагдаж буй асуудлыг сум, дүүргийн Засаг дарга хариуцахаар заасан байдаг ба энэ талаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын 2017 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн А/149 дүгээр Мэргэжлийн хяналтын байгууллагын чиг үүрэгт хамааралгүй асуудлын жагсаалт шинэчлэн батлах тухай тушаалыг баталсан ба тушаалын хавсралтын 42-т Засаг дарга арга хэмжээ авахаар тодорхой заасан атал Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын байцаагч нь эрх мэдлээ хэтрүүлэн шалгаж, шийтгэл ногдуулсан нь хууль бус юм.



pdfelement

Remove Watermark Now

Нөгөөтэйгүүр Юу Эм Ди ХХК-ийн зүгээс 2014 оны 10 дугаар сард пантус барихдаа Классик лэнд ХХК-аар барилгын гадна тохижилтын зургийг хийлгэсэн юм. Байцаагчийн шийтгэлийн хуудсыг даган гарсан даалгаварт барилгыг буюу пандусыг буулгах тухай байдаг ба барилга, байгууламж гэдэг ялгаа заагийг мэдэхгүйгээр эрх зүйн зөрүүтэй үр дагавар үүсгэхээр байгааг анхаарч үзсэнгүй.

Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар нь төрийн байгууллага бөгөөд Төрийн хяналт, шалгалтын хуулийн дагуу $5^1$, $5^2$, $5^3$ дугаар зүйлд заасны дагуу төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн шалгалтуудыг удирдамжийн дагуу эсвэл онцгой нөхцөлийн дагуу хийх ёстой байдаг атал Нар урт ХХК-ийн эрх ашгийг хамгаалах замаар эрх мэдлээ хэтрүүлэн шалгалт хийсэн нь үндэслэлгүй юм.

Иймд Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 128/ШШ2017/0960 дугаар шийдвэрт өөрчлөлт оруулж, Нийслэлийн мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагчийн 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 1702000095 дугаар шийтгэлийг хүчингүй болгож өгнө үү гэжээ.

ХЯНАВАЛ:

**1. Хэргийн үйл баримтын талаар:**

Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиуд хүчин төгөлдөр болсноос хойш уг хуулийн дагуу шалгагдаж давж заалдах шатны журмаар хянагдаж буй эхний хэрэг Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газар Нар урт ХХК-иас батлагдсан төлөвлөлтийн дагуу орц гарцыг чөлөөлж өгөх талаар хүсэлт ирүүлснийг үндэслэн,

Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэр 13 дугаар хороолол, Дамдинсүрэнгийн гудамжинд байрлах байршил дээр Юу Эм Ди ХХК орц гарцыг хааж хашаа барьсан нь Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 /Газрыг заасан зориулалт, хугацаа, болзолтойгоор гэрээний үндсэн дээрх зөвхөн гэрчилгээгээр эзэмшүүлнэ/, 27.4 /Хүчин төгөлдөр эрхийн гэрчилгээгүй аливаа этгээд газар эзэмшихийг хориглоно/ заалтууд, Монгол Улсын галын аюулгүй байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 19 дүгээр зүйлийн 19.3 дахь заалт, Хот тосгоны төлөвлөлт барилгажилтийн норм ба дүрэм БНбД 30-01-04-ийн заавал мөрдөх 4 дүгээр хавсралтад заасан галын аюулаас хамгаалах шаардлагыг тус тус зөрчсөн гэж дүгнэн,

pdfelement

Батлагдсан зургийн дагуу авто замын орц гарцыг чөлөөлж галын аюулгүй байдлын норм дүрмийг хангуулж, холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу шийдвэрлүүлэхээр Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн газрын албанд 2017 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 5/3765 Зөрчил арилгуулах тухай албан бичгийг хүргүүлжээ.

Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын 5/3765 дугаар албан бичгийг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын хэлтсийн Байгаль орчин, газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч Б.Отгонцэнгэл 2017 оны 10 дугаар сарын 24-ний өдөр хүлээн авч Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.2 дугаар зүйлд заасны дагуу тэмдэглэл үйлдэж, 2017.10.27-ны өдөр Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу зөрчлийн хэрэг нээж, Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор Ж.Ганцэцэг зөрчлийн хэргийн дугаар олгосон байна.

2017.10.26-ны өдрийн 04-Ц1710230390/097 дугаар тэмдэглэлээр Юу Эм Ди ХХК-д Нийслэлийн Засаг даргын 2013 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн А/895 дугаартай захирамжаар 767 м.кв газрыг худалдаа, үйлчилгээ, конторын зориулалтаар эзэмшүүлсэн. Эзэмшил газраас хэтрүүлэн хашаа барьсан, мөн газар доорх граж руу орох пандусыг эзэмшил газраас хэтрүүлсэн. Эргэлтийн цэг тэмдэгтийг хөдөлгөсөн. Барилгын ажлыг эхлүүлэхдээ 2013 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 2013/675 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавар батлуулсан. Мөн 2014 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 0000768 №147/2014 дугаартай барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл авсан зэрэг нөхцөлийг тогтоогдсон гэж үзжээ.

Улмаар, хариуцагч улсын байцаагч Б.Отгонцэнгэл 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 1702000095 дугаар шийтгэлийн хуудсаар Юу Эм Ди ХХК-ийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй газар ашигласан зөрчил гаргасан гэж үзэн Зөрчлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 10.1 дахь хэсэгт заасны дагуу 5000 нэгжээр торгох шийтгэл ногдуулжээ.

**2. Хэргийг шийдвэрлэхэд хэрэглэгдэх хуулийн талаар:**

Remove Watermark Now

Юу Эм Ди ХХК-ийн гомдолтой хэргийг шийдвэрлэхэд Зөрчлийн тухай хууль[1], Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль[2], Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хэрэглэгдэхээр байна.

Захиргааны хэргийг шүүх хянан шийдвэрлэх ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн байх нь эрх зүйн суурь шаардлага юм. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1-д *Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Захиргааны ерөнхий хууль, Монгол Улсын шүүхийн тухай хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, энэ хууль болон эдгээртэй* нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжоос бүрдэхийг заасан.

Өөрөөр хэлбэл, аливаа захиргааны хэргийг шүүх хянан шийдвэрлэх үед хэрэглэгдэх хууль нь Үндсэн хууль болон дээрх хуулиудад нийцсэн байх шаардлагатай бөгөөд энэхүү шаардлагыг Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиуд шинээр боловсруулж, баталсантай холбогдуулан баталсан Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль[3](2017 оны 05 дугаар сарын 18ны өдрийн) болон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль[4] (2017 оны 05 дугаар сарын 18ны өдрийн)ийн дараах зарим зүйл, заалт хангахгүй байна.

**2.1. Энэ хэргийг хянан шийдвэрлэхэд хэрэглэгдэх хууль Үндсэн хуульд нийцээгүй байгаа талаар:**

Зөрчлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудыг баталсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 05 дугаар сарын 18ны өдөр баталсан, Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн:

1 дүгээр зүйл.Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийн захиргааны байгууллагаас гэсний дараа зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас бусад гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын гэмт хэрэг мөрдөн байцаах ажиллагаа гэснийг хууль сахиулах, гэмт хэрэг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа гэж өөрчилсүгэй. гэсэн зүйл болон,

pdfelement

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн:

1 дүгээр зүйл.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалт:

3.1.11.гомдол гэж хуульд тусгайлан заасны эрх бүхий этгээдийн шийдвэрийг хянуулахаар захиргааны хэргийн шүүхэд гаргасан өргөдөл, ... Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу гаргасан прокурорын дүгнэлтийг.

2/7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг:

7.3.Энэ зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэгт заасан зарчим нь гомдол хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй.

5/112 дугаар зүйлийн ... 112.9 дэх хэсэг:

112.9.Шүүх гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэмэлт нотлох баримт цуглуулахгүй. гэсэн зүйл, заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна, Арван зургадугаар зүйлийн 14/-д Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах ... шударга шүүхээр шүүлгэх ... эрхтэй, Арван есдүгээр зүйлийн 1-д Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна, Дөчин долдугаар зүйлийн 2-д ... шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно гэж заасантай нийцээгүй байна.

Remove Watermark Now

Учир нь захиргааны эрх зүйн суурь ухагдахуун, харилцааг зохицуулсан Захиргааны ерөнхий хуулийн бүтцийг Зөрчлийн хууль шинээр боловсруулсантай холбогдуулан хөндсөн байгаа нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-ийн хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим алдагдахад хүргэж болзошгүй болжээ.

Тухайлбал, Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсгийн захиргааны байгууллагаас гэсний дараа зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас бусад гэж нэмснээр зөрчил[5] гэсэн ойлголтыг хуулиар тогтоосон журам зөрчсөн зөрчил гаргасан этгээдэд шийтгэл ногдуулах зорилго бүхий харилцаанаас нь хэтрүүлэн зөрчлийн бус[6], захиргааны эрх зүйгээр зохицуулагдах харилцаа буюу захиргааны удирдан зохион байгуулах эрх хэмжээ, иргэний эрх, үүргийн хоорондын харилцаа, уг харилцаанаас үүссэн маргаанд хэрэглэхээр өргөжүүлж[7], жишээ нь газар эзэмшлийн маргаан, татварын[8] харилцаанаас үүссэн маргааныг зөрчилд хамруулж, зөрчил шалган шийдвэрлэх журмаар хэлэлцэх болсноор иргэд угтаа ижил захиргааны шийдвэрийн (захиргааны акт) маргааныг захиргааны хэргийн шүүхээр хоёр[9] өөр журам, зарчим бүхий хянан шийдвэрлэх ажиллагаа-гаар хянуулахад хүрч хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим алдагдахаар байна. Өөрөөр хэлбэл, захиргааны эрх зүйн хэм хэмжээ, зарчмаар шийдвэрлэгдвэл зохих харилцаа, маргаан эрүүгийн эрх зүйн (зөрчлийн буюу шийтгэлийн эрх зүйн) хэм хэмжээгээр шийдвэрлэгдэхэд[10] хүрч байгаа нь шүүхээс эдгээр хуулийг хэрэглэхэд хүргэж байна.

**2.2.Захиргааны эрх зүй дэх шүүхийн үүрэг буюу захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны зорилго:**

Хүн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд заасан бол захиргааны байгууллагаас гаргасан нэхэмжлэлийг үндэслэн захиргааны хэргийг шийдвэрлэхэд оршдог. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлж, захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагаагаар хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх тогтолцоог бий болгож буй хэрэг юм. Гэхдээ энэхүү баталгаа, тогтолцоо нь гагцхүү оролцогчдын процессын эрх хангагдсан, мэтгэлцэх, шүүх нотлох[11] зарчмыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэгжүүлж байж, эдгээрт үндэслэж шүүх эцсийн шийдвэр гаргах[12]зохицуулалттай нөхцөлд л (2.3-д тайлбарласан) бодитой хэрэгжих боломжтой.

pdfelement

**2.3.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, журам:**

Эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх эрх нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, журам нь (*анхнаасаа шийтгэл хүлээх зөрчил гаргасан гэж тогтоогдсон этгээдийн хувьд бус*) эрхээ хамгаалан шүүхэд мэдүүлэгчийн хувиар шаардлага гарган нэхэмжлэх, маргаж буй асуудлыг үндэслэх эсхүл няцаах баримтыг заах, гаргах, тайлбарлах, мэргэжлийн байгууллагаар шинжлүүлэх зэргээр мэтгэлцэх, нотлох ажиллагаа хийгдэх боломжтой, шүүх (*захиргааны байгууллагын тогтоосон зөрчил-ийг хэлбэрийн төдий батлагчийн хувьд бус*) иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхол захиргааны шийдвэр, үйл ажиллагаанаас зөрчигдсөн эсэхийг тогтоогчийн хувьд хянан шийдвэрлэх ажиллагааг явуулах хууль зүйн зохицуулалт бүрдсэн үед бодитоор хэрэгжих учиртай.

Гэтэл Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулиар Захиргааны ерөнхий хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4, 37 дугаар зүйлийн 37.1д нэмэлт, өөрчлөлт оруулснаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд Захиргааны ерөнхий хууль үйлчлэхгүй болох, улмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үр дүнд гарсан шийдвэр нь захиргааны актад хамаарахгүй болсон байна. Ингэснээр захиргааны хэргийн шүүх захиргааны байгууллагаас зөрчил шалган шийдвэрлэх журмаар гаргасан захиргааны актыг агуулгын хувьд Захиргааны ерөнхий хуульд заасан хуульд үндэслэх болон зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, үндэслэл бүхий байх шаардлага хангасан эсэхийг нь хянах, захиргааны акт гаргах процессын шаардлага хангасан эсэхийг нягтлах боломжгүй болсон байна.

Түүнчлэн, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулиар Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.11, 7 дугаар зүйлийн 7.3, 112 дугаар зүйлийн 112.9 д нэмэлт, өөрчлөлт оруулснаар шүүх нотлох зарчим, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хэрэгт ач холбогдол бүхий нотлох баримт гаргаж өгөх, энэ талаар хүсэлт гаргах эрхийг хязгаарласан төдийгүй хэргийн үйл баримт, хэргийн оролцогчийн буруутай үйл ажиллагаа, хууль зүйн үндэслэл, хууль хэрэглээний талаар нотлох болон үгүйсгэх

байдлаар мэтгэлцэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зарчмыг хэрэгжүүлэх боломжгүйд хүргэсэн байна.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны зарчим, журам нь *шүүхийн өмнө эрх тэгш байх, эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулах, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх*, *хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгаар бүрдүүлэх* Үндсэн хуулийн баталгааны хэрэгжилтийг харуулах гол шалгуур үзүүлэлт юм. Гэтэл захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны гол зарчмууд болох шүүх нотлох, мэтгэлцэх зарчмууд захиргааны хэргийн шүүхээс гомдол хянан шийдвэрлэх ажиллагаа ны дагуу хянах хэргийн, тухайлбал энэ хэргийн хувьд хэрэгжих боломжгүй байгаа нь хэргийн оролцогчдын Үндсэн хуулиар хамгаалагдсан эрх, баталгаа хангагдахгүй нөхцөлд хүргэж байна.

Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар дамжуулан Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд шинээр бий болгосон гомдол хянан шийдвэрлэх ажиллагаа нь хянан шийдвэрлэх ажиллагаа нэршилтэй боловч шүүхээс бодит байдлаар хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах боломжгүй, хэлбэрийн хувьд шүүх хянан шийдвэрлэж байгаа мэт, шүүх хянасан гэх нэр төдий процесс болоход хүрч байна.

Учир нь захиргааны хэргийн шүүх гомдол хянан шийдвэрлэх ажиллагаа ны үед шүүх нотлох, мэтгэлцэх зарчим хэрэгжихгүй, зөвхөн зөрчил шалгах ажиллагааны үед цуглуулсан баримтад үндэслэн хэргийг шийдвэрлэх болно. Тиймээс нь энэ тохиолдолд шүүх үндсэн үүргээ биелүүлэх боломжгүй, бодит байдлаар хууль зүйн болон үйл баримтыг тогтоох боломжийг үгүйсгэснээр Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 2-д ... шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно гэж заасантай нийцэхгүйд хүргэж байна. Нэг үгээр хэлбэл, гомдол хянан шийдвэрлэх ажиллагаа нь шүүх хэрэг, маргаан хянан шийдвэрлэх үндсэн зарчим, ажиллагаа хийгдэхгүй учир үнэн чанартаа шүүх хянах шийдвэрлэх ажиллагаа явагдсан гэж үзэх боломжгүй (агуулгын хувьд) энэ утгаараа шүүхээс өмнө шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлсэнтэй ялгаагүй нөхцөлд хүргэж байна.

Ингэснээр иргэн, хуулийн этгээд эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, шударга шүүхээр шүүлгэх эрх нь хэлбэрийн хувьд хангагдсан мэт боловч агуулгын хувьд хязгаарлагдсан байна.

**3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх:**

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2д зааснаар Юу Эм Ди ХХК-ийн гомдолтой хэргийг хянан шийдвэрлэхэд хэрэглэх 2017 оны 05 дугаар сарын 18ны өдөр батлагдсан Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухайхуулиудын холбогдох зүйл, заалт нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй байна гэж шүүх бүрэлдэхүүн үзэж уг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, Улсын дээд шүүхэд энэ талаар саналаа гаргаж байна.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1, 111.2 дахь хэсэгт заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 65 дугаар зүйлийн 65.1.5 дахь хэсэгт заасныг баримтлан Юу Эм Ди ХХК-ийн гомдолтой, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч Б.Отгонцэнгэлд холбогдох Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчин, газар, геодези, зураг зүйн хяналтын улсын байцаагч Б.Отгонцэнгэлийн 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 1702000095 дугаар шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах шаардлага бүхий захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, уг хэргийг хянан шийдвэрлэхэд хэрэглэх 2017 оны 05 дугаар сарын 18ны өдөр батлагдсан Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудын холбогдох зүйл, заалт нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй байна гэсэн саналыг Улсын Дээд шүүхэд гаргасугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ Д.БАТБААТАР
ШҮҮГЧ С.МӨНХЖАРГАЛ
ШҮҮГЧ Ц.ЦОГТ



Remove Watermark Now
pdfelement

Remove Watermark Now

**МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН**
**НИЙТ ШҮҮГЧДИЙН ХУРАЛДААНЫ**
**ТОГТООЛ**

2018 оны 04 сарын 19 өдөр Дугаар 02 Улаанбаатар хот

Монгол Улсын Үндсэн хуулийн
цэцэд хүсэлт мэдүүлэх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5, $17^1$ дүгээр зүйлийн $17^1.1$ дэх хэсэг, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэгт заасныг тус тус удирдлага болгон Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

Нэг. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 221/ШТ2018/0085 дугаар тогтоолоор Монгол Улсын Дээд шүүхэд ирүүлсэн саналыг үндэслэлтэй гэж үзэж, Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн хуулийн 1, 2 дугаар зүйл, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн хуулийн 1 дүгээр зүйлийн 1/, 2/, 5/ дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх асуудлаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хүсэлт мэдүүлсүгэй.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ Ц.ЗОРИГ

ШҮҮГЧ Г.БАНЗРАГЧ

Бүртгэлийн дугаар ..........
МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ТАМГЫН ГАЗАР
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны
Албан тушаал Гарын үсэг
050011
2018 оны 6 сарын 05 -ний өдөр

pdfelement

Remove Watermark Now

# МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН НИЙТ ШҮҮГЧДИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2018 оны 05 сарын 07 өдөр Дугаар 03 Улаанбаатар хот

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс шилжүүлсэн өргөдөл, мэдээллийн тухай

Улсын Дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдааныг Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч Ц.Зориг даргалж, Танхимын тэргүүн Б.Цогт, Х.Сонинбаяр, М.Батсуурь, шүүгч Г.Алтанчимэг, Ц.Амарсайхан, Л.Атарцэцэг, Г.Банзрагч, С.Батдэлгэр, Х.Батсүрэн, Д.Ганзориг, П.Золзаяа, Б.Мөнхтуяа, П.Соёл-Эрдэнэ, Ч.Хосбаяр, Г.Цагаанцоож, Д.Цолмон, Д.Эрдэнэбалсүрэн, Х.Эрдэнэсувд нарын бүрэлдэхүүнтэй, Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга Ж.Наранпүрэв, нарийн бичгийн дарга Б.Дүүрэнжаргал нарыг суулцуулан тус шүүхийн хуралдааны танхимд хийж, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс 2018 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн "Шүүхийн үйл ажиллагааг Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт нийцүүлэх тухай" 1/142 тоот албан бичиг болон түүнд хавсаргаж шилжүүлсэн иргэдийн өргөдөл, мэдээллийг хянан хэлэлцэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4-д заасныг үндэслэж шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн 3 иргэний өргөдөл, мэдээллийн агуулгыг нэгтгэн үзвэл: иргэн Д.Хатанбат, Б.Итгэлбат, Р.Баттагчаа нар нь Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1 дэх заалтад "Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн" гэж, Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно" гэж, Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх заалтад "Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн" гэж, Жаран долдугаар зүйлд "Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болно" гэж тус тус заасныг зөрчсөн эсэх талаар; Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг нь Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 02 дугаар дүгнэлтээр хүчингүй болсон Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "Монгол Улсын Засгийн газар" гэж заасныг агуулгаар дахин сэргээж, Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн эсэхийг хянан шийдвэрлэж өгнө үү гэжээ.

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсэгт Монгол Улсын Дээд шүүхийн бүрэн эрхийг заасан бөгөөд уг хэсгийн 3/ дахь заалтад "хууль,

pdfelement

түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокуророос шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэх" гэжээ. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргаас Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчид ирүүлсэн албан бичигт Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх заалтыг үндэслэсний зэрэгцээ Үндсэн хуулийн цэцэд гаргасан иргэдийн өргөдлийн агуулгыг харвал Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс Улсын Дээд шүүхэд "хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах" талаарх асуудлыг шийдвэрлүүлэхээр шилжүүлээгүй гэж үзэхээр байна.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх заалтад "Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн" гэж, Жаран зургаадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1/-д "хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх асуудлаар дүгнэлт гаргах" гэж, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 3 дугаар хэсэгт "Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн дагуу хянан шийдвэрлэнэ" гэж, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "...Хэрэв эрх бүхий байгууллага, албан тушаалтан шийдвэр гаргахдаа Цэцийн шийдвэрээр хүчингүй болсон хууль болон бусад шийдвэрийн заалтыг шууд буюу агуулгаар нь дахин сэргээвэл Цэцийн аль нэг гишүүний санаачилгаар Цэц хяналтын журмаар хянан шийдвэрлэж болно" гэж тус тус заасан.

Үндсэн хуулийн цэцэд хандсан иргэдийн өргөдөлд дурдсан нэр бүхий хуулийн заалт Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн, эсхүл, Үндсэн хуулийн цэцийн шийдвэрээр хүчингүй болгосон хуулийн заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн талаар маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэх бүрэн эрхтэй, Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуулиар иргэдийн өргөдөлд дурдсан асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхийг Улсын дээд шүүхэд олгоогүй байна.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4/ дэх заалтад "Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах" гэж Улсын дээд шүүхийн бүрэн эрхийг заажээ.

Хэдийгээр Үндсэн хуульд заасснаар Улсын дээд шүүх Үндсэн хуулиас бусад хуулийг тайлбарлах эрхтэй боловч уг тайлбарлах журмыг тодорхойлсон Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1-д "Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх замаар гаргах бөгөөд тайлбарыг тогтмол нийтлэх" гэж заасныг Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн 07 дугаар тогтоолоор хүчингүй болгосон тул Үндсэн хуулийн цэцийн даргын албан бичигт дурдсанчлан Улсын дээд шүүхээс хууль тайлбарлах боломжгүй байна.

4. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2/ дахь заалтад "давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх" гэж, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-т "Улсын дээд шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэсэн захиргааны хэргийг хяналтын журмаар хянан шийдвэрлэнэ", 16.4-т "Улсын дээд шүүх захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн анхан шатны журмаар хянан шийдвэрлэсэн хэргийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ", 127 дугаар зүйлийн 127.1-д "Хэргийг хяналтын журмаар Улсын дээд шүүх 5



Remove Watermark Now

шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэнэ" гэж тус тус заасны дагуу Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын шүүгч нар хуульд заасан бүрэлдэхүүнээр захиргааны хэргийг давж заалдах болон хяналтын журмаар хянан шийдвэрлэдэг. Ийнхүү хянан шийдвэрлээд гарсан тогтоолд тухайн бүрэлдэхүүний 2 шүүгч тусгай санал бичсэн, эсхүл, Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүгчдийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх үндэслэлтэй гэж Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч үзсэн тохиолдолд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 128 дугаар зүйлд заасныар тогтоолыг дахин хянах боломж байдаг ч мөн зүйлд заасныар зөвхөн хэргийн оролцогчийн гомдлоор хянах учиртай.

Түүнчлэн, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1-д заасныар хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр /анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах болон хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн магадлал, тогтоол/-ийг шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хянан үзэх боломжтой боловч энэ нь мөн хуулийн 132 дугаар зүйлд заасныар хэргийн оролцогчийн хүсэлтээр явагддаг ажиллагаа учир Үндсэн хуулийн цэцийн даргын албан бичигт хавсаргасан, нэгэнт хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрүүдийг дахин хянан үзэх боломжгүй байна.

Иймд, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргаас 2018 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 1/142 тоот "Шүүхийн үйл ажиллагааг Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт нийцүүлэх тухай" албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг хангахгүй орхиж, шилжүүлсэн өргөдөл, мэдээллийг буцаах нь зүйтэй гэж хуралдаанд оролцсон шүүгчдийн олонхи үзэв.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн $17^1$ дугаар зүйлийн $17^1.1$ дэх хэсэгт заасныг удирдлага болгон Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын 2018 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн 1/142 дугаартай "Шүүхийн үйл ажиллагааг Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт нийцүүлэх тухай" албан бичигт дурдсан хүсэлтийг хангахгүй орхисугай.

2. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын 2018 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн 1/142 дугаартай "Шүүхийн үйл ажиллагааг Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт нийцүүлэх тухай" албан бичгээр шилжүүлж ирүүлсэн иргэн Д.Хатанбат, Р.Батрагчаа, Б.Итгэлбат нарын өргөдөл, мэдээллийг буцаасугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ Ц.ЗОРИГ

ТАНХИМЫН ТЭРГҮҮН М.БАТСУУРЬ

Бүртгэлийн дугаар . . . . . . . . .
МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР
ХУУЛБАР ҮНЭН
Хуулбар олгосон ажилтны
Албан тушаал 3.ҮХ Дарга Гарын үсэг
2018 оны 6 сарын 06

Remove Watermark Now

2018 он 04 сарын 16 өдөр     Дугаар 128/ШЗ2018/2387     Улаанбаатар хот

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг
түдгэлзүүлэх тухай

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүх хуралдааныг шүүгч Ц.Мөнхзул даргалж, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Д.Намсрай, гомдол гаргагч “Ард санхүүгийн нэгдэл” ХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Г.Уранцэцэг, Ө.Ашхүү, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Р.Цэвэлмаа нарыг оролцуулан “Ард санхүүгийн нэгдэл” ХК-ийн гомдолтой, Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгалт, зохицуулалтын газрын хянан шалгагч Ж.Цэрэндамбад холбогдох захиргааны хэргийг хянан хэлэлцээд,

ТОДОРХОЙЛОХ нь:

Гомдол гаргагч “Ард санхүүгийн нэгдэл” ХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Г.Уранцэцэг урьдчилсан хэлэлцүүлэгт гаргасан хүсэлтдээ: “...Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон зөрчлийн тухай хуулийн заалтууд нь хоорондоо нийцэхгүй, нотлох баримтыг шүүх гаргаж авах талаар арга хэмжээ авахгүй байгаа нь бас мэтгэлцэх боломжийг хааж байна, мөн нотлох баримт олж авах замыг хааж байгаа учраас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх хүсэлтийг хангаж өгнө үү” гэв.

ҮНДЭСЛЭХ нь:

Гомдол гаргагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Г.Уранцэцэг нь “...“Ард санхүүгийн нэгдэл” ХК-ийн гаргасан өрийн бичгийг худалдан авсан этгээдэд ямар хууль тогтоомжийн дагуу ямар хариуцлага тооцсон тухай баримтыг болон өрийн бичгийг бараа, ажил үйлчилгээний аль төрөлд хамруулж, бараа, ажил үйлчилгээг аль хуулийн зохицуулалтад хамруулж зөрчлийн хэрэг нээсэн тухай баримтыг Санхүүгийн зохицуулах хорооноос гаргуулах” тухай хүсэлт гаргажээ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д заасны дагуу захиргааны хэргийг нотлох үүргийг захиргааны хэргийн шүүх хэрэгжүүлэх зарчимтай, гэтэл Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль хүчин төгөлдөр болж мөрдөгдөж эхэлсэнтэй холбогдуулан  Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар уг хуулийн 112 дугаар зүйлийн 112.9-д “Шүүх гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэмэлт нотлох баримт цуглуулахгүй” гэж тусгайлан заасны дагуу захиргааны хэргийн шүүх гомдол шалган шийдвэрлэх ажиллагаанд нотлох баримт цуглуулах эрх хэмжээгүй байна.

Иймд “Ард санхүүгийн нэгдэл” ХК-ийн гомдолтой, Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгалт, зохицуулалтын газрын хянан шалгагч Ж.Цэрэндамбад холбогдох зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэхэд хэрэглэгдэх Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 5/112 дугаар зүйлийн 112.9-т “Шүүх гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэмэлт нотлох баримт цуглуулахгүй” гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлийн 16.14-т “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, эрхтэй ...” гэж заасныг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байх тул Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 221/ШТ2018/0085 дугаартай тогтоолоор Улсын дээд шүүхэд хүргүүлсэн “...Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

... 5/112 дугаар зүйлийн 112.9-д “Шүүх гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэмэлт нотлох баримт цуглуулахгүй” гэсэн зүйл заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, 16 дугаар зүйлийн 16.14-д “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах.... шударга шүүхээр шүүлгэх... эрхтэй”, 19 дүгээр зүйлийн 19.1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц... хууль зүйн... баталгааг бүрдүүлэх,... хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”, 47 дугаар зүйлийн 47.2-т “...шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно” гэж заасантай нийцээгүй

Remove Watermark Now

байна” гэсэн саналыг дэмжиж Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-д “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дараах тохиолдолд шүүгч захирамж, шүүх тогтоол гарган түдгэлзүүлнэ” 65.1.5-т “хэрэг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй тухай асуудлаар Улсын Дээд шүүхэд санал оруулсан” гэж заасны дагуу захиргааны хэргийн хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж шийдвэрлэх нь зүйтэй гэж шүүх дүгнэлээ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1, 111.2-т заасныг тус тус удирдлага болгон ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.5-т зааснаар “Ард санхүүгийн нэгдэл” ХК-ийн гомдолтой, Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгалт, зохицуулалтын газрын хянан шалгагч Ж.Цэрэндамбад холбогдох захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсүгэй.

2. Захирамжийн хувийг хэргийн оролцогч нарт танилцуулахыг шүүгчийн туслах Ө.Акмаралд даалгасугай.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1-д зааснаар энэхүү шүүгчийн захирамжийг эс зөвшөөрвөл хэргийн оролцогчид, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч шүүгчийн захирамж бичгээр гарсан өдрөөс нь хойш 7 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

ДАРГАЛАГЧ ШҮҮГЧ Ц.МӨНХЗУЛ

pdfelement

Remove Watermark Now

2018 он 06 сарын 04 өдөр Дугаар 128/ШЗ2018/3480 Улаанбаатар хот

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг
түдгэлзүүлэх тухай

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн рьдчилсан хэлэлцүүлгийг А.Сарангэрэл шүүгч даргалж, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Б.Болд-Эрдэнэ, гомдол гаргагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Х.Содном-Иш, хариуцагч Ч.Мөнхжаргал, Т.Номин-Эрдэнэ нарыг оролцуулан “Хаан банк” ХХК-ийн гомдолтой, Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч Ч.Мөнхжаргалд холбогдох зөрчил шалган шийдвэрлэх хэргийг урьдчилан хэлэлцээд,

ТОДОРХОЙЛОХ нь:

Гомдол гаргагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Х.Содном-Иш урьдчилсан хэлэлцүүлэгт гаргасан тайлбартаа: Үндсэн хуулийн цэцэд Зөрчлийн тухай хууль Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар хэрэг маргаан үүссэн байх тул уг хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл хугацаагаар тус “Хаан банк” ХХК-ийн гомдолтой зөрчлийн хэргийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.6-д заасныг баримтлан түдгэлзүүлж өгнө үү” гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2018 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 55 дугаар тогтоолоор Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт Энэ зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэгт заасан зарчим нь гомдол хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй гэж заасан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн ...шударга ёс ... тэгш байдал ...-ийг хангах нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах ... гэж заасныг тус тус зөрчсөн эсэх асуудлаар Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэжээ.

Ийнхүү хэрэг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар Үндсэн хуулийн цэцэд маргаан үүссэн тул Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65.1.6-д “хэрэг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэсэн тохиолдолд шүүгч захирамж гаргаж түдгэлзүүлнэ” гэж заасны дагуу зөрчил хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж шийдвэрлэх нь зүйтэй байна.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1, 111.2-т заасныг тус тус удирдлага болгон ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.6-д заасныг баримтлан “Хаан банк” ХХК-ийн гомдолтой, Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч Ч.Мөнхжаргалд холбогдох зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсүгэй.

2. Захирамжийн хувийг хэргийн оролцогч нарт танилцуулахыг шүүгчийн туслах П.Энх-Амарт даалгасугай.

3. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1-д зааснаар шүүгчийн энэхүү захирамжийг эс зөвшөөрвөл хэргийн оролцогчид, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч шүүгчийн захирамж бичгээр гарсан өдрөөс нь хойш 7 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

ШҮҮГЧ А.САРАНГЭРЭЛ

Remove Watermark Now

2018 он 05 сарын 16 өдөр Дугаар 128/ШЗ2018/3112 Улаанбаатар хот

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг
түдгэлзүүлэх тухай

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүх хуралдааныг шүүгч Д.Халиуна даргалж, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Э.Номин, хариуцагч С.Оюун-Эрдэнэ нарыг оролцуулан Нийслэлийн Прокурорын газрын Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор Ж.Ганцэцэгийн дүгнэлттэй, Нийслэлийн Тээврийн газрын Авто тээврийн хяналтын улсын байцаагч С.Оюун-Эрдэнэд холбогдох зөрчил шалган шийдвэрлэх хэргийг урьдчилан хэлэлцээд,

ТОДОРХОЙЛОХ нь:

Хариуцагч С.Оюун-Эрдэнэ урьдчилсан хэлэлцүүлэгт гаргасан тайлбартаа: “Тус маргааныг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн эсэх талаар Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцээс шийдвэр гарах хүртэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэхэд татгалзах зүйлгүй” гэжээ.

ҮНДЭСЛЭХ нь:

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2018 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 55 дугаар тогтоолоор Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт Энэ зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэгт заасан зарчим нь гомдол хянан шийдвэрлэх ажиллагаанд хамаарахгүй гэж заасан нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн ...шударга ёс ... тэгш байдал ...-ийг хангах нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна, Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах ... гэж заасныг тус тус зөрчсөн эсэх асуудлаар Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэжээ.

Ийнхүү хэрэг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар Үндсэн хуулийн цэцэд маргаан үүссэн тул Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65.1.6-д “хэрэг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх талаар Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэсэн тохиолдолд шүүгч захирамж гаргаж түдгэлзүүлнэ” гэж заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж шийдвэрлэх нь зүйтэй байна.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.1, 111.2-т заасныг тус тус удирдлага болгон ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.6-д заасныг баримтлан Нийслэлийн Прокурорын газрын Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн хяналтын прокурор Ж.Ганцэцэгийн дүнэлттэй, Нийслэлийн Тээврийн газрын Авто тээврийн хяналтын улсын байцаагч С.Оюун-Эрдэнэд холбогдох зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсүгэй.

2. Захирамжийн хувийг хэргийн оролцогч нарт танилцуулахыг шүүгчийн туслах П.Энх-Амарт даалгасугай.

3. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1-д зааснаар шүүгчийн энэхүү захирамжийг эс зөвшөөрвөл хэргийн оролцогчид, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч шүүгчийн захирамж бичгээр гарсан өдрөөс нь хойш 7 хоногийн дотор Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй.

ШҮҮГЧ Д.ХАЛИУНА

Remove Watermark Now

**Танд энэхүү судалгаанд оролцож байгаад талархал илэрхийлэе. Энэхүү судалгаа нь Захиргааны ерөнхий хуулийн зарим зүйл, заалтыг сайжруулах үндэслэл, шаардлагыг судлахад ашиглаж байгаа юм.**

**Та дор дурдсан асуултад бүтэн өгүүлбэрээр хариулах, эсхүл шаардлагатай хариултыг дугуйлна уу.**

1.Та захиргааны аль байгууллагад ажилладаг бэ?/Байгууллагын нэрээ тодорхой дурдана уу. /Тухайлбал, Нийслэлийн газрын алба, Ашигт малтмал, газрын тосны газар зэргээр/

Засгийн Ерөнхий газар

2.Захиргааны байгууллагаас тухайн захиргааны актад уг актыг гаргах болсон бодит нөхцөл байдлыг зайлшгүй дурдах талаар мэддэг үү?

- ✓ Мэддэг
- Үгүй

3.Мэддэг бол ямар хуульд энэ шаардлага байдаг вэ, та захиргааны актыг боловсруулах, гаргах үедээ акт гаргах болсон бодит нөхцөл байдал, шалтгааныг тодорхойлон зааж, дурдаж байсан уу?

- ✓ Тийм
- Үгүй

4.Захиргааны акт гаргах шаардлага бүхий бодит нөхцөл, байдал гэдгийг Та юу гэж ойлгож байна вэ? Жишээгээр илэрхийлж болно.

- ✓ Ажлаас чөлөөлөх шийдвэрийн хувьд бүтэц, орон тоо өөрчлөгдсөн нөхцөл байдал
- Газар эзэмших эрх хүчингүй болгох шийдвэрийн хувьд бусдын газартай давхцал бий болсон
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүчингүй болгох шийдвэрийн хувьд тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлт гаргаагүй нь баримтаар тогтоогдож байгаа
- ✓ Дээр дурдсан бүх нөхцөл байдлыг бодит нөхцөл байдалд тооцно

5.Танай байгууллагын хувьд захиргааны актыг иргэн, хуулийн этгээдэд мэдэгдэх ажиллагааг явуулахад ямар хүндрэл учирч байна вэ?

- Иргэн, хуулийн этгээд шийдвэрээ гардан авдаггүй
- Иргэн, хуулийн этгээд хаягтаа байдаггүй тул байгууллагад буцан ирдэг
- ✓ Мэдэгдсэн хугацааг тодорхойлоход хүндрэлтэй байдаг
- Бусад /энэ хариултыг дугуйлсан бол Та дэлгэрэнгүй тайлбараа бичнэ үү/

6.Захиргааны актыг мэдэгдэх Захиргааны ерөнхий хуулийн зохицуулалтыг илүү нарийвчлах шаардлага бий юу?

- ✓ Шаардлагатай
- Шаардлагагүй

1

pdfelement

Ямар үндэслэл, агуулгаар энэ зохицуулалтыг сайжруулах шаардлагатай гэж Та үзэж байна вэ?

7.Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6-д "47.1.Дараах тохиолдолд захиргааны акт илт хууль бус болно: 47.1.6.иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байгаагүй;" гэж заасан заалтыг Танай байгууллагаас захиргааны акт гаргахдаа хэрэглэж байсан уу?

- Тийм
- Үгүй
- ✓ Мэдэхгүй

8.Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6-д "47.1.Дараах тохиолдолд захиргааны акт илт хууль бус болно: 47.1.6.иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байгаагүй;" гэж заасан заалт ойлгомжгүй учир дэлгэрэнгүйгээр тайлбарласан өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж Та үзэж байна уу?

- Тийм ойлгомжгүй учир хэрэглэхэд хүндрэлтэй байдаг
- ✓ Ойлгомжтой өдөр, тутам хэрэглэдэг

8.Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийг хэрэглэж захиргааны актыг цуцалж байсан тохиолдол байна уу?

- ✓ Байхгүй
- Байгаа
- Байгаа бол актын нэр, огноо, дугаарыг дурдана уу.

(49 дүгээр зүйл.Эрх зүйн зөрчилгүй захиргааны актыг цуцлах

49.1.Захиргааны актад гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаа өнгөрснөөс үл хамааран түүнийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн цуцалж болно.

49.2.Энэ хуулийн 49.1-д заасан захиргааны актыг ижил агуулгаар дахин батлах шаардлагатай, эсхүл хууль зүйн үндэслэлгүй бол цуцлахгүй.

49.3.Эерэг нөлөөлөл бүхий захиргааны актыг түүнд гомдол гаргах боломжгүй болсон хэдий ч дараах тохиолдолд цуцалж болно:

49.3.1.цуцлах нөхцөлийг хууль, захиргааны хэм хэмжээний актад, эсхүл тухайн захиргааны актад заасан бол;

49.3.2.захиргааны актад нэмэлт зохицуулалт заасан бөгөөд түүнийг тухайн этгээд хуульд заасан хугацааны дотор биелүүлээгүй бол;

49.3.3.шинэ нөхцөл байдал бий болсноор нийтийн ашиг сонирхол зөрчигдөхөөр бол;

49.3.4.хууль, захиргааны хэм хэмжээний акт өөрчлөгдсөний үндсэн дээр захиргааны байгууллага тухайн захиргааны актыг гаргах эрхгүй болсон бөгөөд уг актаар эрх олгогдсон этгээд эрхээ хэрэгжүүлж эхлээгүй бол;



pdfelement

49.3.5.нийтийн ашиг сонирхолд ноцтой сөрөг нөлөө үзүүлэхээс урьдчилан сэргийлэх, эсхүл түүнийг зайлуулахын тулд.

49.4.Захиргааны актаар олгосон болон олгож байгаа мөнгөн тэтгэмж, эсхүл тодорхой зорилго бүхий үйлчилгээг хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн ч уг захиргааны актыг дараах тохиолдолд бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн цуцална:

49.4.1.захиргааны актаар олгосон тэтгэмж, үйлчилгээ уг актад заасан зориулалтаар ашиглагдаагүй бол;

49.4.2.захиргааны актаар нэмэлт зохицуулалт заасан бөгөөд тухайн этгээд уг үүргийг биелүүлээгүй, эсхүл захиргааны актад заасан хугацаанд биелүүлээгүй бол.

49.5.Захиргааны байгууллагаас өөрөөр заагаагүй бол захиргааны акт цуцлагдснаар хүчин төгөлдөр бус болно.)

9.Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийг хэрэглэж захиргааны актыг цуцлах зохицуулалт нь ойлгомжгүй учир дахин дэлгэрэнгүй тайлбарлах шаардлагатай?

- Тийм ойлгомжгүй учир хэрэглэхэд хүндрэлтэй байдаг
- Ойлгомжтой өдөр, тутам хэрэглэдэг

10.Танай байгууллагын хувьд Захиргааны ерөнхий хуулийн 50 дугаар зүйлийг хэрэглэж захиргааны актыг дахин гаргаж байсан тохиолдол байна уу?

- Байхгүй
- Байгаа
- Байгаа бол актын нэр, огноо, дугаарыг дурдана уу.

(50 дугаар зүйл.**Захиргааны акт гаргах ажиллагаар дахин хийх**

50.1.Захиргааны актад гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаа дууссан хэдий ч хаяглагдсан этгээдийн хүсэлтээр дараах тохиолдолд захиргааны акт гаргах ажиллагаар дахин хийж болно:

50.1.1.захиргааны актын үндэслэж байгаа бодит эсхүл эрх зүйн нөхцөл байдал нь хаяглагдсан этгээдийн талд хожим зэрэгээр өөрчлөгдсөн;

50.1.2.хаяглагдсан этгээдийн хувьд ашигтай нотлох баримт бий болсон.

50.2.Хаяглагдсан этгээд нь өргөдөл, гомдлыг шийдвэр гаргах ажиллагаар дахин явуулах үндэслэл бий болсныг мэдсэнээс хойш гурван сарын дотор гаргана.)

9.Захиргааны ерөнхий хуулийн 50 дугаар зүйлийг хэрэглэж захиргааны актыг дахин гаргах зохицуулалт нь ойлгомжгүй учир дахин дэлгэрэнгүй тайлбарлах шаардлагатай?

- Тийм ойлгомжгүй учир хэрэглэхэд хүндрэлтэй байдаг
- Ойлгомжтой өдөр, тутам хэрэглэдэг



pdfelement

Remove Watermark Now

Танд энэхүү судалгаанд оролцож байгаад талархал илэрхийлэе. Энэхүү судалгаа нь Захиргааны ерөнхий хуулийн зарим зүйл, заалтыг сайжруулах үндэслэл, шаардлагыг судлахад ашиглаж байгаа юм.

Та дор дурдсан асуултад бүтэн өгүүлбэрээр хариулах, эсхүл шаардлагатай хариултыг дугуйлна уу.

1.Та захиргааны аль байгууллагад ажилладаг бэ?/Байгууллагын нэрээ тодорхой дурдана уу. /Тухайлбал, Нийслэлийн газрын алба, Ашигт малтмал, газрын тосны газар зэргээр/

Гадаад харилцааны яам

2.Захиргааны байгууллагаас тухайн захиргааны актад уг актыг гаргах болсон бодит нөхцөл байдлыг зайлшгүй дурдах талаар мэддэг үү?

- Мэддэг
- Үгүй

3.Мэддэг бол ямар хуульд энэ шаардлага байдаг вэ, та захиргааны актыг боловсруулах, гаргах үедээ акт гаргах болсон бодит нөхцөл байдал, шалтгааныг тодорхойлон зааж, дурдаж байсан уу?

- Тийм
- Үгүй

4.Захиргааны акт гаргах шаардлага бүхий бодит нөхцөл, байдал гэдгийг Та юу гэж ойлгож байна вэ? Жишээгээр илэрхийлж болно.

- Ажлаас чөлөөлөх шийдвэрийн хувьд бүтэц, орон тоо өөрчлөгдсөн нөхцөл байдал
- Газар эзэмших эрх хүчингүй болгох шийдвэрийн хувьд бусдын газартай давхцал бий болсон
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүчингүй болгох шийдвэрийн хувьд тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлт гаргаагүй нь баримтаар тогтоогдож байгаа
- Дээр дурдсан бүх нөхцөл байдлыг бодит нөхцөл байдалд тооцно

5.Танай байгууллагын хувьд захиргааны актыг иргэн, хуулийн этгээдэд мэдэгдэх ажиллагааг явуулахад ямар хүндрэл учирч байна вэ?

- Иргэн, хуулийн этгээд шийдвэрээ гардан авдаггүй
- Иргэн, хуулийн этгээд хаягтаа байдаггүй тул байгууллагад буцан ирдэг
- Мэдэгдсэн хугацааг тодорхойлоход хүндрэлтэй байдаг
- Бусад /энэ хариултыг дугуйлсан бол Та дэлгэрэнгүй тайлбараа бичнэ үү/

6.Захиргааны актыг мэдэгдэх Захиргааны ерөнхий хуулийн зохицуулалтыг илүү нарийвчлах шаардлага бий юу?

- Шаардлагатай
- Шаардлагагүй

1

pdfelement

Remove Watermark Now

Ямар үндэслэл, агуулгаар энэ зохицуулалтыг сайжруулах шаардлагатай гэж Та үзэж байна вэ?

7.Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6-д “47.1.Дараах тохиолдолд захиргааны акт илт хууль бус болно: 47.1.6.иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байгаагүй;” гэж заасан заалтыг Танай байгууллагаас захиргааны акт гаргахдаа хэрэглэж байсан уу?

- Тийм
- Үгүй
- Мэдэхгүй

8.Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6-д “47.1.Дараах тохиолдолд захиргааны акт илт хууль бус болно: 47.1.6.иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байгаагүй;” гэж заасан заалт ойлгомжгүй учир дэлгэрэнгүйгээр тайлбарласан өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж Та үзэж байна уу?

- Тийм ойлгомжгүй учир хэрэглэхэд хүндрэлтэй байдаг
- Ойлгомжтой өдөр, тутам хэрэглэдэг

8.Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийг хэрэглэж захиргааны актыг цуцалж байсан тохиолдол байна уу?

- Байхгүй
- Байгаа
- Байгаа бол актын нэр, огноо, дугаарыг дурдана уу.

(49 дүгээр зүйл.Эрх зүйн зөрчилгүй захиргааны актыг цуцлах

49.1.Захиргааны актад гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаа өнгөрснөөс үл хамааран түүнийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн цуцалж болно.

49.2.Энэ хуулийн 49.1-д заасан захиргааны актыг ижил агуулгаар дахин батлах шаардлагатай, эсхүл хууль зүйн үндэслэлгүй бол цуцлахгүй.

49.3.Эерэг нөлөөлөл бүхий захиргааны актыг түүнд гомдол гаргах боломжгүй болсон хэдий ч дараах тохиолдолд цуцалж болно:

49.3.1.цуцлах нөхцөлийг хууль, захиргааны хэм хэмжээний актад, эсхүл тухайн захиргааны актад заасан бол;

49.3.2.захиргааны актад нэмэлт зохицуулалт заасан бөгөөд түүнийг тухайн этгээд хуульд заасан хугацааны дотор биелүүлээгүй бол;

49.3.3.шинэ нөхцөл байдал бий болсноор нийтийн ашиг сонирхол зөрчигдөхөөр бол;

49.3.4.хууль, захиргааны хэм хэмжээний акт өөрчлөгдсөний үндсэн дээр захиргааны байгууллага тухайн захиргааны актыг гаргах эрхгүй болсон бөгөөд уг актаар эрх олгогдсон этгээд эрхээ хэрэгжүүлж эхлээгүй бол.

2

pdfelement

49.3.5.нийтийн ашиг сонирхолд ноцтой сөрөг нөлөө үзүүлэхээс урьдчилан сэргийлэх, эсхүл түүнийг зайлуулахын тулд.

49.4.Захиргааны актаар олгосон болон олгож байгаа мөнгөн тэтгэмж, эсхүл тодорхой зорилго бүхий үйлчилгээг хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн ч уг захиргааны актыг дараах тохиолдолд бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн цуцална:

49.4.1.захиргааны актаар олгосон тэтгэмж, үйлчилгээ уг актад заасан зориулалтаар ашиглагдаагүй бол;

49.4.2.захиргааны актаар нэмэлт зохицуулалт заасан бөгөөд тухайн этгээд уг үүргийг биелүүлээгүй, эсхүл захиргааны актад заасан хугацаанд биелүүлээгүй бол.

49.5.Захиргааны байгууллагаас өөрөөр заагаагүй бол захиргааны акт цуцлагдснаар хүчин төгөлдөр бус болно.)

9.Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийг хэрэглэж захиргааны актыг цуцлах зохицуулалт нь ойлгомжгүй учир дахин дэлгэрэнгүй тайлбарлах шаардлагатай?

- Тийм ойлгомжгүй учир хэрэглэхэд хүндрэлтэй байдаг
- Ойлгомжтой өдөр, тутам хэрэглэдэг

10.Танай байгууллагын хувьд Захиргааны ерөнхий хуулийн 50 дугаар зүйлийг хэрэглэж захиргааны актыг дахин гаргаж байсан тохиолдол байна уу?

- Байхгүй
- Байгаа
- Байгаа бол актын нэр, огноо, дугаарыг дурдана уу.

pdfelement

(50 дугаар зүйл.Захиргааны акт гаргах ажиллагааг дахин хийх

50.1.Захиргааны актад гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаа дууссан хэдий ч хаяглагдсан этгээдийн хүсэлтээр дараах тохиолдолд захиргааны акт гаргах ажиллагааг дахин хийж болно:

50.1.1.захиргааны актын үндэслэж байгаа бодит эсхүл эрх зүйн нөхцөл байдал нь хаяглагдсан этгээдийн талд хожим зэрэгээр өөрчлөгдсөн;

50.1.2.хаяглагдсан этгээдийн хувьд ашигтай нотлох баримт бий болсон.

50.2.Хаяглагдсан этгээд нь өргөдөл, гомдлыг шийдвэр гаргах ажиллагааг дахин явуулах үндэслэл бий болсныг мэдсэнээс хойш гурван сарын дотор гаргана.)

9.Захиргааны ерөнхий хуулийн 50 дугаар зүйлийг хэрэглэж захиргааны актыг дахин гаргах зохицуулалт нь ойлгомжгүй учир дахин дэлгэрэнгүй тайлбарлах шаардлагатай?

- Тийм ойлгомжгүй учир хэрэглэхэд хүндрэлтэй байдаг
- Ойлгомжтой өдөр, тутам хэрэглэдэг

Remove Watermark Now

**Танд энэхүү судалгаанд оролцож байгаад талархал илэрхийлэе. Энэхүү судалгаа нь Захиргааны ерөнхий хуулийн зарим зүйл, заалтыг сайжруулах үндэслэл, шаардлагыг судлахад ашиглаж байгаа юм.**

Та дор дурдсан асуултад бүтэн **өгүүлбэрээр хариулах, эсхүл шаардлагатай хариултыг дугуйлна уу.**

1.Та захиргааны аль байгууллагад ажилладаг бэ?/Байгууллагын нэрээ тодорхой дурдана уу. /Тухайлбал, Нийслэлийн газрын алба, Ашигт малтмал, газрын тосны газар зэргээр/

СХД-н ЗДТГ-т

2.Захиргааны байгууллагаас тухайн захиргааны актад уг актыг гаргах болсон бодит нөхцөл байдлыг зайлшгүй дурдах талаар мэддэг үү?

- (•) Мэддэг
- Үгүй

3.Мэддэг бол ямар хуульд энэ шаардлага байдаг вэ, та захиргааны актыг боловсруулах, гаргах үедээ акт гаргах болсон бодит нөхцөл байдал, шалтгааныг тодорхойлон зааж, дурдаж байсан уу?

- (•) Тийм
- Үгүй

4.Захиргааны акт гаргах шаардлага бүхий бодит нөхцөл, байдал гэдгийг Та юу гэж ойлгож байна вэ? Жишээгээр илэрхийлж болно.

- Ажлаас чөлөөлөх шийдвэрийн хувьд бүтэц, орон тоо өөрчлөгдсөн нөхцөл байдал
- Газар эзэмших эрх хүчингүй болгох шийдвэрийн хувьд бусдын газартай давхцал бий болсон
- Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүчингүй болгох шийдвэрийн хувьд тусгай зөвшөөрлийн хугацаа сунгуулах хүсэлт гаргаагүй нь баримтаар тогтоогдож байгаа
- (•) Дээр дурдсан бүх нөхцөл байдлыг бодит нөхцөл байдалд тооцно

5.Танай байгууллагын хувьд захиргааны актыг иргэн, хуулийн этгээдэд мэдэгдэх ажиллагааг явуулахад ямар хүндрэл учирч байна вэ?

- Иргэн, хуулийн этгээд шийдвэрээ гардан авдаггүй
- Иргэн, хуулийн этгээд хаягтаа байдаггүй тул байгууллагад буцан ирдэг
- Мэдэгдсэн хугацааг тодорхойлоход хүндрэлтэй байдаг
- (•) Бусад /энэ хариултыг дугуйлсан бол Та дэлгэрэнгүй тайлбараа бичнэ үү/

6.Захиргааны актыг мэдэгдэх Захиргааны ерөнхий хуулийн зохицуулалтыг илүү нарийвчлах шаардлага бий юу?

- (•) Шаардлагатай
- Шаардлагагүй

1

pdfelement

Remove Watermark Now

Ямар үндэслэл, агуулгаар энэ зохицуулалтыг сайжруулах шаардлагатай гэж Та үзэж байна вэ?

Сонсох ажиллагаа.

7.Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6-д "47.1.Дараах тохиолдолд захиргааны акт илт хууль бус болно: 47.1.6.иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байгаагүй;" гэж заасан заалтыг Танай байгууллагаас захиргааны акт гаргахдаа хэрэглэж байсан уу?

- Тийм
- Үгүй
- ✓ Мэдэхгүй

8.Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6-д "47.1.Дараах тохиолдолд захиргааны акт илт хууль бус болно: 47.1.6.иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байгаагүй;" гэж заасан заалт ойлгомжгүй учир дэлгэрэнгүйгээр тайлбарласан өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж Та үзэж байна уу?

- Тийм ойлгомжгүй учир хэрэглэхэд хүндрэлтэй байдаг
- ✓ Ойлгомжтой өдөр, тутам хэрэглэдэг

8.Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийг хэрэглэж захиргааны актыг цуцалж байсан тохиолдол байна уу?

- ✓ Байхгүй
- Байгаа
- Байгаа бол актын нэр, огноо, дугаарыг дурдана уу.

(49 дүгээр зүйл.Эрх зүйн зөрчилгүй захиргааны актыг цуцлах

49.1.Захиргааны актад гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаа өнгөрснөөс үл хамааран түүнийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн цуцалж болно.

49.2.Энэ хуулийн 49.1-д заасан захиргааны актыг ижил агуулгаар дахин батлах шаардлагатай, эсхүл хууль зүйн үндэслэлгүй бол цуцлахгүй.

49.3.Эерэг нөлөөлөл бүхий захиргааны актыг түүнд гомдол гаргах боломжгүй болсон хэдий ч дараах тохиолдолд цуцалж болно:

49.3.1.цуцлах нөхцөлийг хууль, захиргааны хэм хэмжээний актад, эсхүл тухайн захиргааны актад заасан бол;

49.3.2.захиргааны актад нэмэлт зохицуулалт заасан бөгөөд түүнийг тухайн этгээд хуульд заасан хугацааны дотор биелүүлээгүй бол;

49.3.3.шинэ нөхцөл байдал бий болсноор нийтийн ашиг сонирхол зөрчигдөхөөр бол;

49.3.4.хууль, захиргааны хэм хэмжээний акт өөрчлөгдсөний үндсэн дээр захиргааны байгууллага тухайн захиргааны актыг гаргах эрхгүй болсон бөгөөд уг актаар эрх олгогдсон этгээд эрхээ хэрэгжүүлж эхлээгүй бол;

2

pdfelement

49.3.5.нийтийн ашиг сонирхолд ноцтой сөрөг нөлөө үзүүлэхээс урьдчилан сэргийлэх, эсхүл түүнийг зайлуулахын тулд.

49.4.Захиргааны актаар олгосон болон олгож байгаа мөнгөн тэтгэмж, эсхүл тодорхой зорилго бүхий үйлчилгээг хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн ч уг захиргааны актыг дараах тохиолдолд бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн цуцална:

49.4.1.захиргааны актаар олгосон тэтгэмж, үйлчилгээ уг актад заасан зориулалтаар ашиглагдаагүй бол;

49.4.2.захиргааны актаар нэмэлт зохицуулалт заасан бөгөөд тухайн этгээд уг үүргийг биелүүлээгүй, эсхүл захиргааны актад заасан хугацаанд биелүүлээгүй бол.

49.5.Захиргааны байгууллагаас өөрөөр заагаагүй бол захиргааны акт цуцлагдснаар хүчин төгөлдөр бус болно.)

9.Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийг хэрэглэж захиргааны актыг цуцлах зохицуулалт нь ойлгомжгүй учир дахин дэлгэрэнгүй тайлбарлах шаардлагатай?

- Тийм ойлгомжгүй учир хэрэглэхэд хүндрэлтэй байдаг
- ✓ Ойлгомжтой өдөр, тутам хэрэглэдэг

10.Танай байгууллагын хувьд Захиргааны ерөнхий хуулийн 50 дугаар зүйлийг хэрэглэж захиргааны актыг дахин гаргаж байсан тохиолдол байна уу?

- Байхгүй
- ✓ Байгаа
- Байгаа бол актын нэр, огноо, дугаарыг дурдана уу.

pdfelement

(50 дугаар зүйл.**Захиргааны акт гаргах ажиллагаар дахин хийх**

50.1.Захиргааны актад гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаа дууссан хэдий ч хаяглагдсан этгээдийн хүсэлтээр дараах тохиолдолд захиргааны акт гаргах ажиллагаар дахин хийж болно:

50.1.1.захиргааны актын үндэслэж байгаа бодит эсхүл эрх зүйн нөхцөл байдал нь хаяглагдсан этгээдийн талд хожим зөрсгээр өөрчлөгдсөн;

50.1.2.хаяглагдсан этгээдийн хувьд ашигтай нотлох баримт бий болсон.

50.2.Хаяглагдсан этгээд нь өргөдөл, гомдлыг шийдвэр гаргах ажиллагаар дахин явуулах үндэслэл бий болсныг мэдсэнээс хойш гурван сарын дотор гаргана.)

9.Захиргааны ерөнхий хуулийн 50 дугаар зүйлийг хэрэглэж захиргааны актыг дахин гаргах зохицуулалт нь ойлгомжгүй учир дахин дэлгэрэнгүй тайлбарлах шаардлагатай?

- Тийм ойлгомжгүй учир хэрэглэхэд хүндрэлтэй байдаг
- ✓ Ойлгомжтой өдөр, тутам хэрэглэдэг

Ямар үндэслэл, агуулгаар энэ зохицуулалтыг сайжруулах шаардлагатай гэж Та үзэж байна вэ?

Сонсох ажиллагаа.

7.Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6-д "47.1.Дараах тохиолдолд захиргааны акт илт хууль бус болно: 47.1.6.иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байгаагүй;" гэж заасан заалтыг Танай байгууллагаас захиргааны акт гаргахдаа хэрэглэж байсан уу?

- Тийм
- Үгүй
- ✓ Мэдэхгүй

8.Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6-д "47.1.Дараах тохиолдолд захиргааны акт илт хууль бус болно: 47.1.6.иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдах хуульд заасан үндэслэл байгаагүй;" гэж заасан заалт ойлгомжгүй учир дэлгэрэнгүйгээр тайлбарласан өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж Та үзэж байна уу?

- Тийм ойлгомжгүй учир хэрэглэхэд хүндрэлтэй байдаг
- ✓ Ойлгомжтой өдөр, тутам хэрэглэдэг

8.Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийг хэрэглэж захиргааны актыг цуцалж байсан тохиолдол байна уу?

- ✓ Байхгүй
- Байгаа
- Байгаа бол актын нэр, огноо, дугаарыг дурдана уу.

(49 дүгээр зүйл.Эрх зүйн зөрчилгүй захиргааны актыг цуцлах

49.1.Захиргааны актад гомдол гаргах хөөн хэлэлцэх хугацаа өнгөрснөөс үл хамааран түүнийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн цуцалж болно.

49.2.Энэ хуулийн 49.1-д заасан захиргааны актыг ижил агуулгаар дахин батлах шаардлагатай, эсхүл хууль зүйн үндэслэлгүй бол цуцлахгүй.

49.3.Эерэг нөлөөлөл бүхий захиргааны актыг түүнд гомдол гаргах боломжгүй болсон хэдий ч дараах тохиолдолд цуцалж болно:

49.3.1.цуцлах нөхцөлийг хууль, захиргааны хэм хэмжээний актад, эсхүл тухайн захиргааны актад заасан бол;

49.3.2.захиргааны актад нэмэлт зохицуулалт заасан бөгөөд түүнийг тухайн этгээд хуульд заасан хугацааны дотор биелүүлээгүй бол;

49.3.3.шинэ нөхцөл байдал бий болсноор нийтийн ашиг сонирхол зөрчигдөхөөр бол;

49.3.4.хууль, захиргааны хэм хэмжээний акт өөрчлөгдсөний үндсэн дээр захиргааны байгууллага тухайн захиргааны актыг гаргах эрхгүй болсон бөгөөд уг актаар эрх олгогдсон этгээд эрхээ хэрэгжүүлж эхлээгүй бол;

2

Remove Watermark Now

**Танд энэхүү судалгаанд оролцож байгаад талархал илэрхийлэе. Энэхүү судалгаа нь Захиргааны ерөнхий хуулийн зарим зүйл, заалтыг сайжруулах үндэслэл, шаардлагыг судлахад ашиглаж байгаа юм.**

**Та дор дурдсан асуултад бүтэн өгүүлбэрээр хариулах, эсхүл шаардлагатай хариултыг дугуйлна уу.**

1.Та захиргааны аль байгууллагад ажилладаг бэ?/Байгууллагын нэрээ тодорхой дурдана уу. /Тухайлбал, Нийслэлийн газрын алба, Ашигт малтмал, газрын тосны газар зэргээр/

НХТБЯГ

---

2.Захиргааны байгууллагаас тухайн захиргааны актад уг актыг гаргах болсон бодит нөхцөл байдлыг зайлшгүй дурдах талаар мэддэг үү?

- Мэддэг
- Үгүй

3.Мэддэг бол ямар хуульд энэ шаардлага байдаг вэ, та захиргааны актыг боловсруулах, гаргах үедээ акт гаргах болсон бодит нөхцөл байдал, шалтгааныг тодорхойлон зааж, дурдаж байсан уу?

- Тийм
- Үгүй

| 7 | Дугаар: 331<br>Огноо: 2017-05-02<br>/Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр./<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3254/view<br><br>Дугаар: 484<br>Огноо: 2017-07-04<br>/ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх /<br>http://new.shuukh.mn/zahirgaadavah/1305/view<br><br>Дугаар:347<br>Огноо: 2017-10-04<br>/Улсын дээд шүүх/<br>http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/1004/view | "Сонин хад" ХХК | Ашигт малтмал, газрын тосны газрын дарга | • **Ашигт малтмал**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>"Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн а/63 дугаар тушаалын нэг дэх хэсгийн "2016 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн а/41 дүгээр" гэснийг хүчингүй болгуулах"<br>Шийдвэрлэсэн байдал:<br><br>Шүүхийн шийдвэрийн ТОГТООХ хэсгийн 1 дэх заалтаар: Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Захиргааны ерөнхий хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 48 дугаар зүйлийн 48.2.1-д заасныг баримтлан "Сонин хад" ХХК-иас Ашигт малтмал, газрын тосны газрын даргад холбогдуулан гаргасан "Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн а/63 дугаар тушаалын нэг дэх хэсгийн "2016 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн а/41 дүгээр" гэснийг хүчингүй болгуулах" тухай ***<u>нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож,</u>***<br><br>2 дахь заалтаар: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 51 дүгээр зүйлийн 51.1-д зааснаар нэхэмжлэгчээс улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 70200 /далан мянга хоёр зуун/ төгрөгийг ***<u>улсын орлогод хэвээр үлдээж шийдвэрлэжээ.</u>***<br><br>Давж заалдах шатны шүүх шийдвэрлэсэн байдал:<br>Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 128/ШШ2017/0331 дүгээр шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасугай<br><br>Улсын дээд шүүх шийдвэрлэсэн байдал:<br>Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 221/МА2017/0484 дүгээр магадлалыг хүчингүй болгож, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 128/ШШ2017/0331 дүгээр шийдвэрийг хэвээр үлдээсүгэй |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 8 | Дугаар: 00012<br>Огноо: 2017-04-17<br>/Хөвсгөл аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр./<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/2967/view | Цогнууд Батчулууны Одончимэг | Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын газар | • **Бусад**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>"Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 2016 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн Б/18, 2016 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн Б/33 дугаар тушаалуудыг хүчингүйд болгуулах, Б.Одончимэгийг Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Захиргаа удирдлагын хэлтсийн даргын албан тушаалд эгүүлэн томилохыг Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын газарт даалгах"<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Шүүхийн шийдвэрийн ТОГТООХ хэсгийн 1 дэх заалтаар: Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1, 48 дугаар зүйлийн 48.2, Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, Хөдөлмөрийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.4-т заасныг баримтлан Цогнууд Батчулууны Одончимэгийн нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг ханган Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 2016 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн Б/18 дугаар тушаалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагын үлдсэнийг буюу "Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын газрын даргын 2016 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн Б/33 дугаар тушаалыг хүчингүй болгуулж, Б.Одончимэгийг Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Захиргаа удирдлагын хэлтсийн даргын албан тушаалд эгүүлэн томилохыг Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын газарт даалгах" ***шаардлагуудыг хэрэгсэхгүй болгож,***<br><br>2 дахь заалтаар: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар 48.1, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-т зааснаар нэхэмжлэгчийн улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 70 200 /далан мянга хоёр зуу/ төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээж, хариуцагч Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 70 200 /далан мянга хоёр зуу/ төгрөг гаргуулан ***нэхэмжлэгч Б.Одончимэгт олгож шийдвэрлэжээ.*** |
| 9 | Дугаар: 15<br>Огноо: 2017-02-16<br>/Дархан-Уул аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр./<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/2745/view | Н.Пүрэвдаш | Дархан-Уул аймгийн Засаг дарга | • **Газар**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>"Дархан-Уул аймгийн Засаг даргын 2016 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/443 дугаар Газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох тухай захирамжийн Н.Пүрэвдашид холбогдох хэсгийг хүчингүй болгуулах"<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Шүүхийн шийдвэрийн ТОГТООХ хэсгийн 1 дэх заалтаар: Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1, 4.2.6, 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27 дугаар зүйлийн 27.2, 29 дүгээр зүйлийн 29.1, 48 |

Remove Watermark Now
pdfelement

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | дугаар зүйлийн 48.2.2, Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.4, 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсгийг тус тус заасныг баримтлан нэхэмжлэгч Н.Пүрэвдашийн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, хариуцагч Дархан-Уул аймгийн Засаг даргын 2016 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/443 дугаар газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох тухай захирамжийн ***<u>Н.Пүрэвдашид холбогдох хэсгийг хүчингүй болгож,</u>***<br><br>2 дахь заалтаар: Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-д зааснаар нэхэмжлэгч Н.Пүрэвдашаас улсын тэмдэгтийн хураамжид урьдчилан төлсөн 70200 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээж, хариуцагчаас улсын тэмдэгтийн хураамжид 70200 төгрөг гаргуулж ***<u>нэхэмжлэгчид олгож шийдвэрлэжээ.</u>*** |
| 10 | Дугаар: 14<br>Огноо: 2017-02-16<br>/Дархан-Уул аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр./<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/2744/view | Д.Пүрэвдаш, С.Баярсайхан | Дархан-Уул аймгийн Засаг дарга | • **Газар**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>“Дархан-Уул аймгийн Засаг даргын 2016 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/441 дүгээр захирамжийн Д.Пүрэвдаш, С.Баярсайхан нарт холбогдох хэсгийг хүчингүй болгуулах”<br>Шийдвэрлэсэн байдал:<br><br>Шүүхийн шийдвэрийн ТОГТООХ хэсгийн 1 дэх заалтаар: .Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1, 4.2.6, 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.2, 48 дугаар зүйлийн 48.2.2, Газрын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэгт тус тус заасныг баримтлан нэхэмжлэгч Д.Пүрэвдаш, С.Баярсайхан нарын нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, хариуцагч Дархан-Уул аймгийн Засаг даргын 2016 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/441 дүгээр газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох тухай захирамжийн ***<u>Д.Пүрэвдаш, С.Баярсайхан нарт холбогдох хэсгийг хүчингүй болгож,</u>***<br><br>2 дахь заалтаар: .Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-д зааснаар нэхэмжлэгч Д.Пүрэвдаш, С.Баярсайхан нараас улсын тэмдэгтийн хураамжид урьдчилан төлсөн нийт 140400 төгрөгөөс улсын орлогод 70200 төгрөгийг хэвээр үлдээж, улсын орлогоос улсын тэмдэгтийн хураамжид илүү төлсөн 70200 төгрөгийг гаргуулж Д.Пүрэвдаш, С.Баярсайхан нарт тус бүр 35100 төгрөгийг, хариуцагчаас улсын тэмдэгтийн хураамжид 70200 төгрөг гаргуулж нэхэмжлэгч нарт нарт тус бүр 35100 төгрөгийг ***<u>тус тус олгож шийдвэрлэжээ.</u>*** |

pdfelement
Remove Watermark Now

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| 11 | Дугаар: 12<br>Огноо: 2017-02-15<br>/Дархан-Уул аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр./<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/2691/view | Д.Дунгаамаа, З.Чулуунбаатар, Д.Дэлгэрбаяр, Л.Пүрэвжав, Н.Цолмон, Ж.Насанжаргал, Я.Мөнхсувд болон М.Ундрах, Д.Мөнхбилэг, Ж.Гармаа, Д.Бямбасан, Б.Нина, Ч.Алтанбаатар | Дархан-Уул аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал | • **Газар**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>“Дархан-Уул аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 108 дугаар тогтоолыг хүчингүй болгуулах тухай”<br>Шийдвэрлэсэн байдал:<br><br>Шүүхийн шийдвэрийн ТОГТООХ хэсгийн 1 дэх заалтаар: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.2-т заасанаар нэхэмжлэгч С.Эрдэнэчулуун нь шүүх хуралдааны явцад Дархан-Уул аймгийн Засаг даргын 2016 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/437, А/438 дугаар захирамжуудын өөрт холбогдох хэсгийг хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлийн шаардлагаасаа татгалзсан тул холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, ***нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсаныг баталж,***<br><br>2 дахь заалтаар: Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 15 дугаар зүйлийн 15.1, 47 дугаар зүйлийн 47.1, 48 дугаар зүйлийн 48.2, 49 дүгээр зүйлийг 49.3-т заасныг баримтлан нэхэмжлэгч Д.Дунгаамаа, З.Чулуунбаатар, Д.Дэлгэрбаяр, Л.Пүрэвжав, Н.Цолмон, Ж.Насанжаргал, Я.Мөнхсувд болон М.Ундрах, Д.Мөнхбилэг, Ж.Гармаа, Д.Бямбасан, Б.Нина, Ч.Алтанбаатар нарын итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Цэнд-Аюуш нарын нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж Дархан-Уул аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 108 дугаар ***тогтоолыг хүчингүй болгож***<br><br>3 дахь заалтаар: Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 15 дугаар зүйлийн 15.1, 47 дугаар зүйлийн 47.1, 48 дугаар зүйлийн 48.2, 49 дүгээр зүйлийг 49.3, Газрын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1-д заасныг баримтлан нэхэмжлэгч нарын нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж Дархан –Уул аймгийн Засаг даргын 2016 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/437 дугаар “Газар эзэмших эрхийг хүчингүй болгох тухай” захирамжийн нэхэмжлэгч З.Чулуунбаатар, Д.Дэлгэрбаяр, Л.Пүрэвжав, Н.Цолмон, Ж.Насанжаргал, Я.Мөнхсувд, М.Ундрах, Мөнхбилэг, Д.Дунгаамаа, Б.Батхуяг, Б.Ганзориг нарт, А/438 дугаар “Газар өмчлөх эрхийг хүчингүй болгох тухай” захирамжийн нэхэмжлэгч З.Чулуунбаатар, Д.Дэлгэрбаяр, Л.Пүрэвжав, Н.Цолмон, Ж.Насанжаргал, Я.Мөнхсувд, М.Ундрах, Д.Дунгаамаа, Б.Батхуяг, Б.Ганзориг нарт А/441 дүгээр “Газар эзэмших эрхийг хүчингүй болгох тухай” захирамжийн нэхэмжлэгч Д.Цэнд-Аюуш, Ж.Гармаа, Д.Бямбасан, Ч.Алтанбаатар, Б.Нина нарт болон ”Атаман стиль” ХХК-д холбогдох хэсгийг ***тус тус хүчингүй болгож***<br><br>4 дэх заалтаар: Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | 56 дугаар зүйлийн 56.1, 57 дугаар зүйлийн 57.3, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 60 дугаар зүйлийн 60.1-д зааснаар нэхэмжлэгч нараас улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 70200 төгрөгийг төрийн санд хэвээр үлдээж, хариуцагч Дархан-Уул аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас 35100 төгрөг, аймгийн Засаг даргын Тамгын газраас 35100 төгрөгийг тус тус гаргуулан нэхэмжлэгч нарт, нэхэмжлэгч нараас илүү төлсөн 280.800 төгрөгийг ***төрийн сангаас гаргуулан нэхэмжлэгч нарт буцаан олгож шийдвэрлэжээ.*** |
| 12 | Дугаар: 1027<br>Огноо: 2016-12-20<br>/Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр./<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/2476/view | “Эм Ди глобал трейдинг” ХХК<br><br>**Гуравдагч этгээд**: “Оюу цагаан барс” ХХК<br>**Гуравдагч этгээд:** “Ирмүүн аргамаг” ХХК | Байгаль орчин ногоон хөгжил аялал жуулчлалын яам /хуучнаар/-ны Байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн улмаас хураагдсан эд зүйлийг үнэлэх, худалдан борлуулах, устгах шилжүүлэх Орон тооны бус зөвлөл | • **Бусад**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>“Байгаль орчин ногоон хөгжил аялал жуулчлалын яам /хуучнаар/-ны Байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн улмаас хураагдсан эд зүйлийг үнэлэх, худалдан борлуулах, устгах шилжүүлэх Орон тооны бус зөвлөлийн 2016 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 02/02, 2016 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 02/03 дугаартай шийдвэрийг илт хууль бус болохыг тогтоож, хүчингүй болгуулах”<br><br>Шийдвэрлэсэн байдал:<br>Шүүхийн шийдвэрийн ТОГТООХ хэсгийн 1 дэх заалтаар: Захиргааны ерөнхий хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь хэсэгт заасныг баримтлан нэхэмжлэгч “Эм ди глобал трейдинг” ХХК-ийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, Байгаль орчин ногоон хөгжил аялал жуулчлалын яам /хуучнаар/-ны Байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлийн улмаас хураагдсан эд зүйлийг үнэлэх, худалдан борлуулах, устгах шилжүүлэх Орон тооны бус зөвлөлийн2016 оны 4 дүгээр сарын 28-ны өдрийн 02/02, 2016 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн 02/03 дугаартай шийдвэрийг ***илт хууль бус болохыг тогтоож, хүчингүй болгож,***<br><br>2 дахь заалтаар: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэгт зааснаар нэхэмжлэгчээс улсын тэмдэгтийн хураамжид урьдчилан төлсөн 70200 (далан мянга хоёр зуун) төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээж, хариуцагчаас 70200 (далан мянга хоёр зуун) төгрөгийг гаргаж ***нэхэмжлэгчид олгож шийдвэрлэжээ.*** |
| 13 | Дугаар: 11<br>Огноо: 2017-02-09<br>/Дархан-Уул аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр./<br>http://new.shuukh.mn/zahirgaaanhan/2177/view | “Мөнх зол улам дэлгэр” ХХК | Дархан-Уул аймгийн Засаг дарга | • **Бусад**<br>Нэхэмжлэлийн шаардлага:<br>“Дархан-Уул аймгийн Засаг даргын 2016 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/441 дугаартай “Газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох тухай” захирамжийн “Мөнх зол улам дэлгэр” ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгуулах” |

pdfelement

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | Шийдвэрлэсэн байдал:<br><br>Шүүхийн шийдвэрийн ТОГТООХ хэсгийн 1 дэх заалтаар: .Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.1, 4.2.6, 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.2 , 48 дугаар зүйлийн 48.2.2, Газрын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсгийг тус тус заасныг баримтлан нэхэмжлэгч "Мөнх зол улам дэлгэр" ХХК-ийн нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, хариуцагч Дархан-Уул аймгийн Засаг даргын 2016 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн А/441 дүгээр "Газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох тухай" захирамжийн ***"Мөнх зол улам дэлгэр" ХХК-д холбогдох хэсгийг хүчингүй болгож,***<br><br>2 дахь заалтаар: Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-д зааснаар нэхэмжлэгч "Мөнх зол урам" ХХК-иас улсын тэмдэгтийн хураамжид урьдчилан төлсөн 70200 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээж, хариуцагчаас улсын тэмдэгтийн хураамжид 70200 төгрөг гаргуулж ***нэхэмжлэгчид олгож шийдвэрлэжээ.*** |

Remove Watermark Now
pdfelement

Remove Watermark Now

**Хавсралт 18**

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ
САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Н.ЦЭВЭЛМААТАЙ ХИЙСЭН ЯРИЛЦЛАГЫН ТЭМДЭГЛЭЛ

Ярилцлагыг 2018 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 15 цагт Хууль зүй, дотоод хэргийн яамны 208 тоот өрөөнд, ярилцагчид урьдчилан мэдэгдэж зөвшөөрөл авсны үндсэн дээр хийв.

Судлаач: Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах Хууль зүй, дотоод хэргийн дэд сайдаар ахлуулсан Ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн үр дагаварт Ханнс Зайделийн сантай хамтарсан судалгааны баг гарч үнэлгээ хийж байгаа болно. Судлаач миний хувьд Захиргааны ерөнхий хуулийн 10 дугаар бүлэг Хохирол барагдуулахтай холбоотой хэсэгт үнэлгээ хийж байна.

Өөрөөр хэлбэл танаас төрийн буруутай үйл ажиллагааны улмаас иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирлыг барагдуулах ажиллагааны талаар ярилцлага хийх болно. Ингээд ярилцлагаа эхлүүлье.

Судлаач: Төрийн буруутай үйл ажиллагааны улмаас иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирол барагдуулах ажиллагаанд Хууль зүй, дотоод хэргийн яам ямар эрх зүйн хэм хэмжээний хүрээнд, ямар чиг үүрэгтэйгээр оролцдог талаар Та дэлгэрэнгүй тайлбарлаж өгнө үү?

Судалгаанд оролцогч: Хууль зүй, дотоод хэргийн сайд бол Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагч, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар бол төсвийн төвлөрүүлэн захирагч, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар нь төсвийн шууд захирагч юм. Төсвийн тухай хуулиараа төсвийн ерөнхийлөн захирагч нь жил бүрийн төсвөө төлөвлөөд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлдэг. Энэ үйл ажиллагаа нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цагалбарын дагуу явагддаг. Тэр цагалбарын дагуу манай яам төсвийн төслөө боловсруулж, хүргүүлэхдээ доод шатны байгууллага буюу төсвийн шууд захирагч нараас гаргасан саналыг авч үздэг бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас тухайлбал үндэслэл бүхий, шүүхийн шийдвэр нь эцэслэгдээд гарчихсан, шийдвэр гүйцэтгэлийн албан дээр ирчихсэн байгаа шүүхийн шийдвэрүүдийн жагсаалтыг авдаг юм.

Ер нь энэ төр буруутай шийдвэр гагаснаас хохирол барагдуулах ажиллагаа 2009 оноос буюу Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль хэрэгжиж байх тэр үеэс дээр дурдсан байдлаар буюу Хууль зүй, дтоод хэргийн төсвийн багцад тодорхой хөрөнгө тусгагдах замаар явагддаг болсон. 2009 оноос эхлээд Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсвийн багцад “төрийн буруутай үйл ажиллагааны улмаас иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирлын нөхөн төлбөрийн зардал” гэсэн нэртэйгээр тусгагдаж явж байгаа. Төсөв боловсруулах, хүргүүлэх, батлах үйл ажиллагааны цаг хугацаанаас хамаараад төсвийн жилийн хугацааны дундуур төлөвлөгдөөгүй орж ирэх шүүхийн шийдвэрүүд мөн байдаг. Гэтэл тухайн жилд батлагдсан төсөв маань өмнөх хугацаанд буюу яг төсвийн цагалбараар тасалбар болгогддог. Энэ маань юу гэсэн үг вэ гэхээр бид 8 сарын 15-ны дотор Сангийн яаманд төсвийн саналаа хүргүүлсэн байдаг. 8 сард хүргүүлэхийн тулд 6 сараас 7 сарын 15 хүртэл харьяа агентлаг, байгууллагуудаас саналыг авч эхэлдэг. Ингээд Сангийн яам 9 сарын 15-нд Засгийн газарт хүргүүлээд, Засгийн газар 11 сард УИХ-д өргөн мэдүүлээд УИХ хэлэлцэж батлах гэсээр 12 сартай золгодог. Тэгэхээр төсвийг боловсруулж, батлуулахад бүтэн 6 сар зарцуулдаг байна.

Өөрөөр хэлбэл бүтэн 6 сарын өмнө төрөөс хохирол учруулсан нь тогтоогдон гарсан шүүхийн шийдвэрүүдийг нэгтгээд, нэгтгэхдээ Улаанбаатар болон орон нутагт гарсан, улсын хэмжээнд гарсан шүүхийн шийдвэр нь манай Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шийдвэр гүйцэтгэх хуудсаа бичүүлээд ирчихсэн тохиолдолд тэр шийдвэрийг биелүүлэхийн тулд шаардлагатай төсвийг батлуулахаар нэгтгэсэн дүнгээр бид саналаа тавьж байна гэсэн үг юм. За ингээд 2011 онд бид хуримдлагдсан, биелэгдээгүй байсан хохирол барагдуулах ажиллагааг бараг дуусгачихлаа даа гэж харж байсан ч төсвийн жилийн хугацааны дундаар маш их шийдвэрүүд гарсан. Энээс болоод бидэнд одоо ямар хүндрэл гарч байна гэхээр тэр төсөв батлагдаад өгөх ёстой хүмүүстээ өгчихлөө, батлагдаад ирсэн мөнгөнд ямар учраас Хууль зүй, дотоод хэргийн сайд оролцоод байна вэ гэдэг асуудлыг маш олон газар тавьдаг. Уг үнэндээ төсвийн ерөнхийлөн захирагч Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны бүрэн эрхийнхээ хүрээнд оролцож байгаа. Тэр утгаараа Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас ирүүлсэн саналыг хүлээж аваад тэрэн дээр нь мөнгийг нь олго гэсэн тушаал гардаг юм. Энэ л процедур манай яамаар явж байгаа түүнээс биш манай яам шийдвэр гүйцэтгэх ажиллагааг гардаад хийгээд байгаа асуудал биш.

Судлаач: Өөрөөр хэлбэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар маань төрийн захиргааны байгууллагын бүдүүвчийн хувьд Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудалд хамаарч байгаа учраас, Хууль зүй дотоод хэргийн сайд маань төсвийн ерөнхийлөн захирагч болохын

хувьд өөрийн батлагдсан төсвийг хуваарилах тэр хүрээндээ оролцож байгаа юм байна. Тийм үү? Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар дээр шүүхээс гарч байгаа төрийн гэм буруутай үйл ажиллагаатай холбоотой бүх шийдвэрүүд очдог уу?

Судалгаанд оролцогч: Бүгд очихгүй л дээ. Хэргийн оролцогч болсон иргэн өөрөө шүүхийн шийдвэрийг аваад, түүнийг нөгөө тал биелүүлэхгүй болохоор л Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар дээр шийдвэрээ бариад очсон тохиолдолд шийдвэр гүйцэтгэх хуудас бичигдэж байгаа. Түүнээс шүүхээс ийм шийдвэр гаргалаа гэж албан ёсоор шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт хүргүүлдэггүй.

Судлаач: Та бол шүүхийн гаргасан шийдвэрийг биелүүлэхийн тулд төсвийг хэрхэн баталдаг, хэрхэн хуваарилдаг талаас нь энэ ажиллагаанд оролцож байна. Харин буцаад төрийн хохиролгүй болгох ажиллагаанд танай нэгжийн оролцоо бол байхгүй биз дээ?

Судалгаанд оролцогч: Төрийг эргээд хохиролгүй болгох ажиллагаанд манай нэгж оролцох чиг үүрэг байхгүй тул оролцохгүй байгаа. Хуулийнхаа хувьд ч тийм байгаа.

Судлаач: Та шүүхийн шийдвэрээр иргэн, хуулийн этгээдийг хохиролгүй болгох ажиллагаанд учирж байгаа хүндрэл бэрхшээлийг юу гэж харж байна вэ?

Судалгаанд оролцогч: Санхүүгийн хүний зүгээс харахад хуульд заасан тухайлбал Иргэний хууль, Төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хуульд заасан байгаа тэр этгээдүүд маань буцаагаад тэр мөнгийг нь төсөвт байршуулах эрх хэмжээ байдаггүй л юм байна лээ. Жишээ дотоод аудитор байлаа гэхэд тэр хүн буруутай этгээдээс чиний буруутай үйл ажиллагаанаас учирсан хохирлыг төр барагдуулчихлаа. Одоо тэр мөнгийг буцаагаад төл гэж хэлэх процесс, эрх нь тэр хүнд байхгүй байгаа. Хэрвээ шүүхийн шийдвэр дээрээ буцаагаад төрийг хохиролгүй болгох асуудлыг тэр этгээд хариуц гэсэн агуулга байж байж л буцаагаад төрийг хохиролгүй болгох тэр ажиллагаа хэрэгжинэ. Энэ бол төсвийн мэргэжилтэн хүний хувьд харж байгаа өнцөг. Одоо байгаа хуулин дээр байгаа заалтуудаар бол шийдэгдэхгүй.

Судлаач: Жилд ойролцоогоор хохирол барагдуулахад зориулж ямар хэмжээний мөнгө төсөвт сууж байгаа вэ?

Судалгаанд оролцогч: 2 тэрбум 200 сая орчим төрөг сууж байгаа.

Судлаач: Тэр мөнгө хүрэлцдэг үү?

Судалгаанд оролцогч: Хүрэлцэхгүй ш дээ. Хугацааны дундуур маш их шүүхийн шийдвэр гардаг. Энэ шийдвэрийг бид тооцох ямар ч боломж байхгүй. Бидний өгч байгаа санал бол 2 тэрбумаар биш ш дээ. 17, 18, 20 тэрбум төгрөг гэж саналаа хүргүүлдэг. Тэгтэл танай төсвийн хязгаар ийм байна гээд л 2,28 тэрбум орчим төгрөг баталж өгдөг. Бид баталж өгсөн мөнгөндөө багтаагаад шүүхийн шийдвэрийн он, сар өдрийн дарааллаар нь, түүн дотроо эрүүгийн хэргийн улмаас хэлсээр хохирсон этгээдийн мөнгийг хугацаа харгалзахгүй нэн тэргүүнд гаргаж өгөх гэсэн зарчмаар л хуваарилж байна. Улсын төсөв гэдэг чинь дотроо хэд ангилчихсан нэг л сав байгаа ш дээ. Хэдийгээр шүүхийн шийдвэр дээр Засгийн газрын нөөц сангаас гэж заасан боловч танай сайдын багцад хохиролд зориулсан мөнгө батлагдсан учир тэндээсээ гаргачихаа гэдэг саналыг Сангийн яам ч тавьдаг бид хүлээж авдаг. Тэгэхээр л мөн нь өмнө нь төлөвлөсөн мөнгөнөөс бас л хасагдаад явдаг болохоор бусал шийдвэрүүд тэр хэмээр хойшилдог.

Судлаач: Тэгэхээр бүх хохирлыг барагдуулахаар хэмжээний мөнгө төсөвт батлагддаггүй учир хуримтлагдаад л яваад байна гэсэн үг юм байна. Нөгөө хохирсон иргэн, хуулийн этгээдүүд маань дараалаа хүлээгээд л байж байгаа гэсэн үг үү?

Судалгаанд оролцогч: Зарим шийдвэр нь тухайлсан төрийн байгууллагаас ав гэж бас гарч байгаа л даа. Шийдвэр гүйцэтгэгч нар бол тухайн байгууллага дээр нь очиж байгаа л даа. Томоохон үнийн дүнтэй зүйл бол ихэвчлэн тендерийн маргаан л явж байгаа. Мөн концессийн асуудал байна. Хувь хүний хувьд бол төрийн албан хаагчийг үндэслэлгүйгээр ажлаас халсан асуудал байдаг. Энэ тохиолдолд бол тухайн байгууллага нь хохирлыг барагдуулж байгаа тохиолдол бас байна. Мөн шүүхийн шийдвэр дээр тэр байгууллагаас гарга гэж заaж өгдөг боловч тэр байгууллагын ямар нөөцөөс гаргахыг заaж өгөхгүй байгаа. Үүнийг тодорхой заагаад өгчих юм бол тухайн байгууллагын



Remove Watermark Now
pdfelement

Remove Watermark Now

төсвийн захирагч бас зоригтой шийдээд байгууллагынхаа төсвөөс иргэний хохирлыг барагдуулах арга хэмжээг авчихна ш дээ. Ерөнхийд нь заагаад өгчихөөр манай байгууллага энэнд зориулсан мөнгө байхгүй гээд л суугаад байна ш дээ.

Судлаач:Шүүхийн шийдвэр дээр холбогдох байгууллагыг нэрлэн заасан боловч Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцаас мөн л гарч байгаа юу?

Судалгаанд оролцогч: Тийм ш дээ. Еөрөөсөө л төрөөс гэдгээрээ манайх мөнгө байхгүй гээд шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй болохоор Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар маань тэр төрийн байгууллага дээр албадан гүйцэтгүүлэх арга хэмжээ авч болохгүй байгаа учраас манайхруу ирүүлээд эндээс гаргаж байгаа ш дээ. Та бүхний судалгааны цөм бол хэдий хэмжээний мөнгийг төр гаргасны гэдгийг нэг талдаа гаргах байх, нөгөө талдаа шүүхийн шийдвэр гарахдаа хохирлыг хэрхэн тооцсон юм вэ гэдэг бол маш сонин л байдаг. Газар эзэмших эрхээ хүчингүй болгочихоод би тэр газраас ногоо тарьсан бол хэдэн төгрөгийн ашиг олохоор байсан гээд нэхэмжилснийг шүүх яаж тогтоогоод байна вэ гэдэг бол үндэслэл нь тодорхой биш л байдаг. Гэхдээ төр хохироосон иргэн, хуулийн этгээдийг хохиролгүй болгох тэр үүргээ тодорхой хэмжээнд биелүүлж яваа. 2017 онд бид улсын төсөвт 18 тэрбум төгрөг батлуулаад за бараг “тэглэчихлээ” дээ гэж тооцож байсан ч дахиад л маш их шийдвэрүүд гарч ирээд байна. Үүний үр дүнд маш олон жил хүлээгдсэн байгууллагуудын хохирлыг барагдуулсан боловч одоо дахиад гараад ирчихсэн байна. 2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар 8 тэрбум төгрөг хэрэгтэй гээд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас жагсаалт ирж байна. Ингээд үзэхээр энэ ажлыг хийгдэхгүй байна гэж хэлж болохгүй. Төр ямар нэг байдлаар өөрийнхөө хариуцлагыг үүрээд яваад байгаа боловч нөгөө талдаа төрийг буцаагаад хохиролгүй болгох асуудал огт шийдэгдэхгүй байна.

Судлаач: Иргэд, байгууллага шүүхийн шийдвэрийн талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хандсан тохиолдолд энд бүртгэгдэж явдаг юм байна тийм үү?

Судалгаанд оролцогч: Тийм. Гэхдээ хүмүүс бас янз бүрийн ойлголттой яваад байдаг. Зарим нь шууд Хууль зүй, дотоод хэргийн яаман дээр ирээд танайх барагдуулдаг гэсэн энийг барагдуул гээд байх нь байна. Зарим нь бүр Сангийн яаман дээр очоод барагдуул гээд байдаг. Гэтэл Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хандаад тэр байгууллага тухайн буруутай байгууллагаруу албан журмаар хандаад тэгээд тэр шийдвэр биелэгдэхгүй бол Хууль зүйн сайдын тушаалаар манай иөсвөөс гаргадаг ийм л процесс яваад байгаа юм л даа.

Судлаач: Энэ харилцаанд үйлчилдэг Сайдуудын баталсан захиргааны хэм хэмжээний акт байгаа юу?

Судалгаанд оролцогч: Сангийн сайд ч бай, Хууль зүй, дотоод хэргийн сайд ч бай аль алиных нь баталсан тушаал, хэм хэмжээний акт гэж байхгүй байгаа. Иргэний хууль, Төрийн албаны тухай хууль, Захиргааны ерөнхий хуульд заасан зохицуулалтын хүрээнд л үйлчилж байна даа.

Судлаач: За танд судалгааны ажилд дэмжлэг үзүүлж ярилцлага өгсөнд баярлалаа. Амжилт хүсье.

Судалгаанд оролцогч: За баярлалаа. Шаардлагатай мэдээллийг гаргаж өгч болно.” гэснээр ярилцлага 2018 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 15:45 минутад өндөрлөв.

Судалгаанд оролцогч:
ХЗДХЯ-ны Санхүү, хөрөнгө оруулалтын
хэлтсийн дарга Н.Цэвэлмаа

Судлаач:
Захиргааны ерөнхий хуулийн
Хэрэгжилтийг үнэлэх судалгааны баг
Судлаач: Б.Алтантуяа

pdfelement

Remove Watermark Now

# ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛИЙН ГАЗРЫН МЭРГЭЖЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА Ч.ӨНӨРЦЭЦЭГ

Ярилцлага 2018 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 11:00 цагт Хууль зүй, дотоод хэргийн яамны 312 тоот өрөөнд болов.

Судлаач: Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд энэ хүрээнд хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх судалгаа хийгдэж байгаа юм. Энэ хүрээнд миний бие ЗЕХ-ийн 10 дугаар бүлэг буюу Хохирол барагдуулах хэсгийг үнэлэх юм. Тэгээд Таныг өнөөдөр судалгааны оролцохоор хүрээд ирсэнд баяртай байна. Би танаас дараахь асуултыг асууя. Иргэний хууль дээр байдаг төрийн учруулсан гэм хорыг арилгах асуудал Захиргааны ерөнхий хуульд мөн сууж орж ирсэн бөгөөд төрийн буруутай үйл ажиллагаанаас иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирлыг барагдуулах үүргийг төр хүлээх тухай зохицуулалт юм.

Энэ хүрээнд буюу төр, түүний албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас учирсан хохирлыг барагдуулах талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар ямар чиг үүрэгтэй оролцдог вэ? Энэ талаар эхлээд тодорхой тайлбарлана уу?.

Судалгаанд оролцогч: Төрийн буруутай үйл ажиллагаанаас учирсан хохиролтой холбоотой шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны онцлог нь төлбөр төлөгч маань өөрөө төрийн аль нэг байгууллага байдаг. Ажиллагааны хувьд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 93 дугаар зүйлд заасны улсын төсвөөс санхүүжиж байгаа байгууллагын хувьд түүн дээр явуулах шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа бусад хуулийн этгээдийг бодвол арай хязгаартай, онцлогтой байдаг. Бусад хуулийн этгээдийн хувьд шүүхийн шийдвэрийг биелүүлэхийн тулд хөрөнгөнд ажиллагаа хийгддэг, дансыг битүүмжилдэг гэх мэт арга хэрэгслийг ашигладаг бол улсын төсөвт байгууллагын тухайд зориулалт бүхийн мөнгө байвал түүнээс нь гаргуул, байхгүй бол дараа жилийн төсөвт нь суулга гэсэн үндсэн зохицуулалт байдаг. Яг энэ зохицуулалтын хүрээнд төрийн байгууллагатай холбоотой шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа явагдаж байгаа. 2009 он хүртэл энэ төрлийн шийдвэр гүйцэтгэх хуудас биелэгдэхгүй манайд хуримтлагдчихсан байсан. Тухайн жилийн төсөвт суудаггүй байсан. Үүн дээр Хууль зүй, дотоод хэргийн яам ч нилээд анхаарч байгаа бөгөөд ингээд 2009 оноос хойш Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсвийн багцад тодорхой хэмжээний мөнгө тусгуулаад тэр хөрөнгийн хүрээнд хуваарилалт хийгээд явдаг ийм тогтолцоо сүүлийн хэдэн жил үйлчлээд явж байгаа.

Судлаач: Тэр мөнгө бол зөвхөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудалд хамаарах агентлаг байгууллагад хамааралтай юу? Улсын хэмжээнд байгаа нийт улсын төсөвт байгууллагад хамааралтай мөнгө үү?

Судалгаанд оролцогч: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 93 дугаар зүйлийн хэрэгжилтийг хангахын тулд нэг сайдын багц дээр тавьж өгч байгаа мөнгө л дөө. Улсын хэмжээнд нийт улсын төсөвт байгууллагад хамааралтай. Сүүлийн жилүүдэд санхүүжилт бага тавигдаад байгаа тул шүүхийн шийдвэрүүд биелэгдэхгүй нилээн хуримтлагдаад байна. Мөн зарим тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиилагааг тухайн байгууллага дээр хийхэд зарим байгууллага өөрийн төсвөөс хөрөнгө гаргаж шийдэх тохиолдолд бас байдаг. Зөвхөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцаас л төлөгдөх ёстой гэсэн үг бас биш.

Судлаач: Төрийн буруутай үйл ажиллагааны улмаас иргэн, хуулийн этгээд хохирсон тухай шүүхийн шийдвэрүүд шүүхээс албан ёсоор танай байгууллага буюу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар дээр бүгд ирдэг үү? Эсвэл ямар журмаар ирж байна вэ?

Судалгаанд оролцогч: Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтаар бол яг бүх шийдвэр бол манай дээр шууд гарсан даруйдаа ирэхгүй байгаа. Иргэн өөрөө хүсэлтээрээ шийдвэр гүйцэтгүүлэх хуудас бичүүлээд шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх ажиллагааныхаа зардлыг төлөөд л ажиллагаа хийгдэж байгаа. Түүнээс шүүх 10 хэрэг шийдлээ гэхэд 10-уулаа манай дээр ирэхгүй л дээ. Өөрөөр хэлбэл албадуулах шаардлагагүй бол Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хандах шаардлагагүй байгаа юм л даа. Тухайн байгууллага

Remove Watermark Now

нь өөрөө шүүхийн шийдвэрийг сайн дураараа биелүүлээд явчихсан тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага дээр ирэх шаардлагагүй л дээ.

Судлаач: Практикийг анзаарах юм бол ихэнх тохиолдолд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага ор
олцож байна уу? Эсхүл тухайн байгууллага өөрөө сайн дураараа биелүүлэх нь дийлэнх үү? Төрийн байгууллагын тухайд?

Ёудалгаанд оролцогч: Тухайн байгууллага өөрөө яг хэдийг гүйцэтгэсэн вэ гэдгийг бол би хэлж чадахгүй. Шүүх дээр төрийн байгууллага буруутай талаар хэдий хэмжээний шийдвээр гараад тэрнээс хэд нь манайхруу ирж байгааг бол манайх хэлж чадахгүй. Зөвхөн иргэн, хуулийн этгээд хандсан тохиолдолд л манайд бүртгэгдэж байгаа. Манайхаар гүйцэтгүүлэх тохиолдолд албадах ажиллагааны зардал бас төлдөг л дөө.

Судлаач: энэ төрлийн шүүхийн шийдвэрийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хэрхэн гүйцэтгэдэг вэ? Процессын хувьд.

Судалгаанд оролцогч: Улсын төсвөөс санхүүждэг байгууллагын тухайд азрим хэсэг нь тухайн хариуцагч байгууллагын мөнгөн хөрөнгөнөөс гараад явж байгаа нэг хэсэг байна. Үлдсэн хэсэг нь Хууль зүй, дотоод хэргийн сайдын төсвийн багцад тусгагдсан хөрөнгөнөөс гарч байгаа. Түүнтэй холбоотой тоо судалгаа байгаа.

Судлаач: жилд хэдий хэмжээний мөнгө улсын төсвөөс гаргаж байгаа вэ? Сүүлийн 2 жилийн дундажаар?

Судалгаанд оролцогч: 2017 онд 2 тэрбум гаруй төгрөг төсөвт суугаад төсвийн тодотголоор дахиад 15-16 тэрбум төгрөг нэмж батлууж нилээд хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулсан. 2018 онд 2 тэрбум төгрөг л суусан. Энэ нь 10 хүрэхгүй хувийг л хангадаг даа.
Төсөвт хангалттай эх үүсвэр суугаагүй тул Хууль зүй, дотоод хэргийн яам нэн тэргүүн хэлсээр эрүүгийн хэрэгт хоригдсон этгээдүүдийг хохиролгүй болгох арга хэмжээг авч байгаа. Энэ жил бол ердөө 4 хүнд л олгогдсон байх жишээтэй.

Судлаач: Танайх ирж байгаа шүүхийн шийдвэрүүд дээр анализ хийдэг үү? Энэ төрлийн алдаанаас үүдэлтэй шүүхийн шийдвэр их байдаг юм байна. Үүн дээр анхаарах ёстой гэсэн дүгнэлт, санал гаргадаг уу?

Судалгаанд оролцогч: Төсвийн байгууллагаас хэдэн төгрөг гаргах вэ? Хэдийг гаргасан вэ гэдгийг л хардагаас үүн дээр шүүхийн шийдвэрийн агуулгаар нь ангилж нэгтгэн дүгэдэггүй. Манай ажиллагаанд ач холбогдолгүй тул ингэж гаргадаггүй.

Судлаач: энэ төрлийн шийдвэр гүйцэтгэлийн туахйд учирч байгаа хүндрэл бэрхшээлийн талаар?

Судалгаанд оролцогч: Төрийн байгууллагын хувьд данс нь төрийн санд байршсан байдаг. Төрийн бус хууийн этгээдийн хувьд дансанд нь хаалт хийгээд өмчлөлийн зүйл дээр нь шууд ажиллагаа хийдэг бол төрийн байгууллагын хувьд данс ч барьж чаддаггүй, өмч хөрөнгөнд ч ажиллагаа хийх боломжгүй байдаг. Яагаад гэвэл нийтийн эрх зүйн хуулийн этгээд учир иргэдэд үйлчилж байдаг болохоор очоод өмчлөлийн хөрөнгийг хураагаад байх боломж байдагггүй л дээ. Төрийн сангийн данс нь арилжааны банкны данс шиг гүйлгээ хийгддэггүй. Зөвхөн орлого зарлага хийддэг болохоор дансанд ажиллагаа хийх ямар ч боломж байдаггүй. Тэгэхээр албадлагын арга хэмжээ нилээд хязгаарлагдмал явагддаг.

Судлаач: төр хохирлоо барагдуулах ажиллагааг тодорхой хэмжээнд хийгээд яваад байна. Эргээд төрийг хохиролгүй болгоход танай байгууллагын оролцоо байдаг уу?

Судалгаанд оролцогч: Буцаан төвлөрүүлж төрийг хохиролгүй болгох арга хэмжээ манай чиг үүрэгт хамааралгүй байдаг. Гэхдээ энэ асуудлыг ажиглаад байхад тухайн захиргааны байгууллага өөрөө төрөөс хохрлыг барагдуулсан бол буцааж төвлөрүүлэх асуудлыг тухайн байгууллага өөрөө хэрэгжүүлэх хэрэгтэй. Тухайн захиргааны байгууллага огт нэхэмжлэл гаргадаггүй. Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг төр барагдуулчихлаа тэгээд л орхичихоод байгаа л даа.

Remove Watermark Now

Судлаач: Танайх төр буруутай этгээдээс өөрийн хохирлыг барагдуулсан шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлсэн туршлага, тохиолдолд байгаа юу? Тухайн шийдвэрийг буруутай этгээдээр төлүүлэх тухай шийдвэрийг танайх барагдуулсан туршлага байна уу? Уг нь талаар Захиргааны ерөнхий хуульд дотоод аудит нь хариуцна гээд заасан байгаа ш дээ.

Судалгаанд оролцогч: Манай байгууллагын туршлагын хувьд шийдвэр гүйцэтгэгч нар өөрсдийн буруутай үйл ажиллагаанаас бий болсон хохирлыг барагдуулах эрсдэлийн сан үүсгээд тэндээсээ иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирлыг барагдуулаад явсан туршлага байдаг. Төрийн бусад байгууллагын тухайд дотоод аудит нь буруутай албан тушаалтнаас нэхэмжлээд тэр талаар гаргасан шүүхийн шийдвэрийг биелүүлэхээр манай байгууллагад хандсан тохиолдолд одоогоор гараагүй байгаа. Төр төлчихдөг буруутай этгээд буцаагаад төлсөн тохиолдолд байхгүй байгаа. Улсын төсөвт мөнгө тусгах үед энэ асуудал маш их яригддаг боловч үүнийг хэрэгжүүлсэн тохиолдолд байхгүй байгаа. Төрийн албаны хууль дээр ч байгаа ш дээ. Гэтэл хэрэгжүүлэхгүй байгаа л даа.

Судлаач: Цаашид энэ тогтолцоог боловсронгуй болгох талаар таны санал.

Судалгаанд оролцогч: Өмнө бол хэн буцаагаад төрийг хохиролгүй болгох асуудал зохицуулалтгүй байсан. Одоо Захиргааны ерөнхий хууль гарснаараа ямар ч байсан хариуцах байгууллагыг заагаад өгчихсөн байгаа. Иймүчраас одоо энэ зохицуулалтаа хэрэгжүүлэх, төрийн байгууллагын уялдаа холбоо байхгүй байгааг бий болгох асуудал байна. Одоо байгаа хуулийн хэрэгжилтийг хангуулах байгууллага байхгүй байгаатай холбоотой хэрэгжихгүй байна гэж үзэж байна.

Судлаач: За танд ярилцсанд баярлалаа.

## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА Н.АНХБАЯР

Ярилцлага 2018 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 15:00 цагт Үндэсний аудитын газрын 3112 тоот өрөөнд эхлэв.

Судалаач: Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлд Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулахаар заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн дэд сайдаар ахлуулсан Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байгаа бөгөөд энэ хүрээнд хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх судалгаа хийгдэж байгаа юм. Энэ хүрээнд миний бие ЗЕХ-ийн 10 дугаар бүлэг буюу Хохирол барагдуулах хэсгийг үнэлэх юм. Таныг судалгааны ажлыг дэмжиж ярилцлага хийхийг зөвшөөрсөн явдалд баяртай байна. Би тодорхой асуултууд бэлдсэн байгаа Танаас асуугаад явъя.

Судлаач: Үндэсний аудитын газар нь Захииргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.3 дахь хэсэгт зааснаар тодорхой чиг үүрэгтэй байхаар зохицуулсан байгаа. Өөрөөр хэлбэл төр иргэн, хуулийн этгээдэд төрийн буруутай үйл ажиллагаанаас учирсан хохирлыг барагдуулах, төр өөрт учирсан хохирлыг буруутай этгээд буюу албан тушаалтнаар барагдуулах ажлыг танай байгууллага хүлээж байгаа. Энэ чиг үүргийг танайх яаж хэрэгжүүлж байгаа вэ?

Судалгаанд оролцогч: Захиргааны ерөнхий хуулийн 103.3 дахь хэсгээр аудитын байгууллагад төрийг хохиролгүй болгох үүргийг хүлээлгэсэн байгаа. Өнөөдрийн байдлаар төрөөс иймхохирлыг иргэн, хуулийн этгээдийн өмнө хүлээж барагдуулчихлаа. Одоо төрийг хохиролгүй болгох арга хэмжээг аваач ээ гэж хандсан тохиолдолд байхгүй байна. Манай Үндэсний аудитын газарт хандахын өмнөх шалгуур бол ЗЕХ-ийн 103.2 дахь хэсэгт зааснаар тухайн байгууллагын дээд шатны дотоод аудитын нэгж хариуцахаар зохицуулсан байгаа. Дээд шатны аудитын нэгж байхгүй бол манайд хандахаар заасан боловч тэдгээр эгжээс манайд хандсан тохиолдолд одоогоор байхгүй байна. Аудит хийх явцад зөрчил илэрвэл манайх тодорхой ажиллагаа хийхээс шууд өөрсдөө санаачлагаараа хийхгүй байгаа. Манайх дээд шатны аудит байгүй учир шийдвэрлэж өгөөч гэж хандсан тохиолдолд байхгүй байгаа.

Судлаач: ЗЕХ-ийн 103.3 дахь хэсэгт зааснаар дотоод аудитын нэгжгүй бол танайд хандахаар байгаа. Тэгэхээр улсын хэмжээнд дээд шатны дотоод аудитын нэгжгүй шууд танайд хадах боломжтой ямар ямар байгууллагууд байгаа вэ? Үүн дээр гаргасан судалгаа бий юу?

Remove Watermark Now

Судалгаанд оролцогч: Яг үүнтэй холбоотой судалгааг манайх хийгээгүй байна. Гэхдээ яамдууд бол бүгд дотоод аудитын нэгжтэй, аймгуудын хэмжээнд бас байгаа. Гэхдээ тэдгээр нь шаталж очоод хохирлыг барагдуулсан юм байхгүй. Төрийн захиргааны төв байгууллагууд бол дээд шатны аудитын нэгж гэж байхгүй учир яамдууд дээр гарсан шүүхийн шийдвэртэй холбоотойгоор шууд манайд хандах ёстой л доо.

Судлаач: яамдууд дээр бол өөрсдөд нь холбоотой шүүхийн шийдвэр гарч байгаа тохиолдолд бодит байдал дээр бол байгааг бид мэдэж л байгаа. Наанадаж л хүн ажлаас халахдаа буруу шийдвэр гаргаад буцаагаад ажилд томил гэсэн шийдвэр бол гарч л байгаа. Тэгэхээр шүүхийн шийдвэр гарахгүй байгаа асуудал бол биш шүүхийн шийдвэрийн дагуу төрийг хохиролгүй болгох ажиллагаа хийгдэхгүй байна л гэсэн үг үү? Мөн Хууль зүй, дотоод хэргийн сайдын багц дээр "иргэн, хуулийн этгээдэд учруулсан хохирлын нөхөн төлбөр" гэсэн тодорхой мөнгө батлагдаад түүнийг нь хуваарилаад яваад байдаг юм байна. Танай хувьд тэгвэл ядаж энэ мөнгийг төрөөс гаргасан байна. Тиймээс гаргасан мөнгийг буцааж төлүүлэхэд ямар арга хэмжээ авсан вэ гэж анализ хийдэг үү?

Судалгаанд оролцогч: одоогоор санаачлагаар манай байгууллага өөрөө хэрэгжүүлсэн тохиолдолд бол байхгүй. Аудитын шалгалтын дүнд төрд урчирсан хохирлыг барагдуулахын тулд акт, албан шаардлага бол үйлддэг.

Судлаач: тэр акт, албан шаардлага яаж биелэгддэг вэ?

Судалгаанд оролцогч: тухайн буруутай этгээдийн дээд шатны албан тушаалтанд актыг хүргүүлж байгаа. Дээд шатны албан тушаалтан нь буруутай этгээдэд арга эхжмээ авч байгаа.

Судлаач: төр ямар нэг хэлбэрээр баталж байгаа төсвийнхөө хүрээнд тодорхой хэмжээнд барагдуулаад яваад байгаа юм байна. Тэгэхээр буцаагаад төрийг хохирол болгох энэ арга хэмжээг танайх авах ёстой боловч одоогоор авагдаагүй байна гэж байна. Тэгэхээр үүнийг хэрэгжүүлэхэд яг ямар хүндрэл байгаа учраас хэрэгжүүлэхгүй байна вэ?

pdfelement

Судалгаанд оролцогч: хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, буруутай этгээдэд хариуцлага хүлээлэгэхтэй холбоотой зохицуулалтыг боловсронгүй болгох шаардлага байгаа. Төрийн аудитын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл мөн явж байгаа. Цаг хугацааны аудитын шалгалт бол жилийн дараа ордог. Тэгэхээр зөрчил илэрүүлээд тавьж байгаа акт, албан шаардлага маань үндсэндээ зөрчил гарснаас хойш багадаа нэг жилийн дараа тавигддаг. Энэ нь хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой асуудлыг хөнддөг. Татварын акт бол 6 жил дотроо хүчинтэй ч гэдэг юм уу тийм зохицуулалт нь байдаг. Манайхны хувьд хөөн хэлэлцэх хугацаа дууссан байх тохиолдол байдаг. Иймээс зарим акт биелэдэг, зарим нь энэ шалтгаанаас болоод биелэхгүй байх тохиолдолд байна. Иймээс буруутай албан тушаалтнаар хариуцлага хүлээлгэх асуудлыг сайн зохицуулах хэрэгтэй. Манайх дээд шатны албан тушаалтанд хандаад арга хэмжээ авахгүй байгаа хүн дээр дахиад арга хэмжээ аваачээ гэдэг асуудлыг тавьдаг.

Судлаач: ЗЕХ-ийн 103.4 дээр шүүх холбогдох байгууллагад шүүхийн шийдвэрийг хүргүүлэхээр заасан байгаа. Үүний дагуу шүүхийн шийдвэрүүд танай дээр ирж байгаа юу?

Судалгаанд оролцогч: Огт ирээгүй. Бил шүүхээс
Судлаач: Захиргааны ерөнхий хуулиар бий болгосон төр эхлээд хохирсон хүнийг хохиролгүй болгох, дараа нь буруутай этгээдээс аудитын байгууллагаар дамжуулан хохирлоо барагдуулах гэсэн тогтолцоог хэр оновчтой гэж үзэж байна вэ?

Судалгаанд оролцогч: Зөв. Дээд шатны аудитын шаардлагатай арга хэмжээгээ авах нь зөв. Төрийн хяналтын чиг үүргийг хэрэгжүүлдэг, төсвийн нэгдсэн зарцуулалтыг хянадаг байгууллага болохын хувьд Төрийн аудитад энэ чиг үрэг байх нь зөв. Харин үүнийг яаж боловсронгүй болгох вэ? Хэрэгжих процесс нь ямар байх вэ гэдгийг л шийдвэрлэх хэрэгтэй. Аудит шүүхэд нэмэжлэл гаргаад явах уу?шууд буруутай хүнд хариуцлага хүлээлгэх үү гээд асуудлыг процессыг зааж өгөх хэрэгтэй. Гэхдээ ажлын ачаалалыг мөн тооцох хэрэгтэй. Манай байгууллага 6500 орчим төрийн байгууллагад ажилладаг боловч ажлаа барахгүй байдаг тул хүний нөөцийг бас шийдэх хэрэгтэй. Гэхдээ болохгүй зүйл биш ээ.

Remove Watermark Now

Судлаач: Төрийн аудит энэ асуудал дээр дээд шатны аудитын байгууллагуудыг төрийг хохиролгүй болгох чиглэлээр хэрхэн ажиллах талаар мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж байгаа юу?

Судалгаанд оролцогч: Манайхаас тийм сургалт явуулаагүй. Гэхдээ энэ асуудал манайд нэгэнт хуулиар ирчихсэн учраас цаашид хэрхэх талаар судалж байгаа. Зарим шүүхийн шийдвэрүүд шууд төр буруутай гээд эвлэрчихсэн байна. Эдгээр асуудлыг манайх мөн Авилгатай тэмцэх газарт хүргүүлэх зэрэг ганц нэг арга хэмжээ авч байгаа. Гэхдээ хамгийн гол асуудал нь төрийн байгууллагуудын хоорондын хамтын ажиллагаа, уялдааны асуудал л байгаа. Шүүхийн шийдвэр нь шүүхэд нэхэмжлэл гаргаснаас хойш он давнаад шүүхийн шийдвэр гарахаар л Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцаас гаргагдаад байх шиг байна.

Судлаач: Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцаас биш бусад байгууллагын цалингийн сангаас гаргасан мөнгийг дүнгээр нь танайх гаргадаг уу?

Судалгаанд оролцогч: одоо бол манайх шалгалтууд дуусаагүй учир хэлж мэдэхгүй байна. Бүхэлдээ бол гарахгүй, мөнгөн гүйлгээн дээр анхаарал татсан зүйлийг л харна л даа.
Одоо манай байгууллага Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлээр Төрийн аудитад олосон чиг үүргийг хэрэгжүүлэх асуудлыг нилээн анхааралдаа авсан байгаа. Цаашид хэрхэн хэрэгжүүлэх талаар төлөвлөж ажиллаж байна.

Судлаач: За танд баярлаа

### ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА Ж.БААТАРСАЙХАН

2018 оны 4 дүгээр сарын 30-нд Төрийн албаны зөвлөл дээр

Судлаач: Танд өдрийн мэнд хүргэе. Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу Захиргааны ерөнхий хуулийг хэрэгжилтийн үр дагаврыг судалгааны баг үнэлж байгаа. Энэ хүрээнд Захиргааны ерөнхий хуулийн 10 дугаар бүлэгт заасан "Хохирлыг барагдуулах" асуудлаар танай байгууллагатай ярилцлага хийх юм. Төрийн албан хаагчийн буруутай үйл ажиллагаанаас үүссэн хохирлыг төр хариуцна гэдэг зохицуулалт өмнө байсан. Төрийн албан тухай хуулийн 4.2.7 дээр энэ зарчмыг бататгаад, мөн хуулийн Төрийн албаны зөвлөлийн эрх хэмжээг зохицуулсан 35 дугаар зүйлийн 35.1.2 дээр төрийн албаны зөвлөл нь буруутай этгээдээс төрд учирсан хохирлыг нэхэмжлэн шүүхэд хандахаар заасан байгаа. Энэ хүрээнд Төрийн албаны зөвлөл Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсноос өнөөг хүртэд ямар арга хэмжээ хэрэгжүүлж ирсэн бэ?

Ярилцагч: За маш хүнд асуулт байна. Төрийн албаны зөвлөл 1995 оны 7 дугаар сард байгууллагдснаас хойш 20 гаруй жилийн хугацаа өнгөрч байгаа бөгөөд хуулийн хүрээнд яригддаг гол асуудлын нэг бол таны асууж байгаа наад асуудал. Төрийн албан хаагч төрд хохирол учруулвал төрийг хохиролгүй болгоно гэдэг асуудал байдаг. Гэхдээ буруутай албан тушаалтан нь хэн бэ гэдэг дээр нилээн будилж ирлээ. Өөрөөр хэлбэл шийдвэр гаргасан албан тушаалтан болгон буруутай биш байдаг. Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүдэд ажилд нь эргүүлэн томилохоор гарсан бол буцаагаад ажилд нь томилох, ажилгүй байсан хугацааны цалин хөлсийг нөхөж олгохоор болдог. Төрийг өөрийг нь хохиролгүй болгох асуудал дээр Төрийн албаны зөвлөл яг үнэнийг хэлэхэд хэрэгжүүлсэн ажил, үр дүн байхгүй байна. Гэхдээ бас бид огт зүгээр суугаагүй 2015 онд Нийслэлийн хүүхэд залуучуудын газар, Булган аймгийн холбогдох төрийн байгууллага гэсэн нэр бүхий 3 байгууллагын асуудал дээр Төрийн албаны зөвлөл өөрт оногдсон чиг үүргийг хэрэгжүүлэхээр салбар зөвлөлдөө эрхээ шилжүүлээд Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргуулсан боловч шүүх Төрийн албаны зөвлөл уг асуудлаар шүүхэд хандах эрхгүй гээд манайх хад мөргөөд түүнээс хойш энэ чиглэлээр тодорхой ажил хийгдээгүй байна. Захиргааны ерөнхий хуульд бол эхлээд иргэн, хуулийн этгээдэд учирсан хохирлын тухайн төрийн байгууллага хариуцан төлөөд, дараа нь тухайн байгууллагын дээд шатны аудит нь буруутай этгээдээс гаргуулж авна гэсэн зохицуулалт байгаа. Гэхдээ ЗЕХ батлагдснаас хойш одоог хүртэл ийм хэрэгжүүлсэн тохиолдол гарч ирээгүй л байна.

Судлаач: 2015 онд Захиргааны хэргийн шүүх аваагүй гэдгийг та тодруулчихгүй юу? Шүүхээс яг ямар дугаартай шийдвэр гарсын бол?

Ярилцагч: За би мэргэжилтнээсээ тодруулаад шүүхийн шийдвэрийн огноо дугаарыг олж өгнөө.

Судлаач: Төрийг хохиролгүй болгох энэ асуудал хууль дээр байгаа боловч огт хэрэгжихгүй байгаа юм байна. Хэрэгжихгүй байгаа шалтгааныг та гэж харж байна вэ?

Ярилцагч: Би өөрөө хуульч хүн биш учраас нарийн сайн мэдэхгүй байна. Гэхдээ зарим эрдэмтэн, судлаачтай ярилцахад наад асуудал чинь Үндсэн хуультай зөрчилдөнө гэж тайлбарладаг. Бид энэ асуудлыг шийдвэрлэхээр олон арга зам хайж үзэж байна ш дээ. Өөрөөр хэлбэл эрдэмтэд төр өөрөө буруутай үйл ажиллагаа хэрэгжүүлэхгүй байх ёстой. Гэтэл буруутай үйл ажиллагаа явуулаад дараа нь хохирлын асуудал ярьж байна гэдэг нь "Монгол Улсын иргэний иргэний ажиллах хөдөлмөрлөх, нийгмийн баталгааг хангах" гэсэн Үндсэн хуульд заасан төрийн үүрэгтэй зөрчилдөж байна. Би өөрөө бол мэргэжилтэн хүний хувьд төрийн албан хаагчтөрийн зорилт чиг үүргийг хэрэгжүүлэх гэж явж байгаад төрд хохирол учруулчихвал тэрийг төр хариуцна гэдэг зохицуулалт одоо Төрийн албаны хууль дээр байгаа. Яг эрх үүргээ хэрэгжүүлэх гэж явж байгаа ш дээ. Түүнээс намын шахалт, улч төрийн шахалт зэрэг олон хүчин зүйлийн улмаас буруутай шийдвэр гаргаад хүнийг ажлаас нь халж, солиод байгаа бол энэ бол төрийн зорилт, чиг үүргийг хэрэгжүүлж байгаа хэлбэр биш бөгөөд хөндлөнгийн нөлөөлөлд ороод байна гэж ойлгодог.

Судлаач: Энэ асуудлаар Төрийн албан зөвлөл төрийн бусад байгууллагатай хамтран ажилласан, хамтран ажиллах гэж оролдсон, хамтран ажиллах ёстой гэж үзэж хэрэгжүүлсэн, хийсэн арга хэмжээ байна уу?

Ярилцагч: Ер нь бол бусад байгууллагатай хамтран ажиллах ёстой. Хамгийн наад зах нь Төрийн аудит, Хүний эрхийн үндэсний комисс, хууль хяналтын байгууллагуудтай хамтран ажиллах ёстой. Шүүхтэй хамтран ажиллана гэхээр шүүхээр маргаан явж байгаа үед нөлөөлөлд орох тал ажиглагдсан. АТГ-тай Төрийн албаны зөвлөл хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. Гэхдээ яг энэ төрд учирсан хохирлыг барагдуулах асуудлаар бол биш.

pdfelement

Судлаач: Төрийн буруутай үйл ажиллагаа байна гэж тогтоож байгаа шүүхийн шийдвэрүүд дээр төрийн албаны төв байгууллага болохын хувьд танайх нэгтгэж анализ хийдэг үү? Төрийн албан хаагчид юун дээр их алдаж шийдвэр гаргаад байна. Түүний учир шалгаан нь юу вэ? Цаашид алдаа дутагдлыг багасгах талаар хийх арга хэмжээ? Гэх зэргээр

Ярилцагч: Төрийн албаны зөвлөл жил бүр өөрийн үйл ажиллагааг УИХ-д тайлагнадаг. Энэ хүрээнд хамгийн том дүгнэлтийг 2014 онд хийж танилцуулсан. "Төрийн алба дахь энэ халаа сэлгээ, тогтворгүй байдал Үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх хэмжээнд хүрлээ" гэсэн дүгнэлт гаргасан боловч үүний мөрөөр ямар нэг арга хэмжээ авагдахгүй байна. Хамгийн том ажил гэвэл 2017 оны 12 дугаар сард Төрийн албаны тухай хуулийг шинэчлэн баталсан бөгөөд энэ хууль 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөнө. Энэ хуульд алдаа гаргасан бол төрийн албанд 3 жил хүртэл хугацаагаар буцаж орох эрхгүйгээр албанаас халахаар зохицуулалт туссан. Энэ маань бас түлхэц өгөх байх гэж харж байна. Мөн Засгийн газар тогтворгүй ажилладаг. Үүнтэй холбоотойгоор төрийн байгууллагын бүтэц өөрчлөгддөг. Үүнтэй холбоотойгоор "бүтэц" гэдэг асуудлын доор төрийн албан хаагчдыг олноор нь ажлаас чөлөөлж, хөдөлгөөн ихээр хийгдэж байна. Мөн шүүхийн 3 шатны шийдвэр гарчихаад байхад түүнийг хэрэгжүүлдэггүй байгууллагууд бас байна.

Судлаач: Шүүхээр шийдвэрлэгдсэн төрийн албан хаагчтай холбоотой маргаан дээр нэгтгэж судалгаа хийсэн зүйл байгаа юу?

Ярилцагч: Төрийн албаны зөвлөл нь урьдчилан хянан шийдвэрлэх ажиллагаа явуулдаг. Гэхдээ сүүлийн жилүүдэд шийдэх маргаан багасаад байгаа. Энэ нь улстөртэй холбоотой гэж үзэж байна. Жишээ нь 3 шатны шүүхээр шийдэгдээд байхад шүүхийн шийдвэр биелэгдэхгүй байгаа тохиолдол маш их байна. Мөн ажилд нь эргүүлж томилдоггүй, ажилгүй байх хугацааны цалинг нь өгөөд аргацаагаад яваад байгаа газрууд бас байна.

Remove Watermark Now

# Хавсралт 19 – 20:

# Албан хэрэгцээнд зориулсан

pdfelement

Remove Watermark Now

# Захиргааны ерөнхий хуулийн III, VI, XI дүгээр бүлгийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлангийн Хавсралт 1- 5

pdfelement

Remove Watermark Now

Хавсралт 1

# ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛИЙН ТАЛААРХИ ОЛОН НИЙТИЙН САНАЛ АСУУЛГЫН

# ТАЙЛАН

pdfelement

Remove Watermark Now

ГАРЧИГ........................................................................... Error! Bookmark not defined.

I. СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ.......................................................................................

1.1. Мэдээлэл цуглуулах хэрэгсэл...............................................................................

1.2. Мэдээлэл цуглуулах явц......................................................................................

1.3. Мэдээлэл оруулах...............................................................................................

1.4. Мэдээлэл засварлах............................................................................................

1.5. Мэдээлэл жинлэх................................................................................................

1.6. Мэдээлэл боловсруулалт......................................................................................

II. СУДАЛГААНД ХАМРАГДСАН ОРОЛЦОГЧДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ.....................

3.1. Судалгаанд оролцогчийн талаарх мэдээлэл..........................................................

III. ОЛОН НИЙТИЙН ҮЗЭЛ БОДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН БА ХЭЛЭЛЦҮҮЛЭГ...............

IV. ДҮГНЭЛТ

pdfelement

Remove Watermark Now

# I. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

### *1.1. Түүвэрлэлт*

“Захиргааны ерөнхий хууль”-ийн хэрэгжилт, хуулийн талаарх иргэдийн мэдлэгийг тандах зорилготой "Олон нийтийн санал асуулга"-ын хувьд зөвхөн нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд авсан. Учир нь, хууль хэрэгжээд зөвхөн нэг жил гаруй болж байгаа, мөн засаг захиргааны төв байгууллагууд нийслэлд төвлөрсөн байдлыг харгалзан, түүврийг зөвхөн Улаанбаатар хотоос сонгохоор болсон. Судалгаанд түүврийн нэгжийг сонгохдоо нийслэлийн 9 дүүргээс тодорхой тооны нэгжийг сонгов.

Асуулга судалгааны хувьд зорилтот эх олонлог нь 18 болон түүнээс дээш насны иргэд юм. Зорилтот эх олонлогийг буюу түүврийн хүрээг ЗЕХ-ийн хэрэгжилтийг мэддэг, эсхүл үйлчилгээ авсан иргэдийг зорилтот бүлгээр сонгосон тул уг судалгаа нь үйлчилгээний нэгжид суурилсан судалгаа юм. 2016 оны албан ёсны статистик мэдээллээр нийслэл Улаанбаатар хотод 18 болон түүнээс дээш насны нийт 1,087,867 иргэн амьдарч байна. Түүврийн хэмжээг тогтоохдоо, дараах томъёог ашигласан:

$$n = \frac{T2 * p(1-p)}{M2}$$

Үүнд:

n түүвэрт сонгогдсон насанд хүрсэн иргэний тоо

T2 итгэх түвшний утгыг тодорхойлох утга

P харилтын түвшин болон хамрагдалтын түвшинг засварлах утга

M түүврийн алдаа

pdfelement

Итгэх түвшний утгыг 95 хувь, түүврийн алдааг 4 хувь байхаар тооцов. Түүвэр судалгааны төлөөлөх чадварыг хангахын тулд хамгийн багадаа 506 амжилттай асуулгын хуудас буюу 506 иргэний мэдээллийг цуглуулах шаардлагатай

Хүснэгт 1. Түүвэрт сонгохоор төлөвлөсөн иргэдийн тоо /дүүргээр/

| No. | Дүүрэг | Sample size |
|---|---|---|
| 1 | Сүхбаатар | 100 |
| 2 | Чингэлтэй | 20 |
| 3 | Баянгол | 100 |
| 4 | Баянзүрх | 100 |
| 5 | Сонгинохайрхан | 50 |
| 6 | Хан-Уул | 100 |

Remove Watermark Now

| | | |
|---|---|---|
| 7 | Налайх | 10 |
| 8 | Багануур | 10 |
| 9 | Багахангай | 10 |
| 10 | Туршилт асуулга | 6 |
| Total | | 506 |

Түүвэрлэсэн бүлгүүд дээр очиж ярилцлага авахдаа товч танилцуулгаар эхэлж байв (i) судлаач нар өөрсдийгөө танилцуулна; (ii) судалгааны зорилго, хамрах хүрээ, (iii) ярилцлага авахаар тодорхойлогдсон иргэд хэрхэн сонгогдсон талаар гэх мэт. Гол анхаарах зүйл бол асуулгад оролцогчдын хувийн бүхий л мэдээллийг нууцлах бөгөөд судалгааг зөвхөн судалгааны зорилгоор ашиглах болно гэдгийг сайн тайлбарлах явдал байв. Сонгогдсон иргэнээс асуулга авч байх үед бусад иргэдийн оролцоог хязгаарлах арга хэмжээ авч байлаа.

***1.2. Мэдээлэл цуглуулах хэрэгсэл***

Иргэдийн санал асуулгыг ЗЕХ-ийн хэрэгжилтийн судалгааны баг боловсруулан бэлдэж, судалгааны мэдээлэл цуглуулах ажил эхлэхээс өмнө туршилтыг хийж, асуулгын бүтэц, агууламжийг баталсан болно.

Санал асуулга нь дараах бүлгээс бүрдэнэ:

Бүлэг А – Ерөнхий мэдээлэл (нас, хүйс, боловсрол, байршил, амьжиргааны нөхцөлийн талаарх 6 асуулт.)

Бүлэг Б – ЗЕХ-ийн талаарх мэдлэг, мэдээлэл (2 асуулт)

Бүлэг В – ЗЕХ-ийн хэрэгжилт (11 асуулт)

Иргэдээс санал асуулга авахад зарцуулагдах дундаж хугацаа ойролцогоор 25-30 минут байсан бөгөөд хуулийг тайлбарлах, судлагаанд оролцогчдод нэмэлт тайлбар өгөх зэрэгт тодорхой цаг шаардлагатай байсан.

***1.3. Мэдээлэл цуглуулах явц***

Иргэдийн санал асуулгын мэдээллийг урьдчилж хэвлэсэн цаасан анкет дээр авсан бөгөөд асуулгын ярилцлага амжилттай хийгдсэний дараа судлаач нар асуулгыг судлагааны удирдагчид хураалгаж байсан.

***1.4. Мэдээлэл оруулах***

Мэдээлэл цуглуулах ажил дууссаны дараа судалгааны багийн гишүүд буюу судлаач нар нь мэдээлэл шивэх ажлыг хийсэн бөгөөд үүнд тусгайлан бэлтгэсэн ексель файлыг ашигласан.

***1.5. Мэдээлэл засварлах***

Хэдийгээр мэдээлэл цуглуулах явцад чанарыг хангах тал дээр анхаарал тавьж байсан боловч зарим алдаа гарах магадлалтай юм. Судалгааны мэдээлэл цуглуулалтын ажил дууссаны дараа мэдээллийг засварлах үе шат эхэлсэн бөгөөд энэ үе шатанд судалгааны дугаар давхардсан эсэх, мэдээлэл оруулахад шивэлтийн алдаа гарсан эсэхийг шалгаж, алдаа илэрсэн тохиолдолд мэдээллийг засварлаж байв. Олон сонголттой асуудлуудыг багана тус бүрээр салгаж, кодлож бэлтгэсэн.

***1.6. Мэдээлэл жинлэх***



pdfelement

Remove Watermark Now

Түүвэр судалгааны төлөөлөх чадвар, үзүүлэлтийн найдвартай байдлыг хангахын тулд мэдээллийн жингийн тохируулга хийж жинлэв.

### *1.7. Мэдээлэл боловсруулалт*

SPSS програм дээр засварлагдсан мэдээллийг боловсруулсан болно. Мэдээлэлд дүн шинжилгээ хийхдээ энэхүү судалгаанд зориулж боловсруулсан кодолсон хүснэгтийн загварыг ашиглав. Судалгааны бүх мэдээлэл ирсний дараа задгай асуултуудын хариултын хүснэгтийг үүсгэж мэдээлэл боловсруулалтыг хийж гүйцэтгэсэн.

ОНҮБ-ын асуулгын мэдээллийг шинжлэхийн тулд доорхи аргачлалыг ашигласан болно:

| Иргэдийн санал асуулга | |
|---|---|
| Мэдээлэл оруулах програм | Microsoft excel |
| Шинжлэх програм | SPSS 20.0 |
| Шинжлэх арга зүй | Descriptive Statistics<br>Frequency and Cross Tabulation Testing<br>Graphical Analysis<br>T-test analysis |

pdfelement

## II. СУДАЛГААНД ХАМРАГДСАН ОРОЛЦОГЧДИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

### Судалгаанд оролцогчийн талаарх мэдээлэл

Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг тодорхойлох судалгаанд нийт 506 иргэн хамрагдсан. Иргэдийн хүн ам зүйн мэдээллийг хураангуйлан дараах хүснэгтэд харууллаа.

**Хүснэгт1. Судалгаанд хамрагдсан үйлчлүүлэгчдийн хүн ам зүйн мэдээлэл**

| ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД | НИЙТ | |
|---|---|---|
| **Хүйс** | **хувь** | **тоо**[1] |
| **Эрэгтэй** | 39.6% | 198 |
| **Эмэгтэй** | 52.4% | 262 |
| **Нас** | | |
| **18-30** | 37.9% | 189 |
| **31-45** | 41.3% | 206 |
| **46-61** | 18.4% | 92 |
| **62+** | 2.4% | 12 |
| **Боловсролын түвшин** | | |
| **Дээд** | 80.8% | 403 |
| **Тусгай мэргэжлийн дунд** | 3.2% | 16 |
| **Бүрэн дунд** | 15.0% | 75 |

[1] Судалгаанд 500 иргэд хамрагдсан хэдий ч зарим асуултад хариулт сонгогдоогүй байсан тул тэдгээр тохиолдлуудыг хасч тооцсон. (missing system)

Remove Watermark Now

| | | |
|---|---|---|
| **Бүрэн бус дунд** | 0.8% | 4 |
| **Бага** | 0.2% | 1 |
| **Ажил эрхлэлт** | | |
| **Хувийн хэвшил** | 29.0% | 144 |
| **ТББ болон олон нийтийн байгууллага** | 4.6% | 23 |
| **Хувиараа хөдөлмөр эрхэлдэг** | 8.0% | 40 |
| **Төсвийн байгууллага** | 33.8% | 169 |
| **Тэтгэвэрт** | 4.4% | 22 |
| **Тодорхой эрхэлсэн ажилгүй** | 3.2% | 16 |
| **Сурдаг** | 11.8% | 59 |
| **Бусад** | 4.6% | 23 |
| **Оршин суугаа газрын байршил** | | |
| **Орон сууцны хорооллын бүсэд** | 80.8% | 404 |
| **Гэр хорооллын бүсэд** | 19.2% | 96 |

Ажил эрхлэлтийн хувьд төсвийн байгууллагад ажиллагчид илүү давамгай байдалтайгаар хамрагдсан ба 3 хүн тутмын 1 нь төсвийн байгууллагад ажилладаг гэжээ. Ажил эрхэлдэг байгууллагын хэлбэрээ 23 хүн бусад гэсэн ангилалын сонгосон ба эдгээрийн ихэнх нь төрийн болон орон нутгийн өмчит байгууллагад ажилладаг. Үлдсэн цөөхөн иргэд төсөл, хөтөлбөр дээр ажилладаг байна.

Судалгаанд хамрагдсан иргэдийн 5 хүн тутмын дөрөв нь орон сууцны бүсэд амьдардаг иргэд хамрагдсан бөгөөд нийт иргэдийг байршлаар нь харвал дараах дүр зураг гарна.

pdfelement



Remove Watermark Now

Судалгааг нийслэлд зохион байгуулсан хэдий ч санамсаргүй түүврээр 6,8 хувь (34 хүн) нь орон нутгийн иргэд хамрагдсан байна. Орон нутгийн иргэд дунд Дорноговийн иргэд хамгийн их хамрагдаж, Архангай, Булган, Дорноговь, Дорнод, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Увс, Хөвсгөл зэрэг аймгийн төлөөллөөс 1-2 хүн хамрагджээ.

## III. ОЛОН НИЙТИЙН ҮЗЭЛ БОДЛЫН СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Энэ хэсэгт судалгаанд хамрагдсан иргэдийн "Захиргааны ерөнхий хууль"-ийн талаарх ерөнхий мэдээлэл, оролцсон эсэх туршлагын талаарх мэдээллийг харуулна.

### Захиргааны ерөнхий хуулийн талаарх мэдлэг, мэдээлэл

Судалгаанд хамрагдсан нийт иргэдээс 2016 оны 07-р сарын 1-нээс "Захиргааны ерөнхий хууль" хэрэгжиж эхэлснийг мэдэж байгаа эсэхийг тодруулахад 62.2 хувь (311 хүн) нь "мэднэ" гэж хариулжээ.

*Дүрс 1. Захиргааны ерөнхий хуулийг хэрэгжиж эхэлснийг мэдэж байгаа эсэх, хувь*




Тус хуулийн талаарх мэдлэгийг нас, боловсрол, ажил эрхлэлт зэрэг ерөнхий үзүүлэлтээр ялгаатай байгаа эсэхийг шинжлэн үзвэл дараах үр дүн гарч байна.

Хууль хэрэгжилтийн талаарх мэдээллийг боловсролын түвшнээр нь харвал дээд боловсролтой иргэд бусад түвшний боловсролтой иргэдтэй харьцуулахад илүү мэдээлэл сайтай байна. Үүнийг статистик хамаарал шалгадаг t-test-ээр шалган үзвэл хуулийн талаарх мэдээлэлтэй байдал нь боловсролын түвшнээс хамаарч ялгаатай болох нь батлагдсан.

*Дүрс 2. Хууль хэрэгжиж байгааг мэдэж байгаа эсэх, боловсролын түвшингээр*



Remove Watermark Now

Мөн дараагийн үзүүлэлт болох насны ангилалаар авч үзвэл 30-аас дээш насныхан харьцангуй мэдээлэл сайтай байгаа нь ажиглагдах бөгөөд ялангуяа тэтгэврийн насныхан илүү мэдээлэл сайтай байна. Энэ нь мөн Дүрс 4 дээрх ажил эрхлэлтийн үр дүнгийн мэдээллээр баталгаажиж байна.

*Дүрс 3. Хууль хэрэгжиж байгааг мэдэж байгаа эсэх, насны бүлгээр*




Тэтгэврийн насныханаас гадна төсвийн байгууллагад ажиллагчид тус хуулийн талаар мэдээлэл өндөр байгаа нь зарим талаар тэдний гүйцэтгэдэг ажил, үүрэгтэй шууд холбоотой. Үүнийг мөн статистикийн үүднээс шалган үзэхэд ажил эрхлэлтээс шууд хамааралтай байгаа нь батлагдлаа. Харин бусад секторт ажилладаг иргэдийн хувьд тэдийлэн ялгаа ажиглагдахгүй байгаа ба тал хувь нь л тус хууль хэрэгжиж байгаа талаар сонссон байна.

*Дүрс 4. Хууль хэрэгжиж байгааг мэдэж байгаа эсэх, ажил эрхлэлтээр*

pdfelement




Үүнийг цаашид лавшруулан агуулга талаас нь мэдэж байгаа эсэхийг дараах асуултаар шалгасан ба мөн тус хуулийн талаар ерөнхий мэдээлэл өгөхийг давхар зорьсон болно.

Асуултын үр дүнг дараах хүснэгтээс харна уу.

Remove Watermark Now

*Дүрс 5. Захиргааны байгууллагын шийдвэр гаргах ажиллагааг хэрхэн ойлгож байна вэ?*




Дээрх үр дүнгээс харахад иргэд захиргааны хуулийн талаар харьцангүй боломжийн түвшинд мэдээлэлтэй байгаа нь харагдлаа.

Захиргааны ерөнхий хуулийн талаарх мэдээллийн хүртээмжийг үнэлсэн хэсгийг дүгнэхэд иргэд хууль хэрэгжиж эхэлсэн талаар төдийгүй хуулийн үйлчлэх агуулгыг талаас илүү хувь нь мэдэж байна.

pdfelement

## Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилт

Энэ хэсэгт судалгаанд хамрагдсан иргэдээс “Захиргааны ерөнхий хууль”-тай холбоотой үйл ажиллагаанд оролцож байсан эсэх талаар туршлагын талаарх мэдээллийг багтаасан.

Remove Watermark Now

*Дүрс 6. Захиргааны байгууллагын дараах үйл ажиллагаанд оролцож байсан эсэх туршлага, хувь*




Дүрс 6-аас харахад давхардсан тоогоор 46,7 хувь нь ямар нэг байдлаар захиргааны байгууллагын шийдвэр гаргах ажиллагаанд оролцож байжээ. Эдгээрээс захиргааны шийдвэр гаргах ажиллагааны талаар мэдээлэл авах, холбогдох баримт бичгийг хуулбарлан авах болон шийдвэр гаргахаас өмнө нотлох баримт, шаардлагатай баримт бичгийг бүрдүүлэн өгөх зэрэг үйл ажиллагаанд түлхүү оролцсон тохиолдлууд их байна.

Дээрх үр дүнг ажил эрхлэлтийн үзүүлэлттэй харьцуулан харвал захиргааны байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд хувийн хэвшил, олон нийтийн байгууллага, төсвийн байгууллагад ажилладаг иргэд илүү оролцсон байгаа нь тэдний нийгмийн харилцаа нь идэвхитэй байдагтай холбоотой. Харин эсрэгээр төрийн өмчид байгууллагад ажиллагчдын 82,6 хувь, тэтгэврийн насны иргэдийн 81,5 хувь, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 70 хувь нь дээрх ямар нэгэн үйл ажиллагаанд хамрагдаагүй байна.

Эдгээр иргэдээс оролцож байгаагүй шалтгааныг нь тодруулан асуухад дараах үр дүн гарчээ.

*Дүрс 7. Захиргааны шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцож байгаагүй шалтгаан*




***Энэ үр дүнгээс хойших хэсэгт*** зөвхөн захиргааны байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцож байсан иргэдийн туршлага дээр тулгуурласан үр дүнгүүд гарах бөгөөд нийт 186 иргэний мэдээлэлд үндэслэсэн болно. Энэ нь нийт түүврийн 37,2 хувь нь сүүлийн 2 жилийн хугацаанд захиргааны (төрийн) байгууллагын шийдвэр гаргах дээрх ажиллагаанд оролцож байсан туршлагатай гэсэн үг юм.

Эдгээр иргэдээс захиргааны байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд нийт хэдэн удаа оролцож байсан бэ? Гэсэн асуултанд 43,5 хувь нь хоёроос дээш удаа оролцсон туршлагатай, 44,1 хувь нь нэг удаа оролцож байжээ. Хариулж мэдэхгүй гэсэн шалтгаанд одоогоор шийдвэр гаргах шатанд явж байгаа, санахгүй байна, өргөдөл, гомдол гаргах болон мэдээлэл авах зэрэг шатуудад оролцсон хэдий ч шийдвэр гаргах шатанд оролцоогүй гэсэн зүйлсийг дурьдсан байна.

*Дүрс 8. Сүүлийн 2 жилийн хугацаанд захиргааны байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцсон тоо*




Шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцсон давтамжийг ажил эрхлэлттэй нь харьцуулан харвал ялгаа ажиглагдсангүй. Энэ нь ямар ажил эрхэлдгээс үл хамааран захиргааны байгууллагын шийдвэр гаргах ажиллагаанд оролцож байгааг харуулж байна.

Remove Watermark Now

Тухайн шийдвэр гаргах үйл ажиллагаанд ямар оролцогчийн хувиар оролцсон эсэх асуултанд:

*Дүрс 9. Ямар хэлбэрийн оролцогч болсон бэ?*




Захиргааны байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцсон иргэдийн тал хувь нь өөрөө өргөдөл, хүсэлт гаргасан тул оролцогч болжээ. Харин үүний дараа ашиг сонирхол нь хөндөгдсөний улмаас оролцогч болсон зэргээс үзвэл 65.9 хувь нь шууд өөрийн эрх ашиг, үйл ажиллагаатай холбоотой асуудлаар оролцсон байна. Харин 26.7 хувь нь өөрт шууд хамааралгүй боловч үйл ажиллагаанд нь тодорхой хамааралтай байдлаар оролцжээ. Үлдсэн 10.9 хувь нь бусад гэсэн хувилбарыг сонгосон бөгөөд шалтгааныг дэлгэрүүлэн харвал:

- Өмгөөлөгчийн хувиар
- Бусдын эрх ашиг хөндөгдсөн тул холбогдох байгууллагад нь иргэдийн гомдлыг уламжлах
- Сургалтын зорилгоор
- Материал бүрдүүлэлт дээр оролцоотой байсан зэрэг хариултуудыг өгчээ.

pdfelement

Иргэдийн гомдлыг шийдвэрлэхдээ дараах үйл ажиллагаанууд хийгдсэн эсэхийг тодруулахад:

Remove Watermark Now

*Дүрс 10. Иргэдийн гомдлыг шийдвэрлэх явцад гарсан үйл ажиллагааны үр дүн*




Үр дүнгээс харахад иргэдийн гомдлыг шийдвэрлэхдээ өөрийг нь оролцуулж шийдэх байдал тийм ч сайн биш 5 хүн тутмын 2-ыг нь байлцуулсан бол, гомдлыг нь бусдад шилжүүлэх, шийдвэрлэхдээ бусдыг гэрчээр дуудах, шинжээчээр томилох ажиллагаанд 20 гаруйхан хувь нь “тийм” гэж хариулжээ. Тиймээс цаашид хуулийн хэрэгжилтийг нэмэгдүүлэхийн тулд энэ асуудлуудад анхаарч иргэдэд энэ чиглэлийг мэдээллийг нэмэгдүүлэх явдал чухал байна.

*Дүрс 11. Шийдвэр гаргах ажиллагааны явцад өргөдөл, гомдол гаргах, тайлбар өгөхөөр хандахад хүлээж авахаас татгалзаж байсан эсэх*

pdfelement




Мөн өргөдөл гомдол гаргах, тайлбар өгөхөөр хандахад 21 хувь нь хүлээж авахаас татгалзсан гэсэн хариулт өгсөн нь тийм ч бага биш тоо юм. Тиймээс цаашид ийм тохиолдлуудын шалтгааныг нарийвчлан тодруулах шаардлагатай.

Иргэдээс нотлох баримт цуглуулах явцад оролцож байсан эсэхийг тодруулахад 22 хувь нь оролцож байсан. 52.2 хувь нь оролцож байгаагүй гэж хариулсан. Харин үлдсэн 25,8 хувь нь хариулж мэдэхгүй гэжээ.

*Дүрс 12. Шийдвэр гаргах ажиллагаанд хамаарах нотлох баримтыг цуглуулах үйл явцад оролцож байсан эсэх*




Нотлох баримт цуглуулах үйл явцад оролцсон гэж хариулсан иргэдээс тодорхой жишээг тодруулахад дараах хариултууд өгсөн:

- цалин хөлстэй холбоотойгоор судалгааны материал гаргаж өгдөг
- орон нутагт дараа онд хийгдэх ажлын санал асуулгад оролцож байсан /цаасаар/
- өөрийн эрх ашиг хөндөгдсөн тул
- явган хүний зам хаасан, талбай хаасан гомдлыг шийдвэрлүүлэх гэж
- худалдан авах ажиллагааны явцад алдаатай шийдвэр гаргасан гэдгийг нотлох баримт өгч байсан
- газартай холбоотой асуудлаар оролцож байсан
- захиргааны хэрэгтэй холбоотой тушаал шийдвэр гэх мэт нотлох баримт гаргаж байсан
- ажилд томилох асуудлаар
- холбогдох баримт бичиг гарган өгсөн
- өөрөө хүсэлт гарган цуглуулсан
- Үйлдвэрчний эвлэлийн гишүүдийн эрхийн чиглэлээр хэлэлцээрт орж байсан
- Газар ХХАГ хийж өгч байсан
- Эмчийн тодорхойлолт, шүүхийн ажиллагаа
- Хувийн хэрэг хөтлөх
- Холбогдох эх сурвалжийг олж хүргүүлэх гэх мэт
- ЭМД-аас хөнгөлөлттэй олгодог бараа бүтээгдэхүүнтэй холбоотой үйл ажиллагаанд өгч буй баримтууд
- Галын дүгнэлт гаргуулах, ажлын байрны дүгнэлт хийх зэрэг үйл ажиллагаа, нотлох баримтыг цуглуулсан байна.

Иргэд захиргааны байгууллагад хандсан саналаа дараах хэлбэрээр сонгон гаргадаг байна.

Remove Watermark Now

*Дүрс 13. Захиргааны байгууллагад санал, гомдол гаргадаг хэлбэрүүд*




Иргэд захиргааны байгууллагад гомдол, саналаа гаргах үйл явцыг насны ангиллаар харьцуулан харвал иргэдийн дунд бичгээр болон биечлэн уулзах хэлбэрүүд зонхилж байгаа бөгөөд ялангуяа 30-аас дээш насныхан энэ хэлбэрүүдээр гол төлөв, 30-аас доош насны залуус цахим хэлбэрээр өгөх тохиолдол их байна. Бусад хэлбэрээр санал, хүсэлтээ гаргадаг хэлбэрт албан тоот, 1111 төв зэрэг хэлбэрүүд дурьдагджээ.

Захиргааны байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцсон гэж хариулсан иргэдээс сонсох ажиллагаанд оролцсон эсэх, саналыг нь тухайн байгууллага шийдвэртээ тусгаагүй талаар өөрт мэдэгдсэн эсэх талаар дараах үр дүн гарчээ.

pdfelement

*Дүрс 14. Сонсох ажиллагаанд оролцсон туршлага*




Тус асуултанд тал хувь нь шийдвэрийг нь тусгаагүй талаар мэдэгдээгүй бол дөнгөж 10 гаруйхан хувь нь тусгасан гэж хариулжээ. Тиймээс цаашид сонсох үйл ажиллагааны үр дүнг улам нэмэгдүүлэх шаардлага байгаа нь харагдаж байна.

Remove Watermark Now

## IV. ДҮГНЭЛТ

Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийн талаарх иргэдийн эмпирик үнэлгээний үр дүнгээс дараах дүгнэлт гарч байна:

- Захиргааны ерөнхий хуулийн талаарх мэдээлэл иргэдийн **62.2** хувь нь мэдэж байна гэж хариулсан нь иргэд тус хуулийн талаар боломжийн түвшинд мэдээлэлтэй байгааг харууллаа.
- Харин хуулийн хэрэгжилтэнд оролцсон туршлагатай иргэд судалгаанд **37.2** хувийг эзэлж байна.
- Захиргааны байгууллагын шийдвэр гаргах ажиллагаанд оролцоогүй гол шалтгаан нь иргэд оролцох эрхтэй гэдгээ мэдэхгүй учраас гэж хариулсан байдал өндөр байна. Тиймээс хуулийн хүрээнд иргэдийн эрх, үүргийг тодорхой ойлгуулах, мэдээллээр хангах шаардлага гарч байна.
- Шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцсон иргэдийн тал орчим нь (**44,1** хувь) 2 ба түүнээс дээш удаа оролцсон байгаа нь тус хуулийг мэддэг иргэд хуулийн хэрэгжилтэнд оролцох оролцоо өндөр байгааг харууллаа.
- Мөн оролцогчдын ихэнх хувь нь өөрийн эрх ашигтай шууд холбоотой үйл ажиллагаанд оролцжээ.
- Түүнчлэн, хуульд заасан чиг үүргийг биелүүлэхгүй байх нь тохиолдож байгаа бөгөөд иргэдийн олонхи нь гомдол гаргасныг хүлээж аваагүй, шийдвэрээ эргэж мэдээлээгүй гэж хариулснаас харагдаж байна. Үүний учир шалтгаан хуулийг хэрэгжүүлэгчийн хандлага, эсхүл мэдлэгээс шалгаантай юу гэдгийг чанарын судалгааны үр дүнтэй тулгаж харах шаардлагатай.

pdfelement

Remove Watermark Now

**Хавсралт 2**

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын
Тамгын газрын даргын 2018 оны ...... сарын ......
өдрийн ......... тушаалын нэгдүгээр хавсралт

# ЗАХИРГААНЫ ШИЙДВЭРИЙН ХУВИЙН ХЭРЭГ ХӨТЛӨХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь захиргааны шийдвэрийн хувийн хэрэг хөтлөх, шийдвэрийн төсөлд санал авах хуудас хавсаргах, шийдвэрийн хэрэгжилтийг тэмдэглэх үйл ажиллагааг зохицуулж Захиргааны ерөнхий хуулийг хэрэгжүүлэхэд оршино.

1.2. Захиргааны шийдвэрийн хувийн хэрэг хөтлөх журам / цаашид “журам” гэх / нь Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга болон Засаг даргын Тамгын газраас гаргаж буй захиргааны шийдвэрийг хувийн хэрэг хөтлөх, бүртгэх, хадгалах, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулна.

ХОЁР. Хамрах хүрээ

2.1. Энэхүү журам нь Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын даргын захирамж, тушаал, албан даалгавар, гэрээ бусад баримт бичгийн төсөл буюу бичгээр гаргах захиргааны шийдвэрийн үйл ажиллагаанд хамаарна.

pdfelement

ГУРАВ. Захиргааны шийдвэр гарах, түүний хувийн хэргийг хөтлөх

3.1. Захиргааны шийдвэрийн хувийн хэрэгт энэ журмын 3.2-т заасан шийдвэр гаргах үйл ажиллагааны үндэслэл, үе шат, оролцогчийн санал, холбогдох баримт, сонсох ажиллагаа, уулзалт, хуралдааны тэмдэглэл, шийдэл, хүргүүлсэн, мэдэгдсэн баримт зэргийг хавсаргана.

3.2. Захиргааны хэргийн шийдвэрийн хувийн хэрэг бүрдүүлэх ажлыг дараах этгээд хариуцана.

3.2.1. Захирагааны шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын байгуулагдаагүй бол төслийг боловсруулсан ажилтан.

3.2.2. Захиргааны шийдвэрийн төсөл боловсруулах ажлын хэсгийн харийн бичгийн дарга.

3.3. Захиргааны шийдвэрийн хувийн хэргийг дараах дараалаар бүрдүүлнэ.

Үүнд:

3.3.1. Товъёог

3.3.2. Захиргааны шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан албан тушаалтны шийдвэрийн хуулбар.

3.3.3. Захиргааны шийдвэрийн төсөл.

Remove Watermark Now

3.3.4. Захиргааны шийдвэрийн анхны төсөл танилцуулга, судалгаа, иргэдээс санал авсан бол холбогдох баримт.

3.3.5. Ажлын хэсгийн хэлэлцүүлсэн хувь.

3.3.6. Санал авахаар хүргүүлсэн хувь.

3.3.7. Ирүүлсэн саналыг тусгасан хувь.

3.3.8. Хянасан болон танилцсан хувь.

3.3.9. Санал авсан байгууллагуудын жагсаалт, саналын хуулбар.

3.3.10. Асуудалыг хурлаар хэлэлцсэн тохилдолд хуралдааны тэмдэглэл.

3.3.11. Захиргааны шийдвэрийн төсөлд ирүүлсэн санал.

3.3.12. Захиргааны шийдвэрийн төсөл боловсруулахад үндэслэсэн болон ашигласан баримт бичиг, цугларсан нотлох баримт / эх хувиараа боломжгүй бол хуулбар хувь,үндэслэсэн хуулийн хувьд зөвхөн үнэслэл болгосон заалтыг, өргөдөл хүсэлт/.

3.4. Захиргааны шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцогч биечилэн ирэх шаардлагатай тохиолдолд оролцогчид мэдэгдэж, энэхүү тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Оролцогчид мэдэгдэх хуудас”-г хөтөлнө.

3.5. Захиргааны ерөнхий хуулийн 13 дугаар зүйлд заасан оролцогч буюу захиргааны актын эрх зүйг үйлчлэл шууд болон шууд бусаар чигэлсэн этгээдэд шийдвэрийн агуулагтай танилцуулж, энэхүү тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Шийдвэрийн төсөл танилцуулах хуудас”-г хөтөлнө.

pdfelement

3.6.Захиргааны шийдвэрийн төсөл боловсруулж, батлуулахдаа энэхүү тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Шийдвэрийн төсөлд санал авах хуудас”-г дагалдуулна.Санал авах хуудсанд захиргааны шийдвэр боловсруулхад оролцсон албан хаагч бүрийн эцэг /эх/-н нэр, өөрийн нэр, албан тушаал, оролцоо, гүйцэтгэлийн тухай дэлгэрэнгүй тэмдэглэсэн байна.

3.7. Бичгээр гаргасан захиргааны шийдвэр нь Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан байна.

3.8. Захиргааны шийдвэрийг мэдэгдэх ажиллагааг Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу явуулах бөгөөд 5 дугаар хавсралтаар батлагдсан “Захиргааны шийдвэрийг мэдэгдэх хуудас”-г хөтөлнө. Захиргааны шийдвэр нь мэдэгдсэнээр хүчин төгөлдөр болно.

3.9. Оролцогч захиргааны шийдвэртэй танилцах, танилцсан тухай болон гардан авсан тухай баримтад гарын үсэг зурахаас татгалзсан бол энэ тухай тайлбар бичүүлнэ. Тйалбар бичихээс татгалзвал шийдвэрийн төсөл боловсруулсан албан тушаалтан тайлбар бичиж хавсаргана.

3.10. Захиргааны шийдвэрийг эрх бүхий албан тушаалтан баталсанаас хойш ажлын 3 өдрийн дотор энэ журмын 3.2-т заасан этгээд захиргааны шийдвэрийн хувийн хэргийг бүрдүүлэн, архивын нэгж болгон хадгалхад бэлтгэн тухайн асуудалд хамаарах хэлтэсийн даргад танилцуулсаны дараа Хууль зүйн  тасгийн даргад хүлээлгэн өгнө.

ДӨРӨВ.Захиргааны шийдвэрийн хувийн хэрэг бүртгэх, хадгалах, ашиглуулах

Remove Watermark Now

4.1.Засг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэсийн Хууль зүйн тасгийн дарга захиргааны шийввэрийн хувийн хэргийг хүлээн авч, шийдвэрийн хамт хадгалан, дараа онд архивын нэгж болгон бүртгэлээр байгууллагын архивд шилжүүлнэ.

4.2. Захиргааны шийдвэрийн хувийн хэрэгтэй танилцах ашиглахад Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын “Архивын албан хэрэг хөтлөлтийн журам”-ыг баримтална.

ТАВ. Хариуцлага

5.1. Энэхүү журмыг зөрчсөн ажилтанд Төрийн албаны тухай, Хөдөлмөрийн тухай хуулвд заасны дагуу сахилгын шийтгэл ноогдуулна.

5.2. Энэхүү журмыг хэрэгжүүлсэн байдлыг төрийн захиргааны албан хаагчдын үр дүнгийн гэрээг дүгнэхэд харгалзан үзнэ.

pdfelement

Remove Watermark Now

газрын даргын 2017 оны ....... дугаар сарын
.......... өдрийн ............................ тушаалын
хоёрдугаар хавсралт

**ЗАХИРАМЖИЙН ТӨСӨЛД САНАЛ АВАХ ХУУДАС**

Төслийн товч утга:________________________________________________

______________________________________________________________

...... оны....сарын.....өдөр
/Нэгжийн нэр/ ____________________________________
/Боловсруулсанажилтан, албантушаал,нэр/

| № | Саналөгөхалбантушаалтан | Сонирхлын зөрчилтэй эсэх | Санал | Гарынүсэг он,сар, өдөр |
|---|---|---|---|---|
| 1 | Засаг даргын орлогч | | | |
| 2 | Тамгынгазрындарга | | | |
| 3 | Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга | | | |
| 4 | Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга | | | |
| 5 | /Нэгжийн дарга/ | | | |
| 6 | Хууль зүйн тасгийн дарга | | | |

Жич:Сонирхлын зөрчилтэй бол зөрчил үүссэн тухай мэдэгдэл, тайлбар гаргах

**ЗАСАГ ДАРГЫН ЗӨВШӨӨРӨЛ**:

pdfelement

Remove Watermark Now

**ТУШААЛЫН ТӨСӨЛД САНАЛ АВАХ ХУУДАС**

Төслийн товч утга:________________________________________________________

...... оны....сарын.....өдөр
/Нэгжийн нэр/

______________________________
/Боловсруулсанажилтан, албантушаал,нэр/

| № | Саналөгөхалбантушаалтан | Сонирхлын зөрчилтэй эсэх | Санал | Гарынүсэг он,сар, өдөр |
|---|---|---|---|---|
| 1 | Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга | | | |
| 2 | Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга | | | |
| 3 | /Нэгжийн дарга/ | | | |
| 3 | Хууль зүйн тасгийн дарга | | | |
| 4 | Архивын тасгийн дарга | | | |

Жич:Сонирхлын зөрчилтэй бол зөрчил үүссэн тухай мэдэгдэл, тайлбар гаргах

**ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ЗӨВШӨӨРӨЛ**:

____________________________________________________________

pdfelement

Remove Watermark Now

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2017 оны ....... дугаар сарын ........өдрийн.................. тушаалын гуравдугаар хавсралт

ЗАХИРГААНЫ ШИЙДВЭР ГАРГАХ АЖИЛЛАГААНЫ ОРОЛЦОГЧИД МЭДЭГДЭХ ХУУДАС

| д/д | Агуулга | Холбогдох мэдээлэл |
|---|---|---|
| 1 | Хүрэлцэн ирэх газар | |
| 2 | Хүрэлцэн ирэх өдөр | |
| 3 | Хүрэлцэн ирэх цаг | |
| 4 | Зорилго | |
| 5 | Захиргааны шийдвэрийн талаарх мэдээлэл, үндэслэл | |
| 6 | Захиргааны шийдвэр гаргах ажиллагаанд оролцогч ирээгүй тохиолдолд гарах үр дагавар | |

pdfelement

Жич: Захиргааны ерөнхий хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу оролцогчид мэдэгдэхдээ энэхүү хуудсыг бөглөнө.

Хүснэгтийн 5 дугаар баганад буюу "...гарах үр дагавар." гэдэгт оролцогч ирээгүйгээс үүсэх хууль зүйн үр дагаврыг бичнэ. Тухайлбал; "шийдвэрийн талаар тайлбар, санал гаргах, энэ үйл ажиллагааны талаар гомдол гаргах эрхгүй болно" гэх мэт агуулгаар бичнэ.

Мэдэгдэх хуудас бичсэн: Албан тушаал.....................................
Эцэг /эх/-ийн нэр...........................нэр.............................................

Гарын үсэг…………………………………………………………………..

Огноо..............................

Remove Watermark Now

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2017 оны ....... дугаар сарын .......... өдрийн ........................... тушаалын дөрөвдүгээр хавсралт

ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛ ТАНИЛЦУУЛАХ ХУУДАС

| № | Албан хаагчийн албан тушаал, овог нэр | Захиргааны актын агуулга /дэлгэрэнгүй бичих/ | Танилцсан | | Гарын үсэг /зөвшөөрсөн, зөвшөөрөөгүй талаарх болон бусад санал/ |
|---|---|---|---|---|---|
| | | | Он,сар, өдөр | Цаг, минут | |
| | | | | | |

Оролцогч шийдвэрийн төсөлтэй танилцахаас болон гарын үсэг зурахаас татгалзсан бол энэ тухай тайлбар бичүүлнэ. Тайлбар бичихээс татгалзвал шийдвэрийн төсөл боловсруулсан албан тушаалтан тайлбар бичиж хавсаргана.

pdfelement

Remove Watermark Now

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын
газрын даргын 2017 оны ....... дугаар сарын
......... өдрийн ...........................тушаалын
дөрөвдүгээр хавсралт

**ЗАХИРГААНЫ ШИЙДВЭРИЙГ МЭДЭГДЭХ /ГАРДУУЛАХ/ ХУУДАС**

20.... оны.....дугаар сарын ....-ны өдөр Улаанбаатар хот

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 20...... оны ......дугаар сарын ......ны өдрийн ...... дугаар тушаалыг гардуулах /мэдэгдсэн/, /мэдэгдсэн хэлбэрийг бичих/..........................................................................................
.....................................................................................................................................................
.....................................................................................................................................................
.....................................................................................................................................................
................................

Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 дэх хэсэгт заасны дагуу захиргааны актыг гардан авснаас хойш 30 хоногийн дотор гомдлыг дээд шатны байгууллага /Төрийн албаны зөвлөл гэх мэт/-д гаргах эрхтэй.

pdfelement

ШИЙДВЭРИЙГ ГАРДАН АВСАН:........................................./.................................../
/гарын үсэг/ /нэр/

Жич: 1/Захиргааны шийдвэрийг мэдэгдэх ажиллагааг Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу хэрэгжүүлнэ.

2/Захиргааны актыг утас, факс, шуудан, цахим болон бусад хэлбэрээр мэдэгдсэн бол холбогдох нотлох баримтыг хавсаргах;

3/Оролцогч захиргааны актыг гардан авахаас татгалзсан бол энэ тухай тайлбар бичүүлнэ. Тайлбар бичихээс татгалзвал шийдвэрийн төсөл боловсруулсан албан тушаалтан тайлбар бичиж хавсаргана. Эдгээр ажиллагааг хийсний дараа Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу захиргааны шийдвэрийг мэдэгдэх ажиллагааг хэрэгжүүлнэ.

Remove Watermark Now

Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын
газрын даргын 2017 оны ....... дугаар сарын
....... өдрийн .....тушаалын долоодугаар
хавсралт

**БУСАД БАЙГУУЛЛАГА, АЖ АХУЙН НЭГЖ, ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГАТАЙ БАЙГУУЛАХ ГЭРЭЭНИЙ ХЯНАЛТЫН ХУУДАС**

| № | Гарчиг | | | |
|---|---|---|---|---|
| 1 | Гэрээний утга | | | |
| 2 | Дүн шинжилгээ хийсэн байдал | | | |
| 3 | Хянасан: | Санал | огноо | Гарын үсэг |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| 4 | | | | |
| | | | | |

1/Хүний нөөц, сургалттай холбоотой шийдвэрийн төсөлд Засаг даргын Тамгын газрын дарга, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргаас санал авна.

2/Санхүү, төсвийн хөрөнгийн асуудалтай шийдвэрийн төсөлд Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга, ерөнхий нягтлан бодогчоор заавал гарын үсэг зуруулж, саналыг авсан байна.

pdfelement

Remove Watermark Now

**Хавсралт 3**

## Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрт хийсэн судалгаа

| № | Захиргааны хэргийн шүүх хуралдааны шийдвэрүүд | Холбогдох хуулийн зүйл, заалт | | |
|---|---|---|---|---|
| | | **Тодорхойлох хэсэгт** | **Үндэслэх хэсэгт** | **Тогтоох хэсэгт** |
| 1 | Төв аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2017.12.19 | | Захиргааны ерөнхий хуулийн **24-р зүйлийн 24.2, 24.3, 24.4, 25-р зүйл, 26-р зүйлийн 26.1, 27-р зүйлийн 27.4, 27.5** | Захиргааны ерөнхий хуулийн **24-р зүйлийн 24.2, 24.3, 24.4, 25-р зүйл, 26-р зүйлийн 26.1, 27-р зүйлийн 27.4, 27.5** |
| 2 | Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2017.12.15 | Захиргааны ерөнхий хуулийн 92-р зүйлийн 92.1, 92.2, 93-р зүйлийн 93.1, 94-р зүйлийн 94.1, 98-р зүйлийн 98.1.5, мөн хуулийн 37-р зүйлийн 37.1, **27-р зүйлийн 27.2.2 27.5** | Захиргааны ерөнхий хуулийн **24-р зүйлийн 24.1, 24.2, 24.4** | Захиргааны ерөнхий хуулийн **24-р зүйлийн 24.1, 24.2, 24.4** |
| 3 | Дархан-Уул аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2017.11.17 | Захиргааны ерөнхий хуулийн **13-р зүйл,** 40-р зүйл | | |
| 4 | Сүхбаатар аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2017.12.01 | | Захиргааны ерөнхий хуулийн 4-р зүйлийн 4.1, **26, 27-р зүйл** | Захиргааны ерөнхий хуулийн 4-р зүйлийн 4.2.6, **26-р зүйлийн 26.1, 27-р зүйлийн 27.4, 27.6** |
| 5 | Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2018.02.09 | Захиргааны ерөнхий хуулийн **27-р зүйл** | Захиргааны ерөнхий хуулийн 4-р зүйлийн 4.2.6, **24-р зүйлийн 24.1, 24.4, 25-р зүйлийн 25.1, 26-р зүйлийн, 27-р зүйлийн 27.5, 27.6** | Захиргааны ерөнхий хуулийн 4-р зүйлийн 4.2.6, **24-р зүйл, 27-р зүйл** |
| 6 | Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2017.08.09 | Захиргааны ерөнхий хуулийн **26-р зүйлийн 26.1, 27-р зүйл, 28-р зүйлийн 28.1, 28.1.1** | Захиргааны ерөнхий хуулийн **26-р зүйлийн 26.1, 26.2, 27-р зүйл 27.1, 27.2, 28-р зүйлийн 28.1.2, 28.1.3** | |
| 7 | Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2018.03.05 | Захиргааны ерөнхий хуулийн **20-р зүйлийн 20.1, 27-р** | Захиргааны ерөнхий хуулийн 47-р зүйлийн | |

pdfelement

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | **зүйл 27.2.2,** 47-р зүйлийн 47.1.6, 92-р зүйлийн 92.2, 94-р зүйлийн 94.1 | 47.1.6 | |
| 8 | Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2018.03.02 | Захиргааны ерөнхий хуулийн 4-р зүйлийн 4.2.6, 4.2.8, 6-р зүйл, **26-р зүйлийн 26.1** | Захиргааны ерөнхий хуулийн 4-р зүйлийн 4.2.1, 4.2.5, **26-р зүйл, 27-р зүйл** | Захиргааны ерөнхий хуулийн 4-р зүйлийн 4.2.1, 4.2.5, 4.2.6, 4.2.8, 6-р зүйл, **26-р зүйлийн 26.1** |
| 9 | Баянхонгор аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2018.02.07 | Захиргааны ерөнхий хуулийн **27-р зүйл** | Захиргааны ерөнхий хуулийн **27-р зүйл, 29-р зүйлийн 29.1** | |
| 10 | Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2017.07.03 | Захиргааны ерөнхий хуулийн 47-р зүйлийн 47.1.6 | Захиргааны ерөнхий хуулийн **15-р зүйлийн 15.1.4** | Захиргааны ерөнхий хуулийн 47-р зүйлийн 47.1.6 |
| 11 | Завхан аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2017.11.17 | Захиргааны ерөнхий хуулийн 4-р зүйлийн 4.2.3, 4.2.6, **13-р зүйлийн 13.2, 13.2, 24-р зүйлийн 24.1** | Захиргааны ерөнхий хуулийн 4-р зүйлийн 4.2.3, 4.2.6, **13-р зүйлийн 13.2, 13.2, 24-р зүйлийн 24.1, 27-р зүйл,** 47-р зүйлийн 47.1 | |
| 12 | Булган аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2018.01.02 | Захиргааны ерөнхий хуулийн 4-р зүйлийн 4.2.1, 4.2.8, 6-р зүйл, **27-р зүйл** | | |
| 13 | Булган аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2017.10.23 | Захиргааны ерөнхий хуулийн **27-р зүйл, 28-р зүйлийн 28.1.3,** 40-р зүйлийн 40.2.3, 47-р зүйлийн 47.1.6 | Захиргааны ерөнхий хуулийн **24-р зүйл, 26-р зүйлийн 26.1, 27-р зүйл, 28-р зүйлийн 28.1.3** | Захиргааны ерөнхий хуулийн **24-р зүйл 24.1, 24.2, 26-р зүйлийн 26.1, 27-р зүйл, 28-р зүйлийн 28.1.3,** 40-р зүйлийн 40.2.3 |
| 14 | Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2018.03.15 | | Захиргааны ерөнхий хуулийн 4-р зүйлийн 4.2.6, 5-р зүйлийн 5.1, 5.4, **11-р зүйлийн 11.1.1, 12-р зүйлийн 12.1, 15-р зүйлийн 15.1.4, 24-р зүйлийн 24.1, 24.2, 25-рзүйлийн 25.1.2, 26 дугаар зүйлийн 26.1, 26.2, 27-р** | |



Remove Watermark Now
pdfelement

Remove Watermark Now

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | **зүйлийн 27.2, 27.6,** 92-94-р зүйл | |
| 15 | Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2017.12.15 | Захиргааны ерөнхий хуулийн **27-р зүйлийн 27.2.2, 27.6, 37-р зүйлийн 37.1,** 92-р зүйлийн 92.1, 93-р зүйлийн 93.1, 94-р зүйлийн 94.1, 98-р зүйлийн 98.1.5 | Захиргааны ерөнхий хуулийн **24-р зүйлийн 24.1, 24.2, 24.4** | Захиргааны ерөнхий хуулийн **24-р зүйлийн 24.1, 24.2, 24.4** |
| 16 | Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2017.11.16 | Захиргааны ерөнхий хуулийн 37-р зүйлийн 37.3 | Захиргааны ерөнхий хуулийн **26-р зүйлийн 26.1, 27-р зүйлийн 27.3, 27.5** | Захиргааны ерөнхий хуулийн **26-р зүйлийн 26.1, 27-р зүйлийн 27.3, 27.5** |
| 17 | Дундговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр, 2017.11.28 | | **Захиргааны ерөнхий хуулийн 11-р 11.2,** 52-р зүйлийн 52.1 | |

pdfelement

Remove Watermark Now

**Хавсралт 4**



Зураг 1

Remove Watermark Now



Зураг 2

Remove Watermark Now

**Хавсралт 5**

**Цахим хаягт хийсэн шинжилгээ:**

| № | Байгууллага | Биелэлт<br>ЗЕХ-ийн 67.6 |
|---|---|---|
| 1 | Нийслэлийн ИТХ<br>http://www.citycouncil.mn/ | 4/16<br>Цахим хуудсандаа тэргүүлэгчдийн баталсан 2016 оны 8 сарын 31-ний өдрийн “Хэв журмын урамшилт эргүүл ажиллуулах журам”, 2016 оны 09 сарын 16 өдрийн “Нийслэлийн удирдлагын шагналын төрөл, түүнийг олгох журам“ 2016 оны 09 сарын 16 өдрийн “Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн иргэдтэй хийх уулзалтын журам”-ыг тус тус байрлуулсан байна.<br>Харин улсын нэндсэн бүртгэлд бүртгэсэн он, сар, өдөр, дугаарыг заагаагүй байсан болно. |
| 2 | Нийслэлийн ЗДТГ<br>www.ulaanbaatar.mn | Байхгүй. |
| 3 | ЗГХЭГ<br>http://cabinet.gov.mn/ | Байхгүй. |
| 4 | Монголбанк<br>https://www.mongolbank.mn/ | 4/23<br>Монгол банкны ерөнхийлөгчийн болон хамтарч гаргасан тушаалаар батлагдсан журмуудаа цахим хуудсандаа байрлуулсан хэдий ч улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн он, сар, өдөр, дугаарыг заагаагүй байсан болно. |
| 5 | УИХ-ын Тамгын газар<br>www.parliament.mn | 4/23<br>Байхгүй. |
| 6 | Санхүүгийн зохицуулах Хороо<br>http://www.frc.mn/<br>. | 5/1<br>2016 оны 7 сарын 01-нээс хойш баталсан журам тавиагдаагүй болно |
| 7 | Төрийн албаны Зөвлөл<br>http://www.csc.gov.mn | 4/30<br>2016 оны 7 сарын 01-нээс хойш |

pdfelement

Remove Watermark Now

| | | |
|---|---|---|
| | | баталсан журам тавигдаагүй болно. |
| 8 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам<br>http://www.mlsp.gov.mn/ | 4/27<br>2016 оны 7 сарын 01-нээс хойшхи Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын болон хамтарсан 6 тушаалаар баталсан дүрэм, журмыг байрлуулсан байх бөгөөд үүнээс 4 нь улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн он сар өдөр дугаарыг заасан байна. 4 тушаалыг www.legalinfo.mn цахим хуудас руу дамжиж орж үзэхээр байрлуулсан байх ба үүний хоёрынх нь улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн он сар өдөр дугаарыг заасан байна |
| 9 | Эрүүл мэндийн яам<br>https://www.mohs.mn/ | 5/4<br>2016 оны 7 сарын 01-нээс хойшхи Эрүүл мэндийн сайдын болон хамтарсан 9 тушаалаар баталсан дүрэм, журам байрлуулсан байх бөгөөд үүнээс 3 нь улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн он, сар, өдөр дугаарыг заасан байна. |
| 10 | Сонгинохайрхан дүүргийн ЗДТГ<br>http://zasag.mn/m/skhd<br>http://www.shd.mn/. | 5/11<br>үндсэн энэ цахим хуудас нь ажиллахгүй байна |
| 11 | Орхон аймаг ИТХ<br>http://itkh.orkhon.gov.mn/ | 6/4<br>2016 оны 07 сарын 01-нээс хойшхи Аймгийн ИТХ-ын болон тэргүүлэгчдийн тогтоол, баталсан журмыг цахим хуудсандаа байрлуулсан хэдий улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн, он сар өдөр дугаартай акт байхгүй байна. |
| 12 | Булган аймгийн Тэшиг сум<br>http://teshig.bulgan.khural.mn | 6/5<br>Сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоол, баталсан журмаа байрлуулсан байна. Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн, он сар өдөр, дугаар заагаагүй болно. |
| 13 | Дорнод аймаг ИТХ<br>http://dornod.khural.mn/ | 4/10<br>2016 оны 07 сарын 01-нээс |

pdfelement

Remove Watermark Now

| | | |
|---|---|---|
| | | хойшхи Аймгийн ИТХ-ын болон тэргүүлэгчдийн тогтоол, баталсан журмыг цахим хуудсандаа байрлуулсан хэдий улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн, он сар өдөр дугаартай акт байхгүй байна. |
| 14 | Дорноговь аймаг ИТХ<br>http://dornogovi.khural.mn/ | 5/16<br>2016 оны 07 сарын 01-нээс хойшхи Аймгийн ИТХ-ын болон тэргүүлэгчдийн тогтоол, баталсан журмыг цахим хуудсандаа байрлуулсан хэдий улсын нэгдсэн бүртгэлд бүртгэсэн, он сар өдөр дугаартай акт байхгүй байна. |

**Захиргааны байгууллагын мэдээллийн самбар**



Remove Watermark Now

# Захиргааны ерөнхий хуулийн V, VIII, IX дүгээр бүлгийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлангийн Хавсралт 1- 4

pdfelement

Remove Watermark Now



**Хавсралт: Захиргааны ерөнхий хууль мөрдөгдөж эхэлснээс хойш захиргааны байгууллагуудын байгуулсан гэрээ**

| д/д | Гэрээний нэр | Гэрээ байгуулсан зорилго | Огноо | Гэрээ байгуулах үндэслэл | Байгууллагын нэр төлөөлж гэрээ байгуулсан этгээдийн нэр | Гэрээний заалт | Гэрээний бичилт |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Жагсаал цуглаан бүртгэх тухай гэрээ | Жагсаал цуглаан хийх журмын тухай хуульд заасны дагуу зохион байгуулагч нь үүрэг хүлээдэг. Тус үүргийн биелэлтийг хангахын тулд гэрээ байгуулсан. | 2018.04.11 | Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль | НЗДТГ ХЭЗХ-ийн дарга А.Даваажаргал | 2.1 | Нэг талаас НЗДТГ, түүнийг төлөөлж Хууль эрх зүйн хэлтсийн дарга А.Даваажаргал, нөгөө талаас суулт, тайван жагсаал, цуглааны ерөнхий зохион байгуулагч Ш.Баярсайхан... |
| 2. | Хог хаягдлын үйлчилгээнд хяналт тавих хамтран ажиллах гэрээ | ... дүүргийн хог хаягдлын үйлчилгээнд захиалагчийг төлөөлөн хяналт тавих ажил гүйцэтгэх | 2018.03.01 | 2018.02.23-ны өдрийн гэрээ дүгнэсэн протокол. Төсвийн тухай хуулийн 6.4.3, НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 145 тогтоол | Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба Уб хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга Т.Гантөмөр | - | Нэг талаас Уб хотын Захирагчийн ажлын алба, түүнийг төлөөлж ... дарга Т.Гантөмөр, нөгөө талаас “Эмэгтэйчүүдийн эрх, хамгаалал хөгжлийн хүрээлэн” ТББ, түүнийг төлөөлж тэргүүн А.Мягмардолж... |
| 3. | Гоёл чимэглэлийн мод, сөөгний суулгац нийлүүлэх ажлын гэрээ | Гоёлын мод, бут сөөгний суулгац нийлүүлэх | 2017.12.05 | Иргэний хууль болон бусад хууль тогтоомж, Ногоон байгууламжийн сангийн дүрмийн 3.1.5, УХЕМ-ийн 2017 оны А/227 тушаал МУЕ-ийн 2010 оны 63 дугаар зарлигийг хэрэгжүүлэх | Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба Уб хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга Т.Гантөмөр | - | Нэг талаас УБ хотын Захирагчийн ажлын алба, түүнийг төлөөлж ... дарга Т.Гантөмөр, нөгөө талаас “Мөнх ногоон цэцэрлэг холбоо” ТББ, түүнийг төлөөлж тэргүүн Ц.Баттулга... |
| 4. | Орон сууцны нөхцөл сайжруулах | | | | | | |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төсөл хэрэгжүүлэх гурван талт гэрээ | | | | | | |
| 5. | Тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоолын үйл ажиллагаа эрхлэн явуулах тухай гэрээ | Нийтийн эдэлбэр газарт тээврийн хэрэгслийн төлбөртэй зогсоолын байгуулах тухай | | НИТХ-ын 2009 оны 4/27, 2011 оны 7/66 дугаар тогтоол | Нийслэлийн авто замын хөгжлийн газар | | |
| 6. | Ажил гүйцэтгэх гэрээ | Хэрэглэгчийн үнэлгээ хийх | 2018.02.07 | Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын даргын 2018 оны А/9 тушаалаар батлагдсан удирдамж | Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын ХШҮДА хэлтэс С.Буянбадрах- | | |
| 7. | “Цайртминерал ХХК нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах гэрээ” | Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгал орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх ажлын байр нэмэгдүүлэхтэй холбоотойгоор хамтран ажиллах | 2017.04.19 | МУЗГ-ийн 2016 оны 03 сарын 28-ны өдрийн 179 тогтоол | Сүхбаатар аймгийн Засаг дарга З. Энхтөр | - | Нэг талаас Сүхбаатар аймгийн Засаг дарга З.Энхтөр, нөгөө талаас ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Цайртминерал” ХХК түүнийг төлөөлж ерөнхий захирал С.Батхүү |
| 8. | Иргэн, хуулийн этгээдэд хадлангийн зориулалтаар газар ашиглуулах гэрээ | Хадлангийн зориулалтаар газар ашиглуулах | 2017.08.28 | Газрын тухай хууль 20.1.1, 20.2.1, Аймгийн иргэлийн төлөөлөгчдийн хурлын 51 дүгээр тогтоол, Мөнххаан сумын Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөө аймгийн Засаг даргын 2017 оны 08 сарын 13-ны өдрийн А/117 тоот шийдвэр | Мөнххаан сумын газрын асуудал эрхэлсэн албан тушаалтан Э.Алтанзул<br><br>/Сүхбаатар аймгийн Засаг дарга З.Энхтөр баталсан/ | - | Газар ашиглуулагчийг төлөөлж Мөнххаан сумын газрын асуудал эрхэлсэн албан тушаалтан Э.Алтанзул, газар ашиглагчийг төлөөлж Ч.Ганболд |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 9. | Худалдах худалдан авах гэрээ | ЮМЗ маркийн 76-75 СҮА улсын дугаартай автомашиныг худалдах | 2018.01.03 | Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Иргэний тухай хууль, АИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 81 дүгээр тогтоол болон холбогдох бусад эрх зүйн акт | Сүхбаатар аймгийн орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн Г.Баадай<br><br>/Орон нутгийн өмчийн газрын дарга И.Батсүх баталсан/ | 1.1 | Нэг талаас Сүхбаатар аймгийн орон нутгийн өмчийн газар нөгөө талаас дуудлага худалдаанд ялагч болсон Б.Ганбат |
| 10. | Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ | Аймгийн нутгийн удирдлагын ордон доторх 276 мкв талбай бүхий өрөөг түрээслэх | 2018.01.02 | Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйл, Монгол улсын бусад хууль тогтоомж, Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоол, холбогдох бусад дүрэм, журам | Орон нутгийн өмчийн газрыг төлөөлж ОНӨГ-ын мэргэжилтэн Г. Баадай<br><br>Аймгийн засаг даргын тамгын газрыг төлөөлж нягтлан бодогч Б.Эрдэнэцэцэг<br><br>/Орон нутгийн өмчийн газрын дарга И.Батсүх баталсан/ | - | Түрээсийн гэрээг өмчлөгч орон нутгийн өмчийн газрыг төлөөлж ОНӨГ-ын мэргэжилтэн Г.Баадай, өмч эзэмшигчийг төлөөлж Аймгийн засаг даргын тамгын газрын нягтлан бодогч Б.Эрдэнэцэцэг, Түрээслэгчийг төлөөлж Аудитын газрын дарга М.Нарантуяа |
| 11. | Автомашины зогсоолын гэрээ | Захиалагч нийлүүлэгч хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтоох | 2017.09.02 | Иргэний хууль болон бусад хууль тогтоомж | Нийслэлийн хот төлөвлөлт ерөнхий төлөвлөгөөний газрын орлогч дарга Ш.Уртнасан, нягтлан бодогч Б.Болормаа, Хуулийн хэлтсийн мэргэжилтэн Я.Болор<br><br>/Улаанбаатар хотын ерөнхий архитектор бөгөөд Нийслэлийн хот төлөвлөлт, | - | Нэг талаас Нийслэлийн хот төлөвлөлт ерөнхий төлөвлөгөөний газар, нөгөө талаас “Полипласт” ХХК |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ерөнхий төлөвлөгөөний газрын дарга Э.Анар баталсан/ | | |
| 12. | Орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах гэрээ | Тусгай зөвшөөрөл эзэмшигч байгал орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх ажлын байр нэмэгдүүлэхтэй холбоотойгоор хамтран ажиллах | 2017.08.01 | Үндсэн хууль, Ашигт малтмалын тухай хууль, Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, олон улсын гэрээ | Сүхбаатар аймгийг төлөөлж аймгийн Засаг дарга З.Энхтөр | - | Нэг талаас Сүхбаатар аймаг түүнийг төлөөлж аймгийн Засаг дарга З.Энхтөр, нөгөө талаас ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Бадмаараг Хаш” ХХК захирал Гао Хайфэн |
| 13. | Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ортопед тусгай хэрэгслэлийн үйлчилгээ үзүүлэх гэрээ | Хараагүй хүний тусгай хэрэгслэлийг 10 хүнд олгох | 2017.10.11 | - | Сүхбаатар аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрыг төлөөлж, нийгмийн халамжийн хэлтсийн дарга Т.Алтаннавч<br><br>/Сүхбаатар аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газрын дарга баталсан/ | - | Нэг талаас Сүхбаатар аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газар, нөгөө талаас Монголын хараагүйчдийн үндэсний холбоо ТББ-ыг төлөөлж ЕНБ-ийн дарга Б.Болдбаатар |
| 14. | Ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асрах тухай гэрээ | Ахмад настай, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхдийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа болон хөдөлмөрийн насны иргэнээс гадна ахмад настан болон 16-аас дээш насны хүүхдэд асаргааны тэтгэмж олгохтой холбоотой | 2017.04.13 | Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.2.1, 13.2.3,13.2.4 | Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн З.Урангоо | 1.2 | Нэг талаас Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн З. Урангоо, сумын хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 3 дугаар багт оршин суух Ё.Алтанцэцэг, ахмад настанг асарч буй иргэн А.Энхмөнх |

Remove Watermark Now

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | үүссэн харилцааг зохицуулах | | | | | |
| 15. | Хамтран ажиллах гэрээ | Протез, ортопед тусгай хэрэгслэлээр чанартай үйлчилгээ үзүүлэгч үйлчлүүлэгчийн өмнөөс үйлчилгээг худалдан авагч талын харилцан хүлээх үүрэг хариуцлага, гэрээний нөхцөлийг зохицуулах | 2017.01.02 | Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5.1.1, 5.1.3, 5.1.4 | Аймгийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Нийгмийн халамжийн хэлтсийн дарга Т.Алтаннавч<br><br>/Сүхбаатар аймгийн ХХҮГ-ын дарга Г.Гэрэлбадрах баталсан / | - | Нэг талаас аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний газар, нөгөө талаас “Аатэй Ганзагадай” ХХК-ийн захирал Д.Эрдэнэ-Очир |
| 16. | Хамтран ажиллах гэрээ | Даатгуулагчдад нийгмийн даатгалын үйлчилгээг банкны байгууллагаар дамжуулан үзүүлэх | 2018.02.20 | Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох, тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Банкны тухай хууль, Банк эрх бүхий этгээдийн мөнгөн хадгаламж, | Сүхбаатар аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга П.Амар<br><br>/Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга Д.Зоригт баталсан/ | - | Нэг талаас Сүхбаатар аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга П.Амар, нөгөө талаас Хас банкийг төлөөлж С.Наранцэцэг |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2010 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан “ Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмжийн үйлчилгээ үзүүлэх арилжааны банктай хамтран ажиллах журам” | | | |
| 17. | Даатгуулагчдад эмийн хөнгөлөлт үзүүлэх үйлчилгээг худалдан авах гэрээ | Амбулаторийн төрөлжсөн мэргэжлийн эмчийн жороор бичсэн зайлшгүй шаардлагатай эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх | 2018.02.22 | Эрүүл мэндийн тухай хуулийн 10.1, 10.2, 13.1.2, 16.1.3 | Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрыг төлөөлж Бодлогын хэрэгжилтийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Гийхнаран<br><br>Сүхбаатар аймгийн эрүүл мэндийн даатгалын эмч В.Нэргүй /Эрүүл мэндийн даатгалын ерөнхий даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Алтанхуяг/ | - | Нэг талаас Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, нөгөө талаас “Хатанцагаан тун” ХХК-ийн Эрдэнэцагаан сумын эмийн сан |
| 18. | Аймгийн төсвийн ерөнхийлөн захиарагчтай | Сүхбаатар аймгийн Засаг даргын худалдан авах бүтээгдэхүүний стратегийн ач | 2018.02.27 | Төсвийн тухай хуулийн 39.1, 39.2, 39.3, 39.4, 40.1, | Аймгийн засаг дарга З.Энхтөр | 1.2 | Нэг талаас аймгийн засаг дарга З.Энхтөр, нөгөө талаас Асгат сумын Засаг дарга У.Мөнхбаяр |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Асгат сумын Засаг даргын байгуулсан үр дүнгийн гэрээ | холбогдол, тоо хэмжээ, чанарыг тодорхойлж, харилцан хүлээсэн үүрэг хариуцлагыг тодорхой болгон, эцсийн үр дүнг үнэлж дүгнэх замаар тус суманд тухайн төсвийн жилд төвлөрсөн болон орон нутгийн төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх төр, нийгмийн үйлчилгээний чанар хүртээмж, үр ашгийг дээшлүүлэх | | Иргэний хуулийн 195-205 | | | |
| 19. | Хамтран ажиллах гэрээ | | 2017.03.27 | Иргэний хууль, Нөхөрлөл хоршоо, Компанийн тухай хууль, Малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Хүнсний тухай хууль, Амьтан ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт шалгалтын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль,Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан | Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга Э.Өлзийтогтох | - | Нэг талаас Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга Э.Өлзийтогтох, нөгөө талаас Баруун-Урт сумын засаг дарга, Баруун-Урт сумын мал эмнэлэг үржлийн тасгийн дарга<br><br>/Засаг дарга, мал эмнэлэг үржлийн тасгийн дарга нар гэрээнд гарын үсэг зураагүй / |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | сэргийлэх тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Тариалангийн тухай хууль, ЖДҮ-ийн тухай хууль, Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгааны тэмдэг, түүнийг хэрэглэх журам, Мал эмнэлэг үржлийн үйлчилгээний нэгжийн бүтэц, үйл ажиллагаа MNS 5368-2:2011" стандарт, Монгол улсын бусад эрх зүйн акт | | | |
| 20. | Хувийн хэвшлийн мал эмнэлэг, үржлийн нэгжтэй байгуулах үр дүнгийн гэрээ | Хувийн хэвшлийн мал эмнэлгийн стандарт шаардлагыг хангах, ажил үлйчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, халдварт болон гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд мал сүргийг бүрэн хамруулах улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө, эм биобэлдмэлийн зарцуулалт, үр ашгийг сайжруулах | 2018.04.02 | Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4.5.3 | Засаг даргын нэрийн өмнөөс Мал эмнэлэг, үржлийн тасгийн дарга Т.Тунгалаг | - | Нэг талаас Засаг даргын нэрийн өмнөөс Мал эмнэлэг, үржлийн тасгийн дарга Т.Тунгалаг нөгөө талаас Хувийн хэвшлийн мал эмнэлэг, үржлийн нэгж "Гүн Гуу" ББН-ийн малын их эмч Ч.Оюунчимэг |
| 21. | Хамтран ажиллах гэрээ | Суманд мал эмнэлгийн, хүнсний аюулгүй байдлын хяналтыг хамтран хэрэгжүүлэхэд | 2018.03.13 | - | Мэргэжлийн хяналтын газрын дарга С.Сарантуяа | - | Нэг талаас Мэргэжлийн хяналтын газрын дарга С.Сарантуяа Баруун-Урт сумын засаг дарга С.Идэрбат |

pdfelement

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | талуудаас хүлээх, эрх, үүргийг зохицуулах | | | Баруун-Урт сумын засаг дарга С.Идэрбат | | |
| 22. | Газар худалдах, худалдан авах гэрээ | Газар худалдах, худалдан авах | - | - | Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газрын Захирагчийн албаны дарга Х.Баатарсүх | 1.1 | Нэг талаас Баруун-Урт сумын Засаг даргын Тамгын газрын Захирагчийн албаны дарга Х.Баатарсүх, нөгөө талаас ............................................... |

Remove Watermark Now

pdfelement

Remove Watermark Now



**Хавсралт: Захиргааны ерөнхий хууль мөрдөгдөж эхэлснээс хойш захиргааны байгууллагуудын байгуулсан гэрээ /концесс/**
*(Доорх гэрээнүүдийг уулзалт, ярилцлага хийх хүрээнд захиргааны байгууллагуудаас судалгаанд зориулж авсан болно.)*

| Д/д | Концессын зүйлийн нэр | Эрх олгосон Засгийн газрын тогтоол | Төслийн ангилал | Гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээ | Маргаан шийдвэрлэх журам |
|---|---|---|---|---|---|
| 1 | Дундговь, Сайнцагаан сум, Цэцэрлэгийн барилга барих төсөл /ЗГ-ын 2016 оны 73-р тогтоолоор нэмсэн/ | 2016.06.06/308 | Боловсролын төслүүд | Дундговь аймгийн Сайнцагаан суманд 150 ортой цэцэрлэгийн барилга барих, шилжүүлэх | 7.3 Талууд маргааныг эвийн журмаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын шүүхийн байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлнэ. |
| 2 | Хөвсгөл, Цагаан-Уул сум, Цэцэрлэгийн барилга барих төсөл /ЗГ-ын 2016 оны 73-р тогтоолоор нэмсэн/ | 2016.06.06/308 | Боловсролын төслүүд | Хөвсгөл аймгийн Цагаан-Уул суманд 150 ортой цэцэрлэгийн барилга барих, шилжүүлэх | 7.3 Талууд маргааныг эвийн журмаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын шүүхийн байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлнэ. |
| 3 | Ховд, Жаргалант, 1 дүгээр цэцэрлэгийн барилга барих төсөл /ЗГ-ын 2016 оны 73-р тогтоолоор нэмсэн/ | 2016.06.06/308 | Боловсролын төслүүд | Ховд аймгийн Жаргалант суманд 180 ортой цэцэрлэгийн барилга барих, шилжүүлэх | 7.3 Талууд маргааныг эвийн журмаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын шүүхийн байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлнэ. |
| 4 | Баянхонгор аймаг, Баянхонгор сумын Баян-Ойт 1-р цэцэрлэгийн 100 ортой өргөтгөлийн барилга барих төсөл | 2016.06.06/308 | Боловсролын төслүүд | Баянхонгор, 6 суманд цэцэрлэгийн барилгын өргөтгөл барих, шилжүүлэх | 7.3 Талууд маргааныг эвийн журмаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын шүүхийн байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлнэ. |
| 5 | Баянхонгор аймгийн Баянхонгор сумын 6-р цэцэрлэгийн 100 хүүхдийн өргөтгөлийн барилга барих төсөл | 2016.06.06/308 | Боловсролын төслүүд | Баянхонгор, 6 суманд цэцэрлэгийн барилгын өргөтгөл барих, шилжүүлэх | 7.3 Талууд маргааныг эвийн журмаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын шүүхийн байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлнэ. |
| 6 | Баянхонгор аймгийн Өлзийт суманд баригдах 100 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөл барих төсөл | 2016.06.06/308 | Боловсролын төслүүд | Баянхонгор, 6 суманд цэцэрлэгийн барилгын өргөтгөл барих, шилжүүлэх | 7.3 Талууд маргааныг эвийн журмаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын шүүхийн байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлнэ. |
| 7 | Баянхонгор аймгийн Богд суманд баригдах 50 хүүхдийн | 2016.06.06/308 | Боловсролын төслүүд | Баянхонгор, 6 суманд цэцэрлэгийн барилгын өргөтгөл барих, шилжүүлэх | 7.3 Талууд маргааныг эвийн журмаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын шүүхийн байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлнэ. |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | цэцэрлэгийн өргөтгөл барих төсөл | | | | |
| 8 | Баянхонгор аймгийн Шаргалжуут тосгонд баригдах 75 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөл барих төсөл | 2016.06.06/308 | Боловсролын төслүүд | Баянхонгор, 6 суманд цэцэрлэгийн барилгын өргөтгөл барих, шилжүүлэх | 7.3 Талууд маргааныг эвийн журмаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын шүүхийн байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлнэ. |
| 9 | Баянхонгор аймгийн Баянговь суманд баригдах 100 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөл барих төсөл | 2016.06.06/308 | Боловсролын төслүүд | Баянхонгор, 6 суманд цэцэрлэгийн барилгын өргөтгөл барих, шилжүүлэх | |
| 10 | Хөвсгөл, Жаргалант сум, Цэцэрлэгийн барилга барих төсөл /ЗГ-ын 2016 оны 73-р тогтоолоор нэмсэн/ | 2016.06.06/308 | Боловсролын төслүүд | Хөвсгөл аймгийн Жаргалант суманд 150 ортой цэцэрлэгийн барилга барих, шилжүүлэх | 7.3 Талууд маргааныг эвийн журмаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын шүүхийн байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлнэ. |
| 11 | Хөвсгөл, Цагаан-Уул сум, Сургуулийн барилга барих төсөл /ЗГ-ын 2016 оны 73-р тогтоолоор нэмсэн/ | 2016.06.06/308 | Боловсролын төслүүд | Хөвсгөл аймгийн Цагаан-Уул суманд 320 суудалтай сургуулийн барилга барих, шилжүүлэх | 7.3 Талууд маргааныг эвийн журмаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын шүүхийн байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлнэ. |
| 12 | Дархан-Уул, Дархан сум, 5 дугаар баг, Жигүүр цогцолбор сургуулийн хашаанд Цэцэрлэгийн барилга барих төсөл /ЗГ-ын 2016 оны 73-р тогтоолоор нэмсэн/ | 2016.06.06/308 | Боловсролын төслүүд | Дархан-Уул аймгийн Дархан сумын 5 дугаар багт 100 ортой цэцэрлэгийн барилга барих, шилжүүлэх | 7.3 Талууд маргааныг эвийн журмаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын шүүхийн байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлнэ. |
| 13 | Хөвсгөл, Шинэ-Идэр сум, Цэцэрлэгийн барилга барих төсөл /ЗГ-ын 2016 оны 74-р тогтоолоор нэмсэн/ | 2016.06.06/308 | Боловсролын төслүүд | Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр суманд 150 ортой цэцэрлэгийн барилга барих, шилжүүлэх | 7.3 Талууд маргааныг эвийн журмаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын шүүхийн байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлнэ. |
| 14 | Хөвсгөл, Тариалан сум, Соёл, спортын цогцолборын барилга барих төсөл /ЗГ-ын 2016 оны 74-р тогтоолоор нэмсэн/ | 2016.06.06/308 | Боловсролын төслүүд | Хөвсгөл аймгийн Тариалан суманд 500 хүний суудалтай соёл, спортын цогцолборын барилга барих, шилжүүлэх | 7.3 Талууд маргааныг эвийн журмаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын шүүхийн байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлнэ. |
| 15 | Нийслэлийн Хан-Уул дүүрэг, 32 дугаар дунд сургууль төсөл | 2016/243 | Боловсролын төслүүд | Хуучин барилга буулгаж, шинээр барих, санхүүжүүлэх, шилжүүлэх | 7.3 Талууд маргааныг эвийн журмаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын шүүхийн байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлнэ. |
| 16 | Баянзүрх дүүрэг, 14-р дунд сургууль төсөл | 2016/259 | Боловсролын төслүүд | Хуучин барилга буулгаж, шинээр барих, санхүүжүүлэх, шилжүүлэх | 7.3 Талууд маргааныг эвийн журмаар шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын шүүхийн байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлнэ. |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 17 | Сонгино сум-Хяргас нуурын зүүн хаяа чиглэлийн 135.5 км хатуу хучилттай авто зам төсөл 12.1 65.5 км авто зам 12.2 70 км авто зам | 2016.12.28/63 | Авто замын төслүүд | Авто замын барилгын ажлыг гүйцэтгэх, санхүүжүүлэх, шилжүүлэх. | 7.3 Талууд маргааныг энэхүү гэрээний 7.2-т заасны дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Арбитрын шүүхэд гомдол гаргах замаар шийдвэрлүүлнэ. |
| 18 | Яармагийн товчооноос Жаргалантын ам хүртэлх 3.4 км хатуу хучилттай авто зам, Чингисийн хүрээ жуулчны баазад байрлах 400 автомашины зогсоол барих төсөл /ЗГ-ын 2016 оны 273-р тогтоолоор нэмсэн/ | 2016.06.20/ 343 | Авто замын төслүүд | Авто замын барилгын ажлыг гүйцэтгэх, санхүүжүүлэх, шилжүүлэх | - |
| 19 | Дархан-Сэлэнгийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км хатуу хучилттай авто зам төсөл /ЗГ-ын 2015 оны 306-р тогтоолоор нэмсэн. ЗГ-ын 2016 оны 226-р тогтоолоор өөрчлөн найруулсан/ | 2016.04.25/ 226 | Авто замын төслүүд | Авто замын зураг төсөл боловсруулах, барих | Гэрээ олдоогүй |
| 20 | Дархан-Эрдэнэтийн авто замаас Амарбаясгалантын хийд чиглэлийн 63 км хатуу хучилттай авто зам /ЗГ-ын 2015 оны 306-р тогтоолоор нэмсэн. ЗГ-ын 2015 оны 334-р тогтоолоор өөрчлөлт орсон/ | 2016.05.31/ 296 | Авто замын төслүүд | Авто замын зураг төсөл боловсруулах, барих | 7.3 Талууд маргааныг энэхүү гэрээний 7.2-т заасны дагуу шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын харьяа шүүхээр шийдвэрлүүлнэ. |

pdfelement

Remove Watermark Now



**Хавсралт: Захиргааны гэрээтэй холбогдуулан гаргасан нэхэмжлэл болон хэргийг хянан шийдвэрлэсэн судалгаа**

| № | Нэхэмжлэгч | Хариуцагч | Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан эсэх, татгалзсан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолын огноо дугаар | Анхан шатны шүүхийн шийдвэрийн огноо дугаар | Шүүхийн шийдвэрийг shuukh.mn цахим хуудаст болон Захиргааны хэргийн бүртгэл, хяналтын нэгдсэн системд байршуулсан эсэх | Давж заалдах болон хяналтын шатны шүүхэд хянагдсан эсэх, хянагдсан бол магадлал, тогтоолын огноо дугаар |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | “Бридж Констракшн” ХХК | Зам, тээврийн хөгжлийн яам | 2017.07.18 №4588 | - | БХСН-д байршуулсан | 2017.08.01 № 572 |
| 2. | “Өгөөж баян хангай” ХХК | Ашигт малтмал, газрын тосны газрын Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтсийн дарга | 2018.03.23 №3002 Захирамжаар захиргааны хэрэг үүсгэсэн бөгөөд одоо хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж байгаа | - | БХСН-д байршуулсан | - |
| 3. | “Мандал голомт” ХХК | Эрчим хүчний яам | 2018.03.23 №3489 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрээтэй холбоотойгоор нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлэн ажиллагаа явуулж байгаа | - | БХСН-д байршуулсан | - |
| 4. | Д.Цэнд-Аюуш Ц.Бямбабаатар И.Сүрэнхүү Д.Мөнхбаатар | Нийслэлийн Засаг дарга | 2018.06.04 №3489 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрээтэй холбоотойгоор нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлэн ажиллагаа явуулж байгаа | - | БХСН-д байршуулсан | - |
| 5. | Г. Ганболд | “Улаанбаатар цахилгаан түгээх станц” ТӨХК | 2018.05.31 №3452 Нэхэмжлэлийн бүрдүүлбэр хангуулахаар хугацаа тогтоосон | - | БХСН-д байршуулсан | - |
| 6. | “Кью эс си” ХХК | Засгийн газар, Үндэсний хөгжлийн газар | 2018.02.22 №1250 Концессын гэрээтэй холбоотой | - | БХСН-д байршуулсан | - |

pdfelement

Remove Watermark Now

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 7. | “Гулзалтын санаачилга” ТББ | Увс аймгийн Засаг дарга | - | 2017.10.11 №52 | Тийм | 2017.12.26 №221/МА2018/0002 2018.04.09 №158 |
| 8. | “Дэвшил Увс” ХХК | Увс аймгийн Засаг дарга | - | 2017.10.26 №54 | Тийм | - |
| 9. | “Бесткарагай” ХХК | Баян-Өлгий аймгийн Сагсай сумын Засаг дарга | Баян-Өлгий аймаг дахь захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2017 оны 04 сарын 05-ны өдрийн “Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах тухай” 110/Ш32017/0155 дугаартай шүүгчийн захирамж | - | Тус шүүхийн шүүгчийн 2017 оны 04 сарын 05-ны өдрийн дугаар 110/Ш32017/0155 нэгдсэн системд байршуулсан | - |
| 10. | Н.Бямбажав | Хөвсгөл аймгийн Баянзүрх сумын Засаг дарга | Татгалзаагүй | 2017.10.12 | Байршуулсан | Гомдол гаргаагүй |
| 11. | “Электрон техник” ХХК | Дундговь аймгийн Засаг дарга, Засаг даргын тамгын газар, Орон нутгийн өмчийн газар, Үнэлгээний хороо | Үгүй | 2017.11.28 №20 | Байршуулсан | 2018.02.01. №94 дугаартай магадлал 2018.04.18 №179 дугаартай тогтоол |
| 12. | “Койот трэйд” ХХК | Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Засаг даргын тамгын газрын дарга | - | 2017.08.09 113/ШШ2017/0008 | Тийм | Үгүй |

pdfelement

Remove Watermark Now



**Хавсралт: Захиргааны гэрээний ойлголттой холбоотойгоор хийсэн ярилцлагын мэдээлэл**

(Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг үнэлэхийн тулд “Захиргааны гэрээ” гэсэн сэдвээр докторантурт суралцаж байгаа А.Онон /ХБНГУ-ын Бавари мужын Аугсбургийн Их Сургууль/, Г.Уянга /Япон улсын Нагояа Их Сургууль/ нартай ярилцлага хийсэн)

**Захиргааны гэрээний судалгаатай холбоотой товч дүгнэлт**

- ХБНГУ-д Захиргааны гэрээг Захиргааны үйл ажиллагааны нэгэн хэлбэр мөн болохыг хүлээн зөвшөөрч, хуульчлах хүртэл тухайн үеийн хууль тогтоогч, хуульч эрдэмтдийн дунд багагүй хэлэлцүүлэг, санал, шүүмж явагдсан ч 1976 онд батлагдсан Verwaltungsverfahrensgesetz буюу Захиргааны үйл ажиллагааны тухай хууль (“ЗҮАтХ”)-д түүнийг Захиргааны актын нэгэн адил Захиргааны үйл ажиллагааны нэг хэлбэр мөн болохыг баталж, хуульчилсан. Захиргааны эрх зүйн шинжлэх ухааны нэрт эрдэмтэн Отто Майер “Төр болон Иргэдийн хооронд төрийн онцгой дээд эрх мэдлээс үүдэж буюу төр иргэдийн хооронд зөвхөн захирах-захирагдах хэлбэрийн харилцаа байдаг тул хувийн эрх зүйд түгээмэл хэрэглэгддэг, харилцан тохиролцоо бүхий тэгш эрхийн харилцаан дээр суурилдаг Гэрээг Захиргааны эрх зүйд байгуулах ямар ч боломжгүй бөгөөд энэ нь хууль зүйн хоосон мөрөөдөл юм.”[1] хэмээн хүчтэй шүүмжилж байсан хэдий ч хэд хэдэн эрдэмтэд түүний дүгнэлтийг шүүмжилж, тухайн үед гаргасан сурах бичгүүддээ Захиргааны гэрээ нь Захиргааны үйл ажиллагааны нэгэн хэлбэр байж болох талаар өөрсдийн байр суурийг илэрхийлсэн байдаг. Мөн шүүхийн практикт ч хэдийгээр Захиргааны гэрээ нь албан ёсоор баталгаажуулагдаагүй байсан хэдий ч энэ төрлийн маргаануудыг шийдвэрлэсэн тохиолдлууд байсныг дараах хүснэгтээс харж болно.

pdfelement

**Нийтийн эрх зүйн буюу Захиргааны гэрээтэй холбоотой маргаан шийдвэрлэсэн байдал[2]**

| | 1900 оноос өмнө | 1900 - 1909 | 1910 - 1919 | 1920 - 1929 | 1930 - 1939 | 1940 - 1949 | 1950 - 1959 | 1960 - 1969 | 1970 - 1979 | 1980 - 1989 | 1990 - 1994 | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Маргааны тоо** | 16 | 7 | 6 | 4 | 1 | - | 42 | 82 | 143 | 160 | 58 | 519 |
| **Маргааны тоо%** | 3,1 | 1,3 | 1,2 | 0,8 | 0,2 | 0,0 | 8,1 | 15,8 | 27,6 | 30,8 | 11,2 | 100,0 |

- 1976 оны 5 сарын 25-ны өдөр батлагдсан ЗҮАтХ-ийн 4-р бүлгийн 54-62 дугаар зүйлүүдэд Нийтийн эрх зүйн гэрээг буюу Захиргааны гэрээг хуульчилж, зохицуулсан байна (Уг хуулинд Захиргааны гэрээг Нийтийн эрх зүйн гэрээ хэмээн томъёолсон). Уг хуулийн 54 дүгээр зүйлд зааснаар Нийтийн эрх зүйд гэрээгээр (Нийтийн эрх зүйн гэрээ) эрх зүйн харилцаа үүсч, өөрчлөгдөж, дуусгавар болох боломжтой ба энэ нь бусад эрх зүйн хэм хэмжээнд харшлаагүй байна. Ялангуяа Захиргааны байгууллагаас тодорхой этгээдэд чиглэсэн Захиргааны акт гаргахын оронд уг этгээдтэй Нийтийн эрх зүйн гэрээ байгуулж болно гэж заасан бөгөөд ингэхдээ Нийтийн эрх зүйн ямар салбарт буюу ямар ямар Нийтийн эрх зүйн гэрээний төрлүүд байж болохыг хуулиар нэрлэн заагаагүй. Нэр томъёоны хувьд ЗҮАтХ-д Нийтийн эрх зүйн гэрээ гэж оруулж өгсөн боловч энэ нь Нийтийн эрх зүйн бүх гэрээнд хамааралтай бус зөвхөн Захиргааны эрх зүйд холбогдох Нийтийн эрх зүйн гэрээнд хуулийн зохицуулалт

[1] Jörn Ipsen, Allgemeines Verwaltungsrecht, 9.Auflage, 2015, 196 дахь тал.
[2] Hartmut Maurer/Bruno Bartscher, Die Praxis des Verwaltungsvertrags im Spiegel der Rechtssprechung, 1997, 13 дахь тал.

Remove Watermark Now

хамаарна гэдгийг Хуулийн 1 болон 2 дугаар зүйлд урьдчилсан нөхцөл болгон зааж өгсөн байна. Ингэснээр Нийтийн эрх зүйн бусад гэрээнүүд болох олон улсын, үндсэн хуулийн болон шашны зэрэг бусад гэрээнүүд хамаарахгүй болохыг ялган хуульчилсан.

- Монгол Улсын Захиргааны ерөнхий хууль (“ЗЕХ”)-ийн 52.2-т Захиргааны гэрээг хэрэглэж болох харилцааны төрлүүдийг заан дурдсан бол ЗҮАтХ-д Гэрээг эрх зүйн харилцааны төрлүүдээр ялган ангилсан зохицуулалт байхгүй бөгөөд 55 болон 56 дугаар зүйлд Захиргааны гэрээний ерөнхий хоёр төрлийг зохицуулсан байна. Хуулийн 55 дугаар зүйлээр “Харьцуулах гэрээ” буюу Гэрээ байгуулж буй хоёр талд гэрээний харилцааны явцад ямар нэгэн үл ойлгогдох нөхцөл байдал үүссэн нөхцөлд харилцан үгүйсгэж, үл ойлголцолд хүрэхгүйн тулд аль аль нь тухайн нөхцөл байдалд таарсан (тухайн нөхцөл байдалтай уялдуулан харьцуулж үйлдэл хийх) буулт хийх үүрэг хүлээсэн гэрээг зохицуулсан бол 56 дугаар зүйлд “Солилцох гэрээ” буюу Захиргаа болон иргэд харилцан бие биенийхээ өмнө үүрэг хүлээсэн хоёр талын үүргийн гэрээг хуульчилсан байна.

  Онолын хувьд Захиргааны гэрээг Тэгш эрх бүхий этгээдийн хооронд байгуулсан болон тэгш бус эрхтэй этгээдүүдийн хооронд байгуулсан гэрээ гэж хоёр ангилдаг. ЗҮАтХ-ийн 54 дүгээр зүйлийн 1 дэх өгүүлбэрт “Нийтийн эрх зүйд гэрээгээр (Нийтийн эрх зүйн гэрээ) эрх зүйн харилцаа үүсч, өөрчлөгдөж, дуусгавар болох боломжтой ба энэ нь бусад эрх зүйн хэм хэмжээнд харшлаагүй байна” гэж зааснаас харахад энэ нь тэгш эрхтэй болон тэгш бус эрхтэй этгээдүүйн хооронд байгуулагдах аль аль гэрээний үндэслэл болж байгаа бол 2 дахь өгүүлбэрт заасан “Ялангуяа Захиргааны байгууллагаас тодорхой этгээдэд чиглэсэн Захиргааны акт гаргахын оронд уг этгээдтэй Нийтийн эрх зүйн гэрээ байгуулж болно” гэсэн заалт нь зөвхөн тэгш бус эрхтэй этгээдүүдийн хооронд буюу Захиргаа иргэний хооронд байгуулагддаг гэрээний үндэслэл болж байна.

  ЗҮАтХ-ийн 55 болон 56 дугаар зүйлд заасан дээрх хоёр гэрээ нь Тэгш бус эрхтэй этгээдүүдийн хооронд байгуулагдах буюу Захиргаа иргэний хооронд байгуулагддаг гэрээний төрлүүд юм. Тэгш эрх бүхий этгээдүүдийн хооронд байгуулагддаг гэрээнд хоёр Захиргааны байгууллагын хооронд байгуулагдсан гэрээнүүд хамаарах бөгөөд тухайн харилцааг Захиргааны актаар зохицуулах ямар ч боломжгүй байна. Тухайлбал ХБНГУ-ын хувьд муж улсуудын хотуудын хооронд дундын хилийн зааг дахь гол, мөрний арчилгаа, хилийн зааг дахь хог хаягдлыг зохицуулах талаар гэх мэт олон гэрээ байгуулагддаг. Харин тэгш бус эрхтэй этгээдүүдийн хооронд байгуулагддаг гэрээний харилцааг эсрэгээрээ Захиргааны акт гарган зохицуулах боломжтой байдаг. Ийм гэрээнүүдэд тухайлбал:

  - Барилга байгууламж барихтай холбогдон байгуулагдах гэрээнүүд
  - Байгууллага болон төрийн албан хаагчийн хооронд хугацаанаас өмнө төрийн албанаас гарахад төлөх боловсрол эзэмшихэд үзүүлсэн дэмжлэгийг буцаан нөхөн төлөх үүрэг бүхий гэрээ
  - Цагдаагийн байгууллага болон цагдаагийн үүрэг хүлээгчийн хооронд байгуулагдах Цагдаагийн үүргийн гэрээ
  - Гудамж талбай дахь Тусгай ашиглалтын гэрээ гэх мэт байна.

- Гэрээний төрлүүдийн хувьд ХБНГУ-ын Захиргааны эрх зүйн практикт хамгийн өргөн хэрэглэгддэг сонгодог гэрээ бол Хот байгуулалт буюу хотжилттой холбоотойгоор Барилгын тухай хуульд үндэслэгдэж байгуулагддаг “Эзэмшил, ашиглалтын гэрээ”, “Барилга барихаас үүдэн гарах зардлын гэрээ”, “Газар ашиглалтын төлөвлөлт”, “Хуваарилалт”, “Авто машины зогсоолыг өөрчлөх” гэх зэрэг хэд хэдэн төрлийн гэрээнүүд байна. Мөн шүүхийн практикт ч нийт Захиргааны гэрээтэй холбоотой шийдвэрлэгдэж байгаа маргааны ихэнх хувийг Барилгын эрх зүйтэй холбоотой гэрээний маргаанууд эзэлж байгаа нь доорх хүснэгтээс харахад тодорхой байна.

Remove Watermark Now

**Захиргааны гэрээний маргааныг төрөлжүүлсэн байдал (тэгш бус эрхтэй эрхтэй этгээдүүдиийн хооронд байгуулагдсан гэрээ)[3]**

| Маргааны төрлүүд* | 1950 оноос өмнө | 1950 - 1959 | 1960 - 1969 | 1970 - 1979 | 1980 - 1989 | 1990 - 1994 | Дүн | Нийт шийдвэрт эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Барилгын эрх зүй | 9 | 6 | 38 | 64 | 77 | 33 | 227 | 43,7% |
| Орон нутгийн удирдлага | 6 | 2 | 5 | 15 | 20 | 3 | 51 | 9,8% |
| Нийтийн албаны эрх зүй | 10 | 4 | - | 9 | 4 | 1 | 28 | 5,4% |
| Боловсролыг дэмжих | - | - | 3 | 17 | 10 | 3 | 33 | 6,4% |
| Гудамж, талбайн эрх зүй | 3 | 2 | 6 | 4 | 1 | 2 | 18 | 3,5% |
| Байгаль орчны эрх зүй | - | - | 1 | 5 | 3 | - | 9 | 1,7% |
| Орон сууцны удирдлага, менежмент | - | 5 | 1 | - | - | - | 6 | 1,2% |
| Татаас | - | 3 | 1 | 5 | 5 | 2 | 16 | 3,1% |
| Булаан эзэлснээс үүдсэн хохирол | - | 3 | 1 | - | - | - | 4 | 0,8% |
| Захиргааны дотоод харилцаанаас үүдэх бусад эрх | 3 | 7 | 14 | 17 | 13 | 11 | 65 | 12,5% |
| Нийгэм хангамжийн эрх зүй | 2 | 4 | 8 | 5 | 29 | 5 | 53 | 10,2% |
| Татварын эрх зүй | 2 | 7 | 5 | 2 | 4 | - | 20 | 3,9% |
| **Нийт** | 35 | 43 | 83 | 143 | 166 | 60 | 530** | 0,0%** |

pdfelement

***** *Ангилалт хийхэд олон тохиолдлыг хамруулах боломжтой байсан*
*** Нийлбэр дүн 519 шийдвэрээс илүү буюу процентын хувь нь 100-аас илүү, учир нь шийдвэрийн нэг хэсэг нь олон салбарт хамаарч байсан*

Гэхдээ Захиргааны гэрээ нь зөвхөн Барилгын хуулиар зохицуулагддаг гэрээгээр хязгаарлагдахгүй олон салбар эрх зүйн хүрээн дэх олон төрлийн харилцаанд үйлчилдэг. Эдгээр гэрээний төрлүүдийг салбар эрх зүйгээр нь дурдвал Нутгийн удирлдагын эрх зүй, Төрийн албаны эрх зүй, Байгаль орчны эрх зүй, Төрийн сангийн дэмжлэг, зээлээр суралцах буюу Боловсролыг дэмжих, Нийгэм хангамжийн эрх зүй сүүлийн үед Татварын эрх зүйд хүртэл Захиргааны гэрээгээр зохицуулах харилцаа бий болсон байна. Энэ нь Захиргааны гэрээ нь өнөөгийн хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн эрх зүйт төрт улсад Захиргааны актаас илүү нийгмийн харилцааг өргөн хамаарч, зохицуулж чадаж байгааг илтгэж байна гэж үзэх боломжтой байна. Мөн түүнчлэн Захиргааны гэрээ нийгмийн хангамж өндөр хөгжсөн ХБНГУ-ын хувьд өдөр тутмын буюу массын захиргаанд өндөр ач холбогдолтой байгаа нь илэрхий болсон. Тухайлбал, Нийгмийн хангамжийн хуулийн 2 дахь дэвтэрт зохицуулсан Hart IV буюу Ажил хайгч иргэдтэй байгуулагддаг "Нэгтгэн

---

[3] Hartmut Maurer/Bruno Bartscher, Die Praxis des Verwaltungsvertrags im Spiegel der Rechtssprechung, 1997, 16 дахь тал

Remove Watermark Now

хамруулах тохиролцоо" нь өдөр тутмын Захиргааны үйл ажиллагаанд байнга байгуулагддаг түгээмэл Захиргааны гэрээний төрөл юм. Цаашлаад Гадаадын иргэдийн тухай хуульд заасан "Интеграцийн гэрээ" нь өнөөгийн Герман улсад маш олон тоогоор байгуулагдаж байгаа учир эдгээр гэрээнүүдийг Захиргааны массын гэрээ гэж үзэх болсон. Тиймээс Захиргааны гэрээ нь зөвхөн Захиргааны үйл ажиллагааны нэгэн төрөл гэхээс илүү нийгмийн олон харилцааг нарийвчлан зохицуулсан, идэхтэй үйл ажиллагааны хэлбэр гэдэг нь улам бүр батлагдаж байгаа бөгөөд нөгөө талаас Захиргаа дундад зууны үеийн зөвхөн захиран тушаах хэлбэрээс татгалзаж, иргэдийн хүсэл, сонирхлыг хүлээн авдаг, шийдвэр гаргахдаа тэдгээрийг оролцуулдаг, иргэдтэйгээ хамтран ажилладаг буюу Төр Иргэдийн хамтын ажиллагаа (Public Private Partnership) нь өнөөгийн нийгэмд улам бүр ач холбогдлоо өгч байгаа нь Захиргааны гэрээ Захиргааны актаас илүү нийгмийн харилцааг нарийн зохицуулж чадаж байна гэж үзэж болохоор байна.

- Захиргааны гэрээ илт хууль бус болох үндэслэл тогтоогдохгүй буюу Захиргааны гэрээ нь хууль ёсны байх тохиолдолд гэрээнд оролцогч талууд гэрээний үүргээ заавал биелүүлнэ. ЗҮАтХ-д гэрээний биелэлтийг хэрхэн хангах, гэрээний үүргээ зөрчсөн тохиолдолд хэрхэх талаар зохицуулалт байхгүй тул хуулийн 62 дугаар зүйлд 1). 54-61 дүгээр зүйлүүдэд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн бусад зүйл заалтууд үйлчлэнэ. 2). Иргэний хуулийн зүйл заалтуудыг нөхөн тохируулж хэрэглэнэ гэж заасны дагуу Иргэний хууль дахь үүргийн гүйцэтгэлийг хожимдож биелүүлэх, үүрэг гүйцэтгэх боломжгүй нөхцөл байдал үүсэх, гэрээний үүргийн зөрчил болон гэм буруу зэрэг гэрээний үүрэг биелүүлэхэд мөрдөгдөх ерөнхий зохицуулалтыг Иргэний хуулийн хэм хэмжээнээс тухайн Захиргааны гэрээний онцлог байдалтай уялдуулан, нөхөн тохируулж хэрэглэдэг. Хэрэв маргаан гарсан тохиолдолд аль аль тал шүүхэд хандан шийдвэрлүүлэх эрхтэй. Түүнчлэн ЗҮАтХ-ийн 62 дугаар зүйлд заасанаар тэгш бус эрхтэй этгээдүүдийн хооронд байгуулагдсан гэрээний аль ч тал нь гэрээний үүргээ биелүүлэхийг шаардаж шууд шийдвэр гүйцэтгүүлэхээр хандах боломжтой байдаг. Энэ тохиолдолд аль талаас Захиргааны гэрээг шууд гүйцэтгүүлэхээр өргөдөл гаргаж байгаагаас хамаарч Захиргааны шийдвэр гүйцэтгэлийн тухай хууль болон Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тодорхой хэм хэмжээг даган мөрдөхийг ялган зохицуулсан байна.

- Захиргааны гэрээний үндсэн шаардах эрхтэй холбоотой маргааныг Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэнэ. Үүнд үүргийн гүйцэтгэлийг дутуу буюу хангалтгүй биелүүлсэн болон хугацаа хожимдуулж биелүүлсэн явдлууд хамаарна. Харин BGH буюу Германы дээд шүүхийн шийдвэрт VwGO буюу Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх хуулийн 40.2-т заасан үндэслэлийг тайлбарлан, Гэрээг байгуулах явцад буюу Гэрээний бэлтгэл үе шатанд үүссэн хохирлын шаардлагыг Иргэний шүүхээр шийдвэрлэнэ хэмээн зөвлөсөн байна.

**Японы захиргааны эрх зүйн зохицуулалт**

Япон улсад захиргааны байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаанд захиргааны гэрээ нь өргөн хэрэглэгддэг. Онол болон шүүхийн жишигт хувийн болон нийтийн эрх зүйг ялган материалаг хуулиудад тайлбар хийх арга нь хэрэглэгдэхээ больсон бөгөөд материаллаг хуулиудад нийтийн эрх зүйн гэрээ гэсэн ойлголтыг хэрэглэх шаардлагагүй болсон гэж үздэг. Иймд захиргааны эрх зүйд гэрээний нэг тал эсвэл хоёр тал нь захиргааны байгууллага байгаа тохиолдолд үүнийг захиргааны гэрээ гэж нэрлэдэг[4].

Шионо Хироши нь Захиргааны эрх зүй Ⅰ-Захиргааны Ерөнхий анги[5] номондоо захиргааны гэрээг дараах 5 төрөлд хувааж авч үзсэн байна. 1. Захиргааны бэлтгэл ажлын хүрээнд байгуулагдах гэрээ 2. Халамжын захиргааны хүрээнд байгуулагдах гэрээ 3. Зохицуулах захиргааны хүрээнд байгуулагдах гэрээ 4. Захиргааны эрх зүйн субьект болон хувийн компануудын хооронд байгуулагдах гэрээ 5. Захиргааны байгууллага хооронд байгуулагдах гэрээ гэсэн 5 төрөлд хуваан тайлбарсан байна.

[4] Ичихаши Кацуяа болон бусад зохиогчид, "Бодит захиргаа" 2015 он, 2-р хэвлэл, 134 тал
[5] Шионо Хироши, "Захиргааны эрх зүй Ⅰ-Захиргааны Ерөнхий анги" 2013 он, 5-р хэвлэл, 186-199 тал



pdfelement

Remove Watermark Now

1. Захиргааны бэлтгэл ажлын хүрээнд байгуулагдах гэрээ

Захиргааны бэлтгэл ажлын хүрээнд байгуулагдах гэрээ гэдэг нь нийтийн захиргааг хэрэгжүүлэх зорилгоор түүнд хэрэглэгдэх материаллаг хэрэгслүүдийг бэлтгэхэд байгуулагддаг гэрээг энд ойлгоно. Өөрөөр хэлбэл, нийтийн үйл ажилллагааг явуулах газрыг сайн дурын үндсэн дээр авах үйл ажиллагаа, захиргааны байгууллагын байр байшинг барих, захиргааны байгуулагын хэрэглэх зарим хэрэгслийг нийлүүлэх үйл ажиллагаа зэрэг нь багтана. Эдгээр үйл ажиллагааны хувьд, Аудитын хууль, Төрийн өмчийн хууль, нутгийн өөрөө удирдах байгууллагын тухай хуульд зохицуулалт байгаа бөгөөд эдгээр нь Иргэний хуулийн хувьд тусгай зохицуулалт болж байна. Гэвч, энэ үйл ажиллагаанд Иргэний хуулиас өөр зарчмыг гаргаж ирж хэрэглээгүй.

Гэрээ байгуулахад гэрээний оролцогчдын тэгш байдлыг хангах нь зохистой үр дүнд хүргэнэ гэсэн баталгаа биш. Түүнчлэн нийтийн мөнгийг зарцуулж байгаа учир шударга байдлыг хангах үүднээс иргэний хууль дахь зарчмыг засах зэргээр хууль тогтоох онол болон тайлбар хийх онолыг хэрэглэх шаардлагатай. Жишээ нь, эдийн засгийн хувь үр ашигтай байх зарчим, өрсөлдөөнд суурилсан байх зарчим, шударга байх зарчим, ил тод байх зарчим зэргийг дурьдаж болно.

2. Халамжийн захиргааны хүрээнд байгуулагдах гэрээ

Халамжийн захиргаа гэдэг нь зам, нийтийн зориулалттай цэцэрлэг барих, түүний үйл ажилллагааг явуулах, нийтийн зориулалттай байгууламж, барих мөн үйл ажиллагааг нь явуулах, иргэдийн амьдралын баталгааг хангахад зориулсан үйл ажиллагаа явуулах, түүнчлэн хувь хүн болон олон нийтийн тав тух, сайн сайхныг бий болгох үйл ажиллагааг гүйцэтгэхэд чиглэсэн захиргааны үйл ажиллагааг хэлнэ[6]. Халамжийн захиргааны чиг үүргийг гүйцэтгэх тохиолдолд хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд захиргааны гэрээг хэрэглэх нь түгээмэл байдаг.

pdfelement

Мөн салбарын хуулиудад захиргааны гэрээг хэрэглэхийг зааж өгсөн нь түгээмэл байна. Гэвч, зарим тохиолдолд шийдвэр гаргахдаа захиргааны актыг ашиглахыг зааж өгсөн зохицуулалт байдаг. Жишээ нь, Усны тухай хуульд иргэдийг усаар хангах чиг үүрэг нь хот, дүүрэг, аймагт байдаг боловч уг чиг үүргээ бусдаар буюу хувийн компаниудаар хийлгэх тухай зааж өгсөн байна. Усны тухай хуулийн 24-р зүйлийн 3-т “Ус хангаан нийлүүлэгч нь Засгийн газрын тогтоолд заасны дагуу, ус хангаан нийлүүлэх үйл ажиллагааг явуулахын тулд техникийн үүднээс хариуцсан үйл ажиллагааны бүгдийг эсвэл нэг хэсгийг бусад хангаан нийлүүлэгч, эсвэл ус хангаан нийлүүлэх үйл ажиллагаа явуулдаг хувь этгээдэд, аль эсвэл уг үйл ажиллагааг зохистой, бүрэн гүйцэд гүйцэтгэж чадах этгээд гэж үзэн Засгийн газрын тогтоолд заасан шаардлага хангасан этгээдэд даалган өгч болно” гэж заасан байдаг.

Халамжийн захиргааны хүрээнд байгуулагдах захиргааны гэрээнд тэгш эрхийн зарчимд үндэслэн шударга байх, шударга чанартай үр дүнгийн баталгаагаар хангах, байнгын тогтвортой нийлүүлэлт /гэрээг цуцлах тохиолдолд хүндэтгэх шалтгаантай байх/, нөхцөл байдал өөрчлөгдсөнтэй холбоотой гэрээний уян хатан байдалд хязгаарлалт байх зэрэг Иргэний хуулийн зарчмуудаас онцлог зарчмууд үйлчилнэ.

3. Зохицуулах захиргааны хүрээнд байгуулагдах гэрээ

Зохицуулах захиргаа гэдэг нь иргэний эрх, эрх чөлөөг хязгаарлах замаар нийтийн зорилтыг биелүүлэх захиргааны үйл ажиллагааг хэлнэ. Зохицуулах захиргааны хүрээнд захиргааны актыг ашиглах нь илүү тохиромжтой байдаг. Захиргааны үйл ажиллагаа хуулийн дагуу явагдах зарчим илүү хүчтэй үйлчлэх салбар, жишээ нь татварын эрх зүйн салбарт талуудын чөлөөт хүсэл зоригт тулгуурласан зөвшилцлын үндсэн байгуулагдах захиргаа үйл ажиллагааны төрөл болох гэрээ нь бараг л хэрэглэгдэхгүй.Зохицуулах

---

[6] Үсүи Мицуаки “Захиргааны эрх зүйн ач холбогдол” 2011 он, 19 тал

Remove Watermark Now

захиргааны хүрээнд байгууллагддаг захиргааны гэрээний төрөл нь байгалийн бохирдлоос сэргийлэх гэрээ, цөмийн аюулгүй байдлын гэрээ зэрэг болно.

Энд жишээ болгон байгалийн бохирдлоос сэргийлэх гэрээний талаар авч үзнэ. Түүхэн талаас нь авч үзвэл, байгалийн бохирдолтой холбоотой зохицуулалт хангалтгүй байсан үед нутгийн өөрөө удирдах байгууллага нь хувийн компануудтай байгалын бохирдлын талаарх зохицуулалтын цоорхойг нөхөх зорилгоор байгалийн бохирдлоос сэргийлэх тухай гэрээг байгуулж эхэлсэн. Байгалийн бохирдлоос хамгаалахтай холбогдсон хуулийн зохицуулалт бий болсны дараа материаллаг хуульд зааж өгөөгүй тодорхой асуудлаар үүрэг бий болгох, мөн хуульд зааснаас илүү хатуу шаардлага тавьсан агуулга бүхий үүрэг тогтоон өгсөн гэрээнүүдийг батлах зэрэг аргыг ашигладаг болсон.

Захиргааны байгууллагын үйл ажиллагаа хуулийн дагуу явагдах зарчмыг хатуу хэрэглэвэл, хуульд тодорхой зааж өгөөгүй байгаа тохиолдолд хууль нь гэрээгээр хувийн компаниудад зохицуулалт бий болгох замаар үүрэг тогтоон өгөхийг үгүйсгэж байна, эсвэл хуульд заасан тохиолдолд хуульд зааснаас илүү хатуу зохицуулалтыг гэрээгээр бий болгох нь уг зарчимд харшилж байна гэж маргаан гарах боломжтой. Гэвч, энэ тохиолдолд оюун санааны эрх чөлөөнд хязгаарлалт тавиагүй, мөн компаниудын эдийн засгийн үйл ажиллагааны хувьд компани нь өөрөө тооцоолж үзээд компанийхаа үйл ажиллагаан дахь эрх чөлөөний нэг хэсгийг тавьж өгч байна гэж үзэх учраас уг гэрээ нь шууд хүчингүй болохгүй. Жишээ нь, байгалийн бохирдлоос сэргийлэх гэрээний агуулгын хувьд хуульд зааснаас илүү хатуу зохицуулалт агуулсан төдийгүй, нутгийн өөрөө удирдах байгууллагын ажилтан газар дээр нь очиж шалгалт хийх эрхийг зааж өгсөн тохиолдолд байдаг. Гэвч гэрээг зөрчсөн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эсвэл газар дээр очиж шалгалт хийхдээ хүч хэрэглэж болохгүй. Мөн гэрээгээр захиргааны байгууллага нь өөртөө эрх шинээр бий болгож болохгүй.

Сүүлийн үед бүс нутгийн орчныг сайжруулах хүрээнд байгуулагдаж байгаа гэрээнүүд нь сонирхол татаж байгаа. Уг гэрээний талууд нь захиргааны эрх зүйн субьект болон оршин суугчид байхаас гадна, хувь этгээдүүдийн хооронд байгуулагдсан гэрээнд захиргааны байгууллага зөвшөөрөл өгөх зэрэг аргууд хэрэглэгдэж байна.

pdfelement

Германд зохицуулах захиргааны хүрээнд байгуулагдах гэрээны төрөлд солилцооны гэрээ гэсэн төрөл байдаг. Уг гэрээгээр захиргаа нь хувь этгээдэд тусгай зөвшөөрөл олгох эрэг үйлчлэл бүхий захиргааны акт гаргахыг амлах бөгөөд хувь этгээд нь үүний хариуд тодорхой гэрээний үүрэг хүлээнэ. Жишээ нь захиргаа нь барилгын тухай хуульд заасан граш барих үүргээс чөлөөлсөний хариуд барилга барих этгээд нь хотод машины зогсоол барих зардлын тодорхой хэсгийг төлөх үүрэг хүлээх гэрээ багтана. Үүнтэй адил Японд захиргаа нь орон сууцны газарт бүтээн байгуулалт явуулах тусгай зөвшөөрөл олгон, хариуд нь гэрээний нөгөө талаас бүтээн байгуулалтанд туслах мөнгө эсвэл хариуцах зардлыг төлүүлэх тухай гэрээ байгуулах тохиолдол байдаг.

4. Захиргааны эрх зүйн субьект болон хувийн компаниудын хооронд байгуулагдах гэрээ

Энд хувийн компаниудын хөрөнгө санхүүжилтээр нийтийн үйлчилгээний шинэчлэлийн хүрээнд байгуулагдах захиргааны гэрээг дурьдсан байна. Энэ төрлийн гэрээний талаар Ичихаши Кацуяа болон бусад зохиогчдын хамтран бичсэн “Бодит захиргаа” номонд дараах байдлаар тайлбарлагдсан байна[7].

Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүргийг бүхэлд нь эсвэл зарим хэсгийг бусад этгээдэд даалгаж болно. Даалгаврын гэрээнд дараах 3 төрөл байдаг: 1. Чиг үүргийг бусдад даалгаж шилжүүлэх 2. Өөрийн чиг үүргийг төлөөлүүлэн гүйцэтгүүлэх буюу төлөөллийг шилжүүлэх 3. Даалгавар гүйцэтгэгч нь захиргааны гар хөл болж тухайн үйл ажиллагааг явуулах боловч даалгавар өгөгч нь гадагш чиглэсэн харилцаанд бүх хариуцлагыг хариуцдаг гэсэн 3 төрөл байна.

[7] Ичихаши Кацуяа болон бусад зохиогчид, “Бодит захиргаа” 2015 он, 2-р хэвлэл, 137 тал

Remove Watermark Now

Эхний 2 төрлийн даалгаварын гэрээнд хууль, ИТХ болон Иргэдийн хурлын тогтоол дээрх хуулийн үндэслэл шаардлагатай учир гуравдах төрөл болох даалгавар гүйцэтгэлийн төрөл нь их ашиглагддаг. Төрийн болон орон нутгийн байгууллагын төсвийг хэмнэх үүднээс хувийн компануудад төрийн болон орон нутгийн байгууллагын чиг үүргийг даалгах үйл ажиллагаа явагдаж эхэлсэн. Ойрын жилүүдэд төрийн зохицуулалт ихтэй зах зээлийг хувийн компануудад нээлттэй болгох хэрэгцээ шаардлагын улмаас, хувийн компануудад төрийн болон орон нутгийн байгууллагын чиг үүргийг даалгах ажиллагааг дэмжихын тулд 2005 онд батлагдсан “Нийтийн үйлчилгээний шинэтгэлийн тухай хууль” батлагдсан.

Мөн үүнтэй төстэй PFI (Private Finance Initiative) буюу хувийн компануудын санжүүжилтын санаачлагын хүрээн дэх арга байдаг. Энэ нь нийтийн байгууламж зэрэг бүтээн байгуулалтын үйл ажиллагааг бүгдийг нь хувийн компануудаар хариуцуулан явуулах арга юм. Уг гэрээгээр хариуцагч болон хувийн компануудын хоорондын үүрэг , хариуцлага, эрсдэл зэргийг хувиарлан, төр болон орон нутгийн байгууллагаас үзүүлэх дэмжлэгийг зааж өгдөг. Энэхүү үйл ажилллагааг 1999 онд батлагдсан “хувийн компануудын санхүү зэргийг ашиглан нийтийн байгууламжын бүтээн байгуулалт зэргийг дэмжих тухай хууль”-аар зохицуулдаг.

5. Захиргааны байгууллага хооронд байгуулагдах гэрээ

Захиргааны байгууллага хоорондоо Иргэний хуульд заагдсан гэрээг байгуулах тохиолдол байдаг. Жишээ нь төрийн өмчийн газрыг нутгийн өөрөө удирдах байгууллагад худалдах худалдан авах гэрээ. Захиргааны байгууллага хооронд байгуулагдах онцлог гэрээний нэг нь хамтарсан үйл ажиллагаа явуулах тухай гэрээ юм. Жишээ нь А хотын бага насны хүүхдүүд олон амьдардаг газар нь В хотын сургуульдаа ойр байгаа тохиолдолд хүүхдүүдийн ойр байгаа газар нь сургуульд явуулах нь илүү тохиромжтой. Одоогийн хуулиар нутгийн өөрөө удирдах байгууллагуудын хоорондын харилцан зөвшилцлын үндсэнд А хот өөрийн боловсролын үйл ажиллагаа явуулах чиг үүргээ В хотод даалган өгөх аргыг ашиглаж байна. Нутгийн өөрөө удирдах байгууллагын тухай хуулийн 252-ын 14[8]-д нутгийн өөрөө удирдах байгууллага нь өөрийн чиг үүргийнхээ нэг хэсгийг бусад нутгийн өөрөө удирдах байгууллагад даалгах тухай зааж өгсөн байна.

pdfelement

[8] Нутгийн өөрөө удирдах байгууллагын тухай хуулийн 252-ын 14-р зүйлийн 1-т “Ерөнхий нутгийн өөрөө удирдах байгууллага нь зөвшилцлын үндсэн дээр тогтоол батлан, ерөнхий нутгийн өөрөө удирдах байгууллагын хариуцсан явуулах үйл ажиллагааны /чиг үүрэг/ нэг хэсгийг, бусад ерөнхий нутгийн өөрөө удирдах байгууллагад даалган өгч, уг бусад ерөнхий нутгийн өөрөө удирдах байгууллагын дарга нь эсвэл хороо аль эсвэл хорооны гишүүнийг хянан гүйцэтгүүлнэ” гэж заасан. 2-д “Өмнөх заалтаар даалган өгсөн хариуцан явуулах үйл ажиллагааг өөрчлөх, эсвэл уг үйл ажилллагааг цуцлах тохиолдолд уг ерөнхий нутгийн өөрөө удирдах байгууллага нь өмнөх заалтанд заасантай ижил зөвшилцсөны үндсэнд явуулах шаардлагатай” гэж заасан.
Мөн уг хуулийн 252-р зүйлийн 15-д “Хариуцсан үйл ажиллагааг даалган өгөх тухай тогтоол” тусгагдах шаардлагатай зүйлүүдийг зааж өгсөн.
Өмнөх зүйлд үндэслэн ерөнхий нутгийн өөрөө удирдах байгууллагын чиг үүргийг даалган өгөх тухай тогтоолд дор дурьдсан асуудлуудтай холбогдох зүйл заалтыг зааж өгөх хэрэгтэй.
1. Даалгаж байгаа ерөнхий нутгийн өөрөө удирдах байгууллага болон дааж авч буй ерөнхий нутгийн өөрөө удирдах байгууллага
2. Хариуцуулан өгөх үйл ажиллагааны цар хүрээ болон хариуцсан үйл ажиллагааг явуулах, хэрэгжүүлэх арга
3. Хариуцсан үйл ажиллаганд шаардагдах зардлыг төлөх арга
4. Өмнө дурьдсан зүйлээс өөр даалган өгөх үйл ажиллагаантай холбоотой шаардагдах асуудлууд.
Захиргааны эрх зүйн субьектын ангилалд ерөнхий болон тусгай нутгийн өөрөө удирдах байгууллага гэсэн ангилал байдаг бөгөөд ерөнхий нутгийн өөрөө удирдах байгууллагад аймаг, хот, дүүрэг, тосгон зэрэг нь хамаарна. Харин тусгай нутгийн өөрөө удирдах байгууллагад Токио хот нь хамаарна.